ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН ЭМХТГЭЛ

(2010-2011)

II

ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн
10 жилийн ойд зориулав.

СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН ЭМХТГЭЛ

/2010-2011 ОН/

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.ilt.gov.mn

Улаанбаатар хот
2012 он

DDC
340'015
С-701

Судалгааны баг:

Удирдсан:

Д.Батжаргал	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал
Б.Чимид	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн зөвлөх /Ph.D/
Б.Гүнбилэг	Хууль зүйн доктор /Ph.D/
Н.Мягмар	Докторант
Р.Мухийт	Захиргаа, хүмүүнлэгийн эрх зүйн секторын эрхлэгч
Ж.Соёлмаа	Олон улсын эрх зүйн секторын эрхлэгч
Б.Тэмүүлэн	Хууль зүйн доктор /Ph.D/
Ж.Энхнасан	Эрүүгийн эрх зүй, криминологийн секторын эрхлэгч

Судалгааны багийн гишүүд:

Л.Амаржаргал
Ц.Баттуяа
Ч.Бат-Уянга
Г.Батчимэг
Р.Болормаа
Д.Мэнджаргал
Б.Наранцацрал
Х.Наранцацрал
Ц.Одмаа
Ц.Одончимэг
Б.Оюунбилэг
Г.Оюунболд
Х.Өсөх
Б.Сансар
Б.Солонго
Д.Сумъяацэрэн
Д.Тамир
А.Түвшинтулга
Г.Халиунаа
Ц.Цэлмэг
Б.Энх-Амгалан

© Хууль зүйн үндэсний хүрээлэн

Эрхлэн бэлтгэсэн:	Х.Наранцацрал
Хянасан:	Б.Амарсанаа /LL.D/
Хэвлэсэн газар:	ХЗҮХ-ийн хэвлэх үйлдвэр
Хэвлэлийн хуудас:	75
Цаасны хэмжээ:	В5
Хэвлэсэн тоо:	250 ш
Хэвлэлийн хугацаа:	2012 оны 6 дугаар сар

ISBN: 978-99962-57-36-0

Хууль зүйн үндэсний хүрээлэн
www.nli.gov.mn

ГАРЧИГ

Өмнөх үг 7

Товчилсон үгийн жагсаалт 8

ЗАХИРГАА, ХҮМҮҮНЛЭГИЙН ЭРХ ЗҮЙН СЕКТОР

Батлан хамгаалах салбарын хууль тогтоомжийн уялдаа /Монгол Улсын Үндсэн хууль болон хууль тогтоомжийн бусад акттай нийцсэн байдал/ 13

Орон сууцны талбайн хэмжээг тогтоох аргачлалтай холбоотой эрх зүйн актын судалгаа 69

Захиргааны хариуцлага хүлээлгэх эрх бүхий албан тушаалтан, түүний эрх зүйн байдал, захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаа, түүнд тавих хяналтын талаарх зохицуулалтыг боловсронгуй болгох нь 81

Хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хүрээнд хийсэн судалгаа 109

Согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, худалдах, түүгээр үйлчлэхэд төрөөс тавих хяналт, хязгаарлалтын боломж, харьцуулсан судалгаа /ОХУ, Канадын эрх зүйн зохицуулалт/ 121

Сонгуулийн эрх зүй дэх хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох нь 137

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хүрээнд хийсэн судалгаа 179

Мэдээллийн "Монцамэ" агентлагийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хүрээнд хийсэн судалгаа 205

Иргэдэд хууль зүйн зөвлөгөө, эрх зүйн туслалцаа үзүүлж буй өнөөгийн байдал, эрх зүйн орчинг сайжруулах арга зам 233

Шүүхийн болон шүүхийн өмнөх шатанд эвлэрэл, зуучлалын эрх зүйн харилцааг зохицуулах хэрэгцээ, шаардлага 261

Төрийн албаны эрх зүйн байдлын түүхэн тойм, шинэтгэл, түүний агуулга 287

ИРГЭН, ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЗҮЙН СЕКТОР

Үүргээ гүйцэтгээгүй болон зохих ёсоор гүйцэтгээгүй эмч, эмнэлэгийн ажилтны бусдад учруулсан хохирлыг нөхөн төлж буй байдал 341

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний эрх зүйн орчны өнөөгийн төлөв байдал, тулгамдсан асуудал 377

Дампуурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахтай холбоотой хийсэн судалгаа 429

Хөдлөх эд хөрөнгийн болон эрхийн барьцааны тухай хуулийн төслийг боловсруулахтай холбоотой хийсэн судалгаа 469

Төрийн бус байгууллагын тухай хуулийн төсөлтэй холбоотой хийсэн судалгаа 505

Арбитрын тухай хуулийн хэрэгжилт, хүндрэл бэрхшээл, эрх зүйн орчныг сайжруулах арга зам 533

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ, КРИМИНОЛОГИЙН СЕКТОР

Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэргийн шалтгаан, нөхцөл 563

Бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах эрх зүйн орчин 589

Өршөөл үзүүлэх тухай хуулийн үр нөлөө 607

Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн хүмүүсийн сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох асуудал 619

Хил хамгаалах байгууллагад үйлдэгдэж байгаа онц хүнд гэмт хэргийн шалтгаан, нөхцөл 645

Шоронгоос суллагдсан хүмүүст нийгэмд дасан зохицоход дэмжлэг үзүүлэх бодлого боловсруулах нь 659

Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн төлөв байдал 681

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн хэрэгжилтийн төлөв байдал 709

Хэвлэлийн хүндэтгэлийн хуулийн эрхлэгч www.nii.gov.mn

ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН СЕКТОР

Зүүн хойд азийн аюулгүй байдал, олон улсын эрх зүйн асуудал 733

Монгол Улсын нэгдэн ороогүй олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцийн судалгаа 761

Монгол Улсын Эрүүгийн хуулийг ОХУ-ын Эрүүгийн хуультай харьцуулсан судалгаа /Ерөнхий анги/ 793

Шүүх эрх мэдлийн хүрээнд олон улсын хувийн эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх үндэслэл, арга зүй: олон улсын худалдааны эрх зүйг арбитрын шүүхэд хэрэглэх асуудал 829

Харьяатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах зорилгоор хийсэн судалгаа 861

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ӨМНӨХ ҮГ

Хууль зүйн үндэсний хүрээлэн нь анх "Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл, сурталчилгааны үндэсний төв" нэртэйгээр 2002 онд байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн ба Монгол Улсын хууль тогтоомжийн төлөв байдал, хандлага, хэрэгцээ, үр нөлөөг судалж, эрдэм шинжилгээний зөвлөмж, аргачлал боловсруулах, шинээр батлагдах хууль тогтоомж болон хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал, дүгнэлт өгөх, хууль зүйн үргэлжилсэн сургалт явуулах, үндэсний хэмжээнд хууль тогтоомжийн бүртгэл, системчлэл, мэдээлэл сурталчилгааг зохион байгуулах, хууль тогтоомжийн тогтолцоо, хэрэгжилт уялдаа, үр нөлөөг шинжлэх ухааны үндэстэй судалж, холбогдох асуудлаар төрийн бодлого боловсруулах, хууль тогтоомжийг боловсронгуй болгох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй.

Тус хүрээлэнгийн эрдэм шинжилгээний Иргэн, эдийн засгийн эрх зүй, Захиргаа, хүмүүнлэгийн эрх зүй, Эрүүгийн эрх зүй, криминологи, Олон улсын эрх зүйн секторууд нь тодорхой салбар эрх зүйн чиглэлээр төлөвлөгөөт болон захиалгат эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудыг хийж ирсэн.

Энэхүү эмхтгэлээр тус хүрээлэнгийн эрдэм шинжилгээний секторуудын 2010, 2011 онд хийж гүйцэтгэсэн урьд өмнө хэвлэгдээгүй эрдэм шинжилгээний судалгааны зарим ажлуудыг эмхтгэн /хавсралтгүйгээр/ гаргаж байгаа бөгөөд энэ нь эрх зүйн шинжлэх ухааныг шимтэн судалдаг, сонирхдог уншигчдын хүртээл болохоос гадна цаашид гүнзгийрүүлэн судлах, тухайн материалыг шинжлэх ухааны болон практик судалгааны эргэлтэд оруулах боломжийг олгож байгаагаараа ач холбогдолтой юм.

Мэргэн уншигч Та болгооно уу.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН
ЗАХИРАЛ Д.БАТЖАРГАЛ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АИХ	Ардын Их Хурал
АДХ	Ардын Депутатуудын хурал
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АПЕК	Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны Форум
АПМСДМ	Ази, Номхон далайн аюулгүй байдлын олон талын яриа хэлцлийн механизм
АСЕАН	Зүүн Өмнөд Азийн улс орнуудын нийгэмлэг
АРФ	АСЕАН-ны бүс нутгийн чуулга
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНАСУ	Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Улс
ДХБ	Дэлхийн худалдааны байгууллага
ЕАБХАБ	Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага
ЕХ	Европын холбоо
ЗХА	Зүүн хойд Ази
ЗХУ	Зөвлөлт Холбоот Улс
ЗХШ	Захиргааны хэргийн шүүх
ЗХХШтХ	Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
ЗХЭЗС	Захиргаа, хүмүүнлэгийн эрх зүйн сектор
ТХЕХ /ГАТТ/	Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр
ГБХТтХ	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
ГХЯ	Гадаад харилцааны яам
ИБМА	Иргэний бүртгэл мэдээллийн алба
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ИУТЭОУП	Иргэний улс төрийн эрхийн олон улсын пакт
ИХШХШтХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
ИЭЗЭЗС	Иргэн, эдийн засгийн эрх зүйн сектор
МДШТ	Мэдээлэл, дүн шинжилгээний тасаг
МӨХ	Монголын Өмгөөлөгчдийн Холбоо
МСНЭ	Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл
МУИХСтХ	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль
МУИС	Монгол Улсын Их Сургууль

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.ulgov.mn

МҮХАҮТ	Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
НҮБ	Нэгдсэн Үндэсний байгууллага
НЦГ	Нийслэлийн цагдаагийн газар
ОНРТ	Олон нийтийн радио телевиз
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ОУЭЗ	Олон улсын эрх зүй
ОУЭЗС	Олон улсын эрх зүйн сектор
ОХУ	Оросын Холбооны Улс
СБДНЭ	Сүхбаатар дүүргийн нэгдсэн эмнэлэг
СБТ	Сонгогчдын боловсрол төв
СЕХ	Сонгуулийн Ерөнхий хороо
СнЗ	Сайд нарын Зөвлөл
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ТББ	Төрийн бус байгууллага
ТТГ	Төлөөлөгчдийн танхимын гишүүд
УДШ	Улсын Дээд шүүх
УЕПГ	Улсын Ерөнхий прокурорын газар
УИХ	Улсын Их Хурал
ЦЕГ	Цагдаагийн Ерөнхий газар
ЦЦАХНҮБЭСБОУБАОТХ	Цэрэг, цагдаагийн албан хаагчдыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай хууль
ҮНТН	Үндэстний нэн тааламжтай нөхцөл
ҮХЦ	Үндсэн хуулийн цэц
ҮХЦМХШтХ	Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль
ҮХЦтХ	Үндсэн хуулийн цэцийн тухай хууль
ХАҮТ	Худалдаа, аж үйлдвэрийн танхим
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман улс
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХЗС	Хууль зүйн сургууль
ХЗҮХ	Хууль зүйн үндэсний хүрээлэн
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХМХ	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ШУА	Шинжлэх ухааны академи
ШХАБ	Шанхайн Хамтын ажиллагааны байгууллага
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ЭБИ	Эмзэг байдлын индекс

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.jus.gov.mn

ЭБША	Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа
ЭБШХ	Эрүүгийн байцаан шийтгэх хууль
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХ	Эрүүгийн хууль
ЭША	Эрдэм шинжилгээний ажилтан
ЭЭЗКС	Эрүүгийн эрх зүй, криминологийн сектор
ЮНКТАД	Худалдаа ба хөгжлийг дэмжих олон улсын бага хурал
ЮНСИТРАЛ	НҮБ-ын комиссын үүргийг гүйцэтгэдэг байгууллага

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

I БҮЛЭГ

ЗАХИРГАА, ХҮМҮҮНЛЭГИЙН ЭРХ ЗҮЙН СЕКТОР

хуулийн мэдээний хүрээлэн
www.nli.gov.mn

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН УЯЛДАА /МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ БОЛОН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН БУСАД АКТТАЙ НИЙЦСЭН БАЙДАЛ/[1]

ОРШИЛ

Улс орны батлан хамгаалах бодлого бол Үндсэн хуулийн үзэл баримтлалд тулгуурлан өөрийн орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хамгаалах төрийн үйл ажиллагааны чухал салбарын нэг мөн. 1992 онд ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдан гарснаас хойш батлан хамгаалах салбарын хууль тогтоомжид эрх зүйн шинэ үзэл санааг нэвтрүүлж, хууль тогтоомж, түүнийг тогтоох, хэрэглэх практикийг зарчмын хувьд шинэтгэх үйл явцыг хэрэгжүүлэх шаардлага бий болсон. Энэхүү үйл явцыг Монгол Улсад "эрх зүйн шинэтгэл" гэсэн нэр томъёогоор илэрхийлсэн. Эрх зүйн шинэтгэл нь улс төр, эрх зүй, нийгэм, эдийн засгийн шинэ бодлоготой салшгүй холбоотой байдаг. Товчоор хэлбэл, хуучин тогтолцоог халж, шинэ тогтолцоог бий болгох зорилгоор эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлдэг байна.

Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд батлагдсан зарим хууль тогтоомж нь онол, арга зүй, үзэл баримтлалын хувьд бүрхэг, хууль тогтоомжийн салбар институтийн уялдаа сул, нэр томьёо, ойлголт нь оновчтой биш, зөрүүтэй, захиргааны шийдвэрийг хуулийн хэмжээнд өргөмжлөхийг оролдсон, давхардал ихтэй, хуулийн зохицуулалтыг илүү нарийн зохицуулалттай дүрэм, журмаар өөрчлөх хандлага ажиглагдаж байгаа нь эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлж байгаа өнөөгийн бодит байдалд дүн шинжилгээ хийх нийтлэг шаардлагыг бий болгож байна. Энэхүү нийтлэг хэрэгцээ шаардлага нь батлан хамгаалах салбарын хууль тогтоомжид нэгэн адил хамаарах учир энэ салбарын хууль тогтоомжид мөн адил судалгаа шинжилгээ хийх үндэслэл болж байна.

Нэг. БАТЛАН ХАМГААЛАХ УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

Монгол Улсын батлан хамгаалах бодлогын нэг үндсэн гол асуудал нь төрийн батлан хамгаалах тогтолцоо юм. Төрийн энэхүү батлан хамгаалах тогтолцоо нь үндэсний аюулгүй байдлыг хангах нэгдсэн тогтолцооны салшгүй бүрэлдэхүүн хэсэг болж, үйл ажиллагаа нь тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг гадны зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалахад улс орныхоо бэлэн байдлыг хангах зорилго бүхий улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүйн, цэргийн нэгдмэл арга хэмжээг төрөөс улсын хэмжээнд нэгтгэн төлөвлөж, уялдуулан зохион байгуулж, удирдан хэрэгжүүлснээр хангах болно.

Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 11.1-т "Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн" гэж заасны дагуу төрийн бүх байгууллага чиг үүргийнхээ хүрээнд батлан хамгаалах тогтолцоонд хамаарагдах бөгөөд улс

[1] Энэхүү судалгааг Батлан хамгаалах яамны захиалгаар хийж гүйцэтгэсэн болно.

орныг батлан хамгаалах ерөнхий удирдлагыг Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар тус тусын хуулиар олгогдсон чиг үүрэг, эрх мэдлийнхээ хүрээнд хэрэгжүүлнэ. Үүнээс гадна батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангах нь цэргийн мэргэжлийн байгууллагууд, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, ард иргэдэд хуулиар тогтоосон үүрэг хүлээлгэсэн. Үндсэн хуулийн 17 дугаар зүйлд зааснаар Монгол Улсын иргэний үндсэн үүрэгт Эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах нь хамаарна.

Үндсэн хуулийн 20 дугаар зүйлд "Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн" болохыг тодорхойлсон бөгөөд Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг жүрмыг хангах нь төрийн үүрэг мөн" батлан хамгаалахын ерөнхий удирдлагад Төрийн дээд байгууллага болох Улсын Их Хуралд тэргүүн ээлжид хамаарна.

Нөгөө талаар Улсын Их Хурлын 1993 оны 10 дугаар сарын 12-ны өдөр баталсан Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн зорилт нь "Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог тогтоож, төрийн байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн эх орноо батлан хамгаалах талаар хүлээх үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино" гэж заасан бөгөөд уг хуулийн хоёрдугаар бүлэгт батлан хамгаалах талаарх Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрхийг, гуравдугаар бүлэгт төрийн захиргааны төв байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн батлан хамгаалахтай холбоотой үүргийг тус тус тусгайлан зохицуулсан байна.

Батлан хамгаалах удирдлагын тогтолцоог Батлан хамгаалах тухай хуульд тусгайлан зохицуулаагүй боловч тус хуулийн бүтэц нь Монгол Улсын батлан хамгаалах удирдлагын үндсэн тогтолцоог тогтоосон бөгөөд харин 1998 оны Дайны байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд "Батлан хамгаалах удирдлагын тогтолцоо нь Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, түүний тэргүүлсэн Үндэсний аюулгүй байдлын хороо, Засгийн газар, Цэргийн дээд командлалын газар, батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Зэвсэгт хүчний Жанжин штаб, цэргийн удирдлагын байгууллагууд, аймаг, нийслэлийн батлан хамгаалах газар, сум, дүүргийн батлан хамгаалах товчооноос бүрдэнэ" гэж тодорхойлсон байна.

А. БАТЛАН ХАМГААЛАХ ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БҮРЭН ЭРХ

1. Батлан хамгаалах тухай хуулийн зохицуулалт

Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлд Улсын Их Хурлын өөрийн онцгой бүрэн эрхийг тусгайлан заасан бөгөөд мөн зүйлийн 4 дэх хэсэгт УИХ-ын бусад бүрэн эрхийг хуулиар тогтоохоор заасан байдаг. Иймд Улсын Их Хурлын батлан хамгаалахтай холбоотой бүрэн эрхийг Үндсэн хуулийн дагуу Батлан хамгаалах тухай хууль болон бусад хуулиар тусгайлан зохицуулсан байна.

Батлан хамгаалах хуулийн 6 дугаар зүйлд Монгол Улсын Их Хурлын батлан хамгаалах талаарх бүрэн эрхийг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

1/ батлан хамгаалах тогтолцооны эрх зүйн үндсийг тогтоох;

2/ дайны аюулыг сэрэмжлэх, бусад улс оронтой маргаантай асуудлыг улс төрийн аргаар шийдвэрлэх;

3/ Монгол Улсын Төрийн цэргийн бодлогын үндсийг тодорхойлох;

4/ цэргийн албан хаагчийн нийгмийн хамгаалал, эрх зүйн баталгааны үндсийг тодорхойлох;

5/ батлан хамгаалах хамтын ажиллагааны талаарх Монгол Улсын олон улсын гэрээг соёрхон батлах, цуцлах;

6/ улс орныг батлан хамгаалах арга хэмжээний төсвийг батлах, батлан хамгаалах хүч чадлыг бэхжүүлэх үндсэн чиглэлийг тодорхойлох;

7/ цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлыг албаны онцлогт нь тохируулж тогтоох;

8/ цэргийн дээд цол бий болгох;

9/ гадаадын цэргийн хүчнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлуулах, дамжин өнгөрүүлэх болон өөрийн цэргийн анги, салбарыг олон улсын энхийг сахиулах болон хүмүүнлэгийн ажиллагаанд оролцуулах асуудлыг шийдвэрлэх.

1.1.Батлан хамгаалах тогтолцооны эрх зүйн үндсийг тогтоох

Улсын Их Хурлын бүрэн эрхэд батлан хамгаалах тогтолцооны эрх зүйн үндсийг УИХ тусгай хуулиар тогтоох бөгөөд Монго Улсын батлан хамгаалах тогтолцооны эрх зүйн үндсийг батлан хамгаалах хууль болон бусад хууль тогтоомжоор тогтоон хэрэгжүүлж байна.

Батлан хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т заасан УИХ-ын батлан хамгаалах тогтолцооны эрх зүйн үндсийг тогтоох бүрэн эрх нь Үндсэн хуулийн 20 дугаар зүйлд заасан хууль тогтоох эрх мэдэл гагцхүү УИХ-д хадгална, мөн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-т хууль батлах эрх нь УИХ-ын онцгой эрх болохыг тусгай хуульд тодотгон тусгасан хэлбэр болно.

Нэр томьёоны хувьд: **тогтолцооны эрх зүйн үндсийг тогтоох** гэсэн нэр томъёог Үндсэн хуулийн 25 дугаар зүйлд нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын **тогтолцоо, ... эрх зүйн үндсийг тогтоох** гэж хэрэглэсэн байдаг бөгөөд Батлан хамгаалах тухай хуульд батлан хамгаалах тогтолцооны эрх зүйн үндсийг тогтоох гэсэн нэр томьёо хэрэглэсэн нь Үндсэн хуулийн нэр томъёотой бүрнээ нийцэж байна.

Харин аливаа зүйлийн эрх зүйн үндсийг тогтоох гэдэг нь Үндсэн хуулийн агуулгаараа өргөн утгатай байдаг бөгөөд эрх зүйн үндсийг зөвхөн хууль батлан гаргаснаар тогтоосон гэж үздэггүй. Иймд батлан хамгаалах тогтолцооны эрх зүйн үндсийг тогтоох асуудал нь батлах хамгаалах тогтолцооны субъектуудын бүрэн эрхийг зөвхөн хуулиар тогтоосон байдлаар бус, бусад олон арга хэмжээ, цогц бодлого, үйл ажиллагаатай нягт холбон үзэх шаардлагатай юм.

Батлан хамгаалах тухай хуульд батлан хамгаалах тогтолцоо нь цаг хугацаа тухайн нөхцөл байдлын улмаас өөрчлөгдөх тул УИХ-ын тухайн ямар нөхцөл байдалд байгаагаас өөрөөр хэлбэл, улс орон онц байдал, эсхүл дайн бүхий болон дайны байдалд байгаа тохиолдолд УИХ батлан хамгаалахтай холбоотой хууль батлан гаргах ажиллагаа нь ердийн хууль батлан гаргахтай адил байх юм бол тэр нь цаг хугацаа шаардах тул энэ байдал нь тухайн нөхцөл байдал тохиромжгүй, шуурхай арга хэмжээг авахад саад учирч болох юм. Иймд онц эсхүл дайн бүхий болон дайны байдал батлан хамгаалахтай холбоотой эрх зүйн үндсийг тогтоох тухайн нөхцөл байдалд тохиромжтой шуурхай арга хэмжээг авах шаардлага байдаг эсэхийг тодруулах нь зүйтэй гэж үзэж байна.

1.2. Дайны аюулыг сэрэмжлэх, бусад улс оронтой маргаантай асуудлыг улс төрийн аргаар шийдвэрлэх

Дайны аюулыг сэрэмжлэх, бусад улс оронтой маргаантай асуудлыг улс төрийн аргаар шийдвэрлэх тухай УИХ-ын бүрэн эрх нь Үндсэн хуульд заасан онцгой бүрэн эрх биш бөгөөд Батлан хамгаалах тухай хуулиар УИХ-д олгосон бүрэн эрх юм.

Дайны аюулыг сэрэмжлэх гэдэг ухагдахуун нь нэлээд өргөн хүрээтэй бөгөөд энэ нь нэг талаасаа тайван цагт бусад орон руу зэвсэгт халдлага, түрэмгийлэхгүй байх, өдөөн хатгалах, террорист ажиллагаа явуулахгүй байх бүхий л арга хэмжээг нийт нутаг дэвсгэрийн хүрээнд бат сахих, нөгөө талаас дайны үед учирч болох дайн бүхий нутаг дэвсгэрийн иргэдийг нүүлгэн аюулгүй байдалд шилжүүлж, зэвсэгт хүчнийг дайнд оруулах, орон нутгийн батлан хамгаалах эрх зүйн үндсийг бүрдүүлэх зэрэг олон асуудал хамаардаг. Иймд Батлан хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан УИХ-ын дайны аюулгүй байдлыг сэрэмжлэх шийдвэр гаргах бүрэн эрх нь тайван цагт, дайн бүхий болон дайны байдалд хэрхэн хэрэгжүүлэх нь арга зүй, агуулгыг нарийвчлан тооцон тодорхойлсон байх нь чухал асуудал болж байна. Өөрөөр хэлбэл, УИХ дайны аюулыг сэрэмжлэх талаар цогц бодлого хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд Батлан хамгаалах тухай хуульд дайны аюулыг сэрэмжлэх асуудалд юу юуг хамааруулах вэ гэдгийг тогтоох нь зүйтэй болов уу.

Бусад улс оронтой маргаантай асуудлыг улс төрийн аргаар шийдвэрлэх тухай Батлан хамгаалах тухай хуулийн зохицуулалт нь дайны аюулыг сэрэмжлэхийн үндсэн нэг хэлбэр юм.

Улс төрийн арга гэдэг нэр томъёог дахин судлах шаардлагатай байна. Учир нь бусад улс оронтой маргаантай асуудал нь олон улсын нийтийн эрх зүйн асуудал бөгөөд уг асуудлыг олон улсын нийтийн эрх зүйн хүлээн зөвшөөрөгдсөн зарчмын хүрээнд шийдвэрлэдэг. Улс хоорондын маргаантай асуудлыг дипломат замаар асуудлыг шийдвэрлэх гэсэн нэр томъёог мөн хэрэглэдэг ба Улс төрийн арга гэдэг нь илүү явцуу агуулгатай гэж үзэж байна. Улс төр гэдэг ойлголтыг олон улсын хувьд авч үзэхээс илүү нэг улсын дотоод ажлын зохион байгуулалт, хэрэгжилттэй холбох нь зүйтэй юм. Иймд

Батлан хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлд хэрэглэсэн улс төрийн арга гэсэн нэр томъёог өөрчлөн **олон улсын эрх зүйн зарчмын** дагуу гэх мэт нийтлэг нэр томъёог хэрэглэх нь зүйтэй болов уу.

1.3.Монгол Улсын Төрийн цэргийн бодлогын үндсийг тодорхойлох

УИХ нь Үндсэн хуулийн дагуу төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох онцгой бүрэн эрхтэй бөгөөд Батлан хамгаалах тухай хуульд УИХ-ын бүрэн эрхэд төрийн цэргийн бодлогын үндсийг тодорхойлохоор заасан нь батлан хамгаалах хууль тогтоомжийн зохицуулалт юм. Энэхүү зохицуулалт нь нэр томьёоны хувьд Үндсэн хуулийн нэр томьёотой бүрнээ нийцэж байна. Төрийн цэргийн бодлого бол төрийн дотоод бодлогын нэг хэсэг бөгөөд өөрийн онцлогийн дагуу гадаад бодлоготой нягт уялдаатай юм.

№	Үндсэн хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалт	Батлан хамгаалах тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг заалт /1993/
1.	**25 дугаар зүйл** 1.Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ: 2/ төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох;	**6 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх** 1.Монгол Улсын Их Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 3/ Монгол Улсын Төрийн цэргийн бодлогын үндсийг тодорхойлох;

Үндсэн хуульд нэгэнт УИХ-ын онцгой бүрэн эрхэд төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлохыг хамааруулсан байхад дахин Батлан хамгаалах хуулиар УИХ-ийн бүрэн эрхэд төрийн цэргийн бодлогыг хамааруулсан нь давхардсан зохицуулалт болсон байна. Учир нь төрийн цэргийн бодлого бол төрийн дотоод, гадаад бодлогын нэг хэсэг юм.

1.4.Цэргийн албан хаагчийн нийгмийн хамгаалал, эрх зүйн баталгааны үндсийг тодорхойлох

Нийгмийн хамгаалллын эрх зүй нь иргэд өндөр наслах, эмнэлгийн үйлчилгээ авах, өвдөх, тахир дутуу болох, ажилгүй болох зэрэг тохиолдолд нийгмийн даатгал болон нийгмийн халамжийн туслалцаа авах, түүнийг дуусгавар болгохтой холбогдон гарч буй харилцаа зохицуулдаг.

Цэргийн албан хаагчийн нийгмийн хамгаалал, эрх зүйн баталгааны үндсийг тогтоох нь УИХ-ын хуулиар олгосон бүрэн эрх бөгөөд УИХ тус бүрэн эрхийнхээ дагуу цэргийн албан хаагчийн онцгой нөхцөл байдлыг харгалзан 1994 онд Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг батлан гаргасан байна.

1994 онд Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль нь нийгмийн даатгал, нийгмийн халамжийг цэргийн албан хаагчийн албаны онцлог шинжид нийцэж байгаа эсэхийг тодруулан, өнөөгийн зах зээлийн

эдийн засгийн хөгжил, эдийн засгийн тогтворгүй байдалд цэргийн албан хаагчийн албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай нийгмийн хөнгөлөлт, үйлчилгээ, тэтгэмж олгох нөхцөл байдлыг сайжруулах нь зүйтэй.

УИХ-ын Цэргийн албан хаагчийн нийгмийн хамгаалал, эрх зүйн баталгааны үндсийг тогтоох бүрэн эрх нь тайван цагт хууль гаргаад зогсохгүй дайны болон онц байдалд оролцон нийгмийн хамгаалал шаардлагатай болсон цэргийн албан хаагчийн нийгмийн хамгааллын асуудлыг тодорхой цэргийн албан хаагчийн онцлогт тохируулах шаардлагатай байна. Энэ талын эрх зүйн зохицуулалт дутмаг болон хэрэгжилт нь дутуу байгаатай холбоотойгоор зарим асуудлыг зохицуулаагүй хийдэлтэй орхигдуулсан байна.

Цэргийн албан хаагч нэг талаас эрт тэтгэвэрт гарах явдал байдаг тул тэдгээрийг дахин ажлын байраар хангах, эсхүл цаг заваа өнгөрөөх, дахин ажил, мэргэжилд дадлагажуулах зэрэг цогц арга хэмжээг авах эрх зүй, эдийн засгийн нөхцөл хангалтгүй байгаагаас цэргийн албан хаагч тэтгэвэрт гарсаны дараа асуудал гардаг байна. Иймд эдгээр асуудлыг цогцоор нь нарийвчлан судалж холбогдох арга хэмжээг авах нь зүйтэй юм. Холбогдох арга хэмжээнд эрх зүйн орчинг нь бий болгох, нийгэм, эдийн засгийн баталгааг нь хангах, сайжруулах, сургалт, дадлага хийлгэх орчинг бүрдүүлэх зэрэг хамаарна.

1.5.Батлан хамгаалах хамтын ажиллагааны талаарх Монгол Улсын олон улсын гэрээг соёрхон батлах, цуцлах

Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 15-д Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын олон улсын гэрээг соёрхон батлах, цуцлах нь УИХ-ын онцгой бүрэн эрхийн асуудал юм. Батлан хамгаалах тухай хуульд Батлан хамгаалах хамтын ажиллагааны талаарх Монгол Улсын олон улсын гэрээ соёрхон батлах, цуцлахыг УИХ-ын бүрэн эрхэд хамааруулан зохицуулсан нь Үндсэн хуулиар онцгойлон зохицуулсан асуудлыг дахин хуулиар зохицуулсан буюу хуульд давхардуулан зохицуулсан зохицуулалт болсон байна. Учир нь Монгол Улсын олон улсын гэрээг соёрхон батлах, цуцлах бүрэн эрх нь Үндсэн хуулийн дагуу зөвхөн УИХ-д хадгалагдах бөгөөд түүнийг бусад хуульд салбарын шинжээр нь томьёолон оруулсан нь **хуульд техникийн шинжтэй давхардсан зохицуулалт** болсон байна.

№	Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалт	Батлан хамгаалах тухай хуулийн холбогдох зүйл, заалт /1993/
1.	25 дугаар зүйл 1.Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ: 15/ Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын олон улсын гэрээг соёрхон батлах, цуцлах, гадаад улстай дипломат харилцаа тогтоох, цуцлах;	6 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх 1.Монгол Улсын Их Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 5/ батлан хамгаалах хамтын ажиллагааны талаарх Монгол Улсын олон улсын гэрээг соёрхон батлах, цуцлах;

1.6.Улс орныг батлан хамгаалах арга хэмжээний төсвийг батлах, батлан хамгаалах хүч чадлыг бэхжүүлэх үндсэн чиглэлийг тодорхойлох

Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 25.1.7-д улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах нь УИХ-ын онцгой бүрэн эрх бөгөөд өнөөгийн байдлаар улсын төсөв түүний дотор батлан хамгаалахтай холбоотой төсвийг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн дагуу төсвийн /Ерөнхийлөн захирагч нь зохиогоод Сангийн яамд төвлөрүүлэн Сангийн яамнаас Засгийн газарт оруулан Засгийн газар УИХ-д өргөн барин хэлэлцэж баталдаг байна./ Улсын төсвийг батлах нь Үндсэн хуулиар олгогдсон УИХ-ын онцгой бүрэн эрх бөгөөд Батлан хамгаалах тухай хуульд тусгайлан батлан хамгаалахтай холбоотой улсын төсвийг батлах нь УИХ-ын бүрэн эрхэд хамааруулсан нь **давхардсан зохицуулалт** болсон гэж үзэж байна. Төсөвгүйгээр батлан хамгаалах асуудал байхгүй, жил бүр батлан хамгаалахтай холбоотой төсөв холбогдох сайдын багцаар батлагддаг.

№	Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалт	Батлан хамгаалах тухай хуулийн холбогдох зүйл, заалт /1993/
1.	<u>25 дугаар зүйл</u> 1.Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараахь асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ: 7/ төрийн санхүү, ..., улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах;	**6 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх** 1.Монгол Улсын Их Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 6/ улс орныг батлан хамгаалах арга хэмжээний төсвийг батлах, батлан хамгаалах хүч чадлыг бэхжүүлэх үндсэн чиглэлийг тодорхойлох;

Нөгөө талаас улс орны батлан хамгаалах арга хэмжээний төсөв гэдэг томьёо нь оновчгүй болсон гэж үзэж байна. Улс орны **батлан хамгаалах арга хэмжээ гэдэг нэр томъёогоор юуг илэрхийлж байгаа нь тодорхойгүй** бөгөөд **улс орны батлан хамгаалах арга хэмжээ нь батлан хамгаалах үйл ажиллагааг хэрхэн агуулж байгаа, аль нэр томъёо нь өргөн хүрээтэй гэдэг нь тодорхой бус байна**. Батлан хамгаалах арга хэмжээ гэдэг батлан хамгаалах үйл ажиллагаа, батлан хамгаалах нэгдмэл тогтолцоо зэрэгтэй хэрхэн уялдаж байгаа нь тодорхойгүй байна.

Батлан хамгаалах хүч чадлыг бэхжүүлэх үндсэн чиглэлийг тодорхойлох нь УИХ-ын бүрэн эрхэд хамааруулсан хуулийн зохицуулалт бөгөөд уг үндсэн чиглэлийг УИХ хэрхэн тодорхойлох нь тодорхойгүй байна. Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 25.1.7-т заасны дагуу төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлохыг УИХ-ын онцгой бүрэн эрхэд хамааруулсан ба УИХ жил бүр улсын мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлдог. Өнөөг хүртэл **УИХ батлан хамгаалах хуулиар олгосон Батлан хамгаалах хүч чадлыг бэхжүүлэх үндсэн чиглэлийг тодорхойлох бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй байна**.

1.7.Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлыг албаны онцлогт нь тохируулж тогтоох

Эрх зүйн байдал гэдэг нь товч утгаараа эрх зүйн хэм хэмжээгээр тогтоосон субьектын эрх ба үүргийн нийлбэр цогц бөгөөд цэргийн албан хаагчийн онцлогийг харгалзан түүний эрх зүйн байдлыг тогтоох нь УИХ-ын хувьд Батлан хамгаалах тухай хуулиар тогтоосон бүрэн эрх юм. УИХ 1992 оны 5 дугаар сарын 5-ны өдөр Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг батлан гаргасан байна. Гэвч цэргийн албан хаагч, цэргийн тэтгэвэр, тэтгэмж авах албан хаагч зэрэг өөр хоорондоо уялдаа холбоог хэр байгааг тодруулан, нэр томьёо нь УИХ-аас батлан гаргасан бусад хуулиудтай хэрхэн нийцэж байгаа нь тодорхой бус байна. Эдгээр өөр хоорондоо уялдаа холбоо багатай нэр томьёог нэг мөр болгох шаардлагатай байна. Энэ асуудал цэргийн тэтгэвэр, тэтгэмжийн хэсэгт дурдагдсан болно.

1.8.Цэргийн дээд цол бий болгох

Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 25.1.13-т УИХ-ын онцгой бүрэн эрхэд цэргийн дээд цол бий болгох гэж байхад дахин Батлан хамгаалах тухай хуульд УИХ-ын бүрэн эрхэд цэргийн дээд цол бий болгох гэж заасан нь Үндсэн хууль, **хууль хоорондын давхардлыг бий болгож байна**. Иймд Батлан хамгаалах тухай хуулийн цэргийн дээд цол бий болгох талаарх зохицуулалт нь **шаардлагагүй зохицуулалт** болсон байна гэж үзэж байна.

№	Үндсэн хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалт	Батлан хамгаалах тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалт /1993/
1.	**25 дугаар зүйл** 1.Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараахь асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ: 13/ улсын цол, одон, медаль, **цэргийн дээд цол бий болгох**, төрийн албаны зарим тусгай салбарын албан тушаалын зэрэг дэвийг тогтоох;	**6 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх** 1.Монгол Улсын Их Хурал дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 8/ **цэргийн дээд цол бий болгох**;

1.9.Гадаадын цэргийн хүчнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлуулах, дамжин өнгөрүүлэх болон өөрийн цэргийн анги, салбарыг олон улсын энхийг сахиулах болон хүмүүнлэгийн ажиллагаанд оролцуулах асуудлыг шийдвэрлэх

Гадаадын цэргийн хүчнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлуулах, дамжин өнгөрүүлэх болон өөрийн цэргийн анги, салбарыг олон улсын энхийг сахиулах болон хүмүүнлэгийн ажиллагаанд оролцуулах асуудлыг шийдвэрлэх нь Батлан хамгаалах тухай хуулиар УИХ-д бүрэн эрхэд хамааруулсан бөгөөд зарим улс уг асуудлыг Үндсэн хуулиар парламентын

бүрэн эрхийн хүрээнд хамааруулсан байдаг. Үнэхээр гадаадын цэргийн хүчнийг өөрийн улсын нутаг дэвсгэрт байрлуулах, дамжин өнгөрүүлэх нь тухайн орны батлан хамгаалах асуудалтай нягт холбоотой бөгөөд уг асуудлыг Үндсэн хууль, холбогдох хуулиараа тусгайлан зохицуулдаг. Учир нь гадаадын цэргийн хүчийг өөрийн улсын нутаг дэвсгэрт байрлуулах, дамжин өнгөрүүлэх нь бусад улс орны хувьд таагүй байдал үүсгэх ба энэ нь дайн бүхий байдалд хүргэх аюултай юм. Иймд уг асуудлыг шийдвэрлэх нь парламентын бүрэн эрхийн асуудал юм.

Харин гадаадын цэргийн хүчийг өөрийн улсын нутаг дэвсгэрт байрлуулах, дамжин өнгөрүүлэх болон өөрийн цэргийн анги, салбарыг олон улсын энхийг сахиулах болон хүмүүнлэгийн ажиллагаанд оролцуулах асуудлыг УИХ хуулиар, эсхүл тогтоолоор шийдвэрлэх үү гэдэг асуудал нь тодорхой бус байна. Гэвч өнөөгийн практик нь УИХ хуулиар гадаадын цэргийн хүчийг өөрийн улсын нутаг дэвсгэрт байрлуулах, дамжин өнгөрүүлэх өөрийн цэргийн анги, салбарыг олон улсын энхийг сахиулах болон хүмүүнлэгийн ажиллагаанд оролцуулах асуудлыг шийдвэрлэж байна. Гадаадын цэргийн хүчнийг байрлуулах, дамжин өнгөрүүлэх тухай хууль /1998/, Цэрэг, цагдаагийн албан хаагчийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай хууль /2002/ тус тус асуудлыг зохицуулж байна. Цагдаагийн албан хаагч ямар учраас Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах ажиллагаанд оролцож байгаа нь тодорхой бус бөгөөд цагдаа зөвхөн дотоодын хэргийн асуудал хамаарах байтал цэрэгтэй эн дүйцүүлэн авч үзсэн нь хууль тогтоомжийн уялдаа холбоог хэр байгааг харуулж байна гэж үзэж байна.

Батлан хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан "Монгол Улсын Их Хурал хуульд заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ" гэсэн зохицуулалт нь Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, ... журмыг хуулиар зохицуулна, Улсын Их Хурлын тухай /2006/ хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан Улсын Их Хурал нь Үндсэн хуулийн 25 дугаар зүйлд заасан онцгой болон хуулиар тогтоосон бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гэсэнтэй тус тус давхцаж байгаа тул Батлан хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн зохицуулалт нь шаардлагагүй, зохицуулалт болсон байна.

2. Дайны байдлын тухай хуулийн зохицуулалт

Дайны байдал зарлах, цуцлах үндэслэл, улс орныг дайны байдалд шилжүүлэх үед авах үндсэн арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх бэлтгэлийг тайван цагт хангах үеийн төр, захиргаа, цэргийн удирдлагын байгууллагуудын бүрэн эрхийг 1998 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн Дайны байдлын тухай хуулиар тогтоосон.

Дайны байдал зарлах нь УИХ-ын онцгой бүрэн эрх ба Дайны байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "УИХ-ын чуулганы чөлөөт цагт, хойшлуулшгүй тохиолдолд Монгол Улсын Ерөнхийлөгч дайны байдал зарлах тухай зарлиг гаргана. УИХ уг зарлигийг Монгол УИХ-ын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн дагуу хэлэлцэн 7 хоногийн дотор батлах, эсхүл хүчингүй

болгоно" гэж заасан. Хуулийн уг зүйл нь УИХ-ын тухай 1997 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн хуулийн 11 дүгээр зүйл буюу УИХ-ын онцгой чуулганы асуудлаар ишлэл хийсэн боловч өнөөг хүртэл УИХ-ын тухай хуулийг 2001 болон 2006 онд тус тус хоёр удаа шинэчлэн найруулж мөрдөж байна. Одоогоор 2006 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн УИХ-ын тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бөгөөд уг хуулийн 11 дүгээр зүйл нь УИХ-ын даргын бүрэн эрхийг зохицуулсан бөгөөд УИХ-ын онцгой чуулганы 17 дугаар зүйлээр зохицуулсан байна. Үүнээс үзэхэд Дайны байдлын тухай хууль нь **хүчингүй болсон хуулийн заалт руу ишлэл хийсэн** байгаа бөгөөд уг асуудлыг нэг мөр болгож Дайны байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн УИХ-ын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн ишлэлийг **нэн яаралтай өөрчлөх шаардлагатай** байна.

Дайны байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлд тайван болон дайн байдлын үед УИХ-ын бүрэн эрхэд дараах зүйлийг хамааруулан зохицуулсан байна. Үүнд:

Тайван цагт:

1.Дайны байдлын үед үйлчлэлийг зогсоох, хязгаарлах хууль тогтоомжийн нэр, заалтыг тодорхойлох;

2. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын хороо, Цэргийн дээд командлалын газрын бүтэц, зохион байгуулалт, бүрэн эрхийг тогтоох;

3.Монгол Улсын Засгийн газар, УИХ-аас байгуулсан болон түүнд ажлаа тайлагнадаг байгууллагын дайны байдлын үеийн бүтэц, зохион байгуулалт, түүнд шилжих журам, эрх зүйн үндсийг тодорхойлох;

4.Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр улс орныг дайны байдалд шилжүүлэх ерөнхий төлөвлөгөөг батлах.

Дайны байдлын үед:

1.төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг дайны байдлын нөхцөлд нийцүүлэн тодотгох;

2.дайны байдлын үед мөрдөх хууль тогтоомжийг батлах, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах;

3.дайны байдлын үед байгуулсан олон улсын гэрээг соёрхон батлах;

4.Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын хороо, Цэргийн дээд командлалын газрыг байгуулах, Засгийн газрыг дайны байдлын үеийн бүтэц, зохион байгуулалтад шилжүүлж, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

5.гадаад улс оронтой цэрэг-улс төрийн холбоотны харилцаа тогтоох, цэргийн эвсэл холбоонд элсэн орох эрх зүйн үндсийг тогтоох;

6.дайны байдлын үед бусад улс оронтой байгуулсан цэргийн хамтын ажиллагааны гэрээг батлах, гадаадын цэргийн хүчнийг өөрийн нутаг дэвсгэрт хууль тогтоомжийн дагуу байрлуулах, дамжин өнгөрүүлэх талаар хууль гаргах;

7.орон нутгийн цэргийг байгуулах шийдвэр гаргах;

8.Монгол УИХ, Монгол Улсын Ерөнхийлөгч, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн хугацааг дайны байдлыг цуцлах хүртэл хойшлуулах эсэх тухай шийдвэр гаргах.

Уг хуулийн зохицуулалтаас үзэхэд УИХ өнөөг хүртэл тайван цагт хэрэгжүүлэх ёстой зарим бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй байгаа эдгээр бүрэн эрхийг хэрэгжүүлэх асуудлыг нэн даруй зохицуулах шаардлагатай байна.

Нөгөө талаас УИХ-ын хууль тогтоох ажиллагаа дайны байдалтай холбогдуулан тухайн цаг үед нийцсэн шуурхай болгох асуудлыг өнөөгийн хууль тогтоомжид нарийвчлан зохицуулаагүй байна. Өөрөөр хэлбэл, УИХ-ын дайны байдлын үед мөрдөх хууль тогтоомжийг батлах, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах бүрэн эрхээ хэрэгжүүлэх тайван цагийнхтай адилхан зохицуулалттай байна. Иймд энэ асуудлыг өөрчлөн дайны байдлын нөхцөл байдалд тохирсон түргэн шуурхай хууль тогтоомжийг батлах, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах боломжийг бий болгох шаардлагатай эсэхийг тодруулан үзэх нь зүйтэй юм.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын хороо, Цэргийн дэзд командлалын газрын эрх зүйн статус нь тодорхой бус байна.

Дайны байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 12.1.11-т орон нутгийн цэрэг гэсэн нэр томъёог хэрэглэсэн байна. Орон нутгийн цэрэг гэдэгт хэн хамаарах нь тодорхой бус бөгөөд орон нутгийн цэрэг нь орон нутгийн хамгаалах тогтолцоотой хэрхэн уялдаатай байх асуудлын эрх зүйн орчин бүрдээгүй байна.

Харин Дайны байдлын тухай 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Дайны байдлын үеийн онцгой нөхцөл байдлаас шалтгаалан Монгол Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл зарим бүрэн эрхээ Монгол Улсын Ерөнхийлөгчид шилжүүлж болно" гэж заасан боловч ямар бүрэн эрхээ шилжүүлэх нь тодорхойгүй бөгөөд Үндсэн хуульд заасан онцгой бүрэн эрхээ шилжүүлж болох эсэх тэр дундаа хууль тогтоох эрх мэдлээ шилжүүлж болох эсэх нь тодорхой бус байна. Иймд УИХ-ын Ерөнхийлөгчид шилжүүлж болох бүрэн эрхийг нарийвчлан тогтоох хэрэгтэй юм.

Дайны байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Монгол Улсын Их Хурал хуульд заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ" гэсэн заалт нь Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, ... журмыг хуулиар зохицуулна, Улсын Их Хурлын тухай /2006/ хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан Улсын Их Хурал нь Үндсэн хуулийн 25 дугаар зүйлд заасан онцгой болон хуулиар тогтоосон бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гэсэн тус тус давхцаж байна.

Дайны байдлын тухай хуульд УИХ-ын бүрэн эрхийг тайван болон дайны байдлын цагт тус тусад нь авч үзсэн байгаа бөгөөд тайван цаг дахь УИХ-ын бүрэн эрхийг Батлан хамгаалах тухай хуульд оруулаад дайны байдлын үед зөвхөн Дайны байдлын тухай хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр зохицуулах нь зүтэй гэж үзэж байна.

3.Зэвсэгт хүчний эрх зүйн зохицуулалт

Зэвсэгт хүчний тухай хууль /2002/-ийн 1 дүгээр зүйлд Зэвсэгт хүчний удирдлага нь ерөнхий болон цэргийн мэргэжлийн удирдлагаас бүрдэнэ гэж заасан бөгөөд 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт нь Зэвсэгт хүчний ерөнхий удирдлагад нь УИХ, Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Засгийн газар, Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Үндсэн

хууль, энэ хууль, бусад хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд хэрэгжүүлэхээр заасан.

Мөн хуулийн 12 дугаар зүйлд Монгол УИХ Үндсэн хууль, Монгол УИХ-ын тухай хуульд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- зэвсэгт хүчний үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох;
- зэвсэгт хүчинд тайван цагт алба хаах цэргийн албан хаагчийн тооны дээд хязгаарыг Засгийн газрын саналыг үндэслэн тогтоох;
- онц байдлын үеийн зэвсэгт хүчний гүйцэтгэх үүргийг тодорхойлох;
- зэвсэгт хүчний анги, салбарыг энхийг сахиулах олон улсын хамтын ажиллагаанд оролцуулах шийдвэр гаргах;
- цэргийн тангарагийг батлах;
- хуульд заасан бусад бүрэн эрх гэж заасан байдаг.

3.1.Зэвсэгт хүчний үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох

Зэвсэгт хүчний үйл ажиллагаа гэдэгт яг юу хамаарах нь тодорхой бус байна. УИХ зэвсэгт хүчний үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож байна гээд зөвхөн хууль батлан гаргаад болох уу гэдэг асуудал гарч байна. Эргэлзээтэй асуудлыг бий болгохгүй байхын тул УИХ зэвсэгт хүчинтэй холбоотой ямар үйл ажиллагаанд эрх зүйн үндэс шаардлагатай байгааг тодруулан тогтоох нь чухал юм.

3.2.Зэвсэгт хүчинд тайван цагт алба хаах цэргийн албан хаагчийн тооны дээд хязгаарыг Засгийн газрын саналыг үндэслэн тогтоох

Уг бүрэн эрхийг Зэвсэгт хүчний тухай хуулиар УИХ-д олгосон бүрэн эрх бөгөөд бусад хууль тогтоомжтой давхцаагүй байна.

3.3.Онц байдлын үеийн зэвсэгт хүчний гүйцэтгэх үүргийг тодорхойлох

УИХ онцгой байдлын үед зэвсэгт хүчний гүйцэтгэх үүргийг тодорхойлох гэдэг нь нэлээд өргөн утга агуулгатай байна. Зэвсэгт хүчин гэдэг нэр томьёонд хэн хамаарч байгааг нарийвчлан тогтоох шаардлагатай бөгөөд уг асуудлыг холбогдох хэсэгт тодорхой авч үзсэн.

3.4.Зэвсэгт хүчний анги, салбарыг энхийг сахиулах олон улсын хамтын ажиллагаанд оролцуулах шийдвэр гаргах

Цэрэг, цагдаагийн албан хаагчийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай /2002 оны/ хуулиар асуудлыг тусгайлан зохицуулсан бөгөөд уг хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтад Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэрийг үндэслэн цэрэг, цагдаагийн багийг энхийг сахиулах ажиллагаанд оролцуулах, эгүүлэн татах шийдвэр гаргах нь Засгийн газрын бүрэн эрхэд хамааруулсан. Гэтэл Зэвсэгт хүчний тухай хуулиар УИХ зэвсэгт хүчний анги, салбарыг энхийг сахиулах олон улсын хамтын ажиллагаанд оролцуулах шийдвэр гаргах эрхтэй байна. Уг хоёр

хуулийн зохицуулалт хоорондоо зөрчилдөж байгаа бөгөөд цэрэг, зэвсэгт хүчний анги, салбар нь өөр хоорондоо холбоо хамааралгүй ойлголтууд болж байна. Нөгөө талаас цэрэг нь ямагт нэг анги, салбарт харьяалагддаг байх шаардлагатай байдаг. Иймд энэхүү зөрчлийг нэг мөр болгох шаардлагатай байна.

Дүгнэлт

Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлд Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийг тусгасан байдаг.

Эдгээрийг харьцуулан дараах дүгнэлтэд хүрч байна. Үүнд:

1.Батлан хамгаалах тухай хуулийн УИХ-ын бүрэн эрхийн зарим зохицуулалт нь Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлд заасан УИХ-ын онцгой бүрэн эрхийн зохицуулалттай давхцаж байна. Тухайлбал, Батлан хамгаалах тухай хуульд УИХ-ын бүрэн эрхэд Цэргийн дээд цол бий болгох талаарх зохицуулалт нь Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13 дахь заалтад заасан УИХ-ын онцгой бүрэн эрх болох цэргийн дээд цол бий болгохтой давхцаж байна.

2.Зарим нэг нэр томьёо нь тодорхой бус байна. Тухайлбал, Батлан хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлд хэрэглэсэн улс төрийн арга гэсэн нэр томъёог өөрчлөн олон улсын эрх зүйн зарчмын дагуу гэх мэт нийтлэг нэр томъёог хэрэглэх нь зүйтэй. Улс төрийн арга гэдэг нэр томьёог дахин судлах шаардлагатай байна. Учир нь бусад улс оронтой маргаантай асуудал нь олон улсын нийтийн эрх зүйн асуудал бөгөөд уг асуудлыг олон улсын нийтийн эрх зүйн хүлээн зөвшөөрөгдсөн зарчмын хүрээнд шийдвэрлэдэг. Улс хоорондын маргаантай асуудлыг дипломат замаар шийдвэрлэх гэсэн нэр томъёог мөн хэрэглэдэг ба Улс төрийн арга гэдэг нь илүү явцуу агуулгатай юм. Улс төр гэдэг нь олон улсын хувьд авч үзэхээсээ илүү нэг улсын дотоод ажлын зохион байгуулалт, хэрэгжилттэй холбоотой юм. УИХ дайны аюулыг сэрэмжлэх талаар цогц бодлого хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд Батлан хамгаалах тухай хуульд дайны аюулыг сэрэмжлэх асуудалд юуг хамааруулах вэ гэдгийг тогтоох нь зүйтэй болов уу.

3.УИХ Батлан хамгаалах болон Дайны байдлын тухай хуульд заасан зарим нэг бүрэн эрхээ өнөөг хүртэл хэрэгжүүлээгүй асуудал байгаа нь эргэд Батлан хамгаалахтай холбоотой эрх зүйн зохицуулалтад хийдэл үүсгэж байна. Тухайлбал, Батлан хамгаалах хүч чадлыг бэхжүүлэх үндсэн чиглэлийг тодорхойлох, дайны байдлын үед үйлчлэлийг зогсоох, хязгаарлах хууль тогтоомжийн нэр, заалтыг тодорхойлох, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын хороо, Цэргийн дээд командлалын газрын бүтэц, зохион байгуулалт, бүрэн эрхийг тогтоох зэрэг бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй байна гэж үзэж байна.

4.Дайны байдлын тухай 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Дайны байдлын үеийн онцгой нөхцөл байдлаас шалтгаалан Монгол Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл зарим бүрэн эрхээ Монгол Улсын Ерөнхийлөгчид шилжүүлж болно" гэж заасан боловч ямар бүрэн эрхээ шилжүүлэх нь тодорхойгүй бөгөөд Үндсэн хуульд заасан онцгой бүрэн эрхээ шилжүүлж

болох эсэх тэр дундаа хууль тогтоох эрх мэдлээ шилжүүлж болох эсэх нь тодорхой бус байна. Иймд УИХ-ын Ерөнхийлөгчид шилжүүлж болох бүрэн эрхийг нарийвчлан тогтоох шаардлагатай.

5.Дайны байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн Улсын Их Хурлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн ишлэлийг **нэн яаралтай өөрчлөх шаардлагатай** байна. Учир нь Дайны байдал зарлах нь Улсын Их Хурлын онцгой бүрэн эрх ба Дайны байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Улсын Их Хурлын чуулганы чөлөөт цагт, хойшлуулшгүй тохиолдолд Монгол Улсын Ерөнхийлөгч дайны байдал зарлах тухай зарлиг гаргана. Улсын Их Хурал уг зарлигийг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн дагуу хэлэлцэн 7 хоногийн дотор батлах, эсхүл хүчингүй болгоно" гэж заасан. Хуулийн уг зүйл нь Улсын Их Хурлын тухай 1997 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн хуулийн 11 дүгээр зүйл буюу УИХ-ын онцгой чуулганы асуудлаар ишлэл хийсэн боловч өнөөг хүртэл Улсын Их Хурлын тухай хууль 2001 болон 2006 онд тус тус хоёр удаа шинэчлэн найруулагдан мөрдөгдөж байна. Одоогоор 2006 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн Улсын Их Хурлын тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бөгөөд уг хуулийн 11 дүгээр зүйл нь УИХ-ын даргын бүрэн эрхийг зохицуулсан бөгөөд УИХ-ын онцгой чуулганыг 17 дугаар зүйлээр зохицуулсан байна. Үүнээс үзэхэд Дайны байдлын тухай хууль нь **хүчингүй болсон хуулийн заалт руу ишлэл хийсэн байна**

6.Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын хороо, Цэргийн дээд командлалын газрын эрх зүйн статусыг тодорхойлох шаардлагатай байна.

7.УИХ-ын хууль тогтоох, гаргах, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах зохицуулалт нь тайван, дайны болон онцгой байдалд ижил байна. Иймд Улсын Их Хурал онцгой болон дайн байдлын үед хууль тогтоох ажиллагааг тухайн нөхцөл байдалд тохируулан аль болох түргэн шуурхай хэлэлцэж батлах эрх зүйн зохицуулах шаардлагатай эсэхийг тодруулах нь зүйтэй болов уу гэж үзэж байна.

8.Дайны байдлын тухай хуульд холбогдох субъектуудын бүрэн эрхийг тайван болон дайны гэж ялгаж, зохицуулалт оруулсан нь тодорхой бус байна. Учир нь дайны байдлын тухай хууль нь илүү дайны байдал зарласан үед үйлчлэх бөгөөд тайван цагт Батлан хамгаалах тухай хууль үйлчлэх шаардлагатай гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, УИХ-ын бүрэн эрхийг Дайны байдлын тухай хууль тайван цагт, дайны байдлын үеийн гэж ялган зохицуулах нь хэр зүйтэй вэ гэдэг асуудлыг эргэн харах шаардлагатай байна.

9.Дайны байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 12.1.11-т орон нутгийн цэрэг гэсэн нэр томъёог хэрэглэсэн байна. Орон нутгийн цэрэг гэдэгт хэн хамаарах нь тодорхой бус бөгөөд орон нутгийн цэрэг нь орон нутгийн хамгаалах тогтолцоотой хэрхэн уялдаатай байх асуудлын эрх зүйн орчин бүрдээгүй байна.

10.Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлд Аюулгүй байдал, гадаад бодлогын Байнгын хороотой байхаар зохицуулсан бөгөөд тус хороо нь уг хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын **үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах, зэвсэгт хүчин,** гадаад

бодлого зэрэг асуудлыг эрхлэхээр зохицуулсан байна. Түүнчлэн Байнгын хороо нь УИХ-ын хянан шалгах бүрэн эрхийг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байдаг. Гэтэл өнөөгийн Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын Байнгын хорооны эрхлэх асуудлыг ерөнхий томъёоллоор оруулсан боловч Батлан хамгаалахтай холбоотой цэргийн гүйцэтгэх үүрэг даалгавар, зохион байгуулалт, албан хаагчид, цэргийн үйл ажиллагаа, санхүүжилт, цэрэг татлага, дайчилгаа, зэрэг **нарийвчилсан асуудлыг тодорхой зааж** хариуцуулбал уг хорооны үйл ажиллагаа **илүү үр нөлөөтэй** байх болов уу. Уг хороо хянан шалгах бүрэн эрхийнхээ хүрээнд цэргийн томоохон албан тушаалтнуудын томилгоог авч хэлэлцэж, нотолгоожуулах боломжтой юм. Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын Байнгын хороо 1996-2009 /Хаврын чуулганы байдлаар/ хугацаанд нийт 28 хянан шалгах ажлын хэсэг байгуулан ажилласнаас 6 ажлын хэсэг ажилласан эсэх нь тодорхойгүй байна. Үүнээс үзэхэд 22 ажлын хэсэг хянан шалгах ажиллагаа хийсэн байна. Энэ нь УИХ-ын холбогдох байнгын хороо хангалттай ажиллаж байна гэж хэлэхэд хэцүү байдлыг бий болгож байна.

11.Цэрэг, цагдаагийн албан хаагчийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай болон Зэвсэгт хүчний тухай хууль хоорондын Засгийн газрын бүрэн эрх. УИХ-ын бүрэн эрхийн талаарх зөрчилтэй заалтыг нэг мөр болгож, нэр томъёоны зөрүүтэй байдлыг арилгах шаардлагатай байна.

Б.БАТЛАН ХАМГААЛАХ ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БҮРЭН ЭРХ

Монгол Улсын Засгийн газрын батлан хамгаалах талаарх бүрэн эрхийг Батлан хамгаалах тухай хууль, Засгийн газрын тухай хууль, Дайны байдлын тухай хууль зэрэг эрх зүйн актуудаар зохицуулсан байна.

1.Батлан хамгаалах тухай хуулийн зохицуулалт

Батлан хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлд Монгол Улсын Засгийн газар нь Засгийн газрын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан бүрэн эрхээс гадна дараах тодорхой бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гэж заасан байна. Үүнд:

1/ улс орныг батлан хамгаалах болон орон нутгийн хамгаалалтын асуудлаар төрийн захиргааны байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх;

2/ батлан хамгаалах арга хэмжээний төсвийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

3/ цэргийн анги, байгууллагыг байгуулах, татан буулгах асуудлыг Зэвсэгт хүчний ерөнхий командлагчтай зөвшилцөн шийдвэрлэх, цэргийн анги, байгууллагын байршлыг тогтоох, батлан хамгаалах хэрэгцээний эзэмшил газрын зөвшөөрөл олгох;

4/ төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн дайчилгааны даалгаврыг батлах;

5/ улсын болон зэвсэгт хүчний дайчилгааны материаллаг нөөцийн хэмжээг тогтоож, түүнийг бүрдүүлэх, зарцуулах арга хэмжээг зохион байгуулах;

6/ тайван цагт улсын дайчилгааны бэлтгэлийг хангах, шаардлагатай үед Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн шийдвэрийн дагуу улс орныг дайны байдалд шилжүүлэх;

7/ иргэдийг эх оронч үзлээр хүмүүжүүлэхэд төрийн бүх шатны болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааг нэгтгэн чиглүүлэх, цэрэг иргэний харилцааг төлөвшүүлэх;

8/ иргэдээс цэргийн үүргээ биелүүлэх хүсэл сонирхол, эрмэлзлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх.

Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлд Улсын төсвийн төслийг Улсын Их Хурлаас батлагдсан төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх нь Засгийн газрын бүрэн эрхэд хамаарах бөгөөд Батлан хамгаалах тухай хуульд батлан хамгаалах арга хэмжээний төсвийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх асуудлыг дахин салбарын хүрээнд тусгайлан зохицуулсан хууль хоорондын давхардлыг бий болгосон байна. Үнэхээр улсын төсвийн төсөлд батлан хамгаалах арга хэмжээний төсвийн төсөл хамаарч байгаа бөгөөд нөгөө талаас батлан хамгаалах арга хэмжээний төсвийн төслийг Батлан хамгаалах хууль Засгийн газар Улсын Их Хуралд өргөн барихаар зохицуулсан нь Батлан хамгаалах арга хэмжээний төсвийн төслийг Засгийн газар тусгайлан ганцаарчлан өргөн барихаар ойлгогдох боломжтой юм. Иймд Батлан хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн батлан хамгаалах арга хэмжээний төсвийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэх гэсэн зохицуулалт нь Засгийн газрын хуулийн 8 дугаар зүйлийн зохицуулалттай давхцаж байгаа тул уг давхардлыг нэг болгох шаардлагатай байна.

2.Засгийн газрын тухай хуулийн зохицуулалт

Засгийн газрын тухай хуулийн 13 дугаар зүйлд Улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангах талаарх Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

1.Улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангах болон цэргийн бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

2.Зэвсэгт хүчнийг бэхжүүлэх арга хэмжээ авна.

3.Улсын хилийг хамгаалах ажлыг чиглүүлэн удирдана.

4.Үндэсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлнэ.

5.Улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангахад зайлшгүй шаардагдах материаллаг нөөцийн санг бүрдүүлэх, нөхөн сэлбэх арга хэмжээ авна.

6.Төрийн нууцыг хамгаалах ажлыг чиглүүлэн удирдана.

7. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээ авч, онцгой ажиллагааг удирдан чиглүүлнэ.

Засгийн газрын тухай хуульд Зэвсэгт хүчнийг бэхжүүлэх арга хэмжээ авах гэдэг нэр томъёо нь нэлээд өргөн утга, агуулгатай бөгөөд Зэвсэгт хүчний

тухай хуулийн зэвсэгт хүчнийг зайлшгүй шаардлагатай бүтээгдэхүүнээр хангах арга хэмжээ авах гэсэн нэр томъёо зэрэг нь уул өргөн агуулгатай нэр томъёог задалсан байна гэж үзэж байна.

3.Зэвсэгт хүчний тухай хуулийн зохицуулалт

Зэвсэгт хүчний тухай хуулийн 14 дүгээр зүйлд Монгол Улсын Засгийн газар Үндсэн хууль, Засгийн газрын тухай хуульд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1.зэвсэгт хүчинд тайван цагт алба хаах цэргийн албан хаагчийн тооны дээд хязгаарыг тогтоох саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2.жил бүр цэргийн жинхэнэ албанд татах, дайчилгааны сургууль, цугларалтад оролцуулах хүний тоо, цэрэг татлага явуулах хугацааг зэвсэгт хүчний ерөнхий командлагчтай зөвшилцөн тогтоох;

3.цэрэг, цэрэг-техникийн хамтын ажиллагааны асуудлаар бүрэн эрхийнхээ хүрээнд бусад улсын Засгийн газартай гэрээ байгуулах;

4.зэвсэгт хүчнийг зайлшгүй шаардлагатай бүтээгдэхүүнээр хангах арга хэмжээ авах;

5.гадаад улсаас авах цэргийн зэвсэг, байлдааны техникийн төрөл, тоог тогтоох, Улсын Их Хурлын зөвшөөрснөөр санхүүжүүлэх;

6.хуульд заасан бусад бүрэн эрх.

4.Дайны байдлын тухай хуулийн зохицуулалт

Дайны байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлд дайны байдалтай холбогдуулан Монгол Улсын Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

Тайван цагт:

1.улс орныг дайны байдалд шилжүүлэх ерөнхий төлөвлөгөөний төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах ажлыг зохион байгуулах;

2.эдийн засгийн удирдлага, төлөвлөлт, хөгжлийн стратегийн зорилт, үйлдвэрлэл, шинжлэх ухаан, технологийн бодлогыг эх орноо батлан хамгаалах хэрэгцээ, шаардлагатай зохистойгоор уялдуулах;

3.төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагын дайны байдлын үеийн бүтэц, зохион байгуулалт, түүнд шилжих журам тогтоох;

4.улсын дайчилгааны материаллаг нөөцийн хэмжээ, байршилыг тогтоож, түүнийг шинэчлэх, нөхөн сэлбэх ажлыг зохион байгуулах;

5.улсын болон зэвсэгт хүчний хэрэгцээт бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг байгууллага, аж ахуйн нэгжийг дайны байдалд шилжүүлэх журам тогтоох:

6.нутаг дэвсгэрийн төхөөрөмжлөл, цэргийн дэд бүтцийг бэхжүүлэх арга хэмжээ авах;

7.стратегийн ач холбогдол бүхий зам, гүүр, төмөр замын зангилгаа, нисэх онгоцны буудал, холбооны сүлжээг дайны байдлын үед ашиглахад бэлтгэх арга хэмжээг улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлэх;

8.дайны байдлын үед үйлчлэлийг зогсоох, хязгаарлах Засгийн газрын тогтоол, шийдвэрийн нэр, заалтыг тодорхойлох.

Дайны байдлын үед:

9.улс орныг дайны байдалд шилжүүлэх ажиллагааг удирдан зохион байгуулах;

10.төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагыг дайны байдалд шилжүүлэх;

11.улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт тодотгол хийх тухай саналыг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх;

12.өмчийн хэлбэр харгалзахгүйгээр байгууллага, аж ахуйн нэгжид бүтээгдэхүүн үйлдвэрлэх, нийлүүлэх улсын захиалга-даалгавар өгч, биелэлтийг хангуулах;

13.улсын болон зэвсэгт хүчний хэрэгцээт бүтээгдэхүүн үйлдвэрлэх байгууллага, аж ахуйн нэгжийг техник хэрэгсэл, түүхий эд, ажиллах хүчээр эхний ээлжинд хангах арга хэмжээ авах;

14.улс орны эдийн засаг, нийгмийн үндсэн салбар болон дэд бүтцийн тогтвортой ажиллагааг хангах;

15.дайны байдлын үед байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө, хүнс, тэжээлийн нөөцийг дайчлах журам тогтоох;

16.хүн амын амьжиргааны зайлшгүй хэрэгцээт зүйлийг хуваарилах онцгой журам тогтоох;

17.улсын болон цэргийн дайчилгааны материаллаг нөөцийг захиран зарцуулах;

18.дайны байдлын үеийн нийгмийн дэг журмыг чанд сахиулах;

19.байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн эзэмшилд байгаа галт болон хүйтэн зэвсэг, галт хэрэглэл, тэсэрч дэлбэрэх, шатаах, хүчтэй үйлчлэх химийн хорт болон цацраг идэвхт бодис, сургалтын зориулалттай зэвсэг, байлдааны техник, хэрэгслийн ашиглалт, хадгалалттай холбогдсон асуудлыг шийдвэрлэх;

20.аж төрөхөд нэн аюултай байлдааны ажиллагааны талбар, хөнөөлийн голомт бүхий нутаг дэвсгэрээс хүн ам, мал, эд хөрөнгийг нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах;

21.Нэгдсэн Үндэстний Байгууллага болон олон улсын бусад байгууллага, дэмжигч улс орнуудын бүх талын тусламж дэмжлэг авах, хууль тогтоомжийн дагуу гадаадын цэргийн хүчнийг нутаг дэвсгэртээ байрлуулах ажлыг зохион байгуулах.

Дүгнэлт:

1.Батлан хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4-т төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн дайчилгааны даалгаврыг **батлах** гэж заасан. Гэтэл 1998 оны Дайчилгааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2-т төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн дайчилгааны даалгаврыг **тогтоох** гэж заасан байна. Энэхүү хоёр хуулийн зохицуулалт нь өөр хоорондоо уялдаа холбоогүй байна. Учир нь Засгийн газар дайчилгааны даалгаврыг батлах болон тогтоохын алийг нь хэрэгжүүлэх нь тодорхойгүй бөгөөд хууль хоорондын зөрүүтэй байдлыг бий болгож байна.

Батлах гэдэг нь бат бэх болгох, үнэн болохыг зөвшөөрөх, нотлох гэсэн утгатай бол **тогтоох** гэдэг нь аливаа юмыг үүсгэх, бий болгох, тогтоол гаргаж батлах, алдахгүй байх, цээжлүүлэх зэрэг утгатай.

2. Батлан хамгаалах хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5-т **улсын болон зэвсэгт хүчний дайчилгааны материаллаг нөөцийн хэмжээг тогтоож**, түүнийг бүрдүүлэх, зарцуулах арга хэмжээг зохион байгуулах гэж заасан байхад Засгийн газрын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-т **Улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангахад зайлшгүй шаардагдах материаллаг нөөцийн санг бүрдүүлэх, нөхөн сэлбэх арга хэмжээ авна** гэж заасан нь уг хоёр хуулийн зохицуулалтын **агуулга нь нэг болов нэр томъёо болон илэрхийллийн хувьд өөр хоорондоо зөрүүтэй** болсон байна. Иймд асуудлыг нэг мөр болгох шаардлагатай байна

3.Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлд Улсын төсвийн төслийг Улсын Их Хурлаас **баталсан төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн боловсруулж**, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх нь Засгийн газрын бүрэн эрхэд хамаарах бөгөөд Батлан хамгаалах тухай хуульд **батлан хамгаалах арга хэмжээний төсвийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх** асуудлыг дахин салбарын хүрээнд тусгайлан зохицуулсан хууль хоорондын давхардлыг бий болгосон байна.

4.Батлан хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5-т **улсын болон зэвсэгт хүчний дайчилгааны материаллаг нөөцийн хэмжээг тогтоож, түүнийг бүрдүүлэх, зарцуулах арга хэмжээг зохион байгуулах** гэж заасан бол тус зүйлийн 8.1.6-т **тайван цагт улсын дайчилгааны бэлтгэлийг хангах** гэж заасан байна. Эдгээр заалт нь өөр хоорондоо утгын **давхардалтай байна** гэж үзэж байна. Учир нь **улсын дайчилгааны материаллаг нөөцийн хэмжээг тогтоох гэдэг нь улсын дайчилгааны бэлтгэлийг хангахад агуулагдаж байгаа** болно. Иймд хуулийн уг хоёр зохицуулалтыг нэг мөр болгох шаардлагатай байна.

5. Дайны байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлд Засгийн газрын бүрэн эрхийг мөн тайван цагт болон дайны байдлын үед гэж ангилсныг дахин авч үзэх шаардлагатай гэж үзэж байна. Учир нь Засгийн газрын батлан хамгаалах бүрэн эрхийг Батлан хамгаалах тухай хууль, Дайны байдлын тухай хууль, Засгийн газрын тухай **хууль зэрэгт хуваан өөр хоорондоо утга нэгтэй ч томъёолол, илэрхийлэл нь ялгаатай зохицуулах нь хэр үр дүнтэй вэ** гэдэг асуудлыг бий болгож байна.

В. БАТЛАН ХАМГААЛАХ ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ

Монгол Улсын төрийн захиргааны төв байгууллага буюу Батлан хамгаалах яамны батлан хамгаалах талаарх бүрэн эрхийг Батлан хамгаалах тухай хууль, Засгийн газрын тухай, Яамдын эрх зүйн байдлын тухай, Зэвсэгт хүчний тухай хууль, Дайны байдлын тухай хууль зэрэг тогтоомжоор зохицуулсан байна

1.Батлан хамгаалах тухай хуулийн зохицуулалт

Батлан хамгаалах тухай хуулийн 9 дүгээр зүйлд Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/батлан хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

2/батлан хамгаалах тогтолцоог боловсронгуй болгох саналыг Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд оруулах, зэвсэгт хүчний ерөнхий командлагчид өргөн мэдүүлэх;

3/цэргийн нийтлэг дүрмүүдийг батлуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн барих;

4/шинжлэх ухаан, технологийн дэвшлийг хангах, зэвсэгт хүчнийг зэвсэг, техникээр нөхөн хангах, шинэчлэн сайжруулах бодлого боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, эдгээртэй холбогдсон төсвийг захиран зарцуулах;

5/батлан хамгаалах асуудлаар бусад улстай хамтран ажиллах талаар Засгийн газраас олгосон эрхийн хүрээнд хэлэлцээр байгуулах;

6/батлан хамгаалах арга хэмжээний төсвийн төслийг Засгийн газарт оруулах, батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавих;

7/батлан хамгаалах улсын байцаагчийг томилох, чөлөөлөх;

8/батлан хамгаалах хууль тогтоомж, батлан хамгаалах асуудлаарх Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын болон өөрийн шийдвэрийн биелэлтийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгжид шалган танилцаж, биелэлтийг хангах талаар үүрэг даалгавар өгч гүйцэтгүүлэх;

9/батлан хамгаалах салбарын төрийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах, устгах, шилжүүлэх, шинээр авах асуудлыг шийдвэрлэх, захиалгыг хянаж батлах;

10/батлан хамгаалах салбарын төрийн өмчит хуулийн этгээд, эд хөрөнгийг хувьчлах саналаа Засгийн газарт оруулах талаар үүрэг даалгавар өгч гүйцэтгүүлэхээр тус тус заасан бөгөөд мөн зүйлийн 3 дахь заалтад Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн - улс төрийн албан тушаалтан нь цэргийн жинхэнэ албанаас ангид байна гэж заасан байна.

Батлан хамгаалах тухай хуулиар зохицуулсан Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, зарим хуульд Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалах сайд зэрэг өөр өөр нэр томьёо хэрэглэсэн байна.

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлд яамдын сайд нарын нийтлэг бүрэн эрхийг зохицуулсан бөгөөд уг бүрэн эрхийн зарим зохицуулалт нь Батлан хамгаалах тухай хуулиар зохицуулсан батлан хамгаалах сайдын бүрэн эрхтэй давхцаж байна. Тухайлбал, Яамдын эрх зүйн байдлын тухай хуульд хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах гэж заасан байхад Батлан хамгаалах тухай хуульд батлан хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, батлан хамгаалах хууль тогтоомж, батлан хамгаалах асуудлаарх Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын болон өөрийн шийдвэрийн биелэлтийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгжид шалган танилцаж, биелэлтийг хангах талаар үүрэг даалгавар өгч гүйцэтгүүлэх гэсэн утга нэгтэй боловч илүү өргөтгөн өөрөөр зохицуулсан ч давхцаж байна гэж үзэж байна.

Батлан хамгаалах салбар нь өөрийн санхүүг бүрдүүлэх чадвар сул тул санхүүжилтээ улсын төсвөөс авдаг. Улсын төсөв нь иргэдийн татвараас ихэнх нь бүрддэг тул олон улсын чиг хандлага уг салбарт иргэдийн хяналтыг бий болгох, нөгөө талаар иргэнийг улс орноо батлан хамгаалах үйл хэрэгт идэвхтэй оролцуулах бололцоог бүрдүүлж, аливаа асуудлыг урдчилан тооцсон байх боломжийг олгодог тул батлан хамгаалах салбарын иргэний хяналтыг сайжруулах, боловсронгуй болгох шаардлагатай байна. Энэхүү шаардлагыг хэрэгжүүлэх үндсэн ажил нь Батлан хамгаалах сайдын эрхлэх асуудалд хамаарах юм. Гэвч энэ талаарх зохицуулалт хангалтгүй байна. Уг асуудлаар бусад орны туршлагыг судалж өөрийн хууль тогтоомжид оруулах нь чухал гэж үзэж байна.

Нөгөө талаас Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албанд **ил тод** байх зарчмыг баримтална гэсний дагуу тусгай хуульд өөрөөр заагүй тохиолдолд батлан хамгаалах салбарт ч уг зарчим баримтлагдаж хэрэгжих ёстой. Иймд ил тод байх зарчмыг хэрэгжүүлэх арга, ямар асуудлаар хэрхэн хэрэгжүүлэхийг тогтоох шаардлагатай.

2.Засгийн газрын тухай хуулийн зохицуулалт

Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт "Засгийн газрын гишүүн дор дурдсан хүрээний бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалтын болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг эрхэлнэ": 8 дахь заалтад:

8/ Монгол Улсын Батлан хамгаалахын сайд:

- улсыг батлан хамгаалах болон цэргийн бодлого;
- зэвсэгт хүчнийг чадваржуулах бодлого;
- энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцох бэлтгэл хангуулах асуудал.

3.Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн зохицуулалт

Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлд яам нь сайдын эрхлэх асуудлын хүрээнд дараах нийтлэг ажил эрхэлнэ:

1.хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах;

2.хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын болон сайдын шийдвэрийн төсөл боловсруулах;

3.салбарын хэтийн болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө, үндсэн чиглэл, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төслийг боловсруулах, төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг хангуулах, хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, чиглэлийг тодорхойлж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

4.төсвийн ерөнхийлөн захирагчаас яам, агентлаг, Засгийн газраас байгуулсан бусад байгууллага, холбогдох аймаг, нийслэлийн Засаг даргатай үр дүнгийн гэрээ байгуулах, гэрээний биелэлтийн явц, үр дүнд хяналт тавих, дүгнэх;

5.хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын болон сайдын шийдвэрийг сурталчлах, хуулийг хэрэглэж байгаа практикийг судалж нэгтгэн, боловсронгуй болгох санал боловсруулж холбогдох байгууллагад оруулах;

6.аймаг, нийслэлийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын бүтцийн нэгж, Засаг даргын дэргэдэх холбогдох байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

7.Засгийн газрын агентлаг, Засгийн газраас байгуулсан бусад байгууллагын хоорондын болон эдгээр байгууллага, аймаг, нийслэлийн захиргааны холбогдох байгууллагын харилцан ажиллагааг уялдуулан зохицуулах;

8.төрийн албан хаагчдын хэрэгцээг тодорхойлох, тэднийг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, дахин мэргэшүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг нь хангахтай холбогдсон бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

9.хүний эрхийг хангах эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх арга хэмжээ авах;

10.Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэх, тэдгээрт хууль тогтоомжийг нийцүүлж, биелэлтийг хангуулах;

11.салбарын мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах ад шаардагдах тооцоо, судалгаа, мэдээ материалыг бусад яам, агентлаг, Засгийн газраас байгуулсан бусад байгууллага, аж ахуйн нэгжээс гаргуулж авах;

12.тухайн салбарын ажиллагсдыг урамшуулах, төрийн дээд шагналаар шагнуулах, цол олгуулах саналыг хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас тогтоосон журмын дагуу холбогдох байгуулагад өргөн мэдүүлэх;

13.хууль тогтоомжид заасан бусад нийтлэг эрхлэх асуудал.

Яамны эрх зүйн байдлын тухай хууль нь 2004 онд батлагдсан байх бөгөөд батлан хамгаалах сайдын бүрэн эрхийг зохицуулсан хууль нь уг Яамны эрх зүйн байдлын тухай хуулиас өмнө нь батлагдан гарсан. Гэвч Яамны эрх зүйн байдлын тухай хуульд яамны сайдын бүрэн эрхийг ерөнхийлөн томъёолсон бөгөөд батлан хамгаалахтай холбоотой бусад хууль тогтоомжид батлан хамгаалах сайдын бүрэн эрхийг тусгайлан зохицуулсан байдаг. Нэгэнт ерөнхийлөн зохицуулсан байхад тусгай хуульд уг асуудлыг зөвхөн салбарыг нь тодотгон зохицуулах нь шаардлагагүй зохицуулалт болсон гэж үзэж байна.

4.Дайны байдлын тухай хуулийн зохицуулалт

Дайны байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлд Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дайны үед Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын хорооны ажлын аппарат байж, батлан хамгаалах бодлогыг хэрэгжүүлэн аймаг, нийслэлийн батлан хамгаалах газар, сум, дүүргийн батлан хамгаалах товчоог захиргааны удирдлагаар хангаж, дайны байдалтай холбогдуулан дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

Тайван цагт:

1. улс орныг дайны байдалд шилжүүлэх ерөнхий төлөвлөгөөний төсөл боловсруулж Засгийн газарт оруулах;

2. зэвсэгт хүчнийг бодлогын удирдамжаар хангаж, үйл ажиллагааг нь зохицуулах;

3. улс орныг дайны байдалд шилжүүлэх бэлтгэлийг тайван цагт хангах талаар төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагын хүлээх үүргийн хэрэгжилтэд хяналт тавих;

4. цэргийн дайчилгааны материаллаг нөөцийн хэмжээ, байршлыг тогтоож, түүнийг бүрдүүлэх, шинэчлэх, нөхөн сэлбэх ажлыг зохион байгуулах;

5. байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс дайчлан зэвсэгт хүчний хэрэгцээнд ашиглах техник, материал хэрэгслийн төрөл, тоог тогтоох;

6. орон нутгийн цэргийг зэвсэг, байлдааны техник, галт хэрэглэлээр хангах бэлтгэлийг зохион байгуулах.

Дайны байдлын үед:

7.Монгол Улсын Их Хурал, Үндэсний аюулгүй байдлын хороо, Засгийн газраас батлан хамгаалах талаар гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавих;

8.зэвсэгт хүчнийг хэсэгчилсэн буюу бүх нийтийн дайчилгаагаар өргөтгөн зохион байгуулах, саналыг боловсруулж Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

9.зэвсэгт хүчнийг зэвсэг, цэргийн техник бусад материал хэрэгслээр хангах;

10.орон нутгийн цэргийг зэвсэг, байлдааны техник, галт хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулах;

11.сайн дурын зэвсэглэсэн бүлгийн үйл ажиллагаа, бүх төрлийн хангалтад тусламцаа дэмжлэг үзүүлэх;

12.зэвсэгт хүчний байлдааны хохирлыг нөхөн хангахад шаардлагатай бие бүрэлдэхүүн, зэвсэг, техник, бусад материал хэрэгслийн нэмэгдэл даалгаврыг боловсруулах.

5.Зэвсэгт хүчний тухай хуулийн зохицуулалт

Зэвсэгт хүчний тухай хуулийн 15 дугаар зүйлд Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Батлан хамгаалах тухай хуульд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1.зэвсэгт хүчний байгуулалтын нийгэм, эдийн засаг, эрх зүйн үндсийг хангах бодлого боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах;

2.зэвсэгт хүчнийг бэхжүүлэх саналыг Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд оруулах, зэвсэгт хүчний ерөнхий командлагчид өргөн мэдүүлэх;

3.ерөнхий зориулалтын цэргийн зэвсэг, техник, материал хэрэгслээр нөхөн хангах ажлыг зохион байгуулах;

4.ерөнхий зориулалтын цэргийн зэвсэг, техникийг шинэчлэн сайжруулах саналыг Засгийн газарт өргөн мэдүүлж, шийдвэрлүүлэх;

5.ерөнхий зориулалтын цэргийн батлагдсан төсвийн ангилал хооронд зохицуулалт хийх;

6.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх;

7.Үйл олноор хөнөөх зэвсэг болон хөнөөх хэрэгслийн хөнөөлөөс хамгаалах талаар баримтлах бодлогын үндсийг тодорхойлох, үйл ажиллагааг нь улсын хэмжээнд удирдан чиглүүлэх.

Дүгнэлт

1.Батлан хамгаалах төрийн захиргааны төв байгууллага болон сайдын бүрэн эрхийг олон хуульд тусгайлан зохицуулсан нь өөр хоорондоо уялдаа холбоо муутай байна. Иймд асуудлыг ерөнхий зохицуулалттайгаас нь тусгай зохицуулалттай хууль руу уялдаа холбоотой тусгах шаардлагатай юм.

2.Батлан хамгаалах төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх нь Яамдын эрх зүйн байдлын хуулиас гадна яг юу байх ёстойг нарийвчлан гаргаж, холбогдох хуульд нь зохицуулалт хийх нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, батлан хамгаалах асуудал эрхэлсэн сайд юуны өмнө аливаа цаг үе, байдалд цэрэг татлагад авах ажиллагааг, цэргийн үйлдвэрлэл, эрүүл мэнд, зэвсэг, холбогдох техник хэрэгслийг хангах, салбарын санхүү болон өмчийн тооцоо, барилга байгууламж зэрэг асуудлаар нэн тэргүүнд ажиллагаа явуулах шаардлагатайг анхаарч үзэх хэрэгтэй юм.

3.Дээрх хуулиудын зарим зохицуулалт нь өөр хоорондоо давхцаж байгаа нь илт байгаа тул эдгээрийг нэг мөр болгох нь зүйтэй.

4.Зарим зохицуулалт нь зөвхөн Батлан хамгаалах сайдын эрхлэх асуудлын хүрээнд байгаа эсэхийг тодруулах нь зүйтэй болов уу. Тухайлбал, үй олноор хөнөөх зэвсэг болон хөнөөх хэрэгслийн хөнөөлөөс хамгаалах талаар баримтлах бодлогын үндсийг тодорхойлох, үйл ажиллагааг нь улсын хэмжээнд удирдан чиглүүлэх чиг үүрэг зөвхөн Батлан хамгаалах сайдад хамаарах асуудал биш байх гэж үзэж байна.

5.Нөгөө талаас Батлан хамгаалахын сайд батлан хамгаалах салбарыг иргэдэд нээлттэй байлгах, иргэдийн оролцоог нэмэгдүүлсэн, иргэний хяналтыг бэхжүүлсэн байх талаар шаардлагатай арга хэмжээг авдаг байх талаар хуульчлаагүй байна.

Г. БАТЛАН ХАМГААЛАХ ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БҮРЭН ЭРХ

Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлд Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг тусгайлан заасан. Эдгээр бүрэн эрх дотор батлан хамгаалах салбартай холбоотой хэд хэдэн асуудлыг тусгажээ. Үүнд:

- Улсын цол, цэргийн дээд цол хүртээх, одон, медалиар шагнах;
- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлэх;
- Бүх нийтийн буюу хэсэгчилсэн цэргийн дайчилгаа зарлах;
- Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болбол Улсын Их Хурлын чуулганы чөлөө цагт, хойшлуулшгүй тохиолдолд улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь онц болон дайны байдал зарлах, түүнчлэн цэрэг хөдөлгөх захирамж өгөх. Онц байдал, дайны байдал зарласан Ерөнхийлөгчийн зарлигийг Улсын Их Хурал уул

зарлиг гарснаас хойш долоо хоногийн дотор хэлэлцэж батлах буюу хүчингүй болгоно. Хэрэв Улсын Их Хурал шийдвэр гаргаагүй бол уул зарлиг хүчингүй болно.

- Ерөнхийлөгч Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна гэсэн.

Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг зөвхөн хуулиар олгож болно гэж Үндсэн хуульд заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийг батлан гаргасан. Тус хуулийн 13 дугаар зүйлд Үндэсний аюулгүй байдлыг хангах, улсыг батлан хамгаалах талаарх Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг тодорхойлсон байна.

Мөн батлан хамгаалах салбарын хуулиудад Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг тусад нь хуульчилсан байна. Жишээлбэл, Батлан хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйл, Зэвсэгт хүчний тухай хуулийн 13 дугаар зүйл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуулийн 8.2 дахь хэсэг, Дайны байдлын тухай хуулийн 13 дугаар зүйл, Онц байдлын тухай хуулийн 5 зүйлийг дурдаж болно /хавсралт 1-ээс үзнэ үү/.

Эдгээрээс Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль, Батлан хамгаалах тухай хууль, Зэвсэгт хүчний тухай хуульд заасан бүрэн эрхийг доорх хүснэгтэд зэрэгцүүлэн авч үзье.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль	Батлан хамгаалах тухай хууль	Зэвсэгт хүчний тухай хууль
13 дугаар зүйл. Үндэсний аюулгүй байдлыг хангах, улсыг батлан хамгаалах талаарх Ерөнхийлөгчийн бүрэн эрх 1.Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлнэ. 2.Үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон мэдээллийг зохих байгууллагаас гаргуулан авч, шаардлагатай асуудлыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаанд санаачлан оруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд үүрэг, даалгавар өгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн биелэлтэд хяналт тавина. 3.Үндэсний аюулгүй байдлыг хангах эрх ашгийн үүднээс шаардлагатай гэж үзвэл Тагнуулын байгууллагын тодорхой үйл ажиллагаатай танилцаж, мэдээлэл авна. */Энэ хэсэгт 2002 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/* 4.Батлан хамгаалах, улсын болон эдийн засаг, экологийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий байгууллагын эрх баригчдын илтгэл, мэдээллийг сонсоно. 5.Төрийн цэргийн бодлогын үндэс, зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалтыг Засгийн газартай тохиролцон тодорхойлж Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. */Энэ хэсэгт 2002 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*	**7 дугаар зүйл. Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрх** 1.Монгол Улсын Ерөнхийлөгч Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хувьд Ерөнхийлөгчийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан бүрэн эрхээс гадна дараахь тодорхой бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 1/Монгол Улсын Төрийн цэргийн бодлогын хэрэгжилт, улс орныг батлан хамгаалахад зайлшгүй шаардагдах материаллаг нөөцийн бүрдүүлэлтэд хяналт тавих; */Энэ заалтыг 2002 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/* 2/батлан хамгаалах арга хэмжээний төсвийн талаар Улсын Их Хуралд санал дүгнэлт оруулах; **3/цэргийн нийтлэг дүрмүүдийг батлах;** */Энэ заалтыг 2002 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/* 4/цэргийн албан хаагчид цэргийн цол олгох журмыг тогтоох;" */Энэ заалтыг 2002 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*	**13 дугаар зүйл. Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрх** 13.1.Монгол Улсын Ерөнхийлөгч зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хувьд Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн тухай хуульд заасаснаас гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 13.1.1.зэвсэгт хүчний тайван цагийн болон дайны байдлын үеийн зохион байгуулалтын бүдүүвчийг батлах; 13.1.2.зэвсэгт хүчнийг дайнд ашиглах төлөвлөгөөг баталж, цэргийг байлдааны бэлэн байдлын дээд зэргүүдэд шилжүүлэх, байлдааны ажиллагаа эхлэх шийдвэрийг холбогдох хууль тогтоомжийн дагуу гаргах; 13.1.3.зэвсэгт хүчнийг дайны байдлын үеийн бүтэц, зохион байгуулалтад шилжүүлэх шийдвэр гаргах; **13.1.4.зэвсэгт хүчнийг ашиглах номлолыг батлах;** 13.1.5.зэвсэгт хүчний Жанжин штабын дүрмийг батлах;

6.Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болбол Улсын Их Хурлын чуулганы чөлөө цагт, хойшлуулшгүй тохиолдолд улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь онц болон дайны байдал зарлах, түүнчлэн цэрэг хөдөлгөх захирамж өгнө. Энэ тухай Ерөнхийлөгчийн зарлигийг нэн даруй ард нийтэд зарлан мэдэгдэнэ. Онц байдал, дайны байдал зарласан Ерөнхийлөгчийн зарлигийг Улсын Их Хурал уул зарлиг гарснаас хойш долоо хоногийн дотор хэлэлцэж батлах буюу хүчингүй болгоно. Хэрэв Улсын Их Хурал шийдвэр гаргаагүй бол уул зарлиг хүчингүй болно.

7.Ерөнхийлөгч Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасаар Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна.

8.Зэвсэгт хүчний Жанжин штабын даргыг Улсын Их Хуралтай зөвшилцөж томилно */Энэ хэсэгт 1997 оны 1 дүгээр сарын 9, 2002 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар тус тус өөрчлөлт орсон/.*

9.Бүх нийтийн буюу хэсэгчилсэн цэргийн дайчилгааг хууль тогтоомжид заасны дагуу зарлана.

10.Зэвсэгт хүчний нийтлэг дүрмүүдийг батална.

11.Зэвсэгт хүчний дайны үеийн бүтэц, зохион байгуулалт, зэвсэгт хүчнийг дайнд ашиглах ерөнхий төлөвлөгөөг баталж, цэргийг байлдааны бэлэн байдлын зэргүүдэд шилжүүлэх, байлдааны ажиллагаа эхлэх шийдвэр гаргана.

12.Дайн бүхий байдал, дайны байдал зарласан тохиолдолд Ерөнхийлөгч зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хувьд хэрэгжүүлэх бүрэн эрхийг хуулиар тогтооно.

5/цэргийн дүрэмт хувцас, цол, ялгах тэмдгийн загвар батлах;

6/онцгой нөхцөл бий болсон үед байлдагч, түрүүчийн алба хаах хугацааг гурван сараас дээш хугацаагаар сунгах саналыг Улсын Их Хуралд оруулах.

2.Монгол Улсын Ерөнхийлөгч хуульд заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

13.1.6.зэвсэгт хүчний Жанжин штабын даргыг Улсын Их Хуралтай зөвшилцөн томилох;

13.1.7. улсын хил, онц чухал обьектын хамгаалалтад ерөнхий зориулалтын цэргээр дэмжлэг үзүүлэх шийдвэр гаргах;

13.1.8.зэвсэгт хүчний анги, байгууллагыг аж ахуй, бүтээн байгуулалтын ажилд оролцуулах журмыг тогтоох;

13.1.9.хуульд заасан бусад бүрэн эрх.

Эндээс дараах асуудалд анхаарал хандуулах нь зүйтэй байна. Үүнд:

1. Үндсэн хуулийн 33.1.12 дахь заалт болон Ерөнхийлөгчийн тухай хуулийн 13.6 дахь хэсэг давхардсан гэж үзэж болно.

www.nli.gov.mn

Монгол Улсын Үндсэн хууль	Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль
Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болбол Улсын Их Хурлын чуулганы чөлөө цагт, хойшлуулшгүй тохиолдолд улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь онц болон дайны байдал зарлах, түүнчлэн цэрэг хөдөлгөх захирамж **өгөх**. Онц байдал, дайны байдал зарласан Ерөнхийлөгчийн зарлигийг Улсын Их Хурал уул зарлиг гарснаас хойш долоо хоногийн дотор хэлэлцэж батлах буюу хүчингүй болгоно. Хэрэв Улсын Их Хурал шийдвэр гаргаагүй бол уул зарлиг хүчингүй болно.	Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болбол УИХ-ын чуулганы чөлөө цагт, хойшлуулшгүй тохиолдолд улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь онц болон дайны байдал зарлах, түүнчлэн цэрэг хөдөлгөх захирамж **өгнө. Энэ тухай Ерөнхийлөгчийн зарлигийг нэн даруй ард нийтэд зарлан мэдэгдэнэ.** Онц байдал, дайны байдал зарласан Ерөнхийлөгчийн зарлигийг Улсын Их Хурал уул зарлиг гарснаас хойш долоо хоногийн дотор хэлэлцэж батлах буюу хүчингүй болгоно. Хэрэв УИХ шийдвэр гаргаагүй бол уул зарлиг хүчингүй болно.

Тайлбар: Тод хараар ялгаатай хэсгийг харуулав.

2. Ерөнхийлөгчийн тухай хуульд Ерөнхийлөгч **"Зэвсэгт хүчний нийтлэг дүрмүүдийг батална"**, Батлан хамгаалах тухай хуульд **"цэргийн нийтлэг дүрмүүдийг батлах"** бүрэн эрхтэй гэж заажээ. Гэтэл энэхүү 2 өөр нэр томъёо бүхий нийтлэг дүрмүүдийн ялгаа нь юу вэ? гэдэг асуудал зүй ёсоор тавигдаж байна. Үүнийг нэг мөр шийдэх нь батлан хамгаалах салбарын хуулиудын нэр томъёог жигдрүүлэхэд ач холбогдолтой юм.

Хэрэв энд 2 өөр томъёолол бүхий нэг зүйлийн тухай яригдаж байвал зэвсэгт хүчин болон цэрэг /цэргийн/ гэх томъёолол ижил ойлголт болно. Эсрэг тохиолдолд ялгаатай ойлголт болох ёстой. Цэрэг гэсэн нэр үгийг амьдрал дээр нийтлэг утгаар хэрэглэх боловч хууль зүйн нэр томъёо болох хувьдаа олон салаа утгатай байх нь сөрөг үр дагавар авчирдаг.

Нэр томьёоны энэ асуудал ямар ач холбогдолтой болохыг дараах жишээгээр харуулъя.

А/ Үндсэн хуулийн 33.1.12 дахь заалт болон Ерөнхийлөгчийн тухай хуулийн 13.6 дахь хэсэгт "Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болбол Улсын Их Хурлын чуулганы чөлөө цагт, хойшлуулшгүй тохиолдолд улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь онц болон дайны байдал зарлах, түүнчлэн **цэрэг хөдөлгөх захирамж өгнө**" гэж заасан байна. Нэг талаас энэхүү цэрэг хөдөлгөх захирамж нь зөвхөн зэвсэгт хүчин хамаарах уу гэсэн асуудал бий. Учир нь Монгол Улсын Ерөнхийлөгч бол Зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. Нөгөө талаас нь авч үзвэл Дайны байдлын тухай хуулийн 13.1.5-д Дайны байдлын үед Монгол Улсын Ерөнхийлөгч "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын хороо, Цэргийн дээд командлалын газрыг тэргүүлнэ", Зэвсэгт хүчний тухай хуулийн 13.1.2-т "Ерөнхийлөгч зэвсэгт хүчнийг дайнд ашиглах төлөвлөгөөг

баталж, **цэргийг** байлдааны бэлэн байдлын дээд зэргүүдэд шилжүүлэх, байлдааны ажиллагаа эхлэх шийдвэрийг холбогдох хууль тогтоомжийн дагуу гаргах бүрэн эрхтэй" гэснээс харвал "цэрэг" гэдгийг өргөн утгаар авч үзэх боломжтой мэт.

Б/ Түүнчлэн Батлан хамгаалах тухай хуулийн 7.1.1-д "Төрийн цэргийн бодлого", Зэвсэгт хүчний тухай хуулийн 17.1.1-д "цэргийн бодлого", 17.1.5-д "цэргийн алба", 17.1.10-т "цэрэг татах", 17.1.13-т "цэргийн дайчилгаа", 12.1.5-д "цэргийн тангараг", Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 18.1.5-д "Цэргийн бодлогын ажлын хэсэг" гэсэн нэр томъёоны цэргийн гэх тодотголыг явцуу хүрээнд зэвсэгт хүчин гэж ойлгох уу, эсхүл өргөнөөр ойлгох уу? Тэгвэл Зэвсэгт хүчний тухай хуулийн 5.1-д "Зэсвэгт хүчний байгуулалтын үндэс нь төрийн хууль тогтоомж, Төрийн цэргийн бодлогоор тодорхойлогдоно" гэж заасан байх юм.

В/ Үндсэн хуулийн 33.1.7-д Монгол Улсын Ерөнхийлөгч " ... **цэргийн дээд цол хүртээх** ... " бүрэн эрхтэй. Батлан хамгаалах тухай хуулийн 7.1.4, 7.1.5-д "**цэргийн албан хаагчид** цэргийн цол олгох журмыг тогтоох; **цэргийн дүрэмт хувцас, цол, ялгах тэмдгийн** загвар батлах" бүрэн эрхийг эдэлнэ гэсэн.

Эндээс цэргийн албан хаагч гэж хэн бэ? гэдгийг тодорхойлох шаардлага гарч байна.

Д. БАТЛАН ХАМГААЛАХ ТАЛААРХ ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭН ЭРХ

Батлан хамгаалах болон Зэвсэгт хүчний тухай хуульд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн бүрэн эрхийг тусгаагүй байдаг.

Гэвч Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 6, 7-д "Зөвлөл нь төрийн батлан хамгаалах бодлогыг тодорхойлж, зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгон бэхжүүлэх, улс төрийн гадаад нөхцөл байдлыг харгалзан төрийн цэргийн бодлогын үндсийн талаарх саналыг бэлтгэж, Монгол Улсын Ерөнхийлөгчөөр уламжлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; түүнчлэн Монгол Улсын үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдлын ашиг сонирхлын үүднээс олон улсын нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, технологи, **цэрэг**, улс төрийн байдалд дүн шинжилгээ хийж, шаардлагатай арга хэмжээг тодорхойлох асуудлаар үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн нэгдмэл бодлого боловсруулах үйл ажиллагааг болон түүнийг хэрэгжүүлэх явдлыг уялдуулан зохицуулах, энэхүү зохицуулалтад хяналт тавих чиг үүрэгтэй" гэж заасан.

Мөн хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Монгол Улсын Засгийн газрын гишүүн, тусгай газар, Зэвсэгт хүчний ерөнхий штабын дарга нар Зөвлөлийн илтгэгч байх бөгөөд тэдгээр нь тус тусын хариуцсан салбар, хүрээнд үндэсний язгуур ашиг сонирхол, аюулгүй байдлыг хангахтай холбоотой асуудлыг судалж зохих илтгэл, санал, шийдвэрийн төслийг боловсруулан Зөвлөлд оруулж, гарсан шийдвэрийг эрхэлсэн салбар, хүрээндээ хэрэгжүүлэх ажлыг хариуцна". 7.1.2-т "Зөвлөл нь үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн дотоод, гадаад, **батлан хамгаалах**

бодлогын үндсийг боловсруулах, **түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон онц чухал асуудлыг шийдвэрлэх чиглэл өгөх** бүрэн эрхийг эдэлнэ" гэж заасан байна.

Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 7.1.6-д "Зэвсэгт хүчин, бусад цэрэг нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг тусгайлсан чиг үүрэгтэй байгууллага" юм. Мөн хуулийн 18.1.5-д "Үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон мэдээлэл харилцан солилцох, Зөвлөлөөс гарах шийдвэрийн төсөл боловсруулахад туслах болон гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх асуудлаар зөвлөлдөх төрийн байгууллага хоорондын **Цэргийн бодлогын** орон тооны бус байнгын ажлын хэсгийг Зөвлөлийн дэргэд байгуулна" гэж заасан. /хавсралт-2-оос үзнэ үү/

Монгол Улсын Төрийн цэргийн бодлогын үндэст "Монгол Улсын төрийн цэргийн бодлогыг хэрэгжүүлэх явдлыг хууль тогтоомжоор зохицуулж, эдгээр хууль тогтоомжид төрийн цэргийн бодлого хэрхэн тусч байгаад Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөл хяналт тавина" гэж заажээ. Харин үндэсний аюулгүй байдлын зөвлөл энэ үүргээ хэрхэн хэрэгжүүлэх механизмын тухай тодорхой мэдээлэл байхгүй юм.

Дээр дурдсан үндэслэлээр Үндэсний аюулгүй байдлын зөвлөл бол батлан хамгаалах төрийн бодлого боловсруулахад жинтэй нөлөө үзүүлдэг, батлан хамгаалахын удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлдэг субъектийн нэг мөн боловч энэ талаарх зарим чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж чадахгүй байна гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Хоёр. ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТАЛААР

Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлыг тодорхойлдог суурь хууль бол Монгол Улсын Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль мөн. Энэ хуульд:

3 дугаар зүйл. Цэргийн алба

1.Цэргийн алба нь төрийн албаны онцлог төрөл бөгөөд цэргийн жинхэнэ болон бэлтгэл албанаас бүрдэнэ.

2.Монгол Улсын иргэн Зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд цэргийн үүрэг гүйцэтгэхийг цэргийн жинхэнэ алба гэнэ.

Цэргийн жинхэнэ алба нь байлдагч, түрүүчийн алба, ахлагчийн болон офицерийн албанаас бүрдэнэ. Харин цэрэгт бүртгэлтэй мэргэжил бүхий эмэгтэйчүүд сайн дурааараа офицер, ахлагчийн албыг хуулийн дагуу хааж болно */Энэ хэсгийг 2006 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчилсөн/.*

3. Энэ хуульд заасан бэлтгэл албаны насны эрэгтэйчүүд, цэрэгт бүртгэлтэй мэргэжил бүхий эмэгтэйчүүд цэргийн тоо бүртгэлд байж дайчилгааны сургууль, цугларалтаар болон хууль тогтоомжид заасан цэргийн албаны бусад үүрэг гүйцэтгэхийг цэргийн бэлтгэл алба гэнэ. Цэргийн бэлтгэл алба нь нэг, хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтний албанаас бүрдэнэ.

4 дүгээр зүйл. Цэргийн албан хаагч, цэргийн үүрэгтэн

1.Цэргийн жинхэнэ алба хааж байгаа иргэнийг цэргийн албан хаагч гэнэ.

2.Цэргийн бэлтгэл албанд байгаа иргэнийг цэргийн үүрэгтэн гэнэ. Цэргийн жинхэнэ алба хаасан байлдагч, түрүүч, ахлагч, офицерыг нэгдүгээр зэргийн цэргийн үүрэгтэн гэнэ. Бэлтгэлд байгаа цэргийн алба хаагаагүй эрэгтэйчүүд, мөн цэрэгт бүртгэлтэй мэргэжил бүхий эмэгтэйчүүдийг хоёрдугаар зэргийн цэргийн үүрэгтэн гэнэ гэж заасан байна.

Хуулийн энэ заалтаас харвал цэргийн албан хаагч гэж зөвхөн Зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд цэргийн үүрэг гүйцэтгэж буй Монгол Улсын иргэн юм.

Харин Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд цэргийн албан хаагчийг Монгол Улсын Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулиас өөрөөр тодорхойлсон байна. Учир нь уг хуулийн зорилтод "Энэ хуулийн зорилт нь Зэвсэгт хүчин, хилийн болон дотоодын цэрэг, тагнуул, цагдаа, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон хорих ял эдлүүлэх байгууллагын генерал, комиссар, офицер, ахлагч, түрүүч, байлдагч **/энэ хуульд цаашид "цэргийн албан хаагч" гэх/** нарт тэтгэвэр, тэтгэмж тогтоож, олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино" гэж заажээ[2].

Эндээс цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлыг тодорхойлсон суурь хууль болон түүнд нийцсэн байх ёстой бусад хуулийн хэм хэмжээ **зөрчилдөж байгааг** харж болно.

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1-ийн 1-д Цэргийн тэтгэвэр дор дурдсан төрөлтэй байна гэзд "**цэргийн жинхэнэ алба болон** тагнуул, цагдаа, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон хорих ял эдлүүлэх байгууллагад алба хаасан тэтгэвэр /цаашид "цэргийн алба хаасны тэтгэвэр" гэх/" гэж заажээ. Эндээс цэргийн албыг "цэргийн жинхэнэ алба" болон "цэргийн бусад алба /жинхэнэ бус/" гэсэн ангилал байсан мэт харагдаж байна. Гэтэл Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 3-т "хилийн цэргийн жинхэнэ албаны, дотоодын цэргийн жинхэнэ албаны" гэж заажээ. Цэргийн жинхэнэ алба дотроо ингэж олон задарч байгаа нь Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3.2-той мөн зөрчилдөж байна.

Учир нь Монгол Улсын Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3.1-т "Цэргийн алба нь төрийн албаны онцлог төрөл бөгөөд **цэргийн жинхэнэ** болон **бэлтгэл албанаас**

---

[2] Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн **4 дүгээр зүйл.** Дор дурдсан **Цэргийн тэтгэвэр, тэтгэмж авах албан хаагч** авах эрхтэй:

1/зэвсэгт хүчний цэргийн жинхэнэ албаны генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч;

2/ хилийн цэргийн жинхэнэ албаны генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч;

3/ дотоодын цэргийн жинхэнэ албаны генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч;

4/ тагнуулын байгууллагын генерал, офицер, ахлагч;

5/ цагдаа, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон хорих ял эдлүүлэх байгууллагын генерал, комиссар, офицер, ахлагч, байлдагч;

/Энэ заалтад 1999 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт орсон ба 2005 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон//Энэ заалтад 2008 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

6/ дайчилгааны сургууль цугларалтад оролцож байгаа цэргийн үүрэгтэн.

7/ онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын алба хаагч.

/Энэ заалтыг 1999 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар нэмсэн ба 2003 оны 6 дугаар сарын 20, 2005 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар тус тус өөрчлөлт орсон/

бүрдэнэ" гэж заасан байдаг. Ингэхлээр Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан тагнуул, цагдаа, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон хорих ял эдлүүлэх байгууллагын албан хаагчид цэргийн жинхэнэ албан хаагч биш учир бэлтгэл албанд хамаарах уу? Харин Монгол Улсын Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3.3-т "Энэ хуульд заасан бэлтгэл албаны насны эрэгтэйчүүд, цэрэгт бүртгэлтэй мэргэжил бүхий эмэгтэйчүүд цэргийн тоо бүртгэлд байж дайчилгааны сургууль, цугларалтаар болон хууль тогтоомжид заасан цэргийн албаны бусад үүрэг гүйцэтгэхийг цэргийн бэлтгэл алба гэнэ. Цэргийн бэлтгэл алба нь нэг, хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтний албанаас бүрдэнэ" гэж заажээ.

Мөн түүнчлэн Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн зорилтод **хилийн болон дотоодын цэрэг** гэж байхад 3.1.1-д алга байгаа нь эдгээр албан хаагчийг **цэргийн жинхэнэ алба** хаасанд тооцох уу, эсхүл? гэдэг толгой эргэм асуултыг давхар үлдээсэн байна. Ингэхдээ мөн хуулийн 4.1, 4.2, 4.3-т "зэвсэгт хүчний цэргийн жинхэнэ албаны генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч"; "хилийн цэргийн жинхэнэ албаны генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч"; "дотоодын цэргийн жинхэнэ албаны генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч" гэж заасан байна. Энэ нь Монгол Улсын Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3.2-т заасан "Монгол Улсын иргэн Зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд цэргийн үүрэг гүйцэтгэхийг цэргийн жинхэнэ алба гэнэ" гэсэнтэй бас зөрчилдөж байгаа юм.

Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 13.2-т "Энэ зүйлийн 1-д заасан насны дээд хязгаарт хүрсэн цэргийн өндөр мэргэжил, дадлага сайтай зарим офицер, ахлагчийн **цэргийн жинхэнэ алба** хаах хугацааг **батлан хамгаалах** болон **хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр** 5 хүртэл жил сунгаж болно гэж заасан байна. Хуулийн заалтад хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад /түүний харьяа/ цэргийн жинхэнэ албан хаагчид алба хаахыг хуульчилсан байна.

Харин 2009 оны 10 дугаар сарын 28-ны өдөр Улсын Дээд шүүхээс Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Цэргийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай 32 дугаар тогтоол гарсан байна. Энэ тогтоолд:

1.Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1, 2-т заасан[3] цэргийн жинхэнэ

[3] Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйл. Цэргийн жинхэнэ алба хаах насны дээд хязгаар

1. Цэргийн албан хаагч нь:

1/ байлдагч, түрүүчийн албыг: -хугацаат цэрэг 27 нас хүртэл; -гэрээт цэрэг 31 нас хүртэл */Энэ заалтыг 2006 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчилсөн/*;

2/ ахлагчийн албыг 45 нас хүртэл;

3/ офицерын албыг: - дунд офицер 45 нас хүртэл; - ахлах офицер 50 нас хүртэл ; - дээд офицер 55 нас хүртэл тус тус хааж болно. Эмэгтэйчүүд ахлагч, офицерын албыг цэргийн цол харгалзахгүйгээр 45 нас хүртэл хааж болно.

2. Энэ зүйлийн 1-д заасан насны дээд хязгаарт хүрсэн цэргийн өндөр мэргэжил, дадлага

албан хаагчийн насны дээд хязгаарт Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1, 2, 3-т заасан[4] цэргийн албан хаагчид хамаарна.

2.Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4, 5-д заасан[5] генерал, комиссар, офицер, ахлагч, байлдагчийн цэргийн алба хаах насны дээд хязгаарыг тогтоох, алба хаах хугацааг сунгах асуудлыг эрх бүхий этгээд Төрийн албаны тухай хуульд заасан төрийн алба хаах насны дээд хязгаарт багтаан шийдвэрлэхэд Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д заасан зохицуулалт саад болохгүй.

Ингэснээр цэргийн жинхэнэ албан хаагчид зэвсэгт хүчин, хилийн цэрэг, дотоодын цэргийн албан хаагчид хамаарахаар талаар Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль /13.2/, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн дурдсан зүйл, заалт болон Улсын Дээд шүүхийн хууль тайлбарласан тогтоолд заасан.

Энэ нь Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3.2-т "Монгол Улсын иргэн **Зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд** цэргийн үүрэг гүйцэтгэхийг цэргийн жинхэнэ алба гэнэ" гэсэнтэй хэрхэн нийцэж байгаа нь ойлгомжгүй байна. Эндээс нэг бол хилийн болон дотоодын цэрэг бол зэвсэгт хүчинд хамаарна гэсэн гаргалгаа гарна. Эсхүл хилийн болон дотоодын цэргийг үндэслэлгүйгээр цэргийн жинхэнэ албан хаагчид тооцсон хууль баталсан гэсэн дүгнэлтэд хүрэх юм.

ГУРАВ. ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ БҮТЦИЙН ТАЛААР

Зэвсэгт хүчин гэдэгт юуг хамруулах вэ гэсэн асуудал юм. Учир нь одоогийн дагаж мөрдөж буй хуулиар цэргийн албан хаагч бол Зэвсэгт хүчинд алба хааж буй иргэн мөн.

Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлд "Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн. Монгол Улс өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчинтэй байна. Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалт, түүнд алба хаах журмыг хуулиар тогтооно" гэж заасан.

1993 оны 10 дугаар сарын 12-ны өдөр батлагдсан Батлан хамгаалах тухай хуульд анх зэвсэгт хүчин ба бусад цэрэг гэсэн нэр томъёо орсон. Улмаар зэвсэгт хүчин бол ... батлан хамгаалах зорилт бүхий төрийн цэргийн байгууллагуудын тогтолцоо мөн. Харин бусад цэрэгт хилийн ба дотоодын цэрэг хамаарч байв.

Тус хуулиар зэвсэгт хүчний бүтцэд ерөнхий зориулалтын, улсыг агаарын сайтай зарим офицер, ахлагчийн цэргийн жинхэнэ алба хаах хугацааг батлан хамгаалах болон хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр 5 хүртэл жил сунгаж болно.

/Энэ хэсэгт 2006 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар үг нэмсэн/.

[4] 1/ зэвсэгт хүчний **цэргийн жинхэнэ албаны** генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч;
2/ хилийн **цэргийн жинхэнэ албаны** генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч;
3/ дотоодын **цэргийн жинхэнэ албаны** генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч;

[5] 4/ тагнуулын байгууллагын генерал, офицер, ахлагч;
5/ цагдаа, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон хорих ял эдлүүлэх байгууллагын генерал, комиссар, офицер, ахлагч, байлдагч;

довтолгооноос хамгаалах, барилгын, иргэний хамгаалалтын, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн багтана. Дайн бүхий байдал, дайны байдлын үед зэвсэгт хүчний бүтцэд бусад цэрэг орж үүрэг гүйцэтгэнэ. Зэвсэгт хүчин нь зохион байгуулалтын хувьд цэргийн удирдлагын байгууллага, төрөл мэргэжлийн цэргийн болон ар тал, техникийн нэгтгэл, ангууд, цэргийн сургууль, эрдэм шинжилгээ, соёл урлаг, эмнэлэг, аж ахуй, үйлчилгээний байгууллагатай байхаар тусгагдсан байв.

Улмаар 2002 онд Зэвсэгт хүчний тухай хууль батлагдсанаар Батлан хамгаалах тухай хуульд байсан зэвсэгт хүчинтэй холбоотой зүйл заалтууд хүчингүй болсон.

Харин Зэвсэгт хүчний тухай хуулийн **6 дугаар зүйл "Зэвсэгт хүчний бүтэц"** гэсэн нэртэй. Зэвсэгт хүчний тухай хуулийг батлан гаргах үед Ерөнхийлөгчийн Тамгын газраас гаргасан хуулийн танилцуулгад "зэвсэгт хүчний бүтцийг ерөнхий зориулалтын цэрэг, хилийн цэргээс бүрдэж байхаар хуулийн төсөлд тусгав. Гэхдээ энэ нь зэвсэгт хүчин, хилийн цэргийн одоогийн удирдлага, бүтэц, зохион байгуулалтад нөлөөлөхгүй бөгөөд зарчмын заалт болно. ... тайван цагт цэргийн жинхэнэ алба хааж буй иргэдийн бараг тал хувийг хилийн цэрэг бүрдүүлж байгаа тул зэвсэгт хүчний ерөнхий нэгэн удирдлагын нэгдмэл байдлыг бэхжүүлэх, хилийн цэргийн удирдлагын тогтвортой байдлыг хангах үүднээс Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн хувьд Хилийн цэргийн командлагчийг томилж байхаар тусгав" гэсэн байна.

Харин УИХ-аас 2002.5.16-ны өдөр баталсан Зэвсэгт хүчний тухай хуулийн 6.1-д "Зэвсэгт хүчний бүтцэд тайван цагт ерөнхий зориулалтын цэрэг, дайны байдлын үед ерөнхий зориулалтын, хилийн, дотоодын цэрэг багтана. Дайны байдлын үед иргэний ба цэргэгсэн зарим байгууллагыг бүрэн ба хэсэгчилсэн хэмжээгээр зэвсэгт хүчний бүтцэд оруулж болно" гэсэн заалт байв.

Зэвсэгт хүчний тухай хуулийн 6.1-ийн "Зэвсэгт хүчний бүтцэд тайван цагт ерөнхий зориулалтын цэрэг, дайны байдлын үед ерөнхий зориулалтын цэрэг, хилийн, дотоодын цэрэг багтана..." гэсэн хуулийн энэ заалт Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалтай нийцэхгүй байна хэмээн Монгол Улсын Ерөнхийлөгчөөс хориг тавьсан ба УИХ энэхүү хоригийг хүлээн авч уг заалтыг хүчингүй болгожээ.

Ингэснээр "Тайван цагт ерөнхий зориулалтын, хилийн, дотоодын цэрэг мэргэжлийн бие даасан үйл ажиллагаа явуулна" гэсэн 6.2. дахь хэсэг үлдсэн. Эндээс зэвсэгт хүчний бүтцийг тодорхойлох боломжгүй болж байна.

Харин Улсын Дээд шүүхийн 2003 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 4 дүгээр тогтоолд "Зэвсэгт хүчний тухай Монгол Улсын хууль"-ийн Хоёрдугаар бүлгийн 6 дугаар зүйлийн "Зэвсэгт хүчний бүтэц" гэдэгт мөн зүйлийн 6.2 дахь хэсэгт заасан "тайван цагт ерөнхий зориулалтын, хилийн, дотоодын цэрэг"-ийг хамааруулан ойлгохыг тайлбарласугай гэсэн байна. Энд ерөнхий зориулалтын, хилийн, дотоодын цэрэг Зэвсэгт хүчнийг бүрдүүлнэ гэж үзжээ. УДШ ямар үндэслэлээр хилийн, дотоодын цэрэг Зэвсэгт хүчний бүтцэд хамааруулсан нь ойлгомжгүй болжээ.

Түүнчлэн Зэвсэгт хүчний тухай хуулийн 16.1 дэх хэсэгт "Зэвсэгт хүчний Жанжин штаб нь улс орныг цэргийн хүчээр батлан хамгаалах зорилго бүхий төрийн цэргийн байгууллагуудыг цэргийн мэргэжлийн нэгдмэл удирдлагаар хангах **дээд байгууллага** мөн" гэж заасан. Энэ утгаар ерөнхий зориулалтын, хилийн, дотоодын цэргийг Зэвсэгт хүчний Жанжин штаб нэгдмэл удирдлагаар хангах ёстой мэт. Гэтэл мөн хуулийн 16.3 дахь хэсэгт "Тайван цагт ерөнхий зориулалтын, хилийн, дотоодын цэргийн харилцан ажиллагааг зэвсэгт хүчний Жанжин штаб, хилийн болон дотоодын цэргийн штабууд хамтран шийдвэрлэж хэрэгжүүлнэ" гэсэн нь дээрх ойлголтууд хоорондоо зарчмын хувьд зөрөөтэй байгааг харуулж байна. Ингэхлээр бид энд **"батлан хамгаалах зорилго бүхий төрийн цэргийн байгууллага"** гэдэгт юу хамаарахыг тодорхойлохгүй бол мухардалд хүргэхээс цаашгүй болж байна.

Нөгөөтэйгүүр Монгол Улсын Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйл "Монгол Улсын Зэвсэгт хүчин, бусад цэргийн бие бүрэлдэхүүнийг нөхөн хангах" нэртэй, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 7.1.6-д заасан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгуулагуудын жагсаалтад "зэвсэгт хүчин, бусад цэрэг" гэсэн нэр томъёо одоо болтол хэвээр үлдсэн байна.

Түүнчлэн Зэвсэгт хүчний тухай хуулийн 13.1.7, 15.1.3, 15.1.4, 15.1.5, 17.1.4, 17.1.5, 17.1.6, 17.1.8, 17.1.14, 18.2.3, 18.2.5, 18.2.7, 18.2.10 зэрэг заалтад "ерөнхий зориулалтын цэрэг" гэсэн нэр томъёо оржээ. Зэвсэгт хүчний бүтэц тодорхой биш учраас Зэвсэгт хүчний тухай хуульд орсон "ерөнхий зориулалтын цэрэг" болон "зэвсэгт хүчин" гэсэн ойлголтуудын ялгаа огт байхгүй болсон.

Эндээс Зэвсэгт хүчний тухай хуульд зэвсэгт хүчний бүтцийг тодорхойлж чадаагүй байна гэсэн дүгнэлтэд хүрч байна. Харин Монгол Улсын Төрийн цэргийн бодлогын үндэст "Зэвсэгт хүчний бүтэц, төрөл мэргэжлийн цэргийн зохистой харьцааг цэрэг-улс төрийн байдал, батлан хамгаалах хэрэгцээ, шаардлагыг үндэслэн **хуулиар тогтооно**" гэсэн ба Төрийн цэргийн бодлогын үндэс хэмээх энэ баримт бичиг нь батлан хамгаалах үйл ажиллагааны талаарх Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээ, хэлэлцээрийн үндэс болно гэж заажээ.

Зэвсэгт хүчний бүтцийг хуулиар тогтоох эрх зүйн шаардлагыг тойрч гарах үндэсгүй бөгөөд тодорхой болгох нь батлан хамгаалах салбарын хууль тогтоомжийн цаашдын хандлагад чухал ач холбогдолтой юм.

ДӨРӨВ. ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН АСУУДАЛ

Удаан жил алба хаасны тэтгэвэр нь өндөр насны /хөдөлмөрийн/ тэтгэвэртэй үндсэн шинж, зориулалтын хувьд ихээхэн ойролцоо. Өндөр насны тэтгэврийг хүний нас, ажилласан жилийг харгалзан олгодог бол удаан жил алба хаасны тэтгэврийг зөвхөн ажилласан жилийг харгалзан, насыг харгалзахгүй олгодгоороо ялгаатай. Ийнхүү цэргийн албан хаагчдыг

тусгайлан авч үзэж зохих хөнгөлөлт үзүүлж байгаагийн гол агуулга нь тэдний эрхэлж байгаа үйл ажиллагааны онцлогтой холбоотой ба тэдний мэргэжлийн хөдөлмөрийн чадвар нь эрт буурдаг гэж үзэх үндэстэй бөгөөд хөдөлмөрийн нөхцөл нь өөрийн онцлогтой гэж зүй ёсоор үздэг[6] байна.

Цэргийн албан хаагчид ямар субъект хамаарах талаар:

Цэргийн алба нь төрийн албаны онцлог алба бөгөөд Төрийн албаны тухай хууль[7]-д зааснаар **төрийн тусгай албанд** хамаарахаар тусгагдсан байна.

Төрийн тусгай албан тушаалд Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, Цагдаагийн төв байгууллагын дарга, Хилийн цэргийн удирдах газрын дарга, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга, зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, цагдаа, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын байгууллагын офицер, ахлагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, гаалийн байцаагч нарыг хамааруулахаас гадна хуульд заасан бусад албан тушаалыг хамааруулахаар хуульд тусгасан.

Зэвсэгт хүчин, хилийн цэрэг, тагнуул, цагдаа, галын болон хорих ял эдлүүлэх зэрэг байгууллагад 25-аас доошгүй жил алба хаасан эрэгтэй, 20-оос доошгүй жил алба хаасан эмэгтэй, байлдааны нисдэг тэрэгний нисгэгчээр 23-аас доошгүй жил, байлдааны тийрэлтэт сөнөөгч онгоцны жинхэнэ нисгэгчээр 20-оос доошгүй жил алба хаасан генерал, офицер, ахлах байлдагч нас харгалзахгүйгээр цэргийн алба удаан жил хаасны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй. Энэ хугацаагаар бүрэн ажиллаагүй боловч 10-аас доошгүй жил алба хаасан цэргийн албан хаагч орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлтөөр биеийн эрүүл мэндийн байдлаар, эсхүл цэргийн алба хаах нас хэтэрсэн шалтгаанаар цэргийн албанаас чөлөөлөгдсөн бол цэргийн алба хаах насны хязгаарт хүрээд цэргийн алба хаасан тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгож авах эрхтэй.

Цэргийн тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах хугацаанд цэргийн жинхэнэ алба болон тагнуул, цагдаа, галын болон хорих ял эдлүүлэх байгууллагад алба хаасан нийт хугацааг тооцно.

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль[8]-д Зэвсэгт хүчин, хилийн цэрэг, дотоодын цэрэг, тагнуул, цагдаа, шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээч, онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага, хорих ял эдлүүлэх байгууллагын генерал, комиссар, офицер,

---

[6] Монгол Улсын нийгмийн хангамжийн эрх зүй, УБ., 2000 он, 108 дахь тал

[7] Төрийн албаны тухай хууль 2002 оны 6 дугаар сарын 28-ны өдөр батлагдсан бөгөөд "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 28 дахь дугаарт нийтлэгдсэн.

[8] 1994 оны 6 дугаар сарын 13-ны өдөр батлагдсан бөгөөд "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1994 оны 8 дахь дугаарт нийтлэгдсэн.

* Энэ хууль 2002 оны 5 дугаар сарын 16-ны өдөр батлагдсан бөгөөд Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 21 дэх дугаарт нийтлэгдсэн.

** Энэ хууль 1993 оны 10 дугаар сарын 21-ний өдөр батлагдсан бөгөөд Төрийн мэдээлэл эмхтгэлийн 1993 оны 4-5 дахь дугаарт нийтлэгдсэн.

*** Энэ хууль 1995 оны 10 дугаар сарын 17-ны өдөр батлагдсан бөгөөд "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1995 оны 12 дахь дугаарт нийтлэгдсэн.

ахлагч, түрүүч, байлдагч нарыг Цэргийн албан хаагч гэдэгт хамааруулан ойлгохоор байна.

Үүнийг хүснэгтлэн үзүүлбэл:

Албан хаагчийн нэр	Хуулийн заалт	Тодорхойлолт
Зэвсэгт хүчин	Зэвсэгт хүчний тухай хуулийн* 8 дугаар зүйл	Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн нь **цэргийн албан хаагч болон цэргийн анги, байгууллагад гэрээгээр ажиллагсдаас** бүрдэнэ.
Хилийн цэрэг	Хилийн тухай хуулийн** 31 дүгээр зүйл	Улсын хил хамгаалалтыг улс орны хэмжээнд удирдан зохион байгуулах үүрэг бүхий хил хамгаалалтыг удирдах төрийн захиргааны байгууллага, түүний харъяа тусгай анги, салбарыг хил хамгаалах байгууллага гэнэ. Улсын хил хамгаалах байгууллага нь үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардлагатай штаб, тагнуул, зэвсэглэл, инжинер, техник, ар тал, хэрэг бүртгэлт, эмнэлэг, хангалт, үйлчилгээ, соёл урлаг, спорт, боловсрол, эрдэм шинжилгээний болон шаардлагатай бусад нэгжтэй байна гэж зааснаас үзэхэд дээрх байгууллагын албан хаагчдыг хилийн цэргийн албан хаагчид гэж ойлгож болно/.
Дотоодын цэрэг	Дотоодын цэрэг гэдэгт Дотоодын цэргийн тухай хуулийн*** 13 дугаар зүйл	Монгол Улсын цэргийн тангарагийг өргөж, дотоодын цэргийн аль нэг байгууллагад алба хаж байгаа Монгол Улсын иргэнийг хэлнэ гэжээ.
Тагнуул	Тагнуулын тухай хуулийн /1999.07.08-ны өдөр батлагдсан/ 17 дугаар зүйл	Тангараг өргөж, тагнан турших болон түүнтэй адилтгах ажил эрхэлж буй төрийн тусгай албан хаагчийг **тагнуулын ажилтан** гэнэ гэж хуульчилсан. /ТЕГ-ын захиргаа, үйлчилгээний ажилтны эрх зүйн байдлыг Төрийн албаны тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хууль, хууль тогтоомжийн бусад актаар зохицуулна хэмээн тус хуулийн 17 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заажээ. /

* Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1999 оны 35 дахь дугаарт нийтлэгдсэн.

** "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1994 оны 8 дахь дугаарт нийтлэгдсэн.

*** Энэ хууль 2003 оны 6 дугаар сарын 20-ны өдөр батлагдсан бөгөөд "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2003 оны 25 дахь дугаарт нийтлэгдсэн.

Цагдаа	Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хууль-/1993.12.2/ийн** 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт	Цагдаагийн тангараг өргөж, цагдаагийн аль нэг байгууллагад ажиллаж, суралцаж байгаа иргэнийг **цагдаагийн алба хаагч** гэнэ. Үүнд цагдаагийн төв байгууллага, түүний харьяа албад аймаг, нийслэлийн харьяа албад болон аймаг, нийслэлийн цагдаагийн газар /хэлтэс/, сум, дүүргийн буюу сум, дүүрэг дундын цагдаагийн хэлтэс /тасаг, хэсэг/-ийн алба хаагчдыг ойлгоно. Мөн Цагдаагийн төв байгууллагын харьяанд цагдаагийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх сургууль, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах асуудлаар шинжилгээ, судалгаа явуулах үүрэг бүхий байгууллага байж болно гэж 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заажээ.
Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага	Гамшгаас хамгаалах тухай хуулийн*** 14.1-д	Гамшгаас хамгаалах арга хэмжээг улсын хэмжээнд Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайд чиглүүлж, онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга, тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хэмжээнд аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга удирдан зохион байгуулна гэж заасан.
Хорих ял эдлүүлэх байгууллагын албан хаагчид	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 5 дугаар зүйл	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар /шийдвэр гүйцэтгэх төв байгууллага/, **хорих байгууллага**, аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанаас бүрдэнэ. /ШШГБ нь иргэний болон эрүүгийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх үүрэг бүхий төрийн байгууллага мөн гэжээ./ Үүнээс үзэхэд ШШГЕГ-ын эрүү, иргэний шийдвэр гүйцэтгэгч нар энд хамаарагдахгүй зөвхөн хорих ангийн албан хаагч нар хамаарахаар байна.
Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн алба хаагч	2009 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн хуулиар нэмсэн.	Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн шинжээчийг цэргийн албан хаагчид хамааруулахаар заасан байна.
Дээрх байгууллагуудын генерал, комиссар, офицер, ахлагч, түрүүч, байлдагч нарыг хамааруулан ойлгохоор заасан байна.		

Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль[9]-ийн 3 дугаар зүйлд **Цэргийн алба** нь төрийн албаны онцлог төрөл бөгөөд **цэргийн жинхэнэ** болон **бэлтгэл** албанаас бүрдэнэ гэжээ.

2. Монгол Улсын иргэн Зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд цэргийн үүрэг гүйцэтгэхийг **цэргийн жинхэнэ алба** гэнэ. Цэргийн жинхэнэ алба нь:

- байлдагч,
- түрүүчийн алба,
- ахлагчийн алба,
- офицерийн албанаас бүрдэнэ.
- Цэрэгт бүртгэлтэй мэргэжил бүхий эмэгтэйчүүд сайн дураараа офицер, ахлагчийн албыг хуулийн дагуу хааж болно.

Энэ хуульд заасан бэлтгэл албаны насны эрэгтэйчүүд, цэрэгт бүртгэлтэй мэргэжил бүхий эмэгтэйчүүд цэргийн тоо бүртгэлд байж дайчилгааны сургууль, цугларалтаар болон хууль тогтоомжид заасан цэргийн албаны бусад үүрэг гүйцэтгэхийг **цэргийн бэлтгэл алба** гэнэ.

Цэргийн бэлтгэл алба нь нэг, хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтний албанаас бүрдэнэ.

Цэргийн жинхэнэ алба хаасан байлдагч, түрүүч, ахлагч, офицерийг **нэгдүгээр зэргийн цэргийн үүрэгтэн** гэнэ.

Бэлтгэлд байгаа цэргийн алба хаагаагүй эрэгтэйчүүд, мөн цэрэгт бүртгэлтэй мэргэжил бүхий эмэгтэйчүүдийг **хоёрдугаар зэргийн цэргийн үүрэгтэн** гэнэ.

Тус хуулийн 4 дүгээр зүйлд: Цэргийн албан хаагч, цэргийн үүрэгтний талаар дараах байдлаар томъёолжээ. Үүнд:

1. Цэргийн жинхэнэ алба хааж байгаа иргэнийг **цэргийн албан хаагч** гэнэ.

2. Цэргийн бэлтгэл албанд байгаа иргэнийг **цэргийн үүрэгтэн** гэнэ.

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд дээрх субъектуудыг "цэргийн албан хаагч" хэмээн тодорхойлоод генерал, комиссар, офицер, ахлагч, түрүүч, байлдагч нарыг хамааруулан ойлгохоор заасан байна. Гэтэл "комиссар" гэсэн цол зөвхөн Онцгой байдлын албаны офицерын цол хэргэмийн нэгэн төрөл болж байна. Мөн "офицер" гэсэн цол дотор Онцгой байдлын албаны албан хаагчдын хувьд 8 цолыг нийтэд нь нэрлэж байна. Цагдаагийн байгууллагын албан хаагчдын хувьд энэ цол байхгүй. Энэ нь бага албан тушаалтнуудаа нийтэд нь нэрлэж байгаа мэт ойлгогдохоор байна. Үүнээс үзэхэд ЦАХТТТХ-д заасан дээрх албан тушаалтнуудад дурдсан цол бүгд байхгүй байгаа нь харагдаж байна.

Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль нь тэдгээрийн эрх зүйн байдлыг зохицуулсан гол хууль юм. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд "цэргийн албан хаагч" гэдэгт цэргийн албанд хамаарахаргүй субъектуудыг нэмсэн нь буруу гэж үзэж байна. Харин Тагнуулын байгууллагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Тагнуулын ажилтны тэтгэвэр, тэтгэмжийн харилцааг цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай

[9] "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 3 дахь дугаарт нийтлэгдсэн

хууль тогтоомжид зааснаар зохицуулна хэмээн заасан нь маш зөв бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Цагдаагийн байгууллагын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Шүүхийн шинжилгээний тухай хуульд энэ байдлаар зохицуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 6 дугаар зүйлд Цэргийн тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах хугацаанд цэргийн жинхэнэ алба болон тагнуул, цагдаа, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон хорих ял эдлүүлэх байгууллагад алба хаасан нийт хугацааг тооцно. Мөн хуулийн 22 дугаар зүйлд генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагчаар 1О-аас доош жил алба хаасан бол уг хугацааг тухайн иргэний нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаанд оруулан тооцно хэмээн заасан ч Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийг **Цэргийн албан хаагчийн тэтгэврийг тогтоох, олгох байгууллага нь** тухайн тэтгэвэр авагчийн алба хааж байсан зэвсэгт хүчин, хилийн болон дотоодын цэрэг, тагнуул, цагдаа, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон хорих ял эдлүүлэх байгууллага буюу тэдгээрээс гэрээ байгуулсан этгээд байх талаар хуульд тусгасан.

Нийгмийн даатгалын сангаас тэтгэврийг олгохдоо энгийн байгууллагад ажиллаж байгаад цэргийн албанд цөөн жил ажилласан хүний тэтгэврийг тогтоохдоо Засгийн газраас тогтоосон тодорхой итгэлцүүрийг хэрэглэн тогтоодог ч Төрийн сангаас Нийгмийн даатгалын санд мөнгийг нь шилжүүлээгүйгээс тэтгэврээ тогтоолгон авч чадахгүй тохиолдол байхыг үгүйсгэхгүй. Учир нь тухайн байгууллагын зардалд энэ талаар тусгагдаагүй байдгаас Нийгмийн даатгалын сан руу шилжүүлэх нь удаан байдаг байна.

Удаан жил алба хаасан цэргийн албан хаагчдад олгох тэтгэврийг хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос бодох хувь хэмжээ нь ердийн өндөр насны хэмжээнээс илүү ажилласан жилийн нэмэгдэл нь ердийн насны тэтгэврээс арай бага байдаг байна.

Сүүлийн жилүүдэд энэ тэтгэврийг авах эрх бүхий байгууллагын цэргийн албан хаагчийн хүрээ өргөжсөөр байгаа билээ. Тухайлбал, 1995 онд гал түймэртэй тэмцэх байгууллагын албан хаагч, 1996 онд галын байгууллагын алба хаагч зэрэг цэргийн албан хаагчид хамаарахаар болсон.

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийг авч байгаа хүний тоог хүснэгтлэн харуулбал дараах байдалтай байна.

Нийслэлийн хэмжээнд Нийгмийн даатгалын сангаас цэргийн тэтгэвэр авагч иргэдийн тоо[10] /1995-2008/

Тэтгэвр-ийн төрөл /он/		1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008
Тэтгэвэр авагч нийт иргэний тоо		**80671**	**85599**	**74437**	**75529**	**77228**	**80554**	**83536**	**85526**	**87613**	**94356**	**100372**	**104723**	**107896**	**111479**
Үүнээс	Өндөр насны тэтгэвэр	5063	5502	3875	3928	4037	5593	5796	6597	6898	7385	7806	8063	8315	8473
	Тахир дутуугийн тэтгэвэр	96	143	1537	1547	1572	210	217	216	210	223	252	216	217	204
	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	99	174	362	428	462	528	575	620	614	642	673	628	611	565
Цэргийн тэтгэвэр авагчдын нийт тоо		**5258**	**5819**	**5774**	**5903**	**6071**	**6331**	**6588**	**7433**	**7722**	**8250**	**8731**	**8907**	**9143**	**9242**

[10] Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, Нийслэлийн нийгмийн даатгалын газар, Нийгмийн даатгалын статистикийн эмхтгэл, УБ., 2009 он. 39 дэх тал

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nligov.mn

Нийслэлийн хэмжээнд Цэргийн тэтгэвэр тэтгэмжийг шинээр тогтоолгосон тэтгэвэр авагчдын болон тэтгэврийн эрх зогсоогдсон хүний тоо[11] /1999-2008/

Тэтгэврийн төрөл /он		1999	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008
Шинээр тогтоолгосон хүний тоо	Нийт	4724	5589	5417	6732	6416	8102	10800	9265	8329	8403
	Үүнээс цэргийн албан хаагч	383	478	460	870	617	735	235	618	440	442
Тэтгэврийн эрх зогсоогдсон	Нийт	4235	4604	4338	6764	5963	5174	8595	6107	7509	7149
	Үүнээс цэргийн албан хаагч	283	279	235	323	356	301	261	377	400	412

Хүний эрхийн үндэсний хүрээлэн www.nhrc.gov.mn

[11] Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, Нийслэлийн нийгмийн даатгалын газар, Нийгмийн даатгалын статистикийн эмхтгэл, УБ., 2009 он. 51 дэх тал

Дүгнэлт:

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийг тогтоож олгохтой холбогдсон энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн холбогдох заалтаар зохицуулна гэжээ. Гэтэл энэ хууль нь 7 бүлэг 25 зүйлтэйгээс 10 зүйл нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль болон Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Хөдөлмөрийн хуультай давхардсан заалт байгаагаас Цэргийн албан хаагчийн тэтгэвэр. тэтгэмжийн тухай хуулийн давхардлыг арилгах шаардлага зүй ёсоор гарч байна.

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тогтоохдоо батлан хамгаалах салбарт энгийнээр ажиллаж байсан хүмүүсийг нэгэн адил хамааруулах талаар тусгах шаардлагатай байна.

Цэргийн алба хааж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадуудад бэлтгэл офицер, ахмадууд ахмад настанд үзүүлэх нийгмийн халамж, үйлчилгээг хүртэж чадахгүй байгаагаас гадна эрүүл мэндийн талаар үзүүлэх үйлчилгээнд хамрагдах боломжгүй байна.

Энгийн байгууллагад ажиллаж байгаад тэтгэвэрт гарахад нийт ажилласан жилд оруулан тооцдог болгох шаардлагатай байна гэж үзлээ.

ТАВ. ГАДААД ЦЭРГИЙН ХҮЧНИЙГ БАЙРЛУУЛАХ, ДАМЖИН ӨНГӨРҮҮЛЭХ АСУУДАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн 4 дүгээр зүйлийн 3-т хууль гаргахгүйгээр гадаадын цэргийн хүчнийг байрлуулах, дамжин өнгөрүүлэхээр улсын хил нэвтрүүлэхийг хориглоно гэсэн нь Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу Монгол Улсын Төрийн бүрэн эрхт байдлын тулгуур болох тусгаар тогтнолын үндэс, Монгол төрийн энх тайванч гадаад бодлогын хийгээд үндэсний аюулгүй байдлыг хангах чухал баталгаа юм.

Энэ асуудлыг 1998 онд баталсан Гадаад цэргийн хүчнийг байрлуулах, дамжин өнгөрүүлэх тухай хуулиар зохицуулсан бөгөөд энэ хууль нь Монгол Улсад олон улсын чанартай хэзрийн сургууль болон цэрэг, цагдаагийн албан хаагчдыг НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцох бэлтгэл ажлыг гадаад улсын бие бүрэлдэхүүнтэй хамтарч хангах. террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд гадаадын цэрэг, цагдаагийн тусгай хүчний салбар, нэгжийг оролцуулах болон хуулиар тогтоосон эрх зүйн үндэслэл болсон байна.

Гадаад цэргийн хүчнийг байрлуулах, дамжин өнгөрүүлэх ямарч тохиолдолд Үндсэн хуулийн Дөрөвдүгээр зүйлийн 3-т заасны дагуу болон Гадаад цэргийн хүчнийг байрлуулах, дамжин өнгөрүүлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т заасны дагуу бие даасан хууль гаргаж байхаар хуульчилсан бөгөөд үүгээр Засгийн газар эрх мэдэн шийдэж чадахгүй байх бөгөөд хууль тогтоогч эцэслэн шийдвэр гаргана.

5.1. Хууль тогтоомжийн зохицуулалт, хэрэгжилт

Энэхүү судалгааны хүрээнд Үндсэн хууль болон Гадаад цэргийн хүчнийг байрлуулах, дамжин өнгөрүүлэх тухай хуулийн холбогдох заалтыг хэрхэн хэрэгжүүлж буйд шинжилгээ хийж дүгнэлт хийхийг зорив.

Гадаад цэргийн хүчнийг байрлуулах, дамжин өнгөрүүлэх тухай хуулиар "*Гадаадын цэргийн хүчин*" гэж орон тооны бие бүрэлдэхүүн, зэвсэг, байлдааны болон тусгай зориулалтын техник хэрэгслээр хангагдсан НҮБ, олон улсын бусад байгууллага, гадаад улсын зэвсэгт хүчний харьяалал бүхий цэргийн зохион байгуулалттай бүлэг, салбар, анги, нэгтгэл, байгууллагыг/ ГЦХБДӨТХ-ийн 3.1/ ойлгохоор бол "*Гадаадын цэргийн хүчнийг байрлуулах*" гэж энэ хууль, Монгол Улсын олон улсын гэрээний дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын цэргийн хүчнийг оруулан байрлуулж, тодорхой үүрэг гүйцэтгүүлэхийг /ГЦХБДӨТХ-ийн 3.2/ ойлгохоор хуульчилсан байна.

Харин үүрэг гүйцэтгэх гэдгийг цэргийн хүчний уламжлалт бөгөөд үндсэн үүргийг ойлгохоос гадна мөн НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаа болон олон улсын бусад ажиллагаанд хамааруулан ойлгож болно. Тухайлбал, Цэрэг, цагдаагийн албан хаагчдыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай хуулиар /3.1.3 -т/ "НҮБ-ын энхийг сахиулах, олон улсын бусад ажиллагаанд оролцох" гэдгийг тодорхойлохдоо цэрэг, цагдаагийн албан хаагч сайн дурын үндсэн дээр томилогдон хилийн чанадад үүрэг гүйцэтгэхийг ойлгохоор хуульчилжээ.

Мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаа гэдэгт "энх тайван, тогтвортой байдлыг сахин хамгаалах, бэхжүүлэх зорилгоор зохион байгуулж байгаа олон үндэстний цэрэг, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанаас" /ЦЦАХНҮБЭСБОУБАОТХ-ийн 3.1.1/ гадна "олон улсын холбогдох байгууллага, аливаа улсын санаачилгаар зохион байгуулж байгаа энхийг сахиулах төрөл бүрийн сургалт, дадлага, цэргийн хээрийн сургууль; гамшиг, ослын хор уршгийг арилгах, авран хамгаалах болон хүмүүнлэгийн олон улсын үйл ажиллагааг" /ЦЦАХНҮБЭСБОУБАОТХ-ийн 3.1.2/ ойлгохоор байна.

Иймд Монгол Улсын нутаг дэвсгэрд дээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцон үүрэг гүйцэтгэж буй гадаад зэвсэгт хүчний харьяалал бүхий цэргийн болон бусад бүрэлдэхүүнийг байрлуулах тухай шийдвэрийг Гадаад цэргийн хүчнийг байрлуулах, дамжин өнгөрүүлэх тухай хуулиар УИХ тус бүрт хууль хэлбэрээр гаргаж байхаар зохицуулсан байна. Өөрөөр хэлбэл, манай улсын нутаг дэвсгэр дээр зохион явагдаж буй олон улсын цэргийн хээрийн дадлага, сургуулийг тус бүрт нь батлан гаргаж байсан Гадаад цэргийн хүчнийг зохих хугацаагаар байрлуулах тухай хуульд үндэслэн зохион байгуулах эрх зүйн зохицуулалттай байна.

Мөн түүнчлэн Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн улсын хувьд НҮБ-ын дүрмийн 43 дугаар зүйлийн дагуу ... олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахиулах үйл хэрэгт хувь нэмрээ оруулахын тулд Аюулгүйн Зөвлөлийн шаардсанаар ... нутгаар нь дамжин өнгөрөх эрх олгох зэрэг үйлчилгээний холбогдох арга хэмжээ авах үүрэг хүлээнэ.

Мөн энэ асуудлыг бусад хуульд дараах байдлаар тусгасан байна:

Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд гадаадын цэрэг цагдаагийн тусгай хүчний салбар, нэгжийг мөн адил хууль батлан гаргасны үндсэн дээр оруулан байршуулан оролцуулж болох тухай зохицуулалтын Терроризмтой тэмцэх тухай 2004 оны хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т зохицуулсан байна.

Энэ хуулийг 1998 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр баталсан байх бөгөөд өнөөдрийг хүртэл энэ хуульд нэмэлт, өөрчлөлт хийгээгүй байна.

Харин нь энэ асуудал амьдрал дээр хэрхэн хэрэгжиж байгааг судлан шинжлэх боломжгүй байв. /УИХ-ын Тамгын газрын хөтөлдөг Монгол Улсын хуулийн жагсаалтад огт байхгүй байв/

Монгол Улс "Дархан", "Хааны эрэлд" гэх зэрэг энхийг сахиулах ажиллагааны хээрийн сургалт, дадлагыг хэд хэдэн удаа өөрийн нутаг дэвсгэр дээр зохион явуулсан бөгөөд эдгээр ажиллагаанд ОХУ, АНУ, Ази номхон далайн бүс нутгийн 10 гаруй улсын цэргийн бие бүрэлдэхүүн оролцож, мөн Катар зэрэг улстай хамтарч хээрийн дадлагыг өөрийн нутаг дэвсгэр дээр зохион явуулсан байна.

5.1.1. Хууль тогтоомжийн хийдэл, зөрчил, даөхцал

Гадаад цэргийн хүчнийг байрлуулах, дамжин өнгөрүүлэх тухай хуулийн бичвэрт дүн шинжилгээ хийж дараах зөрчил, хийдэлтэй байна гэж үзэж байна:

а/ энэ хуулийн нэр томъёо хэсэгт 3.1-т "Гадаадын цэргийн хүчин"-г томьёолохдоо НҮБ, олон улсын бусад байгууллага, гадаад улсын зэвсэгт хүчний харьяалалтай гэсэн нь НҮБ-ын хувьд хэрхэн оновчтой буйд судалгаатай хандмаар байна. Учир нь НҮБ нь өөрийн гэсэн зэвсэгт хүчингүй.

b/ 4.1.2-т Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийг 10 дугаар зүйлд тусгагдсан Монгол Улсын олон улсын гэрээнээс хэт өргөн утгатайг анхаарах.

с/ 5.1-т дайсагнагч талууд манай улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд аюул занал учруулаагүй бол тэдгээрийн аль нэгний цэргийн хүчнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлуулах, дамжин өнгөрүүлэхийг хориглоно гэсэн нь логик алдаатай байна.

Энд дайсагнагч л бол ямар ч тохиолдолд байрлуулах, дамжин өнгөрүүлэхийг хориглох нь зохимжтой.

d/ нэгэнт Монгол Улс Үндсэн хуулиараа энхийг эрхэмлэсэн гадаад бодлогыг явуулах /Аравдугаар зүйлийн 1-т/ бол 5 дугаар зүйлд мөн шинээр "аливаа гадаад улс руу түрэмгийлэх зорилго бүхий гадаадын зэвсэгт хүчнийг" нутаг дэвсгэр дээр байрлуулах, дамжин өнгөрүүлэхийг хориглох нь зохимжтой.

е/ 7 дугаар зүйлийн 7.1-ийн өгүүлбэрийн эхэнд "Үндсэн хууль," гэж нэмэх. Учир нь олон улсын гэрээ нь тэргүүн ээлжид манай улсын Үндсэн хуульд нийцэж байж /Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 4/ бид түүнийгээ дагаж мөрдөнө.

5.2. МОНГОЛ УЛС ӨӨРИЙГӨӨ ХАМГААЛАХ ЗЭВСЭГТ ХҮЧИНТЭЙ БАЙХ, ТҮҮНИЙГ ЭНХИЙГ САХИУЛАХ БОЛОН ОЛОН УЛСЫН БУСАД АЖИЛЛАГААНД ОРОЛЦУУЛАХ АСУУДАЛ

5.2.1.Хууль тогтоомжийн зохицуулалтын үзэл баримтлал, хэрэгжилт

Монгол Улсын Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлийн 2-т өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчинтэй байна гэсэн нь Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу Монгол Улсын Төрийн бүрэн эрхт байдлын тулгуур болох тусгаар тогтнолын үндэс, Монгол төрийн энх тайванч гадаад бодлогын хийгээд үндэсний аюулгүй байдлыг хангах чухал баталгаа юм.

Үндсэн хуулийн энэ заалттай 2002 оны Цэрэг, цагдаагийн албан хаагчдыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай хууль концепцийн хувьд хэрхэн нийцэж буйд дүгнэлт өгөхийг зорив.

Үндсэн хуулийн холбогдох заалтын агуулга дэлхийн орчин үеийн хандлагыг агуулах ба өөрийн тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор л зэвсэгт хүчинтэй байна. Энэ нь нэг талаас зөрчилдөж буй мэт боловч олон улсын эрх зүйн үүднээс шинжилж үзвэл зөрчлийн асуудал огт хөндөгдөхгүй байна. Өөрөөр хэлбэл, олон улсын эрх зүйн үндсэн зарчмын нэг болох Хуч ул хэрэглэх, хүчээр заналхийлэхгүй байх зарчим нь агуулгын хувьд олон улсын хамтын нийгэмлэгийн гишүүн бүрэн эрхт улс болгон зөвхөн өөрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор зэвсэгт хүчинтэй байхаас биш ардчилсан нийгэмд аливаа түрэмгийлэх санаа агуулж зэвсэгт хүчинтэй байж болохгүй.

Харин хүйтэн дайнаас хойш үндэсний аюулгүй байдлыг хангах "аюулгүй байдлын хамтын хамгаалалт" хөгжиж ирсэн. Өнөөдөр бүс нутаг, тив хязгаараар хамтын хамгаалалт хэлбэрээр хүн төрөлхтний, тэр дундаа гишүүн улс өөрийн энх тайван, аюулгүй байдлыг хангах бодлого баримталж байна. Тухайлбал, ТУХН, ЕХ, ШХНБ, НАТО, НҮБ гэх зэрэг байгууллага, холбоо, эвсэл, нэгдлийн зорилгын тэргүүлэх чиглэлийн нэг бол яах аргагүй энэ асуудал болоод байна.

Аливаа "жижиг улс"-ын өөрийгөө хамгаалах чадвар нь бага байх нь ойлгомжтой бөгөөд эдгээр улс өөрийгөө хамгаалах аргыг газар зүй, улс төр, эвсэл, нэгдлийн бодлогын хүрээнд бусад улстай хамтарч, эсхүл нийтийн аюулгүй хамгаалалтад багтахыг зорьдог.

Харин үндэсний аюулгүй байдал өнөөдөр зөвхөн газар зүйн хил хязгаараар биш мөн хилийн чанад дахь ашиг сонирхол, заналхийллээр хэмжигдэж байна.

Монгол Улсын хувьд УИХ-ын 56 дугаар тогтоолоор 1994 оны 6 дугаар сарын 30-ны өдөр баталсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын Үндэсний аюулгүй байдлыг хангах арга зам, баталгаа гэх гуравдугаар хэсгийн 13-т "... Олон улсын баталгааг дангаар, хоёр болон олон талын арга хэмжээг хослуулан авах замаар буй болгож бэхжүүлнэ. Цэрэг-

улс төрийн аюулгүй байдлын баталгааг хамтын хүчээр аюулгүй байдлыг хангах тогтолцоо бүрдүүлэх, оролцох замаар хангана" гэж үндэсний аюулгүй байдлыг хангах арга зам, баталгааг тогтоосон байна.

Монгол Улсын "өөрийгөө хамгаалах" зэвсэгт хүчин нь хилийн чандад үүрэг гүйцэтгэхийг ийнхүү тайлбарлаж болохын зэрэгцээ Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 1-д тунхагласан Монгол Улс энхийг эрхэмлэсэн гадаад бодлогыг явуулна" гэсэн заалт, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын нэгдүгээр бүлгийн Үндэсний аюулгүй байдлыг хангах арга зам, баталгаа гэх 3 дугаар хэсгийн 10-т "Үндэсний аюулгүй байдлыг ... цэрэг, тагнуул, хууль зүйн аргаар дангаар буюу олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар хангана", Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдал гэх хоёрдугаар бүлгийн Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдлыг хангах арга зам гэх 23 дугаар заалтын 2.1-д Монгол Улс бусад улс орон, олон улсын байгууллагуудтай цэргийн салбарт хамтран ажиллаж, өөрийгөө болзошгүй түрэмгийллээс урьдчилан сэргийлэх, хамтын хүчээр батлан хамгаалах бодлогодоо хөрш зэргэлдээ, гурав дахь улс гүрэн, НҮБ-ын болон олон улсын бусад нэгдсэн зэвсэгт хүчнийг ашиглах чиг баримтална гэсэн нь аливаа энхийг сахиулах ажиллагаанд оролцуулах эрх зүйн үндэс болно.

Мөн түүнчлэн Монгол Улс НҮБ-ын гишүүн улсын хувьд НҮБ-ын дүрмийн дагуу хүлээх үүргээ ёсчлон биелүүлэх ёстой байдаг. НҮБ-ын дүрмийн 43 дугаар зүйлд НҮБ-ын бүх гишүүн олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахиулах үйл хэрэгт хувь нэмрээ оруулахын тулд ... олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахиулахад шаардагдах зэвсэгт хүчин гаргаж өгөх, тусламж үзүүлэх ... зэрэг үйлчилгээний холбогдох арга хэмжээ авах үүрэг хүлээнэ.

Ийнхүү Цэрэг, цагдаагийн албан хаагчдыг НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай хуулийн гол зорилго нь НҮБ-ын гишүүн Монгол Улсын зэвсэгт хүчнийг НҮБ-ын дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлэх бөгөөд энэ арга хэмжээнд оролцоход шаардлагатай бэлтгэлийг хангах ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох явдал юм. Энэхүү хууль нь 2002 оны 5 дугаар сарын 17-ны өдөр батлагдан гарсан бөгөөд хүчин төгөлдөр болсноос хойш нэг л удаа нэг заалтад өөрчлөлт оруулсан байна. Тухайлбал, 4.1.5-д Засгийн газрын бүрэн эрхийг тогтоосон Монгол Улсад зохион байгуулах энхийг сахиулах хүчний хээрийн сургуульд оролцох гадаад орны томилгоот бүрэлдэхүүний агсамж, нормт хангалтын зүйл, тээврийн хэрэгсэлд хил, гаалийн шалгалт хийх, навигацийн болон бусад үйлчилгээний "хялбарчилсан журам" гэснийг "журам" болгон өөрчлөлт оруулсан байна. Энэ өөрчлөлтийг 2008 оны 5 дугаар сарын 20-ны өдөр буюу Гаалийн тухай /шинэчилсэн найруулга/ Монгол Улсын хууль баталсантай холбогдуулж баталжээ.

5.2.2. Хууль тогтоомжийн хийдэл, зөрчил, давхцал

Цэрэг, цагдаагийн албан хаагчдыг НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай хуульд дүн шинжилгээ хийж дараах зөрчил, хийдэлтэй байна гэж үзэж байна:

а/ хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4-т Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрхэд энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагааны хээрийн сургууль, дадлагыг өөрийн оронд зохион байгуулах бүрэн эрхийг хэрэгжүүлэх хуульчилсан байна. Харин энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаа гэдэгт "энх тайван, тогтвортой байдлыг сахин хамгаалах, бэхжүүлэх зорилгоор зохион байгуулж байгаа олон үндэстний цэрэг, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа" болон "олон улсын холбогдох байгууллага, аливаа улсын санаачлагаар зохион байгуулж байгаа энхийг сахиулах төрөл бүрийн сургалт, дадлага, цэргийн хээрийн сургууль; гамшиг, ослын хор уршгийг арилгах, авран хамгаалах болон хүмүүнлэгийн олон улсын үйл ажиллагаг" ойлгохоор байна. Мөн түүнчлэн 3.1.3-д "НҮБ-ын энхийг сахиулах, олон улсын бусад ажиллагаанд оролцох" гэдгийг цэрэг, цагдаагийн албан хаагч сайн дурын үндсэн дээр томилогдон хилийн чандад үүрэг гүйцэтгэхийг ойлгохоор тодорхойлсон байна. Иймд манай улсын нутаг дэвсгэр дээр зохион явуулж буй энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагааны хээрийн сургууль, дадлагад монгол цэргийн бүрэлдэхүүн оролцох боломжгүй мэт ойлгогдож байна. Харин уг хуулийн 6.1.1, 6.1.2-т Батлан хамгаалах болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гүшүүний бүрэн эрхэд энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах бие бүрэлдэхүүнийг томилох, оролцуулах бүрэн эрх багтсан байна.

b/ Энэ хуулийн 4.1.1, 4.1.3-т заасан шийдвэр гаргах журмыг нэг мөр болгох, эсхүл дараалыг тогтоох шаардлагатай. Мөн Батлан хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9-д УИХ мөн ...өөрийн цэргийн анги, салбарыг олон улсын энхийг сахиулах болон хүмүүнлэгийн ажиллагаанд оролцуулах асуудлыг шийдвэрлэнэ, Зэвсэгт хүчний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т УИХ зэвсэгт хүчний анги, салбарыг энхийг сахиулах олон улсын хамтын ажиллагаанд оролцуулах шийдвэр гаргах гэж хуульчилжээ.

с/ хуулийн зарим нэр томъёо, найруулгыг жигдлэх

Тухайлбал, 4.1.6-д "энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаа" гэсэн байхад 4.1.7-д "энхийг сахиулах, олон улсын бусад ажиллагаа" гэсэн байна. /энэ байдал энэ хууль болон журмын хувьд нийтлэг байна/.

Мөн хуулийн нэр томъёоны тодорхойлолтод НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааг тодорхойлсон байхад хуулийн бусад заалтад НҮБ-ын гэх тодотголгүйгээр зүгээр энхийг сахиулах ажиллагаа гэсэн нь нийтлэг байна.

Энэ хуулиас гадна Батлан хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9-д "...өөрийн цэргийн анги, салбарыг олон улсын энхийг сахиулах болон хүмүүнлэгийн ажиллагаанд оролцуулах..., Зэвсэгт хүчний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т ... энхийг сахиулах олон улсын хамтын ажиллагаа ... гэж найруулан хуульчилжээ.

d/ НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагааны хээрийн сургууль, дадлагыг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр зохион байгуулах тохиолдолд зэвсэг, техник, агсамж, нормт хангалтын зүйлд хил, гаалийн шалгалт хийх, бусад үйлчилгээний журмыг тогтоохоор хуульчилсан боловч эдгээрийн болон цэргийн бүрэлдэхүүнд тоо хэмжээг хуульчлан заах

/Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үүднээс цаг хугацааны хувьд нэг дор, нэг улсаас тоо, хэмжээний хязгаарлалт квот тогтоох/ боломжийг судлах.

е/ журмыг тогтоосон эсэх, хуульд нийцэж буй эсэх асуудал

Хуулиар удирдлага, зохион байгуулалттай холбоотойгоор эрх бүхий этгээд тодорхой асуудлаар журам тогтоох бүрэн эрхтэй байна.

Тухайлбал:

- 4.1.5-д зааснаар Засгийн газар Монгол Улсад зохион байгуулах энхийг сахиулах хүчний хээрийн сургуульд оролцох гадаад орны томилгоог бүрэлдэхүүний агсамж, нормт хангалтын зүйл, тээврийн хэрэгсэлд хил гаалийн шалгалт хийх, навигацийн болон бусад үйлчилгээний журам:

2004 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн Засгийн газрын 32 дугаар тогтоолоор "Энхийг сахиулах хүчний хээрийн сургуульд оролцох гадаад орны томилгоот бүрэлдэхүүний агсамж, нормт хангалтын зүйлс, тээврийн н хэрэгсэлд хил, гаалийн хялбарчилсан шалгалт хийх, навигацийн болон бусад үйлчилгээний журам" баталсан. Энэ журам нь дөрвөн хэсэг 16 заалт бүхий зохицуулалттай.

Энэ журам нь Цэрэг, цагдаагийн албан хаагчдыг Нэгдсэн Үндэстний байгууллагын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай хуульд <u>үндэслэсэн</u> байх бөгөөд энэ хуультай бүрэн <u>нийцэж</u> байна.

- 4.1.6-д зааснаар Засгийн газар энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллгаанд оролцох бие бүрэлдэхүүний агсамж, хангалтын төрөл тэдгээрийн хэмжээ, олгох журам:

Засгийн газрын 2003 оны 88 дугаар тогтоолын хавсралтаар "Энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцох бие бүрэлдэхүүний агсамж, хангалтын төрлийг тогтоох, олгох журам" баталсан байх бөгөөд энэ журам нь ерөнхий зохицуулалт бүхий 7 заалттай байна.

Энэ журмаар бие бүрэлдэхүүний агсамж, хангалтад заавал байх болон нэмэлт хэрэгслийн төрөл, хэмжээний жагсаалтыг Зэвсэгт хүчний Жанжин штаб, Цагдаагийн Ерөнхий газар, Улсын иргэний хамгаалалтын газрын саналыг үндэслэн Батлан хамгаалах болон Хууль зүйн асуудал эрхэлдэг Засгийн газрын гишүүд хамтран батална.

Энэ журам нь Цэрэг, цагдаагийн албан хаагчдийг Нэгдсэн Үндэстний байгууллагын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай хуульд <u>үндэслэсэн</u> байх бөгөөд энэ хуультай бүрэн <u>нийцэж</u> байна.

- 4.1.7-д зааснаар Засгийн газар энхийг сахиулах, олон улсын бусад ажиллагаанд бэлтгэх, оролцох асуудлыг зохицуулах үүрэг бүхий зөвлөлийг мэргэжлийн байгууллагын төлөөлөлтэйгөөр шаардлагатай үед байгуулж, ажиллах журам:

"Цэрэг, цагдаагийн багийг НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд бэлтгэх, оролцуулах асуудлыг зохицуулах үүрэг бүхий зөвлөлийн бүрэлдэхүүн"-ийг 1 дүгээр, "Цэрэг, цагдаагийн багийг НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд бэлтгэх, оролцуулах тухай

асуудлыг зохицуулах зөвлөлийн ажиллах журам"-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталж 1 дүгээр хавсралтаар баталсан Зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2005 оны 66 тогтоолоор хүчингүй болгож, Засгийн газрын 2005 оны 66 дугаар тогтоолын 15 дугаар хавсралтаар Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинээр баталсан байна.

Энэ журам нь Цэрэг, цагдаагийн албан хаагчдыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай хуульд <u>үндэслэсэн</u> байх бөгөөд энэ хуультай бүрэн <u>нийцэж</u> байна.

- 6.1.4-т зааснаар <u>Батлан хамгаалахын болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн</u> энхийг сахиулах, олон улсын бусад ажиллагаанд оролцуулах бие бүрэлдэхүүнийг сургаж бэлтгэх, сонгох, үүрэг гүйцэтгэх журам:

Энэ журмыг 2004 оны 2 дугаар сарын 5-ны өдөр Батлан хамгаалахын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан №23/24 тоот тушаалаар баталж ХЗДХЯ-д 2441 дугаараар бүртгүүлсэн байна. Тушаалын 1 дүгээр заалтаар журмыг баталсан байх бөгөөд энд баталсан журмын нэр болон хавсарсан журмын нэр өөр байна. Тухайлбал, "<u>НҮБ-ын</u> энхийг сахиулах ажиллагаа", "энхийг сахиулах ажиллагаа" гэсэн байна. Харин журмын 2 дугаар заалтад "НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааг" товчлон "энхийг сахиулах ажиллагаа" гэж ойлгохоор заажээ. Энэ журам нь Цэрэг, цагдаагийн албан хаагчдыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай хуульд <u>үндэслэсэн</u> байх бөгөөд энэ хуультай бүрэн <u>нийцэж</u> байна.

Монгол Улс 1999 оноос эхлэн "Баланс межик", "Центр-Азбат-2000" олон улсын цэргийн хээрийн сургуульд оролцон 2001 онд Зэвсэгт хүчнээс НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаа /ЭСА/-нд оролцуулах бэлтгэлийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд Зэвсэгт хүчний Жанжин штабын Энхийг сахиулах албыг хэлтэс болгон өргөжүүлжээ. Үүнээс хойш Зүүн хойд Азийн бүс нутгийн орнуудын ЭСА /2002 он/, Бангладеш Улсад ЭСА-ны "Энхийн элч" /2003 он/ сургуульд оролцож Конго болон Баруун Сахарт ажиглагчаар үүрэг гүйцэтгэж /2003 он/, "Иракийн эрх чөлөө" /2003 он/, Афганистанд сургалтанд цэргийн баг илгээж /2003 он/, гэрээт цэргүүдийн анх оролцсон "Энхийн үйлс" /2004 он, Шри-Ланка Улс/, Ирак дахь үүрэг гүйцэтгэх ажиллагаа, Аюулгүйн Зөвлөлийн ЭСА-ны олон улсын сургалт /2003 он, Монгол Улс/, "Core tunder" ажиллагаа /2004 он, АНУ/, НҮБ-ын мандаттай ажиллагаа /2005 он, Сьерра Леон, Косово/, НҮБ-ын Олон улсын үндэсний штаб /2005 он/, "Нүүдэлчин заан", "Анадолу-2007", "Энхийн элч-Бангладеш, 2008", "Дархан", "Хааны эрэлд", гэх зэрэг энхийг сахиулах ажиллагааны хээрийн сургалтад оролцож, зохион байгуулж, Конго, Сахар, Судан, Этиоп, Эритрей, Гүрж зэрэг улсад ажиглагчаар, Ирак, Сьерра-Лион, Афганистан, Чадад үүрэг гүйцэтгэж энхийг сахиулах ажиллагаанд идэвхтэй оролцож иржээ.

__oOo__

ХАВСРАЛТ 1

БАТЛАН ХАМГААЛАХ ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БҮРЭН ЭРХ

Шалгуур үзүүлэлт	Батлан хамгаалах тухай хууль	Зэвсэгт хүчний тухай хууль	Үндэсний аюулгүй байдлын тухай хууль	Дайны байдлын тухай хууль	Онц байдлын тухай хууль	ИЦҮБЦАХ ЭБТХ	УХТХ	ДЦТХ
Ерөнхийлөгчийн бүрэнэрх/Ерөнхий командлагчийн хувьд бусасуудлыг тусд нь/	**7 дугаар зүйл. Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрх** 1.Монгол Улсын Ерөнхийлөгч Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хувьд Ерөнхийлөгчийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан бүрэн эрхээс гадна дараахь тодорхой бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 1/Монгол Улсын Төрийн цэргийн бодлогын хэрэгжилт, улс орныг батлан хамгаалахад зайлшгүй шаардагдах материаллаг нөөцийн бүрдүүлэлтэд хяналт тавих; */Энэ заалтыг 2002 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/* 2/ батлан хамгаалах арга хэмжээний	**13 дугаар зүйл. Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрх** 13.1. Монгол Улсын Ерөнхийлөгч зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хувьд Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн тухай хуульд заасаас гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 13.1.1. зэвсэгт хүчний тайван цагийн болон дайны байдлын үеийн зохион байгуулалтын бүдүүвчийг батлах; 13.1.2. зэвсэгт хүчнийг дайнд ашиглах төлөвлөгөөг баталж, цэргийг байлдааны бэлэн байдлын дээд	8.2. Монгол Улсын Ерөнхийлөгчнь Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүний хувьд Үндсэн хууль, бусад хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангаж, үндэсний аюулгүй байдлыг	**13 дугаар зүйл. Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрх** 13.1. Дайны байдалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: Тайван цагт: 13.1.1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын хороо, Цэргийн дээд командлалын газрын бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн тухай саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; 13.1.2. улс орныг дайны байдалд шилжүүлэх ерөнхий төлөвлөгөөний талаар Улсын Их Хуралд санал, дүгнэлт оруулах; 13.1.3. зэвсэгт хүчийг бэхжүүлэх талаар Засгийн газарт чиглэл өгөх; 13.1.4. улсын болон цэргийн дайчилгааны	**5 дугаар зүйл.Онц байдал зарлах** 3.Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл Улсын Их Хурлын чуулганы чөлөө цагт бий болсон бөгөөд үйл явцын өрнөлт нь онц байдал нэн даруй зарлахыг шаардаж байгаа хойшлуулшгүй тохиолдолд Монгол Улсын Ерөнхийлөгч Онц байдал зарлах тухай зарлиг гаргана. 5.Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2-т заасан үндэслэлээр онц байдал зарлахын өмнө Улсын Их			

	төсвийн талаар Улсын Их Хуралд санал дүгнэлт оруулах; 3/ цэргийн нийтлэг дүрмүүдийг батлах; */Энэ заалтыг 2002 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/* 4/ цэргийн албан хаагчид цэргийн цол олгох журмыг тогтоох;" */Энэ заалтыг 2002 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/* 5/ цэргийн дүрэмт хувцас, цол, ялгах тэмдгийн загвар батлах; 6/ онцгой нөхцөл бий болсон үед байлдагч, түрүүчийн алба хаах хугацааг гурван сараас дээш хугацаагаар сунгах саналыг Улсын Их Хуралд оруулах. **2. Монгол Улсын Ерөнхийлөгч хуульд заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.**	зэргүүдэд шилжүүлэх, байлдааны ажиллагаа эхлэх шийдвэрийг холбогдох хууль тогтоомжийн дагуу гаргах; 13.1.3. зэвсэгт хүчнийг дайны байдлын үеийн бүтэц, зохион байгуулалтад шилжүүлэх шийдвэр гаргах; 13.1.4. зэвсэгт хүчнийг ашиглах номлолыг батлах; 13.1.5. зэвсэгт хүчний Жанжин штабын дүрмийг батлах; 13.1.6. зэвсэгт хүчний Жанжин штабын даргыг Улсын Их Хуралтай зөвшилцөн томилох; 13.1.7. улсын хил, онц чухалобьектынхамгаалалтад ерөнхий зориулалтын цэргээр дэмжлэг үзүүлэх шийдвэр гаргах; 13.1.8. зэвсэгт хүчний анги, байгууллагыг аж ахуй, бүтээн байгуулалтын ажилд оролцуулах журмыг тогтоох; 13.1.9. хуульд заасан бусад бүрэн эрх.	хангах асуудлаар холбогдох байгууллагуудын ажилтай танилцаж, чиглэл өгнө.	материаллаг нөөцийн бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавих. Дайны байдлын үед: 13.1.5. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын хороо, Цэргийн дээд командлалын газрыг тэргүүлэх; 13.1.6. дайны байдал зарлахад хүргэсэн нөхцөл байдал өргөжин гүнзгийрүүлэхгүй байхад чиглэсэн арга хэмжээ авах; 13.1.7. Цэргийн дээд командлалын газрын бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх саналыг Үндэсний аюулгүй байдлын хороонд оруулах; 13.1.8. дайны байдлын үед зэвсэгт хүчний гүйцэтгэх үүргийг тодорхойлон түүнийг хэрэглэх төлөвлөгөөг баталж, зэвсэгт тэмцлийг ерөнхий удирдлагаар хангах. 13.2. Монгол Улсын Ерөнхийлөгч хуульд заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.	Хурал, түүний чөлөөт цагт Монгол Улсын Ерөнхийлөгч нийтийн эмх замбараагүй байдал бий болгосон, түүнд оролцсон байгууллага, хүмүүст уг үйлдлээ 12 цагийн дотор таслан зогсоохгүй бол онц байдал тогтоож болохыг урьдчилан сануулна. Хэрэв заасан хугацаанд уул онцгой нөхцөл хэвээр үргэлжилбэл энэ зүйлийн 1, 2, 3 дахь хэсэгт заасны дагуу онц байдал зарлана.			

www.nli.gov.mn

ХАВСРАЛТ 2

БАТЛАН ХАМГААЛАХ ТАЛААРХ ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭН ЭРХ

Үндэсний аюулгүй байдлын тухай хууль	Дайны байдлын тухай хууль	Онц байдлын тухай хууль
15.2. Зөвлөл нь үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны зохицуулалт, хэрэгжилтэд хяналт тавина. 15.3. Зөвлөлөөс үндэсний аюулгүй байдал хэрхэн хангагдаж буй талаар Улсын Их Хуралд жилд нэгээс доошгүй удаа мэдээлж байна. 17.1. Үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн бодлого, үйл ажиллагаат төрийн нэгдмэл бодлогод нийцүүлэн уялдуулан зохицуулах чиг үүргийг Зөвлөл хэрэгжүүлнэ. 17.2. Зөвлөл нь энэ хуулийн 17.1-д заасан чиг үүргийн хүрээнд дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 17.2.1. үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаат уялдуулан зохицуулах асуудлаар холбогдох байгууллагад чиглэл өгөх; 17.2.2. шаардлагатай мэдээллийг төрийн байгууллага, албан тушаалтнаар гаргуулан авах. 17.3. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан чиг үүргээ хэрэгжүүлэх, Зөвлөлийн шийдвэр болон түүний гишүүдээс өгсөн чиглэлийн дагуу үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаат уялдуулан зохицуулах	**14 дүгээр зүйл. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын хороо** 14.1. Монгол Улсын Их Хурал дайны байдал зарламагц Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг өргөтгөн Үндэсний аюулгүй байдлын хороог байгуулна. 14.2. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын хороо нь дайны байдлын үеийн засаглалын бүрэн эрх бүхий захиргааны удирдлагын онцгой дээд байгууллага бөгөөд батлан хамгаалах бодлогын хэрэгжилтийг хариуцна.	**8 дугаар зүйл.Онц байдал тогтоосон шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах байгууллага** 1.Онц байдал тогтоосон шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах онцгой чиг үүргийг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл/цаашид "Зөвлөл" гэх/ эрхлэн гүйцэтгэнэ. 2.Улсын Их Хурал Зөвлөлийн тэргүүний санал болгосноор онц байдал үргэлжлэх хугацаагаар Зөвлөлийн бүрэлдэхүүнийг өргөтгөж болно. **9 дүгээр зүйл.Онц байдал тогтоосон шийдвэрийг хэрэгжүүлэх талаархи Зөвлөлийн онцгой бүрэн эрх** 1.Зөвлөл онц байдал тогтоосон шийдвэрийг хэрэгжүүлэхдээ дор дурдсан онцгой бүрэн эрх эдэлнэ: 1/онц байдал зарлах тухай Улсын Их Хурлын шийдвэр буюу Ерөнхийлөгчийн зарлигийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулж, явцад нь хяналт тавьж, биелэлтийг хангуулах шаардлагатай арга хэмжээ авах; 2/онц байдал зарлах тухай Улсын Их Хурлын шийдвэр буюу Ерөнхийлөгчийн зарлигийн хэрэгжилтийг холбогдох байгууллагад хянан шалгах, шаардлагатай бол тэдгээрийн удирдлагын илтгэл, мэдээллийг сонсож, үүрэг даалгавар өгөх; 3/шаардлагатай асуудлыг Улсын Их Хуралд оруулж шийдвэрлүүлэх; 4/онц байдал тогтоосон шийдвэрийг хэрэгжүүлэх асуудлаар Засгийн газар,холбогдох бусад байгууллагад заавал биелүүлэх үүрэг даалгавар өгөх; 5/онц байдал тогтоосон шийдвэр, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Зөвлөлөөс өгсөн үүрэг даалгаврыг зохих ёсоор биелүүлээгүй Засгийн газрын гишүүн, Улсын Их Хурал болон Засгийн газарт ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын удирдах албан тушаалтан, аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрхийг онц байдлын хугацаагаар түдгэлзүүлж, орны хүнийг томилох, шаардлагатай гэж үзвэл тэдгээрийг огцруулах тухай асуудлыг эрх бүхий байгууллагад оруулж шийдвэрлүүлэх; 6/онц байдал тогтоосон шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар холбогдох байгууллагаас мэдээ, судалгаа, шаардлагатай бусад баримт бичиг гаргуулан авах; 7/онц байдал үргэлжлэх хугацаанд Зөвлөлийн ажлын аппаратыг бэхжүүлэх асуудлыг шийдвэрлэх; 8/онц байдал тогтоосон нутаг дэвсгэрт Зөвлөлийн бүрэн эрхт төлөөлөгч томилж ажиллуулах;

асуудлаар Зөвлөлийн нарийн бичгийн дарга холбогдох байгууллага, албан тушаалтанд үүрэг даалгавар өгч, биелэлтэд хяналт тавина.		9/шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Зөвсөгт хүчний ерөнхий штаб,цагдаа,тагнуул, хил болон иргэний хамгаалалтын асуудал эрхэлсэн төв байгууллагуудын дарга нарын бүрэлдэхүүнтэй шуурхай штаб байгуулж ажиллуулах; 1О/онцгой нөхцөлийн үр дагаврыг арилгах асуудлаар гадаад улс, олон улсын байгууллагатай харилцах, хамтран ажиллах, туслалцаа авах; 11/онц байдал тогтоосон шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан хуулиар олгосон бусад онцгой бүрэн эрх. 2.Зөвлөл хэлэлцсэн асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэж тогтоол гаргана. Зөвлөлийн тогтоолд Монгол Улсын Ерөнхийлөгч гарын үсэг зурна.Санал зөрвөл Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Энэ тохиолдолд Ерөнхийлөгч зарлиг гаргана. 3.Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 9-д заасны дагуу байгуулагдсан шуурхай штаб онц байдлын үр дагаврыг арилгахад оролцож байгаа цагдаа, тагнуул, цэргийн анги, салбарын өдөр тутмын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж шуурхай удирдлагаар хангах, нийгмийн болон хүн амын амьдралыг хэвийн болгоход эдгээр байгууллагын хүч хэрэглийг дайчлах үүрэг хүлээнэ. 4.Онц байдал тогтоосон нутаг дэвсгэрт байгаа тер, нам, олон нийт, хоршооллын төв, орон нутгийн байгууллага, аж ахуйн нэгж,албан тушаалтан, иргэд онц байдал тогтоосон шийдвэрийг хэрэгжүүлж байгаа төрийн байгууллага, албан тушаалтанд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлж, гаргасан шийдвэр, өгсөн үүрэг даалгаврыг хэлбэрэлтгүй биелүүлэх үүрэгтэй. 5.Онц байдал тогтоосон шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Зөвлөлөөс оруулсан саналыг Улсын Их Хурал хэлэлцэх асуудлын дараалал харгалзахгүйгээр нэн даруй, тэргүүн ээлжинд шийдвэрлэнэ. **12 дугаар зүйл.Онцгой нөхцөл, түүний үр дагаврыг арилгахад цэргийн зарим анги, байгууллагыг татан оролцуулах** 1.Энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан онцгой нөхцөл, түүний үр дагаврыг арилгах, нийгмийн амьдралыг хэвийн болгоход нутгийн захиргааны болон цагдаа, дотоодын цэргийн хүч хэрэгсэл хүрэлцэхгүй байгаа тохиолдолд дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд зэвсэгт хүчин, хилийн цэргийн зарим анги, байгууллагыг татан оролцуулж болно: 1/энэ хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1,2,3,5,6,7, 3 дахь хэсгийн 1,2,3,5,6,7,8,9-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх; 2/онц байдлын үр дагаврыг арилгах, аврах,хамгаалах, сэргээн босгох ажилд оролцуулах. 2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу онц байдлыг хэрэгжүүлэх арга хэмжээнд зэвсэгт хүчин, хилийн цэргийн зарим анги, байгууллагыг татан оролцуулах шийдвэрийг Зөвлөл гаргана. **3.Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд оролцож байгаа зэвсэгт хүчин, хилийн цэргийн анги, байгууллага, тэдгээрийн бие бүрэлдэхүүн үүрэг гүйцэтгэхдээ хууль тогтоомжоор цагдаа, дотоодын цэргэт зөвшөөрөгдсөн зэвсэг, тусгай хэрэгсэл ашиглаж эрх, үүргийг нь эдэлнэ.**

Нийслэлийн хэмжээнд Нийгмийн даатгалын сангаас цэргийн тэтгэвэр авагч иргэдийн тоо[10] /1995-2008/

Тэтгэвр-ийн төрөл /он/		1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008
Тэтгэвэр авагч нийт иргэний тоо		80671	85599	74437	75529	77228	80554	83536	85526	87613	94356	100372	104723	107896	111479
Үүнээс	Өндөр насны тэтгэвэр	5063	5502	3875	3928	4037	5593	5796	6597	6898	7385	7806	8063	8315	8473
	Тахир дутуугийн тэтгэвэр	96	143	1537	1547	1572	210	217	216	210	223	252	216	217	204
	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	99	174	362	428	462	528	575	620	614	642	673	628	611	565
Цэргийн тэтгэвэр авагчдын нийт тоо		5258	5819	5774	5903	6071	6331	6588	7433	7722	8250	8731	8907	9143	9242

[10] Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, Нийслэлийн нийгмийн даатгалын газар, Нийгмийн даатгалын статистикийн эмхтгэл, УБ., 2009 он. 39 дэх тал

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nligov.mn

Нийслэлийн хэмжээнд Цэргийн тэтгэвэр тэтгэмжийг шинээр тогтоолгосон тэтгэвэр авагчдын болон тэтгэврийн эрх зогсоогдсон хүний тоо[11] /1999-2008/

Тэтгэврийн төрөл /он		1999	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008
Шинээр тогтоолгосон хүний тоо	Нийт	4724	5589	5417	6732	6416	8102	10800	9265	8329	8403
	Үүнээс цэргийн албан хаагч	383	478	460	870	617	735	235	618	440	442
Тэтгэврийн эрх зогсоогдсон	Нийт	4235	4604	4338	6764	5963	5174	8595	6107	7509	7149
	Үүнээс цэргийн албан хаагч	283	279	235	323	356	301	261	377	400	412

Хүний эрхийн үндэсний хүрээлэн www.nhrc.gov.mn

[11] Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, Нийслэлийн нийгмийн даатгалын газар, Нийгмийн даатгалын статистикийн эмхтгэл, УБ., 2009 он. 51 дэх тал

ХАВСРАЛТ 3

ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН АСУУДАЛ ХУУЛИУДАД ДАВХАРДСАН БАЙГАА НЬ

	Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль /1994.06.13/	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль /1994.06.07/	Тайлбар
1.	4/ жирэмсний болон амаржсаны тэтгэмж	2 дугаар зүйлийн 2-т жирэмсний болон амаржсаны тэтгэмж	Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн ... дугаар зүйл, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 2.2-т жирэмсний амралтын тухай давхардсан байна.
2.	**Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль /1994.06.13/**	**Нийгмийн даатгалын сангаас олгх тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль /1994.06.07/**	
	11 дүгээр зүйл. Тахир дутуу болсныг тогтоох Цэргийн албан хаагчийн тахир дутуу болсон шалтгаан, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс тогтооно.	**8 дугаар зүйл. Тахир дутуу болсныг тогтоох** 1. Тахир дутуу болсныг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан, хагас /хэсэгчлэн/ алдсан гэж ангилна. 2. Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, түүний хугацааг эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс тогтооно.	
3.		**Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /1994.06.07/**	
	12 дугаар зүйл. Тахир дутуугийн тэтгэврийн хэмжээ 1. Энэ хуулийн 1О дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1,2-т заасан шалтгаанаар тахир дутуу болсон цэргийн албан хаагч /байлдагч, түрүүчээс бусад/-нд тэдний сарын дундаж цалин хөлснөөс хөдөлмөрийн чадвараа 1О хүртэл хувиар алдсан бол 1О хувиар, 1О- аас дээш хувиар алдсан бол хөдөлмөрийн чадвар алдалтын хувиар бодож тахир дутуугийн тэтгэвэр тогтооно. 5. Тахир дутуугийн тэтгэврийн доод хэмжээ нь Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75 хувиас багагүй байна.	**6 дугаар зүйл. Тахир дутуугийн тэтгэврийн хэмжээ** 1. Тахир дутуугийн тэтгэврийг даатгуулагчийн сарын дундаж хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого /цаашид "Хөдөлмөрийн хөлс" гэх/-оос хөдөлмөрийн чадвараа 1О хүртэл хувиар алдсан бол 1О хувиар, 1О-аас дээш хувиар алдсан бол хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээгээр тогтооно. 2. Хөдөлмөрийн чадвараа 30, түүнээс дээш хувиар алдаж тахир дутуу болсон даатгуулагчийн тахир дутуугийн тэтгэврийн хэмжээ нь Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75 хувиас багагүй байна	

7.	**Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль /1994.06.1**	**Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /1994.06.07/**	
	16 дугаар зүйл. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгох хугацаа 1. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг хөдөлмөрийн чадвараа алдсан өдрөөс эхлэн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл тахир дутуу болсон нь тогтоогдох хүртэлх хугацаанд олгоно.	**15 дугаар зүйл. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгох хугацаа** 1. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг хөдөлмөрийн чадвар алдсан өдрөөс эхлэн хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх, эсхүл тахир дутуугийн тэтгэвэр тогтоогдох эрх үүсэх хүртэл хугацаанд олгоно.	
		НДСОТТТХ	
8.	**17[1] дугаар зүйл. Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх** 1.Цэргийн албан хаагч эх жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрхтэй. 2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан эх хүүхдээ 196 хоног тээгэзэд дутуу төрүүлсэн буюу үр хөндүүлсэн, жирэмслэлтийг эмнэлгийн аргаар тасалсан, мөн 196 хоног тээгэзгүй боловч амьдрах чадвартай хүүхэд төрүүлсэн бол жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрхтэй. 3.Цэргийн албан хаагч эмэгтэй хууль тогтоомжид заасны дагуу хүүхэд асрах чөлөөтэй байх хугацаандаа дахин хүүхэд төрүүлсэн бол түүнд жирэмсний болон амаржсаны тэтгэмж олгоно. Энэ тохиолдолд уг эхийн зөвхөн хоёр удаагийн төрөлт хамаарна.	**19[1] дүгээр зүйл. Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх** 1. Тэтгэмжийн даатгалын шимтгэлийг жирэмсний чөлөө авахаас өмнө 12 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн 6 сард нь уг шимтгэлийг тасралтгүй төлсөн даатгуулагч эх жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрхтэй. 2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан тэтгэмжийн даатгалын шимтгэл төлөх хугацааг хангасан даатгуулагч эх, хүүхдээ 196-гаас доошгүй хоног тээгэзэд дутуу төрүүлсэн буюу үр хөндүүлсэн, жирэмслэлтийг эмнэлгийн аргаар тасалсан, мөн 196 хоног тээгэзгүй боловч амьдрах чадвартай хүүхэд төрүүлсэн бол жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрхтэй. 3. Хөдөлмөр эрхэлж байгаад хууль тогтоомжид заасны дагуу хүүхдээ асрах чөлөөтэй байх хугацаанд дахин хүүхэд төрүүлсэн эхэд жирэмсний болон амаржсаны тэтгэмж олгоно. Энэ тохиолдолд уг эхийн чөлөөтэй байсан хугацааны хоёр удаагийн төрөлт хамаарагдана.	
9.	**17[2] дугаар зүйл. Жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн хэмжээ, хугацаа** 1.Цэргийн албан хаагч эхэд сүүлийн 12 сард авсан цалин хөлсний дунджаас 100 хувиар тооцож 4 сарын хугацаанд тэтгэмж олгоно. 2.Жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг ажлын өдрөөр тооцно	**19[3] дугаар зүйл. Жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн хэмжээ, хугацаа** 1. Тэтгэмжийн даатгалд даатгуулж шимтгэл төлсөн хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг болон төрийн албан хаагч эхэд жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 12 сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас 100 хувиар тооцож 4 сарын хугацаанд нийгмийн даатгалын сангаас олгоно. 2. Тэтгэмжийн даатгалд сайн дураар даатгуулсан эхэд жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 12 сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас 70 хувиар тооцож 4 сарын хугацаанд нийгмийн даатгалын сангаас олгоно. 3. Жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг ажлын өдрөөр тооцно.	

__oOo__

ОРОН СУУЦНЫ ТАЛБАЙН ХЭМЖЭЭГ ТОГТООХ АРГАЧЛАЛТАЙ ХОЛБООТОЙ ЭРХ ЗҮЙН АКТЫН СУДАЛГАА[12]

ОРШИЛ

Орон сууцны талбайн хэмжээг тогтоох аргачлал, түүнтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг судлан, тэдгээрийн онол практикийн үндэслэлийг тодорхойлох нь судалгааны ажлын гол зорилго оршино.

Орон сууцны талбайн хэмжээг тогтоохтой холбоотой эрх зүйн актыг судлах судалгааны ажил манай улсад урьд өмнө хийгдэж байгаагүй бөгөөд энэхүү судалгаа нь анхных болж байна. Энэ үүднээсээ уг сэдэв нь судлагдаагүй шинэлэг сэдэв юм.

Түүнчлэн энэ чиглэлээр ном гарын авлага байдаггүй бөгөөд 2009 оноос боловсруулж, 2010 онд Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвөөс гаргасан "Орон сууцны барилгын доторх талбай тооцох аргачлал" нь цаашид салбартаа болон хууль зүйн сургалт, судалгааны хувьд гарын авлага, судалгааны ач холбогдолтой эх сурвалж болох юм.

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ: ХУУЛИЙН ДЭД АКТААР УРЬД ӨМНӨ ЗОХИЦУУЛЖ БАЙСАН БАЙДАЛ:

Дэд бүтцийн сайдын 2001 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 190 тоот тушаалаар баталсан "Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөх норм ба дүрэм", Барилга, хот байгуулалтын сайдын 2006 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 10 тоот тушаалаар батлагдсан "Айлын сууцны хэмжээг тооцох журам", Дэд бүтцийн хөгжлийн сайдын 1998 оны 23 тоот тушаалын нэгдүгээр хавсралтын 4-д заасан "Жилые здания" СНиП 2.08-01-98"/1990.01.01/ нормыг мөрдөж байсан.

Энэ норм Зөвлөлт Холбоот Улсад мөрдөж байсан байна. Дэд бүтцийн сайдын 2001 оны 190 тоот тушаалаар уг нормыг бүхэлд нь орчуулж, мөрдөж эхэлсэн байна.

Дэд бүтцийн сайдын энэхүү тушаалаар баталсан "Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөх норм ба дүрэм" нь Монгол Улсад анх удаа дотоодын хууль, тогтоомжийн актаар зохицуулсан орон сууцны талбайн хэмжээг тооцох аргачлал болсон.

Уг дүрмийн агуулга нь 25 давхар хүртлэх орон сууцны барилгад тавигдах ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага, нарны гэрэлтүүлэг, тусгалын хамаарал, галд тэсвэрлэх чанар зэрэг шаардлагуудыг багтаасан байна.

Энэхүү норм ба дүрмийн 2 дугаар хавсралтаар орон сууцны барилгын талбайн хэмжээг тооцох дүрмийг оруулж баталсан байдаг.

2006 оны ЗТБХБСайдын 10 тоот тушаалаар баталсан журмын агуулга нь зөвхөн айлын сууцны талбайн хэмжээг тооцох журмыг тогтоож өгсөнөөрөө Дэд бүтцийн сайдын 2001 оны 190 тоот тушаалаар баталсан "Орон сууцны

[12] Энэхүү судалгааг ХЗДХЯ-ны захиалгаар хийж гүйцэтгэсэн болно.

барилгын зураг төсөл төлөвлөх норм ба дүрэм"-ээс ялгаатай */Зам тээвэр, барилга хот байгуулалтын Сайдын 10 тоот "Журам батлах тухай" тушаал/.*

Судалгааны ажлын сэдвийн хүрээнд дараах ойлголтуудыг хуулиар хэрхэн тодорхойлсныг авч үзвэл:

1."Орон сууц" гэж "Орон сууцны тухай хууль"-ийн 3.1.1-д зааснаар "Хүн суурьшин амьдрах зориулалттай нийтийн болон амины орон сууцны байшин, сууц, гэр";

2."Сууц өмчлөгч" гэж "Орон сууц хувьчлах тухай хууль"-ийн 3 дугаар зүйлийн 6-д зааснаар "нийтийн зориулалттай орон сууцны байшингийн сууц /нэг буюу нэгээс дээш өрөө/ болон тухайн байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийг энэ хуульд заасан журмын дагуу хувьчлан авсан иргэн, түүний гэр бүлийн гишүүд";

3."Өмчлөх эрх" гэж "Монгол Улсын Үндсэн хууль"-ийн 1 дүгээр бүлгийн 5 дугаар зүйлийн 2-т зааснаар "Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална" гэж тодорхойлсон.

Иргэний хуулийн 145.1-д зааснаар "Орон сууцыг дангаар өмчлөх эрх хууль буюу хэлцлийн үндсэн дээр үүснэ" гэж заасны дагуу орон сууцыг захиалан худалдан авч байгаа иргэд барилгын компанитай хэлцэл буюу гэрээ байгуулан орон сууцны төлбөрийг бүрэн төлсний үндсэн дээр орон сууцныхаа өмчлөгч болдог.

Ингэснээр нийтийн зориулалттай орон сууцны өмчлөгч тус бүр дангаар өмчлөх өмчлөлийн зүйл болох өөрийн орон сууцаа хуульд заасан журмын дагуу үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газарт бүртгүүлснээр өмчлөх эрхээ баталгаажуулдаг.

Гэвч сүүлийн үед орон сууцны дангаар өмчлөх талбайн хэмжээг зохих хуульд заасан үндэслэлээр бус дээр дурдсан актуудыг үндэслэн "Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн үндэсний төв" орон сууцны талбайн хэмжээг тодорхойлж байгаа нь иргэдийн өмчлөх эрхийг зөрчих болсон байна.

Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 3-т зааснаар өмчлөгчийн эрхийг зөвхөн хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно гэсэн Үндсэн хуулийн заалт зөрчигдөж байна.

Иргэний хуулийн 146.1-д зааснаар "Дангаар өмчлөх өмчлөлийн зүйлд уг хуулийн

142 дугаар зүйл. Нийтийн зориулалттай орон сууц өмчлөх

142.2.Дангаар өмчлөх өмчлөлийн зүйлд хамаарахгүй орон сууцны барилга, байгууламж, төхөөрөмжийн хэсэг нь орон сууц өмчлөгчдийн дундын өмчлөлд байна.

142.3.Дундын өмчлөлийн эд хөрөнгөөс орон сууц өмчлөгчид ногдох хэсэг нь тэдгээрийн тус тусын өмчлөлд байгаа орон сууцны талбайн хэмжээ, нийт талбайн харьцаагаар тодорхойлогдоно.

142.4.Дангаар өмчлөх өмчлөлд гагцхүү тодорхой хил хязгаар бүхий

тусгаарлагдсан сууцны байр /сууц, өрөө/ болон барилгын тусгаарлагдсан бусад байгууламж хамаарна" гэснээс үзвэл:

Сууцны өрөөний талбай:

Дундын өмчлөлийн зүйлд хамаарахгүй сууцны бус зориулалттай талбай /дангаар өмчлөх өмчлөлийн зүйлд хамаарах сууцны өрөөний сууцны бус зориулалттай талбай нь дангаар өмчлөх өмчлөлийн зүйл болж байна/.

ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭГДСЭН ХЭРЭГ

2007 оны 11 дүгээр сарын 6-ны өдөр Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн 279 тоот шийдвэрээр иргэн А-гийн нэхэмжлэлтэй Барилга, хот байгуулалтын сайдад холбогдох Дэд бүтцийн сайдын 2001 оны 190 тоот тушаалын хавсралтаар баталсан "Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөх норм ба дүрэм"-ийн 1,2,3,5 дугаар заалтуудыг хүчингүй болгуулах нэхэмжлэлийг хянан хэлэлцээд Иргэний хуулийн 147.1, 147.4-ийг үндэслэн нэхэмжлэлийн зарим хэсгийг хангаж, дүрмийн 2 дугаар хавсралт "Орон сууцны нийтийн байрны, сууцны талбай, барилгын эзлэхүүн, барилгажих талбай, барилгын давхрыг тооцох дүрэм"-ийн 1, 2 дугаар заалтыг хүчингүй болгож байсан байна.

Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2008 оны 25 тоот тогтоолын дагуу 2009 оны 2 сарын 12-ны өдрийн Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 35 тоот тушаалаар уг журмын 2.1.1, 2.1.2, 4.1 заалтуудыг, Дэд бүтцийн сайдын 2001 оны 190 тоот тушаалын хавсралтаар баталсан "Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөх норм ба дүрэм"-ийн 1, 2 дугаар заалтуудыг хүчингүй болсонд тооцсон байна.

Дээрх заалтууд нь хүчингүй болсноор уг дүрэм журмын хавсралтаар баталсан айлын орон сууцны талбайн хэмжээг тооцох журмыг мөрдөх боломжгүй болсон. Учир нь:

Эдгээр заалтууд нь тухайн дүрэм журмуудын гол тулгуур заалтууд байсан.

Дэд бүтцийн хөгжлийн сайдын 2001 оны дээрх тушаалын 2 дугаар хавсралтын дүрмийн 1, 2 дугаар */дүрмийн 2.1.1-д "Айлын сууцны талбай" гэж "хүн амьдрах талбай /амралтын, унтлагын, хүүхдийн, ажлын, хооллох өрөө/, туслах өрөө тасалгаа, /гал тогооны, ариун цэврийн, хонгил, ханын шүүгээ, агуулах, угаалгын өрөөнүүд/-ны талбайн нийлбэр байна гэж тодорхойлсон.*

Дүрмийн 2.1.2-т "Айлын сууцны нийт талбай" гэж айлын сууцны талбайгаас гадна лодж, тагт, террас, веранд, /камин зуух, пийшин, баганын болон хаалганы нүхний шалны талбай орохгүй/-ын нийлбэр байна. гэхдээ лоджийн талбайг 0.5, тагт, террасын талбайг 0.3 гэсэн итгэлцүүрээр бууруулан тооцно/ заалт нь Иргэний хуулийн 147 дугаар зүйлийн 147.4 дэх хэсгийн "Дангаар өмчлөх талбайн хэмжээг тодорхойлохдоо, сууц өмчлөгчийн сууцны талбай дээр дангаар өмчлөх сууцны бус зориулалтай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь хэсгийн **"Дангаар**

өмчлөх сууцны талбай, сууцны бус зориулалттай хэсэг" гэж тухайн сууцны гал зуух, ариун цэврийн болон угаалгын өрөө, өрөө хоорондын хонгил, агуулахыг хэлнэ" гэсэн заалтуудыг зөрчсөнийг шүүхээс тогтоосон байна.

Иймд Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын 2009 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 35 тоот тушаалаар дээрх заалтуудыг хүчингүй болгожээ.

Түүнчлэн "Барилгын тухай хууль"-ийн 2.1-д зааснаар "Барилгын хууль тогтоомж нь Үндсэн хууль, Иргэний хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ" гэж хуульчилсан.

Гэтэл Дэд бүтцийн сайдын 2001 оны 7 сарын 6-ны 190 тоот тушаалын хавсралтаар батлагдсан "Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөх норм ба дүрэм"-ийн дараах заалтууд холбогдох хуулийн зохицуулалтуудтай зөрчилдөж байна.

Тухайлбал:

1. Дүрмийн 2.1.1-д "Айлын сууцны талбай нь хүн амьдрах талбай, туслах өрөө тасалгааны /тагт, лодж, веранд, террас, агуулах, ханын шүүгээ, цонхноос бусад/ нийт талбайн нийлбэр байна" гэж сууцны талбайд сууцны бүх өрөө /ажлын, амралтын, гал зуух, ариун цэврийн, угаалгын/ болон өрөө хоорондын хонгил, агуулахын талбай зэргийг хамааруулсан нь:

"Орон сууц хувьчлах тухай хууль"-ийн 16.2-д "Хувьчлах сууцны нийт талбайгаас гал зуух, угаалга, ариун цэврийн болон өрөө хоорондын хонгил, агуулахын талбайг хасч сууцны талбайг тодорхойлно" гэж зохицуулсан.

"Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хууль"-ийн 4.1.4-д "Дангаар өмчлөх сууцны бус зориулалттай хэсэг" гэж тухайн сууцны гал зуух, ариун цэврийн болон угаалгын өрөө, өрөө хоорондын агуулах хонгилыг ойлгоно.

Иргэний хуулийн 147.4-д "Дангаар өмчлөх сууцны талбайн хэмжээг тодорхойлохдоо тухайн сууц өмчлөгчийн сууцны талбай дээр дангаар өмчлөх сууцны бус зориулалттай талбайн гуравны нэгийг нэмнэ" гэснийг тус тус зөрчсөн байна.

2."Айлын сууцны нийт талбай нь өрөө тасалгааны дээрх талбайгаас гадна ханын шүүгээ, лодж, тагт, веранд, террас, сууцны доторх шатны доорх талбай, агуулахын талбай, /зуух байрлах талбай орохгүй/ нийлбэр байна. Гэхдээ байрны нийт талбайг тооцохдоо лоджид 0.5 террас, тагтад 0.3 веранд, хүйтэн агуулахад 1.0 гэсэн бууруулах итгэлцүүр хэрэглэнэ" гэж айлын сууцны нийт талбайд тагт веранд зэргийг оруулсан нь "Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хууль"-ийн 4 дүгээр зүйлээр зохицуулсан дундын өмчлөлийн эд хөрөнгөд тагт, сэрүүн тавцан буюу веранд хамаарна гэснийг зөрчсөн байна.

Өөрөөр хэлбэл, дундын өмчлөлийн эд зүйлд хамаарах эд хөрөнгийг дангаар өмчлөх талбайд оруулан талбайг тооцсон нь "Иргэний хууль"-ийн 142.1, 142.2, 146.2, 147.4 дэх заалтуудтай зөрчилдөж байсан.

142 дугаар зүйл. Нийтийн зориулалттай орон сууц өмчлөх

142.1.Нийтийн зориулалттай орон сууцны барилгын доторх сууц /өрөө/ болон дундын өмчлөлийн зүйлд хамаарахгүй сууцны бус зориулалттай талбайн хэсгийг дангаар өмчилж болно.

142.2.Дангаар өмчлөх өмчлөлийн зүйлд хамаарахгүй орон сууцны барилга, байгууламж, төхөөрөмжийн хэсэг нь орон сууц өмчлөгчдийн дундын өмчлөлд байна .

146 дугаар зүйл. Орон сууцны дангаар өмчлөх болон дундын өмчлөлийн зүйл

146.2.Дангаар өмчлөх талбайд байрлаж байгаа боловч барилгын бат бэх чанар, аюулгүй байдлыг хангахад шаардагдах тэр хэсэг, мөн өмчлөгчдийн дундын ашиглалтад байгаа байгууламж болон бусад төхөөрөмж дангаар өмчлөх өмчлөлийн зүйл болохгүй.

147 дугаар зүйл. Орон сууцны дундын өмчлөлийн зүйлийн төлбөр, зардлыг хуваарилах

147.4.Дангаар өмчлөх талбайн хэмжээг тодорхойлохдоо, сууц өмчлөгчийн сууцны талбай дээр дангаар өмчлөх сууцны бус зориулалттай талбайн гуравны нэгийг нэмнэ гэж зохицуулсан байна.

Өөрөөр хэлбэл сууц өмчлөгчийн дангаар өмчлөх сууцны талбай дээр сууц өмчлөгчдийн дундын өмчлөлийн талбайг нэмж оруулахдаа Иргэний хуулийн 147 дугаар зүйл. Орон сууцны дундын өмчлөлийн зүйлийн төлбөр, зардлыг хуваарилах

147.4.Дангаар өмчлөх талбайн хэмжээг тодорхойлохдоо, сууц өмчлөгчийн сууцны талбай дээр дангаар өмчлөх сууцны бус зориулалттай талбайн гуравны нэгийг нэмнэ гэсэн зохицуулалтыг баримтладаггүй байдал нь маргаан гарах бас нэгэн үндэслэл болж байгаа юм.

2.2 ХУУЛЬ, ДЭД АКТУУДААР ЗОХИЦУУЛСАН БАЙДАЛ

- Иргэний хуулийн 142.3, 147.4;
- Орон сууцны тухай хуулийн 16.2;
- Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 4.1.5-д ерөнхий зохицуулалтуудыг тусгасан.
- "Орон сууцны барилгын доторх сууцны талбай тооцох аргачлал" СТХЗҮЗөвлөлийн 2009 оны 52 тоот тогтоолоор баталан гаргасан.

Орон сууцны талбайн хэмжээг тогтоох аргачлал, түүнтэй холбоотой эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийн байдал

Манай улсад 2010 оны байдлаар айлын орон сууцны талбайн хэмжээг тогтоох аргачлал, түүнтэй холбоотой эрх зүйн зохицуулалтын хэм хэмжээг агуулсан 3 хууль, 1 стандарт хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Үүнд:

- Иргэний хууль;
- Орон сууцны тухай хууль;
- Орон сууц хувьчлах тухай хууль;
- Орон сууцны барилгын доторх сууцны талбай тооцох аргачлал.

Иргэний хуулийн 142, 147 дугаар зүйлүүдэд ерөнхий зохицуулалт тусгагдсан.

ТАВДУГААР ДЭД БҮЛЭГ
НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ОРОН СУУЦ ӨМЧЛӨХ ЭРХ

142 дугаар зүйл. Нийтийн зориулалттай орон сууц өмчлөх

142.1.Нийтийн зориулалттай орон сууцны барилгын доторх сууц /өрөө/ болон дундын өмчлөлийн зүйлд хамаарахгүй сууцны бус зориулалттай талбайн хэсгийг дангаар өмчилж болно.

142.2.Дангаар өмчлөх өмчлөлийн зүйлд хамаарахгүй орон сууцны барилга, байгууламж, төхөөрөмжийн хэсэг нь орон сууц өмчлөгчдийн дундын өмчлөлд байна.

142.3.Дундын өмчлөлийн эд хөрөнгөөс орон сууц өмчлөгчид ногдох хэсэг нь тэдгээрийн тус тусын өмчлөлд байгаа орон сууцны талбайн хэмжээ, нийт талбайн харьцаагаар тодорхойлогдоно.

142.4.Дангаар өмчлөх өмчлөлд гагцхүү тодорхой хил хязгаар бүхий тусгаарлагдсан сууцны байр /сууц, өрөө/ болон барилгын тусгаарлагдсан бусад байгууламж хамаарна.

147 дугаар зүйл. Орон сууцны дундын өмчлөлийн зүйлийн төлбөр, зардлыг хуваарилах

147.2.Орон сууцны цахилгаан болон явган шат, шатны хонгил, сууц хоорондын талбай болон тагт, сууцны доторх дундын ашиглалтын талбай, орцны хаалга, довжоо, цонх, хог зайлуулах хоолойн засвар үйлчилгээтэй холбогдсон, түүнчлэн өөр нийтлэг зардлыг санхүүжүүлэхэд сууц өмчлөгчдийн оролцох хэмжээг тодорхойлохдоо уг зардлыг тухайн орон сууцны нийт сууцны тоонд хуваана.

Өмнөх хэрэгжиж байсан журам зэргээс үзэхэд эдгээр нь Монгол Улсад орон сууцны талбайн хэмжээг тооцохтой холбоотой хууль тогтоомжийн зохицуулалт дутагдмал байгааг харуулж байна.

Гэтэл орон сууцны компаниуд өөрсдөө дур мэдэн стандартын бус аргачлал хэрэглэж байсан дутагдал олноор гарах болсныг иргэд нэхэмжлэлдээ дурдсан байна.

Иргэд үүнтэй холбогдуулан УДШ-д гомдол гаргаж уг журмын тодорхой заалтуудыг хүчингүй болгуулсантай холбогдуулж, шинэ зохицуулалтын акт боловсруулах шаардлагын үүднээс Зам тээвэр, Барилга хот байгуулалтын Яам, Стандартчилал хэмжил зүйн үндэсний төв, Барилга, орон сууцны нийтийн аж ахуйн газрын мэргэжилтнүүд 2009 онд шинэчилэн боловсруулж, стандарт **"Орон сууцны барилгын доторх сууцны талбай тооцох аргачлал MNS 6058:2009"** болгон гаргасан.

Уг стандарт нь агуулгын хувьд өмнө мөрдөгдөж байсан журмын хавсралт болох талбайн хэмжээг хэмжих аргачлал нь өөрчлөгдөөгүй бөгөөд зөвхөн салбарын хүрээнд бус иргэн аж ахуйн нэгжүүд нийтээр заавал дагаж мөрдөх зохицуулалттай хэвээр байгаа юм.

Улсын Мэргэжлийн Хяналтын газрын мэргэжилтэн Б-тэй хийсэн ярилцлагаас үзэхэд, өмнө мөрдөгдөж байсан журмын хувьд Иргэний хуулийн холбогдох заалтуудад /Иргэний хуулийн 147.1, 147.4./ нийцэхгүй байсныг шинээр боловсруулсан стандартаар нийцүүлж, журмын хавсралтаар батлагдаж байсан талбайн хэмжээг тооцох аргачлалыг хэвээр баталсан байна.

Шүүхээр шийдвэрлэгдсэн маргаануудыг авч үзвэл 2004-2008 оны 5 жилийн байдлаар нийт 43007 иргэний хэргээс 47 хэрэг нь орон сууцны талбайн хэмжээг тооцохтой холбогдон гарсан байна.

Эдгээр нэхэмжлэлийг гаргасан субьект нь байрны захиалга өгсөн иргэд бөгөөд нэхэмжлэлийн агуулга нь орон сууцны барилгын компаниуд нь гэрээнд заасан метр квадратаас дутуу буюу эд хөрөнгийн доголдолтой орон сууцыг иргэдэд хүлээлгэн өгч хохироосон гэх агуулгатай. Хариуцагчийн зүгээс хариу тайлбартаа дийлэнх нь Монгол Улсад орон сууцны талбайн хэмжээг тооцох нэгдсэн аргачлал байхгүй гэсэн нийтлэг тайлбарыг өгсөн нь үндэслэлгүй байна. Барилга, хот байгуулалтын сайдын 2006 оны 10 тоот тушаалын хавсралтын 1, 2 дахь заалтад "Монгол Улсын нутаг дэвсгэр дээр орон сууцны барилгыг шинээр барьж, худалдан борлуулах үйл ажиллагаа эрхэлж буй гадаад дотоодын хуулийн этгээд энэхүү журмыг мөрдөнө" гэж заажээ.

Дэд бүтцийн сайдын 2001 оны 190 тоот тушаалаар батлагдсан "Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөх норм ба дүрэм"-ийн хавсралтаар баталсан "Айлын сууцны өрөө, тасалгааны талбайн хэмжилт хийж, түүний борлуулалтын талбайг тогтоосон тэмдэглэл"-д багтсан аргачлалыг нотлох баримтаар үнэлэн авч үзэж, дээрх хэрэг маргаануудыг шүүхээр шийдвэрлэжээ.

Дээрх маргаануудыг шийдвэрлэхэд шинжээчээр оролцсон Мэргэжлийн хяналтын улсын байцаагчид нь энэ аргачлалын дагуу талбайн хэмжилт хийж маргаан таслахад оролцсон байна.

Өмнөх иргэн А-гийн нэхэмжлэл бүхий маргаанаас үзэхэд:

Иргэн А нэхэмжлэлдээ дүрмийн 1,2,3,5 дахь заалтуудыг хүчингүй болгуулахаар дурдсан байсан.

Нэхэмжлэлийг Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн тэнхимд хандсанаар уг хэргийг Улсын Дээд шүүх Дэд бүтцийн сайдын 2001 оны

190 тоот тушаалын хавсралтаар баталсан "Орон сууцны талбайн хэмжээ тогтоох аргачлал" журмын 1, 2 дахь заалт нь Иргэний хуулийн 147.1, 147.2 дахь заалтуудыг зөрчсөн үндэслэлээр хүчингүй болгох шийдвэрийг 2008 оны 2 сарын 20-ны өдрийн 25 тоот тогтоолоор гаргасан нь 2008 оны 2 сарын 25-наас 2010 оны 2 сарын 1-нийг хүртэл зохицуулалтгүй байсан байна.

Эрх зүйн зохицуулалтын хувьд Орон сууц хувьчлах тухай хууль, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулиудад Иргэний хуулийн уг зохицуулалтыг иш татаж хэрэглэсэн.

Барилга, хот байгуулалтын сайдын 2006 оны 2 сарын 15-ны өдрийн 10 тоот тушаалаар баталсан "Айлын орон сууцны талбайн хэмжээг тооцох журам"-аар зохицуулагдаж ирсэн.

Стандартчилал хэмжил зүйн үндэсний зөвлөлийн 2009 оны 12 сарын 24-ний өдрийн 52 дугаар тогтоолоор батлагдсан "Айлын сууцны барилгын доторх сууцны талбай тооцох аргачлал" нь нарийвчилсан зохицуулалт болж байна.

Дэд бүтцийн сайдын 2001 оны 190 тоот тушаалын хавсралтаар баталсан "Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөх норм ба дүрэм" хэрэгжиж байгаа бөгөөд Газрын харилцаа, геодези, зураг зүйн газраас шинэчлэн боловсруулахаар ажиллаж байгаа.

2006 оны Барилга хот байгуулалтын сайдын 10 тоот тушаалаар баталсан "Айлын орон сууцны талбайн хэмжээг тооцох журам" нь Стандартчилал хэмжил зүйн үндэсний зөвлөлийн 2009 оны 12 сарын 24-ны өдрийн 52 дугаар тогтоолоор батлагдсан "Айлын сууцны барилгын доторх сууцны талбай тооцох аргачлал" батлагдан гарснаар ЗТБХБСайдын 2010 оны 4 сарын 7-ны 98 тоот тушаалаар хүчингүй болсон.

2009 онд Стандартчилал хэмжил зүйн үндэсний төв, Газрын харилцаа, Геодези, зураг зүйн газар, Барилга хот байгуулалтын Яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас холбогдох мэргэжилтнүүд томилогдож уг журмыг нийтээр дагаж мөрдөх стандарт болгон гаргаж, Стандартчилал хэмжил зүйн үндэсний төв 2009 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Стандартчилал хэмжил зүйн үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлж, батлан гаргасан. 2010 оны 2 дугаар сарын 1-нээс стандарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

2.2. Цаашид хэрэгжих боломж, нөхцөл:

Стандарт нь Иргэний хууль, Орон сууцны тухай хууль, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулиудад харшилсан зүйл, заалт байхгүй бөгөөд цаашид хэрэгжихэд холбогдох хууль тогтоомжуудтай зөрчилдсөн дутагдалтай зүйл байхгүй байна.

Өмнө мөрдөж байсан дүрэм журмуудыг барилгын байгуулллагууд зөрчих, мөрдөхгүй байх, гэрээнд тусгахдаа иргэдийн мэдлэггүй байдлыг ашиглан хэмжих аргачлалыг өөрчилсөн зэрэг хууль бус үйлдлүүд давтагдах боломж байсаар байна.

22 дугаар зүйл. Барилгын норм, нормативын баримт бичиг

22.1. Барилгын норм, нормативын баримт бичгийг заавал мөрдөнө: /Барилгын тухай хууль; 26.1.2.энэ хуулийн 10, 11, 12, 16, 17, 18, 22 дугаар зүйл, 9.1.1, 9.1.3, 9.1.4, 9.1.5, 13.2, 13.5, 14.1, 14.8, 15.1-д заасан журмыг зөрчсөн иргэнийг 250000-500000, хуулийн этгээдийг 1000000-2000000 хүртэл төгрөгөөр торгох Барилгын тухай хууль/

Хуулийн дээрх заалтуудын хэрэгжилт хангалтгүй байгааг шүүхээр шийдвэрлэгдсэн 47 хэрэг, маргаануудын 26 нь хариуцагч /Барилгын компани/ нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрч эвлэрсэн байдлаар тайлбарлаж болохоор байна.

Иргэд шүүхэд хандахдаа өмнөх журмыг огт мэддэггүй, дутуу ойлголттой байсан, барилгын компаниуд журмыг тайлбарлаж өгдөггүй байсан зэргээр гомдол гаргадаг байсан. Иймд стандартыг сурталчилж, иргэдэд мэдлэг олгож байх нь стандартын хэрэгжилтэд сайнаар нөлөөлж, хэрэгжих баталгаа хангагдах юм.

Уг стандартын 8.2 дахь хэсэгт зааснаар "хэмжилт хийж баталгаажуулах хэсгийн хэмжилтийн зураг, талбайн хэмжээг уг аргачлалын "А" хавсралтын дагуу гаргаж, хуудас бүрийг баталгаажуулна" гэсэн нь стандартыг дагаж мөрдөхөд аль нэг хэсгийг орхигдуулахгүй байх үүргийг барилгын компаниудад өгч байгаагаараа хэрэгжих баталгааг дээшлүүлж өгчээ.

Стандарт нь хэрэгжих боломжтой байна гэж үзэж байна.

Гэхдээ анхаарах нэг асуудал нь уг стандартыг батлан гаргах эрх бүхий этгээдийн хувьд: **Барилгын тухай хуулийн**

22 дугаар зүйл. Барилгын норм, нормативын баримт бичиг

22.2. Норм, нормативын баримт бичгийг барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж мөрдүүлнэ гэсэн заалт бий.

Стандартчилал, хэмжил зүйн үндэсний Зөвлөлийн 2009 оны 12 сарын 24-ний өдрийн 52 дугаар тогтоолоор батлан гаргасан нь дээрх Барилгын тухай хуулийн 22.2 дахь заалтыг **зөрчсөн** байж болохоор харагдаж байна. Иймд зөрчсөн эсэхийг эрх зүйн үүднээс нягтлан үзэх шаардлага байна.

3.Судалгаанд авагдсан шүүхийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийвэл:

Шүүхээс:

Нэхэмжлэлийн шаардлагыг хангасан – 11

Нэхэмжлэлийн шаардлагыг хангаагүй – 5

Нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангасан – 5

Зохигчид шүүхийн шатанд эвлэрсэн захирамж бүхий шийдвэр – 26 гарчээ.

Шүүхийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийж үзэхэд:



- Нэхэмжлэлийн шаардлагыг хангасан 11 шийдвэр бүгд талбайн хэмжээ гэрээнд заасан хэмжээнээс зөрсөн буюу дутсан гэсэн шинжээчийн дүгнэлт гарсан байсан.
- Нэхэмжлэлийн шаардлагыг хангаагүй 5 шийдвэр бүхий хэргүүдэд шинжээчийн дүгнэлтээр талбайн хэмжээ зөрсөн буюу дутсан зүйл гараагүй.
- Нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангасан 5 шийдвэр бүхий хэргүүдэд шинжээчийн дүгнэлтээр талбайн хэмжээ нь нэхэмжлэгчийн нэхэмжилсэн хэмжээнд хүрэхгүй байсан байна.
- Эвлэрсэн шийдвэр бүхий 26 хэргүүдэд шинжээчийн дүгнэлтээр талбайн хэмжээ гэрээнд заасан хэмжээнээс зөрсөн буюу дутсан нь тогтоогдсон боловч хариуцагчийн санаачлагаар эвлэрсэн байна. Мөн сөрөг нэхэмжлэлээр орон сууцны компаниудын байрны дутуу төлсөн төлбөрийн нэхэмжлэлийг иргэд хүлээн зөвшөөрч, эвлэрлийн гэрээ байгуулсан тохиолдол багагүй хувийг эзэлж байна.

Тухайн хэргийн оролцогчид эвлэрсэн үндэслэл нь хариуцагч нэхэмжлэлийн шаардлагын тодорхой хувийг хүлээн зөвшөөрсөн болзолтойгоор эвлэрсэн маргаанууд дийлэнх нь байна. Үүнээс дүгнэж үзвэл:

Орон сууцны барилгын талбайн хэмжээг тооцох дүрэм, журмыг талууд мөрдөж гэрээ байгуулаагүй нь тогтоогдож байна.

Мөн Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын 2008 оны 2 сарын 20-ны өдрийн 25 тоот тогтоолоор Дэд бүтцийн хөгжлийн сайдын 2001 оны 190 тоот тушаалын хавсралтаар батлагдсан "Орон сууцны талбайн хэмжээ тогтоох аргачлал" журмын 1, 2 дахь заалт нь Иргэний хуулийн 147.1 147.2 дахь заалтуудыг зөрчсөн үндэслэлээр хүчингүй болгох шийдвэрийг гаргасантай холбогдуулан ХЗДХЯ-наас нийтээр дагаж мөрдүүлэх хэм хэмжээний акт болох норм, дүрмийн 1, 2 дугаар заалтууд хүчингүй болсон тул шинээр журам батлуулж, Улсын бүртгэлд бүртгүүлэхийг Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яаманд мэдэгдсэн байна.

Талбайн хэмжээг тооцохдоо баримтлах нэгдсэн нэгж хэмжигдэхүүнийг мөрдөж ажиллаагүйгээс гадна гэрээлэгч талууд гэрээнд заасан талбайн талаар ойлголтын зөрүүтэй байх явдал түгээмэл байгааг тэмдэглэх хэрэгтэй. Энэ нь дээрх 47 хэргийн материалыг судалж үзэхэд:

Орон сууцны компаниуд иргэдэд гэрээнд заасан талбайн хэмжээг тайлбарлаж өгдөггүйтэй холбоотой. Ойлголтын зөрүү гэдэгт талбайг хэмжихдээ орон сууцны компани тухайн орон сууцны тагт, лодж, цонх, үүдний хэсэг зэргийг багтаасан хэмжилт хийдэг.

Гэтэл эдгээр сууцны бус зориулалттай туслах талбайнуудын үнэлгээг бууруулах итгэлцүүрээр тооцох Иргэний хуулийн "147.4. Дангаар өмчлөх талбайн хэмжээг тодорхойлохдоо, сууц өмчлөгчийн сууцны талбай дээр дангаар өмчлөх сууцны бус зориулалттай талбайн гуравны нэгийг нэмнэ" гэсэн заалт хэрэгжихгүй байна.

Мөн хананы зузааныг оруулж хэмждэг. Үүнийгээ гэрээнд нарийвчлан тусгадаггүй. Өрөөний метр квадратын ерөнхий тоон илэрхийлэлийг гэрээнд тусгадаг. Иргэд байраа хүлээж аваад сууцны тагт, лож, гонх, үүдний хэсэг зэргийг оруулалгүй хэмждэг, өөрсдөө хэмждэг. Хэмжих журам, аргачлал байдгыг иргэд мэддэггүй, мэдээлэл дутмаг байна.

Иргэд ханын дотор талаас хэмжээд талбайн зөрүүтэй байдлаас гомдол гаргадаг байна.

Эдгээрээс үзэхэд иргэд талбайн хэмжээг тооцох аргачлалын талаар тодорхой мэдлэггүй, ерөнхий мэдээлэлтэй байна.

Үүнээс үүдэж сууцны талбайн ашигтай талбай, ашиггүй талбай гэсэн ойлголт гарч ирдэг. Энэ нь шинэ стандарт гарснаар хэрэглэгдэхгүй болсон.

Стандартын 3.1-д ***сууцны зориулалттай талбай*** – дангаар өмчлөх сууцны зориулалттай хэсэг /зочны, унтлагын, хүүхдийн, ажлын г.м./-ийн талбай хамаарна.

3.2-т ***сууцны бус зориулалттай талбай*** - дангаар өмчлөх сууцны бус зориулалттай хэсэг /гал тогооны, хооллох өрөө, ариун цэврийн болон угаалгын өрөө, өрөө хоорондын хонгил, агуулах, ханын шүүгээ/-ийн талбай тооцно.

3.3-т ***сууцны бус зориулалттай туслах талбай***- лодж, тагт, террас, веранд зэрэг бие даан орших чадваргүй сууцны барилгын туслах бүтээцийн талбай хамаарна.

3.4-т ***сууцны нийт талбай***- сууцны зориулалттай талбай, сууцны бус зориулалттай талбай, туслах талбайн нийлбэр байна. Гэхдээ лоджийн талбайг 0,5; тагт, террасын талбайг 0,3 гэсэн итгэлцүүрээр бууруулан тооцно.

Эдгээр нэр томьёо нь талбайн хэмжээг тооцоход мөрдөх ба ашигтай талбай, барилгажих талбай, борлуулалтын талбай гэсэн ойлголтуудыг бүрэн багтаасан агуулгатай юм.

Иргэн, аж ахуйн нэгжүүд гэрээндээ тухайн үед мөрдөгдөж байсан дүрэм журмаар зохицуулагдаж байсан аргачлалыг төдийлөн баримтлаагүй нь шүүхийн шийдвэрүүдээс харагдаж байна.

Сууцны талбайн ашигтай талбай, ашиггүй талбай гэсэн ойлголтыг арилгаж Стандартчилал хэмжил зүйн үндэсний төвөөс гаргасан аргачлалын дагуу сууцны талбайг хэмжихдээ ханын дотор тал хоорондын хэмжээсээр тооцдог нийтлэг аргачлал боловсруулсан. Энэ нь маргаан гарсан тохиолдолд талууд нэгэн адил баримтлах эх сурвалж болж өгсөн байна.

Дүгнэлт:

1.Стандартыг шинээр боловсруулж, гаргасны үр дагавар нь стандартын "Б" хавсралтад байгаа "Сууцны өрөө, тасалгааны хэмжилт хийж, түүний талбайг тооцсон тэмдэглэл" схемийг гэрээний хавсралт болгон оруулж, заавал дагаж мөрдөх журамтай болсноороо давуу талтай зохицуулалт болж өгчээ. Ингэснээр гэрээний нэг тал болох орон сууц худалдан авагчийн эрх зөрчигдөхөөс сэргийлж байна. Өмнөх журмуудад уг зохицуулалт байдаггүй байснаас барилгын компаниуд гэрээндээ нарийвчилсан зохицуулалт төдийлөн тусгахгүй, ерөнхий тойм хэмжилтийн нэгжээр талбайн хэмжээг тодорхойлж байсан тохиолдол цөөнгүй байна. Ингэснээр иргэд хохирч илүү квадрат метрийн мөнгө төлөх явдал их байсан. Үүнийг энэ зохицуулалтаар сэргийлж өгч байгаа юм. Энэ нь гэрээний салшгүй нэг хэсэг болж өгснөөр талбайг хэмжих аргачлалын хувьд зөрөх, маргах нөхцөл байдлыг арилгаж байгаагаас гадна урьд гарч байсан дүрэм журмыг хэрэгжүүлдэггүй нийтлэг дутагдал гарахгүй байх боломжтой болж байна. Иймд урьд өмнө гарч байсан маргаанууд дахин давтагдахгүй байх нөхцөл бүрдэх юм.

2.Судалгаанд авагдсан хэрэг маргаануудаас үзэхэд иргэд өөрсдөө талбайг хэмждэг/ханын дотор талаас, шалны хүрээ модноос гэх мэт/. Мэргэжлийн байгууллагын мэргэжилтнээр хэмжүүлэхээ мэддэггүй. Барилгын компаниуд дүрмийн бус аргаар хэмждэг /ханын зузааныг оруулж, гадна талаас хэмждэг/ дутагдал нийтлэг байсан. Өөрөөр хэлбэл гэрээнд орон сууцны талбайн хэмжээг тооцох аргачлалыг тодорхой тусгаж оруулаагүй нь маргаан гарах бас нэг шалтгаан болж байна. Үүнд иргэдийн мэдлэг дутмаг байдал, компаниудын хариуцлагагүй, дүрэм журмыг сахин биелүүлдэггүй байдал нөлөөлсөн. Иймээс иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх хүрээнд уг аргачлалын талаар гарын авлага гаргаж, сурталчлах шаардлага байна. Нөгөө талаас дүрэм журмуудыг мөрдөж ажиллаагүй аж ахуйн нэгжүүдэд тооцох хариуцлагын хэм хэмжээг/захиргааны хариуцлага хүлээлгэх/ холбогдох хуульд /Захиргааны хариуцлагын тухай хууль/ оруулах шаардлага байна. Орон сууцны талбайн хэмжээг тооцох аргачлалыг зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх зохицуулалт Барилгын тухай хууль, Орон сууцны тухай хууль, Орон сууц хувьчлах тухай хуулиудад байдаггүй.

<u>Санал:</u>

Стандартчилал хэмжил зүйн үндэсний төвөөс гаргасан "Орон сууцны барилгын доторх сууцны талбай тооцох аргачлал"-ыг мөрдөж ажиллаагүй этгээдэд Захиргааны хариуцлагын тухай хуулийн 54 дүгээр зүйл "Барилгын тухай хууль тогтоомж зөрчих" гэж нэрлээд, 54.1. дүгээр заалтад "Айлын сууцны талбайн хэмжээг тооцоход баримтлах журмыг зөрчсөн бол байгууллагыг ...төгрөгөөр торгох, албан тушаалтныг ...төгрөгөөр торгох" гэсэн зүйл нэмж оруулах саналтай байна. Ингэснээр уг "Орон сууцны барилгын доторх сууцны талбай тооцох аргачлал"-ын хэрэгжилтийн үр нөлөө дээшлэх болно гэж үзэж байна.

__oOo__

ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ, ЗАХИРГААНЫ ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ БҮРТГЭХ АЖИЛЛАГАА, ТҮҮНД ТАВИХ ХЯНАЛТЫН ТАЛААРХ ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГҮЙ БОЛГОХ НЬ[13]

I.Монгол Улсын хууль тогтоомж дахь захиргааны зөрчлийн ойлголт, үндсэн шинж, бүрэлдэхүүнийг тодорхойлох асуудалд

Захиргааны зөрчил нь гэмт хэрэгтэй харьцуулахад олон үйлдэгддэг, иргэн, нийгэмд багагүй хор уршиг, хохирол учруулдаг боловч түүний шалтгаан нөхцөлийг судлах онол, практик, арга зүйн шаардлага хангасан судалгаа шинжилгээний ажил их хоцронгуй яваа нь судлаачдийн анхаарлын гадна байна гэлтэй.

Захиргааны хариуцлага, зөрчил, шийтгэлийн талаар захиргааны эрх зүйн сурах бичиг, ном зохиолд[14] түүний ойлголт, мөн чанарыг ямар нэг түвшинд авч үзсэн нь бий. Захиргааны зөрчлийн тухайд 11 жилийн өмнө Доктор Ж.Долгорсүрэн Цагдаагийн Академийн багш нартай хамтран судалгааны баг цуврал бүтээл туурвих зорилгоор "Захиргааны зөрчил"[15] гэсэн бэсрэгхэн ном бичсэн. Үүнээс хойш ямар нэг хамтын бүтээл гаргасангүй.

Доктор Ж.Долгорсүрэн энэ сэдвээр "Захиргааны хариуцлага[16]" хэмээх ганц сэдэвт бүтээл бичсэнийг эс тооцвол судалгааны эргэлтэд одоог хүртэл ороогүй гэж хэлж болно. Дээр дурьдсан ном зохиолд буй захиргааны зөрчил, хариуцлагын тодорхойлолтод үнэлэлт, харьцуулалт хийхийг чухалчлаагүй бөгөөд харин захиргааны зөрчлийн ойлголт, үндсэн шинж, бүрэлдэхүүнийг дагнан судлахад энэхүү хэсгийн зорилго оршино.

Цагдаагийн байгууллага шийдвэрлэсэн захиргааны зөрчлийн бүртгэл хөтөлж улирал, жилээр нэгтгэн гаргадаг, харин улсын хэмжээний нэгдсэн тоо бүртгэлгүй учир жилд хичнээн захиргааны зөрчил гардаг нь мэдэгдэхгүй, түүнд ямар нэг дүн шинжилгээ хийдэггүй ажээ.

Нэг. Захиргааны зөрчлийн ойлголт, үндсэн шинжийн тухайд ...

"Захиргааны хариуцлагын тухай Монгол Улсын хууль"-ийн 3 дугаар зүйлд: **"Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр буюу тухайн нутаг дэвсгэрт дагаж мөрдүүлэхээр тогтоосон захиргааны журам санаатай буюу болгоомжгүйгээр зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг захиргааны зөрчил гэнэ"**[17] гэж тодорхойлжээ.

---

[13] Энэхүү судалгаар ХЗДХЯ-ны захиалгаар ЗХЭЗС, ЭЭЗКС хамтран хийж гүйцэтгэсэн болно.

[14] Б.Чимид. БНМАУ-ын захиргааны эрх зүй. Ерөнхий анги. Сурах бичиг.-УБ., 1988, 285-289 дэх тал; Д.Дашцэдэн. Монгол Улсын захиргааны эрх зүй. 1 –УБ, 218-236 дахь тал; Ж.Сүхбаатар. Монгол Улсын захиргааны эрх зүй. Сурах бичиг, 181-187 дахь тал гэх мэт

[15] Захиргааны зөрчил. Гарын авлага. Ред. Ж.Долгорсүрэн,-УБ, 1999, 3 дахь тал болон 60 дахь тал.

[16] Ж.Долгорсүрэн. Захиргааны хариуцлагын тухай хуулийг биелүүлэх аргачилсан зөвлөмж.-УБ., 1993, 7-12 дахь тал; Захиргааны хариуцлага. Нэг сэдэвт бүтээл. –УБ, 1998, 140 н.

[17] "Төрийн мэдээлэл", 1992, №3-4

Захиргааны хариуцлагын тухай хуулийн заалтаас үзвэл улсын хэмжээгээр бүх нийтээр дагаж мөрдөхийн зэрэгцээ орон нутгийн онцлогтой уялдан тухайн нутаг дэвсгэрт тогтоосон захиргааны харицлага хүлээлгэх журам бас байна. Энэ нь орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчид, Засаг даргад нутаг дэвсгэртээ захиргааны журам тогтоож зөрчигчдөд хариуцлага хүлээлгэх бүрэн эрх олгосон хэрэг. Тэгэхдээ захиргааны хариуцлагын тухай хуульд байгаа захиргааны шийтгэл, түүний хэмжээ, хязгаарын хүрээнд тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа иргэдээс чухам ямар журам зөрчвөл захиргааны зөрчил болохыг нь тодорхой зааж ойлгуулна.

Хуульд дээрх тодорхойлолт хийж, нэгдмэл ойлголт өгсөн нь сайшаалтай боловч уг тодорхойлолтод захиргааны зөрчлийн мөн чанар, үндсэн шинжийг бүрэн илэрхийлсэн гэвэл учир дутагдалтай билээ.

Захиргааны зөрчлийн үндсэн шинж нь түүний бүрэлдэхүүнтэй салшгүй холбоотой ойлголт юм. Өөрөөр хэлбэл **захиргааны зөрчил нь захиргааны хариуцлага тогтоосон хэм хэмжээний эсрэг, хүн, иргэний нийгэмд хор уршигтай, гэм буруутай зөрчигч этгээдэд захиргааны шийтгэл ногдуулах** зэрэг үндсэн шинжүүдтэй.

Захиргааны зөрчлийн бүрэлдэхүүн нь эрх зүйн хэм хэмжээгээр урьдчилан тодорхойлсон захиргааны хариуцлага хүлээлгэхээр тогтоовол зохих шинжүүдийн нийлбэр цогц юм. Эдгээрийг хууль зүйн ач холбогдлоор нь зөрчлийн объект, объектив тал, субьект, субьектив тал гэсэн заавал байх шинж, хөнгөрүүлэх, хүндрүүлэх, эсхүл хариуцлагыг үгүйсгэх нөхцөл байдал, түүнчлэн хугацаат цэргийн албан хаагч, насанд хүрээгүй хүний үйлдсэн зөрчил мэтийн нэмэгдэл шинж гэж хуваах үзэж болно [18].

Үүнээс үүдэн бидний бодлоор бол захиргааны зөрчил гэдэгт **захиргааны хууль тогтоомжоор эрх зүйн хариуцлага хүлээлгэхээр тогтоосон** бүх нийтээр дагаж мөрдөх журмыг зөрчсөн **хор уршигтай,** гэм буруутай, **захиргааны шийтгэл хүлээх хүн, хуулийн этгээдийн** үйлдэл, эс үйлдэхүйг **ойлгоно.**

"Хуулийн этгээд" гэдэг нь иргэний эрх зүйн нэр томьёогоор тухайлбал: Монгол Улсын Иргэний хуулийн 4 дүгээр бүлгийн 25 дугаар зүйлд "өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй, тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ"[19] гэж тодорхойлжээ.

Хуулийн этгээд ашгийн төлөө буюу ашгийн төлөө бус байж болно. Ашгийн төлөө хуулийн этгээдийг нөхөрлөл, компанийн хэлбэрээр, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг холбоо, сан, хоршооны хэлбэрээр тус тус байгуулна.

---

[18] Ж.Долгорсүрэн. Захиргааны хариуцлага. Нэг сэдэвт бүтээл. –УБ, 1998, 22 дахь тал

[19] Монгол Улсын Иргэний хууль. ИХШХШТХ.-УБ., 2002 он. Монгол Улсын ХЗДХЯ, Хууль зүйн мэдээллийн төв. 13 дахь тал.

Хоёр. Захиргааны зөрчлийн объект, объектив тал

Захиргааны эрх бүхий албан тушаалтан захиргааны хариуцлага хүлээлгэхийн тулд газар дээр нь торгууль ногдуулахаас бусад тохиолдолд уг зөрчлийг бүрдүүлэгч объект, объектив тал, субъект, субъектив талыг задлан шинжилсний үндсэн дээр захиргааны зөрчил мөн эсэх хийгээд түүний үндсэн шинж болон бусад нөхцөл байдлыг тогтооно.

Захиргааны зөрчлийн нэг үндсэн шинж болох захиргааны хариуцлага тогтоосон хэм хэмжээний эсрэг үйлдэл, эс үйлдэхүй нь захиргааны хариуцлага бүхий хууль тогтоомжоор урьдчилан хориглосон заалт буюу нийтээр дагаж мөрдөх журмыг зөрчсөн байна. Өөрөөр хэлбэл, захиргааны эрх зүйн хэм хэмжээгээр нийтээр дагаж мөрдөхөөр урьдаас журамлан тогтоогоогүй бол уг үйлдэл, эс үйлдэхүй нь хүн, иргэний нийгэмд хор уршиг учруулсан ч зөрчлийн бүрэлдэхүүнгүй, захиргааны хариуцлага хүлээлгэхгүй гэсэн хэрэг юм.

Захиргааны зөрчлийн объект нь захиргааны зөрчилд хариуцлага хүлээлгэхээр тогтоож хуулиар хамгаалагдсан нийгмийн харилцаа юм. Захиргааны хариуцлагын ерөнхий хууль нь Захиргааны хариуцлагын тухай 1992 оны хууль юм. Жишээлбэл энэ хуулийн 21 дүгээр зүйлээр олон нийтийн газар хэрүүл, маргаан, зодоон үүсгэсэн, бусдыг өдөөн хоргоосон, айлган сүрдүүлсэн зэргийг "Танхайрах" захиргааны зөрчил хэмээн томьёолжээ. Энэ нь нийгмийн хэв журмын захиргааны хариуцлага хүлээх зөрчил буюу шууд обьект болно.

Захиргааны зөрчлийн обьектыг ерөнхий, төрлийн, шууд гэж хуваах болно. Судалгаанаас үзвэл зөрчлийн хэлбэр, хүлээх хариуцлагыг тодорхойлсон 190 гаруй хууль Монгол Улсад байна.

Захиргааны хариуцлагын тухай хуулийн 2 дугаар бүлэг болон захиргааны хариуцлага тогтоосон бусад хуулийн чухам ямар, зүйл, хэсгийг зөрчиж, эрх зүйн эсрэг чиглэгдэг вэ гэдгийг тогтооно. Энэ нь захиргааны зөрчлийг зүйлчлэн ангилж, зөрчлийн обьектыг тодорхойлно гэсэн хэрэг.

Захиргааны зөрчлийн объектив тал нь хүн, хуулийн этгээдийн иргэний хүмүүнлэг нийгэмд учруулсан хор уршигтай үйлдэл, эс үйлдэхүй мөн. Энэ нь захиргааны хариуцлага тогтоосон ямар хуулийн аль заалт, бүх нийтээс мөрдөх ямар журмыг гажуудуулсан болохыг шалгаж, зөв зүйлчлэхийн зэрэгцээ хууль бус үйлдэл, эс үйлдэхүй, учруулсан хор уршиг, шалтгаант холбоог тогтоох явдлаар илэрнэ.

Захиргааны зөрчлийн нийгмийн хор уршгийн хэр хэмжээ янз бүр байх боловч гэмт хэрэгтэй харьцуулбал бага байна. Жишээ нь: авто тээврийн хэрэгслийн жолооч замын хөдөлгөөний дүрмийг зөрчиж хурд хэтрүүлсэн нь Захиргааны хариуцлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан захиргааны зөрчил болдог бол хурд хэтрүүлсний улмаас зорчигчдийг дайрч гэмтээсэн нь гэмт хэрэгт тооцогдоно.

Гэхдээ захиргааны зөрчлийн хор уршиг бүхэлдээ бага байдаг гэсэн хэрэг бас биш. Тухайлбал, агнахыг хориглосон буюу хориотой аргаар ан амьтан агнасан, эсхүл байгаль орчныг эвдэж сүйтгэсэн нь хүмүүнлэг нийгэмд ихээхэн хор уршиг учруулна. Өөрөөр хэлбэл захиргааны зөрчил нь

гэмт хэргээс илүү хор уршигтай, эрүүгийн хуульд зааснаас ч илүү торгууль ногдуулж болох хуулийн заалт шаардлагатай байна гэсэн үг.

Эрх бүхий албан тушаалтан захиргааны зөрчлийг шалгаад шийтгэлийн хоёр төрөл ногдуулахаар байгаа бол илүү оновчтой шийтгэл, түүний хэмжээг сонгон ногдуулахад харгалзан үзэх хүчин зүйл нь хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдал юм.

Захиргааны хариуцлагын хөнгөрүүлэх нөхцөл байдалд учирсан хор уршгийг сайн дурааараа арилгасан, эд хөрөнгийн байдал, бусдыг тэжээн олуулаа амьдардаг, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур орлоготой, зөрчил гаргагч гэм буруугаа чин сэтгэлээсээ ойлгосон, хувийн болон гэр бүлийн хүнд нөхцөлийн улмаас, эсхүл сэтгэхүйн цочирлоос болж зөрчил үйлдсэн, зөрчигч насанд хүрээгүй үедээ болон жирэмсэн буюу нялх хүүхэдтэй зэрэг бусад нөхцөл байдал байж болно.

Захиргааны хариуцлагын хүндрүүлэх нөхцөл байдалд хууль бус үйлдлээ зогсоохыг шаардсаар байхад үргэлжлүүлсэн, согтуугаар болон бүлэглэн үйлдсэн, урьд нь гэмт хэрэг үйлдсэн этгээд зөрчил гаргасан, эсхүл шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байхад зөрчил давтан гаргасан, насанд хүрээгүй хүнийг уруу татсан, байгалийн гамшиг, онцгой бусад нөхцөлийн үед эрх зүйн зөрчил үйлдсэн зэрэг бусад нөхцөл байдал хамаарна.

Захиргааны хариуцлагын дээр дурьдсан нөхцөл байдал нь зөрчлийн обьектив талд тодийгүй, субъект, субъектив талын шинжийг давхар агуулсан байна.

Гурав. Захиргааны зөрчлийн субъект, субъектив тал

Захиргааны зөрчлийн өөр нэг үндсэн шинж нь захиргааны шийтгэл хүлээх байдал буюу субъектын тухай асуудал юм. Энэ тухай Захиргааны хариуцлагын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1-д "Зөрчил үйлдэх үед 16 насанд хүрсэн Монгол Улсын иргэн, тус улсын нутаг дэвсгэрт захиргааны зөрчил гаргасан гадаадын иргэн, харъяалалгүй хүнд захиргааны хариуцлага хүлээлгэнэ" гэжээ. Үүний зэрэгцээ зөрчил гаргагч этгээд нь захиргааны шийтгэл хүлээх чадамжтай, өөрөөр хэлбэл, хууль бус ажиллагаандаа /үйлдэл, эс үйлдэхүйдээ/ үнэлэлт өгөх, түүнээ жолоодон залах бүрэн чадвартай байх явдал юм.

Захиргааны зарим зөрчлийн субъект нь хуульд заасан тохиолдолд захиргааны албан тушаалтан байж болно. Энэ талаар хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Бүх нийтээр дагаж мөрдөх захиргааны журмын биелэлтийг тухайн байгууллагадаа зохион байгуулах үүрэг бүхий албан тушаалтан энэ үүргээ зохих ёсоор биелүүлээгүй нөхцөлд түүнд захиргааны хариуцлага хүлээлгэнэ", мөн зүйлийн 4-т "Иргэний хуульд заасны дагуу хуулийн этгээд болох аж ахуйн нэгж, байгууллагад захиргааны хариуцлага хүлээлгэнэ" гэж тус тус заажээ.

Захиргааны хариуцлагын тухай хуульд субъектын талаар 1995 онд орсон нэг өөрчлөлт нь захиргааны зөрчил гаргасан зарим этгээд-цэргийн бүх албан хаагчид сахилгын хариуцлага хүлээлгэхээр байсныг өөрчилж

зөвхөн хугацаат цэргийн албан хаагчаас бусад зөрчигчдөд тухайн зөрчилд нь захиргааны шийтгэл ногдуулах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан юм.

Захиргааны хариуцлагын тухай хуульд 1995 онд орсон өөр нэг өөрчлөлт нь уг хуулийн 6 дугаар зүйлийн 2-т зааснаар "Сэтгэл мэдрэлийн архаг өвчин, сэтгэл мэдрэлийн үйл ажиллагааны түр сарнилт болон сэтгэцийн бусад өвчний улмаас өөрийн үйлдэл, эс үйлдэхүйг хариуцах буюу жолоодох чадваргүй үедээ зөрчил гаргасан бол захиргааны хариуцлагаас чөлөөлөх тухай заажээ.

Үүнээс гадна аргагүй хамгаалалт, гарцаагүй байдлын нөхцөлд зөрчил гаргасан бол захиргааны хариуцлагаас чөлөөлнө. Өнөөгийн байдлаар захиргааны хариуцлагаас чөлөөлөх нь практикт төдийлэн хэвшиж тогтоогүй гэж хэлж болохоор байна.

Захиргааны зөрчлийн өөр нэг шинж нь гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүй мөн. Энэ нь захиргааны хариуцлага хүлээлгэх үндэслэл болохын зэрэгцээ уг **зөрчлийн субьектив талыг** тогтооно гэсэн үг юм.

Гэм буруу нь зөрчил гаргагчийн үйлдэл, эс үйлдэхүйдээ хандсан сэтгэхүй ухамсрын харьцаа болох санаатай, болгоомжгүйн хэлбэрээр илэрнэ. Зөрчил гаргагч өөрийн хууль бус үйл ажиллагааныхаа явцад хор уршигтай үр дагавар бий болгоно гэдгийг мэдсээр байж үйлдсэн бол гэм буруугүйн санаатай хэлбэр гэж үзнэ. Үүнийг нь шууд ба шууд бус санаатай гэж хоёр хуваана. Танхайрах, согтуурах, өмч хөрөнгийг ашиглан шамшигдуулах зэрэг захиргааны зөрчлийн олонх нь энэ хэлбэрээр үйлдэгдэнэ.

Гэм буруугийн болгоомжгүй хэлбэр нь хайхрамжгүй хандсан, хөнгөмсгөөр найдсан гэсэн хоёр янз байна. Зөрчил гаргасан гэм буруутай этгээд хууль бус үйл ажиллагааныхаа явцад хор уршиг учруулахыг мэдээгүй боловч урьдчилан мэдэх үүрэгтэй бөгөөд бололцоотой нөхцөлд уг зөрчлийг үйлдсэн бол хайхрамжгүй хандсан гэж үзнэ. Харин хууль бус үйл ажиллагааныхаа хор уршгийг мэдсэн боловч түүнийгээ зайлуулж чадна гэж өөртөө найдсаны улмаас зөрчил гаргагч хөнгөмсгөөр хандаж үйлдсэн бол гэм буруугүйн болгоомжгүй хэлбэр болно. Тухайлбал, хөдөлгөөний аюулгүй байдлын болон зөвшөөрлийн тогтолцооны журмыг гажуудуулсан зарим зөрчил нь гэм буруугийн энэ хэлбэрээр үйлдэгдэх нь бий.

"Захиргааны хариуцлагын тухай Монгол Улсын хууль"-д эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол захиргааны шийтгэл ногдуулна гэсэн заалттай олон зүйл бий. Тэрчлэн захиргааны хариуцлага тогтоосон бусад хуулиудаас ч үүнийг харж болно.

Гэмт хэрэг, захиргааны зөрчлийн зааг ялгаа, холбогдох байдлын талаар нийтлэгдсэн бүтээл Монгол Улсад өнөөг хүртэл хараахан гараагүй, онол, практикийн талаас нь судлах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Үүнтэй холбогдуулан юуны өмнө дараах саналыг дэвшүүлж байна.

Захиргааны зөрчлийн гаралт, төрөл, хөдөлгөөн, хандлагын нэгдсэн бүртгэл судалгаа бий болгох. Энэ нь гэмт хэрэг, захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, харьцуулан үнэлэлт өгөх боломжийг бүрдүүлнэ.

Захиргааны шийтгэл ногдуулж буй Монгол Улсын өнөөгийн байдалд судалгаа хийх. Үүнээс үүдэн нэг талаас захиргааны хариуцлага хүлээлгэх эрх бүхий албан тушаалтны шийдвэрлэсэн зөрчлийн тоо нэгтгэгдэх, одоогийн эрх бүхий янз бүрийн 10 гаруй албан тушаалтны эрх зүйн байдлыг тодруулах; нөгөө талаас практикт торгууль ихэвчлэн хэрэглэгддэг боловч захиргааны бусад шийтгэлийн эзлэх байрыг харуулах, цаашид шаардлагатай эсэх асуудалд хариу өгнө.

"Захиргааны хариуцлагын тухай Монгол Улсын хууль"-д буй 48, захиргааны хариуцлага тогтоосон бусад 197 бүгд 275 төрлийн /салбарын/ захиргааны зөрчил тогтоосон байгааг нэг хуульд салбар чиглэлээр нь бүлэглэн төрөлжсөн хууль болгох нь зүйтэй хэмээн үзнэ.

II.Захиргааны хариуцлагын тухай Монгол Улсын хууль тогтоомжийн өнөөгийн байдал, чиг хандлагын тухайд

Захиргааны хариуцлага нь эрх бүхий албан тушаалтнаас өөрийн бүрэн эрхийн хүрээнд эрх зүйн зөрчил гаргасны учир захиргааны хууль тогтоомжийн дагуу хүлээлгэдэг хууль зүйн хариуцлагын бие даасан нэг төрөл юм.

Захиргааны зөрчил, гэмт хэрэгтэй харьцуулахад хэдэн зуу дахин олноор үйлдэгдэх боловч нэгдсэн тоо бүртгэл хөтлөгддөггүй, тэрээр гэмт хэргийн гаралтад ихээхэн нөлөөлдөг гэдгийг хуульч судлаачид мэддэг боловч өнөөг хүртэл анхаарал бага хандуулсаар иржээ.

Одоогийн мөрдөгдөж буй "Захиргааны хариуцлагын тухай Монгол Улсын хууль" 1992 оны 11 дүгээр сарын 27-нд гарч, мөн оны 12 сарын 15-ны өдрөөс үйлчилж эхэлсэн. Тэр үеийн Улсын Их Хурал 33 дугаар тогтоолоороо Захиргааны хариуцлагын тухай төрөлжсөн хууль боловсруулж УИХ-ын 1993 оны хаврын чуулганд оруулахыг Засгийн газарт даалгасан ч өнөөг хүртэл буюу 17 жил хэрэгжсэнгүй.

Энэхүү сэдвийг авч үзэхдээ Монгол Улсад захиргааны хариуцлага тогтоосон хууль тогтоомжийн түүхэн хөгжлийн байдлаас эхлэх нь илүү зохистой хэмээн санагдсанаа өгүүлэх юун.

2.1.Захиргааны хууль тогтоомжийн түүхэн хөгжлийн тухай товчхон ...

Монголын ард түмний олон үеийнхний оюун ухаанаар бүтээгдэн арвижиж ирсэн хууль цаазын сан хөмрөг хосгүй баялаг юм. Монгол орон, түүний хүн ардын унаган ахуй амьдрал, дүр төрх, зан төлөвшил, суурьшилтай хууль цаазын хөгжил олон зуун жилийн түүхтэй юм.

Монгол Улс 1921 оны 7 дугаар сарын 11-нд тусгаар тогтнолоо тунхаглан зарласнаас хойш Ардын Засгийн газраас нийгмийн дэг журмыг хангах талаар хууль тогтоомжийн шинжтэй акт гарган мөрдүүлж, тэдгээрийг зөрчигчдөд хариуцлага хүлээлгэж байв.

Засгийн газрын 1923 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 18 дугаар хурлаар "Цагдан цээрлүүлснийг зөрчигсдийг яллах хууль"-ийг батлан

гаргажээ. "Цагдан цээрлүүлснийг зөрчигсдийг яллах хууль"[20]-иар цагдан сэргийлэх байгууллагад гэмт хэрэг, зөрчилд тохируулан ялгавартайгаар 1-15 төгрөгөөр торгох, мөн 1-15 хоногоор хорих шийтгэл ногдуулах эрх олгож байжээ.

Мөн уг шийтгэлийг яаж ногдуулах, цааз бичгийн хоёр зүйлээс дээшихэд халдвал зохих шийтгэлийг ялган салгаж, хүндрүүлэн яллавал зохих / тэгэхдээ хорих хугацааг 30 өдөр, торгох хэмжээг 30 төгрөгт хүрвээс зогсоох/, ялыг хэрхэн гүйцэтгэх зэрэг хуулийг хэрэглэх нийтлэг зүйлийг тухайлан тогтоожээ.

Уг хуульд "Засгийн хэрэгт холбогдох", "Олны түгшүүр хорлолд холбогдох", "Харилцан нэвтрэхэд холбогдох", "Мэдээ нэвтрүүлэхэд холбогдох", "Бие ба амийг хамгаалахад холбогдох", "Эд хөрөнгөнд холбогдох", "Цээрлэлийг зөрчсөн ял" гэсэн 2-9 дүгээр бүлэг, 13-35 дугаар зүйлд эрх зүйн зөрчлийг төрөлжүүлэн заасан байна. Ийнхүү эрүүгийн гэмт хэрэг хүлээлгэхээргүй, эсхүл гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан үйлдэлд торгох, донгодох, түр хугацаагаар хорих зэрэг харьцангуй хөнгөн шийтгэл ногдуулж байсан бөгөөд энэ нь нэлээд тогтвортой удаан хугацаагаар уг харилцааг зохицуулж байсан болтой юм.

"Аливаа торгууль ногдуулах дүрэм"[21]-ийг 1932 онд баталсан бөгөөд уг дүрэмд урьдах хуулийг бодвол торгууль ногдуулах зөрчил бүхий хэргийг тодруулан зааж, торгуулийн хэмжээг нэмэгдүүлж 40 хүртэл төгрөгөөр торгох болсон байна. Уг дүрмийн нэг онцлог нь торгох шийтгэлийг хэрхэн яаж ногдуулах, түүнийг хэрхэн гүйцэтгэх гэх мэт асуудлыг багтааж байв.

Монгол Улсад 1992 оныг хүртэл захиргааны янз бүрийн хүчин чадал бүхий олон төрлийн хууль тогтоомж, эрх зүйн актаар захиргааны хариуцлага хүлээлгэж байв. Тэдгээрийг:

1.Хууль

2.БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн зарлиг

3.СнЗ-ийн тогтоол

4.Орон нутгийн АДХ-ын заавал биелүүлэх шийдвэр гэж хуваан үзэж болох юм.

1921-1990 ээд оны үеийн хууль тогтоомжоор захиргааны шийтгэл ногдуулж байсан байдалтай холбон дүгнэвэл:

1. Монгол оронд Ардын хувьсгал ялж, тусгаар тогтнолоо олсноос хойш манай захиргааны эрх зүйн шинэхэн үеийн тогтолцоо бүрдэж, БНМАУ-ын 3 удаагийн Үндсэн хуулийн дагуу тэр нь нийгмийнхээ хөгжлийн аясаар улам сайжирч иржээ.

2. Улмаар 1960-аад оноос эрх зүйн бие даасан салбарууд онол, практикийн зохих түвшинд хөгжиж, үндэсний эрх зүйн тогтолцоо төлөвшиж уламжлан, Монгол Улсын 1992 оны Үндсэн хуультай залгасан байна.

3. БНМАУ-ын захиргааны эрх зүйн хүрээнд:

а/ сануулах

[20] БНМАУ-ын цагдан сэргийлэх байгууллагын зарим эрхийн актууд. Эмхтгэсэн А.Думбурай. УБ., 1988, 74-83 дахь тал

[21] БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчид ба СнЗ-ийн хуулиуд хийгээд тушаалуудыг эмхтгэн хавсруулсан сэтгүүл. Уб., 1932, 19-24 дэх тал

б/ торгох

в/ хууль бус орлого, эд зүйл хураах

г/ тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах

д/ баривчлах захиргааны шийтгэл тухайн үеийн хууль тогтоомжид тусгагджээ. Үүний дотор захиргааны бараг бүх зөрчилд торгууль ногдуулдагаар тэр нь зонхилох байр эзэлж байжээ.

2.2.Захиргааны хариуцлагын тодорхойлолт, хууль тогтоомжийн өнөөгийн байдал

Хууль зүйн бусад хариуцлагатай харьцуулан үзэхэд захиргааны хариуцлага нь дараах нийтлэг шинжтэй. Үүнд:

1.Төрөөс тогтоосон эрх зүйн хэм хэмжээ зөрчсөний төлөө хариуцлага хүлээлгэх

2.Эрх зүйн зөрчлөөс урдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоох

3.Иргэдийг төрийн хууль тогтоомжоо хүндэтгэн биелүүлэх үзэл бодол, итгэл үнэмшил, эрх зүйн хүмүүжилтэй болгох

4.Зөрчигдсөн эрхийг сэргээн хангах

5.Эрх зүйн зөрчил гаргасан этгээдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг төрийн албадлага хэрэглэх замаар нийгмийн харилцааг зохицуулах гэх мэт.

Захиргааны хариуцлага нь захиргааны эрх зүйн албадлагын бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд өөрийн мөн чанараараа хууль зүйн бусад хариуцлагаас ялгагдах дараах өвөрмөц онцлог шинжийг агуулна. Үүнд:

1.Захиргааны хариуцлага хүлээлгэх үндэслэл нь бүх нийтээр даган биелүүлбэл зохих захиргааны журам зөрчих буюу захиргааны зөрчил гаргах явдал мөн. Харин гэмт хэргийн шинж агуулсан, хор уршиг бага, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй үйлдэл, эс үйлдэхүйг хууль тогтоомжийн дагуу захиргааны хариуцлагад татуулахаар төрийн эрх бүхий байууллагаас шилжүүлэн ирүүлсэн тохиолдолд захиргааны шийтгэл ногдуулж болно.

2.Захиргааны шийтгэл ногдуулах хэм хэмжээг хуульд урьдчилан заасан байна. Өөрөөр хэлбэл захиргааны эрх зүйн хэм хэмжээ зөрчигдсөн байсан ч уг зөрчилд захиргааны шийтгэл ногдуулахаар хуульд заагаагүй бол захиргааны хариуцлага хүлээлгэхгүй.

3.Төрийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, тэдгээрийн албан хаагч бүхэлдээ бус, зөвхөн хууль тогтоомжоор эрх олгогдсон албан тушаалтан захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

4.Захиргааны хариуцлагад татах журмыг хууль тогтоомжоор тусгайлан тогтооно. Захиргааны зөрчилтэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа нь иргэний болон эрүүгийн хэргийн нэг адил, захиргааны процессын эрх зүйн хэм хэмжээний дагуу явагдана.

5.Захиргааны хариуцлага хүлээлгэгч, хариуцлагад татагдагчийн хоорондох эрхэлсэн ажлын талаар захирах, захирагдах харилцаагүй байдаг гэх мэт.

Эдгээр шинжүүдэд үндэслэн захиргааны хариуцлага гэдэг нь төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх хүрээнд захиргааны хариуцлага хүлээлгэх

эрх бүхий албан тушаалтнаас нийтээр дагаж мөрдөх захиргааны журмыг зөрчсөн гэм буруутай этгээдэд хууль тогтоомжид заасан захиргааны шийтгэл /санкц/ ногдуулах үүрэг /ажиллагаа/ мөн хэмээн тодорхойлж болно.

Захиргааны хариуцлагын илрэх хэлбэр нь захиргааны шийтгэл. Өнөөгийн хүчин төгөлдөр "Захиргааны хариуцлагын тухай Монгол Улсын хууль"-ийн 4 дүгээр зүйлд: 1. Торгох, 2. Хууль бусаар олсон орлого, эд зүйл буюу зөрчил гаргахад ашигласан тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, байрыг хураах, 3. Тусгайлан олгосон эрх хасах /тээврийн хэрэгсэл жолоодох/

4. Баривчлах гэсэн захиргааны шийтгэлийн төрөлтэй.

Захиргааны хариуцлагын тухай хуулиас гадна захиргааны шийтгэл ногдуулах заалт бүхий одоо хүчин төгөлдөр үйлчилж буй 197 хууль байна. Энэ талаар нарийвчлан судлах зайлшгүй хэрэгцээт шаардлага бий.

Хууль тогтоомжийн өнөөгийн энэ байдал нь дээрх хуулиудаар тогтоосон захиргааны шийтгэлийн төрөл, хэмжээ аль хэр оновчтой томьёологдсон, хоорондын давхардал, зөрчил, хийдэл байгаа эсэх зэргийг хамтын хүчээр шинжлэн судалгааны эргэлтэд оруулах нь хамгаас чухал.

2.3.Захиргааны хариуцлага хүлээлгэх үндэслэлийг тодорхойлох нь

Захиргааны хариуцлагын мөн чанар, илрэх хэлбэр, одоогийн хүлээлгэж буй практикаас шууд урган гарах тулгамдсан нэг асуудал нь түүний үндэслэлийг зөв тодорхойлох явдал юм.

Захиргааны хариуцлагын үндэслэлийг дараах гурван хэсэгт зааглан үзэж болно. Үүнд:

1.Захиргааны хариуцлагыг тодорхойлогч хэм хэмжээ, тэдгээрийн бүхэл тогтолцоо

2.Захиргааны санкцаар хамгаалагдаж буй эрх зүйн заалтыг гажуудуулсан тодорхой субъектийн үйлдэл, эс үйлдэхүй буюу бодит үндэслэл /захиргааны зөрчил/

3.Эрх бүхий албан тушаалтны захиргааны зөрчилд шийтгэл ногдуулах тухай гаргасан шийдвэр

Товчоор илэрхийлбэл нэг дэх хэсэгт захиргааны хариуцлагын хууль тогтоомж, бусад хуулиар захиргааны хариуцлага тогтоосон хэм хэмжээ, хоёр дахь хэсэгт захиргааны зөрчил гаргасан этгээд, гуравдахь хэсэгт тухайн зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаа байх болно.

Гэхдээ энэ нь захиргааны бүх зөрчилд хамааралтай биш гэдгийг хэлэх хэрэгтэй. Учир нь захиргааны зөрчлийг эрх бүхий албан тушаалтан газар дээр нь буюу зөрчлийн хор уршиг, шинж, хэмжээг харгалзан хялбарчилсан журмаар захиргааны торгууль ногдуулдаг.

Цаашилбал захиргааны зөрчил гэж чухам юу болох, тэр нь хуулиар тодорхойлогдсон эсэх, мөн чанар, агуулгаа бүрэн тусгасан гэх мэт олон асуудалд хариу өгөх шаардлага гарна. Энэ бүхнээс судлаачид юуны өмнө нэг дэх, хоёр дахь үндэслэлийг илүү анхаарч гүнзгийрүүлэн үзэх нь зүйтэй болов уу.

2.4.Захиргааны хариуцлагын тухай хууль тогтоомжийн шинэтгэлтэй холбогдох зарим асуудал

Захиргааны хариуцлагын тухай хууль 1992 оны сүүлчээр батлагдах үеийн нийгэм, эдийн засаг, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдалд багагүй өөрчлөлт орсон. Үүнээс хойш энэ хуульд олон удаагийн нэмэлт хийгдэхдээ нэг үзэл баримтлалаар шинэтгэгдээгүй, нийгмийн янз бүрийн салбарт олон хууль гарч, захиргааны хариуцлага тогтоогдсон, тэр нь 1992 оны дурьдсан хуультай зөрчилдсөн буюу нэгдмэл бодлого алдагдсан зэрэг нь уул хуульд бүхэлд нь шинэчилсэн найруулга хийх зүй ёсны шаардлагатайг харуулж байна.

Нөгөөтэйгүүр 1992 оны энэ хуулийн төслийг нэг салбар, чиглэлийн төлөөлөл боловсруулж, УИХ-ын нэр бүхий гишүүд өргөн барьж, чуулганаар хэлэлцэгдсэн, тэр нь хуулийн 21 дүгээр зүйл, түүний дараа дараагийн олон зүйлээс илтэд ажиглагдана.

Зарим тохиолдолд захиргааны зөрчлийг хор аюул багатай, амьдралд байх ёстой мэт ойлгох, эсхүл гадаадын зарим оронд захиргааны хариуцлага байдаггүй, шүүгч гэмт хэргийн нэгэн адил шийдвэрлэдэг гэх маягаар хуульчид хүртэл тайлбарлах нь бий.

Хууль зүйн шинжлэх ухааны хөгжил Монгол Улсад 1960-аад оноос эрчимтэй хөгжсөн гэвэл тэр үеэс захиргааны эрх зүйн ном зохиолын эхлэл тавигдаж, бусад салбар эрх зүйгээс хоцронгуй, өнөөг хүртэл төрөлжсөн хуулийн тухай ярьсаар байгаа нь бодит үнэн юм.

"Монгол Улсын хууль тогтоомжийг 2012 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-д энэ хуулийг шинэчлэн найруулсан байхаар тусгасан хугацаа хаяанд иржээ.

Тэгвэл бид юунаас, хаанаас, хэзээ эхлэх вэ? Юуны өмнө "Захиргааны хариуцлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал"-аа сонордуулж, санал бодлоо нэгтгэж, боловсруулалтын эхний шатыг алгасмаар байна.

Судлаачийн саналын хувьд захиргааны зөрчлийг олон хуульд биш, төрөлжүүлэн нэгтгэе. Харин захиргааны шийтгэлийн төрлийг нэмэх үү, хасах уу? Хасах бус, нэмэгдүүлье.

Үүнтэй холбогдуулан хэлэхэд манай зарим хуульд "Захиргааны хариуцлагын тухай хууль"-д байхгүй шийтгэлийг хуульчилсан нь тааралддаг.

"Торгуулийн тухай хууль"-ийн төслийг 2000 оны үед нийтлэн санал авсан боловч бүтэлгүйтсэн. Үүнийг эдийн засгийн өсөлт, нийгмийн амьжиргааны түвшингийн өөрчлөлттэй холбон нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай. Тэгэхдээ тийм хэмжээний мөнгөгүй, захиргааны зөрчил удаа дараа гаргасан хүнд ямар шийтгэл ногдуулах нь илүү зохистойг бодолцох хэрэгтэй. Цаашилбал нийгмийн амьжиргааны түвшингөөс дээш орлоготой этгээдэд ногдуулах торгуулийн дээд хэмжээг мөн ихэсгэх нь зүйтэй гэх мэт.

Захиргааны зөрчил шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтны тухайд нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагч арай баймааргүй байна. Нөгөө талаар хуульч биш хүн, захиргааны зөрчил хянан тогтоогоод,

ногдуулах шийтгэлийн төрөл, хэмжээг сонгоход бас л бэрхшээлтэй. Энэ бүхэнтэй уялдсан, өнөө үед тохирсон, алсыг харсан хууль бүтээх шаардлагатай байна.

III.ЗАХИРГААНЫ ШИЙТГЭЛИЙН ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ АСУУДАЛД

Монгол Улсын захиргааны эрх зүйн шинжлэх ухаанд захиргааны шийтгэлийн үр нөлөөг судлах зайлшгүй шаардлага, хэрэгцээ байгаа боловч энэ нь хууль судлаачдын анхаарлын гадна огт хөндөгдөөгүй сэдэв гэж хэлж болно.

Захиргааны зөрчил, гэмт хэрэгтэй харьцуулахад хэдэн зуу дахин олноор үйлдэгддэг, гэмт хэргийн гаралтад ихээхэн нөлөөлдөг нь судалгаанаас ажиглагддаг.

Цагдаагийн байгууллагын судалгаагаар зөвхөн Улаанбаатар хотын сүүлийн 3-н жилийн байдлаар захиргааны зөрчил 2007 онд 441008, 2008 онд 413858 гарсан нь зөрчлийн тоо бууралттай атлаа 2009 онд 653002 үйлдэгдсэн нь өмнөх оноос 239144-өөр нэмэгдэж, 57,8% -иар өссөн байна.

Улсын хэмжээнд 2008 онд 561263 захиргааны зөрчил үйлдэгдсэн бол 2009 онд 880988 болж, зөрчлийн тоо 319725-аар нэмэгдэж, мөн л 57,0% -иар өссөн статистик мэдээ гарчээ.

Дээрх тоо баримт нь захиргааны хариуцлага хүлээлгэх эрх бүхий 11 субьектын ганцхан цагдаагийн эрх бүхий ажилтных гэхээр бусад 10 субъектын илрүүлсэн захиргааны зөрчил, ногдуулсан шийтгэлийг нэмбэл хэд болох нь тодорхойгүй бөгөөд Монгол Улсад харамсалтай нь захиргааны зөрчлийн нэгдсэн тоо бүртгэл өнөөг хүртэл хөтлөгдөөгүй байна.

Үүнээс үүдэн захиргааны зөрчлийн тоо бүртгэл бий болгох, ямар төрлийн шийтгэлийн ногдуулалт ихээр зонхилж байгаа, аль нь хүмүүжлийн илүү зохистой, эдийн засгийн хэмнэлттэй, тэрчлэн шийтгэлийн үр нөлөөг судалж, цаашдын хандлага болон Захиргааны хариуцлагын тухай хуулийг боловсронгуй болгоход юуг анхаарах зэрэг олон асуудал хуульч судлаачдын өмнө тавигдаж байна.

3.1.Эрх зүйн үр нөлөөний тухай

Эрх зүйн шинжлэх ухааны аль ч салбарт хууль зүйн хариуцлагын үр нөлөө, түүний шалгуурын талаар хийгдсэн судалгаа шинжилгээний ажил тун цөөн, чамлалттай юм шиг санагдана. Ялангуяа гэмт хэргийн гаралт, шалтгаан нөхцөл, хандлага, эрүүгийн ялын оногдуулалт, ялтны засрал хүмүүжил, гэмт этгээдийн хэрэг давтан үйлдэлт зэрэг нь нарийн тоо бүртгэлтэй, олон талаар судлагдсан хэдий ч ял шийтгэлийн үр нөлөөний асуудал судлаачдын анхаарлын төвд байсаар, чухал ач холбогдолтой хэвээр байна.

Эрх зүйч эрдэмтэн, судлаачдаас өөрийн сурах бичиг, гарын авлагадаа хууль зүйн хариуцлага, шийтгэл, түүний мөн чанар, бусад шинж, төлөв байдлын талаар бичсэн нь тааралдах боловч хууль зүйн хариуцлагын үр нөлөөг тухайлан тодорхойлсон нь цөөн.

Хууль зүйн шинжлэх ухааны доктор Д.Лүндэжанцан "БНМАУ-д байгаль орчныг хамгаалахад захиргааны хариуцлагын арга хэмжээний үр нөлөөг дээшлүүлэх асуудал"[22] сэдвээр хууль зүйн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалсныг сайшаах нь зүйтэй бизээ.

Эрх зүйн хэм хэмжээний үр нөлөөний ойлголтыг түүний үйлчлэлийн бодит үр дүн, батлан гаргасан тухайн хэм хэмжээний хүрвэл зохих нийгэмшлийн зорилго хоорондын **харьцаа** хэмээн тодорхойлж болно[23] гэж ОХУ-ын ШУА-ийн сурвалжлагч гишүүн /академич/ В.Н. Кудрявцев нарын нэрт эрдэмтэд хамтын бүтээлдээ тэмдэглэжээ.

Зарчмын хувьд үүнийг аль ч эрх зүйн цогцолбор /төрөл- хэсэг, дэд салбар болон салбар эрх зүйд/–т тохирохуйц, хүлээн зөвшөөрч болохуйц эрх зүйн үр нөлөөний тодорхойлолт гэж бидний хувьд үзэж байна. Гэхдээ эрх зүйн хэм хэмжээний үр нөлөөг эрх зүйн нэг хэм хэмжээний үйлчлэлийн тодорхой шинж чанарыг харуулах явцуу ойлголт гэх нь илүү зүйд нийцнэ. Эрх зүйн төрөл бүрийн бүрдэл хэсэг /цогцолборын/-ийн үр нөлөө нь тодорхой хэм хэмжээнээс бус, харин тэдгээрийн тогтолцооны үйлчлэлийн шинж чанар, үр дүн юм.

3.2.Захиргааны шийтгэлийн ойлголт, түүний үр нөлөөг тодорхойлох тухайд

Захиргааны шийтгэл гэж захиргааны эрх бүхий албан тушаалтнаас захиргааны зөрчил гаргасан этгээдэд хууль тогтоомжийг үндэслэн хэрэглэж буй **албадлагын цээр зэмлэл үзүүлж, нөлөөлөн үйлчлэх арга хэмжээг** ойлгоно.

Захиргааны зөрчлийг хор аюул багатай, амьдралд байх ёстой мэт ойлгох, эсхүл гадаадын зарим оронд захиргааны хариуцлагыг чухалд үздэггүй, шүүгч гэмт хэргийн нэгэн адил хүлээлгэдэг гэх маягаар хуульчид хүртэл тайлбарлах нь бий.

Одоогийн байдлаар "Захиргааны хариуцлагын тухай хууль"-иас гадна захиргааны шийтгэл ногдуулах заалт бүхий одоо хүчин төгөлдөр үйлчилж буй 197 хууль лавтай байна. Иймд захиргааны хариуцлагын тухай хууль тогтоомжийг эмхлэн цэгцлэх, шийтгэлийн үр нөлөөг дээшлүүлэх зайлшгүй шаардлагатайг харуулна.

Захиргааны шийтгэлийн үр нөлөөг дээшлүүлэх нь нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, эрх зүйн зөрчилтэй тэмцэх үндсэн аргын нэг юм. Ийм үзэл баримтлал нь хууль сахиулах байгууллагын гэмт хэрэг, хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын гол чиглэл байх ёстой хэмээн үзнэ.

Захиргааны шийтгэлийн зорилго нь эрх зүйн зөрчил шинээр үйлдэгдэх-ээс урьдчилан сэргийлэх, зөрчигч этгээдийг хууль тогтоомж дээдлэн хүндэтгэх үзэл бодол, эрх зүйн хүмүүжилтэй болгох, гаргасан зөрчилд нь цээр зэмлэл үзүүлэх явдалд оршино.

---

[22] Данзангийн Лүндэжанцан. Проблемы повышения роли мер административной ответственности в охране природной среды МНР. Автореферат диссертации на соискание ученой степени кандидата юридических наук. –Улан-Батор, 1989, 24с.

[23] Эффективность правовых норм /Кудрявцев В.Н, Никитинский В.И, Самошенко И.С, Глазырин В.В./ –М.; Юрид. лит., 1980, с 22.

Захиргааны шийтгэлийн үр нөлөөг дээшлүүлэхэд эрх зүйн үр нөлөө, түүний нийгэмд ашигтай үр дүнгээр нь тооцож, эрх зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэхийн тулд тавигдсан зорилгодоо хүрэх явдал юм.

Захиргааны шийтгэл бүр захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлж, **анхааруулга, сануулга** болохын зэрэгцээ зөрчил гаргагчдад цээр зэмлэлийг төрүүлж нөлөө үзүүлнэ.

Тухайлбал, захиргааны баривчлах шийтгэл, зөрчил гаргахад ашигласан тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, байрыг хураах шийтгэл нь захиргааны зөрчил гаргагчийн сэтгэхүй, эд хөрөнгөд халдсан цээр зэмлэл төрүүлэх зорилгыг гол болгоно. Энэ зорилго нь захиргааны зөрчил үйлдсэн этгээдийг гэмт хэргээс сэргийлж, хууль дэздлэх үзэл бодол, ухамсар, эрх зүйн соёлтой болоход нөлөөлнө.

Цээр зэмлэл нь хүний нэр төр, алдар хүнд, эрх эрх чөлөөнд ямар нэг хор хохирол, сэтгэхүйн дарамт үзүүлэх зорилгыг агуулдаггүй.

Үр нөлөө гэдэг нь үр ашигт шинж, үр дүн өгөх, үр дүн үзүүлэх утгыг илэрхийлэх бөгөөд хууль зүйн шинжлэх ухааны хэллэгт үр нөлөө нь дараах хэд хэдэн агуулгыг өөртөө багтаасан өргөн хүрээтэй ойлголт юм. Үүнд:

1. Эрх зүйн хэм хэмжээний үндэслэлтэй, үр ашигтай байдал
2. Хууль тогтоогчийн бодлогын зөрэг үр дүн
3. Цаг хүч, материалын хамгийн хэмнэлттэйгээр тавьсан зорилгодоо хүрэх явдал юм.

Захиргааны шийтгэлийн зорилгыг:

1. Ерөнхий сануулгын
2. Хэсэгчилсэн сануулгын
3. Хүмүүжлийн гэж зааглан үзнэ.

Онолын дээрх үндэслэл, зорилгод үндэслэн захиргааны шийтгэлийн үр нөлөөг:

ҮН- шийтгэлийн үр нөлөө

ҮдҮ- шийтгэлийн үр дүнтэй үйлчлэл

З- шийтгэлийн зорилго гэсэн үндсэн агуулгатай томьёоллын гаргалгаа хийж байна.

$$ҮН = \frac{ҮдҮ}{З}$$

Захиргааны шийтгэлийн үр нөлөөг тодорхойлоход дараах хүчин зүйлийг анхааран тооцох хэрэгтэй.

1.Эрүүгийн хариуцлагатай харьцуулахад цээр зэмлэл нь бага байх

2.Захиргааны шийтгэл богино хугацааны үйлчлэлтэй байх, өөрөөр хэлбэл эрүүгийн ялтай харьцуулахад богино хугацаанд хүмүүжих, хууль зөрчигчийг дахин зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх.

3.Захиргааны зөрчил гаргасан этгээдийн хувийн байдал. Хууль зөрчсөн ялимгүй үйлдэл, эс үйлдэл хийсэн хүмүүст илүү үр дүн үзүүлэх гэх мэт.

Захиргааны шийтгэлийн үр нөлөөний тодорхой нөхцөл нь хоёр чиглэлээр хэрэгжинэ.

1.Хууль тогтоогчоос гаргасан захиргааны шийтгэлтэй хууль тогтоомжийн үр нөлөөтэй байдал. Хууль тогтоомжийн өнөөгийн энэ байдал нь дээр

дурдсан "Захиргааны хариуцлагын тухай хууль" болон бусад захиргааны хариуцлага тогтоосон хуульд шийтгэлийн төрөл, хэмжээ аль хэр оновчтой томьёологдсон, хоорондын давхардал, зөрчил, хийдэл байгаа эсэхэд анхаарал хандуулж судлахын чухлыг илтгэнэ.

2.Эрх бүхий албан тушаалтны ногдуулсан захиргааны шийтгэлийн үр нөлөөтэй байдал. Энэ нь дотроо:

- Захиргааны зөрчилтэй хэргийг хянан шалгаж шийдвэрлэх ажиллагааны шуурхай байдал. Энд юуны өмнө захиргааны хууль тогтоомж зөрчигчийн гаргасан зөрчлийг түргэн шуурхай хялбарчилсан журмаар шийдвэрлэх явдал орно. Нөгөө талаас захиргааны зөрчлийн хөөн хэлэлцэх хугацааны дотор шийтгэл ногдуулж, биелэлтийг хангуулах хүртэл үргэлжлэх ажиллагаа юм. Дээрх хугацаа алгуурласнаар шийтгэлийн үр нөлөө багасах магадлалтай.
- Гаргасан захиргааны зөрчилд нь шийтгэл зайлшгүй байх
- Хууль сахиулах байгууллагын нэр хүндийн түвшин зэргээс бүрдэнэ.

3.3.Захиргааны шийтгэлийн үр нөлөөг дээшлүүлэхэд анхаарах зарим асуудал

Захиргааны шийтгэлийн үр нөлөөний зөрэг болон сөрөг тал нь үр нөлөөний шалгууруудаар хэмжигдэнэ. Захиргааны шийтгэлийн зорилго нь хууль зөрчигч этгээдэд үйлчлэх сануулгын үйлчлэл юм. Энэ нь шийтгэлийн үр нөлөөний шалгуур-ерөнхий сануулгын үр дүнг харуулах үзүүлэлт юм.

Эрх зүйн үр нөлөө нь ямар зорилго тавигдсан байна, тийм л хэмжүүрүүдээр илэрхийлэгдэнэ. Хэмжүүр тус бүр нь хэд хэдэн үзүүлэлттэй байж болох ба түүгээр нь шийтгэлийн үр нөлөөг дүгнэх юм. Ийнхүү дүгнэхийн тулд захиргааны шийтгэлийн үр нөлөөний тухай тоон мэдээлэл шаардлагатай.

Захиргааны шийтгэлийн үр нөлөө хууль сахиулах байгууллагын тогтвортой, шуурхай, уян хатан ажиллагаа, захиргааны шийтгэл ногдуулж буй албан тушаалтны хууль зүйн өндөр мэдлэгээс шалтгаалах нь практикт ажиглагддаг. Энэ нь захиргааны шийтгэлийн үр нөлөөг дээшлүүлэхэд тус дэм үзүүлнэ.

Захиргааны шийтгэлийн үр нөлөөг дээшлүүлэхэд анхаарах зүйл нь захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гарсан захиргааны зөрчилд шийтгэл оновчтой, бодитой, тохирсон байх, захиргааны шийтгэлийг хянан шийдвэрлэхэд уян хатан хандах зэрэг асуудлыг хамарсан өргөн хүрээтэй ажиллагаа юм.

Захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх гэдэгт захиргааны зөрчлийн гаралтыг багасгах, түүнийг бий болгодог шалтгаан, нөхцөлийг багасгахад чиглэсэн төр, олон нийтийн байгууллага, иргэдээс зохион явуулж байгаа үйл ажиллагааны нийлбэрийг ойлгоно.

Захиргааны шийтгэл оновчтой, бодитой болгоход захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэж буй эрх бүхий албан тушаалтан шийтгэл ногдуулахдаа зөрчлийн хор уршиг ямар болох, санаатай болон болгоомжгүй үйлдэл, эс үйлдэхүйдээ гэмшин ухамсартайгаар ойлгож буй байдал зэргийг харгалзан

торгуулийг доогуур тогтоох, эсхүл торгуулийн хэмжээ, хэлбэлзлийг дээгүүр сонгох гэх мэтээр тохируулна.

Захиргааны шийтгэлийн үр нөлөөг дээшлүүлэхэд хамгийн чухалчлан анхаарах зүйл нь учруулсан хор уршиг харьцангуй их, гэмт хэргийн шинжийг зарим талаар агуулсан, тэгэхдээ эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй байвал захиргааны шийтгэлийг хүндрүүлэн ногдуулах явдал юм. Энд захиргааны торгуулийн дээд хэмжээгээр ногдуулах, баривлах шийтгэл байгаа бол түүний дээд хугацааг баримтлах, өөрөөр хэлбэл шийтгэлийн төрлийг зөв сонгож, хэмжээ, хугацааг зөрчилд нь тохируулан үр нөлөө өгөхүйц байдлаар захиргааны хариуцлага хүлээлгэнэ гэсэн хэрэг юм. Захиргааны зөрчил гаргахад ашигласан тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, байрыг хураах нэмэгдэл шийтгэл ч үүнд бас хамаарна. Авто тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасах шийтгэлийн дээд хэмжээг баримтлах буюу ногдуулах нь зөрчлийн хүндрүүлэх шалтгаан байгаа эсэхтэй холбоотой.

Тэгэхлээр захиргааны зөрчлийн хүндрүүлэх, хөнгөрүүлэн үзэх үндэслэлийг тодруулах нь зайлшгүй чухал. Захиргааны эрх зүйн зарим ном зохиолд "Хууль хэрэглэх хүнлэг шинж чанар нь гаргасан захиргааны зөрчлийн хор уршиг ялимгүй бага бол хэрэг шийдвэрлэх эрх бүхий байгууллага /албан тушаалтан/ зөрчлийг захиргааны хариуцлагаас чөлөөлөх, амаар сануулах явдлаар илэрнэ"[24] гэж тэмдэглэснийг сануушгай. Тэгвэл өмнөх хууль тогтоомжид байсан захиргааны сануулах шийтгэлийг өнөөгийн нөхцөлд сэргээх магадлалтайг үгүйсгэж болохгүй.

Сүүлийн үед захиргааны олон зөрчил шинээр нэмэгдсэний дотор "Захиргааны хариуцлагын тухай хууль"-ийн 2 дугаар бүлэгт Нислэгийн аюулгүй байдал, Барилга хот байгуулалт, Тээвэр ашиглалт, Замын болон цэргийн барилга байгууламж, Хөдөлмөр хамгаалалд холбогдох төрийн удирдлагын зохих салбар хүрээнд хамааралтай захиргааны журам, түүнийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага бий. Захиргааны хариуцлага тогтоосон олон арван хууль байгааг өмнө нь дурдсан. Эдгээр нь захиргааны зөрчлийг бүхэлд нь нэгтгэж хуулийн тусгай анги, цаашид төрөлжих боломжтойг харуулна.

Захиргааны шийтгэлийн үр нөлөөг дээшлүүлэхэд зайлшгүй анхаарах бас нэг чухал зүйл нь зөрчил гаргасан этгээдэд ногдуулсан захиргааны шийтгэлийн шийдвэрийн биелэлтийг хангуулах явдал юм.

Захиргааны хариуцлага хүлээлгэх эрх бүхий албан тушаалтны захиргааны зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаа хуульд хэрхэн нийцэж байгааг прокурорын байгууллага бүрэн эрхийнхээ хүрээнд хяналт тавьдаг. Энэхүү хяналтын явцад эрх бүхий албан тушаалтан Захиргааны хариуцлагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн дагуу зөрчлийн тэмдэглэл үйлдэхгүй орхих /газар дээр нь 5000 хүртэл төгрөөр торгууль ногдуулахаас бусад тохиолдолд/, шийтгэвэрээр торгох ёстой зөрчилд торгуулийн хуудсаар шийтгэл ногдуулах, хуульд заасан торгуулийн хэмжээнээс доогуур буюу хэтрүүлж хэрэглэх, хуулийн зүйл анги, холбогдох заалтыг буруу сонгох, өөрт ногдсон эрхээ бусдад дур мэдэн шилжүүлэх зэрэг зөрчил түгээмэл илрэх

[24] Тихомиров.Ю.А. Курс административного право и процесса. М., Юринформцентр. 1998. С.745

нь бий. Ийм олон янзын зөрчил, дутагдлыг засаж арилгах нь тухайн хууль хэрэглэгчийн нэр хүндийг сайжруулж, захиргааны шийтгэлийн үр нөлөөтэй болоход тус дэм үзүүлнэ.

Захиргааны зөрчил гаргагч этгээд төлбөрийн чадваргүй байх, нөгөө талаас захиргааны торгуулийг төлөх чадвартай ч зарим этгээд санаатайгаар захиргааны журмыг зөрчих явдал олонтаа тохиолдох болсон. Үүнээс үүдэн Захиргааны хариуцлагын тогтолцоог зайлшгүй байх, шийтгэлийн төрлийг оновчтой тогтоох, түүнийг хэрэгжүүлэх механизмыг цаашид боловсронгуй болгох шаардлагатай гэх мэт зарим зүйлүүд нь захиргааны шийтгэлийн үр нөлөөг дээшлүүлэхтэй холбоотой.

Дүгнэлт

Захиргааны хариуцлага, шийтгэлийн талаарх хууль тогтоомж, түүний хэрэгжилтийн зарим байдал, энэ чиглэлийн эрх зүйн бүтээлд зохих судалгаа шинжилгээ хийж, асуудал дэвшүүлсэн энэхүү судалгааг эргэцүүлэн үзсэнээр дараах дүгнэлтэд хүрэв.

1.Ажилгүйдэл, ядуурал, эрх зүйн ухамсар, соёлын доройтол зэрэг нийгмийн сөрөг үзэгдлийг дагалдан гэмт хэрэг, захиргааны зөрчлийн гаралт нэмэгдэн өсч байгаа нь түүнтэй хийх тэмцлийг эрчимжүүлж, урьдчилан сэргийлэх, захиргааны хариуцлагын үр нөлөөг дээшлүүлэхийн чухлыг харуулж байна.

2.Захиргааны зөрчлийг багасгах, цаг тухайд нь таслан зогсоож, түүний гаралтад нөлөөлөх, тухайн захиргааны зөрчилд илүү тохирохуйц өгөөжтэй шийтгэл ногдуулах, шийтгэлийн үр нөлөөг дээшлүүлэх нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга мөн.

3.Захиргааны хариуцлагын тухай Монгол Улсын 1992 оны хууль, захиргааны хариуцлага тогтоосон бусад 190-ээд хуулийн үйлчлэл, хоорондын давхардал, зөрчил зэрэгт судалгаа шинжилгээ хийж, "Монгол Улсын хууль тогтоомжийн 2012 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-д заасан хугацааны дотор Захиргааны хариуцлагын тухай төрөлжсөн хуулийн төсөл боловсруулан нэг мөр болгон цэгцлэх, захиргааны шийтгэлийн одоогийн төрөлд дүн шинжилгээ хийж, илүү оновчтой хувилбарт хүрэх нь захиргааны шийтгэлийн үр нөлөөг дээшлүүлэх чухал нөхцөл хэмээн үзнэ.

4.Захиргааны зөрчлийн нэгдсэн тоо бүртгэл бий болгох, захиргааны хариуцлага хүлээлгэх эрх бүхий албан тушаалтны эрх зүйн байдлыг шинжлэн, шийтгэл ногдуулах 11 субьектын тоог багасгах, шийдвэрлэх хэргийн харьяаллыг зөв тогтоох, тэдгээрийг эрх зүйн зохих мэдлэг, боловсролтой болгох зэрэг нь захиргааны зөрчилтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хуулийн дагуу явагдах, ногдуулсан шийтгэлийн үр нөлөөг дээшлүүлэхэд сайнаар нөлөөлнө.

5.Хууль сахиулах болон захиргааны хариуцлага хүлээлгэх эрхтэй бусад байгууллага захиргааны шийтгэлийн үр нөлөөг тооцож, ажлынхаа үнэлгээнд оруулах, тодорхой нутаг дэвсгэрт туршиж, гэмт хэрэг, захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөшүүрэг болгон ашиглах санаачилга өрнүүлэх нь зүйтэй гэж судлаачийн хувьд үзэж байна.

ЗАХИРГААНЫ ШИЙТГЭЛ НОГДУУЛЖ БАЙГАА ТАЛААРХ СУДАЛГАА

Нэг. Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй бие даасан 424 хууль байгаагаас Захиргааны хариуцлага ногдуулсан хэм хэмжээ бүхий зүйл, заалттай 197 хууль байна. Үүнээс 14 хуульд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ гэж ерөнхий байдлаар заажээ.

Харин 41 хуульд Захиргааны хариуцлагын тухай хуульд зааснаар хариуцлага хүлээлгэхээр иш татсан зохицуулалттай байна. Жишээ нь: Монгол Улсын Иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн 10.1-д "Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн болон захиргааны хариуцлагын тухай хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ"; 10.2-д "Үндэсний гадаад паспортаа үрэгдүүлсэн, гэмтээсэн Монгол Улсын иргэнд консулын албан тушаалтан Захиргааны хариуцлагын тухай хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ" гэж заажээ.

Үүнийг бид захиргааны хариуцлага тогтоогоогүй буюу хийдэл агуулсан хууль гэж үзлээ.

Хоёр. 197 хуулиас түүвэрлэсэн хэм хэмжээг захиргааны шийтгэлийн төрөл, хэмжээ /торгох, тусгайлан олгосон эрх хасах, хууль бусаар олсон орлого, эд зүйл буюу зөрчил гаргахад ашигласан тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, байрыг хураах, баривчлах/, түүнчлэн захиргааны хариуцлага хүлээлгэх субъект тус бүрээр ангилан түүвэрлэсэн.

Гурав. Захиргааны хариуцлагын тухай хуульд мөнгөн торгууль ногдуулах, хууль бусаар олсон орлого эд зүйлийг хураах, тээврийн хэрэгсэл, орон байр хураах, тусгайлан олгосон эрх хасах /тээврийн хэрэгсэл жолоодох, баривчлах/ гэсэн 4 шийтгэл ногдуулж байна.

Гэтэл "Өрсөлдөөний тухай" 2010 оны 6 сарын 10-ны өдрийн хуульд аж ахуйн эрхлэгчийг тухайн бараа бүтээгдэхүүний өмнөх жилийн борлуулалтын орлогын 6 хүртлэх хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, 20.000.000 хүртэл төгрөгөөр торгох гэх мэт Захиргааны хариуцлагын тухай ерөнхий хуультай зөрчилдсөн заалт, захиргааны шийтгэлийн шинэ төрлийг буй болгожээ. Захиргааны хариуцлагын тухай хуульд мөнгөн торгуулийн хэмжээг зөрчиж байна.

Дөрөв. Захиргааны хариуцлагын хуулийн хэрэгжилт, үр нөлөөний асуудалд нэлээдгүй бэрхшээл, давхардал үүсгэдэг хууль бол Монгол Улсын Эрүүгийн хууль мөн. Учир нь Захиргааны хариуцлагын хуульд заасан захиргааны зөрчил болон Эрүүгийн хууль дахь гэмт хэргийн хоорондын ялгаатай шинжийн асуудал өнөөдөр чухал сэдэв болоод байна.

Тав. Захиргааны зөрчилтэй холбоотой хэм хэмжээ олон хуульд тусгагдсан байна. 197 хуулиас захиргааны зөрчилтэй холбоотой хэсгийг төрөлжүүлэн нэгтгэж ЗХТХ-д ямар нэг байдлаар тусгах, эсхүл зөвхөн нийтлэг хэм хэмжээ, ерөнхий ангийн заалт уг харилцааны эрх зүйн үндсийг

тусгаж, захиргааны зөрчил хянан шийдвэрлэх ажиллагааг бүхэлд нь нэгтгэх зэрэг асуудлыг шийдвэрлэх, түүнчлэн захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулсан заалтуудыг ч оруулж өгөх, хууль гаргах талаар шийдвэрлэх хэрэгтэй байгаа юм. Энэ үүднээс энэхүү 197 хуулиас түүвэрлэсэн захиргааны зөрчлийн бүрэлдэхүүнийг төрөлжүүлэн нэгтгэх анхны оролдлогыг хийлээ.

Зургаа. Судалгааны ажлын хүрээнд "Захиргааны хариуцлагын тухай хууль"-ийн талаар хуульчдаас 16 асуулт бүхий санал асуулгын хуудсаар санал авсан болно. Асуулгад нийт 581 хуульч хамрагдсан байна.

Долоо. Гадаад орнуудын ижил төрлийн харилцааг зохицуулсан хуулиудаас захиргааны хариуцлага ногдуулах эрх бүхий албан тушаалтны эрх зүйн байдал.

Найм. Захиргааны хариуцлага хүлээлгэх эрх бүхий албан тушаалтны давхардсан харьяалалын байдал зэргийг судалсан ба дэлгэрэнгүй байдлаар /хавсралтыг/ ХЗҮХ-ийн номын сангаас үзнэ үү.

IV. ЗАХИРГААНЫ ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ БҮРТГЭХ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ХЯНАЛТЫН ТАЛААРХ ЗОХИЦУУЛАЛТЫН СУДАЛГАА

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захиргаа, хүмүүнлэгийн эрх зүйн секторт голчлон гүйцэтгэж буй "Захиргааны хариуцлагын тухай хуулийн биелэлт" сэдэвт судалгааны удирдамж, төлөвлөгөөний дагуу "Захиргааны хэрэг бүртгэх ажиллагаа, түүнд тавих хяналт"-ын талаарх зохицуулалтыг ЭЭЗКС-т тусгайлан судлав.

4.1. Судалгааны зорилго, ач холбогдол

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, түүнд тавих хяналтын тухай асуудал дотоодын хууль тогтоомжид одоо хэр нэг мөр, хангалттай зохицуулагдаагүй байна. Үүнд:

1992 онд батлагдсан Захиргааны хариуцлагын тухай хууль /11-19 дүгээр зүйл/-д захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг маш ерөнхий байдлаар тусгасан бөгөөд зөрчил хянан шалгах, шийдвэрлэх ажиллагаанд прокурор хяналт тавих тухай заалт огт байхгүй юм.

Монгол Улсын Үндсэн хуулиар прокурорын байгууллагын чиг үүрэгт томоохон өөрчлөлт оруулсны дотор "...байгууллага, албан тушаалтан, ард иргэдээс хуулийг хэрхэн нарийн чанд биелүүлж буй эсэхэд тавих хяналт..." буюу прокурорын ерөнхий хяналтын чиг үүрэг үгүй болжээ.

Шинэ Үндсэн хуульд нийцүүлэн Прокурорын байгууллагын тухай хуулийг батлахад "Захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд тавих прокурорын хяналт" /1993 онд батлагдсан Прокурорын байгууллагын тухай хуулийн 10 дугаар зүйл/ гэх хяналтын үйл ажиллагааны шинэ хэлбэрийг хуульчилсан байна. Гэвч "Захиргааны хэрэг бүртгэх ажиллагаа" хэмээх хууль зүйн шинэ ойлголт нь Захиргааны хариуцлагын тухай хуулийн "захиргааны зөрчил хянан шалгах ажиллагаа"-тай нэг адил ойлголт ууд, аль эсхүл өөр өөр ойлголт уу гэдэг нь тодорхой бус хууль тогтоогчийн зүгээс үүнд нэг мөр хариулт өгөлгүй эдүгээ хүрчээ. Үүнд: Захиргааны хариуцлагын тухай хуулийг

дагаж мөрдсөнөөс хойшх хугацаанд хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь их төлөв захиргааны журам зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйн шинэ хэлбэрүүдийг тодорхойлох, тэдгээрт ногдуулах захиргааны шийтгэлийн төрөл, хэмжээг тогтоох, шийтгэл ногдуулах эрх бүхий этгээд /субъект/-ийн хүрээг өргөтгөхөд чиглэсэн байх бөгөөд Прокурорын байгуулагын тухай хуулийг 2002 онд шинэчлэн батлахад "захиргааны хэрэг бүртгэх ажиллагаанд тавих хяналт" мөн хэвээр үлджээ.[25]

Харин 2002 онд баталж, 2004 оны 6 дугаар сарын 1-нээс мөрдсөн Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны шүүх байгуулах тухай хуулиар иргэн, хуулийн этгээдийг захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус үйл ажиллагаа, шийдвэрээс хамгаалах журам тогтоож, түүнийг хангах үүрэг бүхий төрөлжсөн захиргааны шүүхийн тогтолцоо бий болгожээ.

Гэвч Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар захиргааны байгууллага, албан тушаалтны ***нэгэнт гаргасан шийдвэр /үйл ажиллагаа/-т*** иргэн, хуулийн этгээд гомдол гаргах, тэрхүү гомдлыг дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан урьдчилан шийдвэрлэх болон шүүхийн журмаар хэргийг эцэслэн шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан учраас захиргааны зөрчил /үйлдэл, эс үйлдэхүй/-ийг хянан шийдвэрлэх анхан шатны ажиллагааны журамд ямар нэг өөрчлөлт хийгдээгүй болно.

Иймд захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор хяналт тавих эсэх, захиргааны хэрэг бүртгэх ажиллагаанд эрх бүхий байгууллага, албан тушаалтны чухам ямар үйл ажиллагааг хамааруулж ойлгох, түүнчлэн прокурор хяналт тавих бол тэрхүү хяналтын зорилго юу болохыг тодруулах, цаашид уул асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар санал, зөвлөмж боловсруулахад энэхүү судалгааны ач холбогдол оршино.

4.2. Хуулиудын харьцуулсан дүн шинжилгээ

4.2.1.Захиргааны зөрчлийн хянан шийдвэрлэх ажиллагаа

Захиргааны хариуцлагын тухай хуулийн 11-19 дүгээр зүйлд заасан захиргааны зөрчлийг хянан шалгаж, шийдвэрлэх журам /процесс ажиллагаа/-ыг баримтлан мөн хуулийн 7 дугаар зүйлд заасан захиргааны хариуцлага хүлээлгэх эрх бүхий албан тушаалтан /шүүгч, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга, цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан, улсын байцаагч зэрэг 11 субъект/ зөрчлийг хянан шалгах ажиллагаа явуулдаг байна. Ингэхдээ зөрчлийн шинж байдлаас шалтгаалж зөрчил гаргасан этгээдийн биед болон эд зүйлд үзлэг хийх, эд зүйл, баримт бичиг түр хураах, шаардлагатай бол зөрчил гаргасан этгээдийг захиргааны журмаар албадан саатуулах, захиргааны таслан сэргийлэх арга хэмжээ авах зэрэг хянан шалгах ажиллагааг 14 хоногийн дотор /тухайн эрх бүхий байгууллагын удирдлага

[25] 1993 оны 10 дугаар сарын 21-ний, мөн оны 12 дугаар сарын 21-ний, 1994 оны 7 дугаар сарын 8-ны, 1995 оны 4 дүгээр сарын 17-ны, 1997 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар зөрчил гаргасан этгээдийг захиргааны журмаар албадан саатуулах, албадан саатуулах байрны дэглэм, журам, үзлэг хийх зэрэг асуудлаар Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

нэмж 14 хоногоор сунгаж болно/ явуулж, мөн хуулийн 4 дүгээр зүйлд заасан захиргааны шийтгэлийн аль тохирохыг сонгож хэрэглэнэ. Зарим тохиолдолд зөрчлийг илрүүлмэгц буруутай этгээдэд тухай бүрт нь хариуцлага ногдуулах тохиолдлуудад зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаа хялбар явагдах талтай.

Мөн хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар захиргааны шийтгэл ногдуулсан шийдвэрийг зөрчил гаргагч, хохирогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч буюу өмгөөлөгч давж заалдах гомдол гаргах эрхтэй бөгөөд гомдлыг дээд шатны байгуулагад нь буюу дээд шатны шүүхэд, эсхүл дээд шатны албан тушаалтанд гаргахаар байна. Давж заалдах гомдол гаргах дээрх журам нь эрх бүхий албан тушаалтны нэгэнт гаргасан шийдвэрт гомдол гаргах тохиолдолд хамаатай ба түүнээс өмнөх үе шатанд буюу захиргааны зөрчлийг шалгах явцад зөрчил гаргасан гэж сэрдэгдэж буй этгээд болон "захиргааны процесс"-ын бусад этгээд хэрхэн гомдоллох, түүнийг хэн хэрхэн шийдвэрлэх талаар хуульд тусгайлан зохицуулаагүй.

Хуулийн энэхүү цоорхой /хийдэл/-г Прокурорын байгууллагын тухай хуулийн "захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд тавих хяналт"-ын тухай заалтаар нөхөж зохицуулсан гэж үзэх боломжгүй юм.

Харин энэ хийдэл 10 жилийн дараа буюу 2002 онд батлагдсан Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар ямар нэг хэмжээгээр зохицуулагдсан гэж үзэж болохоор байна.

Дээр дурдсанаас үзвэл захиргааны зөрчлийг хянан шалгаж, шийдвэрлэх ажиллагаа болон эрх бүхий албан тушаалтны шийдвэрт зөвхөн зөрчил гаргасан этгээд, хохирогч буюу тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч нь гомдол гаргаж болох ба гомдол гаргаагүй тохиолдолд эрх бүхий албан тушаалтны шийдвэрийн буруу зөвийн тухай өөр хэн ч давж заалдах, гомдол гаргах эрхгүй байна. Өөрөөр хэлбэл, прокурор захиргааны зөрчлийн хянан шалгах болон шийдвэрлэх ажиллагаанд хяналтын болон бусад үүрэг гүйцэтгэж шууд оролцох зохицуулалт Захиргааны хариуцлагын тухай хуульд тусгагдаагүй байна[26].

4.2.2.Захиргааны хэрэг бүртгэх ажиллагаа, түүнд тавих прокурорын хяналт

Монгол Улсын Үндсэн хуулийн 56 дугаар зүйлийн 1-д "Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно" гэж прокурорын үндсэн чиг үүргийг маш тодорхой заажээ.

Шинэ Үндсэн хуульд прокурорын байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиг үүргүүдийг ийнхүү тодорхойлхдоо прокурор нь шүүх эрх мэдлийг хянах бус, харин түүний хүрээнд багтаж, ***эрүүгийн мөрдөн мөшгих ажиллагааны гол хөдөлгөгч хүч - "эрүүгийн заргач"-ийн*** үүрэг гүйцэтгэж байхаар болгон өөрчилсөн нь чиг үүргийн хувьд дэлхий нийтийн жишигт ойртсон гэж үзэж болохоор байна.

[26] Захиргааны хариуцлагын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт 1993 оны 10 дугаар сарын 21-ийн өдрийн хуулиар оруулсан "Улсын хилийн дэглэм зөрчигчийн хувийн байдлыг нотлох баримт бичиггүй тохиолдолд прокурорын зөвшөөрөлтэйгөөр 10 хоног хүртэл хугацаагаар саатуулж болно" гэсэн өгүүлбэрийг нэмсэн.

"Хэрэг бүртгэлт" гэдгийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн хүрээнд хөнгөн, хүндэвтэр /одоогийн хуулиар зөвхөн хөнгөн хэрэгт/ хэргийг шалгаж нотлох ажиллагаа хэмээн олонх судлаачид санал нэгдсэн байдаг. Гэтэл 1993 онд баталсан Прокурорын байгууллагын тухай хуулийн төслийг дээрх суурь үзэл баримтлалд тулгуурлан боловсруулахдаа хэрэг бүртгэх ажиллагааг "захиргааны зөрчлийн хэрэг бүртгэлт", "эрүүгийн хэрэг бүртгэлт" гэх хоёр тусдаа ажиллагаа болгон хуульд тусгажээ. Эдгээрээс Прокурорын байгууллагын тухай хуулийн 11 дүгээр зүйл буюу "Захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд тавих прокурорын хяналт"-ын тухай авч үзье.

Прокурорын хяналтын талаар прокурорын байгууллагын практик ажилтнуудын туурвисан судалгааны бүтээлд "***Хэрэг бүртгэх гэдэг нь эрх бүхий албан тушаалтан гэмт хэрэг болон захиргааны зөрчлийн тухай үйл баримтыг хууль тогтоомжийн дагуу анхлан шалгаж, нотлох баримтыг бэхжүүлж байгаа үйл ажиллагаа юм***"[27]. "***Хэрэг бүртгэлт нь эрүүгийн болон захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаа гэсэн 2 төрөлтэй***"[28], "***Захиргааны хэрэг бүртгэх ажиллагаа гэдэг нь эрх бүхий албан тушаалтан захиргааны зөрчилтэй холбоотой үйлдэл, эс үйлдэхүйг шалгаж баримтаар нотлох ажиллагаа***"[29] мөн гэж дүгнэжээ.

Энэхүү дүгнэлтээр "захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаа" гэдэг нь "захиргааны зөрчлийг хянан шалгах ажиллагаа"-тай агуулгын хувьд адил ойлголт гэж судлаачид үзсэн байна.

Прокурорын байгууллагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн задлан шинжилгээ, дүгнэлт

11.1. Прокурор захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх дараах ажиллагаанд хяналт тавина:

11.1.1. төрийн захиргааны эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх талаар явуулж байгаа ажиллагаа хуульд нийцэж байгаа эсэх;

11.1.2. захиргааны журмаар таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх, түр саатуулах болон албадан саатуулах ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаж байгаа эсэх;

11.1.3. түр саатуулах болон албадан саатуулах шийдвэрийг биелүүлэх ажиллагаа хуулиар тогтоосон нөхцөл, журамд нийцэж байгаа эсэх.

Дээрх заалтыг захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд прокурор хяналт тавихдаа эдлэх бүрэн эрхийн талаарх заалт /11.2./-тай багцалж авч үзвэл хуульд заасан эрх бүхий албан тушаалтны захиргааны зөрчлийг хянан шалгах, цаашилбал хянан шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавих нэрээр прокурор маш гүнзгий оролцож болохоор байна. Тухайлбал: прокурор захиргааны эрх бүхий байгууллагад гомдол, мэдээлэл хүлээн авч, шалгах үеэс нь эхлэн шалгаж шийдвэрлэх гэж буй материалыг татаж хянах, танилцах, тодорхой үүрэг гүйцэтгүүлэхээр даалгавар өгөх зэргээр

[27] Б.Цэрэнбалтав, Б.Амарбаясгалан нар. Прокурорын хяналт, УБ., 2009 он, 162 дахь тал.
[28] Прокурорын ном. Прокурорын гарын авлага. Хамтын бүтээл. УБ., 2001 он, 14 дэх тал
[29] Прокурорын байгууллагын тухай хуулийн тайлбар. Хамтын бүтээл. УБ., 2003 он, 16 дахь тал

ажиллагаанд оролцож, тэр ч байтугай ногдуулсан захиргааны шийтгэлийг хүчингүй болгох хүртэл эрх эдлэхээр байна. Өөрөөр хэлбэл, прокурор нь хяналт тавих нэрээр захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд өөрийн үзэмжээр, шууд хутгалдан оролцох бүрэн боломжтой харагдаж байна.

Захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд тавих хяналтын талаар гаргасан удирдамжийн баримт бичгийн талаар

Захиргааны зөрчлийг хянан шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналтын талаар Захиргааны хариуцлагын тухай хуульд заалт байхгүй тул Монгол Улсын Ерөнхий прокурорын тушаалаар "Захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд тавих прокурорын хяналтын аргачилсан заавар"-ыг хэд хэдэн удаа /2000, 2007 он/ батлан мөрдүүлж, захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэх эрх бүхий бусад байгууллага /албан тушаалтан/, Тухайлбал: Улсын мэргэжлийн хяналтын газартай хамтран "Мэргэжлийн улсын хяналтын байцаагчаас захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаа явуулах, түүнд прокурор хяналт тавих журмыг 2004 онд батлажээ. Эдгээр заавар, журам нь захиргааны зөрчлийг хянан шалгах ба хянан шийдвэрлэх ажиллагаа, тэдгээрт тавих хяналтын талаар Захиргааны хариуцлагын тухай хуульд үгүйлэгдэж буй зохицуулалтыг нөхөх зорилготой бөгөөд прокурор мөнхүү ажиллагаанд маш өргөн оролцоотой байхаар заажээ. Тухайлбал: Ерөнхий прокурорын 2000 оны 34/б дугаар тушаалаар баталсан аргачилсан зааврын дагуу прокурор нь:

нэгдүгээрт: Захиргааны хариуцлагын тухай хууль, улсын мэргэжлийн хяналтын албадын дүрмийн биелэлтийг шалгах,

хоёрдугаарт: эрх бүхий албан тушаалтнаас захиргааны шийтгэл ногдуулсан шийдвэрийн хууль ёсны үндэслэлийг хянах,

гуравдугаарт: эрх бүхий байгууллага, албан тушаалтан захиргааны шийтгэл ногдуулах үйл ажиллагаандаа хууль хэрхэн биелүүлж байгааг судлах хэлбэрээр хяналт хэрэгжүүлэх ба ингэхдээ шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар мэдэгдэл бичиж, буруутай албан тушаалтанд арга хэмжээ авахуулах, захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаа явуулсан материалыг нэг бүрчлэн хянаж, бүртгэл хөтлөх, 5000 төгрөгөөс дээш хэмжээгээр шийтгэвэрээр захиргааны шийтгэл ногдуулсан материалыг болон 5000 төгрөгөөс доош хэмжээгээр торгуулийн хуудсаар захиргааны шийтгэл ногдуулсан боловч уул зөрчилд хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулсан бол заавал хянаж байх, хянах хугацаа нь 20 хоногоос илүүгүй байхаар тус тус журамлан тогтоожээ. Түүнчлэн захиргааны журмаар албадан саатуулах, таслан сэргийлэх арга хэмжээ авах шийдвэрийн үндэслэл, мөнхүү шийдвэрийг хэрэгжүүлэх ажиллагаа хуулиар тогтоосон нөхцөл, журамд нийцэж буй эсэхэд өргөн хэмжээний хяналт /агуулгаараа дээд хяналт/ тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар прокурорын бүхий л арга хэрэгслийг ашиглах боломжтой байхаар зааварлажээ.

Ерөнхий прокурорын 2007 оны 270 дугаар тушаалаар аргачилсан зааврыг шинэчилсэн боловч прокурорын хяналтын арга, хэлбэрийн талаарх үндсэн заалтууд хэвээр үлджээ.

Аргачилсан зааварт заасанчлан захиргааны зөрчлийг хянан шалгах ажиллагааны материалыг прокурор нэгбүрчлэн, тухай бүр нь хянах боломжтой эсэх нь эргэлзээтэй. Тухайлбал, зөвхөн цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтнууд 2009 онд 90.0 гаруй мянган хүнд захиргааны шийтгэл ногдуулжээ. Энэ статистик үзүүлэлт дээр мэргэжлийн хяналтын улсын байцаагчид болон захиргааны шийтгэл ногдуулах эрх бүхий бусад албан тушаалтны шалгаж шийдвэрлэсэн захиргааны зөрчил, түүнд ногдуулсан шийтгэлийн тухай үзүүлэлтийг нэмбэл улсын хэмжээнд бага бус тоо гарах нь ойлгомжтой юм.

Прокурорын байгууллагын тайлан мэдээнд дурдсанаар прокурорууд 2007 онд 89749, 2008 онд 85072, 2009 онд 110760, сүүлийн гурван жилд дунджаар 95.0 мянга гаруй материал хянаснаас 707 буюу 0.7 хувьд нь шийтгэврийг үндэслэлгүй гэж үзэж хүчингүй болгож, өөрчилсөн ба 53 эрүүгийн хэрэг үүсгэн шалгуулжээ. ***Үүнээс үзвэл прокурорууд маш олон тооны захиргааны зөрчлийн материал хянаж ихээхэн цаг, хүч зарцуулж байгаа боловч хэрэг бүртгэлтийн ажиллагаанд тавих прокурорын хяналтын үр нөлөө төдийлөн өндөр биш байна***[1].

Прокурор өөрөө энэ байдалд дүгнэлт хийж, захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд тавих хяналтыг нилээд хялбаршуулах шийдвэр 2010 оны эхээр гаргажээ. Тухайлбал, Ерөнхий прокурорын 2010 оны 35 дугаар тушаалаар захиргааны хэрэг бүртгэх ажиллагаанд дараах байдлаар хяналт тавина. Үүнд:

- Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын гомдол, хүсэлт, мэдээллийг үндэслэн төрийн захиргааны эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас явуулж буй захиргааны зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа хуульд нийцсэн эсэх асуудлыг Захиргааны хариуцлагын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан хугацааны дотор хянан шийдвэрлэх,
- Төрийн захиргааны эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас явуулж буй захиргааны зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг дээд шатны прокуророор батлуулсан удирдамжийн дагуу шалгах,
- Төрийн захиргааны эрх бүхий байгууллагаас гэмт хэргийн шинжтэй эсэхийг хянуулахаар ирүүлсэн материалыг хянах.[30]

Энэхүү шинэ журмаар прокурор захиргааны зөрчлийг хянан шалгах ажиллагааны буюу захиргааны зөрчлийн хэрэг бүртгэлт явуулсан материалыг нэг бүрчлэн хянах арга барилаасаа татгалзаж, зөвхөн гомдол, мэдээлэл ирүүлсэн тохиолдолд материалыг хянах болсон боловч, эрх бүхий захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хутгалдан оролцох ерөнхий үзэл санаа, баримтлал хэвээр үлдсэн байна.

[30] Ерөнхий прокурорын 2010 оны 35 дугаар тушаалд дээрх дүгнэлтийг хийжээ.

Санал, зөвлөмж

1.Төрийн захиргааны байгууллага, албан тушаалтны гүйцэтгэж буй захиргааны зөрчлийн хянан шалгах болон хянан шийдвэрлэх ажиллагаанд "захиргааны зөрчлийн хэрэг бүртгэлт, түүнд тавих хяналт" нэрээр өргөн оролцоотой байх нь Үндсэн хуулиар тодорхойлсон прокурорын байгууллагын одоогийн чиг үүрэгт бүрнээ нийцэхгүй байна.

2.Прокурор захиргааны зөрчлийг хянан шалгах ажиллагаанд хяналт тавих практик шаардлага нь эрх бүхий албан тушаалтан гэмт хэргийн шинжтэй үйлдлийг нуун дарагдуулж, захиргааны шийтгэл ногдуулсан гэх нэрийн дор халхавчлан ял завшуулж, гэмт этгээдийг эрүүгийн хариуцлагаас зайлсхийх боломж олгохоос сэргийлэх зорилтоос үүдэлтэй.

3.Захиргааны зөрчлийг хянан шалгах, шийдвэрлэх ажиллагаанд тавих хяналт нь прокурорын хяналтаар бус харин иргэний зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар гаргасан гомдол, нэхэмжлэлийн дагуу захиргааны журмаар урьдчилан шийдвэрлэх болон уул захиргааны хэргийг захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэх журмаар хэрэгжих боломжтой.

Иймд:

нэгдүгээрт: эрх бүхий албан тушаалтнаас явуулж буй захиргааны зөрчлийг хянан шалгах, шийдвэрлэх ажиллагааны журмыг Захиргааны хариуцлагын тухай хуульд маш дэлгэрэнгүй тусгаж өгөх, энэ талаар "***Дүрэм, журам, заавар"*** нэртэй, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон олон дэд актаар янз бүрийн журам тогтоодог явдлыг таслан зогсоох;

хоёрдугаарт: Прокурорын байгууллагын тухай хуулиас захиргааны хэрэг бүртгэлтийн тухай заалтыг хасч, төрийн захиргааны эрх бүхий байгууллага, албан тушаалтан захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад илрүүлсэн гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйн тухай мэдээлэл, материалыг прокурорт нэн даруй мэдэгдэж, шилжүүлэн хянуулах журмыг Эрүүгийн байцаан шийтгэх хуультай уялдуулан Захиргааны хариуцлагын тухай хуульд тусгах;

гуравдугаарт: Эрүүгийн хуульд заасан зарим гэмт хэрэг, Захиргааны хариуцлагын тухай хууль болон холбогдох бусад хуульд заасан захиргааны зөрчлийн ялгаа заагийг холбогдох хуулиудад тодорхой болгох арга хэмжээ авахыг санал болгож байна.

Дүгнэлт

1.Захиргааны хариуцлагын тухай хууль бусад хуульд заасан захиргааны шийтгэл хоорондоо давхардах нь элбэг байна. Тухайлбал: ЗХТХ-ийн 41 дүгээр зүйл болон Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн 13 дугаар зүйл 13.2 дахь заалт. Захиргааны хариуцлагын тухай хууль дахь торгууль ногдуулсан зүйл хэсэг бусад хуульд торгууль ногдуулсан зүйл хэсэг давхардах, зөрөх явдал байгаа тул цаашид нэг мөр цэгцлэх шаардлага байна.

2.Өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөж буй хуулиудаас захиргааны хариуцлага тогтоосон хэм хэмжээ бүхий 197 хууль байгаагаас захиргааны зөрчлийг нийгмийн харилцааны обьектоор нь төрөлжүүлэн нэгтгэж, Захиргааны хариуцлагын төрөлжсөн хууль гаргаж түүний тусгай ангийг эдгээр хэм хэмжээнээс бүрдүүлэх боломжтой байна. Судалгааны ажлын хүрээнд хуульчдаас авсан санал асуулгаас үзэхэд нийт 424 хуульч оролцсоноос 293 буюу 69% нь Захиргааны хариуцлагын төрөлжсөн хуультай байх нь зүйтэй гэж үзсэн байна. 131 буюу 31% нь одоогийн хуулийг хангалттай гэж үзжээ. Судлаачдын хувьд мөн энэ байр суурийг дэмжиж байна.

3.Мөнгөн торгуулийн доод болон дээд хэмжээг, түүнчлэн иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллагад ногдуулах торгуулийн хэмжээ хязгаарыг хуульд заасан хэмжээнээс хэтрүүлсэн байдал цөөнгүй байна.

4.ЗХТХ-ийн нийт 38 зүйл, хэсэг нь эрүүгийн хууль тогтоомжтой давхардаж, эрх зүйн хэм хэмжээний давхардал, зөрчилдөөн бий болгож байна.

5.Захиргааны шийтгэл хүлээлгэх болон захиргааны шийтгэл хүлээх субъект тодорхой бус байх тохиолдлууд байна.

6.ЗХТХ-ийн 21, 22, 25-р зүйлд заасан зөрчилд авч буй захиргааны шийтгэл нь зөрчил гаргагчид үзүүлэх цээрлэлийн нөлөөлөл багатай, захиргааны арга хэмжээ авагдсан этгээд дахин энэ төрлийн захиргааны зөрчил гаргах явдал олонтаа байна. Жишээ нь: Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох явдал улсын хэмжээнд буурахгүй, торгуулийн хэмжээний заалт нь зөрчилд гаргагчид нөлөөлөх эдийн засгийн нөлөөлөл болж чадахгүй байна. ЗХТХ-ийн "удаа дараа" гэж заасан заалт нь хэдэн удаа зөрчил гаргасныг хэлэх вэ? гэдэг асуудал тодорхойгүй байна.

7. 1992 онд батлагдан хүчин төгөлдөр болсон "Монгол Улсын Захиргааны хариуцлагын тухай хууль" нь өнөөдөр захиргааны зөрчил, түүнийг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулж байгаа бөгөөд энэхүү хуульд эрх зүйн шинэтгэлийн хүрээнд 1995,1997, 2004, 2006 онуудад нийт 30 гаруй удаа нэмэлт, өөрчлөлт оруулж байсан ч зарчмын шинжтэй шинэчлэлт төдийлөн хийгдээгүй байна.

8.Төрийн захиргааны байгууллага, албан тушаалтны гүйцэтгэж буй захиргааны зөрчлийн хянан шалгах болон хянан шийдвэрлэх ажиллагаанд "захиргааны зөрчлийн хэрэг бүртгэлт, түүнд тавих хяналт" нэрээр өргөн оролцоотой байх нь Үндсэн хуулиар тодорхойлсон прокурорын байгууллагын одоогийн чиг үүрэгт бүрнээ нийцэхгүй байна.

Прокурор захиргааны зөрчлийг хянан шалгах ажиллагаанд хяналт тавих практик шаардлага нь эрх бүхий албан тушаалтан гэмт хэргийн шинжтэй үйлдлийг нуун дарагдуулж, захиргааны шийтгэл ногдуулсан гэх нэрийн дор халхавчлан ял завшуулж, гэмт этгээдийг эрүүгийн хариуцлагаас зайлсхийх боломж олгохоос сэргийлэх зорилтоос үүдэлтэй.

Захиргааны зөрчлийг хянан шалгах, шийдвэрлэх ажиллагаанд тавих хяналт нь прокурорын хяналтаар бус харин иргэний зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар гаргасан гомдол, нэхэмжлэлийн дагуу захиргааны журмаар урьдчилан шийдвэрлэх болон уул захиргааны хэргийг захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэх журмаар хэрэгжих боломжтой.

9.Захиргааны хариуцлага хүлээлгэх эрх бүхий албан тушаалтан хэт олон байгаа /11/ нь судалгааны дүнгээс харагдаж байна. Санал асуулгад 498 хуульч хариулт өгснөөс хариуцлага хүлээлгэх албан тушаалтны тоог багасгах нь зүйтэй гэж 209 буюу 41.9% нь, хариуцлага хүлээлгэх албан тушаалтан олон байна гэж 125 буюу 25.1% хувь хариулсан байна. Иймд цөөрүүлэх шаардлага байгааг хуульчид зөвшөөрч байна.

10.Захиргааны хариуцлага хүлээлгэх эрх бүхий албан тушаалтны хянан шийдвэрлэх хэргийн харьяаллын тухайд шүүхээс олон төрлийн захиргааны зөрчил шийдвэрлэж байгааг багасгах, хүний эрх, эрх чөлөөг ноцтой хөндсөн цөөн зөрчлийг */зөвхөн баривчлах шийтгэл/* харьяалуулан үлдээх нь оновчтой гэж үзэж байна.

11.Үүнтэй холбон тэмдэглэхэд "Ханнс Зайделийн сан"-гийн "Төр эрх зүйн хуудас-эргэцүүлэл" сэтгүүлд /2010 оны №37/ ХБНГУлсын Гегансбургийн их сургуулийн профессор Фридрих-Кристиан Шредёрын зөвлөмжид энэ талаар **"Иргэд нь орлого багатай, ядуу амьдралтай орнуудад баривчлах шийтгэлийг ногдуулах зайлшгүй шаардлага тулгардаг байж болох юм"** гэсэн санааг дэвшүүлжээ. Цаашилбал захиргааны шийтгэлийн төрөлд шинээр сануулах шийтгэлийг нэмж оруулах нь зүйтэйг судалгаанд оролцогчдын 69.4% нь дэмжжээ.

Энэ нь манай өнөөгийн нийгэм эдийн засгийн амьдрал, соёл иргэншил, хүн амын эрх зүйн ухамсрын хүрсэн түвшин, гарч буй гэмт хэрэг, хэв журмын зөрчлийн одоогийн байдал, хандлага зэргээс үүдэн захиргааны баривчлах шийтгэлийг нэг хэсэгтээ хэвээр үлдээх нь зөв. Хэрэв захиргааны баривчлах шийтгэлийг хасвал оронд нь таслан зогсоох албадлагын арга хэмжээ болох албадан хөдөлмөрлүүлэхийг захиргааны шийтгэлийн хэлбэрээр ногдуулах өөр нэг хувилбар байж болох юм.

12.Хэв журам хамгаалах олон нийтийн байцаагч, цэргийн штабын даргыг энэ албан тушаалаас хасах, төрийн тусгай хамгаалалтын гадуур хамгаалалтын албан хаагчийн эрхийг цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтанд, байгаль хамгаалагчийн эрхийг байгаль орчны хяналтын улсын байцаагчид шилжүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Ингэснээр захиргааны хариуцлага хүлээлгэх эрх бүхий албан тушаалтны тоо цөөрнө.

Санал

Захиргааны хариуцлага тогтоосон хэм хэмжээг төрөлжүүлэн Захиргааны хариуцлагын тухай төрөлжсөн нэг хуульд хуульчлах саналыг захиргааны эрх зүйн эрдэмтэн судлаачид нилээд эртнээс дэвшлүүлж ирснийг анхааран үзэх шаардлагатай. Захиргааны зөрчлийн тухай тодорхойлолт өгөх, зарчим, хуулийн зорилтыг шинээр тодорхойлох ялангуяа захиргааны зөрчилтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгыг оруулж өгөх зайлшгүй шаардлагыг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна.

1.ЗХТХ-ийн Ерөнхий ангийн заалтанд тус хуулийн зорилт хэсэгт олон улсын нийтээр зөвшөөрсөн хэм хэмжээ болон, баримтлах зарчмууд ялангуяа гэм буруугүйн презумпци, эрх тэгш байх зарчим, захиргааны хариуцлагын тухай хуулиар хамгаалагдах харилцаа, хуулийн үйлчлэх хэмжээ хязгаар, орон зай, цаг хугацаа, гадаадын иргэд, харьяалалгүй этгээд, гадаадын хуулийн этгээдэд захиргааны хариуцлага хүлээлгэх, мансуурсан үед хүлээлгэх захиргааны хариуцлагыг хэрхэн авч үзэх, захиргааны шийтгэлийн зорилго, төрөл, хэлбэрийг боловсронгуй болгох талаар оруулах.

2.Захиргааны зөрчлийн тухай ойлголт, мөн чанар, нутаг дэвсгэрт нийтээр дагаж мөрдүүлэхээр тогтоосон журмыг зөрчсөн, нийгэмд хор уршигтай, гэм буруутай, захиргааны шийтгэл хүлээлгэх үйлдэл, эс үйлдэхүй, ЗХТХ-иар хамгаалагдаж байгаа нийгмийн харилцаа болох хүний эрх, эрх чөлөө, эрүүл мэнд, хүн амын аюулгүй байдал, нийгмийн ёс суртахуун, байгаль орчин, түүнчлэн захиргааны журам зөрчсөн талаас нь хуульд оруулахдаа бүлэглэн тусгай ангид оруулахаар тусгах, ЗХТХ-ийн тусгай ангид оруулж өгөх, захиргааны зөрчлүүдийг эрүүгийн хууль тогтоомжтой давхардуулахгүй байх, эрүүгийн гэмт хэргийн шинжийг ялимгүй агуулсан, нийгмийн хор аюул багатай хэргүүдийг захиргааны зөрчилд оруулж болохоор тодорхой зааж өгөх, Эрүүгийн хууль, ЗХТХ нь харилцан бие биеэ нөхөж байхаар зохицуулалт хийх.

3.Захиргааны шийтгэвэрээр торгууль хүлээлгэх асуудлыг нэг мөр цэгцлэх, зөрчил гаргагчид үзүүлэх эдийн засгийн нөлөөллийг дээшлүүлэх үүднээс тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний хэмжээнээс хамааралтай, эсхүл хэдээс хэдэн төгрөгөөр торгох гэсэн хэлбэрийн аль нэгийг сонгож ижилсүүлэх. Мөнгөн торгуулийн доод болон дээд хэмжээг, түүнчлэн иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллагад ногдуулах торгуулийн хэмжээ хязгаарыг хуульд заасан хэмжээнээс зөрүүлэхгүйгээр салбар хуулиудад янз бүр байгааг ЗХТХ-д нийцүүлэн хуульчлах.

4.Хуульд заасан "удаа дараа гэдгийг 2 ба түүнээс дээш" гэж тодорхойлох.

5.Захиргааны зөрчлийн нэгдсэн сан байгуулах талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудын саналыг авч, энэ төрлийн мэдээллийн бааз, судалгааны байгууллагыг байгуулах чиглэлийг баримталж ажиллах;

6.Захиргаанд шийтгэл хүлээлгэх болон захиргааны шийтгэл хүлээх субъект тодорхой бус заалт байгааг анхаарч тодорхой болгох.

7.Бага хэмжээтэй ашиглан шамшигдуулах гэдгийг Эрүүгийн хуульд заасан байдлаар ойлгож, хэрэв бага хэмжээтэйгээр, бусдын эд хөрөнгийг

залилан мэхэлж авах, бусдын эд хөрөнгийг завших үрэгдүүлэх, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийг үйлдсэн бол ЗХТХ-иар ашиглан шамшигдуулах гэмт хэрэгт тооцож, давтан үйлдсэн, бага хэмжээнээс дээш буюу үлэмж хэмжээтэйгээр үйлдсэн бол эрүүгийн гэмт хэрэгт үзэж байхаар Эрүүгийн хуульд тусгах.

8.Эрх бүхий албан тушаалтнаас явуулж буй захиргааны зөрчлийг хянан шалгах, шийдвэрлэх ажиллагааны журмыг Захиргааны хариуцлагын тухай хуульд маш дэлгэрэнгүй тусгаж өгөх, энэ талаар "***Дүрэм, журам, заавар"***-нэртэй, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон олон дэд актаар янз бүрийн журам тогтоодог явдлыг таслан зогсоох.

9.Захиргааны шийтгэл хүлээлгэж байгаа торгуулийн тасалбар янз бүр байгаа нь түүнийг хуурамчаар үйлдэх, буруугаар ашиглах үйлдэл буурахгүй байгааг анхаарч захиргааны шийтгэл хүлээлгэж байгаа торгуулийн тасалбар, захиргааны шийтгэврийн хуудсыг нэгдсэн нэг стандартад оруулах.

10.Прокурорын хяналтыг зайлшгүй гэж үзэхгүй гэсэн саналтай байна. Захиргааны зөрчлийн хор уршиг, зөрчил үйлдсэн этгээдийн гэм буруу, эдийн засгийн байдалтай холбон захиргааны сануулах шийтгэлийг бий болгож болох юм. Прокурорын байгууллагын тухай хуулиас захиргааны хэрэг бүртгэлтийн тухай заалтыг хасч, төрийн захиргааны эрх бүхий байгууллага, албан тушаалтан захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад илрүүлсэн гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйн тухай мэдээлэл, материалыг прокурорт нэн даруй мэдэгдэж, шилжүүлэн хянуулах журмыг Эрүүгийн байцаан шийтгэх хуультай уялдуулан Захиргааны хариуцлагын тухай хуульд тусгах.

11.Төрийн тусгай хамгаалалтын газрын гадуур хамгаалалтын албан хаагч, харуулын захирал;

- Нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагч;
- Байгаль хамгаалагч;

-Цэргийн штабын дарга гэсэн албан тушаалтнуудыг захиргааны хариуцлага хүлээлгэх эрх бүхий субъектээс хасах саналтай байна

12.Захиргааны зөрчилд шинэ төрлийн зөрчлүүдийг нэмж оруулах;

- Сануулах /анхааруулах/;
- Албадан хөдөлмөрлүүлэх /баривчлах шийтгэлээс тусдаа/;

__oOo__

ХИЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД ХИЙСЭН СУДАЛГАА[31]

ОРШИЛ

Хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хүрээнд судалгааны ажлын удирдамжид заасны дагуу 1-2 улсын жишиг эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлахаар заасан. Энэ дагуу Хөрш залгаа орон болох ОХУ, БНХАУ-ын Хилийн тухай хуулийг судалж удирдамжид заасан асуулгад хариулт өгөх зорилт дэвшүүлсэн. Гэвч улс орнуудын Хилийн тухай хууль, хил хамгаалах байгууллагын бүтэц зохион байгуулалт нь улс үндэстний аюулгүй байдал, тусгаар тогтнолын асуудалтай шууд холбогддог учир интернэт, бусад боломжит эх сурвалжаар хайхад энэ төрлийн мэдээлэл ховор байлаа. Ялангуяа БНХАУ-ын Хилийн тухай хууль олдсонгүй. Иймд ОХУ-ын Хилийн тухай хууль, Хилийн албаны хууль болон Казакстан улсын Хилийн тухай хуулийн хүрээнд удирдамжид заасны дагуу судалгаат хийв.

Судалгааны удирдамжийн 4 дэх асуулгын хувьд Хилийн талаарх олон улсын гэрээ нь ОХУ, Монгол Улс, БНХАУ-ын хоорондын хилийн асуудлаарх Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрүүд */БНХАУ-Монгол Улсын Засгийн газар хоорондын 15 гэрээ, ОХУ Монгол Улс хоорондын 17 гэрээ/*[32] байгаа бөгөөд эдгээрийг Хилийн тухай хуулийн шинэчилсэн төсөлтэй нэг бүрчлэн харьцуулан үзэх шаардлагагүй гэж судлаачийн зүгээс үзсэн болно. Учир нь улс хоорондын хилийн гэрээгээр хилийн дэглэм, хилийг тогтоож гэрээгээр баталгаажуулдаг. Энэ дагуу ОХУ, БНХАУ-тай хилийн талаар байгуулсан хилийн гэрээтэй нийцүүлж холбогдох мэргэжлийн байгууллагаас төслийг боловсруулсан тул тухайлан энэ асуудлыг судлах шаардлагагүй юм.

Хилийн тухай хуулийг шинэчлэн найруулах гол үндэслэл шаардлага бол дотооддоо буюу хил хамгаалах байгууллагын бүтэц бүрэлдэхүүн, үйл ажиллагаа, албан хаагчдын нийгмийн хамгааллын асуудал, хил хамгаалалтад иргэдийн оролцооны асуудал зэргийг төсөлд нэлээд тусгаж ач холбогдол өгч зохицуулалт хийсэн байна. Судалгааны тайланд Улсын хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд оруулах зарим санал, зөвлөмжийг боловсруулсан болно.

1.Эрх зүйн ижил бүлд хамаарах 1-2 улсын энэ төрлийн хууль тогтоомжийн судалгаа, тухайн улсын ижил төрлийн байгууллагын үндсэн чиг үүрэг, харьяалал, бүтцийн асуудал

ОХУ-ын Хилийн аюулгүй байдлын албаны Сибирийн Холбооны тойргийн Бүс нутгийн хилийн удирдах газрын Тува, Буриад улс, Өвөр байгалийн хязгаар дахь Хилийн удирдах газруудын харьяа 3 хил хамгаалах алба, 3

[31] Энэхүү судалгааг ХЗДХЯ-наас баталсан удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэв.

[32] Хил хамгаалах ерөнхий газрын Хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн ажлын хэсгийн материалаас

хэлтэс, 38 шугамын тасгийн хүчээр хил хамгаалалтыг зохион байгуулдаг. 2007 онд ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлигаар хил хамгаалалтын дэд бүтцийг хариуцах чиг үүрэг бүхий Холбооны агентлаг шинээр байгуулан, Холбооны хилийн албандаа бүтцийн өөрчлөлт хийж, хил хамгаалалтад орчин үеийн техник хэрэгслийг нэвтрүүлэн, хилийн хэсгүүдээ техникийн хяналтын системээр төхөөрөмжилж, улсын хилийг тагнуулын аргаар хамгаалахад түлхүү анхаарч байна.[33]

ОХУ-ын Хилийн тухай хууль нь 1993 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр батлагдсан бөгөөд 11 бүлэг 45 зүйл бүхий хууль юм. Тус хууль 1994, 1996, 1999, 2000, 2001, 2003, 2004, 2005, 2006 онд тус тус батлагдсанаас хойш 17 удаа өөрчлөлт оржээ.

Харин ОХУ-ын Хилийн албаны тухай хууль 2000 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр батлагдсан байна.

ОХУ-ын Хилийн тухай хуулийн 28 дугаар зүйлд зааснаар Хилийн байгууллага нь: Холбооны аюулгүй байдлын бүрэлдэхүүнд багтаж улсын хилийг хамгаалах үүргийг хүлээдэг байна.

ОХУ-ын Хилийн албаны хуулийн дагуу ОХУ-ын хилийн алба нь Хилийн алба хариуцсан гүйцэтгэх эрх мэдлийн тусгай эрх бүхий холбооны байгууллага, хилийн цэрэг болон хилийн албаны бусад байгууллагаас бүрддэг байна.

ОХУ-ын Хилийн албаны бүрэн эрх нь:

1.Холбооны Улсын хууль тогтоомжоор Хилийн албаны эрх хэмжээнд хамааруулахаар заасан захиргааны зөрчилтэй хэрэгт хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах, хил зөрчих гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж, зохион байгуулах;

2.Холбооны Улсын хууль тогтоомжоор Хилийн албаны эрх хэмжээнд хамааруулахаар заасан захиргааны зөрчилтэй хэрэгт хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах эсхүл гэмт хэрэг үйлдсэн этгээдийг саатуулах;

3.Холбооны Улсын хууль тогтоомжид заасны дагуу цэргийн, тагнуулын, сөрөг тагнуулын, шуурхай-эрэн сурвалжлах болон бусад үйл ажиллагаа явуулах;

4.Холбооны Улсын хууль тогтоомжид нийцүүлэн ижил төрлийн чиг үүрэг гүйцэтгэдэг гадаад улсын байгууллагатай хамтран ажиллах, байгууллага хоорондын шинжтэй олон улсын гэрээ байгуулах, улсын хилийг гэрээгээр бэхжүүлэх буюу олон улсын эрх зүйн шинжтэй болгоход оролцох;

5.ОХУ-ын усан болон агаарын орон зай, нисэх буудлын нутаг дэвсгэр, нисэх буудал, тэнгисийн болон голын боомт /өмчийн хэлбэрээс үл хамааран/ зэргийг албан үүргээ гүйцэтгэх явцдаа хариу төлбөргүйгээр ашиглах, албан үүргээ гүйцэтгэх явцдаа нислэг болон усан онгоцыг ... хариу төлбөргүйгээр авах;

[33] "Монгол Улсын хил хамгаалалтын асуудал" эрдэм шинжилгээний хурал. Хил хамгаалах ерөнхий газрын дарга бригадын генерал Ц.Сэргэлэнгийн "Монгол Улсын хил хамгаалалтын өнөөгийн байдал" илтгэлээс

6.Холбооны улсын хууль тогтоомжид мэдээллийг авах тусгай журам тогтоосноос бусад тохиолдолд төрийн байгууллага, нутгийн удирдлагын байгууллага, бусад байгууллага /өмчийн хэлбэрээс үл хамааран/, төрийн бус байгууллага, ОХУ-ын иргэн, гадаад улсын иргэн, харьяалалгүй этгээдээс шаардлагатай мэдээллийг /тэр дундаа навигаци, метеорологи, гидрографи, радиоэлектроник, сансарын болон бусад/ шаардах, гаргуулан авах;

7.Төрийн байгууллага, нутгийн удирдлагын байгууллага, бусад байгууллага /өмчийн хэлбэрээс үл хамааран/, төрийн бус байгууллага/ гадаад улсын дипломат төлөөлөгчийн газар, консулын байгууллага болон олон улсын байгууллагаасаас/, мөн түүнчлэн зайлшгүй шаардлагатай тохиолдолд ОХУ-ын иргэн, гадаад улсын иргэн, харьяалалгүй этгээдээс албан үүргээ гүйцэтгэхийн тулд тэдгээрийн суваг болон хэрэгслийг саадгүй авах, ашиглах. Эзэмшигчийн шаардлагаар гарсан зардлыг нөхөн төлөх асуудлыг Холбооны улсын хууль тогтоомжоор тогтоосон журмын дагуу шийдвэрлэнэ;

8.ОХУ-ын иргэн, гадаад улсын иргэн, харьяалалгүй этгээдээс гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдлын талаар мэдүүлэг авах буюу Холбооны Улсын хууль тогтоомжоор Хилийн албаны эрх хэмжээнд хамааруулахаар заасан захиргааны зөрчилтэй хэрэгт хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах;

9.Холбооны хууль тогтоомжид нийцүүлэн төрийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай мэдээллийг үнэ төлбөргүй гаргах;

10.Төрийн байгууллага, нутгийн удирдлагын байгууллага, бусад байгууллага /өмчийн хэлбэрээс үл хамааран/, төрийн бус байгууллага, албан тушаалтанд гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлөх шалтгаан, нөхцөлийг арилгах шаардлага тавих, Холбооны Улсын хууль тогтоомжоор Хилийн албаны эрх хэмжээнд хамааруулахаар заасан захиргааны зөрчилтэй хэрэгт хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах;

11.ОХУ-ын Засгийн газраас тогтоосон журмын дагуу Хилийн албаны чиг үүргийг хэрэгжүүлэхэд сайн дурын үндсэн дээр ОХУ-ын иргэдийг татан оролцуулах;

12.ОХУ-ын Засгийн газраас тогтоосон журмын дагуу байлдааны зэвсэг, тусгай хэрэгсэл, байлдааны, тусгай болон бусад техник хэрэгсэл, мэх, албаны нохой хэрэглэх;

13.Холбооны хууль тогтоомжид заасны дагуу этгээдүүдийн бүртгэл хөтлөх, статистик мэдээлэл гаргах;

14.Холбооны хууль тогтоомжид зааснаар мэдээллийн тогтолцоо бий болгох, ашиглах;

15.Шифрлэгдсэн алба болон байгууллагын шифрлэгдсэн холбоог зохион байгуулах, улс хоорондын болон байгууллага хоорондын шифрлэгдсэн холбоог байгуулахад оролцох;

16.Холбооны хууль тогтоомжид зааснаар төрийн аюулгүй байдлыг хангахад оролцох;

17.Өөрсдийн аюулгүй байдлыг хангах зайлшгүй шаардлагатай арга хэмжээ авах;

18.Гадаад улсад байгаа ОХУ-ын дипломат төлөөлөгч болон консулын байгууллагыг хамгаалахад оролцох;

19.Холбооны хууль тогтоомжид заасны дагуу онц байдлын дэглэмийг хангах, хууль бус цэргийн нэгтгэлийг устгах, байгалийн болон техногенийн шинжтэй онцгой нөхцөл байдлын үр дагаврыг арилгахтай холбоотой хилийн бүс нутагт үүрэг гүйцэтгэхэд оролцох;

20.Холбооны хууль тогоомжид заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх.

Казакстан улсын Хилийн тухай хууль 1993 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан. Энэ хууль нь 10 бүлэг, 36 зүйлтэй.

Казакстан улсын хувьд Үндэсний аюулгүй байдлийн хорооны хилийн алба, түүний бүрэлдэхүүн хэсэг нь хил хамгаалалтын асуудлыг хариуцдаг гол байгууллага болдог. Тус улсын Хилийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д зааснаар:

Үндэсний аюулгүй байдлын хороо нь:

а/ БНКУ-ын хилийн аюулгүй байдлыг сахих үүднээс хувь хүний, нийгэм болон төрийн ашиг сонирхлыг хамгаална;

б/ БНКУ-ын хилийн аюулгүй байдлыг хөндөж болзошгүй улс орнуудын улс төрийн, санхүүгийн, нийгмийн, эрүүгийн байдал болон гамшигийн нөхцөл байдлын талаар олон улсын мэдээллийн дагуу урьдчилан таамаглан судалгаа хийх;

в/ БНКУ-ын хилийн тухай хуулийг зөрчсөн зөрчилд урьдчилсан мөрдөн байцаалт явуулах эрүүгийн хэргийг нэн түрүүнд үүсгэн шалгах, БНКУ-ын захиргааны хариуцлагын хуулийн дагуу хил дээр саатуулагдсан этгээдийг шалгахад оролцох;

г/ Үндэсний аюулгүй байдлын хорооны хилийн албыг шуурхай удирдан БНКУ-ын хилийг хамгаалан аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг байна. Бусад төрийн байгууллагын хувьд:

БНКУ-ын гадаад хэргийн яам:

а/БНКУ-ын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн БНКУ-ын хилийг давахыг зөвшөөрсөн бичиг баримтыг өгөх;

б/БНКУ-ын Үндэсний аюулгүй байдлын хорооны хилийн албаны удирдлагыг бусад улс орнуудтай болон тодорхой улс орнуудтай баримтлах боомтоор орох, гарах дэглэм болон визийн бодлогын талаар мэдээллээр хангах;

в/БНКУ-ын хил дээр гарсан маргааныг Үндэсний аюулгүй байдлын хорооны хилийн албаны хилийн төлөөлөгчөөр дамжуулан шийдэх боломжгүй бол дипломат журмаар шийдвэрлэх;

БНКУ-ын дотоод хэргийн яам:

а/ БНКУ-д байнгын оршин суудаггүй гадаадын иргэн харьяалалгүй хүнд БНКУ-ын хилийн зурвасыг давах /орох/ бичиг баримтыг бүрдүүлэх;

б/ Үндэсний аюулгүй байдлын хорооны хилийн албатай хамтран хилийн дэглэмийг сахиулах;

в/ БНКУ-ын Үндэсний аюулгүй байдлын хорооны хилийн албанд үл мэдэгдэх нөхцөл байдлын улмаас оршин суугаа газраа орхисон, гэмт хэргийн бүлэглэл болон Үндэсний аюулгүй байдлын хорооны хилийн албатай мөн БНКУ-ын хилийн зөрчилтэй иргэдийн талаар мэдээллэх;

г/ БНКУ-ыг хил, дэглэм, боомтоор гарах дэглэмийг зөрчсөн этгээдүүдийг эрэн сурвалжлахад Үндэсний аюулгүй байдлын хорооны хилийн албатай хамтран ажиллах, БНКУ-ын хилийн тухай хууль тогтоомжуудыг зөрчсөн этгээдүүдийн шалтгаант холбоог тогтооход туслах;

д/ Байгалийн гамшиг, техникийн саатал, хил зөрчсөн этгээдүүдийг хайж байгаа, зэвсэгт мөргөлдөөн, хөрш орноос БНКУ-ын хил рүү олноороо дүрвэх онцгой нөхцөлийн улмаас БНКУ-ын Үндэсний аюулгүй байдлын хорооны хилийн алба БНКУ-ын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг БНКУ-ын хил рүү түр болон удаан хугацааны туршид орохыг хориглож болно;

е/ Үндэсний аюулгүй байдлын хорооны хилийн албатай хамтран БНКУ-ын хилийн ойролцоох суурин газрын оршин суугчдад болон боомтуудад БНКУ-ын хилийн тухай хууль болон холбогдох хууль заалтуудыг тайлбарлах, ойлгуулах, ухуулан сурталчлах үйл ажиллагаа явуулах;

БНКУ-ын Батлан хамгаалах яам:

а/ БНКУ-ын агаарын орон зайг хамгаалах;

б/БНКУ-ын холбогдох хууль тогтоомжийн дагуу БНКУ-ын хилийг хамгаалахад Зэвсэгт хүчнийг оролцуулах.

в/ БНКУ-ын Гаалийн газар нь холбогдох хуулийн дагуу иргэд, тээврийн хэрэгсэл, ачаа, барааг шалган нэвтрүүлнэ.

г/ БНКУ-ын бусад байгууллагууд өөрсдийн эрх хэмжээнийхээ хүрээнд Үндэсний аюулгүй байдлын хорооны хилийн албатай хамтран БНКУ-ын хилийг хамгаалах мөн хилийн дэглэм, боомтын дэглэм, эх газрын болон ус /нуур/-ын ойролцоох дэглэмийг хянан сахиулах үйл ажиллагаанд оролцох.

Дүгнэлт, санал

Хилийн албаны бүтэц зохион байгуулалтын хувьд ОХУ нь холбооны улс тул Хилийн албадын бүтэц зохион байгуулалт, Хил хамгаалах байгууллагын тогтолцоо нь манай улсаас өргөн хүрээг хамарч байна. Казахстан улсын хувьд Хилийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд зааснаар Үндэсний аюулгүй байдлын хорооны хилийн алба голлох үүрэг гүйцэтгэнэ. Эдгээр улсын хувьд Ерөнхийлөгчийн засагтай. Ерөнхийлөгч нь гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаа тэргүүлдэг учраас хил хамгаалах асуудалд гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын эрх хэмжээ түлхүү байна. Монгол Улсад ХЗДХЯ-ны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ХХЕГ ажилладаг. Энэ нь мөн гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд хамаарч байна.

Түүнчлэн ОХУ-ын Хилийн албаны тухай 18 дугаар зүйлд зааснаар Хилийн албаны үйл ажиллагааг зохицуулж буй холбооны хууль тогтоомжийн биелэлт, Хилийн алба үйл ажиллагаандаа хууль ёсыг хэрхэн сахиж байгаад Ерөнхий прокурор хяналт тавьдаг байна. Казахстан улсын хувьд мөн прокурор ерөнхий хяналтыг хэрэгжүүлдэг. Харин манай улсын хувьд

прокурорын ерөнхий хяналт байхгүй бөгөөд прокурор зөвхөн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьдагаараа ялгаатай байна.

Хилийн дэглэм болон бусад асуудлын хувьд 2 орны Хилийн тухай хуулийг харьцуулан үзэхэд эрх зүйн зохицуулалтууд ерөнхийдөө ижил байна.

2. 1993 оны Хилийн тухай хууль батлагдахаас өмнөх эрх зүйн орчин

1928 оны 9 дугээр сарын 24-нд Засгийн газрын 27 дугаар хурлаар харуулын цагдаа нарын үүрэг хариуцлагыг тодорхойлсон дүрэм баталж уг дүрэмд улсын хил хамгаалах арга ажиллагаа, хилийн журам дэглэмийг сахиулах талаар тодорхой заасан байна.[34]

Дотоод явдлын яамны сайдын 1943 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 84 тоот тушаалаар батлагдсан БНМАУ-ын хилийн хамгаалалтын албаны дүрэм нь хязгаарын цэргийн эрх, үүрэг хилчдийн албан үүргээ гүйцэтгэх журам, арга ажиллагааг тодорхойлсон анхны чухал баримт бичиг юм.

1973 оны 7 дугаар сарын 16-нд БНМАУ-ын Хил хамгаалах хуулийг Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 161 дугээр зарлигаар батлан гаргасан нь анхны бие даасан хууль юм. Уг хууль нь тухайн үедээ Хууль, зарлиг тогтоолын эмхтгэл сэтгүүлд нийтлэгдэж байгаагүй бөгөөд зөвхөн албан хэрэгцээнд зориулан хэвлэгдэж байжээ. БНМАУ-ын Хил хамгаалах хууль нь 3 бүлэг 37 зүйлтэй байв.

Энэ хуулийг МУ-ын Хилийн тухай 1993 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн хууль батлагдсанаар хүчингүй болгосон. 1973 оны БНМАУ-ын Хил хамгаалах хууль нь Нэгдүгээр бүлэг. Ерөнхий заалт, Хоёрдугаар бүлэг. Улсын хилийн тусгай дэглэм, Гуравдугаар бүлэг. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хил хамгаалах журам гэсэн үндсэн гурван бүлэгтэй.

Уг хуулиар БНМАУ-ын хил хамгаалалтын гол зорилго, улсын хил тогтоох, хамгаалах зарчим, хилийн журам, чухам ямар үйлдлийг хилийн зөрчилд тооцох зэргийг тодорхойлон хязгаарын цэргийн эрх, үүргийг тогтоожээ. Эдгээр бүлгүүдэд тухайлбал: БНМАУ-ын хилийг тогтоох ба тэмдэглэх тухайд "БНМАУ-ын хил нь тус улсын нутаг дэвсгэрийн зах хязгаарыг зааглан тогтоосон шугамаар болон уг шугамаас босоо гадаргаар агаарын зайд, мөн шугамаас газрын хөрсний гүн тал руу тогтоогдсон шугамаар тодорхойлогдоно гэж заасан байна.

1973 оны Хил хамгаалах хуульд улсын хилийн тухай нийтлэг үндэслэл, хилийг хамгаалах асуудал тодорхой зааг ялгаагүй тусгагдаж, улсын хилийн тусгай дэглэм гэсэн зүйлд зэргэлдээ улстай хилийн асуудлаар харилцан тохирсон дэглэмийн асуудлыг хилийн журамтай хамтатган зааж, хилийн тогтоосон дэглэмээ хүндэтгэн сахиулахад хил орчмын нутаг дэвсгэрт мөрдөх журам тогтоож тэр нь дэглэмдээ үйлчилж байдгийг тодорхой зааг

[34] Лувсан.Ч, Дашням.Ж нар. "Хилчний сурах бичиг". Уб., 1978 он. 22 дахь тал. Армийн СХ-ийн Хэвлэх үйлдвэр

ялгаагүй тусгаснаас хоёр өөр асуудлыг хутган ойлгоход хүргэж, улсын хил хамгаалах журамд зөвхөн хилийн цэргийн эрх, үүргийг тодорхойлсоноор ард иргэдийн үүрэг оролцооны асуудлыг орхигдуулсан, түүнчлэн хилийн хууль тогтоомж зөрчсөн хүмүүст хариуцлага тооцох зэрэг асуудлыг төдий л оновчтой тусгаагүй байжээ.

1973 оны БНМАУ-ын Хил хамгаалах хуулиар БНМАУ-ын хил хамгаалалтын гол зорилго, улсын хил тогтоох, хамгаалах зарчим, хилийн журам, чухам ямар үйлдлийг хилийн зөрчилд тооцох зэргийг тодорхойлон хязгаарын цэргийн эрх, үүргийг тогтоож заасан хууль байсан бол 1993 оны /одоогийн үйлчилж буй/ Хилийн тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуульд "Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна. Улсын хилийг хуулиар бататгана" гэж тодорхойлсон зорилтыг хэрэгжүүлэх, 1980 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн "Монгол-Зөвлөлтийн улсын хилийн дэглэм, хилийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай БНМАУ-ын Засгийн газар, ЗСБНХУ-ын Засгийн газрын хоорондын гэрээ", 1988 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн "Монгол-Хятадын хилийн дэглэм, хилийн асуудлыг зохицуулж байх тухай БНМАУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газрын хоорондын гэрээ зэргийн үзэл санааг тусгах, мөн тухайн үеийн нийгэм эдийн засгийн өөрчлөлттэй уялдуулан 1993 оны 10 дугаар сарын 21-ний өдөр батлагджээ.

Харин Хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр дараах асуудлыг шинэчлэн зохицуулахаар тусгасан нь зөв болжээ. Үүнд:

1.Иргэд, төрийн болон төрийн бус байгууллагыг хил хамгаалалтад татан оролцуулах, тэдгээрийг урамшуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх зохицуулалтыг тусгасан. Ингэснээр иргэдийн хил хамгаалалтад оролцох идэвх санаачилгыг нэмэгдүүлнэ.

2.Улсын хил хамгаалах байгууллагын албан хаагчид, тэдгээрийн гэр бүлийн нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэх хүрээнд тодорхой сан байгуулах эрх зүйн үндсийг тавьсан.

3.Хуулийн нэр томъёоны асуудлыг тодорхойлон тайлбарласан;

4.Хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах явцад Хилчид галт зэвсэг, тусгай техник хэрэгсэл ашиглах эрх зүйн орчинг боловсронгуй болгох хүрээнд тодорхой зохицуулалтыг тусгасан.

5.Хил хамгаалалтад туслах хүчний оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр зохицуулалт оруулсан.

6.Улсын хил хамгаалалтыг хугацаат цэргийн албан хаагчид болон гэрээт хилчдээр гүйцэтгүүлэх зохицуулалтыг тусгасан.

7.Улсын хил хамгаалалтыг бүсчилсэн байдлаар зохион байгуулах зэрэг олон чухал зүйлийг хамруулсанд Улсын хилийн тухай хуулийн төслийн ач холбогдол оршиж байна.

3.Үндэсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлогын баримт бичиг болон бусад хуультай Хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нийцэж байгаа байдал

НЭГ. ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ БА УЛСЫН ХИЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд "Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлын бүрэлдэхүүнд нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдлыг багтаасныг хуульчлан баталгаажуулах" гэж заажээ. Мөн Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоог нэгдмэл, үр нөлөөтэй, боловсронгуй болгох чиглэлд шаардлагатай эрх зүй, удирдлага, зохион байгуулалтын шинэчлэл хийнэ /4.1.2 дахь заалт/ гэсэн.

Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын албан хаагчид тавих ёс зүй, мэргэжлийн чадвар, хариуцлага, хууль сахин биелүүлэх шаардлагыг өндөржүүлж, эрх зүй, нийгмийн хамгааллын баталгааг дээшлүүлнэ /4.1.4 дэх заалт/ гэсэн заалтуудтай Улсын Хилийн тухай хуулийн төсөл нийцэж байна.

Үзэл баримтлалд "Хил дээр боомт нээх, хаах, боомтын ажиллагааны горимд өөрчлөлт оруулах асуудлыг төрийн эрх барих дээд байгууллага шийдвэрлэнэ" /3.1.2.6 дахь заалт/ гэж заасан. Харин Хилийн тухай хуулийн /1993 он/ 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт "Хилийн боомтыг нээх, хаах түүгээр нэвтрэх хөдөлгөөнийг түр хязгаарлах, зогсоохыг хуульд өөрөөр заагаагүй бол *Засгийн газар* шийдвэрлэнэ гэжээ. Энэ нь Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.1.2.6 дахь заалттай нийцэхгүй байна.

Хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 16.2-д "Улсын хил дээр хилийн боомт нээх, хаах, хилийн боомтын ажиллагааны горимд өөрчлөлт оруулах асуудлыг *Улсын Их Хурал* шийдвэрлэнэ" гэж тусгасан нь Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцжээ.

Үзэл баримтлалд Орон нутгийн хамгаалалтад тулгуурласан батлан хамгаалах, зэвсэгт хүчний нэгдмэл тогтолцоог төлөвшүүлж, зэвсэгт хүчнийг мэргэжлийн чиг баримжаатай, чадварлаг болгон хөгжүүлнэ. Улсын хамгаалалтад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, урамшуулах бодлого явуулна /3.1.2.2 дахь заалт/ гэж тусгасан.

Хилийн тухай хуулийн төслийн 46 дугаар зүйлийн 46.2.1-д "Улсын хил хамгаалалтад идэвхтэй оролцсоны шагнал, мөнгөн урамшуулал авах"; 46.2.2-д "Улсын хил хамгаалалтай холбогдсон санал, хүсэлтээ Улсын хил хамгаалах байгууллагын удирдлагад уламжлах"; 47 дугаар зүйлийн 47.5-д "Засаг захиргаа, орон нутгийн удирдлага нар хил хамгаалалтад туслах хүчний гишүүдийг цалинжуулах, шагнаж урамшуулах санхүүжилтийг орон нутгийн төсөвт тусгаж, улсын хил хамгаалах байгууллагын удирдлагатай зөвшилцсөний үндсэн дээр тогтоосон журмын дагуу захиран зарцуулна" гэж тусгасан. Энэ нь хил хамгаалалтад оролцсон иргэн, туслах хүчний гишүүний оролцоог дэмжих, урамшуулах асуудлыг Хилийн тухай /1993 он/ хуульд тодорхой тусгаагүй байсныг тодруулж нэмж тусгасан байгаа нь Үндэсний

аюулгүй байдлын үзэл баримтлалын дээрх заалттай нийцэж байна. Улсын хилийн хамгаалалт, хилийн халдашгүй дархан байдлыг хангахад тухайн бүс нутаг дахь иргэдийн оролцоо зайлшгүй чухал юм.

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ТӨРӨӨС ХИЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО БА УЛСЫН ХИЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

УИХ-ын 2002 оны 20 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого"-ын "Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах талаар олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулах, нэгдэн орох, тэдгээрийг хүндэтгэн сахих, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгоно /1.1 дэх заалт/. "Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны зохицуулалт, уялдаа холбоог сайжруулах, эрх зүйн орчинг боловсронгуй болгох заалтуудыг хэргэжүүлнэ".

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан хилийн бүс, зурвасын эзэмшлийг сайжруулж, хил орчмын нутаг дэвсгэрийн хөгжлийн талаар нийгэм, эдийн засгийн цогцолбор арга хэмжээ авна /1.2 дахь заалт/ гэж заасантай Улсын хилийн тухай хуулийн төсөл нийцэж байна.

ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОД СУУРИЛСАН ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГО

Хилийн болон дотоодын цэргийн бүтэц, зохион байгуулалт, цэргийн сургалт бэлтгэл, зэвсэглэл, техникийн хангалтыг олон улсын жишигт ойртуулан хөгжүүлнэ /7.6.2 дахь заалт/ гэсэн заалт Хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд гэрээт цэргийн албан хаагчийг хил хамгаалалтад оруулахаар заасантай агуулгын хувьд нийцэж байна.

ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2008-2012 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Улсын хилийн бүсчилсэн /уулын, ой тайгын, говь цөлийн, тал хээрийн хэсгийн/ хамгаалалтын тогтолцоог бүрдүүлнэ /4.3.2 дахь заалт/. Улсын хилийг "хугацаат цэргийн албан хаагч"-аар хамгаалуулдаг тогтолцоог өөрчилж, улсын хилийг хамгаалах үүргийг "мэргэшсэн гэрээт хилчин"-ээр гүйцэтгүүлэх тогтолцоонд үе шаттайгаар шилжүүлэх" тухай заалтыг хэрэгжүүлэх хүрээнд Хилийн тухай хуулийн төслийн 31 дүгээр зүйлд Гэрээт хилчний алба, гэрээт хилчнээр гүйцэтгүүлэх эрх зүйн зохицуулалтыг оруулсан үйл ажиллагааны хөтөлбөр зорилттой нийцэж байна.

Дүгнэлт

Энэ бүгдээс үзэхэд Улсын хилийн тухай хуулийн төсөл нь бодлогын баримт бичгүүдтэй зөрчилдсөн зүйлгүй байна. Харин Улсын хилийн тухай хуулийн төслийг үйлчилж буй бусад хууль тогтоомжтой хэрхэн уялдаж байгааг судлахад зарим нэг анхаарвал зохих асуудал байгааг санал, зөвлөмжид тусгав.

Санал, зөвлөмж

Монгол Улсын Хилийн тухай хуулийн төслийн тухайд:

1.Төслийн 3.9-д хил хамгаалалтыг удирдах төрийн захиргааны төв байгууллага /цаашид хил хамгаалах төв байгууллага гэх/ гэж тусгасныг өөрчлөх нь зүйтэй. Учир нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсын яам нь Засгийн газрын үйл ажиллагааны зохих хүрээ, тодорхой чиг үүргийг дагнан эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мөн" гэж заасан. Иймд "төрийн захиргааны төв байгууллага" гэдгийг "яам" гэж ойлгоно. Түүнчлэн төслийн 29.1-д заасантай зөрж байгаа тул нэг мөр болгох шаардлагатай.

2.Төслийн 3.10-т "хилийн шалган нэвтрүүлэх алба гэж ... улсын хил хамгаалах байгууллагаас хэрэгжүүлж буй үйл ажиллагаа"-г ойлгоно гэсэн байна. Нэр томъёоны тодорхойлолт ойлгомжгүй болсон байна. Хилийн шалган нэвтрүүлэх алба нь ... байгууллага гэдэг байдлаар тодорхойлох нь зүйтэй.

3.Төслийн 3.22-т "хилийн ус гэж ... түүнчлэн газрын доорх орд газрыг" гэжээ. Энд хилийн усны тухай яригдаж байгаа. Орд газар гэхээр ашигт малтмалын бусад төрлүүдтэй ижил утгаар ойлгогдож байна.

4.10.2-д ...Тус бүрэлдэхүүнд төрөл мэргэжлийн хүмүүсээс гадна тухайн орон нутгийн төлөөлөгч оролцоно гэжээ. Энд дурдсан "төрөл мэргэжлийн хүмүүс" гэдэгт ямар төрөл мэргэжлийн хүмүүсийг хэлж байна вэ? Тодруулж оруулах.

5.14 дүгээр зүйлд "Улсын хилийн дэглэмийн эрх зүйн үндсийг хуулиар тодорхойлж..." гэжээ. Улсын хилийн дэглэмийн эрх зүйн үндэсийг энэ хуулиар тодорхойлж буй учир "энэ" гэдэг үг нэмэх нь илүү тодорхой болно.

6.Төслийн 3.11-д улсын хилийн зөрчлийг тодорхойлсон ба 22 дугаар зүйлд заасан улсын хил зөрчсөнд тооцох гэдгийг хоорондоо нь уялдуулж нийцүүлэх.

7.Төслийн 22 дугаар зүйлд буй *давуулсан, давуулахыг завдсан, давсан* зэрэг нэр томьёог тодруулж томьёолох нь зүйтэй. Хожим маргаан гарах эсхүл УДШ-ээс тайлбар хийх шаардлага үүснэ. Энэ зүйлийн зохицуулалт нь зарчмын хувьд маш зөв зохицуулалт.

8. Төслийн 23.1-д " ... тодорхой хэсэгт хэрэгжүүлэх гэдгийн дараа хил орчмын дэглэмийг сахиулах" гэж нэмэх. Ингэснээр нэр томъёоны хэсэгтэй ижил болно.

9. Төслийн 29.3-т "... Улсын хил хамгаалах байгууллагын хилийн анги, салбарын зэргийг тусгайлан тогтооно" гэжээ. Энд хэн, ямар журмаар тогтоох нь тодорхой бус болсон тул тодруулах шаардлагатай.

10. Төслийн 37.6-д " ... зэрэг тогтооно" гэсэн боловч хэн тогтоох нь тодорхой бус байна.

11. Төслийн 39.5-д "хил давуулан буудахыг хориглоно" гэж заажээ. Энд хил давуулан буудаж болох *онцгой тохиолдол* байж болох эсэх талаар тусгах саналтай байна. Тухайлбал "Хилийн зөрчлийг таслан зогсоох зорилгоор хил давуулан буудсанаас бусад тохиолдолд хил давуулан буудахыг хориглоно." гэх мэтээр.

12.Төслийн 34.3.-т "Улсын хилийн аюулгүй байдлын санг бүрдүүлэх, захиран зарцуулах журмыг тусгайлан тогтооно." *Хэн ямар субьект* энэ журмыг батлах вэ? Тодорхойгүй зарцуулалтад хэн хяналт тавих вэ? Тодруулж оруулах нь зүйтэй.

13. 39.6-д "... цагийн байдлын өрнөлт харгалзан зэрэг тогтооно" гэжээ. Хэлзүйн хувьд "*өрнөлтийг*" гэж засах;

14. Төслийн 44.5. Нийгмийн хэв журам хангах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 44.1 Хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага. Эдгээр нь хамаарах асуудлын хүрээгээр нь авч үзвэл "Хууль зүй, дотоод хэргийн асуудал"-тус яаманд хамаарах эрх хэмжээний асуудал байхад хоёр өөр томьёололоор хоёр өөр хэсэгт заасан нь буруу юм. Нэгтгэх нь зүйтэй.

15. Төслийн 45.1-д "... иргэн ... хил хамгаалалтад оролцоно" гэснийг "оролцож болно" гэж тусгах саналтай байна.

16. Төслийн 45.6-д "улсын хил хамгаалалтад туслах хүчийг тогтоосон журмын дагуу хил хамгаалалтад үүрэг гүйцэтгэнэ" гэжээ. Энд тогтоосон журам гэдгийг тодруулах нь зүйтэй. Журмыг хэн тогтоох, тэр нь хуульд байгаа зүйл, заалт уу, эсхүл тусдаа батлагдах уу гэх мэт.

17. Төслийн 47.4-т "Аймаг, сумын Засаг дарга нь..." гэзэд заасан мөртлөө 47.5-д "Засаг захиргаа, орон нутгийн удирдлага нар..." Монгол Улсад аймаг, сумын нутгаар улсын хилийн шугам дайран өнгөрдөг бол шууд *аймаг, сумын Засаг дарга* гэж шууд томъёолвол оновчтой.

18. Гэрээт хилчин, хил дээр алба хааж буй цэргийн албан хаагч хоёрын чиг үүрэг, хэм хэмжээг хэрхэн зохицуулах талаар цаашид тодорхой байх нь зүйтэй.

—oOo—

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

СОГТУУРУУЛАХ УНДАА ҮЙЛДВЭРЛЭХ, ИМПОРТЛОХ, ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧЛЭХЭД ТӨРӨӨС ТАВИХ ХЯНАЛТ, ХЯЗГААРЛАЛТЫН БОЛОМЖ, ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА /ОХУ, КАНАДЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ/[35]

ОРШИЛ

Монгол Улсад согтууруулах ундаанд тавьж буй хяналт, эрх зүйн орчин, тулгамдаж байгаа асуудал, эдгээр хорт зүйлсийн зохисгүй, хууль бус хэрэглээ сүүлийн жилүүдэд хавтгайрч гэмт хэрэг, хүний аюулгүй байдал, цаашилбал үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх түвшинд хүрэзд байна.[36]

Статистик мэдээллээс[37] үзэхэд хүний амь насыг хохироох, амиа хорлох, бусдын бие махбодид хөнгөн, хүндэвтэр, хүнд хэлбэрээр гэмтэл учруулах, хүчиндэх, хулгайлах, булаах, дээрэмдэх, танхайрах зэрэг гэмт хэргийн тодорхой хувь нь архидан согтуурсаны улмаас үйлдэгдэж байна.

Мөн эдгээр хэргүүд нь нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин өндөр буюу бүртгэгдсэн гэмт хэргийн 80.0 орчим хувийг эзлэж байна.

Гэмт хэргийн 42.0 хувь нь хөнгөн, 35.8 хувь нь хүндэвтэр, 18.3 хувь нь хүнд, 3.8 хувь нь онц хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд 26.9 хувь нь гудамж талбайд, 34.7 хувь нь гэр, орон сууцанд, 3.3 хувь нь албан газар, аж ахуйн нэгжид, 2.7 хувь нь нийтийн зах худалдаа, үйлчилгээний газарт, 5.8 хувь нь зочид буудал, ресторан, бааранд, 12.1 хувь нь 06-14, 26.9 хувь нь 14-19, 23.7 хувь нь 19-22, 37.4 хувь нь 22-06 цагт тус тус үйлдэгджээ.

ОХУ болон Канад улсыг /судалгаанд/ сонгон харьцуулсан үндэслэл нь Монгол улстай уур амьсгалын хувьд адил байгаад оршино[38].

Судалгааны ажлын хүрээнд ОХУ, Канад улсад согтууруулах ундааны үйлдвэрийн тоог хуулиар хязгаарладаг эсэх, согтууруулах ундааны үйлдвэрт хяналт тавих төрийн чиг үүргийг хэрэгжүүлдэг нэгж үйлдвэрт байдаг эсэх, импортлогчид тавих шаардлага, согтууруулах ундаа худалдах цэгийн тоог хүн амын тооноос хамааран тогтоодог эсэх, согтууруулах ундаагаар үйлчлэх цагийн хязгаарлалт /Шөнийн 02 эсхүл 04 цаг хүртэл үйлчлэх зөвшөөрөл олгох асуудлыг судлан үзэх/, согтууруулах ундааны хэрэглээнд тавих хяналт,

---

[35] ХЗДХЯ-ны захиалгаар ЗХЭЗС, ОУЭЗС хамтран 2011 оны 2 дугаар сарын 01-ны өдрөөс мөн оны 03 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хийж гүйцэтгэв.

[36] Өнгөрсөн 7 дугаар сард Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын шинэ үзэл баримтлалыг УИХ-аас батлсан. Энэ үзэл баримтлалд хүний аюулгүй байдал, хүний удмын сангийн аюулгүй байдал, согтууруулах ундаа болон мансууруулах бодис, элдэв хорт зуршлаас үндэстнээ хамгаалах бодлогыг шинээр томъёолсон.

[37] ЦЕГ-ын Мэдээлэл, судалгааны төвөөс гаргасан 2009-2010 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн статистик мэдээ.

[38] Нэрт сэтгэгч Ш.Л.Монтескье "Аагим халуун цаг агаар хүний эрч хүчийг шавхан, эр зоригийг нь мохоодог бол хүйтэн уур амьсгал хүмүүсийг урт удаан хугацааны хүнд бэрх, үлэмж их, зоримог шийдэмгий үйлдэлд чадвартай болгодог хүч тамир, оюун ухаан өгдөг. Энэ нь улс орнуудын хууль тогтоомжид нөлөөлдөг гэж үзжээ" /Хуулийн амин сүнс. Уб., 2008 он. 248-295 дахь тал/.

хязгаарлалт /21 наснаас доош насны этгээд согтууруулах ундаа хэрэглэх, худалдан авах боломжийг хориглох механизм/, согтууруулах ундааны ил, далд сурталчилгааг хэрхэн зохицуулдаг талаарх жишгийг судаллаа.

Нэг.ОХУ, Канадад согтууруулах ундааны үйлдвэрийн тоог хуулиар хязгаарладаг эсэх талаар

ОХУ-д жил болгон 75000 хүн согтууруулах ундаа хэрэглэсний улмаас нас барж, сэтгэл мэдрэлийн өвчний 1/3 хувь нь согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэснээс үүдэлтэй байдаг бөгөөд ОХУ-ын Эрүүл мэндийн яамны судалгаанаас үзэхэд 2009 оны байдлаар нэг хүнд ноогдох согтууруулах ундааны жилийн хэрэглээ 18 литр байна[39].

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 2010 оны байдлаар согтууруулах ундааны хэрэглээний талаар улс орнуудын дунд явуулсан судалгааг үзэхэд Молдав улс нь согтууруулах ундаа хамгийн их "хэрэглэдэг" улсаар тодорчээ. Тус судалгаагаар тухайн орны нэг иргэн жилд уудаг цэвэр спиртний хэмжээг гаргасан бөгөөд Молдав улс уг жагсаалтыг тэргүүлсэн нь сонирхолтой юм. Ер нь олон улсын түвшинд тогтоосон хэмжээгээр нэг хүний спиртийн жилийн хэрэглээ 6,1 литр байна[40]. Тус судалгааны үр дүнг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын "Согтууруулах ундаа ба эрүүл мэндийн салбар дахь дэлхийн нөхцөл байдал" сэдэвт илтгэлийн хүрээнд олон нийтэд мэдээлсэн юм[41].

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын 2010 оны судалгаа[42]:



[39] Статистика алкоголизма http://www.bydzdorov.ru/alk-stat.html /сүүлд үзсэн 2011.03.31/

[40] Названы самые пьющие нации http://24news.ru/news/254621251s.html /сүүлд үзсэн 2011.03.31/

[41] Глобальном докладе о положении в области алкоголя и здоровья http://24news.ru/news/254621251s.html /сүүлд үзсэн 2011.03.31/

[42] Исследование ВОЗ http://www.pageranker.ru/forum/showthread.php/ /сүүлд үзсэн 2011.03.30/

ОХУ-ын "Этилийн спирт, согтууруулах ундаа болон спиртийн агууламжтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг улсаас зохицуулах тухай Холбооны хууль"-ийн 26 дугаар зүйлээр этилийн спирт, согтууруулах ундаа болон спиртийн агууламжтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтын эргэлтэд дараах үйл ажиллагааг хориглодог[43]. Үүнд:

✓ Хүнсний бус түүхий эдээр бэлтгэсэн этилийн спирт, спиртийн агууламжтай хүнсний бус түүхий эдээр бэлтгэсэн согтууруулах ундаа болон спиртийн агууламжтай хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг;

✓ Бэлэн бүтээгдэхүүн дэх цэвэр спиртийн агууламжийн хэмжээг зориулалтын техник хэрэгслээр шалгуулалгүй, эсхүл хянуулалгүй бүтээгдэхүүн үйлдвэрлэх;

✓ Этилийн спирт, согтууруулах ундаа, спиртийн агууламжтай бүтээгдэхүүнийг тусгай зөвшөөрөлгүйгээр жижиглэнгээр худалдаалах;

✓ Тус хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөлгүйгээр этилийн спирт, согтууруулах ундаа, спиртийн агууламжтай бүтээгдэхүүний эргэлтийг хангах;

✓ Улсын стандартад нийцээгүй сав, баглаа боодолтой согтууруулах ундаа үйлдвэрлэх, борлуулах;

✓ Этилийн спирт, согтууруулах ундаа, спиртийн агууламжтай бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үндсэн техник, тоног төхөөрөмжийг бусдад түрээслэх;

✓ Этилийн спирт, согтууруулах ундаа, спиртийн агууламжтай бүтээгдэхүүнийг өөр бараагаар солих тухай гэрээ байгуулах. Энэ төрлийн гэрээг хууль бус гэрээ хэмээн тооцно;

✓ Хувь хүн, хуулийн этгээд этилийн спирт, согтууруулах ундаа, спиртийн агууламжтай бүтээгдэхүүнийг гэрийн нөхцөлд бэлтгэн борлуулах;

✓ Тус хуулийн 5 дугаар зүйлд заасан хэмжээнээс хэтрүүлсэн спиртийн агууламжтай согтууруулах ундаа үйлдвэрлэх;

✓ Спиртийг боловсруулахдаа тусгайлсан тоног төхөөрөмжөөр оруулж спиртнээс "барда" /спиртнээс гарах илүүдэл бүтээгдэхүүн/-г арилгах боловсруулалтын шатыг хийгээгүй үйлдвэрлэлийг тус тус хориглодог байна.

ОХУ-ын Засгийн газраас этилийн спирт, согтууруулах ундааны улсын хяналтыг хангах үүднээс 1998 оны 10 дугаар сарын 6-ны өдөр "Этилийн спирт болон согтууруулах ундааны үйлдвэрлэл, эргэлтэд төрийн хяналтыг чангатгах тухай" ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлигийг баталжээ[44]. Зарлигт тусгаснаар:

"Ард иргэдийн эрүүл мэндийн байдлыг сайжруулах, хэрэглэгчдийн сайн чанартай, сайн бүтээгдэхүүн хэрэглэх эрхийг хангах, улсын төсөвт нэмэлт орлого оруулах үүднээс дараах арга хэмжээ авахаар тусгав. Үүнд:

✓ Этилийн спирт, согтууруулах ундаа, спиртийн агууламжтай бүтээгдэхүүн үйлдвэрлэх газруудад үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний тоог өдөр тутам төрөөс хянах тогтолцоог чангатгах;

[43] Мөн тэнд. Статья 26.

[44] Указ Президента РФ "О усилении государственного регулирования в сфере производства и оборота этилового спирта и алкогольной продукции" 6 октября 1998 года № 1199

✓ Хэрэглэгчдэд нийлүүлж буй согтууруулах ундааны үйлдвэрлэл, чанарт хяналт тавих;

✓ Улсаас тогтоосон стандартад үл нийцсэн согтууруулах ундааны үйлдвэрлэл, борлуулалтыг таслан зогсоох зэрэг арга хэмжээ юм.

Канад улсад үйлдвэрлэлийн тоог хязгаарладаг эсэх тухай хуульд заагаагүй байна.

Хоёр. ОХУ, Канадад согтууруулах ундааны үйлдвэрт хяналт тавих төрийн чиг үүргийг хэрэгжүүлдэг нэгж үйлдвэрийн талаар

Тус улсын хувьд 1995 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 171 тоот "ОХУ-ын Этилийн спирт, согтууруулах ундаа болон спиртийн агууламжтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг улсаас зохицуулах тухай Холбооны хууль[45]"-иар ОХУ-ын нутаг дэвсгэрт эрхэлж буй этилийн спирт, согтууруулах ундаа, спиртын агууламжтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг улсаас зохицуулах эрх зүйн үндсийг тодорхойлсон байна. Тус хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу согтууруулах ундааны хяналт, зохицуулалтын асуудлыг эрхэлсэн төрийн байгууллагын үндсэн чиг үүрэг нь:

- Этилийн спирт, согтууруулах ундаа, спиртийн агууламжтай бүтээгдэхүүний үнийг зохицуулах;
- Этилийн спирт, согтууруулах ундаа, спиртийн агууламжтай бүтээгдэхүүний импорт, экспортыг зохицуулах;
- Этилийн спирт, согтууруулах ундаа, спиртийн агууламжтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, эргэлт, чанар болон аюулгүй байдлыг улсаас хянах ажиллагааг зохион байгуулах, явуулахад оршино[46].

ОХУ-ын Татварын ерөнхий газрын 1998 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн №3-31/213 тоот "Этилийн спирт, согтууруулах ундаа, спиртийн агууламжтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, эргэлтэнд улсаас техникийн хяналт тавих, шинжилгээ хийх журмын тухай" тушаалын дагуу[47] **28 хувиас дээш спиртийн агууламжтай согтууруулах ундаа үйлдвэрлэх тоо хэмжээнд өдөр тутам хяналт тавих зорилгоор хяналтын тоног төхөөрөмж байршуулах талаар зохицуулжээ**. Тухайн хяналтын тоног төхөөрөмж нь **тухайн үйлдвэрийн өдөр тутмын согтууруулах ундааны үйлдвэрлэлтийн тоо хэмжээг илрүүлэх бөгөөд тус төрлийн тоног төхөөрөмжийг байршуулаагүй үйлдвэрийг торгож, тоног төхөөрөмж байршуулах хүртэл үйл ажиллагааг нь зогсоодог** байна[48].

---

[45] Федеральный закон РФ "О государственном регулировании производства и оборота этилового спирта, алкогольной и спиртосодержащей продукции" 19 июля 1995 года /с изменениями от 28.12.2010/

[46] Мөн тэнд. Статья 5.

[47] Приказ Государственной Налоговой службы Российской Федерации от 26 августа 1998 г. N бф-3-31/213 "О порядке проведения Контрольных технологических проверок и обследований организаций в сфере производства и оборота этилового спирта, спиртосодержащей алкогольной продукции"

[48] Налоговые органы установили контроль за объемами выпуска алкогольной продукции http://mostorik.ru/130/106 /сүүлд үзсэн 2011.03.31/

Канад улсын Согтууруулах ундаанд[49] хяналт тавих хуулийн[50] 1 дүгээр хэсэгт согтууруулах ундаанд хяналт тавих төрийн чиг үүргийг хэрэгжүүлэгч Комиссын эрх, үүргийн зааж өгсөн. Хуульд зааснаар:

Согтууруулах ундааны хяналтын комисс нь таваас доошгүй гишүүнээс бүрдэж, бүх согтууруулах ундааны дэлгүүрийн хяналт болон менежмент, ерөнхий хяналтыг энэ актын дагуу удирдан хариуцаж хуулийн этгээдийн хэлбэртэйгээр эрх эдэлж үүрэг хүлээнэ.

Гишүүдийн томилгоо

3/1/ Зөвлөлийн Lieutenant захирагч нь комиссын гишүүд болон гишүүд дотроос дарга, дэд даргыг томилно.

Дэд даргын үүрэг

3 /2/ Комиссын дарга чөлөөтэй, эзгүй үед, эсхүл ямар нэгэн шалтгаанаар ажил үүргээ гүйцэтгэж чадахгүй үед комиссын дэд дарга комиссын даргын бүх эрх мэдэл, эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

Даргын үүрэг

4 /3/ Дарга нь комиссын үүргийг гүйцэтгэхэд өөрийн цагаа зориулах, мөн комисс энэ хуулийг хэрэгжүүлэх, хяналт тавих, мөн бусад хуулиар үүрэг болгосон зохицуулалт, гүйцэтгэл, үүргийг хариуцах ёстой.

Комиссын эрх

1.1. Комисс нь дараах эрхтэй.

✓ Согтууруулах ундааг худалдан авах, худалдах, импортлох;

✓ Энэ хуулийн дагуу согтууруулах ундааны хүргэлт, тээвэрлэлт, худалдаа, эзэмшилд хяналт тавих;

✓ 7 дугаар хэсэг болон 16 дугаар зүйлтэй[51] холбоотойгоор согтууруулах ундааны дэлгүүрийн байршлыг тухайн орон нутагт тогтоож, дэлгүүрийн нөхцөл байдал, эсхүл дэлгүүрийг тухайн орон нутгийн хэмжээнд бий болгох;

✓ Согтууруулах ундааг худалдах зөвшөөрлийг олгох, татгалзах, цуцлах, түдгэлзүүлэх мөн зөвшөөрөл эзэмшигчдэд мөнгөн торгууль оногдуулах;

✓ Энэ хуулийн дагуу үйл ажиллагаа явуулахад шаардлагатай ямар нэгэн газар болон байшинг түрээслэх;

✓ Энэ хуулийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, тавилга, байр, газрыг түрээслэх, эсхүл худалдан авах;

✓ Энэ актыг хэрэгжүүлэх, удирдан зохион байгуулахаас бусдаар

[49] "Согтууруулах ундаа" гэж 1 хувиас илүү спирт агуулсан бүх төрлийн ундаа, ууж болох шингэн болон согтууруулах ундааны бүх нэгдэл, исгэсэн, согтууруулах зүйл агуулсан, буудайгаар хийсэн согтууруулах ундаа. Мөн бодисыг уусгаж эсвэл шингэрүүлж ууж болох шингэн зүйл болгож энэ нь 1 хувиас илүү спирт агуулсан байхыг хэлнэ.

[50] http://web2.gov.mb.ca/laws/statutes/ccsm/l160e.php

[51] **16.1 Согтууруулах ундааны дэлгүүрийг байгуулах** 2 дугаар дэд хэсэг болон 7 дугаар бүлэгтэй холбоотойгоор комисс энэ хуулийн дагуу согтууруулах ундааг худалдан борлуулах дэлгүүрийг зохимжтой гэж үзсэн газруудад орон нутагт байгуулж, ажиллуулан иргэдэд үйлчилнэ /Комиссоос согтууруулах ундаа худалдах дэлгүүрт зөвшөөрөл өгч байршлыг тогтооно/.

16.2 Зохион байгуулалтгүй нутаг дэвсгэр дэх согтууруулах ундааны дэлгүүр

Согтууруулах ундааны дэлгүүрийг Зөвлөл дэх Lieutenant-ийн удирдагчийн зөвшөөрөл, зөвлөмж, санал болгосноос бусад тохиолдолд зохион байгуулалтгүй нутаг дэвсгэрт комисс байгуулж болохгүй.

ажилтанг томилохдоо Комиссын ерөнхийлөгч болон гүйцэтгэх захиралтай зөвшилцөнө.

✓ Хэрвээ шаардлагатай гэж үзвэл мэргэжлийн туршлагатай хүн болон шинжээчийг авч ажиллуулж болно.

✓ Энэ хуулийн дагуу согтууруулах ундааг худалдах болон хадгалах сав, баглаа боодлын багтаамж, хэлбэр, шинж чанарыг тодорхойлно.

✓ Согтууруулах ундааны агуулахыг байгуулж, ашиглалт үйлчилгээний талаар арга хэмжээ авч агуулахаас, эсхүл агуулахад хүргэлт, хадгалалтад хяналт тавих;

✓ Согтууруулах ундааны дэлгүүр, агуулахын тоног төхөөрөмж, менежментийг тодорхойлох, тэнд хадгалж байгаа бүртгэл тэмдэглэлийг тодорхой болгох;

✓ Энэ хуулийн дагуу байгуулсан согтууруулах ундааны дэлгүүрийг тохижуулах болон худалдан авалтад хяналт тавих;

✓ Ямар нэгэн согтууруулах ундааны дэлгүүрт худалдахаар хадгалж байгаа согтууруулах ундааны нэр, шошго, төрөл, ангиллыг тогтоох;

✓ Хуулийн дагуу гар аргаар үйлдвэрлэсэн дарс болон шар айрагны хэрэглээ, ээмшлийг зохицуулах;

✓ Энэ хуулийн дагуу согтууруулах ундаа зарж байгаа газрын тоног төрөөрөмж, менежмент, зохицуулалтад хяналт тавих;

✓ Согтууруулах ундааг хуулийн дагуу хадгалах арга, газар, байршлыг тодорхойлон тогтоох мөн түүнчлэн нийлүүлэлтийн хуваарилалтад хяналт тавих;

✓ Энэ хуулийн дагуу ямар согтууруулах ундааг аль өдөр, ямар цагт, ямар арга зам, арга барилаар хуулийн дагуу зөөж тээвэрлэхийг тодорхой тогтоох, зохицуулах, хяналт тавих, дээр дурдсантай холбоотойгоор согтууруулах ундааны хүргэлтийн үнийг тогтооно.

✓ Энэ хуульд өөрөөр заагаагүй бол худалдаж авах согтууруулах ундааны төрөл, тоо, түүний дотор нэг удаа эсхүл тодорхой заасан цаг хугацаанд худалдаж авах согтууруулах ундааны тоо, согтууруулах ундаанд агуулсан спиртийн агууламжийг зааж өгнө.

Гурав. ОХУ, Канад дахь согтууруулах ундаа импортлогчид тавих шаардлага

1995 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 171 тоот "ОХУ-ын Этилийн спирт, согтууруулах ундаа болон спиртийн агууламжтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг улсаас зохицуулах тухай Холбооны хууль[52]"-ийн 13 дугаар зүйлээр согтууруулах ундааны экспорт, импортын асуудлыг зохицуулжээ. Тус зүйлд зааснаар импортоор оруулж ирж буй согтууруулах ундааны чанар нь ОХУ-ын Засгийн газраас согтууруулах ундаанд тогтоосон улсын стандартад нийцсэн байхыг шаарддаг.

[52] Федеральный Закон РФ О государственном регулировании производства и оборота этилового спирта, алкогольной и спиртосодержащей продукции 1995.11.15 /с изменениями от 2010.12.28/

ОХУ-ын нутаг дэвсгэр дээрх согтууруулах ундааны импортын төрийн хяналтын гол үүргийг ОХУ-ын Гаалийн ерөнхий газар хүлээдэг байна[53]. Судалгаанаас үзэхэд, сүүлийн жилүүдэд ОХУ-ын согтууруулах ундааны импортын хэмжээ 30 хувиар нэмэгдсэн байна[54]. 2009 оны байдлаар ОХУ-ын согтууруулах ундааны импортын хэмжээ өсөөд зогсохгүй импортолж буй согтууруулах ундааны нэр төрөл нэмэгдсэн байна. Зөвхөн франц дарс гэхэд 2000 гаруй нэр төрлөөр импортлогдсон байна. 2009 онд ОХУ-д дэлхийн нийт 46 орноос согтууруулах ундаа импортлогдсон байна[55].

Дээрх тоо баримтууд нь ОХУ-ын согтууруулах ундааны импортын зах зээлийн хэмжээг илэрхийлж байна. Энэ ч үүднээс ОХУ-ын Засгийн газраас согтууруулах ундааны хэрэглээг багасгах төрийн бодлого явуулахын зэрэгцээ импортын асуудалд анхаарал хандуулах болсон юм.

Канад улсын хувьд нутаг дэвсгэр дээрх согтууруулах ундааны импортын төрийн хяналтын гол үүргийг Комисс хүлээдэг[56]. Дотоодын үйлдвэрлэгч нар үйлдвэрлэсэн согтууруулах ундаагаа Комисст хүлээлгэн өгөөд буцаан худалдан авдаг.

18.1 Борлуулалтын хяналт

2 дугаар дэд хэсэг болон энэ хууль бусад хуулиар комиссыг хэн нэгэнд согтууруулах ундаа худалдах, хүргэж өгөхийг шаардахгүй.

18.2 Дахин импортлох болон нийлүүлэх комиссын үүрэг

Тусгай дарсны дэлгүүрийн ажиллуулагчийн хүсэлтээр комисс

а/ худалдахаар зөвшөөрөгдсөн бүтээгдэхүүнийг зөв зохистой хүчин чармайлт гаргаж цаг үеэ олсон аргаар импортлоно.

b/ Импортоор ирсэн бүтээгдэхүүнийг дэлгүүр ажиллуулагчид цаг хугацаанд нь нийлүүлнэ.

Дөрөв. ОХУ, Канадад согтууруулах ундаагаар үйлчлэх цагийн хязгаарлалтын талаар:

1995 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 171 тоот "ОХУ-ын Этилийн спирт, согтууруулах ундаа болон спиртын агууламжтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг улсаас зохицуулах тухай Холбооны хууль[57]"-ийн 3.1 дүгээр зүйлд зааснаар согтууруулах ундааны жижиглэнгийн борлуулалтад цагийн хязгаарлалт тогтоож болно. ОХУ-ын хувьд согтууруулах ундааны борлуулалтад тавих цагийн хязгаарлалтыг ОХУ-ын субъектүүд дор бүрнээ хуульчлан зохицуулдаг бөгөөд ОХУ-ын зарим субъектүүдын харьяалах нутаг дэвсгэртээ тогтоосон цагийн хязгаарлалтыг хүснэгтлэн үзүүлэв[58].

[53] Мөн тэнд. Статья 13.

[54] «Граница на замке». // Народная газета, 2008 г., № 335.

[55] Импорт алкогольной продукции// реферат. www.allbest.ru /сүүлд үзсэн 2011.03.31/ С. 14

[56] Хуулийн 8.1 /а/ Согтууруулах ундааг худалдан авах, худалдах, импортлох эрхтэй.

[57] Федеральный Закон РФ О государственном регулировании производства и оборота этилового спирта, алкогольной и спиртосодержащей продукции 1995.11.15 /с изменениями от 2010.12.28/

[58] Ограничение времени розничной продажи алкогольной продукции /по субъектам РФ/ http://www.fsrar.ru/industry/analytics/ogranichenie-vremeni-roznichnoi-prodazhi-alkogolno /сүүлд үзсэн 2011.03.23/

Үүнд:

д/д	Бүсийн нэр	Борлуулахыг хориглосон цаг	Тайлбар
1	Москва хот	22^{00}-10^{00}	
2	Татар Улс	20^{00}-8^{00}	5 дугаар сарын 1-нд, 6 дугаар сарын 12-нд болон 9 дүгээр сарын 1-ний өдөр 8^{00} -аас эрт, 13^{00} -аас хойш борлуулахыг хориглоно.
3	Ульяановын бүс	20^{00}-8^{00}	
4	Ненецийн автономит тойрог	20^{00}-11^{00}	
5	Ивановын бүс	21^{00}-9^{00}	
6	Эрхүү хот	22^{00}-8^{00}	Бага, дунд сургуулийн ойролцоо бүсийн хувьд 8^{00}-19^{00}
7	Нижненовгородын бүсэд	22^{00}-8^{00}	Татваргүй барааны дэлгүүрт хамааралгүй

Тус хүснэгтээс харахад согтууруулах ундааны цагийн хязгаарлалтыг дараах байдлаар тогтоодог байна. Үүнд:

1.Тогтмол цагийн хязгаарлалт тогтоох;

2.Тодорхой бүсэд /бага, дунд сургуулийн ойролцоо, орон сууц нягтрал ихтэй бүс г.м./ согтууруулах ундааны борлуулалтын цагийн хязгаарлалтыг ялгаатай тогтоох;

3.Тогтоосон цагийн хязгаарлалт нь татваргүй барааны дэлгүүрт хамааралгүй байх;

4.Согтууруулах ундааны хэрэглээ өндөрсөж болох зарим баяр ёслолын үеэр борлуулалтын цагийг илүү хязгаарлах зэрэг зохицуулалтууд хийгддэг байна.

5.Тус хязгаарлалт нь нийтийн хоолны газарт хамаарахгүй.

Мөн согтууруулах ундааны борлуулалтад цагийн хязгаарлалт тогтооход ОХУ-ын субъект тус бүр өөрийн хуулираа согтууруулах ундааны спиртийн хэмжээг мөн тогтоодог байна. Тухайлбал, Кемерова мужийн хувьд 2010 оны 10 дугаар сарын 27-ны өдөр батлагдсан №108 "Кемерова мужид согтууруулах ундаа борлуулах цагийг хязгаарлах тухай хууль"-ийн 1 дүгээр зүйлд "15 хувиас дээш спиртийн агууламжтай согтууруулах ундааны жижиглэнгийн борлуулалтыг орон нутгийн цагаар 22^{00}-09^{00} цагийн хооронд хориглоно[59]" хэмээн зохицуулжээ. Москва хотын хувьд 2006 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн байдлаар 15 хувиас дээш хувийн спиртийн агууламжтай согтууруулах ундааны жижиглэнгийн борлуулалтыг 23^{00}-аас 08^{00} цагийн хооронд хориглодог байсан бол 2010 оны 9 дүгээр сараас эхлэн энэ хугацааг 3 цагаар уртасгаж 22^{00}-10^{00} болгон зохицуулсан байна[60].

[59] Закон Кемеровской области "Об установлении ограничения времени розничной продажи алкогольной продукции" 27 октября 2010 года № 108-ОЗ

[60]Запрет на ночную торговлю алкоголем в России http://www.rian.ru/infografi-

Москва хотын дарга ноён Сергей Собяниний нийслэлд хэрэгжүүлсэн тус хязгаарлалт нь шөнийн цагт гарч буй гэмт хэргийн тоог бууруулсан байна[61].

Канад улсын "Согтууруулах ундаанд хяналт тавих хууль"-д дараах байдлаар зохицуулжээ.

Хориглосон цаг:

41.16 Олон нийтийн арга хэмжээг дараах тохиолдолд зохион байгуулбал зөвшөөрөл олгохгүй.

а/Улаан өндөгний баярын өмнөх өдөр

б/18 дугаар зүйлээс гадна, орон нутгийн засаг захиргаа байрладаг газар

Худалдаалах цагууд:

54 /1/ Дараах өдрүүдэд согтууруулах ундааны борлуулалтын эсхүл согтууруулах ундааны худалдааны газраас өөр газарт согтууруулах ундааны худалдаа, хүргэлт хийхгүй.

/а/Ням гаригт:

- Шөнийн 00 цагаас өдрийн 12 цаг хүртэл;
- Оройн 18 цагаас хойш.

/b/ Улаан өндөгний баярын өдрийн өмнөх Баасан гариг, Улаан өндөгний баярын өдөр, Ням гариг эсхүл Зул сарын баярын өдөр

/c/ Дурсгалт өдрийн 13 цагаас өмнө;

/d/ бусад хугацаа, иймэрхүү бусад өдрийг комисс зааж өгч болно.

54/2/ Тусгай дарсны дэлгүүрт дээрх 1 дүгээр заалт хамаарахгүй.

Тав.ОХУ, Канадад согтууруулах ундааны хэрэглээнд тавих хяналт, хязгаарлалтын талаар

Согтууруулах ундааны жижиглэнгээр борлуулах зөвшөөрөл авсан хувь хүн, хуулийн этгээд нь **18 наснаас доош этгээдэд согтууруулах ундаа худалдаалахыг, тусгай зөвшөөрөлд хамаарах нутаг дэвсгэр дээр согтууруулах ундаа 18 наснаас доош насны этгээдэд хэрэглүүлэхийг хориглоно**[62]. ОХУ-ын Захиргааны хариуцлагын тухай хуульд зааснаар[63] энэ тохиолдолд худалдаж буй этгээдийн адилаар худалдаж авч буй 18 наснаас доош насны этгээд мөн хариуцлага хүлээнэ. Шар айраг, дарс, портвейн, алимны, эсхүл лийрний дарсыг **16-17 насны этгээдэд хооллох зориулалт бүхий газарт хоолны хамтаар өгөхийг зөвшөөрдөг байна**.

ОХУ-ын "Этилийн спирт, согтууруулах ундаа болон спиртын агууламжтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг улсаас зохицуулах тухай Холбооны

ka/20100901/271022218.html /сүүлд үзсэн 2011.03.23/

[61]Польза от запрета на торговлю алкоголем ночью очевидна, заявил Собянин http://rian.ru/moscow/20101112/295423170.html /сүүлд үзсэн 2011.03.23/

[62]Федеральный закон РФ "О Государственном регулировании производства и оборота этилового спирта, алкогольной и спиртосодержащей продукции" 19 июня 1995 года № 171-ФЗ /с изменениями от 28.12.2010/ Статья 16.

[63]Кодекс РФ об административный правонарушениях 30 декабря 2001 года № 195-ФЗ / с изменениями от 07.02.2011/

хууль[64]"-ийн 16 дугаар зүйлд зааснаар **насанд хүрэгүй этгээдэд** согтууруулах ундаа борлуулахдаа худалдагч нь **тухайн этгээдийн насны хувьд эргэлзээ төрсөн тохиолдолд иргэний үнэмлэх, гадаад иргэнээс гадаад паспортыг үзэж шалгах эрхтэй** байна[65].

ОХУ-ын Засгийн газраас 2009 оноос эхлэн согтууруулах ундааны хэрэглээ, үйлдвэрлэлтийн талаар төрийн бодлого боловсруулахад анхаарал хандуулж ирсэн байна. Тухайлбал, ОХУ-ын Согтууруулах ундааны зах зээлийг зохицуулах Холбооны албаны 2009 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн "2010 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөх Жижиглэнгийн архины доод үнийг тогтоох тухай" №17 тоот тушаалаар ОХУ-ын нутаг дэвсгэр дээр 0,5 литрийн хэмжээтэй архийг 89 рублээс хямд үнээр жижиглэнгээр худалдаалж болохгүй болохыг тогтоов[66]. Судлаачдын үзэж байгаагаар ОХУ-ын Засгийн газраас шар айрагны зах зээлд хөнгөлөлт үзүүлэх замаар архины хэрэглээг багасгаж, "илүү зөөлөн" шар айраагаар орлуулах бодлого баримталж байгаа[67]. "ОХУ-ын Засгийн газраас баримталж буй уг "зөөлрүүлэх" арга хэмжээ нь харин ч сөрөг нөлөө үзүүлнэ хэмээн дүгнэгдсэн байна. Дэлхийн практикаас харахад архийг "зөөлрүүлэх" арга хэмжээнд шар айраг бус виног ашигладаг. Европын зарим орнуудын жишээг харахад төрөөс виноны зах зээлд хөнгөлөлт, дэмжлэг үзүүлснээр архины хэрэглээ багасдаг байхад харин шар айраг бол сөрөг нөлөөтэй. Учир нь шар айраг хэрэглэгчдийн дийлэнх хувийг өсвөр үеийнхэн эзэлдэг нь ирээдүйн архичдыг бэлтгэх шат болж өгдөг[68]" хэмээн "Ведомости" сонинд "Ладога" ХХК-ны /согтууруулах ундааны томоохон үйлдвэрлэгч/ Ерөнхийлөгч Вениамина Грабар ярилцлага өгчээ.

ОХУ-ын Засгийн газрын тогтоолоор 2009 оны 12 дугаар сарын 30-ны өдөр "2020 он хүртэлх хугацаанд ОХУ-ын ард иргэдийн дунд согтууруулах ундааны зохисгүй хэрэглээний хэмжээг бууруулах буюу архидан согтуурлыг урьдчилан сэргийлэх улсын бодлогыг хэрэгжүүлэх тухай үзэл баримтлал[69]"-ыг баталжээ. Тус үзэл баримтлалд ОХУ дахь архины хэрэглээний нөхцөл байдал, статистик тоо баримт, өсөлтийн хэмжээний талаар тус тус тусгажээ. Тухайлбал, Согтууруулах ундааны нэг хүнд ногдох жилийн нормыг /6 литр/ хэтрүүлэн хэрэглэсэн тохиолдолд эрэгтэй хүний наснаас 11 сар, эмэгтэй хүний наснаас 4 сар богиносдог хэмээн үзжээ. Үзэл баримтлалын 7 дугаар бүлэгт 2020 он хүртэл ОХУ-ын ард иргэдийн дунд согтууруулах ундааны

---

[64]Федеральный Закон РФ О государственном регулировании производства и оборота этилового спирта, алкогольной и спиртосодержащей продукции 1995.11.15 /с изменениями от 2010.12.28/

[65] Мөн тэнд.

[66] Федеральная служба по регулированию алкогольного рынка http://www.fsrar.ru /сүүлд үзсэн 2011.03.31/

[67]Интервью Президента ОАО «Промышленная группа «Ладога» Вениамина Грабара, опубликованное в газете "Ведомости"22 июля 2010 г http://www.spap.ru/announces/article11/ /сүүлд үзсэн 2011.03.31/

[68] Мөн тэнд.

[69]"Концепция реализации государственной политики по снижению масштабов злоупотребления алкогольной продукцией и профилактике алкоголизма среди населения Российской Федерации на период 2020 года" 2009.12.30 № 2128-р

зохисгүй хэрэглээний хэмжээг бууруулах буюу архидан согтуурлаас урьдчилан сэргийлэх улсын бодлогыг хоёр үе шаттайгаар явуулахаар болсон байна.

Нэгдүгээр үе шат /2010-2012 он/: Үүссэн нөхцөл байдлыг дүгнэх, үнэлэх, нөхцөл байдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх эрх зүй, зохион байгуулалт болон санхүүгийн тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох;

Хоёрдугаар үе шат /2013-2020 он/: Тодорхойлсон хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хэрэгжүүлэлтийн арга хэмжээгээр статистик тоо мэдээгээр үр дүнг баталгаажуулах, цаашид арга хэмжээний хэрэгжилтийг урт хугацааны болгох суурь тавих зорилгуудыг тавьжээ[70].

Согтуурулах ундааны хэрэглээтэй холбоотой төрийн хяналт, хязгаарлалтын талаар бас нэгэн асуудлыг судлалгүй үлдээж болохгүй. 2010 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль[71]"-д орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу тус хуулийн 23 дугаар зүйлд тээврийн хэрэгсэл жолоодогч согтуурулах ундаа хэрэглэхийг хориглосон байна. Өмнөх хуулийн зохицуулалтаар тээврийн хэрэгслийн жолоочийн согтуурулах ундааны зөвшөөрөгдсөн хэрэглээ 0,3 промилле буюу энэ нь 330 гр шар айрагны хэмжээнээс хэтрэхгүй байх ёстой. Шинэ зохицуулалтаар согтуурулах ундааны хэрэглээг жолооч нарт бүрмөсөн хориглосон байна[72].

Согтуурулах ундааны хэрэглээг хязгаарлах зорилгоор ОХУ-ын Засгийн газраас онцгой албан татвар ногдуулах хэмжээг ихэсгэх бодлогыг баримтлах болсон[73]. ОХУ-ын Сангийн яамны санаачилгаар татварын хууль тогтоомжид согтуурулах ундааны онцгой албан татварын хэмжээг ихэсгэх талаар нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. ОХУ-ын Татварын ерөнхий хуулийн 193 дугаар зүйлд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу согтуурулах ундааны онцгой албан татварын хэмжээг 2011 оны 1 дүгээр сарын 1-нээс 12 дугаар сарын 31-ний хооронд ногдуулах хэмжээ, 2012 оны 1 дүгээр сарын 1-нээс 12 дугаар сарын 31-ний хооронд ногдуулах хэмжээ, 2013 оны 1 дүгээр сарын 1-нээс 12 дугаар сарын 31-ний хооронд ногдуулах онцгой албан татварын хэмжээг тус тус тогтоосон байна[74].

[70] Мөн тэнд. Глава 2.

[71] Федеральный закон от 10.12.1995 N 196-ФЗ /ред. от 27.07.2010/ "О безопасности дорожного движения"

[72] Мөн тэнд. Статья 23.

[73] Виноват не алкоголь, виноват человек! http://www.fsrar.ru /сүүлд үзсэн 2011.03.31/

[74] Федеральный закон "О внесении изменений в часть первую и часть вторую Налогового Кодекса Российской Федерации и закон Российской федерации "О налоговых органах Российской Федерации" 19 ноября 2010 года.

Үүнд:

№	Согтууруулах ундааны төрөл	Онцгой албан татвар ногдуулах хэмжээ /рублээр/		
		2011.01.01-12.31-ний хооронд мөрдөгдөх хэмжээ	2012.01.01-12.31-ний хооронд мөрдөгдөх хэмжээ	2013.01.01-12.31-ний хооронд мөрдөгдөх хэмжээ
1.	Этилийн спиртийн 9 хувиас илүү хэмжээтэй согтууруулах ундаа	1 литр цэвэр этилийн спиртэд 231 рубль	1 литр цэвэр этилийн спиртэд 254 рубль	1 литр цэвэр этилийн спиртэд 280 рубль
2.	Этилийн спиртийн 9 хувиас доош хэмжээтэй согтуруудах ундаа	1 литр цэвэр этилийн спиртэд 190 рубль	1 литр цэвэр этилийн спиртэд 230рубль	1 литр цэвэр этилийн спиртэд 245 рубль
3.	Дарс /этилийн спиртний 6 хувиас хэтрэхгүй агууламжтай/	1 литр дарсанд 5 рубль	1 литр дарсанд 6 рубль	1 литр дарсанд 7 рубль
4.	Оргилуун дарс	1 литр тутамд 18 рубль	1 литр тутамд 22 рубль	1 литр тутамд 24 рубль
5.	Шар айраг /этилийн спиртний 0.5 хувиас хэтрэхгүй агууламжтай /	1 литр тутамд 0 рубль	1 литр тутамд 0 рубль	1 литр тутамд 0 рубль
6.	Шар айраг /этилийн спиртний 8.6 хувь хүртэл хэтрэхгүй агууламжтай /	1 литр тутамд 10 рубль	12 литр тутамд 0 рубль	13 литр тутамд 0 рубль
7.	Шар айраг /этилийн спиртний 8.6 хувиас дээш агууламжтай /	1 литр тутамд 17 рубль	1 литр тутамд 21 рубль	1 литр тутамд 23 рубль

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nji.gov.mn

Канадын комисс бол согтууруулах ундааг хувь хүнд худалдах эрхтэй байдаг. Канадын Согтууруулах ундаанд хяналт тавих хуулийн 49 /4/-т Комиссоос согтууруулах ундааг худалдаж авахаар хандсан иргэн 18 нас хүрээгүй гэдэгт Комисс эргэлзвэл насанд хүрснээ нотлох хүртэл худалдан авах эрхийг олгохгүй.

Мөн хуулийн 121 /5/-д Энэ хуулиар зөвшөөрөгдсөнөөс бусдаар 18 нас хүрээгүй хүн согтууруулах ундаа хэрэглэсэн тохиолдолд зөрчил гаргасанд тооцно.

121 /4/ Хуурамч бичиг баримт.

Согтууруулах ундааг худалдаж авах, эсхүл зөвшөөрөгдсөн газарт орохдоо хэн ч:

a/ нас болон өөрийгөө хуурамчаар таниулах бичиг баримтыг үзүүлж болохгүй.

b/ Хууль бусаар олгосон байж болохгүй

c/ Өөр хүнд олгосон

Зургаа. ОХУ, Канад улсад согтууруулах ундааны ил, далд сурталчилгааг зохицуулж буй байдлын талаар

ОХУ-ын хувьд 2006 онд олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр соогтууруулах ундааны зар сурталчилгаанд олон тооны хязгаарлалт тогтоож өгсөн. 2006 онд ОХУ-ын Зар сурталчилгааны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, соогтууруулах ундааны зар сурталчилгааг бүрэн хориогүй ч тус сурталчилгааны агуулга, нэвтрүүлэх арга хэлбэрийн хувьд хориглосон зохицуулалтыг хуульчилж өгсөн байна. ОХУ-ын "Зар сурталчилгааны тухай хууль"-ийн 21 дүгээр зүйлд соогтууруулах ундааны зар сурталчилгааны талаар зохицуулсан ба соогтууруулах ундааны зар сурталчилгаа нь дараах мэдээлэл агуулахыг хориглосон байна[75]. Үүнд:

✓ Соогтууруулах ундаа хэрэглэснээр нийгэмд эзлэх байр суурьиа дээшлүүлэх, мэргэжлийн, биеийн тамирын болон хувийн амжилтанд хүрэх арга зам олох гэх мэт мэдээллийг агуулсан байх;

✓ Соогтууруулах ундааны хэрэглээг багасгаж буй байдлыг шүүмжилсэн утгатай мэдээлэл;

✓ Соогтууруулах ундаа хэрэглэснээр эрүүл мэндэд ямар ч сөрөг нөлөөгүй, харин ч эерэг нөлөөтэй гэсэн мэдээлэл;

✓ Соогтууруулах ундаа хэрэглэх нь амны цангааг тайлах нэг арга мэт сурталчлах;

✓ Насанд хүрээгүй этгээдэд шууд хандсан мэдээлэл;

✓ Насанд хүрээгүй этгээдийг сурталчилгаанд оролцуулах.

Дараах аргаар Олон нийтийн хэвлэл, мэдээллээр соогтууруулах ундаа сурталчлахыг хориглоно. Үүнд:

✓ Сонин, сэтгүүлийн хамгийн эхний болон сүүлийн нүүрэнд;

✓ Насанд хүрээгүй этгээдэд зориулсан хэвлэл, аудио болон видео бүтээгдэхүүнд;

✓ Телевиз болон радио нэвтрүүлгээр, кинотеатрын үзвэрийн үеэр;

✓ Нийтийн тээврийн хэрэгсэлд байршуулах замаар;

✓ Бага насны хүүхдийн, боловсрол, эрүүл мэнд, амралт сувилал, эмчилгээ, цэргийн байгууллагын байр, театр, цирк, музей, соёлын төв, концерт, тоглолтын танхим, үзэсгэлэн, номын сан, лекцийн танхим болон тэдгээртэй 100 метрийн ойролцоо талбайд байршуулахыг;

✓ Спортын ордон, эрүүлжүүлэх, бялдаржуулах төвийн байранд болон тэдгээртэй 100 метрийн ойролцоо талбайд байршуулахыг тус тус хориглоно.

ОХУ-ын "Зар сурталчилгааны тухай хууль"-ийн 24.3-т заасны дагуу "Соогтууруулах ундааны зар сурталчилгаа нь соогтууруулах ундааны эрүүл мэндэд хортой талаарх сануулгыг агуулах ёстой ба тус сануулга нь тухайн зар сурталчилгааны талбайн орон зайн 10 хувийг эзлэх ёстой" хэмээн хуульчилжээ[76]. Мөн соогтууруулах ундааны зар сурталчилгааг явуулж байгаа тохиолдолд тус арга хэмжээнд насанд хүрээгүй этгээдийг оролцуулах, тус бүтээгдэхүүний жижиглэсэн загварыг /тестээр/ тусгай зөвшөөрөлгүйгээр тараах зэргийг хориглоно.

ОХУ-ын хувьд олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр соогтууруулах ундааны далд сурталчилгааг явуулах тохиолдол элбэг байдаг байна. Ингэхдээ соогтууруулах ундаа үйлдвэрлэгчид өөрийн үйлдвэрлэж буй соогтууруулах ундаа бүхий бүтээгдэхүүнтэйгээ ижил, төсөөтэй нэр, шошго

[75] Федеральный закон РФ "О Рекламе" 2006.03.13 24 статья.

[76] Мөн тэнд. Статья 24.2.

бүхий цэвэр ус, коктейлийн зар сурталчилгааг явуулах аргыг өргөн хэрэглэсэн байна[77]. Тухайлбал, Diageo ХХК-ний Johnnie Walker брэнд, РВВК ХХК-ний «Флагман» брэнд, «Кристалл» ХХК-ний «Гжелка» брэнд зэрэг жишээ татаж болно[78]. Сүүлийн үед энэ аргыг илрүүлэн тогтоож таслан зогсоох арга хэмжээг ОХУ-ын Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах хороо, ОХУ-ын Согтууруулах ундааны зах зээлийг зохицуулах Холбооны албатай хамтран тухайн сурталчилгааны далд утгын талаар ард түмний дунд санал асуулга авсны үр дүнд тус сурталчилгаа нь санал болгож буй коктейль, цэвэр усыг бус ижил нэр бүхий согтууруулах ундааны талаар ойлголт өгч байгаа гэсэн дүгнэлтэд хүрчээ. Үүний дагуу 2010 оны 10 дугаар сард "Флагман" болон Оросын зарим үйлдвэрүүдийн бүтээгдэхүүний сурталчилгааны кампанит ажлыг таслан зогсоожээ. Гэвч тухайн арга хэмжээ нь согтууруулах ундаа үйлдвэрлэгчдийг зогсоож чадаагүй төдийгүй цэвэр ус, коктейлээр далд сурталчилгаа явуулах аргын оронд шинэ аргуудыг хэрэглэж эхлэхэд хүргэсэн байна[79]. Тухайлбал, согтууруулах ундааг ном, дууны түүвэр зэрэг хэрэгслийг ашиглан далд аргаар сурталчлах болжээ. Үүнээс зарим жишээг дурьдахад: Москва хотын төвийн гудамжаар "Миний овог Виноградов" гэсэн бичилт бүхий дундаж насны, чинээлэг дүр төрхтэй эрэгтэйн дүрстэй сурталчилгааны зураг олноор байршуулсан байв. "Виноградов" гэдэг нь Орос улсад олонд танигдсан согтууруулах ундааны брэнд бөгөөд энэхүү сурталчилгааг харсан хүмүүст нэг талаасаа "Виноградов" хэмээх согтууруулах ундааны талаар сэтгэгдэл шууд төрдөг байна. Мөн нэг талаас олон жилийн түүхтэй архи гэдэг нь нас тогтсон эрэгтэй хүний дүрээр илэрхийлж, нөгөө талаас чинээлэг эрэгтэй хүний хэрэглээ гэсэн ойлголтуудыг хэрэглэгчдийн дунд төрүүлж байна. Далд сурталчилгааны бас нэгэн жишээг дурьдахад, "Эх орон" нэртэй дууны түүвэр ном худалдаанд гарсан байна. Номны нүүрэн дээр "Эх оронтой байвал илүү хөгжилтэй" хэмээн бичсэн байна. Энэхүү номонд найз нөхдийн дунд дуулж болох ардын дууны үгийг агуулсан нь "Эх орон" нэртэй брэндийн согтууруулах ундааг сурталчилаад зогсохгүй, түүвэрт орсон дууг "Эх орон" брэндийн согтууруулах ундааг хэрэглэх үед дуулж болно гэсэн сэтгэгдэл төрүүлэхийг эрмэлзсэн байна.

Энэхүү далд зар сурталчилгаатай тэмцэх үүрэг ОХУ-ын Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах хороо, ОХУ-ын Согтууруулах ундааны зах зээлийг зохицуулах Холбооны албанд тус тус оногддог байна. Тус байгууллагууд нь согтууруулах ундааны далд сурталчилгаг хуулийн хүрээнд таслан зогсоох боломжгүй хэмээн үзэж ард түмний дунд албан ёсны санал асуулга явуулсны үр дүнд зарим суртачилгааны кампанит ажлыг таслан зогсоодог байна. Гэвч энэ нь дорвитой үр дүнд хүрч чаддаггүй төдийгүй согтууруулах ундааны үйлдвэрлэгчид шинэ шинэ аргуудыг сэдсээр байна. Тухайлбал, дээр дурьдсан "Виноградов" брэндийн хувьд уг согтууруулах ундааны тэмдэг болох лого, шошгыг суртачилгаандаа хэрэглээгүйн улмаас "далд сурталчилгаа" явуулсан хэмээн үзэх боломжгүй болсон байна. ОХУ-ын Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах хорооны санаачилгаар

[77] Производители водки обходят ограничения на рекламу http://foodsmarket.info/news/content.php?id_ groups=25&id_news=1131 /сүүлд үзсэн 2011.03.30/

[78] Реклама зонтичных брэндов алкогольной продукции http://www.dela.ru/news/other/4153/ / сүүлд үзсэн 2011.03.30/

[79] Производители водки обходят ограничения на рекламу http://foodsmarket.info/news/content.php?id_ groups=25&id_news=1131 /сүүлд үзсэн 2011.03.30/

"Зар сурталчилгааны тухай хууль"-д "Согтууруулах ундааны барааны тэмдэгтэй ойролцоо тэмдэг бүхий зар сурталчилгааг хориглох" талаар нэмэлт, өөрчлөлт оруулахаар хуулийн төсөл бэлтгэж байна[80].

Канадын Согтууруулах ундаанд хяналт тавих хуульд:

125 /1/ Сурталчлах

Энэ хуулийн дагуу эсхүл Хууль тогтоох байгууллагын бусад актаар, парламентын хууль тогтоомж болон зөвшөөрөгдсөн зохицуулалтаас гадна хэн ч

a/ Комиссоос тусгайлан зөвшөөрөгдөөгүй бол согтууруулах ундаа худалдаж авах болон худалдах эсхүл төлөөлөгч болон зуучлагч болж согтууруулах ундааг худалдах болон худалдан авах, өөрсдийгөө төлөөлөгч болон зуучлагч гэж үзэж сурталчлах шийдвэрийг хүлээж авах, олж авахаар хөөцөлдөх;

b/ согтууруулах ундааны тухай, эсхүл энэ талаарх мэдээлэл болон согтууруулах ундааг хэнээс, хаанаас авсан, мөн газар, хүнийг заан сурталчлахаар нэвтрүүлэх, хэвлэх, нийтэд мэдээлэх, дэлгэн харуулах, үзэсгэлэн гаргах зөвшөөрөл олгох, мөн түүнчлэн хэвлэх, эсхүл хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлэх, нөлөөлөхийг хориглоно.

125 /2/ Хамаарахгүй зүйл

Дараах зүйлийг энэ хэсэг хориглохгүй

a/ Комисс согтууруулах ундааны талаарх мэдээллийг хэвлүүлэх, нийтэд үзүүлэх, дэлгэн тавих;

b/ Комисс, эсхүл зөвшөөрөл эзэмшигч нь согтууруулах ундааг хууль ёсоор худалдан борлуулах, эсхүл согтууруулах ундааг хэрэглэх газарт үзэсгэлэн гаргах /дэлгэн тавих/;

c/ Хувь хүн сурталчилахаар согтууруулах ундааг худалдан авах шийдвэр комиссоос гарсан тохиолдолд.

7. Орос, Канад зэрэг оронд согтууруулах ундаа худалдах цэгийн тоог хүн амын тооноос хамааран тогтоодог эсэх, Монгол Улсад уг туршлагыг нэвтрүүлэх боломжтой эсэх

Канадад Комисс нь согтууруулах ундааны дэлгүүрийн байршлыг тухайн орон нутагт тогтоож, дэлгүүрийн нөхцөл байдал эсхүл ямар нэгэн газарт дэлгүүрийг тухайн орон нутгийн хэмжээнд бий болгоно[81] гэсэн заалт нь хүн амын тоог биш согтууруулах ундааны дэлгүүрийн байршил, менежмент, ерөнхий хяналтыг удирдан хариуцдаг.

ОХУ болон Канадад одоогоор ийм зохицуулалт байхгүй. Энэ бүгдээс үзэхэд судалсан 2 орны эрх зүйн зохицуулалт болон практикт согтууруулах ундаа худалдах цэгийн тоог хүн амын тооноос хамааруулан тогтоогоогүй байна.

Иймд судлагдсан орны жишээгээр Монгол Улсад согтууруулах ундаа худалдах цэгийн тоог хүн амын тооноос хамааруулан тогтоох туршлага нэвтрүүлэх боломжгүй байна.

[80] Мөн тэнд.

[81] Согтууруулах ундаанд хяналт тавих хуулийн 8.1 /c/ дэх заалт.

Дүгнэлт

1.Үйлдвэрийн тоог хуулиар нарийвчлан зохицуулаагүй. Харин улсын стандартад нийцэхгүй байгаа **үйлдвэрлэл, борлуулалтыг зогсоох, бүтээгдэхүүний чанар, тоонд хязгаарлалт** тавих замаар асуудлыг зохицуулж байна.

2.ОХУ-д үйлдвэрт хяналт тавьж төрийн чиг үүргийг хэрэгжүүлдэг нэгж байдаггүй. 28 хувиас дээш спиртийн агууламжтай согтуруулах ундаа үйлдвэрлэх үйлдвэрийн тоо хэмжээнд хяналт тавих зорилгоор хяналтын тоног төхөөрөмж тухайн үйлдвэрт байршуулдаг. Байрлуулахгүй бол торгох, байрлуулах хүртэл үйл ажиллагааг нь зогсоодог арга хэмжээ авдаг байна.

3.ОХУ-ын хилээр оруулж ирж буй согтуруулах ундаа нь Засгийн газраас тогтоосон стандартад нийцсэн байхыг шаардаг. Канадад Улсын Комисс нь импортыг хариуцдаг.

4.ОХУ-ын хувьд 6 бүс нутгийн хэмжээнд авч үзэхэд 20^{00}, 21^{00}, 22^{00} цагаас 8^{00}, 9^{00}, 10^{00}, 11^{00} цаг хүртэл согтуруулах ундаа худалдахыг хориглосон байна.

Харин Канад улс цагийн төдийгүй олон нийтийн арга хэмжээ, амралтын өдөр

/a/ Ням гаригт: - Шөнийн 00 цагаас өдрийн 12 цаг хүртэл; - Оройн 18 цагаас хойш.

/b/ Улаан өндөгний баярын өдрийн өмнөх Баасан гариг, Улаан өндөгний баярын өдөр, Ням гариг эсхүл Зул сарын баярын өдөр;

/c/ Дурсгалт өдрийн 13 цагаас өмнө;

/d/ бусад хугацаа, иймэрхүү бусад өдрийг комисс зааж өгч болно.

5.ОХУ, Канад улсад 18 насанд хүрээгүй хүнд[82] согтуруулах ундаа худалдаалах, хэрэглүүлэхийг хориглож, зөрчилд тооцож байна. Мөн согтуруулах ундаа борлуулахдаа худалдагч нь тухайн этгээдийн насны хувьд эргэлзээ төрсөн тохиолдолд бичиг баримтыг шалгах, нотлох хүртэл худалдан авах эрх олгохгүй байхаар аль алинд нь зохицуулагдсан байна.

6.ОХУ болон Канадад одоогоор ийм зохицуулалт байхгүй. Энэ бүгдээс үзэхэд судалсан 2 орны эрх зүйн зохицуулалт болон практикт согтуруулах ундаа худалдах цэгийн тоог хүн амын тооноос хамааруулан тогтоогоогүй байна.

Иймд судлагдсан орны жишээгээр Монгол Улсад согтуруулах ундаа худалдах цэгийн тоог хүн амын тооноос хамааруулан тогтоох туршлага нэвтрүүлэх боломжгүй байна.

--oOo--

[82] Согтуруулах ундааг насанд хүрээгүй байх үедээ /залуугаас/ хэрэглэснээр архинд донтох өвчинд өртөх эрсдэл нэмэгдэг байна.
- 15 насанд хүрээгүй бол 40%
- 17 насанд хүрээгүй бол 25%
- 21-25 насанд хүрээгүй бол 10%
- 25-аас дээш бол 2,5% байна /Архины хэрэглээг хязгаарлах/

"СОНГУУЛИЙН ЭРХ ЗҮЙ ДЭХ ХАРИУЦЛАГЫН ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ"[83]

ОРШИЛ

1992 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр анхны Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийг баталсан. Энэ хуулийн дагуу 1992 оны ээлжит сонгуулийг зохион байгуулж явуулсан. Түүнээс хойш нэг удаа буюу 1996 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Тус хуулиар 1996, 2000, 2004 оны Улсын Их Хурлын /цаашид УИХ гэх/ ээлжит сонгууль болон нөхөн сонгуулийг зохион байгуулсан.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль /цаашид МУИХСТХ гэх/ нь 11 бүлэг, 58 зүйлтэй юм.

Энэ хуулийн дагуу 2008 оны УИХ-ын сонгуулийг зохион байгуулж явуулсан билээ. 2008, 2009, 2010, 2011 онуудад буюу нийт 4 удаагийн нэмэлт, өөрчлөлт орсон.

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль, болон бусад хуульд заасан сонгуулийн маргаантай холбогдуулан хүлээлгэх хариуцлагын хэм хэмжээ түүний хэрэгжилт, сонгуулийн холбогдолтой маргааныг шийдвэрлэх үйл явц, шүүхийн практик, харьяаллын асуудлыг энэхүү судалгаагаар хөндөж авч үзэв. Мөн судалгааны ажлын удирдамжид заасны дагуу эрх зүйн болон сонгуулийн ижил буюу төстэй систем бүхий зарим орон тухайлбал, ОХУ, Украйн, Тайланд, Канад зэрэг орны хариуцлагын тогтолцооны эрх зүйн үндсийг судлав. Түүнчлэн Мексик, Мали, Буркина Фасо, Армени, Алжир зэрэг улсын хууль тогтоомж дахь сонгуулийн холбогдолтой зөрчилд хүлээлгэх хариуцлагын зарим төрөл хэмжээ, сонгуулийн маргааныг шийдвэрлэх байгууллагын талаар хүснэгтлэн харууллаа.

Тус судалгааг хийж гүйцэтгэхийн тулд Сонгуулийн ерөнхий хороо /цаашид СЕХ гэх/, Нийслэлийн шүүх, Цагдаагийн ерөнхий газар /цаашид ЦЕГ гэх/-аас зохих мэдээлэл авахаар албан бичиг илгээсэн ба СЕХ-ноос судалгаанд холбогдох зохих мэдээлэл авч чадаагүйг дурдах нь зүйтэй. Бусад байгууллагаас зарим мэдээллийг авсан.

Иймээс СЕХ-ны хүлээн авсан, шийдвэрлэсэн маргааны тухайд дүгнэлт хийхэд хүндрэлтэй болсон. Судалгаанд Үндсэн хуулийн цэц /цаашид Цэц гэх/, иргэний хэргийн шүүхийн шийдвэр, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр, шүүгчийн захирамж зэргийг ашиглав.

[83] Энэ судалгааг ХЗДХЯ-аас боловсруулж буй төслийн хүрээнд ЗХЭЗС 2011 оны 5 дугаар сард хийж гүйцэтгэсэн болно.

НЭГ. ҮНДСЭН ХУУЛЬ БАТЛАГДСАНААС ХОЙШХ ХУГАЦААНД ЯВАГДСАН УИХ-ЫН СОНГУУЛИЙН ҮЕД ГАРЧ БАЙСАН МАРГААН ЗӨРЧИЛ, СОНГУУЛИЙН МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ҮЙЛ ЯВЦ

1.1.Сонгуулийн маргааны тухай

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуульд гомдол, маргааныг хянан шийдвэрлэхтэй холбогдсон асуудлыг тусгайлсан 2 зүйл /21, 57/, 15 заалтаар, Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд 2 заалт /7.4.3, 14.3/-аар тус тус зохицуулж байна.

Зөрчил гаргасан иргэн, албан тушаалтан, байгууллагад хариуцлага хүлээлгэж буй нь маргаан зөрчилтэй асуудлыг шийдвэрлэсний үр дүн юм. Эрх, журам зөрчсөнтэй холбоотой өөр цөөнгүй асуудал сонгуулийн явцад үүсдэг билээ.

Сонгогчийн эрх, сонгуулийн харилцааны талаарх Үндсэн хууль, сонгуулийн болон бусад хууль, тэдгээрт нийцсэн хэм хэмжээний /дэд/ актыг зөрчсөн тухай иргэн, нам, эвсэл, нэр дэвшигч, тэдгээрийн төлөөлөгчдөөс гаргасан хүсэлт, гомдол, нэхэмжлэлийн үндсэн дээр үүссэн маргааныг сонгуулийн маргаан гэж болно /Б.Чимид. Сонгуульд суралцахуй: тогтолцоо, үйл явц, эрх зүй. УБ., 2008.271 дэх тал/.

Маргааныг дотор нь:

- Иргэний сонгох сонгогдох эрх, сонгуулийн талаарх Үндсэн хуулийн заалт зөрчсөн тухай маргаан;
- Сонгуулийн үйл явцын талаарх засаг захиргааны журам зөрчсөн тухай маргаан;
- Сонгууль бэлтгэн явуулахтай холбогдсон эд хөрөнгийн болон түүнтэй холбоотой эд хөрөнгийн биш хувийн эрхийн маргаан;
- Иргэдийн сонгох, сонгогдох эрх, сонгуулийн хууль тогтоомжийг гэмт хэргийн шинж бүрдэлтэйгээр зөрчсөн тухай маргаан гэхчлэн ялган хуульчилж шийдвэрлэнэ. Эдгээрээс гадна сонгуулийн хорооны гишүүн, холбогдох бусад албан тушаалтан төрийн албаны зарчим, холбогдох журамд харш эндэгдэл, ёс зүйн шинжтэй зөрчил гаргаж болзошгүйг МУИХСтХ-иар сэргийлж заасан зүйл байдаг.

Дээрх ангилал нь **маргаан бүхий хэргийн харьяаллыг,** өөрөөр хэлбэл сонирхогч этгээд өргөдөл, гомдол, нэхэмжлэлээ хаана, ямар байгууллагад гаргаж шийдвэрлүүлэхийг олж мэдэхэд зайлшгүй хэрэгтэй юм[84].

1.2.Маргааны /хэргийн/ харьяалал

Сонгуулийн маргааны хувьд «**нутаг дэвсгэрийн**», "**шийдвэрлэгч байгууллагын** /субъектын/", мөн **хэргийн харьяаллын маргаан** гэж бий.

[84] Чимид Б.Сонгуульд суралцахуй: тогтолцоо, үйл явц, эрх зүй. УБ., 2008. 271 дэх тал.

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлд сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн маргааныг шийдвэрлэх харьяаллыг тогтоосон байна. Энэ зүйлд зааснаар:

1.Хуульд зааснаар сонгуулийн хороод харьяалан шийдвэрлэх зөрчил гаргасан бол гомдлыг холбогдох сонгуулийн хороонд гаргах;

2.Энэ хуульд заасан захиргааны шийтгэлийг сум, сум дундын болон дүүргийн шүүхийн шүүгч ногдуулах ба түүнийг давж заалдсан гомдлыг ИХШХШТ хуульд заасны дагуу сум, сум дундын болон дүүргийн шүүх хянан шийдвэрлэх;

3.УИХСТХ-ийн холбогдох заалтыг зөрчсөн этгээдэд эрүүгийн болон иргэний хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх асуудлыг Эрүүгийн байцаан шийтгэх хууль /цаашид ЭБШХ гэх/ болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /цаашид ИХШХШТХ гэх/ заасан журам, харьяаллын дагуу шийдвэрлэх;

4.Хөрөнгө улсын орлого болгох тухай нэхэмжлэлийг СЕХ нь хяналт шалгалтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн сум буюу сум дундын, дүүргийн шүүхэд гарган шийдвэрлүүлэх журам тогтоожээ.

Сонгуулийн маргааныг **шийдвэрлэгч байгууллагаар** нь:

- Захиргааны журмаар шийдвэрлэх;
- Шүүхийн журмаар шийдвэрлэх гэсэн хоёр үндсэн хэсэгт хуваана.

Захиргааны журмаар шийдвэрлэх маргаан гэдэгт УИХСТХ-д зааснаар сонгуулийн хороодоос тус тусын эрх хэмжээ, нутаг дэвсгэрийн харьяаллын дагуу өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэх маргаан орно.[85]

Шүүхийн журмаар шийдвэрлэх маргаан гэдэгт:

- Сонгуулийн талаарх захиргааны зөрчлийн тухай маргааныг шүүх анх тутам шийдвэрлэхээр хуульд тусгайлан заасан маргаан;
- Дээд шатны захиргаа /тойргийн болон СЕХ/ шийдсэний дараа уг шийдвэрийг холбогдох этгээд эс зөвшөөрч шүүхэд хандсанаар үүссэн сонгуулийн маргаан;
- Мөн хуульд шүүх шууд /шат дамжлагагүй/ харьяалан шийдвэрлэнэ гэж тусгайлан заасан **эд хөрөнгийн** болон **эрүүгийн хэргийн шинжтэй** маргаан хамаарна.

Хоёр. Сонгуулийн хороодоос /захиргааны журмаар/ шийдвэрлэх маргаан

2.1. Хороодын тус тусын харьяалах маргаан

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 19.10-т зааснаар хэсгийн болон салбар хорооны шийдвэрийн талаар тойргийн хороонд, тойргийн хорооны шийдвэрийн талаар Сонгуулийн ерөнхий хороонд гомдол гаргах бөгөөд холбогдох хороо гомдлыг хүлээн авснаас хойш ажлын гурван өдрийн дотор хянан шийдвэрлэж хариуг мэдэгдэх нийтлэг журмыг тогтоожээ. Харин сонгогчдын нэрийн жагсаалтын талаарх гомдлыг хэсгийн хороо хүлээн

[85] Мөн тэнд

авснаас хойш ажлын гурван өдрийн дотор, хэрэв санал авах өдөр болон уул өдөр хүртэлх гурван өдрийн хугацаанд гомдлыг хүлээн авсан бол нэн даруй хянан үзэж шийдвэрлэх, хэсгийн хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо салбар, эсхүл тойргийн хороонд гаргахаар журамлажээ.

Жишээлбэл: МУИХСТХ-д сонгуулийн талаарх захиргааны журам зөрчсөн этгээдэд торгууль ногдуулах эсэх тухайг шүүгч, хэрэв прокурор, шүүх, цагдаагийн ажилтан сонгуулийн хорооны гишүүдийн эрхэд хууль бусаар халдсан бол тэдгээр байгууллагын тухай хуульд зааснаар сахилгын хариуцлага хүлээлгэхээр заасан байна /МУИХСТХ-57.2; 14.9/. Ийнхүү тусгайлан зааснаас бусад сонгуулийн холбогдолтой захиргаааны зөрчлийн талаарх маргааныг сонгуулийн хороо харьяалан шийдвэрлэхийг дор дурдсанаар заажээ.

Тодорхой маргааныг аль хороо нь шийдвэрлэх /хэргийн/ харьяаллыг олохын тулд МУИХСХТ-ийн /Сонгуулийн байгууллага/ гэсэн бүлгийн 18 /хэсгийн хорооны бүрэн эрх/; 17 /салбар хороо, түүний бүрэн эрх/, 16 / тойргийн хороо, түүний бүрэн эрх/ дугаар зүйлийг харгалзан өргөдөл, гомдол, нэхэмжлэлээ гаргана.

Тодорхой зарим маргааны харьяаллыг жич тогтоосон байна.

МУИХСТХ-ийн 57 дугаар зүйлээс:

« 57.1 Энэ хуульд сонгуулийн хороод харьяалан шийдвэрлэхээр заасан зөрчил гарсан бол гомдлыг холбогдох сонгуулийн хороонд гаргана».

«Холбогдох байгууллага» гэдэгт ямар маргааныг аль байгууллага шийдвэрлэхээр хуульд заасныг ойлгоно.

Хэсгийнхээс бусад хороо нь өөрийн бүрэн эрхэд хамаарах маргааныг анх тутам шийдвэрлэхээс гадна дээд шатныхаа хорооны маргаан шийдвэрлэхэд гаргасан тогтоолыг эрх бүхий этгээдийн гомдлоор «давж заалдах» журмаар хянан шийдвэрлэнэ. Өөрөөр хэлбэл тойргийн ба Ерөнхий хороо сонгуулийн маргааныг **анхан** болон **давах** хоёр шатны журмаар шийдвэрлэх эрхтэй.

МУИХСТХ-ийн 16 дугаар зүйлд зааснаар тойргийн хороо:

16.2.9. харьяалах салбар болон хэсгийн хорооны шийдвэрийг давж заалдсан болон сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн маргаан бүхий өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх» эрхтэй.

МУИХСТХ-ийн 18 дугаар зүйлд хэсгийн хороо нь:

«18.3.8. сонгууль бэлтгэн явуулах асуудлаар гарсан өргөдөл, гомдлыг өөрийн эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэх, холбогдох байгууллагад уламжлах» гэж заажээ.

Маргаан шийдвэрлэх хуулийн хугацааны хувьд СЕХ "14 хоногийн дотор" гэсэн нэг хугацаа /МУИХСТХ-57.5/ бий. Харин нийт хороод ямар хугацаа баримтлах вэ гэдэг нь тодорхой бус байна. Орон нутгийн хороодоос сонгуулийн маргаан шийдвэрлэх хугацааг тухайлан заасан зүйл МУИХСТХ-д байхгүй тул мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 10 дахь хэсгийг баримтлах нь зүйтэй.

МУИХСТХ-ийн 19 дүгээр зүйлээс:

*«19.10. Хуульд өөрөөр заагаагүй бол хэсгийн болон салбар хорооны шийдвэрийн талаар тойргийн хороонд, тойргийн хорооны шийдвэрийн талаар Сонгуулийн ерөнхий хороонд тус тус гомдол гаргаж болох бөгөөд зохих шатны хороо гомдлыг хүлээж авснаас хойш ажлын **гурван** өдрийн дотор хянан шийдвэрлэж, гомдол гаргагчид бичгээр хариу мэдэгдэнэ».*

«Хуульд тусгайлан заасан» гэдэгт хойшлуулшгүй асуудлыг шийдвэрлэх жич хугацааг тогтоосныг ойлгоно. Жишээ нь:

МУИХСТХ-ийн 21 дүгээр зүйлээс:

«21.1.Сонгогчийг нэрийн жагсаалтад бүртгэхгүй буюу буруу бүртгэсэн байвал сонгогч, сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч тухайн хэсгийн хороонд гомдол гаргах эрхтэй.

*21.2.Хэсгийн хороо энэ хуулийн 21.1-д заасан гомдлыг хүлээн авснаас хойш ажлын гурван өдрийн дотор, хэрэв санал авах өдөр болон уул өдөр хүртэлх **гурван** өдрийн хугацаанд гомдлыг хүлээн авсан бол **нэн даруй** хянан үзэж, сонгогчдын нэрийн жагсаалтад зохих өөрчлөлтийг тэр даруй оруулах буюу гомдлыг хэрэгсэхгүй болгох шийдвэр гаргаж хариу мэдэгдэх бөгөөд уг шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо **хоёр** хоногийн дотор харьяалагдах салбар хороонд, салбар хороогүй бол тойргийн хороонд гаргана».*

2.2. Ерөнхий хороо шийдвэрлэх маргаан

Сонгуулийн ерөнхий хороо хянан шийдвэрлэх маргааныг МУИСТХ-ийн 57 дугаар зүйлийн 57.5 дахь хэсэгт тусгайлан заасан байна. Энд зааснаар СЕХ нам, эвслийг бүртгэхээс татгалзсан асуудлаар гарсан маргааныг 14 хоногийн дотор, тойрогт явуулсан сонгуулийг хүчингүйд тооцох асуудлаар гарсан маргааныг санал хураалт явуулсан өдрөөс хойш 14 хоногийн дотор, нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсан, тойргийн хороо нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах, санал хураалтыг хүчингүйд тооцсон асуудлаар гарсан маргааныг санал хураалт явуулсан өдрөөс хойш 14 хоногийн дотор тус тус эцэслэн шийдвэрлэхээр заасан.

МУИХСТХ-ийн 50 дугаар зүйлийн 50.7-д зааснаар санал хураалтын дүнгийн талаар маргаан гарвал тойргийн хороо санал хураалт явуулснаас хойш 14 хоногийн дотор эцэслэн шийдвэрлэх заалт Үндсэн хуулийн цэцийн шийдвэрээр хүчингүй болсон. МУИХСТХ-д СЕХ шийдвэрлэвэл зохих маргааныг ямар нэг шат дамжлагагүйгээр хүлээн авч **анх тутам** шийдвэрлэх, **давж заалдах шатанд** нь шийдвэрлэх маргаан гэж хоёр хэсэгт ялган тогтоожээ.

Өөрийнх нь шийдвэрийн талаар дор дурдсан гомдлыг **анх тутам** шийдвэрлэнэ.

- нам, эвслийг бүртгэхээс татгалзсан;
- тойрогт явуулсан сонгуулийг хүчингүй болгосон;
- нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсан.

Түүнээс гадна тойргийн хороодын дор дурдсан шийдвэрийн талаарх маргааныг **давж заалдах журмаар** шийдвэрлэнэ:

-нам, эвсэл, нэр дэвшигчээ, бие даагч нэр дэвшүүлснээ бүртгүүлэхэд бүрдүүлдэг баримт бичгийг хуурамчаар үйлдсэн тухай /30.17/;

-хууран мэхэлж нэр дэвшигчийг бүртгүүлсэн нь хожим илэрсэн тухай /38.18/;

-сонгогчийн санал худалдан авахад чиглэсэн аливаа үйл ажиллагаа явуулсан тухай /37.18/;

-нам, эвсэл, нэр дэвшигчийн дансанд төвлөрүүлсэн мөнгийг хурааж улсын орлого болгосон тухай /40.7/;

-хууль бусаар өгсөн, авсан хандивыг хурааж улсын орлого болгосон тухай /41.9/ шийдвэр.

Түүнчлэн сонгуулийн маргаан шийдвэрлэхэд тойргийн хорооноос гаргасан бусад тогтоолыг давж заалдаж болно.

МУИХСТХ-ийн 57.5-д СЕХ дээр дурдсан ёсоор /«...нам, эвслийг бүртгэхээс татгалзсан», «нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсан», «хассан» зэрэг маргааныг/ «**санал хураалт явуулсан өдрөөс хойш 14 хоногийн дотор шийдвэрлэнэ**» гэжээ. Үүнийг өргөдөл, гомдол **хүлээн авсан өдрөөс 14 хоногийн дотор шийдвэрлэнэ** гэж залруулах талаар судлаачид тэмдэглэн бичсэн нь бий[86].

Сонгуулийн холбогдолтой үндсэн хуулийн, захиргааны, иргэний маргаан, гэмт хэргийн асуудлыг шүүх хянан шийдвэрлэхдээ тэр тухайд баримталдаг **хянан шийдвэрлэх буюу байцаан шийтгэх хуулийг** хэрэглэнэ. Тэдгээр хуульд тус тусын хугацааг жич тогтоосон байдаг. Эдгээрээс үзвэл маргаантай асуудлаар өргөдөл, гомдол гаргахад хөөн хэлэлцэх, шийдвэрлэх хугацааг МУИХСТХ-д цаашид зөв тусган эрэмбэтэй тогтоох шаардлага байна.

МУИХСТХ-д сонгуулийн хороо «эцэслэн шийдвэрлэнэ» гэснийг Үндсэн хуулийн цэцийн шийдвэрээр* хүчингүй болгосон. Харин Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гарахаас өмнө хуулийн энэ заалтаас болж иргэний эрх зөрчигдөх тохиолдол гарч байсан. Жишээ нь: 2010 онд Р.Бурмаагийн тойргийн хороог, түүний гаргасан гомдлыг шийдвэрлэж хариу өгөөгүй байхад СЕХ татан буулгасан нь буруу учир СЕХ-ны шийдвэрийг хүчингүй болгуулах нэхэмжлэлийг Чингэлтэй дүүргийн шүүх болон Нийслэлийн шүүхээс "... тойргийн хороо Р.Бурмаагийн хүсэлтэд хариу өгөх үүрэгтэй байжээ. ... Сонгуулийн тойргийн хороо хариу өгсөн эсэхээс үл хамааран хуульд заасан үндэслэлээр түүний бүрэн эрх, үйл ажиллагааг дуусгавар болгож байгаа тул нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн бөгөөд нэхэмжлэгчийн гомдолд хариу өгөхийн тулд сонгуулийн тойргийн хороог дахин байгуулах үндэслэлгүй болно" гэж шийдсэн байдаг.

---

[86] Б.Чимид. Сонгуульд суралцахуй: тогтолцоо, үйл явц, эрх зүй. УБ, 2008, 277 дахь тал

*Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн №2 дүгнэлт

2.3. Шүүх хянан шийдвэрлэх маргаан, түүний харьяалал

Сонгуультай холбоотой маргааны шүүхийн харьяаллыг нарийвчлан тогтоосон хууль ба судалгааны бүтээл манай улсад хараахан байхгүй.

МУИХСТХ-д захиргааны торгууль тогтоосон 30-аад зүйл хэсэг, маргааны ерөнхий харьяалал тодорхойлсон ганц нэг зүйл байдаг. Мөн Эрүүгийн хуульд иргэдийн сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэргийн тухай хоёр /130, 131/ зүйл бий.

Доктор, профессор Б.Чимид сонгуулийн хууль зөрчсөн үйлдэл явдлыг:

- Үндсэн хууль зөрчсөн;
- захиргааны журам зөрчсөн;
- эд хөрөнгийн болон түүнтэй шууд холбоотой эдийн бус эрх зөрчсөн;
- гэмт хэрэг үйлдсэн;
- сахилга, ёс зүйн зөрчил гаргасан гэхчлэн бүлэглэн үзэж хуульчилна гэж үзжээ.[87]

Зөрчлийн буюу тухайн маргааны дотроос сонгох сонгогдох эрх, сонгуулийн тогтолцоо, оролцогчийн эрх зүйн байдлын тухай Үндсэн хууль, сонгуулийн үйл явцын үндсэн журмыг зөрчсөнийг **сонгуулийн маргаанд** хамааруулна. Энэ үйл явцад үүссэн нийтийн дэг журмын болон эд хөрөнгө, гэмт хэргийн шинжтэй зөрчлийг захиргааны, иргэний, эсхүл эрүүгийн шинжтэй болох учир «сонгуулийн холбогдолтой" бусад зөрчил гэж үзэж, ямар хууль баримталж шийдвэрлэхийг тогтоосон байна.

Шүүх хянан шийдвэрлэх сонгуулийн болон сонгуультай холбоотой маргааныг шийдвэрлэх /хэргийн болон/ шүүхийн харьяаллын үндсийг УИХСТХ-д дараах байдлаар тогтоожээ:

- Үндсэн хуулийн цэц /цаашид "Цэц" гэх/ шийдвэрлэх маргаан;
- Иргэний шүүхийн шийдвэрлэх маргаан;
- Эрүүгийн шүүхийн шийдвэрлэх маргаан гэж гурав хуваагдах болно.

Харин амьдрал дээр сонгуулийн явцад хамгийн их тохиолддог «нийтийн захиргааны журам» зөрчсөн маргааныг шийдэх үүрэгтэй захиргааны хэргийн шүүхийн /цаашид ЗХШ гэх/ тухайд МУИХСТХ-д ямар ч заалт орсонгүй. Энэ нь Үндсэн хуулийн цэцээс[88] СЕХ-ны аливаа шийдвэрийг Цэц хянах ёстой гэсэн дүгнэлт гаргаж, УИХ түүнийг хүлээн зөвшөөрч улмаар Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /цаашид ЗХХШТХ гэх/-иас «Сонгуулийн Ерөнхий хороо» гэсэн заалтыг хассантай холбоотой. Ингэснээр захирганы олон зүйл маргааныг ЗХШ-ийн харьяаллаас гаргасан байна. Үүнийг судлаачид ихээхэн шүүмжилдэг.

2.3.1. Цэцийн шийдвэрлэх маргаан

Монгол Улсын Үндсэн хуулийн жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын дагуу СЕХ-ны шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх асуудлаар гаргасан гомдлыг Цэц хянан шийдвэрлэхээр заасан.

Улсын Дээд шүүхийн 2008 оны 16 дугаар тогтоолоор дээр дурьдсан маргаан, гомдлыг хянан шийдвэрлэхтэй холбогдсон хуулийн зүйл, заалтуудыг тайлбарласан.

[87] Б.Чимид. Сонгуульд суралцахуй: тогтолцоо, үйл явц, эрх зүй. УБ., 2008, 279 дэх тал.
[88] Үндсэн хуулийн цэцийн 2005.3.31-ний өдрийн №02 дүгнэлт.

Сонгуулийн маргаан шийдвэрлэх тухайд Цэц нь сонгуулийн тогтолцоо, үндсэн зарчим, иргэдийн болон тэдгээрийн /нам, эвсэл зэрэг/ хамтлагийн сонгуулийн эрхийг зөрчсөн тухай **Үндсэн хуулийн чанартай маргааныг эцэслэн хянан шийдвэрлэнэ**. Сонгуулийн талаар Цэцийн шийдвэрлэх маргаан ямар ч байсан гагцхүү Үндсэн хууль зөрчсөн эсэхтэй шууд холбоотой байна.

Цэцийн хяналт, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа бол сонгуулийн тогтолцооны эрх зүйн үндсийг бэхжүүлэхэд голлох, шийдвэрлэх үүрэгтэй билээ.

Цэцээс СЕХ-той холбогдох маргааныг хянан шийдвэрлэнэ гэсэн өнгөц ойлголтоор ердийн шүүхүүд иргэний гаргасан нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож байгаа байдал ихээхэн байгаа нь 2008 оны УИХ-ын сонгуулийн дараа гарсан маргааныг шүүх хянан шийдвэрлэсэн байдлаас харагдаж байна. Жишээлбэл: Чингэлтэй дүүргийн шүүхээс 2008 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн 640 дүгээр шийдвэр гаргасан.

Шүүх ийнхүү шийдвэр гаргахдаа "Сонгуулийн тойрог, салбар, хэсгийн хороодын бүрэлдэхүүнд сонгуульд оролцогч аль нэг нам эвслийн төлөөлөл давамгайлахыг хуулиар хязгаарласан нь уг хороодын бүрэлдэхүүнд сонгуульд оролцогч аль нэг нам эвслийн төлөөллөөс зайлшгүй оролцуулна гэсэн үг биш юм. Нэхэмжлэгч нь сонгох, сонгогдох эрхтэй холбоотой эрх нь зөрчигдсөн гэж үзэж байгаа бол харьяаллын дагуу Цэцэд хандах эрх нь нээлттэй байна" гэж дүгнэсэн байна.

Ингэснээр ердийн шүүхүүд Цэцийн дүгнэлтийг баримтлан "иргэний сонгох, сонгогдох эрх"-тэй холбоотой асуудал гэсэн ерөнхий томъёоллоор Цэцэд ханд хэмээн иргэний нэхэмжлэл, гомдлыг хянан шийдвэрлэхгүй орхигдуулах боломжтой болжээ.

2.3.2. Иргэний шүүх хянан шийдвэрлэх маргаан

Сонгогчийн эрхийг шууд зөрчөөгүй боловч түүнтэй холбоотойгоор сонгуулийн хууль тогтоомж зөрчсөнөөс үүсэх ***иргэний маргааныг*** МУИХСТХ-д маш явцуу хүрээгээр хязгаарлан тогтоожээ. Уг хуулиас үзвэл сонгуулийн хороо зөвхөн дор дурдсан гурван зүйл нэхэмжлэлээр иргэний хэргийн шүүхэд хандах боломжтой. Үүнд:

- нам, эвсэл, нэр дэвшигч нь банкинд нээж мэдээлсэн хууль ёсны данснаас өөр данс нээж төвлөрүүлсэн хөрөнгийг;
- мөн этгээд хандивын хуульд зөвшөөрсөн дээд /1 ба 3 сая/ хэмжээнээс илүүгээр өгч авалцсан хийгээд хориглосон /өгч үл болох/ этгээдээс авсан хандивыг;
- санал хураалт дуусанаас хойш зардлын тайланг гаргаж Ерөнхий хороонд өгөх /1 сарын/ хугацаанд банкин дахь данснаас авч зарцуулсан мөнгийг тус тус хариуцагч нам, эвсэл, нэр дэвшигч, банкнаас гаргуулан авч улсын орлого болгох тухай нэхэмжлэл.

Эдгээр нэхэмжлэлийг Ерөнхий хороо холбогдох хяналт шалгалтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн сум, сум дундын болон дүүргийн шүүхэд нэхэмжлэнэ. Шүүх нь уг нэхэмжлэлээр маргааныг "**Иргэний хэрэг шүүхэд**

хянан шийдвэрлэх тухай хууль"-ийн дагуу хянаж зохих шийдвэр гаргана. Түүнийг мөн хууль ёсоор давж заалдаж болно.

Энэ журмаар шийдвэрлэх иргэний өөр маргааныг МУИХСТХ-д заагаагүй аж. Гэвч Иргэний эрх зүйн үүднээс сонгуулийн хуультай харьцуулж үзвэл эвслийн нэр, түүнчлэн нам, эвслийн болон нэр дэвшигчдийн нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр төрийг гутаасан тухай зэрэг эд хөрөнгөтэй холбоотой эд хөрөнгийн бус маргаан сонгуулийн өрсөлдөөний явцад гарахгүй гэх баталгаагүй билээ. Энэ мэт учрал нь гэмт хэргийн шинжтэй бус бол «хохирогч» нэхэмжлэл гаргаж, иргэний шүүхэд хянан шийдвэрлэж л таарна. Тэгэхлээр асуудлыг ганц хоёр зүйлээр хязгаарлалгүй иргэний маргааны хүрээнд авч үзэх нь зөв болой.

Иргэний шүүх нь шүүгчийн захиргааны журмаар хүлээлгэсэн торгох шийтгэлийг давж заалдах шатанд гомдсоныг хянан шийдвэрлэх өөр нэг үүрэгтэйг МУИХСТХ-д заасан байна.

МУИХСТХ-ийн 57 дугаар зүйлээс:

«57.2. Энэ хуульд заасан захиргааны шийтгэлийг сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн шүүгч ногдуулах ба түүнд давж заалдсан гомдлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу сум буюу сум дундын, дүүргийн шүүх хянан шийдвэрлэнэ».

Энэ асуудлаар УДШ-ийн иргэний хэргийн танхимын тэргүүн шүүгч Ц.Амарсайхан: "Захиргааны хэргийн дагнасан шүүхийн харьяалалд хамаарахгүй болсон маргааныг эргээд ерөнхий харьяаллын шүүхүүд хянан шийдвэрлэх үндэслэлтэй гэж үзэхээр боловч Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дээрх заалтыг хүчингүй болсонд тооцсон үндэслэл нь Цэцийн 2005 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 2/02 дугаар дүгнэлтэд маш тодорхой тусгагдсан тул эрх зүйн энэ төрлийн маргааныг ерөнхий харьяаллын шүүхүүд мөн хянан шийдвэрлэх боломжгүй болсон.

Цэцийн 2005 оны 3 дугаар сарын 31-ний едрийн 2/02 дугаар дүгнэлтэд: "Сонгуулийн ерөнхий хороо хуульд зааснаар ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийг улсын хэмжээнд зохион байгуулах үндсэн чиг үүрэгтэй байгууллага бөгөөд Үндсэн хуульд заасан иргэдийн сонгох, сонгогдох эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар шийдвэр гаргадаг байна. Дэлхийн ардчилсан улсуудын Үндсэн хуулийн заалтаас үзэхэд энэ төрлийн маргааныг Үндсэн хуулийн шүүхтэй улсад Үндсэн хуулийн шүүх, Үндсэн хуулийн шүүхгүй улсад Дээд шүүх нь хянан шийдвэрлэдэг жишиг тогтсон байна. Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2-т Сонгуулийн төв байгууллагын шийдвэр Үндсэн хууль зөрчсөн бол Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэхээр заажээ. Гэтэл СЕХ-ны шийдвэр хуульд нийцэхгүй тохиолдолд Захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэж байхаар Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар хуульчилсан нь Үндсэн хуулиар Үндсэн хуулийн цэцэд тусгайлан олгосон эрх хэмжээнд халдсан байна" гэж зааж, "Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1.6,-д "... Сонгуулийн ерөнхий хороо" гэж заасан нь Үндсэн

хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2-ын ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар Үндсэн хуулийн цэц дүгнэлт гаргах тухай заалтыг ... зөрчсөн байна" гэж дүгнэжээ.

ЗХХШТХ-ийн дээрх заалтыг хүчингүйд тооцох болсон үндэслэл дагнасан шүүхийн хянан шийдвэрлэх маргаан, түүний онцлогтой холбоотой биш харин Үндсэн хуулийн цэцийн харьяаллын асуудлыг шүүхэд харьяалуулснаас үүдэлтэй тул ерөнхий харьяаллын шүүхүүд ч мөн энэ харьяаллыг зөрчих, улмаар Үндсэн хууль зөрчих үндэслэлгүй болно.

Цэц Улсын Их Хурлын сонгуультай холбоотой буюу иргэдийн сонгох, сонгогдох Үндсэн хуулиар олгогдсон эрхтэй холбоотой, Сонгуулийн Ерөнхий хорооны шийдвэрийн талаарх маргаан Үндсэн хуулийн цэцийн харьяалалд хамаарна гэж 2005 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 2/02 дугаар дүгнэлтээр тухайн төрлийн маргааны хэргийн харьяаллыг тодорхой тогтоосон бөгөөд үүнд тодорхой бус, эргэлзээх асуудал байхгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуульд заасан Үндсэн хуулийн цэцийн бүрэн эрх, Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасан шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх журам, Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 2/02 дугаар дүгнэлт, иргэний болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх журмыг тодорхойлсон хуулиудыг Монгол Улсын шүүх зөрчөөгүй тул сонгуультай холбогдолтой маргааныг шүүх шийдвэрлэхгүй байна гэх шүүмжлэлийг үндэслэлгүй гэж үзэж байна.[89]

Сонгуультай холбогдолтой захиргааны зөрчлийн асуудлыг, мөн үйл ажиллагааны талаарх гомдлыг хянан шийдвэрлэх эзэн, журмыг тодорхой, хууль зүйн үндэслэлтэй болгоогүй тохиолдолд түрүүчийн сонгуулийн үеийн байдал хэвээр үлдэнэ гэдэгт эргэлзэхгүй байна"[90] гэжээ.

Иймд цаашид сонгуулийн эрх нь зөрчигдсөн хэн боловч шүүхэд хандаж асуудлаа шийдүүлэх боломжийг олгох нь зүйтэй байна.

2.3.3. Эрүүгийн шүүх хянан шийдвэрлэх хэрэг

Иргэдийн сонгуулийн эрх хийгээд сонгуулийн хуулиар тогтоосон бусад журмыг эрүүгийн эрх зүйгээр хамгаална. УИХСТХ-ийн 57.3-т **энэ хуулийн холбогдох заалтыг зөрчсөн этгээдэд эрүүгийн хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй байвал асуудлыг Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан журам, харьяаллын дагуу шийдвэрлэнэ** гэжээ.

Монгол Улсын Эрүүгийн хууль **сонгуулийн эрхийн эсрэг** дараах хоёр зүйлийн **гэмт хэргийн шинжийг** тодорхойлсон.

- «Иргэн сонгуулийн эрхээ эдлэхэд болон сонгуулийн хорооны ажилд саад хийх»;
- «Сонгуулийн болон бүх нийтийн санал хураалтын баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санал хураалтын дүнг буруу гаргах» ийм хоёр зүйл хэргийн ердийн болон хүндрүүлэх бүрэлдэхүүнийг тодорхойлсон байна.

---

[89] Улсын дээд шүүхийн иргэний хэргийн танхимын тэргүүн Ц.Амарсайхан "Сонгуулийн эрх зүйн хариуцлага" зөвлөлдөх уулзалтын үеэр тавьсан илтгэлээс

[90] Мөн тэнд

«130.1. Иргэний сонгох, сонгогдох, бүх нийтийн санал асуулгад оролцох эрхээ хэрэгжүүлэхэд болон сонгуулийн хорооноос хуулийн дагуу явуулж байгаа аливаа ажиллагаанд санаатай саад хийсэн бол» ердийн бүрэлдэхүүнтэй.

130.2. Энэ хэргийг хуч хэрэглэж буюу хуч хэрэглэхээр заналхийлэх, хуурч мэхлэх, эд мөнгөөр татах, санал худалдаж авах зэрэг аргаар үйлдсэн бол» хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг болно.

Энэ бол нийтлэг субъекттэй гэмт хэрэг. Өөрөөр хэлбэл иргэн, албан тушаалтны алин ч уг хэргийн /хариуцагч/ субъект байж болно.

Харин Эрүүгийн хуулийн 131-д заасан дээр дурдсан 2 дахь хэргийн субъект нь зөвхөн сонгуулийн болон бусад байгууллагын албан тушаалтан байна.

«131.1. Сонгуулийн болон бүх нийтийн санал асуулгыг зохион байгуулах хорооны дарга, гишүүн, бусад албан тушаалтан сонгуулийн баримт бичгийг хуурамчаар үйлдсэн, Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50.3-т заасныг ноцтой зөрчиж санал хураалтын дүнг зориуд буруу гаргасан, 57.4-т заасныг ноцтой зөрчиж буруу шийдвэрлэсэн, мөн сонгогчоос санал нууцаар гаргах, саналаа чөлөөтэй илэрхийлэх эрхийг зөрчсөн, түүнчлэн сонгуулийн дүнд хууль бусаар нөлөөлсөн бол» албан тушаалтны үйлдсэн сонгуулийн эрхийн эсрэг гэмт хэрэг болно.

2.3.4. Захиргааны хэргийн шүүх шийдвэрлэх маргаан

2004 онд ЗХХШТХ анх батлахдаа СЕХ нь захиргааны хэргийн шүүхэд хариуцагч болохоор хуульчилсан байсан.

Энэ нь сонгуулийн хууль тогтоомжтой холбогдуулан захиргааны байгууллага, албан тушаалтан түүний дотор Сонгуулийн хороодоос гаргасан бичмэл ба бичмэл бус шийдвэрт, түүнчлэн тойргийн болон ерөнхий хорооноос давж заалдах журмаар хянаад гаргасан шийдвэрийн дотор "**захиргааны акт**" гэж үзэж байсантай холбоотой.

ЗХШ энэ мэт маргаан /захиргааны акт/-ыг хянаад:

- Илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрөх;
- Хууль бус бол хүчингүй болгох;
- Хууль ёсоор хийх ёстой зүйлээ хийгээгүй бол үүргээ биелүүлэхийг захиргаанд даалгасан шийдвэр гаргаж гүйцэтгүүлэх үүрэгтэй.

Харин 2005 онд дээр дурдсанчлан Цэцийн дүгнэлт гарч улмаар УИХ-аас ЗХХШТХ-ийн СЕХ гэснийг хассан хууль батлан гаргасан.[91]

Үүнтэй холбоотойгоор одоо дагаж мөрдөж буй МУИХСТХ-д захиргааны хэргийн шүүхэд харьяалагдах хэргийн талаар дурдаагүй.

Доктор, профессор Б.Чимид: "Захиргааны шинжтэй хэрэг маргааныг, шийдвэрлэх тухай, түүнийг эрхэлсэн шүүх байдаг тухай юу ч заагаагүй нэг хийдэл гарчээ. Сонгуулийн маргааны дотор "Захиргааны хэрэг" болох зөрчил, зөрчилдөөн олон бий. ИБМА нэрийн жагсаалтад буруу бичих,

[91] 2005 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулиар хүчингүйд тооцсон.

орхигдуулах, хэсгийн хороо сонгогчийн үнэмлэх өгөхгүй байх, сум, дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчид нам, эвсэл, нэр дэвшигчдэд ухуулах хуудас, зар мэдээ тавих /наах/ газар тогтоож өгөхгүй хугацаа алдуулах, үүрэг бүхий байгууллага уулзалтын байр танхимаа цагт нь чөлөөлж өгөхгүй байх, СЕХ радио телевизээр төлбөргүй нэвтрүүлгийн хуваарийг тэгш бусаар тогтоох, төрийн болон нутгийн удирдах байгууллага нам, эвслийн сонгуулийн сурталчилгаа явуулах, эсхүл түүнд төрийн жинхэнэ албан хаагчийг татан оролцуулах, төрийн өмчийн зүйлс, хэрэгслийг нам, эвслийн сурталчилгаанд дам ашиглах, шилжүүлэг хийж өгөхгүй гацаах, хэсэг тойргийн хороо нэрийн жагсаалтыг цаг тухайд нийтэд тавьж танилцуулахгүй, санал хураалтын бэлтгэл хийхгүй /үүргээ биелүүлэхгүй/ байх гэх мэт захиргааны эрх бүхий албан тушаалтны санаатай үйлдэл, эс үйлдэхүй тохиолддог. Цэцэрлэг СЕХ-г захиргааны шүүхийн хяналтаас хасахаас өмнөх хэсэгхэн хугацаанд ЗХШ сонгуулийн хууль зөрчсөн захиргааны шинжтэй зөрчил бүхий цөөнгүй маргаан хүлээн авч шийдэж байсныг судлан авч үзэв. 2004 оны УИХ-ын болон орон нутгийн ИТХ-ын сонгуулиар Дарханы ЗХШ 25 нэхэмжлэл хүлээн авч 11-ийг; Хөвсгөлийн ЗХШ 31 нэхэмжлэл хүлээн авч 9-ийг шийдвэрлээд байсан зэргээс үзэхэд "сонгуулийн тойрог хэсгийн хороо гомдол шийдвэрлэж өгөөгүй", "нэрийн жагсаалт хууль бусаар бүрдүүлсэн", "жагсаалтаас санаатай орхигдуулсан", "саналын хуудас үрэгдүүлсэн", "хууль зөрчиж сурталчилгаа явуулсан", "цуглуулсан гарын үсэг хууль бусаар хүчингүй болгосон", "ажиглагч оролцуулаагүй" гэх мэт Цэцэд хүрэхээргүй журам зөрчсөн нэлээд маргаан аймаг бүрт л олон цөөнөөр үзэгджээ"[92] гэсэн байдаг.

Ер нь зарчмын хувьд СЕХ-ны үйл ажиллагаа, шийдвэр Үндсэн хууль зөрчсөн бол Цэцэд харьяалуулан шийдвэрлэх, Үндсэн хуулиас бусад хууль зөрчсөн "захиргааны акт" болох үйл ажиллагаа, шийдвэрийг Захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэдэг байх нь зөв гэж үзэж байна.

Гурав. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ БОЛОН ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ЗААСАН ХАРИУЦЛАГА НОГДУУЛАХ ТУХАЙ ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТ

Сонгуулийн хууль зөрчсөний хариуцлага

"Хууль зөрчсөн гэм буруу буюу эрх зүйн зөрчил гаргасан" байх нь хууль зүйн хариуцлага хүлээлгэх үндэс нь болдог билээ.

Сонгуулийн хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг дараах байдлаар ангилж болно. Үүнд:

1. Сахилгын хариуцлага;
2. Эд материалын буюу иргэний эрх зүйн хариуцлага;
3. Захиргааны хариуцлага;
4. Эрүүгийн хариуцлага;

Эдгээрийг дэлгэрүүлэн авч үзвэл:

1. Сахилгын шийтгэлийг сонгуулийн эрх зүйн харилцааны хүрээнд зөвхөн "**албан ажлын эндэгдэл**" гэх зөрчил гаргасан сонгуулийн хорооны болон бусад зарим ажилтан, албан тушаалтанд сахилгын талаарх хууль, ёс

[92] Б.Чимид. Сонгуульд суралцахуй: тогтолцоо, үйл явц, эрх зүй. УБ., 2008, 286-290 дэх тал.

зүйн дүрэмд зааснаар захиргааны зүгээс хүлээлгэнэ. УИХСТХ-д сонгууль бэлтгэн явуулах албан ажлын эндэл гаргасан сонгуулийн хорооны гишүүн, шүүх, прокурор, цагдаагийн байгууллагын ажилтанд ийм хариуцлага хүлээлгэх дараах тохиолдол буюу зөрчлийг тодорхойлжээ.

Сонгогчдын эрхийн эсрэг болон сонгуулийн байгууллагын ажилтны хараат бус ажиллах зарчмын эсрэг хууль бус аливаа үйлдлийг зохион байгуулах, өөгшүүлэх, бусад хэлбэрээр дэмжихийг хориглосон заалтыг зөрчих шилжигчдийн санал авах, сонгогчийн үнэмлэх олгох, нэр дэвшигчийг бүртгэх, саналын хуудас хүлээн авах журмыг зөрчсөн; хүчин төгөлдөр бус хуудсаар санал авсан зэрэг 10 гаруй зөрчлийн аль нэгийг гаргасан нь гэмт хэргийн шинжгүй бол сонгуулийн хорооны бүрэлдэхүүнээс хасахыг УИХСТХ-д заажээ /МУИХСТХ-ийн 14.3.7; 22.3; 22.4; 22.5; 23.1; 23.5; 28.1; 30.10.1-30.10.3; 30.10.6-30.10.7; 44.9; 44.10/. Тэдгээр зөрчлийн нэг нь гэхэд л хэд хэдэн үйлдэлтэй учир тус тусад нь тодорхойлж шийдвэрлэх шаардлагатай юм. 14.3.7-д заасан зөрчлийн байж болох үйлдлийг доор жишээ болгон жагсаая.

–аль нэгэн нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар сурталчилгаа явуулах;

–энэ зорилгоор сонгогчоос сонгуулийн эрхээ хэрэгжүүлэх, санал хураах, тоолох ажилд санаатайгаар саад хийх;

–бусдыг төлөөлж санал өгөх;

–саналын хайрцгийн лац, битүүмжлэлийг гэмтээх;

–гарын үсэг хуурамчаар үйлдэх;

–саналын хуудас солих;

–хүчингүй саналын хуудсаар санал авах.

• Шүүх, прокурор, цагдаагийн байгууллагын ажилтан УИХСТХ-ийн 14 дүгээр зүйл буюу дор дурдсан заалт зөрчсөн бол "Шүүхийн тухай", "Прокурорын байгууллагын тухай", "Цагдаагийн байгууллагын тухай" хуульд зааснаар сахилгын хариуцлага хүлээнэ.

МУИХСТХ-ийн хуулийн 14 дүгээр зүйлээс:

«14.6.Сонгууль зохион байгуулж явуулах хугацаанд тойрог, салбар, хэсгийн хороодын гишүүнийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилснаас бусад тохиолдолд дээд шатны сонгуулийн хорооны зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хариуцлагад татах, баривчлах, албадан саатуулах буюу цагдан хорих, өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр ажилд шилжүүлэх, захиргааны санаачилгаар ажлаас халахыг хориглоно»

Сахилгын шийтгэл нь хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлд зааснаар:

• сануулах;

• цалин бууруулах;

• ажлаас халах зэргийн хэлбэртэй байдаг бөгөөд түүнийг зөрчлийн шинж байлдлыг харгалзан ажлын газрын захиргаанаас хөдөлмөрийн дотоод журамд зааснаар ногдуулна.

Харин сахилгын тусгай дүрэмтэй газар байгууллагад бол асуудлыг тэр дүрмийн дагуу шийдвэрлэнэ.

Сахилгын шийтгэл нь зан суртахууны зэмлэлийн шинжтэй бөгөөд зарим талаар намын гэх мэт улс төрийн, ёс зүйн хариуцлагын арга хэмжээтэй төстэй байдаг. Сонгуулийн хууль зөрчсөн нэр дэвшигчийг жагсаалтаас хасах, сонгуулийн хорооны бүрэлдэхүүнээс хасах явдал ч энэ төрлийн шийтгэлд хамаарна /МУИХСТХ-30.17; 30.18/.

2.Эдийн буюу иргэний эрх зүйн хариуцлага. Энэ нь улс, хувь хүн, хуулийн этгээд хууль бус ажиллагаагаараа бусдад учруулсан хохирол, гэм хорыг нөхөн төлөхөд шууд чиглэсэн онцлогтой юм. Сонгуулийн харилцааны тухайд зардлын мөнгийг хууль бусаар зарцуулснаас үүссэн гурван зүйл хариуцлага МУИХСТХ-д заасан нь бий /40.7; 41.9; 42.8/.

МУИХСТХ-д заасан дээрх гурван зүйл эдийн хариуцлагаас гадна сонгуулийн үйл явцад бусдын нэр төрийг гутаан доромжилсон, гүтгэсэн сонгуулийн хорооноос байгуулсан гэрээний үүрэг зөрчсөн зэргээс үүссэн эдийн хариуцлага бусад маргаан байж болно. Тухайлбал, МУИХСТХ-ийн 56.1-д "Сонгуулийн хууль тогтоомж зөрчсөний улмаас бусдад эд хөрөнгийн болон бусад хохирол учирсан бол гэм буруутай этгээдэд Иргэний хууль болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ" гэж заасан.

Эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах тохиолдол практикт гарсан байна. Жишээлбэл, *2008 оны УИХ-ын сонгуульд нэр дэвшигч С.Эрдэнэ Чингэлтэй дүүргийн шүүхэд 2008.8.28-аас 2009.10.9-нийг хүртлэх цалин 10.306.000 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэл гаргасан боловч шүүх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан байна.* Иймд энэ төрлийн маргааныг шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтыг сайжруулах хэрэгтэй байна.

3. Захиргааны хариуцлага. Иргэний сонгуулийн эрхийг хамгаалах, сонгууль бэлтгэн явуулах хэвийн нөхцөлийг хангахын тулд хуулиар тогтоосон засаг захиргааны журам олон янз бөгөөд өргөн хүрээтэй билээ. Тэдгээр журмыг гэмт хэргийн зэрэгт хүргэхгүйгээр зөрчих нь бас цөөнгүй тохиолдоно.

Сонгуулийн талаар харьяалал, "дээр, доор" мэтийг харгалзахгүйгээр бүх нийтээс дагаж баримтлахаар тогтоосон засаг захиргааны журмыг зөрчсөн нь гэмт хэргийн бүрдэлгүй бол **захиргааны зөрчил** гэдэг. Энгийн жишээ хэлэхэд "зөвшөөрөлгүй газар ухуулах хуудас наасан", "шөнийн цагаар чанга яригч ажиллуулсан" тогтоосон хэмжээнээс илүү хэмжээгээр сонин, товхимол хэвлүүлж тараасан, төрийн жинхэнэ албан хаагч нам, эвслийн ухуулга хийсэн гэвэ "жижиг" мэт боловч нийгэмд хортой хэрэг зөрчил хаалга үүднээс чинь авахуулаад хараддаг. Хуулиар хориглосон зүйл хийж байгаа учир эрх зүйн зөрчил болдог. Гэмт хэрэгт арай "хүрээгүй" учир "захиргааны зөрчил" гэдэг. Захиргааны хариуцлагыг захиргааны /улсын/ хяналт тавих эрх бүхий байгууллага, хянагч, байцаагч зэрэг албан тушаалтнаас иргэн, албан тушаалтанд тэдний харьяаллыг харгалзахгүйгээр /хөндлөнгөөс/

ногдуулдагаар сахилгынхаас ялгаатай. Уул хариуцлагын арга хэмжээ хэдэн янз болов**ч** сонгуулийн журам зөрчсөн гэх **захиргааны зөрчлийн** тухайд **МУИХСТХ-д** дан ганц **торгох шийтгэл** тогтоож, түүнийг гагцхүү сумын буюу сум дундын, мөн дүүргийн **шүүгч ногдуулахаар заасан** гоц онцлог бий. [93]

МУИХСТХ-д захиргааны торгууль хүлээлгэх үндэслэл болсон зөрчил, эзэн олон, торгуулийн хэмжээ өөр, өөр байх тул бүгдийг тайлбарлах боломжгүй. Иймд зөрчлийн тоог хариуцлага хүлээх эзнээр нь бүлэглэж дор хүснэгтлэв[94].

д/д	Зөрчил гаргагчдын төрөл	Торгууль ногдуулах зөрчлийн тоо	Торгуулийн хэмжээ /төгрөгөөр/	
			доод	дээд
1.	Иргэн	8	100.000	150.000
2.	Албан тушаалтан	10	150.000	250.000
3.	Сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүн	10	150.000	250.000
4.	Засаг дарга	3	150.000	250.000
5.	Хувийн өмчит хуулийн этгээд	7	500.000	800.000
6.	Төрийн өмчит болон түүний оролцоот хуулийн этгээд	1	500.000	700.000
7.	Нам, эвсэл	7	700.000	1.000.000
8.	Нам, эвслээс нэр дэвшигч	6	100.000	200.000
9.	Бие даан нэр дэвшигч	3	100.000	250.000
10.	Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, бие даан нэр дэвшигчийн туслагч	11	100.000	250.000
11.	Нам, эвслийн ажиглагч	1	100.000	150.000
12.	Аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх ИБМА-ны дарга	1	150.000	250.000
13.	Хэвлэл мэдээллийн байгууллага	3	600.000	800.000
14.	Банкны захирал	1	200.000	250.000
15.	Банк	1	800.000	1.000.000
Нийт	**Торгуулах субьект 15**	**Торгох зөрчлийн тоо 25**		

Захиргааны зөрчлийг шүүхээр шийдвэрлэсэн байдал

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасан захиргааны зөрчил гаргасан иргэн, хуулийн этгээд, нэр дэвшигч, нам, эвсэлд захиргааны хариуцлага тооцуулахаар шүүхэд хүсэлт гаргахдаа сонгуулийн хороод дараах дутагдал гаргаж байна[95]:

Сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн тухай мэдээлэл, гомдлыг хүлээн авч, холбогдох шалгалтыг бүрэн хийхгүй, энэ талаарх нотлох баримтыг ирүүлэхгүйгээр зөвхөн мэдээлэл, гомдлыг албан бичгээр шүүхэд ирүүлж байна.

[93] Б.Чимид. Сонгуульд суралцахуй: тогтолцоо, үйл явц, эрх зүй. УБ, 2008, 255-261 дэх тал.
[94] Мөн тэнд.
[95] Улсын дээд шүүхийн иргэний хэргийн танхимын тэргүүн Ц.Амарсайхан "сонгуулийн эрх зүйн хариуцлага зөвлөлдөх уулзалтын үеэр тавьсан илтгэлээс.

Захиргааны хариуцлагын тухай хуульд зааснаар зөрчлийг хянан шалгах байгууллагын хувьд хороод нь зөрчлийн талаарх тэмдэглэл үйлдэж, холбогдох иргэд, байгууллагаас тайлбар, тодорхойлолт авах, зөрчил гаргагчид мэдэгдэх, түүний тайлбарыг авах зэрэг ажиллагаа явуулах ёстой боловч энэ шаардлагыг хангах наад захын материалыг шүүхэд гаргаж өгөхгүй байна.

Нотлох баримтыг бүрдүүлэхэд шаардлагатай бол Цагдаагийн байгууллагын туслалцаа авах боломжийг хороод огт ашиглахгүй байна.

Тухайн зөрчил хэзээ, хаана гарсан, хэрхэн илэрсэн болох нь ч тодорхойгүй материал ирүүлж байна.

Сонгуулийн хууль зөрчсөн хэний ч үйлдэл, эс үйлдэхүй нь захиргааны зөрчил мөн тул түүнд хариуцлага ногдуулах эсэхийг шүүх зөвхөн нотлох баримтад үндэслэж шийдвэрлэнэ. Сонгуулийн хууль зөрчсөн асуудлыг захиргааны бусад зөрчлөөс өөрөөр авч үзэх, хууль бус, үндэслэлгүй шийдвэр гаргах эрх шүүхэд байхгүй.[96]

Захиргааны зөрчилд ногдуулж буй хариуцлагыг иргэн, эсхүл хуулийн этгээд хүлээдэг учир хариуцлага хүлээлгэх гэж буй этгээд өөрөө тодорхой байж, түүнд энэ талаар мэдэгдсэн, түүний тайлбар, хүсэлтийг авсан байх учиртай.

Гэтэл тойргийн хороодоос ирүүлж буй хүсэлтийн ихэнхэд хариуцлага хүлээх этгээдийг огт нэрлээгүй, хэн гэдэг иргэн, аль нэр дэвшигчийн ухуулагч, эсхүл шадар туслагч, эсхүл намын ажилтан тухайн зөрчлийг гаргасан нь тодорхой бус хүсэлтийг шүүхэд ирүүлж байна.

Тухайн үйлдэл, эс үйлдэхүйг захиргааны зөрчил гэж үзэхийн тулд энэ талаар хуульд заасан байх учиртай юм. Өөрөөр хэлбэл зөвхөн хуульд заасан тохиолдолд аливаа үйлдлийг зөрчил гэж үзнэ[97].

Гэтэл зарим хороодоос шүүхэд ирүүлсэн хүсэлтэд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн ямар зүйл, заалтыг тухайн этгээд өөрийн үйлдлээр зөрчсөн гэж хороо үзсэн талаар огт заагаагүй байна.

Шүүх нь захиргааны зөрчил гаргагчид хариуцлага ногдуулах эрх, үүрэг бүхий этгээд учир зөрчлийн талаар хянан шалгах ажиллагаа явуулах эрхгүй юм. Шүүх хөндлөнгийн байр суурьа хадгалж, зөвхөн хуульд захирагдан зөрчил гаргасан этгээдэд хариуцлага ногдуулж, зөрчил гаргаагүй, эсхүл зөрчил гаргасан болох нь нотлогдоогүй этгээдийг хариуцлагаас чөлөөлөх тухай хоёр шийдвэрийн аль нэгийг гаргах ёстой.

Гэтэл одоогийн байдлаар шүүхүүд дээрх огт нотлогдоогүй зөрчлийн тухай хүсэлт, тодорхой бус материалыг тойргийн хороонд буцаах, тайлбарлах, зөвлөх зэргээр, зөрчил гаргасан этгээдийг хариуцлагаас чөлөөлөхөөс болгоомжилж, өөрт ногдоогүй үүргийг хүлээж, хуульд заагдаагүй ажиллагаа явуулж байна.

Захиргааны хариуцлагын тухай хуульд заасан зөрчилд хариуцлага ногдуулах, эсхүл хариуцлагаас чөлөөлөх шийдвэрийг шүүх хянан шалгалтын ажиллагаа бүрэн хийгдсэн тохиолдолд гаргах боломжтой байтал зөрчил гарсан үйл баримт бүрэн нотлогдоогүй нь тухайн хороодын мэдлэг, туршлага,

[96] Мөн тэнд

[97] Мөн тэнд

чадвартай холбоотой тул тухайн хүсэлтэд ямар материал хавсаргаж ирүүлэх талаар тойргийн хороонд мэдэгдэх, түргэн шуурхай арга хэмжээ авагдах боломжгүй бол шүүгчийн захирамжаар хороонд буцаах зэргээр Захиргааны хариуцлагын тухай хуульд заагдаагүй хэдий ч дутуу материалыг хүсэлт гаргагчид буцааж, зөрчил гаргасан этгээдийг хариуцлагаас чөлөөлхөөс хор уршиг багатай гэж үзэж, энэ ажиллагааг явуулж ирлээ.

Сонгуулийн тухай хуульд захиргааны зөрчил гэж заагдаагүй, эсхүл өөр хууль тогтоомж зөрчсөн хууль бус үйлдэл, ажиллагааны талаар иргэд, байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээллийг зарим хороо "арга хэмжээ авхуулахаар" гэж тоймлон шүүхэд шилжүүлж байна.[98]

Гомдол, мэдээлэлд заасан зөрчил нь Сонгуулийн хуулийн зохицуулалтад хамааралгүй бол хороо энэ талаар гомдол гаргагчид хариу өгч, ямар байгууллагад хандахыг зааж өгөх ёстой. Хорооны энэ шийдвэрт хуульд заасан журмын дагуу гомдол гаргах эсэхийг тухайн этгээд өөрөө шийднэ.

Хууль зөрчсөн шийдвэр, ажиллагааны талаар шүүхэд гомдол гаргах нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулагддаг тул сонгуулийн хорооноос шилжүүлсэн гомдол, мэдээллээр шүүх иргэний хэрэг үүсгэх боломжгүй юм. Иргэний хэрэг үүсгэх үндэслэл, нэхэмжлэл, гомдол гаргах эрхтэй этгээд, бусдыг төлөөлөх эрх зэрэг асуудлыг зохицуулсан хуулийн зүйл, заалт сонгуультай холбогдолтой маргаанд хамаарахгүй байх үндэслэлгүй юм.

Шүүх бол сонгуулийг хуулийн дагуу явуулах үүрэг бүхий этгээд биш харин сонгуулийн ажиллагаанд гарсан зөрчил, маргааныг хуулийн дагуу хянан шийдвэрлэх үүрэгтэй тул аливаа зөрчил, маргаан, үйл баримтын талаар шүүхэд хандахдаа хуульд заасан шаардлагыг хангах учиртайг хэсэг, тойргийн хороодод анхааруулахаас гадна сонгуулийн холбогдолтой маргааныг хянан шалгах, хянан шийдвэрлэх хоёр байгууллагын үйл ажиллагааг зааглан салгаж, хянан шалгах ажиллагааг ямар байгууллага, хэрхэн явуулахыг тодорхой болгох шаардлагатай гэж үзэж байна.

Сонгуулийн холбогдолтой зөрчилд хариуцлага тооцоогүй байдал сонгуулийн өөрийнх нь ач холбогдол, үр дүнг бууруулахаас гадна сонгууль болсноос хойш эрх зүйн өөр маргааны эх үүсвэр үндэслэл болж болзошгүй юм.

Сонгуультай холбоотой захиргааны зөрчилд хариуцлага хүлээлгэх хэм хэмжээ хуульд нэлээд байгаа боловч дээр дурдсан эдгээр нөхцөл байдлын улмаас түүнийг шүүхээр шийдвэрлэж бодитой хариуцлага тооцох боломжгүй болгож байна. Энэ нь шүүхээс сонгуультай холбоотой тухайн захиргааны зөрчилд хариуцлага ногдуулахгүй байгааг харуулж байна.

4. Эрүүгийн хариуцлага гэж гэмт хэрэг үйлдсэн этгээдэд гэм буруугийнх нь учир эрүүгийн хэргийн шүүхээс ногдуулдаг ялыг хэлдэг. Эрүүгийн хуулиар сонгуулийн эрхийг хамгаалахын тулд хоёр зүйлийн гэмт хэргийн шинж бүрдэл, хариуцлагыг заасан байдаг. Үүнд:

1.Иргэн албан тушаалтан **«сонгуулийн эрхээ эдлэхэд болон сонгуулийн хорооны ажилд саад хийх»** гэмт хэрэг үйлдвэл «хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний

[98] Улсын Дээд шүүхийн иргэний хэргийн танхимын тэргүүн Ц.Амарсайхан "Сонгуулийн эрх зүйн хариуцлага зөвлөлдөх уулзалтын үеэр тавьсан илтгэлээс.

төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ».

Энэ гэмт хэргийг **хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр үйлдсэн** бол «хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 71-100 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 3-аас дээш 6 сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ».

2.Сонгуулийн хорооны болон бусад албан тушаалтан «сонгуулийн ... баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санал хураалтын дүнг буруу гаргах»[99] гэмт хэрэг үйлдсэн бол «хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ».

Дээрх заалтаас үзвэл энэ хоёр зүйл гэмт хэрэг үйлдсэн хүнд торгох, баривчлах хоёр төрлийн ялын аль нэгийг оноох бөгөөд тэр нь хэдийгээр захиргааны шийтгэлтэй төстэй боловч эрүүгийн ял болохын хувьд огт өөр үр дагавартай.

Улсын хэмжээнд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 130, 131 дүгээр зүйлээр 2005-2010 онд /2006, 2007 онд бүртгэгдээгүй/ бүртгэгдсэн 9 хэрэг, сонгуультай холбоотойгоор иргэдээс 2010 онд гаргасан 2 өргөдөл, гомдол гаргасан байна.[100] Эдгээрээс Орон нутгийн сонгуулийн үеэр гарсан хэрэг, зөрчил 2005 онд 3 бүртгэгдсэн байна. Харин 2008 онд 1 удаа бүртгэгдсэн. Харин УИХ-ын сонгуулийн холбоотойгоор 2008 онд 4 эрүүгийн хэрэг бүртгэгдэж тухайн шатны прокурорт яллах дүгнэлт үйлдүүлэхээр хүргүүлжээ.[101]

Харин 2008 оны сонгуулийн үеэр нийслэлд сонгуулийн сурталчилгаанд ажиллаж буй иргэдтэй холбоотой болон сонгуулийн байранд халдсан, нэр дэвшигчдийн сурталчилгааны самбарыг гэмтээсэн зэрэг 34 гэмт хэрэг, зөрчлийн дуудлага мэдээлэл ирснийг харьяа дүүргийн цагдаагийн хэлтэс шалгаж шийдвэрлэсэн байна. Эдгээр гарсан гэмт хэрэг, зөрчлүүдийг дүүргүүдээр авч үзвэл Чингэлтэй дүүрэгт 8, Сүхбаатар 5, Сонгино хайрхан 5, Баянгол 6, Хан-Уул 2, Багануур 2 гэмт хэрэг, зөрчил тус тус шалгагдсан байна.

2008 оны Улсын Их Хурлын сонгуулийн үеэр гэмт хэрэг, захиргааны зөрчлийн шинжтэй мэдээ мэдээлэл 34 гарчээ.[102]

Сонгуулийн үед гарсан гэмт хэрэг, захиргааны зөрчлийн шинжийг авч үзвэл:

1.Сонгуулийн сурталчилгааны үед үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил;

2.Сонгуулийн санал авах үед үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил;

[99] Сонгуулийн 25-р тойргийн 9 дүгээр хэсгийн хорооны дарга Ш нь сонгуулийн баримт бичиг болон хэсгийн хорооны тогтоолыг хурамчаар үйлдэж санал хураалтын дүн будилаантуулсан талаар мэдээлэл гарч 2008 оны 8 дугаар сарын 29-нд ЭБШХ-ийн 24.1-д зааснаар хэрэгсэхгүй болгох саналтай прокурорт хүргэгдэж байжээ.

[100] Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, судалгааны төвийн 2011.5.3№4/2053 тоот албан бичиг

[101] Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, судалгааны төвийн 2011.5.3№4/2053 тоот албан бичгийн хавсралт Эрүүгийн хуулийн тусгай ангийн 130, 131, дүгээр зүйлээр бүртгэгдсэн хэргийн дэлгэрэнгүй судалгаа

[102] "Сонгуулийн эрх зүйн хариуцлага" 2011 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн зөвлөлдөх уулзалтын үеэр Улсын мөрдөн байцаах газрын ... хэлэлцүүлсэн илтгэлээс

3.Сонгуулийн дүн гаргах үеийн гэмт хэрэг, зөрчил гэсэн гурван хэсэгт хуваан авч үзэж болохоор байна.

Сонгуулийн сурталчилгааны үед гардаг хэрэг зөрчилд нэр дэвшигч болон намын гаргаж буй сонгуулийн зардлыг хэт өсгөж, хэвлэл мэдээлийн хэрэгслээр цацах, нэр дэвшигчийн урьд өмнө авахуулж байсан дүрс, дууны бичлэгт монтаж засвар хийж, хийгээгүй үйлдлийг хийсэн, яриагүй зүйлийг ярьсан мэтээр бэлтгэн интернет сайтад байрлуулах, өрсөлдөгч нэр дэвшигч, намын нэр хүндийг унагах зорилгоор олон нийт, хэвлэл мэдээллийн хэрэгсллийг ашиглан гүтгэх, доромжлох, иргэдийн саналыг худалдан авч, ил болон далд хэлбэрээр бэлэн мөнгө, эд бараа, материал тусламж олгох, санал өгөх эрх бүхий хөдөө орон нутгийн оюутнуудын судалгааг гаргаж, тэдгээрийн иргэний үнэмлэхийг түр хугацаанд ашиглахаар худалдан авах, нэр дэвшигчийг болон намыг дэмжихгүйг илэрхийлсэн утга бүхий бичигт хуудсыг олны анхаарал татах газар наах, хэвлэмэл хуудас тараах, сурталчилгааны самбар, зурагт хуудсыг эвдэн сүйтгэх, иргэдийн иргэний үнэмлэхний ард хуурамч хаягийн бүртгэл нааж бүртгэлд шинээр авахуулан сонгууль өгүүлэх зэрэг үйлдлүүд хамрагдаж байна.

Сонгуулийн санал авах үед гардаг хэрэг зөрчилд сонгууль явагдаж байхад шинэ иргэний үнэмлэх тарааж өгөх, сонгогч нарыг бөөнөөр зөөвөрлөх унаагаар хангаж, санал өгөхөд нь нөлөөлж, мөнгө тараах, сонгуулийн хэсгийн хорооны гишүүд болон бусад ажиглагчдыг өөрийн нэр дэвшигч, намын талд сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн үйлдэл хийлгэхээр элсүүлэх зэрэг үйлдэл хамаарна.

Сонгуулийн дүн гаргах үеийн хэрэг зөрчилд саналын хуудсыг тоолох явцад саналын дүнг буруу уншиж сонсгох, саналын хуудсыг тоолох маягтанд нэгдсэн дүнг буруу тэмдэглэх, өөрчлөн засварлах, нэр дэвшигч нарын авсан саналын тоог тойргийн хороонд хүргүүлэхдээ өөрчлөлт оруулсан хуудсаар солих, хэсгийн хорооны хурлын тэмдэглэлд олон санал авсан нэр дэвшигчийн оронд өөр нэр дэвшигчийн нэрийг сольж засварлах, саналын хайрцгийг авч зугатах зэрэг үйлдэл, эс үйлдлээр илэрч байна.

Дээрх гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээ, мэдээллийг шалгах явцад 2008 оны УИХ-ын сонгуулиар нэр дэвшигч нарын авсан саналын тоог тойргийн хороонд хүргүүлэхдээ өөрчлөлт оруулсан хуудсаар сольсон, дүнгийн хавтгайд засвар хийсэн, сонгогчийн санал бүхий хайрцгийг авч зугтаасан зэрэг 3 үйлдэлд эрүүгийн хэрэг үүсгэн шалгахад УИХСТХ-ийн 48 дугаар зүйлийн 48.4, 50 дугаар зүйлийн 50.3, 52 дугаар зүйлийн 52.1.2, 57 дугаар зүйлийн 57.4 дах хэсэгт заасныг зөрчсөн үйлдлүүд илэрсэн байна.

Дөрөв. ЭРХ ЗҮЙН ИЖИЛ БОЛОН СОНГУУЛИЙН ИЖИЛ ТӨСТЭЙ СИСТЕМ БҮХИЙ ОРНЫ ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ ДАХЬ ХАРИУЦЛАГЫН ТАЛААРХ ЗОХИЦУУЛАЛТ

ОХУ дахь сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага

Сонгуулийн харилцаанд оролцогч субьект нь иргэдийн сонгуулийн эрхийг зөрчсөн тохиолдолд төрөл бүрийн хариуцлага хүлээнэ. Сонгуулийн эрхийн үндсэн баталгааны тухай хуулийн 79 дүгээр зүйлд эрүүгийн, захиргааны болон бусад хариуцлага хүлээлгэж болохоор заасан. Хуульд заасан бусад хариуцлага гэдгийг сахилгын хариуцлага хүлээлгэх, мөн Үндсэн хуулийн эрх зүйн, иргэний эрх зүйн болон олон улсын эрх зүйн хариуцлага байж болно гэж үзэж байна.

Гэхдээ иргэний эрх зүйн, олон улсын эрх зүйн, сахилгын хариуцлагыг сонгуулийн хариуцлага болох хувьд нь тусгайлан зохицуулсан эрх зүйн хэм хэмжээ байхгүй учир судлаачид өөр өөрийн хандлагаар авч үзэж байна. Мөн тодорхой жишээ ховор байгааг дурдах нь зүйтэй байна. Жишээлбэл, сахилгын хариуцлагын хувьд ОХУ-ын судлаачид төрийн болон орон нутгийн албан хаагчид өөрийн албаны байдлаа ашиглан хэн нэгэн нэр дэвшигчийг дэмжсэн тохиолдолд ногдуулж болно гэж үзсэн.

Ер нь судлаачид Үндсэн хуулийн эрх зүйн, захиргааны, эрүүгийн хариуцлага байх ёстой гэдэгтэй санал нэг байна.

Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлага

ОХУ-ын судлаачид Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлага бол улс төрийн шинжтэй гэдэгтэй санал нэгддэг[103]. Мөн Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлага гэж хууль тогтоомжид тусгайлан заасан эрх зүйн хэм хэмжээ байхгүй учир түүнийг онолын түвшинд судлан гарган тавьж байна.

Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлага нь системчлэлгүй байгааг дурдаад энэ төрлийн хариуцлагад сонгуулийн хороодыг өөрчлөн байгуулах, сонгуулийг хүчингүйд тооцох, сонгуулийн хорооны гишүүнийг тухайн ажилд оролцох эрхгүйгээр чөлөөлөх, санал өгөх байранд байгаа ажиглагч болон бусад этгээдийг уг танхимаас гаргах зэргийг хамааруулж үздэг байна.

Захиргааны хариуцлага

ОХУ-ын Захиргааны хариуцлагын тухай хуулийн 5.1, 5.3-5.24, 5.45-5.52, 5.56-д иргэдийн сонгуулийн эрхэд халддаг захиргааны 33 зөрчлийг хуульчилсан. Үүнд:

1.Иргэний сонгогчийн бүртгэлтэй танилцах эрхийг зөрчих;

2.Сонгуулийн хорооны шийдвэрийг үл биелүүлэх;

3.Сонгогчдод мэдээлэл танилцуулах журам зөрчих;

[103] Избирательное право: учеб. пособие /под ред К.К.Гасанова, А.С.Прудникова, В.А.Виноградова. – 3-е изд., перераб. и доп. – М.: ЮНИТИ-ДАНА: Закон и право, 2010. С. 532-535.

4.Хэвлэл мэдээллийн хэрэгслээс сонгуулийн мэдээллээр хангахад оролцох журмыг зөрчих;

5.Сонгуулийн хорооны гишүүн, ажиглагч, гадаадын ажиглагч, нэр дэвшигч, сонгуулийн нэгдэл, хэвлэл мэдээллийн хэрэгслийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эрхийг зөрчих;

6.Сонгуульд оролцох чөлөө өгөхөөс татгалзах;

7.Хэвлэл мэдээллийн хэрэгслээр сонгуулийн өмнөх сурталчилгаа явуулах журам зөрчих;

8.Сонгуулийн кампанит ажлын үед аж ахуйн болон бусад үйл ажиллагааны зар сурталчилгааны нөхцөлийг зөрчих;

9.Сонгуулийн сурталчилгааг хориглосон хугацаанд, хориглосон газар явуулах;

10.Хуулиар хориглосон этгээд сонгуулийн сурталчилгаа явуулах;

11.Сурталчилгааны материалыг хуульд заасан шаардлагыг зөрчиж бэлтгэх, түгээх;

12.Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндээ хамгаалахын тулд тайлбар хийх, няцаалт хийх боломж олгохгүй байх;

13.Сонгуульд хамааралтай хэвлэлийг санаатайгаар устгах, гэмтээх;

14.Сонгуулийн кампанит ажлын үед байр ашиглах эрхийг зөрчих;

15.Сонгогчийг худалдан авах, эсхүл хууль зөрчсөн байдлаар буяны, сайн санааны үйл ажиллагаа явуулах;

16.Сонгуульд зарцуулсан мөнгөний тайланг гаргаж өгөхгүй байх, нийтэд мэдээлэхгүй байх;

17.Нэр дэвшигч, сонгуулийн нэгдэл нь мөнгөн хөрөнгийг хууль бусаар ашиглах;

18.Нэр дэвшигч, сонгуулийн нэгдлээс хууль бус материаллаг дэмжлэгийг ашиглах;

19.Сонгуулийн кампанит ажлыг сонгуулийн сангаас өөр хөрөнгөөр санхүүжүүлэх, хуулиар хориглосон материаллаг дэмжлэг үзүүлэх;

20.Сонгуулийн хороо, нэр дэвшигч, сонгуулийн нэгдэлд мөнгөн хөрөнгийг шилжүүлэх хугацааг зөрчих;

21.Иргэнд хууль бусаар саналын хуудас олгох;

22.Саналын хуудасны үлдэгдлийг багасгах;

23.Санал тоолох хуулиар тогтоосон журам зөрчих;

24.Сонгуулийн үр дүн, санал тооллогын дүнгийн талаар мэдээлэл өгөхгүй байх;

25.Сонгуулийн кампанит ажлын үеэр албаны болон албан тушаалын давуу байдлаа ашиглах;

26.Сонгогчийн гарын үсгийг хуурамчаар үйлдэх;

27.Хориглосон газраас сонгогчийн гарын үсэг цуглуулах, түүнчлэн хуулиар хориглосон этгээд сонгогчийн гарын үсэг цуглуулахад оролцох;

28.Сурталчилгааны материал байрлуулах талбай гаргаж өгөхтэй холбоотойгоор нэр дэвшигч, сонгуулийн нэгдлийн эрхийг зөрчих;

29.Сонгуулийн кампанит ажлын үед мөрий тавих, хонжвор зэрэг тоглоом явуулах журам зөрчих;

30.Сонгуулийн санд хөрөнгө шилжүүлэх журам зөрчих;

31.Хэвлэх үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагаас сурталчилгааны материал бэлтгэх журам зөрчих;

32. Буртгэгдсэн нэр дэвшигч, сонгуулийн нэгдлийг тэгш нөхцөлөөр хангах хууль тогтоомжийн шаардлагыг албан тушаалтан үл биелүүлэх;

33.Сонгуульд бэлтгэх болон явуулахтай холбоотой баримт бичгийг хадгалах, танилцуулах хугацаа, журам зөрчих.

Эдгээр захиргааны зөрчилд хариуцлага хүлээх этгээдүүд нь хувь этгээд /иргэн, сонгуулийн хорооны дарга, нэр дэвшигч, төрийн болон орон нутгийн албан хаагч г.м/, сонгуулийн нэгдэл, бусад хуулийн этгээд байна. Албан тушаалтан нь тусгай субъект болох бөгөөд хариуцлага нь иргэнээс хүнд байна.

Үндсэн шийтгэл бол торгууль юм. Түүний хэмжээ нь 500-100,000 рубль байна. Нэмэгдэл шийтгэлд эд хөрөнгө хураах шийтгэл хамаарна.

Сонгуулийн хууль тогтоомжийн хүрээнд гарсан захиргааны зөрчилтэй хэргийг дүүргийн шүүгч хянан шийдвэрлэнэ. Хэрэв уг хэрэгт захиргааны хэрэг бүртгэлт хийгдээгүй бол эвийн шүүгч хянан шийдвэрлэнэ. Энэ төрлийн хэргийн нэг гол онцлог бол ихэнх захиргааны зөрчлийн тэмдэглэлийг сонгуулийн хорооны эрх бүхий гишүүн хөтөлдөг.

Эрүүгийн хариуцлага

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 141-142[1] дүгээр зүйлд сонгуулийн хууль тогтоомж зөрчсөнтэй холбоотой 4 гэмт хэргийн бүрэлдэхүүнийг хуульчилсан. Үүнд:

1.Сонгуулийн эрхээ хэрэгжүүлэх, сонгуулийн хороо ажлаа хийхэд нь саад учруулах

2.Нэр дэвшигч, сонгуулийн нэгдлийн сонгуулийн кампанит ажлыг санхүүжүүлэх журмыг зөрчих /их хэмжээгээр/

3.Сонгуулийн материалыг хуурамчаар үйлдэх

4.Санал хураалтын дүнг хуурамчаар үйлдэх

Хамгийн хүнд шийтгэл нь 5 жил хүртэл хугацаагаар хорих ял байна[104].

Канадын сонгуулийн хороог сонгуулийн ерөнхий дарга тэргүүлдэг бөгөөд дарга нь бие даасан, хараат бус, шударгаар Канадын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Канадын сонгуулийн хариуцлага[105]

Канад улсын сонгуулийн тухай хууль 2000 онд батлагдсан бөгөөд 22 бүлэг 577 зүйлтэй. Энэ хуулийг холбооны улсын хэмжээнд дагаж мөрдөнө. Сонгуультай холбоотой бүхий л харилцааг зохицуулсан байна[106].

Удирдлагын эрх

Канадын сонгуулийн хорооны дарга нь дараах арга хэмжээг авах эрхтэй. Үүнд:

[104] Избирательное право и избирательный процесс: учеб. пособие /М.С.Матейкович. – М.: Норма: ИНФРА-М, 2010. С.142-154.

[105] http://www.elections.ca/res/eim/pdf/insight_2003_03_e.pdf

[106] http://www.elections.ca/content.aspx?section=res&dir=loi/fel/cea&document=index&lang=e

• Нэр дэвшигчийн нэр дэвшихдээ төлсөн урьдчилгаа мөнгийг авах /нэр дэвшихийн тулд төлсөн мөнгө/

• Бүртгэлтэй улс төрийн намууд санхүүгийн жилийн тайлангаа өгөөгүй тохиолдолд түдгэлзүүлнэ.

Канадын сонгуулийн хуулийг хэрэгжүүлэх арга зам

• Албадлагын арга нь олон янзын хуулийн нөхцөл байдлаас хамаардаг, харин эрүүгийн шинжтэй мөрдөн байцаалт нь үндсэндээ албадлагын хэрэгсэл болдог

• Сонгуулийн хороо нь заавал биелүүлэх буюу дагаж мөрдөх гэрээ хийх эрхтэй. Сонгуулийн хугацаанд ямар нэгэн үйлдэл хийхийг хориглосон шүүхийн тогтоол гаргуулах эрхтэй.

Ямар нэгэн үйлдэл хийхийг хориглосон шүүхийн тогтоол гаргуулах эрх

Хороо нь хэн нэгэн этгээдийг ямар нэгэн үйлдэл хийхийг хориглосон шүүхийн шийдвэр гаргуулахаар шүүхэд хандаж болно. Энэ хүсэлтийг зөвхөн сонгууль явагдах хугацаанд гаргана. Ямар нэгэн үйлдэл хийхийг хориглосон шүүхийн тогтоол гаргахаас өмнө тухайн этгээд хуулиар хориглосон зөрчил гаргасан үндэслэл, нотлох баримт байгаа, эсхүл хууль зөрчих үйлдэл хийх нь илэрхий болсон нь нотлогдсон байдлыг харгалзан үзэж шүүх тогтоол гаргана.

Шүүх тогтоол гаргахдаа дараах 3 хүчин зүйлийг анхаарч авч үзнэ.

- Зөрчлийн ноцтой байдал, түүний мөн чанар
- Сонгуулийн үйл ажиллагааны шударга байдлыг батлах хэрэгцээ
- Олон нийтийн сонирхол

Заавал биелүүлэх гэрээ байгуулах эрх

Хороо болон зөрчил гаргагч этгээд /гэрээ байгуулагч тал/-ийн хооронд хуульд заасны дагуу заавал биелүүлэх шинжтэй албан ёсны гэрээг сайн дураараа байгуулна. Хорооны зүгээс зөрчил гаргасан этгээд, эсхүл зөрчил гаргана гэсэн хангалттай үндэслэл байгаа бол урьдчилан сэргийлэх зорилгоор зөрчил гаргагч этгээдтэй гэрээ байгуулна. Зөрчил гаргагч тал гэрээнд заасан нөхцөлийг дагаж биелүүлсэн тохиолдолд түүнд мөрдөн байцаалт явуулахгүй. Ил тод байдлыг хангах үүднээс гэрээ байгуулагч тал хэвлэн нийтлэхийг зөвшөөрсөн тохиолдолд нийтэд хэвлэнэ.

Зөрчил

Канадын сонгуулийн хууль нь холбооны сонгуулийн зохицуулалтыг тусгасан. Нийт 175 төрлийн зөрчилтэй. Нэр дэвшигч, сонгогч, сонгогдогч, бүртгэлтэй намууд, гуравдагч этгээд, ажил олгогч, сонгуулийн ажилтан зэрэг этгээдүүд зөрчил гаргах субъектэд хамаарна. Тодорхой зөрчил гаргасан тохиолдолд гэм буруутай гэдгийг тогтоох түвшинг зааж өгсөн.

Ял шийтгэл

Торгох болон шоронд хорих нөхцөл, хүрээг зааж өгсөн.

Тухайн зөрчлийн ноцтой байдал болон сонгуулийн системд нөлөөлөх байдал зэргээс хамаарч шийтгэлийн хөнгөн, хүнд байдал хамаарна. Шүүх уян хатан хандаж ямар шийтгэл ногдуулахаа шийднэ. Сонгох шийтгэлүүд байдаг. Үүнд: албадан ажил хийлгэх, хохиролд нөхөн төлбөр ногдуулах, зөрчлийн улмаас тодорхой үүрэг гүйцэтгэх, бусад боломжит арга хэмжээ /буяны, сайн санаат хандив/ гэх мэт.

Хууль бус үйлдэл хийсэн, эсхүл авилгад өртсөн зөрчил гарсаны улмаас энэ нь бүхэлдээ сонгуулийн үйл явцад нөлөөлсөн тохиолдолд парламентад суух, эсхүл нэр дэвшигч байх эрх нь автоматаар алдагдана.

Канад улсын муж болгон харилцан адилгүй хариуцлагын тогтолцоотой. Өөрсдийн тогтоосон шийтгэлийг зөрчил гаргасан тохиолдолд ногдуулдаг.

Торгууль

- New Brunswick /Бруисвик/ болон Quebec /Квебек/ мужуудад шүүх мандатын зөрчил гаргасан тохиолдолд хамгийн бага торгууль ногдуулдаг байна. Тухайлбал: Груисвикд санал хураах байранд зөрчил гаргасан хүнийг илрүүлж буруутай нь нотлогдвол наад зах нь 70 долларраар торгуулах үүрэгтэй.
- Мужууд торгуулийн дээд хэмжээг тогтоож өгч болно. Тухайлбал: Манитоба мужид сонгочийг сүрдүүлсэн тохиолдолд дээд тал нь 10 000 долларраар торгоно. Хэрвээ холбооны засгийн газар мөрдөн байцаалт явуулахаар сонгосон тохиолдолд зөвхөн дээд тал нь 2000 долларраар торгоно.
- Зарим бүс нутагт хорих байр байхгүй учир торгууль өндөр байдаг.

Хорих ял

- Зөвхөн Квебек мужид хорих байр байхгүй учир орон нутгийн сонгуулийн хуулийн дагуу шийтгэл ногдуулахдаа хорихоос бусад шийтгэл ногдуулдаг.
- Груисвек мужид сонгуулийн санхүүжилттэй холбоотой зөрчилд хорих ял өгдөг.
- Хорих ялын хувьд хамгийн бага хугацаа гэж байхгүй. Энэ нь үндсэндээ шүүхийн эрх мэдлийн хүрээнд шийдэгддэг.
- Практикаас харахад хорих ялд олон нийт анхаарлыг хандуулахаа больсоноос хойш маш ховор хэрэглэдэг болсон. Харин торгох ялыг илүү хэрэглэх болсон.
- Холбооны хууль тогтоомжийн дагуу хорих ялын хамгийн дээд хугацаа 5 жил.

Хууль бус үйлдэл хийсэн, эсхүл авлигад өртөж ял шийтгэл авсан тохиолдолд дээр нь нэмэгдэж тусгай үр дагавар бий болно.

- Хууль бус үйлдэл хийсэн эсхүл авлигад өртсөний улмаас ял шийтгэл авсан бол автоматаар тодорхой цаг хугацаа нэмэгдэх шууд үр дагавар үүснэ.
- Хууль бус үйлдлийн улмаас холбооны хуулиар ял шийтгэл авсан бол нэр дэвшигч, эсхүл албан ёсны төлөөлөгч шийтгэл авсан өдрөөс эхлэн автоматаар 5 жил эрх нь хязгаарлагдах үүрэгтэй.
- Авлигад өртсөн тохиолдолд 7 жилээр эрх нь хязгаарлагдана.
- Эрх хязгаарласан шийтгэлийг олон янзын эрх зүйн актаар ногдуулдаг. Энэ нь улсын хэмжээнд үйлчилнэ. Энэхүү шийтгэлээр дараах эрхийг хязгаарладаг. Үүнд: сонгуульд нэр дэвшүүлэх, гишүүнээр сонгогдох, гишүүнээр парламентад суух, албан тушаалд нэр дэвшүүлэх болон томилох, санал өгөх, төрийн албанд томилогдох.

Нэмэлт шийтгэл

Зарим мужид шүүхийн саналын үндсэн дээр нэмэлт санкц ногдуулж болно. Торгууль эсхүл хорих ял дээр нэмэлт төлбөр төлөхөөр ногдуулж болно. Сонгуулийн сурталчилгаанд тогтоосон хэмжээнээс илүү их зардал гаргасан тохиолдолд ногдуулсан шийтгэл дээр нэмж нэмэлт төлбөр төлөхөөр тогтоож болно.

ЗАРИМ ОРНУУДЫН СОНГУУЛЬТАЙ ХОЛБООТОЙ ЗӨРЧИЛД НОГДУУЛАХ ШИЙТГЭЛ[107]

Улс	Санал худалдаж авах	Сонгогчийн залилан/ хууран мэхлэлт/	Санал хураалтыг тасалдуулах /саатуулах/	Зөвсөг хэрэглэн санал хураах байранд нэвтэрсэн	Сонгуулийн хайрцагийг авч явах	Санал хураалтын дүнг өөрчлөх
Алжир	Шийтгэлийн хуулийн дагуу зохицуулна	3 сараас 3 жил + 500-5000 динар	6 сараас 2 жил; Хэрвээ зэвсэг хэрэглэсэн бол 6 сараас 3 жил	6 сараас 3 жил /хуулийн мэргэжилтэн хамаарахгүй/	5-10 жил; Хэрвээ хүч хэрэглэвэл 10-20 жил	5-10 жил
Армени	-	1 жил хүртэл эсхүл хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 500 дахин хүртэл	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 200-400 дахин; Хэрвээ хүч хэрэглэсэн эсхүл заналхийлсэн бол 5 жил хүртэл	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 500 дахин хүртэл	-	2-5 жил
Буркина Фасо	2 жил хүртэл +/ эсхүл 2000 франк	1 сараас 1 жил +/ эсхүл 10 000-100 000 франк	1-5 жил +/эсхүл 300 000-600 000 франк; Хэрвээ зэвсэг хэрэглэсэн бол 5-10 жил	8 000-20 000 франк; Хэрвээ нуугдсан бол 20 000-50 000 франк	1-5 жил +600 000 франк; Хэрвээ бүлэглэсэн бол 5-10 жил	6 сараас 2 жил
Мали	1-5 жил, 100 000-1 сая франк	6 сараас 2 жил +25 000-250 000 франк	1-5 жил +120 000-600 000 франк; Хэрвээ зэвсэг хэрэглэсэн эсхүл саналыг хүч хэрэглэсэн бол 5-10 жил албадан ажил хийлгэх	20 000-120 000 франк; Хэрвээ нуусан бол 15 өдрөөс 3 сар + 60 000 -360 000 франк	1-5 жил + 120 000-600 000 франк; Хэрвээ хүч хэрэглэсэн бол 5-10 жил албадан ажил хийлгэнэ.	1-5 жил + 60 000-600 000 франк
Мексик	200-400 ажлын өдрийн цалингаар торгоно + 1-9 жил шоронд хорих /төрийн албан хаагч/	10-100 ажлын өдрийн цалингаар торгоно + 6 сараас 3 жил шоронд хорино.	10-100 ажлын өдрийн цалингаар торгоно +6 сараас 3 жил шоронд хорино.	-	10-100 ажлын өдрийн цалингаар торгоно +6 сараас 3 жил шоронд хорино	10-100 ажлын өдрийн цалингаар торгоно, эсхүл 6 сараас 3 жил шоронд хорино /иргэд/
Тайланд	1-10 жил +20 000 - 200 000 батт	1-10 жил +20 000 -200 000 батт	1-5 жил +/эсхүл 20 000-100 000 батт	5 жил хүртэл +/эсхүл 10 000 батт хүртэл	1-10 жил + 20 000-200 000 батт	1-5 жил +/эсхүл 20 000 -100 000 батт /төрийн албан хаагч 1-10 жил + 20 000-200 000 батт /

[107] Тухайн улсуудын сонгуулийн хуулинд сонгуультай холбоотой зөрчилд ногдуулах шийтгэлийг заасан байна.

СОНГУУЛИЙН МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭДЭГ БАЙГУУЛЛАГА

Сонгуулийн төв байгууллага	Шүүх	Сонгуулийн трибинал	Бусад
Албани	Австрали	Барбадос	Белги
Канад /Сонгуулийн хороо/	Вотсвана	Итали	Денмарк
Өмнөд Африк	Энэтхэг	Өмнөд Африк	Норвеги
АНУ	Англи	Турк	Швейцарь

ТАЙЛАНД УЛСЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ[108] [109]

III бүлэг. Сонгуулийн хариуцлага

Тайланд улсын сонгуулийн тухай хууль нь 3 бүлэг 161 зүйлтэй. Хаант засаглалын толлоор 62 дахь жилийн 2550 оны 10 дугаар сарын 6-ны өдөр батлагдсан, харин Христосын он толлоор 2007 оны 10 дугаар сарын 6-ны өдөр батлагдсан. Тайланд улсын сонгуулийн тухай хуулийн 3 дугаар бүлэгт сонгуулийн хариуцлагын талаар нарийвчилсан зохицуулалтыг тусгажээ. Хуулийн заалт тус бүрт ямар харилцаанд ямар хариуцлага хүлээлгэхээр заасныг товч бичиж хуулийн заалт болон тухайн заалтад дурдагдсан заалтыг орчуулан ишлэлээр оруулаа.

Удирдах албан тушаалтан санал өгөхөд саад болсон тохиолдолд хэрхэн хариуцлага тооцохыг заасан байна.

136 дугаар зүйл. Албан хаагч эсхүл ажилтнаа санал өгөх эрхээ эдлэхэд нь саатуулсан эсхүл хязгаарласан эсхүл зохих дэмжлэг үзүүлээгүй аливаа удирдах албан тушаалтан эсхүл ажил олгогч нь 2 жилээс ихгүй хугацаагаар шоронд хоригдох эсхүл 40,000 баттаас дээшгүй хэмжээгээр торгуулах хариуцлага хүлээнэ.

Сонгуулийн хорооны ажилтнууд санаатайгаар үүргээ гүйцэтгэхгүй, шударга бус байх, хууль, дүрэм, шүүхийн шийдвэрийн эсрэг үйлдэл хийх, нэр дэвшигч, намд санал өгүүлэх эсхүл өгүүлэхгүйн тулд нөлөөлөх, төрийн албан хаагч нам, эвсэл, нэр дэвшигчид ашигтай үйлдэл хийх, хуурамч бичиг баримт ашиглах, саналын хуудсыг санаатайгаар буруу тоолох зэрэг үйлдэлд ямар хариуцлага хүлээлгэхийг доорх хуулийн зүйлд зохицуулсан байна.

[108] Тайландын Сонгуулийн тухай хуулийг Сонгогчдын боловсрол төвийн тэргүүн Р.Бурмаагийн орчуулгаар оруулсан болно. Мөн доорх линкээс англи хэлээр харж болно. http://www.ifes.org/~/media/Files/Publications/Election%20Law/2007/1148/Election%20of%20Senators%20and%20Representatives.pdf

[108] http://www.elections-lebanon.org/elections/docs_6_G_8_1_14.aspx/сүүлд үзсэн 2011.5.1/

137 дугаар зүйл. 20[110], 53[111], 57[112] дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 70[113] болон 83[114] дугаар зүйлд заасан дүрмийг зөрчсөн аливаа хүн 1-ээс 10 жилийн хугацаанд шоронд хоригдох ба 20.000-аас 200.000 баттын торгууль төлөх хариуцлага хүлээнэ. Мөн шүүх нь тухайн хүнийг 10 жилийн хугацаанд сонгуулийн эрхийг хасна. Хэрэв 53 дугаар зүйлийг зөрчсөн бөгөөд шүүх нь тухайн зөрчил үйлдэгчийг яллах шийдвэр гаргасан бол зөрчлийн тухай мэдээлэл өгсөн хүнийг төлбөрийн хагасаас илүүгүй хэмжээгээр шагнана.

Сонгуулийн дүнд шударга бусаар нөлөөлөхөөр өрхийн бүртгэлд хүн нэмсэн тохиолдолд ямар хариуцлага хүлээлгэх, ямар тохиолдлыг өрхийн бүртгэлд хүн нэмсэн гэж үзэх зохицуулалтыг доорх зүйлээр зохицуулжээ.

138 дугаар зүйл. 33[115] дугаар зүйлийг зөрчсөн аливаа хүн 2 жилээс

[112] **20 дугаар зүйл.**

/1/ СЕХ-ны гишүүн, СЕХ-ны Ерөнхий Нарийн бичгийн дарга, Changwat-ын сонгуулийн хорооны дарга, тойргийн хорооны дарга, тойргийн хорооны гишүүн, хэсгийн хорооны дарга, гишүүн, хамгаалалтын ажилтан эсвэл санал авах явцад туслахаар томилогдсон иргэд санаатайгаар үүргээ гүйцэтгэхгүй эсвэл шударга бус байх, хууль, СЕХ-ны мэдэгдэл, дүрэм, өгсөн тушаал болон энэхүү хуулийн дагуу сонгуулийн үйл явцад хамаарах шүүхийн шийдвэрийн эсрэг үйлдэл хийх ёсгүй.

/2/ Хэрэв 1-р зүйлд заасан иргэн хууль, мэдэгдэл, дүрэм журам, СЕХ-ны тушаал болон сонгуулийн үйл явцад хамаарах шүүхийн шийдвэрийн дагуу өөрийн үүргээ гүйцэтгэвэл тэрээр халдашгүй эрхтэй байж аливаа иргэний эсвэл эрүүгийн хариуцлага хүлээхгүй.

[111] **53 дугаар зүйл.** Нэр дэвшигч эсвэл аль нэг хүн сонгогчийг аль нэг нэр дэвшигч, намд эсвэл өөртөө санал өгүүлэх болон эсхүл өгүүлэхгүйн тулд нөлөөлөх дараах үйлдлийг хийх ёсгүй:

/1/ мөнгөөр хэмжиж болох аливаа хөрөнгийг эсвэл бусад тэтгэлгийг хэнд ч өгөх, санал болгох, өгнө гэж амлах эсвэл өгөхөд бэлдэх;

/2/ мөнгө, хөрөнгө эсвэл бусад тэтгэлгийг шууд эсвэл шууд бусаар нэгдэлд, холбоонд, сан, сүм хийдэд, боловсролын байгууллагад, асрамжийн газар эсвэл аливаа өөр байгууллагад өгөх, санал болгох эсвэл амлах;

/3/ үзвэр, зугаа цэнгэл эсвэл аливаа яармаг зохион байгуулж сонгуулийн кампанит ажил хийх;

/4/ аливаа хүнийг дайлах эсвэл дайлна гэж амлах;

/5/ аливаа нэр дэвшигч эсвэл намын алдар нэрийг буруугаар ойлгуулах эсвэл гүжирдэхийн тулд луйвардах, албадах, айлгах, нөлөөлөх;/6/ /1/ эсвэл /2/-д дурдсан аливаа зөрчил нь Монгө Угаахын Эсрэг Актын эсрэг зөрчил болох ба СЕХ нь эдгээр зөрчлийг Монгө Угаахын Эсрэг албанд мэдүүлэх эрхтэй.

[112] **57 дугаар зүйл.**

/1/ Аль ч түвшний төрийн албан хаагч хууль бусаар нэр дэвшигч эсвэл улс төрийн намд ашигтай ямар нэгэн үйлдэл хийх ёсгүй.

/2/ Дээр дурдсан хууль бус үйлдэлд нэр дэвшигч эсвэл намд ашигтай байсан ч дараах үйлдэл хамаарахгүй: тухайн төрийн албан хаагчийн энгийн үүргэг биелүүлэх ажил бол эсвэл нэр дэвшигч эсвэл намын сонгуульд төрийн албан хаагчийн үүрэгт ажил нь биш ба ажилд нь хамааралгүй зөвлөгөө тусламж өгөх.

/3/ Дээр дурьдсан дүрмийг зөрчсөн гэдэг хангалттай нотлох баримт байгаа тохиолдолд СЕХ нь аливаа нэр дэвшигч эсвэл улс төрийн намд ямар ч үйлдэл нь ашигтай гэж үзвэл тухайн төрийн албан хаагчийг үйлдлээ зогсоохыг тушаах эрхтэй. Ингэхийн тулд тухайн төрийн албан хаагчийг тур ажлаас нь чөлөөлөх эсвэл тойрог дотор эсвэл гадна аль нэг Яам, Яамны харьяа, хэлтэс, Changwat төв алба эсвэл дэд дүүргийн албанд тур ажиллуулах, эсвэл тухайн хүнийг аль ч тойрогт оруулахгүй байх гэж тушаах ёстойг тухайн төрийн албан хаагчийн даргад СЕХ мэдэгдэнэ.

[113] **70 дугаар зүйл.** Саналаа өгөх эрхгүй эсвэл тухайн тойрогт саналаа өгөх эрхгүй гэдгээ мэдэж байгаа аль ч хүн саналаа өгөхийг хичээхгүй эсвэл өөрийн биш иргэний үнэмлэх эсвэл бусад бичиг баримт үзүүлж хэсгийн хороог хуурч саналаа өгөхгүй.

[114] **83 дугаар зүйл.** Хэсгийн хорооны аль ч гишүүн санаатайгаар сонгуульд саналын хуудсуудыг эсвэл саналуудыг буруу тоолох эсвэл саналуудыг буруу нэмэх, хуулиар зөвшөөрснөөс бусдаар ямарваа нэгэн үйлдлээр саналын хуудсуудыг гэмтээх, урагдсан эсвэл хүчингүй болгох, ямарваа нэгэн үйлдлээр хүчингүй саналын хуудсыг хүчинтэй болгох, саналын хуудсыг буруу унших, эсвэл хуурамчаар саналын хуудасны тайлан бэлдэхийг хориглоно.

[115] **33 дугаар зүйл.** Сонгуулийн дүнд шударга бусаар нөлөөлөхөөр нэг ч иргэн өөрийн өрхийн бүртгэлд сонгогч нэмэхгүй бөгөөд өөр хүнээр ч нэмүүлж болохгүй. Дараах тохиолдолд өрхийн бүртгэлд шударга бусаар сонгуулийн дүнд нөлөөлөхөөр сонгогчийн нэр нэмсэн гэж үзнэ:

/1/ өрхийн тэргүүнтэй ижил овогтуй 10-аас дээш иргэнийг өрхийн бүртгэлд нэмж, нэмсэн өдрөөс

дээшгүй хугацаанд шоронд хоригдох эсхүл 40.000 баттаас дээшгүй хэмжээгээр торгуулах хариуцлага хүлээнэ. Энэ хоёр шийтгэлийг давхардуулан ногдуулна.

Төлөөлөгчдийн танхимд нэр дэвших гэж байгаа хүн эрх зүйн чадамжтай байх ёстой, нэр дэвшигч байж болохгүй гэсэн хязгаарлалтгүй байх ёстой, нэр дэвшихдээ нэг намыг зөвхөн төлөөлнө, өргөдлөө Дээд шүүхэд 7 хоногийн өмнө өгөх ёстой, тойргийн хороонд бүртгэгдсэн тохиолдолд нэрээ татаж авч болохгүй гэх зэрэг шалгуур үзүүлэлт, процессыг 139 дүгээр зүйлээр зохицуулж мөн зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг заасан байна.

139 дүгээр зүйл. Аливаа хүн төлөөлөгчдийн танхимын гишүүдийн сонгуульд нэр дэвшигч байх эрхгүй, эсхүл сонгуульд нэр дэвшихийг хориглосон хориг хязгаарлалттай гэдгээ мэдсээр байж 34[116], 35[117] болон 38[118] дугаар зүйлийн 2 дахь хэсгийг зөрчиж сонгуульд нэр дэвших өргөдөл өгсөн бол 1-ээс 10 жилийн хугацаанд шоронд хоригдох ба 20,000-аас 200,000 баттын торгууль төлөх хариуцлага хүлээнэ. Мөн шүүх нь тухайн хүнийг 10 жилийн хугацаанд сонгуулийн эрхийг хасна.

Иргэн, нэр дэвшигч хууль зөрчсөн, хуулийн дагуу үйлдэл хийгээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг 140 дүгээр зүйлд тусгажээ.

140 дүгээр зүйл.

/1/ Аливаа хүн, аливаа нэр дэвшигч энэхүү хуулийг зөрчсөн эсхүл энэхүү хуулийн дагуу үйлдэл хийгээгүй гэж хэн нэгэнд итгүүлэхийн тулд хуурамч үйлдэл хийсэн бол 2 жилээс дээшгүй хугацаанд шоронд хоригдох эсхүл 40,000 баттаас дээшгүй хэмжээгээр торгуулах хариуцлага хүлээнэ. Мөн шүүх нь тухайн хүнийг 5 жилийн хугацаанд сонгуулийн эрхийг хасна.

/2/ Хэрэв дээр дурдсан үйлдийг хорон санаатайгаар тухайн нэр дэвшигчийн сонгуулийн эрхийг хасуулахын тулд эсхүл сонгуулийн үр дүнг зарлуулахгүй байхын тулд үйлдсэн бол тухайн хүн 5-аас 10 жилийн хугацаанд шоронд хоригдох ба 100.000-аас 200.000 баттын торгууль төлөх хариуцлага хүлээнэ. Мөн шүүх нь тухайн хүнийг 10 жилийн хугацаанд сонгуулийн эрхийг хасна.

хойш 2 жилийн дотор болох сонгуульд санал өгөх эрхтэй болгох;

/2/ бодитоор тухайн байранд нүүх ороогүй иргэнийг өрхийн бүртгэлд нэмэх;

/3/ өрхийн тэргүүний зөвшөөрөлгүйгээр өрхийн бүртгэлд иргэн нэмэх.

[116] **34 дүгээр зүйл.** Төлөөлөгчдийн танхимын гишүүдийн сонгуулийн тойргийн ба пропорционал сонгуульд нэр дэвшигч байх эрхтэй иргэн эрх зүйн чадамжтай байх ёстой ба Үндсэн хуулийн заалтын дагуу Төлөөлөгчдийн танхимын гишүүдийн сонгуулийн нэр дэвшигч байж болохгүй гэсэн хориг хязгаарлалтгүй байх ёстой.

[117] **35 дугаар зүйл.**

/1/ Сонгуульд нэр дэвших хүсэлтэй иргэн бүр зөвхөн нэг л намыг төлөөлж сонгуулийн тойргийн эсвэл пропорционал сонгуульд оролцох эрхтэй. Тэрээр зөвхөн нэг л тойрогт нэр дэвшинэ.

/2/ Иргэн нь нэр дэвшихээр өргөдлөө өгөхдөө зүйл 1-ийг зөрчсөн гэдгийг тойргийн хорооны дарга эсвэл СЕХ мэдвэл 37, 43 дугаар заалтын дагуу тухайн иргэнийг нэр дэвшигчээр зарлахгүй. Тухайн иргэн нэр дэвших өргөдлөө өгснөөс 7 хоногийн дотор Дээд шүүхэд өргөдөл гаргах боломжтой. 39, 44 дүгээр заалтууд *mutatis mutandis* гүйцэтгэнэ. Хэрэв нэр дэвшигчийн өргөдлөө өгөх өдрийн дараа зүйл 1-ийн заалтыг зөрчсөн тохиолдолд 40 болон 45 дугаар заалтууд *mutatis mutandis* гүйцэтгэнэ.

[118] **38 дугаар зүйл.**

/1/ Тойргийн хорооны дарга нэр дэвшигчдэд 37 дугаар зүйлийн дагуу баримт бичгийг хүлээж авсан тухай баримт өгснөөс хойш нэр дэвшигч нэрээ татах боломжгүй. Нэр дэвшигчийн төлсөн бүртгэлийн хураамжийг Улс Төрийн Намуудын тухай хуулийн дагуу Улс Төрийн Намуудыг Хөгжүүлэх Санд байрлуулна.

/2/ Зүйл 1-д дурдсан нэр дэвшигч тухайн тойрогтоо эсвэл өөр тойрогт нэр дэвших өргөдлөө дахин өгөхгүй.

/3/ Хэрэв зүйл 1-д дурдсан үйлдэл нь СЕХ-нд өгсөн мэдэгдэл эсхүл тайлан бол тухайн хүн нь 7-оос 10 жилийн хугацаанд шоронд хоригдох ба 140.000-аас 200.000 баттын торгууль төлөх хариуцлага хүлээнэ. Мөн шүүх нь тухайн хүнийг 20 жилийн хугацаанд сонгуулийн эрхийг хасна.

/4/ Хэрэв улс төрийн намын дарга эсхүл Гүйцэтгэх хорооны гишүүний үйлдсэн, эсхүл өөр хүнээр үйлдүүлсэн, хамтарсан эсхүл дэмжсэн зүйл 1, 2, 3-д дурдсан үйлдэл бол тухайн улс төрийн нам нь Улс Төрийн Намуудын тухай хуулийн дагуу үндэсний аюулгүй байдлын эсрэг үйлдэл хийсэнд тооцогдоно.

Сонгуулийн зардлыг тодорхойлох, зардлын хэмжээг, зардлын зарцуулалт зэргийг зөрчсөн тохиолдолд ямар хариуцлага хүлээлгэхийг 141 дүгээр зүйлд заасан байна.

141 дүгээр зүйл. 50[119] дугаар зүйлийг зөрчсөн аливаа нэр дэвшигч эсхүл улс төрийн намын дарга нь 1-ээс 5 жилийн хугацаанд шоронд хоригдох эсхүл 20.000-аас 100.000 баттын эсхүл СЕХ-ны тодорхойлсноос 3 дахин илүү, аль өндөр торгуулийг төлөх, эсхүл 2 шийтгэлийн хоёуланг эдлэх хариуцлага хүлээнэ. Мөн шүүх нь тухайн хүнийг 5 жилийн хугацаанд сонгуулийн эрхийг хасна.

Албан ёсны зардлын данснаас гадна өөр данс нээсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг доорх заалтад тусгажээ.

142 дугаар зүйл. 52[120] дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу СЕХ-ны тодорхойлсон дүрэм журмаас өөрөөр зарлагын дансыг бэлдсэн аливаа сонгуулийн нэгтлан нь 1 жилээс дээшгүй хугацаанд шоронд хоригдох ба

---

[119] **50 дугаар зүйл.** Төлөөлөгчдийн танхимын пишуудийн сонгууль болгонд СЕХ нь сонгуулийн зардлыг тодорхойлсон мэдэгдэл гаргана:

/1/ тойргийн үндсэн дээр явагдах сонгуульд нэр дэвшигч болгоны /нэг нэр дэвшигчийн/ зардлын хэмжээ;

/2/ пропорционал сонгуульд өрсөлдөж буй улс төрийн намын пропорционал сонгуулийн тойрогт зарцуулах зардлын хэмжээ. Аль ч намын жагсаалтад буй нэр дэвшигч сонгуульд зарцуулах ямар ч хэмжээний хөрөнгийг гаргасан бол энэ хөрөнгийг улс төрийн намын зардалд оруулна.

/3/ Төлөөлөгчдийн танхимын пишуудийн сонгууль явагдах бол зүйл 1-д заасан сонгуулийн зардлын хэмжээг тодорхойлоход, СЕХ нь Улс Төрийн Намуудын тухай хуулийн дагуу мөн СЕХ-ны дүрэм журмын дагуу улс төрийн намуудын удирдлагуудтай зөвлөлдөнө.

/4/ Нэр дэвшигч эсвэл улс төрийн нам зүйл 1-ийн дагуу тодорхойлогдсон зардлын хэмжээг давсан сонгуулийн зардал гаргахгүй. Ийм зардалд нэр дэвшигч эсвэл намын нэрийн өмнөөс ямар ч хүний төлсөн болон төлөхөөр амласан эсвэл нэр дэвшигч эсвэл намын зөвшөөрөлтэйгээр кампанит ажилд төлбөргүйгээр хэрэглэхийг санал болгосон мөнгө эсвэл бусад хөрөнгийг оруулна. Хөрөнгө хэрэглүүлэхээр санал болгосон бол зардлыг ердийн түрээсийн хэмжээгээр эсвэл ижил байрлалд төлдөг төлбөрөөр тооцоолж гаргана.

/5/ Улс Төрийн Намын тухай хуульд сонгуульд холбогдолтой зардал гэж тодорхойлогдсон зардлыг нэр дэвшигч эсвэл намын энэ зүйлд тодорхойлсон зардалд нэмнэ.

/6/ Бүх нийтийн сонгуулийн үр дүнг зарласны дараа ТТ-ийн бүх гишүүд сонгогдсон өдрөөс хойш 3 сарын дотор СЕХ нь улс төрийн намуудын удирдлагуудтай уулзаж ирэх бүх нийтийн сонгуульд хүчин төгөлдөр байх нэр дэвшигч ба намын зарцуулах хөрөнгийн хэмжээг тодорхойлно.

[120] **52 дугаар зүйл.**

/1/ Сонгуулийн үр дүнг зарласан өдрөөс хойш 90 хоногийн дотор нэр дэвшигч болгон ба пропорционал сонгуульд нэр дэвшигч нарыг дэвшүүлсэн улс төрийн нам нь нэгтлангийн бэлдсэн ба нэр дэвшигч эсвэл намын даргын баталгаажуулсан орлого ба зарлагын дансуудыг СЕХ-нд өгнө. Орлого ба зарлагын дансуудад ядахдаа бүх төлсөн зардлын ба төлөх ёстой төлбөрийн нарийн мэдээлэл ба түүнтэй холбоотой зөв ба бүрэн баримтууд байх ёстой.

/2/ Зүйл 1-ийн дагуу СЕХ зардлын нарийн баримтыг шалгасны дараа СЕХ нь зардлын шалгалтын үр дүнг СЕХ-ны дүрэм журмын дагуу зарлана.

/3/ Хэрэв нэр дэвшигч эсвэл улс төрийн нам нь СЕХ-ны зааснаас илүү хөрөнгө сонгуульдаа зарцуулсан гэсэн шаардах бичиг байвал зардлын нарийн мэдээлэл ба холбогдолтой нотлох баримтыг СЕХ дансуудыг шалгаж дуустал хадгална.

20.000 баттаас дээшгүй хэмжээгээр торгуулах хариуцлага хүлээнэ. Мөн шүүх нь 5 жилийн хугацаагаар тухайн хүний сонгуулийн эрхийг хасаж 5 жилийн хугацаанд нягтлан хийхийг хориглоно.

СЕХ-нд заасан хугацаанд зардлаа тайлагнаагүй, тайлагнасан боловч нотлох баримт бүрдүүлээгүй, эсхүл зардлын нарийвчлал хуурамч бол хэнд ямар хариуцлага хүлээлгэхийг 143 дугаар заалтаар зохицуулсан байна.

143 дугаар зүйл.

/1/СЕХ-нд заасан хугацаанд зардлаа тайлагнаагүй эсхүл тайлангаа өгсөн боловч бүлэг 52-т заасан нотлох баримт бүрдүүлээгүй аливаа нэр дэвшигч эсхүл улс төрийн намын лидер нь 2 жилээс дээшгүй хугацаанд шоронд хоригдох эсхүл 20,000 баттаас дээшгүй хэмжээгээр торгуулах, эсхүл 2 шийтгэлийг хоёуланг эдлэх хариуцлага хүлээнэ, мөн шүүх нь 5 жилийн хугацаагаар тухайн хүний сонгуулийн эрхийг хасна.

/2/Хэрэв бүлэг 52-ын дагуу тайлагнасан зардлын нарийвчлал нь хуурамч бол, нэр дэвшигч эсхүл улс төрийн намын лидер нь 1-ээс 5 жилийн хугацаанд шоронд хоригдох эсхүл 20,000-аас 100,000 баттын торгууль төлөх хариуцлага хүлээнэ, мөн шүүх нь тухайн хүнийг 5 жилийн хугацаанд сонгуулийн эрхийг хасна.

Аливаа хүн, эсхүл улс төрийн нам нь нэр дэвшигч эсхүл намд ашигтай гэсэн зорилгоор сонгуульд оролцох, эсхүл оролцохгүйн төлөө мөнгө нэхэх, хүлээж авсан тохиолдолд ямар хариуцлага хүлээлгэхийг 144 дүгээр заалтад заасан байна.

144 дүгээр зүйл.

/1/ 54[121] дүгээр зүйлийг зөрчсөн аливаа хүн 1-ээс 10 жилийн хугацаанд шоронд хоригдох эсхүл 20,000-аас 200,000 баттын торгууль төлөх, эсхүл 2 шийтгэлийг хоёуланг эдлэх хариуцлага хүлээнэ. Мөн шүүх нь тухайн хүнийг 10 жилийн хугацаанд сонгуулийн эрхийг хасна.

/2/ Хэрэв улс төрийн нам нь 54 дүгээр зүйлийг зөрчвөл улс төрийн намын дарга ба Гүйцэтгэх хорооны гишүүд нь дээр дурдсан шийтгэлийг эдлэх хариуцлага хүлээх бөгөөд тус зөрчил нь Улс Төрийн Намуудын тухай хуулийн дагуу улс төрийн намыг тараах шалтгаан болно.

Сонгогчийг саналаа өгөхөд нөлөөлөх, хянахын тулд тэзврийн хэрэгслээр үйлчилсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг доорх заалтад тусгажээ.

145 дугаар зүйл. 55[122] дугаар зүйлийг зөрчсөн аливаа хүн 1-ээс 5

[121] **54 дүгээр зүйл.**

/1/ Аль нэг хүн эсвэл улс төрийн нам нь бусад нэр дэвшигч эсвэл намд ашигтай гэсэн зорилгоор сонгуульд оролцох, эсвэл оролцохгүйнхээ төлөө хөрөнгө нэхэх эсвэл хүлээж авах ёсгүй.

/2/ Өөр хүн эсвэл өөр намд 88 дугаар зүйлийн дүрмийг хуурахад туслахын тулд аливаа хүн эсвэл улс төрийн нам нь сонгуульд оролцохоор өргөдөл өгөх, эсвэл гишүүдээ сонгуульд тодорхой хэлбэрээр оролцуулах ёсгүй.

[122] **55 дугаар зүйл.**

/1/ Хэн ч сонгогчийг аль нэг нэр дэвшигч эсвэл намын төлөө санал өгөхөд нөлөөлөх эсвэл хянахын тулд сонгогчийг ердийн тэзврийн хөлс төлөхгүйгээр сонгуулийн хэсэгт хүргэх эсвэл сонгуулийн хэсгээс буцааж хүргэж өгөх тэзврийн хэрэгслээр хангах ёсгүй.

/2/ Дээр дурдсан сонгуулийн хэсэг гэдэгт мөн 95, 96 ба 97-д дурдсан санал өгөхөд бэлдсэн сонгуулийн хэсгүүд хамаарна.

/3/ Хэрэв төрийн байгууллага сонгогчдод туслахаар тэзврийн хэрэгслээр хангасан

жилийн хугацаанд шороно хоригдох эсхүл 20,000-аас 100,000 баттын торгууль төлөх, эсхүл 2 шийтгэлийг хоёуланг эдлэх хариуцлага хүлээнэ. Мөн шүүх нь 5 жилийн хугацаанд тухайн хүний сонгуулийн эрхийг хасна.

Гадаадын иргэн нэр дэвшигч, намд туслах зорилгоор сонгуулийн кампанит ажилд дэмжлэг үзүүлэхэд хүлээлгэх хариуцлагыг доорх заалтад дурдъя.

146 дугаар зүйл. Тайланд үндэстэн биш аливаа хүн 56[123] дугаар зүйлийг зөрчвөл 1-ээс 10 жилийн хугацаанд шороно хоригдох ба 20,000-аас 200,000 баттын торгууль төлөх хариуцлага хүлээнэ.

Сонгуулийн кампанит ажил зохиохгүй байх хугацааг тогтоож өгч өгсөн мөн СЕХ-ноос зааснаас өөр үйл ажиллагаа явуулсан тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг 147 дугаар заалтаар зохицуулсан байна.

147 дугаар зүйл. 58[124], 60[125] дугаар зүйлийг зөрчсөн эсхүл 107[126] дугаар

тохиолдолд энэ бүлэгт дурдсан дүрмүүд үйлчлэхгүй.

[123] **56 дугаар зүйл.** Тайландын бус иргэншилтэй ямар ч хүн кампанит ажил дэмжих эсвэл сонгуульд нэмэр үзүүлэх үйлдлийг аливаа нэр дэвшигч эсвэл намд ашигтай бол хийх ёсгүй. Хэрэв тухайн үйлдэл нь төрийн үйлчилгээнд нэмэр болох бол эсвэл тухайн хүний энгийн ажлын шугамаар шударгаар хийгдсэн бол дээрх дүрэм үйлчлэхгүй.

[124] **58 дугаар зүйл.** Сонгуулийн санал авах өдрийн өмнөх өдрийн 18:00 цагаас сонгуулийн өдөр дуустал ямар ч хүн, нэр дэвшигч эсвэл намд ашигтай эсвэл ашиггүй байх сонгуулийн кампанит ажил зохиохгүй.

[125] **60 дугаар зүйл.**

/1/ 59 дүгээр зүйлийн дагуу нэг ч нэр дэвшигч, улс төрийн нам эсвэл хүн төрийн дэмжлэгтэйгээр хийгдэхээр СЕХ-оос тодорхойлогдсон үйл ажиллагаатай давхцах, сонгуульд холбогдолтой мэдээлэл ба хуудас төрийн эзэмшлийн эсвэл хувийн эзэмшлийн газар өлгөж болохгүй. Радио телевизээр ийм сурталчилгаа явуулж болохгүй.

/2/ СЕХ-ны дүрмээр тодорхойлсноос өөр хэмжээтэй, өөр тооны сонгуулийн холбогдолтой мэдээлэл эсвэл хуудас байх ёсгүй.

59 дүгээр зүйл. Сонгуулийг дэмжих дараах төрийн үйл ажиллагааны дүрэм журмыг СЕХ тодорхойлно:

/1/ төрийн эзэмшлийн газруудад сонгуульд холбогдолтой мэдэгдэл өлгөх зай, нэр дэвшигч болгонд хангалттай ба тэнцүү сурталчилгааны хуудас өлгөх зайг олгох;

/2/ сонгууль болон нэр дэвшигч нарын талаарх сонгогч нарт хүргэх бичиг баримтыг хэвлэх ба тараах;

/3/ нэр дэвшигч нарт сонгуулийн кампанит ажлыг явуулах газрыг тэнцүү олгох. Үүнтэй холбоотойгоор сонгогчдыг сонгуулийн кампанит ажилд татан оролцуулах зорилготойгоор төр нь үзвэр эсвэл бусад үйл ажиллагааг зохион байгуулж болно. Гэхдээ тухайн үйл ажиллагаа нь аль нэг нэр дэвшигчийг дэмжих ёсгүй;

/4/ улс төрийн намд сонгуулийн кампанит ажлыг радио эсвэл телевизээр явуулах, мөн шууд нэвтрүүлэгт орох дүрэм ба цагуудыг тодорхойлох, нам болгонд тэнцүү боломж олгох;

/5/ СЕХ-ны тодорхойлсны дагуу бусад үйл ажиллагааг төр дэмжинэ.

/6/ Сонгуулийг эмх журамтай явуулахын тулд СЕХ сонгуулийн явцад байж болох үйл ажиллагаа ба хориотой үйл ажиллагааны талаарх дүрэм журмыг тодорхойлж. Төрийн мэдээлэлд нийтэлнэ.

[126] **107 дугаар зүйл.**

/1/ Хэрэв 49 дүгээр зүйлийн тодорхойлсон хугацаанд багтаж ямар нэгэн хүн сонгогчид аль нэг нэр дэвшигч эсвэл улс төрийн намын төлөө санал өгүүлэх, эсвэл санал өгүүлэхгүй байхаар мөнгө эсвэл хөрөнгө өгсөн, санал болгосон, эсвэл тухайн үйлдлийн төлөө мөнгө эсвэл хөрөнгө бэлдсэн гэсэн хангалттай нотлох баримт байгаа бол СЕХ нь тухайн хүний мөнгө эсвэл хөрөнгийг шүүхийн шийдвэр гартал түр хугацаанд хураах ба битүүмжлэх эрхтэй.

/2/ Дээр дурьдсан битүүмжлэх үйл ажиллагаа болсноос хойш 3 хоногийн дотор СЕХ нь тухайн битүүмжлэгдсэн хөрөнгийн харъяалагдах Changwat-ын шүүх эсвэл Иргэний шүүхэд нэхэмжлэл гаргана. Шүүх нь нэхэмжлэл хүлээж авсан өдрөөс хойш 5 хоногийн дотор нэг талын /зөвхөн шүүх өөрөө харуцаг

зүйлд дурдсан СЕХ-ны шийдвэрийг зөрчсөн аливаа хүн 6 сараас дээшгүй хугацаанд шоронд хоригдох эсхүл 10,000 баттаас дээшгүй хэмжээгээр торгуулах, эсхүл 2 шийтгэлийг хоёуланг эдлэх хариуцлага хүлээнэ.

Санаатайгаар саналын хуудсыг гэмтээсэн, устгасан, хүчингүй болгосон, эсхүл ямар хүчингүй саналын хуудсыг хүчинтэй саналын хуудас болгосон тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг 148 дугаар зүйлд заажээ.

148 дугаар зүйл.

/1/ Санаатайгаар саналын хуудсыг гэмтээсэн, устгасан, хүчингүй болгосон, эсхүл ямар нэг үйлдлээр хүчингүй саналын хуудсыг хүчинтэй саналын хуудас болгосон аливаа хүн 1 жилээс дээшгүй хугацаанд шоронд хоригдох ба 20,000 баттаас дээшгүй хэмжээгээр торгуулах хариуцлага хүлээнэ. Мөн шүүх нь 5 жилийн хугацаагаар тухайн хүний сонгуулийн эрхийг хасна.

/2/ Хэрэв дээр дурдсан зөрчил үйлдэгч нь сонгуулийн ажилтан бол 1-ээс 10 жилийн хугацаанд шоронд хоригдох ба 20,000-аас 200,000 баттын торгууль төлөх хариуцлага хүлээнэ. Мөн шүүх нь тухайн хүнийг 10 жилийн хугацаанд сонгуулийн эрхийг хасна.

Санал авч байх хугацаанд сонгогчийн өгсөн саналын талаар хэсгийн хорооны гишүүн мэдээлсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг доорх заалтад дурдъяа.

149 дүгээр зүйл. Санал авах ажил нээснээс хаах хүртэл хугацаанд санал авах хэсгийн хорооны гишүүн нь хэн нэгэн хүнд сонгогчийн аливаа нэр дэвшигч эсхүл улс төрийн намын төлөө өгсөн саналыг мэдээлбэл 1 жилээс дээшгүй хугацаанд шоронд хоригдох эсхүл 20,000 баттаас дээшгүй хэмжээгээр торгуулах, эсхүл 2 шийтгэлийг хоёуланг эдлэх хариуцлага хүлээнэ.

Сонгуультай холбоотой санал асуулга зохион байгуулах хугацааг зааж өгсөн, заасан хугацааг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын зохицуулалтыг 150 дахь заалтад тусгасан байна.

150 дугаар зүйл. Сонгуультай холбоотой олон нийтийн санал асуулга зохион байгуулах, түүний үр дүнг сонгуулийн өдрөөс 7 хоногийн өмнөөс санал авах явц дуустал хугацаанд мэдээлсэн аливаа хүн 3 сараас дээшгүй хугацаанд шоронд хоригдох эсхүл 6,000 баттаас дээшгүй хэмжээгээр торгуулах, эсхүл 2 шийтгэлийг хоёуланг эдлэх хариуцлага хүлээнэ.

Саналын хуудсыг авах, ашиглах, саналын хайрцаг болон саналын хуудасны аюулгүй байдал, сонгогчийг санал өгөхөд саад болох үйлдэл хийх, сонгогчийг мөнгөөр худалдаж авах, худалдахыг шаардах зэрэг асуудлыг зохицуулж хуулиар зохицуулсан асуудлыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг 151-153 дугаар зүйлд заажээ.

талд мэдэгдэхгүйгээр/ судалгаа мөрдөн байцаалт явуулна.

/3/ Хэрэв шүүх нь нэхэмжлэлд холбогдолтой мөнгө ба хөрөнгийг сонгуулийн шударга бус үйл ажиллагаанд хэрэглэхээр завдаж байсан гэж үзвэл сонгуулийн үр дүн гартал тухайн мөнгө ба хөрөнгийг битүүмжлэх шийдвэр гаргана.

151 дүгээр зүйл. 71[127] дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 80[128] дугаар зүйлийг зөрчсөн аливаа хүн 1-ээс 10 жилийн хугацаанд шоронд хоригдох ба 20,000-аас 200,000 баттын торгууль төлөх хариуцлага хүлээнэ. Мөн шүүх нь 10 жилийн хугацаагаар тухайн хүний сонгуулийн эрхийг хасна.

152 дугаар зүйл.

/1/ 71 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 72[129], 74[130], 76[131] болон 77[132] дугаар зүйлийг зөрчсөн аливаа хүн нь 1-ээс 5 жилийн хугацаанд шоронд хоригдох эсхүл 20.000-аас 100.000 баттын торгууль төлөх, эсхүл 2 шийтгэлийг хоёуланг эдлэх хариуцлага хүлээнэ. Мөн шүүх нь 5 жилийн хугацаагаар тухайн хүний сонгуулийн эрхийг хасна.

/2/ Хэрэв дээр дурдсан зөрчлийг үйлдсэн хүн нь мөнгө, хөрөнгө эсхүл бусад тэтгэлэг хүлээж авсан, хүлээж авахыг хүлээн зөвшөөрсөн бөгөөд энэ үйлдлээ СЕХ эсхүл СЕХ-ны томилсон хүнд сонгуулийн өдөр эсхүл өмнө нь, эсхүл сонгуулийн өдрөөс хойш 7 хоногийн дотор мэдээлсэн бол тухайн хүн хариуцлага хүлээхгүй бөгөөд сонгуулийн эрхээ хасуулахгүй.

153 дугаар зүйл. 73[133], 75[134] дугаар зүйлийг зөрчсөн аливаа хүн нь 1 жилээс дээшгүй хугацаанд шоронд хоригдох эсхүл 20,000 баттаас дээшгүй хэмжээгээр торгуулах, эсхүл 2 шийтгэлийг хоёуланг эдлэх хариуцлага хүлээнэ.

СЕХ-ны тушаалыг гүйцэтгээгүй, хуулийн дагуу үүргээ гүйцэтгээгүй, мөн зохих мэдээллийг СЕХ-нд хүргүүлээгүй нөхцөлд хүлээлгэх хариуцлагыг 154-155 дугаар зүйлд заасан байна.

154 дүгээр зүйл.

/1/106[135] дугаар зүйлийн дагуу СЕХ-ны тушаалыг гүйцэтгээгүй, эсхүл

[127] **71 дүгээр зүйл.** Ямар ч сонгогч 61 дүгээр зүйлийн дагуу саналын хуудаснаас өөр цаас санал өгөхөд ашиглахгүй бөгөөд 64 дүгээр зүйлийн дагуу иргэний үнэмлэхээ үзүүлснээр хүлээж авсан саналын хуудаснаас өөр саналын хуудсаар саналаа өгч болохгүй. Ямар ч сонгогч саналын хуудсыг санал авах байрнаас авч гарч болохгүй.

[128] **80 дугаар зүйл.** Хуулиар зөвшөөрөөгүй бол санал авах хугацаанд нээлттэй байгаа саналын хайрцагийг, санал авах ажил дуусснаа дараа саналын хайрцаг лацадсан байхад ямар ч хүн саналын хайрцгийг эсвэл саналын хуудсуудыг эсвэл хэсгийн хорооны бэлдсэн холбогдолтой бичиг баримтууд ба нотлох баримтуудыг устгах, эвдлэх, өөрчлөх эсвэл хучингүй болгох эсвэл авч явах зорилготойгоор саналын хайрцгийг онгойлгож болохгүй.

[129] **72 дугаар зүйл.** Ямар ч хүн саналын хуудсан дээр санаатайгаар ямар нэгэн таних тэмдэг тавихгүй.

[130] **74 дүгээр зүйл.** Ямар ч хүн зөвшөөрөлгүйгээр саналын хуудсыг саналын хайрцагт хийж болохгүй эсвэл сонгогчдын нэрсийн жагсаалтад саналаа өгөхөөр ирсэн сонгогчдын тоог өөрчлөхөөр эсвэл саналын хуудсын тоог нэмэхээр ямар нэг үйлдэл хийж болохгүй.

[131] **76 дугаар зүйл.** Хуулиар зөвшөөрөөгүй бол ямар ч хүн сонгогчийг саналаа өгөхөд нь саад учруулах үйлдэл хийх, эсвэл санал авах байр руу очиход нь, санал авах байранд ороход эсвэл санал авах хугацаанд тус байранд хүрэхэд нь хоцроох эсвэл саад болох ёсгүй.

[132] **77 дугаар зүйл.** Аль нэг нэр дэвшигч эсвэл улс төрийн намын төлөө өөрөө эсвэл өөр хүнийг санал өгөх эсвэл өгөхгүй байхын төлөө ямар ч сонгогч мөнгө, хөрөнгө эсвэл бусад тэтгэлэг нэхэх, авах эсвэл авна гэж зөвшөөрөх ёсгүй.

[133] **73 дугаар зүйл.** Ямар ч сонгогч саналаа өгсөн саналын хуудасны зургийг авах гэж аливаа хэрэгсэл ашиглаж болохгүй.

[134] **75 дугаар зүйл.** Хуулиар зөвшөөрөөгүй бол ямар ч хүн саналаа өгөхөд ашигласан саналын хуудсыг болон аль нэр дэвшигч эсвэл намын төлөө саналаа өгсөн эсвэл саналаа өгөөгүй гэдгээ бусад хүмүүст харуулж болохгүй.

[135] **106 дугаар зүйл.**

/1/ Хэн нэгэн нэр дэвшигч эсвэл улс төрийн нам болон аливаа нэг этгээд ашгийн төлөө аливаа үйлдэл хийж, тухайн үйлдэл нь сонгуулийг шударга бус ба хуурамч болгож магадгүй гэж СЕХ үзвэл тухайн этгээдийг үйлдлээ зогсоохыг эсвэл тухайн үйлдлийг тогтоосон хугацаанд тодорхой нөхцөлд засахыг тушаах эрхтэй.

112 дугаар зүйлийг зөрчсөн аливаа хүн 1 жилээс дээшгүй хугацаанд шоронд хоригдох эсхүл 20.000 баттаас дээшгүй хэмжээгээр торгуулах, эсхүл 2 шийтгэлийг хоёуланг эдлэх хариуцлага хүлээнэ.

/2/ Аливаа хүн хуулийн дагуу үүргээ гүйцэтгээгүй буюу 112[136] дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу СЕХ-нд мэдээллийг хүргүүлээгүй бол 1 жилээс дээшгүй хугацаанд шоронд хоригдох эсхүл 20.000 баттаас дээшгүй хэмжээгээр торгуулах, эсхүл 2 шийтгэлийг хоёуланг эдлэх хариуцлага хүлээнэ.

Сонгуулийн тойрогт согтууруулах ундаа зарсан, тараасан эсхүл хангасан, санаатайгаар нэр дэвшигчийн сонгуулийн эрхийг хасуулах, сонгуулийн үр дүнг зарлуулахгүйн тулд үйлдэл хийсэн, мөн тухайн үйлдэл нь тухайн хэсэгт болон тойрогт шинэ сонгууль зарлахад хүргэсэн, хууль зөрчсөн үйлдэл аливаа тойрогт гарсан, Сенаторд сонгогдох эрхгүй эсхүл хориотой гэдгээ мэдэж байж сонгогдохын тулд аливаа байгууллагын томилолтыг хүлээн зөвшөөрсөн, эсхүл Сенаторуудын сонгуулийг шударга ба үнэнч явагдахын эсрэг үйлдэл хийсэн зэрэгт хүлээлгэх хариуцлагыг 155-161 дүгээр зүйлээр зохицуулсан байна.

155 дугаар зүйл. Сонгуулийн өмнөх өдрийн 18:00 цагаас сонгуулийн өдөр дуустал аливаа тойрогт согтууруулах ундаа зарсан, тараасан эсхүл хангасан аливаа хүн нь 6 сараас дээшгүй хугацаанд шоронд хоригдох эсхүл 10.000 баттаас дээшгүй хэмжээгээр торгуулах, эсхүл 2 шийтгэлийг хоёуланг

/2/ Хэрэв цагдаагийн ажилтан дээр дурдсан үйлдлийн талаар мэдээлэл авсан, эсвэл тухайн үйлдлийг илрүүлсэн бөгөөд тухайн үйлдэл нь энэхүү хуулийг зөрчсөн үйлдэл мөн бол цагдаагийн ажилтан нь тухайн хүнийг баривчилж зохих хэрэг үүсгэн СЕХ-нд мэдэгдэж, тодорхой арга хэмжээ авахуулахын тулд Changwat-ын сонгуулийн хороонд мэдэгдэх ёстой.

[136] **112 дугаар зүйл.** Сонгуулийн талаар бодит судалгаа ба мөрдөн байцаалт явуулах, сонгуулийг шударга бус ба хуурамч болохоос урьдчилан сэргийлэх зорилгоор СЕХ болон СЕХ-ны томилсон гишүүн дараах эрх мэдэлтэй байна:

/1/ Энэхүү хуулийг зөрчсөн тухай хангалттай нотлох баримт байгаа тохиолдолд бичиг баримт, хөренгө эсвэл бусад нотлох баримтыг шалгах, хайх, хураах эсвэл битүүмжлэхийн тулд оршин суугаа газар, байр эсвэл бусад тээврийн хэрэгсэлд нэвтрэх. Мөн хойшлуулшгүй тохиолдол буюу бичиг баримт, хөренгө эсвэл нотлох баримтыг анхны байдлаас нь зөөвөрлөх, нуух, устгах эсвэл өөрчлөх боломжтой гэж үзэх хангалттай шалтгаан байгаа бол зөвшөөрөлгүйгээр нэгжлэг хийж болно. Ингэсэн тохиолдолд хэргийн нөхцөл байдлыг бүртгэнэ. Дээр дурдсан эрх мэдлийг сонгууль явуулах болсныг мэдэгдсэн Хааны зарлиг гарсан өдрөөс сонгуулийн үр дүнг зарлах хүртэл хэрэгжүүлнэ. Мөн шаардлагатай тохиолдолд аливаа хэрэгт туслуулахаар төрийн албан хаагчдыг дайчилж болно. СЕХ Changwat-ын сонгуулийн хорооны гишүүнийг эсвэл бусад албан тушаалтнуудыг нэгжлэг хийхээр томилж болно. Харин тухайн хүн нь шүүхээс нэгжлэг хийх зөвшөөрөл авсан байна.

/2/ Мөнгө Угахын Эсрэг албанаас сонгуульд холбоотой байж болзошгүй хүмүүсийн мөнгөн гүйлгээний тайланг Хувийн Банкуудын тухай хуулийн дагуу Тайландын Банк болон хувийн банкнаас, эсвэл бусад санхүүгийн байгууллагуудаас СЕХ-нд өгүүлэхээр шаардах эрхтэй.

эдлэх хариуцлага хүлээнэ. Энэхүү дүрэм нь 95[137], 96[138] ба 97[139] дугаар зүйлд заасан санал авах өдөрт мөн хамаарна.

156 дугаар зүйл. Сонгуулийн үр дүнгээр мөрий тавьсан эсхүл мөрий тавихыг зохион байгуулсан аливаа хүн нь 1-ээс 5 жилийн хугацаанд шоронд хоригдох эсхүл 20.000-аас 100.000 баттын торгууль төлөх, эсхүл 2 шийтгэлийг хоёуланг эдлэх хариуцлага хүлээнэ. Мөн шүүх нь 5 жилийн хугацаагаар тухайн хүний сонгуулийн эрхийг хасна.

157 дугаар зүйл. 123 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн аливаа нэр дэвшигч нь 1-ээс 5 жилийн хугацаанд шоронд хоригдох эсхүл 20,000-аас 100,000 баттын торгууль төлөх, эсхүл 2 шийтгэлийг хоёуланг эдлэх хариуцлага хүлээнэ. Мөн шүүх нь 5 жилийн хугацаагаар тухайн хүний сонгуулийн эрхийг хасна.

158 дугаар зүйл.

---

[137] **95 дугаар зүйл.**

/1/ Хэрэв сонгоч өөрийн санал өгөх ёстой тойргоос гадна үүрэг гүйцэтгэх тушаал авсан бол эсвэл санал өгөх ёстой тойргоос гадна аялах болон сонгуулийн өдөр санал авах байранд саналаа өгөх боломжгүй бол сонгоч сонгуулийн санал авах өдрөөс өмнө саналаа өгөх өргөдлийг тойргийн хороонд эсвэл тойргийн хорооноос томилсон хүнд өгнө.

/2/ Дээр дурдсан сонгочийн санал өгөх эрхийг судлаад хэрэв тойргийн хороо тухайн сонгочийг санал өгөх эрхтэй гэж үзвэл тойргийн хороо эсвэл тойргийн хорооны томилсон хүн нь тухайн сонгоч саналаа өгөх боломжтой төв санал авах байрыг тодорхойлно. Мөн тухайн сонгочийн нэр аль санал авах байрны сонгочдын нэрсийн жагсаалтад байгаа, тэр хэсгийн хороонд сонгоч өөр газар саналаа өгөх болсныг мэдэгдэнэ. Саналаа өгөх болсон газрыг баримтан дээр тэмдэглэнэ.

/3/ Зүйл 1-д тодорхойлсон санал өгөх өргөдлийг төв санал авах байр ба тоо,санал өгөх өдөр зэргийг мэдэгдэх журам ба дүрмийг СЕХ тогтооно.

[138] **96 дугаар зүйл.** Сонгуулийн санал авах өдрөөс өмнөх 90 хоногийн дотор сонгуулийн тойргийн өрхийн бүртгэлд бүртгэгдсэн сонгогч тойргийн үндсэн дээр явагдах сонгуульд, 90 дараалсан хоногоос доошгүй хугацаанд бүртгэлтэй байсан сонгуулийн тойроготоо тойргийн үндсэн дээр явагдах сонгуульд саналаа өгөх эрхтэй. Тийм хүн нь өөрийнх нь тойргийн үндсэн дээр явагдах сонгуулийн тойрог байрлаж буй Changwat Группд пропорционал сонгуульд саналаа өгөх эрхтэй. Сонгуулийн өдрөөс өмнө 90 хоногийн дотор өрхийн бүртгэлд бүртгэгдсэн эсвэл нэр нь сонгогчдын жагсаалтад буй өөрийн тойргоос гадна амьдардаг сонгогч саналаа өгөх эрхээ эдлэх боломжийг СЕХ олгож санал өгөх нөхцөл, журам ба дүрмийг тодорхойлно.

[139] **97 дугаар зүйл.**

/1/ ТТГ-ийг сонгох бүх нийтийн шинэ биш сонгуульд хэрэв аливаа сонгогч өөрийн нэр нь өрхийн бүртгэлд байгаа Changwat биш өөр Changwat-д амьдарч байвал эсвэл 96 дугаар зүйлд тодорхойлсон сонгогч бол тухайн сонгогч амьдарч байгаа Changwat-даа саналаа өгөх хүсэлтэй бол СЕХ-ны Төрийн мэдээлэлд нийтэлсэн журмын дагуу тойргийн гадна саналаа өгөх хүсэлтэйгээ бүртгүүлнэ.

/2/ Зүйл 1-д дурдсаны дагуу бүртгэгдсэн хүн сонгуулийн өдрөөс 30 хоногийн өмнө бүртгүүлсэн бол саналаа тойргоос гадна өгөх эрхтэй. Тухайн сонгогч бүртгүүлсэн Changwat-д санал өгөх эрхээ эдлэх ба өөрийн санал өгөх эрхтэй байсан анхны тойроготоо санал өгөх эрхгүй болно. СЕХ нь сонгогчдын нэрсийн жагсаалтад санал өгөх эрхээ эдлэх өргөдлийн бүртгэлийг тэмдэглэж мөн санал өгөх эрхээ эдлэх болсон газрыг сонгогчдын нэрсийн жагсаалтад тэмдэглэнэ.

/3/ Зүйл 1-д дурдсаны дагуу бүртгэгдсэн хүн санал өгөх эрхээ эдлэх ёстой Changwat-аа өөрчлөх өргөдөл өгч болно. Бүртгэлээ өөрчлөх өргөдөл өгснөөс хойш 30 хоног дуусснаас дараа энэ өргөдөл нь хүчинтэй болно. Мөн зүйл 2-д заасан дүрэм *mutatis mutandis* үйлчилнэ. Өөрчлөлтийг бүртгэх өргөдлийг нэг сонгуульд нэгээс илүү удаа өгч болохгүй.

/4/ Зүйл 1-ийн дагуу санал өгөх эрхтэй сонгогч өөрийнх нь нэр аль тойргийн өрхийн бүртгэлд байгаа тэр тойргийн, эсвэл 96 дугаар зүйлийн дагуу хамгийн сүүлд ядаж 90 хоногийн турш өрхийн бүртгэлд бүртгэлтэй байсан тойргийн нэр дэвшигчийн төлөө санал өгөх эрхээ эдэлнэ.

/5/ ТТГ-ийг сонгох бүх нийтийн шинэ эсвэл нөхөн сонгуульд хэрэв зүйл 1-ийн дагуу бүртгэгдсэн хүн бүх нийтийн сонгуульд саналаа өгсөн боловч шинэ эсвэл нөхөн сонгуульд санал өгөх эрхээ эдлэх эрхтэй тойрогт санал өгөх эрхээ эдлэзгүй бол тус бүртгэл нь хүндэтгэн үзэх шалтгаантай гэж үзэж 26 дугаар зүйлд дурдсан эрхээ хасуулахгүй.

/1/ Хэрэв шүүх нь аливаа хүнийг энэхүү хуулийг зөрчсөний төлөө ял оноосон ба тухайн хүн нь санаатайгаар нэр дэвшигчийн сонгуулийн эрхийг хасуулах болон 140[140] дугаар зүйлийн 2 дахь хэсгийн дагуу сонгуулийн үр дүнг зарлуулахгүйн тулд үйлдэл хийсэн, мөн тухайн үйлдэл нь тухайн хэсэгт болон тойрогт шинэ сонгууль зарлахад хүргэсэн бол шүүх тухайн хүнээр сонгуулийн зардлыг нөхөн төлүүлэх шийдвэр гаргана. СЕХ нь Иргэний хэрэг шүүн таслах хуулийн дагуу төлөх шүүхийн зардлыг төлөхгүй.

/2/ Хэрэв сонгуулийн зардлыг нөхөн төлөх ёстой хэд хэдэн тооны хүмүүс байвал хүн болгон хамтран төлөх хариуцлага хүлээнэ.

159 дүгээр зүйл. Хэрэв энэхүү хуулийг зөрчсөн үйлдэл аливаа тойрогт гарсан бол тухайн тойрогт сонгуульд оролцохоор нэр дэвшигчдээ томилсон улс төрийн нам эсхүл нэр дэвшигч нь Эрүүгийн хэрэг шүүн таслах хуулийн дагуу хохирогчоор тооцогдоно.

160 дугаар зүйл. Энэхүү хуулийг Вант улсаас гадна зөрчсөн аливаа хүн нь Вант улсад шийтгэгдэх бөгөөд Вант улсаас гадна хийгдсэн зөрчлийн хамтарсан, дэмжсэн эсхүл өдөөн хатгасан үйлдэл нь Вант улс дотор үйлдэгдсэнд тооцогдоно.

161 дүгээр зүйл. Сенаторд сонгогдох эрхгүй эсхүл хориотой гэдгээ мэдэж байж сонгогдохын тулд аливаа байгууллагын томилолтыг хүлээн зөвшөөрсөн, эсхүл Сенаторуудын сонгуулийг шударга ба үнэнч явагдахын эсрэг үйлдэл хийсэн аливаа хүн нь 1-ээс 10 жилийн хугацаанд шоронд хоригдох ба 20.000-аас 200.000 баттын торгууль төлөх хариуцлага хүлээнэ. Мөн шүүх нь 10 жилийн хугацаагаар тухайн хүний сонгуулийн эрхийг хасна.

Тав. СОНГУУЛИЙН ЭРХ ЗҮЙН ХАРИУЦЛАГЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ТУХАЙ САНАЛ /ЗАХИРГААНЫ ШИЙТГЭЛ, ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА, ЭД ХӨРӨНГИЙН ХАРИУЦЛАГА/

Дүгнэлт 1: Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн зүйл болгон нь дотроо хариуцлагын хэм хэмжээг агуулжээ. Энэ нь хуулийн зүйлийн нэр тухайн зүйлд байгаа хэсэг, заалтын агуулгатай нийцэхгүй

[140] **140 дүгээр зүйл.**

/1/ Аливаа хүн, аливаа нэр дэвшигч энэхүү хуулийг зөрчсөн эсвэл энэхүү хуулийн дагуу үйлдэл хийгээгүй гэж хэн нэгэнд итгүүлэхийн тулд хуурамч үйлдэл хийсэн бол 2 жилээс дээшгүй хугацаанд шоронд хоригдох эсвэл 40,000 баттаас дээшгүй хэмжээгээр торгуулах хариуцлага хүлээнэ. Мөн шүүх нь тухайн хүнийг 5 жилийн хугацаанд сонгуулийн эрхийг хасна.

/2/ Хэрэв дээр дурдсан үйлдлийг хорон санаатайгаар тухайн нэр дэвшигчийн сонгуулийн эрхийг хасуулахын тулд эсвэл сонгуулийн үр дүнг зарлуулахгүй байхын тулд үйлдсэн бол тухайн хүн 5-аас 10 жилийн хугацаанд шоронд хоригдох ба 100,000-аас 200,000 баттын торгууль төлөх хариуцлага хүлээнэ. Мөн шүүх нь тухайн хүнийг 10 жилийн хугацаанд сонгуулийн эрхийг хасна.

/3/ Хэрэв зүйл 1-д дурдсан үйлдэл нь СЕХ-нд өгсөн мэдэгдэл эсвэл тайлан бол тухайн хүн нь 7-оос 10 жилийн хугацаанд шоронд хоригдох ба 140,000-аас 200,000 баттын торгууль төлөх хариуцлага хүлээнэ. Мөн шүүх нь тухайн хүнийг 20 жилийн хугацаанд сонгуулийн эрхийг хасна.

/4/ Хэрэв улс төрийн намын дарга эсвэл Гүйцэтгэх хорооны гишүүний үйлдсэн, эсвэл өөр хүнээр үйлдүүлсэн, хамтарсан эсвэл дэмжсэн зүйл 1, 2, 3-д дурдсан үйлдэл бол тухайн улс төрийн нам нь Улс Төрийн Намуудын тухай хуулийн дагуу үндэсний аюулгүй байдлын эсрэг үйлдэл хийсэнд тооцогдоно.

байна. Хуулийн зүйл нэрнээсээ юуг илэрхийлж байгаа нь ойлгогддог байх ёстой. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэгт "Хуулийн төслийн бүтцийг хэлбэрт оруулж байрлуулах" тухай заасан. Үүнд 17.3.7 дахь заалтад хариуцлага тогтоож байгаа хэм хэмжээг хуулийн арын хэсэгт байрлуулахаар заажээ.

Мөн 2009 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 131 дугаар Хууль зүй, дотоод хэргийн сайдын "Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал" батлах тухай тушаал батлагдсан. Энэ тушаалын 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт хуулийн төслийн бүтцийг заасан ба хариуцлага тогтоох хэсгийг хуулийн ард хийнэ гэжээ. Мөн аргачлалын 5.11 буюу "хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагын зохицуулалтыг томъёолох нь" хэсэгт "хариуцлага хүлээлгэх заалтыг хуулийн төслийн холбогдох заалтын ард шууд байрлуулж болно" гэж заажээ. Гэвч 2010 оны 5 дугаар сарын 10-ны өдөр батлагдсан "дугаар 84" аргачлалын шалгуурын дагуу хуулийн зүйлийн нэр нь тухайн зүйлийн хэсэг, заалтын агуулгатай нийцэхгүй байна.[141]

Санал: Хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хуулийн адил хариуцлагыг хуулийн төгсгөлийн хэсэгт багцлан оруулах.

Дүгнэлт 2: МУИХСТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.3.7 дахь хэсэгт заасан үйлдлийг Эрүүгийн хуульд гэмт хэрэг гэж үзжээ. Эрүүгийн хуулийн 130 дугаар зүйлийг тайлбарласан 2010 оны Монгол улсын Эрүүгийн хуулийн тайлбарт "Иргэний сонгох, сонгогдох, бүх нийтийн санал асуулгад оролцох эрхээ хэрэгжүүлэхэд болон Сонгуулийн хорооноос хуулийн дагуу явуулж байгаа аливаа ажиллагаанд санаатай саад хийсэн гэдэгт ... бусдын нэрийн өмнөөс сонгуульд оролцох, санал тоолох, сонгуулийн дүнг гаргах ажлыг элдэв хэлбэрээр зориуд саатуулах, ... зэрэг сонгуулийн хууль зөрчсөн ажиллагануудыг хамруулна", мөн 131 дүгээр зүйлийн 131.1 дэх хэсгийн тайлбарт "саналаа нуулаар гаргах, саналаа чөлөөтэй илэрхийлэх эрхийг зөрчих гэдэгт ... саналын хайрцгийг битүүмжилж лац хийхгүй байх, албан ёсны бүрдэл хангагдаагүй хуудсаар санал өгүүлэх, саналаа өгөхөд бусад хэлбэрээс саад учруулсан үйлдлүүд байна", "сонгуулийн баримт бичгийг хуурамчаар үйлдэх гэдэгт сонгууль явуулах, бүх нийтийн санал хураалт, сонгуулийн дүн гаргахтай холбогдсон баримт бичгийн ... засвар хийх" гэжээ. Тиймээс Эрүүгийн хуулийн тайлбараар эрүүгийн хэргийн шинжийг агуулсан МУИХСТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.3.7 дахь хэсэгт эрүүгийн хуульд заасан хариуцлагыг хүлээлгэх нь зүйтэй.

Санал: МУИХСТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.8 дахь хэсгийг хүчингүй болгох.

Дүгнэлт 3: МУИХСТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.11 дэх хэсэгт сонгуулийн хороодын тавьсан шаардлагыг хүлээн авсан байгууллага, албан тушаалтанд эргээд хариу мэдэгдэнэ гэж үүрэг хүлээлгэсэн шинжтэй бөгөөд энэ хэсэгт хуулийн хариуцлага ногдуулахаар зохицуулсан. Харин 19.4,

[141] "Иргэн, эдийн засгийн хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах ажил" төслийн багийн хийсэн УИХ-ын сонгуулийн тухай хуульд хийсэн судалгааны ажлын тайланд эл санал туссаныг дэмжиж оруулав.

19.5 дахь хэсэгт сонгуулийн хороодыг хуралдаанаараа дэгээ тогтоож, ил тод, нээлттэй байдал зэрэг зарчмыг тусгаж, иргэдэд ил тод мэдээлнэ гэсэн үүргийн шинжтэй зохицуулалт оруулсан. Гэтэл хуралдааны дэгээ батлаагүй, дэггүй хуралдааныг хийсэн тохиолдлууд гарч байжээ. Энэ тохиолдлуудад сонгуулийн хороодод хүлээлгэх хариуцлагын талаар зохицуулалт байхгүй байна.

Санал: МУИХСТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.4, 19.5 дахь хэсгүүдийн хариуцлагыг хуульд тодорхой заах.

Дүгнэлт 4: Ямар хугацаанд гомдол гаргах нь тодорхойгүй байна. МУИХСТХ-ийн 20.4-т санал авах өдрөөс 15-аас доошгүй хоногийн өмнө сонгогчдод чөлөөтэй танилцах боломжийг олгосон. Жишээ нь 15-аас доошгүй хоногийн өмнө танилцах боломж олгож байгаа учраас гомдлыг санал авах өдрөөс 10-аас доошгүй хоногийн өмнө гаргах эрхтэй байхаар тусгах. Ингэснээр сонгогчдод өөрсдийн нэрсийг шалгаж, гомдол гаргахад 5 хоногийн хугацаа байна. Ингэзд 21.2-т заасан хугацаанд буюу гомдлыг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор гомдлыг шалгаж хариу мэдэгдэнэ гэх зэрэг хугацааг тодорхой болгосноор санал авах өдөр гомдлыг хүлээн авахгүй байхаар зохицуулалт хийх нь зүйтэй юм.

Санал: МУИХСТХ-ийн 21 дүгээр зүйлийн 21.1, 20.2 дахь хэсэгт хугацааг тодорхой болгох.

Дүгнэлт 5: МУИХСТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.10, 21 дүгээр зүйлийн 21.2, 57 дугаар зүйлийн 57.5-д сонгуулийн тойргийн хороо, СЕХ тухайн маргаантай асуудлыг шийдвэрлэж бичгээр хариу мэдэгдэнэ гэж заасан. Гэтэл 2008 оны сонгуулийн үйл явцтай холбоотой гарсан маргааныг шийдвэрлэсэн байдлаас харахад тухайн тойргийн хороо, СЕХ зэрэг нь хариу өгөөгүй тохиолдол нэлээд гарчээ.

Санал: Хэрэв МУИХСТХ-ийн 19.10, 21.2, 57.5- д заасан хугацаандаа хариу өгөөгүй нөхцөлд тухайн буруутай этгээдэд хариуцлага тооцох зохицуулалтыг нэмж тусгах.

Дүгнэлт 6: МУИХСТХ-ийн 48 дугаар зүйлийн 48.10 дахь хэсэгт ногдуулах хариуцлага нь тодорхой бус байна. Харин Орон нутгийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 41.9 дэх хэсэг буюу МУИХСТХ-ийн 48.10 дахь хэсэгтэй адил зохицуулалтад хариуцлага ногдуулахаар /41.10-т/ заасан байна. МУИХСТХ-ийн 48.11 дэх хэсэгт 48.10 дахь хэсгийг орхигдуулсан байна.

Санал: МУИХСТХ-ийн 48 дугаар зүйлийн 48.11 дэх хэсэгт 48.10 дахь хэсгийг зөрчсөнд ногдуулах хариуцлагыг нэмж оруулах.

Дүгнэлт 7: Эрүүгийн хуулийн 130, 131 дүгээр зүйл ангид зааснаар эрүүгийн хэрэг үүсгэн шалгагдсан талаарх баримт судалгаанаас харахад цөөн тоогоор байгаа хэдий ч эцэслэн шийдвэрлэгдэж ял шийтгэл авсан нь тодорхойгүй аль нэг шатанд хэрэгсэхгүй болгосноор дуусгавар болох нь байна. Судалгаанаас харахад УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгууль, орон нутгийн сонгуулийн үеэр тодорхой тооны хэрэг, зөрчил шалгагддаг байна. Гэвч хариуцлага тооцсон, ялангуяа шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн

нь **байхгүй байна**. Эрүүгийн хариуцлага гарцаагүй, зайлшгүй байх зарчим сонгуулийн холбогдолтой хэрэг, зөрчлийн хувьд төдий л хэрэгжиж чадахгүй байна.

Санал: Сонгуулийн санал өгөх сонгогч нарт архи, мөнгө, эд бараа тараасан, хүнсний тусламж олгох нэрийн дор саналыг хууль бусаар худалдан авах гэх зэрэг сонгуулийн үйл явцтай холбоотой гэмт хэргийн шинжтэй үйлдэл илэрсэн тохиолдолд хэсгийн болон тойргийн сонгуулийн хороодын дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс нэн даруй холбогдох хуулийн байгууллагад мэдэгдэж шалгуулж байхыг хуулийн 14.5-д нэмэлтээр оруулах.

Дүгнэлт 8: Нэр дэвшигч эрүүгийн хэрэгт шалгагдаж байгаа, түүнчлэн нэр дэвшигч сонгуулийн хууль тогтоомжийг зөрчсөн, сонгуулийн дүнгийн талаарх маргаантай асуудалтай холбогдуулан[142] эрүүгийн хэрэгт шалгагдаж байгаа гэдэг шалтгаанаар тойрогт сонгогдсон нэр дэвшигчийн тангараг өргүүлэх асуудлыг түдгэлзүүлж, улмаар олон сар жилээр УИХ-ын суудал эзэнгүй байхад хүргэж байгааг цаашид өөрчилж, санал хураалтын дүн будлиангүй тоологдсон тохиолдолд сонгогдсон нэр дэвшигчийг тангараг өргүүлэн бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрүүлж, харин шалгагдаж буй эрүүгийн хэргийг шүүхэд эцэслэн шийдвэрлэсний дараа тухайн гишүүн эрүүгийн хэрэг үйлдсэн нь шүүхийн шийдвэрээр нотлогдсон тохиолдолд хуульд заасны дагуу УИХ-ын гишүүнээс эгүүлэн татах, түүнчлэн тухайн гишүүний сонгогдсон тойрог, хэсгийн сонгуулийн хорооны гишүүн, түүнчлэн нэр дэвшигчийн шадар туслагч, ухуулагч, түүнийг нэр дэвшүүлсэн нам, эвслийн холбогдох ажилтан Эрүүгийн хуулийн 130, 131 дүгээр зүйлд заасан гэмт хэргийг үйлдсэн нь шүүхээр нотлогдож, түүний улмаас тухайн гишүүний сонгогдсон саналын дүнд ноцтой өөрчлөлт орж саналын тоогоор сонгогдоогүй нь тогтоогдсон бол УИХ-ын гишүүнээс эгүүлэн татаж байхаар хуульд тусгаж болно.

Ийнхүү хуульд тусгаснаар төрийн эрх барих дээд байгууллага ямар нэг хийдэлгүй цаг хугацаандаа байгуулагдаж бүрэн эрхээ хэрэгжүүлэх, мөрдөн байцаах, шүүх байгууллага хэрэг шалгах, хянан шийдвэрлэх үйл ажиллагаагаа байцаан шийтгэх хуулийн дагуу түүнд заасан хугацаанд явуулах боломж бүрдэх юм.

[142] Үл таних 2 хүн УИХ-ын гишүүн А хүн бүрт 10.000 төгрөг тарааж байна гэсэн мэдээллийн дагуу мөрдөн байцаагч шалгаж ЭБШХ-ийн 24.1.1-д заасны дагуу хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай прокурорт хүргүүлсэн байна.

Зургаа. СОНГУУЛИЙН МАРГААНЫГ ТҮРГЭН ШУУРХАЙ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ БОЛОМЖ НӨХЦӨЛ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДАЛ

Нэг. Маргаан хянан шийдвэрлэх хугацааг богиносгох

Сонгуулийн маргааныг түргэн шуурхай шийдвэрлэхэд уг маргааныг хэдий хугацаанд шийдвэрлэж эцсийн хариу гаргах нь чухал ач холбогдолтой.

Монгол Улсад үйлчилж буй хуулиудыг авч үзвэл:

1. Үндсэн хуулийн цэц маргааныг хянан шийдвэрлэх хугацаа:

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21.2-т "Үндсэн хууль зөрчсөн тухай иргэнээс гаргасан өргөдөл, мэдээллийг хүлээн авсан гишүүн анхны шалгалтыг **14 хоногийн** дотор хийж маргаан үүсгэх эсэхийг өөрийн санаачилгаар шийдвэрлэнэ". 23.2-т "Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг үүсгэснээс хойш хуралдаанд бэлтгэх ажиллагааг **30 хоногийн** дотор гүйцэтгэх бөгөөд маргаан эздрэх, төвөгтэй шалтгаанаар дээрх хугацаанд дуусахгүй бол Цэцийн дарга **30 хүртэл хоногоор сунгаж** болно" гэж заасан.

2.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа:

ИХШХШТХ-ийн 71.1-т "Хуулиар өөр хугацаа тогтоогоогүй бол хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 60 хоног, давж заалдах болон хяналтын шатны шүүхээс хэргийг дахин хэлэлцүүлэхээр ирүүлсэн бол шүүгч хэргийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор тус тус шийдвэрлэнэ" гэж заасан.

3. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа:

ЗХХШТХ-ийн 47.1-т "Хуулиар тусгайлан хугацаа тогтоогоогүй бол захиргааны хэргийн шүүх хэрэг үүсгэснээс хойш 60 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ" гэж заасан.

Энэ бол зөвхөн анхан шатны шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх хуульд заасан хугацаа. Гэтэл ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд анхан, давж заалдах, хяналтын шатаар дамжин 1-2 жил болох ч тохиолдол байдаг.

Тэгвэл гадаад орнуудын сонгуулийн хууль тогтоомжийн туршлагаас судалж үзэхэд сонгуулийн холбогдолтой маргааныг аль болох богино хугацаанд шийдвэрлэхийн тулд харьяалал, хугацааны хувьд тусгай журам тогтоож өгсөн байдаг. Тухайлбал, ОХУ, Украйн гэх мэт улсад сонгуулийн холбогдолтой маргааныг шүүх, Үндсэн хуулийн шүүхэд харьяалуулж тэдгээрийн тус тусын процессын хуулийн журмын дагуу шийдвэрлэдэг байна. Гэхдээ ердийн журмаар биш процессын хуулиар 7 хоног, 7-14 хоног гэх мэт богино хугацаа тогтоосон байдаг.

Иймд сонгуультай холбоотой маргааныг хянан шийдвэрлэх хугацааг тус тусын процессын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар тусгайлан зохицуулах нь зүйтэй юм.

Хоёр. Маргааны харьяаллыг тодорхой болгох

Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 2/02 дугаар дүгнэлтэд: "Сонгуулийн ерөнхий хороо хуульд зааснаар ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийг улсын хэмжээнд зохион байгуулах үндсэн чиг үүрэгтэй байгууллага бөгөөд Үндсэн хуульд заасан иргэдийн сонгох, сонгогдох эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар шийдвэр гаргадаг байна. Дэлхийн ардчилсан улсуудын Үндсэн хуулийн заалтаас үзэхэд энэ төрлийн маргааныг Үндсэн хуулийн шүүхтэй улсад Үндсэн хуулийн шүүх, Үндсэн хуулийн шүүхгүй улсад Дээд шүүх нь хянан шийдвэрлэдэг жишиг тогтсон байна. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2-т Сонгуулийн төв байгууллагын шийдвэр Үндсэн хууль зөрчсөн бол Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэхээр заажээ. Гэтэл Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр хуульд нийцээгүй тохиолдолд Захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэж байхаар Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар хуульчилсан нь Үндсэн хуулиар Үндсэн хуулийн цэцэд тусгайлан олгосон эрх хэмжээнд халдсан байна" гэж зааж, "Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн ... 4.1.6,-д "Сонгуулийн ерөнхий хороо" гэж заасан нь Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2-ын ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар Үндсэн хуулийн цэц дүгнэлт гаргах тухай заалтыг ... зөрчсөн байна" гэж дүгнэжээ.

Үндсэн хуулийн цэцийн энэ шийдвэртэй холбоотойгоор ердийн шүүх сонгуулийн холбогдолтой маргааныг хянан шийдвэрлэхгүй нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох, хүлээн авахаас татгалзах тохиолдол түгээмэл байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Гэтэл Үндсэн хуулийн цэц сонгуулийн асуудлаар буюу СЕХ-ны шийдвэртэй холбоотой нэг ч маргаан хянан шийдвэрлэсэгүй байна. Жишээлбэл, УИХ-ын сонгуулийн 24 дүгээр тойрогт МАХН-аас нэр дэвшигч Л.Одончимэд, ИЗН-аас нэр дэвшигч Ц.Ганхуяг, Ардчилсан намаас нэр дэвшигч Р.Бурмаа нар Үндсэн хуулийн цэцэд "... Улсын Их Хурлын сонгуулийн 24 дүгээр тойргийн зарим хэсгийн хороон дээр сонгогчдын нэрсийн жагсаалт үйлдэх, танилцуулах, сонгогч шилжих, сонгогчийн үнэмлэх олгох, санал авах ажиллагааг зохион байгуулах, сонгогч санал өгөх, санал тоолох журмыг удаа дараа зөрчсөн нь сонгуулийн дүнд ноцтой нөлөөлөхүйц байгааг баримтаар мэдээлсэн, дахин хянан тоолохыг шаардсан гомдлуудад тус тойргийн хороо ямар ч хариу өгөөгүй энэ тухай СЕХ-д давж заалдах гомдол гаргасан боловч СЕХ хариу өгөөгүй..." СЕХ-ны 2008 оны 7 дугаар 14-ний өдрийн Ерөнхийлөгчид айлтган УИХ-д танилцуулсан нь ҮХ зөрчсөн эсэх асуудлаар өргөдөл гаргахад ...ҮХЦ-ээс тогтоолдоо "...Монгол Улсын сонгуулийн төв байгууллага болох СЕХ-ны шийдвэр гараагүй, СЕХ-ны үйл ажиллагаатай холбоотой дээрх маргаан нь Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх маргаан биш байна гэж маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзах тухай 2008 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн 90 дүгээр тогтоол

гаргажээ. Яг үүнтэй төсөөтэй утга бүхий маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзсан тогтоол 4 удаа гарчээ.

УДШ-ийн 2008 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 16 дугаар тогтоолоор ҮИХСТХ-ийн зарим зүйл заалтыг тайлбарласан[143].

Энэ тогтоол ёсоор СЕХ хууль зөрчсөн гэх маргааныг захиргааны хэргийн шүүх биш ердийн шүүх гомдлоор авч хэлэлцэх маргааны төрлөөр шийдвэрлэх болсон. Харин ердийн шүүх нь сонгох, сонгогдох эрхтэй холбоотой маргаан байна. Шүүхийн харьяалан шийдвэрлэх маргаан биш учир Үндсэн хуулийн цэцэд ханд гэж нэхэмжлэлийг буцаадаг байна.

Иймд Үндсэн хуулийн маргаан, захиргааны акт болон иргэний хэргийг ялган зааглаж тус бүрийн харьяалалд шилжүүлэх хэрэгтэй байна.

---oOo---

хууль зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

[143] Уг тогтоолын **13.2**-д Мөн зүйлийн 57.5, 19 дүгээр зүйлийн 19.10.-т заасныг гомдлыг шийдвэрлэсэн Сонгуулийн Ерөнхий хорооны шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаарх гомдол, хүсэлтийг Үндсэн хуулийн жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын дагуу Үндсэн хуулийн цэцэд гаргана. Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 2/02 дугаар дүгнэлт Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасан **"Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах"** Монгол Улсын иргэний үндсэн эрхийг хязгаарлахгүй тул Сонгуулийн Ерөнхий хорооны шийдвэр Үндсэн хуулиас бусад хуулийг, Үндсэн хуулиар Монгол Улсын иргэнд олгогдсон сонгох, сонгогдох эрхээс бусад эрхийг зөрчсөн талаарх гомдлыг Сонгуулийн Ерөнхий хорооны оршин байгаа дүүргийн шүүхэд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 14 дүгээр бүлэгт заасан журмын дагуу гаргана. **Мөн тогтоолын 13.3-т** Хуулийн 21 дүгээр зүйлд заасан тойргийн хорооны шийдвэрт тухайн тойргийн хороог харьяалах сум буюу сум дундын, дүүргийн шүүхэд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 14 дүгээр бүлэгт заасан журмын дагуу гомдол гаргана гэжээ.

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД ХИЙСЭН СУДАЛГАА

ОРШИЛ

Энэхүү судалгааг батлагдсан судалгааны ажлын удирдамжид дурдсанаар судалгаанд хамаарах 8 асуудлын хүрээнд удирдамжид заасны дагуу нэгээс хоёр орны хүрээнд хязгаарлалгүйгээр АНУ-ын зарим муж/ Иллинойс, Калифорни/, ХБНГУ, ОХУ, БНХАУ, Бүгд Найрамдах Австри Улс, Болгарын Бүгд Найрамдах Улс, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, Данийн Вант улс, Франц, Украйн, Эстони, Израиль, Чех улсын замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбогдох эрх зүйн зохицуулалтын зарим онцлог зэргийг ерөнхий байдлаар тоймлон авч үзсэн бөгөөд удирдамжид заасны дагуу /1-2 улсын эрх зүйн зохицуулалтыг судлах/ ОХУ, БНХАУ-ын замын хөдөлгөөний аюулгүй байдлыг зохицуулах эрх зүйн зохицуулалтыг түлхүү судалсан болно[144].

1.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах төрийн байгууллагуудын тогтолцоо, уялдаа. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын улсын хяналтыг зохион байгуулдаг байгууллага[145]

ОХУ-ын хувьд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр гүйцэтгэх, мөрдөн шалгах, засан хүмүүжүүлэх, хянан шалгах, зөвшөөрлийн үүргийг Замын хөдөлгөөний эргүүлийн алба[146] хариуцдаг байна. Тус алба нь ОХУ-ын Дотоод явдлын яамны харьяа Замын хөдөлгөөний аюулгүй байдлын улсын хяналтын газрын нэг алба болж, ОХУ-ын нийгмийг аюулаас хамгаалах цагдаагийн бүрэлдэхүүнд багтдаг байна.

Тус байгууллага нь дараах бүрэлдэхүүний хүрээнд үйл ажиллагаа явуулдаг байна. Үүнд:

- Замын хөдөлгөөний эргүүлийн албаны үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах албад;
- Хотын, дүүргийн, бүсийн, захиргаа, нутаг дэвсгэрийн хаалттай байгууламж, онцгой зохицуулалттай бүсүүд зэрэг газарт Замын хөдөлгөөнт эргүүлийн албаны чиг үүргийг хэрэгжүүлэгч албад;
- Замын хөдөлгөөний эргүүлийн албаны жагсаалын албууд.

Замын хөдөлгөөний эргүүлийн алба нь Дотоод явдлын яамны харьяа бусад газрууд, тээврийн хэрэгслийн цэргийн эргүүлийн алба, бусад төрийн байгууллага, хуулийн этгээд, олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажилладаг байна.

---

[144] Энэ судалгааг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2011 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 22 дугаар тушаалын дагуу ХЗДХЯ-аас боловсруулж буй төслийн хүрээнд ЗХЭЗС, ОУЭЗС хамтран хийж гүйцэтгэсэн болно. Судалгааг хийх явцад Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн төслийн хувилбарыг ирүүлэгүй бөгөөд судалгааг ажлын хэсгийн хурлын үеэр яригдсан асуудал, судалгааны удирдамжид заасан асуулгын хүрээнд хийсэн болно.

[145] 1, 2 дугаар судалгааны асуултын хариултыг нэгтгэн бичив.

[146] Приказ МВД РФ от 20.04.1999 г. № 297 "Об утверждении наставления по работе дорожного движения службы Государственной инспекции безопасности дорожного движения МВД РФ"

Замын хөдөлгөөний эргүүлийн албаны гол зорилго нь замын хөдөлгөөнд оролцогчдыг замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрэм, журмыг баримтлах, улмаар амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн хохирлоос урьдчилан сэргийлэх, нийгмийн болон улсын эрх ашгийг хамгаалах, тээврийн хэрэгслийн зохистой хөдөлгөөнийг хангахад оршино. Замын хөдөлгөөний хяналтын үүргээ биелүүлэхдээ техник хэрэгсэл ашигласан видео ажиглалт хийх, зам дээр эргүүлийн албаны цагдаа нар хянах, техник хэрэгсэл ашиглан хурдыг хянадаг байна. Замын хөдөлгөөний эргүүлийн албаны ажилтан нь дараах үүрэгтэй[147] Үүнд:

- Замын хөдөлгөөний аюулгүй байдал болон түгжрэлгүй явцыг хангах;
- Постын орчимд болон эргүүлийн талбай дахь нөхцөл байдлыг хянах;
- Замын хөдөлгөөнд оролцогчдыг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг сахиж байгаа эсэхэд хяналт тавих;
- Зам дээр гарч буй гэмт хэрэг, захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх, арилгах;
- Жолооч нарт зам дээр гарсан ослын байдал, замын эвдрэл, гэмтлийн талаар мэдээлэх;
- Тодорхой үйлдэл, дохио ашиглан замын хөдөлгөөнийг зохицуулах;
- Хуулиар тогтоосон журмын дагуу торгууль оногдуулах зэрэг орно.

ОХУ-ын хувьд "Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хариуцсан хотын зөвлөлийн тухай" Москва хотын даргын 2005 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 435-РМ тоот тушаалаар замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой асуудлыг зохицуулах зөвлөл байгуулагджээ[148]. Тус **Зөвлөл**[149]: нь дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажилладаг. Үүнд:

- ✓ Зам дээр гарч буй ослыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийтэд зориулсан ухуулгын, танин мэдэхүйн шинжтэй арга хэмжээ зохион байгуулах;
- ✓ Замын хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр гарч буй хууль, эрх зүйн актын шинэчлэл, хэрэгжилтэнд хяналт тавих;
- ✓ Зам дээр гарсан ослын талаар нэгдсэн статистик дүн гаргах, зам дээрх зөрчлийг бууруулах бодлого боловсруулах, хэрэгжилтийг хангах;
- ✓ Автотээврийн зөрчил, гэмт хэрэг, замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх жил бүрийн мэдээг ОХУ-ын Засгийн газарт бэлтгэх, танилцуулах;
- ✓ "Замын хөдөлгөөний аюулгүй байдал" сэдэвт Москва хотын сан /фонд/-ыг хөгжүүлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх нийгмийн идэвх зүтгэлийг сайжруулах.

Белорусь Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаар, замын хөдөлгөөн, түүний аюулгүй байдлыг Белорусь Улсын Хууль зүйн яамны харьяа Тээврийн хэрэгслийн улсын

[147] Указ Президента РФ от 15.06.1998 № 711 "О дополнительных мерах по обеспечению безопасности дорожного движения"

[148] Распоряжение мэра Москвы" О городской комиссии по безопасности дорожного движения" 2005.12.30 № 435-РМ http://www.businesspravo.ru/Docum/DocumShow_DocumID_107340.html /сүүлд үзсэн 2011.03.17/

[149] Мөн тэнд.

хяналтын газар хариуцдаг байна[150]. Тус байгууллагын эрх, үүргийг "Белорусь Улсын Дотоод Явдлын яамны Тээврийн хэрэгслийн улсын хяналтын газрын тухай тогтоол"-оор зохицуулжээ. Тус байгууллагын бүрэлдэхүүнд Тээврийн хэрэгслийн улсын газрын удирдлагын газар, Минск хотын гүйцэтгэх хорооны тээврийн хэрэгсэл хяналтын газар, дүүргийн, баг, хорооны, тойргийн гүйцэтгэх хорооны тээврийн хэрэгсэл хяналтын газар, зам засварын тусгай барилгын багууд багтдаг.

АНУ-ын Калифорни мужийн хувьд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлд холбогдох төрийн байгууллагууд болон бусад этгэзд нь нэлээд уялдаатай ажилладаг байна. Жишээ нь: улаан гэрлээр дүрэм зөрчсөн, эсхүл машинаа хориглосон зогсоолд тавьсан зэрэг зөрчлөөс үүдсэн торгууль /хотын захиргаанаас оногдуулсан торгуулийг/, мөн шүүхээс /хотын цагдаагийн хүргүүлсэн баримтыг үндэслэн/ авто замын ослын холбогдох зөрчилд оногдуулсан торгуулийг төлөхгүй хугацаа хэтрүүлбэл тухайн торгууль оногдуулсан байгууллагуудаас нь */DMV Department of motor vehicle/* тухайн мужийн авто тээврийн хэрэгслийг бүртгэдэг байгууллагад нь мэдээлэл очиж, тухайн зөрчил гаргасан этгээдийн жолоодох эрхийг хасах, эсхүл машины улсын бүртгэлийг хүчингүй болгох зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлдэг байна.[151]

Мөн авто машины яндангийн утаанаас гарч байгаа хорт хийн зөвшөөрөгдөх хэмжээг тухайн мужийн хотын захиргаанаас жил бүр шалгаж хэрэв шаардлагад нийцэхгүй тохиолдолд мужийн авто машин эзэмшигчидийг бүртгэдэг байгууллагад */DMV Department of motor vehicle/* мэдээллийг хүргүүлж улмаар уг авто тээврийн хэрэгслийн дугаарын бүртгэлийг хийдэггүй бөгөөд энэ тохиолдолд тухайн тээврийн хэрэгслийг жолоодох эрхгүй болдог байна. Өөрөөр хэлбэл авто тээврийн хэрэгслийн бүртгэлийн газар /DMV/, хотын захиргаа, замын цагдаа зэрэг байгууллагууд нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах төрийн байгууллагууд ба эдгээр хоорондоо нягт уялдаатай ажилладаг байна.

АНУ-ын Калифорни мужийн Авто тээврийн хэрэгслийг бүртгэдэг газар */DMV Department of motor vehicle/* нь дараах чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.[152]

- Авто тээврийн хэрэгслийг бүртгэдэг газарт бүртгэлтэй тээврийн хэрэгсэл эзэмшигчийн гэрчилгээ /эрхийн гэрчилгээ/ олгох;
- Жолооч осол аваар, ял шийтгэлд холбогдсон эсэх талаарх мэдээллийг хадгалах;
- Хувь хүмүүст жолооны үнэмлэх олгох;
- Усан онгоцны эзэмшигчийн тэмдэглэл болон бүртгэл хийх;
- Тээврийн хэрэгслийг үйлдвэрлэгч, тээвэрлэгч, нийлүүлэгч , зуучлагч, тээврийн хэрэгслийг борлуулагч, сэлбэг хэрэгсэл худалдагчийг зохицуулах болон гэрчилгээ олгох;
- Санхүүгийн хариуцлагын хуулийг хэрэгжүүлэх;
- Хэрэглэгчийн гомдолыг шалгах;

[150] Закон об Дорожном движении Республики Бурятия, 2006.01.25 4/22

[151] http://www.cyberdriveillinois.com/publications/rules_of_the_road/rr_chap08.html /сүүлд үзсэн 2011.3.25./

[152] http://www.dmv.ca.gov/about/profile/what_dmv_does.htm/visited 2011.3.25./

- Хуулийн дагуу бүртгэлийг тогтмол шинэчилж хадгалах;
- Жилд ойролцоогоор 6,5 тэрбум ам.доллар цуглуулж улсын орлого болгоно.

2.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг зохицуулсан баримт бичигт эрх зүйн ямар зохицуулалтыг тусгасан вэ?

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг зохицуулсан зарим орны онцлог зохицуулалтаас дор дурдав.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар зохицуулсан тусгайлсан хуультай улсад: Бүгд Найрамдах Австри Улс, Болгарын Бүгд Найрамдах Улс, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, Данийн Вант Улс, Украйн Улс, Эстони Улс багтана[153]. Испани Улсад "Механик тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ба замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай Үндсэн /гол/ хууль" хэмээх хууль үйлчилдэг байна. Болгар, Дани, Испани, Украйн, Финлянд зэрэг улсад замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль нь энэ салбарыг зохицуулж буй ерөнхий хууль юм.[154]

Норвеги улсад "Замын хөдөлгөөний тухай" хуулийн зэрэгцээ 1936 оны 7 дугаар сарын 1-ны өдрийн "Зарим төрөл мэргэжил бүхий этгээдийн үүргийн хязгаарлалтын тухай" хуулиар замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах асуудлыг зохицуулна. Энэхүү хуулиар зарим төрлийн мэргэжил бүхий этгээд, түүний дотор ачаа тээврийн жолоочийг жолоо барихын өмнө 8 цагийн дотор архи, мөн мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх зүйл хэрэглэхийг бүрэн хоригложээ.[155]

Франц Улсын хувьд замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх онцлог зохицуулалтыг агуулсан хуультай байна. Франц Улсад Замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрэм /5 боть/, Замын засвар, үйлчилгээний дүрэм, Замын тэмдэг, тэмдэглэгээний болон дохионы тусгай дүрэм зэрэг эрх зүйн баримт бичиг үйлчилдэг байна.[156]

Францын замын хөдөлгөөний дүрмийн 5 боть хууль тогтоох болон журамлах хэсэгт ангилагдахаас гадна замын хөдөлгөөнтэй холбоотой бүх асуудлыг зохицуулах иж бүрэн хэм хэмжээг зохицуулсан байна.

ХБНГУ-д "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль"-иас гадна "Замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийн тухай хууль", "Замын хөдөлгөөнд оролцохыг зөвшөөрөх тухай хууль" /тус хууль нь жолооны үнэмлэх, хүрээлэн буй орчны бохирдол, тээврийн хэрэгслийн улсын бүртгэл, зөвшөөрөл зэрэг асуудлыг зохицуулдаг/ зэрэг хууль үйлчилдэг.

Швед улсад замын хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр дараах хуулиуд үйлчилдэг байна. Үүнд[157]:

---

[153] Правовое регулирование дорожного движения, его безопасности в зарубежных странах http://www.auto016.ru /сүүлд үзсэн 2011.03.03/

[154] Мөн тэнд.

[155] Мөн тэнд.

[156] Мөн тэнд.

[157] Правовое регулирование дорожного движения, его безопасности в зарубежных странах http://www.auto016.ru /сүүлд үзсэн 2011.03.03/

✓ Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль;

✓ Жолооч бэлтгэх, жолооны үнэмлэх олгох, жолооны үнэмлэх хурааж авах тухай хууль;

✓ Жолооч бэлтгэх авто сургуулийн тухай хууль.

Швед улсад тусгай бие даасан хуулиас гадна: замын хөдөлгөөний журмыг ноцтой зөрчсөн зөрчил /жолооны үнэмлэхгүй буюу согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон/; жолооч бэлтгэх болон жолооны үнэмлэх хураах журам; авто сургуульд хамаарах үндсэн шаардлага; зогсоолын журам зөрчсөний торгууль; тээврийн хэрэгслийг албадан зөөвөрлөх тухай; аюултай ачааг тээвэрлэх; зөвшөөрсөн жинг хэтрүүлсний торгууль гэх зэрэг асуудлыг зохицуулсан дээрх хуулиуд үйлчилнэ.

Эстони улсад тээврийн хэрэгслийн төрөл /нийтийн тээврийн, ачаа тээврийн гэх зэрэг/ болгон хуультай байхаас гадна мөн замын тухай хууль ч бий. Мөн тусгай хуулиудаар: захиргааны эрх зүйн хэм хэмжээ зөрчих; тээврийн хэрэгслийн даатгал; замыг хамгаалах, ашиглах, татвар төлөхөд замын хөдөлгөөнд оролцогчид, замын эзэмшигч, өмчлөгчийн хүлээх хариуцлагыг, мөн түүнчлэн тээврийн хэрэгслийн зогсоолын асуудлыг тусгай хуулиудаар зохицуулдаг байна.

Зарим улс орнууд зөвхөн замын хөдөлгөөний дүрэм батлан гаргахаар хязгаарлана. Гэвч эдгээр нь эрх зүйн нэгдмэл актын агуулга байхгүй. Жишээ нь: замын тэмдэглэгээ хийх болон замын тэмдэг ашиглах журам; тээврийн механик хэрэгслийн тухай хуулийг хэрэглэх /Австри/; автомашин бүртгэх болон тээврийн тооллогын бүртгэлтэй холбоотой, техникийн үзлэг, гэрлэн дохионы зохицуулалт; замын барилга, байгууламжтай холбоотой журам, зам хөндлөн гарах, овор ихтэй болон хүнд даацын автомашины хөдөлгөөнийг зөвшөөрөх процедур /Болгар/; тээврийн механик хэрэгсэл, түүний тоног төхөөрөмжийг бүртгэх, жолооны үнэмлэх олгох болон жолооч бэлтгэх /категори бүрийг тус тусад нь, мөн энд жолооны багшийн хүлээх хариуцлагыг мөн тодорхойлж өгсөн/, мөн түүнчлэн замын тэмдэг болон дохионы тухай акт /Дани/ тус тусдаа үйлчилж байна.

ОХУ болон тусгаар тогтносон улсуудын хамтын нөхөрлөлийн бусад улс оронд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиуд үйлчилж байна.

ОХУ-ын Замын хөдөлгөөнийг зохицуулах зарим хууль, эрх зүйн актуудаас:		
1.	Захиргааны хариуцлагын тухай ОХУ-ын хууль	2001.12.30
2.	ОХУ-ын Эрүүгийн хууль	1996.06.13
3.	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай Холбооны хууль	1995.12.10
4.	Тээврийн хэрэгслийн үнэмлэх хэрэглэх тухай ОХУ-ын Засгийн газрын тогтоол	1993.05.18
5.	ОХУ-ын нутаг дэвсгэр дэх автотээврийн хэрэгсэл болон өөрөө явагч тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн тухай ОХУ-ын Засгийн газрын тогтоол	1994.08.12
6.	ОХУ-д тээврийн хэрэгсэл ашиглах тухай зарим асуудлын тухай ОХУ-ын Засгийн газрын тогтоол	1992.04.08
7.	ОХУ-ын Дотоод хэргийн яамны Замын хөдөлгөөний аюулгүй байдлын улсын хяналтын газарт бүртгүүлсэн тээврийн хэрэгслийн улсын техник үзлэгийг явуулах журмын тухай ОХУ-ын Засгийн газрын тогтоол	1998.07.31
8.	Замын хөдөлгөөний Дүрмийн тухай ОХУ-ын ЗГ-ын тогтоол	1993.10.23
9.	Тусгай гэрлэн болон дохиот тэмдэгийн тухай ОХУ-ын ЗГ-ын тогтоол	2006.12.01
10.	Тээврийн хэрэгслийн хараат бус техник шинжилгээ хийх тухай ОХУ-ын ЗГ-ын тогтоол	2003.04.24
11.	Тээврийн хэрэгсэл эзэмшигчдийн даатгалд хамруулах тухай журам	2003.05.07
12.	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нэмэлт арга хэмжээний тухай ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг	1998.05.16
13.	Тээврийн хэрэгслийн бүртгэлийн тэмдгийг улсын бүртгэлд бүртгэх тухай ОХУ-ын Дотоод хэргийн яамны тушаал	2002.03.28
14	Олон улсын жолооны үнэмлэхний тухай ОХУ-ын Дотоод хэргийн яамны тушаал	1998.09.28

БНХАУ-ын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай эрх зүйн зохицуулалт

БНХАУ өндөр хөгжилтэй гүрний хувьд авто замынхаа хөгжлөөр дэлхийд дээгүүрт ордог. Үүнийг дагаад авто замын хөдөлгөөн зохицуулах, замын хөдөлгөөний аюулгүй байдалд хяналт тавих техник хэрэгсэл нь өндөр хөгжсөн. Замын хөдөлгөөнд тавих хяналтыг замын цагдаа дангаараа бус, ажиглалтын видео камер, фото аппарат зэрэг техник хэрэгслийн тусламжтайгаар гүйцэтгэдэг.

БНХАУ-ын замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай эрх зүйн зохицуулалтыг дараах хууль тогтоомжийн хүрээнд судалсан болно. Үүнд:

1. БНХАУ-ын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль[158]

2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх дүрэм[159]

3. Жолоочийн зөрчлийг тооцох шийтгэлийн онооны арга хэмжээ[160]

4. Авто машин жолоодох үнэмлэх авах ба ашиглах дүрэм[161]

БНХАУ-ын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль

Тус хууль нийт 8 бүлэг, 124 зүйлтэй.

Бүтэц

Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл;

Хоёрдугаар бүлэг. Тээврийн хэрэгсэл ба жолооч;

1/ авто машин, автобус машин;

2/ авто машины жолооч;

Гуравдугаар бүлэг. Замаар зорчих нөхцөл;

Дөрөвдүгээр бүлэг. Замаар зорчих дүрэм;

Энгийн дүрэм;

Автомашин замаар зорчих дүрэм;

Автобус машин замаар зорчих дүрэм;

Явган зорчигч ба тээврийн хэрэгслээр зорчигчийн дүрэм;

Өндөр хурдны замын тусгайлсан дүрэм;

Тавдугаар бүлэг. Замын ослын зохицуулалт;

Зургаадугаар бүлэг. Хуулийн хэрэгжилтийн хяналт;

Долдугаар бүлэг. Хуулийн хариуцлага;

Наймдугаар бүлэг. Хавсралт;

Тус хууль дахь замын хөдөлгөөний аюулгүй байдлын удирдлага, зохицуулалттай холбоотой зүйл, заалтууд:

4 дүгээр зүйл. Шат шатны Ардын засгийн газар замын хөдөлгөөний аюулгүй байдлыг удирдах ажил ба эдийн засгийн бүтээн байгуулалт болон нийгмийн хөгжилд тохируулан зохицуулах явдлыг баталгаажуулна.

Хошуунаас дээш орон нутгийн шат шатны Ардын Засгийн газар замын хөдөлгөөний хөгжлийн хэрэгцээнд тохируулан, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, төрийн холбогдох бодлогыг баримтлан замын хөдөлгөөний аюулгүй байдлыг удирдах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулна.

5 дугаар зүйл. Төрийн зөвлөлийн Аюулгүй байдлын яам улс орон даяар авто замын аюулгүй байдлыг удирдах ажлыг хариуцна. Хошуунаас дээш шат шатны Ардын засгийн газар Аюулгүй байдлын байгууллагын замын хөдөлгөөнийг удирдах газар нь тухайн засаг захиргааны нутаг дэвсгэр доторх авто замын хөдөлгөөнийг удирдан зохицуулах ажлыг хариуцна.

[158] 2003 онд батлагдаж, 2004 оноос мөрдөгдөж байна.

[159] **2004 оны 4 дүгээр сарын 28-нд батлаж, 2004 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон.**

[160] "Жолоочийн зөрчлийг тооцох шийтгэлийн онооны арга хэмжээ"-ний 24 дүгээр зүйлд "орон нутгийн шинжтэй дүрэм журамд заасны дагуу жолоочийн зөрчлийг тооцох шийтгэлийн онооны хэлбэр хэмжээг зөвхөн тухайн орон нутгийн жолоочийн хувьд хэрэглэнэ" гэж зааснаас харахад муж, орон нутаг бүрт нэгэн адил дүрэм үйлчилдэггүй байна.

[161] 2009 оны 12 дугаар сарын 7-ны өдөр батлагдсан.

Тус хууль дахь замын хөдөлгөөний аюулгүй байдлын сургалттай холбоотой зохицуулалт:

6 дугаар зүйл. Шат шатны засаг захиргаа нь замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх сургалтыг тогтмол явуулж, иргэдийн замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай мэдлэгийг дээшлүүлэх үүрэгтэй.

Байгууллага, газар хэлтэс, нэгж, аж ахуйн байгууллага, иргэний нийгмийн нэгдэл болон бусад байгууллага бүр тухайн байгууллагын ажилтан, албан хаагчдад замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар сургалт явуулна.

Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, сургуулиуд замын хөдөлгөөний аюулгүй байдлын сургалтыг эрх зүйн сургалтын агуулгад багтааж явуулна.

Хэвлэл мэдээлэл, радио, телевиз зэрэг холбогдох байгууллага нь замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар сургалт явуулах үүрэгтэй.

7 дугаар зүйл. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг удирдан зохион байгуулах ажилд шинжлэх ухааны судалгааг чиглүүлж, тэргүүний, ололтод удирдлагын арга барил, техник, технологи, тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх, ашиглах **тус хуульд замын цагдаагийн ажил үүрэг, эрх хэмжээний асуудлыг** хуулийн хэрэгжилтэд тавих хяналт гэсэн бүлэгт тодотгож өгсөн бөгөөд тухайлбал тус хуулийн 83 дугаар зүйлд зааснаар дараах тохиолдолд замын цагдаа замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомж зөрчсөн үйлдлийг болон замын ослын хэргийг шалгаж шийдвэрлэхээс татгалзана. Үүнд:

1.Тус хэргийн холбогдогч/зохигч/ эсхүл холбогдогчийн ойрын хамаатан садан

2.Тухайн этгээд, эсхүл түүний ойрын хамаатан садан тухайн хэрэгт ашиг сонирхлын зөрчилтэй

3.Тухайн хэргийн холбогдогч болон бусад харилцаа холбооны шалтгаанаар хэргийг шударгаар шийдвэрлэхэд нөлөөлж болзошгүй

Мөн тус хуулийн 117 дугаар зүйлд "Замын цагдаа албан тушаал, эрх мэдлээ ашиглан нийтийн эд хөрөнгийг эзэмших, олж авах, авлига авах, эсхүл эрх мэдлээ урвуулан ашиглах, хэтрүүлэх байдлаар гэмт хэрэг үйлдсэн бол хуулийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ" гэж хуульчилсан байна.

3.Замын хөдөлгөөний зохион байгуулалт, замын хөдөлгөөний зохицуулалт, Авто зам болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаарх зохицуулалт ямар байдаг? Ямар баримт бичгээр зохицуулсан байдаг.

Зам засварын ажлын тухайд ***ОХУ-ын*** Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиар зохицуулсны дагуу замыг засварлах, шинээр зам тавих, эвдрэлийг арилгах нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангана[162]. Холбооны гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагууд, ОХУ-ын субьект улсын гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага болон хариуцдаг замтай хуулийн этгээд, иргэний хувьд зам засвар, эвдрэл

[162] Федеральный Закон о Безопастности дорожного движения 15 ноября 1995 года /с изменениями от 2010.07.27/ Статья 11, 12.

арилгах ажлыг өөрөө хариуцдаг байна. Ингэхдээ улсаас тогтоосон зам засварын журмыг баримтлах буюу мэргэжлийн магадлан итгэмжлэгдсэн зам засвар, барилгын багийг ажиллуулна[163].

ХБНГУ-ын хувьд замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг зөрчсөн жолоочид торгууль оногдуулдаг байна. Тухайлбал, тогтоосон хэмжээнээс хурд хэтрүүлсэн тохиолдолд цагт 25 км-ээр хэтрүүлсэн бол 200 евро, 30 км-ээр хэтрүүлсэн бол 240 евро, 40 км-ээр хэтрүүлсэн бол 400 еврогоор тус тус торгож, жолооны үнэмлэхийг сарын хугацаатай хураан авдаг байна[164]. 150 евро хүртэлх хэмжээний торгуулийг газар дээр нь замын цагдаагийн байцаагчид торгуулж, түүнээс дээш хэмжээний торгуулийг 7 хоногийн дотор банкны тодорхой дансанд тушаах ёстой. ХБНГУ-ын хувьд "нууцаар" буюу видео ажиглалт ашиглах, хурдны зам дээр хурд хэмжигч төхөөрөмж байрлуулах зэрэг аргыг ашиглаж зөрчлийг тогтоодог. Тус төхөөрөмж /Police Pilot/ нь тогтоосон хурд хэтрүүлэхийг хянахаас гадна, гэрлэн дохионы зөрчил, огцом манёвр хийх зэргийг мэдэрдэг байна.

Украин[165], ***Эстони*** Улсын[166] замын хөдөлгөөний хуулиар "Хүрэлэлэн буй орчны хамгаалалтын хувьд хүлээх үүрэг" хэмээх бүлгийг агуулсан байдаг нь бусад орны зохицуулалтаас онцлог юм. Тус зохицуулалтын дагуу жолооч бусдад болон хүрэлэлэн буй орчинд сөргөөр нөлөөлөх нөхцөл үүсгэх, чанга дуу авиа гаргах, их хэмжээгээр утаа гаргах, амьтан болон шувуу дайрахыг хориглодог. Эстони Улсын Замын хөдөлгөөний Дүрмийн 16 дугаар зүйлд зааснаар, жолооч орон сууцны төвлөрөл ихтэй бүсэд 2 минутаас илүү хугацаагаар тээврийн хэрэгслээ асаалттай байлгахыг хориглодог байна[167]. Мөн гол, мөрөн, горхи, усны эргээс 10 м ойр зайд тээврийн хэрэгслээ угаах, зориулалтын бус газар тос, масло солих, хүрэлэлэн буй орчныг бохирдуулах зүйл гоожиж байгаа тээврийн хэрэгсэл жолоодохыг хориглоно. Тээврийн хэрэгслийн гаргах дуу авианы чанга, цацаж буй утааны хэмжээг Эстони Улсын Байгаль хамгаалал, хүрэлэлэн буй орчны Сайдын тушаалын 5 дугаар зүйлээр тогтоодог ба тогтоосон хэмжээг зөрчвөл захиргааны хариуцлага хүлээлгэдэг байна.

4.Олон нийтэд замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх сургалтыг ямар байдлаар олгодог

ОХУ-ын Дотоод явдлын яамны харьяа Замын хөдөлгөөний аюулгүй байдлын улсын хяналтын газрын эрх зүйн байдлын тухай ОХУ-ын Ерөнхийлөгчийн 1998 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 711 тоот зарлиг, ОХУ-ын Дотоод явдлын яамны 2003 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн №930 тоот "ОХУ-ын Дотоод явдлын яамны Замын хөдөлгөөний аюулгүй байдлын улсын хяналтын газрын замын хөдөлгөөний аюулгүй байдлын

[163] Мөн тэнд, статья 13.

[164] ПДД в Германии http://pdd-ru.info/701.php /сүүлд үзсэн 2011.03.17/

[165] Правила Дорожного движения Украйны http://auto.meta.ua/autolaw/pdd_rus/ /сүүлд үзсэн 2011.03.17/

[166] Правила Дорожного движения Республики Эстония http://pdd-ru.info/445.php /сүүлд үзсэн 2011.03.17/

[167] Мөн тэнд. 16 дугаар зүйл.

талаарх ухуулгын ажил зохион байгуулах тухай" тушаалын дагуу ОХУ-ын хувьд замын хөдөлгөөний аюулгүй байдал, замын хөдөлгөөнд оролцож буй явган зорчигч, тээврийн хэрэгсэл жолоодогчийн эрх, үүрэг, зам дээр гарч буй ослын талаар олон нийтэд мэдээлэх үүргийг ОХУ-ын Дотоод явдлын яамны харьяа Замын хөдөлгөөний аюулгүй байдлын улсын хяналтын газар /ГИБДД/ хариуцдаг байна. Өөрийн чиг үүргийн хүрээнд тус байгууллага нь ард иргэдийн дунд замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар, зам дээр гарч буй осол, замын хөдөлгөөнд боловсон, зохистой оролцох, насанд хүрээгүй этгээдийн замын хөдөлгөөнд оролцох, жолоочийн хариуцлагын талаар тус тус сургалт, видео хичээл, материал, зар сурталчилгаа хэлбэрээр ухуулга явуулдаг байна.

Тус тушаал нь замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх ухуулгын арга хэмжээ явуулахад баримтлах журмыг хавсралтаар батлсан бөгөөд тус ухуулгын арга хэмжээг зохион байгуулахдаа дараах зарчмыг баримтлана. Үүнд:

1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын улсын хяналтын газар нь олон нийтийн дунд замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх ухуулгын ажил явуулах ажиллагаа нь тус байгууллагын хотын замын хөдөлгөөний аюулгүй бүх албадуудад хамааралтай арга хэмжээ байна;

2.Ухуулгын ажлыг зохион байгуулахдаа тус байгууллага нь ОХУ-ын Үндсэн хууль, замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой бусад эрх зүйн актуудыг мөрдлөг болгоно.

3.Ухуулгын арга хэмжээний гол зорилго нь замын хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр мөрдөгдөж буй хууль, дүрэм, журмыг олон нийтэд бүрэн дүүрэн, зөв зохистой таниулахад оршино.

4.Ухуулгын ажлын субъектэд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын улсын хяналтын газар, түүний бүрэлдэхүүнд багтаж буй албууд, олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, автотээврийн газар, замын хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг олон нийтийн байгууллагууд, боловсролын байгууллагууд орно.

Судалгааны ажлын асуултын дагуу тус журамд гарч буй олон нийтэд явуулах ухуулгын арга хэмжээний төрлийн хүрээнд авч үзвэл:

✓ Олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд замын хөдөлгөөний аюулгүй байдлын тулгамдсан асуудал, осол гарч буй нөхцөл байдал, шалтгаан, эрх зүйн шинэ зохицуулалтын талаар мэдээлэх;

✓ Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг дэмжсэн уриатай олон нийтийн гүйлт, автомашины уралдаан, тэмцээн, нээлттэй хаалганы өдөр зэрэг арга хэмжээг тогтмол зохион байгуулах;

✓ Замын хөдөлгөөний аюулгүй байдлын сэдэвтэй зурагт хуудас, танилцуулга, брошюр, плакат бэлтгэх, хэвлүүлэх, мэдээллийн самбар байрлуулах;

✓ Галт тэрэгний буудал, нисэх онгоцны буудал, нийтийн тээврийн хэрэгсэл, худалдааны томоохон төвүүд зэрэг олон нийтийн нягтралын

газруудад техникийн хэрэгсэл ашиглан замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх мэдээллийг нэвтрүүлэх;

✓ Насанд хүрээгүй этгэздийн замын хөдөлгөөнд оролцох, тэдгээрийн ослын талаар боловсролын байгууллагатай хамтран ажиллах. Тухайлбал, бага, дунд сургуулийн хүрээнд хүүхдэд зориулсан хичээл зохион байгуулах, сургуулийн бүсэд буй тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хянах, сургуулийн гадна тодорхой бүсийн замын хөдөлгөөний схемийг байрлуулах, замд хурдны хязгаарлалт тогтоох зэрэг арга хэмжээнүүд орно.

ОХУ-ын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын улсын хяналтын газрын боловсруулсан зарим видео материалын уриалгыг танилцуулахад:

1."УУСАН БОЛ БҮҮ ЖОЛООД!" ТӨСӨЛ[168]:

Зорилго:

ОХУ-ын хувьд согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох үед гарч буй ослын дийлэнх хувь нь баярын үеэр таардаг болох нь тогтоогджээ. Тус арга хэмжээг баярын үе болох 2009 оны 12 дугаар сар, 2010 оны 1 дүгээр саруудад явуулахаар төлөвлөсөн байна.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ:

1.12 метрийн өндөртэй, ослын улмаас эвдэрсэн машинаар дүүргэсэн архины шилний дүрс бүхий хөшөөг Москва хотын замын хөдөлгөөний оргил цэгт байршуулжээ. Энэ үеэр Москва хотод замын хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр олон улсын хэмжээний хурал зохион байгуулагдаж байсан бөгөөд гадаад улсын сэтгүүлчид тэрхүү хөшөөг өөрийн улсдаа нэвтрүүлснээр ОХУ төдийгүй гадаадын олон оронд танигджээ.

2."Уусан бол бүү жолоод" уриа бүхий мэдээллийн самбар ОХУ-ын томоохон хотуудын төвд, зурагт хуудсууд орон даяар тараагдсан ба хотын дийлэнх гражийн үүдэн дээр уриа бүхий графикт байршуулсан байна.

3.Авто радиогоор согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох үед үүсэх нөхцөл, ослын талаарх мэдээллийг өдөр тутам сонсогчдод мэдээлсэн төдийгүй телевизээр болон кино театрт кино эхлэхийн өмнө зар сурталчилгааны дундуур видео материал нэвтрүүлж байв. Видео материалын агуулгыг товч тайлбарлахад, энгийн нэгэн гэр бүлийн уулзалтын үеэр гэр бүлийн тэргүүн дарс бага зэрэг уусан бөгөөд хоёр хүүхдийн хамт гарч явахдаа аймшигт осолд орох тухай өгүүлнэ.

Гарсан үр дүн:

Тус төслийн талаар ОХУ-ын нутаг дэвсгэр дээр төдийгүй дэлхий олон орны хүрээнд авч хэлэлцэх болсон бөгөөд интернетэд нийт 74 сая хүн тус арга хэмжээний талаар мэдээлэл солилцож, саналаа үлдээжээ.

Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсоны улмаас нас барсан хүний тоо өнгөрсөн онуудтай харьцуулахад 2009 оны 12 сард 28 хувиар, 2010 оны 1 дүгээр сард 48 хувиар тус тус буурчээ.

[168] Кампания «Выпил – не заводись!» http://www.gibdd.ru/video/1/ /сүүлд үзсэн 2011.03.16/

"АЮУЛГҮЙ ХӨДӨЛГӨӨН" ТӨСӨЛ[169]:

Зорилго:

Зам дээр гарч буй ослын дийлэнх хувийг эзэлдэг зөрчлүүдийг таван дэд сэдэв болгон хуваах төслийг хэрэгжүүлсэн болно. Энэхүү 5 төрлийн зөрчлийг арилгаснаар зам дээр гарч буй ослын хэмжээ буурах гол нөхцөлийг бүрдүүлнэ хэмээн үзсэн байна.

Хэрэгжүүлж буй арга хэмжээ:

Дээр хэлснээр төслийг 5 дэд сэдэвт хуваасан болно. Үүнд:

- "Хурдаа сааруул" /хурд хэтрүүлэх талаар/
- "Биднийг битгий алдаач" /бага насны хүүхдэд зам дээр тохиолдож буй ослын талаар/
- "Согтуу хүнийг зогсоо" /согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох гэж буй хүнийг таслан зогсоох талаар/
- "Хүнлэг бай" /замын хөдөлгөөнд оролцогчдын ёс зүй, зан харилцааны талаар/.
- "Бүсээ бүсэл" /нийт жолооч нарыг тээврийн хэрэгсэл жолоодохдоо аюулгүй бүсээ бүслэх талаар сурталчилсан/.

"Хурдаа сааруул" /хурд хэтрүүлэх талаар/-Энэ ажлын хүрээнд видео материал бэлтгэж олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлсэн байна. "Хурдаа сааруул чамайг хүлээж л байх болно" хэмээх уриатай тус видеоны утгыг тайлбарлавал, бага насны хүүхэд цонхны дэргэд аавыгаа хүлээж байхад, аав нь өндөр хурдтай машин жолоодож явж байгаад машины осолд орж байгаа талаар өгүүлнэ.

Мөн энэ ажлын хүрээнд сахиусан тэнгэрийн далавчтай охид гудамжаар явж "Цагаасаа өмнө тэнгэр лүү нисэхийг хүсэхгүй бол хурдаа хас" гэсэн зөвлөгөө өгч, далавчтай наалт тарааж байв. Уг наалтад "Явах заяатай хүн нисэх заяагүй" гэсэн бичиг байв.

"Биднийг битгий алдаач" /бага насны хүүхдэд зам дээр тохиолдож буй ослын талаар/ - Эцэг, эхчүүдийн дунд бага насны хүүхдээ хараа хяналтгүй орхиж болохгүй, замын ойролцоо талбайд тоглуулахгүй байх талаар сурталчилгаа явуулжээ. Мөн улс даяар дунд сургуулийн хүүхдүүдийн дунд "Анхааралтай яваарай-БИД" гэсэн сэдэвт тэмцээн зарлан явуулсан байна.

"Согтуу хүнийг зогсоо" /согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох гэж буй хүнийг таслан зогсоох талаар/ - энэ ажлын хүрээнд өөрийн ойр дотны, хайртай хүмүүсээ алдахыг хүсэхгүй байгаа бол согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохыг хориглохыг уриалсан сурталчилгаа явуулсан байна. Мөн бүрсгэр дүрслэлтэй хуванцар, нэг удаагийн нүдний шил жолооч нарт тарааж, согтуугаар жолоодоход харах байдал нь тэрхүү нүдний шилийг зүүхтэй ижил мэдрэмж төрүүлэх талаар тайлбарлаж өгөв.

"*Хүнлэг бай"* /замын хөдөлгөөнд оролцогч нарын ёс зүй, зан харилцааны талаар/ - ОХУ-ын зар сурталчилгааны зах зээлийн нийт 6 хувийг тээврийн хэрэгслийн борлуулалтын зар эзэлдэг байна. Гэтэл жолоочийн харилцаа, ёс суртахууны талаар мэдээлэл хомс байдаг. Энэ үүднээс тус төслийн хүрээнд жолоочийг замын хөдөлгөөнд ёс суртахуунтай, эелдэг, хүнлэг оролцохыг

[169] О проекте "Движение без опасности" http://www.gibdd.ru/video/ /сүүлд үзсэн 2011.03.16/

уриалсан сурталчилгаа явуулсан байна. Мөн "гахайн" дүрстэй, "Хүн хэвээрээ бай" гэсэн бичигтэй машинд тавьдаг агааржуулагчийг тараасан байна.

"Бүсээ бүсэл" /нийт жолооч нарыг тээврийн хэрэгсэл жолоодохдоо аюулгүй бүсээ бүслэх талаар сурталчилсан/- тээврийн хэрэгсэл жолоодохдоо аюулгүйн бүсээ байнга бүслэх талаар сурталчилгааны ажил явуулж, "өглөө гэрээсээ гарахдаа охиноо үнсээд 5 давхар цонхноосоо үсэрч байгаа" гэсэн утгатай реклам нь /аюулгүйн бүсгүйгээр 50 км хурдтай тээврийн хэрэгсэл жолоодох нь/ 5 давхар орон сууцнаас үсэрч амиа хорлохтой адил гэдгийг үзүүлжээ.

Гарсан үр дүн:

"Аюулгүй хөдөлгөөн" төсөл нь нийт ОХУ-ын нутаг дэвсгэр дээр өргөнөөр хэлэлцэгдэж, телевизийн нэвтрүүлэг, мэдээ, интернетийн блогоор маш өргөн хүрээнд хэлэлцэгдсэн сэдэв болсон юм. Төслийн үр дүнд тээврийн хэрэгслийн ослын улмаас нас барагсдын тоо 10 хувиар буурсан нь 3 000 хүний амь насыг авч үлдсэн гэж хэлж болно.

Жолооны эрхийн шалгалт

АНУ-ын Иллонис мужийн хувьд жолооны шалгалт нь жолоодох ур чадварыг шалгах явдал юм. Тээврийн хэрэгсэл нь зөвшөөрөгдсөн тоног төхөөрөмжийн хувьд бүрэн бүтэн аюулгүйн ажиллагааг сайн хангасан байх ёстой. Хэрвээ тээврийн хэрэгсэл Иллиноис мужид бүртгэгдсэн бол хүчин төгөлдөр гэрчилгээг Иллиноис мужийн хуулийн дагуу ил харагдах газарт наасан байх ёстой. Хэрвээ тээврийн хэрэгсэл Иллиноис мужаас гадна бүртгэгдсэн бол тухайн мужийн хуулийн шаардлагын дагуу бүртгүүлнэ. Тухайн тээврийн хэрэгсэл нь хөнгөлөлт эдэлдэггүй бол Иллиноис мужийн албан ёсны даатгалын хуулийг заавал биелүүлэх ёстой. Жолооны албаны хэлтэст тээврийн хэрэгсэл даатгагдсан гэдгийг батлан харуулахыг шаардаг. Шалгалт өгч байхдаа замын хөдөлгөөний хууль зөрчих эсхүл аюултай үйлдэл хийвэл шууд шалгалтанд унах зохицуулалттай байна.[170]

5.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагын хэм хэмжээний ямар төрөл байдаг, хариуцлагыг хэрхэн хүлээлгэдэг? Торгуулийг бэлэн бус хэлбэрээр ногдуулж байгаа зохицуулалт? Манай улсад нэвтрүүлэх боломжтой эсэх? [171]

ОХУ-ын замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 31 дүгээр зүйлд зааснаар, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг зөрчсөн тээврийн хэрэгсэл жолоодогч нь хуульд заасан журмын дагуу сахилгын, захиргааны, эрүүгийн болон бусад төрлийн хариуцлага хүлээнэ[172].

ХБНГУ-ын Замын хөдөлгөөний дүрмийн дагуу замын цагдаа ямар ч тохиолдолд бичиг баримтаа шалгуулахыг жолоочоос шаардах эрхтэй ба энэ тохиолдолд бичиг баримт шалгах болсон шалтгаанаа тайлбарлах үүрэг

[170] http://www.cyberdriveillinois.com/publications/rules_of_the_road/rrtoc.html /visited 2011.3.28/

[171] 6,7 дугаар асуултын хариултыг нэгтгэв.

[172] Федеральный Закон о Безопастности дорожного движения 15 ноября 1995 года /с изменениями от 2010.07.27/ Статья 31.

хүлээнэ. Энэ тохиолдолд жолооч Fuhrerschein буюу жолооны үнэмлэх, Kraftfahrzeugschein буюу тээврийн хэрэгслийн гэрчилгээг шалгуулах үүрэг хүлээнэ. Замын цагдаагийн тус үйлдэл нь тухайн жолоочийн эрхийг зөрчиж байгаа хэмээн үзвэл тухайн жолооч дээд шатны байгууллага болох прокурорын газар /Staatsanwaltschaft/ хандах эрхтэй.

Торгуулийг торгууль оногдуулах тухай баримтанд заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд хугацаандаа төлөөгүй тул алданги тооцож, торгуулийн хэмжээ ихсэх талаар Mahnung буюу сануулга өгнө[173].

ХБНГУ-д Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн этгээдэд мөнгөн торгууль ногдуулахаас гадна жолоодох эрхийг нь хураах хүртэл арга хэмжээ авна. 150 хүртэл еврогийн торгуулийг газар дээр нь төлөх ба үүнээс их торгуулийг 7 хоногийн дотор банкинд тушаасан байх ёстой гэнэ. Торгуулийн төлбөрийг заасан хугацаанд нь барагдуулаагүй тохиолдолд төлбөрийн хэмжээ хоног тутамд нэмэгдэнэ. Үүнээс гадна хүнд гэмт хэрэг буюу ноцтой зөрчил гаргасан жолоочид торгуулийн оноо тооцох бөгөөд уг оноог Германы умард хэсэгт орших Фленсбург хотын төв банкинд /үүнийг "зөрчигсдийг бүртгэх компьютер"-«Flensburger Verkehrssunder-Datei» гэж нэрлэнэ/ бүртгэдэг байна. Жолоочийн торгуулийн оноо тогтоосон хязгаараас давсан тохиолдолд түүний тээврийн хэрэгсэл жолоодох эрх цуцлагдаж, түр хугацаагаар эрх хасах шийтгэл ногдуулна.

Герман Улсад Замын хөдөлгөөний дүрмийн зөрчил гаргасдад хариуцлага тооцох механизм их боловсронгуйд тооцогддог. Зөрчлийн төрөл болон тэдгээрт ногдуулах шийтгэлийн арга хэлбэрийг «Торгуулийн цэс /Bussgeldkatalog/» хэмээх баримт бичигт нэг бүрчлэн тоочсон байх бөгөөд санаанд оромгүй зөрчлийг ч нарийвчлан жагсаасан байдаг. Замын цагдаа нар зөрчил илрүүлэхдээ мэргэшсэн бөгөөд хөдөлшгүй баримт нотолгоон дээр тулгуурладаг. Хотын төвийн болон гаднах замуудад, ялангуяа гэрлэн дохионуудын дэргэд байрлуулсан хяналтын автомат фото аппаратууд нь жолоочийн хурд хэтрүүлсэн, хөдөлгөөний чигээ огцом өөрчилсөн, хориглосон дохиогоор нэвтэрсэн зэрэг зохисгүй үйлдлүүдийг тэр даруй фото хальснаа баримтжуулж цагдаагийн хөдөлгөөнт эргүүлүүдэд шуурхай мэдээлдэг. Хэтрүүлсэн хурдны хэмжээг алсын зайнаас мэдрэгч төхөөрөмжүүд өндөр нарийвчлалтайгаар тогтоох зэргээр өндөр хөгжсөн техник, тоног төхөөрөмжийн тусламжтайгаар зөрчлийг илрүүлдэг байна.

Зөрчил гаргасдад хүлээлгэх хариуцлагыг хэрхэн тооцдогийг дараах жишээнээс харж болно. Үүнд:

Суурин газарт тээврийн хэрэгслийн тогтоосон хурдыг дор дурдсан хэмжээгээр хэтрүүлбэл дараах шийтгэлийг ногдуулна:

- цагт 10 хүртэл км-ээр хэтрүүлбэл 15 евро;
- цагт 11-15 км-ээр хэтрүүлбэл 25 евро;
- цагт 16-20 км-ээр хэтрүүлбэл 35 евро;
- цагт 21-25 км-ээр хэтрүүлбэл 50 евро + торгуулийн 1 оноо;
- цагт 26-30 км-ээр хэтрүүлбэл 60 евро + торгуулийн 3 оноо;
- цагт 31-40 км-ээр хэтрүүлбэл 100 евро + торгуулийн 3 оноо + 1 сараар эрх хасах;

[173] Мөн тэнд.

- цагт 41-50 км-ээр хэтрүүлбэл 125 евро + торгуулийн 4 оноо + 1 сараар эрх хасах;
- цагт 51-60 км-ээр хэтрүүлбэл 175 евро + торгуулийн 4 оноо + 2 сараар эрх хасах;
- цагт 61-70 км-ээр хэтрүүлбэл 300 евро + торгуулийн 4 оноо + 3 сараар эрх хасах;
- цагт 70 км-ээс дээш хэтрүүлбэл 425 евро + торгуулийн 4 оноо + 3 сараар эрх хасах.

Суурин газрын гаднах замд тээврийн хэрэгслийн тогтоосон хурдыг дор дурдсан хэмжээгээр хэтрүүлбэл дараах шийтгэлийг ногдуулна:

- цагт 10 хүртэл км-ээр хэтрүүлбэл 10 евро;
- цагт 11-15 км-ээр хэтрүүлбэл 20 евро;
- цагт 16-20 км-ээр хэтрүүлбэл 30 евро;
- цагт 21-25 км-ээр хэтрүүлбэл 40 евро + торгуулийн 1 оноо;
- цагт 26-30 км-ээр хэтрүүлбэл 50 евро + торгуулийн 3 оноо;
- цагт 31-40 км-ээр хэтрүүлбэл 75 евро + торгуулийн 3 оноо;
- цагт 41-50 км-ээр хэтрүүлбэл 100 евро + торгуулийн 3 оноо + 1 сараар эрх хасах;
- цагт 51-60 км-ээр хэтрүүлбэл 150 евро + торгуулийн 4 оноо + 1 сараар эрх хасах;
- цагт 61-70 км-ээр хэтрүүлбэл 275 евро + торгуулийн 4 оноо + 2 сараар эрх хасах;
- цагт 70 км-ээс дээш хэтрүүлбэл 375 евро + торгуулийн 4 оноо + 3 сараар эрх хасах.

АНУ-ын хувьд видео ажиглалтын аргаар аливаа төрлийн зөрчлийг илрүүлдэг бөгөөд зөрчил гаргасан этгээд тун удахгүй өөрийн гаргасан зөрчил, торгуулийн хэмжээ, төлөх банкны мэдээллийг шуудангаар хүлээн авах болно[174]. АНУ-ын хувьд зам нь "нээлттэй ном" гэж нэрлэдэг. Учир нь тус улсын хувьд замын хөдөлгөөний дүрмийг замын хажууд зургаар тайлбарласан байдаг ба тус тайлбар нь гадаадын иргэд ч ойлгох боломжтой байдгаараа давуу талтай. Энэ тохиолдолд замын хажуугийн тэмдэглэгээгээ анхааралтай харж явбал дүрмийн зөрчил гаргахгүй байх боломжтой юм.

Торгуулийг бэлнээр эсхүл чекээр буюу онлайнаар төлж болдог байна. Торгуулийг зөрчлөөс хамааран өөр өөр субьектүүд ногдуулдаг байна. Жишээ нь: АНУ-ын Калифорни мужид л гэхэд хотын захиргааны авто тээврийн хэрэгслийг зам дээр буруу тавьсан тохиолдолд зөрчлөөс нь хамааран 50-1804 доллараар торгодог. Мөн хурд хэтрүүлсэн нөхцөлд замын цагдаа торгууль оногдуулдаг. Харин тухайн зөрчилд торгуулиас өөр шийтгэл оногдуулахаар бол түүнийг шүүхэд шилжүүлдэг бөгөөд жолоодох эрхийн үнэмлэхийг хураан авдаг байна. Харин улаан гэрлэн дохион журам зөрчсөн нөхцөлд камераар зөрчил гаргасан тохиолдлыг бичиж шуудангийн хаягаар торгуулийг хотын захиргаа хүргүүлдэг байна. Торгуулийн шийтгэвэрт гомдол гаргах эрхтэй байдаг байна.

[174] ПДД США http://pdd-ru.info/701.php /сүүлд үзсэн 2011.03.17/

АНУ-ын Иллиноис мужийн Замын хөдөлгөөний дүрэм /2010 он/[175]-д зааснаар жолоодох эрх олгохоос татгалзах, жолоодох эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох мөн дээр дурдсанаар торгох зэрэг шийтгэлийг оногдуулж байна. Эдгээрээс жолоодох эрхийг ямар тохиолдолд хүчингүй болгодог зохицуулалтыг авч үзвэл:[176]

Хүчингүй болгох гэдэг нь тодорхойгүй хугацаагаар жолооны эрхийг мужийн захирагчийн албанаас хасахыг хэлдэг. Жолооны эрхээ дахин авахаар хуульд өөрөөр заагаагүй бол доод тал нь 1 жилийн дараа дахин хандаж болно.

Доорх зөрчлүүд жолооны эрхийг хүчингүй болгоно. Харин хязгаарлахгүй

- Анхаарал болгоомжгүйгээр хүн алах- Болгоомжгүйгээр жолоодсоны улмаас хүний амь нас хохироох /доод тал нь 2 жилийн хугацаатайгаар хүчингүй болгоно./
- Согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэсэн үедээ жолоо барих

а. Согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэсэн үедээ жолоо барьж хүний эрүүл мэндэд хохирол учруулах эсхүл хүний амь нас хохироох;

б. Болгоомжгүйгээр хүний амь нас хохироох ял шийтгэл өмнө нь авч байсан эсхүл хүндрүүлэх нөхцөлтэйгээр согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэсэн үедээ жолоо барьж хүний амь нас хохироох;

в. 3 дахь удаагаа согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэсэн үедээ жолоо барьсан үүний улмаас ял шийтгэгдэж байсан;

г. тээврийн хэрэгслийн даатгалгүй эсхүл хүчин төгөлдөр жолоодох эрхийн зөвшөөрөлгүйгээр согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэсэн үедээ жолоо барих;

д. хүүхэд сургуулийн автобусаар тээвэрлэж байхдаа согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэж жолоо барьсан гэмт хэрэг үйлдсэн;

е. тухайн гэмт хэргийн төрөл болон өмнөх түүхээс хамаарч хамгийн богино хугацаагаар хүчингүй болгох шийтгэл оногдуулахгүйгээр ял шийтгэл хүлээлгэдэг.

- "Согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэсэн үедээ жолоо барих"[177]

а. Мансууруулах бодис болон хар тамхи, архи хэрэглэн жолоо барих.

б. 21 нас хүрээгүй хүн анх удаа энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд доод тал нь 2 жилийн хугацаатайгаар хүчингүй болгох шийтгэл

---

[175] http://www.cyberdriveillinois.com/publications/rules_of_the_road/rrtoc.html /visited 2011.3.28/

[176] Мөнд тэнд

[177] **driving under influence** "Согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэсэн үедээ жолоо барих гэсэн утгатай". Орчуулсан ХЗҮХ-ийн ЭША Л. Амаржаргал

"Согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэсэн үедээ жолоо барих" бол хүнд гэмт хэргийн нэг төрөл бөгөөд Иллиноис муж хуч хэрэглэсэн гэмт хэрэг гэж ангилсан. Энэ төрлийн гэмт хэрэг хийсэн тохиолдолд жолооны бүртгэлд тэмдэглэн үлдэнэ. Хэрвээ баривчлагдсан эсвэл шийтгэгдсэн бол жолоодох эрх болон тээврийн хэрэгслийн бүртгэлээ алдаж магадгүй мөн торгуулах юмуу шоронд сууна. Дахин баривчлагдах эсвэл ял шийтгүүлэх юм бол хүнд шийтгэл ногдуулдаг.

ногдуулна. Өмнөх түүхээс нь хамаарч хамгийн богино хугацаатайгаар хүчингүй болгон өөрчилж болно.

- Хүнд гэмт хэрэг /хүнд гэмт хэрэг үйлдэхдээ тээврийн хэрэгсэл ашигласан нөхцөлд/;
- Хэрэг явдал болсон газрыг орхих авто тээврийн ослын улмаас хүн нас барсан эсхүл гэмтсэн тохиолдолд орхиж явах;
- Хуурамч мэдүүлэг өгөх-буруу ташаа мэдээлэл төрийн байгууллагад өгөх;
- Болгоомжгүйгээр жолоодох-12 сарын дотор 3 удаа болгоомжгүйгээр жолоо барьсан гэсэн шийтгэл авсан, эсхүл тийм байдалтай жолоодсоны улмаас хүний биед хүнд гэмтэл учирсан, тахир дутуу болсон, бусад хүнийг зэрэмдэг болгосон.
- Хүндрүүлсэн байдлаар болгоомжгүй жолоо барих- Болгоомжгүйгээр жолоо барьсаны улмаас хүний биед хүнд гэмтэл учруулж, тахир дутуу болгосон, бусад хүнийг зэрэмдэг болгох.
- Гудамжинд уралдах- Бусад тээврийн хэрэгсэлтэй хууль бусаар уралдах
- Болгоомжгүйгээр харьцах-Болгоомжгүйгээр тээврийн хэрэгсэл жолоодож бусдын биед гэмтэл учруулах эсхүл аюултай байдалд оруулах
- Авто хулгай- Тээврийн хэрэгсэл болон тээврийн хэрэгслийн эд ангийг хулгайлах
- Цагдаагаас зугтах- Цагдаа "зогс" гэж дохиход зугтаах

Финлянд улсын хувьд замын осол, зөрчил багаараа дэлхийд тэргүүлдэг улс юм[178]. Финлянд Улсын хувьд видео ажиглалтын тоног төхөөрөмжийг маш өргөнөөр хэрэглэдэг нь зөрчлийг таслан зогсоох гол арга байдаг. Финляндын хувьд торгуулийн хэмжээ маш өндөр байдаг ба тус улсын жолооч нар замын хөдөлгөөний дүрэм баримтлах байдал, жолоочийн ёс зүй, харилцаагаараа бусад улсаас огцом ялгардаг байна[179].

Гадаадын дийлэнх улс орнууд жолоочид материаллаг хариуцлага ногдуулах бодлогыг баримталдаг. Энэ нь зөвхөн их хэмжээний торгууль бус, мөн тээврийн хэрэгслийг хурааж авах, жолооны үнэмлэх хүчингүй болгох, тээврийн хэрэгслийн зайлшгүй даатгалын хэмжээг ихэсгэх зэрэг арга хэмжээнүүд юм.

Тухайлбал: ХБНГУ-д зөрчил гаргасан жолооч тодорхой торгуулийн оноо цуглуулах ба онооны өсөлтөөс түүний даатгалд төлөх дүнгийн хэмжээ 1000 евро хүртэлх хэмжээгээр өсөх болдог. 3000-4000 еврогийн дундаж цалинтай германы иргэний хувьд энэ нь өндөр төлбөр бөгөөд зарим жолооч нар зөрчил гаргасны хариуд даатгалын төлбөрөө төлөх хүртэл тээврийн хэрэгслээ жолоодохгүй явганаар явах тохиолдол гардаг байна. Мөн энэ жишиг АНУ-д хэрэглэдэг. Гадаадын зарим оронд замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрмийг зөрчсөн тохиолдолд торгуулийн хэмжээг ногдуулахдаа дараах үзүүлэлтийг харгалзаж ногдуулах бодлого баримталж байна. Тухайлбал, торгуулийн хэмжээ оногдуулахдаа дараах үзүүлэлтийг харгалзан үзнэ. Үүнд:

[178] Информация по ПДД и вождению автомобиля в Финляндии http://pdd-ru.info/701.php / сүүлд үзсэн 2011.03.17/

[179] Мөн тэнд.

1.Зөрчил гаргагчийн сарын орлогын хэмжээ /татварыг хассан дүнгээр/, 2. Зөрчил гаргагчийн жилийн орлогын хэмжээг тус тус харгалзаж үзэх болсон байна[180].

Франц, Герман, Итали, Испани зэрэг улсын хувьд торгуулийн системтэй онооны системийг ***хослуулан*** хэрэглэдэг бөгөөд энэхүү зохицуулалт нь гадаадын иргэнд мөн ижил хүчинтэй үйлчилдэг байна. Одоогийн байдлаар АНУ, Белорусь, Герман зэрэг улсад тээврийн хэрэгсэл жолоодох үед тамхи татаж болохгүй талаарх зохицуулалт бүхий хууль бэлтгэгдэж, яригдаж байгаа бөгөөд Австралийн хувьд машинд 12 наснаас доош насны хүүхэд байгаа тохиолдолд тээврийн хэрэгсэлд тамхи татахыг хориглодог байна. Их Британийн Засгийн газраас олон нийтийн шаардлагаар нойрмог байдалтай тээврийн хэрэгсэл жолоодохыг хориглох тухай зохицуулалт Замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрэмд оруулжээ[181].

Израиль Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрэм бусад орноос огцом ялгардаггүй байна. Зарим нэг онцлог талуудыг дурдвал, тус улсын хувьд тээврийн хэрэгслийг заавал хоёр гараараа жолоодох үүрэгтэй, тээврийн хэрэгслийн урд сууж байгаа болон хойно сууж байгаа бүх зорчигчид заавал аюулгүйн бүс зүүсэн байх, 4 хүртэлх насны хүүхдүүд тусгай хүүхдийн суудалд суусан байхыг шаардаг. Тээврийн хэрэгслийн жолооч нь өөрийн согтуурлын хэмжээг тусгай төхөөрөмжөөр шалгуулахаас татгалзах нөхцөл нь түүний согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсоныг хүлээн зөвшөөрч байна гэж тооцдог байна.

БНХАУ-ын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд хариуцлагын талаар заасан нь:

Тус хуулийн 7 дугаар бүлэг нь "Хуулийн хариуцлага" гэсэн нэртэй 88 дугаар зүйлд зааснаар замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомж зөрчсөн үйлдэлд дараах шийтгэлийг ногдуулна. Үүнд: ***анхааруулах, торгох, жолооны үнэмлэхийг түр хураах, эсхүл хүчингүй болгох, баривчлах*** орно.

Замын хөдөлгөөний дүрэм зөрчигсдөд хүлээлгэх хариуцлагын хэмжээ гаргасан зөрчлөөсөө хамаараад харилцан адилгүй. Тухайлбал 87 дугаар зүйлд зааснаар "хэрвээ гаргасан зөрчил хөнгөн, замын хөдөлгөөнд нөлөө үзүүлэхээргүй бол үйлдсэн зөрчлийг хэлж, аман байдлаар анхааруулаад хөдөлгөөнд оролцуулна" гэж заажээ. Тэгвэл 101 дүгээр зүйлд "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчиж, автын онц том осол гаргаж, гэмт хэрэг үйлдсэн бол хуулийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэж, Цагдаагийн байгууллагын замын хөдөлгөөний удирдах газраас жолоочийн үнэмлэхийг хүчингүй болгоно. Авто замын осол гаргасны дараа оргон зугтасан бол цагдаагийн байгууллагын замын хөдөлгөөний газраас жолоочийн үнэмлэхийг хүчингүй болгож, насан туршдаа авто машин жолоодох эрхийн үнэмлэх дахин олж авах эрхгүй болно гэж хатуу заасан байдаг.

[180] Правовое регулирование дорожного движения, его безопасности в зарубежных странах http://www.auto016.ru /сүүлд үзсэн 2011.03.03/

[181] Мөн тэнд.

Зарим онцлог зохицуулалт

89 дүгээр зүйл. Явган зорчигч, тээврийн хэрэгслээр зорчигч, авто биш тээврийн хэрэгслийн жолооч нь замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомж зөрчсөн бол анхааруулах, эсхүл таваас тавь хүртэл юаниар торгох; авто биш тээврийн хэрэгслийн жолооч нь торгуулийн шийтгэлийг эсэргүүцсэн бол түүний авто биш тэргийг хурааж авна.

90 дүгээр зүйл. Авто тээврийн хэрэгслийн жолооч замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчиж замаар зорчсон бол анхааруулах, эсхүл хориос хоёр зуу хүртэл юаниар торгож шийтгэнэ. Тус хуульд өөрөөр заасан бол тухайн заалтын дагуу шийтгэнэ.

91 дүгээр зүйл. Согтууруулах ундаа хэрэглэсний дараа тээврийн хэрэгсэл жолоодсон бол 1-3 сар хүртэл хугацаагаар жолооны үнэмлэхийг хураан авч, хоёр зуугаас таван зуу хүртэл төгрөгөөр торгож шийтгэнэ. Согтууруулах ундаа хэрэглэж согтуурсан үедээ авто машин жолоодсон бол цагдаагийн байгууллагын замын цагдаагийн газар эрүүлжүүлэх арга хэмжээ авч 15 хоног хүртэл баривчлах болон 3-6 сар хүртэл хугацаагаар жолооны үнэмлэхийг хураан авч, таван зуугаас хоёр мянга хүртэл юаниар торгож шийтгэнэ.

7. Жолоочийн хариуцлагын онооны системийн зохицуулалт ямар байдаг

Торгуулийн оноогоор шийтгэх систем

Онооны систем нь 1974 оны 5 дугаар сард Германд анх үүссэн. 1960-аад оны үед Германд авто замын осол эрс ихэссэн бөгөөд түүнтэй тэмцэх арга боловсруулсан нь энэхүү "Онооны систем" юм. "Онооны систем"-ийн анхдагч зорилго нь замын хөдөлгөөний хууль тогтоомжийг давтан зөрчигчийн үйлдлийг тодорхойлох, таслан зогсооход оршиж байжээ. Замын хөдөлгөөний дүрэм давтан зөрчигчийн хайхрамжгүй, болгоомжгүй байдлыг тодорхойлох зорилгыг мөн агуулсан[182].

Замын хөдөлгөөний зөрчлийг тооцох онооны систем гэдэг нь гаргасан зөрчилд оноо тооцох замаар жолооны эрхэд шийтгэл оногдуулах арга хэмжээ юм. Шийтгэлийн оноо нэмэгдэх болон хасагдаж болно. Зөрчлийн төрлийг тодорхой нарийн заалтаар ангилж, оноо тооцсоноор жолооны үнэмлэхийг түр хураах, хүчингүй болгох эрх зүйн үндэслэлийг бүрдүүлж өгдөг.[183] Энд тэмдэглэн хэлэхэд замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрэм зөрчигсдөд торгуулийн арга хэмжээ авахын зэрэгцээ гаргасан зөрчлийг оноогоор бүртгэж, тодорхой хугацаанд[184] тогтоосон хязгаарт[185] хүрвэл арга хэмжээ тооцох арга юм. Улс орон бүрт нэгэн адил биш боловч нийтлэг шинжтэй зохицуулалтыг тухайн улс өөрийн үндэстний онцлогт тохируулан тусгадаг байна.

---

[182] http://www.fit-to-drive.com/2006/downloads/Schade_KBA.pdf

[183] http://en.wikipedia.org/wiki/Point_system_%28driving%29

[184] Ихэвчлэн 12 сар буюу 1 жилийн хугацаат оноо тооцох 1 бүтэн хугацаа гэж үздэг.

[185] Ихэнх улсад оноо тооцох 12 сарын хугацаанд 12 оноог дээд хязгаар гэж авсан байдаг. Тухайлбал Герман, Япон, Хятад, Чех зэрэг улсуудад оноо тооцох нэг бүтэн хугацаанд 12 оноо хүрвэл жолоочийн эрх хасагдана. Гэтэл дээд оноо 24 байхыг заасан орон бас байдаг.

Гадаад орнуудын зохицуулалт

Онооны системийг хэрэгжүүлснээр Германд замын хөдөлгөөний зөрчил буурсан үр дүн гарсан учир бусад улс орон авч хэрэгжүүлсэн. Өнөөгийн байдлаар АНУ, Австрали, Япон, Итали, Франц, Чех, Хятад, Тайвань, Хонгконг зэрэг олон оронд энэхүү арга хэмжээг хэрэглэж байна.

Чех улсад замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн жолоочид мөнгөн торгууль ногдуулахаас гадна торгуулийн оноогоор шийтгэнэ. Торгуулийн оноог тухайн жолоочийн харьяалагдах хотын захиргаа бүртгэх бөгөөд ***12 оноо*** хүрсэн тохиолдолд жолоодох эрх хасах шийтгэл ногдуулна. Тухайлбал, гадаадын харьяат иргэн торгуулийн 12 оноогоор шийтгүүлсэн тохиолдолд 1 жилийн хугацаагаар Чех улсад тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй болно.

Торгуулийн оноогоор шийтгүүлсэн жолооч тодорхой хугацааны туршид /тухайлбал: 12, 24, 36 сар гэх мэт/ дахин зөрчил гаргаагүй бол уг оноог нь шат дараалан бууруулах замаар урамшуулал үзүүлэх бөгөөд энэ нь тухайн жолоочид замын хөдөлгөөний дүрмийг сахин мөрдөх хүсэл эрмэлзэл төлөвшүүлэхэд хөшүүрэг болох ач холбогдолтой гэдэг. Торгуулийн оноог тухайн зөрчлийн агуулгад нийцүүлэн ногдуулах бөгөөд нэг удаагийн хөнгөн зөрчилд 1 оноо, ноцтой зөрчилд хамгийн дээд оноо буюу 7 оноо ногдуулдаг байна. Тухайлбал:

- замын тэмдэг, тэмдэглэлийн заалт зөрчсөн бол 1 оноо;
- хороллын доторх хөдөлгөөний журам зөрчсөн бол 1 оноо;
- тууш замд хориглосон тээврийн хэрэгслээр хөдөлгөөнд оролцсон бол 1 оноо;
- хурдны зөвшөөрөгдөх дээд хэмжээг цагт 20 хүртэл км-ээр хэтрүүлсэн бол 2 оноо;
- хамгаалах бүс, хамгаалах малгай хэрэглээгүй бол 2 оноо;
- тээврийн хэрэгслийн даацыг хэтрүүлсэн бол 3 оноо;
- жолоочийн цусан дахь спиртийн агууламж 0.3 промилл хүртэл байвал 3 оноо;
- хурдны зөвшөөрөгдөх дээд хэмжээг цагт 20-40 км-ээр хэтрүүлсэн бол 3 оноо;
- тээврийн хэрэгсэл жолоодож яваа үедээ гар утсаар ярьсан бол 3 оноо;
- хуурамч улсын дугаар хэрэглэсэн бол 4 оноо;
- давуу эрх бүхий хөдөлгөөнд оролцогчдод зам тавьж өгөөгүй бол 4 оноо;
- хориглосон дохиогоор нэвтэрсэн бол 5 оноо;
- хурдны зөвшөөрөгдөх дээд хэмжээг цагт 40 км-ээс дээш хэтрүүлсэн бол 5 оноо;
- техникийн шаардлага хангаагүй тээврийн хэрэгсэл жолоодсон бол 5 оноо;
- замын хориотой хэсэгт буцаж эргэсэн, ухарсан, урсгал сөрсөн бол 6 оноо;
- хориотой байдлаар гүйцэж түрүүлсэн бол 6 оноо;
- цусан дахь спиртийн агууламж 0.3 промиллоос илүү /гэхдээ согтоогүй/ байвал 6 оноо;

- согтуурсан буюу мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон бол 7 оноо;

- согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхээ шалгуулахаас зайлсхийсэн бол 7 оноо.

БНХАУ-д замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн этгээдэд мөнгөн торгууль ногдуулахаас гадна торгуулийн оноогоор шийтгэх систем үйлчилдэг. Энэ нь "Жолоочийн зөрчлийг тооцох шийтгэлийн онооны арга хэмжээ" , "Авто машин жолоодох үнэмлэх авах ба ашиглах дүрэм" зэрэг журам дүрэмд бүрэн тусгагдсан, нэлээд боловсронгуй зохицуулалт юм. Энэ нь тухайн жолооч 12 сар буюу нэг жилийн хугацаанд жолооч 12-оос илүү торгуулийн оноо авсан тохиолдолд түүний жолоодох эрх хүчингүй болох ба жолоодох эрхээ сэргээлгэхэд заавал шалгалт өгөх ёстой болно. Шалгалтад тэнцсэн тохиолдолд өмнөх торгуулийн оноонуудыг хүчингүйд тооцож, жолоодох эрхийн үнэмлэхийг буцааж олгоно.

Нэг жилийн хугацаанд 12-оос илүүгүй торгуулийн оноо авсан жолооч мөнгөн торгуулийн төлбөрөө хугацаандаа төлсөн бол түүний оноонуудыг хүчингүйд тооцно. Харин төлбөрөө барагдуулаагүй бол уг торгуулийн оноонуудыг дараагийн жилд нь шилжүүлж тооцдог байна. Мөн зөрчилд ногдуулсан мөнгөн торгуулийг 3 сарын дотор төлж барагдуулаагүй, эсхүл хоёр удаа торгууль төлөлтийг хожимдуулсан бол торгуулийн 12 оноогоор шийтгүүлнэ. Өөрөөр хэлбэл эрх шууд хасагдана.

"Жолоочийн зөрчлийг тооцох шийтгэлийн онооны арга хэмжээ" –нд шийтгэлийн онооны утга агуулга, шийтгэлийн оноог хэрхэн хэрэгжүүлэх, дахин шалгалтад хамрагдах журам, түүнчлэн зөрчил гаргаагүй буюу оноогоор шийтгэгдээгүй жолоочийг хэрхэн урамшуулах талаар тодорхой зааж өгсөн байна.

Жолоочид тухайн гаргасан зөрчлийнх нь агуулгаас хамааруулан 1, 2, 3, 6, 12 гэсэн торгуулийн оноог ногдуулна. Дараах нийтлэг[186] байдлаар дүйцүүлэн торгуулийн оноогоор шийтгэнэ.

Үүнд: 12 оноо:

- тухайн ангилалд үл тохирох эрхийн үнэмлэхээр тээврийн хэрэгсэл жолоодсон;
- согтууруулах ундаа хэрэглэсэн, эсхүл согтуурсан үедээ авто машин жолоодсон;
- зорчигч тээвэрлэгч машин зорчигчдын тоон хэмжээг 20-оос дээш хувиар хэтрүүлэн тээвэрлэсэн;
- авто осол гаргасны дараа оргон зугатсан, гэхдээ гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй бол;
- хуурамчаар үйлдсэн эсхүл өөрчлөлт оруулж үйлдсэн улсын дугаар, жолооны үнэмлэх, жолоочийн үнэмлэхийг ашигласан, эсхүл бусад тээврийн хэрэгслийн улсын дугаар, жолооны үнэмлэх ашигласан;

[186] "Жолоочийн зөрчлийг тооцох шийтгэлийн онооны арга хэмжээ"-ний 24 дүгээр зүйлд "орон нутгийн шинжтэй дүрэм журамд заасны дагуу жолоочийн зөрчлийг тооцох шийтгэлийн онооны хэлбэр хэмжээг зөвхөн тухайн орон нутгийн жолоочийн хувьд хэрэглэнэ"гэж зааснаас харахад муж, орон нутаг бүрт нэгэн адил дүрэм үйлчилдэггүй байна.

- өндөр хурдны зам дээр тээврийн хэрэгслээр ухарч буцах, эргэх, тусгаарлах зурвас хэтрэх;

6 оноо:

- жолооны үнэмлэхээ түр хугацаагаар хураалгасан үедээ авто машин жолоодсон;
- зорчигч тээвэрлэх зохистой тоог хэтрүүлсэн боловч хэтрүүлсэн хэмжээ 20 хувиас доош бол;
- хурдны тогтоосон дээд хязгаарыг 50 хувиар хэтрүүлсэн;
- өндөр хурдны замын зорчих хэсэгт тээврийн хэрэгслээ зогсоосон;
- тэсэрч дэлбэрэх аюултай болон шатамхай химийн бодис, бүтээгдэхүүн болон хортой, хийтэй зэрэг аюултай эд зүйлсийг тогтоосон хугацаа, зам, хурдны хэмжээг зөрчиж тээвэрлэсэн, эсхүл анхааруулга тэмдгийг хэрэглээгүй, аюулгүй ажиллагааны зохих арга хэмжээг аваагүй;
- зорчигч тээвэрлэсэн болон аюултай шинж бүхий ачаа тээвэрлэсэн тохиолдолд тээврийн хэрэгслээ жолоодож явсан хугацаа 4 цаг хүрэхэд зогсоолгүй, үргэлжлүүлэн тээвэрлэсэн, эсхүл зогсоосон боловч 20 минутаас бага хугацаагаар зогсоож амраасан бол;
- замын хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслийн улсын дугаарыг зүүгээгүй, эсхүл дугаарыг санаатайгаар эвдэж, гэмтээсэн, эсхүл зохих журмын дагуу байрлуулаагүй;
- нууцаар болон хуурч мэхлэх замаар жолооны үнэмлэх олж авсан;

3 оноо:

- Ачааны тээврийн хэрэгслийн даацыг зохистой хэмжээний 30 хувиас дээш хэмжээгээр хэтрүүлэн тээвэрлэсэн эсхүл зорчигч тээвэрлэх журмыг зөрчсөн;
- Нийтийн зорчигч тээвэрлэх тээврийн хэрэгслээс бусад зорчигч тээвэрлэх машин зорчигчдын зохист тоог 20 хувиас дээш хэмжээгээр хэтрүүлсэн;
- Гэрэл дохио зөрчсөн;
- хурдны тогтоосон дээд хязгаарыг 50 хувиас бага хэмжээгээр хурд хэтрүүлсэн;
- өндөр хурдны зам дээр зөвшөөрөгдсөн хурдны доод хэмжээнээс бага хурдаар жолоодсон;
- өндөр хурдны замаар зорчихыг хориглосон тээврийн хэрэгсэл өндөр хурдны зам руу орж зорчсон;
- хориглосон болон анхааруулсан тэмдэг зөрчих;
- тогтоосон журам зөрчиж тээврийн хэрэгсэл гүйцэж түрүүлэх, зорчих, эсхүл ухарч буцаасан;
- тогтоосон журам зөрчиж бусад тээврийн хэрэгслийг чирсэн;
- хөдөлгөөнд саад тохиолдсон болон осол гарсан тохиолдолд гэрэл асаах ба анхааруулах тэмдэг тавих журам зөрчсөн;
- тогтоосон хугацаанд тээврийн хэрэгслийн аюулгүй ажиллагааны үзлэгт хамрагдаагүй;

2 оноо:

- Нийтийн зорчигч тээвэрлэх тээврийн хэрэгслээс бусад зорчигч тээвэрлэх машин зорчигчдын зохист тоог 20-оос доош хувиар хэтрүүлсэн;

- Ачааны тээврийн хэрэгслийн даацыг зохистой хэмжээний 30-аас доош хувиар хэтрүүлэн тээвэрлэсэн;
- Явган зорчигчийн гарц дээр хурд сааруулах, тээврийн хэрэгслээ зогсоох журмыг зөрчсөн, явган зорчигчид зам тавьж өгөөгүй;
- гар утсаар залгах, утсаа гараараа барьж ярих, сонсох зэргээр хөдөлгөөний аюулгүй байдалд саад учруулах үйлдэл хийх;
- 2 дугуйтай мотоцикль жолоодохдоо хамгаалах малгай өмсөөгүй;
- Өндөр хурдны зам болон хотын хурдны зам дээр тээврийн хэрэгсэл жолоодох үедээ жолооч аюулгүйн бүсээ зүүгээгүй;

1 оноо:

- Зохих журмын дагуу гэрэл ашиглаагүй;
- Тээврийн хэрэгслийн ачааны урт, өргөн, өндрийн хэмжээг зөрчих;
- тээврийн үзлэгийн тэмдэг, даатгалын тэмдгийг нааж байршуулаагүй, жолооны үнэмлэх, жолоочийн үнэмлэхийг биедээ авч яваагүй;

Тус зохицуулалт нь зөвхөн шийтгэлийн асуудлыг багтаагаагүй бөгөөд замын хөдөлгөөний хууль тогтоомжийг сахин биелүүлж, зөрчил гаргаагүй жолоочийг урамшуулах талаар тухайлан онцолж, ***дараах байдлаар урамшуулна*** гэж заасан байна. Үүнд :

- авто машины жолооч шийтгэлийн онооны 2 дараалсан бүтэн хугацаанд шийтгэлийн оноо аваагүй бол 1 удаа хяналтын үзлэгт орохоос чөлөөлөгдөнө;
- Дараалан 5 удаагийн хугацаанд оноогоор шийтгэгдээгүй бол жолооны үнэмлэхийн хүчинтэй хугацааг 2 жилээр сунгана;
- Дараалан 10 удаагийн хугацаанд шийтгэл аваагүй бол 20 жилийн хугацаанд үзлэгт орохоос болон үнэмлэх солихоос чөлөөлөгдөнө.

Дүгнэлт

Энэхүү судалгаагаар АНУ-ын зарим муж /Иллинойс, Калифорни/, ХБНГУ, ОХУ, БНХАУ, Бүгд Найрамдах Австри Улс, Болгарын Бүгд Найрамдах Улс, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, Данийн Вант улс, Франц, Украйн, Эстони Улс, Израиль, Чех Улсын замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбогдох эрх зүйн зохицуулалтаас харахад шинэчлэн боловсруулж буй хуулийн төсөлд тусгавал зохих зохицуулалт нэлээд байна. Иймд тэдгээр улсын эрх зүйн зохицуулалтыг холбогдох мэргэжлийн байгууллага, ажлын хэсгийн гишүүдийн санал, практик нөхцөл байдал, техник эдийн засгийн боломж зэргийг харгалзан, харьцуулан үзэж хуулийн төсөлд тусгах нь зүйтэй юм. Эл үндэслэлээр дараах санал, зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

Санал, зөвлөмж *Зохион байгуулалтыг эрхлэх байгууллага*

✓ ОХУ-ын хувьд "Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хариуцсан хотын зөвлөлийн тухай" Москва хотын даргын 2005 оны 12 дугаар сарын 30-

ны өдрийн 435-РМ тоот тушаалаар замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой асуудлыг зохицуулах зөвлөл байгуулагджээ[187]. Тус Зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг. Үүнд:

-Зам дээр гарч буй ослыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийтэд зориулсан ухуулгын, танин мэдэхүйн шинжтэй арга хэмжээ зохион байгуулах;

-Замын хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр гарч буй хууль, эрх зүйн актын шинэчлэл, хэрэгжилтэнд хяналт тавих;

-Зам дээр гарсан ослын талаар нэгдсэн статистик дүн гаргах, зам дээрх зөрчлийг бууруулах бодлого боловсруулах, хэрэгжилтийг хангах;

-Авто тээврийн зөрчил, гэмт хэрэг, замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх жил бүрийн мэдээг бэлтгэж ОХУ-ын Засгийн газарт бэлтгэх, танилцуулах;

-"Замын хөдөлгөөний аюулгүй байдал" сэдэвт Москва хотын санг /фонд/-ыг хөгжүүлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх нийгмийн идэвх зүтгэлийг сайжруулах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.

Иймд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлд Хууль зүй, дотоод хэргийн яам, Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яам, Замын цагдаагийн газар, Авто тээврийн газар, Нийслэлийн Засаг даргын ажлын алба, авто замын улсын хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, бусад холбогдох төрийн байгууллага, олон нийтийн төлөөллийг оролцуулсан орон тооны бус зөвлөл байгуулан ажиллуулж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр стратеги, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан ажиллах нь оновчтой байна.

Бүртгэлийн тогтолцоог төгөлдөржүүлэх

✓ Авто машин, тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эзэмшигч болон зөрчлийн талаарх бүртгэлийг сайжруулах судалгааны тайланд дурдсан АНУ-ын Калифорни мужийн жишээг авч хэрэгжүүлэх нөхцөлийг судалж үзэх;\

Оноогоор шийтгэх систем ба урамшуулал

✓ Торгуулийн оноогоор шийтгэх системийг Монгол Улсын хувьд авч хэрэгжүүлэх боломжтой. Онооны системийг хэрэглэх боломжийг төсөлд тусгах асуудлыг шийдэхийн зэрэгцээ замын хөдөлгөөний хууль тогтоомжийг сахин биелүүлж, зөрчил гаргаагүй жолоочийг урамшуулах талаар мөн тухайлсан зохицуулалтыг БНХАУ зэрэг орнуудын жишгийг авч хэрэгжүүлж болно;

Хариуцлагын төрөлд эдийн засаг, нийгэмд тустай хэлбэрийг түлхүү оруулах

✓ Гадаадын дийлэнх улс орнууд жолоочид материаллаг хариуцлага оногдуулах бодлогыг баримталдаг. Энэ нь зөвхөн их хэмжээний торгууль бус, мөн тээврийн хэрэгслийг хурааж авах, жолооны үнэмлэх хүчингүй болгох, тээврийн хэрэгслийн зайлшгүй даатгалын хэмжээг ихэсгэх зэрэг арга хэмжээнүүд юм. Тухайлбал, ХБНГУ-д зөрчил гаргасан жолооч

[187] Распоряжение мэра Москвы" О городской комиссии по безопасности дорожного движения" 2005.12.30 № 435-РМ http://www.businesspravo.ru/Docum/DocumShow_DocumID_107340.html /сүүлд үзсэн 2011.03.17/

тодорхой торгуулийн оноо цуглуулах ба онооны өсөлтөөс түүний даатгалд төлөх дүнгийн хэмжээ 1000 евро хүртэлх хэмжээгээр өсч болдог. 3000-4000 евроны дундаж цалинтай германы иргэний хувьд энэ нь өндөр төлбөр бөгөөд зарим жолооч нар зөрчил гаргасны хариуд даатгалын төлбөрөө төлөх хүртэл хугацаанд тээврийн хэрэгсэл жолоодохгүй, явганаар явах тохиолдол гардаг байна. Эндээс авч үзвэл хариуцлага хүлээлгэх шийтгэл, зөрчлийн асуудлыг даатгалын системтэй холбон хэрэгжүүлж болохоор байна. Өөрөөр хэлбэл зөрчил гаргасан хувь хүнд чиглэсэн хариуцлагын механизмыг хэрэглэхийн зэрэгцээ эдийн засгийн хөшүүрэг нийгмийн шинжтэй хариуцлагын механизмыг хэрэгжүүлэх боломжийг судалж үзэх нь зүйтэй байна.

Байгаль орчинд болон иргэдийн амгалан тайван, аюулгүй байдалд үзүүлж буй нөлөө

✓ ***Украйн***[188], ***Эстони*** Улсын[189] замын хөдөлгөөний хуульд "Хүрээлэн буй орчны хамгаалалтын хувьд хүлээх үүрэг" хэмээх бүлгийг агуулсан байдаг нь бусад орны зохицуулалтаас онцлог юм. Тус зохицуулалтын дагуу жолооч бусдад болон хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлөх нөхцөл үүсгэх, чанга дуу авиа гаргах, их хэмжээгээр утаа гаргах, амьтан болон шувуу дайрахыг хориглодог. Эстони Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 16 дугаар зүйлд зааснаар, жолооч орон сууцны төвлөрөл ихтэй бүсэд 2 минутаас илүү хугацаагаар тээврийн хэрэгслээ асаалттай байлгахыг хориглодог байна[190]. Мөн гол, мөрөн, горхи, усны эргээс 10 м ойр зайд тээврийн хэрэгслээ угаах, зориулалтын бус газар тос, масло солих, хүрээлэн буй орчныг бохирдуулах зүйл гоожиж байгаа тээврийн хэрэгсэл жолоодохыг хориглоно. Тээврийн хэрэгслийн гаргах дуу авианы, цацаж буй утааны хэмжээг Эстони Улсын Байгаль хамгаалал, хүрээлэн буй орчны Сайдын тушаалын 5 дугаар зүйлээр тогтоодог ба тогтоосон хэмжээг зөрчвөл захиргааны хариуцлага хүлээлгэдэг байна. Ингэснээр жолоочийн зөвхөн гаргасан ослын зөрчилд нь хариуцлага хүлээлгэхээс гадна бүрэн бус, тээврийн хэрэгсэл ашиглах явцдаа хүрээлэн буй орчин болон иргэдийн амар тайван байдалд нөлөөлөх үйлдэл хийсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэхээр заасан нь манай улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн шинэ төсөлд заавал тусгах зүйл юм. Дээр дурдсан зөрчлүүд нь манайд түгээмэл байгаа бөгөөд эл асуудлыг зохицуулснаар олон хууль тогтоомж, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад түлхэц үзүүлэх ач холбогдолтой.

Хариуцлага ногдуулахдаа зөрчлийн шинжийг харгалзах

✓ Аливаа зөрчлийн шинжээс хамааран шийтгэлийг нарийн ялгамжтай ногдуулдаг болох нь ХБНГУ-ын хуулиас харагдаж байна. Энэ жишгийг судлан үзэж Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн төсөлд тусгах асуудлыг судлах;

Замын аюулгүй байдлыг хангах, холбогдох байгууллагын үүрэг, хариуцлагын асуудал

---

[188] Правила Дорожного движения Украйны http://auto.meta.ua/autolaw/pdd_rus/ /сүүлд үзсэн 2011.03.17/

[189] Правила Дорожного движения Республики Эстония http://pdd-ru.info/445.php /сүүлд үзсэн 2011.03.17/

[190] Мөн тэнд. 16 дугаар зүйл.

✓ ОХУ-ын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиар зохицуулсны дагуу замыг засварлах, шинээр зам тавих, замын эвдрэлийг арилгах нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нөхцөл болно[191]. Холбооны гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагууд, ОХУ-ын субьектийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага болон хариуцдаг замтай хуулийн этгээд[192], иргэний хувьд зам засвар, эвдрэлийг арилгах ажлыг өөрөө хариуцдаг байна. Ингэхдээ улсаас тогтоосон зам засварын журмыг баримтлах буюу мэргэжлийн магадлан итгэмжлэгдсэн зам засвар, барилгын багийг ажиллуулна[193]. Өөрөөр хэлбэл эндээс замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад "зам" чухал үүрэгтэй болох нь харагдаж байгаа бөгөөд энэ асуудлыг тус хуулиар мөн зохицуулж хариуцсан байгууллагын чиг үүргийг зааж өгчээ. ОХУ-ын хуулийн энэ заалтаас харахад:

1.Замын аюулгүй байдал, засварын асуудал нь хөдөлгөөний аюулгүй байдалтай холбогдох болохыг тодорхойлон замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиар зохицуулсан байна.

2.Замын засвартын асуудлыг холбогдох төрийн байгууллага нь хариуцахын зэрэгцээ тодорхой хувь иргэн, хуулийн этгээдэд тодорхой оршин буй газрынх нь замыг хариуцуулж өгдөг байна.

3.Замын засварын асуудлыг тусгай зөвшөөрлөөр магадлан итгэмжлэгдсэн мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлдэг байна. Энэ жишгийг харгалзан тус төсөлд тухайлсан мэргэжлийн байгууллага хариуцахаар тусгах нь зүйтэй.

Олон нийтэд нөлөөлөх ажлыг хэрэгжүүлэх нь

✓ Замын хөдөлгөөний аюулгүй байдал, аливаа зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлд олон нийтийн ойлголт мэдлэгийг дээшлүүлэх сурталт, нөлөөллийн ажлыг тодорхой эрхийн акт, хөтөлбөр, төслийн хүрээнд хэрэгжүүлж хэвших чиглэлээр судалгааны тайланд дурдсан ОХУ-ын жишээ баримт бусад орны жишгийг судалж хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг төсөлд тусгах;

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлд өөр бусад олон төрлийн хууль тогтоомж боловсруулах

✓ Судалгаанаас харахад дийлэнх гадны орнуудад замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлд Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хуулиас гадна холбогдох бусад хамааралтай хууль тогтоомжийг давхар үйлчилдэг байна.

Иймд өөр холбогдох хууль, жишээ нь замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийн тухай гэх мэт хууль тогтоомжийг боловсруулах хэрэгцээ шаардлага үүсч болохоор байна.

--oOo--

[191] Федеральный Закон о Безопастности дорожного движения 15 ноября 1995 года /с изменениями от 2010.07.27/ Статья 11, 12.

[192] ОХУ-ын Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг тухай хуулиар "зам"-засварлалт аюулгүй байдлын талаар тухайн төрийн хариуцсан байгууллагаас тухайлсан газар оршин буй иргэн, хуулийн этгээдэд тодорхой хэсэг замыг хариуцуулдаг бөгөөд уг хариуцсан замынхаа засварлалт аюулгүй байдлыг давхар хариуцдаг байна.

[193] Мөн тэнд, статья 13.

МЭДЭЭЛЛИЙН "МОНЦАМЭ" АГЕНТЛАГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД ХИЙСЭН СУДАЛГАА[194]

ОРШИЛ

Энэхүү судалгааны ажлын зорилго нь Үндэсний мэдээллийн агентлагийг хараат бус, бие даасан үйл ажиллагаа, удирдлагаар хангаж, эрх зүйн байдлыг нь оновчтой шийдвэрлэсэн бусад улсын туршлагыг судалж нэгтгэн дүгнэснээр Монгол Улсын иргэдийг үнэн зөв бодитой мэдээллээр шуурхай хангах, улс орноо гадаадад сурталчлан таниулах, дэлхийн хэмжээний чиг баримжаа, байр суурь бүхий мэдээллийн энэхүү байгууллагын эрх зүйн байдлыг оновчтой зөв тодорхойлох эрх зүйн зохицуулалтыг бий болгоход чиглэсэн зөвлөмж боловсруулахад оршино.

Санхүүжилтийн хувьд төрийн дэмжлэгтэй, хараат бус, бие даасан үйл ажиллагаа бүхий бусад улсын мэдээллийн агентлагийн удирдах байгууллага, түүний бүрэлдэхүүн, эрх зүйн байдал болон санхүүжилт, үйл ажиллагаагаа тайлагнах журам зэрэг туршлагыг судлах.

Ийм агентлаг нь бусад хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хэрхэн, ямар байр суурьтай харилцдаг, түүнийг ямар арга замаар хэрэгжүүлж байгааг судлах.

Энэ ажлын хүрээнд Канадын мэдээллийн агентлаг болох Радио телевизийн корпораци /CBC/Radio-Canada/-ийн удирдлагын бүтэц бүрэлдэхүүн, бүрэн эрх, чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээ, томилох журам, үйл ажиллагаагаа хэрхэн, хэнд тайлагнадаг, санхүүгийн эх үүсвэр; Киприйн мэдээллийн агентлагийн удирдлага, түүний бүрэлдэхүүн, түүнд тавигдах шаардлага, агентлагийн даргын эрх үүрэг, дотоод зохион байгуулалт, санхүүжилтийн эх үүсвэр, зарцуулалт; БНХАУ-ын Синьхуа агентлагийн ерөнхий танилцуулга, бүтэц зохион байгуулалт, чиг үүрэг, гадаад мэдээллийн агентлагтай харьцах харилцаа; ОХУ-ын Итар Тасс агентлагийн түүхэн замнал, эрх зүйн зохицуулалт, удирдлага зохион байгуулалт, санхүүжилт, бусад байгууллагатай харилцах харилцаа зэрэг асуудлыг судлагааны тайланд бичиж эдгээр агентлагуудын үйл ажиллагааг зохицуулсан хууль, дүрэм, журам, цахим хуудас, ном сурах бичиг судлав.

Нэг. КАНАД УЛСЫН МЭДЭЭЛЛИЙН АГЕНТЛАГИЙН ТУХАЙ

Канадад "Канадын пресс" болон Радио телевизийн корпораци /CBC/ Radio-Canada/ гэсэн хоёр мэдээллийн агентлаг байсан. "Канадын пресс" нь 2010 онд татан буугдаж хувийн компанийн өмчлөлд шилжсэн. Одоогоор үйл ажиллагаа явуулж байгаа нь Радио телевизийн корпораци /CBC/Radio-Canada/ юм. "Канадын пресс"-ийн талаар товч дурдаад Радио телевизийн корпорацийн талаар дэлгэрэнгүй авч үзэх болно.

[194] Энэ судалгааг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2011 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 22 дугаар тушаалын дагуу ХЗДХЯ-аас боловсруулж буй теслийн хүрээнд хийж гүйцэтгэсэн болно.

Канадын мэдээллийн агентлагийн түүхээс

1.1 Канадын пресс /Canadian Press/

"Канадын пресс" нь сонин, хэвлэлийн мэдээ хоорондоо солилцдог ашгийн бус холбоо байснаа орчин үед сонингууд интернетээр өөрсдөө мэдээгээ тарааж солилцдог болсноор уг байгууллага нь үндсэндээ хэрэгцээгүй болж 2010 онд гурван том компани дундаа худалдан авсан. Одоо "Канадын пресс"-ийн нэрийг ашиглан мэдээ, мэдээлэл түгээдэг болж хувийн компанийн статустай болжээ. "Канадын пресс"-ийн товч түүхийг дор дурдав.

"Канадын пресс" /Canadian Press/ нь анх 1917 онд байгуулагдаж сонин, хэвлэлийн мэдээ, мэдээллээ хоорондоо солилцох ашгийн бус хувийн холбоо байсан ба сонины гишүүд өмчлөгч нь байжээ.

2010 оны дундуур ашгийн төлөө үйл ажиллагаа явуулахаар болж, тодорхой шаардлага хангасан тохиолдолд хэвлэлийн компанид ээлшүүлэх төлөвлөгөөтэй байгаа гэдгээ "Канадын пресс" зарласан байна[195]. 2010 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Канадын пресс интерпрайс /Canadian Press Enterprises Inc /CPE// нь "Канадын пресс"–ийг бүхэлд нь худалдаж авсанаар бүх өмч хөрөнгө, үүрэг хариуцлага нь Канадын пресс интерпрайс /CPE/-д шилжжээ. Канадын пресс интерпрайс /Canadian Press Enterprises Inc/ –ийг гурван компани хамтран эзэмшдэг, тэдгээр компани нь The Globe and Mail, Torstar Corporation and Square Victoria C.P. Holdings Inc нар юм[196]. Худалдаж авсан компанийн шинэ зөвлөл анх удаа 2010 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр хуралдаж "Канадын пресс"-ийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгсөн байна.[197] [198]

1.2 Канадын радио телевизийн корпораци /Canadian broadcasting corporation/-Radio Canada/

Канадын радио телевизийн корпораци /CBC/Radio-Canada/ нь цэвэр мэдээллийн байгууллага биш атлаа интернетээр мэдээ, сурвалжлагаа тараадаг болсноор МОНЦАМЭ, ИТАР-ТАСС зэрэг байгууллагуудтай ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг болсон бөгөөд канадын үндэсний мэдээллийн агентлаг гэж үзэж дараах байдлаар зохицуулалтыг нь авч үзлээ.

1.2.1 Канадын радио телевизийн корпорацийн түүх

1920 оноос АНУ-ын нөлөө их байсан учир Канадын соёл, ёс заншлыг хадгалж үлдэхийн тулд Канадын үндэсний радио телевизийн компани байгуулах зайлшгүй шаардлага гарчээ. Энэхүү радио телевизийн корпораци нь бусдаас ялгарах үндэсний онцлогийг харуулсан мэдээ, мэдээлэл тарааж үндэсний хэмжээний соёлын том байгууллага болж чадсан байна.[199] Хамгийн

[195] http://en.wikipedia.org/wiki/Canadian_Press_Enterprises_Inc. /сүүлд үзсэн 2011.04.15/

[196] http://www.torys.com/OurExpertise/TransactionsandCases/Pages/CanadianPressEnterprisesacquiresTheCanadianPress.aspx /сүүлд үзсэн 2011.04.15/

[197] http://en.wikipedia.org/wiki/Canadian_Press_Enterprises_Inc. /сүүлд үзсэн 2011.04.21/

[198] Dana Flavelle /November 26/. "Major publishers invest in Canada's oldest news agency". Toronto Star. Retrieved 8 January 2011.

[199] http://www.cbc.radio-canada.ca/history/ /сүүлд үзсэн 2011.04.15/

анхны радио телевиз /нэвтрүүлгийн/-ийн хуулийг 1932 онд баталж Канадын радио телевизийн комиссыг байгуулжээ.

1.2.2 Радио телевизийн корпорацийн танилцуулга[200]

2010 оны 6 дугаар сарын сүүлээр Радио телевизийн корпораци нь ойролцоогоор 9432 ажилтантай, орон нутгийн 27 салбартай байв. Төв байр нь Оттава хотод байрладаг. Радио телевизийн корпораци нь 14 улсад салбартай бөгөөд Канадын хэвлэл мэдээллийн хэрэгслийн бүх мэдээг хамарсан өргөн хүрээний мэдээг олон улсад түгээдэг.

1.2.3 Радио телевизийн корпорацийн үйлчилгээ[201]

Уламжлал ёсоор Радио телевизийн корпорацийн үндсэн үйл ажиллагаа нь радио болон телевизийн үйлчилгээ байсан бол орчин үед болж байгаа үйл явдлын мэдээ, суурь болон хавсарга шинжлэх ухааны мэдээлэл, зар сурталчилгаа зэрэг өргөн хүрээний үйлчилгээг радио, телевиз, интернет, хиймэл дагуулын олон шугамаар үзүүлдэг байна.

Англи, франц хэлээр 6 бүсэд, нутгийн 8 хэлээр үндэсний олон нийтийн нэвтрүүлэг, 7 хэлээр олон улсын түвшинд үйлчилгээ үзүүлж байна.

2008-2009 онд сар бүр ойролцоогоор 2 сая файлыг Радио телевизийн корпорацийн нэвтрүүлгээс хэрэглэгчид татаж авдаг. Эдгээр нэвтрүүлэгт мэдээ, шинжлэх ухааны мэдээлэл, хөгжим, бүжиг, хөгжөөнт нэвтрүүлэг зэрэг орно.

1.3 Канадын радио телевизийн корпорацийн удирдлага, бүтэц зохион байгуулалт

1.3.1 Захирлуудын зөвлөл

Радио телевизийн корпораци нь захирлуудын зөвлөлтэй байна. Захирлуудын зөвлөл нь Радио телевизийн корпорацийн хамгийн дээд удирдлага мөн. Захирлуудын зөвлөл нь 12 захирлаас бүрдэх бөгөөд зөвлөлийн дарга, ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал нь захирлуудын зөвлөлд багтана. Захирлуудыг 5-аас илүүгүй жилийн хугацаатай захирагч /Governor in council/ томилж, чөлөөлөх эрхтэй.[202] /Broadcasting act 36.2/

[200] http://www.cbc.radio-canada.ca/about/pdf/who.pdf /сүүлд үзсэн 2011.04.18/
[201] Мөн тэнд.
[202] http://laws-lois.justice.gc.ca/eng/acts/B-9.01/page-18.html#h-16 /сүүлд үзсэн 2011.04.12/

Захирлуудын зөвлөл нь радио телевизийн корпорацийн удирдлага, үйл ажиллагаа болон корпорацитай холбоотой бусад бүх асуудлыг хариуцна" гэж Радио телевизийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан.

Захирлуудын зөвлөл нь дэргэдээ хороотой байна. Захирлуудын зөвлөл нь бүх хороо болон ерөнхийлөгч, зөвлөлийн даргатай холбоотой бүрэн эрх, үйл ажиллагааны хүрээг тодорхойлсон тогтоол баталдаг.[203] Мөн захирлуудын зөвлөл ач холбогдол бүхий бодлогын жагсаалтыг баталдаг[204].

Захирлуудын зөвлөлийн гол үүрэг нь стратеги болон корпорацийн бизнес төлөвлөгөөг батлах, түүний биелэлтэд үнэлэлт өгөх, мөн түүнчлэн олон нийт, парламенттай үр ашигтай харилцах бодлого, төлөвлөгөөг баталж уялдуулах юм.[205]

Радио, телевизийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн дагуу захирлуудын зөвлөлийн дарга, ерөнхийлөгч нарын ажиллах хугацаа дуусан тохиолдолд дахин томилогдох эрхтэй, бусад захирлууд томилогдох эрхгүй.

Радио телевизийн тухай хуулийн 36.3, 36.4-т заасны дагуу захирлын бүрэн эрхийн хугацаа дуусан бол дараагийн захирал томилогдох хүртэл албан тушаал хашиж байгаа захирал бүрэн эрхээ хэрэгжүүлнэ гэжээ.

Дээрх заалтаас дүгнэхэд:

Захирлуудын зөвлөлийн гол чиг, үүрэг:

- корпорацийн удирдлага, үйл ажиллагаа болон корпорацитай холбоотой бусад бүх үйл ажиллагааг удирдан чиглүүлнэ;
- захирлуудын зөвлөлийн дэргэдэх хороо болон зөвлөлийн дарга, ерөнхийлөгчийн бүрэн эрх, үйл ажиллагааны хүрээг тодорхойлсон тогтоол гаргах;
- ач холбогдол бүхий бодлогын баримт бичиг батлах;
- корпорацийн стратеги төлөвлөгөө, бизнес төлөвлөгөөг батлах, үнэлэлт дүгнэлт өгөх;
- олон нийт, парламенттай үр ашигтай харилцаж бодлого, төлөвлөгөөг батлах, уялдуулах.

1.3.2 Радио телевизийн корпорацийн дарга[206] /Радио телевизийн тухай хуулийн 41/

Даргын эрх мэдэл, ажил, үүрэг:

Радио телевизийн тухай хуулийн 41 дүгээр зүйлд радио телевизийн корпорацийн даргын эрх мэдэл, үүргийг дараах байдлаар зааж өгсөн. Үүнд:

41.1 Дарга нь захирлуудын зөвлөлийн хурлыг даргална. Мөн радио телевизийн корпорацийн дүрэмд заасны дагуу эрх эдэлж, үүрэг хүлээж тодорхой үйл ажиллагаа явуулж болно.

41.2 Дарга нь орон тооны бусаар /хагас цагаар/ тодорхой үүрэг, үйл ажиллагааг гүйцэтгэж болно.

41.3 Хэрвээ дарга эзгүй, чөлөөтэй, үүргээ гүйцэтгэх боломжгүй байгаа

[203] http://www.cbc.radio-canada.ca/submissions/bylaws.shtml /сүүлд үзсэн 2011.04.19/

[204] Мөн тэнд

[205] http://www.cbc.radio-canada.ca/about/pdf/who.pdf /сүүлд үзсэн 2011.04.19/

[206] http://laws-lois.justice.gc.ca/eng/acts/B-9.01/page-19.html#h-17 /сүүлд үзсэн 2011.03.23/

тохиолдолд ерөнхийлөгч даргыг орлоно. Хэрвээ дарга, ерөнхийлөгч хоёр хоёулаа эзгүй тохиолдолд захирал орлоно.

Дарга нь захирлуудын зөвлөлийн үйл ажиллагааг ерөнхийд нь удирдаг бөгөөд дараах үүргийг гүйцэтгэнэ[207].

а/ Захирлын зөвлөлийн ажлыг удирдах;

b/ Радио телевизийн корпорацийн цаашдын ашиг сонирхлыг парламентад мөн захирлуудын зөвлөлд төлөөлөх, ерөнхийлөгч болон захирлуудын зөвлөлийн хоорондын харилцаанд гүүр болох;

с/ Ерөнхийлөгч олон нийттэй үр ашигтай харилцаа бий болгоход дэмжлэг үзүүлэх;

d/ Захирлуудын зөвлөлийг тэргүүлнэ. Мөн ерөнхийлөгчийн ажлын гүйцэтгэлд үнэлэлт дүгнэлт өгөх, хяналт тавих, хариуцлага тооцох;

е/ Захирлуудын зөвлөлд удирдлагын зүгээс хэлэлцүүлэхээр өргөн барьсан стратеги болон бизнес төлөвлөгөөг хариуцах;

f/ Удирдлагын залгамж холбоо болон корпорацийн цаашдын хөгжлийн төлөвлөгөөг хариуцах.

1.3.3 Радио телевизийн корпорацийн Ерөнхийлөгч

Ерөнхийлөгч нь радио телевизийн корпорацийн гүйцэтгэх захирал байна. Ерөнхийлөгч корпорацийн өдөр тутмын үйл ажиллагаа болон ажилтнуудын үйл ажиллагааанд хяналт тавьж чиглэл өгч ажиллана. Хууль болон дүрэм, журам, захирлуудын зөвлөлийн өгсөн чиглэлийн дагуу болон захирлуудын зөвлөлөөс баталсан бүрэн эрх, үйл ажиллагааны хүрээнд эрх эдэлж, үүрэг хүлээж, тодорхой үйл ажиллагаа явуулахаар зааж болно.

Дээр дурдсанаас гадна ерөнхийлөгч ерөнхийд нь бизнесийн үйл ажиллагаа, корпорацийн бусад ажлыг хариуцах бөгөөд ажилтан ажилд авах, ажлаас халах эрхтэй. Захирлуудын зөвлөлийн дэргэдэх хороо болон захирлуудын зөвлөлөөс баталсан бодлого, удирдамжийн хүрээнд шагнал урамшуулал, тэтгэвэрт гарах, ажлаас халах, чөлөөлөхтэй холбогдон гарах зардлыг олгох эрхтэй[208].

1.4. Хороо[209] /By-laws of the Canadian Broadcasting Corporation article 5.1/

Захирлуудын зөвлөл нэг болон түүнээс дээш хороог байгуулж болно. Хороо нь захирлуудын зөвлөлийг ямар нэгэн байдлаар төлөөлж, тодорхой үүрэг гүйцэтгэнэ. Гэхдээ хороо дараах эрхийг эдлэхгүй. Үүнд:

а/ Дотоод журам батлах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох

b/ Удирдах зөвлөлөөс зөвшөөрөгдсөнөөс бусад тохиолдолд аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэх

с/ Дараах зүйлийг батлах

i. Санхүүгийн тайлан болон гадаад аудитын тайлан

ii. Санхүүгийн төлөвлөгөө болон түүний нэмэлт, өөрчлөлт

[207] http://www.cbc.radio-canada.ca/submissions/bylaws.shtml /сүүлд үзсэн 2011.04.20/

[208] Мөн тэнд

[209] Мөн тэнд

iii. Зөвлөлийн даргаар батлуулах шаардлагатай аливаа асуудал, эсхүл захирлуудын зөвлөлөөр батлуулах зайлшгүй хэрэгтэй ямар нэгэн эрх зүйн акт.

Дараах төрлийн хороодтой байна[210]**:** /By-laws of the Canadian Broadcasting Corporation article 5.1/

- Аудитын хороо
- Англи хэлний нэвтрүүлгийн байнгын хороо
- Франц хэлний нэвтрүүлгийн байнгын хороо
- Удирдах зөвлөлийн тогтоолоор баталсан бусад хороо

Хороо нь хуульд зааснаас бусад тохиолдолд жилд наад зах нь 1 удаа хуралдах ёстой. Хорооны хурлыг хорооны даргын өөрийн санаачилгаар эсхүл хорооны гишүүдийн бичгээр гаргасан хүсэлтийн үндсэн дээр хорооны дарга зарлан хуралдуулж болно. /By-laws of the Canadian Broadcasting Corporation article 5.3/

1.4.1 Аудитын хороо

Аудитын хорооны бүрэн эрхийн хүрээг захирлуудын зөвлөлийн тогтоол болон хуулийн дагуу тодорхойлно. Хороо нь гурваас багагүй зургаагаас илүүгүй захирлаас бүрдэх бөгөөд эдгээр захирлуудын хэн нь ч радио телевизийн корпорацийн албан тушаалтан, эсхүл ажилтан байж болохгүй. Хорооны гишүүдийн нэгийг хорооны даргаар захирлуудын зөвлөл томилно. Хорооны гишүүдийн дийлэнх нь кворум байгуулж болно.

Хорооны гишүүд дангаараа эсхүл гадаад болон дотоод аудиторын бичлэгтэй уулзалт хийхээс бусад тохиолдолд зөвлөлийн дарга, ерөнхийлөгч, радио телевизийн корпорацийн санхүүгийн гол ажилтан, дотоод аудитор нар хорооны бүх хуралд оролцох эрхтэй.

Гадаад аудитор хорооны бүх хуралд оролцох урилга, зарлал, мэдэгдэл хүлээж авч болно. Хэрэв хорооны гишүүд гадаад аудиторыг урьсан бол гадаад аудитор хорооны бүх хурал, эсхүл урьсан тэр хуралд оролцох ёстой.

1.4.2 Англи, франц хэлний нэвтрүүлгийн байнгын хороо

Захирлуудын зөвлөлийн тогтоолоор хорооны бүрэн эрхийг тодорхойлно. Нэвтрүүлгийн хороо тус бүр захирлуудын зөвлөлийн бүх гишүүдээс бүрдэнэ.

Хорооны хурал болгоныг зөвлөлийн дарга, даргын эзгүйд ерөнхийлөгч даргална. Хороо тус бүрийн гишүүдийн дийлэнх нь кворум байгуулж болно.

<u>1.5 Радио, телевизийн стратеги чиглэл</u>[211]

- Радио телевизийн корпораци /CBC/Radio-Canada/ нь үндэсний онцлогийг харуулсан том компани болох;

[210] Мөн тэнд

[211] http://www.cbc.radio-canada.ca/about/pdf/who.pdf /сүүлд үзсэн 2011.04.15/

- Радио телевизийн корпораци /CBC/Radio-Canada/ нь сонгож авсан гол хэсгүүдэд Канад улсын үндэсний мэдээ мэдээллийг түгээгч болох;
- Канадууд болон Радио телевизийн корпораци /CBC/Radio-Canada/ нь бүс нутагтаа нөлөө бүхий байдлаар үлдэх арга замыг хайх наад зах нь түүнд багтахын тулд хөрөнгө мөнгө бэлэн байх баталгаагаар хангагдах.[212]

1.6 Радио телевизийн корпораци /CBC/Radio-Canada/ нь хэрхэн ажилладаг, үйл ажиллагаагаа хэнд тайлагнах вэ?

Радио телевизийн корпораци /CBC/Radio-Canada/-ийн өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлж, ерөнхийлөгч болон гүйцэтгэх захирал тэргүүлнэ. Радио телевизийн корпораци /CBC/Radio-Canada/ нь Засгийн газраас хараат бусаар ажилладаг. Гэхдээ парламентын өмнө хариуцлага хүлээнэ. Тайлангаа Соёлын яамаар дамжуулж парламентад тавина. Жилийн тайлан болон корпорацийн төлөвлөгөөний хураангуйг парламентад жил бүр танилцуулна.

Радио телевизийн корпораци нь жилийн эцсийн үйл ажиллагааны тайлангаа Канадын радио телевиз болон харилцаа холбооны комисст тайлагнаж, мөн санхүүгийн тайлангаа тус комисст танилцуулдаг. Түүнчлэн цахим хуудсаар болон олон нийтийн уулзалтаар үйл ажиллагаа, санхүүгийн тайлангаа танилцуулна.

1.7 Радио телевизийн корпорац /CBC/Radio-Canada/-ийн санхүүгийн эх үүсвэр

Парламентаас Радио телевизийн корпорацийн үйл ажиллагааг хэвийн явуулахад зориулж нийт санхүүжилтийн дийлэнх хувийг гаргадаг бөгөөд корпораци өөрөө мэдээ, мэдээлэл зарах, зар сурталчилгаа явуулах, суваг түрээслэх зэрэг бусад эх үүсвэрээс үлдсэн санхүүжилтээ олдог.

Дүгнэлт:

Канадын радио телевизийн корпораци нь төсвөөс тодорхой хувиар санхүүждэг бөгөөд үлдсэн хэсгээ өөрсдийнхөө үйл ажиллагаанаас санхүүжүүлдэг. Тус корпорацийн удирдлагыг ерөнхий удирдагч томилж, чөлөөлдөг. Корпорацийн удирлага гэдэг нь 12 захирлаас бүрдсэн захирлуудын зөвлөл байна. Захирлуудын зөвлөлийн дарга нь зөвлөлийг тэргүүлэн, бодлого, чиглэлийг тодорхойлж, гүйцэтгэх захирлын ажилд хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт өгөх үүрэгтэй өргөн эрх мэдэл, үүрэг хариуцлагыг хүлээдэг. Корпорацийн өдөр тутмын үйл ажиллагааг ерөнхийлөгч буюу гүйцэтгэх захирал удирдан чиглүүлдэг.

Радио телевизийн корпорац нь Засгийн газраас хараат бусаар ажилладаг. Гэхдээ парламентын өмнө хариуцлага хүлээнэ. Тайлангаа Соёлын яамаар дамжуулж парламентад тавина. Жилийн тайлан болон корпорацийн төлөвлөгөөний хураангуйг парламентад жил бүр танилцуулна. Мөн түүнчлэн үйл ажиллагааны тайлангаа Канадын радио телевиз болон харилцаа холбооны комисст тайлагнаж, санхүүгийн тайлангаа танилцуулдаг.

[212] Мөн тэнд.

Эрх зүйн зохицуулалтын хувьд хуульдаа ерөнхий зохицуулалтыг тусгаад дүрмээр тухайн байгууллагын эрх зүйн байдлыг нарийвчлан зохицуулдаг нь харагдаж байна.

Канадын радио-телевиз болон харилцаа холбооны хороо /комисс/ нь радио телевизийн корпорацийн үйл ажиллагаанд чиглэл өгч, удирдан чиглүүлж хяналт тавьдаг байгууллага юм. Хуулийн зарим заалтын орчуулгыг хавсаргав.

Хоёр. КИПРИЙН МЭДЭЭЛЛИЙН АГЕНТЛАГИЙН ТУХАЙ

2.1 Агентлагийн баримтлах зарчим

- хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах
- үнэн бодитой, баталгаатай, бүрэн дүүрэн мэдээллийг түгээх
- нам, бүлгийн эрхшээлд үл орж, тэдний эрх ашигт үл үйлчлэх
- байгууллагаа хөгжүүлэх, бодит мэдээлэл өгөх үүднээс үйл ажиллагаагаа явуулах
- аливаа үйл явдал, үйл ажиллагаанд мэдрэмжтэй хандах

2.2 Агентлагийн удирдлага [213]

2./1/ Агентлагийг нь дарга болон бусад зургаан гишүүн, нийт долоон хүний бүрэлдэхүүнтэй Захирлын Зөвлөл удирдана. Захирлуудын зөвлөлийн гишүүдийг Сайдын Зөвлөлөөс томилно.

2.2.1 Захирлын зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүн, түүнд тавигдах шаардлага

Захирлын Зөвлөлийн бүх гишүүд Бүгд Найрамдах Кипр Улсын иргэд байна.

a/ Дарга нь өндөр мэдлэг боловсрол, ёс суртахуунтай, эн тэргүүнд сэтгүүлч буюу шинжлэх ухааны, эсхүл хуулийн мэргэжлийн хүн байвал зохино.

b/ Сайдын зөвлөмж болгосны дагуу өөр нэг гишүүн нь сэтгүүлч мэргэжилтэй байна.

c/Киприйн Сонин сэтгүүлийн Эздийн Холбоо, Киприйн Сэтгүүлчдийн Эвлэл болон Киприйн Өргөн нэвтрүүлгийн Корпораци тус бүр нэг гишүүнийг томилно.

d/Үлдсэн хоёр гишүүнийг Хэвлэл, Мэдээллийн Газраас томилно.

2.2.2 Захирлын зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа[214]

Дарга болон Захирлын Зөвлөлийн бусад гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 3 жил байх бөгөөд шинээр томилж болно.

Захирлын Зөвлөлийн гишүүдийн олонх нь санал болгож, Сайд нарын Зөвлөл батлахаас бусад тохиолдолд Дарга болон Захирлын Зөвлөлийн бусад гишүүний үүрэгт ажлыг нь тэдгээрийн бүрэн эрхийн хугацаа дуусахаас нааш дуусгавар болгож үл болно.

[213] http://www.olc.gov.cy/olc/olc.nsf/all/E4DDE765066C381F422576C10030C2E7/$file/The%20Cyprus%20News%20Agency%20Laws%201989%20to%202005.pdf?openelement /сүүлд үзсэн 2011.04.08/

[214] Мөн тэнд/Киприйн мэдээллийн агентлагийн тухай хуулийн 3 хэсэг/

Харин Сайд нарын Зөвлөл хүндэтгэн үзэх учир шалтгаанаар аливаа гишүүний томилгоог дуусгавар болгох, эсхүл тухайн албан тушаалд орон тоо гарсан тухай мэдэгдэж болно.

Дарга эсхүл Захирлын Зөвлөлийн аль нэг гишүүний албан тушаалд орон тоо гарсан тохиолдолд бүрэн эрхийн хугацаа дуусах хүртэл үлдэж буй хугацаанд тухайн албан тушаалд шинээр хүн томилох, эсхүл томилохоор зөвлөмж болгоно.

Захирлын Зөвлөл нь анхны хуралдаанаараа Хэвлэлийн байгууллагуудыг төлөөлсөн бүх гишүүдийн дотроос даргыг түр хугацаагаар эзгүй байх үед юмуу албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд үүрэг гүйцэтгэгчээр нь ажиллах Захирлын Зөвлөлийн дэд даргыг сонгоно. Дээрх тохиолдолд дэд дарга захирлын зөвлөлийн даргын бүх үүргийг хүлээнэ. Агентлагийн нэг ажилтан Захирлын Зөвлөлийн нарийн бичгийн дарга байна.

2.3. Захирлын зөвлөлийн хуралдаан[215]

/7/[216] /а/ Дарга Захирлын Зөвлөлийн хуралдааныг зарлан хийлгэх бөгөөд хуралдааныг даргална.

/б/ Даргаас гадна гурван гишүүн ирсэн бол хуралдааны ирц бүрдсэн гэж үзнэ.

/в/ Зөвлөл хүрэлцэн ирсэн бүх гишүүдийн олонхийн саналаар шийдвэр гаргах боловч санал тэнцсэн тохиолдолд дахин санал хураана.

/г/ Хуралдаантай холбогдсон бусад нарийн асуудлыг Зөвлөлөөс гаргасан дотоод журмаар зохицуулна.

Энэхүү хуульд өөрөөр заагаагүй, эсхүл Зөвлөл өөрөөр шийдэгдэгүй бол дарга буюу дэд дарга, эсхүл Зөвлөлөөс холбогдох зөвшөөрөл олгосноор Зөвлөлийн аль нэг гишүүн, эсхүл Захирал Агентлагийг бүх харилцаанд төлөөлнө.

Зөвлөлийн бүх гишүүд Сайд нарын Зөвлөлөөс тодорхойлсон хэмжээний цалин хөлс авч болно.

2.4 Агентлагийн алба

8. /1/ Агентлаг нь зорилгоо биелүүлэхэд нь шаардлагатай өөрийн гэсэн байр болон албатай байна.

/2/ Агентлагийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүднээс Захирал болон ажилтнуудыг томилно.

2.4.1 Агентлагийн захирлын томилгоо

/3/ Захирлыг 9-р зүйлийн 1–д заасны дагуу томилно.

9. /1/ Агентлагийн Захирлыг Агентлагийн Захирлын Зөвлөлийн саналыг үндэслэн Сайд нарын Зөвлөл томилно.

/2/ Захирал нь Агентлагийн гүйцэтгэх гол байгууллага байх бөгөөд Агентлагийн үйл ажиллагааг даргална. Зөвлөлөөс гаргасан гол шийдвэрийг биелүүлж, өөр бусад үүрэг даалгаврыг гүйцэтгэнэ. Зөвлөлөөс түүнд тухай бүр өгсөн чиглэлийн дагуу ажиллана.

[215] Мөн тэнд

[216] Мөн тус хуулийн 7-р зүйл

/3/ Зөвлөл нь өөрт ногдсон аливаа ажил үүргийг эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэж, Зөвлөлийг төлөөлөн ажиллах, Агентлагийн үйл ажиллагааг саадгүй, үр бүтээлтэй явуулахад шаадлагатай гэж үзсэн аливаа арга хэмжээг авч хэрэгжүүлэх эрхийг Захиралд олгоно.

/4/ /Зөвлөлөөс өөрөөр шийдээгүй бол/ Захирал нь Зөвлөлийн бүх хуралдаанд санал өгөх эрхгүйгээр оролцоно.

2.4.2 Агентлагийн ажилтнуудын томилгоо

Агентлагийн ажилтнуудыг Зөвлөл томилох бөгөөд Зөвлөлийн хяналт дор ажиллана.

Хууль болон дэд актуудын дагуу Зөвлөл нь тухайн хүн Бүгд Найрамдах Кипр Улсын иргэн эсэхээс үл хамаарч албан тушаалд тавигдах бүх шаардлагыг хангаж байвал хэнийг ч ажилтнаар томилж болно.

Албан ажил үүргээ гүйцэтгэж буй ажилтан, өөр хэн нэг ажилтан Агентлагт ажил үүргээ гүйцэтгэж байх үедээ авлига, эсхүл хээл хахууль авсаныг олж мэдсэн, эсхүл ингэж үзэх үндэслэл байгаа бол энэ тухайгаа Зөвлөлд бичгээр мэдэгдэх, түүнийгээ баталгаажуулсан нарийн тодорхой бүх мэдээллийг өгөх үүрэгтэй. Ингэхдээ энд "ажилтан" хэмээх нэр томьёонд Захирал төдийгүй Агентлагт түр хугацаагаар ажилд орсон хүн ч багтана.

2.5 Санхүүгийн нөхцөлүүд

11. /1/ Агентлаг нь жил бүр Зөвлөлөөс бэлтгэсэн өөрийн төсөвтэй байх бөгөөд төсвийг Сайд нарын Зөвлөл болон Төлөөлөгчдийн танхим батлана. Уг төсөв нэгдүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 12 дугаар сарын 31-ний өдөр дуусах санхүүгийн жил тутамд Агентлагаас санхүүгийн үйл ажиллагаа явуулахад зарцуулагдана.

/2/ Сангийн сайд төсвийг хэрхэн бэлтгэх, орлого зарлагын хуваарилалтыг хэрхэн хийхийг тодорхойлон өгч болно.

12. /1/ Агентлаг нь үйл ажиллагааныхаа бүртгэл тооцоо, дансыг Сангийн сайдын тодорхойлсны дагуу хөтлөн явуулна.

/1А/ Кипр улсын талаар олон нийтийн хэвлэл мэдээллийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа, мөн арилжааны үйл ажиллагаа явуулах зорилгоор тусдаа данстай байна. Данс тооцоог хөтлөн явуулахдаа тухайн үеийн арилжааны практик, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмыг мөрдлөг болгон дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

а/ Янз бүрийн үйл ажиллагаатай холбогдсон дотоод данс тооцоог салангид тусад нь байлгана;

b/ Бүх орлого, зарлагыг бодит үндэслэлтэйгээр шинжлэн дүгнэсэн тооцооны үндсэн дээр зөв хуваарилах буюу бүртгэн тооцно;

с/ Шинжлэн дүгнэсэн тооцоог нарийн тодорхой хийж, тэр үндсэн дээр салангид данс тооцоог явуулна.

/2/ Жил бүрийн тайланг Зөвлөлийн удирдлагадор, санхүүгийн жил тутмын санхүүгийн менежментэд тулгуурлан Сангийн сайдын тодорхойлсноор, эсхүл аль нэг байдлаар бэлтгэнэ.

/3/ /a/ Агентлагийн данс тооцоонд Улсын Ерөнхий аудитор аудитын шалгалт хийж, Зөвлөлд танилцуулна.

/b/ Ерөнхий Аудитор арилжааны үйл ажиллагаа болон Кипр улсын талаар олон нийтийн хэвлэл мэдээллийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой үйл ажиллагааны хоорондох санхүү, эдийн засгийн болзошгүй өөрчлөлтийг тусган харуулсан тайланг бэлтгэнэ.

/4/ Агентлагийн данс тооцоонд аудитын шалгалт хийж дуусмагц Зөвлөл санхүүгийн менежментийн тайланг Ерөнхий Аудиторын тайлангийн хуулбарын хамт Сайд нарын Зөвлөл болон Төлөөлөгчдийн танхимд мэдээлэхээр хүргүүлнэ. Агентлаг нь санхүүгийн, менежментийн тайлан болон Ерөнхий Аудиторын тайланг Сайд нарын Зөвлөлөөс тодорхойлсон ёсоор нийтлүүлж болно.

13. /1/ Агентлаг нь дараах хөрөнгө мөнгөнөөс бүрдсэн сантай байна. Үүнд:

/a/ Агентлагт өгсөн хандив тусламж;

/b/ аливаа тэтгэмж, бусад орлого буюу агентлагийн хэрэгцээнд зориулж хуримтлуулсан аливаа мөнгөн хөрөнгө;

/c/ Агентлагийн мэдээ мэдээлэл болон бусад хэвлэмэл бүтээгдэхүүн, түүний дотор гэрэл зураг;

/d/ Агентлагийн өмч хөрөнгөөс үүдэлтэй бусад аливаа орлого;

/e/ Засгийн газрын аливаа мөнгөн тусламж

/2/ Дараах төлбөрүүдийг агентлагийн сангуудаас хийнэ. Үүнд:

/a/ Агентлагийн ажилтнуудын бүх цалин, Зөвлөлийн гишүүдэд олгох нөхөн төлбөр;

/b/ холбогдох бусад байгууллагад агентлагаас өргөх хандив;

/c/ Агентлагийн аливаа зээлийн төлбөр;

/d/ хуулийн дагуу агентлагаас төлөх бусад аливаа өр зээл.

/3/ Хууль ёсны төлбөр тооцоо хийхэд зайлшгүй шаардлагатай бус Агентлагийн аливаа мөнгөн хөрөнгийг Сангийн сайдын тодорхойлсон ёсоор оруулж болно.

14. /1/ Агентлаг нь зорилгоо биелүүлэх үүднээс олон нийт буюу төрийн зүгээс дэмжлэг туслалцаа үзүүлэх одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дүрэм журмын дагуу зээлийн гэрээ байгуулахдаа Сайд нарын Зөвлөлөөс тодорхойлсон нөхцөл болзол хийгээд эх үүсвэрийг дагаж мөрдөнө.

/2/ Олон нийт буюу төрийн зүгээс дэмжлэг туслалцаа үзүүлэхдээ одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дүрэм журмын дагуу Сайд нарын Зөвлөлийн шийдвэрийг үндэслэн Сангийн сайд Агентлагийн аливаа зээлийн төлбөрийн баталгааг гаргаж өгнө.

<u>Дүгнэлт:</u>

Кипр улсын мэдээллийн агентлаг нь өөрийн гэсэн бие даасан хуультай. Тус хуулиар мэдээллийн агентлагийн бүтэц тогтолцоо, бүрэлдэхүүн, удирдлагын эрх хэмжээ, санхүүгийн нөхцөл зэрэг шаардлагатай зохицуулалтыг тус хуульд тусгажээ. Агентлагийн даргыг захирлын зөвлөлийн саналыг үндэслэн Сайд нарын зөвлөлөөс томилно. Агентлагийн даргыг

оролцуулаад нийт 7 хүний бүрэлдэхүүнтэй захирлын зөвлөл ажиллана. Кипр улсын хувьд захирлын зөвлөлд орох гишүүдэд тавигдах шаардлага, мэдээллийн агентлагийн баримтлах зарчмыг зааж өгсөн нь давуу талтай.

Кипр улсын агентлаг нь төрөөс санхүүждэг. Агентлагийн захирлын зөвлөлөөс бэлтгэсэн төсвийг Сайд нарын зөвлөл болон Төлөөлөгчдийн танхим баталдаг. Сангийн сайд нь ямар төсөвтэй байх вэ, мөнгийг юунд зарцуулах вэ, орлого, зарлага нь ямар байх вэ гэдгийг тодорхойлдог. Агентлаг нь олон нийтийн болон арилжааны үйл ажиллагаа явуулахдаа тусдаа данс нээж, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу хөтлөн явуулна. Санхүүгийн зарцуулалтанд ерөнхий аудитор хяналт тавьж шалгалтын тайланг захирлын зөвлөлд танилцуулна. Дараа нь аудитын тайланг Сайд нарын зөвлөл болон Төлөөлөгчдийн танхимд хүргүүлнэ. Мөн түүнчлэн агентлаг нь тусдаа сантай байж болно гэж заасан.

Агентлаг нь ажлаа Сайд нарын зөвлөл болон төлөөлөгчдийн танхимд тайлагнана. Кипр улсын мэдээллийн агентлагийн санхүүгийн хяналт хатуу, харин ажилтанг ажилд авахдаа ажлын байранд тавигдсан шаардлага хангаж байвал заавал Кипр улсын иргэн байх албагүй гэсэн хүний нөөцийн чөлөөт бодлого баримталдаг байна.

Гурав. БНХАУ-ЫН СИНЬХУА АГЕНТЛАГ

3.1 Ерөнхий танилцуулга[217]

Мэдээллийн Синьхуа агентлаг нь БНХАУ-ын мэдээллийн төв бөгөөд Хятадын Засгийн газрын бүтцэд шууд харьяалагдаж, үйл ажиллагаа явуулдаг төрийн мэдээллийн албан ёсны байгууллага юм.

1931 оны 11 дүгээр сараас "Хятадын мэдээллийн улаан агентлаг" нэртэйгээр ажиллаж эхэлсэн бөгөөд 1937 онд нэрээ өөрчлөн "Синьхуа мэдээллийн агентлаг" нэртэй болсон. Товч нэр нь Синьхуа агентлаг. 1944 онд англи хэлээр гадаадад мэдээ цацаж эхэлсэн байна.

Тус агентлагийн төв байр Бээжинд байдаг. Дэлхийн өнцөг булан бүрт, нийтдээ 100 гаруй салбартай ба Хятадын эх газарт өөртөө засах орон, муж, шууд харьяалагдах хот болгонд салбар нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулдаг.

Дэлхий дахинд хятад хэлээр мэдээлэл хүргэдэг тус агентлаг мэдээгээ Ази, Ойрхи Дорнод, Латин Америк, Америкт нийлүүлж байна. Тухайлбал, Хонконг, Макао болон өөр бусад олон оронд сурвалжлагчийн товчоотой.

Тус агентлаг өнөөгийн байдлаар хятад, англи, франц, орос, испани, араб, португаль гэсэн 7 хэл дээр мэдээллээ цацаж байна.

Монгол Улсын МОНЦАМЭ, Синьхуа агентлагийн хооронд хамтран ажиллах хэлэлцээрийг 1958 оны 6 дугаар сарын 2-нд байгуулжээ.

3.2 Синьхуа агентлагийн бүтэц, зохион байгуулалт[218]

Синьхуа агентлаг удирдлагын хувьд агентлагийн дарга, ерөнхий редактор, агентлагийн 3 дэд дарга, нарийн бичгийн дарга, нарийн бичгийн

[217] http://zh.wikipedia.org/ /сүүлд үзсэн 2011.04.21/
[218] http://203.192.6.89/xhs/static/e11278/11278.htm /сүүлд үзсэн 2011.04.15/

дэд дарга, ерөнхий редакцийн хэлтсийн 4 дэд редактор гэсэн бүтэцтэй байна.

Түүнчлэн ***дотоод нэгж байгууллага, шууд харьяалагдах ажил үйлчилгээний байгууллага, шууд харьяалагдах аж ахуйн нэгж, байгууллага*** гэсэн бүтэцтэй.

Дотоод нэгж байгууллага:

1. Захиргааны танхим
2. Ерөнхий редакц
3. Дотоод мэдээний хэлтэс
4. Олон улсын мэдээний хэлтэс
5. Гадаад руу мэдээ бэлтгэх хэлтэс
6. Мэдээний зураг авалтын хэлтэс
7. Спортын мэдээний хэлтэс
8. Ерөнхий менежер
9. Захидал харилцаа, техникийн алба
10. Хүний нөөцийн алба
11. Гадаад хэргийн алба
12. Төлөвлөлт, санхүүгийн удирдах алба
13. Ажилчдыг ажлаас чөлөөлөх, тэтгэвэрт гарахтай холбоотой ажлын алба
14. Байгууллагын намын хороо
15. Хяналтын хороо

Үүнээс гадна **шууд харьяалагдах ажил үйлчилгээний байгууллага** гэсэн бүтцийн дор "Синьхуа өдөр тутмын цахилгаан мэдээ" агентлаг, "Эдийн засгийн мэдээ" агентлаг, Синьхуа хэвлэлийн газар, Мэдээ мэдээллийн төв, Боловсрол, сургалтын төв, Мэдээллийн судалгааны институт, байгууллагын удирдлагын үйлчилгээний төв гэсэн байгууллагууд үйл ажиллагаа явуулдаг.

Шууд харьяалагдах аж ахуйн нэгж, байгууллага:

- Синьхуа нет ХХК
- Хятадын мэдээллийн хөгжлийн давтан сургалтын ХХК
- Синьхуа агентлагийн зар сурталчилгааны төв
- Синьхуа агентлагийн хэвлэх үйлдвэр
- Хятадын зургийн үйлдвэр
- "Хятадын үнэт цаасны мэдээ" агентлаг
- "Шанхайн үнэт цаасны мэдээ" агентлаг
- "Шинэ үеийн шуурхай мэдээ" агентлаг зэрэг 10 аж ахуйн нэгжтэй.

Түүнчлэн салбар төлөөлөгчийн газар байгуулж ажиллуулдаг. Тэдгээрийг улс дотоодод байгуулагдсан ба гадаадад байгуулагдсан салбар нэгж гэж ангилна.

Синьхуа агентлагийн албан ёсны сайтад байрлуулсан тус агентлагийн түүхэн хөгжлийн тухай танилцуулгад[219] дурдсанаар 1955 онд Мао Зе Дун дарга Синьхуа агентлагт хандаж "бүх дэлхий даяар биднийг сонсдог болох"

[219] http://203.192.6.89/xhs/lsyg.htm /сүүлд үзсэн 2011.04.15/

тухай хүсч байгаагаа хэлсэн цагаас эхлэн Дэн Сяо Пин, Зян Зяо Мин нарын үе үеийн дарга удирдлагууд тус байгууллагын үйл ажиллагааны тайлантай танилцаж иржээ. Тухайлбал: 1995 онд Зянь Зэ Мин дарга Төв улс төрийн товчооны хурал дээр Синьхуа агентлагийн Намын хорооны ажлын тайланг сонсож, тус агентлагийн үйл ажиллагаа зөвхөн Хятадад төдийгүй дэлхий дахинаа нөлөө бүхий болсныг тэмдэглэсэн бол Ху Жин Тао даргын үед ч өндөр ач холбогдол өгч, 2002 оны 12 дугаар сарын 4-ны өдөр Улс төрийн төв товчооны Ли Жан Чун дарга Синьхуа агентлагт хийсэн ажлын айлчлалын үеэр Ху Жин Тао даргын дэвшүүлсэн оюун санааны салбарын ажлын 6 гол зарчмыг сурталчлан Синьхуа агентлаг мөн шинэ бодлого, шинэ шаардлагын дор ажиллах хэрэгтэйг хэлсэн байна. Эдгээр түүхэн баримтаас харахад Синьхуа агентлаг Төрийн Зөвлөл, Улс төрийн төв товчоонд ажлаа тайлагнадаг байна.

3.3 Синьхуа агентлагийн 4 чиг үүрэг:

1. Нам засаг, иргэдийн нүд, чих, хоолой болох
2. Төрийн мэдээллийн агентлаг
3. Мэдээллийн бааз, суурь
4. Дэлхий нийтийн чанартай мэдээллийн агентлаг

Дээрх чиг үүргээ дараах 3 хэлбэрээр хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Мэдээллийн уламжлалт хэв загвараар. Энэ нь бичиг үсэг, фото зураг, дүрст мэдээ баримтаас бүрдэх олон улсын талаар болон улс дотоодын мэдээг хэлнэ.

2. Шинэ арга хэлбэр буюу шинэ технологи нөхцөл интернет сайт, радио, телевизийн сувгаар, гар утсанд мессежээр мэдээ түгээх зэрэг болно.

3. Хэвлэн нийтлэх хэлбэрийг зохион байгуулах замаар.

Синьхуа агентлаг 24 цагийн турш англи хэлээр мэдээ, мэдээлэл нэвтрүүлэх телевизийн суваг нээн ажиллуулж эхлээд байна.

Нэвтрүүлэг дамжуулах асуудлыг "Синьхуа" агентлагт харьяалагддаг телевизийн "China Network Corporation" компани хариуцдаг. Шинэ сувгаар дэлхийд болон Хятадад болж буй үйл явдлын болон бизнес, соёлын мэдээ, мэдээлэл дамжуулна.

Тус агентлагийн мэдээлснээр шинэ суваг хиймэл дагуул, кабелийн сүлжээгээр дамжуулан Хойд Америк, Европ, Африк, Ази Номхон далайн болон бусад бүс нутагт гарна.

Гадаадын агентлагийн тэмдэглэснээр Хятадад болж буй үйл явдлын талаарх дэлхийн мэдээллийн хэрэгслүүдийн мэдээлэлд тус улсын эрх баригчид сэтгэл хангалуун бус байдаг бөгөөд гадаадын мэдээллийн компаниуд хэт их таамаг дэвшүүлж, зөвхөн сөрөг мэдээлэлд анхаарлаа хандуулдаг гэж Хятадын эрх баригчид үздэг тул ийм арга хэмжээ авч ажиллуулж байна гэж үзжээ. Үүнийг дараах дэд сэдвээр дэлгэрүүлж судаллаа.

3.4"Гадаадын мэдээллийн агентлаг БНХАУ-ын нутаг дэвсгэрт мэдээ мэдээлэл нэвтрүүлэхийг зохицуулах арга хэмжээ"[220] буюу Синьхуа агентлаг гадаадын мэдээний агентлагтай харьцах харилцаа

[220] Тус зохицуулалтын гол үзэл баримтлалыг дэлгэрэнгүй тусгав.

БНХАУ-ын Синьхуа агентлаг 2006 онд "БНХАУ-ын нутаг дэвсгэрт Гадаадын мэдээллийн агентлаг мэдээ мэдээлэл нэвтрүүлэхийг зохицуулах арга хэмжээ" нэртэй зохицуулалтыг баталж мөрдөх болсон нь бусад мэдээний агентлаг Хятадад үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндэс болон Синьхуа агентлаг бусад мэдээний агентлагуудтай хэрхэн харилцах талаар хуульчлан зохицуулсан байна.

Тус арга хэмжээний 3 дугаар зүйлд "Гадаад улсын мэдээний агентлагаас БНХАУ-ын нутаг дэвсгэрт мэдээ мэдээлэл нэвтрүүлэхэд Синьхуа агентлаг нь нэгдсэн зохицуулалтыг хэрэгжүүлнэ" гэж заасан нь гадаад улсуудын мэдээний агентлагийн үйл ажиллагааг Синьхуа агентлаг зохицуулж ажиллах эрх хэмжээг зааж өгсөн байна. Өөрөөр хэлбэл энэ нь гадаад улсын мэдээ мэдээллийн аливаа агентлаг хятадын нутаг дэвсгэрт мэдээ мэдээллийн үйл ажиллагааг дурааараа, шууд эрхлэн явуулахыг хориглосон заалт юм.

Гадаадын мэдээний агентлаг Хятадын нутаг дэвсгэрт мэдээ мэдээлэл нэвтрүүлэхэд болон улс дотоодын хэрэглэгч гадаадын мэдээний агентлагийн мэдээг захиалан ашиглахад мэдээ, мэдээллийн зүй зохистой, эмх журамтай байх явдлыг анхаарч, төрийн хууль, захиргааны акт болон Төрийн Зөвлөлийн холбогдох журмыг үндэслэн тус арга хэмжээг тогтоосон гэж заажээ.

Гадаадын мэдээний агентлаг тус улсад мэдээ цацах үйл ажиллагаа явуулахдаа холбогдох бичиг баримтаа бүрдүүлэн Синьхуа агентлагт өргөдөл гаргаж тус өргөдлийг 20 хоногийн дотор шийдвэрлэж, зөвшөөрөл олгох талаар заасан. Хэрвээ зөвшөөрөхгүй тохиолдолд ямар үндэслэл, учир шалтгаанаар зөвшөөрөл олгоогүй талаар бичгээр хариу мэдэгдэнэ гэж тус арга хэмжээний 8 дугаар зүйлд тусгасан байна.

Гадаад улсын мэдээллийн агентлаг нь БНХАУ-ын нутаг дэвсгэрт мэдээ, мэдээлэл нэвтрүүлэх бол дараах нөхцөлийг хангасан байх ёстой. Үүнд:

- тухайн улс /бүс нутагт/ оронд хууль ёсны, зохих хэмжээний хөрөнгөтэй байх,
- Мэдээ, мэдээллийн үйл ажилагаа явуулдаг салбартаа нэр хүнд сайтай байх,
- Үйл ажиллагаандаа тохирсон технологи, навтрүүлэх арга хэрэгсэлтэй байх,
- Хятадын хууль, захиргааны актад заасан бусад нөхцөлийг хангасан байх.

Тус зохицуулалтын 11 дүгээр зүйлд тус улсын нутаг дэвсгэрт гадаад улсын мэдээний агентлагийн нэвтрүүлэх мэдээ дараах агуулгыг багтааж болохгүй гэжээ. Үүнд:

- *"БНХАУ-ын Үндсэн хууль"-д заасан үндсэн зарчмыг зөрчсөн;*
- *Хятад Улсын нэгдмэл, бүрэн эрхт, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг бусниулах;*
- *Хятадын улсын аюулгүй байдал, улсын нэр хүнд, ашиг сонирхлыг хохироосон;*
- *Хятадын үндэстнүүдийг алагчлах, үндэстний эв нэгдлийг бутаргах, үндэсний ёс заншлыг сүйтгэх, үндэстний өөрмөц сэтгэлгээг хохироосон;*

- Худал, хуурмаг мэдээг тараах, хятадын эдийн засаг, нийгмийн эмх журмыг алдагдуулж, хятадын нийгмийн тогтвортой байдлыг бусниулсан;

- Түрэмгийлэлд уриалсан, гэмт хэрэгт хүч турхирсан, зааж чиглүүлсэн;

- Бусад этгээдийг гутаан доромжилсон, гүтгэсэн, бусдын хууль ёсны ашиг сонирхлыг хохироосон;

- Нийгмийн ёс суртахуун ба хятадын үндэстний соёлын шилдэг уламжлалд хохирол учруулах;

- Хятадын хууль, захиргааны актаар хориглосон бусад зүйл;

Энэхүү заалтаас харахад улс үндэстэн, ард түмний нэгдмэл, нийтлэг ашиг сонирхолд харшлах, хохироох, бусниулах шинж бүхий замбараагүй мэдээ, мэдээлэл хятад улсын нутаг дэвсгэрт нэвтрэх явдлаас урьдчилан сэргийлэх гол зорилгыг агуулсан байна.

Синьхуа мэдээллийн агентлаг Хятад Улсын нутаг дэвсгэрт гадаад улсын мэдээллийн агентлагийн нэвтрүүлэх мэдээ, мэдээллийг сонгох эрхтэй бөгөөд тус арга хэмжээний 11 дүгээр зүйлд заасан агуулгатай мэдээллийг хасах эрхтэй ажээ.

Улс дотоодын хэрэглэгч гадаадын мэдээ, мэдээллийг захиалан ашиглахдаа эх сурвалжийг сайн тодруулах шаардлагатай ба ямар нэгэн арга хэлбэрээр мэдээг бусдад дамжуулж ашиглуулахыг хориглоно.

Тус арга хэмжээн дэх зөрчлийг шийдвэрлэхтэй холбоотой заалтууд

Гадаадын мэдээ, мэдээллийн агентлаг тус арга хэмжээнд заасныг зөрчин дараах зөрчил гаргавал Синьхуа агентлагаас хөнгөн зөрчлийг анхааруулах, тодорхой хугацаатайгаар засч өөрчлөх, тодорхой агуулгаар мэдээ нэвтрүүлэхийг түр хугацаагаар зогсоох, нэвтрүүлэх эрхийг түр хугацаагаар зогсоох, эсхүл хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авна. Үүнд:

1.Зөвшөөрөл олгосон баримт бичиг дээр зааснаас гадуур өөр хүрээний мэдээлэл нэвтрүүлэх

2.Мэдээний агуулгад тус арга хэмжээний 11 дүгээр зүйлд заасан агуулга багтсан бол

Улс дотоодын хэрэглэгч тус арга хэмжээнд заасныг зөрчиж, дараахь зөрчлөөс аль нэг зөрчлийг гаргавал Синьхуа агентлагаас хөнгөн зөрчлийг анхааруулах, тодорхой хугацаатайгаар засвар хийлгэх, зохих байгууллагын захиалан ашиглах гэрээ хэлэлцээрийг зогсоох, эсхүл хүчингүй болгох тушаал гаргана . Үүнд:

1.гадаад улсын мэдээллийн агентлагтай байгуулсан захиалан ашиглах гэрээ хэлэлцээрт заасан хүрээнээс гадуур тухайн мэдээ, мэдээлийг ашигласан бол;

2.гадаадын мэдээллийн агентлагаас захиалан ашиглах мэдээллийг бусдад дамжуулж ашиглуулсан бол;

3.гадаадын мэдээллийн агентлагийн мэдээллийн эх үүсвэрийг тодруулаагүй бол.

Түүнчлэн тус арга хэмжээг зөрчиж, дараах тохиолдол илэрвэл Синьхуа

агентлагаас Төрийн Зөвлөлийн холбогдох яаманд мэдүүлж хуулийн дагуу дараах захиргааны шийтгэлийг оногдуулна. Үүнд:

1.Синьхуа агентлагаас зөвшөөрөл авалгүйгээр мэдээ, мэдээлэл нэвтрүүлсэн, эсхүл Синьхуа агентлаг зааснаас өөр гадаадын агентлагийн мэдээ мэдээллийг захиалан ашигласан;

2.гадаадын мэдээллийн агентлагийн үйл ажилагааг нууцаар эрхлэн явуулсан, эсхүл төлөөлөн гүйцэтгэсэн;

3.гадаадын мэдээний агентлагийн мэдээг нууцаар орчуулан бэлтгэсэн, нийтлүүлсэн.

Синьхуа мэдээллийн агентлагийн ажилтан дараах зөрчил гаргавал Синьхуа агентлагаас сахилгын шийтгэл хүлээлгэнэ. Үүнд:

- Тус арга хэмжээнд заасан нөхцөлийг хангаагүй өргөдөл гаргагч эттэздэд зөвшөөрөл олгосон;
- Хяналт зохицуулалтын ажил үүргээ хуулийн дагуу гүйцэтгээгүй;
- Хууль бус мэдээ, мэдээлийг хүлээж авсны дараа шалган тогтоож шийдвэрлэх арга хэмжээ аваагүй;
- Албан тушаалаа урвуулан ашиглах, эрх мэдлээ хэтрүүлэн хэрэглэх, хувьдаа ашиг хонжоо олох үйлдэл хийх.

Дүгнэлт

Синьхуа агентлаг БНХАУ-ын Төрийн Зөвлөлд шууд харьяалагддаг, төрөөс санхүүждэг ажил үйлчилгээний байгууллага боловч тус агентлагийн бүтэц, зохион байгуулалтаас харахад эн тэргүүнд шаардлагатай дотоод бүтцийн нэгж, хэлтэс, албадаас гадна тус агентлаг ажил үйлчилгээгээ өргөжүүлэх, амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх шууд харьяаны ажил үйлчилгээ, бизнесийн байгууллага болон орон нутаг, гадаад улс оронд хүрч ажиллах салбар төлөөлөгчийн газруудыг мөн зохион байгуулж, эдгээр олон байгууллагуудын харилцаа, ажлын зохион байгуулалт, хуваарилалт, хамтын ажиллагааны үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулдаг болох нь харагдаж байна. Тухайлбал, тус агентлагийн харьяанд мэдээллийн байгууллагын үйл ажиллагаанд холбогдох судалгаа шинжилгээ, сургалтын болон хэвлэлийн, зар сурталчилгааны, мэргэшиж төрөлжсөн мэдээний фото болон бусад зургийн газар зэргийг хамтад нь хөгжүүлж ирсэн байна.

2006 онд "БНХАУ-ын нутаг дэвсгэрт Гадаадын мэдээллийн агентлаг мэдээ, мэдээлэл нэвтрүүлэхийг зохицуулах арга хэмжээ" нэртэй зохицуулалтыг баталж мөрдөх болсон нь бусад мэдээний агентлаг Хятадад үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндэс болон· Синьхуа агентлаг бусад мэдээний агентлагуудтай хэрхэн харилцах байдлыг хуульчлан зохицуулсан байна. "Гадаад улсын мэдээний агентлагаас БНХАУ-ын нутаг дэвсгэрт мэдээ, мэдээлэл нэвтрүүлэхэд Синьхуа агентлаг нь нэгдсэн зохицуулалтыг хэрэгжүүлнэ" гэж заасан нь гадаад улсуудын мэдээний агентлагийн үйл ажиллагааг Синьхуа агентлаг зохицуулж ажиллах эрх хэмжээг тусгайлан олгожээ.

Тус зохицуулалтаар улс үндэстэн, ард түмний нэгдмэл, нийтлэг ашиг сонирхолд харшлах, хохироох, бусниулах шинж бүхий замбараагүй мэдээ,

мэдээлэл хятад улсын нутаг дэвсгэрт нэвтрэх явдлаас урьдчилан сэргийлэх гол зорилгыг агуулсан байна гэж дүгнэж болно. Улс дотоодын хэрэглэгч гадаадын мэдээ, мэдээллийг захиалан ашиглахдаа эх сурвалжийг сайн тодруулах шаардлагатай ба ямар нэгэн арга хэлбэрээр мэдээг бусдад дамжуулж ашиглуулахыг хориглосон байгаа нь мөн ач холбогдолтой юм.

Дөрөв. ОХУ-ЫН ИТАР-ТАСС АГЕНТЛАГИЙН ТУХАЙ

1904 онд үүсгэн байгуулагдсан ОХУ-ын Итар-Тасс агентлаг нь улс төр, эдийн засаг, нийгэм, соёл урлаг, спортын талаар орос, англи, франц, герман, испани, араб хэл дээр өдөр бүр 200 гаруй мэдээ, мэдээлэл түгээдэг байна. ЮНЕСКО-гийн тодорхойлсноор /Reuters, Associated Press болон Agence France-Presse-ын/ нэгэн адилаар дэлхийн хамгийн том 4 мэдээллийн агентлагийн нэгт ордог байна.

4.1 Итар-тасс агентлагийн түүхэн замнал

4.1.1 Санкт-Петербургийн цахилгаан мэдээллийн агентлаг /1904-1914/

1904 оны 9 дүгээр сард *Санкт-Петербургийн цахилгаан мэдээллийн агентлаг* буюу ОХУ дахь анхны мэдээллийн агентлагийн хувиар /ирээдүйн Итар-тасс агентлаг/ үүсгэн байгуулагджээ. Оросын эзэнт гүрний Дотоод явдлын яам, Гадаад хэргийн яам, Сангийн яамны хамтын санаачилгаар "олон нийтийн сонирхол татахуйц улс төр, санхүү, эдийн засгийн, худалдааны болон бусад төрлийн мэдээллийг эзэнт гүрний дотор болон гадагш мэдээлэх үүрэг бүхий" агентлагийг байгуулжээ[221]. Оросын эзэнт гүрний Засгийн газрын тэргүүний 1909 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн шийдвэрээр тус агентлаг Оросын эзэнт гүрний Сайд нарын зөвлөлийн удирдлага дор шилжсэн байна[222].

4.1.2 Петроградын цахилгаан мэдээллийн агентлаг /1914-1918/

1914 оны 8 дугаар сарын 19-ний өдөр Санкт-Петербург хотыг Петроград хот хэмээн болгон өөрчлөгдсөнтэй холбогдуулан Петроградын цахилгаан мэдээллийн агентлаг хэмээн нэрлэгдсэн байна. 1918 оны 3 дугаар сараас тус агентлаг нь Москва хотод байрлах болсон байна.

4.1.3 Оросын цахилгаан мэдээллийн агентлаг /1918-1935/

1918 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр ЗХУ-ын Гүйцэтгэх Төв хорооны шийдвэрийн дагуу Петроградын цахилгаан мэдээллийн агентлагийг хорооны дэргэдэх Хэвлэлийн хүрээлэнтэй нийлүүлэх тухай шийдвэр гаргажээ. Ийнхүү шинээр зохион байгуулагдсан агентлаг нь ЗХУ-ын Гүйцэтгэх Төв хорооны дэргэдэх "Оросын цахилгаан мэдээллийн агентлаг" буюу товчилсноор "РОСТА" хэмээн нэрлэгдэх болжээ. РОСТА нь Зөвлөлтийн мэдээ, мэдээлэл түгээлтийн төв байгууллагын үүрэг гүйцэтгэх болсон байна.

[221] Страницы истории http://www.tass-online.ru/?page=pages&pageID=7&langID=1 /сүүлд үзсэн 2011.04.26/

[222] Мөн тэнд.

4.1.4 Зөвлөлт Холбоот Улсын цахилгаан мэдээллийн агентлаг буюу ТАСС агентлаг[223] /1925-1935/

1925 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн ЗХУ-ын Гүйцэтгэх Төв хороо, Ардын Комиссаруудын Холбооны Тэргүүлэгчдийн нэгдсэн хуралдааны тогтоолоор Зөвлөлт Холбоот Улсын цахилгаан мэдээллийн агентлаг буюу ТАСС агентлаг үүсгэн байгуулагдсан байна. Тус агентлаг нь зөвлөлтийн мэдээллийн төв байгууллагын үүргийг хүлээж, "ЗХУ-ын талаарх мэдээллийг ЗХУ-ын нутаг дэвсгэрээс гадна дамжуулах, ЗХУ-ын нутаг дэвсгэр дээр гадаад орны талаарх мэдээллийг түгээх **цорын ганц** эрх бүхий байгууллага" юм. ТАСС агентлагийн бүрэлдэхүүнд РАТАУ /Украйн/, БЕЛТА /Беларусь/, УЗТАГ/ Узбекистан/, КАЗТАГ/Казакстан/, ГРУЗИНФОРМ /Гурж/, АЗЕРИНФОРМ /А/, ЭЛЬТА /Литва/, АТЕМ /Молдав/, ЛАТИНФОРМ /Латви/, КИРТАГ /Киргизтан/, ТАЖЖИКТА /Таджикистан/, АРМЕНПРЕСС /Армен/, ТУРКМЕНИНФОРМ / Туркменистан/, ЭТА /Эстони/ зэрэг мэдээллийн агентлагууд багтсан байна. ТАСС агентлаг нь мэдээ, мэдээллийг 4 000 гаруй зөвлөлтийн сонин, сэтгүүл, телевиз, радио редакциуд, мянга гаруй гадаад улсын олон нийтийн хэвлэл мэдээллүүдэд түгээж, тэдгээрээс мэдээлэл хүлээн авдаг байсан. Мөн ТАСС агентлаг нь дэлхийд албан хаагчдын тоогоороо тэргүүлэх агентлаг буюу улс дотор 682 мэдээллийн төв, гадаад улсад 94 мэдээллийн төв, 2000 сэтгүүлчдийн бүрэлдэхүүнтэй байна.

4.1.5 Оросын цахилгаан мэдээ, мэдээллийн агентлаг /ИТАР-ТАСС/ /1992-өнөөг хүртэл/

Оросын цахилгаан мэдээ, мэдээллийн агентлаг /ИТАР-ТАСС/-ийг ОХУ тусгаар тогтнолоо зарласны дараа ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлигаар 1992 онд өөрчлөн зохион байгуулсан байна. 1993 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн "ОХУ дахь үндсэн хуулийн шинэчлэлийн үеийн эрх зүйн зохицуулалтын тухай" ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлигийн[224] дагуу "Оросын цахилгаан мэдээ, мэдээллийн агентлаг нь Зөвлөлт Холбоот Улсын цахилгаан мэдээллийн агентлаг буюу ТАСС агентлаг залгамжлагч агентлаг юм" хэмээн тогтоосон байна. 1994 оны 5 дугаар сарын 4-ний өдөр ОХУ-ын Засгийн газар "Оросын цахилгаан мэдээ, мэдээллийн агентлагийн Дүрмийг батлах тухай" тогтоолыг[225] баталжээ.

4.2 Итар-Тасс агентлагийн талаарх эрх зүйн зохицуулалт

1992 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр 37 тоот "Оросын цахилгаан мэдээ, мэдээллийн агентлагийн тухай" ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг[226], 1993 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 1371 тоот "ОХУ-ын Сайд нарын Зөвлөлийн

---

[223] Зөвлөлт Холбоот Улсын цахилгаан мэдээллийн агентлаг буюу Телеграфное агенство Советского союза /ТАСС/

[224] Указ Президента РФ от 7 октября 1993 года "О правовом регулировании в период поэтапной конституционной реформы в Российской Федерации"

[225] Постановление Правительства Российской Федерации "Об утверждении Устава Информационного телеграфного агентства России" 4 мая 1994 года

[226] Указ Президента Российской Федерации от 22 января 1992 г. N 37 "Об Информационном телеграфном агентстве России /ИТАР/"

дэргэдэх Оросын мэдээллийн агентлагийн тухай" ОХУ-ын Засгийн газрын тогтоол[227], 1994 оны 5 дугаар сарын 4-ний өдөр ОХУ-ын Засгийн газар "Оросын цахилгаан мэдээ, мэдээллийн агентлагийн Дүрмийг батлах тухай" тогтоолыг[228] тус тус баталжээ.

"ОХУ-ын Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх Оросын мэдээллийн агентлагийн тухай" ОХУ-ын Засгийн газрын тогтоолын 1-д заасны дагуу ОХУ-ын Дотоод явдлын яам, Гадаад харилцааны яам, Сангийн яам болон бусад төрийн байгууллагууд Итар-Тасс агентлагийн үйл ажиллагааг хангах чиглэлээр анхааран ажиллах үүрэг хүлээлгэсэн байна.

Итар-Тасс агентлагийн үүсгэн байгуулагчнь ОХУ-ын Засгийн газар бөгөөд төрийн өмчит байгууллагын хувиар төрийн мэдээллийн төв агентлагийн үүргийн дагуу үйл ажиллагаагаа эрхэлдэг байна. Итар-Тасс агентлагийн ерөнхий захирлыг ОХУ-ын Засгийн газрын тогтоолоор томилдог байна[229]. Итар-Тасс агентлагийн ОХУ-ын Засгийн газраас баталсан дүрэмд 2004 оны 11 дүгээр сард, 2007 оны 7 дугаар сард ОХУ-ын Засгийн газрын тогтоолоор тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Тус Дүрмээр Итар-Тасс агентлаг нь зорилго, үйл ажиллагааны чиглэл, агентлагийн хөрөнгө, агентлагийн эрх, үүрэг, агентлагийн удирдлага, зохион байгуулалт, агентлагийн салбар, төлөөлөгчийн газрууд, агентлагийг өөрчлөн зохион байгуулах, татан буулгах талаарх зохицуулалтуудыг агуулсан байна.

4.3 Итар-Тасс агентлагийн удирдлага, зохион байгуулалт

1994 оны 5 дугаар сарын 4-ний өдөр ОХУ-ын Засгийн газар "Оросын цахилгаан мэдээ, мэдээллийн агентлагийн Дүрмийг батлах тухай" тогтоолын 5 дугаар бүлгээр тус агентлагийн удирдлага, зохион байгуулалтын талаар зохицуулжээ.

Итар-Тасс агентлагийн удирдлагыг агентлагийн ерөнхий захирал хэрэгжүүлдэг бөгөөд түүнийг ОХУ-ын Засгийн газраас томилж, чөлөөлдөг байна. Агентлагийн Ерөнхий захирал агентлагийн гүйцэтгэх эрх мэдлийн цорын ганц хэрэгжүүлэгч субъект юм. Ерөнхий захирал итгэмжлэлгүйгээр агентлагийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа хэрэгжүүлэх, гэрээ байгуулах, тушаал, захирамж гаргах эрхтэй бөгөөд ОХУ-ын хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

Агентлагийн орлогч нар агентлагийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа эрхэлж, түүнийг төрийн байгууллагын өмнө буюу гадаад улсад төлөөлөх, ерөнхий захирлын олгосон эрх, үүргийн дагуу агентлагийн нэрийн өмнөөс гэрээ байгуулах эрхтэй[230].

ОХУ-ын хууль тогтоомжоор тодорхойлсон хүрээнд албаны болон хувийн нууцын хэмжээ, түүнийг олон нийтэд түгээх эсэх, хамгаалах журмыг агентлагийн ерөнхий захирал тогтоодог байна. Агентлагт ерөнхий захирлын

[227] Постановление Правительства Российской Федерации от 15 сентября 1993 г. "О Российском информационном агентстве при Совете Министров"

[228] Постановление Правительства Российской Федерации "Об утверждении Устава Информационного телеграфного агентства России" 4 мая 1994 года

[229] Постановление Правительства Российской Федерации от 15 сентября 1993 г. "О Российском информационном агентстве при Совете Министров"

[230] "Устав Информационного телеграфного агентства России" утвержденный Постановлением Правительства Российской Федерации 4 мая 1994 года, статья 32, 33.

тодорхойлсны дагуу бүрэлдэхүүнийг багтаасан зөвлөл үйл ажиллагаагаа эрхэлдэг. Тус зөвлөл нь агентлагийн цаашдын зорилтот хөгжил, дэвшил, хүний нөөцийн бодлого, агентлагийн төрийн болон төрийн бус байгууллагатай харилцах талаарх асуудлуудыг тодорхойлдог байна. Мөн зөвлөл нь агентлагийн салбарын удирдлагуудын өөрийн үйл ажиллагааны талаарх тайланг сонсож, орон тооны албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэдэг байна. Зөвлөлийн шийдвэрийг агентлагийн ерөнхийлөгчийн шийдвэрээр гүйцэлдүүлнэ.

Ерөнхий захирлын орлогч захирлыг ерөнхий захирлын санал болгосноор ОХУ-ын Засгийн газраас томилж, өөрчилнө. Засгийн газраас шийдвэрлэсний дагуу ерөнхий захирал орлогч захиралтай хөдөлмөрийн гэрээ байгуулах, цуцлах, тэдгээрийн эрх, үүргийг тодорхойлох эрхтэй.

4.4 Итар-Тасс агентлагийн санхүүжилт

1994 оны 5 дугаар сарын 4-ний өдөр ОХУ-ын Засгийн газар "Оросын цахилгаан мэдээ, мэдээллийн агентлагийн Дүрмийг батлах тухай" тогтоолын 4 дүгээр бүлгээр агентлагийн хөрөнгийн талаар зохилцуулжээ. Тухайлбал, 15 дугаар зүйлд зааснаар Итар-Тасс агентлагийн хөрөнгө холбооны төрийн эрх мэдэлд байна. Итар-Тасс агентлаг нь төсвийн байгууллагын хувиар төсвөөс санхүүжиж, олсон орлогоосоо төсөвт шилжүүлэх үүрэг хүлээнэ.

Итар-Тасс агентлагийн цэвэр активын хэмжээ болон Дүрмийн сангийн хэмжээг ОХУ-ын Засгийн газраас тогтоодог байна. Тухайлбал, 2004 оны 1 дүгээр сарын байдлаар ОХУ-ын Засгийн газраас тогтоосноор Итар-Тасс агентлагийн цэвэр активын хэмжээ 606 797 890 рубль, 2007 оны 7 дугаар сарын байдлаар Дүрмийн сангийн хэмжээ 411 100 097 рубль байна[231]. Агентлаг нь өөрийн эрх мэдлийн хүрээнд ОХУ-ын төрийн эд хөрөнгийг захиран зарцуулах холбооны агентлагийн зөвшөөрөлгүйгээр өөрийн хөдлөх эд хөрөнгө, олсон орлогоо захиран зарцуулах эрхтэй. Агентлаг нь ОХУ-ын Засгийн газраас тогтоосон хэмжээ, хугацаа, журмын дагуу татвар төлөлт, бусад үүргээр хүлээсэн төлбөрөө төлсөнөөс үлдсэн орлогын тодорхой хэсгийг жил бүр төсөвт оруулах үүрэг хүлээнэ. Үүнээс агентлагт үлдсэн мөнгөн дүнг дараах зорилгоор ашиглах эрхтэй. Үүнд:

- ✓ Шинэ техник, технологи олж авах, нэвтрүүлэх, барилга, байгууламж барих, засварлах, хүрээлэн буй орчны болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ зохион байгуулахад;
- ✓ Агентлагийн санхүү-аж ахуйн үйл ажиллагаа, хөрөнгийн эргэлтийг хөгжүүлэх, сан байгуулах чиглэлд;
- ✓ Гадаад валют, бусад үнэт зүйлс, үнэт цаас худалдаж авах /зээлийн байгууллагын үнэт цааснаас бусад/;
- ✓ Агентлагийн сурталчилгаа, хэрэглэгчийн зах зээлд чиглэсэн үйл ажиллагаанд;
- ✓ Агентлагийн албан хаагчдад орон сууц барих;
- ✓ Агентлагийн албан хаагчдын нийгмийн халамжийн нөхцөл байдлыг сайжруулах зэрэг чиглэлүүдэд хөрөнгө зарцуулах эрхтэй.

[231] "Устав Информационного телеграфного агентства России" утвержденный Постановлением Правительства Российской Федерации 4 мая 1994 года, статья 17

Агентлаг нь өөрийн Дүрмийн 23 дугаар зүйлд заасны дагуу Дүрмийн сангийн 10 хувиас доошгүй хэмжээтэй "эрсдлийн сан"-тай байх үүрэгтэй. Тус санг цэвэр орлогоос жил бүр 2 хувь оруулснаар бүрдүүлнэ. Мөн агентлаг нь бусад төрлийн сан үүсгэн байгуулах эрхтэй.

4.5 Агентлагийн бусад байгууллагуудтай харилцах харилцааны талаар

Агентлаг нь өөрийн дүрэмдээ заасны дагуу бусад байгууллага, хувь хүнтэй гэрээний үндсэн дээр харилцдаг. Мөн агентлаг нь өөрийн ажил, үйлчилгээний үнэ, тарифыг тогтоодог байна. Агентлаг нь өөрийн дүрэмд заасан зорилго, зорилтоо хэрэгжүүлэх үүднээс дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ[232]. Үүнд:

- Холбооны төрийн болон төрийн бус байгууллага, Холбооны субъектуудын төрийн болон төрийн бус байгууллага, иргэдээс мэдээ, мэдээлэл эхний ээлжинд олж авах;
- Өөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор салбар, төлөөлөгчийн газар байгуулах;
- Төрийн онцгой захиалга биелүүлэх;
- Хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх гэрээний үндсэн дээр хувь хүн, албан байгууллагаар ажил эрхлүүлэх, захиалга өгөх, мэдээ, мэдээлэл бэлтгэх эрхтэй.

Дүгнэлт

Дэлхийд тэргүүлэх байр суурийг эзэлж буй Итар-Тасс агентлаг нь ОХУ-ын хамгийн том, төрийн агентлаг юм. ОХУ-д мэдээ, мэдээллийн 1000 гаруй агентлаг байдаг төдийгүй төсвөөс санхүүждэг нь Итар-Тасс агентлагийн онцлог юм. Итар-Тасс агентлагийн эрх зүйн байдал, агентлагийн талаарх эрх зүйн зохицуулалтыг судлан авч үзэхэд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

✓ Итар-Тасс агентлаг нь төрийн өмчит байгууллагын хувьд ОХУ-ын Засгийн газраас санхүүжилттэй төдийгүй ОХУ-ын Засгийн газраас тухайн байгууллагын дүрмийг баталдаг байна.

✓ Итар-Тасс агентлагийн хувьд тус агентлагийн статусыг тодорхойлсон бие даасан хуульгүй. Итар-Тасс агентлагийн эрх зүйн статусыг 1994 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн "Оросын цахилгаан мэдээ, мэдээллийн агентлагийн Дүрмийг батлах тухай" ОХУ-ын Засгийн газрын тогтоолоор тодорхойлсон.

✓ Тус Дүрмийн хувьд тухайн агентлагийн эрх зүйн байдал, удирдлага, зохион байгуулалт, санхүүжилтийн асуудал, салбар, төлөөлөгчийн газрын талаар зохицуулсан байна. Ингэхдээ тодорхой асуудлыг ОХУ-ын хуулиар тодорхойлно гэсэн тодотголыг зарим бүлгүүд агуулсан байна.

✓ Тус Дүрмийн 4 дүгээр бүлэг, 27 дугаар зүйлд зааснаар агентлаг нь төрийн байгууллага, төрийн бус байгууллага, хувь хүнээс түгээх гэж буй мэдээ, мэдээллээ "*тэргүүн ээлжинд*" авах эрхийг зохицуулжээ.

[232] Мөн тэнд, статья 27

✓ **Итар-Тасс** агентлагийн удирдлагын хувьд ерөнхий захирал, ерөнхий захирлын орлогч нар гэсэн удирдлагын бүтэцтэй. Дүрмээр зохицуулснаар ерөнхий захирал нь ганц агентлагийн гүйцэтгэх эрх мэдлийн цорын ганц хэрэгжүүлэгч субъект хэмээн тогтоожээ. Мөн агентлагт зөвлөл үйл ажиллагаагаа эрхэлдэг төдийгүй энэхүү зөвлөл нь ерөнхий захирлын тодорхойлсон асуудлын хүрээнд байгууллагын хөгжлийн хөтөлбөр, хүний нөөцийн бодлогыг тодорхойлдог байна.

✓ Агентлагийн санхүүжилтийн хувьд төсвийн байгууллагын хувиар дүрмэнд зааснаар санхүүжилтийн хэмжээг төрөөс тогтоодог. Тухайлбал ОХУ-ын Засгийн газрын тогтоолоор байгууллагын цэвэр активын хэмжээ болон дүрмийн сангийн хэмжээг тогтоодог байна. Мөн байгууллага нь жил бүр орлогоо тодорхой хувийг төсөвт оруулж, үлдсэн тодорхой хувиа захиран зарцуулах эрх нь нээлттэй байна.

Тав. ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Канад, Кипр, БНХАУ, ОХУ–ын мэдээллийн агентлагийн эрх зүйн байдал, үйл ажиллагааны онцлог зэргийг судаллаа. Эдгээр улсын улс төр, эрх зүйн системээс хамаарч агентлагийн бүтэц, зохион байгуулалт, эрх зүйн орчин, хариуцлага тооцох механизм, санхүүжилт зэрэг нь харилцан адилгүй байна. Гэхдээ дараах нийтлэг зүйл ажиглагдлаа. Үүнд:

✓ Ихэнх улсуудын мэдээллийн агентлаг нь захирлын зөвлөл буюу удирдах зөвлөлтэй байдаг юм байна. Захирлын зөвлөлийн дарга гол үүрэг гүйцэтгэж, агентлагийг удирдан чиглүүлдэг. Удирдлагын баг буюу гүйцэтгэх захирлаар удирдуулсан баг агентлагийн өдөр тутмын үйл ажиллагаа эрхлэн явуулдаг.

✓ Эрх зүйн зохицуулалтын хувьд хуулиар ерөнхий зохицуулалт хийж агентлагийн дүрмээр үйл ажиллагааг нарийвчлан зохицуулдаг байна.

✓ Санхүүжилтийн хувьд бүгд төрөөс бүрэн буюу төрийн дэмжлэгтэйгээр үйл ажиллагаа явуулдаг. Зарим агентлагийн хувьд санхүүжилтэнд хяналт тавих нь сул, зарим нь хатуу байдаг. Энэ нь улс орны онцлогоос хамаарч байна. Ихэнх орнуудын хувьд төсвөөс санхүүжихээс гадна өөрсдийн үйл ажиллагаанаас орлого олох боломж нь нээлттэй байдаг.

✓ Агентлагийн дарга нь нэг бол удирдах зөвлөлийг томилсон байгууллагын өмнө аль эсхүл санхүүжилт өгч байгаа байгууллагын өмнө ажлаа хариуцан тайлагнадаг.

<u>Дэвшүүлж буй санал, зөвлөмж:</u>

Төрөөс дэмжлэгтэй, хараат бус, бие даасан үйл ажиллагааны тухайд судалсан улсуудын ихэнх нь хараат байдлаар үйл ажиллагаа явуулдаг байна., Кипр улсын мэдээллийн агентлагийн тухай хуулийн 2 дугаар бүлгийн 6ᵉ-д агентлагийн баримтлах зарчмыг тодорхойлсон байна. Үүнд: "агентлаг нь ямар ч нөхцөлд аливаа улс төрийн болон намын бүлэг, эдийн засгийн болон бусад бүлгийн эрхшээлд орох, эсхүл тэднийг дэмжих, эсхүл тэдний эрх ашигт үйлчилж үл болно" гэж зааснаас харахад эрх зүйн хувьд хараат бус үйл ажиллагаа явуулдаг гэж дүгнэж болох ч нотлоход хүндрэлтэй. Ажиглалтын арга ашиглах боломж байхгүй зэрэг объектив

хүчин зүйлээс шалтгаалж хараат бус бие даасан үйл ажиллагаа явуулдаг эсэхийг бүрэн гүйцэд нотлох боломжгүй.

Судалсан улсуудын дотор Кипр улсаас гадна өөр улсууд хараат бусаар үйл ажиллагаа явуулах эрх зүйн зохицуулалтыг тусгасан эсэх ажиглагдсангүй.

Канад улсын зохицуулалтаас харахад улсын төсвөөс санхүүждэг хэдий ч өөрсдийн үйл ажиллагаанаас орлого олох боломжтой, нээлттэй үйл ажиллагаа явуулдаг. Санхүүгийн хувьд харьцангуй хараат бусаар үйл ажиллагаа явуулдаг нь санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны тайлангаас харагдаж байна. Канад улсын хувьд мэдээ, мэдээллийг дамжуулахад аль нэг улс төрийн хүчин, нам, бүлэглээс хараат бусаар үйл ажиллагаа явуулах боломж нээлттэй байна.

✓ Кипр улсын мэдээллийн агентлаг шиг агентлагийн баримтлах зарчмыг тодорхойлох /Кипр улсын мэдээллийн агентлагийн зарчмаас жишээ авах/;

✓ Эрх зүй, эдийн засгийн талаас нь хараат бус байхаар хуулийн төсөлд зохицуулалт хийж өгөх /Кипр, Канад улсын жишээг судлах/

Удирдах байгууллага, түүний бүрэлдэхүүн, эрх зүйн байдлын тухайд ихэнх улсуудын мэдээллийн агентлаг нь захирлын зөвлөл буюу удирдах зөвлөлтэй байдаг байна. Захирлын зөвлөлийн дарга нь гол үүрэг гүйцэтгэж, агентлагийг удирдан чиглүүлдэг. Удирдлагын баг буюу гүйцэтгэх захирлаар удирдуулсан баг агентлагийн өдөр тутмын үйл ажиллагаа эрхлэн явуулдаг. Канад улсын ерөнхийлөгч /гүйцэтгэх захирал/-өөр ахлуулсан алба, хэлтсийн дарга нар удирдлагын багт багтдаг. Удирдлагын баг буюу гүйцэтгэх захирал нь захирлын зөвлөлд ажлаа хариуцан тайлагнадаг. Захирлын зөвлөлөөр мэдээллийн агентлагийн стратеги болон бизнес төлөвлөгөө, дүрэм, журам, бодлогын баримт бичгүүд батлагддаг. Кипр улсын хувьд Мэдээллийн агентлагийн тухай хуульдаа захирлын зөвлөлийн гишүүд ямар байгууллагаас хэдэн хүн байх, ямар мэргэжилтэй байх зэрэг захирлын зөвлөлийн гишүүдэд тавигдах шаардлагыг тодорхой заасан байна.

Судалсан улсуудаас харахад Кипр улс Мэдээллийн агентлагийн эрх зүйн байдлыг тодорхойлсон бие даасан хуультай байна. Бусад улсын хувьд мэдээллийн агентлагийн удирдлагын нийтлэг зохицуулалтыг ерөнхий хуулиар, харин захирлын зөвлөл, түүний гишүүдийн, эрх, үүрэг, хүлээх хариуцлага, дотоод зохион байгуулалт зэрэг мэдээллийн агентлагийн дотоод асуудлыг дүрмээр зохицуулдаг юм байна.

✓ Агентлаг нь удирдах зөвлөлтэй байх, удирдах зөвлөлийн гишүүдэд тавигдах шаардлага, гишүүдийг сонгох эсхүл нэр дэвшүүлэх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгах /Кипр улсын жишээг авах/;

✓ Удирдах зөвлөлийн дарга болон гүйцэтгэх захирлын эрх, үүрэг, эрхлэх асуудлын хүрээг нарийн тодорхой зааж өгөх /Канад улсын жишээг авах/;

✓ Кипр улсын мэдээллийн агентлагийн тухай хуульд заасан шиг захирлын зөвлөлийн гишүүд ямар байгууллагаас хэдэн хүн байх вэ, ямар мэргэжилтэй байх, ямар шаардлага хангасан байх ёстой зэргийг хуулийн төсөлд тусгавал удирдлагын төлөөллийг тэгш хангана.

Санхүүжилт, үйл ажиллагаагаа тайлагнадаг журмын хувьд судалсан орнуудын мэдээллийн агентлаг нь төрөөс бүрэн буюу тодорхой хувиар санхүүжилт авч, төрийн дэмжлэгтэйгээр үйл ажиллагаа явуулдаг. Канад улсын хувьд парламентаас санхүүжилт авч мөн ажлаа парламентад тайлагнадаг. Кипр улсын хувьд улсын төсвөөс санхүүжиж Сайд нарын зөвлөл, Төлөөлөгчдийн танхимд ажлаа тайлагнадаг. Захирлын зөвлөл буюу удирдах зөвлөлийг томилсон байгууллагын өмнө аль эсхүл санхүүжилт өгч байгаа байгууллагын өмнө ажлаа хариуцан тайлагнадаг нь судалсан улсуудын жишгээс харагдаж байна.

✓ Удирдлагыг томилсон байгууллага эсхүл санхүүжилт өгсөн байгууллагын өмнө ажлаа тайлагнаж, хариуцлага хүлээж байхаар хуулийн төсөлд тусгах.

✓ ОХУ-ын Итар-Тасс агентлаг шиг орлогын тодорхой хувийг төсөвт оруулж, үлдсэн тодорхой хувийг захиран зарцуулах эрх нь нээлттэй байхаар төсөлд тусгавал үндэсний мэдээллийн агентлаг бие даан үйл ажиллагаа явуулах, цаашид бэхжихэд чухал түлхэц болно гэж үзэж байна.

Агентлаг нь бусад хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хэрхэн, ямар байр сууринаас харилцах, ямар арга замаар хэрэгжүүлэхийн хувьд судалсан улсуудын жишгээс харахад мэдээллийн агентлагууд бусад хэвлэл мэдээллийн байгууллага болон хэрэгсэлд мэдээ, мэдээллээ зарж, хамтарч ажиллах хувийн эрх зүйн зарчим үйлчилж байна. Судалсан орны холбогдох хууль, дүрэм, журмаас харахад энэ талаар нарийн зохицуулалт байхгүй байна. Харин БНХАУ-ын Синьхуа агентлаг гадаад улсуудын мэдээллийн агентлагтай хэрхэн харьцах зохицуулалтыг 2006 онд "БНХАУ-ын нутаг дэвсгэрт Гадаадын мэдээллийн агентлаг мэдээ, мэдээлэл нэвтрүүлэхийг зохицуулах арга хэмжээ" нэртэй эрх зүйн актыг баталж мөрдөх болсон нь бусад мэдээний агентлаг Хятадад үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндэс болон Синьхуа агентлаг бусад мэдээний агентлагуудтай хэрхэн харилцах талаар хуульчлан зохицуулсан байна. "Гадаад улсын мэдээний агентлагаас БНХАУ-ын нутаг дэвсгэрт мэдээ, мэдээлэл нэвтрүүлэхэд Синьхуа агентлаг нь нэгдсэн зохицуулалтыг хэрэгжүүлнэ" гэж заасан нь гадаад улсуудын мэдээний агентлагийн үйл ажиллагааг Синьхуа агентлаг зохицуулж ажиллах эрх хэмжээг тусгайлан олгожээ.

✓ Монгол Улсад энэ талаар зохицуулалт байхгүй тул Синьхуа агентлагийн энэхүү зохицуулалтыг хуулийн төсөлд тусгаж болох юм.

➢ БНХАУ-ын Синьхуа агентлаг шиг гадагшаа чиглэсэн бодлого явуулж, гадаадад салбар төлөөлөгчийн газраа байгуулах, хүрээгээ тэлэх үйл ажиллагаа явуулахад шаардагдах хөрөнгө мөнгө, харилцаа, хамтын ажиллагааг хуулийн төсөлд тусгах;

➢ БНХАУ-ын Синьхуа агентлаг шиг мэдээллийн байгууллагын үйл ажиллагаанд холбогдох судалгаа шинжилгээ, сургалтын болон хэвлэлийн, зар сурталчилгааны, мэргэшсэн мэдээний фото болон бусад зургийн газар зэргийг хамтад нь хөгжүүлэх зохицуулалтыг тусгах;

Хавсралт 1

Канадын радио-телевиз болон харилцаа холбооны хорооны /комисс/ хууль

Хорооны бүрэлдэхүүн болон тогтолцоо[233]

3.1 Канадын радио телевиз болон харилцаа холбооны хороо нь арван гурваас илүүгүй орон тооны, зургаагаас илүүгүй орон тооны бус гишүүнээс бүрдэх ба тэдгээрийг Зөвлөлийн дарга томилно.

3.2 Гишүүд 5 жилээс хэтрэхгүй хугацаагаар албан тушаалд томилогдоно. Ямар нэгэн шалтгааны улмаас Зөвлөлийн дарга хэдийд ч албан тушаалаас нь огцоруулж болно.

4. Орон тооны гишүүд нь энэ хуулийн дагуу үүргээ гүйцэтгэхдээ ямар нэгэн давхар алба хашихгүй.

5.1 Хорооны гишүүнээр томилогдох, эсхүл үргэлжлүүлэн ажиллахад дараахь тохиолдолд шаардлага хангахгүй. Үүнд: хэрвээ канадын иргэн, байнгын оршин суугч биш, эсхүл шууд болон шууд бусаар өмчлөгч, хувь нийлүүлэгч, захирал, ажилтан, хамтрагч, эсхүл хувь хүн нь:

a/ харилцаа холбооны салбарт ажилладаг

b/ мөнгө санхүүгийн болон өмчийн сонирхолтой байх

/i/ харилцаа холбооны салбарт

/ii/ харилцаа холбооны тоног төхөөрөмжийг түгээх эсхүл үйлдвэрлэх, тараалт нь жижиглэн худалдаа эсхүл бөөний худалдаагаар борлуулсан барааны дагалдах эд зүйл биш бол.

Дарга болон дэд дарга

6.1 Зөвлөлийн дарга орон тооны /үндсэн ажилтан/ нэг гишүүнийг хорооны даргаар мөн орон тооны /үндсэн ажилтан/ хоёр гишүүнийг хорооны дэд даргаар томилно.

6.2 Дарга бол хорооны гүйцэтгэх захирал байна. Хорооны ажил болон ажилтанд чиглэл өгч бүхэлд нь хяналт тавина. Мөн хорооны хурлыг даргална.

6.3 Даргын эзгүйд, эсхүл чөлөөтэй, амралттай үед комисс дэд даргын аль нэгийг даргын эрхийг эдэлж үүрэг, үйл ажиллагааг гүйцэтгүүлэхээр зөвшөөрч болно.

6.4 Хэрвээ дарга болон хоёр дэд дарга эзгүй, ажил үүргээ гүйцэтгэх чадваргүй, эсхүл амралттай байгаа тохиолдолд нэг, эсхүл түүнээс дээш гишүүнийг тухайн цаг хугацаанд үүрэг гүйцэтгүүлэхээр комисс томилох эрхтэй.

Цалин, хөлс

7.1 Орон тооны гишүүн бүр зөвлөлийн даргын тогтоосон хэмжээгээр цалин авна. Орон тооны бус гишүүн комиссын өмнөх шатны олон нийтийн сонгол, эсхүл ямар нэгэн хороо, комиссын хуралд оролцсон ирцийн үндсэн дээр хөлс авна.

7.2 Гишүүн бүр комиссын дотоод журмын дагуу гүйцэтгэх үүрэгтэйгээ холбоотойгоор гарах амьдралын болон зорчих зардлыг төлүүлэх эрхтэй.

[233] http://laws-lois.justice.gc.ca/eng/acts/c-22/FullText.html /сүүлд үзсэн 2011.04.08/

Ажилтан

8. Комиссын ажилд шаардлагатай ажилтан, албан хаагчийг авахдаа Төрийн албанд ажилд авах хуулийн дагуу томилно.

Тэтгэвэр:

Орон тооны гишүүдийн тэтгэвэр тэтгэмж

9.1 Комиссын орон тооны гишүүдийг Төрийн албаны тэтгэвэр, тэтгэмжийн хуулийн дагуу төрийн албанд ажилласан гэж үзэн тэтгэвэр, тэтгэмж олгоно.

Нөхөн төлбөр

9.2 Комиссын орон тооны гишүүнийг Холбооны засгийн газарт ажилд орсон гэж үзнэ.

Төв байр

10.1 Үндэсний нийслэл хотын хуульд заасан болон тодорхойлсоноор комиссын төв байр нь үндэсний төв бүсэд байна. Канад улсын бусад газруудад байрлах эсэхийг Зөвлөлийн дарга тогтооно.

Орон нутаг дахь байр

10.1.1 Зөвлөлийн дарга комиссын байрыг Канадын аль нэг бүс нутагт байгуулахыг комисст үүрэг өгөх ба комисс заавар зөвлөмжийг биелүүлнэ.

/2/ Хурал

Комисс жилд наад зах нь 6 удаа хуралдана.

/3/ Кворум

Орон тооны гишүүдийн олонхи нь мөн орон тооны бус гишүүдийн олонхи нь цугларснаар комиссын кворумыг бүрдүүлнэ.

__oOo__

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.mnlaw.mn

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ИРГЭДЭД ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЖ БУЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ[234]

ОРШИЛ

Төлбөрийн чадваргүй иргэнд эрх зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор эрх зүйн туслалцааны төв байгуулагдан 4 дэх жилийн нүүр үзэж байна. Энэ хугацаанд эрх зүйн туслалцааны төв нь тодорхой хэмжээнд тогтсон үйл ажиллагаа явуулж иржээ.

Ололт амжилттай тал байгаа ч нөгөө талаар алдаа, дутагдалтай зүйл ч байна. 21 аймаг, 9 дүүрэгт эрх зүйн туслалцааны төвүүд байгаа ч алслагдсан аймгийн сум, багууд, нийслэлийн дүүргүүдэд иргэд эрх зүйн үйлчилгээгээр хангагдах боломж хомс байдаг.

Гэхдээ энэ байдлыг шүүмжлэхээс илүүтэйгээр өмнөх байдлаа засч аль болох түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх тал дээр анхаарах нь зүйтэй бөгөөд дан ганц Засаг даргын Тамгын газрын дэргэдэх эрх зүйн туслалцааны төвийн үйл ажиллагаанд тулгуурлах бус илүү өргөн хүрээг хамарсан ажил явуулах нь зүйтэй юм.

Иймд иргэдэд сургалт, сурталчилгаа, эрх зүйн туслалцааны төвийн хүний нөөцийн ажлын зохицуулалт, төлбөрийн чадваргүй иргэн гэмт хэрэгт холбогдож шүүхээр шийдвэрлүүлэхэд шүүхэд тэдний эрхийг өмгөөлөгчөөр хангах тал дээр шүүх, прокурор, өмгөөллийн байгууллагын хамтын оролцоо, иргэд ядуу байдлаасаа болж гэмт хэрэгт холбогдоход түүнээс урьдчилан сэргийлэхэд цагдаагийн байгууллагын оролцоо, эрх зүйн туслалцааны төвийн ажлын ачааллыг хөнгөвчлөх үүднээс их дээд сургуулийн төгсөх курсын оюутнуудын уртын дадлагын хугацаанд тэднийг дадлагажуулж ажиллуулах гэх мэт олон байгууллагын хамтын ажиллагааны үр дүнд иргэдийн хүртэх эрх зүйн халамж үйлчилгээ нь цогц байдлаар шийдэгдэж тэдний эрх зөрчигдөхгүй байх боломж бүрдэх юм.

НЭГ. Төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх эрх зүйн туслалцааны хүрээг тодорхойлох: гадны улс орнуудын хууль тогтоомж, жишгийг харьцуулан судалж, Монголын онцлог, 2004 оноос хэрэгжиж буй төслийн хэрэгжилт зэргийг судлан оновчтой хувилбар, үндэслэлийг гаргах.

Монгол Улсын Үндсэн хуулийн[235] 16 дугаар зүйлийн 14 дүгээрт "Монгол Улсын хууль, Олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уг эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохиролыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг, эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр

[234] Энэ судалгааг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2011 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 22 дугаар тушаалын дагуу ХЗДХЯ-аас боловсруулж буй төслийн хүрээнд ЗХЭЗС 2011 оны 9 дүгээр сард хийж гүйцэтгэсэн болно.

[235] Монгол Улсын Үндсэн хууль, "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

шүүлгэх, шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно" гэж заажээ. Энэ нь иргэн бүр зөрчигдсөн эрхээ сэргээлгэх талаар хуульчлан баталгаажуулсан зохицуулалт юм.

1.1.Нэр томьёоны тухай:

Монгол Улсын шүүхийн тухай хууль[236], Өмгөөллийн тухай хууль,[237] Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 263 дугаар тогтоол, түүний хавсралт болох "Төлбөрийн чадваргүй иргэнд эрх зүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр" зэрэг хууль зүйн баримт бичигт төлбөрийн чадваргүй иргэн гэдэг ойлголтыг тайлбарласан ч, яв цав тодорхойлсон зүйл байхгүй байна. Дээр дурдсан үндэсний хөтөлбөрт заахдаа төлбөрийн чадваргүй иргэн гэдэгт "ядуу орлого багатай иргэнийг ойлгон төлбөрийн чадваргүйд тооцох шалгуурыг боловсронгуй болгох" зорилт дэвшүүлсэн. Үүнээс өмнө Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2003 оны 69 дүгээр тушаалын хавсралт "Өөрийгөө болон гэр бүлээ тэжээх сарын орлого нь хүн амын амжиргааны доод түвшингийн хэмжээнд хүрэхгүйн улмаас байнгын хязгаарлагдмал хэрэглээтэй амьдардаг" иргэнийг төлбөрийн чадваргүй иргэн гэж тооцно гэжээ. Цаашилбал тухайн иргэнийг төлбөрийн чадваргүй болохыг оршин суугаа нутаг дэвсгэрийн баг, хорооны Засаг дарга тодорхойлно гэж заасан[238].

Эдгээр баримт бичгүүдэд тодорхойлсноос харахад төлбөрийн чадваргүй иргэн гэж нэрлэх нь утга агуулгын хувьд тохирч байгаа эсэх, шалгуур нь ямар байх ёстой зэргийг тодруулж заажээ. Төрөөс үзүүлж буй үйлчилгээ гэдэг утгаар нь **эрх зүйн халамж** гэсэн үзэл баримтлалыг гаргаж ирсэн нь зүйтэй юм. Төлбөрийн чадваргүй иргэн нь холбогдох хууль, журамд зааснаар амьжиргааны доод түвшингийн орлоготой бөгөөд түүнийг нь баг, хорооны Засаг дарга тодорхойлох, эсхүл орон нутагт төлбөрийн чадваргүй иргэдийн жагсаалт гаргаж туслалцаа үзүүлэх гэх мэт шалгуур байдаг, харин энэ шалгуурууд нь учир дутагдалтай юм.[239]

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн[240] **3.1-д** тодорхой боловсрол, тусгай мэргэжил үл шаардагдах энгийн ажил гүйцэтгэсэн ажилтанд олговол зохих хөлсний хамгийн бага хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ гэнэ.

---

[236] Шүүхийн тухай хууль. "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 08 дугаар сар № 29-32 дахь дугаарт нийтлэгдсан.

[237] Өмгөөллийн тухай хууль. "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 06 дугаар сарын № 21-24 дэх дугаарт нийтлэгдсэн.

[238] 2009 онд ХЗДХЯ-аас захиалан хийгдсан "Төлбөрийн чадваргүй иргэдэд зориулсан эрх зүйн туслалцаа, сургалт, сурталчилгааны боломжийг судлах" төслийн үр дүнгийн тайлан 3 дахь тал.

[239] 2010 онд "Төлбөрийн чадваргүй иргэдэд зориулсан эрх зүйн туслалцааны үндэсний тогтолцоог боловсронгуй болгох нь" судалгааны ажлын багийн тайланд дүн шинжилгээ хийх нь сэдэвт судалгаа Хууль зүйн үндэсний хүрээлэн гүйцэтгэсэн. 7 дахь тал.

[240] Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2007 оны 9 дүгээр сар №33-36 дахь дугаарт нийтлэгдсэн.

Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай хуулийн[241] 3.1.1. "Хүн амын амьжиргааны доод түвшин" гэж хэрэглээний доод хэмжээг мөнгөн хэлбэрээр илэрхийлснийг,

3.1.2."Хэрэглээний доод хэмжээ" гэж хүний нэн тэргүүний зайлшгүй хэрэгцээг хангах хүнсний болон хүнсний бус хэрэглээний сагсаар тодорхойлсон бараа, үйлчилгээний шинжлэх ухааны үндэслэлтэй тоо, хэмжээг хэлнэ гэж тус тус заажээ.

Дээрх хуулийн заалтаас харахад иргэдийн олсон орлого нь мөнгөн дүнгээр илэрхийлэхэд наад захын ахуйн түвшинг хангаж хүрэлцэхээргүйн зэрэгцээ аль нэг үйлчилгээний газраас хүртэж байгаа үйлчилгээнийхээ хариу төлбөрийг төлөх чадваргүй иргэдийг төлбөрийн чадваргүй гэж үзэхээр байна. Дээрх хууль тогтоомжуудаас харахад төлбөрийн чадваргүй иргэн гэж тодорхойлсон хууль зүйн нэр томьёо байхгүй байгаа нь харагдаж байна.

1.2.Эрх зүйн туслалцааны төвийн үйл ажиллагаа

Төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх эрх зүйн туслалцаа нь иргэн өөрөө хүссэн үедээ зөвхөн нэг удаа хүртдэг үйлчилгээ тодий биш. Төрийн халамжийн бодлогын хүрээнд үзүүлж буй нэг ёсны эрх зүйн халамж үйлчилгээ гэсэн ойлголтоор, үйлчилгээний чанар, хүртээмжийг бодитой дээшлүүлэх, байнга боловсронгуй болж байх тогтолцоог бүрдүүлэх нь төрөөс санхүүжүүлэх энэхүү үйл ажиллагааны үр ашиг, өгөөжийг баталгаатай хангах нэг гол үндэс юм.[242]

Эрх зүйн туслалцааны төвүүд байгуулагдсанаар ядуу иргэдэд өөрийнхөө эрхийг шүүхийн өмнө хамгаалуулах боломж тодорхой хэмжээнд хангагдаж байна гэж үзэж болох юм. Эрх зүйн туслалцааны төв нь Аймгуудад Засаг даргын тамгын газрын байранд, нийслэлд дүүргийн Засаг даргын тамгын газрын байранд байрлаж иргэдэд хууль зүйн туслалцаа, үйлчилгээг эрх зүйн сургалт сурталчилгаа хариуцсан ажилтан болон мэргэжлийн өмгөөлөгч үзүүлж байна. Тэдгээр нь иргэдэд дараах чиглэлийн үйлчилгээ үзүүлж байна.

1.Эрүүгийн хэрэгт холбогдсон төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй үзүүлэх;

2.Эрүү, иргэн, захиргааны хэрэгт анхан шатны хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх;

3.Эрх зүйн албан бус сургалт, сурталчилгаа явуулах;

Эрх зүйн туслалцаа үйлчилгээний төвд хандсан иргэд ихэвчлэн нийгмийн халамж, газар, өмчлөлтэй холбоотой асуудлаар зөвлөгөө авдаг байна. Дээр дурдсан гурван чиг үүргийн туслалцааг хэрэгжүүлэхэд хамрах хүрээ нь тодорхой байх хэрэгтэй юм.

Эрх зүйн туслалцаа гэдэг ойлголт нь Эрх зүйн туслалцааны төвийн дүрэмд[243] зааснаар эрх зүйн туслалцаа гэдэг нь тухайн орон нутгийнхаа

---

[241] Хүн амын амьжиргааны доод түвшингийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2000 оны 5 дугаар сар №17-20 дугаарт нийтлэгдсэн.

[242] 2009 онд ХЗДХЯ-аас захиалгаар хийгдсэн "Төлбөрийн чадваргүй иргэдэд зориулсан эрх зүйн туслалцаа, сургалт, сурталчилгааны үндэсний тогтолцоог боловсронгуй болгох боломжийг судлах" төслийн үр дүнгийн тайлан 5 дахь тал.

[243] Эрх зүйн үйлчилгээ үзүүлэх төслийн зөвлөлөөс батлагдсан "Эрх зүйн туслалцааны төвийн дүрэм" 2008.

хүрээнд хууль зүйн туслалцаа, эрх зүйн албан бус сургалт, сурталчилгааны чанар, хүртээмж, үр нөлөөг дээшлүүлэх зорилго бүхий нэгж юм[244]. Дээрх нэгж нь уг зорилгодоо хүрэхийн тулд холбогдох эрх зүйн баримт бичигт хууль, эрх зүйн туслалцаа, түүнээс тусдаа эрх зүйн албан бус сургалт, сурталчилгаа гэх зэргээр нэр томъёог нэг мөр хэрэглэж хэвшээгүй байдал ажиглагдаж байна. Өнгөрсөн хугацаанд нэлээд хэвшиж тогтсон "Эрх зүйн туслалцааны төв" гэсэн нэршлийг суурь болгон авч логикийн хувьд эрх зүйн туслалцаа гэдэгт эрх зүйн сургалт, сурталчилгааг багтаан ойлгох нь зүйтэй болов уу. Эрх зүйн бусад туслалцаанд өмгөөлөл, хууль зүйн мэргэжлийн зөвлөгөө багтах нь зүйн хэрэг. Эрх зүйн мэдээлэл, лавлагаа бол эрх зүйн сурталчилгааны салшгүй хэсэг байх нь ойлгомжтой юм.

Иргэдэд эрх зүйн туслалцааг ямар түвшинд өгч байгаагаас хамаар ч дараах байдлаар ангилах нь зүйтэй байна. Үүнд:

1.Иргэн өөрийн үйлдлийн улмаас эрх зүйн ямар үр дагаварт хүрэх түүнээс урьдчилан сэргийлэх, өөрт тулгарах эрсдэлийг урьдчилан шийдвэрлэхийн тулд заавар чиглэл, түүнээс үүдэн гарах хор уршиг үр дүнг мэдэх зорилготой хууль зүйн туслалцаа авах /Иргэн эрх зүйн харилцаа үүсэхээс өмнө аль шийдвэрийг сонговол өөрт ашигтай байгаа талаар зөвлөгөө хүсч/

2.Иргэнд эрх зүйн аль нэг нөхцөл байдал өмнө үүссэн тухайн нөхцөлөөс гарах, хууль зүйн хувьд тодорхой үр дагавар үүсэх түүнээс гарах арга зам болон хууль шүүхийн өмнө өөрийн эрх ашгаа хэрхэн хамгаалуулах. /гэмт хэрэгт холбогдсон, зээлийн гэрээний үндсэн дээр мөнгөө алдсан, өмгөөлөгчийн туслалцаа хэрэгтэй байгаа/ зэрэг.

3.Иргэд эрх зүйн сургалт сурталчилгааны талаар тасралтгүй мэдээлэл авах. Эрх зүйн харилцааны наад захын мэдлэгтэй болохын тулд сургалт болон бусад мэдээллээр хангагдах гэсэн дээрх гурван түвшинд эрх зүйн туслалцааг ангилан авч үзвэл эрх зүйн туслалцааны ач холбогдол болон эрх зүйн үйлчилгээг хүртэж байгаа иргэдийн хэрэгцээ шаардлага тодорхой болно. Үүнтэй уялдаад одоо үйл ажиллагаагаа явуулж байгаа эрх зүйн туслалцааны төвийн ажил ч тодорхой системтэй болох юм.

Эрх зүйн туслалцааны төвийн орон тоо

Эрх зүйн туслалцааны төв Монгол Улсын хэмжээнд 21 аймаг, 9 дүүрэгт ажилладаг бөгөөд тэдгээрт хандсан төлбөрийн чадваргүй иргэд ихэвчлэн эрүүгийн хэрэгт өмгөөлөгчөөр оролцуулах хүсэлтэй байдаг ба бусад хэрэгт анхан шатны хууль зүйн зөвлөгөө хүсдэг байна.

Хөдөө орон нутгийн иргэд эрх нь зөрчигдсөн эсэхээ ч сайн мэддэггүй байх тохиолдол олон байдаг. Манай орны газар зүйн байдлаас хамаарч хүртээмжтэй үйлчилгээг яаж бий болгох вэ гэдэгт нэлээд анхаарал хандуулах зүй ёсны шаардлага байна. Тухайлбал эрх зүйн туслалцааны төв нь тухайн аймаг дүүргийн Засаг даргын тамгын газарт байрладаг гэдгийг хүмүүс тэр бүр мэддэггүй, ийм төрлийн үйлчилгээ байдаг эсэхийг ч мэдэхгүй байх нь судалгааны явцад ажиглагдлаа. Эрх зүйн туслалцааны төв нь 2 ажилтны орон тоотой эрх зүйн үйлчилгээг үзүүлдэг. Гэтэл манай улс нутаг дэвсгэрийн нэгжийн хувьд хүн ам нь тархсан байдалтай. Хүн ам

[244] Монгол Улсын засгийн газрын 2006 оны 263 дугаар тогтоолыг үндэслэн. Хууль зүй дотоод хэргийн сайдын 2007 оны .. дугаар тушаалын 2 дугаар хавсралтын дагуу "Төлбөрийн чадваргүй иргэнд" Хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудлыг хариуцсан Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнээр хэлэлцэн гаргасан журам.

харилцан адилгүй. Зарим аймагт хүн амын тоо бусад аймгаас их байдгийг үл харгалзан эрх зүйн туслалцааны төвийн орон тоог адил түвшинд буюу 2 хүн ажиллахаар тогтоосон нь хүн ам ихтэй аймаг, дүүрэгт ажлын ачаалалд нөлөөлөх байдал харилцан адилгүй байдлыг үүсгэх нь тодорхой юм. Иймд тус төвийн ажилчдын орон тооны асуудлыг ялгамжтай байдлаар зохицуулах нь зүйтэй байна. Цаашид төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг уялдуулах байдлаар зохицуулах шаардлагатай юм. Тухайлбал Орон нуттийн засаг захиргаа, Монголын өмгөөлөгчдийн холбоо /Цаашид МӨХ гэх/, Хууль зүйн их, дээд сургуулиуд, стратегийн өмгөөлөл хийдэг олон нийтийн байгууллагууд гэзд хамтран ажиллаж үр дүнд хүрэхийн тулд хамтын үйл ажиллагаа явуулж эцэст нь бид ард иргэдийнхээ эрхийг хамгаалахад эерэг үзүүлэлт гаргах хэрэгтэй[245].

Эрх зүйн туслалцааг улам боловсронгуй болгох буюу дээр дурдсан хууль зүйн үйлчилгээ үзүүлж байгаа төр, өмгөөллийн мэргэжлийн байгууллага, Төрийн бус байгууллага /Цаашид ТББ/ гэх мэт оролцогчдын үйл ажиллагааны онцлог, уялдаа, чанар, хүртээмжийг нэгдсэн зохицуулалтаар хангах мөн эрх зүйн туслалцааны төвд харьяалагддаг өмгөөлөгч нарт олгох цалин хөлсийг хүртээмжтэй болгох тал дээр анхаарч, мөнгөн тэтгэмжийг төрөөс олгох зарчмаар явагдаж байгаа хэдий ч өмгөөлөгчдөд олгож байгаа цалин хөлс нь сүүлийн үеийн жишигт нийцэхээр олгож чаддаггүй байна. Эрх зүйн туслалцааны төвийн гэрээт өмгөөлөгчийн 1 сарын цалин 2010 оны байдлаар 216.000 төгрөг байна.

Эрх зүйн туслалцаа бол олон талын ач холбогдолтой, төрийн нэг төрлийн халамжийн үйлчилгээ юм. Эрх зүйн туслалцааны төв нь иргэн хүн хуулийн мэдлэг боловсролыг хүртэх хамгийн дөт хэрэгсэл болдог. Төлбөрийн чадваргүй иргэнд өмгөөллийн үйлчилгээ үнэгүй үзүүлэх нь тухайн хүний эрхийг хамгаалах ач холбогдолтой, амьдралд нь тустай, нийгэмд хүний эрхийг дээдлэх, шударга ёсыг тогтооход онцгой үүрэгтэй. Эрх зүйн туслалцааны төв бол зүгээр нэг ядуу хүнд хууль зүйн үйлчилгээ үзүүлж байгаа хэрэг бус. Үүний цаана улс орны ардчилал, хүний эрх, шударга ёсны хөгжлийн үзүүлэлт харагдах ёстой. Энэ бол эрх зүйт төрийн аливаа нийгэмд зайлшгүй байх ёстой халамж юм.[246]

Гадаад орнуудын жишиг

Бангладеш улс

Бангладешийн шүүхийн систем хүн амын ядуу зүдүү байдалд үл нийцсэн бөгөөд шүүхэд хэрэглэдэг маргаан шийдвэрлэх уламжлалт институт нь эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах тал дээр анхаарч ажилладаг байна. 1995 онд үндэсний хэрэглэгчдийн хэрэгцээ, шаардлагыг үндэслэн АНУ-ын USAID-ийн санхүүжилтийн дэмжлэгтэйгээр 1995 онд төрийн бус байгууллагыг байгуулжээ. Стратегийн үндсэн гол зорилго нь маргаан шийдвэрлэх аргуудыг хэрэглэх асуудлыг сайжруулах, эмэгтэйчүүдийн эрхийг хүлээн зөвшөөрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах олон нийтэд үзүүлэх эрх зүйн туслалцааг "Мадипур Хууль зүйн туслалцаа үзүүлэх Ассоциаци" төрийн бус байгууллагыг USAID-ийн төслийн хүрээнд байгуулж, удирдлагаар хангах,

[245] 2009 онд Хууль зүй дотоод хэргийн яамнаас захиалан хийгдсэн "Төлбөрийн чадваргүй иргэдэд зориулсан эрх зүйн туслалцаа, сургалт, сурталчилгааны үндэсний тогтолцоог боловсронгуй болгох боломжийг судлах" төслийн үед судалгаагаар хийгдсэн өмгөөллийн хөлсний жишиг.

[246] Эрх зүйн туслалцаа бол төрийн халамжийн үйлчилгээний нэг төрөл. ХЗДХЯ-ны Бодлого хэрэгжилтийн газрын дарга Т.Алтангэрэлтэй хийсэн ярилцлага. 2010.05.20.

мөн орон нутгийн иргэд, мэргэжилтнүүдээс зуучлагч болох сонирхолтой хүмүүсийг сонгон авч энэ талаар мэргэшүүлэн сургах үйл ажиллагаа ч явуулдаг байна. Энэхүү төрийн бус байгуулага нь нэр хүнд бүхий лидерүүд, шашны өндөр цол хэргэмтэй санваартнууд, орон нутгийн эрх баригчидтай хамтран орон нутагт үйл ажиллагаа явуулахаар бэлтгэгдсэн зуучлагчдын зөвлөл сард хоёр удаа уулзаж тухайн нутаг дэвсгэрт гарсан маргаантай асуудлыг шийдвэрлэхэд үнэ төлбөргүй туслалцаа үзүүлдэг ба гарч буй маргаантай хэргүүдийн дийлэнх хувийг өмчийн болон гэр бүлийн асуудал эзэлдэг байна. Зуучлалын гэрээг сайн дурын үндсэн дээр хийдэг бөгөөд шүүхэд байдаг шиг албадлагын арга хэмжээ хэрэглэхгүй юм. Тус төрийн бус байгууллагад жилд дунджаар 5000 гаруй хэргийг шийдвэрлүүлэхээр ханддаг бөгөөд үүнээс гуравны хоёр хувийг нь амжилттай шийдвэрлэдэг гэсэн тоо баримт байна. USAID-ийн төслийн үйл ажиллагаанд орон нутгийнхан сэтгэл ханамжтай байдгаас харахад маргаан шийдвэрлэх сонголтот аргыг хэрэглэж буй нь их үр дүнтэйг харуулсан ажил болдог байна. Хэрэглэгчдийн ихэнх нь маргаан шийдвэрлэх сонголтот аргыг шүүхийн системтэй хослуулан хэрэглэх сонирхолтой байдаг[247].

Хүн амын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, орон нутгийн зуучлагчдыг мэргэшүүлэх, эмэгтэйчүүдийг зуучлагчаар сонгох зэрэг арга хэмжээ авдаг ажээ.

Маргаан шийдвэрлэх үйлчилгээний чанарыг дээшлүүлэх үүднээс дээрхи төслөөс сургалтыг үнэ төлбөргүй явуулдаг. Зардлыг хэмнэх, сайн дурын зуучлагчдыг дэмжих нь маргаан шийдвэрлэх ажиллагаа шуурхай, хэмнэлттэй явуулах, бичиг баримт шаардлаг хүнд суртлыг арилгах зэрэгт үйл ажиллагаагаа хандуулдаг. Энэ бүх үйл ажиллагааг үр дүнтэй явуулахад зардал, менгөний асуудал хүндрэлтэй байдаг тул төрийн бус байгууллагыг өөрөө өөрийгөө санхүүжүүлдэг систем рүү оруулах шаардлага тулгардаг байна. Иймд зарим нэг үйл ажиллагааг төлбөртэй явуулах хэрэгтэй юм. Түүнчлэн уг төслийн үр дүнг хүн амын дийлэнх хэсэгт хүртээмжтэй болгохын тулд хүний нөөц, боловсон хүчний асуудал, нэмэлт санхүүжилт хэрэгцээтэй болжээ.

Япон улс

Анх 2004 онд JFBA[248] нэртэй байгуулагдсан энэ төв нь Японд эрх зүйн туслалцаны нэгдсэн цогц үйлчилгээг явуулдаг юм. Энэ байгууллага нь засгийн газраас хараат бус үйл ажиллагаагаа явуулдаг хэдий ч засгийн газраасаа санхүүждэг ба Японы өмгөөлөгчдийн холбоотой хамтран ажилладаг байна. Мөн тавин хоёр орчим орон нутгийн барын холбоотой хамтардаг. Үйл ажиллагааны гол зорилго нь хүний эрх зөрчигдөж байгаа эсэхийг судалж түүн дээр тулгуурлан судалгаагаа хийж, хуулиудад өөрчлөлт оруулах, боловсронгуй болгох, санал боловсруулж өгөх зэрэг ажил хийдэг байна. Энэ төв нь Японд хамгийн томд тооцогддог бөгөөд иргэдийг эрх зүйн мэдээллээр хангаж өгдөг. Ард иргэдийг эрх зүйн туслалцаа авах, мөн өмгөөлөгчөөр хангагдаж байх ёстой гэсэн зарчмыг үндэслэн хамтарсан бодлого баримталдаг байна. Энэ төв байгуулагдахаас өмнө иргэний эрх зүйн чиглэлээр туслалцаа үзүүлдэг засгийн газраас санхүүждэг байгууллага байжээ. Мөн эрүүгийн эрх зүйн туслалцаа үзүүлдэг шүүхийн дэмжлэгтэй туслалцааны төв байдаг байсан ба JFBA нь эдгээрийг нэгтгэн үйл

[247] Alternative Dispute resolution practitioners' guide, March 1998, page 8

[248] Japan Fenderetion Of Bar Associations.

ажиллагаагаа явуулж эхэлсэн байна. Тус төвд нийт өмгөөлөгчдийн ихэнх хувь нь хамрагдан оролцож эрх зүйн туслалцааны төвийн үйлчлүүлэгч нарт тогтсон хуваарийн дагуу үйлчилгээ үзүүлдэг бөгөөд тус төв нь иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлж мөн шүүхийн өмнөх шатанд иргэд хоорондоо маргаанаа эвийн журмаар тохирох бололцоог бүрдүүлж өгдөг. Японд ямар нэгэн маргаан гарахад ихэнх иргэн энэ төвөөр үйлчлүүлдэг бөгөөд олон нийт мэдэж өргөн цар хүрээтэй болох болсон гол шалтгаан нь сургалт, сурталчилгааны ажлын үр дүнтэй холбоотой ажээ[249].

Дээрхээс харахад ихэнх улс орнуудын иргэддээ үзүүлдэг хууль, эрх зүйн туслалцаа үйлчилгээ нь Засгийн газраасаа санхүүждэг болох нь ажиглагдлаа. Мөн төвийн үйл ажиллагаанд өмгөөлөгч нарыг олноор татан оролцуулдаг болох нь харагдаж байна. Манай улсын хувьд ч энэ туршлага нь боломжтой зүйл юм.

Доорх хүснэгтээс харахад Японы эрх зүйн туслалцааны төвд хандсан иргэдийн өмгөөлөгчөөр хангагдсан байдал нь маш өндөр хувьтай байна. Энэ нь эрх зүйн туслалцааны төвийн үйл ажиллагаа хэрхэн тэлж мөн өмгөөлөгчдийн нэгдсэн холбоотойгоо хэрхэн уялдаж байгааг харуулж байна.



ХОЁР: Төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх Өмгөөлөгчийн эрх зүйн байдлыг гадаадын туршлага, өөрийн орны процесс болон өмгөөллийн тогтолцоотой уялдуулан судалж, үндэслэлийг тодорхойлох:

Эрх зүйн туслалцаа бол өмгөөллийн үйлчилгээнээс арай өргөн ойлголт бөгөөд эрх зүйн албан бус сургалт, сурталчилгааг өөртөө багтаадаг албан ёсны хэллэг юм. Хууль зүйн туслалцааны нэг чухал хэлбэр бол эрүү, иргэн, захиргааны хэрэгт иргэнийг өмгөөлөх үйлчилгээ бөгөөд МӨХ-нд нэгдсэн өмгөөлөгчид энэ үүргийг гүйцэтгэж байна. Гэвч өмгөөлөл нь голдуу төлбөртэй үйлчилгээ байдаг учраас хүн амын ядуу, эмзэг хэсэг хууль зүйн туслалцаа авч чадахгүйд хүрч, Үндсэн хуулиар баталгаажсан эрхээ бодитой эдлэх нөхцөл тэр бүр бүрдэж өгөхгүй байна.[250] Өөрөөр хэлбэл манай улсын

[249] /2010/ *guide to the family court of japan*

[250] 2010 оны 5 дугаар сарын 26-ны өдөр болсон " Хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний тогтолцоог боловсронгуй болгох арга зам" хэлэлцүүлэгийн материалаас.

хүн амын 3,1 хувь нь ядуу амьдралтай байна гэсэн судалгаа байна. Дээрх судалгаанд оролцогчдын 65 хувь нь цалин мөнгө хүрэлцэхгүй, ажлын байр тэр бүр олдохгүй байна гэж хариулсан байдаг.

Өмгөөлөгчдийн ажлыг тодорхойлох

Өмгөөллийн тухай хуулийн[251] 12 дугаар зүйлийн 12.3.8-д Өмгөөлөгч жилд 2 удаа төлбөрийн чадваргүй иргэнийг өмгөөлнө гэсэн заалтыг үүрэг болгон заасан байна. Гэвч бодит амьдралд хуулийн заалт үр дүнгээ өгч хэрэгжиж байгаа эсэх нь эргэлзээ төрүүлэхээр байна.

Тоо баримт

Манай улсын хувьд нийт 1306 өмгөөлөгч албан ёсны өмгөөллийн үйлчилгээ эрхлэх эрхтэй гэсэн баримт байна[252]. МӨХ-оос эдгээр өмгөөлөгчид нь Өмгөөллийн тухай хуулийн 12.3.8-д заасны дагуу жилд 2 төлбөрийн чадваргүй иргэн өмгөөлвөл МӨХ-д харьяалалтай нийт өмгөөлөгч жилд 2612 төлбөрийн чадваргүй иргэнийг өмгөөлөхөөр байна. Төлбөрийн чадваргүй иргэн нь тухайн оршин суугаа баг, хорооны Засаг даргын тодорхойлолтын үндсэн дээр төлбөрийн чадваргүй гэдгээ нотлон МӨХ-д өмгөөлүүлэх үйлчилгээгээр хангуулахаар хүсэлт тавибал МӨХ-оос өмгөөлөгч томилж өгдөг тогтолцоо үйлчилж байна.

Төлбөрийн чадваргүй иргэдээс МӨХ-д хандан өмгөөлөгч томилуулахаар ирүүлсэн хүсэлтийн судалгаа /сүүлийн 3 жилийн байдлаар/

№	Он	Тоо
1	2008	1285
2	2009	1302
3	2010	1310

МӨХ-д сүүлийн 3 жилийн хугацаанд хандсан иргэдийн хүсэлтийг МӨХ-оос хангаж, өмгөөлөгч томилуулан ажилуулжээ.



Дээрх графикаас харахад төлбөрийн чадваргүй иргэдийн өмгөөлөл

[251] Өмгөөллийн тухай хууль, "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2002 оны 06 дугаар сарын №21-24 дэх дугаарт нийтлэгдсэн.

[252] Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Сургалтын төвөөс, кредит цагийн сургалтанд суух албан ёсны өмгөөлөх эрхтэй өмгөөлөгчидын тоог тодруулсан.

хууль зүйн туслалцаа авахаар хандсан иргэдийн тоо, сүүлийн 3 жилд өсөх хандлага харагдаж байна. Гэвч Монгол Улсын Дээд шүүхийн судалгааны төвийн архиваас[253] төлбөрийн чадваргүй иргэн жилд шүүхэд үнэ төлбөргүй өмгөөлөгчөөр хэрхэн хангагдсан талаар сүүлийн 3 жилийн байдлаар судлахад дараах тоон үзүүлэлт гарч байна.

- **2008 онд Улсын хэмжээнд нийт 3468 эрүүгийн хэрэг шийдсэнээс 47 хүнд томилолтоор үнэ төлбөргүй өмгөөлөх үйлчилгээ үзүүлсэн байна.**
- **2009 онд Улсын хэмжээнд нийт 3505 эрүүгийн хэрэг шийдсэнээс 65 хүнд томилолтоор үнэ төлбөргүй өмгөөлөх үйлчилгээ үзүүлсэн байна.**
- **2010 онд Улсын хэмжээнд нийт 3690 эрүүгийн хэрэг шийдсэнээс 58 хүнд томилолтоор үнэ төлбөргүй өмгөөлөх үйлчилгээ үзүүлсэн байна[254].**

Дээрх тоо баримт нь МӨХ-оос төлбөрийн чадваргүй иргэнд үнэ төлбөргүй өмгөөллийн үйлчилгээ үзүүлдэг гэсэн тоотой хэтэрхий зөрж байгаа нь Өмгөөллийн тухай хуулийн 12.3.8 дахь заалтыг хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна. Өмгөөлөгч жилд төлбөрийн чадваргүй хоёр иргэнийг өмгөөлнө гэсэн үүргээ биелүүлэхгүй байгаагийн зэрэгцээ үүнийг хянах хяналт, хариуцлагын тогтолцоо байхгүй байна.

Эрх зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоонд өмгөөлөгчийн оролцоо:

МӨХ нь өмгөөлөгчдийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, өмгөөлөгч бэлтгэх, сургах, давтан сургах, тэдгээрийн эрх, ашиг сонирхолыг төр захиргаа, олон нийтийн байгууллагад төлөөлөх, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх чиг үүрэгтэй байгууллага юм.[255]

Монгол улс дахь хүний эрхийг хангах тулгуур асуудлын нэг бол төлбөрийн чадваргүй иргэдийн хууль зүйн туслалцаа авах эрх юм. Ядуу, орлого бага, төлбөрийн чадваргүй иргэдийн хувьд Үндсэн хуулиар баталгаажсан Монгол Улсын иргэний баталгаатай эдлэх шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг, эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх зэрэг үндсэн эрхээ хэрхэн хэрэгжүүлэх нь өмгөөлүүлэх эрх хэрхэн хэрэгжиж байгааг хэмжих нэг гол шалгуур нь төлбөрийн чадваргүй, ядуу иргэд маань энэ эрхээ хэрхэн эдлэж байгаагаар хэмжигдэнэ. Хэдийгээр иргэдийн өмгөөлүүлэх эрхийг Үндсэн хууль, Эрүү, Иргэн, Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар баталгаажуулж, төлбөрийн чадваргүй иргэдийн өмгөөлүүлэх эрхийг хуульчилж өгсөн хэдий ч манай судалгаанаас харахад энэ эрхийн хэрэгжилт туйлын хангалтгүй байна. Өмгөөллийн туслалцаа хүссэн төлбөрийн чадваргүй иргэдийн хүсэлт МӨХ-д тасралтгүй ирдэг байна. Түүнчлэн орон байргүй, оршин суух хаяггүй, дөнгөж шоронгоос гарч ирсэн хүмүүс өмгөөллийн туслалцаа авахад илүү хүндрэлтэй, бараг боломжгүй байдалд хүрч байна. Энэ нь оршин суух тодорхой хаяггүй учир тэдэнд оршин суугаа харьяаллын баг, хорооны Засаг даргын тодорхойлолтыг авах боломж байдаггүйтэй холбоотой юм.

[253] Монгол Улсын Дээд шүүхийн судалгааны төвийн баримтыг 2011 оны 7 дугаар сарын 21-нд шүүж үзэв.

[254] Монгол Улсын Дээд шүүхийн судалгааны төвөөс шүүсэн 2010.07.08.

[255] "Төлбөрийн чадваргүй хүмүүст эрх зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоог боловсронгуй болгох теслийн танилцуулга"-аас 2010 он.

Зөрчигдсөн эрхээ сэргээх боломж /Боловсролын байдлаар/

	Боломжтой	Дунд зэрэг	Боломжгүй	Мэдэхгүй	Хариулаагүй	Нийт
Дээд	160	226	178	133	23	820
Тусгай дунд	27	79	50	118	10	284
Бүрэн дунд	62	233	157	215	11	678
Бүрэн бус дунд	18	49	51	103	10	231
Бага ба боловсролгүй	1	6	8	67	-	82
Хариулаагүй	9	5	15	31	23	83
Нийт	277	598	459	667	77	2078

Зөрчигдсөн эрхээ сэргээлгэх боломж хэр байдаг талаар иргэдийн өгсөн хариулт /насны бүлгээр/

	Боломжтой	Дунд зэрэг	Боломжгүй	Мэдэхгүй	Хариулаагүй	Нийт
17 хүртэл	12	36	27	19	27	121
18-24	69	187	127	189	9	581
25-30	43	77	62	98	6	286
31-35	27	83	51	88	8	257
46-40	24	63	41	86	6	220
41-45	52	54	66	72	2	246
46-50	29	51	32	62	1	175
51-60	13	29	39	37	12	130
61-ээс дээш	8	18	15	16	6	63
	277	598	460	667	77	2079

Судлагдсан байдлаас харахад зөрчигдсөн эрхээ сэргээх, хамгаалуулах боломжтой гэж хариулсан нь бага хувийг эзэлж байгаа нь иргэд өмгөөллийн үйл ажиллагаа зөвхөн төлбөртэй явагддаг гэсэн ойлголттой байна[256].

Эрх зүйн туслалцааны төвийн өмгөөлөгч нь тогтмол цалинтай, гэрээт өмгөөлөгч байдаг. Сард нэг дүүргийн өмгөөлөгч төлбөрийн чадваргүй 10 хүн өмгөөлөхөд ажлын ачаалал маш хүндрэлтэй байдаг байна. Сүүлийн үед төлбөрийн чадваргүй иргэдийн өмгөөлүүлэх хүсэлт нэмэгдэж байгаа. Учир нь хувиараа өмгөөлөл хийх боломж бараг байхгүй болж байна. Сард улсаас төлбөрийн чадваргүй иргэнийг өмгөөлсний төлөө 216.000 төгрөг авдаг нь ажлын ачаалалд тохирсон үнэлгээ болж чаддаггүй гэж байв /Баянгол дүүргийн эрх зүйн туслалцааны төвийн өмгөөлөгчтэй ярилцав./

Эрх зүйн туслалцааны төвүүд байгуулагдсанаар ядуу иргэд эрх ашгаа хамгаалуулах боломж нээгдэж байгаа бөгөөд хууль зүйн чиглэлийн бүх үйлчилгээг үнэгүй авах бололцоотой.

Төлбөрийн чадваргүй иргэнд эрх зүйн туслалцаа үзүүлэх шалгуур буюу амьжиргааны доод түвшний орлоготой иргэнийг баг, хорооны Засаг дарга тодорхойлох, эсхүл орон нутагт төлбөрийн чадваргүй иргэний жагсаалт гаргах зэрэг нь учир дутагдалтай байна. Жишээ нь: Хүсэлт хүлээн авах маягтыг дэлгэрэнгүй болгох, зохих газраас сонгон шалгалт хийж танил

[256] Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар хийгдсэн. Иргэдийн албан бус боловсролын эрэлт хэрэгцээний судалгааны тайлан 2006 он.

талдаа үнэгүй үйлчлэхээс сэргийлэх зэрэг.[257] Иргэнд хууль зүйн ямар нэг туслалцаа үзүүлэхдээ төлбөрийн чадваргүй гэдгийг үнэн, зөв, шударга тогтооход тухайн баг, хорооны Засаг даргын оролцоо чухал үүрэг гүйцэтгэх ёстой. Энэ талаар нарийвчлан тодорхойлоос гадна Засаг дарга бодит байдлыг тогтоолгүй илтэд худал тодорхойлолт гаргаж өгдөг бол түүнд тодорхой хариуцлага тооцох талаар хууль зүйн хариуцлага тусгах нь зөв юм.

1998 онд батлагдсан "Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай" хуулиар[258] амьжиргааны доод түвшинг жилд нэгээс доошгүй удаа Үндэсний статистикийн газар тодорхойлно. Амьжиргааны түвшин 2010 оны байдлаар бүсээс хамааран 90900-101600 төгрөг байна[259]. Өмгөөллийн тухай хуульд төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх тухай болон энэ зардлыг санхүүжүүлэх, тайлан тооцоо гаргах журмыг холбогдох эрх бүхий байгууллага тогтоохоор энэ эрхийг баталгаажуулж өгсөн.

Төлбөрийн чадваргүй иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаанд зориулж улсын төсвөөс тодорхой хэмжээний хөрөнгө гаргадаг. Энэ хөрөнгө, хаана төвлөрч байгаагаас үл хамаараад жинхэнэ эзэндээ хугацаандаа хүрэх асуудал маш хангалтгүй зохион байгуулагдаж ирсэн тухай судалгаа байна.[260] Төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудал өнөөдөр ямар түвшинд байна гэдгийг эрүү, иргэний хэргийн хүрээнд, түүнчлэн гэмт хэргийн хохирогчид, эмэгт бүлгийнхэнд хэрхэн хүрч байгаа дүр зургийг харуулахаас гадна энэ асуудалд зарчмын шинжтэй өөрчлөлтүүдийг хийх нь зөв юм. Төлбөрийн чадваргүй үйлчлүүлэгчийн өмгөөллийн зардлыг батлагдсан жишгийн дагуу сар бүрийн эцэст нэг удаа тухайн өмгөөлөгчид нь бэлнээр олгох тухай заасан[261] байдаг. Өмгөөлүүлэх эрх нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны нэг үндсэн зарчим, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нараас эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцохдоо өөрийн эрх, ашиг сонирхолыг хууль зүйн дагуу хамгаалах эрхийн баталгаа мөн. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нь мэргэжлийн өмгөөлөгчийн тусламжид түшиглэн хуулиар олгосон эрхээ бүрэн бөгөөд ашигтай, боломжтой байдлаар эдлэх, хариуцлага хүлээх эсэхийг шийдвэрлэхэд хуулиар олгогдсон өмгөөлүүлэх эрхийн хэрэгжилт чухал ач холбогдолтой байдаг. Хууль зүйн туслалцаа авах эрхийг хэрэгжүүлэхийн тулд өмгөөлөгчөө өөрөө сонгох, хууль зүйн туслалцаа авах эрхийг хангасан байх явдлыг хуульчлан баталгаажуулах нь хүний эрхийг хангах нэг гол арга зам юм.

Төлбөрийн чадваргүй иргэн эрх зүйн туслалцааны төвийн өмгөөлөгчөөс хуулийн зөвлөгөө авах, наад зах нь нэхэмжлэл бичүүлэх, шаардлагатай

---

[257]Төлбөрийн чадваргүй иргэдэд зориулсан эрх зүйн туслалцааны үндэсний тогтолцоог боловсронгуй болгох нь судалгаа 9 дахь тал.

[258] Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай хууль"Төрийн мэдээлэл эмхэтгэл" 2000 оны 5 дугаар сарын №17-20 дугаарт нийтлэгдсэн.

[259] Үндэсний статистикийн газрын даргын 01/53 дугаар тушаал 2011.04.01.

[260] 2008 онд Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөлийн хуралдааны зөвлөмжид оруулах санал /Мэдээлэл шинжилгээний үнэлгээний газар/

[261] Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 263 дугаар тогтоолыг үндэслэн Хууль зүй дотоод хэргийн сайдын 2007 оны .. дугаар тушаалын 2 дугаар хавсралтын дагуу "Төлбөрийн чадваргүй иргэнд" Хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудлыг хариуцсан Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнээр хэлэлцэн гаргасан журам.

гэж үзвэл мөрдөн байцаах, шүүхийн шатанд өмгөөлүүлэх бололцоотой. Гэхдээ бүхэл бүтэн Аймаг, дүүргийн хэмжээнд нэг өмгөөлөгчийн үйл ажиллагаа тухайн нутаг дэвсгэрт харьяалагдах төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөллийн үйлчилгээгээр бүрэн хангах хэмжээнд хүрэлцэхгүй нь ойлгомжтой. Иймд эрх зүйн туслалцааны төвийн өмгөөлөгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Тоо баримт

2009 онд Эрх зүйн туслалцааны төв улсын хэмжээнд **1843** хүнд эрх зүйн туслалцаа үзүүлсэн гэсэн тоо баримт байгаагаас тэдгээрийн **1594**-д нь өмгөөлөгч авсан байна.[262]

Эндээс харахад төлбөрийн чадваргүй иргэд өмгөөлөгч авах шаардлага их байдаг нь харагдаж байна. Иймд дан ганц эрх зүйн туслалцааны төвийн нэг өмгөөлөгчөөр бүх асуудлыг зохицуулах биш МӨХ-ны өмгөөлөгчдийг шаардлагатай гэж үзвэл төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөллийн үйлчилгээ үзүүлэхэд татан оролцуулах ажлыг зохион байгуулж болох юм.

- *Иймийн тулд шаардлагатай тохиолдолд МӨХ-оос төлбөрийн чадваргүй иргэд өмгөөллийн үйлчилгээ хүссэн үед дан ганц эрх зүйн туслалцааны төвийн гэрээт өмгөөлөгч гэлтгүй бусад өмгөөлөгчдийг татан оролцуулах талаар нарийвчлан зохицуулах, мөн хариуцлагын тогтолцоог тусгах талаар анхаарах нь зүйтэй юм.*
- *Өмгөөллийн тухай хуулийн 12.3.8-д заасныг жилд төлбөрийн чадваргүй 2 хүн өмгөөлөх үүргийг нь эрх зүйн туслалцааны төвөөр дамжуулан хангуулж байх нь оновчтой юм.*

Улмаар энэ нь:

1.Эрх зүйн туслалцааны төвийн өмгөөлөгчийн ачаалал багасах

2.Иргэдэд хүртээмжтэй байдлыг хангах явдал тэнцвэржих зэрэг олон талын ач холбогдолтой юм.

Дээрх тоо баримтаас харахад өмгөөллийн туслалцаа авсан **1594** хүний 70-80 хувь нь Эрүүгийн хэрэгт холбогдсон хүмүүс байна. Үүнээс харахад иргэд ядуу байдлаасаа шалтгаалан гэмт хэрэгт холбогддог болох нь харагдаж байна. **Нөгөө талаас төрөөс иргэдийн амжиргааны түвшинг нэмэгдүүлэх талаар арга хэмжээ авах, ядуу иргэд юунаас болж гэмт хэрэгт холбогдож байгааг тогтоох, цагдаагийн байгууллага энэ асуудлыг анхааралдаа авч төлбөрийн чадваргүй иргэдийн үйлдэж байгаа гэмт хэргийг бууруулах тал дээр анхаарал тавьж түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь үр дүнтэй юм.**

Сургалт, сурталчилгааны ажилтан

Эрх зүйн туслалцааны төвд ажиллаж буй хууль зүйн хэлтсийн мэргэжилтэн нь үндсэн ажлын хажуугаар хавсарга шинжтэй өөр олон давхар ажил хариуцдаг. Засаг даргын Тамгын газрын хуулийн хэлтсийн ажил болон эрх зүйн туслалцааны төвийн ажлыг давхар хариуцан ажиллаж мөн тухайн аймаг, дүүргийн хувьд төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлыг дангаараа үзүүлж байна. Үлдсэн нэг мэргэжилтэн бусад ажлыг бүгдийг хариуцаж ажилладаг. Энэ бүхний цаана иргэд эрх зүйн үйлчилгээгээр хангагдах ёстой. Эцэст нь тодорхой төлбөрийн чадваргүй

[262] Эрх зүйн туслалцааны төвүүдийн 2009 онд хийсэн ажлын тайлангаас.

иргэнд л эрх зүйн туслалцаа үзүүлнэ гэж хязгаарлаж болохгүй юм. Гэвч нөгөө талаас бодит байдал дээр ядуу иргэдийн эрх ашиг хамгийн их хөндөгдөж хилс хэрэгт ч холбогдох нөхцөл байдал үүсдэг. Энэ бүх ачааг дан ганц эрх зүйн туслалцааны төвд хариуцуулах нь зохимжтой биш юм.

Иймд:

1. Эрх зүйн туслалцааны төвийн өмгөөлөгчдийн тоог нэмэгдүүлэх;
2. Эрх зүйн туслалцааны төвийн мэргэжилтний ажил үүргийн хуваарийг тэнцвэржүүлэх;
3. Эрх зүйн туслалцаа үзүүлэхэд хариуцлагатай хандах ёстой ажил юм. Иргэд эрүүгийн хэрэгт, сэжигтэнээр татагдсан үедээ л эрх зүйн туслалцаа хүсч ханддаг. Тийм учраас эрх зүйн туслалцааг анх хэдий үеэс эхлэх вэ? гэдгийг хуульчлах хэрэгтэй. Эрх зүйн туслалцааны төв нь албан ёсны байх ёстой бөгөөд дан ганц өмгөөллийн үйл ажиллагаа биш юм. Өөрөөр хэлбэл өмгөөлөгчөөс гадна эрх зүйн туслалцааны төвийн мэргэжилтны ажлын ур чадвар шаардагдах ажил юм.

Эрх зүйн туслалцааны төвийн дүрэм

Эрх зүйн туслалцааны төвд хандаж байгаа нийт иргэдийн 70-80 хувь нь эрүүгийн хэрэгт холбогдолтой туслалцаа авдаг бол үлдсэн 20-30 хувь нь иргэн, захиргааны хэрэгт туслалцаа авдаг байна.

Дүрмийн: 2.1.1.-д Төлбөрийн чадваргүй нь тогтоогдсон иргэнд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бүхий л үе шатанд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлнэ гэж заасан байгаа нь эрүүгийн эрх зүйн талаар зөвлөгөө өгөх авахыг тусгайлан зааж өгсөн байна.

2.1.3. Үйлчлүүлэгчийн санал хүсэлтийг үндэслэн эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаа явуулна гэж заасан байна.

Энэ талаар Иргэдийн эрх ашгийг чирэгдэлгүй түргэн шуурхай хангахын тулд эрх зүйн үйлчилгээ үзүүлж байгаа иргэд өөрсдөө өндөр мэдлэг чадвартай байх ёстой. Иймд тэднийг сургах сургалт семинарыг тасралтгүй чанарын өндөр түвшинд явуулах шаардлагатай байна.

4.1.1. Төлбөрийн чадваргүй нь тогтоогдсон иргэн буюу үйлчлүүлэгчийнхээ эрх ашгийг бүрэн хамгаалах үйл ажиллагааг хууль тогтоомжид заасан эрх, үүргийнхээ хүрээнд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бүхий л шатанд үнэ төлбөргүйгээр явуулах[263] гэж заасан байдаг. Гэтэл төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлж байгаа эрх зүйн туслалцааны төвийн зарим өмгөөлөгчид дор хаяж 50-60 мянган төгрөг авч өмгөөлдөг гэх яриа ч яригдаж байна. Гэвч энэ асуудлыг тогтоох боломж байхгүй юм. Тухайн өмгөөлөгч нь эрх зүйн туслалцаа үзүүлснийхээ төлөө төрөөс цалинжиж байдаг. Иймд дээрх асуудлыг таслан зогсоохын тулд иргэд тухайн эрх зүйн туслалцааг үнэ төлбөргүй авсан гэх тухай гарын үсэг зуруулан баримт үлдээх тухай нарийвчлан тусгаж өгөх шаардлагатай байна. Мөн бүхий л шатанд үнэ төлбөргүй эрх зүйн туслалцаа үзүүлнэ гэж байхад эрх зүйн туслалцааны төвийн өмгөөлөгч бүхий л шатанд үнэ төлбөргүй эрх зүйн туслалцаа үзүүлэхдээ иргэнээс төлбөр аваагүй шалтгаанаар түүний эрх ашгийг хамгаалахдаа хайнга хандах өөр бусад шалтгааны улмаас хоёрт

[263] Монгол Улсын засгийг газрын 2006 оны 263 дугаар тогтоолыг үндэслэн Хууль зүй дотоод хэргийн сайдын 2007 оны 02 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын дагуу Төлбөрийн чадваргүй иргэнд, Хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудлыг хариуцсан Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнээр хэлэлцэн гаргасан журам.

тавьж ажиллахгүй байхыг ёс зүйн дүрэмд тусгаж өгөх, түүнээс гарах үр дагавартай холбогдуулж торгууль оногдуулах болон цалинг тодорхой хэмжээнд бууруулах талаар тусгаж зохицуулах шаардлагатай байна.

Эрх зүйн мэдээлэл, сурталчилгааны тодорхой чиглэл тогтоон хэрэгжүүлэх: Иргэдэд эрх зүйн мэдээллийг тодорхой түвшинд үргэлжилсэн хэлбэрээр явуулж байх, эрх зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааг тодорхой нээлттэй байлгах, телевиз болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр иргэдэд мэдээлэл хүргэж байх үйл ажиллагааг тусгаж өгөх нь зүйтэй юм.

Эрүүгийн хэрэгт үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл явц:

Хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын шатанд иргэдийн өмгөөлүүлэх эрх ноцтойгоор зөрчигддөг байна. Ганц худаг дахь цагдан хорих төвд хийсэн шалгалтаар тэнд хоригдогсодын өмгөөлүүлэх эрх зөрчигдөх нь түгээмэл байдаг нь илэрсэн байна. Зөрчлийн шалтгааныг нь хоригдож байгаа хүнээс тодруулахад өөрөө хоригдсон болохоор ар гэрийнх нь хөөцөлдөж мэдэхгүй, өмгөөлөгчийн хөлс төлөх мөнгөгүй гэсэн хэд хэдэн шалтгаантай байдаг байна. Үүнээс харахад сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн өмгөөлүүлэх эрхийг хэрэгжүүлэх үүрэг бүхий өмгөөлөгчдийн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь төлбөрийн чадваргүй иргэдийн үнэгүй хууль зүйн туслалцаа авах эрхийг баталгаажуулах асуудлыг цогцоор нь шийдвэрлэх нь чухал байна. Тухайлбал иргэдийн өмгөөлүүлэх эрхийг нь танин мэдүүлэх, тэднийг өөрөө өөрийнхөө эрхийн төлөө тэмцэх чадвартай болгох, хуульчид өмгөөлөгчдийг энэ асуудалд хариуцлагатай хандах ухамсарыг төлөвшүүлэх нь чухал юм. Түүнчлэн шүүн таслах ажиллагаанд оролцогчид болох хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүгч, прокурор, өмгөөлөгч бүгд л хуулиар өөр өөрийн хүлээсэн үүргийг зохих ёсоор биелүүлж, өөртөө тавих шаардлагыг улам өндөржүүлж, хуулийг нэг мөр, хэлбэрэлтгүй биелүүлж хэвших нь хүний эрхийг хамгаалах явдлын үндэс юм.

Нөгөөтэйгүүр хөдөө орон нутагт иргэдийн өмгөөлүүлэх эрх зөрчигдөж байгаад дүгнэлт хийж, тэнд ажиллах өмгөөлөгчдийн цалин, хангамж болон шаардлагатай зарим асуудлын талаар төрөөс тусгайлан анхаарах хэрэгтэй байна.

Иргэний хэрэгт хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл явц:

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэн, хуулийн этгээд өөрийн эрх, эрх чөлөө, ашиг сонирхолоо хамгаалах үйл ажиллагааг өөрөө хэрэгжүүлэх буюу төлөөлөгчөөр дамжуулан гүйцэтгүүлдэг. Мөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд хуульд зааснаар төлөөлөх гэсэн ойлголт байдаг. Иргэний хэргийн хувьд хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа хэрэгтэй хүмүүсийн ихэнх нь орон байрнаасаа хөөгдөхөд тулаад байгаа, ажлаас үндэслэлгүй халагдсан гэх асуудалтай төлбөрийн чадваргүй иргэд байдаг байна. Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардлыг төсвөөс санхүүжүүлэхэд ямар нэгэн хязгаарлалт байхгүй юм. Өөрөөр хэлбэл төлбөрийн чадваргүй иргэн жилд хэдэн ч удаа хууль зүйн зөвлөгөө авч болно. Иргэд хуулийн этгээд нь иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд өөрийнхөө эрх, эрх чөлөө, ашиг сонирхолыг хамгаалахын тулд өөрийн биеэр, өөрийн нэрийн өмнөөс төлөөлөгч оролцуулах замаар гүйцэтгүүлдэг. Энэ талаар Иргэний хуулийн[264]

[264] Монгол Улсын иргэний хууль."Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2009 оны 7 дугаар сар №25-

62 дугаар зүйлд зааснаар төлөөлөл хэрэгждэг. Энэ нь зөвхөн эрх зүйн чадамжгүй болон зарим хэсэгчилсэн чадамжтай, түүнчлэн сураггүй алга болсонд тооцогдсон, нас барсан гэж зарлагдсан хүнийг төлөөлөх явдлаар хязгаарладаг. Иймээс төлбөрийн чадваргүй иргэнийг ИХШХШ ажиллагаанд төлөөлөх, хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудал сайн дурын буюу гэрээний үндсэн дээр төлөөлөх явдалд хамаарна.

Эрх зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоонд Цагдаа, Прокурорын байгууллагын үүрэг:

Ядуу иргэдийн тоо олширч байгаагийн улмаас, иргэд гэмт хэрэгт холбогдох нь олширч байна. Энэ үед төрийн үйлчилгээ нь цаг үетэйгээ уялдсан хууль хяналтын байгууллага өргөн хүрээнд ажиллах хэрэгтэй.[265] Прокурор нь гэмт хэргийн улмаас мэргэжлийн үүргийн хүрээнд шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно. Эрх зүйн туслалцааны төвийн үйл ажиллагаанд прокурорын байгууллагын оролцоо байгаа бол холбогдох дүрэм, журам, үүрэг нь тодорхой байх мөн эрх зүйн орчинг төгөлдөржүүлж нөгөө талаас насанд хүрээгүй хүнд эрх зүйн туслалцаа үзүүлэх, түүний эрх зүйн орчин ямар байх тухай тодорхой тусгах шаардлагатай юм[266]. Нийслэлийн дүүргүүдэд гарч байгаа гэмт хэргийн 60 хувь нь хулгай, дээрэм бөгөөд ихэнх нь ядуурал, ажилгүйдэлтэй холбоотой гардаг байна. Тэдгээрийн 40-60 хувь нь шүүхээр эцэслэн шийдвэрлэгддэг байна.

ЦЕГ-аас гаргасан статистик мэдээнээс үзэхэд, өнгөрсөн онд улсын хэмжээнд 20373 гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Тэдгээрт 19612 хүн холбогдсоноос 12637 нь эрхэлсэн тодорхой ажилгүй иргэд байсан. Мөн сургууль завсардсан 70, тэнэмэл, гэр оронгүй гэх 68 хүүхэд гэмт хэрэгт холбогдсон байна.

Амьжиргааны доод түвшингийн орлоготой иргэд багадаа 300 мянган төгрөгөөр өмгөөллийн үйлчилгээ үзүүлдэг өмгөөлөгчдөөр эрхээ хамгаалуулах чадвартай нь бага байдаг. Ийм байдалд амьдарч байгаа иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг аль ч улс орон бий болгодог[267].

Монгол улсын прокурорын байгууллага нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох чиг үүргийг хэрэгжүүлнэ[268] гэж заасан байдаг. Иргэд прокурорт ял өгдөг яллагч гэсэн байр сууринаас ханддаг бөгөөд прокуроруд ч энэ чиг үүргээ илүү баримталдаг билээ. Гэтэл прокурор эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд, тухайлбал хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хуулийн дагуу явагдаж байгаа эсэхэд, энэ үйл явцад хүний эрх хэрхэн зөрчигдөж байгаа эсэхэд хяналт тавьдаг гол субьект гэдгийг иргэд тэр бүр сайн мэддэггүйгээс прокурорт цагдаагийн хууль бус үйл ажиллагааны талаар гомдол, хүсэлт гаргаж шалгуулах нь ховор байдаг.

---

28 дахь дугаарт нийтлэгдсэн.

[265] 2010 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн төлбөрийн чадваргүй иргэнд үзүүлэх үндэсний тогтолцоо хэлэлцүүлгийн хурлын протоколоос

[266] 2010 оны 5 дугаар сарын 25-нд болсон төлбөрийн чадваргүй иргэнд үзүүлэх үндэсний тогтолцоо хэлэлцүүлгийн үеэр "Улсын ерөнхий прокурорын газрын" хяналтын прокурор Ё.Сарсайн ярилцлагаас.

[267] http://www.e-hutuch.gov.mn/eztt_durem. сүүлд 2011 оны 8 дугаар сарын 8-нд үзсэн.

[268] Прокурорын байгууллагын тухай хууль."Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2003 оны 1 дүгээр сар №01-04 дэх дугаарт нийтлэгдсэн.

Эрх зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоонд /шүүхийн оролцоо/

Шүүхийн тухай хуулийн[269] 8.1. Монгол Улсад хүн бүр үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол болон бусад байдал, түүнчлэн аж ахуйн нэгж, байгуллага өмчийн хэлбэр, эрх хэмжээний ялгаваргүйгээр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна. Энэ эрхийнхээ хүрээнд иргэд шүүхийн өмнө эрх ашгаа хамгаалуулах эрхтэйг баталгаажуулсан заалт байна.

Мөн хуульд хууль ёс, хүний эрх, эрх чөлөөний баталгааг хангах бас нэг субьект нь өмгөөлөгч гэж заасан байна. Мэргэжлийн өмгөөлөгч эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны аль үе шатнаас эхэлж оролцсоноос хамаарч тухайн иргэний эрх хэрхэн хангагдсаныг тодорхойлж болно. Шүүхийн тухай хуульд[270] Шүүгдэгчийг шүүх хуралдаанд заавал биеэр оролцуулна гэж заасан байдаг. Харин шүүх тухайн этгээдэд энэхүү эрхээ хэрэгжүүлэх боломжийг хангах үүрэг хүлээнэ гэжээ.

Эрүү, иргэний хэргийн анхан шатны болон давж заалдах шатны журмаар хянан хэлэлцэх шүүх хуралдаан мэтгэлцэх зарчмын үндсэн дээр явагддаг. Энэ үед эрүү, иргэний хэрэгт хууль зүйн туслалцаа хэр хангагдаж байгаа нь харагдаж, улмаар шүүхийн шийдвэрт тусгалаа олж эцсийн үр дүн нь харагдах болно. Монгол Улсын шүүхчүүд нь зохион байгуулалтын хувьд орон нутагт жигд тархсан байдаг. Өнөөдөр Монгол Улсын 21 аймаг, нийслэлийн 22 шүүх, сум буюу сум дундын шүүх 29, дүүргийн шүүх 8, УДШ-ийг оролцуулаад нийт 61 шүүх ажиллаж байна. Гэвч шүүх өргөдөл, гомдлыг түдгэлзүүлэх, бусад байгуллагад шилжүүлэх, хугацаа хэтрүүлэх, буруу шийдвэрлэх зэргээр иргэдийг хохироох явдал гаргасаар байна[271].

ГУРАВ. АНХАН ШАТНЫ ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ ТӨВИЙН ХАМРАХ ХҮРЭЭ:

Эрх зүйн туслалцааны төв байгуулагдан бүх аймаг, нийслэлийн бүх дүүргүүдэд үйл ажиллагаа явуулсаар байна. Хууль зүйн туслалцааг иргэдэд үнэ төлбөргүй, шуурхай, чанартай хүртээмжтэй хүргэхэд эдгээр төвийн үйл ажиллагаа чиглэж байна. Одоогийн байдлаар өмгөөлөгчдөөс гэрээний үндсэн дээр Эрх зүйн туслалцааны төвд ажиллуулж байгаа ба төв нь аймаг, нийслэл, дүүргийн хууль зүйн асуудал эрхэлсэн нэгжид харъяалагдаж, санхүүжилтийн хувьд хандивлагчдын тусламжид тулгуурлаж байна. Монгол Улсын Үндсэн Хуулийн[272] 19 дүгээр зүйлийн 1-д Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна гэжээ. Мөн Өмгөөллийн тухай хуулийн[273]

[269] Шүүхийн тухай хууль. "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2002 оны 8 дугаар сар № 29-32 дэх дугаарт нийтлэгдсэн.

[270] Шүүхийн тухай хууль. "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2002 оны 8 дугаар сар № 29-32 дэх дугаарт нийтлэгдсэн.

[271]Хууль зүй, дотоод хэргийн яам, Монголын нээлттэй нийгэм хүрээлэн хамтарсан /2003 он/ Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний тогтолцоог боловсронгуй болгох нь сэдэвт үндэсний бага хурлын эмхэтгэлээс.

[272]Монгол Улсын Үндсэн Хууль."Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

[273] Өмгөөллийн тухай хууль. Өмгөөллийн тухай хууль, "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002

21.1-д зааснаар төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ гэж заасан нь төлбөрийн чадваргүй иргэнд эрх зүйн тусламж үйлчилгээ үзүүлсэн зардал улсын төсвөөс санхүүжүүлэх тухай заалт юм. 2009, 2010 онуудад Эрх зүйн туслалцааны төвийн өмгөөлөгчдийн хөлсөнд нийт 156.820.000 төгрөг зарцуулагдсан байна. Мэдээж ажиллах хүч, хүний нөөцийн боломж, ажлын ачаалал, эрх зүйн үйлчилгээний хүртээмжтэй байдал зэрэг бэрхшээлтэй зүйл олон бий. Эрх зүйн туслалцааны төвөөр үйлчлүүлж байгаа иргэдийн 60-70 хувь нь төлбөрийн чадваргүй иргэд хаңддаг гэсэн албан бус тоо байна[274].

2010 оны байдлаар ажилгүйдлийн түвшин их байгаа аймгууд

№	Аймаг	Хувь
1	Орхон	29,2%
2	Говьсүмбэр	21,2%
3	Дорноговь	20,7%
4	Сүхбаатар	15,9%
5	Булган	19,5%

Ажилгүйдлийн түвшин нийт 2.735.780 хүн амаас тоон үзүүлэлтээс харахад 38.7 хувь нь ажилгүй байна гэсэн тоо баримт гарч байна.

Ажилгүйдлийн түвшинг бүсээр нь

№	Байршил	Хувь
1	Хотод	30,6%
2	Хөдөөд	49,6%
3	Улаанбаатарт	86,7%
4	Аймгийн төвд	37,0%
5	Сумын төвд	42.6%

Дээрх тоон үзүүлэлтээс харахад манай улсын хэмжээнд төлбөрийн чадваргүй иргэн хот, хөдөөд, хүн амын нягтаршилаас хамаарахгүй тоон үзүүлэлтийн хувьд адил түвшинд байна. Эрх зүйн туслалцааны төв нь сургалт болон сурталчилгааны хэлбэрээр иргэдийн ухамсрыг төлөвшүүлэхэд нөлөөлөхүйц байдлаар тодорхой ажил хийх шаардлагатай байгаа нь харагдаж байна. Хуулийг нийгмийн харилцааг зохицуулагч үндсэн хэрэглүүр гэдгийг чухалчилан үзэх хэрэгтэй юм. Иймээс эрх зүйн шинэтгэлийн тусагдахуунаар баримжаалан дүгнэлт хийж үзвэл:

1.Тоон үзүүлэлтийн хувьд эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд 460 гаруй хууль бүртгэгдсэн байна. Хууль тогтоомж шинэчлэгдэж батлагдах үйл явц амжилттай хэрэгжиж байгаа хэдий ч давхардал, хийдэл, орхигдол, гарсаар байгаа билээ.

2.Хууль тогтоох, хуулийн биелэлтийг хангах, хууль хэрэглэх тогтолцоо, арга ажиллагааг шинэтгэх хүрээнд хэд хэдэн хөтөлбөр боловсруулсан боловч хөдөө орон нутаг, хот суурин газрын онцлогоос хамаарч хуулийн үүйцэтгэлийг хангах, хууль хэрэглэх арга ажиллагааг шинэтгэх ажил төдийлөн хангалттай явагдаж чадахгүй байна.

оны 06 дугаар сарын №21-24 дэх дугаарт нийтлэгдсэн.

[274] 2009 онд Нээлттэй нийгэм форум, Монгол Улсын хууль зүй, дотоод хэргийн яам, НҮБХХ-ийн Хууль зүйн үйлчилгээний хүртээмж ба хүний эрх төсөлийн судалгааны тайлангаас

3.Хууль зүйн мэргэжлийн боловсролыг шинэтгэх тал дээр тоон үзүүлэлтийн хувьд маш их ахиц гарсан. Чанарын хувьд ч цөөнгүй, гологдохооргүй боловсон хүчинтэй болсон боловч, тэдгээрээс төрийн байгууллагад ажиллах сонирхолтой мэргэшсэн, чадварлаг боловсон хүчин цөөн байна.

4.Хууль зүйн эрдэм шинжилгээний ажлын зохион байгуулалт, арга зүйг шинэтгэх үйл явц хөрөнгө оруулалтын байдлаас төдий л ахицтай байж чадахгүй байна.

5.Нийгэмд эрх зүйн шинэ ухамсар төлөвшүүлэх үйл явц нь дээрх 4 тусгадахууны шууд илрэл учир эрх зүйн ухамсарын төлөвшлийг эергээр дүгнэх боломжгүй байна. Үүний гол шалтгаан нь улсын хэмжээнд гарч буй гэмт хэрэг, зөрчлийн тоо буурахгүй байгаагаас харж болно[275].

Иймд эрх зүйн туслалцааны төвийн үйл ажиллагаг цаашид улам бэхжүүлж, эрх зүйн туслалцааны үндэсний тогтолцоог боловсронгуй болгох асуудал чухлаар тавигдаж байна. Аливаа бодлогын шийдлийг аль болох олон талаас нь шүүн хэлэлцэж, эрх ашиг нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, хэсгийн дуу хоолойг сонсож байх нь ардчилсан нийгмийн гол шаардлага билээ. Төлбөрийн чадваргүй гэдэг ойлголтод амьжиргааны доод түвшинд хүрэхгүй иргэдийн эрх ашиг хөндөгдөнө. Мөн иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх одоогийн үндсэн тогтолцоо буюу МӨХ-ны санал, санаачилга чухал үүрэгтэй. Төлбөрийн чадваргүй иргэнд үзүүлэх хууль зүйн туслалцааг хувийн хэвшлийн биш чухамдаа төрийн үйлчилгээний нэг төрөл болгох шаардлага өнөөгийн монголын нөхцөл байдлаас урган гарч байна. Хууль зүйн туслалцаа үзүүлэх чиг үүргийг мэдээж мэргэжлийн хуульч өмгөөлөгч хэрэгжүүлнэ. Энэ утгаараа МӨХ-ны гишүүдээс сайн дурын үндсэн дээр, тодорхой шалгуур хангасан этгээд томилогдон ажиллана. Харин түүний ажиллах нөхцөл, эдийн засгийн хөшүүрэг нь төрийн албан хаагчийн статус олгосноор бүрэлдэн бий болох боломжтой юм. Энэ нь маш энгийн логикоос үүдэлтэй дүгнэлт юм. Өмгөөлөгчийн хувьд зах зээлийн өрсөлдөөн, чөлөөт үнийн механизм үйлчилж байдаг бөгөөд тэрээр бизнесийн эрсдэл, орлого олох боломжийг өөрөө бүрэн хариуцна. Энэ тохиолдолд өмгөөлөгч төлбөрийн чадваргүй иргэнд үнэ төлбөргүй мөртлөө чанартай үйлчилгээ үзүүлэх эдийн засгийн хөшүүрэг байхгүй. Тиймээс тэрхүү зах зээлийн хөшүүргийг орлох чадвартай ямар нэгэн механизм байж гэмээ нь өмгөөлөгчөөс чанартай үйлчилгээг шаардах боломжтой юм. Төсвийн тогтмол, баталгаатай цалин, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал, нэмэлт урамшууллын системд хамрагдах боломжтой төрийн албан хаагчийн орон тоо бий болгосноор уул механизмыг бүрдүүлж чадна гэж үзэж байгаа болно. Үндсэн хуулиар төрд хүлээлгэсэн үүргээс зайлах аргагүй бөгөөд дээр гаргасан үндэслэл ёсоор уг үүргийг хувийн хэвшил биш төрийн тогтолцоогоор дамжуулан хэрэгжүүлэхээс өөр аргагүй нөхцөл байдал байгаа юм. Цаашилбал төрөөс ядуу иргэндээ хууль зүйн үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлэх нь төрийн халамж, үйлчилгээний нэг хэлбэр мөн бөгөөд оновчтой тусламж болно. Хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа нь хувь хүнд ч, төрд ч ашигтай буюу гарах зардлаасаа заавал илүү ур ашгийг авчирна.

Шинэ тогтолцоо бүрдсэнээр монголын хүн амын багагүй хувийг эзэлж

[275]Хууль зүйн алба байгуулагдсаны 100 жилийн ойд зориулсан "Монгол Улсын эрх зүйн хөгжлийн асуудлууд" эрдэм шинжилгээний бага хуралд тавигдсан "Монгол Улсын шинэхэн үеийн эрх зүйн хөгжил" сэдэвт харьцуулсан эрх зүйн үүднээс авч үзсэн илтгэл /Ph.D/ Б.Гүнбилэг

буй амьжиргааны түвшингээс доогуур орлоготой олон иргэний хувь заяанд эргэлт гаргах нь дамжиггүй. Эдгээр хүмүүс эрх зүйн тусламжийн гадна үлдэх эрсдэл үүсч болохыг анхаарах хэрэгтэй юм. Хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй байж, тэгш боломжоор хангагдах учиртай. Энэхүү хууль зүйн зарчим, хүний эрхийг дээдлэх үзлийн үүднээс дэлхийн олон оронд хууль зүйн үнэ төлбөргүй туслалцааг төрөөс дэмждэг байна. Тэгвэл эдийн засгийн утгаараа ч ийм тогтолцоо нийгмийн хөгжил, дэвшилд хувь нэмрээ оруулах чухал зүйл гэдгийг бодлого боловсруулах түвшинд харгалзан үзэх хэрэгтэй.[276]

Хүний эрх, хууль эрх зүйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 21 төрийн бус байгууллага байна. Дийлэнх нь үйл ажиллагаагаа нийслэлд төвлөрүүлж явуулдаг учраас орон нутагт иргэдэд хүрч үйлчлэх боломж хомс байна. Эдгээр байгууллага нь эрх зүйн зөвлөгөө, сургалт, судалгааны ажил гэсэн үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Зарим төрийн бус байгууллага тухайлбал "Хүний эрх хөгжил төв" стратегийн өмгөөллийн чиглэлээр сургалт явуулж өмгөөлөгчдийг дэмжин ажиллаж байгаа өмгөөллийн хамрах хүрээ нь хэтэрхий явцуу, жишээ нь зөвхөн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг өмгөөлөх гэх мэтээр нэг чиглэлийг барьдаг байна. Харин эдгээр төрийн бус байгууллагууд нь мэргэжлийн өмгөөлөгчдийг үйл ажиллагаандаа татан оролцуулж, байнгын холбоотой ажиллаж, цаашид төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлэх чиглэлээр ажиллах нөөц бололцоо байгааг харуулж байна. Нөгөө талаар, төрийн бус байгууллага нь тогтвортой үйл ажиллагаа явуулах хэмжээнд бэхжиж чаддаггүй, богино хугацаанд үйл ажиллагаа явуулаад зогсдог тал байдаг. Иймээс эрх зүйн туслалцааны байнгын найдвартай эх үүсвэр гэж үзэхэд учир дутагдалтай юм.

Эрх зүйн туслалцааны төвийн үйл ажиллагаатай хамтарч эрх зүйн туслалцааг үзүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор хамтран ажиллаж тэдний үйл ажиллагаанд төлбөрийн чадваргүй иргэнд үзүүлэх эрх зүйн туслалцаа алслагдсан орон нутагт бүс бүсээр нь ангилан эрх зүйн туслалцаа үзүүлэх төрлөөр нь ангилж өгвөл зохимжтой гэсэн саналтай байна. Ингэснээр уг төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа ч бэхжих юм.

[276] 2010 оны 5 сарын 23-нд болсон "Хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний тогтолцоог боловсронгуй болгох" хэлэлцүүлэг.

ДӨРӨВ: /ПАРА-ЛЕГАЛ[277]/-ИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ, ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ ХҮРЭЭ, ХЯЗГААР.

Эрх зүйн үйлчилгээ бол хууль зүйн салбарын чухал хэрэгсэл бөгөөд бүхэл бүтэн нийгэм болон хувь хүмүүст маргааныг шийдвэрлэхэд тусалдаг.

Эрх зүйн үйчилгээн дээр суурилсан нийгэмд амьдарч ажиллаж байгаа ядуу иргэдэд хууль зүйн асуудал тулгарсан үед эрх зүйн боловсрол олгох мөн зуучлал үзүүлэх зэргээр албан ёсны хууль зүйн системийн мэдлэгээ эрх зүйн зөвлөгчид хэрэглэдэг.

Эрх зүйн үйлчилгээ үзүүлэгч нь хуульчдыг бодвол ажлын хөлс, зардлын хувьд хямд бөгөөд албан ёсны хууль зүйн шат дамжлагыг бодвол хурдан. Эрх зүйн үйлчилгээн дээр суурилсан нийгэм нь зөрчилдөөн тэмцэлдээнтэй байгаа орон, шилжилтийн болон хөгжиж байгаа оронд үр нөлөөтэй. Жишээлбэл Сиерра Леонед 3 сая хүнд ердөө 100 хуульч байдаг үүнээс 10 нь шүүгч хууль зүйн хэрэгцээ шаардлагыг хангаж байна. Эрх зүйн үйлчилгээ үзүүлэгчид төрийн албан хаагчидтай хариуцлага тооцох, гэр бүл салалт, газрын маргаан зэргийг шийдвэрлэхэд тусалдаг. Магадгүй нэг чухал зүйл бол эрх зүйн үйчилгээ үзүүлэгчид бүхэл бүтэн нийгмийг эрх зүйн боловсролтой болгох иргэдийг эрхээ мэдэх боломжийг нэмэгдүүлж, иргэдийн төлөөлөгчдийг бий болгож тэд засгийн газарт шаардлага тавихад нь тусладаг юм.

Энэ нь эрх зүйн үйлчилгээний хөтөлбөрийг бий болгох мөн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай бүх талын мэдээллийг багтаасан, түүнчлэн нийгмийн хэрэгцээг үнэлэх шаардлагатай сургалт явуулах, хууль зүйн асуудлыг шийдвэрлэх зэрэг бүхий л ажиллагаг явуулдаг байна[278].

Монгол Улсад төлбөрийн чадваргүй хэн боловч эрх зүйн туслалцаа авах боломжийг бүрдүүлэх үлмаар эрх зүйн туслалцааны үндэсний тогтолцоог бэхжүүлэн хөгжүүлэхэд мэргэжлийн хуульч, өмгөөлөгч нарын зэрэгцээ эрх зүйн "хөтөч" бий болгох явдал зайлшгүй шаардлагатай байгааг үндэслэн хүн амын 38.7 хувийг ээлж байгаа ядуу иргэдэд хүртээмжтэй, чанартай үйлчилгээ хүргэх бодит боломжийг судлахад нааштай дүр зураг харагдаж байгаа ч цаашид анхаарах, шийдвэрлэх асуудлууд нэлээд байна.

Гадаад орнуудын туршлагаас харахад "Паралегал"[279] гэсэн ойлголт байдаг. Энэ нь хууль зүйн мэргэжлийн зөвлөгөө болон өмгөөллийн үйлчилгээ үзүүлэхээс бусад чиглэлээр эрх зүйн туслалцаа үзүүлэх чадвартай, тусгайлан

[277] Гадаадын улс орнуудад хууль зүйн анхан шатны зөвлөгөө өгдөг, өмгөөлөгч бус хүмүүсийг паралегал гэж нэрлэдэг. Эмнэлэгт эмнэлгийн анхны тусламж үзүүлдэг шиг хуулийн анхны тусламж үзүүлдэг байна. Паралегал гэдэг үг хаанаас гарсан бэ гэвэл, Энэтхэг, Филиппин, Африкийн зарим хэсэг ихэнхдээ хөдөөгүүр "хөл нүцгэн эмч," "хөл нүцгэн хуульч" гэж нэрлэгдсэн хүмүүс тосгоноос тосгон дамжин явж эмнэлгийн, хуулийн үйлчилгээ хүрч чаддаггүй хэсэгт очиж хүмүүст эдгээр чиглэлээр туслалцаа үзүүлдэг байна. Энэ мэтчилэн ажилладаг хүмүүсийг тэдний ажил үүргийг илүү тодорхой болгохын тулд "пара-медикал", "пара-легал" гэж нэрлэх болсон байна. Пара гэдэг үг нь " –тэй адилхан" "-тэй төстэй" гэсэн утгатай. Зарим улс оронд анагаахын сургууль төгсөж эмч болоогүй мөртлөө эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлдэг хүмүүс байдаг. Эдгээр хүмүүсийг "пара-медикал" гэж нэрлэдэг. Үүнтэй адил хуулийн сургууль төгсөж хуульч болоогүй мөртлөө хуулийн анхан шатны зөвлөгөө тусламж үзүүлдэг хүмүүсийг паралегал гэж нэрлэдэг байна. Паралегал гэдэг нь хуульч бус хуульч гэж орчуулагддаг. /Иргэдийн эрх зүйн хөтөч УБ, 2007 он 477 дахь тал/

[278] Community-based Paralegals /A Practitioner,s guide/ open society foundations 2009.

[279] http://uslugi.slando.kuban.ru/

бэлтгэгдсэн этгэздийг хэлдэг байна. Эрх зүйн туслалцаа гэдэгт өмгөөлөл, хууль зүйн мэргэжлийн зөвлөгөө, эрх зүйн сургалт, сурталчилгааг хамруулан ойлгож байгаа. Тэгэхээр манай нөхцөлд паралегалууд эрх зүйн сургалт, сурталчилгаанд оролцох нь илүү зохистой гэж үзэж байна. Эрх зүйн сургалт сурталчилгааг тодорхой түвшинд мэргэшсэн эрх зүйн мэдлэгтэй бэлтгэгдсэн хүн байж паралегалийн үйлчилгээ үзүүлнэ. Эс тэгвэл энэ үйлчилгээ нь цаашаа шүүхийн шатанд очиход түүнээс гарах үр дагавар нь хуулийн хүрээнд гарсан тодорхой үр дагавартай үйлчилгээ байх ёстой.[280] Мөн эрх зүйч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн боловсон хүчин хангалттай их байна. Мэргэжлээрээ ажиллах гэхэд хуульчийн сонгон шалгаруулалтанд тэнцсэн хуульчийн гэрчилгээ шаардаж ажил олдохгүй байх нь элбэг. Энэ байдал нь ажилгүйдэлд хүргэх бас нэг шалтгаан болж байна гэж болно. Иймд эдгээр боловсон хүчнийг "Паралегал" болгон ажиллуулах нөхцөлөөр хангах нь зохистой юм.

Мөн төлбөрийн чадваргүй иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэхэд эрх зүйн туслалцааны төвийн зэрэгцээ бусад иргэд, төр, иргэний нийгмийн байгууллага, албан тушаалтан хамтран оролцох шаардлагатай байна.

Манай нөхцөлд дараах иргэд, төр, иргэний нийгмийн байгууллага, албан тушаалтан паралегалийн үүргийг гүйцэтгэх боломжтой гэж үзэж байна.

Үүнд:

- Баг, хорооны Засаг дарга

Баг, хорооны Засаг дарга нь өөр олон ажил хариуцдаг, цагийн боломж таруу болов эрх зүйн наад захын мэдлэг, мэдээлэл, зөвлөгөө өгөх чадвартай байвал өөрт нь хандаж тусламж дэмжлэг хүсэхээр ирсэн баг, хорооныхоо иргэдэд илүү сайн үйлчлэх боломжтой.

- Багийн орон тооны болон сайн дурын ажилтан

Баг, хорооны ажилтан иргэдэд хамгийн ойр, тэдний амьдралыг маш сайн ойлгодог хэнд ямар зовлон гарсан талаар шуурхай мэдээлэл авдаг. Иймд баг, хорооны ажилтан иргэдэд ямар асуудал тулгарч байгааг эрх зүйн талаас нь ялгаж, зааглах наад захын чадвартай байвал иргэдийг Эрх зүйн туслалцааны төвийн өмгөөлөгчтэй холбож өгөх, тэгснээр эрх зүйн туслалцааг хэрэгтэй хүнд нь хүргэх боломж улам нэмэгдэх юм.

- Сумын Засаг даргын Тамгын газрын дарга

Иргэд, сум, баг, хорооны Засаг даргын шийдвэрлэж чадаагүй асуудлаар сумын захиргаанд хандах нь тодорхой. Тийм үед Засаг даргын Тамгын газрын дарга эрх зүйн талаасаа боломжтой, боломжгүй зүйлсийг ялган зааглаж, иргэнд тайлбарлан ойлгуулж, зааж, чиглүүлж өгдөг байх хэрэгтэй юм.

- Суманд ажиллаж байгаа цагдаагийн төлөөлөгч

Цагдаагийн байгууллагын хүч бололцоог иргэдэд хүргэх, ухуулан таниулах талруу чиглүүлж болох юм. Хамгийн гол давуу тал нь сумын цагдаагийн төлөөлөгч, аймгийн төвтэй харилцаатай байж иргэдэд гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх болон бусад ажлыг зохицуулах боломжтой юм.

- Сумын төвд байнга оршин суудаг нийгмийн идэвхтэй нэр хүндтэй, нөлөө бүхий иргэн.

[280] 2008 онд ХЗДХЯ-ны захиалгаар АНУ-ын Азийн хөгжлийн сангийн гүйцэтгэсэн тайлан " Паралегал буюу эрх зүйн хөтөч" судалгааны тайлангаас

Ийм хүмүүс сум болгонд байдаг. Голдуу нас тогтсон, тодорхой нэг салбарт олон жил ажиллаж түүгээрээ мэргэшсэн, тэтгэвэрт гарсан хүмүүс байдаг. Тэдэнд эрх зүйн анхан шатны тодорхой мэдлэг олгож иргэдэд ухуулан, таниулах ажилд татан оролцуулах нь үр дүнтэй юм. Эдгээр хүмүүс нь сайн дураар ажиллахад ч татгалзахгүй гэж үзэж байна.

- Хуулийн сургууль төгсөгчид.

Хуульчийн сонгон шалгаруулалтанд бэлтгэж байгаа бөгөөд орон нутагтаа мэргэжлээрээ ажиллах хүсэлтэй ч ажлын байргүй байгаа хуулийн сургуулийн төгсөгч. Паралегалийг бий болгоход тусгай сургалт болон урамшуулал гэсэн хоёр үндсэн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай. Паралегал бэлтгэх сургалт нь хоёр түвшинд байж болно. Эхний түвшинд эрх зүйн туслалцааны төвийн өмгөөлөгч нар өөрсдөө сургалт явуулна. Энэ нь баг, хорооны Засаг дарга, ажилтан зэрэг иргэдийг өмгөөлөгчтэй холбож өгөх үүрэгтэй паралегал нарт зориулсан сургалт байна. Өмгөөлөгч практикт ямар төрлийн хэрэг маргаан зонхилж байгааг өөрийн өмгөөллийн туршлага дээр үндэслэн тодорхойлж, тэдгээрийн гол шинж, иргэд хэргийн холбогдогч, гэрч, хохирогч болж байгаа байдал, ер нь иргэдийн эрх зөрчигдөж байгаа ямар нуугдмал тохиолдлууд байж болох талаар сургана. Дараагийнх нь анхан шатны эрх зүйн мэдлэг олгох паралегал нарыг бэлтгэх сургалт. Эдгээрт хамгийн гол нь сумын төвд байнга оршин суудаг, иргэдтэй байнга харьцах боломжтой хүмүүс байх хэрэгтэй.

ТАВ. Хууль зүйн сургууль төгсөгчдийг төлбөрийн чадваргүй иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх төвд ажиллуулах нөөц, бололцоо. Тухайлбал, Хуулийн сургууль төгсөөд "Хуулийн шалгалт" өгөх хүртэл 2 жилийн хугацаанд дадлагажих шаардлагатай боловч ажлын байр олоогүй төгсөгчдийн тоо, судалгаа, шалтгаан.

Хууль зүйн бакалаврын сургалт явуулдаг нийт 22 их, дээд сургуулиас судалгаа авч үзэхэд 21 сургуульд клиник сургалтын тэнхим эсхүл төв байгуулагдан ажиллаж байна. Нэг сургууль жилд дунджаар 30 орчим оюутан клиник сургалтын хичээлийн программд бүрэн хамрагдаж, иргэдэд үнэ төлбөргүй зөвлөгөө өгдөг байна. Эдгээр сургуулиудын клиник сургалтын төвийн ачаалал харьцангуй бага бөгөөд хамгийн их ачаалалтай ажилладаг нь МУИС - ХЗС -ийн клиник сургалтын төв жилд дунджаар 100 хүнд зөвлөгөө өгч, 2007-2009 онд 300 орчим иргэнд зөвлөгөө өгсөн байна. Оюутан багшийн удирдлаган дор тухайн иргэнийг шүүхэд төлөөлөхөөс бусад үйлчилгээг үзүүлдэг байна. Клиник сургалт нь зөвхөн нийслэлд төвлөрсөн учраас орон нутгийн иргэд хамрагдахгүй үлдэж байгаа юм. Их, дээд сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгссөн төгсөгчид төрийн албанд орох гэхэд Хуульч сонгон шалгаруулах тухай хуульд зааснаар мэргэжлээрээ 2 жил ажилласан хүн сонгон шалгаруулалтанд орно[281] гэж заасан ингэхдээ хуулийн дагуу нийгмийн даатгалын шимтгэл төлсөн тохиолдолд бүртгэх, мөн төрийн албаны шалгалтанд тэнцсэн, ажлын туршлага гэх мэт шалгуур тавьдаг. Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургуулийг төгсөгчид тодорхой хугацаанд цалинтай дадлагажиж байж гэрчилгээгээ авдаг шиг хууль зүйн салбарт ийм тогтолцоо байх нь зүйтэй. Энэ бол хангалттай их тоо учраас эдгээр эрх зүйчдийн саналыг нь харгалзан тэдний нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэн апсладгдсан бүс нутгийн хуулийн зөвлөгөө өгөх төвийг боловсон хүчнээр

[281] Хуульч сонгон шалгаруулах тухай хууль. "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2010 оны 3 дугаар сар № 9-12 дэх дугаарт нийтлэгдсэн.

хангахад тохиромжтой юм. Хуулийн мэргэжлийн оюутнууд хуулийн зөвлөгөө туслалцаа үзүүлэх тогтолцоонд 2 замаар оролцох боломжтой.

Нэгдүгээрт: Их дээд сургуулиар дамжуулан

Хоёрдугаарт: Шууд хуулийн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх төвд сайн дураар ажиллах арга зам байна. Их сургууль сургалтын хөтөлбөртөө мэргэжлийн дадлагыг тусгаж өгсөнөөр оюутнуудад болон хуулийн зөвлөгөө туслалцаа үзүүлэх төвийг энэхүү тогтолцоонд хамруулж болох юм. АНУ-ын их сургууль оюутнууддаа гэрээслэл бичих, орлого багатай, нийгмийн доод давхаргын иргэдэд төлөөллөөр өмгөөлийн үйлчилгээ үзүүлэх зэрэг нийгмийн үйл ажиллагаанд оролцохыг нь дэмжин ажилладаг. АНУ-ын хуулийн сургуулиудад энэ ажлыг хуулийн боловсролын хөтөлбөрт тусгахыг хуульчилж өгсөн байдаг.[282]

Хамгийн наад зах нь хуулийн мэргэжлийн оюутнууд хууль зүйн туслалцаа үзүүлэх төвүүд болон бусад байгууллагуудад сайн дураараа ажиллах боломжтой юм. Австралийн хуулийн шинэчлэлийн комисс энэхүү арга хэмжээ нь хуулийн мэргэжлийн оюутнуудад хариуцлагыг нэмэгдүүлж, ёс зүйд сургахын хамт мэргэжлийн боловсрол, тэдгээрийн хөгжилд нөлөөлнө гэж үзсэн байна. Оюутнууд захидал төлөвлөх, хавтаст хэрэг цэгцлэх болон бусад оффисын ажлыг гүйцэтгэх төдийгүй хуулийн туслалцаа, зөвлөгөө өгөх төв дээр ажиллаж байгаа хуулийн сургуулийн төгсөгчдөд тусалдаг байна. Иймд Монголын хуулийн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх төвүүдэд тулгараад байгаа ачаалтыг багасгахад сургууль төгссөн эрх зүйчдийг хуулийн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх төв дээр дадлагажуулбал үр дүнтэй ажил болно. Монгол Улсад 21 аймаг, 9 дүүрэгт, эрх зүйн туслалцааны төв байна.

Нийт 30 эрх зүйн туслалцааны төвийн үйл ажиллагаанд эдгээр эрх зүйчдийг татан оролцуулж гол үр дүн нь алслагдсан хөдөө орон нутгийн баг, хороонд хүртээмжтэй болгох зорилгоор ажиллах нь тохиромжтой юм. Иргэдийг чанартай үйлчилгээгээр хангахын тулд оюутнуудын туршлага арга барил хэрэгтэй. Энэ талаар МУИС-ХЗС-ийн практик сургалтын тэнхимтэй Хууль зүй, дотоод хэргийн яам хамтран, эрх зүйн үйлчилгээнд их сургуулийн төгсөх ангийн оюутнуудыг хамруулах талаар хамтарсан гэрээ байгуулсан боловч одоогоор гэрээний биелэлт хангалтгүй байна. Учир нь оюутнуудыг албадах боломжгүй гэсэн хариулт хэлсэн /"МУИС-ХЗС-ийн практик сургалтын тэнхмийн ажилтан Б.Бурмаатай ярилцав"/ Манай улсын Хууль зүйн их, дээд сургуулиудын Клиникүүдийн нийгэмлэг 2011 онд байгуулагдсан бөгөөд энэ нийгэмлэг нь 2011 оны 9 дүгээр сараас үйл ажиллагаагаа эрчимжүүлэх зорилттой ажиллаж байна. Иймд энэ нийгэмлэгт эрх зүйн туслалцааны төвд ажиллах оюутнуудыг хамруулах талаар хамтран ажиллаж болох юм.

Одоо манай улсад хэрэгжиж байгаагаас харахад эрх зүйн туслалцааны төвд төгсөх курсын оюутнууд уртын дадлага хийдэг. Гэхдээ эрх зүйн туслалцааны төвд ажиллаж байгаа нэг өмгөөлөгч ажлын ачаалал их тул оюутаныг дадлагжуулахад төдийлөн туслах боломж хомс юм. Иймд

1.Төгсөөд 2 жил хуульчийн сонгон шалгаруулалт өгөх хүртэл ажиллах хүмүүсийг татан оролцуулвал боломжтой. Эдгээрийг мэргэшүүлж, дадлагажуулахын тулд албан бус сургалтанд тасралтгүй хамруулж байх. мөн эрх зүйн туслалцааны төвүүд нь түшиц газар болвол боломжтой гэж үзлээ.

[282] 2008 оны Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагуудын 2008 оны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай тайлан.

2. Их дээд сугуулийн төгсөх ангийн уртын дадлага хийж байгаа оюутнуудыг бэлдэж, төгсөхөд нь үргэлжлүүлэн ажиллуулах боломжтой юм.

Монголын хуулийн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх төвүүдэд тулгараад байгаа ачааллыг багасгахад саяхан сургууль төгссөн хуульчдийг хуулийн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх төв дээр дадлагжуулбал маш их үр дүнтэй ажил болно. Өмнөд Африк болон Австралид төгсөх курсын оюутнууд хуулийн туслалцаа үзүүлэх төвүүдэд сайн дураар ажиллаж төгсөлтийн дипломны нэг хэсэг болгодог бөгөөд бичиг хэрэгтэй ажиллах дадлага хийдэг байна. Энэхүү аргаар хуулийн байгууллагууд их хэмжээний зардлаа хэмнэхийн сацуу, ажлынхаа ачааллыг бууруулдаг. Энэхүү тогтолцоо нь амжилттай хэрэгжиж байгаа нь доорх зүйлтэй холбоотой ажээ. Үүнд:

- Мэргэшсэн хуулийн зөвлөхийн шууд удирдлаган дор төгсөх курсын оюутнууд ноцтой бус хэрэг дээр иргэнийг дүүргийн шүүхэд төлөөлүүлж болно. Гэхдээ Австралийн бүсийн болон дээд шүүх, хоригдох ял авах магадлалтай хэргүүдэд мэргэшсэн хуулийн зөвлөх заавал оролцдог.
- Нэг оюутныг сард тодорхой хэрэг дээр ажиллуулж болох зэрэг давуу талууд бий болдог. Монгол Улсад хуулийн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх төв дээр нэг мэргэшсэн өмгөөлөгчид дагалдуулан 10 оюутан ажиллуулна гэж тооцвол тухайн төв сард 200 хэрэгт хууль зүйн туслалцаа үзүүлж ажиллах боломжтой болж байна. Энэ тогтолцоо нь төгсөх ангийн оюутнуудад мэргэжлийн дадлага болж өгөх зэрэг ач холбогдолтой.

ЗУРГАА. 2008-2010 онд ял шийтгэгдсэн хүмүүсээс төлбөрийн чадваргүй байх магадлалтай хувь хэмжээ

2010 онд шүүхээс нийт 9876 хүнд баривчлах ял оноожээ. Тэдний дийлэнх нь эрхэлсэн тодорхой ажилгүй иргэд байжээ. Хуулийн өмнө хийсэн хэргийнхээ төлөө хариуцлага хүлээж ялтан, шүүгдэгч, сэжигтэн гэгдэж буй хүмүүсийн 70 хувь нь амьжиргааны түвшингээс доогуур орлоготой, нэн ядуу иргэд байна. Иймд төлбөрийн чадваргүй иргэдийн эрх ашгийг хамгаалахад шүүх болон өмгөөллийн байгууллагын хамтын ажиллагаа шаардлагатай байна[283].

Өмгөөллийн тухай хуулийн 12.3.8-д зааснаар өмгөөлөгч жилд хоёр удаа төлбөрийн чадваргүй иргэнийг хууль ёсны эрх, ашгийг хамгаалуулах зорилгоор өмгөөлөгчөөр ажилладаг юм. Дээрх хуулийн дагуу Монгол Улсын Хууль зүй дотоод хэргийн сайдын 2003 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 69 тоот тушаалаар "Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн хөлсний жишиг тогтоох, зардлыг төсвөөс санхүүжүүлэх, тайлан гаргах журам"-ыг батлан гаргасан ба уг журамд заахдаа Төлбөрийн чадваргүй өмгөөлүүлэгч гэдэг нь өөрийгөө болон гэр бүлээ тэжээх сарын орлого нь хүн амын амьжиргааны доод түвшингийн хэмжээнд хүрэхгүйн улмаас байнгын хязгаарлагдмал хэрэглээтэй амьдардаг иргэнийг ойлгоно гэжээ.[284]

[283] http://humanrights.mn/beta/images/my/center.html

[284] Өмгөөлөгч сэтгүүл 2007 оны 12 дугаар сар № 10/16 дахь дугаарт нийтлэгдсэн.

Тодорхой оршин байгаа хаягтай төлбөрийн чадваргүй иргэний өмгөөлөгчөөр үйлчлүүлсэн судалгаа 2010 он хүртэлх байдлаар

№	Он	Иргэдийн өргөдлийн тоо	Өмгөөлөгч томилуулсан холбогдогчдын тоо	Ажилласан өмгөөлөгчийн тоо
1.	2003	48	41	41
2.	2004	131	124	124
3.	2005	104	111	111
4.	2006	129	126	126
5.	2007 эхний 10 сар	101	98	98
6.	2008	261	212	212
7.	2009	356	296	296
8.	2010	432	421	421
9.	Нийт	1562	1429	1429

Дээрх хүснэгт нь МӨХ-ны нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөлд төлбөрийн чадваргүй гэмт хэргийн холбогдогчид өмгөөлөгч томилуулахаар шүүх, прокурор, цагдаагийн байгууллагаас ирсэн хүсэлтүүдийг үндэслэн өмгөөлөгч томилсон тухай баримт юм. Хэдийгээр аймаг, нийслэлийн салбар зөвлөлд хандаагүй ч өмгөөлөгчдөд шууд хүсэлт гарган хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хамгаалуулж буй төлбөрийн чадваргүй иргэд, тэднийг өмгөөлсөн өмгөөлөгчдийн тоо нь дээрх тооноос хэд дахин илүү байдаг.

Эрх зүйн туслалцааны төвөөр 2010 онд үйлчлүүлсэн нийт төлбөрийн чадваргүй иргэний 90 хувь нь эрүүгийн хэрэгт зөвлөгөө авсан гэсэн судалгаа байна[285]. Дээрх судалгаанаас харахад дэндүү хангалтгүй тоо харагдаж байна. Манай улсын нийт хүн амын 3,1 хувь нь ядуу байна. Энэ тоо маш өндөр үзүүлэлт. Гэтэл улсын хэмжээнд жилд эрүүгийн хэрэгт 50-70 хүн л үнэ төлбөргүй өмгөөллийн үйлчилгээ авч байгаа нь дэндүү хангалтгүй тоо байна. МӨХ-нд 2011 оны байдлаар нийт /1360-д өмгөөлөгч/ албан ёсны өмгөөлөх эрхтэй өмгөөлөгч бүртгэлтэй байна. Тэдгээр өмгөөлөгчид жилд дунджаар төлбөрийн чадваргүй 3000 хүнд өмгөөлөл хууль зүйн туслалцаа үзүүлэхээр байна.

Төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөлөл болон хууль зүйн туслалцаа үзүүлэх явдал өсөн нэмэгдэж байгаатай холбогдуулан Монгол Улсын Өмгөөллийн тухай хуулийн 12.3.8 дахь заалтын хэрэгжилтэнд хяналт тавих, төлбөрийн чадваргүй гэх байдлыг тогтоохдоо тухайн иргэн хөдөлмөр эрхлэгчгүй байсан буюу амьжиргааны түвшингээс доогуур орлоготой болохыг харуулсан баримтуудыг үнэн зөв эсэхийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, Засаг дарга шалгаж тогтоодог байх нь зүйтэй юм.

[285] http://news.niigem.mn/content/17341.shtml, /сүүлд 2011 оны 8 дугаар сарын 10-нд үзсэн/.

Дүгнэлт

Сүүлийн үед төлбөрийн чадваргүй иргэнд эрх зүйн туслалцаа үзүүлэх тал дээр түлхүү анхаарлаа хандуулан ярих болсон. Эрх зүйн туслалцааны төв байгуулагдан үйл ажиллагаа явуулснаар төлбөрийн чадваргүй иргэд үнэ төлбөргүй эрх зүйн туслалцаа авах ач холбогдлыг нь ойлгож, үнэлдэг болжээ. Эрх зүйн туслалцаа гэдгийг төлбөрийн чадваргүй иргэнд нэг удаа үзүүлдэг үйлчилгээ төдий ч биш төрийн халамжийн бодлогын хүрээнд үзүүлж буй нэг ёсны "эрх зүйн халамж үйлчилгээ" гэж ойлгоно. Үйлчилгээний чанар, хүртээмжийг бодитой дээшлүүлэх, байнга боловсронгуй болгож байх тогтолцоог бүрдүүлэх нь чухал ач холбогдолтой юм.

Манай улс нь өргөн уудам газар, нутагтай хүн ам тархан байрладаг бөгөөд алслагдсан аймаг, суманд байгаа иргэд эрх зүйн туслалцааг тэр бүр тэгш хүртэх боломжоор хомс байна. Хөдөө орон нутагт ахуйн түвшинд зэзл, газрын тухай маргаан зэрэг зөрчил зонхилдог байна. Гэтэл энэ талаар эрх зүйн зөвлөгөө тусламж үйлчилгээг аймгийн төвд ирж авах шаардлагатай болдог.

Иймд:

- Иргэдийг албан бус сургалтын хүрээнд энгийн түвшинд эрх зүйн мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд анхаарч Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтарч сургалт сурталчилгаагаар тогтмол хангах боломжтой.
- Эрх зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааг илүү тархацтай, хүртээмжэй болгох, эрх зүйн туслалцааны төв дээр дан ганц зөрүүгийн хэрэгт өмгөөлөх үйлчилгээг үзүүлэх биш иргэн, захиргааны эрх зүйн чиглэлээр тэнцвэртэй хандах /Судалгаанаас харахад эрх зүйн туслалцааны төвөөр үйлчлүүлсэн иргэний 90 хувь нь өмгөөлөх эрхээр хангуулсан байгаа ч тэдгээрийн дийлэнх нь эрүүгийн хэрэгт холбогдсон байна/.
- Эрх зүйн туслалцаа үйлчилгээний хүртээмжтэй байдлыг хангахын тулд хууль зүйн их дээд сургууль төгсөгчдийг мэргэшүүлж энэ ажилд татан оролцуулах буюу сургуулиа төгссөн орон нутгийн оюутан 2 жилийн хугацаанд өөрийн нутгийнхаа эрх зүйн туслалцааны төвд ажиллуулах тэдэнд ажлын байр, ажиллах нөхцөл зэрэг зүйлүүдийг тусгаж тэдэнтэй гэрээ байгуулж ажиллуулах, нөгөө талаар 2 жилийн дараа хуульчийн сонгон шалгаруулалтанд ороход нь нийгмийн даатгалын шимтгэл зэрэг тэдэнд тулгардаг бэрхшээлтэй асуудлыг зохицуулж өгвөл боловсон хүчин, хүний нөөц, иргэдэд хүртээмжгүй зэрэг асуудал тодорхой хэмжээнд шийдэгдэх боломж бүрдэх юм.
- Өмгөөллийн тухай хуулийн 12.3.8-д заасан Төлбөрийн чадваргүй иргэнийг жилд 2 удаа үнэ төлбөргүй өмгөөлнө гэсэн заалтын хэрэгжилтэнд хяналт тавьж, МӨХ-той хамтран ажиллах.
- Мөн Төлбөрийн чадваргүй гэсэн Засаг даргын тодорхойлолтыг үнэн зөв тогтоох, танил талаараа дамжуулан төлбөрийн чадваргүй, эсхүл нэн ядуу гэх тодорхойлолтыг авдаг явдлыг зогсоох бодит байдалд төлбөрийн чадваргүй гэдэг нь эргэлзээтэй хүмүүс байдаг. Өөрөөр хэлбэл уг тодорхойлолтыг гаргаж өгч буй Засаг даргын хариуцлагын асуудлыг тодорхой болгох, дан ганц тодорхойлолтоор төлбөрийн чадваргүйг нотлох биш төлбөрийн чадваргүй иргэнийг үнэн зөв тодорхойлох тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай юм.

- Төлбөрийн чадваргүй иргэдийн эрх ашгийг хамгаалж, зөвлөгөө өгөх төв байдаг гэдгийг мэдэх хүн хомс байна. Иймд сурталчилгааны ажлыг зохион байгуулах нь зүйтэй юм.
- Аймаг, нийслэлийн хүн амын тоо, ачааллыг харгалзан эрх зүйн туслалцааны төвийн ажилтнуудын орон тоог нэмэгдүүлэх
- Эрх зүйн туслалцааны төвийн байршлын асуудлыг анхаарч шийдвэрлэх нь зөв юм. Эрх зүйн туслалцааны төвийн орон тоог нэмэгдүүлсэн ч үйл ажиллагааны хүрээ дан ганц Засаг даргын тамгын газрын байранд явагдвал эрх зүйн туслалцааны төвийн ажилтны хүчээр жигдэрч олон нийтийг хамарсан ажил болох боломжгүй.

__oOo__

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ШҮҮХИЙН БОЛОН ШҮҮХИЙН ӨМНӨХ ШАТАНД ЭВЛЭРЭЛ, ЗУУЧЛАЛЫН ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА[286]

ОРШИЛ

Эвлэрүүлэн зуучлал гэдэг нь хуулийн хатуу хүрээнд хязгаарлагдалгүйгээр тухайн бодит нөхцөл байдалд нь тохирсон шийдэлд хүрэхийн тулд харилцан ярилцаж, түүний үр дүнд талууд санал нэгдсэнээр маргааныг шийдвэрлэх тогтолцоо бөгөөд шүүгч, арбитр зэрэг гуравдагч этгээдийн гаргасан шийдвэрийг дагах биш талууд өөрсдөө харилцан тохиролцож эцсийн шийдвэрийг гаргадаг нь хамгийн гол онцлог юм.[287] Нөгөөтэйгүүр эвлэрүүлэн зуучлагч оролцох тул маргалдагч талууд тайван ярилцаж, хууль зөрчсөн болон шударга бус шийдвэр гаргахаас сэргийлэх боломжтой.

Өөрөөр хэлбэл хуулиар хориглоогүй бүхий л арга хэрэгслээр, талуудын хүсэл сонирхолд тулгуурлан бодит шийдлийг гаргахын тулд харилцан ярилцаж, талуудын зөвшилцлөөр үр дүнд хүрдэг хэрэг маргааныг шийдэх тогтолцоо юм. Зарим тохиолдолд иргэн, аж ахуй нэгжийн хувьд асуудлыг заавал шүүхэд аваачихгүй байх хүсэл, эрмэлзэл байдгаас гадна хувь хүн болон тухайн байгууллагын хувийн нууц мөн зардал мөнгөний хувьд ч бэрхшээлтэй олон асуудлуудтай тулгардаг. Үүнийг зохицуулахад зуучлал чухал үүрэг гүйцэтгэдэг олон улсын жишиг байна.[288]

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн[289] 74 дүгээр зүйлд зааснаар нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагаасаа татгалзсан, хариуцагч шаардлагыг зөвшөөрсөн, зохигчид эвлэрсэн, хариуцагч шаардлагыг сайн дураар биелүүлсэн тохиолдолд шүүх хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэдэг гэж заасан байдаг. Хялбаршуулсан журмаар шийдвэрлэхэд ердийн журмаар хэрэг шийдвэрлэхээс хугацаа, ажиллагаа бага зарцуулдаг ч хэрэг үүсгэх шүүхээс эрхийн акт гаргах зэрэг тодорхой ажиллагаа явуулдаг. Монгол Улсын Дээд шүүхийн судалгааны төвөөс шүүж үзэхэд манай улсад анхан шатны шүүхүүдээр нийт шийдвэрлэсэн иргэний хэргээс 40 хувийг нь шүүх хялбаршуулсан журмаар шийдвэрлэжээ. Үүнээс харахад эвлэрүүлэн зуучлах тогтолцоог нэвтрүүлбэл шүүхийн ачаалал багасах, аливаа төрлийн маргаан эвийн журмаар шийдэгдэх мөн цаг хугацааны хувьд хэмнэлттэй зэрэг чухал ач холбогдолтой юм.

---

[286] Энэ судалгаат Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2011 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 22 дугаар тушаалын дагуу ХЗДХЯ-аас боловсруулж буй төслийн хүрээнд ЗХЭЗС 2011 оны 9 дүгээр сард хийж гүйцэтгэсэн болно.

[287] Монголын өмгөөлөгчдын холбоо, LGL, JICA хамтарсан /2008/ Эвлэрүүлэн зуучлалын гарын авлага УБ. Odsar Ink Ktd.

[288] МӨХ-ны дэргэдэх "LGL" төвийн тэргүүн М.Алтан-өлзийтэй уулзаж хийсэн тэмдэглэл 2010.4.16-нд.

[289] Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль."Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2009 оны 7 дугаар сар № 25-28 дахь дугаарт нийтлэгдсэн.

НЭГ. ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ АЖИЛЛАГААНЫ ТӨРӨЛ, ЗАГВАР АЖИЛЛАГАА

Маргааныг эвлэрүүлэн зуучлах /цаашид ЭЗА гэх/ гэдэг нь манай улсын хувьд тодийлөн хөгжөөгүй шинэ харилцаа юм. Шинэ ойлголт хэдий ч Ази, Европын бусад орнуудын хууль зүйн практикт нэгэнт хэвшиж, өргөн хүрээнд явагддаг. Энэ нь эрх зүйн эерэг соёл, ухамсарыг төлөвшүүлэх, шүүхийн бус арга замаар иргэний хэрэг, маргааныг эвлэрүүлэн шийдвэрлэнэ гэсэн ойлголт юм.[290]

Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хэрхэн явуулах талаар иргэд болон салбарын хуульчид мэдээлэл багатай байна. Иймд маргааныг эвлэрүүлэн зуучлах ажлыг оновчтой байдлаар ашиглах нь чухал юм.[291]

Нэр томьёо

Эвлэрэл ба зуучлал: Энэ ухагдахуун нь цоо шинэ ойлголт биш юм. Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн[292] 74-р зүйлийн 74.6-д "зохигч **эвлэрсэн** тохиолдолд талууд нэхэмжлэлийн нийт шаардлага буюу тодорхой хэсгийн талаар тохиролцож шүүхийн өмнө эвлэрлийн гэрээ байгуулж болно. Гэрээний агуулгыг зохигч талууд бичгээр гарган түүнийг хоёр тал хүлээн зөвшөөрч, гарын үсэг зурснаар **эвлэрлийн гэрээ** хүчин төгөлдөр болно гэсэн заалт байдаг. Нэхэмжлэгч, хариуцагч хоёр ИХШХША-ны аль ч үе шатанд эвлэрэн зохицох эрхтэй ба талууд эвлэрлийн гэрээ байгуулж болно" гэж тайлбарласан. Мөн Монгол Улсын иргэний хуулийн[293] 39 дүгээр бүлэг, "**Зуучлал**" гэсэн заалт байдаг. Энэ заалтаар нь зуучлалын ухагдахууныг тайлбарлахдаа "Зуучлагч, зуучлуулагч, гуравдагч этгээд хоорондын харилцааг зохицуулдаг, иргэний эрх зүй дэх бусдад туслалцаа үзүүлэхтэй холбогдож үүссэн үүргийн нэгэн төрөл болно" гэж тайлбарласан байна.[294] Дээрх хуулиудад тусгагдсан заалтууд нь иргэний эрх зүйн харилцаанд талуудын эвлэрэн зохицох эрхийг нь хуульчилж өгсөн байна.

Эвлэрүүлэн зуучлал ба шүүхийн ялгаа

1.Асуудлыг шийдвэрлэх арга

Шүүгч нь хуульд захирагдан зөвхөн нотлох баримтанд үндэслэн шийдвэр гаргана. Шүүхийн шийдвэрийн агуулга нь талуудын хүсэл зоригоос үл хамаарах тохиолдол ч байдаг. Харин эвлэрүүлэн зуучлалд бол зуучлагч нь шийдвэр гаргах бус талууд харилцан ярилцаж, бие биедээ тодорхой хэмжээгээр буулт хийн нэгдсэн шийдэлд хүрч маргаантай асуудлаа өөрсдөө шийдвэрлэх боломжтой бөгөөд хуулийн дагуу хатуу чанга бус уян хатан шийдвэр гаргаж чаддаг байна[295].

---

[290] Эвлэрүүлэн зуучлах тогтолцоог сайжруулах төслийн 7 дугаар хуралдаанаас хийсэн тэмдэглэл. 2010 оны 6 дугаар сарын 15-нд.

[291] Хууль зүйн, дотоод хэргийн яамны захиалгаар 2010 онд Азийн хөгжлийн сангийн гүйцэтгэсэн. Иргэний эвлэрүүлэн зуучлалын судалгаа.

[292] Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2009 оны 7 дугаар сар № 25-28 дахь дугаарт нийтлэгдсэн

[293] Монгол Улсын иргэний хууль."Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2009 оны 7 дугаар сар №25-28 дахь дугаарт нийтлэгдсэн.

[294] Монголын өмгөөлөгчдын холбоо, LGL, JICA хамтарсан /2008/ Эвлэрүүлэн зуучлалын гарын авлага 9 дахь тал, УБ Odsar Ink Ktd.

[295] http://www.jica.go.jp/project/mongolian/mongolia/003/outline/index.html

Эвлэрүүлэн зуучлалаар маргаан шийдвэрлэхэд талуудын хүсэл зориг маш чухал юм. Талуудын байр суурь зөрчилдөж, харилцан буулт хийх бодолгүй байгаа тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлэхээс өөр аргагүй байдаг. Нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрөхгүй байгаа хариуцагчаас мөнгө гаргуулах, эсхүл нэхэмжлэлийн шаардлага нь үндэслэлгүй бол хүлээн авахаас татгалзах боломжтой байдаг бөгөөд тухайн шүүхийн шийдвэр нь төрийн эрх мэдлээр албадан биелүүлэх боломжтой. Шүүхийн хувьд гурван шатны тогтолцоотой тул шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол дээд шатны шүүхэд хандаж болох боловч тэр хэмжээгээр хугацаа алдана. Эвлэрүүлэн зуучлалд мөн адил шүүхийн шийдвэр үйлчилнэ.

Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа	***Шүүхийн ажиллагаа***
Талууд харилцан тохиролцоны үндсэн дээр дүрмээ тогтоох боломжтой. Ашиг сонирхолын холбогдолтой этгээдүүдийн оролцоо нээлттэй байна. • Шийдвэрлэх асуудал, явц дундаа ямарч асуудлаар зохицуулах боломжтой • Тохиролцоонд хүрснээр ажиллагаа дуусна	• Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу, шаардлагаа тайлбарлах, нэхэмжлэл, мэдүүлэг, нотлох баримт гаргах; • бичмэл нотлох баримт, харилцан асуулт тавих; • Шүүхээс тогтоосон өдөр, зохигчдын төлөөлөгчийн зав чөлөө. Зөвхөн шүүх дээр явагдана; • Оролцогч нь зохигч, эс бол түүний төлөөлөгч • Нэхэмжлэлд бичигдсэн шаардлагын талаар л зөвхөн хэлэлцэнэ; • Нэхэмжлэлийн шаардлагыг өөрчлөх • Давж заалдах гэх мэт;

<u>Эвлэрүүлэн зуучлал ба Арбитрын ялгаа</u>

Нэхэмжлэл гаргах үйл явц

Арбитрт хандахын тулд талуудын тохиролцоо зайлшгүй шаардлагатай ба арбитрын харьяалал тогтоосон тохиолдолд талууд шүүхэд хандах эрхгүй болдог. Эвлэрүүлэн зуучлалд талуудын тохиролцоо байхгүй боловч хэн алины хүсэлтээр зуучлал явагдах боломжтой. Шүүхэд нэхэмжлэл гаргах эрх нь нээлттэй байх ба шүүхийн үе шатнаас эвлэрүүлэн зуучлалд хандах бүрэн боломжтой байдаг[296]

Арбитр

Эхлэхийн өмнө	
• 1.Маргалдагч талууд арбитраар шийдвэрлүүлэхээр тохиролцох, • 2.Маргалдагч талууд арбитрчаа сонгох ➢ *Энэ нь эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаатай төстэй.*	• Арбитрч шийдвэр гаргана ➢*Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай төстэй.*

<u>Хэрэг маргааныг шийдвэрлэх аргууд</u>

Арбитр нь шүүхтэй адил хамгийн сүүлд талуудын байр суурь санал нийлэхгүй байсан ч шийдвэрээ гаргана. Харин эвлэрүүлэн зуучлалд талууд

[296] Монголын өмгөөлөгчдын холбоо, LGL, JICA хамтарсан /2008/ Эвлэрүүлэн зуучлалыг гарын авлага 10 дахь тал, УБ Odsar Ink Ktd.

тохиролцоонд хүрэгүй бол маргаан шийдвэрлэгдэхгүй учир талууд ямар ч үед нэхэмжлэлээ эргүүлэн татах боломжтой.

Үр дүнгийн биелэлт

Арбитрын шийдвэр нь хуульд заасны дагуу шүүхийн шийдвэртэй адил хүчин чадалтай байна. Тиймээс талууд арбитрын шийдвэрийг биелүүлэхгүй байх тохиолдолд шүүхийн нэгэн адил албадлага хэрэглэнэ. Одоогоор эвлэрүүлэн зуучлалын тусдаа хууль байхгүй учир талуудын тохиролцсон шийдвэр нь ердийн гэрээтэй адил хүчин чадалтай байна.[297]

Эвлэрүүлэн зуучлалын давуу тал

• Түргэн шуурхай

Аливаа иргэний хэрэг маргааныг шүүхээр шийдвэрлэхэд хуульд заасан хугацаа заавал баримтлах шаардлагатай байдаг.

• Хямд төлбөртэй

Шүүхээр хэрэг маргаан шийдвэрлүүлэхэд улсын тэмдэгтийн хураамж, шүүхийн зардал, өмгөөллийн хөлс, гэх мэт зардал ихтэй.

• Хаалттай явагдана

Шүүх хуулиар тогтоосноос бусад тохиолдолд /шүүх хуралдаан/-ыг ил тод нээлттэй явуулах ёстой бол эвлэрүүлэн зуучлал нь хаалттай явагдах боломжтой тул нууц хадгалагдана.

• Уян хатан зохицуулалттай

Эвлэрүүлэн зуучлалд хандахад заавал хуульд заасан нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг хангах шаардлагагүй, талуудын ярилцсан үр дүнд хүрэхийн тулд уян хатан зохицуулалттай байдаг.

• Мэргэшсэн зуучлагчид

Шүүхэд эрх зүйн аль нэг чиглэлээр мэргэшсэн шүүгч гэж байдаггүй. Харин эвлэрүүлэн зуучлалд тодорхой нэг чиглэлээр мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагчийг сонгож болно.

• Эв найрамдалтай шийдэл

Шүүхийн хувьд ялахгүй л бол болохгүй учраас эсрэг талтайгаа зөрчилдөж байж шийдвэр гаргуулдаг. Эвлэрүүлэн зуучлалд харилцан ойлголцож буулт хийж маргаан дуусанаар талууд эвийн журмаар сална.

• Бодит шийдэлтэй

Бусдын эзэмшлийн газарт гуравдагч этгээд байшин барьсан бол шүүх барьсан барилгыг нураахаас өөр шийдвэр гаргахгүй. Гэтэл эвлэрэлд байшин барьсан хэсгийн газрыг түрээслэх мөнгийг сар бүр тогтоосон хугацаанд төлүүлэх, эсхүл худалдах худалдан авах гэрээ байгуулах зэрэг шийдвэр гаргаж болно.

• Талууд харилцан сэтгэл ханамжтай үлдэнэ

Хоёр талын санаа бодлыг сайтар сонссоны үндсэн дээр хоёр тал хоёулаа сэтгэл ханамжтай үлдэхүйц шийдвэр гарна.

• Албадлага хэрэглэхгүй шийдэлд хүрнэ

Шүүхийн шийдвэрээр бол хариуцагч бүгдийг нь нэг удаагаар төлөх боломжгүй байсан ч албадан гүйцэтгэдэг учир аль аль талдаа хүндээр тусгах нөхцөл үүсдэг. Харин зуучлалд бол талууд тохиролцоонд хүрч тодорхой хугацаанд төлөхөөр тохиролцож болно

[297]Монголын өмгөөлөгчдын холбоо, LGL, JICA хамтарсан /2008/ Эвлэрүүлэн зуучлалын гарын авлага 10 дахь тал, УБ Odsar Ink Ktd.

• Зохигч талуудын идэвхтэй оролцоо

Шүүхээр хэрэг маргаан шийдвэрлэхэд нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд ярьсан л бол талуудын оролцоо дуусч, дараа нь маргалдагч талууд шүүх шийдвэрлэхийг л хүлээдэг. Харин эвлэрүүлэн зуучлалд талууд өөрийн байр сууринаас гадна эсрэг талын байр суурь, утга агуулга, шалтгаан нөхцөлийг нь тунгааж, шийдэлд хүрэх алхамуудыг идэвхтэй эрэлхийлж. шаардлагатай үед эсрэг талтайгаа хамтрахгүй бол тодорхой шийдэлд хүрч чадахгүй юм.

• Авилга авах боломжгүй

Эвлэрүүлэн зуучлалд зуучлагч нь шийдвэр гаргах бус, талууд харилцан ярилцаж бие биедээ тодорхой хэмжээгээр буулт хийн санал нэгдэн эцсийн шийдэлд хүрдэг. Тиймээс зуучлагчид авилга өгөх авах тухай асуудал яригдсан ч эсрэг талтайгаа ойлголцохгүй бол өөрт ашигтай шийдвэр гаргаж чадахгүй.

Зуучлал явагдах хэрэг маргаануд: Шүүхээр шийдвэрлүүлэх иргэний хэргийн бүх маргаанд эвлэрүүлэн зуучлал явуулах боломжтой бөгөөд шүүхэд байгаа маргааныг ч гэсэн шүүхийн шийдвэр гарахын өмнө. эвлэрүүлэн зуучлал явуулах боломжтой.[298]

Монгол Улсын дээд шүүхийн судалгааны төвөөс шүүж үзэхэд манай улсад хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа сүүлийн 3 жилд дараах хувьтай явагдаж байна.

➢ 2008 онд Улсын хэмжээнд нийт иргэний 38120 маргаан хүлээж авснаас, шийдсэн хэрэг 28480, үүнээс 1721-ийг хялбаршуулсан журмаар шийдсэн бөгөөд энэ нь нийт шийдсэн хэргийн 6 хувьтай тэнцэж байна.

➢ 2009 онд Улсын хэмжээнд нийт 48204 иргэний маргаан хүлээж авснаас, шийдсэн хэрэг 35822, үүнээс 3603-ыг хялбаршуулсан журмаар шийдсэн бөгөөд энэ нь нийт шийдсэн хэргийн 10 хувьтай тэнцэж байна.

➢ 2010 онд Улсын хэмжээнд нийт иргэний маргаан 48170 хүлээж авснаас, шийдсэн хэрэг 35787, үүнээс 4892-ыг хялбаршуулсан журмаар шийдсэн бөгөөд энэ нь нийт хэргийн 30 хувьтай тэнцэж байна.



Дээрх үзүүлэлтээс харахад хэрвээ талууд маргаантай асуудлаар шүүхэд хандахаас өмнө эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулдаг мэргэжлийн байгууллагад ханддаг бол шүүхийн ажлын ачаалал ойролцоогоор 30 хувь

[298] Монгол Улсын дээд шүүх, Монголын Өмгөөлөгчдын холбоо, JICA хамтарсан Нийслэлийн Баянзүрх дүүрэг, Дархан-Уул аймгийн Сум дундын шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагааны талаарх танилцуулга.

багасах боломжтой гэж үзэхээр байна. Нөгөөтэйгүүр хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдсан хэрэг сүүлийн 3 жилийн байдлаар өсөх хандлага харагдаж байна. Иргэд аливаа маргаантай асуудлаа аль болох цаг алдахгүй түргэн шуурхай шийдвэрлэх талаас нь бодолцож эвлэрүүлэн зуучлалын аргыг сонгох нь зүйтэй. Иймээс эвлэрүүлэн зуучлах ажлыг нэвтрүүлж иргэдэд давуу талыг нь сайтар ойлгуулж сурталчилах ажлыг анхаарах шаардлагатай байна.

Шүүх дэх эвлэрүүлэн зуучлах тогтолцоог бүрдүүлэхэд үндэслэл болохуйц Монгол Улсын хуулийн заалтууд

Гадаад орнуудын жишигт Эвлэрүүлэн зуучлалын талаар тусгайлан зохицуулсан хууль байдаг бөгөөд Манай улсын хувьд "**Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх" тухай хуульд:**[299]

74.1.Хэрэг үүсгэснээс хойш шүүх хуралдаан хүртэлх хугацаанд нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн, эсхүл зохигчид эвлэрсэн, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг биелүүлсэн бол хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэнэ.

74.2.Хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх боломжтой гэж үзвэл шүүгч нэхэмжлэгчийн татгалзал, хариуцагчийн зөвшөөрөл, зохигч талуудын эвлэрэл, нэхэмжлэлийн шаардлагыг хариуцагч биелүүлсэнийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосон тухай захирамж гаргана.

74.3.Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн, эсхүл зохигч эвлэрсэн, нэхэмжлэлийн шаардлагыг хариуцагч биелүүлсэн тухай зохигч талууд бичгээр тохиролцож, гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

74.4.Хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн тохиолдолд зохигч давж заалдах, хяналтын журмаар хянан шийдвэрлүүлэхээр гомдол гаргах, тухайн асуудлаар анхан шатны шүүхэд дахин нэхэмжлэл гаргах эрхгүй.

74.5.Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн тохиолдолд улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг тал хувиар бууруулж тогтоох ба түүнийг энэ хуульд заасан журмын дагуу гаргуулна.

74.6.Зохигчид эвлэрсэн тохиолдолд зохигч талууд нэхэмжлэлийн нийт шаардлага буюу тодорхой хэсгийн талаар тохиролцож шүүхийн өмнө эвлэрлийн гэрээ байгуулж болно. Гэрээний агуулгыг зохигч талууд бичгээр гарган түүнийг хоёр тал хүлээн зөвшөөрч, гарын үсэг зурснаар эвлэрлийн гэрээ хүчин төгөлдөр болно. Эвлэрлийн гэрээ нь Иргэний хуульд нийцсэн, гуравдагч этгээдийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хөндөөгүй байна.

75 дугаар зүйл. Хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамж

75.1.Хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамж удиртгал, тодорхойлох, үндэслэх, захирамжлах хэсгээс бүрдэнэ.

[299] Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2009 оны 7 дугаар сар. № 25-28 дахь дугаарт нийтлэгдсэн.

75.2.Удиртгал хэсэгт захирамжийг хэзээ, хаана ямар шүүх гаргаж байгаа, шүүгч, хэргийн оролцогчийг заана.

75.3.Тодорхойлох хэсэгт нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан хариуцагч нэхэмжлэгчийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн, эсхүл зохигч талуудын эвлэрсэн, нэхэмжлэлийн шаардлагыг хариуцагч биелүүлсэн тухай хэргийн оролцогчдын тайлбарын агуулгыг заана.

75.4.Үндэслэх хэсэгт хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхэд үндэс болгосон нотлох баримт, зохигч эвлэрсэн, нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрч биелүүлсэн тухай бичгээр баталгаажуулсан баримт, эвлэрлийн гэрээ зэргийг тусгана.

75.5.Захирамжлах хэсэгт хялбаршуулсан журмаар хэргийг хянан шийдвэрлэхэд баримталсан хуулийн нэр, зүйл, заалтыг тодорхой зааж, нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн, эсхүл зохигч талууд эвлэрсэн, нэхэмжлэлийн шаардлагыг хариуцагч биелүүлснийг баталсан аль нь болох, улсын тэмдэгтийн хураамж, шүүхийн зардал төлүүлэх асуудлыг хэрхэн шийдвэрлэснийг заана.

75.6.Энэхүү захирамжийг хариуцагч сайн дураар биелүүлээгүй бол шүүхийн шийдвэрийн нэгэн адил албадан гүйцэтгэнэ.

64 дүгээр зүйл. Нэхэмжлэлийг хүлээн авах

64.1.Нэхэмжлэлийг тухайн шүүхийн шүүгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга хүлээн авч ийнхүү хүлээн авсан нэхэмжлэл, хавсаргасан материалын хуудасны тоо, огноо, цаг, минутыг нэхэмжлэлд тэмдэглэн баталгаажуулна. Тэмдэглэн бичсэн дараалаар нэхэмжлэл бүртгэх дэвтэрт бичнэ.

26 дугаар зүйл. Зохигч

26.1.Хэргийн зохигч гэдэгт нэхэмжлэгч, хариуцагч, хуульд заасны дагуу тэдгээртэй эрх зүйн хувьд ижил эрх, үүрэгтэйгээр хэрэгт оролцож байгаа этгээд хамаарна.

26.2.Нэхэмжлэгч гэж хуульд заасан эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэж эрхээ сэргээлгэхээр өөрийн болон бусдын нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргасан этгээдийг хэлнэ. Нэхэмжлэгч нь нэхэмжлэл гаргасан үндэслэл болон нэхэмжлэлийг өөрчлөх, нэхэмжлэлийн шаардлагын хэмжээг ихэсгэх, багасгах, нэхэмжлэлээс татгалзах, эвлэрэх эрхтэй.

26.3.Хариуцагч гэж нэхэмжлэгчийн эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд хохирол учруулсан буюу үүргээ биелүүлээгүй, эсхүл зохих ёсоор биелүүлээгүй гэж нэхэмжлэлд дурьдагдсан этгээдийг хэлнэ. Хариуцагч нь нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх буюу хүлээн зөвшөөрөхөөс татгалзах, сөрөг нэхэмжлэл гаргах, эвлэрэх эрхтэй.

26.4.Зохигч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тэгш эрх эдэлнэ.

129 дүгээр зүйл. Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх урьдчилсан арга хэмжээ

129.1.Шүүгч шаардлагатай гэж үзвэл гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэхдээ дараахь арга хэмжээг урьдчилан авахаар захирамж гаргаж болно:

129.1.1.насанд хүрээгүй хүүхэд болон хөдөлмөрийн чадваргүй эцэг,эхийг тэжээн тэтгүүлэх;

129.1.2.насанд хүрээгүй хүүхдийг эцэг, эхийн хэн нэг дээр байлгах;

129.1.3.гэрлэгчдийг тусдаа амьдрахыг даалгах;

129.1.4.гэрлэгч хэн нэгийг тэжээн тэтгүүлэх;

129.1.5.орон сууц болон хамтран өмчлөх дундын өмч, үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөх эрхийг бусдад шилжүүлэх, худалдах, бэлэглэх, захиран зарцуулахыг хориглох;

129.1.6.шүүхийн зардлын зохих хувийг урьдчилгаа болгон төлүүлэх;

129.1.7.зохигчийг эвлэрэх талаар хугацаа заах.

130 дугаар зүйл. Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх урьдчилсан арга хэмжээг өөрчлөх, хүчингүй болгох, дуусгавар болгох.

130.1.Шүүгч энэ хуулийн 129 дүгээр зүйлд заасан гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх урьдчилсан арга хэмжээг зохигчийн хүсэлтээр өөрчлөх, эсхүл хүчингүй болгож болно.

130.2.Гэр бүлийн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх урьдчилсан арга хэмжээ дараахь нөхцөлд дуусгавар болсонд тооцно:

130.2.1.гэрлэгчид эвлэрч шүүгч эвлэрлийг баталсан захирамж гаргаж хэргийг хэрэгсэхгүй болгосон;

130.2.2.гэрлэлт цуцлах, тэжээн тэтгэхтэй холбогдсон хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр гарсан.

Гэр бүлийн тухай хууль:[300]

14 дүгээр зүйл. Гэрлэлтийг шүүхийн журмаар цуцлах

14.1. Энэ хуулийн 13-т зааснаас бусад тохиолдолд гэрлэгчдийн харилцан тохиролцсон буюу тэдний хэн нэгний, эсхүл иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй гэж тооцогдсон эхнэр, нөхрийн асран хамгаалагчийн нэхэмжлэлийн дагуу гэрлэлт цуцлах асуудлыг шүүх шийдвэрлэнэ.

14.2. Шүүх шаардлагатай гэж үзвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг гурван сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж, энэ хугацаанд гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээ авна.

14.3. Гэрлэгчид эвлэрэх боломжгүй бол шүүхийн шийдвэрт заасан хугацаа дуусмагц шүүх гэрлэлтийг цуцална.

13 дугаар зүйл. Гэрлэлтийг захиргааны журмаар цуцлах

13.1. Гэрлэлтээ цуцлуулахыг харилцан зөвшөөрсөн, 18 хүртэлх насны хүүхэдгүй, эд хөрөнгийн маргаангүй гэрлэгчид энэ тухай тус тусдаа бичиж, гарын үсэг зурсан хүсэлтээ иргэний гэр бүлийн бүртгэлийн байгууллагад гаргана.

13.2.Иргэний гэр бүлийн бүртгэлийн байгууллага нь энэ хуулийн 13.1-д заасан хүсэлтийг хянан үзэж 30 хоногийн дотор гэрлэлтийг цуцалж болно.

116 Хөдөлмөрийн хамтын маргаан эвлэрүүлж зохицуулах хэлбэр

116.1. Хөдөлмөрийн хамтын маргааныг дор дурдсан арга хэмжээгээр эвлэрүүлж зохицуулна:

116.1.1. зуучлагч урьж оролцуулах;

116.1.2. хөдөлмөрийн арбитраар хэлэлцэх.

[300] Монгол улсын гэр бүлийн тухай хууль. "Төрийн мэдээлэл" эмхэтгэл 2011 оны 3 дугаар сар №9-12 дахь дугаарт нийтлэгдсэн.

116.2. Талууд энэ хуулийн 116.1-д заасан эвлэрүүлэх арга хэмжээнд оролцохоос татгалзах эрхгүй.

116.3. Эвлэрүүлэх арга хэмжээний үед ажилтны төлөөлөгчид тавьсан шаардлагаа дэмжих зорилгоор хууль тогтоомжийн дагуу жагсаал, цуглаан хийх эрхтэй.

116.4.Талуудын төлөөлөгчид, зуучлагч, хөдөлмөрийн арбитрч нь хөдөлмөрийн хамтын маргааныг зохицуулахын тулд хууль тогтоомжоор олгосон бүх боломжийг ашиглах үүрэгтэй.

Эдгээр хуулийн заалт манай улсад эвлэрүүлэн зуучлах тогтолцоо нэвтрэхэд үндэслэл болохуйц заалтууд болохын зэрэгцээ Өмгөөллийн тухай хууль, Хуульчийн ёс зүйн дүрмүүд хэрэглэгдэх боломжтой юм.

Япон улсын хувьд иргэний хэрэг эвлэрүүлэн зуучлах ерөнхий үндэслэл гэсэн тусгайлсан хуулиар зохицуулахийн хамт эвлэрлийн талаар нарийвчлан Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. шуурхай эвлэрлийн журам зэргүүдэд нарийвчлан зохицуулсан байх бөгөөд эдгээр хууль журамд эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд шүүгчийн оролцоо, талуудын оролцоо, ёс зүй, зуучлагчийн цалин хөлсний талаар нарийвчлан тусгаж өгдөг байна.

2011 оны 4 дүгээр сарын 14,15-нд болсон "Шүүх эрх мэдлийн шинэчлэл ба шударга ёс" үндэсний чуулганы "Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа" сэдэвт салбар хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцэж, доорх санал, зөвлөмж гаргасан. Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзсэн иргэн уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд мэдүүлэх эрхийг Монгол Улсын үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14-т заасан эрхийг баталгаатай, тэгш, шударгаар эдлүүлэхийн тулд иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг иргэн, хуулийн этгээд бүрт хүртээмжтэй, алагчлалгүй хэрэгжүүлэх шаардлагыг иргэний хэрэг шүүн таслах ажиллагааны гол зорилтуудын нэг гэж үзэж, "ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН ШИНЭЧЛЭЛ, ШУДРАГА ЁС" Үндэсний тогтолцоог боловсронгуй болгож, шинэчлэх, холбогдох хууль тогтоомжийн шинэ зохицуулалтыг бий болгохыг уриалан ЗӨВЛӨМЖ БОЛГОЖ БАЙНА.

Хот суурин газар дахь хүн ам нягтарших, шилжилт хөдөлгөөн ихсэх хандлага нь шүүхийн ажлын ачаалыг нэмэгдүүлж, улмаар шүүхээс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмжийг багасгах, зардал чирэгдэл, цаг хугацаа алдах болон үргүй зардлыг ихэсгэж байгааг дан ганц шүүхийн орон тоо, хүний нөөцийн хангамжаар шийдвэрлэх боломжгүй тул эрх зүйн маргааныг шийдвэрлэх дараах хэлбэрийн ажиллагааг нэвтрүүлэн холбогдох хууль тогтоомжид тусгах шаардлагатай гэж үзлээ.

ШҮҮХИЙН БУС БОЛОН ШҮҮХИЙН ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ЭРХ ЗҮЙН МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АРГА, ХЭЛБЭРИЙГ ТҮЛХҮҮ ХЭРЭГЛЭХ:

ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ АЖИЛЛАГАА

Аливаа эрх зүйн маргаан шийдвэрлэхэд маргаантай харилцааны оролцогчдын өөрсдийн идэвхтэй, ухамсартай оролцоог бий болгох, эрх зүйн харилцааг өөрсдөө зохицуулах чадвартай болгох, тэдний эд хөрөнгө, цаг завыг хэмнэх, эрх зүйн ухамсарыг нь дээшлүүлэх, төрийн оролцоо

албадлагагүйгээр сайн дураар гаргасан шийдвэрээ биелүүлэх зан байдлыг төлөвшүүлэх нэг арга зам бол маргааныг эвлэрүүлэн зуучлах замаар хянан шийдвэрлэх ажиллагаа юм.

Талуудын хооронд үүссэн маргааныг эв зүйгээр зохицуулах боломжийг тэдэнд олгож, энэ талаар мэргэжлийн туслалцаа үзүүлэх нь шүүхийн бус журмаар маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа боловч шүүхийн ажиллагаанд шууд нөлөөлөх учиртай. Шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа олон шат, дамжлага, нарийн дэг журамтай байдгаараа эрх зүйн маргааны оролцогчдын цаг зав, хөрөнгө, мөнгө, сэтгэл санааны дарамт зэргийг үүсгэдэг боловч шүүн таслах ажиллагааг хэт хялбаршуулах үндэслэл болдоггүй. Харин талууд маргаанаа өөрсдөө зохицуулж чадвал ашигтай үр дүнд хүрэхээс гадна ихээхэн хөрөнгө зарцуулдаг шүүхийн ачааллыг багасгаж, хөнгөвчлөх боломжтой гэж үзэж байна.

Эвлэрүүлэн зуучлах төвийг шүүхийн дэргэд ажиллуулж, үйл ажиллагааг нь тогтмолжуулснаар маргааныг эвийн журмаар, шүүхээс өмнө шийдвэрлэх Монголд огт байгаагүй арга, хэлбэрийг бий болгохын зэрэгцээ шүүхэд үүссэн иргэний хэргийн оролцогчдын эвлэрэх ажиллагаанд тус дэм үзүүлэх шинэ арга барилыг хөгжүүлнэ.

Эвлэрүүлэн зуучлагчийг бэлтгэх, сонгон шалгаруулах, сургах тогтолцоо, тэдгээрийн үйл ажиллагааны журам, зарчим, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэлбэр, баталгаа, зуучлагчдын хөлс, талуудаас авах хураамж зэрэг багц асуудлыг зохицуулсан бие даасан хууль гаргах, эсхүл холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх саналыг чуулганд оролцогсод гаргасан болно.

Шүүхээр хянан шийдвэрлэгдэж байгаа гэр бүлийн холбогдолтой маргаан гэрлэлт цуцлах ажиллагаатай холбоотой боловч энэхүү ажиллагааны зорилт нь улс үндэстний хөгжил, дэвшлийн эх үндэс, нийгмийн анхдагч нэгж болох гэр бүлийн бат бэх байдлыг хамгаалах явдал юм. Тиймээс ялангуяа гэр бүлийн холбогдолтой маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг нэвтрүүлсэнээр шүүхээр гэрлэлтээ цуцлах явдлыг 10-20 хувь бууруулж, улмаар залуу гэр бүлийг ноцтой бус, бага зэрэг шалтгаанаар гэрлэлтээ цуцлуулахаас урьдчилан сэргийлж, гэрлэгчдийн бие биенийхээ өмнө хүлээх үүргийг өндөржүүлж, хүүхдийн хүмүүжил, бие бялдрын өсөлт, өсөн бойжих орчныг сайжруулах дорвитой арга хэмжээ бол гэр бүлийн тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндэслэл болно гэж үзлээ.

ШҮҮХИЙН ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагаасаа татгалзсан, хариуцагч нэхэмжлэгчийн шаардлагыг зөвшөөрсөн, зохигчид эвлэрсэн, хариуцагч шаардлагыг сайн дураар биелүүлсэн тохиолдолд шүүх ийнхүү хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэдэг.

Хялбаршуулсан журмаар хэрэг маргааныг шийдвэрлэхэд баримтлах тодорхой, ойлгомжтой, иргэдэд дөт арга, хэлбэрийг боловсруулж, сонгох. Иргэний хэрэг маргаан шийдвэрлэдэг шүүгчид маргааныг шийдвэрлэхдээ талуудыг аль болох идэвхтэй оролцох боломжоор хангах тухай Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд тусгах. Маргалдагч талуудыг эвлэрүүлэх арга барилыг шүүгчдэд эзэмшүүлэх нь зөв юм.

ИРГЭНИЙ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААГ ОРЧИН ҮЕИЙН ТЕХНИК, ТЕХНОЛОГИД ТУЛГУУРЛАСАН НЭГДСЭН СТАНДАРТ, ПРОГРАММ ХАНГАМЖААР ЯВУУЛЖ, ШҮҮХИЙН МЕНЕЖМЕНТИЙГ ШИНЭЧЛЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ

Иргэний хэрэг маргааныг хүлээн авахаас эхлээд эцсийн шийдвэр гаргах хүртэл шүүх зөвхөн өөрийн үйл ажиллагаагаар хянан шийдвэрлэдэг ба энэхүү ажиллагаа нь хуулиар нарийн тодорхойлогдсон, шат дараалалтай, хоорондоо харилцан уялдаа бүхий холбоотой ажиллагаанаас бүрддэг тул эдгээр ажиллагаа тус бүрийн үндэслэлтэй, нэгдсэн стандартын дагуу, алдаа мадаггүй гүйцэтгэх нь иргэний хэрэг маргааныг үндэслэл бүхий шийдвэрлэх, нэгэнт гарсан шийдвэрийг хожим процессын алдааны улмаас хүчингүй болгож, хэргийг дахин хянан шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэхгүй байх, улмаар иргэнийг чирэгдүүлж, залхаахгүй байх, зөрчигдсөн эрхийг хугацаа алдалгүй сэргээх үндэслэл болох юм.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд заасан дараалын дагуу явуулах, шүүхийн бүртгэл, статистик тайлан, шүүхээс гарах шийдвэрийг тодорхойлох хэсэг зэргийг алдаа, мадаггүй нэг загвар хэлбэрээр баримтжуулах, шүүхийн ажиллагаанд давхардал, үргүй зардал, хийдэл зэргийн аль алиныг үгүй болгох, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа, зардал хэмнэх, иргэдийн чирэгдлийг багасгах, шүүхийн мониторингийг хэрэгжүүлэх, хяналтын байнгын тогтолцоог бий болгох мэргэжлийн нэгдсэн программ хангамжтай болгох нэн тэргүүний шаардлага тавигдаж байна. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримт бүрдүүлэх, шүүх хуралдааны бэлтгэл хангах шатанд хийгдэх ажиллагааны 70-80 хувийг шүүхийн туслах ажилтан гүйцэтгэдэг тул эдгээр ажилтныг мэргэшүүлэн бэлтгэх, тодорхой шалгуураар томилох, мэргэжил, ажлын байрны ёс зүйг төлөвшүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомжид тусгах. Шүүхээр маргааныг хянан шийдвэрлэхээс өмнө иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгоор шүүх шаардлагатай тохиолдолд зарим этгээдэд холбогдуулан ИХШХШТ хуулийн 129 дүгээр зүйлд заасан зохицуулалтын адил агуулгаар урьдчилсан арга хэмжээ авах боломжийг хуульчлах шаардлагатай байна. Жишээлбэл тодорхой зайнаас харьцах, тухайн байр, газарт очихыг хориглох, утас, холбооны бусад хэрэгслээр харьцахгүй байх зэргийг үүрэг болгох тухай зөвлөмж "шүүх эрх мэдлийн шинэчлэл ба шудрага ёс" үндэсний чуулганаас гарсан байна .

Шүүхийн өмнөх шатанд хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа боловсронгуй болгох: ИХШХШТХ-дэвлэрүүлэн зуучлах механизмыг хэрэглэх талаар дараах зохицуулалтыг тусгах шаардлагатай байна.[301] Үүнд:

- Шүүгч эвлэрэл, зуучлалын механизмыг хэрэглэх эрхтэй байх
- Шүүхийн дэргэд эвлэрүүлэн зуучлах төвүүдийг байгуулах
- Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр дүн хэрэгжихгүй болсон нөхцөлд шүүхэд хандах эрх нь нээлттэй байх
- Эвлэрүүлэн зуучлагч нь /тусгай зөвшөөрөлтэй/ эрх бүхий байх

[301] 2011 оны 4 дүгээр сарын 14.15-нд Ерөнхийлөгчийн ивээл дор Төрийн ордонд болсон "Шүүх эрх мэдлийн шинэчлэл ба шудрага ёс" үндэсний чуулганаас гарсан зөвлөмжөөс.

• Үйлчилгээний хураамж төлөх асуудлыг хуульчлах

• Тэмдэгтийн хураамж төлөхөд төрөөс хөнгөлөлт үзүүлэх, хураамжийг шүүхийнхээс багаар тогтоох

• Эвлэрэлийн гэрээг баталгаажуулж шүүгч захирамж гаргах зэрэг асуудлыг ярилаа Салбар хуралдаанд явагдсан хэлэлцүүлэгт санал хүсэлт өгсөн 309 хүн оролцсон бөгөөд үүнээс ихэнх нь эвлэрүүлэн зуучлах тогтолцоог нэвтрүүлэх нь зүйтэй гэж үзсэн байна. 26 хүн өөрийн санал зөвлөмжөө хэлэхэд Эвлэрүүлэн зуучлах тогтолцоог монголд нэвтрүүлэх зайлшгүй хэрэгцээ шаардлага байна гэж үзэж байсан бөгөөд энэ талаар зохицуулсан хуулийн талаар бие даасан хууль гаргах эсхүл тодорхой хуулиудад тусгаад явах талаар санал гарч байлаа.

Үүнээс дүгнэхэд эвлэрүүлэн зуучлах тогтолцоог манай улсад бий болгох хэрэгцээ шаардлага хангалттай байна гэж үзэхээр байна.

Монгол Улсад эвлэрүүлэн зуучлах тогтолцоо бий болгоход дараах асуудлуудыг зүйтэй юм :

• Эвлэрүүлэн зуучлалын талаар зохицуулсан нарийвчлсан хуулийн талаар

• Эвлэрүүлэн зуучлагчийн эрх, үүрэг

• Эвлэрүүлэн зуучлагчийн ёс зүй

• Эвлэрүүлэн зуучлагчийн цалин хөлс

• Эвлэрүүлэн зуучлагч бэлтгэх сургалт

• Эвлэрүүлэн зуучлагчийн эрх олгох

• Эвлэрүүлэн зуучлал явуулах байгууллага нь шүүхийн дэргэдэх байгууллага уу, эсхүл бие даасан байгууллага уу зэрэг асуудлыг чухалчлан үзэх нь зүйтэй байна.

№	Үнэлэх хэлбэрийн эвлэрүүлэн зуучлах ажиллагаа	"Харилцан буулт хийхийг шаардах хэлбэрийн ЭЗА"	"Бие даан хэлэлцээ хийх явцыг дэмжих хэлбэрийн ЭЗА"
1.	Шүүхийн шийдвэртэй адил үр дүн	Маргалдагч талуудын шаардлагын дундыг барьж шийдвэрлэх	Маргалдагч талуудыг жинхэнээс нь сэтгэл ханамжтай болгох.

№	Үнэлэх хэлбэрийн эвлэрүүлэн зуучлах ажиллагаа	"Харилцан буулт хийхийг шаардах хэлбэрийн ЭЗА"	"Бие даан хэлэлцээ хийх явцыг дэмжих хэлбэрийн ЭЗА"
1.	Хамгийн тохиромжтой гэсэн шийдлийг санал болгох	Шаардлагын дэзд болон доод хязгаарыг тогтоон, харилцан буулт хийхэд чиглүүлэх	Харилцан ярилцах явцыг дэмжих

№	Үнэлэх хэлбэрийн эвлэрүүлэн зуучлах ажиллагаа	"Харилцан буулт хийхийг шаардах хэлбэрийн ЭЗА"	"Бие даан хэлэлцээ хийх явцыг дэмжих хэлбэрийн ЭЗА"
1.	Үр дүн гартал тууштай оролцох	Оролцоо бага	Харилцан яриаг дэмжих байдлаар оролцоно

Эвлэрүүлэн зуучлал нь харилцан тохиролцож өөрсдөө шийдэлд хүрдэг учраас энэ нь бие даах хэлбэрийн эвлэрүүлэн зуучлал юм. "Бие даах хэлбэрийн гэгдэх эвлэрүүлэн зуучлал" нь өнөөг хүртэл ерөнхийлсөн байж ирсэн хуулийн мэргэжилтний үнэлгээ зуучлал нь гадаадын улс орнуудад ерөнхийлөн хэрэглэж ирсэн.[302] Өөрөөр хэлбэл маргаанд оролцогч талуудын ириаг идэвхтэй дэмжиж, хоёр талын саналыг нэгдүүлэхээр эвлэрүүлэн зуучлах хэлбэрээр нэгтгэх зорилготой зохицуулалт бөгөөд ингэх нь харилцан ярилцсанаар оролцогч талууд бие биенийхээ ашиг сонирхол болон байр суурийг ойлгож, харилцан давуу талаа нэмэгдүүлэн, санал нэгдэн шийдвэрт хүрч, маргааны шийдвэрийн дараа ч хоорондын харилцаагаа хадгалж үлддэг.

ХОЁР. ХУУЛЬ ЗҮЙН АРГА ХЭРЭГСЛЭЭР БУС, ЭНГИЙН АХУЙН ТҮВШИНД ЖИЖИГ ХЭРЭГ, МАРГААНЫГ АЙЛ ХӨРШ, ОРОН НУТГИЙН /COMMUNITY LEVEL/ ТҮВШИНД ЭВЛЭРҮҮЛДЭГ ТОГТОЛЦОО НЬ ДЭЭР ДУРДСАН "ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ ХУУЛЬ"-Д ХАМААРЧ БОЛОХ, ЭСХҮЛ ТУСДАА ХУУЛИАР ЗОХИЦУУЛАГДАХ ЭСЭХ.

Талууд хоорондын асуудлаа ямар нэгэн байдлаар шийдэж чадахгүй болсон тохиолдолд л шүүхэд ханддаг. Эхэн үедээ талуудын байр суурь ихээхэн зөрүүтэй байх нь мэдээж. Зөрүү их байх тусам шүүхийн ч бай шүүхийн өмнөх шатанд эвлэрэх асуудалд ажиллагаа их шаардагдах нь ойлгомжтой.

Шүүхийн өмнөх шатны эвлэрүүлэн зуучлал нь Өмгөөлөгчийн холбооны дэргэдэх эвлэрүүлэн зуучлах төв, мэргэжлийн өмгөөлөгчдийн оролцоотой эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулдаг байгууллага юм. Олон нийтэд түшиглэсэн эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь[303] Хууль зүй, дотоод хэргийн яамнаас төсөл хэлбэрээр ахуйн түвшний жижиг хэрэг маргаануудад эвлэрэл явуулахаар ажиллаж байна. Иймд шүүхийг түшиглэсэн эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд хуульч мэргэжилтэй эвлэрүүлэн зуучлагчдыг ажиллуулах нь зөв юм. Харин Олон нийтэд түшиглэсэн ахуйн шинжтэй жижиг хэрэг маргаанд эрх зүйн мэдлэггүй эвлэрүүлэгч нарыг ур чадварын өндөр түвшинд бэлдэх боломжтой юм. Учир нь Орон нутгийн түвшинд гарч байгаа иргэний шинжтэй маргаан, зөрчилтэй асуудлууд байнга тохиолдож байдаг[304] бөгөөд эрх зүйн мэдлэгтэй хүн эвлэрүүлэх ажиллагаа явуулбал асуудлыг дэвэргэх нөхцөлийг бүрдүүлж магадгүй учраас өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулсан оновчтой зохицуулалт шаардлагатай байна гэж үзлээ.[305] Иргэд,

[302] 2011.01.20. Бие даан хэлэлцээрт туслах хэлбэрийн эвлэрүүлэн зуучлал ба хүний харилцааны дасгал.

[303] Олон нийтэд түшиглэсэн эвлэрүүлэх ажиллагаа нь маргалдагч талууд сайн дурын үндсэн дээр ашиг сонирхолын зөрчилгүй гуравдагч этгээдийн туслалцаатайгаар асуудал маргаанаа харилцан зөвшилцөж аль аль талдаа ашигтай шийдвэрлэдэг шүүхийн бус процесс бөгөөд маргаан, үл ойлголцлоос үүдсэн дайсагналцал, өшөө хорсол, хүчирхийллээс зайлсхийх, мөн цагдаа, шүүхийн байгууллагын ажлын ачаалал буурах, цаг хугацаа, зардал хэмнэх арга зам болдог. 2011.9.26-нд Хууль зүйн үндэсний хүрээлэнд болсон "Олон нийтэд түшиглэсэн эвлэрүүлэн зуучлах ажиллагаа" сэдэвт нээлттэй хурлын гарын авлагаас.

[304] Иргэдээс цагдаагийн байгууллагад ирж байгаа өргөдөл гомдлын 30 хувь нь жижиг маргаан, зөрчил байна. Нийт эрүүгийн хэрэг үүсгэсэн материалын 90 хувь нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй буюу гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан зөрчил маргаан байна.

[305] Орон нутагт гарч буй маргаантай асуудал судалгаа 2010 он.

аж ахуй нэгж, байгууллагад иргэний эрх зүйн чиглэлээр туслалцаа үзүүлэх, маргааныг эвлэрүүлэн зуучлах, өмгөөлөл, төлөөлөл явуулах, ажиллагааг тогтвортой хэрэгжүүлж, энгийн хэрэг маргааныг ахуйн түвшинд тогтвортой явуулж байж төлөвшинө. Өөрөөр хэлбэл хуульд баригдахаргүйгээр, хуулиар хориглоогүй бүхий л арга хэрэгслээр, талуудын хүсэл сонирхолд тулгуурлан бодит шийдлийг гаргахын тулд харилцан ярилцаж, талуудын зөвшилцлөөр үр дүнд хүрэх замаар маргааныг шийдэх тогтолцоо юм.

Тухайлбал зарим иргэн, аж ахуй нэгжийн хувьд асуудлыг заавал шүүхэд аваачихгүй байх хүсэл байдаг. Үүнийг зохицуулахад зуучлал чухал үүрэг гүйцэтгэдэг олон улсын жишиг байна. Айл хөрш аливаа маргаантай асуудлаа ахуйн түвшинд эвлэрлийн журмаар шийдвэрлэхэд түүнийг баталгаажуулсан гэрээ албан ёсны баримт бичгийн үндсэн дээр хүчин төгөлдөр болно. Иймд иргэдэд тодорхой хэмжээнд эрх зүйн мэдлэг түгээх шаардлагатай. Энэ асуудлыг хөгжүүлэхэд МӨХ-ны дэргэдэх "Эвлэрүүлэн зуучлах төв"-ийн үйл ажиллагааг тогтворжуулах нь илүү хүртээмжтэй болох болов уу. Учир нь МӨХ олон нийтийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагын хувьд үйл ажиллагааныхаа нэг хэлбэр болгон шүүхийн өмнөх шатны эвлэрүүлэн зуучлалыг албан ёсоор явуулах боломжтой юм.

ГУРАВ. ОЛОН НИЙТЭД ТҮШИГЛЭСЭН ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛД ХАМРАГДАЖ БОЛОХ ХЭРЭГ, МАРГААНЫ ТӨРЛИЙГ ТОДОРХОЙЛОХ

Төслийн талаар

Эвлэрүүлэх ажиллагааг талууд маргааныг чөлөөтэй ярилцах замаар асуудлаа зөвшилцөж шийдвэрлэхэд туслах ажиллагаа гэж ойлгож болно. Энэ нь шүүх, хэрэг бүртгэх ажиллагааны өмнөх шат бөгөөд үүнд оролцогч талууд сайн дурын үндсэн дээр хамтран ажилладаг. Орон нутагт түшиглэсэн эвлэрүүлэх ажиллагаа нь иргэд өөрсдөө орон нутгийнхаа түвшинд маргааныг шийдэх зохицуулалт бөгөөд өргөн уудам нутагтай, хүн ам сийрэг манай улсын хувьд ихээхэн тохиромжтой. Учир нь хүн ам тархуу алслагдсан сумуудад шүүх байхгүй байгаагаас иргэд аливаа маргаан, зөрчилтэй асуудлаа шийдүүлэхэд цаг, хугацаа, зардал шаарддаг. Гэтэл жижиг маргаан, зөрчил дээр заавал шүүх гэхгүйгээр орон нутагтаа нэр хүндтэй хүмүүсийг оролцуулах байдлаар шийдэх боломж байна.

Олон нийтэд түшиглэсэн иргэдийг эвлэрүүлэх ажиллагаа нь төр, иргэдийн харилцааг зохистойгоор хөгжүүлэх, удирдлагын болон хуулийн процессийн ажиллагааны зарим хэлбэрийг нийгмийн харилцаанд оролцогч иргэдэд шилжүүлэх, нийгмийн дэвшилд хүргэх орчин үеийн арга замын дэвшилтэт нэг хэлбэр юм. Олон нийтэд түшиглэсэн эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь хувиараа болон бүлгээрээ зөрчилдөөнд орсон хүмүүст ялгаатай байдлыг нь шийдвэрлэж өгөх, илэрхий бөгөөд харилцан зөвшөөрөхүйц хүрэх хэлэлцээр хийхэд нь тусладаг маргаан зөрчилдөөнийг шийдвэрлэх сайн дурын үйл явц юм[306].

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хэрэгжиж байгаа төслийн зүгээс доорх зөрчил, маргааныг эвлэрүүлэх үйл ажиллагааны төрөлд хамруулжээ:

[306] Олон нийтэд түшиглэсэн эвлэрүүлэн зуучлах ажиллагаа /COMMUNITY MEDIATION/ гарын авлага 2011 он.

- Хувь хүн хоорондын өр төлбөр, зээлийн маргаан
- Сууц өмчлөлийн маргаан
- Хүмүүс хоорондын үл ойлголцол хэрүүл
- Үзэл бодлын зөрүүнээс үүссэн маргаан
- Иргэдийн орон байр, орчны тав тухтай, амгалан тайван байдлыг алдагдуулсантай холбоотой маргаан
- Худалдаа, үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаа, хэрэглэгчийн сэтгэл ханамжгүй байдалтай холбоотой маргаан
- Бэлчээр, худаг, ус, малын хашаа, саравч, айлын хашаа саравч, зуслангийн орчин дахь ашиглалттай холбоотой маргаан
- Эд зүйл, өмч хөрөнгийг түрээслүүлэх, түрээслэх, хөлслөх, хөлслүүлэх, шилжүүлэх, ашиглах, ашиглуулах, өгөх, авахтай холбоотой жижиг маргаануудыг оруулсан байна.

Дээрх төрлийн маргаанууд шүүхэд хандах нь элбэг байдаг. Иймд эдгээр маргаануудад ажлын туршлагатай эвлэрүүлэгч нар сонгох нь зүйтэй юм.

Эвлэрүүлэн зуучлах тогтолцоог сайжруулах төслийн талаар:

Анх 2004 оны 4 дүгээр сард Монгол Улсын хууль зүй, дотоод хэргийн яам Монгол дахь АНУ-ийн Азийн санд хандан Монгол Улсад эвлэрүүлэн зуучлах тогтолцоог нэвтрүүлэх талаар судалгаа хийлгэх хүсэлт гаргажээ. Маргаан, зөрчлөө эвийн журмаар шийдвэрлүүлэхээр хууль зүйн туслалцаа авах төлбөрийн чадваргүй иргэдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй эрх зүйн туслалцааны үндэсний хөтөлбөрийн хүрээнд энэхүү хүсэлтийн үндсэн дээр судалгаа хийгдсэн байна. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг Монгол Улсад нэвтрүүлэхээр "Эвлэрүүлэн зуучлах тогтолцоог сайжруулах төсөл" ажиллаж байна.

2006 онд ЖАЙКА-ийн "Эрх зүйн шинэтгэл, туслалцаа" төслийн дэмжлэгээр МӨХ-ны дэргэд эвлэрүүлэн зуучлах төв гэх одоогийн "LGL"-ийг байгуулсан бөгөөд тус төв нь одоог хүртэл үйл ажиллагаагаа явуулж байна. Энэ нь Японы эвлэрүүлэн зуучлах тогтолцоогоор авч үзвэл хувийн хэвшлийн болон олон нийтийн байгууллагыг түшиглэсэн шүүхийн өмнөх шатны эвлэрүүлэн зуучлах байгууллага юм. Төслийн энэ үе шат нь 2006-2009 онд хэрэгжиж дуусан бөгөөд

"Эвлэрүүлэн зуучлах тогтолцоог сайжруулах төсөл"-ийн 2 дугаар үе шат нь 2010 оны 5 дугаар сараас 2012 оны 12 дугаар сарыг дуустал явагдах ба УДШ, МӨХ, "ЖАЙКА" Олон улсын хамтын нийгэмлэгийн удирдлагууд санамж бичигт гарын үсэг зурж Хууль зүй, дотоод хэргийн яам, Хууль зүйн үндэсний хүрээлэн зэрэг байгууллагууд хамтран "Шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагаа"-г нэвтрүүлэхээр ажиллаж байна.[307]

Уг төсөл нь Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг тогтолцооны хэмжээнд хэрэгжүүлэхийг зорьж 2011 оны 5 дугаар сарын 1-ээс 2011 оны 10 дугаар сарыг дуустал туршилтын журмаар түшиц шүүх болох Дархан-Уул аймгийн сум дундын шүүх, Нийслэлийн Баянзүрх дүүргийн шүүхэд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулж байна. Үүнтэй холбоотой Эвлэрүүлэн зуучлах тогтолцоог сайжруулах төслийн зөвлөлийн зүгээс:

- Иргэний болон гэр бүлийн маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагааны удирдамж
- Эвлэрүүлэн зуучлагчийн хөлс олгох журам
- Эвлэрүүлэн зуучлагчийн үйл ажиллагаандаа баримтлах журам

[307] МӨХ-ны дэргэдэх "LGL"төвийн тэргүүн М.Алтан-Өлзийтэй хийсэн ярилцлагаас 2011.2.17-нд.

• Эвлэрүүлэн зуучлагчийн ёс зүйн дүрэм

• Эвлэрүүлэн зуучлагчийн хүний нөөцийн журам зэргийг туршилтын хугацаанд удирдлага болгон ажиллахаар зөвлөлийн хурлаар сайшаан Монгол Улсын Дээд шүүхийн ерөнхий шүүгч, Монголын өмгөөлөгчдын холбооны ерөнхийлөгч, Жайка олон улсын хамтын нийгэмлэгийн удирдлагуудад танилцуулж үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Эвлэрүүлэн зуучлах тогтолцоог сайжруулах төслийн зүгээс шүүхэд эвлэрүүлэн зуучлал явагдах боломжтой хэрэг, маргаанд дараах маргааныг оруулжээ:

• Гэр бүлийн харилцаанаас үүссэн маргаан

• Ажилтан, ажил олгогчдын хооронд үүссэн маргаан

• Хөрөнгө оруулалтын харилцаанаас үүссэн маргаан

• Иргэд хоорондын зээлийн харилцаанаас үүссэн маргаан

• Хугацаандаа гүйцэтгээгүй аливаа төлбөрийн маргаан

• Орон сууцны төлбөрийн маргаан зэрэг маргаануудыг эвлэрүүлэн зуучлах болох цоотой гэж үзэж байна.

2011 оны 5 дугаар сарын 24-нд Эвлэрүүлэн зуучлах тогтолцоог сайжруулах төслийн зөвлөлийн гишүүд хуралдаж Эвлэрүүлэн зуучлах тухай хуулийн төсөл боловсруулан МУ-ын ерөнхийлөгчид өргөн барьсан. Иймд хууль батлагдвал Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг зохицуулсан бие даасан хуультай болох боломжтой тул салбар хуулиудад өөрчлөлт орох нь тодорхой юм.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль[308] нь 7 бүлэг 32 зүйлтэй төсөл хэлбэрээр бэлэн болсон байна.

Хуулийн 1.1-д. Энэ хуулийн зорилт нь эрх зүйн маргааныг зуучлалд хөндлөнгийн этгээдийн оролцоотойгоор зохицуулах шүүхийн бус аргыг хэрэглэх эрх зүйн үндсийг бий болгох, ажил хэргийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх, нийгмийн харилцааг төгөлдөржүүлэхэд оршино гэжээ. Хуулийн төслөөс харахад эвлэрүүлэн зуучлах ажиллагааны оролцогчдын эрх, үүрэг, зуучлах ажиллагааны төрөл, эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах газар, нөхцөл, харьяалал, зуучлалын хураамж зэргийг хангалттай тусгасан байна.

Хуулийн төслийн талаар:

3 дугаар зүйл. Хуулийн зохицуулах зүйл, үйлчлэх хүрээ

3.2.Шүүх маргалдагч талуудад эвлэрүүлэн зуучлалын талаарх мэдээллийг бүрэн өгч, шүүхэд иргэний хэрэг үүсгэхээс өмнө болон хойно, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шат бүрд талуудыг эвлэрэх боломжоор хангаж, эвлэрүүлэн зуучлагчийн туслалцаа авах талаар сануулах үүрэгтэй. Иргэний хэрэг үүсгэхээс өмнөх шүүхийн үйл ажиллагааны тухайд "Жич: шүүхийн энэ сануулга нь талуудын шүүхээр хэрэг хянан шийдвэрлүүлэх эрхийг хязгаарлахгүй" гэх мэтээр нэмэлт заалттай байх нь зохистой. Талуудыг эвлэрэх боломжоор хангах, эс бол эвлэрүүлэн зуучлагчийн туслалцаа авах талаар сануулах гэсэн агуулгыг илүү тодруулах шаардлагатай байна.

3.3. Гэр бүлийн эрх зүйн харилцаанаас үүссэн маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах боломжгүйгээс бусад тохиолдолд эвлэрүүлэн

[308] 2011.5.25-нд Монгол Улсын Дээд шүүхэд "Эвлэрүүлэн зуучлах тогтолцоог сайжруулах төслийн" зөвлөлийн гишүүдийн хурлаар хэлэлцсэн Эвлэрүүлэн зуучлах тухай хуулийн төслөөс.

зуучлах ажиллагаа явгдаагүй бол шүүх иргэний хэрэг үүсгэхгүй гэсэн заалт зөвхөн гэр бүлийн хэрэгт эхлээд эвлэрүүлэн зуучлал явуулах талаар тусгах, мөн эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулж болохгүй тохиолдол гэж ямар тохиолдол байж болох талаар тодруулах. /Японы гэр бүлийн шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль/-д ЭЗА явуулж болох хэргүүдийг нэг төрөл болгон зааж өгсөний үндсэн дээр ЭЗА явуулж болох төрлийн хэргийн хувьд урьдчилан ЭЗА-ны журмаар шийдвэрлэх хэрэгтэй гэж заасан байдаг. Монгол Улсын гэр бүлийн хуулиар 18 хүртэлх насны хүүхэдгүй, эд хөрөнгийн маргаангүй тохиолдлоос бусад үед шүүхийн журмаар цуцлуулахаас өөр аргагүй байдаг. Хэрэв гэр бүлийн маргаан нь эд хөрөнгийн болон өөр гэмт хэргийн шинжтэй, эвлэрэл явуулах боломжгүй маргааныг шүүхээр шийдүүлэхээр зохицуулах шаардлагатай.

Түшиц шүүхүүд дээр Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг туршилтын журмаар явуулж эхэлсэн. Удирдамжийн 1.1-д Иргэний болон Гэр бүлийн эрх зүйн маргаанд шүүх, өмгөөллийн байгууллагын дэмжлэгтэйгээр маргалдагч этгээдүүдийг эвлэрүүлэн зуучлах болон эвлэрлийг шүүхээр баталгаажуулах /цаашид "эвлэрүүлэн зуучлах гэх" /ажиллагаг зохицуулахад энэхүү удирдамжийн зорилт оршино **гэсний дагуу манай улсад иргэний болон гэр бүлийн хэрэгт эвлэрүүлэн зуучлал явуулж эхлээд байна.** Удирдамжийн 4 дүгээр зүйлийн 4.1-д Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг шүүхэд иргэний хэрэг үүсгэхээс өмнө, эвлэрүүлэх ажиллагааг иргэний хэрэг үүсгэсний дараа дор дурдсан хэлбэрээр хэрэгжүүлж болно. Үүнд:

4.1.1. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг шүүхэд иргэний хэрэг үүсгэхээс өмнө, шүүхийн эвлэрүүлэн зуучлах хэсгийн зуучлагч хэрэгжүүлнэ.

4.1.2. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг шүүхэд иргэний хэрэг үүсгэсний дараа шүүгч хэрэгжүүлэх бөгөөд шаардлагатай гэж үзвэл зуучлах хэсгийн дэмжлэгийг авч болно. Эвлэрүүлэн зуучлагч нь тусгайлан бэлтгэгдэж, сургалтанд хамрагдаж сертификат болон тэмдгийг гардаж авсан хүн эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулах эрхтэй болно. Мөн шүүхийн өмнөх шатанд эвлэрэл амжилтгүй болоод шүүхийн шатанд хэрэг үүсвэл дээрх журмын 11.6-д зааснаар аль нэг тал энэ журмын 11.5-д заасан хүсэлт гаргавал гэрээг шүүх хянан үзэж ирүүлсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор шүүгчийн захирамжаар /ИХШХШТХ-ийн 184.2, 183.3 мөн хуулийн 10.4-ийг баримтлан төсөөтэй хэрэглэх/ баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх хуудас бичиж 7 хоногийн дотор төлбөр авагч, төлбөр төлөгч, шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүргүүлнэ гэж заажээ[309].

Эрүүгийн хэрэгт: Эвлэрүүлэн зуучлалд дан ганц зуучлагчийн ажлын оролцооноос хараарахгүй мөрдөн байцаалт болон прокурорын шат давхар ажиллах шаардлагатай болно. Иргэний болон гэр бүлийн маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагааны удирдамжийн 11.6-д заасны дагуу талууд хүсэлт гаргасан тохиолдолд шүүгч оролцох боломж нээгдэнэ. Гэтэл эрүүгийн хэрэг нь өөрөө нарийн эздрээ төвөгтэй учир хөндлөнгөөс цагдаа, прокурор, мөрдөн байцаагч оролцох шаардлагатай. Мөн талууд гомдолгүй гэж тохирсон ч санкцийн асуудал яригдах боловч хөнгөн хэрэг болон иргэний нэхэмжлэл байгаа үед хохирол, гэм буруутай холбогдох хэсгээр зуучлагч оролцуулах боломжтой юм.

[309] "Эвлэрүүлэн зуучлах тогтолцоог сайжруулах" төслийг хамтран судалж, хэрэгжүүлэх зөвлөлийн 2010 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хурлаар сайшаагдсан. Иргэний болон гэр бүлийн маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагааны удирдамж.

Захиргааны хэрэгт: Зарим тохиолдолд зуучлал явуулах боломжтой. Аж ахуйн нэгжүүд зуучлалаар шийдэлд хүрэх боломжтой гэж үзэж буй тохиолдолд зуучлагч оролцож болно. Тухайлбал төрийн захиргааны байгууллагаас олгосон зөвшөөрөл, лиценз, тусгай зөвшөөрөл, газар эзэмших, ашиглах зэргийг хамтран ашиглах, хуваах, эзэмших асуудлыг зуучлалаар шийдвэрлэж тохиролцоонд хүрч болох юм.[310]

Маргааны талууд эвлэрсэн тохиолдолд Иргэний болон гэр бүлийн маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагааны удирдамжийн[311] 17.1-д заасны дагуу талууд шүүх хуралдааны өмнө эвлэрсэн тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74, 75 дугаар зүйлд заасны дагуу хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэнэ. Хялбаршуулсан журмаар шийдвэрлэх ажиллагаатай уялдаж байх бөгөөд ИХШХШТХ-ийн 106.5-д тусгаж өгсөн байна. Эвлэрлийн талаар ИХШХШТХ болон Хөдөлмөрийн хуульд тусгаж өгсөн нь давуу талтай юм.

ДӨРӨВ. ГАДААД ОРНУУДЫН ТУРШЛАГА:

Япон улс

Япон улсад эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь түүхэн уламжлалтай, өргөн хэрэглэгддэг. Газар, байшингийн түрээстэй холбоотой маргааныг эвлэрүүлэн зуучлалаар зохицуулах хууль 1992 онд батлагдсанаар эхэлж "шүүхээс гадуур маргаан шийдвэрлэх механизмыг өргөнөөр ашиглах тухай хууль" 2004 онд батлагдах хүртэл хөгжиж ирсэн байна. Энэ туршлагаас харахад хүн ам ихтэй улсын хувьд газрын болон үл хөдлөх хөрөнгийн түрээстэй холбоотой маргаан байдаг. Хэрэг маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг зорьж энэ тогтолцоог хөгжүүлсэн байна.

Япон улсад шүүхийн ADR[312]-тай хамт, хувийн хэвшлийн ADR-ыг түлхүү бэхжүүлэх бодлого барьж байгаа нь анзаарагдсан. Хувийн хэвшлийн ADR-ийг баталгаажуулж, шүүхийн ADR-тай өрсөлдөхүйц хэмжээнд болгох зорилт төрийн оролцоотой хэрэгжиж явагддаг байна.

Япон улсад ADR-ийг гурван хэлбэрээр хэрэгжүүлж байна.

1.Шүүхийг түшиглэсэн эвлэрүүлэн зуучлах ажиллагаа

2.Захиргааны байгууллагыг түшиглэсэн эвлэрүүлэн зуучлах ажиллагаа

3.Хувийн болон олон нийтийн байгууллагыг түшиглэсэн эвлэрүүлэн зуучлах ажиллагаа

Эдгээр нь шүүхээс гадуур маргаан шийдвэрлэх оновчтой механизмыг сонгох боломжийг бүрдүүлэн, иргэдийн эрх, ашиг сонирхлыг зохистой байдлаар хангахад оршино. Япон улсад Шүүгч 2684, Прокурор 1679, Өмгөөлөгч 26964 хүн байна.

---

[310] Монголын өмгөөлөгчдын холбоо, LGL, JICA хамтарсан /2008/ Эвлэрүүлэн зуучлалын гарын авлага УБ Odsar Ink Ktd.

[311] 2011 оны 5 дугаар сарын 7-нд Эвлэрүүлэн зуучлах тогтолцоог сайжруулах төсөлийн зөвлөлөөс сайшаасан Иргэний болон гэр бүлийн маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагааны удирдамжаас.

[312] Alternative Dispute Resolution буюу 1.Шүүх дахь ADR Шүүхийн бус журмаар маргааныг шийдвэрлэх. Шүүхэд хэрэг үүссэнээс хойш хянан шийдвэрлэх ажиллагааны явцад зохигчид нэхэмжлэлийн шаардлагын талаар эс бол хянан шийдвэрлэх ажиллагааг даусгавар болгох тал дээр шүүгчийн оролцоотойгоор тохиролцоонд хүрэхийг "шүүх дэх "эвлэрэл гэнэ. /Mediation system F.Y.2010 January 198 2011/

Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа шүүхэд хэрэг шийдэх ажиллагаанаас ялгаатай нь шүүгчээс гадна энгийн ард иргэдээс сонгогдсон 2-оос доошгүй тооны эвлэрүүлэн зуучлагч оролцсон "Эвлэрүүлэн зуучлах зөвлөл" нь нэг ахлах эвлэрүүлэн зуучлагч, хоёр иргэний хэрэг эвлэрүүлэн зуучлагчаас бүрддэг.[313] Зөвлөл нь маргалдагч талуудын тайлбарыг сонсож, эрх зүйн дүгнэлтэнд үндэслэн нийгэмд дагаж мөрддөг ёс журамд харшлахгүй байдлаар бие биедээ буулт хийх явцыг дэмжсэнээр маргалдагч талууд тохиролцон тухайн нөхцөл байдалд нийцсэн шийдэлд хүрдэг.

Шүүх дэх иргэний хэргийн эвлэрүүлэн зуучлалын хувьд эвлэрэл амжилтгүй болсноос хойш 1 сарын дотор шүүхэд нэхэмжлэлийн өргөдөл гаргавал эвлэрүүлэн зуучлалын өргөдөл гаргасан өдрөөс нь эхлэзд хөөн хэлэлцэх хугацаа тасалдана. Мөн шүүхийн бус журмаар маргааныг шийдвэрлэх процедурын ашиглалтыг нэмэгдүүлэх тухай хуульд тулгуурлан, батламжлуулсан эвлэрүүлэн зуучлалын процедурын хувьд эвлэрэл амжилтгүй болсноос хойш 1 сарын дотор шүүхэд нэхэмжлэлийн өргөдөл гаргасан өдрөөс нь эхлэзд хөөн хэлэлцэх хугацаа тасалдаж болно. Харин шүүхийн бус журмаар маргааныг шийдвэрлэх процедурын ашиглалтыг нэмэгдүүлэх тухай хууль 2007 онд батлагдсан байна.

Япон улсын хувьд шүүх дэх эвлэрүүлэн зуучлал нь анхан шатны шүүх, гэр бүлийн шүүх, хялбаршуулсан шатны шүүхүүдэд байнга тасралтгүй явагддаг болгох нь дараах судалгаанаас харагдаж байна.

Японы анхан шатны шүүхэд шинээр хүлээж авсан иргэний хэргийн судалгаа:



Нийт 751398 нэхэмжлэлээс хялбаршуулсан шатны шүүхээр шийдвэрлэсэн 551875, Орон нутгийн шүүхээр шийдвэрлэсэн 199523 хэрэг байна.

Дээрх шийдвэрлэсэн байдлаас харахад Япон улс цаг хугацаа хэмнэх ажлын ачааллыг тэнцүү хуваарилах болон иргэдийг цаг заваа хэмнэхэд ихээхэн анхаарч ажилладаг нь харагдаж байгаа бөгөөд иргэд ч эвлэрүүлэн зуучлах ажиллагааг хангалттай сайн мэддэг байна.

[313] Японы Иргэний хэрэг эвлэрүүлэн зуучлах тухай хууль

Японы Орон нутгийн шүүх дэх иргэний хэрэг эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үзүүлэлт:



Хялбаршуулсан шатны шүүх дэх Иргэний хэрэг эвлэрүүлн зуучлах ажиллагааны үзүүлэлт:



Шүүх дэх эвлэрэл

Он	*Шүүхийн шийдвэр*	*эвлэрэл*
2000	50,7%	49.3%
2002	46,8%	53.3%
2006	42,4%	57.6%
2007	35,5%	64.4%
2008	70.8%	29,2%
2009	31,9%	68.1%

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

Гэр бүлийн шүүхийн шүүгч, шүүхийн эвлэрүүлэн зуучлагч нь иргэдээс сонгогдсон гэр бүлийн маргааныг эвлэрүүлэн зуучлагчтай хамтран маргалдагч талуудын тайлбарыг сайн сонсож, төвийг сахисан байр сууринаас бүх гишүүд сэтгэл хангалуун байж оновчтой бөгөөд боломжийн шийдлийг олж, тохиролцоонд хүргэхээр зуучлах үйл ажиллагаа явуулна. Гэр бүлийн эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд хүүхдийн асран хамгаалагч тогтоолгох, хүүхдийн тэтгэлэг гаргуулах, гэрлэлтийн зардал хуваарилах, эд хөрөнгө хуваах талаар маргалдагч талууд харилцан яриагаар дамжуулан өөрсдөө бие даан маргаан шийдвэрлэхийг зохистойд тооцох тул ихэнхдээ ЭЗА-аар шийдэхийг урьтал болгодог байна. Японд гэр бүлийн маргаанд эхлээд заавал эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулдаг байна.Гэр бүлийн шүүхийн эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаа нь гэр бүлийн шүүхийн шүүгч, иргэдээс сонгогдсон 2 эвлэрүүлэн зуучлагч, гэр бүлийн шинжээч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, нэхэмжлэгч, хариуцагч гэсэн дараалалтай явагдана.[314]

Боливи улс

Худалдааны маргаанд эвлэрэл болон хувийн арбитрыг хэрэглэх талаар 1980-аад оноос эхлэн шүүхийн системийг шинэтгэх үүднээс АНУ-ын USAID-аас хэд хэдэн төрлийн төсөл хэрэгжүүлж эхэлсэн. 1990 он гэхэд тус улсад шүүх байгууллагуудын шийдвэрлээгүй байсан олон тооны хэрэг маргаануудыг шуурхай шийдвэрлэх, шүүхийн ачааллыг багасгах үүднээс худалдаатай холбоотой гарсан маргаанд эвлэрэл болон хувийн арбитрыг хэрэглэх талаар шинээр төсөл хэрэгжүүлэх болсон байна. USAID-тэй хамтын ажиллагаатай байдаг "Америк хоорондын Баарын сан" /Inter-American Bar Foundation/ болон Боливийн худалдааны танхимаас санаачлан эвлэрэлийн болон арбитрын төвийг байгуулсан. Ингээд Боливид томоохонд тооцогддог хотуудад худалдааны танхимын дэргэд тус төв үйл ажиллагаа явуулдаг байна. 1994 оноос анх үйл ажиллагаагаа эхэлсэн. Үйл ажиллагааны гол хэлбэр нь бизнесийн салбарт гарсан маргааныг шийдвэрлэх мэдлэг, боловсролтой, чадварлаг эвлэрүүлэгч, арбитрчидыг сургаж, мэргэжлийн удирдлагаар хангаж, түүнчлэн энэ төрлийн үйлчилгээг байнгын тогтмол шинжтэй болгоход чиглэж ирсэн бөгөөд тус төв нь шүүхээс баталгаажсан арбитрын шийдвэр болон эвлэрэх гэрээг хийх эрх зүйн үндэслэлийг тусгасан арбитрын болон эвлэрлийн хуулийн төслийг цоо шинээр бэлтгэн гаргасан байна. Төвийн үндсэн үйл ажиллагаа нь маргалдагч талуудын сайн дурын хүсэл зоригт тулгуурлан хийсэн гэрээний дагуу эвлэрлийн болон арбитрын ажиллагаа явуулах явдал байдаг нь маргааны шинж чанараас хамаарч төлбөрийн хэмжээ харилцан адилгүй байна. Энэхүү төлбөр нь зохион байгуулалтын ажилд зарцуулагддаг. 1994 оноос хойш жилд дунджаар 10-25 хэрэгт эвлэрэл, 1-8 хэргийг арбитраар шийдвэрлэж байгаа хэдий ч маргаанаа шийдүүлсэн хүмүүсийн хувьд сэтгэл ханамжийн баталгаа маш өндөр байдаг нь судалгаагаар тогтоогдсон ажээ. Маргаан шийдвэрлэх эдгээр сонголтот аргыг өргөнөөр хэрэглэхгүй байгаагийн гол шалтгаан нь бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаа харьцангуй доод түвшинд явагддаг, мөн маргаан шийдвэрлэх сонголтот аргын талаарх мэдлэг муу байгаатай холбоотой. USAID-ийн төслийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж

[314] 2011.1.18. Япон улсад болсон "Эвлэрүүлэн зуучлагчийн сургагч багш" бэлтгэх сургалтад Осака хотын орон нутгийн шүүхийн шүүгч Инаба Казуто-ийн лекцнээс

буй Арбитр, эвлэрлийн төвийн гол зорилго нь шүүхийн ачааллыг багасгах явдал юм. Гэвч бодит амьдрал дээр энэ зорилгоо бүрэн хангаж чадаагүй ч бизнесийн салбарт гарч буй маргаануудыг түргэн, шуурхай, хэмнэлттэй шийдвэрлэж чаддаг давуу талаа хадгалсаар байна.

Анх үйл ажиллагаагаа явуулж эхэлснээс хойш гурван жилийн туршид эвлэрэл, арбитрын үйл ажиллагааны дунд гаргасан шийдвэрийг шүүхээс баталгаажуулах ажлыг эхлүүлж чадаагүй. Үүний гол шалтгаан нь шүүх болон тус төвийн үйл ажиллагааны уялдаа холбоог нарийн гаргаж өгөөгүйд оршино. Магадгүй маргаан шийдвэрлэх эдгээр сонголтот аргуудын талаарх ойлголт шүүхийн хүрээнд ч муу байсантай холбож ойлгодог байна.

Төвийн үйл ажиллагааг USAID-ээс санхүүжүүлэх ажлыг 1997 он гэхэд зогсоосон. Гагцхүү сургалт явуулах, мэргэжилтнүүдийг бэлтгэх зардлыг хариуцахаар болсон. Энэ нь тус төв үйл ажиллагаагаа цааш явуулахын тулд хэрэглэгчдийг татах, тэдэнд төлбөртэй үйлчилгээ үзүүлэхэд дөхөм болсон. Ингэснээрээ тус төв өөрөө өөрийгөө санхүүжүүлэх системд орох ёстой юм.

Маргаан шийдвэрлэх эдгээр сонголтот аргыг зөвхөн бизнесийн салбарт хэрэглэхээр хязгаарласан нь шүүхийн ачааллыг жинхэнэ утгаар нь бууруулахад нөлөөлж чадаагүй шалтгаан гэж үзэж болох юм. Гэвч шүүхээр шийдвэрлэгдэж буй бизнесийн болон худалдааны маргаануудыг дангаар шийдвэрлэх бололцоотой ч энэ талаарх дорвитой судалгаа хийгдээгүйн дээр боловсон хүчний мэргэжлийн чадвар боломж хангалтгүй байна гэж үздэг [315].

Өмнөд Африк */Хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх Зуучлал болон арбитрын үйл ажиллагаа явуулах төрийн бус байгууллага/*

Энэхүү төрийн бус байгууллагын нэр нь Өмнөд Африкийн бие даасан зуучлалын үйлчилгээ үзүүлэх байгууллага бөгөөд үйл ажиллагааны гол чиглэл нь хөдөлмөрийн маргаантай асуудлыг шийдвэрлэх явдал. Маргаан шийдвэрлэх сонголтот аргуудыг хэрэглэх асуудал нь сайн дурын бөгөөд арбитраас гаргаж буй шийдвэрийг шүүхээс баталгаажуулдаг. Зуучлалын гэрээ хийх эсэх нь албадлагын бус шинжтэй байдаг. Тус байгууллагын ажилчид нь маш өндөр хэмжээнд бэлтгэгдсэн, чадварлаг хүмүүс байдгийн ачаар тодорхой хэмжээний төлбөр авч санхүүждэг. USAID-ээс санхүүжихийн хажуугаар үйлчилгээ үзүүлсний хөлснөөс тодорхой хувийг /20%/ авч үйл ажиллагаагаа явуулдаг байна. 1984 он гэхэд 44 хэрэг шийдвэрлэж байсан бол 1996 он гэхэд 1500 гаруй хэргийг шийдвэрлэсэн. Аливаа маргааныг цөөн өдөрт шийдвэрлэж чаддаг давуу талтай. Байнгын мониторинг хийдэггүй хэдий ч маргаанаа шийдвэрлүүлсэн талуудын сэтгэл ханамж өндөр байдаг. Удирдлага болон ажилчдын хоорондын харилцаа уялдаа муутай байдгийг өөрчлөх нь Өмнөд Африкийн бие даасан зуучлалын үйлчилгээ үзүүлэх байгууллагын гол зорилго. Хөдөлмөрийн маргааныг шийдвэрлэх төрийн байгууллагын ажил үр дүн муутай, өндөр зардалтай, хугацаа их шаарддаг байсан тэр үед уг байгууллага байгуулагдсан нь олны талархлыг хүлээжээ.

Өмнөд Африкт улс төрийн өөрчлөлт гарснаар төрийн бүтцэд шинэчлэлт хийгдэж улмаар хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх Эвлэрэл, Зуучлал, Арбитрын Зөвлөл байгуулагдсан байна. Тус улсад өрнөдөд ашигладаг маргаан шийдвэрлэх сонголтот аргын загвар хэрэглэгддэг. Энэ загвар нь үйлдвэрийн салбарын хүрээнд институцийн болон соёлын хэм хэмжээг нэвтрүүлэх нь илүү зохистой гэж үздэг. USAID-ийн төслийн хүрээнд хэрэгжиж

[315] Alternative Dispute resolution practitioners' guide, March 1998, page 15

буй программ нь өөрийн гэсэн амжилтаа хадгалсаар байгаа ч улс төрийн тогтворгүй байдлаас болж санхүүгийн хувьд бэрхшээлтэй тулгарсан. Бие даасан зуучлалын үйлчилгээ үзүүлэх байгууллагын ажил амжилттай байгаад нөлөөлдөг гол хүчин зүйлс нь олон тооны чадварлаг, сайн бэлтгэгдсэн ажилтан /эвлэрүүлэгч, зуучлагч, арбитрч нар/, хөдөлмөрийн салбар дахь маргаан шийдвэрлүүлэх сонирхол бүхий хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээ, ажилтан болон удирдлагын хоорондын ажлын уялдааг сайжруулах талаар төслийн хүрээнд авсан арга хэмжээнүүдийн үр дүн зэрэг юм.

Үйл ажиллагааны эрх зүйн үндэс болсон гол хууль 1995 онд батлагдсан. Өмнөд Африкийн Бие даасан зуучлалын үйлчилгээ үзүүлэх байгууллага нь харьцангуй бие даасан, хараат бус байдлаар үйл ажиллагаа явуулж чадсан ч тухайн үедээ шүүмжлэлд ихээр өртөж байв. Харин шинэ засгийн газар байгуулагдсанаас хойш шинээр байгуулагдсан хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх Эвлэрэл, Зуучлал, Арбитрын Зөвлөлтэй хамтран ажиллаж эхэлсэн. Хэмнэлттэй, хурдан шуурхай, талуудын сэтгэлд нийцсэн үйл ажиллагаа явуулж чаддаг боловч тус байгууллагын үйл ажиллагааг үнэлэх системчилсэн үнэлгээ байдаггүй. Хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх Эвлэрэл, Зуучлал, Арбитрын Зөвлөл болох төрийн байгууллагын тэргүүнээр өмнө нь Өмнөд Африкийн бие даасан зуучлалын үйлчилгээ үзүүлэх байгууллагад ажиллаж байсан хүн сонгогдсоноос харагдаж байна. Одоогоор тус байгууллага маргаан шийдвэрлэх сонголтот аргуудыг нийгэмд нэвтрүүлэхэд Эвлэрэл, Зуучлал, Арбитрын Зөвлөл болох төрийн байгууллагад мэргэжлийн туслалцаа үзүүлэх, түүний салбарыг улс орны өнцөг булан бүрт бий болгоход туслах зорилт тавин ажиллаж байна.

Украин */Иргэний болон худалдааны маргааныг шийдвэрлэх зуучлал эрхлэх төрийн бус байгууллага/*

Украин Улс нь хуучин социалист системтэй байсан улсын хувьд хувийн өмчийг бий болгох, иргэний нийгмийг хөгжүүлэх, шүүхийн системийг шинэчлэх, маргаан шийдвэрлэх сонголтот аргуудыг хэрэгжүүлэх зэрэг хэд хэдэн зорилтыг өмнөө тавиад байгаа билээ. Украины Зуучлалын групп хэмээх төрийн бус байгууллагыг АНУ-ын USAID-ээс дэмжин ажилладаг. Тус групп нь худалдааны маргаанд зуучлалыг хэрэглэхээс гадна олон тооны иргэний хэргүүдийг мөн адил шийдвэрлэсӭэр ирсэн. Маргаан шийдвэрлэхэд талуудын ардчилсан оролцоог нэмэгдүүлэх, эрх зүйн болон эдийн засгийн шинэтгэл хийх асуудлыг стратегийнхаа гол зорилго болгосон. Украины Зуучлалын групп нь олон донор байгууллага, төсөл, сангуудаас санхүүждэг байна.

Зуучлалын групп нь өөрийн үйл ажиллагааг Донетцк, Луганск, Одесс, Киев зэрэг томоохон 4 хотод явуулдаг. Украины Зуучлалын Групп нь зуучлагчдыг сургах, зуучлагчдыг үйлчлүүлэгчидтэй холбох зэрэг үйлчилгээг санал болгох, аж ахуйн нэгжүүдэд зөвлөгөө өгөх зэрэг ажил эрхэлдэг. Худалдааны болон хөдөлмөрийн маргаантай асуудлын нэгэн адилаар иргэний эрх зүйн хүрээнд өмч хувьчлалтай холбоотой маргаан ихээр гардаг тул энэ салбарт зуучлал явуулж эхлэсэд байна. Тус группын сонгаруудад ажилладаг зуучлагчдыг сургаж, сертификат олгох ажлыг Украины Зуучлалын групп хариуцдаг. Уг төсөл нь 1996 оны нэгдүгээр сараас 1997 оны гуравдугаар сарын хоорондо хэрэгжсэн. Энэ хугацаанд нийт 61 өргөдөл гомдол ирснээс 26 хэрэгт зуучлалын ажиллагаа явуулсан. Тус байгууллагын үндсэн зорилго нь "маргаан, зөрчилгүй ажлын орчинг бүрдүүлэх нөхцөлийг бий болгох, үндэсний үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийг хангах, эрүүл эдийн засгийн

орчин бий болоход нөлөөлөх үндсэн хүчин зүйлсийг олж илрүүлэх" явдал юм. Тус байгууллагаар үйлчлүүлэгчид голчлон хөрөнгийн чадвартай томоохон бизнесмэнүүд байдгаас гадна шүүх ажиллагаар өндөр зардалтай, хугацаа их шаардсан хэмээн үздэг хүмүүс байдаг байна. Тус улсад хэрэгжиж буй зуучлалын хэлбэр нь хөгжингүй улс орнуудад ашиглагддаг зуучлалын загвар билээ. Маргаан шийдвэрлэх сонголтот аргын талаарх мэдээллээр нийгмийг хангах, мониторингийн болон үнэлгээний ажлыг сайжруулах, санхүүгийн тогтвортой эх сурвалжтай болох нь тус байгууллагын тулгамдсан асуудал юм. Дээр дурдсаны дагуу мониторингийн асуудлаарх бэрхшээлийг арилгах, хяналтын чанарыг сайжруулах, зуучлагчдын сургалтыг өргөн хүрээтэй явуулахад тус байгууллага анхааран ажиллаж байна. Одоогийн хэрэгжиж байгаа хууль, төрийн бус байгууллагын үйл ажиллагааны санхүүжилтийг тогтвортой, үр ашигтай байлгах явдалд маш ихээр хязгаарлалт тавьсан байдаг. Иймд үйлчилгээний хөлс авах явдлыг бий болгох үүднээс хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үздэг. Маргаан шийдвэрлэх сонголтот арга болон шүүх тогтолцооны хоорондын ажлын уялдааг эрх зүйн хувьд маш нарийн гаргаж, тодруулах шаардлагатай. Украины Зуучлалын Группын хувьд худалдааны салбар дахь маргаан шийдвэрлэх нөөц бололцоо байна. Үүний хажуугаар нийгэмд энэ салбарын маргааныг шийдвэрлэхэд зуучлалыг ашиглах сонирхол байгааг анхаарах нь чухал юм. Гэхдээ юуны өмнө байнгын санхүүжилтийг бий болгох, санхүүжилтийн найдвартай байдлыг хангах хууль эрх зүйн орчин хэрэгтэй ажээ. Үүний хажуугаар зуучлалын асуудалд үр дүнтэй мониторинг хийх, маргаан шийдвэрлэх сонголтот аргуудын талаарх мэдээллийг олон нийтэд түгээх хэрэгтэй гэдэг.

Эдгээр Улс орнуудын эвлэрүүлэн зуучлах тогтолцооны туршлагаас харахад өөр өөрийн эрх зүйн онцлогоос хамаарч харилцан адилгүй байна. Япон улсын хувьд 120 сая гаруй хүн амтай шүүхийн ажлын ачаалал маш их байдагт ч Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр дүнд ачааллаа тэнцвэржүүлдэг нь тоо баримтаас харагдаж байна. Иймд эвлэрүүлэн зуучлах тогтолцоог Япон улсын жишгээр шүүхэд нэвтрүүлж хэрэгжүүлбэл тохиромжтой юм.

Дүгнэлт

Монгол Улсад эвлэрүүлэн зуучлах тогтолцоог нэвтрүүлэхээр Нийслэлийн Баянзүрх дүүргийн шүүх, Дархан-Уул аймгийн Сум дундын шүүхүүдэд 6 сарын хугацаанд "эвлэрүүлэн зуучлах тогтолцоог сайжруулах" төслөөс туршилт явуулж тодорхой хэрэг маргааныг эвлэрүүлж нийт 101 маргаанд тодорхой эвлэрлийн ажиллагаа явуулсан байна. Мөн хуулийн төсөл боловсруулж Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн барьжээ. МӨХ-ны дэргэдэх Эвлэрүүлэн зуучлах төв шүүхийн өмнөх шатанд эвлэрүүлэн зуучлах ажлыг 2006 оноос хойш явуулж байна. Энэ хугацаанд иргэд "эвлэрүүлэн зуучлалын"-ын үр шимийг тодорхой хэмжээнд хүртэж ач холбогдолыг нь ойлгож, үнэлдэг болжээ. Иймээс иргэд маргаанаа эвийн журмаар шийдвэрлэх хэрэгцээ нэмэгдэх нь тодорхой юм. Аливаа маргааныг хүмүүс өөрсдөө бий болгодог тул харилцан тохиролцож, хүндрэлтэй асуудлаа өөрсдөө эвийн журмаар шийдвэрлэж, маргааныг дуусгана гэдэг бол харилцааны том соёл, гуравдагч этгээдүүдийн оролцоотойгоор маргалдагч талууд тохиролцож маргааныг эвийн журмаар шийдвэрлэдэг энэхүү тогтолцоо нь анхан шатны шүүхийн ачаалал их байдаг манай улсад

тохиромжтой юм. Шүүхийн ачааллыг багасгахад дан ганц шүүгчийн орон тоог нэмэх шүүхийн хүний нөөцөөр зохицуулагдах асуудал биш юм. Иймд шүүн таслах ажиллагаатай эвлэрүүлэн зуучлалыг хавсран явуулах нь үр дүнтэй ажил болно.

1.Шүүгч эвлэрэл, зуучлалын механизмыг хэрэглэх эрхтэй байх;

2.Шүүхийн дэргэд эвлэрүүлэн зуучлах төвийг байгуулах;

3.Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа үр дүнгүй болсон тохиолдолд шүүхэд хандах эрх нь нээлттэй байх талаар тусгайлан зохицуулах;

4.Эвлэрүүлэн зуучлагч нь тусгай хүлээн зөвшөөрөгдсөн эрхтэй байх, эрх олгох тогтолцоог нарийвчлан зохицуулах;

5.Тэмдэгтийн хураамж төлөх асуудлыг шүүхийнхээс багаар тооцох;

6.Олон нийтэд түшиглэсэн эвлэрүүлэн зуучлалыг жижиг хэрэг маргаан дээр ахуйн түвшинд чанартай явуулахад, эвлэрүүлэгч нарын мэдлэг чадварыг байнга дээшлүүлэх мөн тэднээр дамжуулж иргэдийн ухамсарт эрх зүйн үйлчилгээг таниулах ажлыг хийх нь чухал юм.

7.Эвлэрүүлэн зуучлах тогтолцооны талаар хуульчдын багц цагийн сургалтанд өргөнөөр оруулах, эрх зүйн шинэтгэлд хуульчдын сургалт өндөр ач холбогдолтойн зэрэгцээ уг сургалт нэгдсэн бодлого тодорхой тогтолцооны дагуу чанартай тасралтүй явагдах хэрэгтэй байна.

Маргааны учир шалтгааныг тодорхойлох, асуудлыг эв зүйгээр зохицуулахыг хуульчдад олгох энэхүү ажиллагааны үр дүнд нийгмийн эх үндэс болох гэр бүлийн бат бэх байдлыг хангах, гэрлэлт цуцлалтыг багасгаж, улмаар гэр бүл, хүүхдийн эрх ашгийг хамгаалах зорилгод хүрэх томоохон алхам болох юм.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ТӨРИЙН АЛБАНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТҮҮХЭН ТОЙМ, ШИНЭТГЭЛ, ТҮҮНИЙ АГУУЛГА[316]

ОРШИЛ

Төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны хууль болон **төрийн жинхэнэ албан хаагчийн** эрх зүйн байдлын талаарх бусад хуулийг харьцуулан судлахад оршино.

Үүний тул дараах зорилтыг дэвшүүлэн ажиллана. Үүнд:

- Монгол Улсын төрийн албанд холбогдох эрх зүйн актыг 1911-1921 он хүртэл түүвэрлэн гаргах;
- 1921-1940-1960 он хүртэлх үеийн Төрийн албаны хууль тогтоомж дахь төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, залгамж холбоог гаргах, шинжлэн судлах;
- 1960-1990, 1992-1994, 1994-2002 оны үеийн төрийн албаны хууль тогтоомж дахь төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, залгамж холбоог гаргах, шинжлэн судлах;
- 1990-1992 /завсрын үеийн/ болон 1994 оны Төрийн албаны тухай хууль /1992-1994 оны Үндсэн хууль-Төрийн албаны тухай хууль/-ийн шинэтгэл, ялгагдах онцлогийг тухайлан судлах;
- Монгол Улсын Төрийн албаны тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлт. 2002 оны шинэчилсэн найруулгын агуулга, ялгагдах байдал;
- Төрийн албаны тухай хуульд 2008 оны 5 дугаар сарын 6-ны өдөр орсон нэмэлт, өөрчлөлтийн гол утга агуулгад дүн шинжилгээ хийх;
- Төрийн жинхэнэ албан хаагчийн эрх зүйн байдлын талаарх /1994 оноос хойшх/ тусгайлсан судалгаа гаргах;
- АНУ, ХБНГУ, Япон, ОХУ-ын төрийн албаны эрх зүйн зохицуулалт.

[316] Тус секторын 2010 оны төлөвлөгөөт судалгаа болно.

НЭГ. ТҮҮХЭН БАЙДЛЫН ТОЙМ /1911-1992 он хүртэл/

1.1.1911-1921 ОНЫ ҮЕИЙН ТӨРИЙН АЛБАНЫ ХӨГЖЛИЙН ТОЙМ

Монголчууд 2200 гаруй жилийн төр, эрх зүйн хөгжлийн түүхтэй ард түмэн билээ. Монгол Улсын эрх зүйн хөгжлийн үечлэлийг, өөрөөр хэлбэл эрх зүйн тогтолцооны бүрдэлт, хөгжилтийг Монголын нэгдсэн улс байгуулснаас хойш үзвэл:

1.Монголын тулгар төр байгуулагдаж, нийт үндэстний эрх зүйн тогтолцоо бүрэлдэн төлөвшин тогтсон үе /1206-1634 он/;

2.Эрх зүйн 2 дахь төрөлжүүлэлт хийгдсэн үе /1640-1921 он/;

3.Орчин үеийн эрх зүйн тогтолцооны үүсэл, хөгжлийн үе /1921 оноос өнөөг хүртэл/ гэсэн үндсэн 3 үе шатанд авч үзэж болох юм[317].

Бид судалгаагаа Монгол оронд өрнөсөн **үндэсний эрх чөлөөний хувьсгал**, түүнээс хойших үеийг хамруулан тоймлон судалж байгаа болно.

Төрийн алба одоогийн бидний хэлж байгаагаар **засаглалын хэлбэр буюу удирдлагын хэлбэртэй холбоотой юм**. Тухайн улсад **улс төрийн ямар дэглэм ноёрхож байгаагаас шалтгаалж төрийн алба өөр өөр утгатай** байдаг. **Хаант засагтай оронд хааны төлөө алба, бүгд найрамдах засагтайд нь нийтийн алба буюу нэг хүний төлөө бус алба** гэзд **мөн чанарын хувьд өөрчлөгдсөн** түүхтэй.

Манай улсын хувьд төрийн алба нь эртнээсээ хаант засагтай **байсан учир эзний алба болж үүссэн** түүхтэй. Өөрөөр хэлбэл **эзэн хаан хийгээд түүний шадруудын төлөө, түүний бие төлөөлөгч болох аймаг, хошуудын засаг ноёдын төлөө** байжээ[318]. **1924 оноос л төгсгөл болсон**. Энэ хүртэл **манай төрийн алба хааны төлөө, засаг ноёдын төлөө алба гувчуур татах зэргээс тэдний ноёрхлыг хамгаалж хангахад чиглэсэн байв**. Мэдээж улс орны тусгаар тогтнол, хил хязгаар, аюулгүй байдлаа хамгаалах гэсэн ард түмний тэмцэл байсныг үгүйсгэж болохгүй. **Гэхдээ л эцсийн эцэст төрийн алба гэдэг нэг хүний төлөө л байсан**[319].

1911 онд өрнөсөн үндэсний эрх чөлөөний хувьсгал нь Монголын эрх зүйн хүрээнд үндэсний шинжтэй өөрчлөлт шинэчлэлт хийх нөхцөлийг бүрдүүлсэн юм. Монголд шинэ тулгар тогтсон **төр нь хэлбэрийн хувьд шашин-төрийг хослон барьсан хамжлагат ёсны-хэмжээгүй эрхт хаант төр** байв. Шинэ тулгар Монгол Улсын хэмжээгүй эрхт хаан бол VIII Богд Жибзумдамба хутагт байв. Тэрээр Чин ван Ханддорж, Да лам Цэрэнчимэд нарын үүсгэн санаачилсан их хэргийг идэвхтэй дэмжиж, 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалд тэргүүлэх үүрэгтэй оролцсон юм[320].

Энэ үеийн **хууль зүйн гол эх сурвалж нь** 65 дэвтэрээр эмхтгэсэн "**Зарлигаар тогтоосон Монгол Улсын Хууль зүйлийн бичиг**" /ЗТМУХЗБ/ байсан. ЗТМУХЗБ-ийг 1913 оноос боловсруулж дагаж шийтгүүлж байсан[321]

---

[317] Ж.Амарсанаа. Ардчилсан эрх зүйт ёс. УБ., 2010 он. 4 дэх тал.

[318] Төрийн захиргаа сэтгүүл. "Б.Чимид. Хуулийн биелэлтийг зохион байгуулах үүрэг бол төрийн албаны үйл ажиллагааны амин сүнс юм даа". Тусгай дугаар. Уб., 2010. 6 дахь тал.

[319] Төрийн захиргаа сэтгүүл. "Б.Чимид. Хуулийн биелэлтийг зохион байгуулах үүрэг бол төрийн албаны үйл ажиллагааны амин сүнс юм даа". Тусгай дугаар. Уб., 2010. 5 дахь тал.

[320] Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан. Монголын төр, эрх зүйн түүхэн уламжлал. Уб., 1997 он. 175 дахь тал.

[321] Монголын төр, эрх зүйн түүх /Дээж бичиг/. V дэвтэр. Эрхлэн хэвлүүлсэн Б.Баярсайхан нар. Уб., 2010

гэсэн бол зарим судлаач нар 1915-1918 онд зохион эмхтгэн бэлтгэж, Улсын Дээд, Доод хурлаар хэлэлцүүлж, Богд хааны зарлигаар батлуулсан[322] гэжээ. Энэ хууль цаазад анх удаа төрийн байгууллагуудын бүтэц, эрх хэмжээ, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага, түшмэлийн зэрэг дэв, цалин пүнлүү зэрэг асуудлыг нарийвчлан зохицуулсан юм.[323]

ЗТМУХЗБ-т орсон хуулиудыг нийгмийн харилцааны олон тал, эрх зүйн харилцааны объектоор төрөлжүүлбэл, Хаант Монгол Улсын төрийн байгуулалд хамаарах 6 дэвтэр, **төрийн захиргааны асуудлыг хөндсөн 9 дэвтэр**, ..., ..., цэргийн харилцааг зохицуулсан 3 дэвтэр, ..., ... гэх зэрэг байна.

Энэ үеийн төрийн алба нь тухайн үеийн дорно дахины[324] хэв шинжийг агуулсан гэж үзэж болно. Төрийн бодлогодоо хоёр ёсны онолыг тусган илэрхийлж байсан ба Богд Жибзумдамба шашин төрийг хослон барьсан Улсын хаан болгон өргөмжилсөн учир түүний нөлөө их байжээ. Энэ үеийн төрийн байгууллагын бүтцийг схем зургаар үзүүлбэл[325]:



гэсэн бүтэцтэй байв.

он. 6 дахь тал.

[322] Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан. Монголын төр, эрх зүйн түүхэн уламжлал. Уб., 1998 он.

[323] Б.Баярсайнхан. Хууль зүйн тайлбар толь /Монголын төр, эрх зүйн түүх/. Уб., 2003 он. 83 дахь тал

[324] Н.Лүндэндорж. "Төрийн онол". Уб., 1995 он. 93 дахь тал; Мөн Ц.Сарантуяа. "Төрийн ерөнхий онол". Уб., 1998 он. 84 дэх талд "Дорно дахины төр ёсны ... нэг онцлог бол "шашин, төр хоёр хослох явдал юм" гэж тер судлаачид үздэг.

[325] Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан. Монголын төр, эрх зүйн түүхэн уламжлал. Уб., 1998 он. 179 дэх тал; Монголын төр, эрх зүйн түүх /Дээж бичиг/. V дэвтэр. Эрхлэн хэвлүүлсэн Б.Баярсайхан нар. Уб., 2010 он. 32-38 дахь тал; ЗТМУХЗБ-ийн Тэргүүн дэвтэр. Бүгдийн хууль дэвд. 2-32 дахь тал.

* Хэргийг бүгд эрхлэн шийтгэх

** Бүгд захиран шийтгэх

ЗТМУХЗБ-ийн Хоёрдугаар дэвтэр, Бүгдийн хууль Дундад: Бүх яамны сайд /дотоод, гадаад, цэргийн хэргийн, сангийн, шүүн таслах, улсын хурлын яамны, Улиастайн, Ховдын, Хиагтын сайдын/, түшмэл, бичээч, олон харьяат ардын тооны ор.[326] Жишээ нь Дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яамны айлтгаж тавих тэргүүн сайд 1 ор, дэд сайд 2 ор, дэс түшмэлийн зэрэг ёслолыг удирдагч түшмэл 1 ор, харьяат яамнаас эрхэлж тохоох эх бичиг зохиогч түшмэл 6 ор, эх зохиогч·түшмэлийн зэрэг ёслолыг удирдагч түшмэл 1 ор, жинхэнэ бичээч 12 ор, яамны сав хэрэглэлийг эрхэлж сахих нярав 1 ор, хаалганы дарга 1 ор, зарлага 5 ор, хаалга сахигч 4 ор, галч 4 ор байгуулагтун гэх мэтээр 9 яамны орон тоог зааж өгсөн байна.

ХЗБ-ийн Гуравдугаар дэвтэр, Бүгдийн хууль Доодод: Богд хаанаар толгойлуулсан автономит засгийн газар Бүгд ерөнхийлөн захирах яам / засгийн газар/, олон яам, хэлтсийн эрхлэн шийтгэх хэргийг тусгасан.[327] Үүнд: Дотоод хэргийн сайд, дэд сайд аливаа дотоод засгийн үндсэнд холбогдох хэргийг эрхлэн шийтгэнэ. Түшмэл, ёслол, төв 3 хэлтэс бий. Эрхэлсэн, дэс түшмэл 3 хэлтсийн хэрэг зүйлийг нэгэн адил хянан үзэж шийтгэнэ. Төвийн түшмэлийн, тоо бүртгэлийн, өртөөний зэрэг хэлтсүүдтэй байсан ба албан тушаал, зэрэг хэргэм олгох, хүн ам, малын тоо бүртгэл, өртөө, ёслолын зэрэг ажил эрхэлдэг. Мөн монгол, орос хэл бичгийн сургууль, цахилгаан мэдээний сургууль, хэвлэлийн хороо, өртөө харуулын зэрэг газрууд захирагдаж байсан эрхийн талаар бусад яамдаас илүү байжээ.

ХЗБ-ийн Дөрөв, тавдугаар дэвтэр, Зэрэг залгамжлах нь Дээд, доод

Таван яамны сайд нарыг хаан сонгож хэрэглэнэ. Дэд сайд, эрхэлсэн, дэс түшмэлийг тэргүүн сайдууд сонгож батлан айлтгаад зарлигаар тавина. Эх бичиг зохиогчоос доош түшмэлийг анх удаа сонгоход өөр өөрийн яамны бичээчээс дэвшүүлэн хэрэглэх, эсвэзс олон хошуу шавийн газраа албан хааж хэрэг өнгөрүүлсэн нэр гарсан, түшмэл буй бөгөөс жил хуучин эндэгдэлгүй төв чигч байдлыг үзэж ор хүлээлгэнэ. Тушаалыг чадваас жинхэнэ оронд тохоон тавигтун гэжээ.

Энэ байгууллагад ажиллах төрийн албан хаагчийн эрх хэмжээ, цалин пүнлүүг зохицуулсан. Гэхдээ тэдгээрийн хэргэм зэргээс хамааран цалинг ялгамжтай ногдуулдаг байсан нь нэг талаас албаны зиндааг тодорхойлж байгаагаас гадна, тэдгээртэй холбоотой аливаа гэмт үйлдэл гарахаас урьдчилан сэргийлсэн шинжтэй болов уу.

Монголчууд эртнээс төрийн өмсгөл хэрэглэлийн тухай тусгай хууль гарган зохицуулдаг байсан.[328] Энэхүү хуулиар тогтоосон цалин хүртэхээс гадна өөрийн зэрэг дэвийг ялгасан хувцас хэрэглэлтэй байж түүнийг жилийн 4 улирал, төрийн ёслолын арга хэмжээний зэрэглэлээс хамааран хэрэглэж байхаар зохицуулсан байна. Мөн тэдгээр өмссөн хувцасны өнгө, хээ, дэг

[326] Монголын төр, эрх зүйн түүх /Дээж бичиг/. V дэвтэр. Эрхлэн хэвлүүлсэн Б.Баярсайхан нар. Уб., 2010 он. 39-40 дэх тал.

* Хэргийг бүгд эрхлэн шийтгэх

** Бүгд захиран шийтгэх

[327] Монголын төр, эрх зүйн түүх /Дээж бичиг/. V дэвтэр. Эрхлэн хэвлүүлсэн Б.Баярсайхан нар. Уб., 2010 он. 42-43 дахь тал.

[328] Б.Баярсайхан. "Монгол цаазын бичиг"-т хийсэн эрх зүйн судалгаа. Уб., 2005 он. 91 дэх тал.

маягаас хамааран бие биедээ хүндлэл үзүүлэхээс гадна төрийн эрхэмсэг байдлыг илтгэн харуулдаг эрх зүйн үндсийг тогтоож өгчээ.

Төрийн албан хаагчийн хэргэм зэрэг дэв дэс нь албан тушаалын хэлбэрээс шууд хамааарч байсан бөгөөд түүнийг ЗТМУХЗБ-ийн хэм хэмжээний хүрээнд авч үзье. Зургадугаар дэвтэр /Түшмэл байгуулах тушаал хууль/-т: Төрийн албанд авах ерөнхий болзол болох эрдэм чадал, сахилга бат, ажил хэргийн байдал, төлөв, насыг тус тус зохицуулсан. Тэргүүн сайдууд харьяат түшмэдийнхээ ажилд байнгын хяналт тавьж байх үүрэгтэй бөгөөд шалгах ажилд тэргүүн сайдууд хамт нийлж шалгуулах түшмэдийн нэрсийг гарган, улс орны байдалд холбогдох чухал сэдвээр 1 хуудас зохион бичлэг хийлгэж шалгахыг хуульчилж өгчээ. Түшмэлийг шалгахдаа гол үнэлэлт өгөх "чухам шалгах" 4 гол зүйлийг анхаарч байжээ. **Манжийн ноёрхлын үед төрийн түшмэлийг сонгохдоо** гол төлөв **эзэн хаандаа үнэнч эсэхийг гол шалгуур болгодог байсан** бол **Богд хаант төрийн хуулиар олон яам, нутгийн захиргааны түшмэдүүдийг эрдэм, сахилга, хэрэг /ажил/, нас мэдлэг, авъяас чадвар, ноён нуруу гол болгон** нягтлан шалгаж дэвшүүлэх ёстойг хуульчлан тогтоож өгсөн байна[329]. Тухайлбал, Долдугаар дэвтэр. Шалгаж байцаах нь. Угаас эрдэм илүү, сахилга ариун, хэрэгт хичээнгүй, нас идэр залуу, эсвээс тэнхлүүн, тушаалыг чадахыг нь тэргүүн зэрэг шалгарсанд болгоно. Эрдэмд зэрэг, хэрэг зэрэг тушаалд эндэгдэлгүй, хичээнгүйг болгоомжтойг дэд зэрэг шалгарсанд болгоно. Эрдэм сахилга, хэрэгт зэрэг, нас залуу тэнхлүүн тушаалд энгийн зэрэг явахыг нь гуравдугаарт зэрэгт болгож уг тушаалд хэвээр агуулна.

Мөн түшмэл хүний үл тэвчих 8 зүйлээр буруутгаж байсан. Үүнд: 1/ховдог, 2/харгис 3/зөөлөн үхээнц, 4/чадалгүй, 5/хичээнгүй бус, 6/өвчтэй, 7/долгин хатан, 8/эрдэм дорой явдал хэмээн тодорхойлж буруушаах зэргээр тодорхой хэлэлцэж, дэвшүүлж, бууруулах асуудлыг шийдэж байсан байна. Тухайлбал, Эрдэм дорой долгин хатныг нь зэрэг бууруулж улиран хэрэглэх эсвээс бууруулсан зэрэгтэй өөр тушаалд халж тавина. Зөөлөн үхээнц чадалгүй хичээнгүйг түшмэлийн түнлүүг зогсоож дахин шалгах жил хүрүүлэн дараа удаа эс орвоос түшмэл эвдэнэ. Нас хөгшин, өвчтэйг нь түшмэл суулгахгүй гэрт илгээнэ гэх мэтээр зохицуулсан байна[330].

Яамдын дэс түшмэлээс доошх түшмэдийг хууль ёсоор **3 жилд 1 удаа байцаан шалгаж дэвшүүлэх, бууруулах, тушаалд нь хэвээр байлгах зэргийг шалган тогтоохоор** заажээ.

Монголын хаант улсын хуулиар түшмэлийн дагаж мөрдөх зүйл зөрчвөл авах арга хэмжээг нарийвчлан заасан. Жишээ нь: албаны хэргийн учир ял халдвал засгийн түнлүү хасах, засгаас өөрчлөгдвөл түнлүүний мөнгийг жил хувааж үл суутгуулах, хулгай хийсэн тайж нарын харьяалах засгийг ялган салгаж түнлүү хасах, аливаа ард хулгай хийвэл тэднийг захирах тайж, сумын занги, отгийн даргыг ялган салгаж ес торгох, малын тогтоосон тоо, ялд авсан малыг албанд хадгалж шагнахад бэлтгэх, жүжиг тавихыг цаазлах, нийслэл хүрээнд ирж харилцан заалдахыг хууль ёсоор хүндрүүлж ял торгох олон хэм хэмжээ тогтоожээ/Түшмэлийн засаг, дөрөвдүгээр хэмээх хуульд үзнэ үү/. Эдгээрээс заримыг сийрүүлбэл: Нэгэн зүйл, Аливаа харц, албат хуяг ардууд хулгайн хэрэг халдвал харьяат захирах тайж сумын занги отгийн даргыг хууль ёсоор ялган салгаж ес торго. Хэрэв тогтоосон малыг үнэхээр

[329] Монголын төр, эрх зүйн түүх /Дээж бичиг/. V дэвтэр. Эрхлэн хэвлүүлсэн Б.Баярсайхан нар. Уб., 2010 он. 64-65 дахь тал;

[330] Дээрх номын 64-65 дахь талаас дэлгэрүүлэн үзнэ үү.

бүрэн тушаах хөрөнгө чинээгүй бол ес торгох тогтоосон хугацааны хууль ёсоор шийтгэхтүн гэжээ. Энэ хууль нь Монголын автономийг устгаснаар үйлчилж чадаагүй юм[331].

1.2. 1921-1960 ОНЫ ҮЕИЙН ТӨРИЙН АЛБАНЫ ХӨГЖЛИЙН ТОЙМ

1921 оны Монголын үндэсний ардчилсан хувьсгалын дараахан үеэс тухайн цаг үеийн нөхцөл байдалд нийцүүлэн Ардын Засгийн газраас төв, орон нутагт төрийн аппаратын үндэс болох Ардын Хурлуудыг байгуулах арга хэмжээ авч энэ талаар Засгийн газрын төлөөлөгчдийн дүрэм[332], Улсын түр цагийн дүрэм, Ардын Засгийн газар ба Богд хоёрын хооронд байгуулсан Тангарагийн гэрээ, хууль цааз зохиох тухай тогтоол, Монгол Улсын Нутгийн захиргааны дүрэм, засаг ба засаг бус ван, гүнгүүдийн эрх хэмжээний дүрэм[333] зэргийг баталж тэдгээрээр ардын хурлуудыг байгуулах ардчилсан журам, зохион байгуулалт үйл ажиллагааны зарчим, үүрэг зорилтыг тогтоож өгчээ.

1921 оны 7 дугаар сарын 23-нд Ардын Засгийн газраас гаргасан тогтоолд хаанаы эрхийг хязгаарлаж, эрх мэдлийг өөртөө төвлөрүүлсэн билээ.

Тангарагийн гэрээгээр "Богд хаан Жибзумдамба хутагт шарын шашны Богд эзэн болох тул улс төрийн хэрэгт холбогдолгүй, шашны бүх хэргийг хязгааргүй эрхэлбэл зохино. Хууль дүрмийг Ардын Засгийн газраас үүсгэн зарлахад Богд хаанд сонсгон айлтгаж ёсоор явуулах тул энэ мэт хууль дүрмийг Богд хаантан үл зөвшөөрөх ба эвдэж үл болно"[334] хэмээн Ардын Засгийн газар, Богд хаан хоёрын харилцан үүрэг, хэм хэмжээг тогтоосон байна.

Үндсэн хууль батлахын өмнө Монгол Улс нь 1921-1924 онд "Монгол Ардын Түр Засгийн газрын дүрэм" /1921.04.23/; "Засгийн хэргийг бүгд түр захиран шийтгэх газраас Монгол газраа суулгах төлөөний түшмэдийн дагаж явах дүрэм хэмжээ" /1921.04.28/; "Монгол олон газар суулгах төлөөний түшмэдийн дагаж явах дүрэм буюу засгийн газрын төлөөлөгчийн дүрэм" /1921.06.03/; "Засгийн газрын 11-р хурлын дүрэм"[335] /1921.07.11/; "Улсын түр цагийн хурлын дүрэм" /1921.09.20/; "Тангаргийн гэрээ дүрэм" /1921.11.01/; "Монгол Улсын нутгийн захиргааны дүрэм" /1921.03.05/; "Монголын засаг ба засаг бус ван, гүнгүүдийн эрх хэмжээний дүрэм" /1922.03.22/; "Засгийн газрын төлөөлөгчийн дүрэм[336]" /1922.09.20/; "Монгол Улсын Нутгийн

[331] И.Майский. Современная Монголия Иркутск. 1921 г. С.331.

[332] Засгийн газрын төлөөлөгч гэдэг нь Ардын Засгийн газраас тус засгийн гол бодлогыг олон харьяат газар оронд нэвтрүүлэн нэгттгх ба дэлгэрүүлэн удирдах явдлыг чухал болгохын тулд тусгай төлөөлөгчдийг зохих газруудад хуваан суулгана. Төлөөлөгч суулгах газрыг тухай бүр засгийн газар хянан тогтооно.

[333] Арван гэрээс дээш баг, сум, хошуу, аймаг, улсын засгийн газар хүртэл тус тусын ардын төлөөлөгчдийг сонгон хуралдуулж, дэс дараалан хурал байгуулан, элдэв хэрэг зүйлийг шүүмжлэн хэлэлцүүлж, олонхийн саналаар таслан тогтоож, ардын эрхийг эрхэмлэн хүндэтгэвэл зохино.

[334] БНМАУ-ын Үндсэн хууль түүнд холбогдох зарим актын эмхтгэл. Уб., 1972 он. Ардын Засгийн газар ба Богд хоёрын хооронд байгуулсан Тангарагийн гэрээ. Дөрөвдүгээр зүйл.

[335] Энэхүү хурлын бичиг нь олон ямны албан хаагчдын цалин лангийн хэмжээг тогтоожээ.

[336] БНМАУ-ын Үндсэн хууль түүнд холбогдох зарим актын эмхтгэл. Уб., 1972 он. 60-62 дахь тал. Дүрмийн 1, 3 дугаар зүйлд заасаар "Монгол Ардын Засгийн Газраас тус засгийн гол бодлогыг олон харьяат газар оронд нэвтрүүлэн нэгттгх ба дэлгэрүүлэн удирдах явдлыг чухал болгохын тулд тусгай төлөөлөгчдийг зохих газруудад хуваан суулгана. Төлөөлөгчийг сонгон томилоход засгийн бодлогыг гүйцдээр ухуулан нэвтрүүлж чадах, уул газар орны хэв суртлыг боловсон мэдэх, олны сананд үнэнээр нийлүүлэн чадах, эрдэм үзэл тэнцэх хүнийг эрхлэх газрын хуралд хэлэлцэн сонгон томилно" гэжээ. 4-14 дүгээр зүйлд эрх хэмжээг заажээ.

захиргааны дүрэм[337] /1923.03.22/"; "Аймгийн захиргааны дүрэм /1923.06.29/"; "Бүгд Найрамдах засаг тогтоон явуулах тухай Ардын Засгийн газрын тогтоол" /1924.06.13/; "Монгол Улсын Их Хурлын дүрэм" /1924.09.19/ гэх зэрэг[338] Үндсэн хуулчилсан актууд гарган төр улсаа төвхнүүлж анхны Үндсэн хуулиар Бүгд Найрамдах засгийг бэхжүүлэх хууль зүйн нөхцөл бүрдүүлсэн байдаг. Энэ бүхэн нийгэмд Үндсэн хуулийн шинэ ухамсар бүрэлдэхэд бодитой нөлөөлсөн нь мадаггүй билээ.

Ардын Засгийн газар хууль тогтоох, гүйцэтгэх засаглал төдийгүй, шүүн таслах эрхийг эдэлж байсан. Мөн Ардын Засгийн газар болон түүний анхны 5 яамыг байгуулснаар төрийн захиргааны төв байгууллагын тогтолцооны баттай эх суурь тавигдсан. Үүнд: Шүүх яам орон тоо 58, /ерөнхий, ял шийтгэх 2 хэлтэс/; Дотоод явдлын яам орон тоо 40 /сургуулийн хэлтэс/; Сангийн яам орон тоо 79 /цахилгаан гэрлийн хороо, гар тариаг, сангийн тариаг/; Цэргийн яам орон тоо 116 /их буу засах газар, булигаарын завод/; Гадаад яам орон тоо 35 /шуудан бичиг-цахилгаан, мэдээний ерөнхий хороо/ газруудыг хариуцуулж, дээрх тоогоор ажиллуулахаар тогтжээ. Мөн яам, газрын албан хаагчдын цалин хэрэглэлийн дүрмийн ёсоор яамдын тэргүүн сайдад сар бүр 80 лан, эрхэлсэн түшмэдэд 65 лан, бичээчид 40 лан, зарлагад 30 лан зэргээр ажлын ачаалал, хүлээх хариуцлагыг харгалзан цалин тогтоосон байна.

Батлан хамгаалах, зэвсэгт хүчний байнгын Монгол Ардын хувьсгалт цэргийг байгуулсан. Мөн Дотоодыг хамгаалах газар, Сэргийлэх цэрэг нэртэйгээр шинэ төрийн цагдаагийн байгууллагын эх үндсийг тавьсан.

Монголын ард түмэн 1924 онд Улсын анхдугаар Их Хурал БНМАУ-ын анхдугаар Үндсэн хуулийг санал нэгтэй баталж **"Бүх Монгол Улсыг үүнээс хойш Бүгд Найрамдах Бүрэн эрхтэй Ард Улс гэж Улсын дээд эрхийг жинхэнэ ардад эзлүүлэн улсын аливаа хэргийг Улсын Их Хурал ба мөн хурлаар сонгогдсон Засгийн газраас гүйцэтгэн шийтгүүлэх явдлыг нийтээр сүсэглэн дагавал зохино**"гэж тунхагласан нь **Монголын шинэ эрх зүйн суурь, анхны гол хууль болсон юм.**

[337] БНМАУ-ын Үндсэн хууль түүнд холбогдох зарим актын эмхтгэл. Уб., 1972 он. 65-75 дахь тал. Нэгдүгээр дүгээр зүйлд: Бидний Монгол Улс нэгэнт ардын эрхт хэмжээт цаазат улсын засгийг байгуулсны тулд 10 гэрээс дээш баг, сум, хошуу, аймаг, улсын засгийн газар хүртэл тус тусын ардын төлөөлөгчдийг сонгон хуралдуулж, дэс дараалан хурал байгуулан, элдэв хэрэг зүйлийг шүүмжлэн хэлэлцүүлж, олонхийн саналаар таслан тогтоож, ардын эрхийг эрхэмлэн хүндэтгэвэл зохино. Гуравдугаар зүйл: Улсын ба аймаг, ... 10 гэрийн даргад хүртэл аливаа албан тушаалтан буюу тус бүрийн хурлын төлөөлөгчдийг сонгоход цөм эрх биш ард олны зовлон зүдгүүр нэвтэрхий мэдэх, олны тусыг бодох цэвэр шударга, бичиг үсэгт боловсронгуй, өөр өөрийн оролдсон зүйлийг магадаар бүтээн чадах хүнийг сонговол зохино. 10 гэрийн дарга бичиг үсэгт боловсроогүй ч шударга хүн байх бол сонгож болно". Дөрөвдүгээр зүйлд: "Дээрх тушаалтан ба төлөөлөгчийг сонгоход харьяат хурлын гишүүд дэмий ноёд, ураг төрлийн нүүрчлэх ба эзэрхэг харгисын сүрээс айх ба эд ашигт шунах зэргээр зусарч бялдууч, ховдог авлигач, хааш яйш хүнийг сонговол сонгосон сонгогдсон 2 этгээдийг хууль ёсоор хүндэд яллан уул тушаалын орыг өөр сонгуулна" гэжээ. Нэгж тус бүрийн дүрмийг тусгажээ.

[338] Төрийн албаны харилцаанд холбогдох түүхэн эрх зүйн актыг Хавсралтаас үзнэ үү.

Ардын төрийн тогтолцоо /1924/:



Энэхүү хуулиар:

- Шашин төрийг хослон барьсан **хэмжээгүй эрхт хаант засгаас ардын эрхт хэмжээт цаазат хаант засаг**, түүнээс **Бүгд Найрамдах засаг**т дэвшин орсон нь төрийн байгууллын хувьд яах аргагүй нэн чухал дэвшил болсон.

- Монголын **төрийн байгууллагуудын /Их, бага хурал, түүний Тэргүүлэгчид, Засгийн газар, яамд гэсэн/ шинэ тогтолцоог** бэхжүүлсэн;

- Монгол оронд анх удаа парламентат ёсыг хэрэгжүүлж УИХ, УБХ-ыг байгуулсан билээ[339]. Тус хуульд "БНМАУ-ын дээд эрхийг УИХ хадгалах бөгөөд, мөн хурлын чөлөөт цагт Улсын Бага Хуралд хадгалуулах, бас хурлын чөлөөт цагт Бага Хурлын Тэргүүлэгчид ба Засгийн газрын дунд хадгалуулбал зохино"[340] хэмээн төрийн эрх мэдлийг хуваарилсан байна.

- Монгол Улсын Засгийн газар нь бол тус улсын ерөнхийлөн захирах газар мөн бөгөөд гишүүд нь Ерөнхий сайд, жинхэнэ, орлогч сайд, бүх цэргийн ба эдийн засгийн зөвлөлийн тэргүүлэгчид, бүх цэргийн жанжин, Улсын хянан байцаагч, Дотоод, гадаад, санхүү, аж үйлдвэр, шүүх, ардыг гэгээрүүлэх яамны сайдууд болно. Засгийн газар нь тус газрын эрхлэн шийтгэх зүйлүүдийн **дүрэмд дурдсан аливаа хэргийг гүйцэтгэн явуулбал зохино**[341].

-Төрийн байгууламжийн нэгдмэл хэлбэрийг тогтоож, нутгийн захиргааны 5 шатат тогтолцооны /10 гэр, баг, сум, хошуу, аймгийн/ үндсийг бэхжүүлсэн;

Анхдугаар Үндсэн хуулийг залгамжилсан Үндсэн хуулийг 1940 оны 6 дугаар сарын 30-нд БНМАУ-ын Улсын VIII Их Хурал баталсан.

1940 оны Үндсэн хуульд оруулсан **хамгийн том нэмэлт өөрчлөлт бол** нийтийн биш, тэгш бус, олон шатат ил сонгуулиас нийт, шууд, тэгш эрхийн үндэслэл дээр саналаа нууцаар гаргах **сонгуулийн шинэ зарчмыг тунхаглаж төрийн төв, орон нутгийн байгууллагын тогтолцоог дорвитой**

[339] Ж.Болдбаатар, Д.Лүндэзжанцан. Монголын төр, эрх зүйн түүхэн уламжлал. Уб., 1998 он. 229 дэх тал.

[340] Монгол Улсын Үндсэн хууль. Эмхтгэсэн Ж.Амарсанаа нар. Уб., 2004 он. 44 дэх тал.

[341] Монгол Улсын Үндсэн хууль. Эмхтгэсэн Ж.Амарсанаа нар. Уб., 2004 он. 46 дахь тал.

өөрчилсөн заалт юм. Үндсэн хуульд Улсын IX Их Хурлаас оруулсан энэхүү нэмэлт, өөрчлөлтөөр анх 95 зүйлтэй Үндсэн хууль 108 зүйлтэй болж томорсон бөгөөд хэдийгээр нэг намын залууураар хэлбэрдэлд орсон ч гэсэн сонгуулийн ардчилсан зарчмын үзэл санааг Монголд нэвтрүүлсэн ач холбогдолтойг тэмдэглэх нь зүйтэй болов уу[342].

1940 оны Үндсэн хуулийн зорилго, төр-нийгмийн байгууллын үндсэн зарчмын хувьд **социалист маягийн хууль** мөн. Үүнийг дараах нийтлэг шинж буюу шалгуураар нотлон харуулж болно.

Нэгдүгээрт: Үндсэн хуулиар тогтоосон үндсэн зарчим:

1/ Нийгэм журам байгуулах, социализмын бүрэн ялалтыг хангах гэсэн агуулгатай/;

2/ засаг төрийн нийгэмшлийн үндэс нь малчин, ажилчин, оюутан /сэхээтэн/;

5/ "улс нийгмийн бүх байгууллагыг удирдах гол хүч нь МАХН мөн";

6/ төрийн эрх барих ба захиргааны байгууллага нь дээрээс доош төвлөн захирч, доороос дээш ажлаа хариуцан тайлагнадаг бөгөөд бүхэлдээ нам, АИХ-д хянагдах 4-5 дэд тогтолцооноос бүрдсэн;

7/ орон нутаг нь мөн дан ганц төрийн удирдлагатай;

8/ Үндсэн хууль болон нийтийн засаг захиргааны байгууллагын үйл ажиллагаа шүүхийн хяналтаас гадуур үлдсэн зэргийг дурдаж болно.

1949 он хүртэл бүгд 9 удаа хуралдсан Улсын Их Хурал; түүнийг чөлөөт цагт Улсын Бага Хурал; түүний чөлөөт цагт Бага Хурлын тэргүүлэгчид; 1949 /51/. 1932-1956–Ардын Сайд нарын Зөвлөл; 1956-1990 онд –Сайд нарын Зөвлөл /СнЗ/ хэмээн нэршиж байв.

1940 оны 6 дугаар сарын 30-нд шинэчлэн баталсан БНМАУ-ын Үндсэн хуулийн 95 дугаар зүйлд **МАХН-ыг «...Улс нийгмийн бүх байгууллагыг удирдах гол хүчин болох»**-ыг бататган заажээ. Энэ нь Монгол Улсад нэг намын /монополь/ онц эрхийг хуульчлан тогтоосон хэрэг байв[343].

1949 онд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж тогтоосон социалист маягийн сонгуулийн тогтолцооны ёсоор Ардын Их Хурлын ээлжит сонгуулийг 1951-1986 онд нийтдээ 11 удаа явуулжээ. Энд «Эрх баригч» нам ба нам бусчуудын эвслээс нэг тойрогт зөвхөн нэг хүний нэр дэвшүүлж / **өрсөлдөгчгүй/ *сонгох журамтай байв.***

1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгал болон 1921 оны хувьсгалын өмнөх Монголд гүйцэтгэх засгаас тусдаа шүүх үндсэндээ байгаагүй. 1921-1926 онд Ардын засгийн шүүх явдлын яам, 1923 оноос хошуудын Тамгын газрын зарга шийтгэх хэлтэс шүүн таслах ажил эрхэлж байв. Иймд анхны Үндсэн хуульд шүүхийн тухай заалт байхгүй. Шүүх анх Улсын II Их Хурлаас 1925 онд баталсан тогтоол дүрмийн дагуу 1926-1927 оны заагаар байгуулагдаж эхэлсэн. Тэр үеэс л нам, засгийн хяналтад, Шүүх явдлын / одоогийн хууль зүйн/ яамны удирдлагад ажиллаж эхэлсэн. 1930-аад онд УДШ, УПГ хоёр шүүх яамны хоёр газрын статустай байв[344].

---

[342] Монгол Улсын Үндсэн хууль /баримт бичгийн эмхтгэл. Ж.Амарсанаа, О.Батсайхан/ Уб., 2004 он. 16 дахь тал.

[343] БНМАУ-ын Үндсэн хууль. 1940 он, 95 дугаар зүйл.

[344] Б.Чимид, ... нар. Монгол Улсын Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн тойм. Уб., 2010 он. 40 дэх тал.

1940 оны Үндсэн хуульд БНМАУ-д шүүн таслах ажлыг гагцхүү **шүүх** хэрэгжүүлнэ гэж заасан боловч их хэлмэгдүүлэлтийн үед Онц бүрэн эрхт комисс зэрэг шүүхийн бус байгууллага уг үүргийг гүйцэтгэж байсан үе бий. Ардчилалд шилжихийн өмнөх үеэс өгүүлбэл 1960 оны Үндсэн хуульд зааснаар шүүхүүд бүх үйл ажиллагаандаа өнгөндөө ардчилсан зарчмууд баримталж байсан мэт боловч захиргаадлын зэвсэг болж байсан ба шүүхүүд сонгуулиар зохих хурал ба иргэдээс байгуулагдах зарчимтай[345] байв.

Өмнөх тогтолцооны үед Улсын дээд, тусгай, аймаг, хотын болон хэсгийн /дүүргийн/ шүүх гэсэн нэгдмэл "босоо" тогтолцоо, бүхэлдээ намын хяналт, Ардын Их Хурал, Засгийн газрын нөлөөнд оршин ажиллаж байв.[346]

Прокурорын газрууд анх зохих шүүхийн дэргэд, Шүүх яамны харъяанд 1930 онд үүсэжд 1940 оноос бие дааж, нам, төрийн өмнөөс бүх байгууллага, албан тушаалтан, нийт иргэний үйл ажиллагаанд хяналт тавьдаг болсон. Хожим шүүхийг хүртэл хянаж, хэрэг зөрчилтэй тэмцэх талаар зохицуулдаг, төрийн байгууллагын бие даасан тогтолцоо болсон байна.

Төрийн эрх мэдлийг 3 салаанд хуваарилах шинэ тогтолцоонд шилжсэн хийгээд иргэдээ эх адаггүй хянах захиргаадлын дэглэмийг халсантай уялдуулан прокурорын хяналтын хүрээг ихэд хязгаарлаж шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцох болгон шинэчилсэн юм.

1940 оны Үндсэн хуульд "Бүх яамд ба төв, орон нутгийн албан байгууллагууд хийгээд тэдгээрийн харьяа газрууд, мөн албан тушаалын хүмүүс ба ард нийтээс хууль цаазыг нарийвчлан биелүүлж байгаа явдлыг байцаан хянах үүргийг Улсын прокурор /хууль сахиулагч/ гүйцэтгэнэ" гэж заасан байв. Тэр үеэс өмнөх тогтолцооны турш /1990-ээд он хүртэл/ прокурор одоогийн Үндсэн хуульд заасантай төстэй үүргээс гадна бусад дээр дурдсан "Ерөнхий хяналт" нэрийн дор төр, олон нийт, хоршоолол, аж ахуйн бүх байгууллага, албан газар, тэдгээрийн албан тушаалтан төдийгүй, нийт иргэний үйл ажиллагаанд хууль ёсыг хэрхэн биелүүлж буйг хянах бүхнийг хамарсан чиг үүргийг хэрэгжүүлэх болжээ[347].

1.3. 1960-1992 ОНЫ ШИЛЖИЛТИЙН ҮЕ ДЭХ ТӨРИЙН АЛБАНЫ ХӨГЖЛИЙН ТОЙМ

Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо:

БНМАУ-ын Үндсэн хуулиар хуульчлан бэхжүүлсэн ёсоор энэхүү систем нь

а/ төрийн захиргааны дээд байгууллага;

б/ төрийн захиргааны төв байгууллага;

в/ төрийн захиргааны орон нутгийн байгууллагууд гэсэн гурван хэсгээс бүрэлдэнэ.

Төрийн захиргааны дээд байгууллага нь БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл байсан бөгөөд СнЗ-ийн шууд удирдлаганд улс орны хэмжээнд төрийн

[345] БНМАУ-ын Үндсэн хууль. 66, 67, 68 дугаар зүйл. 1960 он. Ж.Амарсанаа, О.Батсайхан. Монгол Улсын Үндсэн хууль. Баримт бичиг. УБ., 259 дэх тал.

[346] Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал: Хүний эрх, шүүх эрх мэдэл /хоёрдугаар дэвтэр/. УБ, 2004. 118-123 дахь тал.

[347] Б.Чимид, ... нар. Монгол Улсын Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн тойм. Уб., 2010 он. 41 дэх тал

удирдлагын зохих салбар хүрээнд гүйцэтгэн захирамжлах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байгууллагуудыг төрийн захиргааны төв байгууллага гэдэг байв. Төрийн захиргааны төв байгууллагын тогтолцоонд БНМАУ-ын яам, улсын хороод, СнЗ-ийн дэргэдэх тусгай газрууд орж байв. 1960 оны Үндсэн хуулиар "Улсын яам, хороо, тусгай газрууд бол БНМАУ-ын төрийн захиргааны төв байгууллага мөн" гэж заажээ. Эдгээр байгууллага нь СнЗ-ийн удирдлаган дор тус тусын эрх хэмжээний дагуу улсын хэмжээнд гүйцэтгэн захирамжлах ажиллагааг хэрэгжүүлдэгээрээ төв байгууллагын нийтлэг шинжийг агуулах боловч эрх зүйн салбарын хувьд зохих ялгаа онцлогтой байна.

Тэдгээрийг ажиллах салбар, хүрээ, эдлэх эрх хэмжээ, үйл ажиллагааны онцлогоор нь:

а/яам;

б/Улсын хороо;

в/Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх тусгай газар гэсэн 3 төрөлд хуваагдаж байв.

БНМАУ-ын төрийн захиргааны дээд, төв байгууллага:

БНМАУ-ын 1960 оны Үндсэн хуулийн 3 дугаар бүлэг "Төрийн эрхийг барих дээд байгууллагууд" гэсэн бүлэгт А.БНМАУ-ын Ардын Их Хурал. 18 дугаар зүйлд "Бүгд Найрамдах Монгол Ард Улсын төрийн эрх барих дээд байгууллага нь Ардын Их Хурал мөн". БНМАУ-ын Ардын Их Хурлын Байнгын комисс, Ардын Их Хурлын Тэргүүлэгчид, Сайд нарын Зөвлөл, БНМАУ-ын дээд шүүх, Ардын Их Хурлын депутатууд нь хуулийн төсөл санаачлах эрх хэмжээтэй байжээ. Мөн хуулийн гучин долдугаар зүйлд зааснаар: БНМАУ-ын төрийн гүйцэтгэн захирах дээд байгууллага бол БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл мөн хэмээн тодорхойлон зааж өгчээ.

Сайд нарын Зөвлөл нь дагаж шийтгүүлж байгаа хуулиудыг үндэслэж, тэдгээрийг биелүүлэхийн тулд тогтоол, захирамж гаргаж гүйцэтгэлийг шалгана. /38 дугаар зүйл/

БНМАУ-ын тусгай газрын эрх баригчид төрийн захиргааны зохих салаа мөчрийн ажил төрлийг удирдаж тэдгээрийн байдал үйл ажиллагааны талаар Сайд нарын Зөвлөлийн өмнө бүрэн хариуцна.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл /Засгийн газар/[348] төрийн захиргааны дээд байгууллага юм. Сайд нарын Зөвлөл гагцхүү БНМАУ-ын Ардын Их Хурал, түүний Тэргүүлэгчдэд ажлаа хариуцаж тэдгээрийн хууль, зарлигийг биелүүлэх үндсэн дээр төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагыг нэгтгэн удирдах замаар улс орныхоо хэмжээнд төрийн гүйцэтгэн захирамжлах үйл ажиллагааг эрхэлдэг байна. БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тухай

[348] БНМАУ-ын Засгийн газар нь ардын хувьсгал ялахын өмнө буюу 1921 оны 3 дугаар сарын 13-нд байгуулагдсан "Монголын Ардын Засгийн Хэргийг Байцаах ба Түр Ерөнхийлөн Захирах газар" буюу Монгол Ардын Түр Засгийн газраас үүссэн түүхтэй. Ардын хувьсгал ялмагц 1921 оны 7 дугаар сарын 16-нд "Түр" гэсэн үгийг халж "Ардын Засгийн газар", 1924 онд батлагдсан анхдугаар Үндсэн хуулиар "БНМАУ-ын Засгийн газар" гэж тус тус нэрлэсэн байна. 1932 оны 7 дугаар сард болсон БНМАУ-ын 17 дугаар онц Бага Хурлаас тус улсын төрийн захиргааны төв байгууллагын системийг өөрчлөхийн хамт Засгийн газрыг Сайд нарын Зөвлөл гэж нэрлэжээ. Хожим 1992 оны шинэ Үндсэн хуулиар төрийн гүйцэтгэх эрх мэдлийг Засгийн газар хэрэгжүүлэхээр болсон билээ. Өөрөөр хэлбэл хуучин Сайд нарын Зөвлөлийн эрхлэх асуудал шинэ Үндсэн хуулиар Засгийн газарт шилжсэн билээ.

хуулийн 1 дүгээр зүйлд "БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл бол БНМАУ-ын төрийн гүйцэтгэн захирах дээд байгууллага мөн" гэж заажээ. 1960 оны Үндсэн хуульд заасан ёсоор Сайд нарын Зөвлөлийг БНМАУ-ын Ардын Их Хурлын ээлжит сонгууль бүрийн анхдугаар чуулганаас мөн Их Хурлын бүрэн эрхийн /5 жилийн/ хугацаагаар байгуулдаг. Сайд нарын Зөвлөл нь бүрэн эрхийнхээ хугацаа дуусмагц БНМАУ-ын Ардын Их Хуралд ээлжит сонгууль бүрийн анхдугаар чуулган дээр шилжүүлж мөн хугацаанд явуулсан үйл ажиллагааг хэлэлцүүлэн дүгнүүлдэг байна. Сайд нарын Зөвлөл ажлынхаа тухай Ардын Их Хуралд тогтмол тайлагнахын хамт түүний чуулганы чөлөө цагт Ардын Их Хурлын Тэргүүлэгчдэд хариуцан тайлагнадаг байна. Энэхүү зохицуулалт нь өнөөгийн Үндсэн хуулийн /1992 он/ 38 дугаар зүйл 38.1-д Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн. 41 дүгээр зүйл 41.2-д Засгийн газар үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд тайлагнана. гэж заасантай зохицуулалтын хувьд ижил юм. Сайд нарын Зөвлөлийн ажлын албыг Сайд нарын Зөвлөлийн Хэрэг эрхлэх газрын дарга толгойлох бөгөөд тэр нь Сайд нарын Зөвлөлийн гишүүн байна.

Сайд нарын Зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах асуудлыг Ардын Их Хурал, уг бүрэлдэхүүнд ордог албан тушаалтныг чөлөөлөх, нөхөн томилох асуудлыг Ардын Их Хурлын Тэргүүлэгчид дараа чуулганд оруулан батлуулахаар тус тус шийдвэрлэнэ.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн бүрэлдэхүүнд Сайд нарын Зөвлөлийн дарга, нэгдүгээр орлогч дарга, орлогч дарга, БНМАУ-ын сайд, Улсын хорооны дарга нар орно.

БНМАУ-ын яамд;

Улсын яамд, тусгай газрууд бол БНМАУ-ын төрийн захиргааны төв байгууллага мөн /Үндсэн хууль 1960 он. 43 дугаар зүйл/.

1988 оны байдлаар л гэхэд 17 яам Тухайлбал: Ардын боловсролын, Батлан хамгаалах, Байгаль хамгаалах, Гадаад явдлын, Нийгмийг аюулаас хамгаалах, Нийтийн аж ахуй, үйлчилгээний, Сангийн, Соёлын, Тээврийн, Холбооны, Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрийн, Хөнгөн үйлдвэрийн, Худалдаа бэлтгэлийн, Шүүх, Эдийн засгийн, Гадаад харилцаа, хангамжийн, Эрүүлийг хамгаалах, Эрчим хүч, уул уурхайн үйлдвэр, геологийн яам зэрэг ажиллаж байжээ. Яамдыг Сайд нарын Зөвлөлөөс өргөн мэдүүлснээр БНМАУ-ын Ардын Их Хурал, түүний чуулганы чөлөө цагт Ардын Их Хурлын Тэгүүлэгчид байгуулж, татан буулгана. Яамны сайдыг Сайд нарын Зөвлөлийн даргын өргөн мэдүүлснээр БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчид томилж, мөн журмаар албан тушаалаас өөрчилдөг байна.

Яамны эрх зүйн байдал

БНМАУ-ын Үндсэн ба холбогдох бусад хууль, тэдгээрт нийцүүлэн Сайд нарын Зөвлөлөөс баталсан тус тусын дүрэм тухайлбал: Сангийн яам БНМАУ-ын СнЗ-ийн 1960 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 449 дүгээр тогтоолоор, 1983 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 341 дүгээр Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор Гадаад явдлын яамны дүрэм, 1968 Сангийн яамны.

дүрмийг баталсан гэх мэт. Мөн тухайн яаманд эрх олгож үүрэг ногдуулан гарсан тогтоол, дүрэм, заавар зэрэг байна.

1960 оны Үндсэн хуульд зааснаар "БНМАУ-ын яамд, тусгай газруудын үйл ажиллагаа нь нэгдмэл захирамжийн зарчим асуудлыг хамарч хэлэлцэх зарчмыг тууштай хэрэгжүүлэх үндсэн дээр зохион байгуулагдана гэж заажээ. Энэ дагуу яамны үйл ажиллагаа нь хамтын удирдлагын зохих арга, хэлбэрийг захиргааны эрх зүйн хэм хэмжээгээр тогтоон хэрэгжүүлдэг байв. Яамны үйл ажиллагаанд нэгдмэл захирамжийг хамтын удирдлагатай хослуулах зохион байгуулалтын гол хэлбэр нь яамны коллеги юм. Түүний эрх зүйн үндэс, үйл ажиллагааны журмыг Сайд нарын Зөвлөөс 1962 онд баталсан БНМАУ-ын яамдын коллегийн дүрмээр тодорхойлжээ. Яамдын коллегийг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор тус бүр 7-9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулна. Коллегийн бүрэлдэхүүнд яамны сайд /коллегийн дарга/ орлогч сайд нар бусад хариуцлагатан болон харьяа газар байгууллагын эрх баригчдаас оруулж, хүн бүрийг яамны сайдын танилцуулан тодорхойлсноор БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл батална.[349]

Улсын хороо, түүнтэй адилсах төрийн албан газрууд

Улсын хороо бол БНМАУ-ын Ардын Их Хурлаас байгуулагдан төрийн удирдлагын тусгай асуудлаар буюу нэг төрлийн чиг үүргээр нийт салбарын үйл ажиллагааг уялдуулан холбож, хянан зохицуулдаг салбар хоорондын эрх хэмжээтэй, хамтын удирдлага бүхий төрийн захиргааны төв байгууллага юм. Харин 2004 оны Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 3.1-д зааснаар Яам нь Засгийн газрын үйл ажиллагааны зохих хүрээ, тодорхой чиг үүргийг дагнан эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мөн" гэж заасан бөгөөд эндээс авч үзвэл төрийн захиргааны төв байгууллага гэдэгт тухайлсан асуудлаарх салбарын яамдуд орж байна. Улсын хороо хэмээх эдгээр төрийн захиргааны төв байгууллага нь эрх зүйн байдлын хувьд төрийн удирдлагын зохих хүрээнд салбар хоорондын зохицуулах чиг үүргийг эрхлэн хэрэгжүүлдэгт оршино.

Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх тусгай газрууд

Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх тусгай газар бол БНМАУ-ын 1960 оны Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлд зааснаар Сайд нарын Зөвлөлөөс байгуулагдаж, түүнээс томилогдсон дарга толгойлж, улсын хэмжээнд гүйцэтгэн захирах ажиллагаа явуулдаг төрийн захиргааны төв байгууллага мөн. 1988 оны байдлаар л гэхэд ийм тусгай газарт БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх Авто замын ерөнхий газар, Иргэний агаарын тээврийг удирдах ерөнхий газар, Улсын Арбитрын газар, Хэвлэл утга зохиолыг хянах ерөнхий газар, Улсын стандартын газар, Шашны хэрэг эрхлэх зөвлөл зэрэг тусгай газар ажиллаж байсан байна.[350]

Тусгай газрын үндсэн эрх хэмжээ нь хууль тогтоомж болон Сайд нарын Зөвлөлөөс баталсан тус тусын дүрмээр тогтоогдоно. Тусгай газар эрх

[349] БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн коллегийн дүрэм. 1962 он. 2 дугаар зүйл

[350] Чимид.Б Бүгд Найрамдах Монгол Ард Улсын захиргааны эрх зүй /ерөнхий анги/ УБ.,1988 он.148-дахь талд

хэмжээнийхээ шинжээр а/ салбарыг удирдах, б/салбар хоорондын гэсэн хоёр янз байдаг. Жишээ нь, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх Авто замын ерөнхий газар нь салбарын эрх хэмжээтэй байгууллага юм.

БНМАУ-ын Шүүх

БНМАУ-ын шүүхийн байгууллага бол төрийн байгууллагын бүрэлдэхүүн хэсэг юм. Шүүх байгууллага нь БНМАУ-ын Иргэний хуулиар заасан иргэний хэрэг, БНМАУ-ын эрүүгийн хуулиар заасан эрүүгийн холбогдолтой гэмт хэргийг хянан үзэж шийдвэрлэдэг юм.[351] БНМАУ-д шүүн таслах ажлыг БНМАУ-ын дээд шүүх, тусгай шүүх, аймаг, хотын шүүх, түүнчлэн нүүдлийн болон районы шүүх, гүйцэтгэж байв. БНМАУ-ын дээд шүүх нь: Дээд шүүхийн бүгд хурал, Дээд шүүхийн тэргүүлэгчид, Улсын дээд шүүхийн эрүүгийн хэрэг эрхэлсэн коллеги, Улсын дээд шүүхийн иргэний хэрэг эрхэлсэн коллеги зэрэг дотоод аппаратыг байгуулан ажил хэргээ явуулж байв. Улсын дээд шүүхийн бүгд хурал нь БНМАУ-ын Ардын Их Хуралд оруулахаар дээд шүүхээс санаачилсан хуулийн төсөл болон Ардын Их Хурлын Тэргүүлэгчдэд оруулах саналыг нягтлан хэлэлцэнэ.[352]

Улсын Дээд шүүхийн эрүү, иргэний хэрэг эрхэлсэн коллеги нь тус бүр дарга, гишүүдээс бүрдэнэ. Коллеги бүр нь БНМАУ-ын эрүүгийн болон иргэний байцаан шийтгэх хуулиар өөртөө шууд харьяалуулсан хэргийг анхан шатны журмаар таслан шийдвэрлэхээс гадна мөн аймаг, хотын ба тусгай шүүхээс таслан шийдвэрлэсэн харьяаллын хэргийн хучин төгөлдөр болоогүй тогтоол, шийдвэр магадлалыг давж заалдсан гомдол эсэргүүцлийн үндсэн дээр II шатны журмаар хянан шийдвэрлэнэ. Түүнчлэн орон нутгийн шүүхийн шийдвэрлэсэн хуулийн хүчин төгөлдөр болсон таслан шийдвэрлэх тогтоол, шийдвэр, магадлалд хяналтын журмаар бичигдсэн эсэргүүцлийн үндсэн дээр эрүү, иргэний хэргийг II шатны журмаар хянаж зохих шийдвэр гаргадаг байна. БНМАУ-ын дээд шүүхийн тэргүүлэгчид нь тус улсын бүх шүүхийн зохион байгуулалтын ажлыг удирдах төв байгууллага юм. Улсын дээд шүүхийн хамтын удирдлагын байгууллага болох тэргүүлэгчдийг БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн газраас батална. Түүнчлэн улсын дээд шүүхэд шүүхийн зохион байгуулалтын өдөр тутмын ажлыг удирдах шүүхийн байгуулалтын хэлтэс ажиллана. Шүүхийн зохион байгуулалтын хэлтсийг БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1962 оны 262 дугаар зарлигаар БНМАУ-ын дээд шүүхийн тэргүүлэгчдийг байгуулсан бөгөөд мөн дээд шүүхийн зохион байгуулалтын ажлыг эрхлэх шүүхийн байгууллагын хэлтсийг байгуулжээ. Тэр үеийн шүүхийн зохион байгуулалтын системийн нэг онцлог нь БНМАУ-ын бүх шатны шүүхийг сонгуулиар байгуулдагт оршиж байв. БНМАУ-ын Ардын Их Хурлаас БНМАУ-ын дээд шүүхийг, Ардын Их Хурлын Тэргүүлэгчдээс тусгай /цэргийн/ шүүхийг хуульд заасан хугацаагаар тус тус сонгоно. Аймаг, хотын шүүхийн шүүгч, ардын төлөөлөгчдийг аймаг, хотын ардын депутатуудын хурал, мөн аймгийн нүүдлийн шүүхийн шүүгчийг аймгийн ардын депутатуудын хурлын чуулганаас 3 жилийн хугацаагаар сонгодог юм. Харин районы шүүхийн

[351] Авиримэд. Э Бүгд Найрамдах Монгол Ард Улсын төрийн эрх УБ., 1969 он 290 дэх талд

[352] Энэ нь өнөөгийн эрх зүйн зохицуулалтын үүднээс харвал өөр зохицуулалттай байв.

шүүгчийг тухайн районы ардын депутатуудын хурлын чуулганаас 3 жилийн хугацаагаар сонгоно. Нүүдлийн болон районы шүүхийн ардын төлөөлөгчдийг тухайн нүүдлийн шүүхийн ажиллах сум ба районы хөдөлмөрчдийн хурлаас манай сонгуулийн системийн зарчмыг үндэслэн мөн 3 жилийн хугацаагаар ил сонгодог байна. Шүүгчид 23 нас хүрсэн иргэнийг сонгодог байв. Шүүгчид болон ардын төлөөлөгчид нь өөрийг нь сонгосон хөдөлмөрчид ба ардын депутатуудын хуралд хийсэн ажлынхаа талаар тайлагнаж байжээ. Энэ өнөөгийн өнцгөөс харвал нэг талаар авууштай зохицуулалт онцлог тал хэдий ч шүүхийн бие даасан хараат бус байх зарчим хэрхэн хэрэгжиж байв гэдэг нь эргэлзээтэй юм.

БНМАУ-ын прокурор

1930 онд БНМАУ-ын шүүх явдлын яаманд прокурорын хяналтын ажил эрхэлсэн орлогч сайд, орон нутагт аймаг, хотын прокурорын орон тоог баталжээ. Мөн оны 7 дугаар сарын 25-ны өдрийн Засгийн газрын 42 дугаар тогтоол, 8 дугаар сарын 14-ний өдрийн Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор "Прокурорын дүрэм"-ийг баталсан бөгөөд энэ өдрийг улсын прокурорын байгууллага байгуулагдсан өдөр гэж үздэг юм. Өнөөдөр прокурорын байгууллагын 80 жилийн ой тохиож буй юм. Төрийн байгууллагын салшгүй нэг хэсэг бол прокурорын байгууллага юм. БНМАУ-ын Үндсэн хуульд прокурорын байгуулагын үүрэг зорилт зохион байгуулалтын зарчмыг заажээ. 1960 оны Үндсэн хуулийн 72 дугаар зүйлд БНМАУ-ын бүх яам, төв байгууллагууд, тэдгээрийн харьяа албан газар, байгууллага, орон нутгийн засаг захиргааны болон олон нийтийн хоршооллын бүх байгууллага мөн албан тушаалтан ард иргэдээс хуулийг хэрхэн нарийн чанд биелүүлж байгааг нэгэн адил хянах дээд хяналтыг улсын прокурор гүйцэтгэнэ. Төрийн байгуулалтын дотроос хамгийн нэгдмэл удирдлагатай байгууллагын нэг нь БНМАУ-ын прокурорын газар байв. Өөрөөр хэлбэл дээд шатны прокурорт доод шатны прокурор нь шууд захирагдах хатуу төвлөрсөн нэгдмэл системтэй юм.

БНМАУ-ын прокурорыг Ардын Их Хурлаас хуульд заасан хугацаагаар томилдог. Аймаг, хот, хэсгийн болон районы прокурорыг улсын прокуророос 3 жилийн хугацаагаар томилно. Өөрөөр хэлбэл төрийн албаны томилолтын систем шууд хэрэгждэг байгууллагын нэг нь байв. Улсын прокурор нь нэгдмэл удирдлагатайн зэрэгцээ бас хамтын удирдлагын системийг хослон хэрэглэж байв. БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1959 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн 144 дүгээр зарлигаар улсын прокурорын газрын дэргэдэх зөвлөх эрхтэй байгууллага коллегийг байгуулжээ. БНМАУ-ын прокурорын газрын коллегийн гишүүдийг улсын прокурорын саналаар БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдээс баталдаг байв. Мөн Улсын прокурорын төв аппаратын зохион байгуулалтыг БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдээс баталж байв. Энэ нь прокурорын байгууллагад нэгдмэл төвлөрсөн удирдлагатайн дээр хамтын удирдлага хэрэгжиж байсны жишээ юм. Тухайн үеийн прокурорын байгууллага, прокурорын эрх хэмжээний өөр нэг онцлог шинж бол БНМАУ-ын дээд шүүхийн бүгд хуралд улсын ерөнхий прокурор буюу түүний орлогчийн аль нэг нь сууж

өөрийн санал дүгнэлт өгөх замаар хяналтыг явуулах, хэрэв дээд шүүхийн бүгд хурлын тогтоол хууль зөрчсөн байвал БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн газарт мэдэгдэл бичих зэргээр өөрийн хяналтыг шүүх ажиллагаанд тавьж байжээ.

Төрийн албан хаагчийг сонгох, томилох, огцруулах арга зам, эрх зүйн зохицуулалт

1960-1992 оны хоорондох төрийн алба нь үндсэндээ Марксист-Ленинист онолын үндэслэлтэй зарчмуудад тулгуурлаж байдгаараа феодал, хөрөнгөтний төрийн албаны шууд эсрэг мөн чанартай юм гэж доктор, профессор Б.Чимид бичжээ[353]. Эндээс харахад эл хугацааны төрийн албаны хөгжил нь үндсэндээ социалист ёсыг эрхэмлэсэн төвлөрсөн удирдлага бүхий тогтолцоонд тулгуурлан төрийн албаны хөгжил явагдаж ирсэн юм.

Албан тушаалд иргэдийг авах журмыг БНМАУ-ын Үндсэн хууль, Хөдөлмөрийн хууль, тэдгээрт үндэслэн бусад хэм хэмжээгээр тогтоосон байдаг. Төрийн албанд иргэдийг авч ажлуулах үндсэн нөхцөл нь ***сонгох, томилох*** хоёр юм.

1.Сонгох журмыг зарим удирдах албан тушаалд хүмүүсийг авч ажиллуулахад хэрэглэнэ. Албан тушаалд хүмүүсийг а/хөдөлмөрчдөөс шууд сонгох, б/төлөөлөгчдийн байгууллагаас сонгох, в/хамт олноос сонгох хэлбэртэй байжээ. Тухайлбал депутатболонардыншүүгчдийгхөдөлмөрчдөөс БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн удирдах бүрэлдэхүүн /дарга, орлогч, нарийн бичгийн дарга/ АДХ-ын гүйцэтгэх захиргааны удирдах бүрэлдэхүүн, Улсын Дээд Түсгай болон аймаг, хотын шүүхийн шүүх бүрэлдэхүүнийг төрийн эрх барих зохих шатны байгууллагаас, Шинжлэх ухааны академийн удирдах бүрэлдэхүүн /ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч, эрдэмтэн нарийн бичгийн дарга, их дээд сургуулийн факультетийн декан зэрэг албан тушаалд хүмүүсийг Академийн бүх гишүүдийн хурал, факультетийн зөвлөлийн хурлаас сонгох журам байсан.[354]

Төрийн эрх барих орон нутгийн хурлууд, Улсын Их Хурлыг 4 жил, аймаг, хотын хурлыг 3 жил, сум, баг, хороо, хорины хурлыг 3 жил, ардын хэсгийн шүүх, аймаг хотын шүүхийг 3 жил, Улсын Дээд шүүхийг 4 жилийн хугацаагаар сонгох эрх зүйн зохицуулалтай байв.

2. Томилох журмаар төрийн албан тушаалд авах

Энэ үеийн улс төр, нийгмийн хөгжлийн онцлогтой уялдан төрийн алба хаагчийг томилох журмаар албан тушаалд авдаг байна. Албан тушаалд томилох нь албан томилолтоос ялгаатай юм. Албан томилолт гэж албан хаагчийг тогтмол ажилладаг газраас нь өөр газарт албан үүрэг гүйцэтгүүлэхээр үйлдвэр, албан газар, байгууллагын удирдлагын шийдвэрээр түр хугацаагаар явуулж ажлуулахыг хэлдэг. Харин томилох журам нь боловсон хүчний /хүний нөөцийн/ асуудлыг шуурхай шийдэж

[353] Б.Чимид. БНМАУ-ын Захиргааны эрх зүй /Ерөнхий анги/ УБ., 1988 он. 209 дэх тал.

[354] БНМАУ-ын Үндсэн хууль 1960 он. 20, 52, 66, 68 дугаар зүйл, БНМАУ-ын Шүүхийн байгууламжийн хууль 78, 35 дугаар зүйл, БНМАУ-ын дээд сургуулийн дүрэм, 1974, 28 БНМАУ-ын ШУ-ны Академийн дүрэм, 1974 37-р зүйлд тус тус заасан.

шаардлагатай газарт хуваарилж ажлуулахад сайн талтай боловч тухайн аппаратыг бүрдүүлэхэд олон нийтийн оролцооны асуудлыг үгүйсгэдэг дээрээс төлөвлөсөн, шаталсан босоо удирдлагын тогтолцоог дэмждэгээрээ сул талтай юм.

Сайд нарын Зөвлөлийн тогтоол, шийдвэрээр яамдын орлогч сайд, тусгай газрын дарга, орлогч нарыг тушаалаар томилдог байв. Томилолтын эдгээр акт нь улсын байгууллага ба албан хаагчид хоёрын хоорондын эрхийн харьцааг бий болгох гол үндэс нь байв.[355]

3. Уралдаант шалгалтын журам

Төрийн албанд мэргэжилтэй боловсон хүчнийг сайтар шалгаруулж авах илүү боломж олгодог бөгөөд эл журмыг 1970-аад оноос л нэвтрүүлж эхэлжээ. Тухайн албан тушаалд тавигдах үндсэн шаардлагуудыг тусгасан тодорхой болзол, журам тогтоож түүний үндсэн дээр урьдаас өргөн олон нийтэд зарлаж тухайн албан тушаалд ажиллахыг сонирхогчдоос сорилт шалгалт авч, дүнг хамтын журмаар хэлэлцэж шалгарсан хүн бүр дээр нууц санал хураалт явуулж олонхын санал авсан тухайн албан тушаалд баталж авдаг нь энэ журмын гол онцлог юм. Уралдаант шалгалтаар ажилд ороход уг албан тушаалыг гүйцэтгэх бүрэн эрхийн хугацаатай байхаар зохицуулжээ. Хугацаа дуусмагц дахин болзолт шалгалт авах зохицуулалттай байв. БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс баталсан дүрмийн ёсоор яам, улсын хороо, тусгай газар, аймаг, хотын гүйцэтгэх захиргаанаас баталсан жагсаалтад заасан дээд тусгай дунд боловсролтой мэргэжилтэн түүнчлэн мэргэжилгүй боловч зохих мэргэжлийн албан тушаалд ажиллаж байгаа хүмүүсийг 3-5 жилд 1 удаа аттестатчилдаг байжээ. Захиргаа, нам, олон нийтийн байгууллагын төлөөлөгчдөөс бүрддэг, аттестатчиллын комисс тухайн ажилтныг албан тушаалд үргэлжүүлэн ажиллуулах эсэхийг төгс шийдвэрлэхгүй боловч түүний улс төр, ажил хэргийн хувийн чанар, ажил мэргэжлийн өсөлт үр дүнгээр нь зохих болзлын дагуу шалгаж а/албан тушаалд тэнцэх, б/ илэрсэн дутагдлыг арилгаад ажлаа сайжруулбал тэнцэх, в/үл тэнцэх зэргийг тодорхойлдог байна. Комисс нь өндөр амжилт гаргасан ажилтныг дэвшүүлэх, ажлаа сайжруулах зэрэг зөвлөмж гаргадаг байна. Өнөөдрийн хувьд Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлд энэ тухай заасан бөгөөд тухайлбал 17.1-д Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллагад ажиллаж байгаа буюу төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр нь сонгон шалгаруулах замаар уг орон тоог нөхнө. Өөрөөр хэлбэл одоогийн зохицуулалтын онцлог бол төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулах замаар бүрдүүлдэг болсон билээ.

4.Огцруулах журмын тухайд:

"БНМАУ-ын Ардын Их Хурлын депутат сонгогчдоосоо хүлээлгэсэн итгэмжийг хөсөрдүүлж, депутатын нэр алдарт харш явдал гаргавал түүнийг сонгосон сонгуулийн тойргийн сонгогчдын олонхийн шийдвэрээр хөөсөн ч

[355] Төр эрхийн асуудал 1958 III сэтгүүл БНМАУ-ын төрийн алба С.Баатар 27-дахь тал

огцруулж болно" гэж БНМАУ-ын Ардын Их Хурлын Депутатыг огцруулах журмын тухай хуульд[356] заажээ. Энэ нь өнөөгийн эрх зүйн зохицуулалтын үүднээс авч үзвэл тун дэвшилттэй заалт байсан байна. Өөрөөр хэлбэл төрд төлөөлж буй түшээгээ эгүүлэн татах эрхийг сонгогчдод олгосон заалт байжээ гэж судлаачдын зүгээс дүгнэж байна. Учир нь өнөөгийн Монгол Улсын Их Хурлын тухай 2006 оны хуулийн зохицуулалтад байхгүй дэвшилтэт заалт юм.

Мөн орон нутгийн буюу БНМАУ-ын аймаг, хот, сум хороодын Ардын депутатуудын хурлын депутатуудыг огцруулах журмын тухай хуулиар[357] нэгдүгээр зүйл "Аймаг, хот, сум, хороодын ардын депутатуудын хурлын депутат, сонгогчдын итгэмжийг хөсөрдүүлж, депутатын нэр алдарт харш явдал гаргавал сонгуулийн зохих тойргийн сонгогчдын олонхийн саналаар хэзээ ч огцруулж болно. гэж заажээ.

Төрийн албан хаагчид хүлээлгэх хариуцлагын тогтолцооны онцлог

Албан хаагчид хүлээлгэх хууль зүйн хариуцлага гэдэг бол төрийн албаны хэвийн үйл ажиллагааг зөрчсөн гэм буруутай албан хаагчид эрх бүхий байгууллагаас хэрэглэх төрийн албадлагын арга хэмжээ юм.

Тухайн үеийн БНМАУ-ын Хөдөлмөрийн хууль болон хөдөлмөрийн үлгэрчилсэн дотоод дүрэмд сахилгын хариуцлагын дараах арга хэмжээг заажээ. Үүнд:

а/ сануулах

б/ донгодох

в/ хатуу донгодох

г/ ажлаас халахыг сануулан донгодох

д/ бага цалинтай буюу доод тушаалын ажилд 3 сар хүртэл хугацаагаар шилжүүлэх зэрэг сахилгын шийтгэл оногдуулдаг байжээ.[358] Мөн албан хаагчийг төрийн албаны болон хөдөлмөрийн сахилга ноцтой зөрчсөний учир ажлаас халах нь сахилгын эцсийн арга хэмжээ болж байв.

Албан үүргээ зөрчсөн албан хаагчийн хүлээх сахилгын хариуцлагын арга хэмжээнүүд үндсэндээ ижил боловч Ардын хяналт шалгалтын хууль, улсын хяналтын болон сахилгын тусгай дүрэм зэрэгт үндэслэл, журмын хувьд өөрмөц байдлаар тусгагдаж байжээ. Эдгээр нөхцөл байдалтай уялдан төрийн албан хаагчдад сахилгын хариуцлага хүлээлгэх журам нь өөрийн онцлогтой байсан юм. Тухайлбал:

а/ дотоод дүрэмд заасны дагуу;

б/ захирах захирагдах журмаар;

[356] 1961 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр БНМАУ-ын Ардын Их Хурлын 4 дэх удаагийн сонгуулийн хоёрдугаар чуулганаар батлагдсан.

[357] 1963 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн Дугаар 10 "Орон нутгийн АДХ-ын депутатыг огцруулах журмын тухай хуулийг батлах тухай зарлиг, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын аймаг, хот, сум, хороодын ардын депутатуудын хурлын депутатыг огцруулах журмын тухай хууль 13 зүйл. БНМАУ-ын Хууль, дүрэм, тогтоолын эмхтгэл УБ., 1963 он №2, 30-32 дахь талд нийтлэгдсэн.

[358] БНМАУ-ын Хөдөлмөрийн хууль 119 дүгээр зүйл, Үйлдвэр албан газар, байгууллагын хөдөлмөрийн үлгэрчилсэн дотоод дүрэм 27-р зүйл

в/ сахилгын тусгай дүрэмд зааснаар арга хэмжээ авах гэж ангилагдаж байна.

Эдгээрээс тухайн үеийн онцлог зохицуулалт нь захирах захирагдах журмаар сахилгын хариуцлага хүлээлгэх юм. Энэ гол төлөв удирдах албан тушаалд хамааралтай бөгөөд ажлын газрын захиргаанаас биш, харин тухайн ажилтан шууд харьяалж захирах дээд байгууллагаас нь сахилгын шийтгэл оногдуулахыг хэлнэ. Үүний жишээ нь, Сайд нарын Зөвлөл яамны сайд, улсын хороо, өөртөө харьяалагдах бусад байгууллагын дарга болон тэдгээрийн орлогчдод сахилгын арга хэмжээ авч болохоор заасан зохицуулалтаас харагдах юм. [359] Харин сахилгын тусгай дүрмийн хувьд төрийн албаны зарим салбарт эрх бүхий байгууллагаас баталсан сахилгын тусгай дүрэм дагаж мөрдөх нь бий. Тухайлбал: "Төмөр замын ажилчин, албан хаагчдын сахилга батын дүрэм", "БНМАУ-ын зэвсэгт хүчний сахилга батын дүрэм", "БНМАУ-ын шүүгчдийн сахилга батын дүрэм" гэх мэт байжээ. Эл сахилгын тусгай дүрмийн хувьд өнөөгийн эрх зүйн зохицуулалтаар ч гэсэн бий юм. "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажилтны сахилгын дүрэм", "Шүүгчийн сахилгын дүрэм", "Цагдаагийн албан хаагчийн сахилгын дүрэм" гэх мэт үйлчилж буй юм.

Төрийн албан хаагчдын ангиллын хувьд

Төрийн албан хаагчдыг ажиллаж байгаа байгууллагын системээр АДХ-ын ажилтан, захиргааны байгууллагын ажилтан, шүүх, прокурорын байгууллагын ажилтан, мөн захиргааны салбар байгууллагын ажилтанг аж ахуйн удирдах байгууллагын ажилтан нийгэм, соёлын удирдах байгууллагын ажилтан, захиргаа-улс төрийн байгууллагын ажилтан гэх зэргээр ангилж бүлгэлжээ. Харин албан хаагчдыг тухайн байгууллагад эзэлж байгаа байр суурь албан ажлын хууль зүйн шинж чанарыг харуулахын тулд эрх хэмжээгээр нь

1/албан тушаалтан;

2/туслах буюу техникийн гүйцэтгэх ажилтан гэсэн үндсэн хоёр бүлэгт хуваагдаж байжээ.

Өөрөөр хэлбэл өнөөгийн эрх зүйн зохицуулалтаар ангилагдсан төрийн улс төрийн, захиргааны, үйлчилгээний гэх шууд ялгамжтай тодорхойлсон ангилалт байхгүй байв.

1.4. 1990-1992 оны хоорондох шилжилтийн зурвас үеийн төрийн албаны онцлог, эрх зүйн зохицуулалтын тойм

1990 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн Үндсэн хуулийн Нэмэлтийн тухай хуулиар төрийн албаны бүтэц зохион байгуулалтад нэлээд өөрчлөлт орсон юм. Тухайлбал:

Хуулийн 1 дүгээр зүйлд: "БНМАУ-ын Ардын Их Хурал бол Монголын ард түмний бүрэн эрхийг илэрхийлсэн төрийн эрх барих төлөөлөгчдийн дээд байгууллага мөн" гэсэн бол мөн хуулийн 6 дугаар зүйлд: "БНМАУ-ын Бага Хурал нь хууль тогтоох, хянан шалгах, зохион байгуулах бүрэн эрх бүхий

[359] БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тухай хуулийн 20 дугаар зүйл

төрийн эрх барих байнгын дэзд байгууллага мөн "БНМАУ-ын Бага хурал дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, 50 гишүүнээс бүрдэнэ. БНМАУ-ын Бага хурлын орлогч дарга, нарийн бичгийн даргыг БНМАУ-ын Ардын Их Хурал депутатуудын дотроос шууд сонгоно. БНМАУ-ын Бага Хурлын дарга нь БНМАУ-ын Дэд ерөнхийлөгч байна. гэж Ардын Их Хурал, Улсын Бага Хурлын эрх хэмжээний асуудлыг шинэчлэн тусган оруулсан бөгөөд БНМАУ-ын Бага Хурлын дарга нь тус улсын Дэд ерөнхийлөгч байхаар зохицуулж өгсөн нь төрийн албаны шинэтгэлд хийсэн шинэ алхам байлаа.

Мөн хуулиар БНМАУ-ын Бага хурлын гишүүний бүрэн эрх, түүнийг сонгох, огцруулах журмыг БНМАУ-ын хууль тогтоомжоор тодорхойлно" гэж заажээ. Түүнчлэн 13 дугаар зүйлд: БНМАУ-ын Ерөнхийлөгч бол Ардын төрийн тэргүүн, БНМАУ-ын тусгаар тогтнол, Монголын ард түмний эв нэгдлийн баталгаа мөн. БНМАУ-ын Ерөнхийлөгчөөр 40 нас хүрсэн, Монголын ард түмний аж амьдрал, ёс заншлыг сайн мэддэг, сүүлийн таваас доошгүй жил БНМАУ-д байнга оршин суусан БНМАУ-ын иргэнийг Ардын Их Хурлаас саналаа нууцаар гаргаж 5 жилийн хугацаагаар сонгоно. БНМАУ-ын Ерөнхийлөгчийн албан тушаалд хоёр түүнээс дээш хүний нэрийг дэвшүүлнэ. БНМАУ-ын Ардын Их Хурлын нийт депутатын олонхийн санал авсан нэр дэвшигчийг БНМАУ-ын Ерөнхийлөгчөөр сонгогдсонд тооцно. Ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаа улируулан сонгож болно[360] гэж заажээ. Өөрөөр хэлбэл энэ хуулиар БНМАУ-ын Ерөнхийлөгч гэсэн албан тушаал анх бий болсон юм.

Мөн уг хуулиар төрийн албанд хийсэн бас нэгэн шинэчлэл бол тус хуулийн хоёрдугаар бүлэг. "Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар" гэсэн бүлэг 18 дугаар зүйлд зааснаар "БНМАУ-ын Засгийн газар нь төрийн гүйцэтгэн захирамжлах дэзд байгууллага мөн" гэж зааснаар 1960 оны Үндсэн хуулиар тодорхойлон заасан Сайд нарын Зөвлөлийн эрх хэмжээ Засгийн газарт шилжсэн юм.

Ийнхүү 1990 оны Үндсэн хуулийн Нэмэлтийн хуулиар төрийн албаны хөгжил, бүтэц зохион байгуулалтын шинэ өөрчлөлтийг хийсэн байна.

ХОЁР. 1992 ОНЫ ҮНДСЭН ХУУЛИЙН ДАГУУХ ТӨРИЙН АЛБАНЫ ШИНЭТГЭЛИЙН ҮЕ

2.1. 1994 ОНЫ ТӨРИЙН АЛБАНЫ ХУУЛИЙН ЗОРИЛТ, БҮТЭЦ, АГУУЛГЫН ТОВЧООН

Өмнө нь төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг Хөдөлмөрийн хуулиар зохицуулдаг байсан. Төрийн албаны тухай хуулийг 1992 оноос боловсруулж, Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсанаар Төрийн албан хаагчдын эрх зүйн байдлын үндэс тавигдсан ба 1994 оны 12 дугаар сарын 30-нд Төрийн албаны тухай хуулийг баталж дараа жилээс нь мөрдүүлж эхэлсэн. Ингэж төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг улс төрөөс хараат бус, мэргэшсэн, тогтвортой байх зарчимд тулгуурласан бөгөөд хуулиар зохицуулагдсан нийгмийн харилцаа болгож өөрчлөн шинэчилсэн /1999-05-14; 1999-05-28; 2000-08-03; 2000-12-07; УИХ-аас 2002 онд баталсан уг хуулиийг шинэчлэн баталсан ба энэ хуульд 2002 оны 11 дүгээр сарын 8-нд,

[360] БНМАУ-ын Үндсэн хуулийн Нэмэлтийн тухай хууль 1990.05.10 13 дугаар зүйл

2003 оны 1 дүгээр сарын 2, 10, 5 дугаар сарын 30-нд, 6 дугаар сарын 20-нд, 2005 оны 05 дугаар сарын 26-нд, 2006 оны 1 дүгээр сарын 12-нд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан/.

1994 оны Төрийн албаны хуулиар УИХ, Ерөнхийлөгч, Үндсэн хуулийн Цэц, Засгийн газар, Шүүх, тэдгээрийн харьяа газар, албан хаагчийн эрх зүйн байдлыг нэгтгэн зохицуулжээ. Уг хууль нь 7 бүлэг, 42 зүйлээс бүрдэх бөгөөд хуулийн зорилт нь Монгол Улсын төрийн албаны ангилал, зарчим, төрийн албан тушаал, түүнд тавигдах шаардлага, төрийн алба хаагчийн эрх зүйн байдал, түүнээс төрийн алба хаах болзол, журам, баталгааг тогтоон зохицуулахад оршино.

Төрийн албаны нэгдмэл тогтолцоонд **төрийн жинхэнэ алба** тэргүүлэх байр суурь эзэлнэ. Хууль тогтоох, шүүх эрх мэдлийн албаны үйл ажиллагаа нь нэг чиглэлийн байдаг бол **төрийн захиргааны болон тусгай алба төрийн** бүх эрх мэдэлд хамаарахын зэрэгцээ захиргааны байгууллагын доторх цэргийн алба, дипломат алба, хууль зүйн, эсхүл гаалийн,татварын зэрэг тодорхой аль нэг салбар алба нийлж, төрийн албаны бүхэллэг нэгдмэл тогтолцооны цөмийг бүрдүүлнэ. Төрийн албыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагад юуны өмнө ажлын аппарат, албан тушаал, албан хаагч шаардагдана.

Манай улсад нам төвтэй улс төрийн тогтолцооны үеийн "спойл" буюу төрийн албаны удирдлагын "эвдрэх" тогтолцоог өөрчилж, төрийн эрх мэдлийн гурван салаа мөчирт тогтвортой ажиллах төрийн албан хаагчаар хангах нь Монгол Улсын 1992 оны шинэ Үндсэн хуулиас хойш төрийн байгууллын тулгамдсан асуудлын нэг болсон юм.

"Монгол Улсын Төрийн албаны хууль"-д /1994/ гадаадын олон оронд үр дүнгээ үзүүлсэн төрийн албаны удирдлагын "мерит" буюу "төрд тогтвортой үйлчлэх" тогтолцоог тусгасан билээ.

"Нийтлэг үндэслэл" гэсэн нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, төрийн албаны тухай хууль тогтоомж, төрийн албаны ойлголт, ангилал, зарчмын үндсийг тоймлон тодорхойлжээ.

Төрийн албыг төрийн улс төрийн, тусгай, захиргааны, үйлчилгээний гэж дөрөв ангилан төрийн захиргааны болон тусгай албыг төрийн жинхэнэ алба хэмээн томьёолж, төрийн албаны үндсэн зарчим нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн хоёр дахь хэсэгт заасан ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх явдал болохыг тогтоон бэхжүүлжээ.

Үүний зэрэгцээ төрийн албанд хуульд өөрөөр заагаагүй бол дараах тусгай зарчим баримтлана. 1.Захирах, захирагдах ёс; 2.Ил тод байх; 3.Ард түмэнд үйлчлэх; 4.Иргэд хуульд заасан болзол, журмын дагуу төрийн албанд орох адил тэгш боломжтой байх; 5.Төрийн алба мэргэшсэн тогтвортой байх; 6.Төрийн албан хаагчаас бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөл, баталгааг төр хангах; 7.Хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад гаргасан алдааны улмаас төрийн албан хаагчийн учруулсан хохирлыг төр хариуцах. Ийнхүү төрийн албанд удирдлага болгох үзэл баримтлал, үндэслэлийг зарчим хэмээн хуульд анх удаа тусгайлан тогтоосон билээ.

"Төрийн албан тушаал" гэсэн хоёрдугаар бүлэг, 5-10 дугаар зүйлд заасанчлан төрийн албан тушаал нь төрийн улс төрийн, төрийн захиргааны, төрийн тусгай, төрийн үйлчилгээний гэсэн ангилалттай, удирдах, гүйцэтгэх, туслах гэсэн төрөлтэй байна. Тэрчлэн төрийн аль албан тушаалд төрийн ямар албан хаагч хамаарахыг хуулийн 6-9 дүгээр зүйлд нэг бүрчлэн зааж, төрийн албан тушаалтны зэрэг зиндаа, зэрэг дэв, зэрэглэлийн талаар тусгажээ.

Төрийн албан тушаалд тавих ерөнхий шаардлага нь хуульд өөрөөр заагаагүй бол тухайн албан тушаалыг эрхлэх мэдлэг, боловсрол, туршлага, ур чадвартай, мэргэжлийн бэлтгэлтэй байх явдал мөн.

"Төрийн албан хаагч" хэмээх хуулийн гуравдугаар бүлэг, 11-15 зүйлд "Төрийн албан тушаалыг эрхэлж, бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг төрийн албан хаагч гэнэ" гэсэн тодорхойлолт өгч, төрийн албан хаагчийн эрх зүйн байдлын үндсийг ялгавартайгаар тогтоожээ.

Цаашилбал төрийн захиргааны албан хаагчийн тангараг, тэдгээрийн нийтлэг үүрэг, эрх, үйл ажиллагаанд хориглох зүйлийг ерөнхийлөн томьёолсон.

"Төрийн захиргааны албан тушаал эрхлэх болзол, журам" гэсэн хуулийн дөрөвдүгээр бүлэг, 16-26 дугаар зүйлд заасанчлан төрийн албан тушаалын болзол нь "Төрийн тухайн албан тушаалд иргэний төрийн захиргааны албан тушаал эрхлэх эрхийг үндэс, угсаа, арьс, өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол болон нам, олон нийтийн бусад байгууллагын харьяалал зэргээр ялгаварлаж үл болно". Мөн төрийн захиргааны албан тушаалд авч ажиллуулахыг хориглох тохиолдлуудын тухай заалт бий.

Төрийн захиргааны албан тушаалд авах, албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэжлийн түвшинг үнэлэх, албан тушаал хавсрах, орлон гүйцэтгэх, өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, түр томилох, албан тушаал бууруулах, албанаас чөлөөлөх, халах үндэслэлийг анх удаа хуульчилсан нь энэ бүлгийн гол агуулга юм.

Төрийн захиргааны албан хаагчид албаны сахилгын зөрчлийн шинж байдлыг харгалзан сануулах, албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, төрийн албанд нэг жил хүртэл хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах сахилгын шийтгэл ногдуулахаар болов.

"Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгаа" гэсэн тавдугаар бүлэг, хуулийн 27-32 дугаар зүйл нь төрийн албан хаагчийн ажил үүргээ гүйцэтгэх баталгаа, цалин хөлс, шагнал урамшуулал, тэдгээрт олгох нөхөн төлбөр, тусламж, тэтгэвэр, тэтгэмжийн асуудалд зориулагджээ.

"Төрийн албаны удирдлага, зохион байгуулалт" гэсэн хуулийн 33-39 дүгээр зүйл, зургаадугаар бүлэг нь төрийн албаны удирдлага, стандарт, санхүүжилт, төрийн албаны төв байгууллага, түүний чиг үүрэг, төрийн захиргааны албан хаагчийн эрх зөрчигдсөн тухай маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын үндэст хамаарагдана.

Төрийн албан хаагчийн ерөнхий удирдлагыг Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Шүүхийн Ерөнхий зөвлөл, Улсын Ерөнхий прокурор; стандартын удирдлагыг Төрийн албаны төв байгууллага; шуурхай удирдлагыг төрийн байгууллагын ажлын албаны эрх бүхий албан тушаалтан тус тус бүрэн эрхийнхээ хүрээнд хэрэгжүүлнэ.

Төрийн албаны 1994 оны хуулиар гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд бие даасан статустай стандартын удирдлагыг хэрэгжүүлэгч Төрийн албаны зөвлөл гэсэн шинэ байгууллага бий болов.

Төрийн албаны стандарт нь төрийн албыг үр дүнтэй удирдах, хэрэгжүүлэх, төрийн байгууллага, төрийн албан хаагчийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулахад чиглэгдэж, төрийн албан хаагчаас албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэх, санхүү, статистикийн болон төрийн албатай холбогдсон бусад мэдээ тайлан гаргах, төрийн байгууллага, албан хаагчаас албан хэрэг хөтлөх, ангилах, архивын баримт бичиг, нэгж бүрдүүлэх, хяналт шалгалт хийх, мэдээллээр хангах зэрэг бусад үйл ажиллагааны журмыг тогтооно.

"Бусад зүйл" гэсэн хуулийн 7 дугаар бүлэг, 40-42 дугаар зүйлд төрийн албан хаагчаас төрийн албаны хууль тогтоомж, стандарт зөрчих, албаны үйл ажиллагаатай холбогдсон хууль бус бусад ажиллагаа явуулахыг хориглож, Монгол Улсын төрийн албаны хуулийн холбогдох зарим заалт зөрчсөн гэм буруутай этгээд, төрийн албан хаагчид эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэх, хуулийн 17 дугаар зүйлийн нэг дэх хэсгийг зөрчсөн албан тушаалтанд захиргааны торгууль ногдуулах, уг зөрчлийг давтан үйлдэж торгуулбал түүнийг ажил албан тушаалаас халах, саналыг эрх бүхий этгээдэд тавих эрх зүйн үндсийг бүрдүүлжээ.

2.2. 2002 оны Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга, түүнд орсон нэмэлт, өөрчлөлтийн онцлог

"Төрийн албаны тухай хууль"-д удаа дараа орсон олон нэмэлт, өөрчлөлт байгаа болов 2002 оны 06 дугаар сарын 28-ны өдөр уг хуулийг бүхэлд нь хэлэлцэж, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуультай нийцүүлэн хуулийг шинэчлэн найруулж, боловсронгуй болгож УИХ баталсан.

Төрийн албаны тухай 2002 оны хуулийн шинэчилсэн найруулгын талаар товчхон: Монгол Улсын Төрийн албаны тухай энэ хууль нь өмнөх хуулийн нэг адил 7 бүлэг 41 зүйлтэй, нэг зүйл хасагдсаныг эс тооцвол бүтэц бүлгийн хувьд өөрчлөгдөөгүй байна.

Төрийн албаны 2002 оны хуулийн шинэчилсэн найруулгаар сайжруулсан нэмэлт өөрчлөлтийг тоймловол:

1. "Нийтлэг зүйл " Нэгдүгээр бүлгийн хуулийн зорилтод "... **төрийн албаны чиг үүргийг**" нэмж, өөрчлөн найруулсан

2. Хуулийн 2 дугаар бүлгийн 5.2-т **төрийн захиргааны болон тусгай албан тушаалыг "төрийн жинхэнэ албан тушаал гэнэ"** хэмээн шинээр нэмсэн.

3. Төрийн албан тушаалын ангилалд хамаарах зарим албан тушаалтанд өөрчлөлт хийсэн. Тухайлбал 2002 оны хуулиар төрийн улс төрийн албан тушаалд "хэвлэл мэдээллийн ажилтаны албан тушаал, Улсын Их Хурал дахь нам эвслийн бүлгийн ажлын албаны албан тушаал"-ыг нэмж, "хуульд өөрөөр заагаагүй бол Засгийн газрын тохируулагч агентлагын дарга" байсныг хассан гэх мэт.

4. Хуулийн "төрийн үйлчилгээний албан тушаал"-д **агуулгын болон зарчмын шинжтэй** зарим өөрчлөлт найруулга хийгдсэн. Заримаас нь дурдвал "боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёл урлаг зэрэг төрийн байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаал" гэдэгт "боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёл урлаг зэрэг төрийн үйлчилгээний төсөвт байгууллагын" гэсэн өөрчлөлт оруулсан; "Засгийн газраас байгуулсан төрийн захиргааны бусад байгууллага болон хуульд өөрөөр заагаагүй бол аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх нутгийн захиргааны байгууллагын удирдах ба гүйцэтгэх албан тушаал"-ыг нэмсэн; "яам, тохируулах болон хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын агентлагын эрхлэх асуудлын хүрээнд ажилладаг төрийн өмчийн үйлдвэрийн газрын захиргааны албан тушаал"-ыг /энэ хэсгийг 2003 оны 1-р сарын 10-ны өдрийн хуулиар хассан/.

5. Хуулийн 10 дугаар зүйлийн " төрийн албан тушаалд тавих ерөнхий шаардлагад... " мэдлэг"-ийг нэмж" мэргэжлийн бэлтгэл" гэснийг "мэргэшсэн байх явдал" хэмээн өөрчилсөн.

6. Хуулийн 11.2-т төрийн захиргааны болон тусгай албан тушаалын ангилалын хүрээнд төрийн удирдах, гүйцэтгэх албан тушаалыг мэргэшлийн үндсэн дээр байнга эрхэлж байгаа Монгол Улсын иргэнийг төрийн жинхэнэ албан хаагч гэнэ гэж шинээр нэмсэн. Цааш нь хуулийн 13, 14, 15 дугаар зүйл "төрийн захиргааны албан хаагчийн нийтлэг үүрэг, эрх, үйл ажиллагаанд хориглох зүйл" байсныг "төрийн жинхэнэ албан хаагч" болгон нэмэлт хийж өргөтгөсөн. Мөн хуулийн "Төрийн захиргааны албан тушаал эрхлэх болзол, журам" гэсэн 4 дүгээр бүлэгт хуулийн 20 дугаар зүйлээс бусдыг нь "төрийн жинхэнэ албан тушаал" болгон бүхэлд нь өөрчилсөн.

7.1994 оны хуулийн "төрийн албаны удирдлага" гэсэн 33 дугаар зүйлийн 4-т төрийн байгууллага нь төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хангахтай холбогдсон дараах асуудлаар: 4.1 төрийн албан хаагчийн сургалт; 4.2 ...төрийн албан хаагчийн аж байдал; 4.3 ... төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа; 4.4...төрийн албан хаагчийн эрүүл мэнд; 4.5 ...төрийн албан хаагчийн амралт, сувилал; 4.6 ...төрийн албан хаагчийн аюулгүй байдал/ гэж байсныг "төрийн байгууллага нь дараах хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ; 33.4.1. Төрийн албан хаагчийн сургалт; 33.4.2 төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгаа" болгон өөрчлөн найруулжээ.

8.Өмнөх хуулийн 34.1-д "төрийн захиргааны албаны зөвлөл" гэж байсны "захиргааны" гэдгийг хасаж, "Төрийн албаны зөвлөл" хэмээн өөрчилж нэрлэсэн. Мөн хуулийн 35 дугаар зүйлд "Зөвлөлийн чиг үүрэг"

байсан бол "Зөвлөлийн бүрэн эрх" болж агуулгын хувьд баяжин нэр томъёо өөрчлөгдсөн гэх мэт.

Шинэчилсэн найруулгын дагуух нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн дээр дурдсанаар хязгаарлагдахгүй нь мэдээж.

2.3. 2002 оны "Монгол Улсын Төрийн албаны тухай хууль"-д 2008 онд орсон нэмэлт, өөрчлөлтийн онцлог

Монголын өнөөгийн нийгмийн хөгжлийн явцад төрийн албаны мэргэшсэн, тогтвортой байдлыг хангах, төрийн жинхэнэ алба хаагч төвийг сахиж, улс төржихгүй, зөвхөн төр, засагтаа үйлчилж, ард түмний тусын тулд ажиллах шаардлага хурцаар тавигдаж байна.

Гэвч төрийн албаны практикт төр, нийгмийн эрх ашгийг бус, намчирхан бүлгэрхэж, аль нэг намын эрх ашгийн төлөө зүтгэх, төрийн нэгдмэл бодлого, тогтвортой чанарыг алдаж, төрийг иргэнээс холдуулан нэр хүндийг нь бууруулах тохиолдол багагүй гарч байгаас улбаалан хэд хэдэн удаагийн чуулганд зүтгүүлэн байж 2008 онд Ерөнхийлөгчийн санаачилгаар Төрийн албаны тухай хуульд төрийн алба мэргэшсэн, тогтвортой байх буюу мерит зарчмыг хэрэгжүүлэх явдлыг улам илүү баталгаажуулсан агуулга бүхий томоохон нэмэлт, өөрчлөлт оруулсныг УИХ баталсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан оруулж, Монгол Улсын Их Хурлын хэлэлцэн баталсан Төрийн албаны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дараах гурван үндсэн чиглэлд хуваах болох юм.

1.Төрийн албаны мэргэшсэн, тогтвортой байдлыг хангах талаар. Ийм нэмэлт, өөрчлөлтөөс хэсэгчлэн дурдвал:

1.1 Төрийн зарим албан тушаалд тодорхойлолт өгсөн юм. Тухайлбал "Төрийн албаны тухай хууль"-ийн 7.1. төрийн захиргааны албан тушаалд "... төрийн бодлого боловсруулахад мэргэжлийн зөвлөгөө өгөх, уг бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах чиг үүрэг бүхий" албан тушаал хамаарна; мөн хуулийн 8.1: төрийн тусгай албан тушаалд "... үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, хууль дээдлэх үндсэн зарчмыг сахиулах, нийгмийн хэв журам хамгаалахтай холбогдсон" төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх албан тушаал хамаарна; мөн хуулийн 9.1: Төрийн үйлчилгээний албан тушаалд "...төрийн суурь үйлчилгээг адил тэгш, чанартай хүртээмжтэй хүргэх болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад" туслах чиг үүрэг бүхий албан тушаал хамаарна гэж шинээр нэмэлт оруулжээ.

1.2 Төрийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйлд: төрийн улс төрийн албан тушаалд байсан Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын Зөвлөлийн нарийн бичгийн дарга, Монгол Улсаас гадаад улс, олон улсын байгууллагад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг төрийн улс төрийн албан тушаалаас хассан, мөн баг, хорооны Засаг даргыг улс төрийн албан тушаалаас төрийн захиргааны албан тушаалд хамааруулж албан тушаалын ангилалыг өөрчилсөн.

1.3 Төрийн албаны тухай хуулийн 7.3-д төрийн захиргааны албан тушаалыг тэргүүн, эрхэлсэн, ахлах, дэс, туслах гэж ангилж байсан бол

төрийн жинхэнэ албан тушаалд бүхэлд нь хамруулан нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Үүний зэрэгцээ эрхэлсэн, ахлах, дэс, туслах түшмэлийн албан тушаалын ангилалтад нэмэлт хийж өөрчлөн найруулсныг мөн хуулийн 7.5-7.8-аас харьцуулан үзнэ үү.

1.4 Төрийн албаны мэргэшсэн, тогтвортой байдлыг хангах зарчмыг хэрэгжүүлсэн арав гаруй жилийн "баг бүрдүүлэх", "бүтцийн өөрчлөлт хийх" нэрээр төрийн жинхэнэ албан хаагчдыг халах, өөрчлөх практикийг харгалзан төрийн албан тушаалд тавих ерөнхий болон тусгай шаардлага, жинхэнэ албан тушаал эрхлэх болзол, журмыг хангах иргэнийг элдэв хэлбэрээр ялгаварлахгүй байх, хуульд заасан үндэслэл, журмаас гадуур халж солихгүй, ажил үүргээ гүйцэтгэхдээ аливаа улс төрийн нөлөөнөөс ангид хөдөлмөрлөх эрх зүйн зохицуулалтад энэхүү нэмэлт, өөрчлөлт хийхдээ ихээхэн анхаарал хандуулсаныг дурдах хэрэгтэй.

Жишээлбэл: "Төрийн албаны тухай хууль"-ийн 10.4-д төрийн захиргааны албан тушаалд тавих тусгай шаардлагыг шаардлагатай гэж үзвэл Засгийн газар хуульд нийцүүлэн тогтоож болохоор байсныг энэ өөрчлөлтөөр зогсоосон. Харин захиргааны албан тушаал эрхэлж байгаа албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг Засгийн газар тогтоохоор бол Төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн нэмэлт, өөрчлөлт оруулах болов.

Төрийн албаны тогтвортой байдлыг туушгай хангах үүднээс Төрийн албаны тухай хуулийн 10.5-ийг өөрчлөн найруулж, төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг болон "...улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй төвийг сахихтай холбогдсон зохицуулалтыг Төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн хөдөлмөрийн дотоод журам болон хөдөлмөрийн гэрээ, контрактаар тодорхойлно" гэх мэтээр томьёолсон.

1.5 "Төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх болзол, журам" гэсэн 4 дүгээр бүлгийн 16.2.4-т хуулийн дагуу цэргийн жинхэнэ алба хаах үүрэг хүлээсэн иргэн төрийн албаны онцлог төрөл болох энэ үүргээ биелүүлээгүй бол"., мөн зүйлийн 16.2.5-д "гадаадын иргэн, харьяалалгүй хүн"-ийг төрийн жинхэнэ албан тушаалд авч ажиллуулахыг хориглоно гэсэн нэмэлт оруулжээ.

1.6 Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх, жинхэнэ албан тушаалд авах талаарх "Төрийн албаны тухай хууль"-ийн 17.2-г энэ хуулийн 10.1-д заасан ерөнхий /төрийн албан тушаалд тавих ерөнхий шаардлага нь хуульд өөрөөр заагаагүй бол тухайн албан тушаалыг эрхлэх мэдлэг, боловсрол, туршлага, ур чадвар, мэргэшсэн байх явдал юм/ болон 33.5-д заасан тусгай /энэ шаардлагын талаар Төрийн албаны төв байгууллагын тухайн хэсэгт тусад нь авч үзнэ/ шаардлага, 16 дугаар зүйлд заасан болзлыг хангасан Монгол Улсын иргэн төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх эрхтэй гэж тодотгож өөрчлөн найруулжээ.

2. Улс төрийн намын гишүүнчлэлийн талаар. Төрийн албанд тогтвортой ажиллахад нөлөөлөх сөрөг хүчин зүйлийн нэг нь улс төрийн аль нэг намын гишүүнчлэлтэй байж, төрийн эрх ашгийн урд тухайн намын бодлого, зорилтоо хэрэгжүүлэхийг хичээх явдал юм.

2.1. "Төрийн албаны тухай хууль"-ийн 10.6-д "улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч нь төрийн албан тушаал эрхлэх хугацаандаа улс төрийн аливаа нам, хөдөлгөөний үйл ажиллагаанд ямар нэг хэлбэрээр оролцохгүй байх, хэрэв улс төрийн намын гишүүн бол намын гишүүнээс түдгэлзэж, төрийн тухайн албан тушаалд томилогдсон өдрөөс хойш 7 хоногийн дотор энэ тухайгаа байгууллагын захиргаа болон харьяалах намдаа бичгээр албан ёсоор мэдэгдэнэ" гэж томъёолжээ. Энэ нь 2009 оны 1 дүгээр сарын 1-ны өдрөөс хүчин төгөлдөр болж үйлчилж эхлэв.

2.2. Хуулийн 15.1.14-т "Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн сурталчилгаанд аливаа хэлбэрээр оролцох, түүнд зориулалтын бус төсвийн хөрөнгө зарцуулах, төрийн өмч хөрөнгийг дайчлах"-ыг төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаанд хоригложээ.

2.3. Хуулийн 23.2-т "Төрийн жинхэнэ албан хаагч Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын, түүнчлэн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвших болсон бол хуульд заасны дагуу нэр дэвчигчээр бүртгүүлэхээр сонгуулийн хороонд холбогдох баримт бичгийг ирүүлэхээс өмнө төрийн албанаас чөлөөлөгдөх өргөдлөө төрийн эрх бүхий албан тушаалтанд гаргана. Төрийн жинхэнэ албан хаагч өргөдлөө гаргаагүй нь тухайн төрийн байгууллага түүнийг төрийн албанаас чөлөөлөхөд саад болохгүй" гэсэн нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Эдгээр нь төрийн жинхэнэ албан хаагчийг тогтвортой үр нөлөөтэй ажиллуулах, түүнийг улс төржүүлэхгүй, улс төрийн намын нөлөөнөөс ангид байлгах чухал ач холбогдолтойг тэмдэглэж байна.

3. Төрийн албаны төв байгууллагын эрх хэмжээний талаар. Төрийн албаны удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах, түүний төв байгууллагын эрх хэмжээг өргөтгөх нь төрийн алба тогтвортой байх, төрийн жинхэнэ албан хаагчийн мэргэшлийн түвшинг дээшлүүлэх үндсэн нөхцөлийг бүрдүүлнэ.

Төрийн албаны төв байгууллагын эрх хэмжээтэй холбоотой олон шинэ зүйл, хэсэг нэмэгдэж, нэмэлт, өөрчлөлт орсноос заримыг нь хэсэгчлэн авч үзье.

3.1. Хуулийн 33.4-т заасанчлан: "Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 45.1-д заасан төрийн албаны удирдах албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтооно".

Хуулийн 33.5-д: "Энэ хуулийн 33.4-т зааснаас бусад төрийн жинхэнэ албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг төрийн жинхэнэ албан тушаалын ангилал, зэрэглэл бүрээр Төрийн албаны төв байгууллага тогтооно" гэж шинээр тус тус нэмжээ.

3.2. Хуулийн 34.3-т "Зөвлөл нь хамтын удирдлагын зарчмаар ажиллах бөгөөд дарга, 6 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Тэдгээрийн хоёр нь орон тооны, 4 нь орон тооны бус байна".

Хуулийн 34.4-т "Зөвлөлийн орон тооны 2 гишүүнд Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар тус бүр нэг хүний нэр

дэвшүүлэх бөгөөд нэр дэвшигч нь төрийн жинхэнэ албан тушаалд 15-аас доошгүй жил ажилласан, мэргэшсэн, ял шийтгэлгүй, 45 насанд хүрсэн иргэн байна".

Хуулийн 34.5-д "Зөвлөлийн даргыг Ерөнхийлөгчийн санал болгосноор Улсын Их Хурал 6 жилийн хугацаагаар томилох бөгөөд нэр дэвшигч нь төрийн жинхэнэ албан тушаалд 15-аас доошгүй жил ажилласан, удирдах ажлын дадлага, туршлагатай, ял шийтгэлгүй, 45 нас хүрсэн иргэн байна" гэж тус тус өөрчлөн найруулжээ.

Хуулийн 34.13-т "Зөвлөл нь орон тооны болон орон тооны бус салбар зөвлөл, ажлын албатай байна. Ажлын албаны даргыг Төрийн албаны зөвлөл томилж чөлөөлнө. Орон тооны салбар зөвлөл болон ажлын албаны зохион байгуулалтын бүтэц, орон тоо, төсвийг Улсын Их Хурал батална. Төрийн албаны төв байгууллага нь дэргэдээ сургалт, судалгааны болон зөвлөх үйлчилгээний нэгжтэй байж болно" гэх мэтээр удирдлага зохион байгуулалтыг нь бэхжүүлэх, бүрэн эрхийг нь өргөтгөх арга хэмжээ авчээ.

3.3. "Төрийн албаны хууль"-ийн 35-39 дүгээр зүйлд шинээр нэмсэн долоон хэсэг заалт байгаа нь энэ хуулийн 2008 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтийн нэгэн онцлог гэж үзэж болно.

Заримаас нь дурдвал:

Хуулийн 35.1.14. Төрийн албаны шинэтгэл болон сайн засаглалын зарчмыг хэрэгжүүлэх, өөрчлөлтийн менежмент, төрийн захиргааны болон хүний нөөцийн менежментийн асуудлаар гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, тэдгээрийн удирдах ажилтанг мэргэжил арга зүйн зөвлөлгөө, үйлчилгээгээр хангах.

Хуулийн 39.5. Төрийн жинхэнэ албаны хүний нөөцийн удирдлагатай холбоотой холбогдон гарсан эрх бүхий албан тушаалтны шийдвэр хууль зүйн үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол Төрийн албаны төв байгууллага өөрчлөх буюу хүчингүй болгох эрхтэй гэх мэт.

"Төрийн албаны удирдлага, зохион байгуулалт" гэсэн хуулийн 6 дугаар бүлэг, 8 зүйлд гэхэд шинээр нэмэгдсэн, өөрчлөн найруулсан 36 заалт-хэсэг байгаа нь Монгол Улсын Их Хурлын 2008 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар оруулсан нэмэлт, өөрчлөлт, бусад нэмэлт, өөрчлөлтийн дотор зонхилох байр суурь эзэлсэн, ялгагдах онцлогтойг харуулна.

2009 оны 5 дугаар сард баталсан хуульд Баг, хорооны Засаг даргыг төрийн захиргааны ангилалд багтаасан нь багагүй хэл ам дагуулсан. Тэднийг захиргааны ангилалд багтаасан учраас баг, хорооны Засаг дарга болох сонирхолтой хүмүүсээс төрийн албаны шалгалт авч, нөөц бүрдүүлчихээд байж байтал хуульд өөрчлөлт оруулж магадгүй гэзд зогсонги байдалтай болчихоод байсан. Ингэснээр бүрэн эрх нь дуусан баг, хорооны Засаг дарга нар ажиллах болсон.

Баг, хорооны Засаг даргыг захиргааны албан тушаалтан болгосон нь Үндсэн хуультай нийцэхгүй байна гэсэн Цэцийн дүгнэлт гарсан.

ТАЗ-өөс Цэцийн шийдвэр хууль зүйн болон нийгмийн таагүй үр дагавартай гэж үзсэн. Учир нь Баг, хорооны Засаг даргыг улс төрийн ангилалд хамруулах нь улстөржих нэг урхаг болдог, харин захиргааных

болгосон нь илүү үр дүнтэй гэж тухайн нутаг, орныхон үзэж байгаа. Тэднээс төрийн албан хаагчийн шалгалт авч, сонгон шалгаруулалт явуулсан нь зүйтэй ажил болсон. Засаг дарга нарын чадавхийг сайжруулах, нутгийн захиргааны болон өөрөө удирдах ёсны байгууллагыг бэхжүүлэхэд ихээхэн тус нэмэртэй болсон нь тодорхой харагдаж байгаа.

Улс төрийн юм уу, намчирхах үүднээс биш, сэтгэлээрээ ажилладаг хүмүүс л Засаг дарга байх ёстой. Гэтэл улс төрчид үүнийг өөрчлөх ёстой, хуульд яаралтай өөрчлөлт оруулна гээд эхэлсэн. Ганцхан хүнийг, хэн нэгний үзэмж, таалаар, намын бодлогоор томилдгийг олон түмэн эсэргүүцдэг юм. Ард иргэд ядаж гурван хүнээс сонголтоо хийхийг чухалчилдаг юм билээ.

ГУРАВ. ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТАЛААРХ /1994 ОНООС ХОЙШХ/ ТУСГАЙЛСАН СУДАЛГАА

Төрийн албаны хуулийн шинэчилсэн найруулгын гол онцлог нь нийгмийн хөгжлийн тухайн үеийн ололт, эрх зүйн практик хэрэглээ, хууль зүйн шинжлэх ухааны төлөвшлийн хүрсэн түвшинд тулгуурлан хийсэн шинэтгэлийн үр дүн байсан бол **2008 оны нэмэлт, өөрчлөлт нь** төрийн албаны мэргэшсэн тогтвортой байдлыг хангах; төрийн жинхэнэ алба, албан хаагчийн үйл ажиллагааг боловсронгуй болгох; төрийн жинхэнэ албан хаагч улс төржихгүй, төвийг сахиж, зөвхөн төр, засагтаа үйлчилж, ард түмний тусын тулд ажиллах; Төрийн албаны төв байгууллагын эрх хэмжээг өргөтгөх зэрэг цогц арга хэмжээг тусган хэрэгжүүлснээрээ бусад нэмэлт, өөрчлөлтүүдээс ялгагдах юм.

"Төрийн алба"-ыг Франц, ХБНГУ-д болон бусад зарим оронд нийтийн алба, нийтийн албаны эрх зүй, Их Британи, АНУ-д иргэний алба, ОХУ, Япон болон бусад оронд Төрийн алба[361] гэсэн нэр томъёогоор хууль зүйн ном зохиолд авч үзэж, зарим нь захиргааны эрх зүйн төрөл-хэсэг, голлох институтын нэг[362] эсхүл эрх зүйн дэд салбар хэмээн тайлбарласаар ирэв.

Монгол Улсын хувьд сурах бичиг, гарын авлага, сургалтын хөтөлбөртөө гол төлөв төрийн алба, судлаач Ж.Долгорсүрэнгийн хувьд сүүлийн үеэс өөрийн зарим бүтээлдээ[363] нийтийн албаны эрх зүй нь Монгол Улсын захиргааны эрх зүйн дэд салбар хэмээн бичсэн нь бий.

"Төрийн албан хаагч"-ийн тухайд бол наад зах нь гурван үзэл бодлоор авч үзэж болох юм. **Нэг дэх нь,** төр-эрх зүйн талаасаа төрийн албан хаагч-төрийн "зарц" /түүний байгууллагын/, төрийн чиг үүрэг хэрэгжүүлэгч, нийгэм, төрийн бүтээгдэхүүн мөн, **хоёр дахь нь** эрүүгийн эрх зүйн үүднээс төрийн албан хаагч бол эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэх онцгой субъект, албан тушаалтан мөн; **гурав дахь** нь захиргааны эрх зүйн үзэл бодлоор төрийн албан хаагч тусгай засаглах, зохион байгуулан захирах бүрэн эрхтэй, хууль хамгаалан хэрэгжүүлэх, захиргааны эрх зүйн санкци хэрэглэх чиг үүрэгтэй засаглалын төлөөлөгч гэж үзэж байна.

---

[361] Административное право зарубежных стран. Учебник. Под ред. А.Н.Козырина и М.А.Штатиной.-М., Спарк, 2003, 91-128, 240-252, 309-311, 342-353, 375-377, 427; Старилов.Ю.Н. Публичное право.-М.:1996 и др. "Административное право России.-3-е изд., перераб.и доп.-М: Юнити-Дана, 2008,-559.с" сурах бичигт "ОХУ-ын төрийн иргэний албаны үндэс" гэсэн бүлэг бий. 180-217 дахь тал.

[362] С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. Нэмж засварласан 2 дахь хэвлэл. УБ., 2008, 412 дахь тал.

[363] Ж.Долгорсүрэн. Монгол Улсын захиргааны эрх зүй. Ерөнхий анги. Сэдэвчилсэн гарын авлага. УБ., 2008, 150-158 дахь тал. Үүний урьд 2001 онд МУИС-ийн ХЗС-ийн "Эрх зүйн онол, практик, арга зүй, мэдээллийн цуврал" сэтгүүлийн №4-5-д ийнхүү бичигдсэн өгүүлэл буй.

3.1. Төрийн албан хаагчийн эрх зүйн байдлын ойлголт, үндсэн шинж, бүтэц

Төрийн албан хаагч гэдэг ойлголтыг өргөн, явцуу хоёр утгаар авч үзэж болно. Өргөн утгаар нь зөвхөн төрийн эрх мэдлийн байгууллагад төдийгүй, НӨУБ болон төрийн өмчийн үйлдвэр, албан газар, байгууллагад төрийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагчийг хамруулан ойлгоно.

Төрийн албан хаагчийг явцуу утгаар нь төрийн албан тушаал, өөрөөр хэлбэл зөвхөн төрийн эрх мэдлийн /хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн/ байгууллагад албан тушаал эрхэлж байгаа этгээд гэж ойлгож болох юм.

Төрийн аль ч албан хаагчийн эрх зүйн байдлын онцлог нь төрийн албан хаагчаас төрийн зорилт, чиг үүрэг, бүрэн эрхээ биелүүлэн хэрэгжүүлэх өвөрмөц чанартай нөхцөлдөн ... жишээлбэл цэргийн ба иргэний алба, татварын алба, дипломат алба, салбарын захиргааны үйл ажиллагаа зэрэг төрийн албаны янз бүрийн төрөл-тусгай шинжээр тодорхойлогдоно[364].

Төрийн албан хаагчийн эрх зүйн байдал нь эрх, үүргийн нийлбэр цогц, хариуцлага болон бусад бүрэлдэхүүн хэсэг, шинжийг өөртөө багтаасан хэд хэдэн элементүүдийн нарийн төвөгтэй, иж бүрэн төрөл-хэсэг мөн.[365]

Төрийн албан хаагчийн эрх зүйн байдал нь төрийн албан тушаал эрхэлж, албан үүрэг гүйцэтгэж, эрх эдлэхтэй холбогдон гарсан хууль тогтоомж, түүнд нийцэж гарсан эрх зүйн тодорхой актаар зохицуулагдана.

Төрийн албан хаагчийн эрх байдлыг хууль тогтоомжоор тогтоогдон баталгаажсан эрх, эрх чөлөө, үүрэг, хязгаарлалт ба хориглолт, албан хаагчийн хариуцлага зэрэг нөхцөл байдлыг өөртөө бий болгохтой холбон үзэж байна. Өөрөөр хэлбэл төрийн албаны харилцааг үүсгэж, өөрчилж, дуусгавар болгоно. Төрийн албаны харилцаа өөрчлөгдөх бүрт **албан хаагчийн эрх зүйн байдал нь** жишээлбэл, албанд орох, халагдах, огцрох, иргэний харьяаллаа алдах, тэтгэвэрт гарах зэрэгт **дагаад өөрчлөгдөнө**.

Монгол Улсын 1994 оны Төрийн албаны хуулиас өмнө төрийн алба, төрийн албан хаагчийн ойлголтын талаар хууль тогтоомжид ямар нэг тодорхойлолт байгаагүй. Харин 1994 оны болон 2002 оны шинэчилсэн найруулгад төрийн албан тушаалын ангилал, төрийн ямар албан тушаалд аль нь хамаарахыг нэг бүрчлэн заасан нь бий.

Улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг хуулиар тогтоох бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол Төрийн албаны тухай хуулийн холбогдох заалтыг дагаж мөрдөнө.

Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг Хөдөлмөрийн хууль, Төрийн албаны тухай хууль болон хууль тогтоомжийн бусад актаар тогтооно.

Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой, Төрийн албаны хуулиар зохицуулагдаагүй бусад асуудлыг Хөдөлмөрийн хуулиар зохицуулна.

[364] Старилов.Ю.Н. Курс общего административного права. В 3 т.п:государственная служба. Управленческие действия. Правовые акты управления. Административная юстиция.-М.:Издательство "Норма", 2002, С 35.

[365] Габричидзе.Б.Н., Чернявский.А.Т. Курс административного права Российской Федерации.В трех частях: Учебных

Төрийн жинхэнэ албан хаагчийн эрх зүйн байдлыг Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, хууль тогтоомжийн бусад актаар тогтооно.

"Монгол Улсын төрийн албаны хууль"-ийн 11 дүгээр зүйлд "Төрийн албан тушаалыг эрхэлж, бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг **төрийн албан хаагч** гэнэ"[366] гэж заажээ.

Төрийн албан хаагчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх ажиллагаа нь дараахь үндсэн шинжийг өөртөө агуулна. Үүнд:

- Төрийн удирдан зохион байгуулах үйл ажиллагааны бүрэлдхүүн хэсэг
- Албан хаагчийн ажлын зорилго, агуулга нь төрийн зорилт, чиг үүргийг практикт биелүүлэх ажиллагаа
- Тусгайлан бэлтгэгдсэн төрийн албан хаагч эзэмшсэн мэргэжлийнхээ үндсэн дээр ажиллана.
- Төр төлөөлөн, түүний нэрийн өмнөөс албан тушаалын үүрэг гүйцэтгэж, үүнийхээ төлөө улсаас цалин хөлсөөр хангагдана.
- Төрийн албаны харилцааны ихэнх нь захиргааны эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдана гэх мэт.

Бидний бодлоор бол төрийн албан хаагчийн онолын зарим тодорхойлолт, эрх зүйн зохицуулалтад шинжилгээ хийн **төрийн жинхэнэ албан хаагчийн эрх зүйн байдлын агуулгын бүтцийг бүлэглэн ангилбал:**

1. төрийн албан тушаал ба албан хаагчийн засаглан захирах эрх мэдэл;
2. албан тушаалын үүрэг, эрх;
3. хуулиар тогтоосон хязгаарлалт, хориглолт;
4. албан хаагчийн баталгаа;
5. урамшил ба хариуцлага гэсэн өөр хоорондоо харилцан холбоотой цогцолбор шинжтэй ажиллагаа хэмээн томъёолж байна.

3.2. Төрийн албан тушаал ба албан хаагчийн засаглан захирах эрх мэдэл

Төрийн албан хаагчийн захиргааны эрх зүйн байдал нь төрийн байгууллагын эрх хэмжээнээс үүсмэл. Хамгийн гол нь **төрийн албан тушаал** юм.

Албан тушаал нь төрийн тухайн байгууллагын зохион байгуулалтын **үндсэн нэгж**, төрийн албаны **анхны бүрдүүлбэр** хэсэг юм. Төрийн албан хаагч төрийн аль нэг байгууллагад тодорхой албан тушаал эрхлэн, албан тушаалын зорилт, чиг үүргийг бүрэн эрхийн хүрээнд өдөр тутам гүйцэтгэдэг. Тухайн албан тушаалд ажлын шаардлагаас хамааран төрийн хичнээн албан хаагч ажиллахыг орон тоогоор тогтооно.

Төрийн албан хаагчийн албан тушаалын чиг үүргээ хэрхэн, амжилттай гүйцэтгэх нь түүний засаглан захирах эрх мэдэлтэй шууд холбоотой. Иймд албан тушаал, албан тушаалын засаглах бүрэн эрх нь өөр хоорондоо харилцан хамааралтай, албан хаагчийн эрх зүйн байдлыг тодорхойлдог үндсэн асуудал юм.

[366] "Төрийн мэдээлэл". 2002., №28-аас тодруулан үзнэ үү.

Албан тушаал нь засаглах эрх мэдэл, албан үүрэг, эрхийн тодорхой хэмжээг тогтооно. Тэгэхлээр төрийн албан тушаал эрхэлсэн албан хаагч бүхэн засаглан захирах бүрэн эрхийг эдлэхгүй. Төрийн үйлчилгээний албан хаагч, багш, эрдэм шинжилгээний болон захиргааны туслах ажилтан гэхэд захиран засаглах бус, сургах, судалгаа хийх, хүнд үйлчлэх зэрэг үүрэг хүлээж, түүндээ зохицсон эрх эдэлнэ.

Төрийн албан хаагчийн дотор **төрийн жинхэнэ албан хаагч** илүү эрх мэдэлтэй, төрийн зорилт, чиг үүрэг, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

Үүнээс үүдэлтэй Төрийн албаны хуулийн 5.1-д төрийн улс төрийн, захиргааны, тусгай, үйлчилгээний гэж ангилан, мөн зүйлийн 5.2-т төрийн захиргааны болон тусгай албан тушаалыг **төрийн жинхэнэ албан тушаал**, хуулийн 11.2-т албан тушаалын энэ ангиллын хүрээнд төрийн удирдах, гүйцэтгэх албан тушаалыг **мэргэжлийн үндсэн дээр байнга эрхэлж байгаа** Монгол Улсын иргэнийг **төрийн жинхэнэ албан хаагч** гэж заасан билээ.

Төрийн албан тушаалын тодорхойлолт хуульд байхгүй боловч 2008 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр зохих тодотгол хийгдсэнийг хэлэх нь зүйтэй.

Тухайлбал, "Төрийн албаны тухай хууль"-ийн 7.1-д Төрийн захиргааны албан тушаалд "... **төрийн бодлого боловсруулахад зөвлөгөө өгөх, уг бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүрэг** ..." бүхий албан тушаал хамаарна, мөн хуулийн 8 дугаар зүйлийн 1-д төрийн тусгай албан тушаалд "... **үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, хууль дээдлэх үндсэн зарчмыг сахиулах, нийгмийн дэг журам хамгаалахтай холбогдсон**" албан тушаал хамаарна; мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 1-д төрийн үйлчилгээний албан тушаалд "... **төрийн суурь үйлчилгээг адил тэгш, чанартай, хүртээмжтэй хүргэх болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад**" туслах чиг үүрэг бүхий албан тушаал хамаарна гэх мэтээр албан тушаалын зориулалтыг тодруулан заажээ.

3.3. Төрийн жинхэнэ албан хаагчийн үүрэг гүйцэтгэлийн тухайд

Төрийн жинхэнэ албан хаагчид **төрийн захиргааны** болон тусгай албан тушаал эрхэлсэн албан хаагч багтах бөгөөд "Төрийн албаны тухай хууль"-ийн 7.1-д заасан төрийн захиргааны зарим албан тушаалыг дурдвал: :

- Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, шүүх, Үндсэн хуулийн Цэц, прокурорын байгууллагын ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал;
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал;
- Хүний эрхийн Үндэсний Комиссын ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал;
- Монгол Улсын яамны Төрийн нарийн бичгийн дарга, хуульд өөрөөр заагаагүй бол тохируулах болон хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын агентлагийн удирдах ба гүйцэтгэх албан тушаал,

- Төрийн албаны Зөвлөлийн орон тооны ґишүүн; ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал;
- аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал гэх мэт;

Хуулийн 8 дугаар зүйлд заасан төрийн тусгай албан тушаалын заримаас нэрлэвэл:

- Үндсэн хуулийн Цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор;
- Монгол банкны Ерөнхийлөгч, тэргүүн дэд, дэд Ерөнхийлөгч, Үндэт цаасны хорооны дарга, Үндэсний статистикийн газрын дарґа, дэд дарга;
- Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Хилийн цэргийн удирдах газрын дарга, Улсын иргэний хамгаалалтын газрын дарга;
- дипломат ажилтан;
- зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, цагдаа, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, гал түймэртэй тэмцэх байгууллагын офицер, ахлагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, гаалийн байцаагч;

Төрийн аль ч албан хаагчид эрх зүйн байдлын үндсэн элемент нь **үүрэг хүлээх явдал.** Үүрэг нь албан тушаалын үндэс, үйл ажиллагааны агуулга. Төрийн албан хаагчийн олон янзын үүргийг: 1/ албаны нийтлэг, 2/ албан тушаалын, 3/ мэргэжлийн, 4/ хязгаарласан гэж хуваан үзэж болно.

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлд зааснаар төрийн жинхэнэ албан хаагчид хамааралтай албаны нийтлэг үүрэг нь:

- Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх;
- эх орон, ард түмнийхээ тусын тулд иргэний ёсоор төрийн ашиг сонирхолд захирагдан өөрт олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ажиллах;
- төрийн албаны болон төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн байгууллага, албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэн дээдлэх;
- албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй төвийг сахих, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр төр, засгийн бодлоготой холбогдсон асуудлаар зөвхөн албан ёсны байр суурийг илэрхийлэх;
- албан тушаалтны хууль бус, шударга бус явдалтай эвлэршгүй байх;
- төрийн албан тушаалд томилогдмогц өөрийн өмчийн байдлын талаар мэдэгдэж, өмчийн байдалд орсон өөрчлөлт, орлогын талаар зохих байгууллагад мэдээ өгч байх гэх мэт.

Төрийн жинхэнэ албан хаагч дээрх нийтлэг үүргээс гадна өөрийн эрхэлж байгаа албан тушаалаас хамааран **албан тушаалын** болон **мэргэжлийн** онцлог шинжийг агуулсан үүрэг гүйцэтгэнэ. Эдгээр үүрэг нь хуулиар тогтоогдсон байх ба зарим тохиолдолд хуульд нийцүүлэн тухайн салбарын эрх бүхий албан тушаалтан нарийвчлан тогтоож болно.

Төрийн албан хаагчийн **албан тушаалын** үүрэг нь эрхэлж буй албан тушаалтайгаа холбоотой. Иймд албан тушаал бүрт янз бүр байна.

Нэг байгууллагад ижил албан тушаалд ажиллаж байгаа хүнд байгууллагын захиргаа нь албаны зарим үүргийг ажлын байрны тодорхойлолтод өөр өөрөөр тусган тогтоож болно.

Монголын гаалийн байгууллагаар төлөөлүүлэн авч үзвэл албан тушаалын, мэргэжлийн өөр өөр үүргийг гүйцэтгэнэ. Гаалийн төв байгууллага, түүний харьяа гаалийн газар, хорооны дарга, тухайн байгууллагынхаа үйл ажиллагааг бүхэлд нь удирдан зохион байгуулдаг бол гаалийн улсын байцаагч хууль тогтоомж түүнд нийцсэн эрх зүйн актын хүрээнд албаны хяналт, хяналт шалгалтын үүрэг гүйцэтгэнэ.

"Гаалийн тухай Монгол Улсын хууль"-ийн 274 дүгээр зүйлд зааснаар Гаалийн байгууллага, гаалийн улсын байцаагчийн гүйцэтгэх албан тушаалын болон мэргэжлийн зарим үүргээс дурдвал:

- гаалийн хяналт, бүрдүүлэлтийг хийхдээ төр, байгууллага, хувь хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохироохгүй, албан тушаалаа урвуулан ашиглахгүй, хэтрүүлэхгүй байх;
- гаалийн хууль тогтоомжийг зөрчсөн хууль бус үйлдэл /эс үйлдэхүй/-ийн талаар зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлэх гэх мэт.

Төрийн албан хаагчийн **мэргэжлийн үүрэг нь** тухайн байгууллагын тодорхой албан тушаалын үүргээс илүү өргөн утга агуулгыг илэрхийлнэ. Жишээлбэл, Цагдаагийн байгууллагын ямар ч албан тушаалын албан хаагч өөрийн хариуцдаггүй нутаг дэвсгэрт, тухайлбал нийслэлийн өөр дүүрэг, эсхүл орон нутагт гэмт хэрэг, золгүй тохиолдол, осол гарсантай тааралдсан бол тухайн цаг үед нь холбогдох байгууллагад мэдээлэх, эмнэлгийн өмнөх бололцоотой туслалцаа үзүүлэх, хүний амь нас аврах, уг аюулыг таслан зогсоох гэх мэт үүргийг хуулиар хүлээлгэсэн байдаг.

3.4. Төрийн жинхэнэ албан хаагчийн эдлэх эрхийн тухайд

Төрийн албан хаагчийн эрх нь хуулиар хүлээсэн үүргээ өдөр тутам биелүүлэх, түүний хэрэгжилтийг хангах нөхцөл бололцоо юм. Ийм эрхийг үүргийн нэгэн адил ерөнхийд нь албаны нийтлэг, албан тушаалын болон мэргэжлийн гэж гурав хуваан үзэж болох юм.

Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг эрхийг "Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлд дараах байдлаар тусгажээ.

- төрийн тухайн албан тушаалын чиг үүрэг, эрх хэмжээг тогтоосон албан тушаал /ажлын байр/-ын тодорхойлолтыг албан ёсоор гаргуулан авах, түүнийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхийг шаардах;
- үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө, түүний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн биелэлт, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн талаар харьяалах дээд шатны удирдах ажилтны үнэлгээг зөвшөөрөх, эс зөвшөөрөх;
- цалин хөлсөө нэмэгдүүлэх, албан тушаалын зэрэглэл дэвших, ажиллах нөхцөл, баталгаагаа сайжруулахтай холбогдсон саналыг дээд шатныхаа албан тушаалтанд амаар буюу бичгээр тавих;
- хууль тогтоомжоор хориглоогүй, албан тушаалынхаа ашиг сонирхолд харшлахгүй арга хэлбэрээр хувийн аж ахуйгаа гардан эрхлэх, аж ахуйн

нэгжийнхээ үйл ажиллагааг өөрийн итгэмжлэгдсэн хүнээр хөтлүүлэх зэргээр орлого олох гэх мэт.

Гаалийн улсын байцаагчийн тухайд дээр дурдсан нийтлэг эрхээс гадна Гаалийн тухай хуулийн 274 дүгээр зүйлд зааснаар эрхэлж буй албан тушаалтайгаа холбоотой дараах эрх эдэлнэ.

- гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавьж, бүрдүүлэлт хийх;
- гаалийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор иргэн, албан тушаалтанд хууль ёсны шаардлага тавьж биелэлтийг хангуулах;
- гаалийн бүрдүүлэлттэй холбоотойгоор аж ахуйн нэгж, байгууллагын байр, агуулахад нэвтрэн орж үзлэг тооллого хийх, тэдгээрийн данс, бүртгэлийг шалгах;
- гаалийн болон бусад татвар ногдох барааг нуусныг гэрчлэх баримт, материалыг татвар төлөгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс түр хугацаагаар хураах, эсхүл хуулбарлуулан авах;
- гаалийн хууль тогтоомж зөрчсөн захиргааны зөрчилд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх гэх мэт.

3.5. Төрийн жинхэнэ албан хаагчийн эрх зүйн байдлын хязгаарлалт ба хориглолт

Хязгаарлалт гэдгийг тодорхой үйл ажиллагаа явуулах, хийхийг хориглоно гэсэн утгаар ойлгож болох юм. Энэ нь эс үйлдэлд ч нэгэн адил хамаарах ба төрийн жинхэнэ албан тушаал эрхэлж байгаа хугацаанд хууль тогтоомж дахь тухайн хэм хэмжээ үйлчилнэ.

Нийтийн албан хаагчийн гол үүрэг нь албаны үүргээ шударгаар биелүүлэх явдал юм. Энэ үүргээ хэрэгжүүлэхэд албан хаагчид хүлээлгэж болох тодорхой хязгаарлалтыг хасахгүй гэж үздэг.[367]

Хуулиар тогтоосон зарим хязгаарлалт, хориглолт нь Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан хүний эрх, эрх чөлөөг хясан боогдуулсан хэрэг биш. Харин төрийн жинхэнэ албан хаагчийн ажлыг үнэнч шударгаар үр нөлөөтэй гүйцэтгэх нөхцөлийг хангах, иргэдэд түүний итгэх итгэлийг улам нэмэгдүүлэх, албан тушаалаа урвуулан ашиглах, хэтрүүлэхээс сэргийлэх чухал ач холбогдолтой.

"Монгол Улсын Төрийн албаны тухай хууль"-ийн 15 дугаар зүйлд зааснаар төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглохоор тусгажээ. Үүнд:

- албан үүрэгтэйгээ холбогдолгүй асуудлаар нам, олон нийтийн болон шашны байгууллагын үйл ажиллагаанд төрийн албан хаагчийн хувьд оролцох;
- ажил хаялт болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад чиглэсэн бусад арга хэмжээ төлөвлөх, зохион байгуулах, тэдгээрт оролцох;
- албан тушаалынхаа бүрэн эрхийг хэрэгжүүлсний төлөө бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс мөнгөн шагнал, шан харамж, зээл

[367] Административное право зарубежных стран: Учебник. Под ред. А.Н.Козырина и М.А.Штатиной.-М., Спарк, 2003, С 118.

авах, төлбөргүй буюу хөнгөлөлттэйгээр үйлчлүүлэх зэрэг хууль бус бусад хангамж эдлэх;

- нутгийн өөрөө удирдах байгууллага, аж ахуйн нэгж, нам, олон нийтийн бусад байгууллагад орон тооны албан тушаал хавсран гүйцэтгэх;
- хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол хувь нийлүүлсэн аж ахуйн нэгжийг гардан удирдах, тэдгээрийн удирдах зөвлөлийн болон захиргааны гишүүн байх;
- хувийн ашиг сонирхлын үүднээс дотоодын болон гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмнө үүрэг хүлээх, санхүүгийн болон бусад туслалцаа авах;

Гаалийн улсын байцаагчийн тухайд Төрийн албаны тухай хуулийн дээр дурдсанаас гадна Монгол Улсын Гаалийн тухай хуулийн 275 дугаар зүйлд зааснаар дараах үйл ажиллагаа явуулахыг хоригложээ. Үүнд:

- улс төрийн намын гишүүн байх;
- өөрийн нь гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүмүүсийн гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт, бүрдүүлэлт хийх, эсхүл уг үйл ажиллагаанд оролцох, нөлөөлөх;
- энэ хуульд зааснаас бусад мэдээлэл шаардах, иргэдэд чирэгдэл учруулах, бусдад давуу байдал олгох зэргээр ялгаварлах гэх мэт.
- жинхэнэ албан тушаал эрхлэхтэй нь холбоотой албан хаагчийн эрх зүйн байдалд иймэрхүү хязгаарлалт хийсэн, хориглосон заалт салбарын бусад хуулиудад бий. Харин төрийн албан хаагчийн эрх зүйн байдалд хийх хязгаарлалт, хориглолт нь зөвхөн тухайн албаны үүрэг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай байхаас бус, хүний түгээмэл эрхийг хязгаарласан, дордуулсан байж үл болно.

3.6. Төрийн албан хаагчийн баталгааны тухайд

Төрийн албан хаагчийн баталгаа нь төрийн албан тушаал эрхэлж буй бүх хүнд нэгэн адил хамааралтай. "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгаа" гэсэн нэгэн бүлэг асуудал "Монгол Улсын Төрийн албаны тухай хууль"-иар баталгаажин мөрдөгдөж байна.

Төрийн албан хаагчийн нийтлэг болон нэмэгдэл баталгааг **эдийн засгийн, нийгмийн, эрх зүйн, зохион байгуулалтын** гэх мэтээр дотор нь хуваан үзэж болох юм. "Төрийн албаны тухай хууль"-ийн 27 дугаар зүйлийн 1-д баталгааг зориулалт, шинж байдал, эх үүсвэр, онцлог зэргийг харгалзан цалин хөлс, нөхөн төлбөр, тусламж, шагнал, урамшил, тэтгэвэр, тэтгэмж гэж төрөлжүүлэн тус бүрийг тусгайлан авч үзжээ.

Төрийн албаны тухай хуулийн 27.2.4, 28, 31, 38 дугаар зүйлд **төрийн албан хаагчийн эдийн засгийн баталгааны** нэг болох цалин хөлс, цол, зэрэг дэвийн нэмэгдэл, шагнал урамшил, санхүүгийн баталгаа, зохих журмын дагуу албаны унаа хэрэглэх, ажилдаа ирэх, буцах нийтийн тээврийн унааны зохих хэсгийг нөхөн авах зэрэг, төрийн жинхэнэ албан хаагчийн нэмэгдэл баталгааны талаар нарийвчлан тусгажээ. Жишээлбэл, уг хуулийн 27.2.4-т "төрийн байгууллагад тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах албан хаагчид аминдаа орон сууц барих болон орон сууц, амьдралын нэн тэргүүний хэрэгцээт зүйлс худалдан авах, өөрийн хүсэлтээр суралцах

болон хүүхдээ сургахад нь зориулан байгууллагаас нь хөнгөлөлттэй зээл олгох, шаардлагатай бол зээлийн баталгаа гаргаж өгөх"-өөр тусгасан. Энэ хуулийн төрийн албан хаагчийн баталгааг зохицуулсан зүйлд буюу 28.10 дахь хэсгийг 2002 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн хуулиар нэмсэн[368].

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 49 дүгээр зүйлд албан хаагчид урамшуулал олгох талаар заасан. Ингэхдээ бүтээгдэхүүн нийлүүлэх, өөрийн буюу удирдаж байгаа ажилтнуудынхаа ажлын үр дүнг сайжруулахад тухайн албан хаагчийн оруулсан хувь нэмэр болон байгууллагын үйл ажиллагааны санхүүгийн үр дүн болон урсгал зардлын хэмнэлтийн хэмжээг харгалзана.

Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг Төрийн албаны тухай хуулийн 27.1, 27.3, 29, 30, 32 дугаар зүйлээр зохицуулсан. Жишээлбэл, тус хуулийн 29.1-д "Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах зорилгоор түүний цалин хөлснөөс төлбөл зохих бүх шимтгэлийн болон эрүүл мэндийн даатгалын хураамжийн 80-аас доошгүй хувийг төрийн байгууллагын төсвөөс нөхөн төлнө" гэжээ. Мөн зүйлд албан томилолтын зардал болон төрийн албан хаагчийн тэтгэмж, тусламжийн талаар тусгажээ. Мөн шаардлагатай ажиллах нөхцөлөөр хангуулах, ээлжийн амралт эдлэх, төрийн алба хаах хугацаанд болон тэтгэвэрт гарсан үедээ хууль тогтоомжоор тогтоосон нөхцөл, журмын дагуу тухайн жилийн эмчилгээний төлбөрийн хэмжээнээс давсан хэсэг, зохих хувь, гэр бүлийн нь болон асрамжид байдаг хүмүүст олгох уналга, тээврийн зардал, тэтгэвэр, тэтгэмж, тэтгэлэг авах, нийгмийн даатгалаас олгох тэтгэмжээс гадна гэр бүлийг дэмжиж хуульд заасан тусламж үзүүлэх гэх мэтийг оруулж болно.

Төрийн албан хаагчийн өндөр насны тэтгэвэр, тэтгэмж олгохтой холбоотой харилцааг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай /1994 оны 6 дугаар сарын 7-ны өдөр батлагдсан. 1999 оны 1 дүгээр сарын 21-нд, 1999 оны 6 дугаар сарын 10-нд, 2000 оны 4 дүгээр сарын 20-нд, 2002 оны 4 дүгээр сарын 19-нд, 6 дугаар сарын 20-нд, 2003 оны 6 дугаар сарын 12-нд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан/ болон Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай /1999 оны 6 дугаар сарын 10-ны өдөр/ хуулиар, төрийн үйлчилгээний албан хаагчийн хөдөлмөрийн эрхийн харилцааг Хөдөлмөрийн тухай /1999 оны 5 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан. 2001 оны 11 дүгээр сарын 30-нд, 12 дугаар сарын 27-нд, 2002 оны 7 дугаар сарын 10-нд, 2003 оны 5 дугаар сарын 2-нд, 2003 оны 5 дугаар сарын 22-нд, 2006 оны 1 дүгээр сарын 12-нд нэмэлт, өөрчлөлт орсон/ хуулиар зохицуулж байна.

Эрх зүйн гэдэгт дээр дурдсан баталгаа хууль зүйн утгаараа хамаарахын зэрэгцээ төрийн албан хаагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд болон албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх зэрэг хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас түүний ажиллаж байгаа төрийн байгууллага нь хамгаалах үүрэг хуулиар хүлээдэг. Энэ нь эрх зүйн баталгааны тод жишээ юм.

[368] Төрийн өндөр албан тушаалтан болон түүнтэй адилтгах албан тушаалтны цалинг төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг харгалзан Улсын Их Хурал тогтооно.

Төрийн албан хаагчийн эрх зүйн баталгааг Төрийн албаны тухай хуулийн 4.2.7, 25 дугаар зүйл, 27.2.1, 27.2.2, 27.2.3 дугаар зүйлээр зохицуулсан. Жишээлбэл, Төрийн албаны тухай хуулийн 4.2.7-д "хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад гаргасан алдааны улмаас төрийн албан хаагчийн учруулсан хохирлыг төр хариуцах"-аар тусгасан. Мөн Иргэний хуулийн 498.2-т "Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч албан үүргээ зөрчсөн гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ийн улмаас бусдад гэм хор учруулсан бол уг гэм хорыг түүний ажиллаж байгаа хуулийн этгээд буюу төр хариуцан арилгана". 498.4-т "Хууль бусаар яллагдагчаар татагдсан, ял шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан буюу гадагш явахгүй гэсэн баталгаа өгсөн, захиргааны журмаар баривчлагдсан этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээсэн тохиолдолд түүнд учирсан хохирлыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор болон шүүгчийн буруутай эсэхээс үл хамааран төр хариуцан арилгана" гэж заасан.

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль 2002 оны 6 дугаар сарын 27-ны өдөр батлагдсан бөгөөд энэ хуульд 2003 оны 1 дүгээр сарын 2-ны, 6 дугаар сарын 20-ны, 2005 оны 1 дүгээр сарын 27-ны, 2005 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн нэмэлт, өөрчлөлт оруулжээ. Хуулийн 14.1.8-д "ажилтныг үндэслэлгүйгээр ажлаас халах, энэ хуулийн 5.1.3-т заасан[369] зарчмыг зөрчих"-ийг улсын төсвийн байгууллагад хоригложээ.

Эдгээр хуулиудаас гадна төрийн тусгай албан хаагчийн хувьд салбар байгууллагын тухай хуулиар давхар эдийн засаг, хууль зүйн баталгааг заажээ. Тухайлбал, Шүүхийн тухай хуулийн 76-87 дугаар зүйл, Прокурорын байгууллагын тухай хуулийн 33-38 дугаар зүйл, Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 37-38 дугаар зүйл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 137 дугаар зүйлд нийгэм, эдийн засаг, эрх зүйн нэмэгдэл баталгааг заажээ.

Төрийн жинхэнэ албан хаагчийн хувьд "Монгол Улсын Төрийн албаны тухай хууль"-ийн 27.2; 30.2-т заасан дараах нэмэгдэл баталгаагаар хангагдана. Үүнд:

Төрийн албаны тухай хуулийн 25 дугаар зүйл, 26.1.3-т зааснаас бусад тохиолдолд төрийн албанаас халагдахгүй байх;

- Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, бүх шатны Засаг даргын бүрэн эрх дуусгавар болох, мөн энэ хуульд заасан улс төрийн албан тушаалтан уг албан тушаалаас өөрчлөгдөх нь төрийн жинхэнэ албан хаагчийг өөрчлөх үндэслэл болохгүй байх;
- төрийн байгууллага өөрчлөн байгуулагдсан /нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх/, эсхүл зохион байгуулалтын бүтэц нь өөрчлөгдсөн боловч төрийн албан хаагчийн албан тушаал /ажлын байр/-ын тодорхойлолтод заасан чиг үүрэг хэвээр хадгалагдан үлдсэн бол түүнийг уг албан тушаалд нь үргэлжлүүлэн ажиллуулах, хэрэв тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх албан тушаал /ажлын байр/-ын орон тоо цөөрсөн бол

[369] Албан хаагчийг зөвхөн мэдлэг, боловсрол, мэргэжил, туршлага, мэргэшлийн ур чадварын үндсэн дээр нээлттэй өрсөлдөөний зарчмаар томилох, ажлын үр дүнг нь бодитойгоор үнэлэх;

уг албан тушаалыг эрхэлж байсан албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ, мэдлэг, ур чадвар, ажлын дадлага, туршлага зэргийг нь харгалзан тухайн албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хамгийн илүү хангаж байгаа албан хаагчийг томилох эрх бүхий албан тушаалтан нь шалгаруулж авах;

- төрийн байгууллага татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан, эсхүл өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар албан тушаалын орон тоо нь хасагдсан тохиолдолд цалин хөлсөө бууруулахгүйгээр мэргэжил, мэргэшлийн дагуу өөр ажил, албан тушаалд шилжих буюу төрийн хөрөнгөөр 6 сар хүртэл хугацаагаар дахин мэргэшиж болох бөгөөд энэ хугацаанд урьд нь эрхэлж байсан албан тушаалынхаа цалин хөлсийг авч, хууль тогтоомжид заасан журмын дагуу ажлын байраар хангуулах, эсхүл 6 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэлэг тухайн байгууллагаас олгоно;
- Төрийн албанаас чөлөөлөгдсөн тохиолдолд 6 сарын албан тушаалын цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж, үүргээ гүйцэтгэхтэй холбогдон амь нас хохирсон тохиолдолд ар гэрт нь 3 жилийн албан тушаалын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тусламж олгох гэх мэт.

Эцэст нь тэмдэглэхэд дээрх баталгаа нь төрийн албан хаагчийн хуульд заасан үүргээ үнэнч шударгаар гүйцэтгэх, үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөл, нийгэм ахуй, эдийн засаг, эрх зүй, сэтгэл зүйн бүрэн бодит хамгаалалтыг бүрдүүлсэн байдгаараа чухал ач холбогдолтой.

3.7. Төрийн жинхэнэ албан хаагчийн урамшуулал, хариуцлага

Хариуцлага нь өндөр шаардлага, зохион байгуулалттай ажиллах, албаа сахилгатай гүйцэтгэх харилцан уялдаатай нөхцөлийг бүрдүүлэгч төрийн албан хаагчийн захиргааны эрх зүйн байдлын бүтцэд хамгийн нөлөөтэй, нэг салшгүй хэсэг, хууль ёс, сахилгыг бэхжүүлэх чухал хэрэглүүр юм.

Одоогоор хариуцлага хүлээлгэдэг гол үндэс нь Төрийн албаны тухай хууль болно. Тухайлбал, Хуульд өөрөөр заагаагүй бол удаа дараа /2 ба түүнээс дээш/ албан үүргээ хангалтгүй биелүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон, Монгол Улсын харьяатаас гарсан зэрэг нөхцөлд ажлаас хална[370].

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 3-д "Төрийн хяналт шалгалт нь Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Төрийн аудитын байгуллага болон төрийн захиргааны байгуллагын хяналт шалгалт /цаашид "мэргэжлийн хяналт" гэх/, Үндсэн хуулийн Цэц, шүүх, прокурорын хяналт, нутгийн өөрөө удирдах байгуллагаас энэ хуулийн дагуу хэрэгжүүлэх хяналт шалгалтаас бүрдэнэ" гэж заасан нь хуулийн биелэлтийг хянах эрх зүйн үндсийг төрөлжсөн хуулийн хэмжээнд тодорхойлсон байна. Иймд төрийн болон нэгжийн өөрөө удирдах байгуллагаас хуулийн биелэлтийг хянан шалгана. Энэ талын харилцааг УИХ-ын тухай, Ерөнхийлөгчийн тухай, ҮХ-ийн Цэцийн тухай гэх зэргийн төрөлжсөн хуулиар нарийсган зохицуулсан байдаг.

[370] Төрийн албаны тухай хууль. 25 дугаар зүйл.

Мөн төрийн жинхэнэ албанд хориглох зүйлийг зөрчсөн болон албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн тохиолдолд тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг харгалзан хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан хаагчид сануулах, албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 2О хүртэл хувиар бууруулах; дараах сахилгын шийтгэлийн аль нэгийг ногдуулна, төрийн албанд 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах[371].

2002 онд Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай болон захиргааны хэргийн шүүх байгуулах тухай хуулийг тус тус батлан гаргасан нь Захиргааны байгууллага, албан тушаалтны хийсэн үйлдэл тус бүрийг болон хийгээгүй үйлдлийг нь хүртэл хууль ёсонд хэрхэн нийцэж байгаа талаар хянах шүүхийн тогтолцоог үүсгэн бий болгосон байна.

Авилгын эсрэг хуулийн шинээр үйлчилж байгаа нь төрийн байгууллага хууль ёсыг сахих бас нэгэн баталгаа болсон байна. Энэүү хуулиар авилгалаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах, хуулийн үйлчлэлд хамрагддаг[372] этгээдэд хориглох зүйлийг тогтоож, албан үүргээ гүйцэтгэж явахдаа авилгалын талаар мэдээлэл олсон төрийн байгууллага, албан тушаалтан мэдээллийг Аилгатай тэмцэх газарт мэдэгдэх үүрэгтэй болохыг, хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргах, бүртгэх, хадгалах харилцааг зохицуулсан байна.

Төрийн захиран засаглах бүрэн эрхээ хэтрүүлэх, эсхүл албаны үүргээ зохих ёсоор биелүүлэхгүй тохиолдолд эрх зүйн зөрчилд үзэн, хууль зүйн хариуцлага хүлээлгэнэ.

Төрийн жинхэнэ албан хаагчид хүлээлгэх хууль зүйн хариуцлагын гол төрөл нь **сахилгын шийтгэл** юм. Сахилгын хариуцлага хүлээлгэх үндэслэл нь сахилгын зөрчил гаргаж албаны үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн гэм буруутай төрийн жинхэнэ албан хаагчид тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг харгалзан хуульд өөрөөр заагаагүй бол "Монгол Улсын Төрийн албаны тухай хууль"-ийн. 26 дугаар зүйлд заасан сахилгын дараах шийтгэлийн аль нэгийг эрх бүхий албан тушаалтан шууд удирдах албан тушаалтан, түүнийг томилсон дарга ногдуулна.

- сануулах;
- албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 2О хүртэл хувиар бууруулах;
- төрийн албанд 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах.

Сахилгын шийтгэлийг заавал дэс дараалан хэрэглэх шаардлагагүй бөгөөд харин сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш 1 сар, зөрчил гаргаснаас хойш 6 сараас илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулж болохгүй.

---

[371] Төрийн албаны тухай хууль. 26 дугаар зүйл.

[372] Төрийн улс төр, захиргаа, тусгай албан тушаалд байнга, эсхүл түр хугацаагаар томилогдсон буюу сонгогдсон албан хаагч, төрийн болон орон нутгийн өмчит, түүнчлэн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн эгээдийн удирдах болон захиргааны албан тушаалтан, ОНРТ-ийн үндэсний зөвлөлийн дарга, ерөнхий захирал, төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу тур буюу байнга гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах болон гүйцэтгэх ажилтан, МУ-ын ерөнхийлөгч, УИХ, бүх шатны ИТХ-ын сонгуулд нэр дэшигчид энэ хуульд хамрагдана.

Сахилгын нэг төрлийн шийтгэлийг давхцуулан ногдуулахгүй ба төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш нэг жилийн дотор сахилгын шийтгэл хүлээлгэхгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно.

Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаанд хуулиар хориглосон заалтыг зөрчсөн төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах нь төрийн албанаас чөлөөлөх, төрийн албанд дахин авахаас татгалзах үндэслэл болно.

Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан хаагч удаа дараа /2 ба түүнээс дээш албан үүргээ хангалтгүй биелүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож, шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон, Монгол Улсын харьяатаас гарсан бол түүнийг төрийн жинхэнэ албанаас хална.

Төрийн жинхэнэ албан хаагч "Монгол Улсын Эрүүгийн хууль"-ийн тусгай ангид заасан албаны үүрэгтэйгээ холбоотой, эсхүл бусад гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээх нь цөөнгүй бий.

Захиргааны хариуцлагын тухай хууль тогтоомжийг зөрчиж, захиргааны зөрчил гаргасан, гэм буруутай, хугацаат цэргээс бусад төрийн жинхэнэ албан хаагчид тухайн хуульд зааснаар эрх бүхий албан тушаалтан захиргааны шийтгэл ногдуулна.

Цэргийн албан хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай Монгол Улсын хууль" /2002 он/[373]-д зааснаар албан үүргээ гүйцэтгэж байх үедээ цэргийн эд хөрөнгөд хохирол учруулсан гэм буруутай цэргийн албан хаагч учруулсан бодит хохиролын хэмжээгээр нь эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэнэ.

ДӨРӨВ. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЗОХИЦУУЛАЛТ

АНУ-ЫН ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ[374]

АНУ-ын профессор Дрисенг Деннисийн туурвисан "**Төрийн бодлого ба төрийн хүний нөөцийн менежмент**" гэсэн бүтээлээс үзэхэд Жорж Вашингтон /1789 оноос/ Ерөнхийлөгчийн алба хашиж байхдаа урьд өмнө нь Британийн ноёрхлын эсрэг тэмцэлд хамтран зүтгэж явсан нөхдөө ихэд анхаарч албан тушаалд томилдог байжээ. Ерөнхийлөгч Андрю Жексон /1829 он/-ыг АНУ-д намууд албан тушаалыг хуваарилах системийг тогтоосон гэж үздэг.

Төр, засгийн албан тушаалыг намуудад хуваарилах явдал мэдэгдэхүйц өргөжсөн үе гэвэл Ерөнхийлөгч Авраам Линкольны үе байв. Иргэний дайн заналхийлж байсан тэр үед Ерөнхийлөгчид тушиг тулгуур болох улс төрийн шинэ нам хэрэгтэй байсан нь тодорхой. Тийм учраас албан тушаалд томилохдоо Линкольн мэдлэг чадвар гэхээсээ илүү эв нэгдлийг хангах зорилгыг эрхэмлэж байлаа. Ерөнхийлөгчийн мэдлийн нийт 1639 албан тушаалтнаас 1457-г Линкольн халж өөрчилжээ. Дээд шатны албан хаагчдыг мөн энэ харьцаатай өөрчилж байв. Линкольний засаг захиргааны үед танил талын харилцаа маш их дэлгэрсэн бөгөөд бүр хошин шог ярианы сэдэв

[373] "Төрийн мэдээлэл".2002 он. №

[374] Civil service of USA-Wikipedia, the free encyclopedia

ч болж XIX-р зууны сүүлийн хагаст албан тушаалд танил талаа томилох асуудлаар улс төрийн ширүүн тулалдаан ч өрнөж байв.

Линкольний дараа гарч ирсэн Ерөнхийлөгч Жонсоны үед энэ нь улам ширүүссэн байна. Иргэний дайны дараах бүтээн байгуулах зорилтуудыг Засгийн газар олигтой шийдвэрлэж чадахгүй байсан АНУ-ын түүхэн дэх нэн гуниглай цаг үед энэ үйл явц өрнөж байлаа.

АНУ-ын эдийн засаг бүхэлдээ технологийн шинэ зорилтын өмнө зогсож байсан бөгөөд түүний хил хязгаар Номхон далайн бүс нутаг хүртэл тэлэх учиртай байлаа. Гэтэл Засгийн газар нь хэрүүл, маргаан, албан тушаалаа урвуулан ашиглах зэрэг сөрөг нөлөөнд идэгдэж, үүргээ гүйцэтгэж чадахгүйд хүрч байжээ. Улс орны нөөц хүч хувийн ашиг хонжоо хөөсөн албан тушаалтнуудын ажил явуулгаас болж суларч мөхөсдсөн байлаа. Чухамхүү энэ үед шинэтгэлийн төлөө бүлгийг АНУ-ын нэрт зүтгэлтнүүд удирдаж байсан бөгөөд тэд улс төрийн аль нэг хүчний ивээлээр албан тушаал хуваарилах тогтолцоог хурцаар шүүмжилж, түүнийг хувь хүний эрх чөлөөг хязгаарласан хэмээн үзэж, халахыг хурцаар шаардаж байсан байна.

Шинэтгэлийн төлөө иргэний хэд хэдэн нийгэмлэг байгуулагдаж, улмаар 1881 онд шинэтгэлийн төлөө үндэсний Лига нэртэй нэг байгууллагад нэгджээ. Энэ байгууллагын оролцоотойгоор ардчилсан намаас нэр дэвшсэн сенатор Жорж Пендлтон намуудад албан тушаал хуваарилах тогтолцоог эцэс болгох тухай хуулийн төсөл боловсруулж эхэлжээ.

Бүгд Найрамдах намаас албан тушаалд томилогдсон зүтгэлтнүүд намуудад албан тушаал хуваарилах системийн хор уршгийг ухамсарлаж чадаагүй учраас 1882 онд болсон Конгрессын сонгуульд ялагджээ. Үүнээс авсан сургамж нь 1883 онд Конгрессын гишүүд бараг санал нэгтэйгээр Пендлтоны хуулийг баталсан явдал бөгөөд энэ мөчөөс эхлэн АНУ-д төрийн удирдлагын "Мерит" /төрийн алба мэргэшсэн, тогтвортой байх/ тогтолцоо бүрдэж эхэлсэн бөгөөд түүнээс хойш АНУ-ын үе үеийн Ерөнхийлөгч энэ тогтолцоог улам боловсронгуй болгон хөгжүүлж ирсэн байна. Үүний үр дүнд АНУ улс төрийн бодлого нь залгамж чанартай, эдийн засаг, нийгэм нь тогтвортой хөгжсөн, ард иргэдийнх нь амьдралын чанар хэлбэрэлтгүй дээшилсэн дэлхийд тэргүүлэх ардчилсан улс орны үлгэр загвар болж чадсан юм.

АНУ-ын судлаач Ван Райл бичихдээ: "Бүгд Найрамдах Улсыг үүсгэн байгуулагчид улс төрийн бодитой хандлага баримталж, улс төрийн үзэл бодлын эрх ашгийг захиргааны ажлын мэдлэг, туршлага, боловсрол, мөн түүнчлэн улс орныхоо өмнө өндөр хариуцлага хүлээх шаардлагатай хослуулж чадсан нь аз завшаантай хэрэг болсон юм. Үүний ачаар шинээр төлөвшин тогтсон улс үндэстэн улс төрийн тогтвортой үндэс суурьа боловсруулж чадсан төдийгүй төрийн албыг өндөр мэдлэг чадварын үндсэн дээр нэгдмэл байдлаар зохион байгуулсан нь өнөөдөр ч ач холбогдолтой хэвээр байна" гэж онцлон тэмдэглэсэн байна.

Пендлтоны хууль бол АНУ-д төдийгүй дэлхийн улс орнуудын төрийн хүний нөөцийн хөгжилд шинэ үеийг нээсэн юм. Үүнийг колончлолын бодлого задран унасны дараа тусгаар тогтносон зарим улс орон /тухайлбал, Энэтхэг/, дэлхийн II дайны дараа Пендлтоны хуулийн үзэл баримтлалыг хэрэгжүүлсэн

олон улс /Тухайлбал Япон, Өмнөд Солонгос зэрэг/ асар богино хугацаанд буюу 30-40-хөн жилийн дотор өндөр хөгжилтэй буюу Азийн барууд болж хөгжсөн амжилтаа тухайн үед төдийлөн таашаан хүлээж авдаггүй байсан Пендлтоны хуулийн дагуу төрийн албандаа мэргэшсэн, тогтвортой /Мерит/ болгосонтой холбоотой гэж өнөөдөр нэгэн дуугаар хүлээн зөвшөөрч байгаагаас харж болох юм. Тухайлбал Англи 300-400 жил, Япон 150 жил, АНУ 100 гаруй жилийн хугацааг зарцуулан байж 1990-ээд оны хөгжлийнхөө түвшинд хүрч байсан бол Өмнөд Солонгос гучхан жилийн хугацаанд өнөөгийн хөгжлийн түвшиндээ хүрч чадсаныхаа нэг "нууц"-ыг Пендлтоны хуулийн үзэл баримтлалын дагуу мэргэшсэн, тогтвортой төрийн албаныг төлөвшүүлсэн явдал мөн гэж бахархан ярьж байгааг үгүйсгэх аргагүй юм.

АНУ-ын төрийн алба 1872 онд байгуулагдсан. Холбооны төрийн алба нь дүрэмт хувцастай үйлчилгээний албан тушаалтнаас бусад нэгдсэн улсын хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн салбарт томилогдсон бүх албан тушаалаар тодорхойлогдоно /АНУ-ын хуулийн 5 дугаар бүлэг 2101 зүйл/. Спойл тогтолцоо гэсэн утга нь улс төрийн намуудаар дэмжигдэж хэрэглэдэг ажил, албан тушаалыг хэлнэ. Энэ нь дараагийн нэмэлт хууль болон 1883 оны Пендлтонын Төрийн албаны шинэчлэлийн актаар удаан хугацаанд үе шаттайгаар өөрчлөгдсөн. 1909 оноор бараг АНУ-ын холбооны ажиллах хүчний 2/3 нь мэрит тогтолцоон дээр үндэслэж томилогддог, мэргэшлийг нь тест, шалгалтаар хэмждэг болсон. Төрийн албаны тодорхой дээд албан тушаалыг үүн дотроо дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн, гүйцэтгэх агентлагууд улс төрийн томилгоогоор томилогддог. 1939 оны Хатч актын дагуу төрийн албан хаагчид ажил үүргээ гүйцэтгэж байхдаа улс төрийн үйл ажиллагаанд оролцохыг хориглосон.

Мэрит тогтолцоо:

Мэрит тогтолцоо гэдэг нь төрийн албан хаагчдыг улс төрийн хэлхээ холбоон дээр үндэслэж бус тэдний ажил гүйцэтгэх ур чадвар дээр үндэслэж ажилд авах болон албан тушаал дэвшүүлэхийг хэлдэг. Мэрит тогтолцоо нь спойл тогтолцооны эсрэг нь юм.

АНУ-ын төрийн алба нь өрсөлдөөний алба /competitive service/, өрсөлдөөнөөс гаднах алба /excepted service/ гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ. Нэгдсэн улсын ихэнх төрийн албаны томилгоо нь сонгон шалгаруулалтын дагуу томилогддог боловч тодорхой төрлүүд болох дипломат алба, FBI, бусад үндэсний аюулгүй байдлын албан тушаалууд өрсөлдөөнөөс гадна албаны дагуу томилдог.

Өрсөлдөөний төрийн алба /Competitive civil service/

Нэгдсэн улсын холбооны засгийн газрын төрийн албаны нэг хэсэг нь өрсөлдөөний /сонгон шалгаруулалт/ алба юм. Ажил горилогч нь сонгон шалгаруулалтын журмаар төрийн албанд орох гэж байгаа бол нээлттэйгээр бусад төрийн албанд орохыг хүсэгчидтэй мэрит тогтолцооны дагуу буюу мэдлэг чадвараараа өрсөлдөнө, энэхүү сонгон шалгаруулалтыг Өрсөлдөөний төрийн албаны Боловсон хүчний удирдлагын газар удирдан зохион байгуулна.

Нэгдсэн улсын хуулийн гарчиг 5 § 2102-р зүйлийн дагуу Өрсөлдөөнийн төрийн алба нь дараах зүйлээс бүрдэнэ.

1. Гүйцэтгэх засаглал дахь төрийн албаны бүх албан тушаал, гэвч дараах албан тушаал хамаарахгүй. Үүнд:

а/ Өрсөлдөөний төрийн албанаас тодорхой шалтгааны улмаас хасагдсан эсхүл хууль тогтоомжийн дагуу хасагдсан албан тушаал

b/ албан тушаалын томилгоо нь нэр дэвшүүлэгч Нэгдсэн Улсын Сенатаар баталгаажуулдаг, Сенат шууд томилохоос бусад тохиолдолд

с/ Өндөр дээд хэмжээний гүйцэтгэх албаны албан тушаал

Ялангуяа, Өрсөлдөөний төрийн албаны гишүүдийг албан тушаал бууруулах болон ажлаас халах процедур нь маш чухал учир нь ажиллагсдын эрхийг хамгаалах зорилгоор Нэгдсэн улсын засгийн газар буюу ажил олгогч нь шударга болон өсөн нэмэгдүүлэх аргыг хэрэглэж эхлэж байна. Ажилтан нь давж заалдах эрх, халах болсон шалтгааны мэдэгдэл, 30 хоногийн өмнөх мэдэгдэл зэргээр хангагдах ёстой.

Өрсөлдөөнөөс гаднах төрийн алба /Excepted civil service/

Нэгдсэн улсын холбооны засгийн газрын ихэнх албан тушаал нь өрсөлдөөний /сонгон шалгаруулалтын/ албаны хэсэг байдаг энэ нь Боловсон хүчний удирдлагын газрын удирдлагаар мэрит тогтолцооны үндсэн дээр ажил горилогчид нь бусад ажил горилогчидтой нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр өрсөлдөнө. Гэсэн хэдий ч зарим агентлагууд /бусад агентлагууд дахь зарим албан тушаал/ энэ хэсгээс хасагдсан. Гэвч голдуу өрсөлдөөнөөс гаднах төрийн алба нь мэрит тогтолцооны үндсэн дээр ажилладаг түүнээс гадна энэ албаныханд өөрийн гэсэн ажиллуулах системтэй мөн үнэлгээний шалгууртай. Эдгээр агентлагуудыг өрсөлдөөнөөс гаднах төрийн алба гэж нэрлэдэг бөгөөд эдгээр агентлагуудын албан тушаалууд нь өрсөлдөөнөөс гаднах төрийн албаны нэг хэсэг. Эдгээр агентлагийн ерөнхий хуваарь болон албан тушаалууд нь үндэсний аюулгүй байдал, оюуны өмчийн үйл ажиллагааны чиглэлийн жишээ нь Оюуны өмчийн төв агентлаг, Төрийн Департмент, Үндэсний аюулгүй байдлын агентлаг, Холбооны мөрдөн байцаах байгууллага, Ерөнхийлөгчийн Удирдлагын Хэсэг, Гадаад албаны албан тушаалууд зэрэг болно.

Багш нар, нэгдсэн улс болон хилийн чанд дахь батлан хамгаалах яамны сургуулийн удирдлагууд, мөн патентын байцаагчид гэх мэт албан тушаалууд Өрсөлдөөнөөс гаднах төрийн албанд хамаардаггүй.

Өрсөлдөөнөөс гаднах төрийн албаны нэг анхаарал татсан зүйл нь ажлаас халах эсхүл сахилгын шийтгэл хүлээлгэх явдалд ажиллагсдын давж заалдах эрх нь /өрсөлдөөний албанд ажиллаж байгаа албан тушаалтантай харьцуулахад/ харьцангуй бага байдаг.

Өрсөлдөөнөөс гаднах төрийн албаны хуулийн тодорхойлолт:

АНУ-ын хуулийн 5 дугаар бүлэг 2103 зүйлээс:

а/ Өндөр дээд хэмжээний гүйцэтгэх алба эсхүл өрсөлдөөний албанд хамаарахгүй төрийн албаны албан тушаалыг өрсөлдөөнөөс гаднах төрийн алба буюу excepted service гэнэ.

б/ Нэгдсэн улсын конгрессын хууль тогтоомжид " ангилагдаагүй төрийн алба", "ангилагдаагүй алба" гэдэг нь өрсөлдөөнөөс гаднах төрийн алба гэсэн утгатай.

ГЕРМАН УЛСЫН ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ /НИЙТИЙН АЛБАНЫ ЭРХ ЗҮЙ/[375]

Нийтийн албаны эрх зүй нь нийтийн эрх зүйн корпораци, нэгдэл, Холбооны нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд алба хаах гэсэн шинжийг илтгэнэ.

Нийтийн албаны субъект нь ажилтан, албан хаагч, түшмэлээс бүрдэнэ. Ажилтан, албан хаагч нь хөдөлмөрийн эрх зүйн хэм хэмжээний дагуу байгуулсан гэрээний үндсэн дээр ажиллах бол түшмэлийн хувьд түүний эрх зүйн байдлыг нийтийн эрх зүйн зарим нэг нэмэлт хэм хэмжээ тогтоосон хуулиар тодорхойлно. Ажилтан болон түшмэлийн хооронд гэрээний харилцаа үйлчлэхгүй бөгөөд тэр харилцаа нь захиргааны актаар тогтоосон захирах захирагдах харилцаанд тулгуурлана. Түшмэл нь өөрийн эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ урт хугацааны туршид бүрэн эрх хэрэгжүүлэх бөгөөд өөрийн ажил олгогчид үнэнчээр зүтгэх нийтийн албаны харилцааны нөхцөлд захирагддаг учраас нийтийн эрх зүйн корпорацийн ажилтан болно.

Мэргэжлийн түшмэлийн харилцааг зохицуулсан гол эрх зүйн акт нь Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 4 ба 5 дахь хэсэг байна: түшмэл нь хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ /бүрэн эрх нь үндсэн эрхийг хязгаарлана/, хууль тогтоогч түшмэлийн мэргэжлийн үйл ажиллагааны зарчмыг уламжлалт харилцааг тооцсоны үндсэн дээр эрх зүйн зохицуулалтыг нь тодорхойлно. Үүнийг Холбооны эрх зүйн болон мужийн хууль тогтоомжид тусгасан байдаг.

Түшмэлийн эрх зүйн байдлыг тодорхойлсон холбооны хэм хэмжээний гол актад дараах актууд хамаарч байна:

-Холбооны түшмэлийн гол харилцааг зохицуулсан Түшмэлийн тухай холбооны хууль,

-Түшмэлийн болон төрийн албан хаагчийн баталгааны тухай холбооны хууль,

-Түшмэлийн нийгмийн хамгаллын харилцааг зохицуулсан /золгүй тохиолдол бий болоход нөхөн төлөх төлбөр, тэтгэвэр, тэтгэмж/ түшмэдийн хангамжийн тухай хууль,

-Түшмэлийг төрийн албанд ажиллуулах тухай Холбооны тогтоол,

-Холбооны, мужийн, орон нутгийн түшмэлийн харилцаан дахь түшмэлийн эрх зүйн байдлыг тогтоосон актууд. Энэ төрлийн актын гол зорилго нь мөнгөн тэтгэмжийг жигдрүүлэх, албанд авах журмыг тогтоох, нийгмийн хангамжийг хангах харилцааг зохицуулахад чиглэнэ.

Эдгээр актаас гадна түшмэлийн нийгмийн асуудлыг зохицуулсан бусад хууль үйлчилж байна. Үүнд дараах актуудыг нэрлэж болно:

[375] Административное право зарубежных стран. Учебник /Под ред. А.Н.Козырина и М.А.Штатиной.-М.: Спарк, 2003, Стр. 309-311

-Амралтын олговрын тухай хууль,

-Томилолтын зардлын тухай холбооны хууль,

-Сахилгын зөрчил гаргасан түшмэлд сахилгын хариуцлага хүлээлгэх харилцааг зохицуулсан сахилгын хууль.

Үндсэн хуульд заасан түшмэлийн мэргэжлийн үйл ажиллагааны ердийн зарчим нь түшмэлийн тухай салбар хуульд хэсэгчлэн агуулагдаж байна. Зарим нэг зарчмыг нарийвчлан зохицуулаагүй боловч бодит байдал дээр хэрэгжилт нь сайн байна. Түшмэлийн мэргэжлийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг тэмдэглэх хэрэгтэй.

Ажил олгогч болон албандаа үнэнчээр ажиллах нийтийн эрх зүйн харилцааны "албаны харилцаа" гэдэг бол түшмэл ажил олгогчтой хувийн эрх зүйн гэрээний харилцаатай байх бус харин түүний эрх зүйн байдлыг нийтийн эрх зүйгээр тогтоодогт оршино. Түшмэлийн үйл ажиллагаа, түүний цалин хангамж зэргийг хуулиар тогтооно. Цалин хангамжийн харилцааг зохицуулсан хуулиас үзвэл түшмэл нь албан үүргээ гүйцэтгэхдээ ажил хаялт зохион байгуулахыг хориглоно. Ажил хаялт нь хууль тогтоогчоос түшмэлд хориглосон нөлөөлөл болно. Албан үүргээ үнэнчээр гүйцэтгэх гэдэг нь түшмэл ямар ч үед Үндсэн хуульт журамд болон төрд хэлбэрэлтгүй зүтгэнэ гэсэн утгатай. Үүнтэй холбоотойгоор нийтийн албанд тэнцэх хатуу шаардлагыг тодорхойлдог. Нөгөө талаас үнэнчээр ажиллана гэдэг нь түшмэл албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бус шүүмжлэлээс хамгаалуулах эрхтэй байна.

Бүх насаараа нийтийн албанд ажиллах: түшмэлийг зөвхөн ноцтой зөрчил гаргасан, эсхүл шүүхийн таслан шийтгэх тогтоолоор эрхийг нь 1-ээс дээш жилээр хасч, хорих ял шийтгүүлсэн тохиолдолд албанаас чөлөөлнө /түшмэлийнд Холбооны хуулийн 48/. Нийтийн алба хаах насны дээд хэмжээнд хүрсэн /дээд хязгаарт/ тохиолдолд түшмэл тэтгэврийн насанд хүрсэн ч үргэлжлүүлэн ажиллаж болно. Боловсролын салбарын түшмэлд ийм шаардлага тавигдахгүй.

Хангамж, баталгаатай байх зарчим: хуулиар тогтоосон мөнгөн тусламж болон нийгмийн халамж нь албан үүргээ гүйцэтгэсний төлөө олгож буй урамшуулал биш, харин түшмэлийн баталгаат хангамж гэж ойлгогдоно. Энэ нь эрх зүй, эдийн засгийн харилцаанд хараат бус байж өөрийн чиг үүргээ биелүүлэх боломж олгоно.

Үр дүнгийн зарчим: энэ зарчим түшмэлийг албан тушаалд томилох, дэвшихэд онцгой үүрэгтэй. Ажил олгогч түшмэл болон ажлын байранд өрсөлдөгчийг зөвхөн ажлын үр дүнгээр үнэлнэ. Арьс өнгө, хүйс, гарал үүсэл, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол энд ямарч үүрэг гүйцэтгэхгүй.

Түшмэл улс төрийн намын өмнө бус, "бүх нийгмийн" өмнө хариуцлага хүлээнэ. Эндээс албан үүргээ нам бусаар гүйцэтгэх буюу ажил олгогчийн зүгээс улс төрийн нөлөө үзүүлэхийг хориглох үүрэг гарч ирдэг.

Улс төрийн итгэл үнэмшил болон нийгэмлэгт гишүүн байх эрх чөлөө гэдэг нь түшмэлд тодорхой улс төрийн итгэл үнэмшил буюу нийгмлэгт гишүүн байхыг тулгах, эсхүл хориглож болохгүй гэсэн агуулгыг илэрхийлнэ. Энэ эрх чөлөө нь Үндсэн хуулийн журмын харилцааны хувьд түшмэл зүй ёсыг баримтлах үүргээр хязгаарлагдана.

ОХУ[376] Төрийн албаны дагнасан 2 хуультай

1. ОХУ-ын Төрийн албаны үндсийн тухай холбооны хууль. 1995 он. 6 бүлэг, 30 зүйлтэй;

2. ОХУ-ын Төрийн албаны тогтолцооны тухай Оросын холбооны хууль. 2003 он. 4 бүлэг. 18 зүйлтэй. III бүлэг нь Төрийн албан хаагчийн эрх зүйн байдлын үндсийг тухайлан авч үзэж, 9-16 дугаар зүйлд төрийн албан хаагчийн эрх зүйн үндсийг, төрийн албан хаагчийн эрх, үүрэг, төрийн албанд холбогдох хязгаарлалт, хариуцлага, баталгаа, төрийн байгууллага, өөрчлөгдөх, татан буугдах үеийн төрийн албан хаагчийн эрх зүйн байдал гэсэн 8 хэсэгт хуваан авч үзжээ.

Төрийн албан тушаал нь Холбооны Улсын хувьд "А", "Б", "В" гэсэн ангилалтай, тус бүрдээ өөр өөр зэрэглэлтэй нь манай улстай харьцуулбал эрх зүйн байдлын талаар харилцан адилгүй юм байна.

Японы[377] Үндсэн хуулийн 73 дугаар зүйлд төрийн албыг тодорхойлсноор 2006 оны №50 дугаараар үндэсний төрийн албаны актыг баталсан.

Үндэсний төрийн албаны албан тушаалыг ердийн болон тусгай алба гэж хоёр хуваадаг Ердийн алба нь тусгай албанд хамаардагаас бусад бүх үндэсний төрийн албанаас бүрдэнэ. Тусгай алба нь дараахь албан тушаалтангаас бүрдэнэ. Ерөнхий сайд, Төрийн сайдууд, Үндэсний боловсон хүчний комиссарууд, Аудитын зөвлөлийн аудиторууд, Хууль тогтоох байгууллагын кабинетын ерөнхий захирал, Кабинетын орлогч дарга, Кабинетын эрсдэлийн удирдлагын орлогч дарга, Ерөнхий сайдын тусгай зөвлөгч, Ахлах дэд сайд болон, агентлагуудын дэд сайд, Ерөнхий сайдын гүйцэтгэх нарийн бичгийн дарга гэх мэт маш олон албан тушаал үүнд хамаарна.

Японы төрийн алба нь нэг сая гаруй албан хаагчтай, шуудангийн салбар нь хамгийн том салбар бөгөөд 400000 ажилчид ажилладаг. Дайны дараах үед энэ тоо хэмжээ улам өндөр байсан ч гэсэн 1980 оноос хойш төрийн өмчит компаниуд хувийн өмчлөлд шилжсэн ч гэсэн Японы үндэсний төмөр зам болон NTT ажилчдын тоо эрс буурсан. Засгийн газрын төрийн албан хаагчдыг тусгай болон ердийн төрөл гэж хоёр хуваадаг. Тусгай төрөлд хамаардаг төрийн албан хаагчдын томилгоо нь улс төрийн шийдвэрээр эсхүл бусад хүчин зүйлээр нөлөөлж томилогддог өрсөлдөөнт шалгаруулалтад ордоггүй. Эдгээр төрөлд кабинетын сайдууд, бие даасан агентлагын дарга нар, зэвсэгт хүчин болон батлан хамгаалах салбарын гишүүд, элчин сайд хамаарна. Төрийн албаны үндсэн хэсэг нь ердийн албанаас бүрддэг бөгөөд энэ албанд ажилд орох гэж байгаа хүмүүс өрсөлдөөнт шалгаруулалтын дагуу ажилд ордог. Ердийн алба нь бага/доод албан тушаал/ алба, мэргэжлийн дээд түвшин гэж хуваж байгаа сүүлийн үед сайн тодорхойлсон төрийн албаны хэлбэр нь элит юм.

[376] www.allpravo.ru

[377] Civil service of Japan-Wikipedia, the free encyclopedia

Элит систем

"Энд хэн удирдаж байна вэ" гэдгийг илрүүлэхийг оролдож Японы олон судлаачид элит системд хамаарч байгаа хүмүүс тухайн орны маш өчүүхэн хувь болох 1 сая гаруй үндэсний засгийн газрын ажилчдаас бүрдэж байгаа хэдий ч яг үнэндээ японы засгийг удирдаж байна гэдгийг тэмдэглэсэн. Хэдэн зуун элитүүд үндэсний яам болон агентлагуудад алба хашиж байна. Элит систем рүү элсэж орох нээлттэй шалгаруулалтын үндсэн дээр ордог бөгөөд их сургууль, коллежийн зэрэг шаардлагагүй байдаг.

Дүгнэлт

1.Манай улсын хувьд төрийн алба нь эртнээсээ хаант засагтай байсан учир эзний алба болж үүссэн түүхтэй. Өөрөөр хэлбэл эзэн хаан хийгээд түүний шадруудын төлөө, түүний бие төлөөлөгч болох аймаг, хошуудын засаг ноёдын төлөө байжээ. Өнгөрсөн зууны 20-иод оны дунд үеэс буюу Анхдугаар Үндсэн хууль батлагдсанаас хойш нийтийн алба гэсэн чиглэлээр хөгжиж эхэлсэн. Энэ үеэс 1990 он хүртэл манай улс социалист чиг баримжаагаар замнасан учир төрийн алба захиргаадалтын дэглэмдээ зохицоод нэг намын төлөө алба болж хувиран гажсан. Өөрөөр хэлбэл төрийн албан хаагчдыг сонгож авах, үнэлж дүгнэх, сайшааж шагнах, буруутгаж шийтгэх гол шалгуур нь тухайн хүний улс төрийн үзэл баримтлал буюу намд үнэнч эсэхийн үнэлэмж болсон байна. Төрийн албанд хүмүүсийг ажилд шалгаруулж авах дөрвөн зарчим гэж байсны хамгийн эхэнд улс төрийн шинж байдал буюу намын бодлого, шийдвэрт үнэнч эсэхийг нь гол болгож байлаа. Ингээд нэг хүний албанаас нийтийн алба руу шилжиж байсан нь гуйваад нийтийн албанаас нэг намын төлөө алба болон хувирчээ.

"Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг" нь юуны өмнө тусгаар тогтносон улсын агуулгыг илэрхийлж, түүний төр засгийн бүтэц, засаг захиргааны хуваарийг нарийвчлан тогтоосны зэрэгцээ уламжлалд тулгуурлан төрийн түшмэлийн албаны эрх, үүргийг нарийвчлан зааж зохицуулсан эрх зүйн цогцолбор шинжтэй баримт бичиг байв.

1924, 1940 оны Үндсэн хуулиар хэдийгээр төрийн захиргааны өмнөхөөс илүү, орчин цагийн БНУ-ын хэлбэрийг сонгосон хэдий ч түүнийг хэрэгжүүлдэг засаг төрийн байгууллагын төвлөрсөн тогтолцоог бэхжүүлсэн байв. Үүнийг цаг үеийн шаардлага мэтээр тайлж болох талтай боловч тэр нь залгамжлагдан чангарснаараа гажуудалд хүргэсэн байна.

2. 1960 оны Үндсэн хуулийн оршилд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын зорилго бол социализмыг төгөлдөр байгуулж цаашдаа коммунист нийгэм байгуулах явдал мөн гэсэн эл үзэл баримтлалын дагуу төрийн албаны хөгжил нь явж ирсэн бөгөөд мөн хуулийн 5 дугаар зүйлд: "Төрийн бүх байгууллагын зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсэн зарчим бол төвлөн удирдах ардчилсан ёс мөн" гэж заасан байна. Энэ дагуу төвлөн удирдах системтэй төрийн захиргааны дээд төв удирдах байгууллагын захиргааны удирдлагын системтэйгээр үйл ажиллагаа явуулж иржээ. Өөрөөр хэлбэл Ардын Их Хурал түүний чөлөө цагт Ардын Их Хурлын Тэргүүлэгчид, Сайд нарын Зөвлөл, Улсын тусгай хороод, орон нутгийн АДХ

тэдгээрийн тэргүүлэгчид Шүүх, Прокурор хууль хяналтын байгууллага зэрэг нь төрийн байгууллагуудын үндсэн цөм нь болж байв. Түүнчлэн БНМАУ-ын Ардын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага байсан бөгөөд шүүх, прокурорын байгууллагын системд хүртэл оролцож тодорхой эрх эдэлдэг байв.

Төрийн албан хаагчдын эрх зүйн зохицуулалтын хувьд үндсэндээ төрийн албан хаагчдыг *томилох* журмаар ажиллуулдаг төвлөрсөн систем бүхий тодорхой улс төрийн алба болон шүүхийн системд *сонгох* зарчмаар ажилуулдаг байв.

Хэдийгээр 1970-аад оноос уралдаант шалгаруулалтын үндсэн дээр төрийн албанд иргэдийг авч ажиллуулж байсан боловч энэ нь өнөөгийн Төрийн албаны хуулийн төрийн жинхэнэ албан хаагчдыг сонгон шалгаруулалтын үндсэн дээр мэргэшлийн шалгалт авч шалгаруулдаг тогтолцооноос зарчмын хувьд өөр байлаа. Өөрөөр хэлбэл "томилох" систем түлхүү байсан нь тухайн үеийн эрх зүйн зохицуулалтаас харагдаж байна.

Харин "*сонгох*" системийн хувьд БНМАУ-ын бүх шатны шүүхийг сонгуулиар байгуулдагт оршиж байв. БНМАУ-ын Ардын Их Хурлаас БНМАУ-ын дээд шүүхийг, Ардын Их Хурлын Тэргүүлэгчдээс тусгай /цэргийн/ шүүхийг хуульд заасан хугацаагаар тус тус сонгоно. Аймаг, хотын шүүхийн шүүгч, ардын төлөөлөгчдийг аймаг, хотын ардын депутатуудын хурал, мөн аймгийн нүүдлийн шүүхийн шүүгчийг аймгийн ардын депутатуудын хурлын чуулганаас 3 жилийн хугацаагаар сонгодог байжээ. Харин районы шүүхийн шүүгчийг тухайн районы ардын депутатуудын хурлын чуулганаас 3 жилийн хугацаагаар сонгоно. Нүүдлийн болон районы шүүхийн ардын төлөөлөгчдийг тухайн нүүдлийн шүүхийн ажиллах сум ба районы хөдөлмөрчдийн хурлаас сонгуулийн системийн зарчмыг үндэслэн мөн 3 жилийн хугацаагаар ил сонгодог байсан нь тэр үеийн шүүхийн зохион байгуулалтын системийн нэг онцлог байв.

Прокурорын байгууллагын хувьд эрх хэмжээ чиг үүргийн хувьд одоогийнхоос ялгаатай зохицуулалттай зүйл нэлээд байсан байна.

Эдгээрээс заримыг тодруулбал прокурор Улсын Дээд шүүхийн бүгд хурлын зарим шийдвэрт хориг тавих АИХ-д энэ талаар мэдэгдэл бичих эрх хэмжээтэй байсан, босоо төвлөрсөн удирдлагын системээс гадна хамтын удирдлагын систем хэрэгжиж байсан зэргийг дурдаж болно.

Төрийн албанд олон ургалж үзэл төдий л хөгжиж эхлээгүй, төрийн албанд улс төрийн тэр тусмаа нэг намын бодлого шийдвэр үйл ажиллагаа нь төрийн аппаратын тусламжтайгаар хэрэгждэг улс төрийн нөлөөлөл бол төрийн албыг бүрэлдүүлэх, үйл ажиллагааг зохицуулах үндсэн тулгуур зохицуулалт нь болж өгч байжээ гэхэд хэлсдэхгүй болов уу.

Харин 1990 оны 5 дугаар сарын 10-ны өдөр Үндсэн хуулийн нэмэлтийн хууль батлагдсан бөгөөд энэ хуулиар төрийн албаны бүтэц зохион байгуулалтанд тодорхой өөрчлөлт орж 1960 оны Үндсэн хуулийн 3, 4 дүгээр бүлэг хүчингүй болсон юм. Тухайлбал уг хууль батлагдсанаар Ардын Их Хурал, Улсын Бага Хурал шинэчлэн зохион байгуулагдаж эрх хэмжээ нь өөрчлөгдсөн. Тухайлбал, БНМАУ-ын дэд Ерөнхийлөгч, Ерөнхийлөгчийн

албан тушаал шинээр бий болжээ. 1960 оны Үндсэн хууль холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулж байсан Сайд нарын Зөвлөлийн эрх хэмжээг Засгийн газарт шилжүүлж эрх, үүргийг уг хуулиар зааж өгсөн нь төрийн албаны хөгжил, бүтэц зохион байгуулалтын шинэ үеийн эхлэл байлаа.

3. Монгол Улсын Төрийн албаны 1994 оны хууль нь манай шинэ Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу боловсруулагдсан, өмнөх төрийн албаны зохих уламжлалд суурилсан төрийн албаны дагнасан анхны хууль юм.

4.Монгол Улсын Төрийн албаны тухай анхны хуульд "төрийн захиргааны албан хаагч"-ийн талаар илүү анхаарал хандуулсан бол **2002 оны Монгол Улсын Төрийн албаны хуулийн шинэчилсэн найруулга төрийн захиргааны болон тусгай албан тушаалын ангиллын хүрээнд "төрийн жинхэнэ албан хаагч" болгон нэр томьёоны төдийгүй үзэл баримтлал, зарчмын шинжтэй агуулгын шинэчлэл, баяжилт хийсэн нь эрх зүйн шинэтгэлийн нэгэн үр дүн** юм.

Мөн онол, арга зүйн хөгжил, практикийн ололтод тушиглэсэн тухайн үеийн эрх зүйн шинэтгэлийн үр дүн, хууль тогтоогчийн өмнөх нэмэлт, өөрчлөлтийн үргэлжлэл, сайжран боловсруулагдсан оюуны үнэлэмж хэмээн үзэж болно.

5. 2008 онд Төрийн албаны тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтөөр улс төрөөс бусад төрийн албан хаагчийг улс төрийн намаас түдгэлзүүлсэн. Захиргаа, тусгай, үйлчилгээний албан хаагч сонгуулийн аливаа үйл ажиллагаанд оролцохыг хориглосон.

Төрийн албаны зөвлөл төрийн албан тушаалд нэг л хүнийг нэр дэвшүүлэх, эрх бүхий этгээд түүнийг нэг л удаа буцаах бололцоо нээгдсэн. Өмнө нь 3-5 хүний нэр дэвшүүлдэг байхад тэднээс ур чадвартайг нь бус өөрийн үзэмжээр дээд албан тушаалтан нь томилох хандлагатай байв.

Төрийн албан тушаалд томилох эрх бүхий этгээдийн гаргасан хүний нөөцийн менежменттэй холбоотой хууль бус шийдвэрийг Төрийн албаны зөвлөл хүчингүй болгох эрх ч бас үүссэн. Энэ нь улс төрөөс хамааралгүй, мэргэшсэн, тогтвортой, төрийн бодлогын залгамж чанарыг хадгалах төрийн албаны шинэтгэлийн шинэ үеийн зааг дээр ирснийг харуулж байгаа юм.

6. Төрийн албан хаагчийн захиргааны эрх зүйн байдал нь Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, эдгээрт нийцэж гарсан хууль тогтоомжийн бусад актаар нарийвчлагдан тодорхойлогдох ойлголт болох нь харагдаж байна.

Төрийн албан тушаал, албан хаагчийн засаглан захирах эрх мэдэл, гүйцэтгэх үүрэг, эдлэх эрх, эрх зүйн байдлын хязгаарлалт ба хориглолт, ажиллах нөхцөл, баталгаа, хүлээх хууль зүйн хариуцлага зэрэг ухагдахуун нь тус бүрдээ онолын үндэс, хууль тогтоомжийн хэрэглээнд зохих судалгаа, нотолгоо хийхийг шаардсан, төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг тогтоох үндсэн элемент хэмээн үзэж болно.

Төрийн албан тушаалын болон албан хаагчийн ангиллын дотор төрийн

жинхэнэ албан тушаал, албан хаагч нь засаглан захирах талаар илүү эрх мэдэлтэй, тэр нь хууль зүйн зохицуулалтаас илэрхий харагдаж байгааг тухайлан тэмдэглэе.

Гэхдээ төрийн улс төрийн болон үйлчилгээний албан хаагчийн эрх зүйн зарим байдлыг орхигдуулаагүй, нэгэн адил авч үзсэн болно. Нөгөө талаар байгууллага, ажилтнаа засаглах талаасаа бус, удирдан захирах, зохион байгуулах үүрэг гүйцэтгэдгийг бас үгүйсгээгүй.

Төрийн албаны эрх зүйн зохицуулалтад төрийн жинхэнэ албан хаагчийн эзлэх байр, гүйцэтгэх үүрэг, захиргааны эрх зүйн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж гүнзгийрүүлэн судлах зайлшгүй шаардлага хэвээр хадгалагдаж буй нь эргэлзээгүй.

__oOo__

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

II БҮЛЭГ

ИРГЭН, ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЗҮЙН СЕКТОР

ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЭЭЛЭН
www.mli.gov.mn

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ҮҮРГЭЭ ГҮЙЦЭТГЭЭГҮЙ БОЛОН ЗОХИХ ЁСООР ГҮЙЦЭТГЭЭГҮЙ ЭМЧ, ЭМНЭЛЭГИЙН АЖИЛТНЫ БУСДАД УЧРУУЛСАН ХОХИРЛЫГ НӨХӨН ТӨЛЖ БУЙ БАЙДАЛ

1.1. Эмч, эмнэлгийн ажилтны хариуцлагатай холбоотой асуудал дотоодын хууль, эрх зүйн дэд актад тусгагдсан байдал, тулгамдаж буй асуудал

Өнөөдрийн байдлаар эрүүл мэндийн салбарт нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ агуулсан 96 эрх зүйн акт хүчин төгөлдөр үйлчилж байгаа бөгөөд үүнээс Эрүүл мэндийн тухай хуульд эмч, эмнэлгийн мэргэжилтэн гэдэгт хэнийг хамааруулан үзэх талаар хуульд дараах байдлаар томьёолсон байна.

Эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтад "**эрүүл мэндийн байгууллага**" гэж хүн **амд** нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үндсэн зорилго, чиг үүрэг бүхий хуулийн этгээдийг ;

Мөн хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтад "**эмнэлгийн мэргэжилтэн**" гэж анагаах ухааны дээд, дунд боловсролтой хүний их, бага эмч, сувилагч, эм зүйч, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, шүдний эмч, эмнэлгийн бусад мэргэжилтнийг;

Мөн хуулийн 3.1.8-д "**эрүүл мэндийн ажилтан**" гэж эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн болон эрүүл мэндийн байгууллагын бусад ажилтныг хэлнэ хэмээн тодорхойлсон.

Эрүүл мэндийн тухай хуульд эмч, эмнэлгийн ажилтнуудын эрх, үүргийг тодорхой тусгасан байна. Үүнд:

Эмнэлгийн мэргэжилтний эрх:

•Мэргэжлийн онцлог асуудлаар аль ч байгууллагын захиргаа, иргэнд шаардлага тавих, зөвлөгөө өгөх;

•Өвчтөний амь насанд аюултай байдал буй болсон, амаржих зэрэг эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх шаардлагатай тохиолдолд иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн эзэмшлийн тээврийн хэрэгслийг дайчлан ашиглах;

•Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн эрх, үүрэгт нь болон өвчтөний амь насанд харш үйлдэл хийлгэхээр шаардсан тохиолдолд түүнийг эмчлэх, үйлчлэхээс татгалзах;

•Өвчтөний амь насанд аюултай байдал бий болсон тохиолдолд эмч өөрөө үр дүнтэй гэж үзсэн эмчилгээний аргыг сонгон хэрэглэх;

•Хууль тогтоомжид заасан бусад эрх.

Үүнээс гадна эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн онцлогтой холбогдсон тодорхой эрхийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтоож болно.

Эмнэлгийн мэргэжилтний үүрэг:

• Эмнэлгийн мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг биелүүлж, хүнлэг энэрэнгүй үзлийг эрхэмлэн, мэргэжлээ хүний эрүүл мэндийн эсрэг ашиглахгүй байх;

• Гэнэтийн өвчин, осол, гэмтлээс амь насанд нь аюул учирсан иргэн, амаржих гэж байгаа эхэд энэ хуулийн 25.1.3-т зааснаас бусад тохиолдолд эмнэлгийн тусламжийг ямар ч нөхцөлд үзүүлэх;

• Эрүүл мэндийн холбогдолтой хууль тогтоомж, оношлогоо эмчилгээ, урьдчилан сэргийлэх ажлын стандарт, технологи, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх удирдамж журам болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан мэргэжлийн үүргийг чанд биелүүлэх;

• Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох, сургалт, сурталчилгаа явуулах, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

• Иргэний эрүүл мэндийн болон байгууллагын нуущыг хадгалах;

• Өвчин, эмгэг болон өвчтөн, нас барагчийн талаархи хууль тогтоомжоор хориглосноос бусад үнэн зөв мэдээллийг холбогдох байгууллага, иргэн, өвчтөний ар гэрийнхэнд өгөх;

• Хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

Эмч болон эмнэлгийн байгууллагын ажилтнуудтай холбоотой дэд актуудыг судалж үзэхэд эрүүл мэндийн яамнаас баталсан тушаал, шийдвэрүүд нь ихэнхдээ дотогшоо чиглэсэн учраас эмч, эмнэлгийн байгууллагын ажилтнуудыг сайдын тушаалыг биелүүлэхгүй байна гэж гомдол гаргах нь бага байдаг байна.

Эрүүл мэндийн сайдын 2008 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 145 тоот тушаалаар батлагдсан "Эмнэлгийн хүлээн авах, яаралтай тусламжийн нэгжийн бүтэц, үйл ажиллагааны үлгэрчилсэн загвар" байна. Энэхүү тушаалтай холбоотой гомдлууд хэвлэл мэдээллийн хэрэгслээр их гарч байгаа нь тушаал хэрэгжихгүй байгаагийн илрэл юм. Мөн эмч, эмнэлгийн байгууллагын ажилтнууд мэддэг боловч хэрэглэдэггүй, хэрэглэж огт сураагүй нэг тушаал нь Эрүүл мэндийн сайдын 135 дугаар тушаалын 3.4. "мэдээллийг үнэн зөвөөр үйлчлүүлэгч, ар гэр, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид өгөх үүрэгтэй" байгаа юм. Гэтэл үүнтэй холбоотой асуудал түгээмэл байна[378].

Мөн Эрүүл мэндийн сайдын 2008 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 145 тоот тушаалаар батлагдсан "Эмнэлгийн хүлээн авах, яаралтай тусламжийн нэгжийн бүтэц, үйл ажиллагааны үлгэрчилсэн загварыг баталсан боловч тэр бүр хэрэгждэггүй гэдэг нь судалгаанд оролцогчдын асуулгын үр дүнгээр батлагдсан юм.

Санал: Хүнд өвчтөн ирсэн үед хүлээн авахын эмч, заавал тасгийн эмчийн зөвшөөрлийг авалгүй шууд шийдээд тасагт хэвтүүлэх эрхтэй баймаар байна. Мөн Эрүүл мэндийн сайдын 2008 оны 6 дугаар сарын 20-

[378] Өдрийн сонин. 2009 он. 2009.4.13-ны өдөр нэгэн дүүргийн эмнэлгийн хавдарын кабинетээр иргэн И.З нар шинжилгээ өгч үйлчлүүлсэн бөгөөд мөн иргэн Р.Д нар ижил шинжилгээ өгсөн. Тухайн эмнэлгийн эмч иргэн И.З нарын шинжилгээний хариуг маргааш өглөө 9.00 цагт ирж аваарай гэж хэлээд явуулсан. Харин Р.Д нарыг тухайн өдрийн 16.30 минутад ирж аваарай гэж хэлээд явуулсан байна. Харамсалтай нь тухайн 2 иргэний шинжилгээний хариу муу гарсан ба хоёулаа ходоодны хорт хавдрын төгсгөлийн шатанд оношлогдсон болох нь тогтоогдсон. Иргэн Р. Д-г өдөр ирэхэд нь шинжилгээний хариуг өөрт нь шууд хэлсэнд гэнэт цочролд орж улмаар бие нь тэр дороо муудаж шууд тухайн эмнэлгийнхээ сэхээн амьдруулах тасагт хүргэгдэж ирээд эмчилгээ хийлгэж байгаад гарсан боловч удалгүй 2 сарын дараа нас барсан байна. Гэтэл иргэн И.З-г шинжилгээний хариугаа авахаар өглөө гэр бүлийнхээ хүнтэй хамт ирэхэд нь тухайн иргэнд мэдэгдэлгүй гэр бүлийнх нь хүнд шинжилгээний хариуг хэлж харилцан тохиролцсоны үндсэн дээр өөрт нь хэлэхгүй байх шийдвэрт хүрсэн бөгөөд иргэн И.З-д хорт хавдарын ямар нэгэн шинж тэмдэг байхгүй ходоодны шарх үүссэн байна сайн эмчилгээ хийлгэвэл эдгэрнэ гэсэн хандлагыг өөрт нь иттүүлж иргэн Р.Д-тэй ижил төрлийн эмчилгээ хийлгэсэн бөгөөд тухайн иргэн эмчийн хяналтанд эмчлэгдэж байгаад оношлогдсоноос хойш 8 сарын дараа нас барсан тохиолдол гарсан байдаг.

ны өдрийн 145 тоот тушаалаар батлагдсан "Эмнэлгийн хүлээн авах, яаралтай тусламжийн нэгжийн бүтэц, үйл ажиллагааны үлгэрчилсэн загвар"-ыг иргэдэд сурталчлах, эмнэлэг бүрийн хүлээн авахын үүдэнд үйлчлүүлэгчдэд харагдахуйцаар байрлуулах нь энэхүү тушаалын хэрэгжилт бодитой хэрэгжихэд дэмжлэг болно гэж үзэж байна.

Эмч, эмнэлгийн байгууллагын ажилтнуудын хариуцлагын асуудлыг дараахь хуулиудад зохицуулсан:

-Эрүүл мэндийн тухай хуульд тусгайлсан эрх олгосон улсын байцаагч, шүүгч хариуцлага ногдуулахаар заасан.

-Төрийн хяналт шалгалтын тухай хуульд улсын ерөнхий болон ахлах байцаагч захиргааны хариуцлага ногдуулна.

-Эрүүгийн, Иргэний, Захиргааны хариуцлагын тухай хуульд шүүгч хариуцлага хүлээлгэхээр тус тус заасан.

<u>Эрүүл мэндийн салбарт тулгамдаж буй асуудал</u>

Энэхүү судалгааны ажилд нийтдээ 150 иргэн, 150 эмч, эмнэлгийн байгууллагын ажилтан анкетын асуулгад оролцсон бөгөөд үүний үр дүнд дараах байдлаар тулгамдсан асуудлыг тодорхойлов. Үүнд:

1.Хууль болон тушаал, заавар, оношлогоо, эмчилгээний стандарт зөрчих;

2. Оношлох шинжилгээг хийхгүй байх;

3. Эмчилгээний аргыг буруу сонгох;

4. Хүндрэлийг хожуу оношлох;

5. Зохих эм тариа, багаж хэрэгсэл байхгүй буюу хоцрогдсон;

6. Ажилбарыг зохих стандартаар хийхгүй байх;

7. Хүнд өвчтөнд асаргаа муу хийх;

8.Эмнэлгийн бичиг баримтын хөтлөлт буруу буюу хийхгүй, эсвэл дутуу хийх;

9. Эмчилгээ, шинжилгээнд эрүүл ахуйн шаардлагыг зөрчих зэрэг юм.

Мөн Дархлаажуулалтын тухай[379] хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтад "Хүн амын дархлаажуулалт нь төрийн ивээлд байх бөгөөд халдварт өвчнөөс сэргийлэх, тэдгээрийн тархалтыг хязгаарлах, өвчнийг устгахад төрөөс дараахь бодлогыг хэрэгжүүлнэ, иргэн бүрт сэргийлэх тарилга хийлгэх боломжийг бүрдүүлэх" хэмээн заасан ч 2009 онд дэлхий даяар тархсан H1N1 өвчнийг гарахад сэргийлэх тарилгыг ялгавартай байдлаар хийхээр шийдвэр гаргасан нь хуулийн дээрх заалтыг зөрчсөн хэмээн судалгаанд хамрагдсан иргэд үзсэн.

Харин судалгаа хийх явцад зөрчил гаргасан эмч нарт Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хорооны гишүүд хариуцлага хүлээлгэхээр заасан нь Эрүүл мэндийн тухай хуульд нийцэхгүй байна гэж дүгнэж болохоор байна. Мөн тус хороо нь эмч нарын бүрэлдэхүүнтэй байдаг, ижил мэргэжлийн хүмүүсийг өмгөөлж, хамгаалдаг байдал ажиглагдаж байна[380].

[379] Төрийн мэдээлэл, 2000 он, №17.

[380] Эрүүл мэндийн яам, Нийслэлийн эрүүл мэндийн газрын холбогдох ажилтнуудаас ярилцлагын аргаар авсан судалгаа.

1.2. Холбогдох байгууллагуудад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байдал

А.Эрүүл мэндийн яаманд ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байдал:

2005 оны 1 дүгээр сараас 2007 оны 9 дүгээр сарыг дуустал Эрүүл мэндийн яаманд 2185 өргөдөл гомдол иржээ. Үүний 45 орчим хувийг хувь хүн, 21 хувийг УИХ-ын гишүүд уламжилсан буюу биечлэн гаргасан, 19 орчим хувийг эрүүл мэндийн байгууллагын ажилтан, 4 хувийг бусад яамны сайдаар дамжуулан хувь хүн, иргэн уламжилсан байна. Эрүүл мэндийн салбараас тэтгэвэрт гарсан болон халагдсан хувь хүн, иргэний санал хүсэлт, өргөдөл 11 хувь байна. Үүнээс 15.2 хувь нь эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааны талаарх санал, хүсэлт, 14.3 хувь нь ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол мэдээлэл ээлж байна[381]. Ёс зүйн зөрчилтэй холбогдуулан ирсэн 313 иргэний гомдлыг ангилан үзвэл:



Уг судалгааны ажилд удирдлагын үйл ажиллагаатай холбоотой 57 өргөдлийн агуулгад холбогдох удирдах албан тушаалаа урвуулан ашиглан улсын нөөцийг хувьдаа завших, хувийн сонирхлоор хандах, ажиллагсадаа дураараа халж сольдог, бэлгийн хүчирхийлэлд оруулан дарамталдаг, харилцааны соёл муу, эмч нарыг үл ойшоон харьцдаг, хууль бусаар тэтгэвэрт гаргах, ажлаас үндэслэлгүй халах зэрэг мэдээлэл багтаж байна.

Эмнэлгийн мэргэжилтний үйл ажиллагааны доголдол, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадвар, харилцаатай холбоотой өргөдөл, гомдлын агуулга болон холбогдох хууль тогтоомж зөрчсөн байдлыг авч үзвэл:

---

[381] "Эрүүл мэндийн салбар дахь сайн засаглал, ёс зүй, шударга байдлыг бэхжүүлэх" төслийн хүрээнд Эрүүл мэндийн яаманд 2005-2007 онд хандсан санал, өргөдөл, гомдолд хийсэн баримтын шинжилгээний тайланг 2008 оны 1 дүгээр сард хийсэн байна.

-Ажлын хариуцлага алдах /эмчилгээ тусламжийг цаг алдалгүй, шуурхай хүргэгүйгээс хүний амь нас хохирох, эмчилгээ, үйлчилгээнд хайхрамжгүй хандан буруу эмчилснээс хүний амь нас хохирох/;

- Эмнэлгийн үйлчилгээ чирэгдэлтэй, шуурхай бус байх;
- Өвчтөнийг буруу оношлох;
- Эмчлэх эрхгүй этгээд эмчилгээ хийж байгаа тухай;
- Үйлчлүүлэгчийг хэл амаар доромжлох зэрэг харилцааны доголдол гаргах;
- Шинжээч эмч гаргасан дүгнэлтээсээ няцах /иргэд энд бухимдалтай хандаж, шинжилгээний дүн эргэлзээтэй байгаа талаарх гомдлууд/ иржээ.

Ирүүлсэн санал хүсэлтийн 21 хувь буюу 5 өргөдөл тутмын 1-ийг УИХ-ын гишүүний нэрээр гаргасан байна. Гэвч эдгээр нь өөрсдийн хүрээнд шийдэж болохуйц, тойргийнхоо иргэдийн хувийн хүсэлтийг тус яаманд ирүүлсэн байна. Хэдийгээр УИХ-ын гишүүд тойргийнхоо иргэдийн элч, төлөөлөгч ч гэсэн энэ салбарт ямар хууль хэрэгтэй, юу нь болохгүй байгааг анхаарах шаардлагатай байна гэжээ[382]. Хэдийгээр 3 жил орчмын хугацаанд /2005-2007 он/ ЭМЯ-нд ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлын тоо харьцангуй бага мэт боловч олон улсын судалгааны жишгээр үйлчлүүлэгч иргэдийн зөвхөн цөөн хэдэн хувь буюу 4-өөс доош хувь нь гомдол өргөдөл гаргадаг байна.

Эмнэлгээр үйлчлүүлж буй иргэдээс авсан санал асуулгын хуудаст эмч, эмнэлгийн ажилтны учруулсан хохирлыг хаана хандаж шийдвэрлүүлэхээ мэддэггүй гэж хариулсан тохиолдол нэлээдгүй байсан ба цөөн тохиолдолд дараа нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах, хийлгэх үед сөрөг нөлөөлөл үүснэ хэмээн үздэг тул гомдол гаргадаггүй байна[383].

Энэхүү судалгааны хүрээнд Эрүүл мэндийн яамнаас 2008-2009 онд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын тоог ирүүлсэн ба Эрүүл мэндийн яамны Ёс зүйн хороонд 2008 онд иргэдээс нийт 7 өргөдөл, гомдол, МХЕГ-аас эмчлэх эрхийг хасуулах тухай 4 албан бичиг ирүүлжээ. Үүнээс 2 эмчийн эмчлэх үйл ажиллагааг хассан ба үлдсэн 5 асуудлыг ёс зүйн хорооны хурлаар хэлэлцэж, Эрүүл мэндийн тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн торгуулийн арга хэмжээ авах тухай саналыг МХЕГ-т, хөдөлмөрийн гэрээг цуцлах асуудлыг байгууллагын даргад нь зөвлөх, ёс зүйн салбар хороогоор хэлэлцэж, 1 асуудлыг ёс зүйн асуудалтай холбогдолгүй тул шүүхэд хандаж, нэр төрөө сэргээлгэх боломжтойг зөвлөсөн байна.

2009 онд нийт 33 өргөдөл, гомдол гаргаснаас:

-Эмчийн тусгай зөвшөөрлийг ЭМЯ-ны Ёс зүйн хорооноос тудгэлзүүлснийг сэргээж өгөхийг хүссэн 9;

-Эмч, сувилагчдын хоорондын харилцаа муу, үндэслэлгүйгээр ажлаас халсан талаар 6;

-Эмч нар хариуцлагагүй байдлаас болж иргэний амь нас хохирсон тул тэдэнд хариуцлага тооцохыг хүссэн 3;

[382] "Эрүүл мэндийн салбар дахь сайн засаглал, ёс зүй, шударга байдлыг бэхжүүлэх" төслийн хүрээнд Эрүүл мэндийн яаманд 2005-2007 онд хандсан санал, өргөдөл, гомдолд хийсэн баримтын шинжилгээний тайлан.

[383] Дурдсан тайлан.

- Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн эмчийн гаргасан шинжилгээний дүнгийн талаар 2;
- Группэд орох ёстой хүнийг группээс хассан 1;
- Резидент эмч H1N халдварын үед ажиллаагүйг үндэслэн сургалтаас чөлөөлснийг хүчингүй болгох 2;
- Эмч иргэнтэй зүй бусаар харьцсан, биед нь гэмтэл учруулсан талаар 1;
- Эмч нар иргэнтэй зүй бусаар харьцсан талаар 1 гомдол ирүүлснийг шийдвэрлэсэн байна.

2009 онд Ёс зүйн хороонд ирүүлсэн өргөдөл, гомдлын 27 хувийг эмчийн буруутай үйл ажиллагааны улмаас эмчлэх эрхийг 1 жилийн хугацаатай хассаныг сэргээж өгөхийг хүссэн талаарх хүсэлт ихээр ирдэг ч үүнээс нэгийг ч хугацааны өмнө сэргээгээгүй байна.

В. Нийслэлийн эрүүл мэндийн газарт ирүүлсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн байдал /2009/

Хугацаа улирал	Хэлбэр				Агуулга				Бусад байгууллагад шилжүүлж хариу өгсөн	Хуулийн хугацаанд хариу өгсөн
	амаар	бичгээр	утсаар	Цахим хэлбэрээр	Гомдол	санал	мэдээлэл	хүсэлт		
I		14	6	-	6	1	2	11	4	16
II		17		-	2	2	3	10	1	16
III		22	4	-	9	2		15	1	25
IV	1	24	24	-	1	1	4	20	3	21
Нийт	**1**	**77**	**77**	**-**	**18**	**18**	**9**	**56**	**9**	**78**

Өргөдөл, гомдлыг агуулгаар нь авч үзвэл[384]: /2009 онд/

Өргөдөл, гомдлын агуулга	**I улирал**	**II улирал**	**III улирал**	**IV улирал**	**Нийт тоо**
Ажил хүссэн	3		2		**5**
Чөлөө хүссэн	2	2		5	**9**
Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай	8	4	8	7	**27**
Дэмжлэг, тусламж, зөвшөөрөл хүссэн	3	6	4	11	**24**
Бусад	4	5	12	3	**24**
Бүгд	**20**	**17**	**26**	**26**	**89**

С. Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байдал

[384] НЭМГазар ийм мэдээллийг ирүүлсэн боловч эмч нарын бусдад учруулсан хохирлын талаарх тоо баримтыг өгөөгүй болно.

-Ажлын хариуцлага алдах /эмчилгээ тусламжийг цаг алдалгүй, шуурхай хүргэгүйгээс хүний амь нас хохирох, эмчилгээ, үйлчилгээнд хайхрамжгүй хандан буруу эмчилснээс хүний амь нас хохирох/;

- Эмнэлгийн үйлчилгээ чирэгдэлтэй, шуурхай бус байх;
- Өвчтөнийг буруу оношлох;
- Эмчлэх эрхгүй этгээд эмчилгээ хийж байгаа тухай;
- Үйлчлүүлэгчийг хэл амаар доромжлох зэрэг харилцааны доголдол гаргах;
- Шинжээч эмч гаргасан дүгнэлтээсээ няцах /иргэд энд бухимдалтай хандаж, шинжилгээний дүн эргэлзээтэй байгаа талаарх гомдлууд/ иржээ.

Ирүүлсэн санал хүсэлтийн 21 хувь буюу 5 өргөдөл тутмын 1-ийг УИХ-ын гишүүний нэрээр гаргасан байна. Гэвч эдгээр нь өөрсдийн хүрээнд шийдэж болохуйц, тойргийнхоо иргэдийн хувийн хүсэлтийг тус яаманд ирүүлсэн байна. Хэдийгээр УИХ-ын гишүүд тойргийнхоо иргэдийн элч, төлөөлөгч гэсэн энэ салбарт ямар хууль хэрэгтэй, юу нь болохгүй байгааг анхаарах шаардлагатай байна гэжээ[382]. Хэдийгээр 3 жил орчмын хугацаанд /2005-2007 он/ ЭМЯ-нд ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлын тоо харьцангуй бага мэт боловч олон улсын судалгааны жишгээр үйлчлүүлэгч иргэдийн зөвхөн цөөн хэдэн хувь буюу 4-өөс доош хувь нь гомдол өргөдөл гаргадаг байна.

Эмнэлгээр үйлчлүүлж буй иргэдээс авсан санал асуулгын хуудаст эмч, эмнэлгийн ажилтны учруулсан хохирлыг хаана хандаж шийдвэрлүүлэхээ мэддэггүй гэж хариулсан тохиолдол нэлээдгүй байсан ба цөөн тохиолдолд дараа нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах, хийлгэх үед сөрөг нөлөөлөл үүснэ хэмээн үздэг тул гомдол гаргадаггүй байна[383].

Энэхүү судалгааны хүрээнд Эрүүл мэндийн яамнаас 2008-2009 онд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын тоог ирүүлсэн ба Эрүүл мэндийн яамны Ёс зүйн хороонд 2008 онд иргэдээс нийт 7 өргөдөл, гомдол, МХЕГ-аас эмчлэх эрхийг хасуулах тухай 4 албан бичиг ирүүлжээ. Үүнээс 2 эмчийн эмчлэх үйл ажиллагааг хассан ба үлдсэн 5 асуудлыг ёс зүйн хорооны хурлаар хэлэлцэж, Эрүүл мэндийн тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн торгуулийн арга хэмжээ авах тухай саналыг МХЕГ-т, хөдөлмөрийн гэрээг цуцлах асуудлыг байгууллагын даргад нь зөвлөх, ёс зүйн салбар хороогоор хэлэлцэж, 1 асуудлыг ёс зүйн асуудалтай холбогдолгүй тул шүүхэд хандаж, нэр төрөө сэргээлгэх боломжтойг зөвлөсөн байна.

2009 онд нийт 33 өргөдөл, гомдол гаргаснаас:

-Эмчийн тусгай зөвшөөрлийг ЭМЯ-ны Ёс зүйн хорооноос түдгэлзүүлснийг сэргээж өгөхийг хүссэн 9;

-Эмч, сувилагчдын хоорондын харилцаа муу, үндэслэлгүйгээр ажлаас халсан талаар 6;

-Эмч нар хариуцлагагүй байдлаас болж иргэний амь нас хохирсон тул тэдэнд хариуцлага тооцохыг хүссэн 3;

[382] "Эрүүл мэндийн салбар дахь сайн засаглал, ёс зүй, шударга байдлыг бэхжүүлэх" төслийн хүрээнд Эрүүл мэндийн яаманд 2005-2007 онд хандсан санал, өргөдөл, гомдолд хийсэн баримтын шинжилгээний тайлан.

[383] Дурдсан тайлан.

- Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн эмчийн гаргасан шинжилгээний дүнгийн талаар 2;
- Группэд орох ёстой хүнийг группээс хассан 1;
- Резидент эмч H1N халдварын үед ажиллаагүйг үндэслэн сургалтаас чөлөөлснийг хүчингүй болгох 2;
- Эмч иргэнтэй зүй бусаар харьцсан, биед нь гэмтэл учруулсан талаар 1;
- Эмч нар иргэнтэй зүй бусаар харьцсан талаар 1 гомдол ирүүлснийг шийдвэрлэсэн байна.

2009 онд Ёс зүйн хороонд ирүүлсэн өргөдөл, гомдлын 27 хувийг эмчийн буруутай үйл ажиллагааны улмаас эмчлэх эрхийг 1 жилийн хугацаатай хассаныг сэргээж өгөхийг хүссэн талаарх хүсэлт ихээр ирдэг ч үүнээс нэгийг ч хугацааны өмнө сэргээгээгүй байна.

В. Нийслэлийн эрүүл мэндийн газарт ирүүлсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн байдал /2009/

Хугацаа улирал	Хэлбэр				Агуулга				Бусад байгууллагад шилжүүлж хариу өгсөн	Хуулийн хугацаанд хариу өгсөн
	амаар	бичгээр	утсаар	Цахим хэлбэрээр	Гомдол	санал	мэдээлэл	хүсэлт		
I		14	6	-	6	1	2	11	4	16
II		17		-	2	2	3	10	1	16
III		22	4	-	9	2		15	1	25
IV	1	24	24	-	1	1	4	20	3	21
Нийт	**1**	**77**	**77**	**-**	**18**	**18**	**9**	**56**	**9**	**78**

Өргөдөл, гомдлыг агуулгаар нь авч үзвэл[384]: /2009 онд/

Өргөдөл, гомдлын агуулга	**I улирал**	**II улирал**	**III улирал**	**IV улирал**	**Нийт тоо**
Ажил хүссэн	3		2		**5**
Чөлөө хүссэн	2	2		5	**9**
Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай	8	4	8	7	**27**
Дэмжлэг, тусламж, зөвшөөрөл хүссэн	3	6	4	11	**24**
Бусад	4	5	12	3	**24**
Бүгд	**20**	**17**	**26**	**26**	**89**

С. Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байдал

[384] НЭМГазар ийм мэдээллийг ирүүлсэн боловч эмч нарын бусдад учруулсан хохирлын талаарх тоо баримтыг өгөөгүй болно.

Улсын хэмжээнд эмчилгээ оношлогооны чанарын хяналтын чиглэлээр 2008 онд 173, 2009 онд 293 санал, хүсэлт, өргөдөл, гомдол хүлээн авч шийдвэрлэсэн бөгөөд хяналт шалгалтаар илэрсэн зөрчлүүдийг төрлөөр нь авч үзвэл:

- 28.3 хувь нь өвчний түүх хөтлөлтийн;
- 17.6 хувь нь стандарт дүрэм журмын;
- 9.6 хувь нь эмчилгээ, оношлогооны тактик, технологийн;
- 12 хувь нь эмнэлгийн баримт бичиг хөтлөлтийн;
- 10.1 хувь нь удирдлага, зохион байгуулалтын;
- 4.6 хувь нь эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагатай холбоотой;
- 17.8 хувь нь бусад зөрчил эзэлж байна.

МХЕГ-ын 2008-2009 онд шийдвэрлэсэн зөрчлүүд:



Илэрсэн зөрчилтэй холбогдуулан 2008 онд 2733 заалт бүхий 457 албан шаардлага, 14005 мянган төгрөгийн шийтгэвэр, 2009 онд 2140 заалт бүхий 426 албан шаардлага, 13055 мянган төгрөгийн шийтгэвэр тус тус ногдуулж, 2008-2009 онд 4 асуудлыг цагдаагийн байгууллагад, 4 асуудлыг прокурорын байгууллагад, 3 асуудлыг Шүүхийн шинжилгээний үндэсний төвийн Шүүх эмнэлгийн хэлтэст тус тус шилжүүлсэн байна[385]. Мөн эрүүл мэндийн байгууллага, эмнэлгүүдэд илэрч буй нийтлэг зөрчлүүдийг арилгуулах зорилгоор 2008 онд 8 удаа, 2009 онд 5 удаа нийт 32 чиглэлийн асуудлыг ЭМЯ-нд тавьж шийдвэрлүүлсэн байна. Дээрх хугацаанд 3 эмчийн ёс зүй, үйл ажиллагаатай холбоотой дүгнэлт, саналыг Эрүүл мэндийн сайд болон ЭМЯ-ны Ёс зүйн хороонд хүргүүлж, эмчлэх эрхийг тодорхой хугацаагаар хасч шийдвэрлүүлжээ.

[385] МХЕГ-аас ирүүлсэн тоо баримт.

- Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн эмчийн гаргасан шинжилгээний дүнгийн талаар 2;
- Группэд орох ёстой хүнийг группээс хассан 1;
- Резидент эмч H1N халдварын үед ажиллаагүйг үндэслэн сургалтаас чөлөөлснийг хүчингүй болгох 2;
- Эмч иргэнтэй зүй бусаар харьцсан, биед нь гэмтэл учруулсан талаар 1;
- Эмч нар иргэнтэй зүй бусаар харьцсан талаар 1 гомдол ирүүлснийг шийдвэрлэсэн байна.

2009 онд Ёс зүйн хороонд ирүүлсэн өргөдөл, гомдлын 27 хувийг эмчийн буруутай үйл ажиллагааны улмаас эмчлэх эрхийг 1 жилийн хугацаатай хассаныг сэргээж өгөхийг хүссэн талаарх хүсэлт ихээр ирдэг ч үүнээс нэгийг ч хугацааны өмнө сэргээгээгүй байна.

В. Нийслэлийн эрүүл мэндийн газарт ирүүлсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн байдал /2009/

Хугацаа улирал	Хэлбэр				Агуулга				Бусад байгууллагад шилжүүлж хариу өгсөн	Хуулийн хугацаанд хариу өгсөн
	амаар	бичгээр	утсаар	Цахим хэлбэрээр	Гомдол	санал	мэдээлэл	хүсэлт		
I		14	6	-	6	1	2	11	4	16
II		17		-	2	2	3	10	1	16
III		22	4	-	9	2		15	1	25
IV	1	24	24	-	1	1	4	20	3	21
Нийт	**1**	**77**	**77**	**-**	**18**	**18**	**9**	**56**	**9**	**78**

Өргөдөл, гомдлыг агуулгаар нь авч үзвэл[384]: /2009 онд/

Өргөдөл, гомдлын агуулга	**I улирал**	**II улирал**	**III улирал**	**IV улирал**	**Нийт тоо**
Ажил хүссэн	3		2		**5**
Чөлөө хүссэн	2	2		5	**9**
Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай	8	4	8	7	**27**
Дэмжлэг, тусламж, зөвшөөрөл хүссэн	3	6	4	11	**24**
Бусад	4	5	12	3	**24**
Бүгд	**20**	**17**	**26**	**26**	**89**

С. Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байдал

[384] НЭМГазар ийм мэдээллийг ирүүлсэн боловч эмч нарын бусдад учруулсан хохирлын талаарх тоо баримтыг өгөөгүй болно.

Улсын хэмжээнд эмчилгээ оношлогооны чанарын хяналтын чиглэлээр 2008 онд 173, 2009 онд 293 санал, хүсэлт, өргөдөл, гомдол хүлээн авч шийдвэрлэсэн бөгөөд хяналт шалгалтаар илэрсэн зөрчлүүдийг төрлөөр нь авч үзвэл:

- 28.3 хувь нь өвчний түүх хөтлөлтийн;
- 17.6 хувь нь стандарт дүрэм журмын;
- 9.6 хувь нь эмчилгээ, оношлогооны тактик, технологийн;
- 12 хувь нь эмнэлгийн баримт бичиг хөтлөлтийн;
- 10.1 хувь нь удирдлага, зохион байгуулалтын;
- 4.6 хувь нь эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагатай холбоотой;
- 17.8 хувь нь бусад зөрчил эзэлж байна.

МХЕГ-ын 2008-2009 онд шийдвэрлэсэн зөрчлүүд:



Илэрсэн зөрчилтэй холбогдуулан 2008 онд 2733 заалт бүхий 457 албан шаардлага, 14005 мянган төгрөгийн шийтгэвэр, 2009 онд 2140 заалт бүхий 426 албан шаардлага, 13055 мянган төгрөгийн шийтгэвэр тус тус ногдуулж, 2008-2009 онд 4 асуудлыг цагдаагийн байгууллагад, 4 асуудлыг прокурорын байгууллагад, 3 асуудлыг Шүүхийн шинжилгээний үндэсний төвийн Шүүх эмнэлгийн хэлтэст тус тус шилжүүлсэн байна[385]. Мөн эрүүл мэндийн байгууллага, эмнэлгүүдэд илэрч буй нийтлэг зөрчлүүдийг арилгуулах зорилгоор 2008 онд 8 удаа, 2009 онд 5 удаа нийт 32 чиглэлийн асуудлыг ЭМЯ-нд тавьж шийдвэрлүүлсэн байна. Дээрх хугацаанд 3 эмчийн ёс зүй, үйл ажиллагаатай холбоотой дүгнэлт, саналыг Эрүүл мэндийн сайд болон ЭМЯ-ны Ёс зүйн хороонд хүргүүлж, эмчлэх эрхийг тодорхой хугацаагаар хасч шийдвэрлүүлжээ.

[385] МХЕГ-аас ирүүлсэн тоо баримт.

1.3. Эмч, эмнэлгийн ажилтнуудын бусдад учруулсан хохирлыг арилгаж байгаа байдал, шүүхээр шийдвэрлэгдсэн байдалд хийсэн дүн шинжилгээ

Судалгааны ажлын энэхүү хэсэг нь эмч, эмнэлгийн байгууллагын үйл ажиллагаанд иргэдийн сэтгэл ханамжийн байдлыг тодорхойлох, иргэд эмч, эмнэлгийн байгууллагад хандан үйлчлүүлэх явцад тэдний Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох хууль тогтоомжид заасан эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдөж буй эсэх талаар болон зөрчигдсөн тохиолдолд учруулсан хохирлыг хэрхэн төлж байгааг шүүхийн практик болон иргэдээс авсан санал асуулгад дүн шилжилгээ хийхэд чиглэгдсэн болно.

Судалгааг хийх явцад Нийслэлийн шүүхийн иргэний хэргийн архиваас 2006-2009 оны хооронд нийслэлийн дүүргүүдийн шүүхээр шийдвэрлэгдсэн хэргүүдээс эмч, эмнэлгийн байгууллага, Эрүүл мэндийн яамтай холбогдуулан гаргасан нэхэмжлэлийг хэрхэн шийдвэрлэгдсэнд анализ хийлээ. Дээрх хугацаанд иргэний журмаар шийдвэрлэсэн 7 шүүхийн шийдвэр байх бөгөөд тоймлон үзвэл:

№	Хариуцагч	Нэхэмжлэлийн шаардлага	Хариуцагчийн тайлбар	Шийдвэрлэсэн байдал
1.	Эрүүл мэндийн яам	Эрүүл мэндийн яам цусны өвчний талаар судалгаагүй, эмнэлэгт шаардлагатай тоног төхөөрөмж байхгүй, эмч мэргэжилтэн бэлтгэзгүй улмаас өвчнийг эрт оношилж зохих эмчилгээг хийж чадаагүй улмаас учирсан нийт 78.075.895 төгрөгийн хохирлыг арилгуулах	Монгол Улс өөрт байгаа боломж бололцоогоо ашиглан чадлын хэмжээгээр эмчилгээ хийж байсан. Төрийн бодлогын хувьд Ч. Монгол Улсад хийгддэггүй мэс засал гэв.	Эрүүл мэндийн тухай хуулийн 28[1]-р зүйлийн 28.1.2 дах хэсэг, Иргэний хуулийн 497, 510 дугаар зүйлийн 510.1-д заасаар Эрүүл мэндийн яамнаас 11.021.060 төгрөгийг гаргуулж О.Лодонд олгож, нэхэмжлэлийн үлдэх хэсгийг хэрэгсэхгүй болгосон.

2.	Улсын Клиникийн төв эмнэлэгт холбогдох .	Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөлийн 2003 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан Иргэний эрүүл мэндийн даатгалын хуулийг хэрэгжүүлэх журмын 18 дугаар заалтыг зөрчин БНХАУ-аас авчиран хийлгэсэн эм тарианы үнэ 12.5 сая төгрөгийг гаргуулах	Өвчний түүхэнд бичигдсэн эмчилгээ хийгдсэн болох нь нотлох баримтаар нотлогдож байгаа эм, тарианы төлбөр 520384 төгрөгийг буцаан олгоход таттгалзах зүйлгүй. Харин үлдэх хэсгийг манай байгууллага хариуцах үндэсгүй.	Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.6, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.5, Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөлийн 2003 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 9 дүгээр тогтоолын 18-д зааснаар УКТЭ-ээс 6.250.000 төгрөг гаргуулж О.Лодонд олгож, нэхэмжлэлийн шаардлагын 6.250.000 төгрөг гаргуулах хэсгийг хэрэгсэхгүй болгосон.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

* "Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан тухайн жилийн эмчилгээний төлбөрийн хэмжээнээс давсан хэсэг болон магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр гадаад оронд эмчлүүлэх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд зардлынх нь 60-аас доошгүй хувийг төр хариуцах".

3.	1. Монгол Улсын Эрүүл мэндийн яам, 2. УКТЭ, 3. ЦЕГ-т холбогдох	Эм тариа, оношлогоо эмчилгээ, замын зардал, хохирлын 95.853.323 төгрөг гаргуулах тухай	1. Төрийн албаны тухай хуулийн 27.1.8 болон Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд зааснаар эмчилгээний тодорхой хувийг төр хариуцана гэсэн боловч энэхүү зардал нь сайдын төсвийн багцад тусгагдаагүй. Мөн хуульд нөхөн гаргуулах эмчилгээний зардлыг ар гэрт нь олгох гэсэн ойлголт байхгүй. 2. Эрүүл мэндийн даатгалын хуулийг хэрэгжүүлэх журмын 18-д заасны дагуу 520.384 төгрөгийг буцаан олгох боломжтой. 3. Хохирогч нь Цагдаагийн байгууллагаас гарсны дараа өвчилсөн тул ЦЕГ-т холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү.	4. Эрүүл мэндийн тухай хуулийн 28[1]-р зүйлийн 28.1.2 дахь хэсэг, Монгол Улсын Иргэний эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 5 дах хэсэг, Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 510 дугаар зүйлийн 510.1 дэх хэсэгт зааснаар Монгол Улсын Эрүүл мэндийн яамнаас 10.996.560 төгрөгийг, УКТЭ-ээс 17.777.428 төгрөгийг тус тус гаргуулж О.Лодонд олгож нэхэмжлэлийн үлдэх хэсэг 67.079.335 төгрөгийг хэрэгсэхгүй болгосон. 5. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 117 дугаар зүйлийн 117.1 дэх хэсэгт зааснаар О.Лодонгийн нэхэмжлэлтэй Цагдаагийн Ерөнхий газарт холбогдох хэсгийг хэрэгсэхгүй болгосон.

Дурдсан хэргүүдийн хувьд нэхэмжлэгч нь нэг хүн байсан ба олон удаа шүүхэд нэхэмжлэл гарган шийдвэрлүүлсэн байна.

№	Хариуцагч	Нэхэмжлэлийн шаардлага	Хариуцагчийн тайлбар	Шийдвэрлэсэн байдал
4.	Монгол Солонгосын Дорнын Анагаах Ухааны төв	Зөв оношлоогүйн улмаас өвчин хүндэрч зайлшгүй мэс засал хийлгэсэн эмчилгээний зардал болох 3.360.000 төгрөг гаргуулах	Хохирогчийн буруутай үйл ажиллагаа байгаа учраас Иргэний хуулийн 514 дүгээр зүйлд зааснаар гарсан зардлаас бага хэмжээгээр төлнө.	Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 498.1, 505.1 дэх хэсгүүдэд зааснаар Монгол Солонгосын Дорнын Анагаах ухааны төвөөс 3.011.452 төгрөгийг гаргуулан Г.Пүрэвсүрэнд олгож, нэхэмжлэлийн шаардлагаас 348.548 төгрөгийг хэрэгсэхгүй болгосугай.
5.	Болор-Мэлмий эмнэлэг	Дур мэдэн хагалгаа хийснээс нүд хараагүй болсон тул учирсан нийт бодит хохирол болох 106.820.540 төгрөг гаргуулах тухай	Эмчилгээ буруу хийгдсэн гэсэн баримт байхгүй нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөхгүй байна.	Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.1, 505 дугаар зүйлд зааснаар нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосугай.
6.	Гэмтэл согог судлалын үндэсний төв	Гэмтэл согог судлалын үндэсний төв эмнэлгийн эмч, сувилагч, асрагч нарын буруутай үйлдлээс болж төрсөн ах Б нь осгож нас барсан учир хохиролын 2.039.600 төгрөгийг гаргуулах тухай	ГССҮТ-ийн буруутай үйл ажиллагааны улмаас иргэн М нас барсан нь тогтоогдсон тул нэхэмжлэлийг үндэслэлтэй гэж үзэн хохирол төлөхийг зөвшөөрч байна.	Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөнийг баталж хэргийг хэрэгсэхгүй болгосугай.
7.	"Энхийн төлөө" эмэгтэйчүүдийн эмнэлэг	Эмчийн хариуцлагагүй хайнга байдлаас эрүүл мэндэд учирсан хохирол болох 5.000.000 төгрөг нэхэмжилсэн.	Нэхэмжлэгчийн нэхэмжлэл хууль зүйн үндэслэлгүй бөгөөд Эмнэлгийн эмчээс шалтгаалахгүй нөхцөл байдлаас үүссэн эмчилгээ, оношлогооны тааламжгүй байдлыг золгүй тохиолдол гэж үздэг. Тиймээс хохирол төлөх боломжгүй.	Иргэний хуулийн 497 дугаар 497 дугаар зүйл 497.1, 505 дугаар зүйлд зааснаар хариуцагчаас 3.900.975 төгрөг гаргуулж нэхэмжлэгчид олгож, үлдэх 1.099.025 төгрөгийг хэрэгсэхгүй болгосугай.

Дээрх хэргүүдэд дүгнэлт хийхэд Эрүүл мэндийн яам болон Улсын Клиникийн төв эмнэлэг нь хуульд зааснаар дараах эмнэлгийн тусламж үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх ёстой.

Эрүүл мэндийн тухай хуулийн 28[1] дүгээр зүйлийн 28[1] дүгээр зүйл. "Төрөөс төлбөрийг нь хариуцах эмнэлгийн тусламж, үйлчилгээ"-нд:

28[1].1-д Монгол Улсын иргэнд түүний эрүүл мэндийн даатгалд даатгуулсан эсэхээс үл хамааран эмнэлгийн тусламж, үйлчилгээний төлбөрийг төр хариуцна:

28[1].1.2. сүрьеэ, хорт хавдар, сэтгэцийн эмгэгийн эмчилгээ, халдвар судлалын үйлчилгээ, төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх тарилга, халдварт өвчний голомтын ариутгал, халдваргүйтгэл гэж заажээ.

Дээрх тохиолдолд эмнэлгийн байгууллагын эмч болон захиргаа нь хуулийн заалтыг мэдсээр байж түүнийг хэрэгжүүлээгүй бөгөөд хорт хавдартай иргэнээс эмчилгээ болон шаардлагатай эм тариаг гадуур авахуулж эмчилгээнд хэрэглэж байснаа хүлээн зөвшөөрч нэхэмжлэлийн тодорхой хэсгийг шүүхийн журмаар буцаан олгосон байна.

Мөн энэхүү хэргийн материалтай танилцахад өвчтөний эмчлэгч эмч нь ховор эм тариаг Нарантуул зах дээрээс худалдан авахыг санал болгодог байсан тухай шүүхэд гаргасан тайлбартаа дурьдсан байна. Гэтэл эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээний 6 дугаар зүйлийн 6.2-т "Эмнэлгийн мэргэжилтэн нь Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй, үр дүн нь тодорхойгүй, стандартын бус, чанарын баталгаагүй эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхи бүтээгдэхүүнийг дэмжиж, сурталчлах, түүнийг оношлогоо, эмчилгээнд хэрэглэх, зарж борлуулах, түгээх ёсгүй[386]" гэж заасан. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.23-т: "эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага" гэж эмийн сан, эрүүл мэндийн байгууллага болон мал эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгслээр бөөний үнээр хангах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг, "эмийн сан гэж" ... жижиглэнгийн үнээр хангах үйл үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг хэлнэ гэж тус тус заажээ. Үүнээс харахад эм, эмнэлгийн хэрэгслийг тусгай зөвшөөрөлгүй баталгаагүй газраас худалдан авахыг санал болгосон нь хууль бус үйлдэл бөгөөд эмнэлгийн мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ болон Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийг бүхэлд нь зөрчиж байна.

Иргэний хуулийн 229 дүгээр зүйлийн 229.2-т зааснаар хохирлын хэмжээг тодорхойлохдоо хохирогчийн ашиг сонирхол, хохирол учруулсан нөхцөл байдлыг харгалзан үзнэ гэж заасан. Мөн хуулийн 230 дугаар зүйлийн 230.1 дэх хэсэгт зааснаар эдийн бус хохирлыг шаардах эрхтэй гэж заасан. Мөн Иргэний хуулийн 505 дугаар зүйлд заасанчлан бусдын эрүүл мэндэд хохирол учруулсан этгээд нь хохирогчийн хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, ийнхүү эрүүл мэндэд хохирол учруулсантай холбогдон гарсан асарч, сувилах, нэмэгдэл хоол өгөх, хиймэл эрхтэн хийлгэх, сувиллын газар сувилуулах, хохирол учруулах үед хохирогч цалин хөлс, орлогогүй байсан бол тэрээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй хэмжээний нөхөн төлбөр шаардах зэрэг зайлшгүй бүр зардлыг хохирогчид төлөх үүрэгтэй. Гэтэл дээрх тохиолдлуудад хохирогчийн эрүүл мэндэд хохирол учирсантай холбоотой гарсан асарч, сувилах, нэмэгдэл хоол өгөх болон өвчтэй байх хугацаанд олох байсан орлого зэргийг нэхэмжилсэн ч түүний тодорхой хэсгийг хангасан байх ба үлдэх хэсгийг хэрэгсэхгүй болгосон байна. Шалтгаан нь хохирогчид өөрт учирсан хохирлоо нэхэмжлэхдээ нотлох баримтаа хангалттай гаргаж өгдөггүй, зарим хэсэг нь иргэний хэрэгт нотлох баримтаа цуглуулж өгөхөө мэддэггүй, шүүх бүх баримтыг цуглуулах ёстой гэж үздэг зэргээс хуулийн

[386] "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ". 2007 он.

дээрх зохицуулалт иргэн бүр сайтар мэдэхгүй байгаа бөгөөд иргэдийн эрх зүйн мэдлэг тааруу байгаа нь гэм хорыг арилгахад нөлөөлж байна.

1.4. Иргэдээс авсан санал асуулгад хийсэн дүн шинжилгээ:

Эмч, эмнэлгийн байгууллагын ажилтнуудын зан харилцааны талаар иргэдээс авсан санал асуулгад 44 хувь нь эмч, эмнэлгийн ажилтнууд сайн харилцаатай гэсэн хэдий ч түүний эсрэг 22 хувь нь хангалтгүй гэсэн байна.

Эмч, эмнэлгийн байгууллагын ажилтнуудын зан харилцааны талаар

Энэ нь Эрүүл мэндийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1-д заасан "Эмнэлгийн мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг биелүүлж, хүнлэг энэрэнгүй үзлийг эрхэмлэн, мэргэжлээ хүний эрүүл мэндийн эсрэг ашиглахгүй байх;", Эмнэлгийн мэргэжилтний баримтлах ёс зүйн хэм хэмжээний 2.3-т "Эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчлүүлэгчийн эрх ашиг, нэр төрийг дээдлэн хүндэтгэж, хүнлэг энэрэнгүй, шударга хандана" гэж заасантай зөрчилдөж байна. Үйлчлүүлэгчийг хүндэтгэх бол эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн үндсэн зарчмын нэг болох "хувь хүнийг хүндэтгэн үзэх" зарчмыг баримтална гэсэн үг. Энэ зарчим нь хоёр үндсэн ухагдахууныг агуулж байна. Үүнд:

1. Бие даасан байдлыг хүндэтгэх–хувь хүн өөрийн сонголт хийх чадвартай байгаа бол өөрөө мэдэж, үнэлж цэгнэх чадварыг нь хүндэтгэж харилцахыг хэлнэ.

2. Бие даасан байдал нь хязгаарлагдмал эсвэл хямарсан хүнийг хамгаалах-бусдаас хамааралтай эмзэг хүмүүст хөнөөл учруулах, эсвэл тэднийг хортойгоор ашиглахын эсрэг аюулгүй байдлыг нь хангаж өгөхийг хэлнэ[387].

Үнэнч шударга байна гэдэг үйлчлүүлэгчид болон мэргэжил нэгтнээ ялгаварлан гадуурхахгүй, тэгш боломжоор хангаж, тусламж үйлчилгээг стандартын түвшинд бүрэн дүүрэн үзүүлнэ гэсэн үг юм. Нөгөөтэйгүүр эмч, эмнэлгийн байгууллагын ажилтнуудын зан харилцаа нь дунд зэрэг болон хангалтгүй гэж дүгнэсэн нь иргэдийн эмч нарт хандах хандлагад шууд нөлөөлж байна. Эмч, эмнэлгийн байгууллагын ажилтнууд өвчтнүүдтэй харилцааны доголдол гаргаснаар тэдэнд итгэх итгэл болоод цаашлаад эмчийн алдаа гаргахад нөлөөлж байна.

Мөн эмч, эмнэлгийн байгууллагын ажилтнуудын буруутай үйл ажиллагаанаас эрүүл мэнд, амь насаараа хохирсон байдаг уу? гэсэн асуултад:

[387] ЭМЯ. "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээний тайлбар". Асуулгын санал хэлэлцүүлэг.



Үүнээс шүүхэд хандаж гомдлоо шийдвэрлүүлсэн иргэд хохирлоо бүрэн барагдуулсан байх бөгөөд харин тухайн эмнэлгийн байгууллагын захиргаанд хандаж өргөдөл гаргасан иргэд гомдлоо шийдвэрлүүлж чадаагүй байна. Дээрх байдлыг дүгнэвэл: Тухайн клиникийн болон аймаг, хотын эмнэлгийн байгууллагын захиргаа нь иргэдийн өргөдөл гомдолд хариу өгдөггүй, тэдний хүсэлтийг хүлээж авдаггүй гэж болохоор байна.

Судалгаанд оролцогсод хууль эрх зүйн орчны талаар мэдлэг бага учир хаана хандахаа мэддэггүй, бухимдан хоцрохоос өөр зүйлгүй үлддэг нь түгээмэл байна. Мөн эмч нар гар их хардаг: цайны цагаас хойш ажилладаггүй, иргэдийг ийш тийш явуулж их чирэгдүүлдэг, эмнэлгийн тоног төхөөрөмж муу, өвчтөн үзэхдээ хайнга тоомжиргүй ханддаг, хүнд суртал гаргадаг, өвчний талаар тодорхой мэдээлэл өгдөггүй, бичсэн эм тариагаа юунд уудаг болох ямар шинж тэмдэг илрэх болон цаашид гарах үр нөлөөний талаар тайлбар хийдэггүй зэрэг байдлыг нэн тэргүүнд засах шаардлагатай байна. Энэхүү байдал нь мөн л эмч нарын өвчтөнтэй харилцах явцад гарсан харилцааны муу хандлагатай холбоотой.

Судалгаанд оролцогчдыг насны байдлаар нь авч үзвэл: 35-55 насны иргэд ихэнхдээ эмнэлгээр үйлчлүүлэх бөгөөд тэдний сэтгэл ханамжийн байдал болон эмч, эмнэлгийн байгууллагын ажилтанд итгэх итгэл сул байдаг байна. Учир нь эмч нар өвчтөнг үзэхдээ бүрэн оношлоогүйн улмаас өвчтнийг чирэгдүүлдэг, буруу эмчилгээ хийдэг нь тухайн өвчнийг илүү хүндрүүлж амь насанд аюул учруулах хүртэл хохирол учруулж байдаг. Мөн өвчний түүх бичилтийг дутуу хөтөлснөөс бүрэн бус эмчлэгдэх зарим тохиолдолд буруу эмчилгээ хийх явдал нийтлэг байна.

Судалгаанд оролцсон иргэд эмнэлгийн үйлчилгээний чанарт дараах байдлаар үнэлгээ өгчээ[388].

[388] Мөн тэнд. 28 дахь тал.

Үнэлгээ	Үйлчлүүлэгчийн тоо	Хувь
Маш сайн	35	23.3
Сайн	44	29.3
Дунд	56	37.3
Муу	13	8.7
Маш муу	2	1.3
Нийт	150	100

Судалгаанд хамрагсдын 50 хувь буюу 76 хүн эмнэлгийн үйлчилгээг тэгш, хүртээмжтэй байж чаддаггүй гэж үнэлсэн бол, 39 хувь нь тэгш хүртээмжтэй үйлчилдэг, үлдсэн хэсэг нь сэтгэлд хүртэл үйлчилж чадахгүй байна гэж үнэлсэн байна. Уг судалгаагаар Сүхбаатар дүүргийн нэгдсэн эмнэлгийн эмч, ажилтнуудын хүнд суртал үйлчлүүлэгчдийн бухимдлыг багагүй төрүүлдэг гэжээ. Тэдний 70-аад орчим хувь нь үйлчилгээний соёлыг маш муу гэж үнэлсэн байна.

Үйлчлүүлэгчдийн дүүрэг тус бүрээр өгсөн үнэлэлт, дүгнэлтийг хүснэгтлэн харуулбал:

	Шалгуур үзүүлэлт	Маш сайн	Сайн	Дундаж	Муу
	Эмчийн харилцаа	5 хувь	40 хувь	45 хувь	10 хувь
СБДНЭ	Сувилагчийн харилцаа	-	62.5 хувь	25 хувь	12.5 хувь
БГДНЭ	Эмчийн харилцаа	4.4 хувь	27.2 хувь	28.9 хувь	41 хувь
	Сувилагчийн харилцаа	16.7 хувь	41.7 хувь	41.7 хувь	-
БЗДНЭ	Эмчийн харилцаа	7.1 хувь	50 хувь	35.7 хувь	7.1 хувь
	Сувилагчийн харилцаа	20 хувь	60 хувь	20 хувь	-
ХУДНЭ	Эмчийн харилцаа	-	80 хувь	20 хувь	-
	Сувилагчийн харилцаа	-	50 хувь	50 хувь	-
СХДНЭ	Эмчийн харилцаа	-	63.6 хувь	36.4 хувь	-
	Сувилагчийн харилцаа	-	50 хувь	16.7 хувь	

Эмнэлэг тус бүрийн хувьд хувийн эмнэлгээр үйлчлүүлснээр түүнээс хүртэх сэтгэл ханамж хамгийн өндөртэй нь БГД-ийн нэгдсэн эмнэлэг гэсэн судалгааны үр дүн гарсан ба сэтгэл ханамжийн байдлаар БЗД, ХУД-ийн нэгдсэн эмнэлгүүд үйлчлүүлэгчдийн саналыг авсан байна. Харин сэтгэл ханамж маш доогуур, муу байдаг гэсэн үзүүлэлтээр СБДНЭ, СХДНЭ өндөр саналтай үр дүн гарсан байна. Үүнээс гадна эмнэлгийн ажилтнуудын хөдөлмөр хамгаалал ямар байгааг асуухад 50 хувь нь муу, дунд гэж үнэлсэн байгаагаас харахад эмч, эмнэлгийн ажилтны сэтгэл ханамж, ажлын ачаалал зэрэг нь үйлчилгээнд нөлөөлж байж болох талтай. Эндээс харахад эмчтэй холбоотой эрх зүйн зөрчлийн гол шалтгаан нь эмч, эмнэлгийн ажилтны дагаж мөрдөх ёстой мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ зөрчигдсөний улмаас

гаргасан алдаа нь хууль зүйн тодорхой үр дагавартай байж болохыг харуулж байна. 2008-2010 онд Өнөөдөр болон Өдрийн сонинд нийтлэгдсэн эмч, эмнэлгийн байгууллагын ажилтнуудын буруутай үйл ажиллагаанаас бусдад учруулсан хохирлын талаар түүвэрлэн үзвэл: Өдрийн сонины ... дугаарт 4 настай хүүг өрхийн эмч нь үзээд эмнэлэгт хэвтэх бичиг хийж өгснөөр Сүхбаатар дүргийн эрүүл мэндийн нэгдлийн хүлээн авахын эмчид үзүүлтэл бичиг баримтыг нь шалгаад эмнэлэг хүнээ багтааж дийлэхгүй байгаа учраас хүлээн авах боломжгүй гэжээ. Хүүгийн эзэн нь Сүхбаатар дүргийн харьяа байсан атал аавынх нь хаягаар Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн нэгдэл явахыг зөвлөсөн байна. Тухайн үед хүүхэд хүнд өвчилсөн байсан бөгөөд олон жил ажилласан эмч хүүхдийг хүнд өвчтэй байгааг мэдэрч чадаагүйн улмаас хүү БЗД-ийн эрүүл мэндийн нэгдэл орох замдаа нас барсан байна. Энд эмч зөвхөн бичиг баримтыг нь шалгаад ийм шийдвэр гаргасан бөгөөд өвчтэй хүүхдийг бүрэн оношилж яаралтай тусламж үзүүлээгүй нь тангараг өргөсөн эмчийн хувьд ноцтой алдаа гаргасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.6-д зааснаар Монгол Улсын иргэн эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. Мөн Эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.10-т "эмнэлгийн яаралтай тусламж" гэж хүний амь насанд аюултай аливаа эмгэгийг оношлох, эмчлэх, түүнийг сэхээн амьдруулах, хүндрэлээс сэргийлэхэд чиглэгдсэн, эмчийн дангаар болон эмнэлгийн бусад мэргэжилтэнтэй хамтран гүйцэтгэх хойшлуулшгүй үйл ажиллагааг; мөн хуулийн 33 дугаар зүйлд "Гэнэтийн өвчин, осол, гэмтэл, хордлогын болон амаржих үед эмнэлгийн яаралтай тусламжийг өвчтөнд хамгийн ойрын эмнэлгийн байгууллага үзүүлнэ" гэж тус тус заасан. Гэтэл 4 настай хүү Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон эрхээ эдэлж чадаагүй бөгөөд СБД-ийн эрүүл мэндийн нэгдлийн эмч холбогдох хуулийг ноцтой зөрчсөн үйлдэл гаргасан байна.

Дөрвөн сартай хүүхдэд буруу тариа хийснээс амь нас нь эрсэдсэн[389] бас нэгэн тохиолдол. Хүнд өвчилсөн хүүхдэд сувилагч анхаарал хайхрамжгүй байдлаасаа болж ижил савалгаатай тариа андуурч хийсэн нь хүүг үхэлд хүргэсэн. Гэтэл сувилагч тариа хийхээсээ өмнө 3 удаа нягталж харах ёстой гэсэн эмнэлгийн заавар байдаг. Гэтэл сувилагч энэхүү зааврын дагуу ажиллаагүй бөгөөд түүнд харин Хөдөлмөрийн хуульд заасны дагуу захиргааны арга хэмжээ аваад өнгөрсөн байна. Дээрх тохиолдлууд нь ихэнхдээ эмчийн хайхрамжгүй, хариуцлагагүй байдал, хүний төлөө гэсэн сэтгэл дутасанаас үүдэлтэй учирсан хохирлууд юм. Хуульд зааснаар эдийн болон эдийн бус хохиролыг нэхэмжилж болох ч сэтгэл санаанд хохиролыг хэрхэн нөхөн төлүүлэх талаарх эрх зүйн зохицуулалт тодорхойгүй байна. Амь нас, эрүүл мэндээрээ хохирсон иргэд холбогдох байгууллагад /Эрүүл мэндийн яам, Нийслэлийн эрүүл мэндийн газар, Тухайн эмнэлэгийн захиргаанд/ гомдлоо гаргадаг хэдий ч шийдвэрлэж өгдөггүй байдал байсаар байна.

2.1.Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээний талаар

Тус хэм хэмжээ буюу дүрэм нь эмч, эмнэлгийн ажилтны баримтлах шаардлагатай нэлээд чухал хэм хэмжээ бөгөөд үүнийг боловсруулахын тулд 10 гаруй орны Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг судлан үзсэний үндсэн дээр боловсруулсан байна. Энэ хэм хэмжээ нь уншихад

[389] "Өдрийн сонин". 2010 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр. 7 дахь тал .

ойлгомжтой ч зарим талаар хэрэгждэггүй байдалтай байна. Хэрэгжилтийн байдлыг иргэдийн дунд санал асуулга явуулах, бодитой баримтад тулгуурлах замаар гаргасан болно.

Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээний 3.5.4-т: Үр хөнөөлтийг насанд хүрээгүй охидод хийх бол эцэг, эхийн зөвшөөрлийг авна гэсэн байна. Эцэг, эхээс гадна "асран хамгаалагч, харгалзан дэмжигч" гэсэн нэр томъёог оруулах нь зүйтэй юм.

3.14-т Эмнэлгийн мэргэжилтэн нь өвчний түүх болон үйлчлүүлэгчийн нууцтай холбоотой бусад бичиг баримтыг үйлчлүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулах буюу бусдад ашиглуулахаар хувилан өгч болохгүй.

3.21-т Эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчлүүлэгчээс шан харамж, албан бус төлбөр авч болохгүй. Энэ нь амьдралд хэрэгждэггүй заалт гэж хэлж болно. Хүний амь насыг аварсан, хүнд өвчнөөс ангижруулсан байхад эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд хүмүүсийн өгч байгаа зүйлийг шан харамж, авлига гэж үзэх эсэх нь судлаачдын дунд маргаантай байдаг. Гэвч тэдгээр эмч, эмнэлгийн ажилтнууд үүргээ гүйцэтгэсний төлөө цалин, хөлс авч байгаа тул иргэдээс мөнгө, эд материал авах ёсгүй юм. Энэ баримт бичгийн хэрэгжилтийг эмнэлгүүд янз бүрээр зохион байгуулдаг байна. Жишээ нь, СБД-ийн Эрүүл мэндийн нэгдэл эмч нарынхаа үйл ажиллагаанд хяналт тавьж ажилладаг ба иргэдээс ямар нэг эд зүйл авсан тохиолдолд ёс зүйн урамшуулллаас нь хасах арга хэмжээг авдаг байна. Харин Улсын клиникийн нэгдүгээр эмнэлэгийн Чанарын хяналтын байцаагчтай уулзалт, ярилцлагын аргаар судалгаа хийхэд "Манай эмнэлгээр үйлчлүүлсэн иргэдийн дийлэнх олонх нь тодорхой хэмжээний шан харамжийг өгдөг. Бид мэдсэн ч ямар нэгэн арга хэмжээ авдаггүй, цалин бага хүмүүс шүү дээ" гэж байв. Энэ асуудлыг цэгцэлж, СБД-ийн ЭМН-ийн явуулдаг урамшууллын системийг нэвтрүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Уг ёс зүйн хэм хэмжээний 6.3-т эмнэлгийн мэргэжилтэн нь эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний болон оношлогоо, эмчилгээний бусад аргатай холбоотой ташаа, бүрэн бус, ойлгомжгүй, хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журам, удирдамжаас гажсан мэдээлэл бүхий сурталчилгааны талаар холбогдох байгууллагад мэдэгдэх ёстой. Ийм тохиолдол байдаг эсэх талаар холбогдох байгууллагаас тодруулахад нэг ч эмнэлгийн ажилтан ийм мэдээлэл өгч байгаагүй, энэ нь ёс зүйн хэм хэмжээнд байх зүйл гэсэн хариулт өгөв.

Мөн 6.5-д "үйлчлүүлэгчийг өөрийн зөвшөөрөлгүйгээр олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр танигдахуйц байдлаар харуулах буюу бусад хэлбэрээр сурталчилгаанд оруулах нь зохисгүй" гэсэн байна. "Сэтгэшгүй" эмнэлгийн захирал Хүрэлбаатар гэгч өөрийн эмнэлгээр үйлчлүүлсэн өвчтнүүдийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр үйлчлүүлэгчийн зөвшөөрлийг авсан эсэх нь тодорхойгүйгээр эмнэлгийн үйл ажиллагааг магтан сайшааж, ирж үйлчлүүлэхийг уриалсан нэвтрүүлэг ихээр цацаж байна /Үндэсний олон нийтийн радио, телевиз, С1 ТВ гэх мэт/.

Ёс зүйн хэм хэмжээний 6.6-д эмнэлгийн мэргэжилтэн нь бусдын хүсэлтээр ямар нэгэн тодорхойлолтыг хуурамчаар үйлдэх, эсвэл хуурамч баримтад гарын үсэг зурах ёсгүй гэж заасан байдаг. Хэдэн жилийн өмнө шүүх сэтгэц гэм судлалын эмч нар гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг хэрэг хариуцах чадваргүй, сэтгэцийн өвчтэй гэсэн дүгнэлт гаргаж байсан нь илэрсэн байдаг. Үүнээс гадна хувийн хэвшлийн эмнэлгүүд Нийгмийн

даатгалын сангаас мөнгө авах зорилгоор шинжилгээ хийсэн, эмчилгээ хийсэн гэж хувийн лабораторитой хүмүүстэй хуйвалдан хуурамчаар бичиг баримт үйлддэг талаар иргэдтэй хийсэн уулзалт, ярилцлагын үеэр дурдаж байсан юм.

6.7-д эмнэлгийн мэргэжилтэн нь тусламж үйлчилгээ үзүүлэхдээ яаралтай тусламжаас бусад тохиолдолд эхэнд ирсэн нь эхэлж үйлчлүүлэх буюу тэгш эрхийг хангасан хуваарилалтын зарчмыг баримтална.

Эмч нар үйлчлүүлэгчдийг эхэнд ирсэн дэс дараалаар үзэхгүй байхаас гадна хэл амаар доромжлох, танил хүмүүстээ дэс дараалал харгалзахгүйгээр үйлчилдэг нь санал асуулгын судалгаагаар тогтоогдсон байна.

6.10-т "Эмч хэрвээ зайлшгүй шаардлагаар өөрийн хувийн өмчийн эсвэл үйл ажиллагааны ашгаас нь хувь хүртдэг эмнэлгийн байгууллагадаа үйлчлүүлэгчийг илгээвэл хувь хүртдэг тухайгаа үйлчлүүлэгчид мэдээлэхийн зэрэгцээ ижил төрлийн тусламж үйлчилгээ үзүүлдэг бусад мэргэжилтэн, байгууллагын талаар бүрэн мэдээлэл өгөх нь ёс зүйд нийцнэ" гэсэн байдаг. Гэвч харамсалтай нь ийм асуудал байсаар байгаа. Улсын эмнэлэгт ажилладаг дадлага, туршлага, мэргэшил сайтай эмч нарын дийлэнх олонх нь өөрсдөө хувийн эмнэлэг байгуулсан байх ийм хувийн эмнэлэггүй нь үйлчлүүлэгчдийг "Өвчтөн илгээх хуудас" гэсэн хуудсаар илгээдэг. Өвчтөний үзүүлсэн төлбөрийн тодорхой хувийг авдаг ч энэ байдлаа хэлдэггүй байна. Үүнд хариуцлага тооцох механизмыг Эрүүл мэндийн тухай хуульд оруулах нь зүйтэй гэж судалгааны баг үзсэн болно.

Хэм хэмжээний 7.1-д Эмнэлгийн мэргэжилтэн ёс зүйн зөрчил гаргасан нь зохих журмын дагуу хийсэн шалгалтаар тогтоогдсон, эмнэлгийн мэргэжилтний Ёс зүйн хорооны болон салбар хорооны шийдвэрийг биелүүлээгүй эмнэлгийн мэргэжилтнүүдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Ёс зүйн зөрчил, мэргэжлийн алдаа гаргасан нөхцөлд Эрүүл мэндийн яамны дэргэдэх Ёс зүйн хороогоор хэлэлцэн 1 жилийн хугацаагаар эмчлэх эрхийг түдгэлзүүлдэг байна.

Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг гэсэн хэсэгт: Эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой бүрэн, бодит мэдээллийг өөрөө асуугаагүй тохиолдолд ч ойлгомжтой үг, хэллэгээр авах эрхтэй гэж заасан хэдий ч хүүхдээ төрүүлээд эмчилгээ хийлгэж байгаа ч ямар эм, тариа хэрэглэж байгаа талаар мэдээлэл өгдөггүй, асуусан ч хэлэхгүй байх тохиолдол байдаг талаар уулзалт ярилцлага хийхэд хэд хэдэн иргэн ярьж байв.

Эмчилгээ, үйлчилгээний үр дүн, өвчний явц, цаашид хийх эмчилгээ, гарч болох үр дагаврын талаар эмнэлгийн мэргэжилтэнтэй ярилцах, тайлбар авах эрхтэй байна. Гэсэн хэдий ч ийм байдлаар тайлбар өгдөггүй. Гадаадын улс орнуудын тухайлбал, Герман, Польш, АНУ гэх мэт олон орны эмч, эмнэлгийн ажилтнууд үйлчлүүлж байгаа иргэдэд эмчилгээний явцад гарч болох хүндрэл, эрсдэл, үйлчилгээний талаар хувиар тооцон баталгаа өгдөг байна. Иймдээ ч тэдний үйлчилгээ өндөр үнэтэй байдаг нь ойлгомжтой.

Эмнэлэг болон эмчийг өөрөө сонгох, тусламж, үйлчилгээг хүлээн авах явцад эмчийг солих санал тавих эрхтэй ч манай улсын хувьд хувийн хэвшлийн эмнэлэгт тухайлан очиж, төлбөртэйгээр эмчийг сонгон үйлчлүүлэх боломжтой байна.

Эрүүл мэндийн сайдын 2006 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн 135 тоот тушаалын 2 дахь хавсралтаар батлагдсан Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хорооны дүрмийн 2.1.4-т Ёс зүйн хороо нь Ёс зүйн хэм хэмжээ зөрчигсдөд өөрийн бүрэн эрхийн хүрээнд хууль журмын дагуу зохих хариуцлага хүлээлгэх эрхтэй гэсэн байна. Энд ямар хариуцлага хүлээлгэх нь тодорхойгүй байна. Мөн 2.1.5-д Ёс зүйн хорооны шийдвэрийг биелүүлэхгүй буюу зөрчсөн хүмүүст хариуцлага хүлээлгэх тухай саналыг холбогдох эрх бүхий албан тушаалтанд тавих эрхтэй байна. Эрүүл мэндийн яамны Ёс зүйн хороо нь одоогоор ийм санал нэгийг ч явуулаагүй байна. 2.2.6-д Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээний зөрчилтэй холбоотой мэдээллийн сан бий болгож хөтлөх гэсэн дүрэм аль 2006 онд батлагдсан боловч одоог хүртэл ийм мэдээллийн сан байхгүй. Одоо хийхээр төлөвлөж байгаа нь баталсан дүрэм, журмынхаа хүрээнд үйл ажиллагаа явуулдаггүй, удирдлага бүтэц өөрчлөгдөх нь их байдаг тул энэ ажил хийгдээгүй гэж үзэх үндэстэй байна. Мөн 3.16.7-д Хорооны нарийн бичгийн дарга нь эмнэлгийн мэргэжилтний ёс зүйтэй холбоотой асуудлыг бүртгэж, мэдээллийн сан бий болгох үүрэгтэй ч одоог хүртэл хийгээгүй байна.

Хорооны бүтэц, зохион байгуулалтын хувьд одоогоор 13 гишүүнтэй. Дарга нь Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, нарийн бичгийн дарга нь тус яамны эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн байна. Сард 1-ээс доошгүй удаа хуралдана гэж дүрэмдээ заасан ч орон тооны бус зөвлөл учраас ингэж хуралддаггүй, 2009 онд гэхэд 4 удаа хуралдсан байна.

Үүнээс ЭМЯ-нд ёс зүйн зөрчил гаргасан эмч, эмнэлгийн ажилтны бүртгэл, мэдээллийн санг ойрын хугацаанд хийх шаардлагатай нь харагдаж байна.

2.2. Хохирол нөхөн төлөх талаарх эрх зүйн баримт бичгийн биелэлтийг хангаж байгаа байдал

Эрүүл мэндийн салбар дахь эмнэлгийн үйлчилгээний соёл, стандарт, эмнэлгийн удирдлагууд болон ажилтнуудын ажлын зохион байгуулалт эмнэлгээр үйлчлүүлж байгаа иргэдийн сэтгэлд нэгэнт хүрч чадахгүй байгаа, нөгөө талаар улсын эмнэлгээр үйлчлүүлэхэд хүлээлт үүсдэг эсвэл удирдлага, эмч, ажилтнуудын гарыг "цайлгах", авлига хээл хахууль өгснөөр эмнэлгийн тусламж үйлчилгээг авч байна хэмээн сонин хэвлэл, болон Эрүүл мэндийн яамны захиалгат судалгаанд ч дурдагдсан байна. Энэ үүднээс иргэдийн дунд бухимдал үүсч, сэтгэл хангалуун үйлчлүүлж чадахгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна[390].

Эмчийн оношилж байгаа оношлогоо, эмчилгээ үргэлж 100 хувийн үр дүнтэй байна гэж байдаггүй. Эмнэлгийн ажилтны үйл ажиллагаа нь буруу, зөв байсан эсэхийг дүгнэхийн тулд үйлдэл, эс үйлдэхүй ба хор уршиг хоёрын хоорондын шалтгаант холбоог зөв тогтоох нь чухал[391].

Эмнэлгийн эрх зүйн зөрчил нь:

- Эмчийн алдаа;
- Гэмт хэрэг, эрүүгийн эрх зүйн зөрчил;
- Гэрээний зөрчил;

[390] Эрүүл мэндийн байгууллагын ёс зүй, шударга байдлыг сайжруулах төсөл. Нээлттэй ил тод үйл ажиллагаа, шударга хүртээмжтэй үйлчилгээ судалгааны ажил, УБ., 2006 он, 4 дэх тал.
[391] Э.Ганбат, М.Цэрэнбат Шүүх эмнэлэг, УБ., 2005 он, 254 дэх тал.

- Золгүй тохиолдол гэсэн хэлбэртэй байна.

Золгүй тохиолдол нь:

Эмч өөрийн үүргийг зохих журмын дагуу биелүүлсэн боловч урьдчилан мэдэж, урьдчилан сэргийлэх боломжгүй нөхцөл байдлын улмаас эмчээс шалтгаалахгүй үйлдсэн эмчилгээ, оношлогооны тааламжгүй төгсгөлийг ойлгоно. Жишээ нь:

- Анх удаа хэрэглэсэн эмийн бодист харшил өгөх;
- Наркозын үед амьсгалын дээд зам бөглөрөх;
- Тодорхой шалтгаангүйгээр зүрх гэнэт зогсох гэх мэт[392]. Дээрх тохиолдолд эмчид хууль зүйн хариуцлага хүлээлгэхгүй.

Эмчийн алдаа буюу захиргааны эрх зүйн зөрчил:

Эрүүл мэндийн салбарт эмчийн алдаа гэдэгт хүйтэн цэвдэг сэтгэлийг болон болгоомжгүй, хайхрамжгүй, хөнгөн хийсвэр хандлагын ямар нэгэн илрэлгүй сайн санааны төөрөгдлийн улмаас үүссэн оношлогоо, эмчилгээний дутагдлыг ойлгоно. Эмчийн алдааны үед эмч өөрийн үүргийг зохих ёсоор биелүүлсэн байх ёстой.

Хууль зүйн үүднээс авч үзвэл эмчийн алдаа нь захиргааны эрх зүйн зөрчил юм. Эмчийн алдааны үед дараах нөхцөл байдлыг тодруулах шаардлагатай.

1. Эмч тухайн захиргааны акт буюу эмчилгээ, оношлогооны стандартыг дагаж мөрдөх ёстой эрх зүйн чадамж бүхий субъект мөн эсэх;

2. Эмч стандартыг зөрчсөн буюу захиргааны эрх зүйн зөрчил гаргасан нь тогтоогдсон эсэх;

3. Эмчийн буруутай үйл ажиллагааны улмаас хохирол бодитой учирсан эсэх. Эмчийн алдааны субъектив шалтгаан нь:

-шинэ эмчид туршлага дутах,

- мэдлэг,

-логик сэтгэлгээ дутах гэх мэт байна. Ноцтой үр дагаварт хүргэсэн тухайлбал, эмчийн алдааны үед буруу оношилсон, цаг хугацаандаа оношлоогүй, эмчлээгүй гэсэн гомдлоор эрүүгийн хэрэг үүсгэн шалгагддаг "эмчийн алдаа"-г гэмт хэргээс ялган тогтоох шаардлагатай байдаг.[393] Буруутай эсэхийг шүүхээс тогтооно. Эмчийн алдаа гэж үзсэн тохиолдолд эмчид эрүүгийн болон сахилгын хариуцлага хүлээлгэхгүй.

Эмчийн алдаа нь дараах хэлбэртэй байна:

- Оношийн;

- эмчилгээний заалт ба эмчилгээ хийх үеийн /эмчилгээний тактикийн ба эмчийн техникийн/;

- эмнэлгийн тусламжийн удирдлага, зохион байгуулалттай холбоотой алдаа гэж ангилдаг байна.

Гэрээний буюу иргэний эрх зүйн зөрчлийн хувьд:

Эмч, өвчтөн 2-ын хооронд дараах гэрээ байгуулагдана.

-эмч ба үйлчлүүлэгчдийн хооронд;

-эрүүл мэндийн байгууллага, үйлчлүүлэгчдийн хооронд байгуулагдана.

Гэрээ байгуулах хууль зүйн ач холбогдол нь:

1. Эмчилгээ, оношлогооны явцад талууд зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх;

[392] Дурдсан бүтээл, 255 дахь тал.

[393] Мөн тэнд .

2. Талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд хохирлыг барагдуулах;

3. Эмчилгээний үр дүн, түүнээс гарах үр дагаварыг урьдчилан тооцож гэрээний шугамаар зохицуулалт хийх;

4. Гэрээний талууд хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд эрх нь зөрчигдсөн гэж үзэж байгаа этгээдийн гомдол, нэхэмжлэлийн үндсэн дээр төрийн албадлагын тусламжтайгаар зөрчигдсөн эрхийг нь сэргээж өгдөг.[394]

Эмч нарын үйл ажиллагаанд зайлшгүй байх зүйл нь үйлчлүүлэгчийн нэр төрийг гутаан доромжлохгүй, эмчилгээний болон оношийн нууцыг чандлан хадгалах шаардлагатай байдаг. Дэлхийн Анагаах ухааны нийгэмлэгээс 1948 онд Швейцарийн Женев хотноо баталж, 1968 онд Австралийн Сидней хотноо Дэлхийн эрүүл мэндийн 22 дугаар чуулганаар шинэчлэн баталсан Эмчийн тангаргийн тухай тунхаг бичигт:

"Эмч би үйлчлүүлэгч амьд ахуйд болон насан өөд болсны дараа ч түүний нэр төрийг хүндэлж, хувийн нууцыг чандлан хадгална"[395] гэж заасан байна.

Эмч, эмнэлгийн мэргэжилтэн дараах хоёр үндэслэлээр үйлчлүүлэгчдийн нэр төр, хувийн нууцыг хүндлэн хадгална.

1. Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байдлын тухай мэдээлэл нь прагматик буюу шууд хувийн шинж чанартай байна.

2. Эмч, үйлчлүүлэгчийн нэр төр болоод хувийн нууцлалын байдлыг хангах баталгаа өгөөгүй тохиолдолд үйлчлүүлэгч эмчилгээ, оношлогоонд шийдвэрлэхүйц буюу амин чухал байж болох мэдээллийг өгөхгүй байж болно.[396]

1998 онд батлагдсан Өгөгдлийн санг хамгаалах акт \Data protection act\-д зааснаар эмч, эрүүл мэндийн байгууллага үйлчлүүлэгчийн хувийн нууцыг хадгалах ёстой байдаг ч нийтийн ашиг сонирхол, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн үүднээс дээрх үүрэг үгүйсгэгдэх боломжтой. Жишээлбэл, шинжлэх ухааны судалгаа, шинжилгээ, аудитын үнэлгээ гэх мэт.

Энэхүү судалгааны хүрээнд хуульчдаас тухайлбал, прокурор, шүүгч, өмгөөлөгчдөөс санал асуулгын аргаар судалгаа авсан. Судалгааны дүнг авч үзвэл:

1. Эмч, эмнэлгийн байгууллагын ажилтнаас үүргээ биелүүлэхтэй холбоотой хэрэг, маргаан хэр их байна вэ? гэсэн асуултад цөөн боловч сүүлийн үед ихсэх хандлагатай байна гэж ихэнх нь үзсэн байна.

2. Ийм хэргийг шийдвэрлэхэд бэрхшээлтэй асуудал байдаг уу? Хэрвээ байдаг бол ямар? гэсэн асуултад ихэнх нь Шүүх эмнэлгийн шинжээч эмч нар ихэвчлэн ойлгомжгүй эсхүл худал дүгнэлт гаргадаг, эмч нарыг хаацайлсан дүгнэлт гаргадаг гэсэн хариултыг өгсөн байна.

3. Таны бодлоор энэ бэрхшээлийг хэрхэн шийдвэрлэх вэ?

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн шинжээч эмч нарын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, мөрдөн байцаагч зөв асуулт тавих, тусгай мэдлэг шаардсан ажил тул шинжээч нь хууль зүйн болон эмчийн мэргэжил эзэмшсэн хүн байх шаардлагатай гэсэн байна.

---

[394] М.Цэрэнбат, Эмнэлгийн эрх зүй, УБ., 2007 он, 61 дэх тал.

[395] http/www.org.library/ethics/geneva.

[396] Confidentially in Helga Kushe and Peter Singer /eds/, A companion to Bioethics/Blackwell Oxford 1998\ 425-31.

4. Хууль тогтоомжийн зохицуулалт бодит байдалд хэр нийцэж байна гэж үзэж байна вэ? Хэрвээ нийцээгүй бол яаж нийцүүлэх вэ?

Эрүүгийн хууль, Эрүүл мэндийн тухай хуулиудыг бодит байдалд нийцүүлэх шаардлагатай гэсэн саналыг бичсэн байна.

Мөн дараах саналыг бичжээ. Үүнд:

- Эрүүгийн хуулийн 197.1-д заасан эмчилгээ эрхэлсэн гэдгийг тодруулах шаардлагатай гэсэн байна;

- Эмч нар өөрсдийн алдааг нуухын тулд оношийг буруу тавьдаг. Өөрөөр хэлбэл, өөр өвчний суурийг тухайн өвчинд хамаатуулдаг байдал элбэг байдаг. Энэ нь тусгайлсан мэдлэг шаардлагатай байгаагаас үүддэг; Хохирогч нар хуулийн байгууллагад хандаж сураагүй, нэхэмжлэл, өргөдөл, гомдол гаргахгүй байна;

- Өөх соруулж, гоо сайхны мэс засал хийснээс нас барсан тохиолдолд хариуцлага хүлээлгэхэд хүндрэлтэй асуудал гарсан;

- Шинжээч эмч нар голыг нь олохгүй, бөөрөнхийлсөн дүгнэлт гаргадаг;

- Эмч, эмнэлгийн ажилтнуудын ёс зүй сүүлийн жилүүдэд их хэмжээгээр доройтсонтой холбоотой;

- Эмч, эмнэлгийн ажилтны үйлдсэн үйлдлийг санаатай эсхүл болгоомжгүй аль хэлбэрээр үйлдсэнийг тогтооход бэрхшээлтэй гэсэн байна;

- Эмч эмнэлгийн ажилтанд холбогдох хэргийг зөвхөн шинжээч эмчийн дүгнэлтэд тулгуурлан гаргадаг тул тогтооход бэрхшээлтэй;

- Монгол Улсад бүртгэгдээгүй эм болон эмчилгээ мөн эсэх нь эргэлзээтэй байдаг. Жишээ нь, гоо сайхны мэс засал болон түүнтэй адил мэс засал хийхэд гардаг хүндрэлийн үед хүлээлгэх хариуцлага тодорхойгүй байна гэжээ.

2.2. Гадаадын зарим орны туршлага, зохицуулалт

Их Британид

Их Британи улсад Үндэсний Эрүүл мэндийн үйлчилгээний шүүн таслах ажиллагааны талаар шүүхэд ирүүлсэн нэхэмжлэлийг эрүүл мэндийн, эрүүл мэндийн бус гэж ангилж үзээд нөхөн төлбөрт хичнээн төгрөг зарцуулсныг тайлагнасан байна.

Их Британи улсад 2008 оны 9 дүгээр сард 6652 нэхэмжлэл гаргаж байсан бол 2009 оны 10 дугаар сарын тайланд 10 хувь өссөн. Энэ нь 2007 оны 8 дугаар сарынхаас 11 хувиар өссөн үзүүлэлт гарчээ[397]. Их Британид эмнэлгийн тусламж үйлчилгээний улмаас хохирсон үйлчлүүлэгч нарын дунд явуулсан санал асуулгын үр дүнгээс харахад тэдгээрийн 60 хувь нь эмч, үйлчлүүлэгчээс зөвхөн уучлал гуйхыг хүссэн бол 11 хувь нь мөнгөн хэлбэрээр нөхөн төлөхийг шаардсан байна[398].

Хууль зүйн зардал

Нэхэмжлэгчийн өмгөөлөгчийн шаардаж байгаа зардал нь манай өмгөөлөгчдийн шаардаж байгаа зардлаас илүү өндөр болсон байна. Үүнд

[397] The national health service litigation authority, report and accounts 2010, pp.7

[398] Making amends: A consultation paper setting out prpopsals for reforming the approach to clinical negligence in tha NHS /DH 2003/ 75 дам ишлэв.

анхаарлаа хандуулах шаардлагатай. Шүүгч Жексон шүүхийн зардлын талаар хэлсэн үгэндээ ".. зардал нь адил тэнцүү биш бөгөөд хууль ёсыг сахиулахад саад болж байна" хэмээн тэмдэглэсэн юм. Бид шүүгч Жексоны гаргасан олон саналыг хүлээн зөвшөөрдөг ба ялангуяа нэхэмжлэгчийн өмгөөлөгчийн Нөхцөлт төлбөрийн гэрээний үндсэн дээр авах төлбөр буюу маргаанд ялалт байгуулсан үед авах мөнгийг хариуцагчаас гаргуулах ёсгүй гэж үзсэн түүний санал зөв юм. Доорх хүснэгтэд 2004 оны 5 дугаар сараас хойш гарсан эмнэлгийн зөрчилтэй холбоотой маргааны хүрээнд нэхэмжлэгчид төлсөн хохирол болон нэхэмжлэгчийн болон хариуцагчийн өмгөөллийн зардлын уялдааг харуулав. 2009 оны 10 дугаар сар гэхэд бид эдгээр нэхэмжлэлтэй холбоотой зардалд нийт 163 сая евро төлснөөс 121 сая евро нь /нийт зардлын 74% нь/ нэхэмжлэгчийн өмгөөлөгчид төлөгдсөн байна.

Хэсэгчилсэн төлбөр

Хэсэгчилсэн төлбөр гэдэг нь уламжлалт нэг удаагийн төлбөрийн оронд тогтмол хугацаанд нэхэмжлэгчийн амьдралын туршид төлөгдөх төлбөрийг хэлнэ. Энэ аргыг тохиромжтой нөхцөлд хэрэглэж байхыг бид дэмждэг. Бид энэ аргыг ирэдүйд зарцуулагдах зардал нь тодорхой байгаа өндөр хэмжээтэй ихэнх эрүүл мэндэд учирсан хохирлыг барагдуулахад нэхэмжлэгч болон Үндэсний эрүүл мэндийн байгууллага аль алинд нь шудрага арга гэж үздэг. 2010 оны 3 дугаар сарын 31-ний байдлаар бид нийт 805 хэрэгтэй холбоотойгоор хэсэгчилсэн төлбөрийг хийж байна. Энэ хэмжээ нь 2009 оны мөн үед 659, 2008 онд 548 байсан юм. 2010 оны 3 дугаар сарын 31-ний байдлаар нийт 1,886,553,690 паунд төлсөн байна.

Хууль зүйн маргаанаас зайлсхийх

Үндэсний эрүүл мэндийн үйлчилгээний эсрэг аливаа маргааныг шийдвэрлэх талаар Монгол Улсад "хууль бус үйлдлээс хүчтэй хамгаалах, хууль ёсны үйлдлийг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлж болох тохиолдлын тоог нэмэгдүүлэх замаар өвчтөнд үзүүлэх үйлчилгээний нөөцийг нэмэгдүүлэх" гэж тусгасан. Бид аливаа маргааныг аль болох хурдан шийдвэрлэхийг зорьдог бөгөөд Үндэсний эрүүл мэндийн байгууллагуудад өвчтөн болон ажилтанд асуудлыг тайлбарлах, уучлалт гуйж байхыг сануулдаг. Бид аль болох албан ёсны хуулийн маргаан үүсгэхгүй байх боломжийг эрэлхийлдэг бөгөөд түүхэн баримтаас харахад нийт маргааны зөвхөн 4% нь шүүхрүү шилжэнийг харуулдаг.

Оросын Холбооны Улсад[399]

Эмчилгээний алдаа бол эмч мэргэжлийн үүргээ шударгаар гүйцэтгэхдээ төөрөгдсөн явдал байдаг. Үүнийг эмчийн үйл ажиллагааны бусад алдаанаас ялгах гол ялгаа нь мэдлэггүй байдал, хайхрамжгүй байдал болон салан задгай байдал юм. Академич Давидовский[400]:

ОХУ-д эмчийн болон эмчилгээний алдаатай холбоотой асуудлыг дараах байдлаар зохицуулжээ. Эдгээр зохицуулалтын зарим нь эмчийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэлүүдийг мөн заасан. Жишээ нь: "Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах" хуулиийн 13 дугаар зүйлд үйлчилгээ үзүүлэгч нь давагдашгүй хүчин зүйлийн улмаас зохих үйлчилгээг үзүүлж чадаагүй гэдэг нь нотлогдсон, мөн хуульд заасан бусад үндэслэл байвал хариуцлагаас чөлөөлөгдөнө

[399] http://med.siteedit.ru/page290.
[400] http://med.siteedit.ru/page290.

гэж заасан. Үүнтэй адил зохицуулалтыг Засгийн газрын 1996 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 27 дугаар тогтоолоор батлагдсан "Эрүүл мэндийн байгууллагын хүрээнд төлбөртэй үйлчилгээ үзүүлэх дүрэм"-ийн 19 дүгээр зүйлд тусгасан байдаг. Эрүүл мэндийн үйлчилгээ авах иргэний эрхийг хамгаалсан дараах эрх зүйн зохицуулалтууд байдаг. Үүнд: Иргэний хууль /2 ба 7 дугаар бүлэг/, ОХУ-ын Үндсэн хууль /41 дүгээр зүйл/, "Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах тухай" хууль /3 дугаар бүлэг/, "ОХУ-ын иргэний эрүүл мэндийг сахин хамгаалах тухай" хууль /6 дахь хэсэг/, "ОХУ-ын иргэний эрүүл мэндийн даатгалын тухай" хууль /6,7 дугаар зүйл/, Засгийн газрын 1996 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 27 тоот тогтоолоор батлагдсан "Эрүүл мэндийн байгууллагын хүрээнд төлбөртэй үйлчилгээ үзүүлэх дүрэм"-ээр тус тус зохицуулдаг. Эмнэлгийн байгууллагын чанаргүй тусламж, үйлчилгээний улмаас иргэнд сэтгэл зүйн болон материаллаг хохирлыг нөхөн төлөх талаарх зохицуулалтуудыг дараах хуулиудад тусгасан байна. Иргэний хууль /1064-1101 дүгээр зүйл/, "Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах тухай" хууль /14-17 дугаар зүйл/, "ОХУ дахь иргэний эрүүл мэндийг сахин хамгаалах хууль тогтоомжийн үндэслэл" хууль /12 дахь хэсэг болон 66, 67, 69 дүгээр зүйл/, "ОХУ-ын эрүүл мэндийн даатгалын тухай" хууль /6 дугаар зүйл/. Түүнчлэн эмч хувийн нөхцөл байдлаас шалтгаалан ОХУ-ын Эрүүгийн хуулийн 109 /Бусдыг болгоомжгүй алах/, 118 /Бусдын биед хүнд гэмтэл болгоомжгүйгээр учруулах/, 293 /Үүрэгт ажилдаа хайнга хандах/ болон бусад зүйл ангиар хариуцлага хүлээж болно.

Шинжилгээ:

Эмчилгээний үед эмнэлгийн байгууллагын ажилтны буруутай эсэхийг тогтооход шинжилгээг зайлшгүй хийх шаардлагатай байдаг. Энэ нь эрүүл мэндийн шинжилгээний бие даасан төрөл бөгөөд үүнийг "эрүүл мэндийн тусламжийн чанарын шинжилгээ" гэдэг. Энэ нь эмнэлгийн тусламж үзүүлэх үеийн эмчилгээний алдааг илрүүлэх, түүний шалтгааныг тодорхой болгох, үүссэн хор уршгийн шалтгаан үр дагаврын холбоог тогтоох зорилгоор шинжээч-мэргэжилтний гүйцэтгэдэг судлан шинжлэх ажил юм.

Түүнчлэн мэргэжилтэн дүгнэлтдээ зайлшгүй дурдах зүйл бол эмнэлгийн байгууллагын ажилтны зүгээс гаргасан зөрчлийн /буруу үйлдэл болон эс үйлдэхүй, алдаа, дутагдал, хангалтгүй байдал/ талаарх заалт юм. Харин хууль зүйн /шинжтэй асуулт/ шинжээчид тавигддаггүй. Энэ төрлийн шинжилгээ нь шүүхийн өмнөх болон шүүхийн шатанд хийгддэг бөгөөд шүүхийн өмнөх шатны шинжилгээ нь шүүхийн ямар нэгэн даалгаваргүйгээр энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар хийгддэг. Үүнийг ерөнхийдөө эрүүл мэндийн даатгалын компаниуд хийдэг. "ОХУ-ын иргэний иргэний эрүүл мэндийн тухай" хуулийн /15 дугаар зүйл/ даатгалын компаниуд ийм шинжилгээ хийх эрхтэй төдийгүй үүрэгтэй байдаг бөгөөд түүнчлэн даатгуулагчдын ашиг сонирхлыг хамгаалах үүргийг давхар хүлээж байдаг. "Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах тухай" хуулийн /45 дугаар зүйл/ дагуу хэрэглэгчдийн олон нийтийн нэгдэл нь үйлчилгээний чанар, аюулгүй байдлын хөндлөнгийн шинжилгээ хийх эрхтэй байдаг. Гэхдээ бодит байдал дээр шүүхийн өмнөх шинжилгээг зөвхөн эрүүл мэндийн даатгалын бүтцийн байгууллагууд гүйцэтгэдэг. Даатгалын байгууллагын хийж буй шүүхийн өмнөх шинжилгээ нь цаг хугацаа хэмнэх, өвчтөний эдийн засгийн байдалд хэмнэлттэй /үнэ төлбөргүй хийгддэг/, торгох шийтгэл хүлээлгэх болон шүүхээс өмнөх шатанд хэрэг маргааныг шийдвэрлэх боломжтойгоороо

давуу талтай байдаг. Энд нэг зүйлийг зориуд онцлон хэлэхэд даатгалын компаниуд орон нутгийн эрүүл мэндийн тогтолцоонд ордоггүй тул эрүүл мэндийн тусламжийн чанарын талаар гаргасан дүгнэлтэд итгэж болно. Гэхдээ ийм шинжилгээ нь шүүх дээр нотлох баримтын чанараа алддаг бөгөөд процессын талаас нь харвал энэ нь "шинжээчийн бичмэл дүгнэлт" болж хувирдаг.

Мөн ОХУ-д даатгалын компаниуд "Эмнэлгийн байгууллагын ажилтны мэргэжлийн хариуцлагын даатгал"-ын үйлчилгээ үзүүлдэг бөгөөд энэ нь нэг талаас эмнэлгийн үйлчилгээ авагсдад эдийн болон эдийн бус хохирлоо нөхөн төлүүлэх боломжийг хялбарчилдаг. Гэвч зарим тохиолдолд өвчтөнүүд үүнийг буруугаар ашиглах нь байдаг бөгөөд ОХУ-ын Эрүүл мэндийн холбооны Санкт-Петербург дахь салбарын төлөөлөгч Евгений Никитиний мэдэгдэж байгаагаар тус хотод 1997-2001 оны хооронд эмчилгээний дутагдалтай холбоотой нэхэмжлэлийн тоо 2 дахин өссөн гэжд, "Гэхдээ нэхэмжлэлийн 15 хувь нь үндэслэлгүй болох нь шүүх эмнэлгийн шинжилгээгээр тогтоогддог" гэжээ. Эдийн болон эдийн бус хохирлыг нөхөн төлөх хууль зүйн үндэслэл нь Иргэний хуулийн 59 дүгээр бүлэг. 1072 дугаар зүйл юм.

"Эмчийн болон эмчилгээний алдаа" гэж одоогоор аль ч хуульд байдаггүй. Үүнийг эрүүл мэндэд хохирол учруулах гэсэн ойлголт дор зохцуулдаг. Нөгөө талаас хууль тогтоомжийн дагуу "Хэн ч өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөх үүрэггүй" тул эмч гаргасан алдааныхаа тухай заавал хэлэх үүрэг хүлээдэггүй.

Эмчийн алдааг олон үндэслэлээр ангилж болдог. Юун түрүүнд ямар хүрээнд, ямар түвшний эмнэлгийн тусламж үзүүлж байна гэдгээр нь дараах байдлаар хуваж болно. Үүнд:

- Оношлогооны /үзлэг хийж өвчний хүндрэл, зовиурыг буруу таних явдал. Энэ төрлийн алдаа илүү их байдаг/;
- Эмчилгээний /оношлогоог буруу тавьснаас үүдэлтэй тактикийн алдаа/;
- Техникийн алдаа /эмчилгээний арга барил, үйл ажиллагаа, процедурын алдаа/;
- Зохион байгуулалтын алдаа /зайлшгүй нөхцөлд үзүүлэх үйлчилгээ, багаж төхөөрөмж тухайн эмнэлэгт хангалтгүй байх/.

Эмчид эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэх асуудал нь гэмт хэргийн бүрэлдэхүүнээс хамаардаг ба тодорхой гэмт хэрэг нь ОХУ-ын эрүүгийн хуулийн 123 дугаар зүйл /үр хөндөлт хууль бусаар хийх/ байдаг. Хүлээлгэх хариуцлага нь 80.000 хүртэлх рублиэр торгох эсвэл, албадан ажил хийлгэдэг[401]. ОХУ-ын хувьд эмч, эмнэлгийн байгууллагын ажилтны учруулсан хохирлыг нөхөн төлөх асуудлыг даатгалын системийн тусламжтайгаар зохицуулахыг зорьдог байна. Гэвч энэ нь хангалтгүй бөгөөд судлаачдын зүгээс "Эмчлүүлэгчийн эрхийн тухай", "Эмнэлгийн байгууллагын ажилтны мэргэжлийн даатгалын тухай" хуулийг ойрын хугацаанд батлахыг зөвлөж байгаа юм[402].

Судалгааны сэдэвтэй холбоотой ОХУ-д Иргэний эрх зүйн журмаар шийдвэрлэгдсэн хэргийг жишээ болгон дурдах нь ач холбогдолтой гэж судалгааны баг үзсэн болно.

[401] http://www.liberty.ru/columns/Antikorrupcioner/Vrachebnaya-oshibka-prestuplenie-prostupok.
[402] http://www.liberty.ru/columns/Antikorrupcioner/Vrachebnaya-oshibka-prestuplenie-prostupok.

Жишээ нь: ОХУ-ын Омск хотын Киров дүүргийн шүүх 2005 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн шүүх хуралдаанаар иргэн А насанд хүрээгүй А, И нарыг төлөөлөн гаргасан, Эрүүл мэндийн орон нутгийн удирдлага, 6 дугаар төрөх, Омск хотын санхүүгийн хэлтэст холбогдуулан эхийгээ алдсаны улмаас учирсан сэтгэл санааны хохиролд насанд хүрээгүй хүүхэд тус бүрт 120000 рубль гаргуулах тухай нэхэмжлэлийг хянан шийдвэрлэсэн байна. Мөн нас барагчийн эцэг эх болох П, В нар дээрх хариуцагчдаас охиноо алдсаны улмаас учирсан /сэтгэл санааны/ хохиролд тус бүртээ 100000 рубль гаргуулахаар гаргасан нэхэмжлэлийг энэхүү хуралдаанаар хянан хэлэлцэж шийдвэрлэжээ. Уг хуралдаанаар 6 дугаар төрөхийн ажилтнуудын буруутай үйлдлийн улмаас хохирогч нас барсныг шүүх-шинжээч эмчийн комиссын дүгнэлтэд[403] үндэслэн тогтоосон ба ОХУ-ын Иргэний хуулийн 151 дүгээр зүйл, ОХУ-ын УДШ-ийн 1994 оны 10 тоот бүгд хурлын тогтоолын 2 дахь хэсгийн "... сэтгэл санааны хохирол нь төрөл саднаа алдсаны улмаас учирч болно" гэснийг, ОХУ-ын "Иргэний эрүүл мэндийг хамгаалах тухай хууль тогтоомжийн үндэс"-ийн 17, 20 дугаар зүйлийг тус тус үндэслэн нэхэмжлэлийн зарим хэсгийг хангаж шийдвэрлэсэн байна. Нэхэмжлэлийн зарим хэсгийг хангахгүй орхихдоо Иргэний хуулийн 1064 дүгээр зүйлийг баримталсан бөгөөд хохирол учрахад хохирогчийн буруутай үйлдэл /жирэмсний үед хагалгаа хийх талаар хохирогчид сануулсан ч эс зөвшөөрсөн/ тодорхой хэмжээгээр байсан гэж шүүх үзжээ.

Шүүх хохирогчийн насанд хүрээгүй хүүхдүүд тус бүрт 80 000 рубль, эцэг эх тус бүрт 60 000 рублийг хариуцагчаас гаргуулан олгохоор шийдвэрлэсэн байна. Дээрх мөнгөн дүнг шударга ба ухаалаг гэж шүүх үзсэнээ шийдвэртээ тусгажээ. Түүнчлэн хохирогчийн насанд хүрээгүй 2 хүүхдэд сэтгэл зүйн хохирол учирсан гэж үзэхээс илүү, бага насанд нь үзүүлэх эхийн хайр халамж болон бусад эх үрийн холбоог юугаар ч нөхөж болохгүй тул энэхүү биеэр эдлэх зовлон шаналлын нөхөн төлбөрт дээрх мөнгийг олгох нь зүйтэй гэж үзжээ[404]. Мөн эмч, эмнэлгийн байгууллагад хүлээлгэх эрүүгийн хариуцлага ямар байдаг талаар гадаадын зарим орны зохицуулалтыг судлав.

Япон улс

Япон улсын Эрүүгийн хуулийн 29 дүгээр бүлэг, 214 дүгээр зүйлд "Мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг этгээд үр хөндөх, түүний улмаас амь насыг нь хохироох, хүнд гэмтэл учруулах" гэж заасан бөгөөд уг гэмт хэргийн субъектыг эмч, эх баригч, эм найруулагч болон эмийн худалдаачин гэж: тусгайлан заасан байна. Жирэмсэн эмэгтэй хэдийгээр өөрөө хүссэн болон хүлээн зөвшөөрсөн хэдий ч үр хөндсөн бол 3 сараас 5 жил хүртэлх хугацаагаар албадан ажил хийлгэж хорих ялаар шийтгэнэ. Хэрэв үр хөндөлтийн улмаас амь насыг хохироосон, хүнд гэмтэл учруулсан бол 6 сараас 7 жил хүртэл албадан ажил хийлгэж хорих ял ногдуулж шийтгэдэг байдаг

Дани улс

Дани улсын хувьд эмч, эмнэлгийн байгууллагын ажилтан гэсэн тусгайлсан субъекттэй гэмт хэрэг байддаггүй бөгөөд Эрүүгийн хуулийн 25 дугаар бүлэг, "Хувь хүний эсрэг гэмт хэрэг" бүлгийн 239, 240 дүгээр зүйлд хохирогчийн хүсэлтээр амийг нь хорлосон буюу амиа хорлоход тусласан

[403] Шүүх хуралдаанд хэлэлцэгдсэн шүүх-шинжээчдийн комиссын дүгнэлтийн талаар http://www.pravo-med.ru/practice/doc.php?ID=4119 цахим хуудаснаас дэлгэрэнгүй үзнэ үү.
[404] http://www.pravo-med.ru/practice/doc.php?ID=4119

үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр тусгасан байна. Гэхдээ уг гэмт хэргийн субъект нь хэн ч байж болно гэж заажээ.

Болгар улс

Тус улсын Эрүүгийн хуулийн 126 дугаар зүйлд жирэмсэн эмэгтэйн зөвшөөрлөөр Эрүүл мэндийн яамны тогтоосон эмнэлгийн нөхцөл болон энэ талаар Яамнаас тогтоосон журмыг зөрчин ургийг үхүүлсэн бол 5 жил хүртэлх хугацаагаар эрх чөлөөг нь хязгаарлана /хорих/. Хэрэв гэм буруутай этгээд нь эмчилгээ эрхлэх дээд боловсролгүй бол, хоёр буюу түүнээс дээш эмэгтэйн ургийг үхүүлсэн бол 8 хүртэлх жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэхээр заасан байна.

Польш улс

Польш улсын Эрүүгийн хуулиар эхийн хэвлийд бүрэлдэж буй ургийн эрхийг голчлон хамгаалсан байна. 1999 оны 7 дугаар сарын 8-ны өдөр уг хуульд нэмэлт /157а дугаар зүйл/ оруулж, ургийн амь насанд аюултайгаар бие махбодь болон эрүүл мэндэд гэмтэл учруулах үйлдлийг гэмт хэрэгт тооцох болсон бөгөөд энэ хэргийг эмч, жирэмсэн эх, ургийн амь нас эрүүл мэндийг аюулаас аврах зорилгоор зайлшгүй хийсэн бол гэмт хэрэгт тооцохгүй гэсэн байна.

Дүгнэлт

1.Энэ төрлийн хэрэг маргааныг шийдвэрлэж буй практикаас харахад Эмч, эмнэлгийн байгууллагын бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх харилцааг үндсэнд нь Иргэний эрх зүйн "Гэм хор учруулснаас үүсэх үүргийн эрх зүй"-ээр зохицуулж байна. Тухайн эрх зүйн зөрчил нь Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг агуулсан бол эрүүгийн эрх зүйгээр зохицуулна. Гэхдээ энэ нь хохирлыг нөхөн төлөх үндсэн зорилготой бус, хуульд заасан хариуцлага хүлээлгэж буй хэлбэр юм. Харин тухайн этгээдийн /эмчийн/ гэм буруутайг тогтоож байгаа нь хохирлыг нөхөн төлүүлэх хууль зүйн үндэслэл болно гэж болно. Анкетын судалгаанаас харахад иргэдийн дийлэнх нь эмч, эмнэлгийн байгууллагын ажилтантай холбоотой дараах 2 асуудлыг нарийн ялгахгүй байна гэж дүгнэж болохоор байна. Үүнд:

- Эмч, эмнэлгийн ажилтанд хариуцлага тооцуулах;
- Эмч, эмнэлгийн ажилтны учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх.

Ийм учраас уг асуудлыг шийдвэрлүүлэх талаар хаана хандахаа төдийлэн мэддэггүй байна. Жишээлбэл, хохирол нэхэмжлэх талаар "Ёс зүйн хороо"-нд хандах боломжгүй. Хороо нь тогтоосон хэм хэмжээний дагуу сахилгын болон захиргааны шийтгэл ногдуулах эрх хэмжээтэй.

2. Мөн эмч нарыг хувийн эмнэлэг байгуулан ажиллуулах болон клиникийн эмнэлэгт зөвлөх эмч байх, мэргэжлийн дагуу хэд хэдэн газар зэрэг ажиллах асуудлыг зохицуулах шаардлагатай. Учир нь эмч нар улсын эмнэлэг дээр үзлэг, оношлогоо, эмчилгээ хийх боломжтой байтал техник тоног төхөөрөмж байхгүй гэх үндэслэлээр өөрийн хувийн эмнэлэгт үзүүлэхийг санал болгодог. Улмаар хувийн эмнэлэгт эмчилгээ, оношлогоо буруу хийгдсэнээс өвчтөн хүндэрсэн, амь нас нь эрсдэж болох нөхцөл бий болоход буцаагаад улсын эмнэлэгт авч эмчлэн гаргасан алдаа, зөрчлөө улсын эмнэлэгийн ажилтны хариуцлагагүй байдлаас болсон мэтээр тайлбарлаж хувийн эмнэлэг /хуулийн этгээд/ хариуцлагаас зайлсхийх явдал түгээмэл байдаг байна.

3. Хэрэг маргааныг шүүхээр шийдвэрлэж байгаа байдлаас харахад хохирлыг эдийн болон эдийн бус гэж төрөлжүүлэн нэхэмжилдэггүй байна. Мөн иргэдийн эрх зүйн мэдлэг төдийлөн хангалттай бус байгаагаас хохирлоо төлүүлэхээр шүүхэд хандаж байгаа тохиолдол харьцангуй цөөн байна. Энэ нь нөгөө талаас эмнэлгийн байгууллагын захиргаа хохирсон иргэдийн гомдлыг ямар нэг байдлаар шийдвэрлэдэгтэй холбоотой юм.

4. Гадаадын зарим орны зохицуулалтаас харахад эмч, эмнэлгийн ажилтны болгоомжгүй үйлдэлтэй холбоотой зөрчилд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэггүй, хүний биед гэмтэл учруулсан, амь биеийг хохироосон санаатай /хүсэж үйлдсэн/ үйлдэлд нь л эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг байна.

5. Дэлхий нийтийн чиг хандлагаас харвал эмч, эмнэлгийн ажилтны учруулсан хохирлыг нөхөн төлөх харилцааг үндсэндээ даатгалын эрх зүйгээр зохицуулж байна. Учир нь урьдчилан харах боломжгүй эрсдлийг даван туулах хамгийн оновчтой хувилбар нь даатгалын тогтолцоо юм. Манай орны хувьд энэ талын харилцаа маш дутмаг байгаагаас энэ төрлийн маргаан эрүү, иргэний журмаар шийдэгдэж байна.

Санал

1. Сэдвийн хүрээнд хөндөгдөн буй харилцааг даатгалын эрх зүйгээр зохицуулдаг "сайн туршлага"-ыг нэвтрүүлэх нь хамгийн оновчтой гэж судалгааны баг үзсэн болно. Ингэхдээ тухайн эмч мэргэжилтнийг ажлын байраар хангаж буй байгууллагын үүрэг байхаар тусгах нь зохимжтой. Үүнийг "Эрүүл мэндийн тухай" хуулийн 15 дугаар зүйлд тусгах байдлаар зохицуулалт хийх боломжтой. Хэрэв тухайн эмч давхар ажил эрхэлдэг бол хөдөлмөр эрхэлж буй байгууллага тус бүртээ даатгалд хамруулна гэсэн үг.

2. Шүүх-шинжээчдийн бүрэлдэхүүн, ур чадвар, хэрэг маргааныг шийдвэрлэх харилцаан дахь тэдгээрийн оролцоог илүү нарийвчлан зохицуулах нь чухал юм. Учир нь энэ төрлийн маргааныг шийдвэрлэхдээ гэм буруутай этгээдийн гэм бурууг нотлох нь туйлын чухал байдаг. Иргэний журмаар шүүхээр шийдвэрлэгдсэн энэ төрлийн хэрэг маргаанаас харвал энэ байдлыг төдийлэн анхаардаггүй ажигдлагдлаа. Зарим тохиолдолд эмчилгээний бус менежментийн алдаанаас хохирол учрахыг үгүйсгэхгүй юм. Нөгөө талаас ашиг сонирхлын зөрчил, хараат бус байдлыг хангах үүднээс шинжээчдийн бүрэлдэхүүнийг даатгалын байгууллагын бүтцэд оруулдаг жишгийг дагах нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлж байна.

3. "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ"-нд өвчтөн нь эмчилгээний явц, үр дүнгийн талаар мэдээлэл авах эрхтэй бус, тухайн өвчтөнд үзлэг, шинжилгээ, эмчилгээ, оношлогоо хийж буй эмч мэргэжилтэн нь эмчилгээний явц, хийх эмчилгээ, сайн болон муу үр дагавар, хүндрэлийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгдөг байх үүрэгтэй байхаар тусгах нь зүйтэй. Учир нь үйлчлүүлэгч нь хүүхэд, өндөр настан зэргээс шалтгаалан ойлголт болон ухамсрын түвшин харилцан адилгүй байдагтай холбоотой юм.

4. Эмч, эмнэлгийн ажилтны ёс зүйн дүрмийг мэргэжил болон мэргэшлийн онцлогт тохируулан дагаж мөрдөх хэрэгтэй. Ёс зүйн нийтлэг хэм хэмжээ байх нь мэдээж боловч, мөн тусгайлсан хэм хэмжээ байх нь зарим талаар хэрэг маргааныг урьдчилсан байдлаар шийдвэрлэхэд ач холбогдолтой.

№	Хууль	Хариуцлага	Хариуцлага ногдуулах субъект
1.	**Эрүүл мэндийн тухай хууль 1998 оны 5 сарын 7-ны өдөр батлагдаж, 2000 онд 2 удаа, 2001 онд 1 удаа, 2003 онд 3 удаа, 2006 онд 2 удаа, 2007 онд 3 удаа, 2008 он 1 удаа, 2009 онд 1 удаа. Нийт батлагдсан үеэсээ хойш 13 удаа нэмэлт, өөрчлөлт орсон.**	**51 дүгээр зүйл. Эрүүл мэндийн тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага** 51.1.Эрүүл мэндийн тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдийн дараахь үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн шинжгүй бол түүнд дор дурдсан захиргааны шийтгэлийг хууль тогтоомжоор тусгайлан эрх олгогдсон улсын байцаагч, шүүгч ногдуулна: 51.1.1. энэ хуулийн 22 дугаар зүйлийг зөрчсөн бол 40000-50000 төгрөгөөр торгох; 51.1.2. энэ хуулийн 26.1.1, 26.1.2, 26.1.5-ыг зөрчсөн бол 10000-20000 төгрөгөөр торгох; 51.1.3. энэ хуулийн 26.1.3-ыг зөрчсөн бол 20000-50000 төгрөгөөр торгох; 51.1.4. энэ хуулийн 31.1, 32.1-ийг зөрчсөн иргэнийг 20000-30000, албан тушаалтныг 30000-40000, аж ахуйн нэгж, байгууллагыг 150000-250000 төгрөгөөр торгох; */Энэ заалтад 2002 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/* 51.1.5. энэ хуулийн 33.1-ийг зөрчсөн бол иргэнийг 20000-30000, тухайн байгууллагыг 100000-150000 төгрөгөөр торгох; */Энэ заалтад 2002 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар нэмэлт орсон/* 51.1.6. энэ хуулийн 34.2-ыг зөрчсөн бол 10000-50000 төгрөгөөр торгох; 51.1.7. энэ хуулийн 36.1, 44, 44[1]-ийг зөрчсөн бол хууль бусаар олсон орлого, бусад эд зүйлийг хурааж, зөрчил гаргасан иргэн, албан тушаалтныг 40000-50000, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-250000 төгрөгөөр торгох; /Энэ заалтад 2006 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар нэмэлт орсон/ 51.1.8. энэ хуулийн 37.1-ийг зөрчсөн бол 40000-50000 төгрөгөөр торгох; 51.1.9. энэ хуулийн 42.1, 42.2-ыг зөрчсөн албан тушаалтныг 20000-50000 төгрөгөөр торгох;	Тусгайлсан эрх олгосон улсын байцаагч, шүүгч ногдуулдаг.

2.	**Төрийн хяналт шалгалтынтухайхууль 2003 онд батлагдсан. 2006 онд 1 удаа нэмэлт өөрчлөлт орсон.**	**16 дугаар зүйл. Төрийн хяналт шалгалтын тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага** 16.1. Төрийн хяналт шалгалтын тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд улсын ерөнхий, ахлах болон улсын байцаагч дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна: 16.1.1. хяналт шалгалтаас зайлсхийсэн албан тушаалтныг 5000-20000 хүртэл төгрөгөөр торгох; 16.1.2.хяналт шалгалтын байгууллага, улсын байцаагчийн албан шаардлагыг эсэргүүцсэн, тогтоосон хугацаанд биелүүлээгүй, шаардлагын биелэлтийг гаргаж ирүүлээгүй албан тушаалтныг 5000-50000 хүртэл төгрөгөөр торгох; 16.1.3.хянан шалгах үйл ажиллагаанд саад учруулсан, гаргах дүгнэлт, шийдвэрт нөлөөлөхийг оролдсон этгээдийг60000хүртэлтөгрөгөөрторгох; 16.1.4.хяналт шалгалтад холбогдолтой баримт бичгийг гаргаж өгөхөөс үндэслэлгүйгээр татгалзсан, гэмтээсэн, устгасан, хуурамч баримт бичиг гаргаж өгсөн албан тушаалтныг 30000-60000 төгрөгөөр торгох; 16.1.5. шаардлагатай гэж үзсэн баримт бичгийг танилцуулах, түр хугацаагаар хүлээлгэн өгөхөөс зайлсхийсэн албан тушаалтныг 30000 хүртэл төгрөгөөр торгох.	Улсын ерөнхий, ахлах болон улсын байцаагч захиргааны шийтгэл ногдуулдаг.
3.	**Эрүүгийн хууль 2002 онд батлагдсан. 2004 онд 1 удаа, 2007 онд 1 удаа, 2008 онд 2 удаа тус тус нэмэлт өөрчлөлт орсон байна.**	**101 дүгээр зүйл. Хүний цус, эд, эрхтэнг хууль бусаар авах** 101.1.Хүний цус, эд, эрхтэнг хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж авсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр **дөрвөн жил** хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 101.2.Энэ хэргийг хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй байгааг мэдсээр байж, эсхүл эд хөренгө, албан тушаалын болон өөр байдлаар эрхшээлдээ байгаа хүний хувьд үйлдсэн бол **тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурваас таван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр таваас дээш арван жил** хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	Шүүгч
		102 дугаар зүйл. Хүний цус, эд, эрхтэнг шаардлага хангаагүй нөхцөлд бэлтгэх, шилжүүлэн суулгах	

		102.1.Эмч, эмнэлгийн ажилтан хүний цус, эд, эрхтэнг шаардлага хангаагүй нөхцөлд бэлтгэсэн, шилжүүлэн суулгасны улмаас хүн өвчилсөн, тахир дутуу болсон, хүний амь нас хохирсон бол **тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаархасахбуюухасахгүйгээр таван жил** хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	
		104 дүгээр зүйл. Дархлалын олдмол хомсдолын өвчнийг эмчлэхгүй орхих 104.1.Эмч дархлалын олдмол хомсдол өвчин, түүний халдварыг илрүүлсэн, оношилсон тухайгаа эрүүл мэндийн байгууллагад мэдэгдээгүй, өвчтөн болон түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчид холбогдох зааварчилгаа өгөөгүйгээс бусдад хүнд хор уршиг учирсан бол **хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучаас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл** хугацаагаар баривчлах ял шийтгэнэ. */Энэ хэсэгт 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/* 104.2.Дархлалын олдмол хомсдол өвчнөөр өвчилсөн хүнд эмнэлгийн зайлшгүй тусламж үзүүлэхээс татгалзсан, энэ өвчнөөр өвчилсөн үндэслэлээр эрхийг нь хязгаарласны улмаас тухайн өвчтөнд хохирол учирсан бол **хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.** */Энэ хэсэгт 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/.*	
		105 дугаар зүйл.Дархлалын олдмол хомсдолын өвчин халдаах 105.1.Эмнэлэг, эм хангамжийн болон бусад байгууллагын ажилтан дархлалын олдмол хомсдолын өвчний нян илрүүлэх шинжилгээ хийлгээгүй цус, цусан бүтээгдэхүүн, эд, эрхтэнийг борлуулсаны улмаас тухайн өвчний халдвар бусдад халдаасан бол **хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин**	

		нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 105.2.Эмч, эмнэлгийн ажилтан үүрэгт ажилдаа хайнга хандсаны улмаас дархлалын олдмол хомсдолын өвчний халдвар бусдад халдаасан бол **дөрвөн жил хүртэл** хугацаагаар хорих ял шийтгэнэ. 105.3.Өөрийн биед дархлалын олдмол хомсдолын өвчин байгааг мэдсээр байж хурьцал үйлдэх буюу өөр замаар бусдад халдаасан бол **таван жил хүртэл хугацаагаар хорих ял** шийтгэнэ.	
		106 дугаар зүйл. Өвчтөнд тусламж үзүүлэхгүй байх 106.1.Эмч, эмнэлгийн ажилтан өвчтөнд эмнэлгийн тусламж үзүүлэх үүргээ хүндэтгэх шалтгаангүйгээр биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйгээс өвчтөний бие махбодид хүндэвтэр гэмтэл учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг **хоёр жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс дал дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял** шийтгэнэ. 106.2.Энэ хэргийн улмаас өвчтөн нас барсан буюу түүний бие махбодид хүнд гэмтэл учирсан **бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасч гурван жил** хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	
		128 дугаар зүйл. Эмнэлэгийн бус нөхцөлд үр хөндөх 128.1.Эмч эмнэлгийн бус нөхцөлд, түүнчлэн мэргэжлийн бус хүн үр хөндсөн бол **хоёр зуун тавин нэгээс дөрвөн зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёроос таван жил** хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	
		128.2.Энэ хуулийн 128.1-д заасан хэргийг давтан үйлдсэн, эсхүл хохирогч нас барсан, бусад хүнд хор уршиг учирсан бол **тодорхой албан**	

		тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасч таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. */Энэ хэсэгт 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар нэмэлт орсон/*	
		197 дугаар зүйл. Хууль бусаар эмчлэх 197.1.Эмчийн мэргэжлийн бус этгээд эмчилгээ эрхэлсний улмаас хүний бие махбодид хүндэвтэр, хүнд гэмтэл учирсан бол **хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял** шийтгэнэ. */Энэ хэсэгт 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/* 197.2.Энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол **хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял** шийтгэнэ.	
		198 дугаар зүйл. Хууль бусаар эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдэрлэх, импортлох, хадгалах, худалдах, түгээх 198.1.Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд эмчилгээнд хэрэглэхийг хориглосон, хугацаа дуусан эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэсэн, импортолсон, хадгалсан, худалдсан, түгээсэн бол **хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял** шийтгэнэ. 198.2.Зохих зөвшөөрөлгүй этгээд хууль бусаар эм үйлдвэрлэх, импортлох, худалдах, түгээх үйл ажиллагаа явуулсан бол **хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял** шийтгэнэ.	

		198.3.Энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол **таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ**	
4.	**Иргэний хууль 2002 онд батлагдсан. 2005 онд 1 удаа, 2009 онд 2 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан.**	**228 дугаар зүйл. Хохиролыг арилгуулах эрх** 228.1.Хохиролыг арилгах үүрэг бүхий этгээд нөгөө талын зөрчигдсөн эрхийг хохирол учруулахаас өмнөх байдалд сэргээх үүрэгтэй. Зөрчигдсөн эрхийг сэргээх боломжгүй, эсхүл харьцангуй их зардал гарахаар бол **хохиролыг мөнгөөр нөхөн төлж болно.** 228.3.Эрүүл мэндийг хохироосноос хохирогч хөдөлмөрийн чадвараа алдсан буюу хөдөлмөрийн чадвар нь буурсан, эсхүл хэрэглээ зардал нь нэмэгдсэн бол хохиролыг арилгах үүрэг бүхий этгээд хохирогчид сар тутам мөнгө /тэжээн тэтгэхтэй холбогдсон тэтгэлэг/ төлөх замаар хохиролыг арилгах үүрэгтэй. 228.4.Хохирогч эмчилгээний зайлшгүй зардлыг урьдчилан төлүүлэхээр хохиролыг арилгах үүрэг бүхий этгээдээс шаардах эрхтэй. 228.5.Хохирогч мэргэжлийн хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд дахин мэргэжил эзэмших зайлшгүй шаардлагатай бол үүнтэй холбогдсон зардлыг нөхөн төлөхөд энэ журам нэгэн адил хамаарна. 228.6.Хүндэтгэн үзэх шалтгаан байвал хохирогч энэ хуулийн 228.3-т заасан сар тутмын мөнгөн төлбөрийн оронд нэг удаагийн нөхөн төлбөр авахаар шаардаж болно.	
		229 дүгээр зүйл. Хохиролыг арилгах хэмжээ 229.1.Үүрэг бүхий этгээд нь хохиролыг арилгахдаа зд хөрөнгөд учруулсан бодит хохирол болон олох ёстой байсан орлогыг нөхөн төлөх үүрэгтэй.	

		230 дугаар зүйл. Эдийн бус хохиролыг арилгах 230.1.Эдийн бус хохиролыг арилгуулахаар хохирогч шаардах эрхтэй. 230.2.Гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус хохиролыг мөнгөөр нөхөн төлнө. 230.3.Хохирол учрах буюу түүнээс урьдчилан сэргийлэх, учирсан хохиролоос үүдэн гарах хохирлын хэмжээ нэмэгдэхэд хохирогчийн буюу эрх бүхий этгээдийн үйлдэл /эс үйлдэхүй/ нөлөөлсөн бол хохиролыг арилгах үүрэг болон түүний хэмжээг тодорхойлохдоо тэдгээрийн гэм буруугийн хэмжээг харгалзана.	
		497 дугаар зүйл. Хохирол учруулснаас хариуцлага хүлээх үндэслэл 497.1.Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэхүй/-ээр хохирол учруулсан этгээд уг хохиролыг хариуцан арилгах үүрэгтэй. 497.3.Хохирол учруулахад хэд хэдэн этгээд оролцсон бол тэдгээр нь уг хохиролыг хамтран хариуцах бөгөөд энэ тохиолдолд шууд хохирол учруулсан этгээд тедийгүй, түүнийг уруу татсан, дэмжин тусалсан, түүнчлэн хохирол учруулсны үр дүнг санаатай ашигласан этгээд нэгэн адил хариуцлага хүлээнэ.	
		498 дугаар зүйл. Байгууллага, албан тушаалтан бусдад хохирол учруулсны хариуцлага 498.1.Ажиллагсад хөдөлмөрийн гэрээ буюу албан тушаалын дагуу хүлээсэн үүргээ гүйцэтгэх явцад гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ээрээ бусдад учруулсан хохиролын хариуцлагыг түүнийг ажиллуулж байгаа ажил олгогч хүлээнэ. 498.2.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч албан үүргээ зөрчсөн гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ийн улмаас бусдад хохирол учруулсан бол уг хохиролыг түүний ажиллаж байгаа хуулийн этгээд буюу төр хариуцан арилгана.	

		505 дугаар зүйл. Бусдын эрүүл мэндэд учирсан хохиролыг арилгах 505.1.Бусдын эрүүл мэндэд хохирол учруулсан этгээд нь хохирогчийн хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, ийнхүү эрүүл мэндэд хохирол учруулсантай холбогдон гарсан асарч сувилах, нэмэгдэл хоол өгөх, хиймэл эрхтэн хийлгэх, сувиллын газар сувилуулах зэрэг зайлшгүй бүх зардлыг хохирогчид төлөх үүрэгтэй. 505.2.Хохирол учруулах үед хохирогч цалин хөлс, орлогогүй байсан бол тэрээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй хэмжээний нөхөн төлбөр шаардах эрхтэй.	
5.	**Шүүхийн шинжилгээний хууль тухай хууль 2009 оны 12 сард батлагдсан.**	**45 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага** 45.1.Шүүхийн шинжилгээний тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн, захиргааны болон сахилгын хариуцлага хүлээлгэнэ. 45.2.Шүүхийн шинжилгээний тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй бол шүүгч зөрчлийн шинж байдлыг харгалзан дараахь хариуцлага хүлээлгэнэ: 45.2.1.энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасныг зөрчсөн албан тушаалтныг 50000-150000 төгрөгөөр торгох; 45.2.2.энэ хуулийн 20.2, 28-32 дугаар зүйл, 34 дүгээр зүйлд заасныг зөрчсөн албан тушаалтныг 50000-150000 төгрөгөөр, байгууллагыг 100000-500000 төгрөгөөр тус тус торгох; 45.2.3.энэ хуулийн 35 дугаар зүйлд заасныг зөрчсөн шинжээчийг 50000-150000 төгрөгөөр торгох; 45.2.4.энэ хуулийн 43.4-т заасныг зөрчсөн иргэнийг 5000-50000, албан тушаалтныг 50000-150000 төгрөгөөр тус тус торгох; 45.2.5.энэ хуулийн 43.5-д заасныг зөрчсөн албан тушаалтныг 50000-150000 төгрөгөөр, байгууллагыг 100000-500000 төгрөгөөр тус тус торгох; 45.2.6.шинжилгээний объектыг шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүйгээр устгасан шинжээчийг 50000-150000 төгрөгөөр торгох	

__oOo__

"ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ"[405]

ОРШИЛ

Энэхүү судалгааны зорилго нь хэвлэл мэдээллийн эрх чөлөөний эрх зүйн орчны төлөв байдлыг судлан түүнд тулгамдсан асуудлыг олж тогтоон, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хууль тогтоомжид оруулах шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийн саналыг боловсруулахад оршино.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний харилцааг зохицуулж буй хэм хэмжээний уялдаа холбоо, давхардал хийдлийг судлан тогтоох зорилтын хүрээнд хүчин төгөлдөр үйлчилж байгаа 410 хуулиас "хэвлэл мэдээллийн эрх чөлөө" болон "хэвлэл мэдээлэлтэй" холбогдох зүйл, заалтыг түүж анализ хийсэн. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой 5 хууль, Хэвлэл, мэдээлэлтэй холбоотой 66 хууль байна. Хуулийн давхардал, хийдлийг судлах гэсэн боловч уг хууль нь 4 зүйлтэй ерөнхий хууль учраас бусад хуулиудтай харшлах зүйлүүд цөөн байлаа. Гэсэн хэдий ч судалгааны явцад 4 хуулийн зөрчил байгааг олж тогтоон өөрсдийн саналаа оруулаа.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангаж байгаа байдал болон практик үр нөлөөг судлах, хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой хэрэг маргааныг шүүхээр шийдвэрлэж байгаа байдалд дүн шинжилгээ хийх зорилгоор Улсын Дээд шүүхийн судалгааны төвөөс холбогдох материалыг авч судалгаа хийсний зэрэгцээ секторын ажилтнууд Нийслэлийн шүүхийн Иргэний хэргийн архивиас 2006-2009 онд шүүхээр шийдвэрлэгдсэн 31465 иргэний хэрэгтэй танилцаж судалгаанд холбогдох 87 шүүхийн шийдвэрийг хувилан авч баримт бичгийн аргаар судлав.

Хамрах хүрээ: Хэвлэл мэдээллийн эрх чөлөө болон хэвлэл мэдээлэлтэй холбоотой үндэсний хууль тогтоомж, 2006-2009 онд Иргэний хуулийн 21, 27, Эрүүгийн хуулийн 110, 111 дүгээр зүйлээр шүүхээр шийдвэрлэгдсэн хэргүүд болон онолын ном зохиолын хүрээнд судалгааг хийлээ.

Хэрэгцээ шаардлага:

Монгол Улсад хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм хөгжсөнөөр хүн бүр үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх болсон билээ. Энэхүү эрх чөлөөний хууль зүйн баталгаа нь 1998 онд батлагдсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль юм. Уг хууль нь "хүний үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулсан, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангасан суурь зохицуулалт юм. Гэсэн хэдий ч нийгмийн хөгжил, мэдээллийн технологийн хөгжлийн хурдыг даган хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо, төрөл жил ирэх

[405] Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 69 дүгээр тогтоол болон Монгол Улсын Их Хурлын 2003 оны 41 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас "Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2009-2010 оны төлөвлөгөө"-ний дагуу эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, зохион байгуулалтын арга хэмжээ авах зорилт дэвшүүлж, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн ЗХЭЗС, ИЭЗЭЗС хамтран "Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний эрх зүйн орчны өнөөгийн төлөв байдал, тулгамдсан асуудал" сэдэвт судалгаг хийсэн болно.

тусам нэмэгдэж байгаа нь тухайн хуулиар уг харилцааг бүрэн зохицуулах боломжгүй байгааг харуулж байна. Жишээ нь: Нийслэлийн нэг хүнд дунджаар 1.5 ширхэг үүрэн телефон ногдож, 3 хүн тутмын 1 нь өдөрт дунджаар нэг цаг радио сонсож, 3 өрх тутмын 1 нь кабелийн телевизийн 50 гаруй сувгаар 3 цагийн турш нэвтрүүлэг үзэж, 5 өрх тутмын нэг нь гэртээ компьютертай бөгөөд компьютертай 5 өрх бүрийн 2 нь өдөр бүр интернет ашигладаг[406] хэдий ч уг харилцаанд оролцогчдын эрх, үүрэг, хэрэглэгчийн эрх ашиг, сэтгүүлч болон иргэдийн үнэн зөв мэдээлэл авах эрх, хэвлэл мэдээллийн хэрэгслийн ажилтнуудын зөрчигдсөн эрхийг хамгаалах гэх мэт нарийн харилцааг нийгмийн хөгжилд нийцүүлэн өөрчлөх хэрэгцээ шаардлага бий болсон нь уг судалгааны ажлын үр нөлөөг ихэсгэж байгаа юм.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөө нь ардчилсан нийгмийн салшгүй хэсэг төдийгүй, улс төрч болон эрх баригчдаас эсхүл төрөөс ард түмэндээ өгч буй боломж бус хүний заяамал, хүн болж төрсний хувьд зайлшгүй эдлэх ёстой эрх. Ийм учраас төр иргэнийхээ эрхийг эдлүүлэхийн тулд улс төр, эдийн засаг, эрх зүйн таатай орчин бий болгох үүрэгтэй байдаг. Өөрөөр хэлбэл: Сэтгүүлч болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь олон нийтийн санаа бодлыг засаг төрд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүргэх, уг үйлдлийнхээ төлөө ямар нэг байдлаар дарамт шахалтад өртдөггүй байх эрх зүйн орчныг бүрдүүлж байж хэвлэл мэдээллийн эрх чөлөө хэрэгжинэ. Мөн сэтгүүлчид болон хэвлэл мэдээллийн байгууллага нь бизнесмен, албан тушаалтан, улс төрөөс ангид байх учиртай. Ингэснээрээ иргэдийн үнэн зөв мэдээлэл авах эрх хэрэгжиж, хэвлэл мэдээллийн эрх чөлөө бүрэн утгаараа хөгжинө.

Судлагдсан байдал: 1998 онд Философи, Социологи эрх зүйн хүрээлэнгээс "Чөлөөт хэвлэл мэдээлэл өнөөдөр" санал асуулга, 2004, 2009 онд Хэвлэлийн хүрээлэнгээс "Монголын Хэвлэл Мэдээллийн байдлын талаарх олон нийтийн үнэлэмж", "Глоб интернэшнл" ТББ-аас 2001 онд "Хэвлэл мэдээлэлтэй холбоотой Монгол Улсын хууль" түүвэр /Глоб интернэшнл ТББ нь энэ талаар дагнаж ажилладаг ба сүүлийн 10 гаруй жил тасралтгүй судалгаа шинжилгээний ажил хийж байгаа учир энэ байгууллагаас гарсан ном бүхэнд хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай байдаг/ гэх мэтээр судалгаа хийсэн байна. Энэхүү судалгаа нь Монгол Улс дахь хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хууль эрх зүйн орчин, тэдгээрийн давхардал, хийдэл, зөрчлийг судалж тэдгээрт ямар нэг ашиг сонирхолгүй хөндлөнгийн байр сууринаас судалгаанд тулгуурласан онолын дүгнэлт өгөх зорилготой.

Нэг. Хэвлэл мэдээллийн эрх чөлөө хүний үндсэн эрх болох нь

1.1. Үндсэн эрхийн тухай ойлголт, түүнд тавигдах шаардлага:

Үндсэн хууль, Хүний эрхийн билл буюу олон улсын тулгуур баримт бичгээр тодорхойлогдсон эрхүүдийг үндсэн эрх гэх бөгөөд уг эрх нь зайлшгүй Үндсэн хуулиар хуульчлагдсан байх ёстой[407]. Энэ эрх нь хувь хүнийг төр засгийн хууль бус үйл ажиллагаанаас хамгаалах шинжтэй бөгөөд хүн төрөлхтний сэтгэлгээний хүрсэн түвшин, оршин буй нийгмийн эрхэмлэлээс

[406] Үндэсний статистикийн хорооны тоо баримтаас авав.

[407] Үндсэн хуулийн эрх зүй. УБ., 2007он, гарын авлага.

шалтгаалан үндсэн эрх гэдгийг янз бүрийн цаг хугацаанд харилцан адилгүй утгаар тодорхойлж ирсэн.

Жишээлбэл: зарим судлаачид энэ эрхийн үзэл баримтлалын гол агуулга нь өөрөө өөрийгөө мэдэхүй[408] юм гэсэн байхад, зарим нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө[409] гэж үздэг байна[410].

Үндсэн эрхэд тавигдах формал шаардлага:

Жам ёсны эрх нь эрх зүйн үндсэн хэм хэмжээ хийгээд зарчмуудад тусгалаа олж байж Үндсэн хуулиар хамгаалагдсан, төрийн эрх мэдлийг хязгаарлах хүчин чадалтай шууд үйлчлэх эрх зүй болж чадна. Хүний үндсэн эрхийг:

- Хувийн эрх, эрх чөлөө
- Эдийн засаг нийгэм соёлын эрх, эрх чөлөө
- Улс төрийн эрх, эрх чөлөө гэж ангилна.[411]

Үндсэн эрх нь Үндсэн хуулийн бүрдэл хэсэг төдийгүй Үндсэн хуульт ёсны давуу хүчин чадалтай байх зарчим болдог.

Үндсэн эрхийг хязгаарлах үндэслэлүүд:

- Зөвхөн хуулийн үндсэн дээр хязгаарлах
- Үндсэн хуулийн өөр заалтад захируулах замаар
- Харьцангуй байх зарчмыг баримтлах
- Үндсэн хуулийг өөрчилж үл болох хэсгийг хөндөхгүй байх
- Эрх зүйт ёсны үндсэн зарчмыг зөрчихгүй байх[412]

Хүний эрх гэдэг нь төрөлхөөс заяасан бөгөөд хамгийн эгэл утгаараа хүнд өөрт нь байдаг, нийгмийн дотор заавал эдлэх боломж юм. Өөрийн бодол санаанд итгэж, итгэл үнэмшилээ болгосон тэр зүйлээ шүтэн биширч, оюун санааны болон үнэ цэнэтэй маргаанд оролцож, тэдгээр үзэл санааг дүгнэн цэгнэж, өнгөрснийг ойлгож, одоод амьдарч, ирээдүйгээ төсөөлөх чадварыг эрх чөлөө" хэмээн тодорхойлдог.[413]

Эрх чөлөө гэж хүний эдлэх ёстой бөгөөд хүнээс салгаж үл болох боломжийг хэлж байгаа учраас энэ нь хүний салшгүй эрх болж илэрдэг байна. Эрх чөлөөг эртний сэтгэгчид ямар нэг бурхан шашинаас өөрт олгогдоогүй хүнд өөрт нь байдаг зүйл гэж үздэг байсан бол боолын нийгэм, хаант засгийн үед боол болон зарц хүнд ямар ч эрх, эрх чөлөө байх ёсгүй гэж үзэх үзэл амь бөхтэй оршиж байсан.

Эрх чөлөө гэдгийг хүнээс хэзээ ч салгаж болдоггүй бөгөөд эрх чөлөө нь эрх болж илрэн гардаг бол эрхийг эдлэх боломж нь хүнд өөрт нь байдаг боловч тодорхой тохиолдолд түүнийг хязгаарлаж болдог. Энэ шинжээрээ

[408] Дэвид Боаз. Либертарианизм. УБ., 2005 он. 91 дэх тал. Ч.Өнөрбаяр, М.Батсуурь "Эрх зүйт ёс" номноос дам ишлэв.

[409] Ц.Сарантуяа. Үндсэн эрх болон Хүний эрх: харьцуулалт, онолын эргэцүүлэл. Эрх зүй сэтгүүл. УБ., 2000 он. №1. 19 дэх тал.

[410] Ч.Өнөрбаяр, М.Батсуурь. "Эрх зүйт ёс". УБ., 2010 он. 48 дахь тал.

[411] Мөн тэнд. 51 дэх тал.

[412] Ёорг Паул Мюллер. Хүний эрх ба улс орны дотоод, гадаад аюулгүй байдлын асуудлууд. Хүний эрх ба үндэсний аюулгүй байдал. Олон улсын симпозиумын эмхтгэл. УБ., 1996. 76 дахь тал.

[413] В.Удвал. Үндсэн хуульт ёс ба үндсэн хуулийн зарчмууд. Шихихутуг. УБ., 2003 он. №8. 9 дэх тал.

эрх, эрх чөлөө хоёр нь хоорондоо ялгаатай гэж дүгнэж болох юм. Жишээ нь: Хүн амьд явах эрхтэй боловч Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ буюу цаазаар авах ялыг оногдуулж түүний амьд явах эрхийг хязгаарлаж болно[414].

1.2. Хэвлэл мэдээллийн эрх чөлөө үндсэн эрх болох нь:

Хэвлэл мэдээлийн эрх чөлөөг үндсэн эрх гэдгийг батлах гол шалгуур нь:

1.Олон улсын тулгуур баримт бичигт тодорхойлогдсон байх;

2. Үндсэн хуулиар баталгаажсан байх ёстой.

Хэвлэл мэдээлийн эрх чөлөөг үндсэн эрх мөн эсэхийг судалж үзвэл:

Түүхэнд анх удаа 1789 оны Францын Хүний ба Иргэний эрхийн тунхаглалын 11 дүгээр зүйлд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх үндсэн эрхийг тунхагласан байна. Зарим эх сурвалжид хүний эрх, эрх чөлөөг Францын хувьсгалаас хүн төрөлхтөнд өргөн барьсан бэлэг гэж тэмдэглэсэн байдаг. 1789 оны Хүний ба Иргэний эрхийн тунхаглалын 11 дүгээр заалт нь Францын /1958/ Үндсэн хуулийн оршилын нэг хэсгийг бүрдүүлдэг ба үүнд "Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх нь хүний хамгийн үнэт эрх чөлөө юм. Иймээс хүн бүр чөлөөтэй ярих, бичих, хэвлэх эрхтэй бөгөөд чингэхдээ энэхүү эрх чөлөөгөө буруугаар ашигласан бол тус хуульд заасан тохиолдлуудад хариуцлага хүлээх болно" гэж заажээ[415].

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйлд: "Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэхүү эрхэд үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрх чөлөө, үзэл санаа, мэдээллийг улсын хилээр үл хязгаарлан аливаа арга замаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана" хэмээн баталгаажуулсан.

Монгол Улс 1961 онд НҮБ-ын гишvvн болсноор Хvний Эрхийн Тvгээмэл Тунхаглалийг хvлээн зөвшөөрч, 1974 онд Иргэний болон Улс Төрийн Эрхийн Олон Улсын Пактад нэгдэн орсон. Иймд Монгол Улс дээрх хоёр баримт бичгийн 19 дүгээр зүйлд заасан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг олон улсын эрх зүйн дагуу хангах үүрэгтэй. Иргэний ба улс төрийн эрхийн тухай Олон улсын пактын 19 дүгээр зүйлд:

1. Хүн бүр үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрхтэй.

2. Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэ эрхэд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан эрхийг эдлэх нь онцгой үүрэг, хариуцлага оногдуулна. Тийм учраас түүнийг зарим талаар хязгаарлаж болох боловч тэр нь заавал хуулиар тогтоогдсон байх ёстой. Энэ нь:

a/ бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх;

b/ үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл

[414] 1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

[415] Д.Оросоо "Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх" Хууль дэдлэх ёс сэтгүүл 2005 он, №3. 11дэх тал

мэнд, ёс суртахууныг хамгаалах шаардлагад үндэслэгдэнэ.

1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд "Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна. Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ гэж заасан нь Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний ба олон улсын Пакт болон бусад нэгдэн орж соёрхон баталсан олон улсын гэрээг манай улс зайлшгүй хэрэгжүүлэх үүргийг бий болгоно.

1924 оны Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт "элдэв хэргийг жинхэнэ ард түмнээр шүүмжлэх эрхийг хүндэтгэж, тус улсаас аливаа хэвлэх, нийтлэх явдлыг бүртгэн гүйцэтгэвэл зохино", 1940 оны Үндсэн хуулийн 85 дугаар зүйлд "Хөдөлмөрчин ард түмний ашиг тусад нийцүүлэн мөн Бүгд Найрамдах Монгол Ард Улсын улсын байгуулалтыг бататган бэхжүүлэхийн төлөө, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын ард иргэдэд хуулиар батлан олгох эрх нь: "Чөлөөтэйгээр үг хэлэх, чөлөөтэйгээр хэвлэн нийтлэх, хурал ба индрийн хурлыг чөлөөтэйгээр явуулах, гудамжаар жагсах, явах" нь тус тус чөлөөтэй" гэж заасан бол 1960 оны Үндсэн хуулийн 87 дугаар зүйлд "БНМАУ-ын төрийн байгууллыг хөгжүүлэн бэхжүүлэх зорилгоор хөдөлмөрчдийн эрх ашигт нийцүүлэн БНМАУ-ын иргэдэд: "Үг хэлэх, хэвлэн нийтлэх, хурал цуглаан хийх, жагсаал ёслол үйлдэх эрх чөлөөг хуулиар батлан олгоно", 1992 оны Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16 дахь хэсэгт "Монгол Улсын иргэн: "Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөөтэй" гэж тус тус заасан байна.

Ард түмэн дундаасаа сонгосон хэсгээр төлөөлүүлэн төр барих үйл ажиллагаанд оролцох. Ийм боломжоор хангагдах хамгийн чухал нөхцөл нь хүний мэдээллийн эрх, эрх чөлөө юм. Энэ эрхийг эдлэхгүйгээр орчин нөхцөлөө зөв үнэлэх, нийгмийн амьдралд зохих ёсоор идэвхитэй оролцох, нийгмийн гишүүнийхээ үнэ цэнийг мэдэрч амьдрах ямар ч боломж байдаггүй болохоор тухайн эрх нь хүний үндсэн эрхүүдийн тоонд зүй ёсоор багтдаг юм. Үүнийг баталгаажуулж 1949 онд НҮБ-ын Ерөнхий Ассамбей хамгийн анхны чуулганаараа 59/1 дүгээр тогтоолыг гаргаж түүнд "мэдээллийн эрх чөлөө нь хүний үндсэн эрх мөн" хэмээн тодорхойлсон билээ[416].

1.3. Хэвлэл мэдээллийн эрх чөлөө

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16-д заасан итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй гэж заасан нь Хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд хамаарна.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөө нь сэтгүүлчдийн мэдээлэл авах, түгээх, түүний бие дааж үйл ажиллагаа явуулах эрх, нийгэмд тулгамдаж байгаа

[416] "Мэдээллийн эрх чөлөө" дугуй ширээний ярилцлага. 2003 он. Доктор Д.Зүмбэрэллхам. "Мэдээллийн эрх чөлөө хүний үндсэн эрх болох нь" илтгэлээс.

асуудлыг үнэн зөвөөр олон нийтэд хүргэх үүргийг хуульчилсан зохицуулалт юм. Монгол Улсад мэдээлэл олж авах, хүртэх эрхийг Үндсэн хуулинд заасан боловч баталгаажуулж, зохицуулсан "Мэдээллийн эрх чөлөөний" тухай хууль байдаггүй иргэд төр, засгаас мэдээлэл олж авах, хүртэх арга, хэлбэрийг тодорхой зааж зохицуулаагүй зэрэг нь иргэдийн нийгмийн идэвхгүй оролцоог бий болгож байна.

1995 оны 5 дугаар сарын 16-ны өдөр баталсан Байгууллагын нууцын тухай хуулиар байгууллагын нууц нь тухайн байгууллагын хамгаалалтад байна. Байгууллага нь нууцаа хамгаалах журмыг өөрөө тогтоож мөрдөнө гэж заасан /5.1-д/ нь байгууллагын дарга, захирал бүрт нууцлахгүй зүйлийг нууцлах боломж олгож, энэ чанараараа хэвлэл мэдээллийн ажилтан сэтгүүлчдээс мэдээлэлд нэвтрэх, олж авах, түгээх эрхийг нь үндэслэл муутай хязгаарлаж буй хэрэг[417] гэсэн дүгнэлт нь нэг талаараа үнэн боловч нөгөө талаараа сэтгүүлч хүн гэдэг бол заавал байгууллагын нууц, дотоод асуудлыг иргэдэд хүргэхдээ биш байгаа бодит мэдээлэлд тулгуурлаж, олон эх сурвалжаас анализ хийн үндэслэлтэй дүгнэлт гаргаж, нийгмийн амьдралд хэрэгтэй санал дэвшүүлэх чадвартай байх ёстой. Өөрөөр хэлбэл: энэ байгууллага бидэнд хэрэгтэй мэдээллийг өгөх ёстой гэж бэлэн мэдээ, ярилцлага шаардаж зогсохдоо биш олон эх сурвалжийг харьцуулан дүгнэсэн бүтээлч, шинжлэх ухааны үндэслэлтэй, бодитой мэдээллийг иргэдэд хүргэх ёстой юм.

Улсын Бүртгэлийн Ерөнхий газраас авсан мэдээллээр 2009 оны 12 сарын 18-ны байдлаар 105 хэвлэл мэдээллийн хэрэгсэл /2 телевиз, 56 сонин, 47 сэтгүүл/ шинээр бүртгүүлжээ. Манай орны хувьд хувийн хэвшлийн мэдээллийн хэрэгсэл давамгайлдаг бөгөөд 2009 оны байдлаар сонины 67 хувь, сэтгүүлийн 58 хувь, телевизийн 90 хувь, радиогийн 54 хувь нь хувийн өмч дээр суурилсан байв.

1998 онд батлагдсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 5.1-д төрийн байгууллага мэдээллийн хэрэгсэл эзэмшихийг хориглосон байдаг боловч өнөөг хүртэл орон нутгийн засаг захиргааны байгууллагууд өөрийн харъяаны мэдээллийн хэрэгсэлтэй байсаар байна. 2007 онд төрийн эзэмшлийн телевиз 20 хувийг эзэлж байсан бол 2008 онд 9 хувь, 2009 онд 6 хувь болж буурчээ. Харин сонины 15 хувь, сэтгүүлийн 20 хувь нь төрийн байгууллагын дэргэд хэвээр байна. 2009 онд 18 телевиз шинээр нэмэгдэж, телевизийн тоо 109 болсноос 6 нь үндэсний хэмжээний, 27 нь Улаанбаатарт, 49 нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байна. Мөн хөдөө орон нутаг болон нийслэлд нийт 27 кабелийн телевиз үйлчилгээ эрхэлж байна[418].

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо ингэж өссөн хэдий ч хэвлэл мэдээллийн хэрэгслийн ард улс төрийн тодорхой нэг нам, хэсэг бүлэг хүмүүс, улс төрчид, томоохон бизнесмэнүүд байдаг бөгөөд сонин, хэвлэл, телевизүүд тэдний удирдамж, зааварчилгаагаар үйл ажиллагаа явуулж, үзэл бодолд нь тааруулж нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэж, захиалгаар бусдын нэр хүндийг гутаах, өөрсдийгөө сурталчлах "зэвсэг" болж хувирснаас

[417] Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө "сэтгүүлч ба хууль цуврал" №3. Уб., 2001 он. 17 дахь тал.

[418] Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр. Хэвлэлийн хүрээлэн. УБ., 2010 он. 6 дахь тал.

мэдээллийн тэнцвэрт байдал алдагдаж, сонины зай талбай, эфирийн үнэт цаг өш хонзон авах, тооцоо бодох, улс төрийн болон эдийн засгийн ашиг хонжоо хайх талбар болж байна[419] гэж үзжээ.

Энэ нь зөв боловч хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь монополчлолд орж, үндэсний аюулгүй байдалд нөлөөлөхүйц байдлыг нийгэмд буй болгож, иргэдийг төөрөгдүүлж байгаа тохиолдолд ноцтой асуудал болох бөгөөд одоогийн манай нийгэмд байгаа эдгээр үзэгдэл нь зах зээлийн жамаараа хөгжиж байгаа хэвлэл мэдээллийн байгууллагад байдаг хөгжлийн нэг үе ч байж болох юм, харин олон хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр гарч байгаа мэдээ, мэдээлэл нэвтрүүлэгт хэрхэн итгэх, яаж үнэлэх нь иргэдийн ухамсрын асуудал юм. Мөн нөгөө талаар хувийн хэвшлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл захиалгаар худал мэдээлэл цацдаг төрийн өмчийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл үнэн мэдээлэл цацдаг гэж үнэлэх нь учир дутагдалтай юм. Учир нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулж байгаа мэдээллийн үнэн зөвийг үнэлэх асуудал нь боломжгүй хийсвэр зүйл юм.

Тэгвэл олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд итгэх иргэдийн итгэл ямар байгааг 2009 онд Хэвлэлийн хүрээлэнгээс явуулсан судалгааны дүнгээс харвал:.

Хэвлэл мэдээллийн талаарх олон нийтийн итгэл үнэмшил[420]

Хүснэгт 1

Та хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хэр итгэдэг вэ?	1998	2004	2009
Бүрэн итгэдэг	6.0%	19.5%	9.4%
Зарим үед эргэлздэг	70.4%	64.0%	71.0%
Итгэдэггүй	16.4%	6.5%	7.7%
Хэлж мэдэхгүй	7.2%	10%	11.9%

1998 онд Философи, социологи, эрхийн хүрээлэнгээс хэрэгжүүлсэн "Чөлөөт хэвлэл мэдээлэл өнөөдөр" санал асуулга, 2004 онд Хэвлэлийн хүрээлэнгээс "Монголын Хэвлэл Мэдээллийн байдлын талаарх олон нийтийн үнэлэмж" судалгаагаар иргэд, хэвлэл мэдээлэл хэрэглэгчид мэдээллийн хэрэгсэлд хэр итгэлтэй байдгийг судалсан байдаг. 5 жилийн дараа буюу 2009 онд иргэдийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд итгэх итгэл хэр алдарсан, эсхүл хэр нэмэгдсэнийг тодруулахад хэвлэл мэдээллийн хэрэгсэлд бүрэн итгэлтэй байдаг иргэд 10 хувиар буурч заримдаа эргэлзэж, заримдаа итгэдэг иргэд 71 хувиар өссөн нь иргэдийн мэдээллийн хэрэгсэлд итгэх итгэл буурч буйг илтгэнэ.

Үүнтэй нэгэн адилаар иргэд Хэвлэл мэдээллийн эрх чөлөө гэдгийг янз бүрээр тайлбарлаж, нийгмийн тодорхой үе шат бүрд өөр өөрсдийнхөөрөө ойлгож ирсэн байна. Жишээ нь:

1998 он, 2004 он, 2008 онуудад "Хэвлэл мэдээллийн эрх чөлөө" гэдгийг иргэд дараах байдлаар тайлбарлаж байсан байна[421].

[419] М.Зулькафиль. МУИС-ийн Сэтгүүл зүйн тэнхимийн эрхлэгч. www.tsagtur.mn сайтаас авав.

[420] Монголын хэвлэл мэдээллийн байдлын талаарх олон нийтийн үнэлэмж судалгааны тайлангаас. Хэвлэлийн хүрээлэн. УБ., 2009 он.

[421] Монголын хэвлэл мэдээллийн байдлын талаарх олон нийтийн үнэлэмж судалгааны тайлангаас. Хэвлэлийн хүрээлэн. Уб. 2009 он.

Хүснэгт 2

№	1998	2004	2008
1	хэвлэл мэдээлэл санхүүгийн хувьд бие даасан байхыг хэлнэ	иргэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хэлнэ	мэдээллийн хэрэгслээр үнэн зөв, тэнцвэртэй мэдээлэл түгээхийг хэлнэ гэж хариулжээ
2	ямар ч сэдвээр чөлөөтэй ил тод бичдэг байх	сэтгүүлчдийн чөлөөтэй бичиж нийтлэх эрх чөлөө	сэтгүүлчдийн чөлөөтэй бичиж, нийтлэх эрх чөлөөг хэлнэ
3	төр засгийг шүүмжилдэг байхыг хэлнэ[1]	гадны ямар нэг дарамт нөлөөгүй байхыг хэлнэ	нам, төр засаг, эрх мэдэлтнээс хэвлэл мэдээллийн хэрэгсэл хараат бус байхыг хэлнэ

Дүгнэлт: Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, мэдээллийн эрх чөлөө нь хоорондоо ялгаатай ойлголт боловч иргэдийн мэдээлэл авах, эрх ашгаа хамгаалах, нийгэмд болж буй үйл явдалд өөрийн байр сууринаас хандахад тус дөхөм болох гэх мэт шинжүүдээрээ төсөөтэй байна. Мөн цаашид Мэдээллийн эрх чөлөөний тухай тусгайлсан хууль батлах, эсхүл Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд иргэд болон сэтгүүлчдийн мэдээлэл авах эрхийг тодорхой тусгах шаардлагатай байна. Монгол Улсад хэвлэл мэдээллийн тоо жил ирэх тусам нэмэгдэж нэг талаас харахад хэвлэл мэдээлэл эрх чөлөөтэй хөгжиж байгаа мэт боловч нөгөө талаар манай зарим нэг сэтгүүлчдийн хууль эрх зүйн мэдлэг дутмаг, мэргэжлийн ур чадвар муу байгаа зэрэг нь тэдгээрийг ёс зүйгүй үйлдэл хийхэд хүргэж ингэснээрээ иргэдийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд итгэх итгэлийг бууруулж байна.

1.4.Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль болон түүнд холбогдох бусад хууль тогтоомж

Монгол Улсын Үндсэн Хуулийн 16 дугаар зүйлд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хамгаалж, дор дурдсан заалтаар баталгаажуулсан.

16.16. Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно.

16.17. Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална.

Уг хоёр заалт нь иргэдийг засаг төрийн байгууллагын үйл ажиллагаанд оролцох, хяналт тавьж, авлига, хүнд суртал чирэгдэл, бусармаг явдалтай тэмцэх баталгааны үндэс нь болдог.

1998 оны 8 дугаар сарын 28-ны өдөр УИХ-аас Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг баталсан юм. Хуулийн 2 дугаар зүйлд "хэвлэл мэдээллийн эрх чөлөө, мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглосон". Мөн 3 дугаар зүйлд "төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тавихыг хориглож, Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ" гэж заасан ба 4 дүгээр зүйлд "Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно" гэж заасан. Гэсэн хэдий ч 2009 оны байдлаар орон нутгийн засаг захиргааны байгууллагууд өөрийн харьяаны мэдээллийн хэрэгсэлтэй байсаар байна. 2007 онд төрийн эзэмшлийн телевиз 20 хувийг эзэлж байсан бол 2008 онд 9 хувь, 2009 онд 6 хувь болж буурчээ. Харин сонины 15 хувь, сэтгүүлийн 20 хувь нь төрийн байгууллагын дэргэд хэвээр байгаа[422] нь нэг талаараа төр хэвлэл мэдээллийн хэрэгслийг монопольчлохоос сэргийлж байгаа боловч нөгөө талаараа төрийн байгууллага өөрийн үйл ажиллагааг ард иргэдэд хүргэх, төрийн байгууллагын мэдээлэл нээлттэй байх гэдэг үүднээс нь харах юм бол төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг үгүйсгэх аргагүй юм. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна" гэдэгтэй нийцэж байгаа.

Глоб интернэшнл төрийн бус байгууллага 2001 онд хүчин төгөлдөр үйлчилж байсан 230 гаруй хуулиудад судалгаа хийхэд сэтгүүлч болон хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 91 хууль байсан бол 2010 онд хэвлэл мэдээллийн эрх чөлөө гэсэн илэрцээр 5 хууль, хэвлэл, мэдээлэлтэй холбоотой илэрцээр 66 хуулийн зүйл заалт илэрч байгааг судалгаагаар тогтоосон. Энэ тооны зөрүү нь бидний судалгааны хүрээтэй холбоотой юм. Глоб интернэшнл ТББ нь сэтгүүлч болон хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хуулиудад задлан шинжилгээ хийсэн бол бид "хэвлэл мэдээлийн эрх чөлөө, хэвлэл мэдээлэл" гэж хүрээгээ хязгаарласан болно.

Судалгааны үр дүнд хүчин төгөлдөр үйлчилж буй 410 гаруй хуулиас "Монгол Улсын Еренхийлөгчийн сонгуулийн тухай хууль", "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай", "Олон нийтийн радио, телевизийн тухай хууль", "Орон нутгийн хурлын сонгуулийн тухай", "Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль" гэх мэт 5 хуульд хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай заасан байна.

2001 онд хийсэн дээрх судалгааны 91 хуулиас "Монгол Улсын шүүх, прокурор, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх байгуллагын хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах журмын тухай хууль", "Монгол Улсын Иргэний эрхийг хохироосон төрийн захиргааны байгуллага, албан тушаалтны хууль бус үйл ажиллагааны талаар шүүхэд гомдол гаргах журмын тухай хууль", "Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай

[422] Монголын хэвлэл мэдээллийн байдлын талаарх олон нийтийн үнэлэмж судалгааны тайлангаас. Хэвлэлийн хүрээлэн. Уб., 2009 он.

хууль", "Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль", "Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль", "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль", "Иргэний хамгаалалтын тухай хууль" гэх мэт 33 хууль нь хүчин төгөлдөр бусад тооцогджээ.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой холбогдох эрх зүйн актуудыг судалж үзэхэд: шууд холбогдох хууль 4, шууд бус холбогдох хууль 66, Улсын дээд шүүхийн тайлбар 13, сайдын тушаал 25, олон улсын гэрээ 4, засгийн газрын агентлагийн даргын тушаал 15, Ерөнхийлөгчийн зарлиг 11, УИХ-аас томилогддог байгууллагын дарга түүнтэй адилтгах албан тушаалтны шийдвэр 22, Үндсэн хуулийн цэцийн шийдвэр 4, Засгийн газрын тогтоол 119, Аймаг нийслэлийн ИТХ-ын шийдвэр 1, Улсын их хурлын тогтоол 27 байлаа. Эдгээр эрх зүйн актуудыг судалж үзэхэд зарим нэг хөтөлбөр болон бусад хийхээр төлөвлөгдсөн ажлууд хийгдээгүй, үр дүн нь гараагүй байгаа мэтээр харагдаж байна.

Жишээ нь: 2003 оны 10 дугаар сарын 24-ний өдөр УИХ-аас Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр батлагдсан бөгөөд уг хөтөлбөрт "Нууц хамгаалах хуулиудаар тогтоосон илүүц хязгаарлалтыг арилгах зэргээр төрийн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, энэ талаар иргэд, хэвлэл мэдээллийн ажилтны хүсэлт шаардлагаар мэдээлэл гаргаж өгөх үүрэг, хариуцлага, иргэдээс мэдээлэл олж авах, түгээх эрхийг нь нарийвчлан тодорхойлсон хууль, эрх зүйн үндсийг бүрдүүлнэ". "Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг дэмжин төрийн болон орон нутгийн өмчид байгаа хэвлэл мэдээллийн хэрэгслийг зах зээлийн харилцаанд нийцүүлэн бие даасан байдлыг бэхжүүлэх зохион байгуулалт эрх зүйн арга хэмжээ авна", "Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбогдох бүх хууль тогтоомжид судалгаа хийж, зөрчилтэй зүйл, заалтыг хүчингүй болгох, нэмэлт, өөрчлөлт оруулах зэргээр хууль тогтоомжийг боловсронгуй болгоно", "Мэдээллийн эх сурвалжаа нууцлан хамгаалах сэтгүүлчийн эрх, үүргийг хуулиар баталгаажуулж, иргэд, хэвлэл мэдээллийн хэрэгслийн ажилтан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдлэхдээ хүний нэр, нэр төр, алдар хүндийн халдашгүй байх эрхийг зөрчихөөс сэргийлэх, зөрчигдсөн эрхийг нь бүрэн сэргээх эрх зүйн механизмыг тодотгон сайжруулна" гэх мэт ажлыг хийхээр тусгасан боловч заагдсан арга хэмжээнүүд төдийлөн хэрэгжээгүй. Өнөөдрийг хүртэл иргэдийн мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан "Мэдээллийн эрх чөлөөний тухай" хууль шинээр батлагдаагүй хэвээр байна.

УИХ-аас 2004 оны 12 дугаар сарын 2-ны өдөр Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2005 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай тогтоол гаргасан бөгөөд уг тогтоолоор "Хэвлэл мэдээллийн зөвлөл байгуулах эрх зүйн орчныг боловсронгуй, болгоно". "Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлыг судлан санал боловсруулж шийдвэрлэнэ" гэж тус тус заасан нь мөн хэрэгжээгүй байна.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой Засгийн газрын тогтоол 3, УИХ-ын тогтоол 5, Үндсэн хуулийн цэцийн шийдвэр 2 байсан ба эдгээр

тогтоол болон шийдвэрүүдэд хэрэгжээгүй болон бусад хуультай давхардсан, зөрчилдсөн, цаашид засаж залруулах шаардлагатай зүйлүүд байгаагүй болно. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг судалсан тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хууль, Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай, Олон нийтийн радио, телевизийн тухай, Орон нутгийн хурлын сонгуулийн тухай гэх мэт 5 хууль, Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр батлах тухай, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай, Шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө батлах тухай, Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг батлах тухай, Төлөвлөгөө батлах тухай гэх мэт Улсын Их Хурлын 5 тогтоол, Үндсэн хуулийн цэцийн 2 шийдвэр, Олон улсын гэрээ 1-ийг харьцуулан судлав.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль нь өөрөө тунхагийн шинжтэй учир хуулийн зүйл заалтууд нь өөр бусад хуультай зөрчилдсөн байж болох 3 хууль байсан.

Зөрчилтэй байж болох хуулийн заалтууд: Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Төрийн байгууллагын харьяалал бүхий хэвлэл, мэдээллийн байгууллага санал асуулга бэлтгэн явуулах ажлын явц, санал асуулгын дүнг олон нийтэд шуурхай, үнэн зөв мэдээлэх үүрэгтэй" гэж заасан байгаа нь Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно" гэсэн заалттай зөрчилдөж байна. Учир нь хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд заасны дагуу төрийн байгууллагад харьяалагдах хэвлэл мэдээллийн байгууллага байх ёсгүй юм.

Мөн хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Санал асуулга явуулах тухай шийдвэрийг гарсан өдрөөс нь хойш нэн даруй хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ" гэж заасан байгаа нь иргэдийн мэдээлэл авах эрхийг хангах заалт болж чадсан боловч санал асуулга явуулах тухай шийдвэрийг нэн даруй мэдээлээгүй тохиолдолд ямар хариуцлага тооцох нь тодорхойгүй байгаа учраас уг заалт хэрэгжихгүй байх магадлалтай мэтээр харагдаж байна. Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтад "согтууруулах ундаа болон согтууруулах ундааны үйлдвэрийн нэр, тэмдэг, зураг ашиглах замаар согтууруулах ундааг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, кино, интернэт, ханын самбар, зурагт хуудас, зар чимэглэл, зорчигчийн тийз болон бусад биет байдлаар гаргахыг хориглосон нь Зар сурталчилгааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт "Орон нутгийн цагаар 22 цагаас 06 цаг хүртэл 18 хувь хүртэл этилийн спирт агуулсан дарс, пиво, шимийн архины зар сурталчилгаа нэвтрүүлж болно" гэсэн заалттай зөрчилдөж байна.

Авлигын эсрэг хууль, Автотээврийн тухай хууль, Ард нийтийн санал асуулгын тухай, Архивын тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай, Аудитын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай, Боловсролын тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Галын аюулгүй байдлын тухай, Гамшгаас хамгаалах тухай, Гэмт

хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Гэрээт харуул хамгаалалтын тухай, Дампуурлын тухай, Дипломат албаны тухай, Жижиг, дунд үйлдвэрийн тухай, Зар сурталчилгааны тухай гэх мэт хуулийн зүйл заалтаас бид Эрүүгийн хууль, Иргэний хууль, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль гэх мэт хэвлэл мэдээлэлтэй холбоотой 66 хуулиудыг судалгааныхаа гол объектоор сонгон баримт бичгийн аргаар судалсан ба эдгээр сонгон авсан хуулиудаа "Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд үүрэг болгосон буюу хориглосон хууль", "Холбогдох аж ахуй нэгж байгуллагад үүрэг болгосон буюу хориглосон хууль", "Иргэдийн мэдээлэл авах эрх чөлөөг баталгаажуулсан хууль" гэж тус тус ангилан судалсан.

1."Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд үүрэг болгосон буюу хориглосон хуулиуд;

Хүснэгт 3

	№ Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд үүрэг болгосон буюу хориглосон хуулийн зүйл, заалт[2]
1	Авлигын эсрэг хуулийн 5.1.6
2	Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн 9.2
3	Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 9.1
4	Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 9.2.1, 10.2
5	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 22.1
6	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11, 23
7	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 11.5, 13.1.2.
8	МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн 2, 3, 8, 27, 28
9	Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн 9.3, 9.4, 35.1, 35.6, 37.17
10	Орон нутгийн хурлын сонгуулийн тухай хуулийн 30.9
11	Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль 5.1, 13.2.3
12	Тамхины хяналтын тухай хуулийн 8.1.1.
13	Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 17

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.hli.gov.mn

2."Холбогдох аж ахуй нэгж, байгуллагад үүрэг болгосон буюу хориглосон хуулиуд;

Хүснэгт 4

	№ Холбогдох аж ахуй нэгж байгуллагад үүрэг болгосон хуулийн зүйл заалт
1	Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн 13.2
2	Архивын тухай хуулийн 25.3.
3	Аудитын тухай хуулийн 18
4	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 48.2.2
5	Барааны тэмдэг газар зүйн заалтын тухай хуулийн 9.3, 10.6, 14.2, 28.6,
6	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 26.2
7	Гамшигаас хамгаалах тухай хуулийн 27.1.10
8	Харуул хамгаалалтын тухай хуулийн 9.1.3
9	Дампуурлын тухай хуулийн 5.5, 26.3, 33.2
10	Жижиг дунд үйлдвэрийн тухай хуулийн 6.9
11	Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 17
12	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 19.1.1
13	Шүүхийн тухай хуулийн 27
14	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 42.1, 47.1
15	Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 394.2

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.mli.gov.mn

Иргэдийн мэдээлэл авах эрх чөлөөтэй холбоотой хуулиудын хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийж үзвэл:

Хүснэгт 5;

Хэрэгжиж байгаа	Хэрэгжихгүй байгаа
-Гамшгаас хамгаалах тухай хуулийн 6.1. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага болон гамшгаас хамгаалах албаны үйл ажиллагаа, гамшиг, түүний аюул, хор уршиг, үр дагаврын тухай мэдээлэл нь хуульд өөрөөр заагаагүй бол нийтэд нээлттэй, ил тод байна, 6.2. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага болон гамшгаас хамгаалах алба гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршигиг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, үр дүнгийн тухай хүн амд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр болон бусад хэлбэрээр цаг тухайд нь үнэн зөв мэдээлнэ.	- Архивын тухай хуулийн 25.3. архивын баримтыг архив өөрөө санаачлан хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж болно. - Аудитын тухай хуулийн 18 зүйл. Мэргэжлийн зөвлөл бүртгэсэн болон бүртгэгдээс хаасан мэргэшсэн нягтлан бодогч, аудиторын тухай мэдээллийг төрийн хэвлэлд нийтлүүлнэ.
-Дипломат албаны тухай хуулийн 11.1.3-т зааснаар дипломат албаны ажилтан нь хэвлэл, мэдээллийн хэрэгслээр Монгол Улсын төр, засийн бодлоготой холбогдсон асуудлаар зөвхөн албан ёсны дүгнэлт, байр суурийг илэрхийлэх үүрэгтэй.	- Барааны тэмдэг газар зүйн заалтын тухай хуулийн 9.3.Оюуны өмчийн байгууллага нь бүртгэгдсэн бараны тэмдгийн ном зүй, дүрсийг хэвлэл, мэдээллийн хэрэгслэлд нийтлэнэ, 10.6. Бараны тэмдгийн бүртгэлийн хүчинтэй байх хугацаат сунгасан, эсхүл бараны тэмдгийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулсан бол оюуны өмчийн байгууллага энэ тухай хэвлэл, мэдээллийн хэрэгслэлд нийтлэхээс гадна хэвлэл, мэдээллийн бусад хэрэгслээр нийтлэд нийтлэнэ. 14.2. Оюуны өмчийн байгууллага нь хамтын тэмдэг, гэрчлэх тэмдгийн ном зүйг таниулсрийг ашиглах журмын хамт хэвлэл, мэдээллийн хэрэгслэлд нийтлэнэ, 18.5. Оюуны өмчийн байгууллага нь газар зүйн заалтын нэр, ном зүйг хэвлэл, мэдээллийн хэрэгслэлд нийтлэнэ, 28.6. Бараны тэмдэг, газар зүйн заалтын бүртгэлийг хүчинтэй болгосон, эсхүл хүчинтэй болсоныг тооцсон тохиолдолд оюуны өмчийн байгууллага нь бараны тэмдэг, газар зүйн заалтын улсын бүртгэлд зохих өөрчлөлт оруулж, энэ тухай хэвлэл, мэдээллийн хэрэгслэлд нийтэлнэ.
-Иргэний хуулийн 175.7-д зааснаар дуудлага худалдаа яаруулахаар шүүхэзс томилогдсон этгээд дуудлага худалдаа эхлэхээс 14 хоногийн өмнө хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх үүрэгтэй.	- Иргэдээс төрөн байгуулгаа, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд зааснаар төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол хугацаанд мэдээлэх, хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчилах үүрэгтэй.
-Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 10 дугаар зүйл Ерөнхийлөгчийн зарлиг, захирамжийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын зөвшөөрснөөр төрийн төв хэвлэлд албан ёсоор нийтлэхээс гадна хэвлэл, мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд мэдээлнэ.	- Нийлмийн даатгалын тухай хуулийн 26 дугаар зүйлд зааснаар нийлмийн даатгалын байцаагч нь нийлмийн даатгалын тухай хуулийг удаа дараа зөрчсөн байгуулллага, аж ахуйн нэгж, албан тушаалтны үйл ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх эрхтэй.
-МУ-ын Засгийн газрын тухай хуулийн 31 дүгээр зүйлд зааснаар Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамжийг тэдгээрт Ерөнхий сайд, гаргын үсэг зурснаас хойш ажлын 3 хоногийн дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвшөөрснөөр "Төрийн мэдээлэл" эмхтгэлд албан ёсоор нийтлэхээс гадна Ерөнхий сайдын ажлын хэсгээс эрхлэн хэвлэл, мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд мэдээлнэ.	- Статистикийн тухай хуулийн 18.3-т зааснаар Яам, Монголбанк, төрийн бусад албан газар, бүх шатны Засаг дарга нар мэдээлэл, судалганы дүнг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд хүргэх бүрэн эрхтэй мөн статистикийн мэдээг удаа дараа тасалж, хоосолдуулсан, санаатайгаар бүрдүүлж мэдээлсэн эж ахуйн нэгж, байгууллагыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх замаар бизнесийн нэр хүндэд нөлөөлөх болно.
-Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн 9.2-д зааснаар Сонгууль зохион байгуулж яаруулах, түүний баттгэл аждлтай холбогдуулан энэ хуулиар олгосон эрхийн хүрээнд нийтээр дагаж мөрдүүлэхээр батлан гаргасан шийдвэр нь хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд албан ёсоор мэдээлэгдсэн байна.	- Төв банкны тухай хуулийн 34 дүгээр зүйлд зааснаар Монголбанк хууль тогтоомжийн дагуу статистикийн мэдээлэл, тайланг хэвлэлд нийтлүүлж болно.
-МУ-ын Их хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 49.2-т зааснаар гишүүний асуулгын хариуг эзлэхит чуулганы үеэр сар бүрийн хоёр дахь, дөрөв дэх долоо хоногийн Баасан гаригийн 15 цагаас нэгэдсэн хуралдаанаар хэлэлцэх бөгөөд энэхүү үйл ажиллагаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр шууд дамжуулна.	- Төрийн Аудитын тухай хуулийн 23.1-д зааснаар хуульд өөрөөр заагаагүй бол Төрийн аудитын байгуллага гүйцэтгэлийн аудитын болон бусад тайлангт хэвлэн нийтлэх бүсэг бусад дүгэ замаар хэвлэл мэдээллийн хэрэгслэл, олон нийтэд түгээж болно, 24.1.Төрийн аудитын байгуллагаа өөрийн хийсэн аудитын тайланхийн жагсаалтыг упрал тутам гаргаж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон цахим сүлжээгээр мэдээлнэ.
-Эрчим хүчний тухай хуулийн 11.3.3-д зааснаар Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл нь харьаалах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн цахилгаан эрчим хүчний үнэ, тарифыг хянаж батлах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэрэгжүүлэхэд мэдээлэх үүрэгтэй. 27.5.3.зохицуулах газар нь эрчим хүчний тарифт орох өөрчлөлтийн талаар түүнийг мөрдөж эхлэхээс 15-аас доошгүй хоногийн өмнө хэрэгжүүлэхэд мэдээлэх бүсэг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.	- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 36 дугаар 21 зүйлд зааснаар Хувьчлагдах төрийн өмчит хуулийн этгээд төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрдногдох хувьцаа, ногдол хувьтай холбогдох мэдээллийг Төрийн өмчийн хороо хувьчлах үйл ажиллагаа эхлэхээс 30-аас доошгүй хоногийн өмнө тер засгийн албан ёсны хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд сонордуулна.
-Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 34 дүгээр зүйлд зааснаар Цэцийн шийдвэрийн тоөч агуулгыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд нэн даруй мэдээлнэ.Цэцийн хаалттай хуралданы шийдвэрээс шаардлагатай хэсэг, заалтын агуулгыг нийтэд мэдээлнэ.	- Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр барааа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21.3. 1,000,000.001 төгрөгөс дээш төсөөт өртөгтэй ажил, 100,000.001 төгрөгөс дээш төсөөт өртөгтэй барааа, үйлчилгээний тендерийн урилгыг олон улсын худалдаанд өргөн хэрэгэлдэх хэд дээр гардаг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ. 48.5.Захиалагч худалдан авах ажиллагааны телеөлгөгөг тухайн жилийн эхний сард хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ. 51.8.2. энэ хуулийн 51.8.1-д/ 51.8.1. өөрийн эрхлэх хүрээний асудал тус бүрээр тендерт оролцогчийн чадахийг үнэлэх үзүүлэлтийг тодорхойлох,/ заасны дагуу чадахийг үнэлэх үзүүлэлтийг тодорхойлсны дараа бүртгэл хөтлөх тухай үндэсний хэмжээний өдер тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх.
	- Улс төрийн хилс хэрэгт хяналтдагдчийг цагаатгах, тэдэнд 22 нөхөн олговор олгох тухай хуулийн 18.1-д заасны дагуу цагаатгагдсан хяналтдагчийн овог, нэр, төөч нэмтар, хэрэгт хяналтдуулсан болон цагаатгасан тухай төрийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон тумэнд үнэ төлбөргүй мэдээлнэ.

1.4.1. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой хэрэг маргааныг шүүхээр шийдвэрлэж байгаа байдалд хийсэн дүн шинжилгээ

Сэтгүүлч ёс зүйн хариуцлага алдан хэвлэн нийтлэгдсэн мэдээ баримтад бусдыг гүтгэсэн, доромжилсон бол хохирлыг арилгуулах асуудал Иргэний болоод Эрүүгийн хуульд тусгалаа олсон байдаг. Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт зааснаар Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол эрх нь зөрчигдсөн этгээдийн шаардлагаар уг мэдээг тараасан хэлбэр, хэрэгсэл, эсхүл өөр хэлбэр, хэрэгслээр няцаах үүрэг хүлээнэ, 21.3 дахь хэсэгт "Бодит баримтыг бүрэн гүйцэд мэдээлээгүйгээс бусдын нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан бол" энэ хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан журмаар няцаах үүрэг хүлээнэ, 511 дүгээр зүйлийн 511.1-д "Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол эд хөрөнгийн хохирол арилгасныг үл харгалзан, эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ" гэсэн байна. Үүнээс харахад сэтгүүлч нь бусдыг гүтгэсэн, доромжилсон мэдээ, мэдээлэл нийтэлсэн тохиолдолд нийтэлсэн хэвлэлийн тоо хэмжээгээр залруулга хийж, эдийн бус гэм хорыг нөхөн төлөх үүрэг хүлээж байна.

Дээрх заалтууд нэхэмжлэгчид учирсан эдийн бус хохирлыг ямар шалгуураар тогтоон хэдэн төгрөг нэхэмжлэх боломжтой вэ? гэдгийг хуульчлаагүй байна. Шүүхийн архиваас авсан шийдвэрүүдээс харахад хэвлэл мэдээллийн байгууллага нь гаргасан мэдээндээ няцаалт хийж, хохирлыг тодорхой хэмжээгээр мөнгөн дүнгээр төлсөн байна. Харин хүний нэр төр, алдар хүндийг гутаасан мэдээлэл цацсан сэтгүүлчид хариуцлага тооцох тухай дурдаагүй, мөн Иргэний хуулийн холбогдох заалтууд нь сэтгүүлчдэд бус хэвлэл мэдээллийн байгууллагатай холбоотой хариуцлагын асуудлыг хуульчилсан байна.

Сэтгүүлчид бид эх сурвалжаа нууцлах эрхтэй гэж үздэг, шүүхэд ч тэгж мэдүүлдэг. Тэгвэл хууль эрх зүйн хувьд уг эрхээ баталгаажуулж өөрсдийгөө хамгаалах тал дээр дутмаг ажилладаг. Энэ нь хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 3.1-дэх заалттай ч холбоотой байж болох юм. Жишээ нь: захиалагч нийтэлсэн эх сурвалжийнхаа хариуцлагыг хүлээхгүй гэсэн тохиолдолд сэтгүүлч тухайн нийтлэлээс үүдэн гарах үр дагавар, гэм хорыг бүрэн хариуцна гэдгээ баталж гэрээ байгуулах; сэтгүүлч захиалагчийн нийтэлсэн нийтлэлийн хариуцлагыг хүлээхгүй гэсэн тохиолдолд захиалагчтай гэрээ байгуулах гэх мэтээр зохицуулах юм бол захиалагч хариуцна би хариуцахгүй гэж хариуцлагаас зугатаах, хэн нэгэнд учруулсан гэм хор хариуцагчгүй болох эрсдэлээс хамгаалагдах юм. Тиймээс Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Хэвлэл мэдээллийн хэрэгсэл өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ" гэсэн заалтыг байгууллага биш, гэм буруутай тодорхой албан тушаалтан субъект хүлээнэ" гэж өөрчлөх шаардлагатай

байгааг харуулж байна. Зохиогчийн өгсөн буюу сурвалжлагчийн нэртэй түгээж байгаа мэдээллээс бусад бүх мэдээллийн хариуцлагыг редакци хариуцах ёстой. Зохиогч буюу сурвалжлагчийн нэргүй түгээж байгаа мэдээллийн нууцыг редакци хадгалах эрхтэй бөгөөд хэрэв редакци тийнхүү нийтлэл, нэвтрүүлгийн зохиогч, сурвалжлагчийн нэрийг нууцалж байгаа бол нийтлэл, нэвтрүүлгийнхээ хариуцлагыг хүлээх ёстой.

Шүүхийн практикаас харахад сэтгүүлчид хэн нэг хүнийг гүтгэж биччихээд би эх сурвалжаа нууцлах эрхтэй гэзэд хэлээд зогсож байдаг, мөн хэн нэгний ярьсан яриаг ярилцлага болгоод биччихдэг, мөн сонин сэтгүүлүүд хүний авчирч өгсөн зүйлийн үнэн бодитойд дүгнэлт хийлгүй мөнгийг нь аваад нийтэлчихдэг зэргээс болж хүний нэр төр хохирох явдал гарч байна. Мөн сонины гэрчилгээ нь өөр хүний нэр дээр үйл ажиллагааг нь өөр хүн явуулж байдаг тохиолдол байдаг. Жишээ нь: Ноцтой мэдээ сонинд шүүгч С-г гүтгэж бичсэн нийтлэлд "Ноцтой мэдээ" сонины ээзэн Г "энэ сонины гэрчилгээ нь миний нэр дээр байдаг ч сонин юу нийтэлж, юу гарч байгааг би мэддэггүй", сонинд нийтэлсэн материалын хариуцлагыг сэтгүүлч хүлээдэг" гэж хариулсан. Түүнчлэн шүүхэд дуудагдсан хариуцагчид "Би Үндсэн хуульд заасан үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдэлсэн" гэж хариулж байгаа нь нэг хүний эрх чөлөө нөгөө хүний эрх чөлөөгөөр хязгаарлагдана гэсэн эрх зүйн үндсэн зарчим болон эрх зүй, ёс суртахууны мэдлэг дутмаг байгааг илэрхийлж байна. Түүнчлэн шүүхэд дуудагдсан сонины удирдлага "сэтгүүлч өөрийн нийтлэлийн үнэн зөвийг хариуцах ёстой" гэж хэлж байгаа нь тэдний эрх зүйн мэдлэг хэр дутмаг байгааг харуулж байна.

Бид энэхүү судалгаагаараа 2006-2009 онд шүүхэд шийдвэрлэгдсэн тэдэн хэрэгт нэхэмжлэгч нь тэдэн хувь нь сэтгүүлчид байлаа гэх мэтээр тоочиж судалсангүй ерөнхийд нь шүүхийн практикт гарч байгаа нийтлэг зөрчлүүд юу байна гэдэгт гол анхаарлаа хандуулсан болно. Учир нь шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн практикийн талаар Глоб интернэшнл ТББ хангалттай судалгаа хийсэн байгаа болно. Харин энд нэг зүйлийг тодруулан хэлэхэд хүний нэр төрийг сэргээх хэргийг шийдвэрлэхэд шүүгчид дотоодын хууль тогтоомжоос гадна /бусад хэргийг шийдвэрлэхэд тэр болгон хэрэглэдэггүй/ олон улсын гэрээ, конвенцийг шүүхийн шийдвэрийн үндэслэл болгож байгаа нь сайшаалтай байлаа.

Нийслэлийн анхан болон давж заалдах шатны шүүхээр хянагдсан хэргүүд[423]

[423] Нийслэлийн шүүхийн архиваас авсан тоо мэдээ

Хүснэгт 6

ИХ-ийн зүйл	Хэргийг шийдвэрлэсэн он	Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн хэргийн тоо	Давж заалдах шатны шүүхээр хянан хэлэлцсэн хэргийн тоо
21	2006	30	4
	2007	36	4
	2008	13	11
	2009	13	10
27	2006	1	1
	2007		
	2008		
	2009		
497	2006	206	50
	2007	253	44
	2008	160	52
	2009	222	55
511	2006	9	4
	2007	17	
	2008	7	3
	2009	3	

хуулийн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

Тайлбар: Иргэний хуулийн 497 буюу гэм хорыг арилгах зүйлээр шийдэгдсэн хэргийн тоо зөрүүтэй гарч байгаа шалтгаан нь энэ зүйлээр зөвхөн иргэдийн нэр төр сэргээлгэхээр гаргасан нэхэмжлэлээс гадна бусад төрлийн гэм хорыг арилгахад хэрэглэдэгтэй холбоотой юм.

Манай Улсын хэмжээнд доромжлох, гүтгэх гэмт хэрэг 2005-2009 оны байдлаар цагдаагийн байгууллагад дараах байдлаар бүртгэгдсэн байна.

- ✓ 2005 онд доромжлох гэмт хэрэг -8, гүтгэх гэмт хэрэг -15,
- ✓ 2006 онд доромжлох гэмт хэрэг -5, гүтгэх гэмт хэрэг -7,
- ✓ 2007 онд доромжлох гэмт хэрэг -5, гүтгэх гэмт хэрэг -16,
- ✓ 2008 онд доромжлох гэмт хэрэг -6, гүтгэх гэмт хэрэг -9,
- ✓ 2009 онд доромжлох гэмт хэрэг -6, гүтгэх гэмт хэрэг -6.

Гэмт хэрэг бүртгэгдсэн нутаг дэвсгэрийн хувьд: 2005 оны байдлаар УБ хотод 50, Хөвсгөл аймагт 2, Увс аймагт 4, Ховд аймагт 5, Дархан-Уул аймагт 2, Дундговь аймагт 2, Завхан аймагт 1, Сэлэнгэ аймагт 2, Баянхонгор аймагт 2, Баян-Өлгий аймагт 1, Архангай аймагт 3, Өмнөговь аймагт 1, Өвөрхангай аймагт 1, Орхон аймагт 1 гэмт хэрэг тус тус бүртгэгдсэн байна[424].

Энэ хэрэг нь хүн ам ихээр суурьшсан, хэвлэл мэдээллийн байгууллага төвлөрсөн газар хэн нэгэн хэрэгт хууль сахиулах байгууллагын ажилтан зөвхөн хэвлэл мэдээллийн байгууллагад хандан худал мэдээлэл өгсөн этгээдийг сэжигтэн яллагдагчаар татан шалгаж, харин худал нийтлэл хэвлэн нийтэлсэн хэвлэл мэдээллийн байгууллагын албан хаагчийг ихэвчлэн гэрчээр тооцон байцааж, түүнд нийтлэн цацсан мэдээллийнх нь талаар анхааруулаад өнгөрч байгаа нь ихээхэн учир дутагдалтай байна. Энэ нь Хэвлэл мэдээллийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 "Хэвлэл мэдээллийн байгууллага өөрөө хариуцлага хүлээнэ" гэсэн заалттай зөрчилдөж байгаа юм[425].

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 110 дугаар зүйлийн 110.1-д Бусдын нэр төр, алдар хүндийг олон нийтийн өмнө доромжилсон бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ, 111 дүгээр зүйлийн 111.1-д Хуний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэг тараасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ, 111.2-д "Гутгэлгийг олон нийтэд тараасан, эсхүл доромжлох, гутгэх гэмт хэрэгт урьд ял шийтгүүлсэн этгээд үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ", 111.3-д Хүнд, онц хүнд гэмт хэрэгт холбогдуулан яллуулахаар гутгэснээс хүнд хор уршиг учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж тус тус заасан.

Бусдыг гутгэсэн, доромжилсон мэдээлэл түгээсэн хэвлэл мэдээллийн байгууллага нь тэрхүү мэдээллийг хэвлэн нийтэлснээрээ олсон орлого, ашиг нь нэр төрөө гутаалгасан иргэнд учирсан хохирлоос давсан байдаг. Эрүүгийн хуульд заасан торгох ял нь тэрхүү мэдээллийг түгээсэн хэвлэл мэдээллийн байгууллагын олсон орлогоос бага болон нэр төр нь гутаагдсан иргэнд учирсан гэм хортой харьцуулах аргагүй байна. Энэ нь иргэний болон эрүүгийн хууль, захиргааны хариуцлагын тухай хууль, зар сурталчилгааны тухай хууль гэх мэт зарим төрлийн хуулиудын торгуулийн хэмжээ нь зах зээлийн одоогийн үнэлгээнд тохирохгүй, хохирлыг арилгаж чадахгүй нөлөө багатай байгаа нийтлэг үзэгдлүүдийн нэг юм. Гэхдээ нэр төрөө сэргээлгэх

[424] Эрүүгийн хэргийн архиваас Эрүүгийн хуулийн 110, 111 дүгээр зүйл ангиар шийдсэн хэргийн тоог гаргах боломжгүй тул ЦЕГ-аас авсан тоо мэдээг оруулав.

[425] Цагдаагийн Ерөнхий газрын мэдээлэл дүн шинжилгээний газраас авсан тоо мэдээ. Бүртгэгдсэн хэргийн тоо

гэдэг бол хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр няцаалт хийж андуу ташаа бичсэндээ уучлалт гуйхад орших болохоос иргэний хуульд зааснаар мөнгөн хэлбэрээр хохирлоо барагдуулахад орших учиргүй бөгөөд шүүхийн практикт ч мөн адил энэ хэлбэрийг хэрэглэхээс аль болох зайлсхийх нь чухал юм. Ингэснээрээ нэр төрөө сэргээлгэхийг мөнгө олох арга гэж ойлгох үзэгдлээс сэргийлэх ач холбогдолтой юм. Гүтгэх доромжлох хоёрын аль аль нь эдийн бус хохирол учруулдаг боловч гэмт хэргийн бүрэлдэхүүнээрээ ялгаатай. Гүтгэх гэмт хэргийн бүрэлдэхүүн нь бодит байдалд үл нийцсэн мэдээлэл тарааж, түүгээрээ хүний нэр төр, алдар хүндийг гутаасан гэсэн ойлголт байдаг. Харин доромжлолын хувьд заавал бодит байдалд нийцсэн, тохирсон нь чухал биш, хамгийн гол нь ямар хэлбэрээр илэрхийлсэн нь чухал байдаг. Аливаа хүний тухай шүүмжилж бичихдээ эвгүй, таагүй байдлаар илэрхийлсэн байвал тэр нь доромжлол болдог. Иймээс Гүтгэх, доромжлох гэмт хэрэг нь зөвхөн сэтгүүлчдэд бус нийт иргэдэд хамаатай заалт юм. Иргэдийн эрх зүйн мэдлэг муу байгаагаас энэ гэмт хэргийн холбогдогч нар нь зөвхөн сэтгүүлчид болж байгаа юм. Зүй нь бол 2 иргэн хоорондоо маргалдаад нэг нь нөгөөгөө олон нийтийн өмнө доромжилсон байхад доромжлуулсан этгээд цагдаагийн байгууллагад хандах эрхтэй юм. Иймээс судалгааны баг Глоб интернэшнл ТББ-аас хийсэн "Нэр төр сэргээх хэрэг ба цензур" судалгааны ажлын үр дүнд Эрүүгийн хуулийн гүтгэх, доромжлох заалтыг улс төрчид болон төрийн өндөр албан тушаалтнууд өөрсдийгөө хамгаалах хэрэгсэл болгон ашиглаж, сэтгүүлчдийг янз бүрийн хэлбэрээр дарамталж шүүхэд дуудах, асуудал гарч байгаа учраас Эрүүгийн хуулиас энэ хоёр заалтыг хасах хэрэгтэй гэдэг дүгнэлттэй санал нийлэхгүй байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд сэтгүүлчид өөрсдийн эрх ашгаа хамгаалан дараах байдлаар бичиж байна. "Албан тушаалтнууд сэтгүүлчдийг сүрдүүлж дарамтлах, эх сурвалжаа илчлэхийг албадах, мэдээлэл өгөхөөс татгалзаж байгаа нь монголын сэтгүүлчдийн үүргээ биелүүлэх явцад тулгарч буй гол бэрхшээл юм". Эрүүгийн хуулийн 139 дүгээр зүйл бол сэтгүүлчдийн эрхээ хамгаалах, эрэн сурвалжлах сэтгүүл зүй хөгжих хамгийн гол эрх зүйн зохицуулалт боловч бодит байдал дээр сэтгүүлчид өөрсдийгөө хамгаалах гол эрх зүйн баталгаа болох энэ заалтыг ч мэдэхгүй, "редакцийн дарамт их байна" /Судалгаанд оролцсон сэтгүүлчдийн 142 буюу 66% нь редакци цензур тавьдаг гэсэн байна/, "бизнесмен болон улс төрчид биднийг дарамталж байна" гэх мэтээр ярих нь зохимжгүй юм.

Учир нь Эрүүгийн хуульд сэтгүүлчдийг хамгаалах заалт байсаар байхад түүнийг ашиглаж өөрийн эрх ашгаа хамгаалах тал дээр сэтгүүлчид хангалтгүй ажиллаж байгаа нь "Глоб интернэшнл" ТББ-ын хийсэн "Нэр төр сэргээх хэрэг ба цензур" болон бусад сэтгүүлчидтэй холбоотой судалгаанд Эрүүгийн хуулийн 139 дүгээр зүйлд зааснаар гомдол гаргаж, хэргээ шийдвэрлүүлэх гэж оролдсон 5 тохиолдлоос өөр тохиолдол байхгүй байгаагаар батлагдаж байна. Сэтгүүлчид техник технологи хөгжсөн энэ үед утсаар дарамталж байгаа хүний яриаг бичлэг хийж аваад, нотлох баримтаар үнэлүүлэн цагдаагийн байгууллагаар шалгуулах гэх мэтээр өөрийн хуульд заасан эрхээ эдлэх боломж хангалттай байна гэж үзэж байна. Жишээ

нь, дараах тохиолдолд сэтгүүлчдийн хуульд нийцсэн үйл ажиллагаагаа явуулахад тулгарч байгаа бэрхшээлийн тухай бичсэн байдаг.

Эрэн сурвалжлах сэтгүүл зүй "Өдрийн сонин" 2010.5.18. №117 /3507/ "Эх сурвалжийн мэдээллийн мөрөөр үнэнийг хайсан нь" Өдрийн сонины эрэн сурвалжлах албаны хамт олон Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн II их хурлаар батлагдсан Монголын сэтгүүлчдийн ёс зүйн зарчмын нэгд "Сэтгүүлч хүн олон түмний үнэнийг мэдэх эрх ашигт ямагт захирагдана" гэсэн заалтыг иш үндэс болгон, далд бугшсан, нууц баримт сэлтийг эх сурвалжаар дамжуулан олон нийтэд ил болгодог эрэн сурвалжлах сэтгүүл зүйн аргыг ашиглаж, Эрүүгийн хуулийн 139 дүгээр зүйлд заасныг үндэс болгон Хууль хяналтынхныг дөнгөлж, УИХ-ын зарим нэр бүхий гишүүдийг өөрийн хамсаатан болгосон "Сүм-Бар" компаний захирал Б-ын талаарх мэдээллийн мөрөөр эрэн сурвалжлах сэтгүүл зүйн аргыг ашиглан нотолж, баримтжуулсан нийтлэлд дүн шинжилгээ хийж үзвэл: Аливаа хэвлэн нийтэлсэн мэдээллийнхээ үнэн зөвийг сэтгүүлчид батлах, нотлох боломжгүй. Учир нь сэтгүүлчдэд тагнах, мөрдөн шалгах эрх байхгүй. Тухайн нийтлэлд дурьдсан зүйл нь олон нийтийн санаа бодол бол түүнийг сонин, сэтгүүл, радио телевизээр түгээх нь сэтгүүлчийн үүрэг юм. Ингэж олон нийтийн санаа бодлыг төр засгийн өндөрлөгүүдэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүргэж, энэ үйлдлээрээ төрд хяналт тавьсаныхаа төлөө сэтгүүлчид ямар нэг байдлаар дарамт шахалтад өртдөггүй, ийм үйл ажиллагаанаас эрх зүйн хувьд хамгаалагдаж байж хэвлэл мэдээлэл эрх чөлөөтэй байна гэж ам бардам дуугарах болно гэж бичсэн байна.

Эрүүгийн хуулийн 139 дүгээр зүйлд "Сэтгүүлчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд саад хийх"-ийг гэмт хэрэг гэж үзсэн. 139.1. Өөрийн болон бусдын ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг нийтэд тараах, эсхүл тараалгахгүй байхын тулд сэтгүүлчийн хуульд нийцсэн мэргэжлийн үйл ажиллагаанд саад хийсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучин нэгээс тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ. 139.2. Энэ хэргийг албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш, зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ гэж тус тус сэтгүүлчдийн эрх ашгийг хамгаалан заасан байхад сэтгүүлчид мэдээлэл технологи өндөр хөгжсөн энэ нийгэмд хэн нэгэнд дарамтлуулсан баримтаа бүрдүүлэн өөрсдийгөө хуулийн хүрээнд хамгаалуулж яагаад болохгүй гэж гэсэн асуулт гарч байна. Глоб интернэшнл ТББ-аас хийсэн "Нэр төр сэргээх хэрэг ба цензур" судалгаанд оролцсон 215 сэтгүүлчийн 60,4% буюу 130 сэтгүүлч нийтлэл, нэвтрүүлгээсээ болж нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд гутаагдсан гэсэн гомдолтой тулгарсан байна.

130 сэтгүүлчийн 50,8% буюу 66 нь сүрдүүлэг заналхийлэлд өртөж, 40% буюу 52 нь дарамтанд орсон бол 23% буюу 30 сэтгүүлчид иргэний хэрэг үүсгэн шалгажээ. Сүрдүүлэг, заналхийлэл нь агуулгын хувьд дийлэнх буюу 42.3% шүүхэд өгнө, 33.1% нь ажлаас чинь халуулна гэж сүрдүүлсэн бол

шоронд суулгана, ална, зодно, хүүхэд, гэр бүлийн гишүүдэд халдана гэж сүрдүүлсэн тохиолдол 5,4% - 7,7%-ийг эзэлж байна.

Дүгнэлт: 130 сэтгүүлчийн 23 хувь буюу 30 сэтгүүлчийн үйл ажиллагаанд иргэний хэрэг үүссэн байгаа нь сэтгүүлчид эх сурвалжаа үнэхээр найдвартай эсэхийг мэддэггүй, яг ямар зүйлийг ямар хүнээс авсан тохиолдолд тэр тухай бичиж болох вэ гэдгээ мэддэггүй, юу сонссон тэрнийгээ л бичдэг. Ер нь хүмүүсийн ярьсан үгийг дамжуулах нь сэтгүүлчдийн үүрэг гэсэн ойлголт сэтгүүлчдийн дунд түгээмэл байдаг. Гэхдээ дамжуулахаасаа өмнө нэг талаар эх сурвалжийнхаа найдвартай эсэхийг хянах, эргэлзээтэй тохиолдолд мэдээлэл бодитой эсэхийг хянах нь сэтгүүлч хүний үүрэг гэдгийг тэр бүр мэддэггүй мэдсэн ч хэрэгжүүлдэггүй. Энэ байдлаас нь болж сэтгүүлчийг ашиглаж гутгэлэг тараасан хүн гэм буруугүй болж байна.

Хоёр. Хэвлэл мэдээллийн байгууллага

2.1. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл ба хэвлэл мэдээллийн байгууллага

Хэвлэл мэдээллийн байгууллага гэх нэр томьёоны тухайд:

1992 оны Үндсэн хуульд үндэслэн 1998 онд Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг батлан гаргасан. Энэ хуулийн 2 дугаар зүйлд "хэвлэл мэдээллийн хэрэгсэл" гэсэн нэр томъёо хэрэглэсэн байдаг. Харин өнөөдөр бид нийтээрээ /энгийн болон мэргэжлийн ухамсрын түвшинд/ хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэдэгт сонин, сэтгүүл, радио, телевиз зэргийг хамруулан ойлгож байна. Нөгөө талаас зарим хуульд "хэвлэл мэдээллийн байгууллага" гэсэн нэр томъёо бас хэрэглэсэн байдаг.

Эндээс "хэвлэл мэдээллийн хэрэгсэл" гэдэг ойлголт маань чухамхүү эдгээр мэдээллийг түгээж байгаа материаллаг зүйлс, дүрс, дуу авиаг хамаарсан ойлголт уу, эсхүл хэвлэл мэдээллийн байгууллагыг нэрлэсэн оноосон нэр үү гэдэг нь ойлгомж муутай, өөр хооронд нь ихээхэн ууссан байдалтайгаар хэрэглэж байгааг нэг мөр болгох, түүнчлэн хууль тогтоомжид "хэвлэл мэдээллийн хэрэгсэл" болон "хэвлэл мэдээллийн байгууллага" гэсэн нэр томъёог нэгэн зэрэг ялгалгүйгээр хэрэглэж байгааг зааглах нь зүйтэй байна. Жишээлбэл, Шүүхийн тухай хуулийн 27.1-д "Ерөнхий зөвлөл бүх шатны шүүхийн шүүгчийн сонгон шалгаруулалт явуулах тухай зарлалыг сонгон шалгаруулалт явуулах тухай өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ" гэж заасан бол Авлигын эсрэг хуулийн 5.1.6-д "хэвлэл мэдээллийн байгууллага авлигын аливаа хэлбэрийг үл тэвчих нийгмийн сэтгэл зүйн орчинг төлөвшүүлэхэд нийтлэл, нэвтрүүлгийнхээ бодлогыг чиглүүлэх, энэ талаар байнга мэдээлэл, сурталчилгаа явуулах үүрэгтэй" гэж заасан байна. Түүнчлэн Аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлд "мэргэжлийн зөвлөл бүртгэсэн болон бүртгэлээс хассан мэргэшсэн нягтлан бодогч, аудиторын тухай мэдээллийг төрийн хэвлэлд нийтлүүлнэ" гэж заажээ. Хэвлэл мэдээлэлд хамаарал бүхий хэмээн үзэж түүвэрлэсэн 66 хуулийн 20 хуульд "хэвлэл мэдээллийн байгууллага" гэсэн нэр томъёо хэрэглэсэн байна. Эндээс "хэвлэл мэдээллийн байгууллага" болон "хэвлэл мэдээллийн хэрэгсэл" гэсэн нэр томъёонууд ижил үү, эсхүл

ялгаатай юу гэсэн асуудал урган гарч байна. Өмнө дурдсанчлан ердийн болон эрх зүйн онолын ухамсрын түвшинд энэ 2 нэр томъёог нэг зүйл мэтээр ойлгосоор байна. Энэ нь дээр дурдсан хуулийн зохицуулалтаас тодорхой харагдана. Учир нь хууль тогтоогч эдгээр нэр томъёог хоёуланг нь хуулийн этгээд гэсэн байдлаар хуульчилсан байна.

"Хэвлэл мэдээллийн хэрэгсэл" гэдэг бол мөн чанарын хувьд нийгэмд түгээж буй тухайн мэдээллийг тээгч мөн. Харин хэвлэл мэдээллийн байгууллага бол мэргэжлийн үйл ажиллагааг эрхэлж буй эрх зүйн субъект юм.

Хэвлэл мэдээллийн байгууллагын мөн чанарын тухайд:

Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлд Хууль зүй, дотоод хэргийн сайд "хэвлэл мэдээллийн хэрэгслийн бүртгэл"-ийн хүрээний бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалтын болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг эрхэлнэ гэж заасан байна. Эндээс хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь улсын бүртгэлд бүртгүүлж үйл ажиллагаа явуулна гэж ойлгож болно.

Энэ утгаараа "хэвлэл мэдээллийн хэрэгсэл" нь эрх зүйн харилцааны субъект болж таарна. Тэгвэл хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэх эрх зүйн субъектийн мөн чанар юу вэ? Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7.1.1-д "Хуулийн этгээдийг буюу нөхөрлөл, компани, хоршоо, төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, холбоо, сан, шашны байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, түүний орон нутаг дахь салбар бүртгэнэ" гэж заасан байна.

Хуулийн энэ зохицуулалтаас "хэвлэл мэдээллийн хэрэгсэл" бол хуулийн этгээд мөн гэсэн дүгнэлт хийлээ. Тэгвэл аливаа субъект хуулийн этгээд байхын тулд тодорхой шинжийг агуулсан байх ёстой.

Хуулийн этгээдийн тухай ойлголтыг иргэний эрх зүйн шинжлэх ухаан судалдаг. Гэхдээ энэ нь хуулийн этгээд зөвхөн иргэний эрх зүйн харилцааны субъект болно гэсэн үг биш юм. Эрх зүйн субьектийг юун түрүүнд бодгаль /хувь хүн/ буюу хамтын /хуулийн этгээд/ гэж ангилна[426]. Хуулийн этгээд нь иргэний эрх зүйгээс гадна ихэнх салбар эрх зүйн харилцаанд субъектээр[427] оролцдог. Иймээс хуулийн этгээд нь юуны түрүүнд зд хөрөнгийн шинжтэй эрх зүйн харилцаа, мөн түүнчлэн иргэний эрх зүйн харилцаанд субъектээр оролцдог[428] болно. Хуулийн этгээдийн тухай ойлголт эртний Ромын үеэс эхлэн хөгжиж эхэлсэн боловч хуульчилсан тодорхойлолтод нилээд хожуу бий болжээ. Жишээ нь: Наполеоний хууль гэдгээрээ алдаршсан 1804 оны

---

[426] Н.И.Матузов., А.В.Малько "Теория государства и права": Учебник.-М.: Юристь, 2002. с.389 /Тэрээр эрх зүйн субьект болон эрх зүйн харилцааны субьектийг адилтгаж авч үзжээ/

[427] МУ-н хувьд хуулийн этгээд нь эрүүгийн эрх зүйн харилцаанд субъект болж чаддаггүй. Тэгвэл гадаадын зарим оронд хуулийн этгээд эрүүгийн эрх зүйн харилцааны субъект болж чаддаг байна. Жишээлбэл: Францыг дурьдаж болно. Энэ тухай С.Нарангэрэл "МУ-н эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги". УБ. 1999.378-р талаас үзнэ үү!

[428] В.Н.Хропанюк "Теория государства и права": Учебное пособие для высших учебных заведений /Под ред.профессора В.Г.Стрекозова-М,2001.с.312

Францын иргэний хуульд хуулийн этгээд гэдэг ойлголт тусгагдаагүй[429] бөгөөд ердөө 19-р зууны сүүлээр Францын хууль тогтоомжуудад хуулийн этгээд хэмээх ойлголт орж ирсэн байна.

Тэгвэл Германы Иргэний хуульд Францын Иргэний хуулиас хойш зуугаад жилийн дараа батлагдан гарсан байх юм. Энэ үед томоохон аж үйлдвэрийн болон тээврийн аж ахуйн нэгжүүд хэдийн үүсчихсэн[430] байлаа. Англи улсын хувьд 1844 оноос хойш компани нь олон төрлийн актуудаар зохицуулагдаж байсан бөгөөд 1985 онд тэдгээрийг нэгтгэн компанийн тухай хуулийг батласан[431] байна. АНУ-н эрх зүй нь 17-р зууны үеийн Английн эрх зүйгээс үүдэлтэй боловч өөрийн гэсэн онцлогтой байдаг. Капитализм маш эрчимтэй хөгжиж байсантай холбоотойгоор Английн эрх зүйд байгаагүй аж ахуйн корпориацын институт, трестийн эсрэг хууль тогтоомжууд бий болсон байдаг[432]. Швейцарын 1907 оны иргэний хууль нь 4 дэвтрээс бүрддэг ба эрх зүйн субъект хэмээх I дэвтэрт нь хувь хүн ба хуулийн этгээдийн тухай[433] хуульчилжээ.

1994 онд батлагдсан Монгол Улсын Иргэний хуульд "Өмчлөх буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан эд хөрөнгөтэй өөрийн үйл ажиллагаагаараа эрх олж, үүрэг бий болгох чадвартай, үйл ажиллагаанаасаа үүсэн гарах үүргийг эд хөрөнгөөрөө хариуцдаг; шүүх арбитрт өөрийн нэрийн өмнөөс оролцдог байгуулагыг хуулийн этгээд гэнэ"[434] хэмээн хуульчилсан байв. Харин 2002 оны Иргэний хуулиар "Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан эд хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаварыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ"[435] гэж тодорхойлжээ. Энэ тодорхойлолт нь утга агуулгын хувьд нэлээд оновчтой болсон. Өөрөөр хэлбэл зохион байгуулалтын нэгдэл хэмээн тодорхойлсныг нь эд хөрөнгийн болоод хүмүүсийн тодорхой эмх журам бүхий нарийн нийлмэл нэгдэл юм гэж ойлгож болно.

Зах зээлийн өндөр хөгжилтэй орнуудын эрх зүйд хуулийн этгээд гэдгийг өөрийн нэрээр эрх зүйн харилцаанд оролцдог, түүний бүрэлдэхүүнд багтдаг этгээдүүдээс хамаарахгүйгээр оршин байдаг, эд хөрөнгийн эрх үүргийг тээгч юм гэж үздэг ажээ. Тэрээр хуулийн этгээдийн шинж гэдэгт:

1. Эд хөрөнгийн тусгаарлагдмал байдал: Хуулийн этгээдийн эд хөрөнгө нь түүний гишүүдийн эд хөрөнгөөс тусгаарлагдсан байхыг ойлгоно.

---

[429] "Гражданское и торговое право капиталистических государств": Учебник.-3-е изд, перераб. и доп.-М.: Междунар. Отношения,1993.с.37

[430] "Гражданское и торговое право капиталистических государств": Учебник.-3-е изд, перераб. и доп.-М.: Междунар. Отношения,1993.с.42

[431] Marsh & Soulsby "Business law".FIFTH EDITION. 1992.p.63

[432] "Гражданское и торговое право капиталистических государств": Учебник.-3-е изд, перераб. и доп.-М.: Междунар. Отношения,1993.с.53

[433] "Гражданское и торговое право капиталистических государств": Учебник.-3-е изд, перераб. и доп.-М.: Междунар. Отношения,1993.с.59

[434] "Иргэний хууль"-ийн 21.1 1994 он

[435] "Иргэний хууль"-ийн 25.1 2002-01-10

2. Эд хөрөнгийн бие даасан хариуцлага: Өөрийн эд хөрөнгөтэй байх нь эд хөрөнгийн бие даасан хариуцлага хүлээх урьдчилсан нөхцөл нь болдог.

3.Үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгч болон түүний бүрэлдэхүүнд багтдаг этгээдүүдээс хамааралгүйгээр оршин байх /энд нэг гишүүнтэй хуулийн этгээдийг авч үзэхэд л хангалттай юм/ чадвар[436]зэргийг хамруулан үздэг байна.

ОХУ-ын судлаачид хуулийн этгээдийн шинжийг аль аль нь зайлшгүй шаардлагатай бөгөөд эдгээр нь бүгд нийлж байж тухайн байгууллага иргэний эрх зүйн субъект гэж хүлээн зөвшөөрөгдөхөд хүргэдэг түүний дотоод чанарууд юм[437] гэж тодорхойлсон байх бөгөөд хуулийн этгээд нь дараах шинжүүдтэй гэдэгтэй ихэнх нь санал нэгтэй байдаг[438] байна. Үүнд:

1.Зохион байгуулалтын нэгдэлтэй байх: Энэ нь тухайн хуулийн этгээдийн бүтцийг бүрдүүлж буй удирдлагын байгууллагуудын тодорхой дараалал болон үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгчид, түүний бүрэлдэхүүнд багтаж буй этгээдүүдийн хоорондын харилцааг тодорхой зохицуулсан байхыг хэлнэ. Ингэсний ачаар олон этгээдүүдийн хүсэл зоригийг нэгтгэн хуулийн этгээдүүдийн нэгдмэл хүсэл зориг болгон хувиргаж болно. Өөрөөр хэлбэл эрх, үүргийг хуулийн этгээдийн гишүүд ч бишь, харин хуулийн этгээд бүхэлдээ хэрэгжүүлнэ гэсэн үг юм. Хуулийн этгээдийн зохион байгуулалтын нэгдэл нь түүний үүсгэн байгуулах баримт бичиг болон хууль тогтоомжийн актуудад тусгагдсан байдаг.

2.Эд хөрөнгийн тусгаарлагдмал байдал: Зохион байгуулалтын нэгдэл нь олон тооны этгээдүүдийг нэгтгэн хамтын бүрдэл /коллективное образование/ болгоход зайлшгүй шаардлагатай байдаг бол тусгаарлагдсан эд хөрөнгө нь энэхүү бүрдлийн үйл ажиллагааных нь материаллаг баазыг бий болгодог. Дурын практик үйл ажиллагааг ямар нэг хэрэгсэлгүйгээр төсөөлөхөд нэн бэрх юм. Жишээ нь: Техникийн зүйлс, мэдлэг, эцэст нь мөнгөн хөрөнгө гэх мэт. Эдгээр хэрэгслүүдийг нэгтгэн тухайн байгууллагад хамаарагдах нэгэн эд хөрөнгийн цогцолбор болгон бусад этгээдүүдийн эд хөрөнгөөс тусгаарласныг бид хуулийн этгээдийн эд хөрөнгийн тусгаарлагдмал байдал гэж нэрлэдэг.

3. Эд хөрөнгийн бие даасан хариуцлага: Энэ нь тухайн хуулийн этгээдийг үүсгэн байгуулагчид болон хувь нийлүүлэгчид нь тухайн хуулийн этгээдийн үүргийг хариуцахгүй. Хуулийн этгээд нь тэдгээрийн үүргийг хариуцахгүй гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл хуулийн этгээд болгон өөрийн үүргийн дагуу эд хөрөнгийн хариуцлагыг бие даан хүлээнэ. Эд хөрөнгийн хариуцлага хүлээх

---

[436] "Гражданское и торговое право капиталистических государств": Учебник.-3-е изд, перераб. и доп.-М.: Междунар. Отношения,1993.с.75-76

[437] "Гражданское право". Учебник.Часть I. Издание второе, переработанное и дополненное. /Под ред. А.П.Сергеева, Ю.К.Толстого.-М: "Проспект",1997.с.112

[438]Энэ тухай "Гражданское право". Учебник.Часть I. Издание второе, переработанное и дополненное. /Под ред. А.П.Сергеева, Ю.К.Толстого.-М: "Проспект",1997.с.112-115; "Гражданское право".Том1. Учебник / Под ред. Е.А.Суханова.-М.: изд. БЕК,1994. с.77-78; "Российское гражданское право": Учебник. /Под ред.З.Г.Крыловой, Э.П.Гаврилова,-М.: Учебно-консультационный центр "ЮрИнфор",1999.с.24; "Гражданское право". Часть первая: Учебник. / Под ред. А.Г.Калпина, А.И.Масляева.-М.: Юристь,1997.с.74 зэргээс үзнэ үү.

урьдчилсан нөхцөл нь тухайн хуулийн этгээд тусгаарлагдсан эд хөрөнгөтэй байх явдал мөн.

4. Иргэний эрх зүйн харилцаанд өөрийн нэрийн өмнөөс бие даан оролцох: Энэ нь өөрийн нэрийн өмнөөс иргэний эрх зүйн эрх эдэлж, үүрэг хүлээх, мөн түүнчлэн шүүхэд нэхэмжлэгч, хариуцагч байх чадвартай байна гэсэн үг юм.

Харин манай улсын судлаачдын хувьд хуулийн этгээдийн дээрх 4 шинжүүд үндсэндээ байх бөгөөд зарим судлаачид энэхүү 4 шинжид багтсан ойлголтуудыг тусад нь нэг шинж болгох гэх мэтээр өөр өөрийн хувилбараар авч үзсэн байна. Жишээлбэл: Доктор Т.Мөнхжаргал хуулийн этгээдийн шинжид дээрх шинжүүдээс гадна "өөртөө оноосон нэр, хаяг, оршин суух газар, бүртгэлийн гэрчилгээтэй, тамга,тэмдэг, банкинд харилцах данстай, үйлдвэрлэл үйлчилгээ, ажил үүргийн мөрийн хөтөлбөр болсон баримт бичигтэй байх"[439] гэсэн шинжтэй байдаг гэж үзсэн байна. Харин Д.Зундуй дурьдсан сүүлийн шинжийг тусад нь хоёр шинж[440] болгон үзсэн байдаг. Доктор Д.Наранчимэг өмнө дурдсан үндсэн 4 шинжийг таван шинжтэй[441] гэсэн хувилбараар авч үзжээ. Харин хуульч, багш, иргэний хуулийн тайлбар бичих ажлын хэсгийн гишүүн Д.Дүгэржав шинэ Иргэний хуульд орсон хуулийн этгээдийн тодорхойлолт дээр үндэслэн хуулийн этгээдийн үндсэн шинжийг тодорхойлсон байна. Үүнд:

• тусгайлсан хөрөнгөтэй;

• үйл ажиллагаанаасаа гарах үр дагаварыг тусгайлсан хөрөнгөөрөө хариуцдаг;

• өөрийн нэрийн өмнөөс иргэний эрх, үүрэг хүлээдэг;

• шүүх арбитрт нэхэмжлэгч, хариуцагч байж чадах;

• тодорхой зорилго бүхий;

• тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг;

• зохион байгуулалтын нэгдэл[442] зэргийг хамруулжээ.

Тэгвэл хэвлэл мэдээллийн байгууллагад эдгээр шинжүүд бий юу? Энэ талаар хуулийн нарийвчилсан зохицуулалт байхгүй. Өөрөөр хэлбэл нийт хэвлэл мэдээллийн байгууллагын эрх зүйн байдлыг нарийвчлан тодорхойлсон суурь хууль байхгүй. Гэхдээ уг байгууллагын үйл ажиллагаа явуулж буй байдлыг ажиглаж үзэхэд дээрх шинжүүд байдаг.

Хэвлэл мэдээллийн байгууллага нь хуулийн этгээд болох хувьдаа хуулийн этгээдийн ямар төрөлд хамаарах тухайд: Өрнөдийн орнуудад хуулийн этгээдийн төрлийг чанд хуульчилсан байдаг ажээ. Хууль тогтоомж болон онолоор хуулийн этгээдийг нийтийн эрх зүйн хуулийн этгээд, хувийн эрх зүйн хуулийн этгээд гэж ангилдаг. Нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг хувийн эрх зүйн хуулийн этгээдээс ялгах янз бүрийн шалгуур байдаг. Эдгээр шалгууруудын нэг нь тухайн эрх зүйн субъект үүсэх үндэс болсон эрх зүйн актын шинж чанар юм. Нийтийн эрх зүйн хуулийн этгээд нь нийтийн эрх зүйн актын үндсэн дээр үүсдэг бол, хувийн эрх зүйн хуулийн этгээд нь хувийн эрх зүйн актын үндсэн дээр үүсдэг.

[439] Т.Мөнхжаргал "Монгол Улсын иргэний эрх зүй". Ерөнхий анги. УБ, 2000. 93-95-р тал
[440] Д.Зундуй "Монгол Улсын иргэний эрх зүй" / Ерөнхий ба тусгай анги/ . УБ, 2001. 42-р тал
[441] Д.Наранчимэг "Иргэний эрх зүйн үндсэн асуудал". I дэвтэр. УБ, 1999. 14-р тал
[442] Legis хууль зүйн суваг сэтгүүл. 1 сар,2003. 28-р тал

Нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн ялгарах шинж нь гишүүд нь өвөрмөц шинжтэй засаглах эрх мэдэлтэй нийтийн төлөө зорилготой байх явдал юм. нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд төр, засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, төрийн байгууллага, худалдаа аж ахуйн танхим зэрэг нь хамаарна. Олон орнуудад төрийн өмчит аж ахуйн нэгжүүд нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн хэлбэрээр ажилладаг. Нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн нийтлэг шинж нь тусгай зөвшөөрөл шаардагддагт оршино. Зохион байгуулалт, үйл ажиллагааны хүрээ, төлөөлөл зэрэг асуудлууд нь нийтийн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдана.

Монгол Улсын Иргэний хууль "нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар хууль заасан журмаар байгуулагдсанаар үүсч, татан буугдсанаар дуусгавар болох бөгөөд иргэний эрх зүйн харилцаанд бусад оролцогчтой адил тэгш эрхтэй оролцоно" /26.3/ гэж заасан. Нийтийн эрх зүйн хуулийн этгээдүүдийг тодорхой байгууллагын статусыг тодорхойлсон хуулиудад заасан байх нь бий. Гэхдээ нийтийн эрх зүйн хувийн этгээдийн талаар ойлголт бүрэн дүүрэн цэгцрээгүй гэж үзэж болох талтай. Манай орны судлаачдын хувьд хуулийн этгээдийг өмчийн төрлөөр нь нийтийн, хувийн, холимог өмчийн[443] гэж ангилах бөгөөд төрийн, төрийн бус, шашны, хувийн , холимог өмчийн[444] гэсэн хувилбар ч байдаг.

Үүсгэн байгуулах үндэслэлээр нь сайн дурын үндсэн дээр, эрх бүхий байгууллагын шийдвэрээр[445] гэж ангилах бөгөөд гэрээ-дүрмийн[446] үндсэнд байгуулагдах хуулийн этгээдийг хамруулж үзэх тал ч бий. Өмчлөгч буюу үүсгэн байгуулагчийн эрхийн байдлаар нь хуулийн этгээдийн тусгайлсан эд хөрөнгийн хувьд түүний өмчлөгч буюу үүсгэн байгуулагч эд хөрөнгийн эрхээ хадгалдаг /нөхөрлөл, компани, хоршоо[447], өмчлөгчөөс санхүүждэг бусад хуулийн этгээд/, хуулийн этгээдийн тусгайлсан эд хөрөнгийн хувьд түүний өмчлөгч буюу үүсгэн байгуулагч эд хөрөнийн эрхээ хадгалдаггүй хуулийн этгээд /олон нийтийн байгууллага/ гэж ангилна.

Хуулийн этгээдийг эрх зүйн байдлаар нь үндэсний ба гадаадын; зохион байгуулалтын шинжээр нь энгийн ба нийлмэл; эрх зүйн зохицуулалтаар нь нийтийн ба хувийн эрх зүйн хуулийн этгээд гэж ангилдаг. Мөн түүнчлэн гишүүнчлэлийн бүтцээр нь нэг буюу дагнасан гишүүнтэй, хэд хэдэн гишүүнчлэлтэй гэж ангилж болох тухай дурьдсан байдаг[448]. Жишээ нь: компани буюу сан нь дагнасан ганц гишүүнтэй байж болохоос гадна, хоршоо нь 9-өөс доошгүй иргэдийн, холбоо нь 2-оос доошгүй хуулийн этгээдээс

---

[443] Д.Зундуй "Монгол Улсын иргэний эрх зүй" /Ерөнхий ба тусгай анги/ . УБ, 2001. 45-р тал; Д.Наранчимэг "Иргэний эрх зүйн үндсэн асуудал". I дэвтэр. УБ, 1999. 17-р тал

[444] Т.Мөнхжаргал "Монгол Улсын иргэний эрх зүй". Ерөнхий анги. УБ, 2000. 104-р тал

[445] Д.Зундуй "Монгол Улсын иргэний эрх зүй" /Ерөнхий ба тусгай анги/ . УБ, 2001. 45-р тал; Д.Наранчимэг "Иргэний эрх зүйн үндсэн асуудал". I дэвтэр. УБ, 1999. 17-р тал

[446] Т.Мөнхжаргал "Монгол Улсын иргэний эрх зүй". Ерөнхий анги. УБ, 2000. 106-107-р тал

[447] ОХУ-н судлаачид өмчлөгч буюу үүсгэн байгуулагч нь эд хөрөнгийн эрхээ хадгалдаг хуулийн этгээдэд төрийн буюу төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллагыг хамруулан үздэг бөгөөд компани, нөхөрлөл, хоршоог эсрэгээр нь өөрөөр хэлбэл өөрийн тусгайлсан эд хөрөнгийнхөө өмчлөгч нь байна, харин өмчлөгч буюу үүсгэн байгуулагчдын хувьд зөвхөн үүргийн буюу шаардах эрхтэй байдаг гэж үздэг.

[448] Д.Зундуй "Монгол Улсын иргэний эрх зүй" / Ерөнхий ба тусгай анги/ . УБ, 2001. 45-р тал

бүрдсэн байх гэх мэт. Хуулийн этгэздийг үйл ажиллагааны чиглэлээр нь ашгийн төлөө ба ашгийн төлөө бус хуулийн этгээд гэж ангилдаг бөгөөд энэ нь нэлэвд түгээмэл, мөн түүнчлэн практик ач холбогдолтой ангилал юм. Ашгийн төлөө хуулийн этгэзд гэдэг нь үндсэн үйл ажиллагаа нь ашиг орлого олоход чиглэгдсэн хуулийн этгэзд юм. Ашгийн төлөө бус хуулийн этгэзд гэдэг нь үндсэн үйл ажиллагаа нь ашиг орлого олоход чиглэгдээгүй, үйл ажиллагаанаас олсон ашиг орлогыг гишүүддээ хувиарладаггүй хуулийн этгэзд юм. Гэхдээ ашгийн төлөө бус хуулийн этгэзд нь үндсэн зорилгодоо хүрэх, түүнийг хэрэгжүүлэх үүднээс аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж болдог.

Монгол Улсын Иргэний хуульд зааснаар ашгийн төлөө хуулийн этгэздэд нөхөрлөл, компанийг[449], харин ашгийн төлөө бус хуулийн этгэздэд холбоо, сан, хоршоог[450] хамруулж үзсэн бөгөөд эдгээр нь тус бүрдээ хуулийн этгэздийн зохион байгуулалт-эрх зүйн хэлбэрүүд мөн.

Харин хэвлэл мэдээллийн байгууллага хуулийн этгэздийн аль төрөлд хамаарч байгаа нь, мөн түүнчлэн хуулийн этгэзд болох хувьдаа зохион байгуулалт-эрх зүйн хэлбэр нь юу вэ гэдэг нь тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл, хэвлэл мэдээллийн байгууллага бол ашгийн төлөө хуулийн этгэзд байна гэж үзвэл Иргэний хуульд заасан нөхөрлөл, компани гэсэн 2 хэлбэрээр байгуулагдах боломжтой болно.

Гэтэл Хуулийн этгэздийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7.1.1-д "нөхөрлөл, компани, ... хэвлэл мэдээллийн хэрэгслийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, түүний орон нутаг дахь салбар бүртгэнэ" гэж зааснаас харвал хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь нөхөрлөл, компаниас өөр хэлбэр мэт харагдаж байна. Иргэний хуульд нөхөрлөл, компаниас өөр ашгийн төлөө хуулийн этгэздийн хэлбэр хуульчлагдаагүй. Тэгвэл ашгийн төлөө бус хуулийн этгэзд мөн үү? Нэг талаас хэвлэл мэдээллийн байгууллага нь төрийн бус байгууллагын статус байхгүй байна. Учир нь Иргэний хуулийн 33.2-т "Ашгийн төлөө бус хуулийн этгэздийг холбоо, сан, хоршооны хэлбэрээр байгуулна" гэж заасан. Хуулийн этгэздийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7.1.1-д "хоршоо, холбоо, сан, ... хэвлэл мэдээллийн хэрэгслийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, түүний орон нутаг дахь салбар бүртгэнэ" гэж зааснаас харвал хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь хоршоо, холбоо, сангаас өөр хэлбэр юм. Түүнчлэн ашгийн төлөө бус хуулийн этгэздийн хувьд Хоршооны тухай хууль, Төрийн бус байгууллагын тухай[451] гэсэн тусгай хуультай байдаг.

Гэтэл нөгөө талаас бие даасан хуультай тодорхой нэг хэвлэл мэдээллийн байгууллагын хувьд хуулийн этгэздийн төрлийг заасан байна. Ийм хууль Монгол Улсад нэг л байгаа нь Олон нийтийн радио, телевизийн тухай хууль юм. Энэ хуулийн 3.1-д "Олон нийтийн радио, телевиз энэ хуулийн дагуу байгуулагдаж, гагцхүү олон нийтийн эрх ашигт үйлчилдэг, тэдний өмнө хариуцлага хүлээж, хяналт дор нь үйл ажиллагаагаа явуулдаг ашгийн

[449] "Иргэний хууль"-ийн 33.1-р зүйл. 2002-01-10

[450] "Иргэний хууль"-ийн 33. 2.-р зүйл. 2002-01-10

[451] Энэ хууль нам, үйлдвэрчний эвлэл, сүм хийдээс бусад төрийн бус байгууллагад хамаарна /мөн хуулийн 3.1/

төлөө бус хуулийн этгээд мөн" гэж заажээ. Энэ нь Иргэний хуульд заасан ашгийн төлөө бус хуулийн этгээдийн хэлбэртэй зөрж байна. Гэхдээ ОНРТ-ийг хуулиар тусгайлан тогтоосон статус бүхий нийтийн эрх зүйн хуулийн этгээд гэж үзэх боломжтой. Ийм хуулийн этгээд Монгол Улсад хэд хэд бий. Жишээлбэл, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, Монголын улаан загалмайн нийгэмлэг, Худалдаа, аж үйлдвэрийн танхим зэрэг. Ингэд үзэхээр хэвлэл мэдээллийн байгууллага гэж чухам юу вэ? гэдэг нь хууль тогтоомжийн хувьд тодорхойгүй байгаа нь илт байна.

Гадаадын зарим орны жишээг авч үзье. Казахстан улсын Хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай хуулийн 5 дугаар зүйлд "хэвлэл мэдээллийн хэрэгслийг хуулийн этгээдийн хэлбэрээр болон хуулийн этгээдийн бүтцийн нэгжийн хэлбэрээр байгуулж болно" гэж заажээ. Армен Улсын хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай хуулийн 3 дугаар зүйлд Үндсэн ойлголтуудын талаар заасан ба энд хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон мэдээллийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээдийг ялгаа заагтай тусгасан байна.ОХУ-ын Хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай хуульд "Үүсгэн байгуулагч нь редакцийн дүрмийг баталж, гэрээ байгуулна. Редакц нь мэргэжлийн бие даасан байдлын үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулах бөгөөд хуулиар зөвшөөрсөн хуулийн этгээд, бие даасан аж ахуй эрхлэгч субьектын дурын хэлбэртэй байж болно" гэж заасан аж.

Иймд манай улсын хувьд цаашид хэвлэл мэдээллийн байгууллагыг хуулиар зөвшөөрөгдсөн хуулийн этгээдийн хэлбэрээр байгуулах, хуульд энэ талаар зохих хэмжээгээр тусгах нь зүйтэй гэж үзэж байна.

2.2.Хэвлэл мэдээллийн байгууллагын хүлээх хууль зүйн хариуцлагын асуудал

2.2.1. Хууль тогтоомж зөрчсөний улмаас хүлээх хариуцлага

Хэвлэл мэдээллийн байгууллага нь хуулийн этгээд болохыг өмнө нь дурдсан. Эндээс хэвлэл мэдээллийн байгууллага хууль тогтоомж зөрчвөл хуулийн этгээд болох хувьдаа хүлээх хариуцлагын талаар авч үзье. Энд хуулийн этгээдийн эрх зүйн чадвар, чадамжийн асуудал чухал байдаг.

Хуулийн этгээдийн субъект байх чадвар: Хуулийн этгээд нь субъект байх чадвартай байна гэдэг нь эрх зүйн чадвар болон эрх зүйн чадамжтай байх явдал[452] юм. Хуулийн этгээдийн эрх зүйн чадварыг ерөнхий ба тусгай гэж хоёр ангилна.

Хуулийн этгээд нь ерөнхий эрх зүйн чадвартай бол хүний байгалиас заяасан шинж чанартай холбоотойгоос бусад бүх иргэний эрхийг эдлэж, үүрэг хүлээх боломжтой юм.

Харин тусгай эрх зүйн чадвартай бол зөвхөн хууль буюу дүрэмд заасан зорилгодоо хүрэх зайлшгүй шаардлагатай байгаа тэрхүү эрх зүйн харилцаанд оролцох эрхтэй байдаг.

Манай улсын хувьд хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсч, хуульд заасан журмын дагуу татан

[452] Иргэний эрх зүйн зарим судлаачид субьект байх чадварыг эрх зүйн чадвартай адилтгаж үздэг байна. //"Гражданское право". Часть первая: Учебник. /Под.ред А.Г.Калпина, А.И.Масляева.-М.:Юристь, 1997. с.77

буугдаж, улсын бүртгэлээс хасагдсанаар дуусгавар болно[453]. Нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар хуульд заасан журмаар байгуулагдсанаар үүсч, татан буугдсанаар дуусгавар болох бөгөөд иргэний эрх зүйн харилцаанд бусад оролцогчтой адил тэгш эрхтэй оролцоно[454].

Монгол Улсын Иргэний хуульд ашгийн төлөө хуулийн этгээд нь хуулиар хориглоогүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлаагүй аливаа үйл ажиллагаа эрхлэх эрхтэй[455] гэж заасан нь хуулийн этгээдийн ерөнхий чадварыг тодорхойлсон хэрэг билээ. Мөн түүнчлэн хуулийн этгээд нь үүсгэн байгуулагдах баримт бичигтээ өөрсдөө зарим үйл ажиллагаа явуулахыг хориглох замаар чадвараа хязгаарлаж болно.

Хуулийн этгээдийн эрх зүйн чадварын хэмжээ хязгаар нь зөвхөн ерөнхий болон тусгай эрх зүйн чадвараар тодорхойлогддоггүй. Хуулийн этгээд нь зөвхөн хүний онцлог шинжид хамаарах эрхийг эдэлж чаддаггүй байна. Мөн түүнчлэн зарим төрлийн үйл ажиллагаа явуулахад тусгай зөвшөөрөл[456] /лиценз/ шаардагддаг. Хуулийн этгээд хуульд заасан зарим үйл ажиллагааг эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ. Үйл ажиллагаа эрхлэх эрх нь тусгай зөвшөөрөл авсан өдрөөс үүснэ. Мөн түүнчлэн хуулиар зарим төрлийн хуулийн этгээдийн эрх зүйн чадварт хязгаарлалт тавьж болно[457]. Жишээ нь: Даатгалын байгууллагад үйлдвэрлэл, худалдаа,зуучлал болон банкны үйл ажиллагаа эрхлэхийг нь хориглодог.

Хуулийн этгээд нь иргэний эрх зүйн харилцаанд оролцохдоо эрх зүйн чадвартай байгаад зогсохгүй эрх зүйн чадамжтай байх шаардлагатай. Хуулийн этгээд иргэнээс ялгарах нэг онцлог нь эрх зүйн чадвар, чадамж нь нэгэн зэрэг үүсч, нэгэн зэрэг дуусгавар болдог байна. Хуулийн этгээд эрх зүйн чадамжтай байна гэдэг нь өөрийн үйл ажиллагаагаараа иргэний эрх, үүргийг олж авч, хэрэгжүүлнэ гэсэн үг юм. Хуулийн этгээд нь эрх, үүргээ өөрийн байгууллагаараа дамжуулан хэрэгжүүлнэ. Монгол Улсын Иргэний хуульд хуулийн этгээд нь удирдах байгууллагаараа дамжуулан иргэний эрх зүйн харилцаанд оролцоно[458] гэж заасан байдаг.

Энэ утгаараа хэвлэл мэдээллийн байгууллага хууль тогтоомж зөрчвөл хуулийн этгээд болох хувьдаа хариуцлага хүлээнэ. Энэ талаар зарим хуульд тодорхой заасан байна. Жишээлбэл, Садар самуунтай тэмцэх тухай хуулийн 13.2.3-т " ... энэ зөрчлийг нэг жилийн дотор давтан гаргасан бол хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагааг зогсоох захиргааны шийтгэл ногдуулна". УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 35.6-д " ... хэвлэл мэдээллийн болон бусад байгууллагыг ... төгрөгөөр торгоно" гэх мэтээр заажээ.

[453]"Иргэний хууль"-ийн 26.1. 2002-01-10

[454] "Иргэний хууль"-ийн 26.3. 2002-01-10

[455] "Иргэний хууль"-ийн 26.7. 2002-01-10

[456] Е.А.Суханов, В.П.Грибанов нар эндээс хуулийн этгээдийн чадвар нь зорилгын шинжтэй буюу түүний зорилгоос нь хамаардаг гэж үзсэн байдаг. //"Гражданское право".Том1. Учебник / Под ред. Е.А.Суханова.-М.: изд. БЕК,1994. с.79

[457] В.В.Долинская ингэж хязгаарлах нь "завсрын байдал"-ыг үүсгэдэг гэж үзсэн байна. /"Гражданское право". Часть первая: Учебник. / Под ред. А.Г.Калпина, А.И.Масляева.-М.: Юристь,1997.с.78

[458] Иргэний хууль"-ийн 26.4. 2002-01-10

Хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хариуцлагын асуудал яригддаг гол хуулийн нэг бол Иргэний хууль мөн. Иргэний хуулийн 21 дүгээр зүйлд иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах талаар заасан. Ингэхдээ иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол эрх нь зөрчигдсөн этгээдийн шаардлагаар уг мэдээг тараасан хэлбэр, хэрэгсэл, эсхүл өөр хэлбэр, хэрэгслээр няцаах үүрэг хүлээнэ.

Энэ зүйлд заасан эрхийг зөрчсөн этгээд бусдад учруулсан гэм хорыг хохирогч буюу сонирхогч этгээдэд энэ хуулийн 497, 511 дүгээр зүйлд заасан журмын дагуу арилгана гэж заасан. Иргэний хуулийн 497 дугаар зүйл бол гэм хор учруулснаас хариуцлага хүлээх ерөнхий заалт юм. Харин 498 дугаар зүйлд хуулийн этгээд гэм хорыг хэрхэн арилгах талаар заасан. Ингэхдээ ажиллагсад хөдөлмөрийн гэрээ буюу албан тушаалын дагуу хүлээсэн үүргээ гүйцэтгэх явцад гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ээрээ бусдад учруулсан гэм хорын хариуцлагыг түүнийг ажиллуулж байгаа ажил олгогч хүлээнэ гэжээ.

Эндээс сэтгүүлч хэвлэл мэдээллийн байгууллагад ажилтан болох хувьдаа ажиллаж байхдаа нийтлүүлсэн мэдээллээс бусдад гэм хор учирсан бол хэвлэл мэдээллийн байгууллага хүлээнэ гэсэн дүгнэлт гарна. Харин Иргэний хуулийн 21, 511 дүгээр зүйлд заасан "гутаасан мэдээ тараасан этгээд" хариуцлага хүлээхээр байна. Гутаасан мэдээ тараасан этгээд хэвлэл мэдээллийн байгууллага 2 ямагт давхцах уу гэсэн асуудлыг одоохондоо нээлттэй үлдээлээ.

2.2.2. Ёс зүйн хэм хэмжээ зөрчсөний улмаас хүлээх хариуцлага

Нийгэмд хариуцлагын олон төрөл, хэлбэр байдаг. Тухайлбал, эдийн засаг, улс төрийн, ёс суртахууны хариуцлага гэх мэт. Нийгэмд байгаа хариуцлагын тогтолцоонд хууль зүйн хариуцлага онцгой байр суурьтай. Хууль зүйн хариуцлага гэдэг нь хууль буюу эрх зүйн хэм хэмжээг зөрчсөний төлөө гэм буруутай этгээдэд эрхийг хязгаарлах буюу цээрлэл үзүүлэх замаар ёс зүйн болоод эрх зүйн нөлөөлөл үзүүлж буй төрийн болон төрийн бус албадлагын арга хэрэгсэл, тэдгээрийн уялдан холбогдсон систем мөн[459].

Ёс зүйн хэм хэмжээ бол шууд утгаараа эрх зүйн хэм хэмжээ биш боловч эдгээр нь хоорондоо уялдаа холбоотой байдаг. Ёс зүйн хэм хэмжээ зөрчсөний улмаас хүлээх хариуцлагыг эрх зүйн онолд сахилгын хариуцлага гэж нэрлэдэг. Сахилгын хариуцлага гэдэг нь байгууллагын хөдөлмөрийн дотоод журам зөрчсөн буюу хөдөлмөрийн сахилгын зөрчил гаргасан /тэрчлэн ёс зүйн зөрчил үйлдсэн нь байгууллагын хэвийн ажиллагааг алдагдуулсан/ буруутай этгээдэд /ажилтанд/ тухайн байгууллагын захиргаанаас оногдуулж буй хууль зүйн хариуцлагын нэг төрөл мөн. Төрийн зарим албан тушаалтанд /шүүгч, прокурор, цагдаа, цэрэг, эмч, багш/ тухайн мэргэшлийн сахилгын болон ёс зүйн дүрмийг зөрчсөн тохиолдолд сахилгын хариуцлага хүлээлгэнэ.

[459] Д.Баярсайхан. Эрх зүйн онол. УБ, 2010. 183 дахь тал.

Сануулах, цалин хөлс бууруулах, хасах, албан тушаал бууруулах, ажлаас өөрчлөх, халах зэрэг төрөл хэлбэртэй байна[460].

Хэвлэл мэдээллийн байгууллагад хамааран мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээд өөрийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх ёс зүйн дүрэмтэй байдаг. Энэхүү ёс зүйн дүрмээ зөрчсөн нь нэг талаас гэм буруутай этгээдэд сахилгын шийтгэл ногдуулах, нөгөө талаас хуульд заасны дагуу эрх нь зөрчигдсөн этгээдийн гомдлыг барагдуулах үндэс болно. Хэвлэл мэдээллийн байгууллагын хувьд ёс зүйн дүрэм нь мэргэжлийн үйл ажиллагаатай нь холбоотой буюу салбарын хэмжээнд үйлчилнэ. Энэхүү ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэх асуудлыг хэвлэлийн консул буюу зөвлөл хэлэлцдэг /энэ талаар тус судалгааны ажлын Сэтгүүлчийн эрх зүйн байдал гэсэн хэсгээс дэлгэрэнгүй үзнэ үү/.

Дүгнэлт, санал:

Монгол Улсын хувьд хэвлэл мэдээллийн байгууллага хуулийн этгээд байх бөгөөд энэ нь хуулийн этгээдийн ямар төрөл, хэлбэрээр байгуулагдах талаарх эрх зүйн зохицуулалт зөрчилтэй мэтээр харагдаж байна. Иймд цаашид хэвлэл мэдээллийн байгууллагыг хуулиар зөвшөөрөгдсөн хуулийн этгээдийн хэлбэрээр байгуулах боломж бий болгох, хэвлэл мэдээллийн салбарын харилцааг зохицуулдаг суурь хуульд энэ талаар зохих хэмжээгээр тусгах нь зүйтэй гэж үзэж байна.

Гурав. Сэтгүүлчийн эрх зүйн байдал

3.1. Сэтгүүлчийн эрх зүйн байдал

Сэтгүүлчийн үйл ажиллагаанд саад хийх тэр ч бүү хэл эрх чөлөөнд нь төрөл бүрийн шалтгаанаар халдах асуудал гарсаар байгааг төрийн бус байгууллагуудын хийсэн судалгааны дүн харуулж байна. Сэтгүүлчдийг утсаар дарамтлах, заналхийлэх, эрүүл мэндэд нь халдах, доромжлох, албан тушаалаар далайлгах, ажлын багаж хэрэгслийг нь эвдэх, хураан авах зэргээр үйл ажиллагаанд нь саад хийдэг байна.

"Глоб Интернэшнл" төрийн бус байгууллага, Нээлттэй нийгэм форум, Нээлттэй нийгэм хүрээлэнгийн Хэвлэл мэдээллийн бүсийн хөтөлбөрийн дэмжлэгээр 2005 оны 10 сараас сэтгүүлчдийн мэргэжлийн эрхийн зөрчилд мониторинг хийжээ.

[460] Д.Баярсайхан. Эрх зүйн онол. УБ, 2010. 185-186 дахь тал

Сэтгүүлчдийн эрхийн зөрчигдсөн хэлбэрийг оноор нь хүснэгтлэн харуулсныг[461] доор сийрүүлбэл:

Хүснэгт 7

Зөрчлийн хэлбэр	2005 оны 10 сараас 2006	2007	2008	Нийт
Бие эрхтэн, эрүүл мэндэд халдсан	3	3	6	12
Сүрдүүлсэн, дарамталсан, заналхийлсэн, доромжилсон, гэр бүлийн хүнийг дарамталсан	16	7	23	46
Мэдээлэл өгөхөөс татгалзсан	8	10	13	31
Ажлын багаж хэрэгсэлд халдсан	3	3	2	8
Шүүх, хүчний байгууллагын дарамт	2	8	5	15
Нууц эх сурвалжаа илчлэхийг албадсан	3	1	5	9
Нийтлэл, нэвтрүүлэг, ХМХ-ийг хориглосон, эсхүл хориглохыг завдсан	2	1	3	6
Эрүүгийн хэрэг үүсгэсэн, түр саатуулагдсан, хоригдсон	4	4	2	10

2008 онд хэвлэл мэдээлэл, сэтгүүлчдийн эсрэг 59 зөрчил бүртгэгдсэн нь урд оныхтой харьцуулахад 22 тохиолдлоор илүү байна. 2008 онд сэтгүүлчдийн эсрэг зөрчлийн 60 хувийг төрийн албан тушаалтан үйлджээ. Үүнээс долоон хэрэг нь сонгуулийн төлбөрт материалаас болж үүссэн байна.

Эрүүл мэндэд нь халдсан сэтгүүлчдийн дунд хүчиндүүлсэн хоёр сэтгүүлч бүртгэгдсэн. Дээр дурдсан зөрчлийн бүртгэлийг тэд бүрэн гэж үзээгүй байна. Учир нь зарим сэтгүүлч дахин дарамт шахалтад өртөхгүйн тулд мэдээлэхээс айдаг, эсхүл бүртгүүлсэн ч өөрийнх нь тухай мэдээллийг нийтэд ил тод болгохыг хүсдэггүй аж. 2008 онд гэхэд 12 сэтгүүлч зөрчлийнхөө тухай мэдээлсэн ч нийтэд зарлахыг хүсээгүй байна.. Дээрх хүснэгтэд зөвхөн нотлогдсон, баталгаажсан зөрчлийг харуулжээ. Бүртгэгдэж, архивт орсон зөрчлийн мэдээлэл мөн нилээд байгаа юм.[462]

Гадаадын орнуудад ч сэтгүүл зүйн таагүй орчин бий болж буй талаар НҮБ-аас мэдээлж байна. НҮБ өнгөрсөн жил 77 сэтгүүлчийн амь насыг бүрэлгэсэн хэргийг хэлэлцжээ. Тэдний ихэнх нь дайн тулааны талбарт бус, орон нутгийн амьдралыг соён гэгээрүүлж яваад амь үрэгдсэн нутгийн сурвалжлагчид байв. Энэ нь манай оронтой харьцуулж болохуйц ойрхон жишээ гэж хэлж болно. "Глоб интернэшнл" төрийн бус байгууллагад өнгөрсөн жилүүдэд эрхээ хамгаалуулахаар багагүй тооны сэтгүүлчид хандсан бол

[461] http://www.globeinter.org.mn/images/upld/Naraa%20egch%20iltgel.pdf
[462] http://www.globeinter.org.mn/images/upld/Naraa%20egch%20iltgel.pdf

өнгөрсөн жил бараг хандаагүй аж. Ингэсэн шалтгаан нь хэвлэлийн эрх чөлөө хөгжиж буйдаа бус эрхээ хамгаалуулж чадна гэсэн итгэл алдарснаас үүдсэн гэж хэлж болох юм.

ЮНЕСКО"-гийн ерөнхий захирал Ирина Боковагийн хэлсэнчлэн дэлхийн олон улс орон мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг баталсаар байна. Гэвч сэтгүүлчдийн эрх ашгийг хохироосон хэрэг буурахгүй төдийгүй Дэлхийн сонины холбоо өнгөрсөн онд 99 сэтгүүлч амь насаа алдсан гэж мэдээлсэн бол НҮБ-ын Сэтгүүлчдийг хамгаалах хороо өнгөрсөн оны 12 дугаар сарын 1-ний байдлаар 136 сэтгүүлч шоронд хоригдож байгаа, 573 сэтгүүлч баривчлагдсан тухай мэдээлсэн.[463]

Хэвлэл, мэдээллийн хэрэгслийн буюу байгууллагын эрх зүйн статус, "Сэтгүүлчийн статус", сэтгүүлчийн мэргэжлийн эрх, үүрэг" гэдэг асуудал манай хууль тогтоомжид хамгийн бүдэг, бүрхэг тусгагдсан зүйлийн нэг бөгөөд энэ нь томоохон хийдэл байж болох юм. Сэтгүүлч хэмээх хэвлэл мэдээллийн мэргэжлийн ажилтны эрх зүйн статусын гол суурь нь:

• Хараат бус байх зарчим

• Мэдээлэл олж авах, түгээх, мэдээлэлд өөрийн үнэлэмж дүгнэлт өгөх, өөрийн ба болзолт /зохиомол/ нэрээр нийтлүүллэх эрх.

• Мэдээллийн үнэн зөвийг шалгах, түүнийг олж авсан эх сурвалжийн нууцыг хадгалах үүрэг

• Хууль зүй, бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх үүрэг

• Хувийнхаа тайлбар, санаа бодлыг мэргэжлийн үүднээс хариуцах ёс зэрэг болно[464].

Сэтгүүлчдийн үйл ажиллагаандаа баримтлах зарчим:

1. Үнэнийг эрхэмлэж, үнэнийг мэдэх гэсэн олон түмний эрхийг хүндэтгэх нь сэтгүүлч хүний нэн тэргүүний үүрэг мөн.

2. Энэ дагуу үүргээ биелүүлэхдээ сэтгүүлч мэдээ сэлтийг зүй зохисынх нь дагуу цуглуулж, хэвлэн нийтлэх эрх чөлөө, шударгаар хэлж шүүмжлэх эрхийн зарчмуудыг цаг ямагт хамгаалах

3. Сэтгүүлч цаад эх сурвалжаар нь мэдэх зөвхөн тийм л баримтуудад тулгуурлан бичиж, мэдээлж байх. Сэтгүүлч чухал мэдээг нуун дарах юмуу баримт сэлтийг мушгин гуйвуулж болохгүй.

4. Шинэ сэргэг мэдээ, гэрэл зураг, баримт мэтийг олж авахдаа сэтгүүлч гагцхүү шударга аргыг хэрэглэх

5. Аль нэг хэвлэгдсэн зүйл, хор уршиг тарихуйц хуудуутай болох нь нотлогдвол түүнийг засч, залруулахын тулд сэтгүүлч бололцоотой бүхнийг хийх шаардлагатай.

6. Итгэл хүлээж олж авсан мэдээллийн нууцыг сэтгүүлч хадгалж байх

7. Мэдээллийн хэрэгслээр дэвэргэсэн ялгаварлан гадуурхалт ямар аюултайг сэтгүүлч хүн ухамсарлаж, улмаар арьсны өнгө, хүйсийн ялгаа, хэл, шашин шүтлэг, улс төрийн юмуу өөр үзэл бодол, үндэс угсаа, нийгмийн гарал бас бусад шалтгаанаар ялгаж гадуурхахаас сэрэмжлэхийн төлөө чадах бүхнийг хийх.

[463] http://news.2beshare.com/

[464] Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө, Сэтгүүлч ба хууль, цуврал, №3, УБ., 2001 он, 18 дахь тал

Дараах зүйлийг сэтгүүлч мэргэжлийн ноцтой алдаанд тооцно. Үүнд:

- бусдын бүтээлийг хулгайлах;
- үнэнийг санаатайгаар мушгин гуйвуулах;
- бусдыг гүтгэх, нэр төрийг нь гутаах, элдвийн нэр хоч өгч, доромжлох, хүнийг ул үндэсгүй буруутгах;
- баримтыг нийтэд мэдээлэх эсэхийг шийдэхдээ ямарваа нэг хэлбэрээр хээл, хахууль авах;

Сэтгүүлчид эрхэм нэр төрдөө эзэн болж, дээрх зарчмуудыг ёсчлон биелүүлэхийг өөрсдийн үүрэг гэж үзвэл зохино. Тухайн улс орны хуулийн хүрээнд сэтгүүлчид үзэг нэгт нөхдийнхөө асуудлыг зөвхөн мэргэжлийн үүднээс шүүн хэлэлцэхийг хүлээн зөвшөөрнө. Засгийн газар болон бусад эрх мэдэлтэн хөндлөнгөөс оролцох явдал байж болохгүй[465].

Оросын Холбооны Улсын Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тухай хуулийн 5 дугаар бүлэгт сэтгүүлчдийн эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхой хуульчилсан байна. Уг хуулийн 47 дугаар зүйлд Сэтгүүлчийн эрхийг дараах байдлаар хуульчилжээ.

1.Мэдээлэл хайх, шаардах, олж авах, тараах буюу нийтлэн нэвтрүүлэх;

2.Төрийн байгууллага, байгууллага, үйлдвэрийн газар, олон нийтийн байгууллага эсхүл тэдгээрийн хэвлэлийн албанд нэвтрэн орох;

3.Шаардсан мэдээлэлтэй холбоотойгоор албан тушаалтнуудтай уулзах;

4. Төр, аж ахуйн нэгжийн эсхүл хуулиар тусгайлан хамгаалагдсан нууцыг бүрдүүлж буй мэдээллийг агуулсан бичиг баримт, материалаас бусад бичиг баримт, материалыг нээлттэй ашиглах боломжийг олж авах;

5. Оросын Холбооны Улсын Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн шаардлагыг дагаж мөрдөх нөхцөлд баримт материалыг хуулбарлах, нийтлэх, олон нийтэд сонсгох эсхүл бусад аргаар олшруулах;

6. Хуульд зааснаас бусад тохиолдолд тэр дундаа аудио, видеотехник, кино, гэрэл зургийн хэрэгслийг ашиглан бичлэг хийх;

7. Байгалийн гамшиг, аваар болон гамшиг, олон нийтийн эмх замбараагүй байдал бий болсон бөгөөд иргэд олноор цугларсантай холбоотойгоор тусгайлан хамгаалагдаж буй газар, мөн түүнчлэн онц байдал тогтоосон газар нэвтрэн орох; жагсаал, цуглаанд байх;

8. Өөрт нь мэдэгдэж буй мэдээллийн үнэн зөвийг шалгах;

9. Өөрийн нэрийн өмнөөс хариуцах нийтлэл нэвтрүүлгэд зориулсан мэдээ материалд өөрийн хувийн дүгнэлт өгөх;

10. Өөрийн итгэл үнэмшилд харшлах мэдээ, материалыг хариуцан бэлтгэхээс татгалзах;

11. Редакцийн бэлтгэлийн явцад агуулга нь өөрчлөгдсөн гэж үзвэл тухайн мэдээ, материалыг хариуцахаас татгалзах, эсхүл Оросын Холбооны Улсын Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тухай хуулийн 42 дугаар

[465] Брюсельд төвтэй Олон улсын сэтгүүлчдийн холбооны 1954 оны Их Хурлаас баталж, 1986 оны Их Хурлаас шинэчлэн засварласан баримт

зүйлийн нэг дэх хэсэгт заасны дагуу тухайн мэдээ, материалыг хориглох эсхүл бусад байдлаар ашиглах нөхцөл ба шинж чанарыг өөрчлөх;

12. Өөрийн бэлтгэсэн мэдээллийг өөрийн нэрийн дээр, өөр нэрээр эсхүл нэргүйгээр нийтлэн нэвтрүүлэх.

Сэтгүүлч нь олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тухай ОХУ-ын хууль тогтоомжоор олгосон бусад эрхүүдийг эдэлнэ гэжээ. Төрийн байгууллага, байгууллага, олон нийтийн байгууллага нь эдгээр байгууллагын итгэмжлэн төлөөлүүлэх журмыг дагаж мөрдөх нөхцөлд мэдүүлсэн сэтгүүлчдийг итгэмжлэн төлөөлүүлнэ.

Итгэмжлэл төлөөлүүлж буй сэтгүүлчдэд тухайн байгууллага хурал, зөвлөгөөн, бусад арга хэмжээний талаар урьдчилан мэдэгдэх, тенограмм, протокол, бусад баримт бичгээр хангах, бичлэг хийхэд таатай нөхцөлийг бий болгох үүрэгтэй.

Итгэмжлэн төлөөлүүлж буй сэтгүүлч нь хаалттай арга хэмжээ явуулах тухай шийдвэр гарснаас бусад тохиолдолд түүнийг итгэмжилж буй байгууллагын явуулж буй хурал, зөвлөгөөн, бусад арга хэмжээнд оролцох эрхтэй.

Хэрвээ редакц итгэмжлэлийн тогтоосон журмыг зөрчсөн эсхүл сэтгүүлчийг итгэмжилсэн байгууллагын нэр төр, ажил хэргийн нэр хүндийг гутаасан, бодит байдалд нийцээгүй мэдээллийг тараасан бөгөөд энэ нь шүүхийн хүчин төгөлдөр болсон шийдвэрээр тогтоогдсон бол сэтгүүлчийн итгэмжлэлийг хүчингүй болгоно.

Оросын Холбооны Улсын Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тухай 49 дүгээр зүйлд сэтгүүлчдийн хүлээх үүргийг хуульчилжээ. Үүнд:

1. Хөдөлмөрийн гэрээ болон редакцийн дүрмийг дагаж мөрдөх

2. Өгч буй мэдээллийн үнэн зөв байдлыг шалгах

3. Мэдээллийн эх сурвалжийг заах тухай, мөн түүнчлэн зохиогчийн нэрийг заах тухай мэдээлэл олгосон этгээдийн хүсэлтийг хангах

4. Мэдээлэл ба түүний эх сурвалжийн нууцыг хадгалах

5.Иргэний хувийн амьдралын тухай мэдээлэлийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлэхэд өөрөөс нь эсхүл түүний хууль ёсны төлөөлөгчөөс зөвшөөрөл авах

3.2. Мэдээллийн эх сурвалжийн нууцлалын асуудал

Ардчилсан орны улс төр, олон нийтийн зүтгэлтнүүд өөрийнх нь хувийн нууцад жирийн хүмүүсийнхээс илүү халдана, албан тушаал нь өндөр, чухал байхын хэрээр шүүмжлэл, мэдээлэлд илүү ихээр өртөнө гэдгийг хүлээн зөвшөөрдөг байна. Нэг талаас үзэл бодлын эрх чөлөө болон олон нийтийн аливааг олж мэдэх эрх, нөгөө талаас хувийн нууцын эрх хоёрыг дэнсэлж үзвэл "нийгмийн хоточ нохой" байх хэвлэлийн үүрэг илүү давуу болохыг Европын зарчимд баримталдаг ажээ. Австрали, Голланд, Швед, Герман, Америк, Норвеги, Франц зэрэг улсад сэтгүүлчид төр, засгийн мэдээллийн санд буй, төрийн нууцад хамаарахаас бусад бүх мэдээлэлд нэвтэрч, үзэж танилцах хууль ёсны эрх эдлэдэг байна[466]. Сэтгүүлчдийг онцгой эрхгүй харин

[466] Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө, Сэтгүүлч ба хууль, цуврал, №3, УБ., 2001 он, 60 дахь тал

онцгой үүрэгтэй гэж үздэг. Нууц эх сурвалж буюу мэдээлэгчээ хамгаалах нь сэтгүүлчийн онцгой үүрэг юм.

2007 онд "Глоб Интернэшнл" төрийн бус байгууллагаас нууц эх сурвалжтай харилцах хэлбэр, нууц эх сурвалжаа хамгаалахад тохиолдох саад бэрхшээл, түүнд эрүүгийн хуулийн гүтгэх, доромжлох заалтууд хэрхэн нөлөөлж байгааг үнэлэх зорилгоор мэдээ, нийгэм, улс төрийн чиглэлээр идэвхтэй ажилладаг 203 сэтгүүлчийг хамарсан судалгаа хийсэн юм. Судалгаанд 72 эрэгтэй, 131 эмэгтэй сэтгүүлч хамрагдсан. Судалгаанд хамрагдсан 203 сэтгүүлчийн 13 хувь нь нууц эх сурвалжийг тогтмол ашигладаг, 40 хувь нь нийтлэл, нэвтрүүлгийнхээ ихэнх хувьд нь ашигладаг, 43 хувь нь шаардлагатай үед, цөөн тохиолдолд ашигладаг ажээ.

Харин сэтгүүлчдийн 4 хувь нь нууц эх сурвалжтай харьцдаггүй байна. Улаанбаатар хотын сэтгүүлчид хөдөө орон нутгийнхнийг бодвол нууц эх сурвалж ашиглах тохиолдол бараг 2 дахин их байна. Хэвлэл мэдээллийн байгууллагын хэлбэрээр авч үзвэл, сонины сэтгүүлчид бусад хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлчдийг бодвол нууц эх сурвалжид түлхүү тулгуурладаг ажээ. Монголд эрэгтэй сэтгүүлчид эмэгтэйг бодвол нууц эх сурвалжийг илүү ашигладаг байна. Мөн хэвлэл мэдээллийн салбарт 2-3 жил ажиллаж буй сэтгүүлчид нууц эх сурвалж ашиглах нь түгээмэл байдаг.

Нууц эх сурвалж ашигладаг 195 сэтгүүлчийн 45,6 хувь нь мэдээлэл ямар ч тохиолдолд найдвартай санагддаг, 43,1 хувь нь өөр аргаар мэдээлэл олж авах боломжгүй үед ашигладаг ажээ. Нууц эх сурвалж тогтмол болон их ашигладаг сэтгүүлчдийн хувьд эх сурвалжийн найдвартай байдал нь илүү чухал, ач холбогдолтой бол цөөн ашигладаг сэтгүүлчдийн хувьд мэдээлэл олж авах боломжгүй байдал нь нууц эх сурвалжийг ашиглах шалтгаан болж байна. Нууц эх сурвалж ашигладаг 195 сэтгүүлчийн 62 хувь нь тэдний өгсөн мэдээлэлд итгэлтэй байдаг хэдий ч үргэлж нэмэлт эх сурвалжуудаар шалгаж баталгаажуулдаг, харин 9 хувь нь нууц эх сурвалжийнхаа өгсөн мэдээлэлд бүрэн итгэлтэй байдаг учир шалгадаггүй, 20 хувь нь олон нийтийн эрх ашигт нийцсэн мэдээллийг нийтэд дэлгэдэг гэжээ. Харин 4 хувь нь нууц эх сурвалжийнхаа өгсөн мэдээлэлд итгэдэггүй ч түүнийг ашиглах шаардлага гардаг гэсэн байна. 195 сэтгүүлчийн 70 хувь нь нууц эх сурвалждаа амлалт өгдөггүй гэжээ. Тэдний 52.3 хувь нь итгэлцлийн үндсэн дээр эх сурвалжтайгаа харилцдаг бол 12.8 хувь нь гэрээ хэлэлцээ хийдэг ажээ. Тогтмол нууц эх сурвалжид үндэслэдэг сэтгүүлчдийн 69 хувь нь тухайн мэдээллийг илчлэх зорилгыг нь үргэлж асуудаг бол, 31 хувь нь асуудаггүй гэжээ.

Сэтгүүлчдийн 41 хувь нь эх сурвалжаа хамгаалж, илчлэхгүй байж чадна гэдэгтээ итгэлгүй байна. Сэтгүүлчдийн нууц эх сурвалж илчлэгдсэн тохиолдолд 56.4 хувь нь ажилгүй болох, 39 хувь нь амь нас, эрүүл мэндээрээ хохирох, 32.8 хувь нь нэр хүндээ алдах, 16.4 хувь нь ар гэрийнхэндээ эрсдэл учруулах, 7.7 хувь нь эд хөрөнгийн хохирол амсахаас айж эмээдэг байна. Судалгаанд хамрагдсан сэтгүүлчдийн 38 хувь нь нууц эх сурвалжаа илчлэх албадлагад өртөж байжээ. Энэ нь Улаанбаатар хотод 37 хувь, орон нутагт 48 хувьтай байна. Тэдгээр 74 сэтгүүлчийн 39.4 хувьд цагдаа, 29.7 хувьд шүүх, 43.2 хувьд улс төрч, төрийн байгууллага, 10 хувьд Тагнуулын ерөнхий газар,

35.2 хувьд хувь хүн, улс төрийн нам, хүчин нууц эх сурвалжаа илчлэхийг шаардаж байжээ. Мөн 6.8 хувьд ийм шаардлага төрийн бус байгууллага, олон улсын байгууллагаас тавьсан байна.

Эдгээр сэтгүүлчийн 23 хувь, өөрөөр хэлбэл 45 сэтгүүлч буюу 4 сэтгүүлч тутмын нэг нь мэдээллийнхээ нууц эх сурвалжийг илчилж байжээ. Тэдгээрийн ихэнх нь буюу 40.9 хувь нь шүүхийн шаардлагаар нууц эх сурвалжаа илчилжээ. Үүнийхээ шалтгааныг тэд аюулгүй байдлаа хангах /28.9 хувь/, шүүх байгууллагын шахалт, сүрдүүлэгт автсан /24.4 хувь/, ажлаасаа халагдахгүйн тулд /20 хувь/, мөн цөөн хувь нь шүүх, хүчний байгууллагын эх сурвалжийг нууцлах амлалтад итгэсэн, шоронд хоригдох, ял эдлэхгүйн тулд гэх зэргээр тайлбарласан байна. Нууц эх сурвалжийн өгсөн мэдээллээс шалтгаалан сэтгүүлчдийн 29 хувь эрүүгийн хэрэг, иргэний маргаанд холбогдож байжээ. Сэтгүүлчдийг нууц эх сурвалжийнхаа өгсөн мэдээлэлтэй холбогдуулан шүүх хуралд гэрчээр дуудаг практик байгаа нь судалгаагаар харагдсан байна. Судалгаанд хамрагдсан сэтгүүлчдийн 15 хувь буюу 31 сэтгүүлч гэрчээр дуудагджээ[467]. Нууц эх сурвалжаа илчлэх албадлагад ертсөн жишээг дор дурдав. Ховд аймгийн "Ховдын мэдээ" сонин мэдээллийн нууц эх сурвалжид тулгуурлан 6 дугаар дунд сургуулийн захирал Д.Цэрэг шинээр ажилд орсон багш нараас 500.0 мянган төгрөгийн хахууль авсан тухай гурван удаа нийтэлжээ. Хожим нь энэ тухай материал өдөр тутмын "Зууны мэдээ" сонинд гарсан байна. Хахууль авсан, өгсөн аль алиныг нь илчилсэн энэхүү нийтлэл гарсны дараа хахууль өгсөн хэмээн нэр нь дурдагдсан нэр бүхий багш нар "Ховдын мэдээ" сонины редакц дээр ирж "Энэ мэдээллийг бичихээс өмнө бидэнд үзүүлэх ёстой. Таныг шүүхэд өгч нэрээ төрөө сэргээлгэнэ. Бичсэн эх сурвалжаа хэлэхгүй бол танай хаалганы дэргэд ирж жагсаж хэвтэнэ" гэж сүрдүүлэн одоохон эдгээр хүнийг хахууль өгөөгүй гэж залруулга хий гэж шаардсан. Дараа нь захирал Х.Цэрэг сонины өрөөнд ирж "Улс орон даяар тараагддаг төвийн хэвлэлд цацагдлаа. Энэ мэдээллийг хэн өгсөн бэ?" гэж нууц эх сурвалжаа илчлэхийг шаардсан байна. Монголд сэтгүүлчдийг нууц эх сурвалжаа илчлэхийг албадах нь хэвийн үзэгдэл аж. Сэтгүүлчийн эх сурвалжийг нууцлах үүрэг хуульчлагдаагүй. Гомдол гаргаж буй хүмүүс хамгийн түрүүнд "Энэ мэдээллийг хэн өгсөн бэ?" гэж асуудаг. Ихэнх тохиолдолд сэтгүүлчдийг эрүүгийн хэрэг үүсгэн шалгах, баривчлах, хорихоор далайлган сүрдүүлдэг. Мөн гэр бүлийн гишүүдийг нь ч дарамталдаг. Үүний улмаас сэтгүүлчид эх сурвалжаа илчлэх тохиолдол гардаг. Дийлэнх сэтгүүлч энэ тухай мэдээллийг ил болгохоос эмээдэг учир таван тохиолдол л бүртгэгджээ. Сэтгүүлчдийг байнга сүрдүүлж, заналхийлдэг нь аюулгүй байдалд хор уршигтай. Ялангуяа утасдаж дарамтлах нь элбэг байдаг байна. 2008 онд ийм тохиолдол 19 бүртгэгдсэнээс ихэнх нь утсаар заналхийлжээ. Дахин дарамтлуулахаас айдаг учир тэд энэ тухай олон нийтэд мэдээлэхийг хүсдэггүй байна[468].

[467] http://www.globeinter.org.mn/images/upld/Naraa%20egch%20iltgel.pdf

[468] Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тайлан. 2008 он. Глоб интернэшнл ТББ

3.3. Онц байдал

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 2-т Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно гэсэн заалт бий. Энэ заалт нь Онц байдлын тухай хуульд тусгалаа олсон байх ба олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд хяналт тогтоох, эсхүл онц байдлыг цуцлах хүртэл үйл ажиллагааг нь хориглож болно гэсэн заалттай. НҮБ-ын анхдугаар чуулганы 59 дүгээр тогтоолд үзэл бодлоо илэрхийлэх нь хүний язгуур эрх бөгөөд энэ нь НҮБ-аас эрхэмлэдэг хүний бусад эрхийн үндсэн хэмжүүр мөн гэж заасан. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйлд үзэл бодлоо илэрхийлэх, мэдээллийн эрх чөлөөг хязгаарлаж болно. Гэхдээ үүнийг хуулиар тогтооно гэж заасан. Энэ бүхнээс харахад мэдээллийн эрх чөлөөг тухайн нөхцөлд тодорхой хэмжээгээр хязгаарлаж болно гэсэн хууль зүйн үндэслэл харагдаж байна. Гэвч Онц байдлын тухай хуулийг хэтрүүлсэн гэж зарим судлаач үзсэн байна. Учир нь хүний итгэл үнэмшил, үзэл бодлоо илэрхийлэх хоёр салшгүй холбоотой.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаанд Засгийн газар хяналтаа тогтоовол өөрийн хүссэн мэдээллийг ОНРТ-ээр дамжуулан цацна. Энэ нь иргэдийг мэдээлэл авах эрхийг нь хаах, хэвлэл мэдээллийн байгууллагад ажиллаж байгаа сэтгүүлчийг төр өөрийн мэдэлд хүчээр шахалт үзүүлэн мэдээлэл бэлтгүүлэн нийтэд хүргэж байгаа хэрэг болохоос гадна хэвлэл мэдээллийн эрх чөлөөг маш ноцтой зөрчсөн үйлдэл болно. Хэдэн жилийн өмнө Киргизэд "Алтан зулын хувьсгал" гэж гарахад эрх баригчид нь мэдээллийн хэрэгслүүдийн үйл ажиллагааг шууд зогсоож байсан. Харин ардчилсан орнуудад бол онц бөгөөд дайны байдлын үед олон нийтийн радио, телевизээ түлхүү ажиллуулдаг туршлага байдаг байна. Өмнө нь жагсаал цуглааны үед сэтгүүлчийн мэргэжлийн эрхэд халдсан тохиолдол нэг бус тохиолдож, сэтгүүлчид тэр бүрт хохирч үлдсэн. Онц байдал зарласан үед сэтгүүлчид мэргэжлийн эрхээ яаж хэрэгжүүлэх вэ гэдэгт туршлага ч, мэдлэг ч дутмаг байдаг. Онц байдал зарлахад зарим сэтгүүлчдийн тархи нь хагарсан, гэмтэл бэртэл авах, цагдаа нарын ашигласан нулимс асгаруулагч хийд хордон тухайн үед ухаан алдаж унасан, жижиг гэмтэл авсан сэтгүүлчид байсан. Сэтгүүлчид ямар ч хамгаалалтгүй л ажиллалаа. Ядаж хантааз өмссөн сэтгүүлч нэг ч байсангүй. Сэтгүүлч гэдгийг нь ялгах ямар ч хувцас, онцгой таних тэмдэггүй байж байна. Редакцийн зүгээс сэтгүүлчдийнхээ аюулгүй байдлыг хангах хэрэгтэй. Ийм үед аюулгүй байдлаа яаж хангаж ажиллах вэ гэдэг талаар заавар зөвлөмж өгч байх ёстой. Ихэнх телевиз сэтгүүлчдээ татаж авсан. Сэтгүүлчдээ хамгаалж байгаа нь сайн ч нийгэм үнэн зөв мэдээллийг авах ёстой[469] гэж судлаач Наранжаргал бичжээ. Телевизийн үйл ажиллагааг түр зогсоохдоо хуулийн өмнө эрх тэгш байх зарчмыг алдагдуулж болохгүй тул сэтгүүлчид үнэн зөв мэдээлэл өгөх үүрэгтэй. Онц байдал зарласан үед Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хязгаарлалт ямар байсан талаар ХЗҮХ-ийн ЭША Г.Оюунболд: "ОНРТ-ээс бусад телевизийн үйл ажиллагааг онц байдал зарласан хугацаанд хориглосон. Хэвлэл

[469] Өдрийн сонины 2008 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн дугаарт

мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааг хязгаарласан нь хууль зөрчсөн гэж зарим хуульч үздэг. Олон нийтийн мэдээллийн хэрэгслийг хаах шаардлага байсан. Үндэсний олон нийтийн телевизээс бусад телевизийн үйл ажиллагааг онц байдал тогтоосон дөрөв хоногийн хугацаагаар түр зогсоох арга хэмжээ авсан. Бусад FM болон сонин хэвлэлүүдийг энэ хязгаарлалтад огт хамруулаагүй. Арилжааны телевизүүдийн үйл ажиллагааг хязгаарлаж, Үндэсний олон нийтийн телевизийг үлдээсэн нь уг телевизийг олон нийтийн статустай, тэнцвэртэй, бодитой мэдээлэл хүргэх үүргийг хуулиар хүлээсэн мэдээллийн хэрэгсэл гэдэг үүднээс хандсан. Үндсэн хуульд ч онц байдал зарласан тохиолдолд хүний эрх, эрх чөлөөг хуулиар хязгаарлаж болохыг заасан байдаг. Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заахдаа "Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө" гэжээ.

Ингэхдээ тэр хязгаарлалтад хамааруулж болохгүй эрхүүдийг тоочин заасны дотор хэвлэл мэдээллийн хэрэгслийн эрх чөлөөний талаар дурьдаагүй. Энэ нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг онц байдлын үед түр хязгаарлалт хийхийг зөвшөөрөх үүднээс хийсэн зохицуулалт гэж үзэж болно. Сэтгүүлчид онц байдал зарласан тохиолдолд албан үүрэгтээ хариуцлагатай хандаж байх шаардлагатай байна. Ингээгүйгээс хүний эрхийг зөрчих хандлага гарч болох юм. АНУ-ын нэгэн сэтгүүлч үймээн самуун гарсан үед сайн дураараа гал унтраасан хүний зургийг сонингийн нүүрэн дээр тавьсныг нотлох баримт болгож, цагдаа нар түүнийг барьж хорьж байсан. Мөн хэвлэл мэдээллийн хэрэгслийн нүүр хуудас болон мэдээллийн оршил болгож график дизайны аргаар хийсэн аймшигт үйлдлийн холбогдолтой зургийг нийтлэлж болохгүй. Ийм зургийг хараад 4 хүнийг хоёр нь гайхалтай зураг байлаа гэсэн байхад 2 нь үймээн самуунд ҮРУУ татах сэтгэгдэл төрүүлэхүйц, horrible буюу ой гутам зураг тавьсан байна гэж шүүмжилдэг байна. Үнэхээр онц байдал зарлах болсон шалтгааныг үнэн бодит байдлаар нь хүргэх ёстой. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ялангуяа телевизээр аймшигт байдал тухайлбал бөмбөг дэлбэлэх зэргийг үзүүлэхэд хүүхдийн сэтгэл зүйд хүчтэй нөлөөлдөг.[470] Иймд болсон нөхцөл байдлыг хүмүүсийн сэтгэл зүйд хэт нөлөөлөхүйц байдлаар хүргэх шаардлагагүй гэж үзэж болохоор байна. Шархадсан хүмүүсийн талаар шууд нэвтрүүлэх үүрэгтэй. АНУ-д онцгой нөхцөл байдалд шархадсан хүмүүсийг газар дээр нь сурвалжилдаг[471]. Ингэснээр ар гэрийнхэн нь мэдэж, эмнэлэгт очих, түүний талаар мэдээллийг эмнэлэг болон цагдаагийн байгууллагад мэдээлэх, хаягийг тодорхойлох, ямар эм бодисоос харшилтай зэргийг шуурхай мэдэхэд ач холбогдолтой юм.

[470] http://www.loc.gov/rr/frd/
[471] Мөн тэнд

3.4. Хэвлэлийн зөвлөл ба сэтгүүлчийн ёс зүй

Хэвлэлийн зөвлөл гэдэг нь Сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мөрдүүлэх, нөгөөтэйгүүр сэтгүүлчдийг хамгаалах, сэтгүүлчийн нэрээр хаягласан гомдлыг шүүхийн өмнөх шатанд эвлэрүүлэх журмаар шийддэг байгууллага[472]. Үгийн үндсийг хайвал консул гэдэг нь үг нь Англи хэлний Council хэмээх үг бөгөөд үүнийг Монгол хэлнээ үг зүйн талаас нь Зөвлөл[473] гэж орчуулдаг. Утга зүйн талаас нь "Үйл ажлыг хамтран хэлэлцэх хурал зөвлөгөөний газар, хамтаар удирдах байгууллага"[474], "зөвлөх, захиргаа болон хууль эрх зүйн үйл ажиллагаа явуулахаар тусгайлан сонгогдсон буюу үүрэг бүхий этгээдүүдийн нэгдэл"[475]-ийг хэлдэг. Иймд үг болон утга зүйн хувьд дүйж байгаа байдлаар нь зөвлөл гэж нэрлэж хэвших нь зөв юм.

Хэвлэлийн консулын талаарх гадаад орнуудын туршлага

Эрх зүйн бүлээс үл хамаарч дэлхий дээр нийтдээ 54 улсад 73 Хэвлэлийн консул ажиллаж байна. Тэдгээрийн нийтлэг шинж нь үйл ажиллагааны санхүүжилт нь гишүүдийн татвараас бүрддэг байна. Мөн гадаад орны хандивлагч байгууллагуудаас хандив тусламж авах явдал бий. Энэ нь эдийн засгийн хувьд төрөөс хараат бус байдлыг илтгэдэг. Түүний үйл ажиллагаа болон хэрэг маргаан шийдвэрлэх эрх зүйн эх сурвалж буюу ёс зүйн дүрэм нь нийтэд болон салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн байдал юм.

Монгол Улс хэвлэлийн консултай /зөвлөл/ байх асуудал

Манай орны хувьд Хэвлэлийн консул /зөвлөл/ нь шинэ асуудал биш бөгөөд урьд нь энэ чиглэлээр сэтгүүлчдийн дунд уулзалт хэлэлцүүлэг зохиогдож байсан бөгөөд харьцуулсан судалгаа ч хийгджээ. Гэвч үүнийг цааш ажил хэрэг болгох талаар дорвитой ажил хийгдээгүй өдий хүрсэн байна. Энэ нь 1998 онд батлагдсан "Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай" хуульд хэвлэлийн зөвлөл болон хэвлэл мэдээллийн салбарын өөрийн зохицуулалтын талаар огт тусгаагүйтэй холбоотой байж болох юм. Өөрөөр хэлбэл, хэвлэлийн консул /зөвлөл/-ыг хэрхэн, хаанаас байгуулах, хичнээн хүний бүрэлдэхүүнтэй байх, гишүүд нь ямар хугацаатай сонгогдох зэрэг асуудлын хууль зүйн үндэслэл бүрдээгүй байгаа нь өдийг хүртэл ийм байгууллага байхгүй байгаагийн хамгийн том шалтгаан юм. Нэгэнт түүний эрх зүйн үндэс байхгүй бол хууль зүйн хувьд хүчин чадалгүй, нийтэд хүлээн зөвшөөрөгдөхгүй гэсэн үг.

Манай улсын хувьд МСНЭ-ийн бүтцэд хэвлэлийн консул /зөвлөл/-ийг байгуулах боломжтой юм. Учир нь уг төрийн бус байгууллага одоогоор эгнээндээ 3000 гаруй сэтгүүлчийг нэгтгэсэн, тухайн салбартаа хамгийн өргөн бүрэлдэхүүнтэй гэж тооцогддог. Нөгөө талаас энэ байгууллагад сэтгүүлч

---

[472]http://www.forum.mn/index.php?sel=resource&f=resone&obj_id=615&menu_id=3&resmenu_id=59, Хэвлэлийн өөрийгөө зохицуулах механизм буюу Хэвлэлийн Консулуудыг харьцуулсан судалгаа

[473] Д.Алтангэрэл, Англи-Монгол толь, УБ хот, 2002 он,.88 дахь тал

[474] Монгол Улсын ШУА, Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь II Д-Л,УБ хот, 2008 он,. 1020 дахь тал

[475] http://dictionary.reference.com/browse/council

мэргэжлийн үүднээс гишүүнээр элсдэг бол салбарын бусад ТББ-ууд нь тодорхой байгууллагуудын нэгдлээс бүрдсэн байдаг. /Жишээ нь: Монголын телевизүүдын холбоо/ Хэвлэлийн консул /зөвлөл/-ыг хэрэг маргааныг урьдчилан шийдвэрлэх чиг үүргийн хувьд төрийн албаны салбар зөвлөл, татварын маргаан таслах зөвлөлийн туршлагатай харьцуулан жишиж авч үзэх боломжтой. Гэхдээ бүрэлдэхүүнийг зөвхөн иргэний нийгмийн байгууллагын төлөөллөөс сонгох нь хамгийн оновчтой хувилбар бөгөөд ингэхдээ мэргэжил болон мэргэшлийн шаардлага тавьж болно. Гадаадын зарим орны туршлагаас харвал зөвлөлийн бүрэлдэхүүнд шүүгч орсон тохиолдол байдаг. Жишээлбэл, Данийн Хэвлэлийн[476] консулын даргаар Дэзд Шүүхийн шүүгч Нельс Груббе ажиллаж байна[477].

Гэвч үүнийг манай орны хувьд шууд авч хэрэглэх боломжгүй. Учир нь шүүгч оролцсон урьдчилан шийдвэрлэх ажиллагааны шийдвэрийг шүүхээр хянуулах тохиолдолд тухайн шүүгч дахин шийдвэрлэх магадлалтай учир "сонирхлын зөрчил" үүсч болно. Нөгөө талаас зөвлөлийн шийдвэрийг эцсийнх гэж үзэж болохгүй. Иргэн уг шийдвэрийг шүүхээр шийдвэрлүүлэх эрх нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт баталгаатай эдлэхээр заагдсан тул хязгаарлах боломжгүй.

Гадаад орнуудын туршлагаас харахад ийм консул /зөвлөл/ салбартаа зөвхөн ганц байдаг бөгөөд түүнийг бусад нь хүлээн зөвшөөрдөг. 2006-2009 оны хоорондо нийслэлийн анхан шатны шүүхүүд Иргэний журмаар нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндтэй холбоотой нийт 129[478] хэрэг маргааныг шийдвэрлэсэн байна. Энэ нь жилд дунджаар 32 орчим хэрэг шийдвэрлэдэг гэсэн үг юм. Үүнээс үзвэл Хэвлэлийн зөвлөлийг байнгын ажиллагаатай бус хувилбараар байгуулах боломжтой нь харагдаж байна.

Сэтгүүлчийн ёс зүй

1978 онд ЮНЕСКО-ийн ивээл дор зохион байгуулагдсан зөвлөлдөх уулзалтын дараа өөр өөр улсын 400 мянган сэтгүүлчийг эгнээндээ нэгтгэсэн олон улсын болон бүс нутгийн байгууллагууд нэгдсэн билээ. Хоёр дахь зөвлөлдөх уулзалт нь /1980 онд Мехикод болсон/ хүний эрхийг хөгжүүлэх, дайнд уриалан дуудах, апартейд, арьс өнгөөр ялгаварлан гадуурхахын эсрэг дэлхий дахины болон олон улсын харилцан ойлголцлыг бэхжүүлэхэд олон нийтийн мэдээллийн хэрэгслийн гүйцэтгэх үүргийн үндсэн зарчмын тухай ЮНЕСКО-ийн Тунхаглалд шийдвэртэй дэмжлэг үзүүлсэн юм.

Дөрөв дэх зөвлөлдөх уулзалт 1983 онд Парис болон Прагад болж өнгөрсөн бөгөөд уг уулзалтаар хүний эрх чөлөөний бүрэлдэхүүний чухал хэсэг нь үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах эрх чөлөөг хангах явдал ба энэ нь энх тайвныг болон олон улсын харилцан ойлголцлыг бэхжүүлэх чухал хүчин зүйл болдог талаар ЮНЕСКО-ийн Тунхаглалын үнэ цэнийг тэмдэглэсэн байна. Түүнээс гадна уг уулзалт дээр олон нийтийн

[476] Дурдсан судалгаа, 2 дахь тал

[477] Дам ишлэв. http://www.forum.mn/index.php?sel=resource&f=resone&obj_id=615&menu_id=3&resmenu_id=59, Хэвлэлийн өөрийгөө зохицуулах механизм буюу Хэвлэлийн Консулуудыг харьцуулсан судалгаа. 12 дахь тал

[478] Судалгааны хүрээнд нийслэлийн шүүхээс ирүүлсэн мэдээ

мэдээллийн хэрэгсэл болон сэтгүүлчийн нийгмийн хариуцлага нь нийгэмд томоохон үүрэг гүйцэтгэж байдаг талаарч авч хэлэлцсэн байна.[479] Эдгээр зөвлөлдөх уулзалтаас "Сэтгүүл зүйн олон улсын мэргэжлийн ёс зүйн зарчим"-ыг батлан гаргасан байна. Энэхүү баримт бичиг нь 10 зарчмаас бүрддэг. ОХУ 1994 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн сэтгүүлчдийн бүгд хурлаараа "Оросын сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүйн дүрэм"-ийг сайшаан дэмжсэн байна.[480] Мөн "Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тухай" ОХУ-ын хуулийн 47 дугаар зүйлд сэтгүүлчийн эрхийг, 49 дүгээр зүйлд үүргийг тодорхойлон хуульчилж өгсөн байна.

Өнөөгийн байдлаар манай улсын хэвлэл мэдээллийн салбарт сэтгүүлчийн ёс зүйн дүрэм гэсэн нэгдсэн баримт бичиг байдаггүй. Харин 2005 оны 3-р сарын 11-ний өдөр хуралдсан Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэлийн II их хурлаас 10 зүйлтэй "Монголын сэтгүүлчдийн ёс зүйн зарчим"-ыг батласан ба уг баримт бичгийн эхэнд "Мэдээлэл авах, уг хэлэх эрх чөлөө бол хүний үндсэн эрх гэдгийг дээдэлж, сэтгүүлчийн эрх үүргээс нийгмийн өмнө хүлээх хариуцлага ямагт дээгүүр байх ёстойг эрхэмлэж, Монголын Сэтгүүлчид дараах ёс зүйн зарчмыг өөрсдийн мэргэжлийн хэм хэмжээ хэмээн тунхаглаж байна" гэжээ. Хэдийгээр сэтгүүл зүйн салбарт тодорхой хэм хэмжээ тогтоох оролдлого гарч байгаа нь сайшаалтай боловч түүнийг тухайн салбарт хүлээн зөвшөөрөгдсөн, хууль зүйн хүчин чадалтай болгох нь дутагдалтай байгаа юм. Өөрөөр хэлбэл Сэтгүүлчийн ёс зүйн дүрмийг ямар субъект хэрхэн батлах, түүнд хэн хяналт тавих, ямар хариуцлага хүлээлгэх зэрэг асуудлыг "Хэвлэлийн эрх чөлөөний тухай" хуульд "суулгана" гэсэн санаа юм. Үүнийг хэвлэлийн өөрийн зохицуулалтын эрх зүйн үндэс гэнэ.

Өнөөгийн байдлаар хэвлэл мэдээлийн салбарт нэгдсэн дүрэм нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ байхгүй, тийм эрх зүйн орчин бүрдээгүйн улмаас Эрүүгийн болон Иргэний хуулиар хэрэг маргааныг шийдвэрлэж байна. Түүнчлэн шүүх байгууллага нь асуудлыг зохицуулсан хэм хэмжээ байхгүй гэсэн үндэслэлээр аливаа хэргийг буцаах, хэрэгсэхгүй болгох, шийдвэрлэхгүй байх эрхгүй байдаг. Хэвлэл мэдээллийн салбарт хийсэн зарим судалгаанаас харахад сэтгүүлчдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь буруу гэжээ Хэвлэлийн Консул нь хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах, сэтгүүлчдийг шүүхээр айлган сүрдүүлэхээс аврах нэг арга төдийгүй бодлого боловсруулах болон эрх зүйн хүрээнд Хэвлэлийн эрх чөлөөний үзэл санаатай холбоотой асуудал үүссэн тохиолдолд олон нийтийн эрх ашгийг, үнэн бодит мэдээллээр дамжуулан олон нийтэд төрийг хянах боломж олгодог хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах нэг бүтэц болно[481] гэсэн байна. Энэ байр суурийг зарим талаар хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж судалгааны баг үзсэн болно. Үүнийг дараах байдлаар тайлбарлая.

1. Шүүх нь хүнийг айлгах арга хэрэгсэл бус хэрэг маргааныг шийдвэрлэж, зөрчигдсөн эрхийг сэргээдэг байгууллага. Тийм ч учраас "Шүүх нь хууль

[479] http://www.yojo.ru/wp/?page_id=82

[480] http://www.ruj.ru/about/codex.htm

[481] http://www.forum.mn/index.php?sel=resource&f=resone&obj_id=615&menu_id=3&resmenu_id=59,Хэвлэлийн өөрийгөө зохицуулах механизм буюу Хэвлэлийн Консулуудыг харьцуулсан судалгаа, 7 дахь тал

ёс, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсны баталгаа мөн"[482] хэмээн хууль зүйн талаас нь тодорхойлж өгсөн байна. Хууль дээдлэх үндсэн зарчмын хүрээнд шүүх нь зөвхөн хуульд заасан тохиолдолд л хариуцлага оногдуулж байдаг. Шүүхийн шийдвэр хууль ёсны болон үндэслэл бүхий байдаг нь ч үүнтэй холбоотой.

2. Сэтгүүлчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байх талаар ярих нь хэт өрөөсгөл юм. Энэ нь хэвлэлийн эрх чөлөөг "боомилох" гэсэн үг, тайлбартай огт дүйхгүй. Учир нь Монгол Улс бол хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг эрхэмлэн дээдэлдэг орон. Энэ утгаараа нийтийн эрх зүйн хүрээнд хүний эрх, эрх чөлөөг Эрүүгийн хуулиар хамгаалж гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэдэг. Нөгөө талаас энэ нь сэтгүүлчийн хариуцлагатай байдалтай салшгүй холбоотой. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулиар зөвхөн гэм буруутай нь тогтоогдсон хувь хүнд хариуцлага хүлээлгэдэг болохоос хэзээ ч хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэдэггүй. Энэ нь тухайн сэтгүүлчийн зөвхөн гэм буруутай үйлдэлд нь хариуцлага хүлээлгэж байгаа асуудал бөгөөд дахин хэвлэн нийтлэх болон бусад эрхийг түр болон бүрмөсөн огт хязгаарлахгүй.

Түүнчлэн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 110 дугаар зүйл /Доромжлох/, 111 дүгээр зүйлд /Гүтгэх/ заасан гэмт хэргийн субъект нь зөвхөн сэтгүүлч, сурвалжлагч байна гэж хатуу тогтоогоогүй. Жишээ нь, шууд нэвтрүүлэг болон ярилцлагад оролцогчид ч энэ гэмт хэргийн субъект байж болно.

Дүгнэлт

Өнөөгийн байдлаар Хэвлэл мэдээллийн салбарын үйл ажиллагааг зохицуулсан хэм хэмжээ 1998 онд батлагдсан "Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай" хуулиас өөр алга байна. Хэвлэлийн консул /зөвлөл/ болон Сэтгүүлчийн ёс зүйн дүрэмтэй байх эрх зүйн орчин бүрдээгүй байна. Энэ нь сэтгүүлчтэй холбоотой хэрэг маргааныг урьдчилан шийдвэрлэх боломжгүй байдалд хүргэдэг. Мөн хэвлэл мэдээллийн салбар нь "дөрөв дэх эрх мэдэл" гэж явдаг, үйл ажиллагааны хувьд төрийн аль нэг байгууллагад харьяалагддаггүй тул тухайн салбарт нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ байдаггүй. Ийм учраас сэтгүүлчидтэй холбоотой хэрэг маргааныг шүүх эрүү, иргэний журмаар шийдвэрлэдэг. Шүүх байгууллага нь асуудлыг зохицуулсан хэм хэмжээ байхгүй гэсэн үндэслэлээр аливаа хэргийг буцаах, хэрэгсэхгүй болгох, шийдвэрлэхгүй байх эрхгүй байдаг учраас сэтгүүлчид хуулийн хариуцлага хүлээлгэдэг. Энэ нь хэвлэл мэдээллийн эрх чөлөөг боогдуулж байна гэх хандлагыг нийгэмд бий болгодог. Сэтгүүлчийн ёс зүйн дүрэм нь Хэвлэлийн зөвлөлийн үйл ажиллагааны болон тухайн салбарын өөрийн зохицуулалтын үндсэн баримт бичиг байх нь ойлгомжтой юм. Эдгээр асуудлыг зохицуулснаар хэвлэл мэдээллийн салбарт гарсан хэрэг маргааныг урьдчилан шийдвэрлэх боломж бүрдэнэ. Энэ нь шүүхийн ачааллыг багасгах, хэрэг маргааныг илүү мэргэшсэн байдлаар /мэргэжлийн онцлогт тохируулан/ оновчтой шийдвэрлэх, шүүхийн нэр хүнд дээшлэх зэрэг эерэг үр дагаврыг үүсгэнэ. Үүний тулд дараах зүйлийг зайлшгүй хийх шаардлагатай гэж судалгааны баг үзэн санал дэвшүүлсэн болно.

[482] Шүүхийн тухай хууль, 3 дугаар зүйл, 3.2

1. Хэвлэлийн консул /зөвлөл/-ын асуудлыг "Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай" хуульд өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах замаар тусгах. Ингэхдээ ямар чиг үүргийг хэрэгжүүлэх, хаанаас хэрхэн байгуулах, хичнээн гишүүнтэй байх, ямар хугацаатай сонгогдох, зөвлөлийн гишүүдийн эрх зүйн байдал, үйл ажиллагааны үндэс нь эрх зүйн ямар акт байх, хэрхэн санхүүжих зэргийг нарийвчлан тусгах.

2. Хэвлэлийн консул /зөвлөл/ нь сэтгүүлчийн ёс зүйн асуудлыг хариуцсан байгууллага бөгөөд хэвлэл мэдээллийн салбар нэг л хэвлэлийн консул /зөвлөл/-тай байна. Мөн зөвхөн гишүүн-сэтгүүлчдээ үйлчилдэг байх нь тохиромжтой. Ингэж тусгавал сэтгүүлчид хэрэг маргааныг шийдвэрлэх асуудлаар нэгдсэн зохион байгуулалтад орох боломжтой. Мөн гишүүнчлэл нэмэгдэхийн хэрээр санхүүжилтэд эерэг нөлөө үзүүлнэ.

3. Сэтгүүлчийн ёс зүйн дүрэмтэй болох. Мөн түүнийг хэрхэн батлах арга механизмыг тодорхойлох. Энэ нь тухайн салбартаа нийтээр дагаж мөрдөх, хэрэг маргааныг урьдчилсан байдлаар шийдвэрлэхэд хэрэглэх хууль зүйн хүчин чадал бүхий эрх зүйн акт байх. Өөрөөр хэлбэл, хэвлэлийн консул /зөвлөл/ хэрэг маргааныг шийдвэрлэхдээ баримталдаг эрх зүйн эх сурвалж болох.

4. Хэвлэлийн консул /зөвлөл/, сэтгүүлчийн ёс зүйн дүрмийг харилцан хамаарал бүхий байдлаар зохицуулах. Зарим тохиолдолд хэвлэн нийтлэх асуудалтай холбоотой харилцаанд сэтгүүлчээс гадна ерөнхий редактор, хэвлэлийн редакци оролцож байдаг.

3.5.Хэвлэлийн зөвлөл ба сэтгүүлчийн хариуцлага

Энэ асуудлыг хэвлэлийн консул гэсэн утгаар хэрэглэдэг ч Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл өргөн мэдүүлэх журмын тухай хууль /2001.11.08/-ийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтад заасны дагуу Монгол хэлэнд тохирох үг нь байвал гадаад хэлний нэр томъёо хэрэглэхгүй байх гэсэн шаардлагыг тавьдаг.

4.1.3. Монгол Улсад ардчилал хөгжиж цэцэглэхийн хэрээр нийгмийн бүхий л харилцааг гагцхүү хуулиар зохицуулах болж сэтгүүлчдийн нийгэмд гүйцэтгэх үүрэг улам нарийсч байна. "Дөрөв дэх засаглал" жинхэнэ утгаараа хөгжих нөхцөл бололцоо бүрдэж эхэлсэн. Өнөө цагт сэтгүүлчдийн хүрч оролцдоггүй нийгмийн нэг ч салбар үгүй. Сэтгүүл зүйн төлөвшил нь нийгмийн сэтгэл зүйд ихээхэн нөлөөлж улмаар нийгэмд хандах ард түмний хандлагыг тодорхойлж байдаг. Учир ийм тул сэтгүүлчид хариуцлагатай, өндөр ёс зүйтэй байх нь үндсэн үүрэг болоод байна. Сэтгүүлчид хариуцлагатай байж чадах эсэх нь тухайн сэтгүүлчийн мэдлэг чадвар, хувийн хандлагаас гадна нийгмийн шинж чанартай олон хүчин зүйлээс ихээхэн шалтгаалдаг. Тийм ч учраас сүүлийн үед хэвлэл мэдээллийн хэрэгслийн хариуцлагын систем /M.A.S/ хэмээх ойлголт өндөр хөгжилтэй улс оронд нэлээд газар авч байна. Энэхүү ойлголтын гол агуулга нь: хэвлэл мэдээлэл нийгмийн бүтээгдэхүүн учир тухайн нийгмийн хөгжлийн түвшинтэй шууд уялдаатай байдаг.

Тиймээс сэтгүүлчдийн хариуцлагын түвшинг өндөржүүлье гэвэл түүнд шаардлагатай орчинг бий болгох нь зүйтэй. Үүний тулд сэтгүүлчдийн баримтлах ёс зүйн зарчмыг баталж, хариуцлага тооцох арга механизмыг

бий болгохоос гадна уран бүтээлчдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор сургалт явуулах, нийтлэл нэвтрүүлэгт ажиглалт хийж, сонсогч, үзэгчдийн дунд тогтмол судалгаа явуулах, олон нийттэй харилцах ажил зохион байгуулж иргэд, хэрэглэгчдийн үгийг сонсох, санал гомдлын дагуу залруулга хийх, радио, телевизийн нэвтрүүлэгт гарсан мэргэжлийн алдааг дахин давтахгүйн тулд бүртгэж, уран бүтээлчдэд түгээж байх гэх мэт олон талын цогц арга хэрэгслийг ашиглах нь зүйтэй.

Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэлийн 2005 оны 3 дугаар сарын 11-ны өдрийн II хуралдаанаар Монголын сэтгүүлчдийн ёс зүйн зарчмыг баталсан. Сэтгүүлчид мэдээлэл авах эрх нь нээлттэй байгаа боловч Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн дээдэлж ажиллах нь зүйн хэрэг юм. Тэрхүү хурлаар баталсан ёс зүйн зарчмын хоёрдугаарт: "Сэтгүүлч нь мэргэжлийн ноцтой алдаа гаргахгүйн төлөө ажиллана. Бусдыг гүтгэх доромжлох, нэр төр гутаахыг цээрлэнэ. Өөрийн болон бусдын эрх ашигт зохицуулан баримтыг санаатайгаар мушгин гуйвуулахаас зайлсхийнэ, нийтлэл, нэвтрүүлгийнхээ төлөө хахууль авахыг ёс бус гэж үзнэ. Баримтыг нуун далдлахыг мэргэжлийн алдаа гэж үзнэ" гэжээ. Энэ зарчмын агуулга өнөөгийн байдлаар нэлээд алдагдсан байна.

2006-2009 оны хооронд нийслэлийн хэмжээнд анхан шатны шүүхээр нийтдээ 87 хэрэг сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээ зөрчсөнөөс хүний нэр төр, ажил хэргийн нэр хүндэд халдсан хэргүүд гарсан байна. Энэ нь сэтгүүлчид ёс зүйн зарчмаа тэр бүр баримталдаггүйн илрэл болж байна. Энэхүү ёс зүйн зарчмыг сэтгүүлчид өөрийн үйл ажиллагаа, өдөр тутмын ажил хэрэгтээ мөрдлөг болгох замаар өөрийн хяналтыг бий болгох шаардлагатай. Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэл хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран энэхүү ёс зүйн зарчмыг практикт хэрэгжүүлэх, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох механизмыг бий болгох ёстой. Энэ бол сэтгүүлчийн ёс зүйн зөвлөл, эсхүл Хэвлэлийн зөвлөл байж болно. Сэтгүүлчдийн ёс зүйн хариуцлага алдсанаас хэвлэн нийтлэгдсэн мэдээ баримтад бусдыг гүтгэсэн, доромжилсон бол гэм хорыг арилгуулах асуудал Иргэний болоод Эрүүгийн хуульд тусгалаа олсон байдаг. /Энэ талаар 1.4.1-ээс дэлгэрэнгүй үзнэ үү./

Манай улсын практикт хэвлэл мэдээллийн байгууллага аливаа нийтлэл мэдээлэлдээ тодорхой шалгууртай, хяналттай байх хэрэгтэйг харуулж байна. Монголын Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн II хурлаар баталсан Сэтгүүлчийн ёс зүйн зарчим нь учир дутагдалтай байна. Сэтгүүлч нь тодорхой үүрэг хүлээх асуудлыг сэтгүүлчдийн ёс зүйн зарчмыг баталснаас бус түүнийг зөрчсөнөөс үүдсэн ёс зүйн хариуцлагын асуудал байхгүй. Сэтгүүлч аливаа нийтлэл, мэдээлэл түгээхдээ хэрэглэгчдэд мэдээллийг чанартай, бодитой өгөх, редакцын хяналтыг хүчтэй болгох шаардлагатай байна.

Сэтгүүлчдийн ёс зүйн зарчмын хэрэгжилт ямар байгааг хүснэгтээр харуулбал:

МОНГОЛЫН СЭТГҮҮЛЧДИЙН ЁС ЗҮЙН ЗАРЧИМ

Хүснэгт 8

Д/д	Зарчмууд	Биелэлт, дүгнэлт
1	Олон түмний үнэнийг мэдэх эрх ашигт ямагт захирагдана.	2006-2009 онд шүүхээр шийдвэрлэгдсэн 8736 хэргийн 74 нь хүний нэр төр, ажил хэргийн нэр хүндийг гутаасан нийтлэл, мэдээллийг сонин хэвлэлээр цацсан нь энэхүү зарчим хэрэгжихгүй олон түмний үнэнийг мэдэх эрх ашгийг үл хүндэтгэж байгааг харуулж байна.
2	Мэргэжлийн ноцтой алдаа гаргахгүй төлөө ажиллана. - Бусдыг гүтгэх, доромжлох, нэр төр гутаахыг цээрлэнэ. - Өөрийн болон бусдын эрх ашигт зохицуулан баримтыг санаатайгаар мушгин гуйвуулахаас зайлсхийнэ. - Нийтлэл нэвтрүүлгийнхээ төлөө хахууль авахыг ёс бус гэж үзнэ. -Баримтыгнуундарагдуулахыг мэргэжлийн алдаа гэж үзнэ.	Сэтгүүлч мэдээллийн эх сурвалжийг бодитой бус эх сурвалжаас авч, мэдээллийн бодит үнэн болон тодорхой шат дамжлагатай редакцын хяналт хангалтгүй байгаагаас сэтгүүлчдийн мэргэжлийн алдаа гаргах асуудал их байна. Телевиз радио, сонин сэтгүүлээр хэн нэгний ашиг сонирхолд нийцүүлэн захиалагат нэвтрүүлэг, нийтлэлийг ямарч хяналтгүй нийтэлж, нэвтрүүлж байна. Энэ үзэгдэл нь ялангуяа нэр дэвшигч сонгуулийн сурталчилгаа хийх үед элбэг байдаг.
3	Бичсэн зүйлийнхээ хариуцлагыг хүлээнэ.	Хуульд энэ талаар зохицуулалт тодорхой бус байдаг. Тухайлбал: Эрүүгийн хуулийн 111 дүгээр зүйлийн 111.1-д Хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэг тараасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ гэж заасныг харахад хэнд хариуцлага оногдуулах нь тодорхой бус байна.
4	Хүний иттэлийг хүлээж, олсон мэдээллийнхээ эх сурвалжийг ямарч тохиолдолд чанд нууцална	Зарим тохиолдолд сэтгүүлчид аливаа дарамт шахалтаас үүдэн мэдээллийн эх сурвалжаа нууцалж чаддагүй.
5	Бусдын бүтээлийг хулгайлах, хуулбарлахыг хориглоно.	Судалгаагаар тодорхой мэдээлэл олдоогүй. Ёс зүйн кодекст заасныг Бусдын бичсэн зүйлээс хэзээ ч хулгайлахгүй.
6	Шашин шүтлэг, хүйс, арьс үндсээр ялган гадуурхах, гэмт хэрэг, хүчирхийлэл, терроризм зэрэг хүнлэг бус зүйлийг хөөрөгдөн сурталчлахгүй байна.	Судалгаагаар тодорхой мэдээлэл олдоогүй.

7	Хувийн нууц, бусдын зовлон шаналалыг ойлгож хүнлэг, энэрэнгүй ёсыг ямагт сахина.	Нэг талаар мэдээлэл авах боломж хязгаарлагдмал байгаа байдлыг сэтгүүлчид өөрсдөө бий болгодог. Учир нь хүнээс ярилцлага аваад, түүний ярьсан зүйлийг шал өөр утга санаагаар бичих тохиолдол байдаг. Мэдээллийн үнэн зөвийг бүх төрлийн эх сурвалжаар шалган тогтоож, болгоомжгүй алдаанаас зайлсхийнэ. Санаатай ташаа мэдээллийг үл тэвчинэ.[3]
8	Мэргэжил нэгтнүүдийнхээ эрх ашгийг хүндэтгэж зөвхөн шударга өрсөлдөөнийг эрхэмлэнэ.	Шударга өрсөлдөөн бус худал, эх сурвалж нь тодорхой, баттай бус байснаас болж зах зээлд шударгаар өрсөлдөж чадахгүй байна. Хэрэглэгчдэд үнэн бодитой мэдээлэл хүрэхгүй байна.
9	Буруу ташаа мэдээлэл гаргасан бол засч залруулахын төлөө бололцоотой бүхнийг хийнэ	Энэ талаар хуульд Эрүүгийн болон Иргэний хуульд заасан. /залруулга хийх./
10	Монголын сэтгүүлчид мэргэжлийн нэр төрөө эрхэмлэн, энэхүү ёс зүйн зарчмыг ямагт мөрдлөг болгохыг үүргээ гэж үзнэ.	Сэтгүүл зүйд ёс зүйн зарчмын 6 нь биелэхгүй байгаа учир сэтгүүлчид өдөр тутмынхаа ажилд энэхүү зарчмыг мөрдлөг болгохгүй байна.

Дүгнэлт: 1995 оны 5 дугаар сарын 16-ны өдөр баталсан Байгууллагын нууцын тухай хуулиар байгууллагын нууц нь тухайн байгууллагын хамгаалалтад байна. Байгууллага нь нууцаа хамгаалах журмыг өөрөө тогтоож мөрдөнө гэж заасан /5.1/ нь байгууллагын дарга, захирал бүрт нууцлахгүй зүйлийг нууцлах боломж олгож, энэ чанараараа хэвлэл мэдээллийн ажилтан сэтгүүлчдээс мэдээлэлд нэвтрэх, олж авах, түгээх эрхийг нь үндэслэл муутай хязгаарлаж буй хэрэг[483] гэсэн дүгнэлт нь нэг талаараа үнэн боловч нөгөө талаараа сэтгүүлч хүн гэдэг бол заавал байгууллагын нууц, дотоод асуудлыг иргэдэд хүргэхдээ бус, байгаа бодит мэдээлэлд тулгуурлаж, олон эх сурвалжаас шинжилгээ хийн үндэслэлтэй дүгнэлт гаргаж, нийгмийн амьдралд хэрэгтэй санал дэвшүүлэх чадвартай байх ёстой. Өөрөөр хэлбэл: энэ байгууллага бидэнд хэрэгтэй мэдээллийг өгөх ёстой гэж бэлэн мэдээ, ярилцлага шаардаж зогсохдоо биш олон эх сурвалжийг харьцуулан дүгнэсэн бүтээлч, шинжлэх ухааны үндэслэлтэй, бодитой мэдээллийг иргэдэд хүргэх ёстой юм. 1998 оны 8 дугаар сарын 28-ны өдөр УИХ-аас Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг баталсан юм. Хуулийн 2 дугаар зүйлд "хэвлэл мэдээллийн эрх чөлөө, мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглосон". Мөн 3 дугаар зүйлд "төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тавихыг хориглож, Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ" гэж заасан ба 4 дүгээр зүйлд "Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно" гэж заасан. 2009 оны байдлаар орон нутгийн засаг захиргааны

[483] Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө "сэтгүүлч ба хууль цуврал" №3. Уб., 2001 он. 17 дахь тал.

байгууллагууд өөрийн харъяаны мэдээллийн хэрэгсэлтэй байсаар байна. 2007 онд төрийн эзэмшлийн телевиз 20 хувийг эзэлж байсан бол 2008 онд 9 хувь, 2009 онд 6 хувь болж буурчээ. Харин сонины 15 хувь, сэтгүүлийн 20 хувь нь төрийн байгууллагын дэргэд хэвээр байгаа[484] нь нэг талаараа /төр хэвлэл мэдээллийн хэрэгслийг монопольчлохоос сэргийлж байгаа боловч/ нөгөө талаараа төрийн байгууллага өөрийн үйл ажиллагааг ард иргэдэд хүргэх, төрийн байгууллагын мэдээлэл нээлттэй байх гэдэг үүднээс нь төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг үгүйсгэх аргагүй юм. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт. Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна гэдэгт ч нийцэж байгаа юм.

Сэтгүүлчид бид эх сурвалжаа нууцлах эрхтэй гэж үздэг, шүүхэд ч тэгж мэдүүлдэг. Тэгвэл хууль эрх зүйн хувьд уг эрхээ баталгаажуулж өөрсдийгөө хамгаалах тал дээр дутмаг ажилладаг. Энэ нь хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 3.1-дэх заалттай ч холбоотой байж болох юм. Жишээ нь: захиалагч нийтэлсэн эх сурвалжийнхаа хариуцлагыг хүлээхгүй гэсэн тохиолдолд сэтгүүлч тухайн нийтлэлээс үүдэн гарах үр дагавар, гэм хорыг бүрэн хариуцна гэдгээ баталж гэрээ байгуулах; нөгөө тохиолдолд сэтгүүлч захиалагчийн нийтэлсэн нийтлэлийн хариуцлагыг хүлээхгүй гэсэн тохиолдолд захиалагчтай гэрээ байгуулах гэх мэтээр зохицуулах юм бол захиалагч хариуцна би хариуцахгүй гэж хариуцлагаас зугатаах, хэн нэгэнд учруулсан гэм хор хариуцагчгүй болох эрсдэлээс хамгаалагдах юм. Тиймээс Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Хэвлэл мэдээллийн хэрэгсэл өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ" гэсэн заалтыг байгууллага биш, гэм буруутай тодорхой албан тушаалтан субъект хүлээнэ" гэж өөрчлөх шаардлагатай байгааг харуулж байна. Зохиогчийн өгсөн буюу сурвалжлагчийн нэртэй түгээж байгаа мэдээллээс бусад бүх мэдээллийн хариуцлагыг редакци хариуцах ёстой. Зохиогч буюу сурвалжлагчийн нэргүй түгээж байгаа мэдээллийн нуцыг редакци хадгалах эрхтэй бөгөөд хэрэв редакци тийнхүү нийтлэл, нэвтрүүлгийн зохиогч, сурвалжлагчийн нэрийг нуцалж байгаа бол нийтлэл, нэвтрүүлгийнхээ хариуцлагыг хүлээх ёстой.

Бусдыг гутгэсэн, доромжилсон мэдээлэл түгээсэн хэвлэл мэдээллийн байгууллага нь тэрхүү мэдээллийг хэвлэн нийтэлсэнээрээ олсон орлого, ашиг нь нэр төрөө гутаалгасан иргэнд учирсан хохирлоос давсан байдаг. Эрүүгийн хуульд заасан торгох ял нь тэрхүү мэдээллийг түгээсэн хэвлэл мэдээллийн байгууллагын олсон орлогоос бага болон нэр төр нь гутаагдсан иргэнд учирсан гэм хортой харьцуулах аргагүй байна. Энэ нь иргэний болон эрүүгийн хууль, захиргааны хариуцлагын тухай хууль, зар сурталчилгааны тухай хууль гэх мэт зарим төрлийн хуулиудын торгуулийн хэмжээ нь зах зээлийн одоогийн үнэлгээнд тохирохгүй, хохирлыг арилгаж чадахгүй нөлөө багатай байгаа нийтлэг үзэгдлүүдийн нэг юм. Гэхдээ нэр төрөө сэргээлгэх

[484] Монголын хэвлэл мэдээллийн байдлын талаарх олон нийтийн үнэлэмж судалгааны тайлангаас. Хэвлэлийн хүрээлэн. УБ., 2009 он.

гэдэг бол хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр няцаалт хийж андуу ташаа бичсэндээ уучлалт гуйхад орших болохоос иргэний хуульд зааснаар мөнгөн хэлбэрээр хохирлоо барагдуулахад орших учиргүй бөгөөд шүүхийн практикт ч мөн адил энэ хэлбэрийг хэрэглэхээс аль болох зайлсхийх нь чухал юм. Ингэснээрээ нэр төрөө сэргээлгэхийг мөнгө олох арга гэж ойлгох үзэгдлээс сэргийлэх ач холбогдолтой юм. Гүтгэх доромжлох хоёрын аль аль нь эдийн бус хохирол учруулдаг боловч гэмт хэргийн бүрэлдэхүүнээрээ ялгаатай. Гүтгэх гэмт хэргийн бүрэлдэхүүн нь бодит байдалд үл нийцсэн мэдээлэл тарааж, түүгээрээ хүний нэр төр, алдар хүндийг гутаасан гэсэн ойлголт байдаг. Харин доромжлолын хувьд заавал бодит байдалд нийцсэн, тохирсон нь чухал биш, хамгийн гол нь ямар хэлбэрээр илэрхийлсэн нь чухал байдаг. Аливаа хүний тухай шүүмжилж бичихдээ эвгүй, таагүй байдлаар илэрхийлсэн байвал тэр нь доромжлол болдог. Иймээс Гүтгэх, доромжлох гэмт хэрэг нь зөвхөн сэтгүүлчдэд бус нийт иргэдэд хамаатай заалт юм. Иргэдийн эрх зүйн мэдлэг муу байгаагаас энэ гэмт хэргийн холбогдогч нар нь зөвхөн сэтгүүлчид болж байгаа юм. Зүй нь бол 2 иргэн хоорондоо маргалдаад нэг нь нөгөөгөө олон нийтийн өмнө доромжилсон байхад доромжлуулсан этгээд цагдаагийн байгууллагад хандах эрхтэй юм. Иймээс судалгааны баг Глоб интернэшнл ТББ-аас хийсэн "Нэр төр сэргээх хэрэг ба цензур" судалгааны ажлын үр дүнд Эрүүгийн хуулийн гүтгэх, доромжлох заалтыг улс төрчид болон төрийн өндөр албан тушаалтнууд өөрсдийгөө хамгаалах хэрэгсэл болгон ашиглаж, сэтгүүлчдийг янз бүрийн хэлбэрээр дарамталж шүүхэд дуудах, асуудал гарч байгаа учраас Эрүүгийн хуулиас энэ хоёр заалтыг хасах хэрэгтэй гэдэг дүгнэлттэй санал нийлэхгүй байна.

-Сэтгүүлчдийн хариуцлагыг өндөржүүлье гэвэл үүнд шаардлагатай орчинг бий болгох нь зүйтэй. Үүний тулд сэтгүүлчдийн баримтлах ёс зүйн зарчмыг баталж, хариуцлага тооцох арга механизмыг бий болгохоос гадна сэтгүүлчдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор сургалт явуулах, нийтлэл нэвтрүүлэгт ажиглалт хийж, сонсогч, үзэгчдийн дунд тогтмол судалгаа явуулах, олон нийттэй харилцах ажил зохион байгуулж иргэд, хэрэглэгчдийн үгийг сонсох, санал гомдлын дагуу залруулга хийх, радио, телевизийн нэвтрүүлэгт гарсан мэргэжлийн алдааг дахин давтахгүйн тулд бүртгэж, сэтгүүлчдэд түгээж байх гэх мэт олон талын цогц арга хэрэгслийг ашиглах нь зүйтэй.

-Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэл хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран сэтгүүлчийн ёс зүйн зарчмыг практикт хэрэгжүүлэх, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох механизмыг бий болгох ёстой.

-Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд хүний нэр төр, алдар хүндийг гутаасан мэдээлэл цацсан сэтгүүлчид хариуцлага тооцох тухай дурдаагүй, мөн Иргэний хуулийн холбогдох заалтууд нь сэтгүүлчдэд бус хэвлэл мэдээллийн байгууллагатай холбоотой хариуцлагын асуудлыг хуульчилсан байна.

-Манай улсын практикт хэвлэл мэдээллийн байгууллага аливаа нийтлэл мэдээлэлдээ тодорхой шалгууртай, хяналттай байх хэрэгтэйг харуулж байна.

Монголын Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн II хурлаар батлсан Сэтгүүлчийн ёс зүйн зарчим нь учир дутагдалтай байна. Сэтгүүлч нь тодорхой үүрэг хүлээх асуудлыг сэтгүүлчдийн ёс зүйн зарчмыг баталснаас бус түүнийг зөрчсөнөөс үүдсэн ёс зүйн хариуцлагын асуудал байхгүй. Сэтгүүлч аливаа нийтлэл, мэдээлэл түгээхдээ хэрэглэгчдэд мэдээллийг чанартай, бодитой өгөх, редакцийн хяналтыг хүчтэй болгох шаардлагатай байна.

4.1. Санал

1/ Мэдээллийн эх сурвалжийг нууцлах, хамгаалах, сэтгүүлчийн нэр төрийг хангах талаар тодорхой тусгасан заалт хуульд байхгүй байна. Эдгээрийг хуульчлаагүйн улмаас сэтгүүлчдэд дарамт шахалт, хавчлага учруулах явдал тохиолддог аж. Иймд мэдээллийн эрх чөлөө, сэтгүүлчийн эх сурвалжаа нууцлах үүрэг, сэтгүүлчийн аюулгүй байдлыг хангах талаар хуульчлах шаардлагатай байна. Хэвлэл мэдээллийн өмчлөл, бөөгнөрөл өргөн нэвтрүүлгийн хэрэгслийн тухай зэрэг чухал хууль байхгүй байна. Мөн хэвлэл мэдээллийн байгууллагын эрх зүйн статус, сэтгүүлчийн статус, сэтгүүлчийн мэргэжлийн эрх, үүрэг гэсэн асуудал манай орны хууль, эрх зүйн баримт бичигт хамгийн бүрхэг тусгагдсан байх тул энэ нь томоохон хийдэл болох боломжтой. Иймд энэ талаарх зохицуулалтыг дэлгэрэнгүй оруулах нь зүйтэй гэж үзлээ. Сэтгүүлчид эх сурвалжаа нууцлах эрхтэй биш үүрэгтэй гэж хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд оруулах. Учир нь үүргээ дагаад хариуцлага хүлээх асуудал бий.

2/ Нийгэмд болж буй үйл явдлын халуун мөрөөр ажиллаж байгаа зарим сэтгүүлчдийг /эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хөгжүүлэх үүднээс/ өөрсдийнх нь хүсэлтээр тодорхой хугацаанд хамгаалалтад авах тогтолцоог бий болгох. Судалгааны явцад сэтгүүлчидтэй хийсэн ярилцлагын үеэр Монгол Улсад түүхэндээ анх удаа сэтгүүлчдийг хамгаалалтад авч байжээ. Энэ нь Гүнтийн буудалцааныг сурвалжилж байсан сэтгүүлчийг хамгаалалтад авч байсан гэх мэтээр нийгмийн ээдрээ төвөгтэй олон хэргүүдийг сэтгүүлч үнэнээр нь ялгаж иргэдэд хүргэх хууль эрх зүйн орчинг нь бий болгох шаардлагатай байна.

3/ Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой хууль тогтоомжийг судлахад зөрчил бүхий 3 хуулийн заалт байна. /Энэ судалгааны 1.3-ийг үзнэ үү/ Иймд эдгээр хуулийн зөрчлийг арилгаж, цаашид хэм хэмжээний хоорондын нийцлийг хангах шаардлагатай байна.

4/ Монгол Улсын хувьд хэвлэл мэдээллийн байгууллага хуулийн этгээд байх бөгөөд энэ нь хуулийн этгээдийн ямар төрөл, хэлбэрээр байгуулагдах талаарх эрх зүйн зохицуулалт зөрчилтэй байна. Өөрөөр хэлбэл, Иргэний хуульд заагаагүй хуулийн этгээдийн хэлбэрийг шууд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд бий болгосон мэтээр харагдаж байна.

Цаашид хэвлэл мэдээллийн байгууллагыг хуулиар зөвшөөрөгдсөн хуулийн этгээдийн хэлбэрээр байгуулах боломж бий болгох, хэвлэл мэдээллийн салбарын харилцааг зохицуулдаг суурь хуульд энэ талаар зохих хэмжээгээр тусгах нь зүйтэй гэж үзэж байна.

5/ Онц байдал зарласан үед сэтгүүлчдийг хэрхэн ажиллах талаар хуульд тусгах саналтай байна. Учир нь үймээн самуун болсон тохиолдолд

сэтгүүлчид ялгарах хувцас, тэмдэггүйгээс болж гэмтэж бэртэх тохиолдол гардгаас гадна олон нийтэд мэдээлэл хүргэх үүргээ биелүүлж чадахгүй байдалд хүрдэг. Энэ үед тухайн сэтгүүлчийн аюулгүй байдлыг хангах талаар редакциас зааварчилгаа өгдөг байх шаардлагатай. Сэтгүүлчид онц болон дайны байдал зарласан үед хүмүүсийн сэтгэл зүйд нөлөөлөхүйц байдлаар мэдээ, баримтыг хүргэх шаардлагагүй. Шархадсан хүмүүсийн талаар шууд эфирт нэвтрүүлснээр тухайн хүний гэр бүлийн хүмүүс түүний талаар эмнэлэгт ямар эм тарианаас харшилдагийг, цагдаагийн байгууллага хаяг тодорхойлох гэж цаг алдахгүй байх ач холбогдолтой юм. Мөн хэвлэл мэдээллийн хэрэгслийг хаасан тохиолдолд бүх телевизэд адил тэгш зарчмаар хандах.

6/ Сэтгүүлчийн ёс зүйн дүрэм нь Хэвлэлийн зөвлөлийн үйл ажиллагааны болон тухайн салбарын өөрийн зохицуулалтын үндсэн баримт бичиг байх нь ойлгомжтой юм. Эдгээр асуудлыг зохицуулснаар хэвлэл мэдээллийн салбарт гарсан хэрэг маргааныг урьдчилан шийдвэрлэх боломж бүрдэнэ. Энэ нь шүүхийн ачааллыг багасгах, хэрэг маргааныг илүү мэргэшсэн байдлаар /мэргэжлийн онцлогт тохируулан/ оновчтой шийдвэрлэх, шүүхийн нэр хүнд дээшлэх зэрэг эерэг үр дагаврыг үүсгэнэ. Үүний тулд дараах зүйлийг зайлшгүй хийх шаардлагатай гэж судалгааны баг үзэн санал дэвшүүлсэн болно. Сэтгүүлчдийн ёс зүйн зарчим"-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох замаар өөрийн хяналтыг бий болгох шаардлагатай. МСНЭ хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран энэхүү ёс зүйн зарчмыг практикт хэрэгжүүлэх, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох механизмыг бий болгох "сэтгүүлчийн ёс зүйн зөвлөл"-ийг байгуулах хэрэгтэй.

Ингэхдээ:

1.Хэвлэлийн консул /зөвлөл/-ын асуудлыг "Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай" хуульд өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах замаар тусгах. Ингэхдээ ямар чиг үүргийг хэрэгжүүлэх, хаанаас хэрхэн байгуулах, хичнээн гишүүнтэй байх, ямар хугацаатай сонгогдох, зөвлөлийн гишүүдийн эрх зүйн байдал, үйл ажиллагааны үндэс нь эрх зүйн ямар акт байх, хэрхэн санхүүжих зэргийг нарийвчлан тусгах

2.Хэвлэлийн консул /зөвлөл/ нь сэтгүүлчийн ёс зүйн асуудлыг хариуцсан байгууллага бөгөөд хэвлэл мэдээллийн салбар нэг л хэвлэлийн консул /зөвлөл/-тай байна. Мөн зөвхөн гишүүн-сэтгүүлчдээ үйлчилдэг байх нь тохиромжтой. Ингэж тусгавал сэтгүүлчид хэрэг маргааныг шийдвэрлэх асуудлаар нэгдсэн зохион байгуулалтад орох боломжтой. Мөн гишүүнчлэл нэмэгдэхийн хэрээр санхүүжилтэд эерэг нөлөө үзүүлнэ.

3.Сэтгүүлчийн ёс зүйн дүрэмтэй болох. Мөн түүнийг хэрхэн батлах арга механизмыг тодорхойлох. Энэ нь тухайн салбартаа нийтээр дагаж мөрдөх, хэрэг маргааныг урьдчилсан байдлаар шийдвэрлэхэд хэрэглэх хууль зүйн хүчин чадал бүхий эрх зүйн акт байх бөгөөд хэвлэлийн консул /зөвлөл/ хэрэг маргааныг шийдвэрлэхдээ баримталдаг эрх зүйн эх сурвалж болно.

__oOo__

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ДАМПУУРЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ ХИЙСЭН СУДАЛГАА[485]

Нэг. ДАМПУУРЛЫН ХЭРЭГ ГҮЙЦЭТГЭГЧИЙН НЭР ТОМЬЁОНЫ ТАЛААР

АНУ-ын Black-ийн 1910 оны хууль зүйн тайлбар тольд "дампуурлын хүрээнд аж ахуйн нэгжийг татан буулгах нэр томъёог–хариуцагчийн хөрөнгийг цуглуулж худалдах, орлогыг нь нэхэмжлэгчид шилжүүлэх замаар өр төлбөрийг зохицуулах шүүхийн ажиллагаа" гэж тодорхойлжээ[486] /Ч.Сарангэрэл орч/. Мөн дээрх тайлбар тольд:

trustee /итгэмжлэгдсэн этгээд/ – хуульд зааснаар заавал байлгавал зохих итгэмжлэгдсэн хувь хүн нь өмч хөрөнгө, ашиг сонирхлын нийтлэг байдлаар нийлсэн хүмүүсээс бусдын эрх ашгийн төлөө тухайн удирдлагыг төлөөлөн явуулахаар тохиролцож, хуулийн дагуу эрх олгогдож итгэмжлэгдсэн этгээд юм. Дампуурлын хэрэг гүйцэтгэгч[487] /*Trustee in bankruptcy*/–дампуурлын хэргийн итгэмжлэгдсэн этгээд нь нэхэмжлэгчдийн итгэлийг хүлээж, дампуурсан этгээдийн хөрөнгийг хуулийн дагуу шийдвэрлэгч хувь хүн юм.[488]

Хэрэг гүйцэтгэгчийг шүүхээс томилохдоо нэхэмжлэгчдийн хурлын саналыг үндэслэх, эсхүл шүүх өөрөө томилох гэсэн 2 аргаар явагддаг:

1/ Хэрэг гүйцэтгэгчийг нэхэмжлэгчдийн хурлаас санал болгох;

Энэ нь нэхэмжлэгчид хамтран ярилцаж хэрэг гүйцэтгэгчээр ажиллах хүний талаар харилцан тохиролцоонд хүрнэ гэсэн үг юм. Үүнд хэрэг гүйцэтгэгч нь түүнийг нэр дэвшүүлсэн этгээд, эсхүл аль нэг нэхэмжлэгчийн төлөө ажиллах биш харин бүх нэхэмжлэгчдийн өмнө хариуцлага хүлээх ёстой гэдэг утга агуулагдаж байгаа болно. Гэвч энэ саналыг шүүх хүлээн аваад шийдвэр гарган баталгаажуулна.

2/ Хэрэг гүйцэтгэгчийг шүүхээс томилох;

Дампуурлын хэргийн эхний шатанд хариуцагчийн хөрөнгөнд яаралтай хамгаалах арга хэмжээ авах үед болон нэхэмжлэгчдийн хурал болохоос өмнөх хугацаанд дээрх арга хэмжээг авах тохиолдолд шүүх томилж болно. Шүүх нь түр болон байнгын хэрэг гүйцэтгэгчийг томилж болох эрхтэй байж томилогдсон хэрэг гүйцэтгэгчид шүүхийн дэмжлэг болон хяналттай байна гэсэн үг юм. Мөн trustee нь дотроо *interim trustee, standing trustee* гэж ангилагддаг.

[485] Энэ судалгаат Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2011 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 22 дугаар тушаалын дагуу ХЗДХЯ-аас боловсруулж буй төслийн хүрээнд хийж гүйцэтгэсэн болно.

[486] Black's Law Dictionary /1910/, page 180.

[487] Академич С.Нарангэрэлийн 2008 оны "Dictionary of law" –д "Хэрэг гүйцэтгэгч - Монгол улсад харилцагчийг татан буулгах, эсхүл дахин хөрөнгөжүүлэх ажлыг эрхлэн гүйцэтгэгч, дахин хөрөнгөжүүлэх ажиллагаанд хяналт тавих, харилцагчийн эд хөрөнгийг хамгаалах эрхтэйгээр нэхэмжлэгчдийн хурлаас санал болгосноор шүүхийн томилсон этгээд" гэж тодорхойлжээ.

[488] Black's Law Dictionary /1910/, page 1177-1178.

interim trustee /түр хэрэг гүйцэтгэгч/ - дампуурлын процесс эхлэхэд шаардлагатай тохиолдолд хязгаарлагдмал эрхтэйгээр итгэмжлэгдсэн этгээдээр түр ажиллах хүнийг шүүх томилдог.

standing trustee /хэрэг гүйцэтгэгч/-хуулийн дагуу эрх бүхий нэхэмжлэгчид өөрсдөө хүнээ сонгох боломжтой бөгөөд сонгогдвол trustee, хэрэв шинээр хүн санал болгохгүй гэвэл түр хэрэг гүйцэтгэгчийг жинхэлж үргэлжлүүлэн тухайн хэрэг дээр ажиллаж болдог.

ДАМПУУРЛЫН ХЭРЭГ ГҮЙЦЭТГЭГЧИЙН ТУХАЙ ЭХ СУРВАЛЖ

а/ Дотоодын эх сурвалж

Дампуурлын тухай хууль Монгол улсад хэрэгжиж эхэлсэн үе болон одоогийн үйлчилж байгаа холбогдох хуулиуд:

1.Иргэний хууль. 2002.01.10 /урьд нь 1994.11.01 батлагдсан/. Энэхүү хуулийн 32 дугаар зүйлд хуулийн этгээдийг татан буулгах нэг үндэслэл нь ...дампуурсанд тооцож... гэж авч үзсэн ба 32.5.2 дахь заалтанд энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлэгч нь ...хэрэг гүйцэтгэгч... гэж оруулсан байна.

2.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. 2002.01.10 /урьд нь 1994.05.09 батлагдсан/. Харин энэ хуулийн 133 дугаар зүйлийн 133.1.10 дахь заалтанд "...шүүх хуулийн этгээдийг дампуурсанд тооцох энэ хэргийг онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх..."-ээр 2007 оны 08 дугаар сарын 03-нд нэмэлт өөрчлөлтөөр оруулжээ.

3.Дампуурлын тухай хууль. 1997.11.20 /Монгол Улсад анхны хууль нь 1991.06.03-нд батлагдсан/ Энэ хууль нь энэхүү судалгааны материалын бүх хэсэгт ишлэл болон орж байгаа ба бусад тайлбарын гол үндэслэл болно. Манай Улсын 1997 оны Дампуурлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтанд "хэрэг гүйцэтгэгч гэж харилцагчийг татан буулгах, эсхүл дахин хөрөнгөжүүлэх ажлыг эрхлэн гүйцэтгэгч, дахин хөрөнгөжүүлэх ажиллагаанд хяналт тавих, харилцагчийн эд хөрөнгийг хамгаалах эрхтэйгээр нэхэмжлэгчдийн хурлаас санал болгосноор шүүхийн томилсон этгэзд" гэж, Мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь заалтанд "хэрэг гүйцэтгэгч нь хариуцагчийн үйл ажиллагаанд хувийн санхүү, эдийн засгийн сонирхолгүй, хууль, санхүү, эдийн засгийн дэзд боловсролтой хувь хүн, эсхүл хууль зүй, эдийн засаг, санхүүгийн чиглэлээр мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх эрх, үүрэг бүхий хуулийн этгээд байна" гэж тус тус томъёолж тодорхойлсон байна.

4.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 2002.05.10 /урьд нь Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль 1996.11.15 батлагдсан./ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтын дагуу шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дампуурлын хэрэг үүсгэсэн үндэслэлээр шүүгчийн захирамжаар түдгэлзүүлж, 16 дугаар зүйлийн 16.1.5 дахь заалтын дагуу төлбөр төлөгч-хуулийн этгээдэд дампуурлын хэрэг үүсгэж явуулсан татан буулгах ажиллагаа дуусгавар болоход эд хөрөнгө төлбөр төлөхөд хүрэлцэхгүй байгаа нь шүүхээр тогтоогдсон үндэслэлээр шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болно.

5.Банкны тухай хууль. 2010.01.21 /урьд нь 1996.09.03 батлагдсан/. Банкны тухай хуулийн 6 дугаар бүлэгт банк зөрчлөө арилгаагүй тохиолдолд банкинд хүлээлгэх албадлагын арга хэмжээг авч, улмаар онцгой дэглэм тогтоож бүрэн эрхт төлөөлөгч томилон ажиллуулах, цаашлаад банкинд

бүтцийн өөрчлөлт хийх буюу банкийг албадан татан буулгах ажиллагааг банкны эрх хүлээн авагчийг томилон ажиллуулж дуусгавар болгоно.

Харин банкны дампуурлыг шүүх зарлах талаар /хуучин хуулийн 48.2 дахь хэсэгт 1999.07.21-нд өөрчлөн найруулж оруулсан/ одооны хуулийн 67 дугаар зүйлд "Шүүх банкны дампуурлыг зарлаж, татан буулгах асуудлыг энэ хуулиар тогтоосон зарчмыг үндэслэн Дампуурлын тухай хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ" гэж заасан байдаг.

Өнөө хүртэл Дампуурлын тухай хуулиар ганц ч банкны дампуурлыг шийдвэрлээгүй ба Монголбанкны эрх хүлээн авагчийн үүргээр дампуурсан банкуудын төлбөрийн чадваргүй болсныг шийдвэрлэж, мөн ХААН банкийг өөрийнх нь суурин дээр, харин Зоос банкны суурин дээр Төрийн банкыг бүтцийн өөрчлөлт хийх замаар сэргээн босгож дахин хөрөнгөжүүлж байсан. Энэ нь санхүүгийн зах зээлийн онцлогоос хамаарч ард иргэдийн банкинд итгэх итгэлийг хадгалах, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлэх үндсэн зорилтын хүрээнд Монголбанкны зүгээс хүчин чармайлт гаргасны үр дүн билээ.

Эндээс дүгнэлт хийхэд манай орны хэрэг гүйцэтгэгчдэд Монголбанкны зүгээс банкны дампуурал дээр ажиллах нөхцөлийг олгохгүй байгаа ба нөгөө талаас манай хэрэг гүйцэтгэгчид банк санхүүгийн салбарт бэлтгэгдсэн боловсон хүчний хувьд дутагдалтай болон тархай бутархай нэгдмэл биш тал харагдаж байгаа юм.

6.Даатгалын тухай хууль. 2004.04.30 /урьд нь 1997.12.05 батлагдсан./

Даатгалын компани буюу даатгагчийн дампуурлын тухай энэ хуульд онцлон үзэж, 16 дугаар бүлэгт авч оруулсан байдаг. Мөн энэ хуулийн нэг онцлог нь Санхүүгийн зохицуулах хороо /цаашид Зохицуулах хороо гэнэ/-ны зүгээс ихээхэн оролцоотой ба даатгагчид дампуурлын хэрэг үүсгэх тохиолдолд тухайн хуулийн 11.2-т заасан шаардлага хангасан, даатгалын компаний үйл ажиллагааны онцлогийн талаар зохих мэдлэгтэй хүнийг хэрэг гүйцэтгэгчээр түр болон байнгын томилуулахаар шүүхэд хүсэлт гаргах ба энэ тохиолдолд Дампуурлын тухай хуулийн 8.2 дахь хэсэг үйлчлэхгүй, мөн шүүх даатгагчийг дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг батлах үйл ажиллагаанд Зохицуулах хорооны зөвшөөрөлгүй батлахгүй байхаар хязгаарлажээ. Гэхдээ манай оронд даатгалын компанийг татан буулгах ажиллагаанд Дампуурлын тухай хуулийг хэрэгжүүлсэн түүх байхгүй байна. Манай улсад хэрэгжүүлсэн 1998 оны 9 дүгээр сард Дэлхийн банкны санхүүжилттэйгээр Монгол улсын Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хэрэгжүүлж байгаа "BELTAC" хөтөлбөрийн хүрээнд Олон улсын хуулийн институтээс Дампуурлын хуулийн талаар сургалт явуулсан билээ. Шүүгч, өмгөөлөгч, банкны ажилтнууд, эдийн засагчид, хуулийн сургуулийн оюутнууд, төрийн холбогдох байгууллагын ажилтнуудаас бүрдсэн 50 гаруй хүмүүс энэ сургалтанд хамрагдсан. Дэлхийн банкнаас "World bank IDF Grant No:027281" ба "Монгол Улсын Дампуурлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах төсөл"-ийн дагуу Хэрэг гүйцэтгэгчдийн сургалтыг 1999 оны 10 дугаар сарын 25-наас 11 дүгээр сарын 08-ныг дуустал 3 долоо хоног үргэлжилсэн ба үүний дараа Хууль зүй зүйн сайдын 2000 оны 5 дугаар сарын 16-ны 185 тоот тушаалаар дампуурлын хэрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг шалгалтанд тэнцсэн 9 хүнд олгосон байдаг юм.

Монголын Дампуурлын хэрэг гүйцэтгэгчдийн үндэсний холбоог СЭЗДС-ийн багш Э.Эрдэнэчимэгийн хүчин чармайлтаар 1999 оны 11 дүгээр сарын 04-нд байгуулсан бөгөөд энэ үед 26 гишүүн нэгдэж байсан боловч одоогоор тус холбооны үйл ажиллагаа идэвхигүй байдалд байна.

Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2002 оны 4 дүгээр сарын 05-ны 74 тоот тушаалаар дээрх эрхийг хүчингүй болгосон ба одоо Дампуурлын тухай хуульд заасан шаардлагуурын дагуу хэрэг гүйцэтгэгчээр оролцох сонирхолтой, зохих шаардлагыг хангасан этгээд томилогдон ажиллаж байна.

Нийслэлийн шүүхээс 2002 оны 11 дүгээр сарын 25-нд гаргасан зөвлөмжинд 1998 оны 1 дүгээр сараас 2002 он хүртэл Дампуурлын хуулиар шийдвэрлэсэн хэргүүдэд судалгаа хийхэд шүүх 17 нэхэмжлэл, хүсэлт хүлээн авч, 8-ыг нь хүлээн авахаас татгалзаж, 9-ийг нь шийдвэрлэсэн байдаг.

б/ Гадаад эх сурвалж

АНУ нь дампуурлын дагнасан шүүхтэй. Дампуурлын хууль нь кодексийн бүтэн нэг бүлэг ба нэг нь 700 орчим хуудас бүхий 6 боть номоос бүрддэг. АНУ-ын Хууль зүйн яамнаас тусгай зөвшөөрөл олгох ажиллагаанд хяналт тавьдаг харьяа байгууллага болох Дампуурлын хэрэг гүйцэтгэгч нарын газартай /United States Trustee Program/ байдаг. Энэхүү газар нь АНУ-ын нутаг дэвсгэр дээрх дампуурлын хэрэг гүйцэтгэгчдийн үйл ажиллагаанд хяналт тавих, удирдах ерөнхий чиг үүрэгтэй бөгөөд гишүүн байгууллагатай түүнээсээ эхний санхүүжилтээ хийж, гүйцэтгэлээсээ төлдөг.

№	Улс орнууд	Дамдуурлын хуулийн үйлчлэх хүрээ	Хэрэг гүйцэтгэгчдийг удирдах байгууллага	Хэрэг гүйцэтгэгчийн эрх, үүрэг, хариуцлага	Санхүүжилтийн хэлбэр
1	Америк	Хувийн болон бизнесийн аль ч салбарт	Хэрэг гүйцэтгэгчдийн Үндэсний Холбоо /ашгийн бус байгууллага/	Тусгай зөвшөөрлөөр олгогдсон эрх, үүрэгтэй	Холбооны гишүүн байгууллагууд санхүүжүүлнэ.
2	Канад	Хувийн болон бизнесийн аль ч салбарт	Орон нутгийн холбоо байдаг	Тусгай зөвшөөрлөөр	Холбооны гишүүдийн санхүүжилтээр
3	Австрали	Хувийн болон бизнесийн байгууллагын дампуурлын хүрээнд	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг хэлбэрээр	Мэдээлэл зөвлөгөөг үнэгүй өгөхөөс гадна хуульд заасан үйл ажиллагаа	Төсвөөс санхүүжүүлнэ.
4	Бразил	Зөвхөн хувийн бизнест хамаарна	Төрийн мэдэлд	Хуульд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.	Төрөөс

5	Хятад	Хувийн болон улсын аль алинд хамааралтай	Төрийн мэдлийн албан хаагч байна.	Мэргэшсэн байхаар хуульчилсан	Төрөөс
6	Энэтхэг	1920 оноос улбаатай хууль хэрэглэдэг. Энэ нь аль ч секторт хамааралтай.	Төрийн мэдлийн санхүүгийн байгууллагад /хуулийн яам биш/ харьяалагдана.	Мэргэшсэн байгууллагад харьяалагддаг учраас тэдгээрийн ажилтан гүйцэтгэнэ.	Төрөөс
7	Япон	Америкийн хуульд үндэслэн	Төрийн байгууллагад	Мэргэшсэн байгууллага	Холимог
8	Нидерланд	Германы хуулиар зохицуулагддаг хувийн болон бизнесийн аль алинд хамааралтай	Төрийн мэдэлд	Мэргэшсэн байгууллага удирддаг.	Төсвөөс
9	Швейцарь	АНУ-тай адил хуулийг хэрэглэдэг.	Адил	Адил	Адил
10	Швед	Бие даасан хуультай	Төрийн мэдэлд	Мэргэшсэн байгууллага	Төсвөөс
11	Англи	Бие даасан хуультай	Төрийн мэдэлд	Мэргэшсэн байгууллага	Төсвөөс
12	Орос	Бие даасан хуультай	Хувийн мэдэлд	Мэргэшсэн байгууллага	Төсвөөс

Аж ахуйн дампуурлын үйл ажиллагааг зохицуулах, өрийн тухайд нэхэмжлэгчийн эрх, хариуцагчийн үүргийг шударгаар шийдвэрлэх, тус харилцаанд оролцогчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах, социалист зах зээлийн эдийн засгийн эмх журмыг хангах зорилгоор тус хуулийг баталсан гэж тодорхойлжээ. Дампуурлын хэргийг хариуцагчийн оршин суугаа газрын шүүх харьяалан шийдвэрлэнэ. Дампуурлыг хэргийг хянан шийдвэрлэхтэй холбогдох тус хуулиар зохицуулагдаагүй харилцааг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасныг баримтална хэмээн хуульчилсан.

Уг хуулийн 3 дугаар бүлэг нь "Хэрэг гүйцэтгэгч" –ийн талаар тусгайлан заасан. Гэхдээ нэр томъёонд оноосон ханз үсгийн хувьд зохион байгуулагч, хэрэг эрхлэгч, эрхлэн гүйцэтгэгч гэсэн утгуудыг агуулж байна. Энэ нь Монгол Улсын Дампуурлын тухай хуулийн "хэрэг гүйцэтгэгч" гэсэн нэр томъёотой утга ойролцоо юм. Мөн 12 дугаар зүйлд зааснаар шүүх хэрэг гүйцэтгэгчийг томилно. Нэхэмжлэгчдийн хурал нь хэрэг гүйцэтгэгчийг хуулийн дагуу, шударгаар үүргээ гүйцэтгэх боломжгүй буюу үүргээ биелүүлэх боломжгүй бусад нөхцөл илэрсэн гэж үзвэл түүнийг солиулахаар шүүхэд хандаж болдог. Хэрэг гүйцэтгэгчийг томилох болон хэрэг гүйцэтгэгчийн цалин хөлсний хэмжээг Дээд шүүхээс тогтоодог байна. Тус хуулийн 23 дугаар зүйлд "Хэрэг гүйцэтгэгч хуулийн дагуу үүргээ гүйцэтгэж, шүүхэд ажлаа тайлагнана. Түүнчлэн Нэхэмжлэгчдийн хурал болон Нэхэмжлэгчдийн зөвлөлийн хяналтанд байна" гэжээ. Мөн 24 дугаар зүйлд "Хэрэг гүйцэтгэгчийг холбогдох

газар, албан байгууллагын ажилтнуудаас бүрдсэн өр барагдуулах алба эсхүл хуулийн дагуу байгуулагдсан хууль зүйн товчоо, нягтлан бодогчдын товчоо, дампуурлын өр барагдуулалтын товчоо зэрэг олон нийтийн зуучлагч байгууллагуудаар гүйцэтгүүлж болно" гэсэн байдаг.

Шүүх нь өртний бодит байдлыг харгалзан, олон нийтийн зуучлагч байгууллагын саналыг зөвлөлдсөний дараа холбогдох мэргэжлийн зохих мэдлэгтэй бөгөөд үйл ажиллага явуулах зөвшөөрөл бүхий этгээдийг хэрэг гүйцэтгэгчээр томилуулдаг байна.

Тус хуулийн 130 дугаар зүйлд зааснаар хэрэг гүйцэтгэгч нь тус хуульд заасны дагуу албан үүргээ хичээнгүйлэн, шударгаар гүйцэтгээгүй тохиолдолд шүүх торгууль оногдуулж болно; нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдэд хохирол учруулсан бол хуулийн дагуу хохирлыг нөхөн төлүүлдэг байна.

НҮБ-ын Олон улсын худалдааны хууль тогтоомжийн хороо /UNCITRAL/-оос янз бүрийн эрх зүйн системтэй 40-өөд улсаар хэлэлцүүлж "Хил дамнасан төлбөрийн чадваргүйдлийг шийдвэрлэх загвар хууль"-ийг батлан гаргасан явдал юм. /UNCITRAL-ын гишүүн 36 орон, ажиглагчаар орсон 40 улс, 13 олон улсын байгууллагын төлөөлөгчдийн өмнө төслийг танилцуулсан./ Энэхүү загвар хуулийг боловсруулах санаачилгыг анх UNCITRAL-аас Олон улсын дампуурлын хэрэг гүйцэтгэгч нарын холбоо /International Association of Insolvency Practitioners-INSOL/-той хамтран гаргасан болно. Энэ асуудлаар мөн Олон улсын өмгөөлөгчдийн холбооны Бизнесийн хууль тогтоомжийн хэсгийн Дампуурлын хорооноос идэвхитэй дэмжлэг зөвлөгөө өгчээ. Хуулийн төслийг дампуурлын салбарт мэргэшиж буй экспертүүдийн олон улсын хурлаар хэлэлцэж сайшаасан байна.

Холбогдох улсуудын шүүх, хэрэг гүйцэтгэгч нарын хооронд харилцаа, хамтын ажиллагааг энэ хуулиар дэмжиж өгсөн. Энэ хуулийн зохицуулалтын хандлага нь мөн зарим төрлийн аж ахуйн нэгжийн тухайд хязгаарагдмал байж болох юм. Тухайлбал банк, даатгалын компани зэрэг тусгай зохицуулалттай аж ахуйн нэгжийн төлбөрийн чадваргүй болсон асуудлыг энэхүү загвар хуулийн хүрээнд хамруулахгүй байх явдлыг дэмждэг.

Дүгнэлт

1.Дампуурлын хуулийн үйлчлэх хүрээг улс бүр өөр өөрөөр хуульдаа тусгасан байна. Ихэнх нь хувийн салбар дахь санхүүгийн хүндрэлийг зохицуулахаар заасан бол зарим орны хувьд төрийн болон хувийн аль ч салбарт үйлчлэхээр хуульчилжээ.

2.Хэрэг гүйцэтгэгчдийг удирдах байгууллагын харьяаллын хувьд төрийн байгууллагад эсхүл ашгийн бус олон нийтийн байгууллагад харъяалуулдаг туршлага түгээмэл байна.

3.Улс орон бүрийн хэрэг гүйцэтгэгчийн эрх үүрэг, хариуцлагын тогтолцоо нь үндсэндээ адил бөгөөд АНУ-д тэдгээрийн үйл ажиллагааны талаар хариуцсан төрийн бус байгууллагын ил тод нээлттэй байнгын сайт ажилладаг байдал, дампуурлын хэргийн талаарх сайн муу кейсүүдийг мэдээлж, сургалт явуулах, зөвлөгөө өгөх үйл ажиллагаа нь онлайнаар явагддаг туршлагууд нь манайд бараг хаалттай байдагтай харьцуулахад шинэлэг хэлбэр болж байна.

4.Дампуурлын болон хэрэг гүйцэтгэлийн үйл ажиллагааны санхүүжилт нь өндөр хөгжилтэй орнуудын хувьд гишүүнчлэлийн /ихэнхдээ томоохон банк санхүүгийн байгууллагуудын санхүүжилтээр/ хөрөнгөөр бүрдүүлдэг

бол европ болон азийн орнуудын хувьд төрийн байгууллагын мэдэлд үйл ажиллагаа нь хэрэгждэг байна.

5. Манай орны хувьд хамгийн зохистой хувилбар бол хэрэг гүйцэтгэгч нь төрийн албан хаагч биш байх бөгөөд харин Хууль зүйн яамны тусгай эрхийн зөвшөөрөлтэй, Дампуурлын хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд ажиллахаар шүүхээс томилогддог, шүүхийн болон нэхэмжлэгчдийн хурлын хяналтанд нь ажиллах хувь хүн байх нь зүйтэй болов уу. Хэрэг гүйцэтгэгч нар нь өөрсдийн сайн дураар нэгдсэн төрийн бус байгууллагын статустай, дотроо Сахилгын болон Эрсдлийн хороотой, тэдгээр нь журмаараа хяналтаа тавьдаг МӨХ шиг үйл ажиллагаа явуулдаг байвал зохимжтой, олон орон энэ хувилбарт шилжиж байна.

6. АНУ-ын Аж ахуйн нэгжийн дампуурлын тухай хуулийн туршлага дээр манай хууль суурилсан тул тухай орны хуулийн сайн талыг дэмжин, мөн хэрэг гүйцэтгэгчдийг удирдах байгууллага нь төрийн бус байгууллагыг сайн ажиллуулж, тэр нь дотроо хяналтын тогтолцоог сайтар боловсронгуй болгох нь илүү зөв арга зам гэж дүгнэж байна.

7.UNCITRAL ба INSOL-ийн хамтын ажиллагааны загвар хууль гаргасан жишээ болон Олон улсын өмгөөлөгчдийн холбооны Бизнесийн хууль тогтоомжийн хэсгийн дотоод бүтэцдээ Дампуурлын хороотой байгаа зэрэг нь манай орны Дампуурлын хэрэг гүйцэтгэгч нарын холбоо эсхүл МӨХолбоо нь дотроо ийм хороотой байж болох ба зах зээлийн эдийн засгийн хөгжлийн хэтийн төлөв нь энэ нэгдэл рүү туршлагажин нэгдэх болно.

Санал

1/ АНУ-ын Henry Cambell Black-ийн 1910 оны хууль зүйн тайлбар толинд "trustee /итгэмжлэгдсэн этгээд/–ийн Trustee in bankruptcy–хэсэгт person гэсэн нэршилээр авч үзсэнийг үндэслэвэл дампуурлын хэрэг гүйцэтгэгч нь дампуурлын хэрэгт хуулийн дагуу төлөөлдөг итгэмжлэгдсэн хувь хүн байхаар тодорхойлогдсон байгаа нь олон улсын жишигтэй уялдуулах шаардлагатай юм.

2/Хэрэг гүйцэтгэгч нь хариуцагчийн үйл ажиллагаанд хувийн санхүү, эдийн засгийн сонирхолгүй, хууль, санхүү, эдийн засгийн дээд боловсролтой хувь хүн байх шаардлага зайлшгүй тавигдаж буй нь дампуурсан аж ахуйн нэгжийг дахин хөрөнгөжүүлэхэд дээрх мэдлэгээс гадна менежерийн ур чадвар, туршлага хэрэгтэй болж байна. Энэ онцлог шаардлагын үүднээс төрөөс мэргэшсэн тусгай зөвшөөрөл зайлшгүй олгогдож, түүнд нь хяналт тавих хэрэгтэй.

3/Хэрэг гүйцэтгэгч нар төрийн бус байгууллагыг байгуулан ажиллаж болох ба тэр байгууллагынхаа хүрээнд хэрэг гүйцэтгэгчид тавих хяналтыг сайжруулан ажиллах боломж байгаа. Жишээ нь Монголын өмгөөлөгчдийн холбоо нь сахилгын хороогоороо өмгөөлөгч нартаа хяналт тавьж, түүний шийдвэрт гомдол гаргавал Хууль зүй, дотоод хэргийн сайд хяналт тавьдагтай адилаар хэрэг гүйцэтгэгч нар төрийн бус байгууллагынхаа ажиллагааг зохион байгуулж болох талтай.

4/Харин хууль зүй, эдийн засаг, санхүүгийн чиглэлээр мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх эрх, үүрэг бүхий хуулийн этгээд байх үндэслэл нь тусгай зөвшөөрөлтэй хүмүүсийн нэгдэл байх болов уу.

5/Манай орны хувьд хэрэг гүйцэтгэгчдийн удирдах байгууллагын хувьд альтернатив буюу олон сонголттой хувилбарыг санал болгож байна. Учир

нь хувийнх нь төрийн бус байгууллага, төр дангаараа, эсхүл хувийн болон төрийн аль ч салбарт үйлчлэхээр 3 хувилбар байж болно.

6/ Төрийн байгууллагын хувьд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяанд байж, тусгай хэлтсийн бүтэцтэй, Дампуурлын хэргийн эхний санхүүжилтийг төрөөс нөхөн төлбөр олгодог журамд оруулан эргүүлэн тооцдог аргачлалаар ажиллаж, өр төлбөрийг барагдуулсан тохиолдолд гарсан зардлаа нөхүүлэн авч төрд эргүүлэн төлдөг зарчмаар ажиллаж болно.

7/Харин үүнтэй уялдуулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай болох бөгөөд шийдвэр гүйцэтгэгч нарыг санхүү, эдийн засаг, дампуурсан аж ахуйн байгууллагыг удирдан ажиллуулж чадах менежерийн мэргэжлээр сайтар бэлтгэх шаардлагатай, эсхүл тийм бэлтгэгдсэн боловсон хүчнээр хангалт хийх хэрэгтэй болно.

8/Мөн Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсэгт заасны дагуу төрийн аудитын байгууллага зарим тохиолдолд хувийн аудитын байгууллагаар санхүүгийн тайлангийн аудитыг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлдэг. Үүнтэй адил Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд дампуурлын тухай хуулийн дагуу ажиллахаар үүрэг оногдвол хариуцан ажиллах хэрэг гүйцэтгэгч/мэдээж тусгай зөвшөөрөлтэй/-ийг гэрээний үндсэн дээр ажиллуулах зэрэг хослосон хувилбар ч хэрэгжүүлж болно.

9/Монгол улсын Дээд шүүхийн тогтоолоор "Дампуурлын хуулинд шүүхийн шийдвэрт гомдол гаргах оролцогч этгээдүүд гэдэгт хэрэг гүйцэтгэгчээс бусад бүх субьектийг багтаан ойлгоно" гэж оруулсан байдаг. Гэтэл хэрэг гүйцэтгэгчийн эрх зөрчигдсөн тохиолдолд хэрхэх талаар зохицуулалт байхгүй байдаг ба хэрэг гүйцэтгэгч эрхээ хэрхэн хамгаалах талаар хуульчилж өгөх нь зүйтэй байна.

Хоёр. "ДАМПУУРЛЫН ХЭРЭГ ҮҮСГЭХ ҮНДЭСЛЭЛҮҮД"-ИЙГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Энэхүү хэсэгт дампуурлын эрх зүйн зохицуулалт - дампуурлын хэрэг үүсгэх үндэслэл, түүний урьдач нөхцөл, шүүх нэхэмжлэл хүлээн авах, хүлээн авахаас татгалзах үндэслэл, хариуцагчийн төлбөрийн чадваргүйг нотлох ажиллагаа, түүний эрх зүйн үр дагавар зэрэг асуудлын хүрээнд Монгол улсын эрх зүйн зохицуулалт болоод гадаад улс орнуудын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судалж, тодорхой дүгнэлтэд хүрэхийг зорив.

Монгол Улсын хувьд дээрх асуудлуудыг зохицуулж буй эрх зүйн эх сурвалж нь:

- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль;
- Дампуурлын тухай хууль байна.

Энэхүү дэд сэдэв нь дээр дурьдсан асуудлын хүрээг хамарсан дараах үндсэн бүтэцтэй байна.

2.2.1.Монгол Улсын эрх зүйн зохицуулалт;

2.2.2.Гадаад орнуудын эрх зүйн зохицуулалт;

2.2.3.Дүгнэлт;

2.2.4.Монгол Улсын эрх зүйн зохицуулалт.

2.1. Монгол Улсын эрх зүйн зохицуулалт

Монгол Улсын Дампуурлын тухай хуульд зааснаар хариуцагчийн хүсэлтээр эсхүл бусад этгээдийн нэхэмжлэлд үндэслэн дампуурлын хэрэг үүсгэдэг ба хариуцагч гэдэгт "төлбөрийн чадваргүй болсон нөхөрлөл, хоршоо, компани, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, хуулийн этгээдийн эрх бүхий төрийн бус байгууллага"-ыг, харин нэхэмжлэгч гэдэгт "хариуцагчаас үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий этгээд"-ийг хамааруулжээ. Өөрөөр хэлбэл, хариуцагч төлбөрийн чадваргүй болсон гэдгийг:

- өөрөө нотолж, дахин хөрөнгөжүүлэх эсхүл дампуурсанд тооцуулж татан буулгах тухай хүсэлт;
- нэхэмжлэгч хариуцагчийн хүлээсэн үүрэг, төлбөрийн хэмжээ, үүрэг гүйцэтгэх хугацаа, дахин хөрөнгөжүүлэх, дампуурсанд тооцуулах тухай саналаа тусгасан нэхэмжлэл нь шүүхээс дампуурлын хэрэг үүсгэх үндэслэл болж байна.

Дээрхээс үзвэл, нэхэмжлэгч хариуцагчийг дампуурсанд тооцуулах тухай нэхэмжлэл гаргахдаа түүнийг үүргээ гүйцэтгэх, төлбөр төлөх тухай холбогдох нотлох баримтыг бүрдүүлэн өгөх үүрэгтэй ба энэхүү үүрэгт нэхэмжлэгчийн зүгээс хариуцагч үүргээ гүйцэтгэх тухай шүүхийн шийдвэр гарсан байхыг заавал шаардахгүй ба Улсын Дээд Шүүх/УДШ/-ийн 2000 оны "Дампуурлын тухай Монгол Улсын хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай" №01 тогтоолын дагуу хариуцагчийн үүргээ гүйцэтгэхтэй холбоотой асуудлыг дампуурлын хэрэгтэй хамтатган шийдвэрлэхээр тайлбарласан байна.

Төлбөрийн чадваргүй болсон гэдгийг УДШ-ийн 2000 оны №1 тогтоолд "хариуцагч банкин дах харилцах болон тооцооны хадгаламжийн данс түүнчлэн өөрийн кассанд бэлэн мөнгөний хүрэлцээгүйгээс нэхэмжлэгчээс нийлүүлсэн буюу худалдан авсан бараа, бүтээгдэхүүн, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний үнэ хөлс, мөн банкны болон бусдаас олгосон зээлийг төлөх зэрэг зээл тооцооны харилцаанд хүлээсэн, өөрийн хөрөнгийн 10-аас доошгүй хувьтай тэнцэх үүргээ хууль буюу гэрээнд заасан хугацаанд биелүүлж чадахгүй байгааг ойлгоно" хэмээн тайлбарлажээ. Тус тайлбарт хариуцагч ямар хугацаанд үүргээ гүйцэтгэхгүй байгаа тохиолдолд нэхэмжлэгч дампуурлын хэрэг үүсгүүлэхээр нэхэмжлэл гаргах хууль зүйн боломжтой талаар тусгаагүй байгаа нь хэрэв хариуцагч өөрийн хөрөнгийн 10 буюу түүнээс доошгүй хувьтай тэнцэх үүргээ гүйцэтгэж чадахгүй тохиолдолд нэхэмжлэгч нь шаардах эрхээ хэрэгжүүлэх ерөнхий хугацаанд шүүхэд хандах боломжтой байна гэх дүгнэлтэд хүргэж байна. Мөн Монгол улсын хуулийн дагуу хувь хэмжээний үндсэн дээр төлбөрийн чадвараа алдсаныг тогтоох нь практикт шүүмжлэлд өртдөг асуудал юм.

Шүүхээс хариуцагчийн төлбөрийн чадваргүй болсон гэдгийг тогтоох нь дампуурлын хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа цааш үргэлжлэх эсэхийг шийдвэрлэх гол үндэслэл болно. Шүүх хариуцагчийг төлбөрийн чадвараа алдаагүй гэдгийг тогтоовол дампуурлын хэргийг хэрэгсэхгүй болгож, зохигчдын өр төлбөрийн асуудлыг Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хэрэг хянан шийдвэрлэх ердийн журмаар шийдвэрлэнэ. Харин хариуцагчийг төлбөрийн чадвараа алдсаныг тогтоосноос хойш 7 хоногийн дотор хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, улмаар энэ нь хариуцагчаас үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий этгээдүүд нэхэмжлэл гаргах эрхээ хэрэгжүүлэх хууль зүйн боломжийг олгоно. Мөн

шүүхээс ИХШХШТХуульд заасан шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авах үндэслэл болно. Монгол улсын дампуурлын эрх зүйн практикийн хувьд компанийг төлбөрийн чадваргүй гэдгийг тогтоох нь компанийг дампуурсанд тооцож, улмаар татан буулгах гол үндэслэл болж болно.

2.2. Гадаад орнуудын эрх зүйн зохицуулалт

Судалгааны хүрээнд ХБНГУ, ОХУ, Их Британи, Болгар улс, БНТурк улсын эрх зүйн зохицуулалтыг авч үзсэн болно. Эдгээр улс нь судалгааны хүрээнд хөндөгдөж буй асуудлыг тодорхой зохицуулсан ба ОХУ, Болгар улс нь Монгол Улсын эрх зүйн адил төсөөтэй зохицуулалттай, ХБНГУ, БНТурк улс, Их Британий хувьд дампуурлын эрх зүйн зохицуулалт нь нилээдгүй боловсронгуй байдаг зэрэг шалтгаанаар эдгээр улсын хууль тогтоомжийг сонгон эрх зүйн харьцуулсан судалгааг хийсэн болно.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын эрх зүйн зохицуулалт

ХБНГУ-ын дампуурлын эрх зүйн эх сурвалж нь 2009 онд батлагдсан Дампуурлын тухай хууль юм.

Дампуурлын хэрэг үүсгэх үндэслэл: Дампуурлын хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг үүсгэхийн тулд хүсэлт гаргахыг шаардах ба энэ талаар Дампуурлын тухай хуулийн 13.1-р зүйлд заасан байдаг. Хүсэлтийг хариуцагч өөрөө мөн нэхэмжлэгч гаргаж болно. Тодруулж хэлбэл эдгээр нь хүсэлт гаргах эрхтэй.

Дампуурлын хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг үүсгэх нийтлэг үндэслэл нь төлбөрийн чадваргүй байдал ба хариуцагч хүсэлт гаргах тохиолдолд ирээдүйд үүсэж болох төлбөрийн чадваргүй байдал буюу тодруулбал, үүсээд байгаа төлбөр төлөх үүргүүдээ тухайн цаг хугацаанд өөрийн чадвараар гүйцэтгэх боломжгүй гэдгээ урьдчилан тооцож буй нөхцөл байдлыг ойлгох юм. Нэхэмжлэгч шаардлагаа хуульд заасан бүхий л нотлох хэрэгслийн тусламжтайгаар нотолж болно. Үүнд мөн эд хөрөнгийн мэдүүлэг хамаарна. Үүний зэрэгцээ нэмэлт баримт бичгүүд тухайлбал, санхүүгийн баримтууд, үүргийг нотолсон баримт бичиг, үүргээ гүйцэтгэхийг сануулсан баримтыг шүүхэд өгөх ёстой. Хүсэлт гаргах үүргийн талаар Дампуурлын тухай хуулиар зохицуулаагүй ба харин компанийн болон иргэний эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулсан байдаг.

Төлбөрийн чадваргүй болсонд тооцох: Үүрэг гүйцэтгэгч төлбөр төлөх үүргээ гүйцэтгэх боломжгүй нөхцөл байдлыг ойлгоно. Үүрэг гүйцэтгэгч жижиг хэмжээний үүргийг гүйцэтгэх чадвартай байгаа нь төлбөрийн чадваргүй байдлыг үгүйсгэхгүй. Хэрвээ үүрэг гүйцэтгэгч үүргээ үргэлжилсэн хугацаанд гүйцэтгэх боломжгүй нь урьдчилсан байдлаар тодорхой байгаа тохиолдолд төлбөрийн чадваргүй байдал бий болсон гэж илүүтэйгээр үзнэ. Богино хугацааны дотор /нийтлэг тохиолдолд 3 долоо хоног/ боломжтой байж болох зээл авах хүртэлх хугацаанд төлбөрөө төлж чадахгүй байгаа нь төлбөрийн чадваргүй байдалд тооцогдохгүй. Үүрэг гүйцэтгэгч төлбөрөө төлөхөө зогсоосныг төлбөрийн чадваргүй байдалд хамруулж үздэг.

ХБНГУ-ын Дампуурлын тухай хуулийн 16 дугаар зүйлд "дампуурлын хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг үндэслэл байгаа тохиолдолд үүсгэнэ" гэж заасан байдаг. Энэ хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "үүсгэх нийтлэг үндэслэл нь төлбөрийн чадваргүй байдал" гэж заасан ба 2 дахь хэсэгт "дээр дурдсаны дагуу төлбөрийн чадваргүй байдал гэдэгт төлбөр

төлөх үүргээ гүйцэтгэх боломжгүй нөхцөл байдлыг хэлнэ" гэж тодорхойлоод үүрэг гүйцэтгэгч төлбөр төлөх үүргээ зогсоосныг төлбөрийн чадваргүй байдалд тооцохыг мөн зөвшөөрсөн байна.

Хуулийн 18 дугаар зүйлээр ирээдүйд үүсэж болох төлбөрийн чадваргүй байдлын талаар зохицуулсан байдаг. 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "үүрэг гүйцэтгэгч дампуурлын хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг үүсгүүлэхээр хүсэлт гаргасан тохиолдолд хэрэг үүсгэх бас нэг үндэслэл нь ирээдүйд үүсэж болох төлбөрийн чадваргүй байдал байна" гэж зохицуулсан байна. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт үүсээд байгаа төлбөр төлөх үүргээ цаг хугацаандаа биелүүлэх боломжгүй байдлыг ирээдүйд үүсэж болох төлбөрийн чадваргүй байдал гэж үзэхээр зохицуулсан байна. Хуулийн 19 дүгээр зүйлд өрийн хэмжээ хэтрэх тухай зохицуулсан ба энэ зүйлийн 1 дэх хэсэгт хуулийн этгээд эсхүл хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын хувьд өр хэтрэх нь дампуурлын хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг үүсгэх бас нэг үндэслэл байна гэж заажээ. Хариуцагчийн хөрөнгө нь төлбөрийн шаардлагыг хангахад хүрэлцэхээргүй болсныг өр хэтэрсэн гэж үзэх бөгөөд өр хэтэрсэн эсэхийг тогтоохдоо 2 шаттайгаар бүрэлдэхүүнийг шалгана. Эхний шатанд актив пассивыг харьцуулан үзсэний үндсэн дээр өр хэтрэлтийн баланс болон үйл ажиллагааг үргэлжлүүлэх талаарх прогноз гарна. Дараагийн шатанд хөрөнгийн байдлыг байгууллагын төлөх өртэй харьцуулан үнэлж татан буулгах эсэх талаарх үнэлгээ гарна. Актив пассивыг харьцуулан үнэлснээр санхүүгийн талаасаа өр хэтэрсэн нь тогтоогдвол байгууллагын үйл ажиллагааг цааш үргэлжлүүлэх эсэх талаарх эерэг, сөрөг прогнозын аль нэг нь гарна. Энэхүү прогнозын дагуу байгууллагын санхүүгийн хүчин чадал үйл ажиллагааг үргэлжлүүлэхэд хангалттай бол үргэлжлүүлнэ.

Төлбөрийн чадваргүй болсон гэж тооцсоны эрх зүйн үр дагавар:

Өр хэтрээгүй гэдэг нь тогтоогдвол дампуурлын шүүхээс үндэслэл байхгүй тул хэрэг үүсгэхээс татгалзана. Хэрвээ хариуцагчийн хөрөнгө төлбөрийн шаардлагыг хангахад хүрэлцэхээргүй нь тогтоогдвол Дампуурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу өр хэтэрсэн гэдгийг тогтоож улмаар дампуурлын хэрэг үүсгэж дампуурлын төлөвлөгөөний зорилгын дагуу юуны өмнө тухайн тохиолдолд дампуурлын хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг уян хатан, эдийн засгийн хувьд үр нөлөөтэй хэрэгжүүлэх арга хэмжээг авна.

Дахин хөрөнгөжүүлэх боломжтой дараах нийтлэг хэлбэрүүд байдаг:

- Хямралын гол шалтгаан нь тухайлсан хувь этгээдээс хамааралтай байх;
- Дампууралд хүргэх болсон шалтгааныг богино хугацаанд арилгах боломжтой байх;
- Эдийн засгийн байдалтай хамааралтай эсхүл бүтцийн шинжтэй проблем байх.

Дампуурлын ажиллагааны дүнд татан буулгахад хүргэзд байгаа зүйлээс чөлөөлөх замаар эсхүл ачаалал болж буй нөхцөл байдлыг /өндөр настныг асрах, эд хөрөнгө хөлслөх гэрээ, лизингийн гэрээгээр хүлээсэн үүрэг/ хүндрэлгүйгээр арилгах боломжтой тохиолдолд тухайн байгууллагыг зарчмын хувьд дахин хөрөнгөжүүлэх боломжтой гэж үздэг. Харин дээр дурдсан дахин хөрөнгөжүүлэх асуудал нь нэхэмжлэгч болон хариуцагчид аль алинд нь ач холбогдолгүй хэмээн үзвэл шүүх төлбөрийн чадваргүй болсон

компанийг дампуурсныг зарлаж, татан буулгах ажиллагааг хэрэгжүүлж эхэлнэ.

Турк улсын эрх зүйн зохицуулалт

Турк улсын дампуурлын эрх зүйн үндсэн эх сурвалжийн хувьд 2003 онд батлагдсан "Дампуурлын болон гүйцэтгэлийн тухай хууль" №4949 юм. Тус хууль 107 зүйлтэй ба 2004 онд нэмэлт оруулсан.

Дампуурлын хэрэг үүсгэх үндэслэл: Дээрх хуулийн дагуу дампуурлын хэрэг үүсгэх гол үндэслэл нь үүрэг гүйцэтгэгч хугацаа нь хэтэрсэн үүргээ гүйцэтгээгүй байх тохиолдол юм. Өөрөөр хэлбэл, Туркийн дампуурлын хуульд үүрэг гүйцэтгэгчийн гүйцэтгэх үүрэг/актив/ үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардах эрх/пассив/-ээс илүү байх нь дампуурах үндэслэл болохгүй. Мөн актив нь пассиваас илүү байгаа үүрэг гүйцэтгэгч активаа мөнгөн хөрөнгөд хөрвүүлж чадаагүй гэх үндэслэлээр хугацаа хэтэрсэн үүргээ гүйцэтгэж чадахгүй бол нэхэмжлэгчид шүүхэд хүсэлт гаргаж болно. Үндсэндээ Туркийн хуульд дампуурлын хэрэг үүсгэх ерөнхий үндэслэл нь үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгээгүй байх явдал юм.

Зөвхөн нэхэмжлэгчид мөнгөн хөрөнгөний хувьд үүрэг гүйцэтгэгчийн эсрэг дампуурлын хэрэг үүсгэж болох тухай хуульчилсан. Мөнгөн хөрөнгөний дүн нь 50000 ам.долларт хүрсэн тохиолдолд нэхэмжлэгч шүүхэд хандан нэхэмжлэл гаргах эрх үүснэ. Үүрэг гүйцэтгэгчийн хувьд ч мөн адил 50000 ам.долларт тэнцэх үүргээ гүйцэтгэх чадваргүй гэдгээ нотлон шүүхэд хүсэлт гаргаж болно.

Туркийн Дампуурлын болон гүйцэтгэлийн тухай хуульд нэг онцлог зохицуулалт байдаг нь 89 дүгээр зүйлд "Дампуурлын хэргийг шууд үүсгэх үндэслэл"-ийг заасан. Шууд дампуурлын хэрэг үүсгэх гэдэгт нэхэмжлэгчид зарим үндэслэлээр эхлээд шийдвэр гүйцэтгэх газар дампуурлын ажиллагаа эхлүүлэх хүсэлт тавилгүйгээр, үүрэг гүйцэтгэгч төлбөрийн захирамж илгээлгүй шууд худалдааны шүүхэд дампуурлын хэрэг үүсгэхийг ойлгоно.

Шууд дампуурлын хэрэг үүсгэх үндэслэлүүд нь:

a/ Үүрэг гүйцэтгэгчийн хаяг тодорхой бус,

b/ Нэхэмжлэгчдийн эрхийг зөрчин залилангийн үйл ажиллагаа явуулах,

c/ Дээрх үйлдэл хийхийг завдах,

d/ Битүүмжлэх ажиллагааны үед хөрөнгөө нуух зэрэг болно.

Төлбөрийн чадваргүй болсонд тооцох: Турк улсын хуулийн зохицуулалтын дагуу дампууралтай холбоотой хэрэг маргааныг Дээд шүүх харъяалан шийдвэрлэх эрх хэмжээтэй ба шүүх нь хүсэлт, нэхэмжлэлд дурдсан нотлох баримтыг үндэслэн компанийг төлбөрийн чадваргүй хэмээн тооцох эрх хэмжээтэй. Төлбөрийн чадваргүй гэж тооцох гол үндэслэл нь тус хуульд заасан 50000 ам.доллар буюу түүнээс их хэмжээний мөнгөн хөрөнгийн үүргээ гүйцэтгэж чадахгүй гэдгийг тодорхойлж хариуцагчийг төлбөрийн чадваргүй гэх шийдвэр гаргана.

Төлбөрийн чадваргүй болсон гэж тооцсоны эрх зүйн үр дагавар: Шүүх нь хүсэлт, нэхэмжлэлд дурдсан нотлох баримтыг үндэслэн компанийг төлбөрийн чадваргүй хэмээн тооцох ба энэ тохиолдолд дампуурлын хэрэг үүсгэнэ. Харин төлбөрийн чадвартай хэмээн тогтоовол шийдвэр гарган хэргийг энгийн шүүхэд шилжүүлнэ. Дампуурлын хэрэг үүсгэн хэргийг хянан шийдвэрлэх процессын ажиллагаа хийх ба уг процессын үр дүнд:

- компанийг дахин хөрөнгөжүүлэх
- компанийн дампуурсныг зарлан, татан буулгах үйл ажиллагаа явуулна.

Сүүлийн тохиолдолд компанийн хувьцааг хөрөнгийн биржээр арилжаалж, эд хөрөнгийг дуудлага худалдаанд оруулах ба үл хөдлөх эд хөрөнгийг барьцаанд тавьж болохоор хуульд заажээ.

Их Британий эрх зүйн зохицуулалт

Их Британий хувьд дампуурлын эрх зүйн харилцааг 1986 оны "Дампуурлын акт" /Insolvency Act/, 2006 оны Компанийн Акт /Companies Act/ болон 2002 оны Аж ахуйн нэгжийн Акт /Enterprise Act/-аар зохицуулдаг. "Дампуурлын акт" нь 19 хэсэг, 444 зүйлээс бүрддэг. Уг актын дагуу татан буулгах /liquidation/ болон дампуурах /bankruptcy/ ажиллагааг ялгаатай байдлаар авч үзсэн байна. Өөрөөр хэлбэл, хувь хүн болон нөхөрлөлийн хувьд дампуурал, компанийн хувьд татан буугдах асуудал яригддаг байна. Нэр томьёоны хувьд ялгаатай байдлаар хэрэглэсэн боловч агуулгын хувьд авч үзвэл компанийг татан буулгах үндэслэлд компани дампуурах асуудлыг авч үзсэн байна.

Дампуурлын хэрэг үүсгэх үндэслэл: Компанийг татан буулгах талаар Дампуурлын актад зохицуулсан байдаг талаар дээр дурдсан. Тус актад компанийг:

/1/ сайн дурын үндэслэлээр буюу компани өөрийн хүсэлт, шийдвэрээр;

/2/ шүүхээр албадан татан буулгах хоёр хэлбэрийг зохицуулсан.

Компанийг сайн дурын үндэслэлээр татан буулгах нь компани сайн дурын үндсэн дээр тусгай тогтоолыг гаргаж, компани дотроосоо татан буугдагчийг томилж, өөрөө өр төлбөрөө сайн дурын үндсэн дээр төлж барагдуулдаг процесс юм. Харин шүүхээр компанийг албадан татан буулгах 7 үндэслэлийг хуульчилсан ба тэдгээр нь:

a/ Шүүхээр татан буулгах талаар тусгай тогтоолыг компаниас гаргавал;

b/ Бүртгүүлснээсээ хойш 1 жил өнгөрсөн боловч дүрмийн сангийн хамгийн бага хэмжээг бүрдүүлэх хэмжээний хувьцааг худалдаалж чадаагүй;

c/ Компанийн актын Хавсралт 3-ын хамаарах нийтийн компани байвал;

d/ Нэг жилийн турш бизнесийн үйл ажиллагаагаа түдгэлзүүлснээс хойш 1 жилийн дотор үйл ажиллагаагаа эхлүүлээгүй байвал;

e/ Хоёроос доош гишүүн үлдсэн хувьцаагаар эсхүл баталгаагаар хязгаарлагдсан компаниас бусад компани байвал;

f/ Өрөө төлөх чадваргүй болсон;

g/ Шүүх компанийг татан буулгах талаар санал гаргасан.

Дээр дурдсан үндэслэл /f/-д заасан "өрөө төлөх чадваргүй" болсон гэдгийг дампуурсан гэх ойлголттой адил байдлаар ойлгож болох ба учир нь компани нь төлбөрийн чадваргүй болсноор дампуурдаг. Их Британи эрх зүйн зохицуулалтын хувьд компанийг өрөө төлөх төлбөрийн чадваргүй болсноор дампуурах буюу татан буугдах асуудлыг авч үзжээ хэмээн дүгнэж болохоор байна. Өөрөөр хэлбэл, компани өрөө төлөх чадваргүй болсны улмаас татан буулгах нь нэхэмжлэлийн шаардлагын үндсэн дампуурах үйл явц юм.

Өмнө дурдсанаас үзвэл, дампуурлын хэрэг нь:

• Компанийн өөрийн санаачлагаар;

• Хөндлөнгийн этгээдийн буюу шүүхийн болон нэхэмжлэгчийн санаачилгаар үүсдэг байна хэмээн товч дүгнэж болохоор байна. Харин нэхэмжлэгч хариуцагч-компанийг өрөө төлөх чадваргүй гэдгийг хэрхэн нотлох буюу шаардах эрхээ зайлшгүй шүүхийн шийдвэрээр баталгаажуулсан байх тухай тусгайлсан зохицуулалт Их Британий эрх зүйн эх сурвалжуудад байхгүй байна.

Компанийг татан буулгах үндэслэлийн нэг нь компани төлбөрийн чадваргүй болсон гэж үзэх, түүнийг тодорхойлох асуудал юм.

Төлбөрийн чадваргүй болсонд тооцох: Дараах тохиолдолд компанийг төлбөрийн чадваргүй болсон гэж үзнэ:

a. Зээлдүүлэгчид 750 фунтаас дээш хэмжээний өрөө төлөөгүй бөгөөд зээлдүүлэгч бичгээр шаардлага хүргэсэн боловч 3 долоо хоногийн турш өрөө төлөх үүргээ гүйцэтгээгүй;

b. Англи болон Уэльсд, компанийн зээлдүүлэгчийн талд шийдвэрлэсэн аливаа шүүхийн захирамж, шүүхийн шийдвэрийг бүхлээр нь эсхүл зарим хэсгийг хангаагүй;

c. Шотландад, ашиг өгөх шийдвэр, ашиг өгөх бүртгэгдсэн өрийн бичиг эсхүл ашиг өгөх бүртгэгдсэн эсэргүүцлийн ашгийн төлбөрийг хийхгүйгээр хугацаа хэтрүүлсэн;

d. Хойд Ирландад, компанийн эсрэг гарсан шүүхийн шийдвэрт заасан хэрэгжүүлж болохгүй сертификат олгогдсон;

e. Компанийг өрөө төлөх чадваргүй гэдгийг шүүх хангалттай нотлох баримтаар тогтоосон зэрэг байна.

Их Британий хувьд компанийг төлбөрийн чадваргүй болсон гэж үзэхдээ компанийн өөрийн хөрөнгийн хувь хэмжээг үл харгалзан 750 фунтаас дээш хэмжээний өрөө төлөөгүй хэмээн тогтоож өгсөн байгаа нь Монгол улсын хувь хэмжээ тогтоосон аргачлалтай харьцуулахад илүү хялбарчилсан байна гэж дүгнэж болохоор байна. Мөн нутаг дэвсгэрийн байршлаар төлбөрийн чадваргүй болсон гэдгийг ялгаатай байдлаар тогтоох тухай зохицуулсан байна.

Төлбөрийн чадваргүй болсон гэж тооцсоны эрх зүйн үр дагавар: Компанийг төлбөрийн чадваргүйг тогтоосны дараагаар түр үүрэг гүйцэтгэгчийг шүүх томилно. Түр үүрэг гүйцэтгэгч нь компанийн ирээдүйн талаар мэргэжлийн хүрээнд дүгнэлт хийн шүүхэд ирүүлж, шүүх түүнийг үндэслэн компанийг дахин хөрөнгөжүүлэх, татан буулгах эсэхийг шийдвэрлэн эцсийн шийдвэрээ гаргадаг.

Болгар улсын эрх зүйн зохицуулалт

Болгар улсын дампуурлын эрх зүйн зохицуулалтын хүрээнд тус харилцааг тусгайлан зохицуулсан хууль байдаггүй бөгөөд компанийн дампуурлын харилцааг 1991 оны Корпорацийн актаар зохицуулж байсан банкны дампуурлын талаар тусгайлсан хуулийг 2002 онд Үндэсний Дээд Ассемблейгээс баталсан. Банкны дампуурлын тухай хууль нь банкны байгууллагын дампуурлын харилцааг нарийвчлан зохицуулсан 10 бүлэг, 112

зүйлтэй. Тус хуулийн дараагаар 2003 онд Дампуурлыг дахин санхүүжүүлэх тухай хуулийг батлан гаргасан. Судалгааны хүрээнд Болгар улсын дампуурлын эрх зүйн ерөнхий зохицуулалтыг бус тусгайлсан зохицуулалт болох Банкны байгууллагын дампуурлын эрх зүйн зохицуулалтыг илүүтэй судалсан болно.

Дампуурлын хэрэг үүсгэх үндэслэл: Дампуурлыг дахин санхүүжүүлэх тухай хуульд дампуурлын хэрэг үүсгэх ерөнхий зарчмын дагуу хариуцагч өөрөө хүсэлт эсхүл нэхэмжлэгч нэхэмжлэл гаргадаг бол Банкны дампуурлын тухай хууль банкны байгууллагад холбогдуулан дампуурлын хэрэг үүсгэх тухай гомдлыг Төв банк шүүхэд гаргахаар заасан байна. Төв банк арилжааны банкийг дампууруулах тухай гомдол гаргах үндэслэл нь хариуцагч банк нь зайлшгүй байх ёстой Хадгаламжийн даатгалын санд байршуулах ёстой хөрөнгөө байршуулахгүй байх эсхүл байнга байршуулах ёстой хэмжээнд хүрэхгүй байх тохиолдол болно. Хуулийн 8 дугаар зүйлээр Төв банкны гомдлын дагуу шүүхээс түр гүйцэтгэгч томилохгүйгээр шууд дампуурлын хэрэг үүсгэж хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулна. Энэ нь банкны харилцагчдыг эрсдэл, хохирлоос хамгаалж буй арга хэмжээ юм.

Төлбөрийн чадваргүй болсонд тооцох: Шүүх Төв банкны ирүүлсэн гомдол, тодорхойлолт, хавсаргасан нотлох баримтыг үндэслэн хариуцагч банкийг төлбөрийн чадваргүй хэмээн шууд тооцон дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлдэг. Гэхдээ хуулийн 17 дугаар зүйлийн дагуу хариуцагч банк нь Төв банкны тодорхойлолтыг хүлээн зөвшөөрөхгүй шүүхэд гомдол гаргаж болно. Хариуцагч банк Төв банкны эсрэг гомдол гаргасан тохиолдолд тус асуудлыг тусгай шүүх эцэслэн шийдвэрлэтэл дампуурлын хэрэг үүсгэх шийдвэр түр зогсоно.

Төлбөрийн чадваргүй болсон гэж тооцсоны эрх зүйн үр дагавар: Ийнхүү төлбөрийн чадваргүйд тооцох нь банкний аливаа үйл ажиллагааг шүүхийн шийдвэрийн дагуу түр зогсоох үндэслэл болно. Шүүхээс хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхээс Төв банкны төлөөлөгчийг оролцуулан гүйцэтгэгчдийн комисс томилох бөгөөд хариуцагч банк Төв банктай дахин санхүүжих тухай гэрээ байгуулж болно. Төлбөрийн чадваргүй хэмээн тооцуулсан банк нь дахин санхүүжих боломжгүй тохиолдолд шүүхээс банк дампуурсны зарлан, татан буулгах комиссыг томилж шийдвэр гаргана.

ОХУ-ын эрх зүйн зохицуулалт

Тус улсын хувьд дампуурлын харилцааг зохицуулдаг эрх зүйн гол эх сурвалж нь 2002 оны 10 дугаар сарын 26-ны өдөр батлагдсан 12 бүлэг 233 зүйлтэй Төлбөрийн чадваргүй болсон буюу дампуурлын тухай холбооны хууль /Федеральный закон о несостоятельности /банкротстве// юм.

Дампуурлын хэрэг үүсгэх үндэслэл: Дээрх хуулийн 6 дугаар зүйлд зааснаар дампуурлын хэрэг нь арбитрын харъяалалд хамаарах бөгөөд хэрэг үүсгүүлэхээр хандах эрх бүхий этгээд нь:

1. Хариуцагч өөрөө;
2. Зээлдүүлэгч;
3. Төлбөр төлүүлэх шаардлага бүхий татварын болон бусад төрийн байгууллага байна.

Харин гэм хороос учирсан хохирлыг нөхөн төлүүлэх шаардлага гаргагч нэхэмжлэгч, төрийн байгууллага болон хувьцаа эзэмшигч нь дампуурлын хэрэг үүсгүүлэхээр шүүхэд хандах эрхгүй болно.

Хуульд тодорхойлсноор хариуцагч гэдэг нь "иргэн, ялангуяа хувиараа үйлдвэрлэл эрхлэгч, эсхүл зээлдүүлэгчийн шаардаж буй мөнгөн төлбөрийн үүргээ биелүүлэх эсхүл энэ хуульд заасан хугацаанд гүйцэтгэх ёстой төлбөр тооцооны үүргээ биелүүлэх чадваргүй хуулийн этгээд" байна. Хариуцагч нь төлбөрийн чадваргүй болсон гэдгээ нотлох баримт байгаа бол шүүхэд гомдол гаргаж болно. Мөн хариуцагч-компанийн гүйцэтгэх захирал нь дараах тохиолдолд арбитрт дампуурлын хэрэг үүсгүүлэхээр өргөдөл гаргаж болно:

- Нэг болон түүнээс дээш зээлдүүлэгчийн шаардлага нь зээлдэгчийг үүргээ биелүүлэх.
- боломжгүй байдалд хүргэж байвал;
- Хариуцагчийн үүсгэн байгуулах баримт бичгээр хариуцагчийг татан буулгах тухай шийдвэр гаргах эрх хэмжээ олгогдсон этгээд арбитрын шүүхэд хандан өргөдөл гаргах шийдвэр гаргасан бол;
- Хариуцагч-нэгдсэн үйлдвэрийн эд хөрөнгийг өмчлөх эрх олгогдсон этгээд арбитрын шүүхэд хандан өргөдөл гаргах шийдвэр гаргасан зэрэг болно.

Төлбөрийн чадваргүй болсонд тооцох: Хуулийн этгээд нь төлбөр тооцооны болон мөнгөн төлбөрийн үүргээ биелүүлэх ёстой байсан хугацаа өнгөрснөөс хойш гурван сарын дотор үүргээ биелүүлээгүй бол зээлдүүлэгчид мөнгөн төлбөрөө төлөх чадваргүй буюу төлөх ёстой төлбөр тооцооны үүргээ биелүүлэх чадваргүй гэж үзнэ.

Төлбөрийн чадваргүй болсон гэж тооцсоны эрх зүйн үр дагавар: Компанийг дампууруулах тухай хэрэг үүсгүүлэхээр өргөдөл, нэхэмжлэл гаргагч этгээд нотлох баримтыг арбитрт гаргах ба дараах зүйлийг дурдсан буюу тусгасан байна. Гол нь нэхэмжлэлийн шаардлага нь 100 000 рублиэс багагүй бөгөөд үүнийгээ төлөх төлбөрийн чадваргүй гэдгийг нотлох баримтуудыг гарган өгсөн тохиолдолд арбитр төлбөрийн чадвараа алдсан эсэхийг тогтоосны дараа дампуурлын хэрэг үүсгэнэ. Харин хүчин төгөлдөр болсон шүүх эсхүл арбитрын шийдвэрээр хариуцагч төлбөрийн чадваргүй гэдэг нь хангалттай нотлогдож байвал арбитр дампуурлын хэрэг үүсгэхээр хуулийн зохицуулалттай байна.

БНХАУ-ын эрх зүйн зохицуулалт

Дампуурлын хэрэг үүсгэх үндэслэл: БНХАУ-ын Аж ахуйн дампуурлын тухай хуулийн 7 дугаар зүйлд зааснаар аж ахуйн хуулийн этгээд нь хугацаандаа төлбөрөө барагдуулах боломжгүй, түүнчлэн хөрөнгө нь өр төлбөрийг бүхэлд нь төлөхөд хүрэлцэхгүй эсхүл чадвар нь мэдэгдэхүйц хүрэлцэхгүй тохиолдолд шүүхэд хандаж дахин хөрөнгөжих, эвлэрэх, эсхүл дампуурсанд тооцож төлбөрөө барагдуулахаар хүсэлт гаргаж болно гэж заасан байна. Нэхэмжлэлд дараах зүйлүүдийг тусгасан байна гэж тухайлан заажээ. Үүнд:

1.Хүсэлт гаргагч, хүсэлт гаргуулагчийн үндсэн байдал;

2.Хүсэлт гаргах зорилго;

3.Хүсэлт гаргах болсон бодит байдал болон үндэслэл;

4.Шүүхээс тогтоох шаардлагатай бусад зүйлүүд.Хариуцагч хүсэлт гаргаж байгаа бол эд хөрөнгийн талаарх тодорхойлолт, өрийн данс бүртгэл, нэхэмжлэлийн данс бүртгэл, санхүүгийн тайлан, ажилтны зохион байгуулалт, цалин хөлсний төлбөр, нийгмийн даатгалын зардал зэргийг тушаасан байдлыг гаргаж өгнө. Үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий тал дампуурлын хэрэг үүсгэх тухай нэхэмжлэл гаргасан бол шүүх нэхэмжлэлийг хүлээж авснаас 5 хоногийн дотор хариуцагчид мэдэгдэнэ. Хариуцагч тухайн нэхэмжлэлд өөр саналтай бол шүүхийн мэдэгдлийг хүлээн авснаас 7 хоногийн дотор шүүхэд хандаж хүсэлтээ гаргана. Шүүх өөр санал гаргах хугацаа дуусах өдрөөс тооцож 10 хоногийн дотор хүлээн авах эсэхийг шийдвэрлэнэ.

Тус заалтаас өөр тохиолдолд шүүх нэхэмжлэлийг хүлээж авснаас хойш 15 хоногийн дотор нэхэмжлэлийг хүлээж авах эсэхийг шийдвэрлэнэ. Онцгой тохиолдолд тухайн 2 заалтад заасан нэхэмжлэл хүлээн авахыг шийдвэрлэх хугацааг хойшлуулж болно. Шүүх дампуурлын хэрэг үүсгэх тухай хүсэлтийг хүлээж авах талаар гаргасан шийдвэрийг 5 хоногийн дотор хүсэлт гаргагчид мэдэгдэнэ.

Хүсэлтийг хүлээж авч шийдвэрлэх боломжгүй гэсэн шийдвэр гарсан тохиолдолд шалтгааныг заавал дурдана. Хэрвээ хүсэлт гаргагч тус шийдвэрийг хүлээж авахгүй бол шийдвэрийг хүлээж авснаас 10 хоногийн дотор дээд шатны шүүхэд давж заалдаж болно. Шүүх хүсэлтийг хүлээн авснаас хойш дампуурлыг зарлахаас өмнө хүртэл хариуцагч тус хуулийн 2 дугаар зүйлд заасан нөхцөл үүсээгүй болохыг шалгаж тогтоовол хүсэлтийг буцаах тухай шийдвэр гаргаж болно. Хүсэлт гаргагч тухайн шийдвэрийг хүлээж авах боломжгүй гэж үзвэл шийдвэрийг хүлээж авснаас хойш 10 хоногийн дотор дээд шатны шүүхэд давж заалдах эрхтэй.

Дүгнэлт

"Дампуурлын хэрэг үүсгэх үндэслэлүүд"-ийг тодорхойлох судалгааны хүрээнд Монгол улсын дампуурлын эрх зүйн зохицуулалт болон гадаад улсын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судалсны үндсэн дээр дараах дүгнэлтүүдийг хийж холбогдох саналыг дэвшүүлж байна.

1. Монгол Улсын дампуурлын хуульд зохицуулсны дагуу дампуурлын хэрэг нь хариуцагчийг төлбөрийн чадвараа алдсан гэх үндэслэл бүхий хүсэлт, нэхэмжлэлээр шууд үүсгэгддэг. Бусад улсын хувьд зарчим нь Монгол улсын эрх зүйн зохицуулалттай төстэй боловч дампуурлын хэрэг үүсгэх гол үндэслэл нь үүргээ төлөөгүй байх болон төлбөрийн чадваргүй болох нь тогтоогдсон байх явдал байдаг байна. ОХУ-ын Дампуурлын хуулийн дагуу компанийг дампууруулах хүсэлтийг төрийн эрх бүхий байгууллага гаргахаар хуульчилсан байна. Энэ нь тодорхой онцгой салбар, тус салбарын онцлогийг харгалзсан зохицуулалт болсон байна. Дампуурлын хэрэг үүсгэх, үүсгүүлэх тухай хүсэлт, нэхэмжлэлийг шүүх, арбитрт гаргахаар зохицуулсан байна. Төлбөрийн чадваргүй гэж үзэхэд зарим улсын хувьд тодорхой хуулийн хугацаа өнгөрсөн байх тухай ч мөн заасан байна.

2.Монгол Улсын хувьд шүүх хэрэг үүсгэн тодорхой ажиллагаа явуулсны дараа хариуцагчийг төлбөрийн чадвараа алдсан эсэхийг тогтоох ба түүнээс

өмнө хариуцагчийг тодорхой үүрэг гүйцэтгэх тухай шүүхийн шийдвэр заавал гарсан байхыг хууль зүйн хувьд шаарддаггүй. Компани эсхүл нэхэмжлэгч нь төлбөрийн чадвараа алдсаныг нотлох нотлох баримтад хамаарч болохоор байна. Судалгааны хүрээнд харьцуулан судалсан 3 улсын хувьд мөн адил зохицуулалт байх ба тийнхүү өмнө нь хариуцагч үүрэг гүйцэтгэх тухай гарсан шийдвэр нь нотлох баримтын чанартай бичиг баримтад тооцогдохоор байна гэж дүгнэж болох юм. ОХУ-ын Дампуурлын хуульд тодорхой хуульчилсан байна. Харин төрийн эрх бүхий байгууллагын гаргасан зарим шийдвэр нь дампуурлын хэрэг үүсгэх шууд үндэслэл болдог.

3.Төлбөрийн чадвар алдсаныг тогтоохдоо Монгол Улсын хувьд тодорхой үнийн дүнг бус хөрөнгийн 10 хувиар тогтоосон байна. Гадаад улсуудын хувьд эрх зүйн зохицуулалтын хүрээнд төлбөрийн чадвараа алдсаныг тогтоох өөр өөр аргачлалыг ашигладаг. Тухайлбал, Их Британид шууд биелүүлээгүй байгаа үүргийн гүйцэтгэлийн үнийн дүнгийн хэмжээгээр тогтоох тухай хуульчилжээ.

4.Хариуцагчийг төлбөрийн чадвараа алдсаныг хүсэлт, нэхэмжлэл хүлээн авсан шүүх, арбитр тогтоох эрхтэй. Ийнхүү төлбөрийн чадвараа алдсаныг тогтоох нь эрх зүйн үр дагаварын хувьд чухал ач холбогдолтой. Хэрэв компани төлбөрийн чадвараа алдаагүй тохиолдолд шүүх дампуурлын хэргийг хэрэгсэхгүй болгон зохигчдын хоорондын харилцааг хэрэг хянан шийдвэрлэх нийтлэг журмаар үргэлжлүүлдэг бол төлбөрийн чадвараа алдсан гэж тогтоосон тохиолдолд дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа цааш үргэлжлэн шүүх өөрийн гаргах шийдвэрийн баталгааг хангах арга хэмжээ авах, нэхэмжлэгчдийн хурлыг хуралдуулах, компанийг дахин хөрөнгөжүүлэх эсхүл дампуурсныг зарлан татан буулгах, нэхэмжлэгчдийн нэхэмжлэлийн шаардлагыг хангах зэрэг онцгой ажиллагаанууд явагддаг нь тухайн хариуцагчийн оршин тогтнох эсэх, үйл ажиллагаагаа цаашид явуулах эсэхийг шийдвэрлэдэг үр дагавартай байдаг. Уг үр дагавар нь аливаа улсын хууль тогтоомжийн хүрээнд адил байдлаар хуульчлагдсан байна.

5.Түүнчлэн авч хэрэгжүүлэх арга хэмжээний хувьд ч мөн адил аль ч улс орнууд хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх арга хэмжээг нэн тэргүүнд авахыг эрхэмлэдэг нь эрх зүйн зохицуулалтад тусгалаа олсон байна.

Гурав. "ХУВЬЦААТ БОЛОН ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ДАМПУУРЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ"

Энэхүү хэсэгт Монгол Улсын дампуурлын эрх зүйн зохицуулалтыг Хувьцаат компани болон Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьд хэрхэн ялгамжтай зохицуулсан, ямар онцлог зохицуулалтуудыг тусгасан байдгийг гадаад орнуудын дампуурлын эрх зүйн зохицуулалттай харьцуулан судлах болно.

Дампуурлын тухай хуульд зааснаар хариуцагчийн хүсэлтээр эсхүл бусад этгээдийн нэхэмжлэлд үндэслэн дампуурлын хэрэг үүсгэдэг ба хариуцагч гэдэгт "төлбөрийн чадваргүй болсон нөхөрлөл, хоршоо, компани, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, хуулийн этгээдийн эрх бүхий төрийн бус байгууллага"-ыг хамааруулжээ. Судалгааны явцад

Иргэний хууль, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Дампуурлын тухай хууль, Компанийн тухай хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг судлахад хувьцаат компани болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийг хооронд нь ялгаатай байдлаар хуульчлаагүй бөгөөд Дампуурлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-д зааснаар ерөнхийлөн зохицуулсан байна. Өөрөөр хэлбэл, хувьцаат компани болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьд нэгэн ижил зохицуулалт үйлчлэхээр заасан байна.

Дампуурлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2.2-т татан буулгах ажиллагаа дуусгавар болмогц хэрэг гүйцэтгэгч энэ тухай бүртгэх байгууллагад мэдэгдэж, улсын бүртгэлээс хасуулна гэжээ. Хөрөнгийн биржийн мэдээлэл лавлагаанаас лавлахад хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьд зөвхөн улсын бүртгэлээс хасуулах бол хувьцаат компаний хувьд Улсын бүртгэлээс хасуулахаас гадна Хөрөнгийн биржийн бүртгэлээс хасуулдаг байна.

Монгол Улсын Компанийн тухай хуулиар хувьцаат компани нь "хувь нийлүүлэгчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа нь нийтэд чөлөөтэй арилжаалагддаг" бол хязгаарлагдмал хариуцлагатай компани нь "хувь нийлүүлэгчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, түүнийг захиран зарцуулах эрх нь компанийн дүрмээр хязгаарлагддаг" гэсэн ерөнхий онцлогтой. Гэтэл дампуурлын тухай хуулиар дампуурлын хэрэг үүсгэснээр эсхүл үүсгэхээс өмнөх хугацаанд нээлттэй буюу хувьцаат компанийн хувьцааг хөрөнгийн бирж дээр арилжаалахыг зогсоох эсхүл үргэлжлүүлэн арилжаалах эсэх асуудлыг зохицуулаагүй байгаа тул хувьцаат болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дампуурлын эрх зүйн зохицуулалтын ялгаа харагдахгүй байна. Өөрөөр хэлбэл, хувьцаат компанийн хувьд хөрөнгийн бирж дээр хувьцаа гаргах замаар дахин хөрөнгөждөг онцлогтой боловч манай улсад ийнхүү хувьцаа гаргах замаар дахин хөрөнгөжүүлэх эсэх асуудлыг авч үзээгүй байна.

3.1.АНУ-ЫН ДАМПУУРЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

АНУ-ын Үндсэн Хуулийн 1 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт Конгресст холбооны хэмжээнд дагаж мөрдөгдөх хүчин чадал бүхий акт боловсруулах эрхийг олгосон байна. Энэхүү бүрэн эрхийнхээ хүрээнд 1978 онд Дампуурлын Шинэчлэлийн акт буюу 11 бүлэг бүхий, Дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх хууль батлан гаргасан нь одоог хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. АНУ-ын Дампуурлын төрөлжсөн шүүхэд дампуурлын хэрэг үүсгэхэд холбооны хуулийг хэрэглэдэг бол мужийн хуулийг зээлдүүлэгчдээс хариуцагчийн хөрөнгийг хамгаалах зэрэг хөрөнгийн эрхийг тодорхойлоход хэрэглэдэг байна. АНУ-ын Дампуурлын Хуулийн дагуу дампуурлын харилцааг зохицуулах бөгөөд хувьцаагаа нийтэд чөлөөтэй худалддаг компани болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дампуурлын эрх зүйн зохицуулалтын хувьд төдийлөн ялгаа байхгүй боловч тус кодексын 7 болон 11 дүгээр бүлгийн хувьд ялгааг гаргаж ирэхийг зорилоо.

Нэхэмжлэгч болон хариуцагчийг тодорхойлсон байдал:

Хариуцагч:

Уг хуулийн дагуу хариуцагчид хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл, хувь хүнээс бусад хувьцаат компани, хувьцаат бус /unincorporated/ компани болон нөхөрлөлийг хамааруулдаг байна.[489] Өөрөөр хэлбэл, хувьцаагаа нийтэд арилжаалдаг компани болон хязгаарлагдмал хариуцлагатай компаниуд нэгэн адил хариуцагч байна.

Нэхэмжлэгч:

АНУ-ын Дампуурлын хуулиар нэхэмжлэгч буюу зээлдүүлэгч гэдэгт хариуцагчийн эсрэг шүүх ажиллагааны үед болон түүнээс өмнө шаардлага гаргаж буй этгээд, компанийн тусгайлан заасан эд хөрөнгийн хувьд шаардлага гаргаж буй этгээд болон хамтын шаардлага /community claim/ гаргаж буй этгээдүүдийг хамааруулдаг байна.[490]

Дампуурлын хэрэг үүсгэх журам: АНУ-ын холбогдох хуулинд дүн шинжилгээ хийх явцад дампуурлын хэргийг сайн дурын /voluntary/ болон сайн дурын бус /involuntary/ хүсэлтийг үндэслэн үүсгэх боломжтой байна. Төлбөрийн чадваргүйд тооцох тухай асуудлыг тусгайлан зохицуулаагүй бөгөөд өрөө төлж чадахгүй бол... гэсэн ерөнхий шаардлагын хүрээнд хүсэлт гаргах үндэслэлийг зохицуулжээ. Хэрэв зээлдэгч буюу хариуцагч өөрөө дампуурах тухай хүсэлт гаргаж байгаа бол түүнийг сайн дурын үндсэн дээр дампуурах гэж ойлгох бөгөөд зээлдүүлэгчдийн зүгээс хүсэлт гаргах замаар дампуурлын хэргийг үүсгэж байгаа бол түүнийг сайн дурын бус гэж ойлгоно. Дампуурлын хэрэг үүсгэх асуудлын хувьд хувьцаагаа нийтэд чөлөөтэй арилжаалдаг компани болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьд ялгаатай байдлаар зохицуулсан зүйл алга байна.

Хүсэлт гаргах журам: Зээлдүүлэгч нь дампуурлын хэрэг үүсгүүлэх тухай хүсэлтийн хувийг шүүхийн нарийн бичигт гаргах бөгөөд түүнийг цааш Нэгдсэн Улсын итгэмжлэгдсэн төлөөлөгчид /Trustee of United States/ шилжүүлдэг.[491] Хэрвээ нэхэмжлэгчдийн тоо 12 болон түүнээс дээш байвал тэдгээрийн хүсэлтийг нэгтгэх ажиллагааг хэрэгжүүлдэг. Хариуцагч буюу зээлдэгч нь сайн дурааараа дампуурч байгаа тохиолдолд компанийн бүх эд хөрөнгийн жагсаалтыг хүсэлтэндээ хавсаргах бөгөөд эд хөрөнгөд өөрчлөлт орох бүрт нэн даруй мэдэгдэж байхаар заасан байна. Монгол Улсын Дампуурлын хуульд заасанчлан зээлдэгч буюу хариуцагч өөрөө хүсэлтээрээ дампуурч байгаа тохиолдолд хүсэлт гаргаж, нэхэмжлэгчдийн зүгээс шүүхэд хүсэлт гаргах замаар ялгаатай байдлаар хуульчилсан байхад АНУ-ын хувьд ийнхүү ялгасан зүйл байхгүй, сайн дурааараа болон зээлдүүлэгчдийн шаардлагаар хэрэг үүсгэж байгаа бол хүсэлт /petition/ гаргахаар хуульчилсан байна.

Хүсэлт гаргах явцад хариуцагч буюу зээлдэгч нь хувьцаа эзэмшигч бүрийн нэр, албан ёсны хаяг, тэдгээрийн эзэмшиж буй хувьцааны тоо, хэмжээ, ангилал зэргийг багтаасан мэдээллийг хүргүүлэх ёстой бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед уг мэдээллийг олон нийтэд танилцуулах эрхийг шүүхэд олгосон байдаг. Ийнхүү хуульчилж өгснөөр хувьцаагаа нийтэд арилжаалдаг компанийн хувьд илүү нарийн төвөгтэй ажиллагаа үүсгэх боломжтой юм.

[489] 101 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, АНУ-ын Дампуурлын хууль.

[490] Уг хуулийн 101 дүгээр зүйлийн 10 дах хэсэг.

[491] 1002b, АНУ-ын Дампуурлын хэрэг хянан шийдвэлэх ажиллагааны тухай хууль, 2009.

Шүүх хүсэлтийг хүлээн аваад хэрэг үүсгэхээс татгалзах эсхүл хэрэг үүсгэх тухай захирамж гарган, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлэх гэсэн 2 процесс ажиллагааг эхлүүлдэг байна.[492] Судалгааны явцад ажиглагдсан зүйл бол АНУ нь дампуурлын төрөлжсөн шүүхтэй учир түүний үйл ажиллагаанд хэрэглэгдэх тусгайлсан хуультай бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь манай улсын Иргэний Хэрэг Шүүхэд Хянан Шийдвэрлэх Тухай Хуулийн нэгэн адил нарийвчилсан зохицуулалтыг оруулж өгсөн байна.

АНУ-ын Дампуурлын эрх зүйн зохицуулалтын нэгэн онцлог бол жижиг бизнес /small business debtor/-ийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг зээлдэгч буюу хариуцагчийн асуудлыг онцгойлон авч үздэг байна. Сайн дурын үндсэн дээр дампуурч байгаа бол тухайн хариуцагч нь жижиг компани мөн эсэхийг тодорхойлох ёстой. Хэрвээ жижиг компанийн дампуурлын хэргийг хянан шийдвэрлэх гэж байгаа бол хариуцагчийн зүгээс гаргаж өгсөн нотлох баримт, мэдүүлэгт үндэслэн хэргийг шийдвэрлэх бөгөөд шүүхийн зүгээс нэмэлт ажиллагаа явуулан уг мэдүүлгийн үнэн зөвийг шалгах шаардлагагүй байдаг байна. Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьд жижиг компанийн хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулах нь хувьцаагаа нийтэд арилжаалдаг компаниудаас илүү боломжтой учир энэхүү давуу тал нь ХХК-ийн хувьд илүү яригдах боломжтой юм.

7 дугаар бүлэг/Chapter 7/-ийн дагуу сайн дурын бус үндсэн дээр татан буугдаж байгаа тохиолдолд дотоод итгэмжлэгдсэн этгээдийг томилдог байна. Мөн түүнчлэн, дампуурлын хэрэг үүсгэснээс хойш зээлдүүлэгчдийн болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг итгэмжлэгдсэн этгээд нь зарлан хуралдуулахаар заасан.[493] Түүнээс гадна хувьцаа эзэмшигчдийн тусгай хороог байгуулж болох[494]-оор хуульчилсан. Уг хороонд компанийн хувьцааны ихэнх хэсгийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчдийг томилох бөгөөд тэдгээр нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед бусад хувьцаа эзэмшигчдийг мэдээллээр хангах, өөрсдийн эрх, ашгаа хамгаалах үйл ажиллагаа явуулахаар заажээ.

Компанийн эд хөрөнгийг хуваарилах ажиллагааны явцад үнэт цаас, болон компанийн хувьцааг барьцаалсан зээлдэгч нь уг үнэт цаасны үнийг тогтоох[495] талаар хуульчилсан боловч компанийн үнэт цаасны үнэлгээ нь маш бага хэмжээнд байдаг.

Компанийг дампуруулах талаар хүсэлт гаргах эрхтэй этгээдүүдэд компани өөрөө, түүний захирал эсхүл нэг болон түүнээс дээш гишүүн, эрх хүлээн авагч, санхүүгийн хэрэг эрхлэх газар хамаарах бөгөөд ийнхүү компанийн нэг болон түүнээс дээш гишүүн хэмээн зааж өгснөөрөө хувьцаагаа нийтэд арилжаалдаг компани болон хаалттай компанийн хувьд процедурын ялгаа харьцангуй байх боломжтой.

Дахин хөрөнгөжүүлэх: 7 дугаар бүлгийн дагуу гомдол гаргасан тохиолдолд тухайн компанийг хязгаарлагдмал хариуцлагатай болон хувьцаагаа нийтэд арилжаалдаг эсэхийг үл харгалзан үйл ажиллагааг нь зогсоож татан буулгах бөгөөд харин 11 дүгээр бүлгийн дагуу шүүх болон талуудын зүгээс өөрөөр шаардаагүй бол компанийг дахин хөрөнгөжүүлэхийн

[492] 1013, АНУ-ын Дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажмллагааны тухай хууль, 2009.
[493] § 1102a, 11 дугаар бүлэг, Дампуурлын хууль, АНУ.
[494] 341,, 3 дугаар дэд бүлэг, 3 дугаар бүлэг, Дампуурлын хууль, АНУ.
[495] 3012, АНУ-ын Дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажмллагааны тухай хууль, 2009.

тулд хувьцаат компанийн хувьд хувьцааг нь Нью-Йорк болон NASDAQ-ийн хөрөнгийн бирж дээр хувьцаагаа чөлөөтэй арилжаалах замаар дахин хөрөнгө босгох боломжийг нь хангасан байна.[496] Үүнтэй холбоотойгоор хувьцаагаа нийтэд арилжаалдаг компаниудын хувьд 11 дүгээр бүлгийн дагуу гомдол гаргах явдал элбэг байдаг.

Дахин хөрөнгөжүүлэх зорилгоор хувьцаа гаргаж, худалдаж байгаа бол Үнэт цаасны тухай 1933 оны актын зарим зүйл, заалтууд үйлчлэхгүй, мөн түүнчлэн мужийн эрх бүхий байгууллагад төлбөл зохих холбогдох татвар, хураамжаас чөлөөлөгдөхөөр заасан. Ийнхүү хувьцаа гаргаж буй компанийн хувьд дарамтыг багасгаснаар хувьцаагаа нийтэд арилжаалдаг компани болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьд ижил хэмжээнд боломж олгож байна.

Дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг батлах ажиллагаа нь зөвхөн нэхэмжлэгч буюу зээлдүүлэгчдийн хүрээнд явагддаггүй байна. Өөрөөр хэлбэл, хувьцаа эзэмшигчид нь хорооноос гаргасан дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг хүлээн зөвшөөрснөөр шүүхийн зүгээс уг төлөвлөгөөг батлах нэг шалгуур хангагдсан гэж үздэг. Үүнээс үүдэн, хувьцаат компанийн хувьд хувьцаа эзэмшигч бүртэй харилцаж, тэдгээрийн зөвшөөрлийг авахын тулд илүү нарийн буюу цаг хугацаа их шаардсан харилцаа үүсэх нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийг бодвол их байна.

Дээрхээс дүгнэн үзвэл, АНУ-ын хувьд хувьцаагаа нийтэд арилжаалдаг компани болон хязгаарлагдмал хариуцлагатай компаниудын дампуурлын эрх зүйн зохицуулалтын хувьд ялгаа байхгүй боловч зохицуулалт нь хувьцаагаа нийтэд арилжаалдаг компанийн хувьд илүү нарийн төвөгтэй бөгөөд ашигтай зохицуулалтууд хуульчлагдсан байна.

3.2.ИХ БРИТАНИ УЛСЫН ДАМПУУРЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Их Британи улс дахь компанийн төрөл

Компанийн дампуурлын эрх зүйн зохицуулалтын онцлог, ялгаатай шинж байдлыг авч үзэхийн тулд юуны өмнө компанийн төрлүүдийг нь авч үзэх хэрэгтэй. Компанийн эрх зүйн зохицуулалтын гол эх сурвалж нь 2006 оны Компанийн акт /Companies Act/ юм. Энэхүү Компанийн актад зааснаар компанийн дараах төрлүүд байдаг:[497]

1.Хязгаарлагдмал болон хязгаарлагдмал бус компани /Limited and unlimited companies/;

2. Хувийн болон нийтийн компани /Private and public companies/;

3. Баталгаагаар болон хувьцааны хөрөнгөөр хязгаарлагдсан компани /Companies limited by guarantee and having share capital/ ;

4.Нийтийн ашиг сонирхол бүхий компани /Community interest companies/

Их Британи улсын хувьд компанийн нилээн олон төрлүүдийг авч үзсэн байна. Үүнээс компанийн эрх зүйн харилцааг хичнээн нарийвчлан зохицуулсан байгааг нь харж болно. Компанийн дампуурлын онцлог, ялгааг авч үзэх нь энэхүү судалгааны ажлын зорилго учир дээрх төрлүүдийг тодорхойлж, нарийвчлан авч үзэхийг зорьсонгүй.

[496] 1108, 11 дугаар бүлэг, Дампуурлын хууль, АНУ.

[497] Companies act, 2006, UK, articles 3-6.

Харин компанийн төрлүүдээр нь дампуурлын асуудлыг хэрхэн ялгамжтай зохицуулсныг авч үзье.

Дампуурлын актад /1986/-д зааснаар хувьцаагаа нийтэд арилжаалдаг /public company/ компанийн хувьд үүсгэн байгуулагдсан өдрөөс нь хойш 1 жил өнгөрсөн боловч дүрмийн сангийн хамгийн бага хэмжээг бүрдүүлэх хэмжээний хувьцааг худалдаалж чадаагүй бол шүүхийн зүгээс татан буулгахаар зохицуулсан. Мөн хувьцаагаар эсхүл баталгаагаар хязгаарлагдсан хувийн компани /private company limited by shares/-ийн хувьд гишүүдийн тоо 2 болон түүнээс доош болсон ч гэсэн татан буулгах үндэслэл болохгүй, нөгөө талаас компанийн бусад төрлүүдийн хувьд энэ нь татан буугдах үндэслэл болохоор зохицуулсан байна.

Компанийн төлбөрийн чадваргүй болсон гэж үзэхдээ компанийн өөрийн хөрөнгийн хувь хэмжээг үл харгалзан 750 фунтаас дээш хэмжээний өрөө төлөөгүй гэх үндэслэлийг шууд авч үзсэн. Мөн-төлбөрийн чадваргүй болсон гэдгийг компанийн төрлөөр бус нутаг дэвсгэрийн байдлаар ялгаатай зохицуулсан байна.

Дампуурлын акт /1986/-д зааснаар татан буулгах процесс нь дараах үе шатаар явагддаг:

- Компани, захирал эсхүл зээлдүүлэгч нь компанийг татан буулгах тухай;
- Хүсэлтийг шүүхэд гаргах. Эдгээр нь тусдаа болон хамтдаа хүсэлт гаргаж болно;
- Шүүх компанийг татан буулгах тухай хэргийг үүсгэх;
- Шүүх хэрэг гүйцэтгэгчийг томилох;
- Хэрэг гүйцэтгэгч татан буугдах болсон үндэслэл, шалтгааныг нягтлан шалгах;
- Татан буулгах тухай шийдвэрийг шүүхээс гаргах;
- Төлбөр нэхэмжлэгчдийн жагсаалтыг гаргах.

Шүүх компанийг татан буулгах тухай шийдвэрийг гаргасны дараа компанийн өртэй этгээдийн жагсаалтыг гаргаж, хөрөнгийг хуваарилна.

Өр төлбөрийг төлөхдөө шүүх дараах шийдвэрийг гаргана:[498]

а/ Хязгаарлагдмал бус компани /unlimited company/ байгаа тохиолдолд, тухайн компанийн байгуулсан гэрээ эсхүл бие даасан тохиролцоонд компанийг төлөөлсөн этгээдийн аливаа хөрөнгөөр өр төлбөрийг нөхөн төлөхийг зөвшөөрөх, гэхдээ компанийн гишүүн болох тухайн этгээдийн дивиденд болон ашигтай холбоотой хөрөнгө хамаарахгүй;

b/ Хязгаарлагдмал компани /limited company/ байгаа тохиолдолд, захирал болон менежерийн хязгаарлагдсан хариуцлагатай холбогдох түүний хөрөнгөөр өр төлбөрийг төлөхийг зөвшөөрөх;

Татан буулгах шийдвэр гаргасны дараа өр төлбөрийг төлөх нөхөн төлбөрт хамаарах хөрөнгийн хувьд хязгаарлагдмал болон хязгаарлагдмал бус компанийн тухайд дээрх байдлаар ялгаатай зохицуулсан байна.

[498] Insolvency act, 1986, UK, article 149 /2/.

3.3.ОХУ-ЫН ДАМПУУРЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Компаний төрөл

ОХУ-ын хувьд дампуурлын харилцааг зохицуулдаг эрх зүйн актууд нь:

• ОХУ-ын иргэний хууль 1994 он;

• Дампуурлын тухай Холбооны хууль 2002 он /компани болон хувь хүний дампуурлыг зохицуулахаас гадна зарим төрийн өмчит компаниудыг зохицуулсан. Жишээлбэл: Росатом, Ростехнологи гэх мэт/;

• Зээлийн байгууллагыг татан буулгах тухай хууль 1999 он;

• Жам ёсны монополь болох шатахуун болон эрчим хүчний салбарын дампуурлыг зохицуулах тухай 1999 он \2009 оныг хүртэл хүчин төгөлдөр байсан\;

Дампуурлын харилцааг зохицуулдаг гол хууль болох төлбөрийн чадваргүйн \дампуурлын\ тухай холбооны хууль буюу Федеральный закон о несостоятельности /банкротстве/ нь 12 бүлэг 233 зүйлтэйгээр 2002 оны 10 дугаар сарын 26-ны өдөр батлагдсан байна.

Дампуурлын ажиллагаа: Энэхүү хуулийн 6 дугаар зүйлд зааснаар дампуурлын хэрэг нь арбитрын харъяалалд хамаарах бөгөөд хэрэг үүсгүүлэхээр хандах эрх бүхий этгээд нь:

- Хариуцагч өөрөө;
- Зээлдүүлэгч;
- Төлбөр төлүүлэх шаардлага бүхий татварын болон бусад төрийн байгууллага

Харин гэм хороос учирсан хохирлыг нөхөн төлүүлэх шаардлага гаргагч нэхэмжлэгч, төрийн байгууллага болон хувьцаа эзэмшигч нь дампуурлын хэрэг үүсгүүлэхээр шүүхэд хандах эрхгүй болно.

Хариуцагч:

Хариуцагч гэдэг нь иргэн, ялангуяа хувиараа үйлдвэрлэл эрхлэгч, эсхүл зээлдүүлэгчийн шаардаж буй мөнгөн төлбөрийн үүргээ биелүүлэх эсхүл энэ хуульд заасан хугацаанд гүйцэтгэх ёстой төлбөр тооцооны үүргээ биелүүлэх чадваргүй хуулийн этгээд болно.

ОХУ-ын иргэний хуулийн 50 дугаар зүйлд зааснаар хуулийн этгээдийг ашгийн болон ашгийн бус гэж ангилах ба ашгийн хуулийн этгээд гэдэгт Монгол Улсын компанийн тухай хуульд заасан компанийн төрлүүдтэй төстэй дараах нэгдлүүд орно.

1.Хязгаарлагдмал хариуцлагатай компани \Общество с ограниченной ответственностью\- нэг буюу хэд хэдэн хуулийн этгээд, хувь хүний байгуулсан, өөрийн хөрөнгө нь хувьцаанд хуваагддаг, компанийн оролцогч нар компанийн өөрийн хөрөнгөнөөс эзэмшдэг хувьцааныхаа үнийн дүнгээр компанийн үйл ажиллагаатай холбоотойгоор эрсдлийг хуваалцаж, хариуцлага хүлээнэ.

2.Хувьцаат компани:

a.Нээлттэй хувьцаат компани \открытых акционерных обществ;

b.Хаалттай хувьцаат компани \закрытых акционерных обществ.

Хариуцагч нь төлбөрийн чадваргүй болсноо нотлох баримт байгаа бол гомдол гаргаж болно \8 дугаар зүйл\.

Мөн хариуцагч байгууллагын гүйцэтгэх захирал нь дараах тохиолдолд арбитрт дампуурлын хэрэг үүсгүүлэхээр өргөдөл гаргаж болно:

• Нэг болон түүнээс дээш зээлдүүлэгчийн шаардлага нь зээлдэгчийг үүргээ биелүүлэх боломжгүй байдалд хүргэж байвал;

• Хариуцагчийн үүсгэн байгуулах баримт бичгээр хариуцагчийг татан буулгах тухай шийдвэр гаргах эрх хэмжээ олгогдсон этгээд арбитрын шүүхэд хандан өргөдөл гаргах шийдвэр гаргасан бол;

• Хариуцагч-нэгдсэн үйлдвэрийн эд хөрөнгийг өмчлөх эрх олгогдсон этгээд арбитрын шүүхэд хандан өргөдөл гаргах шийдвэр гаргасан зэрэг болно.

Ерөнхийдөө дампуурлын хэрэг үүсгүүлэхээр хариуцагч буюу зээлдэгч өөрөө арбитрт хандахад тухайн хариуцагч нь хязгаарлагдмал хариуцлагатай компани эсхүл хувьцаат компани уу гэдгээс үл шалтгаалан адил зохицуулсан байна.

Төлбөрийн чадваргүйд тооцох: Хуулийн этгээд нь төлбөр тооцооны болон мөнгөн төлбөрийн үүргээ биелүүлэх ёстой байсан хугацаа өнгөрснөөс хойш гурван сарын дотор үүргээ биелүүлээгүй бол зээлдүүлэгчид мөнгөн төлбөрөө төлөх чадваргүй буюу төлөх ёстой төлбөр тооцооны үүргээ биелүүлэх чадваргүй гэж үзнэ.

Хариуцагч нь хуулийн этгээд бол нэхэмжлэлийн шаардлага нь 100'000 рублиэс багагүй бөгөөд дээр дурдсан төлбөрийн чадваргүй гэж үзэх үндэслэлтэй эсхүл тэр нь хүчин төгөлдөр болсон шүүх эсхүл арбитрын шийдвэрээр нотлогдож байгаа бол дампуурлын хэрэг үүсгэнэ.

Дампуурлын үйл ажиллагаа дараах таван үе шатаар явагддаг ба эдгээрийн гурав нь тухайн зээлдэгчийн үйл ажиллагааг аварч үлдэхэд чиглэсэн ажиллагаанууд байна:

1/ Ажиглалт /Наблюдение/ 62-75 дугаар зүйл\;

2/ Дахин хөрөнгөжүүлэх \76-92 дугаар зүйл\;

3/ Гадаад удирдлага \93-123 дугаар зүйл\;

4/ Эвлэрлийн гэрээ \150-167 дугаар зүйл\;

5/ Татан буулгалт \124-149 дугаар зүйл\.

Зээлдэгч нар дампуурлын эдгээр үе шатыг бүгдийг нь заавал дамжин өнгөрөхийг чухалчилдаггүй. Хэрэв зээлдэгч татан буугдах бүх шалгуурыг хангасан бөгөөд шүүх түүнийг дахин хөрөнгөжүүлэх боломжгүй гэж үзсэн тохиолдолд шууд татан буулгаж болно. \75 дугаар зүйл\

1/ Ажиглалт: Францийн хандлагад суурилсан. Хэрэг үүсгэх тухай шүүхийн шийдвэр гарснаас хойш шүүхээс дараах зорилгоор 30 хоногийн хугацаа тогтооно.

I.зээлдэгчийн эд хөрөнгийг хамгаалах;

II.түүний санхүүгийн байдлыг тодруулах;

III.зээлдүүлэгч нарыг тогтоох;

IV.зээлдэгчийн цаашдын үйл ажиллагааны талаар шийдвэр гаргуулахаар зээлдүүлэгчдийн анхны хурлыг зохион байгуулах;

V.шүүхээс түр зохион байгуулагчийг томилох.

Ажиглалтын үе үргэлжлэх хамгийн дээд талын хугацаа 7 сар хүртэл байна. Түүний төгсгөлд дараах ажиллагаануудын аль нэгийг явуулахаар шүүх шийдвэр гаргана.

a/ Дахин хөрөнгөжүүлэх эсхүл гадаад удирдлага томилох талаар;

b/ Зээлдэгчийн дампуурсанд тооцож татан буулгах;

c/ Дахин хөрөнгөжүүлж дампуурлын үйл ажиллагааг зогсоох тухай.

2/ Дахин хөрөнгөжүүлэх: Зээлдэгчийн санхүүгийн чадавхийг дахин дээшлүүлж зээлдэгчийг дампуурлаас аврах нэг хэлбэр юм. Зээлдүүлэгчдийн нэхэмжлэлийн шаардлагаас өөрийгөө чөлөөлөх зээлдэгчийн идэвхгүй үйл ажиллагаа бөгөөд ихэвчлэн хувьцаа эзэмшигч нар санаачилдаг. Санхүүг нь дахин сэргээх төлөвлөгөө буюу зээлээ эргүүлэн төлөх графикийг зээлдүүлэгч нарын хурлаар болон шүүхээр батлуулдаг.

Хувьцаа эзэмшигч эсвэл /удирдлага нь компанийн хяналтыг хадгална /зарим хяналтыг шүүх болон зээлдүүлэгч нарын хуралд шилжүүлнэ/. Төлбөр тооцоо, өр төлбөрөө барагдуулах үүрэг үлдэнэ, үүргээ биелүүлэх гэрээнээс татгалзаж болохгүй, хувьцааны үйл ажиллагаанд саад хийхгүй \тухайн хувьцааны үнийг өмнөх гэрээний үнээр биш санхүүг нь дахин сэргээх төлөвлөгөөгөөр дахин тогтооно/ байх гэх зэрэг ажиллагаанууд явагдана. 2 жил хүртэлх хугацаанд үргэлжилнэ. Хэрэв энэ хугацаанд зээлдүүлэгчдийн шаардлагаас чөлөөлөгдөж чадаагүй бол зээлдүүлэгчдийн хурлын шийдвэрээр шүүх гадаад удирдлагын эсхүл татан буулгах шийдвэр гаргана.

3/ Гадаад удирдлага: Шүүхээс зээлдэгчийн гүйцэтгэх захирлын эрх мэдлийг хэрэгжүүлэх гадаад удирдлагыг томилох замаар зээлдэгчийг дампуурлаас аврах нэг хэлбэр юм.

Энэ арга нь ОХУ-д илүү өргөн хэрэглэгддэг. Гадаад удирдлага нь зээлдүүлэгчдийн хурлаар баталсан гадаад удирдлагын төлөвлөгөөний дагуу бүхий л худалдааны үйл ажиллагаанд хяналт тавина.

Энэ үеийн давуу тал нь зээлдүүлэгчдийн шаардлага болон татварын өрийг төлөх хугацааг хойшлуулдаг. Түүнчлэн торгууль болон бусад шийтгэлийн өсөлтийг түдгэлзүүлдэг /одоо төлөх ёстой төлбөрөөс бусад/. зээлдэгчийн эд хөрөнгийн эсрэг албадлагаас сэргийлдэг /2008 оны нэмэлтээр барьцаат зээлдүүлэгч нь барьцаалагдсан хөрөнгийг худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар зааснаас бусад тохиолдолд санхүүг дахин сэргээхтэй ижил журам үйлчилнэ/; үүргээ биелүүлэх гэрээнээс гарах удирдлагын эрхийг сэргээдэг. Хугацаа нь 18 хүртэл сар байх бөгөөд 6 сараар сунгаж болно. Санхүүг нь дахин сэргээх болон гадаад удирдлагыг хамтад нь 2 жилээс хэтрүүлэхгүй байлгаж болно, зээлдүүлэгчдийн хурлаас гарсан шийдвэрийг үндэслээд шүүх хэргийг хэрэгсэхгүй болгох эсхүл зээлдэгчийг татан буулгах шийдвэр гаргана /2008 оны нэмэлтээр зээлдүүлэгчдийн хурлын шийдвэргүйгээр аль нэг оролцогчийн өргөдөлд үндэслэн шүүх татан буулгах тухай захирамж гаргаж болно/.

4/Эвлэрлийн гэрээ: Зээлдэгч, зээлдүүлэгч, төрийн байгууллага нь дампуурлын үйл ажиллагааны аль ч үе шатанд дахин хөрөнгөжүүлэх хэлцэл байгуулж болно. Дахин хөрөнгөжүүлэх хэлцэл нь зээлдэгч нь өөрийн үүргийг бэлэн төлбөрөөр хугацаандаа биелүүлэх болон зарим зээлдүүлэгч нарын хувьд зээлдэгчийг үүргээс нь чөлөөлөх нөхцөл гэх мэт график, процессийг тодорхойлно. Энэ талаар зээлдүүлэгчдийн хурлын шийдвэр гарч, шүүх баталгаажуулна /зээлдүүлэгч болон төрийн байгууллагын олонхийн саналаар шийдвэрлэх боловч энд нь барьцаат зээлдүүлэгчдийн бүгдийнх нь саналаар дэмжигдсэн байх - энэ нь аль нэг барьцаат зээлдүүлэгчийн зүгээс хувийн ашиг сонирхлын үүднээс ажиллагааг өөрчлөх боломж олгож байгаа юм/. Дахин хөрөнгөжүүлэх хэлцлийг гэм хорын улмаас учруулсан

хохирлоо нөхөн төлж дууссан, ажилчид, албан хаагчдынхаа өмнө хүлээсэн үүргээ биелүүлсний дараа л батална.

5/ Татан буулгах: Шүүх зээлдэгчийг төлбөрийн чадваргүйд тооцсоноор түр зохион байгуулагч нь зээлдэгчийн эд хөрөнгийг худалдсанаас орсон орлогоор өр төлбөрийг нь барагдуулна. Зээлдэгчийн удирдлагын эрх хэмжээ дуусгавар болно. Зээлдэгчийн эд хөрөнгийг зарж төлбөрийн үүргийг гүйцэтгэсний дараа, шүүх татан буулгах шийдвэр гаргана. Шийдвэр нь зээлдэгчийн дампуурсан тэмдэглэлийг үйлдэж Хуулийн этгээдийн холбооны бүртгэлд ашиглана.

ОХУ-ын дампуурлын эрх зүйн зохицуулалтыг харахад манай улсын зохицуулалтаас онцлог болон давуу талууд нилээн их ажиглагдаж байна.

Дүгнэлт

Дээр дурьдсан судалгаанд үндэслэн ХК болон ХХК-ийн дампуурлын эрх зүйн зохицуулалтын хувьд дараах ялгаатай асуудлууд үүсч болох юм гэж дүгнэлээ.

1.Хэдийгээр Монгол Улсын дампуурлын хуульд "компани" гэх нэрийн дор ялгаагүй байдлаар хуульчилсан хэдий ч хувьцаат компани болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчдийн эд хөрөнгийн асуудал нь компанийн онцлогтой холбоотойгоор ялгаатай байдлаар үүсч болно. Тухайлбал, хувьцаат компанийн хувьд зээлдүүлэгчдийн үүргийн гүйцэтгэлийг хангасны дараагаар хувьцаа эзэмшигчдэд хөрөнгө хуваарилах асуудалтай холбоотой зохицуулалт үйлчилнэ.

2. Мөн түүнчлэн, дампуурлын хэрэг үүсгэх үндэслэлийн тухайд жишээ авсан улсуудын зохицуулалтаас харахад хувьцаат компанийн хувьд үүсгэн байгуулагдсанаасаа хойш тодорхой хугацаанд хувьцаагаа зарж чадаагүй тохиолдолд дампуурлын хэрэг үүсгэхээр зохицуулсан байна. Тухайлбал Их Британий дампуурлын эрх зүйн зохицуулалт.

3. Дампуурлын хэрэг үүсгэсэнтэй холбоотойгоор ямар арга хэмжээ авах асуудал нь ХХК болон ХК-ийн хувьд ялгаатай байна. Өөрөөр хэлбэл, ХК-ийн хувьд хөрөнгийн бирж дээр хувьцаагаа чөлөөтэй арилжаалах эсэхэд ямар хориг тавьж болохыг хуульчилсан байдаг байна.

4. Дахин хөрөнгөжүүлэх ажиллагааг хэрхэн явуулахыг ХК болон ХХК-ийн хувьд ялгаатай байдлаар хуульчлах боломжтой байна. Өөрөөр хэлбэл, шинээр хувьцаа гаргах эсэх асуудлыг ХК болон ХХК-ийн хувьд ялгаатай байдлаар зохицуулах боломжтой юм.

5. Ямар тохиолдолд төлбөрийн чадваргүйд тооцох вэ гэдэг асуудлыг Монгол улсын хувьд 10 хувьтай холбож үзсэн явдал нь компаниудыг зохиомлоор дампуурч өр төлбөрөөс хууль бусаар зайлсхийх боломжийг бий болгож байна. Учир нь ХХК-ийн хувьд 100000 төгрөг, ХК-ийн хувьд 1 000 000 төгрөг байхаар ялгаатай байдлаар хуульчилсан байна.

3.4. "ДАХИН ХӨРӨНГӨЖҮҮЛЭХ ЭСЭХИЙГ ШИЙДВЭРЛЭХЭД ХАРГАЛЗАН ҮЗЭХ НӨХЦӨЛҮҮД"

Энэхүү дэд сэдвээр дампуурлын хэргийн хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх, энэхүү асуудлыг шийдвэрлэхэд харгалзан үзэх нөхцөлүүдийг тодорхойлон, дахин хөрөнгөжүүлэх шийдвэр гаргах үндэслэлийг тогтоох

асуудлуудын хүрээнд Монгол Улсын эрх зүйн зохицуулалтыг судалж, гадаад улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулахыг зорилоо.

Тус дэд сэдэв нь дээр дурьдсан асуудлуудыг хамарсан дараах бүтэцтэй:

3.4.1. Монгол Улсын эрх зүйн зохицуулалт;

3.4.2. Гадаад улсын эрх зүйн зохицуулалт;

Дүгнэлт.

Англо-Америкийн эрх зүйн бүлээс Нэгдсэн Вант улсыг сонгон авч судалсан бөгөөд Ром-Германы эрх зүйн бүлээс Холбооны Бүгд Найрамдах Герман улсыг сонгон судалсан. ХБНГУ-ыг Монгол улстай эрх зүйн нэг бүлийн улс болохын хувьд илүү дэлгэрэнгүй судалсан болно. Монгол Улсын дахин хөрөнгөжүүлэх эрх зүйн зохицуулалтыг энэхүү хоёр улстай харьцуулан, судалгааны ажлынхаа дүгнэлтийг хийх болно.

3.4.1.МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Дахин хөрөнгөжүүлэх нь дампуурлын эрх зүйн нэг институц юм. Дампуурлын эрх зүй, түүнчлэн дахин хөрөнгөжүүлэх асуудлыг Монгол Улсын Дампуурлын тухай хууль /1997 оны 11 дүгээр сарын 20/-аар зохицуулдаг.

Дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргах үндэслэл:

Монгол Улсын Дампуурлын тухай хуулийн 3 дугаар бүлэгт хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх харилцааг зохицуулсан. Хариуцагчийг өөрчлөн байгуулж дахин хөрөнгөжүүлснээр нэхэмжлэгчдийн шаардлагыг хангаж, улмаар хэвийн үйл ажиллагааг сэргээж, үргэлжлүүлэх боломж олгодог. Дахин хөрөнгөжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэхэд дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө чухал ач холбогдолтой.

Хариуцагчийн үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэх санхүү, удирдлагын болон бусад боломж, тэдгээрийн тооцоо, өөрчлөн байгуулагдсан аж ахуйн нэгжийн хэтийн төлөвийн талаар эрх бүхий этгээдийн боловсруулж шүүхэд оруулж буй баримт бичгийг дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө гэнэ.

Монгол Улсын Дампуурлын тухай хуулиар дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөнд тусгах асуудлыг тодорхой, нарийвчлан хуульчилж өгсөн.[499]

Дампуурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар:

Хариуцагчийг дахин хөрөнгөжүүлж, үйл ажиллагааг нь цаашид үргэлжлүүлэх нь татан буулгаснаас нэхэмжлэгчдийн нэхэмжлэлийн шаардлагыг илүү хэмжээгээр хангах боломжтой гэж үзвэл дараах этгээд хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх тухай хүсэлтийг түүнийг төлбөрийн чадваргүйд тооцсон өдрөөс хойш 6О хоногийн дотор шүүхэд гаргаж болно:

- хариуцагч өөрөө;
- хариуцагчаас нэхэмжилсэн нийт төлбөрийн гуравны нэг буюу түүнээс дээш хувийг нэхэмжилж байгаа нэхэмжлэгчид;
- хэрэг гүйцэтгэгч.

Дээрх хуулийн заалтаас харвал дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргах гол үндэслэл нь нэхэмжлэгчдийн нэхэмжлэлийн шаардлагыг илүү хэмжээгээр хангах явдал байна. Өөрөөр хэлбэл нэхэмжлэгчдийн хохиролыг багасгах, тэдний хохирол, нэхэмжлэлийг барагдуулах боломжийг бүрдүүлэх нөхцөлийг бий болгох нь дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө гаргах гол үндэслэл болж байна.

[499] 24.2 дахь хэсэг, Монгол Улсын Дампуурлын тухай хууль, 1997.

Дахин хөрөнгөжүүлэх шийдвэр гаргах тохиолдол: Юуны өмнө дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг нэхэмжлэгчдийн хурлаар хэлэлцүүлж, санал хураана.

Төлөвлөгөөг батлах санал хураалтад зөвхөн нэхэмжлэлийг нь шүүх хүлээн авсан нэхэмжлэгчид оролцох эрхтэй бөгөөд санал хураалтыг дараахь хэсэг тус бүрээр явуулна:[500]

1. нэхэмжилсэн үнийн дүнгийн 1О буюу түүнээс дээш хувийг эзлэх барьцаат нэхэмжлэгчид;
2. бусад барьцаат нэхэмжлэгчид;
3. хариуцагчтай хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсад;
4. бусад.

Хуралд оролцон тухайн хэсэгт хамаарах санал гаргасан нийт нэхэмжлэгчдийн саналын эрхийн олонхийн дэмжлэг авснаар тэр хэсгээс төлөвлөгөөг зөвшөөрсөнд тооцно. Хэрэв хоёр буюу түүнээс дээш төлөвлөгөө санал болгосон бол нэхэмжлэгчдийн хурлаар бүгдийг хамтад нь хэлэлцүүлж санал хураалгана. Нэхэмжлэгчдийн хурал төлөвлөгөөг зөвшөөрвөл шүүхэд төлөвлөгөөг явуулах ба шүүх дараахь үндэслэлийн аль нэг нь байвал төлөвлөгөөг батална:

1. төлөвлөгөөг нэхэмжлэгчдийн 2-оос доошгүй хэсэг дэмжсэн бол;
2. нэхэмжлэлийн шаардлагыг хариуцагч татан буугдсанаас илүү хангаж чадахаар байвал. Энэ хоёр нөхцөлийн нэг нь биелсэн байхад л шүүх төлөвлөгөөг баталж болно. /тодруулбал: Хуулийн хэллэгээс батлах ёстой гэж ойлгогдож байна/ Өөрөөр хэлбэл нэхэмжлэгчид бүгдээрээ төлөвлөгөөг дэмжээгүй байсан ч гэсэн шүүгчийн үзэж байгаагаар тэр нь татан буулгалтаас илүү ихийг нэхэмжлэгчдэд өгөх боломжтой байвал, нөгөө талаас нэхэмжлэгчдийн хоёр бүлэг төлөвлөгөөг сайшаасан л бол шүүгчид тэр нь хичнээн ашиггүй, биелэгдэшгүй санагдсан ч батлах хэрэгтэй болдог байна. Эндээс, нэг талаар шүүгчийн шийдвэрийг дэндүү өргөсөн, нөгөө талаар нэхэмжлэгчдийн нэг хэсгийн саналыг хэтэрхий хүчтэй болгосон мэт харагдана[501].

Нэхэмжлэгчдийн хурлаас хэд хэдэн төлөвлөгөөг зөвшөөрч дэмжсэн бол шүүх *хариуцагчийн* санал болгосон төлөвлөгөөг батална. Шүүх хариуцагчийн санал болгосон төлөвлөгөөг батлах дээр дурьдсан үндэслэл байхгүй гэж үзвэл *хамгийн тохиромжгүй нөхцөлд хамаарч байгаа нэхэмжлэгчдийн* хэсгийн зөвшөөрсөн төлөвлөгөөг батална. Төлөвлөгөөний дагуу тухайн нэхэмжлэгчид түүний нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангахгүй хэмжээний хөрөнгө хуваарилагдахыг тохиромжгүй нөхцөлд хамаарагдах гэнэ. Төлөвлөгөөг биелүүлэх ажлыг 2 жилийн дотор хариуцагч юмуу эсхүл хэрэг гүйцэтгэгч зохион байгуулна. Хэрэв хариуцагч төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр шүүх шийдвэрлэвэл тэрээр хэрэг гүйцэтгэгчийн шууд хяналт дор ажиллана.

Явцын дунд төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжгүй бол шүүх хариуцагчийг татан буулгах шийдвэр гаргана.

Төлөвлөгөөг бүрэн биелүүлж дуусан, төлөвлөгөөг биелүүлж дуусаагүй боловч нэхэмжлэгчдийн нэхэмжлэлийн шаардлагыг төлөвлөгөөний дагуу

[500] 27.3 дахь хэсэг, Монгол Улсын Дампуурлын тухай хууль, 1997.
[501] http://asuult.net/erkhzui/niitlel/reorganization.pdf.

бүрэн хангасан бол шүүх дампуурлын хэргийг хэрэгсэхгүй болгож тухайн хуулийн этгээдийн хэвийн үйл ажиллагааг сэргээнэ.

Төлөвлөгөө ирээгүй, ирсэн боловч шүүх түүнийг батлаагүй эсхүл төлөвлөгөөг биелүүлэх боломжгүй бол шүүх хариуцагчийг дампуурсанд тооцож, татан буулгах тухай шийдвэр гаргаж энэ тухай нийтэд мэдээлнэ.

3.4.2. ГАДААД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Энэхүү хэсэгт хоёр улсын эрх зүйн зохицуулалтыг авч үзсэн. Англо-Америкийн эрх зүйн бүл болон Ром-Германы эрх зүйн бүлийн нэг нэг улсыг төлөөлөл болгон сонгон авч, судалсан. Юуны өмнө Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын дахин хөрөнгөжүүлэх эрх зүйн зохицуулалтыг авч үзье.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын дахин хөрөнгөжүүлэх эрх зүйн зохицуулалтын зарим асуудал: Холбооны Бүгд Найрамдах Герман улсын хувьд дампуурлын эрх зүйн харилцааг ХБНГУ-ын Дампуурлын тухай хууль /1994 оны 10 сарын 5/-аар зохицуулдаг.

Дампуурлын төлөвлөгөө, түүний төрлүүд: ХБНГУ-ын Дампуурлын тухай хуульд зааснаар нэхэмжлэгчдийн шаардлагыг хангах, дампуурлын хэрэг дэх хөрөнгийг захиран зарцуулах, мөн тэдгээрийг хуваарилах, хариуцагчийн хариуцлагын асуудлыг дампуурлын төлөвлөгөөгөөр шийдвэрлэж болно гэж заасан.[502]

ХБНГУ-ын Дампуурлын тухай хуулиар дампуурлын төлөвлөгөөний талаар нарийвчлан зохицуулсан байдаг. Тус хуулиар дампуурлын төлөвлөгөөний 3 төрлийг заасан байдаг. Үндсэн 3 төрөл байдаг. Үүнд:

- дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө;
- шилжүүлэх төлөвлөгөө;
- татан буулгах төлөвлөгөө.

Үндсэн 3 төрлөөс гадна тухайн нөхцөл байдалд тохирч нийцсэн ажиллагааг хэрэгжүүлэх боломжийг олгох холимог хэлбэр байж болно.

Дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө хэрэгжүүлэхэд хариуцагчийн байгууллагыг хадгалж үлдэх ба дахин хөрөнгөжүүлэх янз бүрийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх замаар орлого бий болгон нэхэмжлэгчдийн шаардлагыг хангах зорилготой. Шилжүүлэх төлөвлөгөөг Дампуурлын тухай хуулинд шилжүүлэх замаар дахин хөрөнгөжих гэж томьёолсон байдаг. Энэ төлөвлөгөөний хувьд хариуцагчийн орлого бүхий салбараас зарим нэгийг нь өөр этгээдэд худалдах замаар явагддаг.

Дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө, түүний агуулга: Үүрэг гүйцэтгэгчийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн явуулснаар үүнээс орох орлогоос зээлдүүлэгчийн ашиг сонирхлыг хангах боломжтой тохиолдолд дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө боловсруулна.[503] Өөрөөр хэлбэл хариуцагчийн байгууллагыг татан буулгахын оронд түүнийг дахин хөрөнгөжүүлж, түүний ирээдүйд олох орлогоор нэхэмжлэгчдийн шаардлагыг хангах асуудал юм. Төлөвлөгөөнд хөрөнгө, түүний үнэлгээний жагсаалт болон төлөвлөгөө үр дүнтэй болох талаарх судалгааг хавсаргана.[504]

[502] 217 дугаар зүйл, ХБНГУ-ын Дампуурлын тухай хууль, 1994.

[503] 229.1 дэх хэсэг, ХБНГУ-ын Дампуурлын тухай хууль, 1994.

[504] Мөн тэнд

Дампуурлын төлөвлөгөө /дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө/-г дампуурлын шүүхэд үүрэг гүйцэтгэгч өөрөө мөн дампуурлын хэрэг гүйцэтгэгч гаргах эрхтэй ба үүнээс гадна нэхэмжлэгчдийн хурлаас дампуурлын хэрэг гүйцэтгэгч этгээдэд энэ талаар үүрэг өгөх боломжтой.[505] Дампуурлын төлөвлөгөө нь авч хэрэгжүүлж байгаа болон ирээдүйд авах арга хэмжээг тодорхойлсон танилцуулах хэсэг болон төлөвлөгөөний хэрэгжилтийн хэсгээс бүрдэнэ.[506]

Дампуурлын тухай хуулийн 220 дугаар зүйлд зааснаар дампуурлын төлөвлөгөөний тодорхойлох хэсэгт дампуурлын хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг үүсгэсний дараа авч хэрэгжүүлсэн болон ирээдүйд авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох ба энэ нь дампуурлын оролцогчдын эрхийн байдалд өөрчлөлт орох үндэслэл болдог. Тухайлбал, ийм арга хэмжээнд үйлдвэрлэлийн өөрчлөлттэй холбоотой болон бусад зохион байгуулалтын мөн хүний нөөцийн шинжтэй байгууллагын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээг дурдаж болно.

Дампуурлын тухай хуулийн 220 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу тодорхойлох хэсэг нь төлөвлөгөөны үндэслэл болон үр дагаварын талаарх бүхий л болон бусад мэдээллийг агуулсан байх ёстой.

Төлөвлөгөөний дараагийн хэсэг буюу хэрэгжилтийн хэсгийн зүйл нь бүлэг зохион байгуулах явдал юм. Дампуурлын тухай хуулийн 222 дугаар зүйлд заасны дагуу нэхэмжлэгчдийг эрх зүйн байдлаараа хоорондоо ялгаа бүхий бүлгүүдэд ангилна. Нэхэмжлэгчдийг дараах байдлаар ангилна:

- Тусгаарлагдсан ашиг сонирхол бүхий нэхэмжлэгчид;
- Доод зэрэглэлийн бус нэхэмжлэгчид;
- Доод зэрэглэлийн нэхэмжлэгчид /тэргүүн ээлжний бус нэхэмжлэгчид/.

Тухайн ангилал дахь нэхэмжлэгчид адилхан эрхтэй бөгөөд нэхэмжлэгчдийг группүүдэд ангилах шалгуурыг төлөвлөгөөнд тусгасан байна.[507]

Дахин хөрөнгөжүүлэх тохиолдолд дампуурлын төлөвлөгөөнд Дампуурлын тухай хуулийн 230 дугаар зүйлд заасны дагуу дараах зүйлсийг хавсаргана:

- Төлөвлөгөөний санхүүгийн тайлан тооцоо;
- Орлогын төлөвлөгөө;
- Нэхэмжлэгчдийн тайлбар.

Дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөний бүтэц, агуулга, түүнд хавсаргах баримтуудын талаар Дампуурлын хуулиар тодорхой зохицуулсан байна.

Дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг батлахаас татгалзах: Дампуурлын тухай хуулийн 231 дүгээр зүйлд төлөвлөгөөг батлахаас татгалзах талаар зохицуулсан байна. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу дампуурлын шүүх нь дараах тохиолдолд төлөвлөгөөг батлахаас татгалзахаар зохицуулсан байна. Үүнд:

- Төлөвлөгөөг шүүхэд гаргах болон түүний агуулгын талаарх хуулийн зохицуулалтад нийцээгүй төлөвлөгөө гаргаж буй этгээд нь дутагдлыг арилгаж чадахгүй эсхүл шүүхээс тогтоосон хугацаанд арилгах боломжгүй бол;

[505] Мөн хуулийн 218 дугаар зүйл.
[506] Мөн хуулийн 219 дүгээр зүйл.
[507] 222.2 дэх хэсэг, ХБНГУ-ын Дампуурлын тухай хууль, 1994.

- Хариуцагчаас гаргаж буй төлөвлөгөөг нэхэмжлэгчид зөвшөөрөхгүй, эсхүл шүүхээс түүнийг батлах боломжгүй гэдэг нь илэрхий байгаа тохиолдолд;

- Хариуцагчаас боловсруулсан төлөвлөгөөний хэрэгжилтийн хэсэгт заасны дагуу оролцогчдоос хэрэгжүүлэх шаардлагууд нь хэрэгжих боломжгүй гэдэг нь илэрхий байгаа тохиолдолд.

Үүнээс дүгнэвэл, дутагдлыг арилгах боломжгүй процессийн дутагдал байгаа эсхүл төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжгүй тохиолдолд шүүхээс төлөвлөгөөг батлахгүйгээр татгалзах талаар заасан байна. Өөрөөр хэлбэл тухайн төлөвлөгөө нь нэхэмжлэгчдийн шаардлагыг хангах арга хэмжээг бий болгож чадахгүй, тэдний ашиг сонирхлыг хангаж чадахгүй тохиолдолд шүүх төлөвлөгөөг батлах шаардлагагүй буюу батлахаас татгалзана.

Дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг зөвшөөрөх, батлах: Дээр дурдсанаас бусад тохиолдолд буюу төлөвлөгөөг батлахаас татгалзаагүй тохиолдолд шүүх дараах этгээдүүдэд зөвлөмж өгнө. Үүнд:[508]

- Ажлын хэсэг, илтгэгч этгээдийг томилвол нэхэмжлэгчдийн зөвлөлд;
- Төлөвлөгөөг хариуцагч гаргасан бол хэрэг гүйцэтгэгчид;
- Төлөвлөгөөг хэрэг гүйцэтгэгч гаргасан бол хариуцагчид зөвлөмж өгнө.

Шүүх зөвлөмжийг хэрэгжүүлж өргөн барих хугацааг тогтооно.

Дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө болон нэхэмжлэгчдийн санал өгөх эрхийг хэлэлцэх уулзалтыг шүүх товлоно.[509] Дампуурлын тухай хуулийн 239 дүгээр зүйлд заасны дагуу уулзалтын үр дүнд санал өгөх эрх бүхий нэхэмжлэгчдийн жагсаалтыг шүүх гаргана. Дампуурлын тухай хуулийн дагуу үүний дараа төлөвлөгөөг зөвшөөрөх /батлах/ санал өгөх уулзалтыг шүүх товлон, саналыг бичгээр өгнө.Төлөвлөгөөг зөвшөөрөхөд дараах нөхцөлийг шаардана:[510]

- Санал өгөх нэхэмжлэгчдийн олонх зөвшөөрсөн байх;
- Санал өгсөн нэхэмжлэгчид нь нийт нэхэмжлэлийн шаардлагын талаас илүү нэхэмжлэлийн шаардлагыг бүрдүүлсэн байх.

Энэ хуулийн 245 дугаар зүйлд дээрх нөхцөл бүрдээгүй тохиолдолд нэхэмжлэгчид зөвшилцсөний үндсэн дээр төлөвлөгөөг зөвшөөрч болохоор заасан. Тухайн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр нэхэмжлэгчид ямар нэг хохирол учрахгүй бол, тухайн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр хөрөнгийн эдийн засгийн үнэлгээ нь нэмэгдэхээр бол шаардлагатай олонхид хүрэзгүй ч төлөвлөгөөг зөвшөөрч болохоор заасан байна. Төлөвлөгөөнд санал өгсний эцэст хариуцагчийн зөвшилцлийг шүүх явуулдаг. Хариуцагч нэхэмжлэгчдийн саналын эсрэг тайлбар гаргаагүй тохиолдолд хариуцагчийг зөвшилцөж байна гэж үздэг.

Төлөвлөгөө байхгүй байх нөхцөлтэй харьцуулахад төлөвлөгөө хэрэгжүүлснээр ямар нэг сул талыг бий болгохгүй байх тохиолдолд, мөн нэхэмжлэгчид шаардсан нэхэмжлэлийн шаардлагаа авч чадах тохиолдолд хариуцагчийг зөвшилцсөн буюу эсрэг тайлбар гаргаагүй гэж үздэг. [511]

Дампуурлын тухай хуулийн 248 дугаар зүйлийн дагуу нэхэмжлэгчид төлөвлөгөөг зөвшөөрсөн, мөн хариуцагчийн зөвшилцлийг олж авсны

[508] Мөн хуулийн 232 дугаар зүйл.
[509] Мөн хуулийн 235 дугаар зүйл.
[510] Мөн хуулийн 244 дүгээр зүйл.
[511] Мөн хуулийн 247 дугаар зүйл.

дараа шүүх төлөвлөгөөг баталдаг. Дээрхээс харвал дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг зөвшөөрөх нь хамгийн чухал хэсэг бөгөөд нэхэмжлэгчид өөрсдөө дахин хөрөнгөжүүлэх эсэхийг шийдвэрлэдэг нь чухал ач холбогдолтой байна. Эцэст нь шүүх дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг ёс төдийгөөр баталж байна. Өөрөөр хэлбэл нэхэмжлэгчдийн зөвшөөрөл, хариуцагчийн зөвшилцлийн үндсэн дээр баталж байна.

Дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг зөвшөөрөх нөхцөл: Дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг зөвшөөрөх, батлах хэсгээс үндсэндээ төлөвлөгөөг зөвшөөрөх нөхцөл шууд харагдаж байна. Өөрөөр хэлбэл дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хэрэгжүүлэх шаардлагатай эсэхийг тогтоох нөхцөлийг авч үзье.

Дампуурлын тухай хуулийн 244 дүгээр зүйлд дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг зөвшөөрөх шаардлагыг тавьсан. Энэ нь хэлбэрийн төдий шаардлага байгаа бөгөөд энэхүү хэлбэрийн шаардлага хангагдахгүй байгаа хэдий ч агуулгын нөхцөл хангагдаж байгаа тохиолдолд төлөвлөгөөг зөвшөөрч болохоор заасан байна.[512] Энэхүү нөхцөлд:

-Төлөвлөгөө хэрэгжүүлээгүй байгаа нөхцөлтэй харьцуулахад төлөвлөгөөг хэрэгжүүлснээр нэхэмжлэгчдэд ямар нэг хохирол учрахгүй тохиолдолд /өөрөөр хэлбэл нэхэмжлэгчдийн шаардлага нь хангагдахаар байгаа тохиолдолд/;

- Тухайн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр дампуурлын хэрэгт хамааралтай хөрөнгийн эдийн засгийн үнэлгээ нь нэмэгдэхээр байгаа тохиолдолд / өөрөөр хэлбэл хөрөнгийн эдийн засгийн үнэлгээ нь нэмэгдэнэ гэдэг нь нэхэмжлэгчдийн шаардлагыг хангах нөхцөл илүү бүрдэх боломжтой байгааг ойлгож болно/;

Тэгэхээр дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг зөвшөөрөх /хэрэгжүүлэх/ үндсэн нөхцөл нь нэхэмжлэгчдийн ашиг сонирхлыг хангах, тэднийг аль болох хохиролгүй болгох, нэг үгээр хэлбэл нэхэмжлэгчдийн шаардлагыг хангаж чадах нөхцөлийг бүрдүүлэх явдал юм.

Нэгдсэн Вант улс дахь дахин хөрөнгөжүүлэх эрх зүйн зохицуулалтын зарим асуудал

Нэгдсэн Вант улсын 1986 оны Дампуурлын тухай хуулийн дагуу дахин хөрөнгөжүүлэх асуудлыг авч үзэх бөгөөд дараах байдлаар ялгаатай зохицуулсан байна. Үүнд:

- *company voluntary arrangement*;
- *administrational orders* /мөн *individual voluntary arrangement*/.

Компанийн сайн дурын хэлэлцээр буюу дахин хөрөнгөжүүлэх нэг арга замын хувьд тухайн компанийн захирлын санаачилгаар компанийн өрийг хэрхэн төлж барагдуулах тухай төлөвлөгөө гарган зээлдүүлэгчдээс санал авдаг.[513] Энэхүү төлөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих зорилгоор тодорхой этгээдийг нэр заан томилдог. Ийнхүү томилогдсон этгээд нь 28 хоногийн дотор шүүхэд дараах мэдээллийг гаргаж өгдөг. Үүнд:

- Дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө хэрэгжих боломжтой эсэх;
- Зээлдүүлэгчдийн хурлыг зарлан хуралдуулах шаардлагатай эсэх.

Хэрэв нэр дэвшигч нь /nominee/ зээлдүүлэгчдийн хурлыг зарлан хуралдуулах шаардлагатай гэж үзвэл шүүхээс зээлдүүлэгчдийн хурлыг

[512] 245 дугаар зүйл, ХБНГУ-ын Дампуурлын тухай хууль, 1994.

[513] Insolvency Act, 1986, 1дүгээр зүйл.

зарлан хуралдуулах бөгөөд уг хурлаас сайн дурын хэлэлцээр буюу дахин хөрөнгөжүүлэхийг зөвшөөрөх эсэх, зөвшөөрвөл өөрчлөлт оруулах эсэх зэрэг асуудлуудыг шийдвэрлэдэг. Сайн дурын хэлэлцээрийг зөвшөөрсөн тохиолдолд хэдэн сарын хугацаанд дахин хөрөнгөжүүлэх ажиллагаа явагдах эсэх нь тодорхойгүй байна. Тухайн төлөвлөгөө хэрэгжээгүй, худал баталгаа, мэдэгдэл гаргаж өгсний үндсэн дээр уг төлөвлөгөөг батлуулсан зэрэг тохиолдолд уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дуусгавар болгодог байна.

• ***administrational orders*** /мөн *individual voluntary arrangement*/,

Хэрэв тухайн компанийн бусдад төлөх өр төлбөрийн хэмжээ 3000 еврогоос хэтэрсэн тохиолдолд administration order гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргаж болох бөгөөд ийнхүү гаргасан тохиолдолд тухайн төлбөрийг тодорхой хугацаанд эргүүлэн төлөх үүргийг хариуцагчид оногдуулж байдаг. Хэрэв дахин хөрөнгөжүүлэх буюу зээлдүүлэгчдийн зээлийг төлж барагдуулах тухай тухайн компани, түүний захирал, зээлдүүлэгч зэрэг этгээд дангаараа болон хамтран шүүхэд хүсэлт гаргаж байгаа бол administration order гэж нэрлэгдэнэ. Хэрэв шүүхийн үзэж байгаагаар тухайн компани төлбөрөө төлөх чадваргүй, эсхүл төлж чадахгүй болж магадгүй төдийгүй хуулинд заасан зорилгуудын аль нэг administration order-ын дагуу биелэх шинжтэй бол administration order гаргана. Ийнхүү энэ замаар хүсэлт гаргасан, уг хүсэлтийг шийдвэрлэх хүртэл тодорхой ажиллагааануудыг түр зогсоодог байна. Тухайлбал: Тухайн компанийг татан буулгах тухай шийдвэр гаргах, түүнтэй холбоотой бусад шүүхийн шийдвэр гаргах. Administration order гарснаар администраторыг томилох бөгөөд уг этгээд нь компанийн үйл ажиллагааг ерөнхийлөн удирдах, компанийн захирлыг оцгруулах зэрэг онцгой эрх эдлэх бөгөөд уг албан тушаалын хувьд Монгол улсын "хэрэг гүйцэтгэгч"-тэй ижилхэн статустай боловч эрх хэмжээний хувьд өргөн хүрээнд олгогдсон байна. Уг аргаар дахин хөрөнгөжүүлэх гэж байгаа тохиолдолд зээлдүүлэгчдийн хороог үүсгэн байгуулах бөгөөд дахин хөрөнгөжүүлэх үйл ажиллагаг хянах ерөнхий чиг үүрэгтэй оролцдог.

Эдгээрээс дүгнэн үзвэл, дахин хөрөнгөжүүлэх асуудлыг Нэгдсэн Вант улсад сайн дурын үндсэн дээр болон бусад этгээдийн хүсэлтийг үндэслэн шийдвэрлэх бөгөөд тодорхой хугацаанд тухайн зээлийг төлж барагдуулах тухай төлөвлөгөөг гарган зээлдүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн, үр дүнг хүлээн авдаг байна.

Дүгнэлт

"Дахин хөрөнгөжүүлэх эсэхийг шийдвэрлэхэд харгалзан үзэх нөхцөлүүд" судалгааны ажлын хүрээнд Монгол Улсын эрх зүйн зохицуулалт, ХБНГУ болон Нэгдсэн Вант улсын эрх зүйн зохицуулалтуудыг судалж үзсэний үндсэн дээр дараах дүгнэлтүүдийг гаргаж байна:

- Дампуурлын эрх зүйн нэгэн институц болох дахин хөрөнгөжүүлэх асуудлын цаана нийгэм, эдийн засгийн тодорхой хэмжээний ашиг, сонирхол байдаг. Дахин хөрөнгөжүүлснээр тэрхүү тодорхой ашиг, сонирхлыг хамгаалах юм. Өөрөөр хэлбэл нэхэмжлэгчдийн нэхэмжилж буй шаардлагыг хангаж, үүгээр дамжуулан тэрхүү ашиг сонирхлыг хамгаалах юм.

- Дахин хөрөнгөжүүлэх шийдвэр гаргах, өөрөөр хэлбэл дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг батлах шалгуурыг Монгол улсын болон Герман

улсын хуульд зөвхөн хэлбэрийн шаардлагын байдлаар илүү тодорхой хуульчилж өгсөн байна. Тухайн нэхэмжлэгчдийн олонхийн дэмжлэг авснаар төлөвлөгөөг хүлээн зөвшөөрсөнд тооцохоор хуульчилсан байна.

- Мөн дахин хөрөнгөжүүлэх асуудлыг шийдвэрлэхэд шалгуур болгож буй агуулгын талын шаардлагыг судалгаанд оруулсан улсуудын хуулиас харж болохоор байна. Монгол улсын хувьд хариуцагчийг дахин хөрөнгөжүүлж, үйл ажиллагааг нь цаашид үргэлжлүүлэх нь татан буулгаснаас нэхэмжлэгчдийн нэхэмжлэлийн шаардлагыг илүү хэмжээгээр хангах боломжтой байх нь дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргах үндэслэл болсон байна. Өөрөөр хэлбэл дахин хөрөнгөжүүлэх шийдвэр гаргах чухал шалгуур нь үүнд оршиж байна.

- ХБНГУ-ын хувьд дээр дурьдсанчлан хэлбэрийн шаардлага тавьсан хэдий ч энэхүү шаардлага нь хангагдаагүй тохиолдолд нэхэмжлэгчдэд илүү бага хохирол учруулах, түүнчлэн тэдний нэхэмжлэлийн шаардлагыг илүү хангах боломжтой тохиолдолд дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг хүлээн зөвшөөрч, баталж болохоор хуульчилсан.

- Дахин хөрөнгөжүүлэх эсэхийг шийдвэрлэхэд нэхэмжлэгчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэж байгаа нь туйлын ач холбогдолтой юм. Эцэст нь шүүх үүнийг нь баталдаг. Тухайн асуудалд ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээдүүд энэхүү асуудлаа өөрсдөө шийдэж байгаа нь дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд илүү дөхөм болох юм.

- Эцэст нь дүгнэвэл дахин хөрөнгөжүүлэх асуудлыг шийдвэрлэхэд авч үзэх шалгуур нь нэхэмжлэгчдийн нэхэмжлэлийн шаардлагыг илүү хангах боломжтой байх нөхцөл байна. Өөрөөр хэлбэл нэхэмжлэгчдэд аль болох хохирол учруулахгүй байх, тэдний нэхэмжлэлийн шаардлагыг хангах нөхцөлийг бүрдүүлэх нь дахин хөрөнгөжүүлэх асуудлыг шийдвэрлэх гол үндэслэл болж байна.

3.5. ДАМПУУРЛЫН АЖИЛЛАГААНЫ ҮЕИЙН ЭД ХӨРӨНГИЙН ХАМГААЛАЛТ

Дампуурлын ажиллагааны үед хариуцагчийн эд хөрөнгийн хамгаалах эрх зүйн зохицуулалтыг авч үзэхдээ юуны өмнө дампуурлын эрх зүйн харилцаа хэдийд эхлэж байгааг тодорхойлохоос эхлэх нь зүйтэй юм. Учир нь энэхүү ажиллагааг эхэлсэн буюу уг харилцааг үүссэн гэж үзэх нь хариуцагчийн эд хөрөнгийг хамгаалах харилцааг мөн адил үүссэн гэж үзэх эрх зүйн үр дагаврыг үүсгэж байдаг. Жишээ нь, зарим судлаачид эд хөрөнгийг хамгаалах харилцаа нь дампуурлын хэрэг үүсгэсэн болон шүүхээс дампуурсан гэдгийг зарласан үеэс эхлэнэ гэж үздэг[514] бол дампуурлын хэрэг үүсгэх талаар шүүхэд нэхэмжлэл гаргасан үеэс эд хөрөнгийн хамгаалах харилцаа үүснэ гэж үздэг судлаачид ч бий. Өөрөөр хэлбэл, дампуурлын эрх зүйн харилцаа үүсэх асуудал нь судлаачдын хувьд маргаантай асуудлын адил дампуурлын ажиллагааны үед хариуцагчийн эд хөрөнгийг хамгаалах харилцаа хэрхэн үүсэх нь мөн л маргаантай асуудал байна. Тийм учраас дампуурлын ажиллагааны үеийн хариуцагчийн эд хөрөнгийн хамгаалах харилцааг:

[514] Сарнакова А.В /2009-11/, *Правовая природа отношений, возникаюших при банкротсве кредитных организации //* Закон и право, 96.

• Дампуурлын ажиллагааны үед эд хөрөнгийг хамгаалах харилцаа үүсэх үндэслэл;

• Дампуурлын ажиллагааны үед эд хөрөнгийг хамгаалах харилцаанд оролцогчдын эрх үүрэг;

• Эд хөрөнгийг хамгаалах талаар зайлшгүй хийх ажиллагаанууд, түүний онцлог;

• Эд хөрөнгийг хамгаалахад хяналт тавих арга, этгээд;

• Эд хөрөнгө хамгаалах харилцаан дахь аж ахуйн үйл ажиллагааны онцлог;

• Эд хөрөнгийг хамгаалах харилцаа дуусгавар болох үндэслэл гэсэн логик дараалын дагуу уг асуудлыг авч үзлээ. Түүнчлэн уг логик дараалын дагуу эрх зүйн хэм хэмжээг боловсруулан хуулийн төсөлд тусгах нь уг харилцааны эрх зүйн зохицуулалтыг илүү ойлгомжтой, тодорхой болгоно гэж судалгааны баг үзсэн болно.

Дампуурлын ажиллагааны үед эд хөрөнгийг хамгаалах харилцаа үүсэх үндэслэл: Хучин төгөлдөр үйлчилж буй "Дампуурлын тухай" хуулиар дампуурлын эрх зүйн харилцаа нь уг хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу хэрэг гүйцэтгэгчийг томилсноор эхлэнэ. Гэхдээ дампуурлын ажиллагаа нь эрх зүйн олон салбарыг хамарсан харилцаанаас бүрддэг бөгөөд ялангуяа энэ нь материаллаг болон процессын эрх зүйн хэм хэмжээнүүдээс бүрддэг.[515] Үүний нэг нь дампуурлын хэрэг гүйцэтгэх субъектэд хариуцагчийн эд хөрөнгийг хамгаалах эрх үүсэх юм. ХБНГУ-ын "Дампуурлын тухай" хуулийн 80 дугаар зүйлийн 80.1-т хариуцагчийн эд хөрөнгөө захиран зарцуулах эрх хэрэг гүйцэтгэгчид шилждэг. Манай улсын хувьд "Дампуурлын тухай" хуулийн зохицуулалтаас харахад хариуцагчийн эд хөрөнгийн эрх нь хуулийн дагуу бус шүүхийн шийдвэрийн дагуу үүснэ. Гэхдээ шүүхийн шийдвэр гарах урьдач нөхцөлийг хуульд дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

• Хариуцагч хуулиар тогтоосон хугацаанд дахин хөрөнгөжүүлэх хүсэлтээ гаргаагүй;

• Төлөвлөгөөг шүүхэд өгөөгүй;

• Ирүүлсэн төлөвлөгөөг шүүх батлаагүй;

• Хариуцагчийг татан буулгах тухай шүүхийн шийдвэр гарсан[516] тохиолдолд.

Харин Казакстан, Финлянд улсын хуулиар хариуцагчийн эд хөрөнгө захиран зарцуулах эрхийг шууд хэрэг гүйцэтгэгчид шилжүүлдэггүй боловч дампуурлын ажиллагааны үед хариуцагчийн эд хөрөнгө захиран зарцуулах эрхийг шууд хязгаарладаг.[517] Үүнийг манай эрх зүйн зохицуулалттай харьцуулбал дараах хоёр ялгаатай.

Нэгдүгээрт, хариуцагчийн эд хөрөнгийг хамгаалах эрх зүйн харилцааны зохицуулалтыг эрх шилжүүлэх болон эрхийг хязгаарлах байдлаар зохицуулсан байна. Өөрөөр хэлбэл, дампуурлын ажиллагааг явуулж эхлэхэд хариуцагчийн эд хөрөнгийн эрх өөр этгээдэд хуулийн дагуу шилжсэн байх эсхүл эрх шилжэгүй боловч хариуцагчийн эд хөрөнгийн эрх хязгаарлагдсан байх явдал юм.

---

[515] Свириденко О.М /2009-02/,*Институти несостоятельности /банкротсва/ в науке и практике современной юриспруденции* // Закон и право, 92.

[516] Дампуурлын тухай хууль-14.1.

[517] Казакстан улсын Дампуурлын хууль-28, Финлянд улсын Дампуурлын хууль-2.

Хоёрдугаарт, дампуурлын эрх зүйн харилцаа нь хариуцагч хэдийгээр төрийн эрх бүхий байгууллага /татвар, нийгмийн даатгал/ болон бусад этгээдэд мөнгөн төлбөр төлөх үүрэгтэй холбоотой боловч хамгаалалтын эрх зүйн харилцааг мөн агуулж байдаг.[518] Тийм учраас энэхүү хамгаалалтын зохицуулалт үйлчлэх хууль зүйн боломж нь хялбар байхаар хуульчлах нь зүйтэй юм. Тодруулбал, хариуцагчийн эд хөрөнгийн эрх нь шүүхийн журмаар бус хууль заасан үндэслэлээр шилжиж, хязгаарлагддаг байхаар зохицуулах гэсэн санаа юм.

Дампуурлын ажиллагааны үед эд хөрөнгийг хамгаалах харилцаанд оролцогчдын эрх, үүрэг: Хариуцагчийн эд хөрөнгийг хамгаалах харилцааны нэг онцлог нь хариуцагчийн эд хөрөнгийн эрхийг шилжүүлсэн болон хязгаарласан нь түүнийг дампуурлын ажиллагааны оролцогч байхыг хязгаарлахгүй. Эд хөрөнгийн эрхийг шилжүүлсэн болон хязгаарласан тохиолдолд эд хөрөнгийг хамгаалахтай холбоотой үүрэг хариуцагчид үүсч байдаг. Өөрөөр хэлбэл, дампуурлын ажиллагааны үед хариуцагчийн эд хөрөнгийн эрх нь эд хөрөнгийн тухай үнэн зөв мэдүүлэх, баримт гаргаж өгөх, мэдээлэл өгөх[519], зэрэг үүргээр солигддог. Энэ нь дампуурлын ажиллагаан дахь эд хөрөнгө хамгаалах харилцааны оролцогчдын мөн чанарыг илэрхийлж байдаг. Гэхдээ дампуурлын ажиллагаа нь хууль заасан хугацаанд явагддаг буюу байнга үргэлжлэх харилцаа биш тул хариуцагчийн эд хөрөнгийн эрхийг туйлын байдлаар хязгаарлаж /дуусгавар болгож/ болохгүй гэдэг нь ойлгомжтой. Нөгөө талаас дампуурлын ажиллагааны үед хариуцагч нь нэгэнт хийгдсэн, дампуурлын ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй гэж үзсэн гэрээ хэлцлийн дагуу аж ахуйн үйл ажиллагааг явуулахын тулд нийт актив хөрөнгийн тодорхой хувиас дээшгүй үнийн дүнтэй эд хөрөнгийг захиран зарцуулах эрхтэй байж болдог. Жишээ нь: ОХУ-ын Дампуурлын тухай хуулийн 4 дүгээр бүлэгт дампуурлын ажиллагааны нэг хэсэг нь хариуцагчийн үйл ажиллагаанд тавих хяналт гэдгийг зааж өгсөн бөгөөд уг хуулийн 64 дүгээр зүйлд хариуцагчийн эд хөрөнгийн эрхэд тавих хязгаарлалтыг тодорхойлсон байна.

Дампуурлын ажиллагааны үеийн бас нэг чухал ойлголт нь эд хөрөнгө юм. Хэрэг гүйцэтгэгч нь дампуурлын ажиллагааны зорилтыг хангах үүднээс хариуцагчийн эд хөрөнгийг хамгаалах арга хэмжээ авах үүрэгтэй байдаг.[520]

Эд хөрөнгийг хамгаалах талаар зайлшгүй хийх ажиллагаанууд, түүний онцлог: Эд хөрөнгө нь нэг талаас нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангах, нөгөө талаас хариуцагчийн эдийн засгийн чадавхийг тодорхойлох үндэслэл болж байдаг. Эд хөрөнгийг дампуурлын ажиллагаатай холбоотойгоор шууд объектив буюу бодит байдлаар авч үзэж болохгүй. Учир нь эд хөрөнгө нь олон талт ойлголт юм. Эд хөрөнгийн харилцаа нь

---

[518] Свириденко О.М /2009-02/,*Институти несостоятельности /банкротсва/ в науке и практике современной юриспруденции* // Закон и право, 94.

[519] Мэдээлэл өгөх гэдэг нь дампуурлын ажиллагаа явагдаж байгаа хэдий ч хариуцагчийн явуулж буй аж ахуйн болон бусад үйл ажиллагааны улмаас ирээдүйд бий болох эд хөрөнгийн талаар мэдээлэхийг хэлсэн болно. /ХЗҮХ/

[520] Свириденко О.М /2009-2/252//, *Участники производства по делам о несостоятельности /банкротстве/* // Право и экономика, 107.

эрх зүй, эдийн засаг, үнэ өртгийн агуулгатай байдаг.[521] Мөн эд хөрөнгийг шинж чанараар нь хөдлөх болон үл хөдлөх, бодит байдлаар нь биет болон биет бус /эрх/ гэж тус тус ангилж болдог. Манай улсын хуульд эд хөрөнгийг өөрийн хөрөнгө гэзд "өөрийн хөрөнгө" гэж хариуцагчийн үндсэн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийн үнийн дүнгээс бусдад төлөх нийт зээл, өр төлбөрийг хассан зөрүүг[522] хэлнэ гэж тодорхойлсон байна. Харин ХБНГУ-ын хуульд дампуурлын хэрэг үүсгэх өдөр хүртэл болон үүссэнээс хойш бий болсон эд хөрөнгө гэж тодорхойлсон бол Казакстан Улсын хуульд дампуурлын хэрэг үүсгэх өдөр хүртэлх хариуцагчийн эд хөрөнгө болон бусад этгээдээс авах авлага гэжээ.

Эд хөрөнгийг хамгаалах талаарх гадаад хэл дээрх зарим эх сурвалжуудад тэмдэглэснээс үзэхэд манайхаас дараах онцлогтой болохыг харж болохоор байна. **Үүнд:** Манай улсын хуульд өөрийн хөрөнгө гэсэн нэр томъёог хэрэглэн түүндээ юуг ойлгохыг тодорхойлсон бол зарим орны хуульд ингэж тодорхойлсон зүйл байхгүй байна. Үүнээс харвал дампуурлын ажиллагаан дахь эд хөрөнгө гэж юуг ойлгох нь төдийлэн маргаантай зүйл биш бөгөөд үүнийг иргэний эрх зүйн үндсэн ойлголт буюу Иргэний хууль тогтоомжид тусгаснаар шууд ойлгодог байж болох юм.

Эд хөрөнгө хамгаалах харилцаан дахь аж ахуйн үйл ажиллагааны онцлог: Манай улсын хуульд байхгүй боловч дампуурлын ажиллагааны үед эд хөрөнгөд хамгаалалт тогтоохдоо тухайн эд хөрөнгийг дампуурлын ажиллагаанд хамаарах болон үл хамаарах гэсэн шалгуураар тогтоодог байна. Учир нь зарим тохиолдолд дампуурлын ажиллагаатай холбоотойгоор өв залгамжлалын асуудлууд ч хөндөгдөж байдаг гэж үздэг. Жишээлбэл, дампуурлын ажиллагааны хариуцагч нь өвлөгч байгаа тохиолдолд өвлөж авсан өвийн хэмжээгээр эд хөрөнгийн хариуцлага хүлээнэ. Гэхдээ үүнийг манай улсын бусад хууль тогтоомжид огт байхгүй зохицуулалт гэж ойлгож болохгүй.

Хамаарах болон үл хамаарах гэж заагаагүй боловч Компанийн тухай хуульд ийм зохицуулалт байдаг. Өөрөөр хэлбэл, компанийн хувь нийлүүлэгч нь хариуцлага хүлээхдээ зөвхөн тухайн компанид оруулсан хөрөнгөөрөө хариуцлага хүлээдэг[523]. Энэ нь дампуурлын ажиллагаанд ч хамаатай бөгөөд хариуцлага хүлээж буй нэг хэлбэр юм.

Эд хөрөнгийг хамгаалахад хяналт тавих арга, этгээд: Дампуурлын ажиллагааны үед эд хөрөнгийг хамгаалахдаа эд хөрөнгө гэж юу вэ гэдгийг тодорхойлохдоо бус хариуцагчийн өмч мөн үү биш үү гэдгийг тодорхойлох нь юу юунаас чухал юм. Өмнө нь хэлсэнчлэн эд хөрөнгө гэдэг нь олон талын ухагдахууныг агуулж байдаг. Тийм учраас хариуцагчийн эд хөрөнгийг хамгаалж, хяналт тавихын тулд хэрэг гүйцэтгэгч нь аудит, мэргэшсэн нягтлан бодогч, салбар эрх зүйгээр дагнан мэргэшсэн хуульч, эдийн засгийн шинжээчийг уг ажиллагаанд татан оролцуулах эрхтэй байх хэрэгтэй юм[524].

---

[521] Сарнакова А.В /2009-11/, *Правовая природа отношений, возникаюших при банкротсве кредитных организации* // Закон и право, 97.

[522] Дампуурлын хууль-3.

[523] Хэрвээ компанийн хөрөнгө, хувь нийлүүлэгчийн хөрөнгө тусгаарлагдсан бол /Компанийн тухай хуулиас дэлгэрүүлж харна уу/.

[524] ОХУ-ын дампуурлын тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт ийм зохицуулалт байдаг.

Нөгөө талаас хариуцагчийн эд хөрөнгийг тогтоох нь түүний явуулж буй аж ахуйн үйл ажиллагаатай салшгүй холбоотой байдаг. Үүнтэй холбоотойгоор хариуцагчийн эд хөрөнгийг манай хуульд заасан шиг явцуу байдлаар тодорхойлох нь учир дутагдалтай юм. Жишээ нь: хэрэглэгчдээс захиалга авч /урьдчилгаа төлбөр/ барилгын үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийн эд хөрөнгийг тогтоох ажиллагаа нь, санхүүгийн үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийн эд хөрөнгийг тогтоож хамгаалалтад авахаас өөр процедуртай байх нь ойлгомжтой. Уг асуудлыг ОХУ-ын хувьд 2002 оны "Дампуурлын тухай" хуулийн 9 дүгээр бүлэг /Онцгой зохицуулалт бүхий хуулийн этгээдийн дампуурлын онцлог/-т тусгасан байдаг бөгөөд үүндээ санхүүгийн байгууллага, хөдөө аж ахуй, стратегийн ач холбогдолтой байгууллага, аж ахуйн нэгж, зүй ёсны монополь болон хувиараа аж ахуй эрхлэгчийг авч үзсэн байдаг. Түүнчлэн 1999 оны "Зээлийн байгууллагын дампуурлын тухай" хуулиар зөвхөн зээлийн байгууллагуудын дампуурлыг зохицуулдаг. Энэ нь эдийн засгийн хямралын үед энэ төрлийн байгууллагууд хамгийн ихээр дампуурсан ба түүнийг зохицуулах нь бусад этгээдийн дампуурлаас ихээхэн онцлог байдагтай холбоотой юм.

Хариуцагчийн эд хөрөнгийг тогтоох олон арга хэлбэр байж болох боловч тухайн эд хөрөнгөд тавигдах хамгийн эхний суурь шалгуур нь биет байдлын доголдолгүй байх буюу зориулалтын дагуу хэрэглэж болох, эрхийн зөрчилгүй буюу тухайн эд хөрөнгийн талаар гуравдагч этгээд маргахгүй, түүний ашиг сонирхол хөндөгдөхгүй байх явдал юм. Нэгэнтээ энэ талаар маргаан байхгүй бол хариуцагчийн эд хөрөнгийг хамгаалах дараа дараагийн үр дагавар үүснэ. Үүний нэг нь хариуцагчийн эд хөрөнгийн эрх шилжсэн, хязгаарлагдсаныг эрх бүхий этгээдэд /эрхийн бүртгэл, тусгай зөвшөөрлийн бүртгэл гэх мэт/ мэдэгдэх үйл ажиллагаа юм. Түүнчлэн өмнө нь эд хөрөнгийн харилцаа нь эдийн засгийн болон үнэ өртгийн агуулгатай, мөн дампуурлын эрх зүйн харилцаа нь хамгаалах харилцаа, эдгээр нь хоорондоо олон талаар шалтгаант холбоотойг дурдсаны дагуу хариуцагчийн эд хөрөнгийн эдийн засгийн утга болох үнэ өртгийг алдагдуулахгүй байх нь түүнийг хамгаалах нэг арга юм. Үүний нэг жишээ нь хариуцагчийн эзэмшиж буй аливаа тусгай зөвшөөрлийг /ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл/ ямар нэг нөхцөл болзолтойгоор бусдад сонирхогч этгээдэд шилжүүлэх байж болно.

Энэ үйл ажиллагаа нь хариуцагчийн эрхийг эд хөрөнгө болгож байгаа процесс болно. Үүнийг хариуцагчийн эд хөрөнгийг хамгаалж байгаа гэж үзэж болох бөгөөд энэ нь манай хуульд заасан өөрийн хөрөнгө гэсэн тодорхойлолтод орохгүй боловч дампуурлын ажиллагаанд хамааралтай хөрөнгө болж байгаа юм.

Хэдийгээр дампуурлын ажиллагааны үед эд хөрөнгийг хамгаалах эрх зүйн зохицуулалт үйлчлэх хэдий ч энэ хариуцагчийн эд хөрөнгийг нэмэгдүүлэх харилцааг хөндөхгүй. Тодруулбал, санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын хувьд зээл олгохгүй боловч дампуурлын хэрэг үүсгэхээс өмнө олгосон зээлийн төлөлт хэвийн журмаар явагдана гэсэн үг юм. Үүнийг ч манай улсын Дампуурлын тухай хуулийн 17 дугаар зүйлд тусгасан байдаг. Гэхдээ хариуцагчийн эд хөрөнгийг хамгаалах нь түүнийг ямар ч хөдөлгөөнгүй зогсонг байдалтай болгож байгаа гэсэн үг биш юм. Дампуурлын ажиллагаа явагдаж байгаа хэдий ч хариуцагч шүүхийн

шийдвэрийн дагуу ямар нэг үүрэг гүйцэтгэх ёстой бол /төлбөр төлөх, эд хөрөнгө шилжүүлэх/ үүнийг хариуцагчийн эд хөрөнгөөс гүйцэтгэнэ. Энэ нь шүүхийн шийдвэр ямар ч тохиолдолд заавал биелэгдэх шинжтэй холбоотой ойлголт бөгөөд түүнийг хянан шийдвэрлэх этгээд нь шүүх байна.

Эд хөрөнгийг хамгаалах харилцаа дуусгавар болох үндэслэл: Дампуурлын эрх зүйн харилцаа нь хуульд заасан хугацаанд үргэлжилж байдагтай адил эд хөрөнгийг хамгаалах харилцаа ч мөн адил хугацаатай байна. Энэ харилцаа нь эд хөрөнгийн эрх хэрэг гүйцэтгэгчээс хариуцагчид шилжсэнээр дуусгавар болно. Гэхдээ үүнийг энгийн зохицуулалт гэж ойлгож болохгүй. Нэхэмжлэгчдийн нэхэмжлэлийг бүрэн хангаж дуусаны дараа шинэ нэхэмжлэгч гарч ирэх боломжит хугацаа байх ёстой. Энэ үр дагаврыг тооцсон зохицуулалтыг хуульд тусгах шаардлагатай юм. Түүнчлэн энэ зохицуулалт нь дампуурлын ажиллагаа дуусанаас хойш уг ажиллагаатай холбоотой маргаан гарахгүй буюу дахин энэ талаар шүүх нэмэмжлэл хүлээн авахгүй байх үр дагаврыг агуулж байдаг.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

__oOo__

ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН БОЛОН ЭРХИЙН БАРЬЦААНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ ХИЙСЭН СУДАЛГАА[525]

ОРШИЛ

Энэ судалгаа нь хөдлөх эд хөрөнгө болон эрхийн барьцааны бүртгэл нийтэд нээлттэй ба хаалттай байж болох үндэслэл барьцааны зүйлийг худалдан борлуулах арга хэлбэрийг гадаад орны туршлагатай харьцуулан судалж, хөдлөх хөрөнгө болон эрхийн барьцааны тухай бие даасан хуультай болох хэрэгцээ шаардлага байгаа эсэх, Монгол Улсын холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ байгаа эсэхэд хууль зүйн үндэслэлтэй дүгнэлт өгснөөрөө ач холбогдолтой болсон.

1.1. ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ БОЛОН ЭРХИЙН БАРЬЦААНЫ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Монгол Улсын Иргэний хуулийн 153-160 дугаар зүйлд барьцааны эрх зүйн ерөнхий зохицуулалтуудыг заасан бол 161-164 дүгээр зүйлд хөдлөх эд хөрөнгө ба эрхийн барьцааны тухай тусгай зохицуулалтыг тусгасан байна. Эдгээр нь барьцааны гэрээнд тулгуурлан үүсдэг өмчийн хязгаарлагдмал эрхийг зохицуулахад чиглэсэн байдаг. Гэвч барьцааны эрх гэдэг нь дан ганц гэрээгээр үүсэх бус, харин нийтийн болон хувийн эрх зүйн аль ч салбарт тохиох бусад гэрээний гүйцэтгэлийг хангах арга хэрэгсэл болж хэрэглэгддэг. Жишээлбэл иргэний эрх зүйн бүхий л саатуулан барих эрхүүд, мөн нийтийн эрх зүйн хууль тогтоомж болох Ашигт малтмалын тухай хууль зэрэгт өмчийн эрх зүйн шинж бүхий барьцааны эрх үүсэх тухай эсхүл оролцогсод төрөөс олгосон лиценз зэргийг барьцаалах зөвшөөрлийг иргэдэд олгосон байна.

Түүнчлэн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх явцад үүрэг гүйцэтгүүлэгчийн хөрөнгийг битүүмжилсэн аль ч нөхцөлд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /ИХШХШТХ/ болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /ШШГТХ/-ийн дагуу төрөөс иргэний хөрөнгөд барьцааны эрх үүсдэг. Энэ барьцааны эрхэд тулгуурлан эд зүйлийг худалдан борлуулж улмаар шаардлагыг хангах тухай ШШГТХ-д дэлгэрэнгүй зохицуулсан.

Дээрхээс үзвэл барьцааны эрх маань талуудын тохиролцоонд суурилан үүссэн бол Иргэний хуулийн 153-160 дугаар зүйлд заасан ***гэрээнээс үүдэлтэй*** барьцааны эрхийг зохицуулалт хэрэглэгдэж, бусад Иргэний хуульд тусгасан ***хуулиас үүдэх*** барьцааны эрхүүдийн хувьд дээрхийг төсөөтэй хэрэглэх эсэх нь тодорхойгүй болжээ.

[525] УИХ-ын 38 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2012 он хүртэл боловсронгуй болгох тухай үндэсний чиглэлийн 1.110-д "Хөдлөх эд хөрөнгө болон түүнтэй холбоотой эрхийг гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах хоёр дахь эх сурвалж болгон барьцаалах, барьцааг бүртгэх, барьцааны шаардлагыг хангах зохицуулалтыг бий болгох" шаардлагын хүрээнд "Хөдлөх эд хөрөнгө болон эрхийн барьцааны тухай" хуулийн төсөл боловсруулан ажиллаж байгаатай холбогдуулан ХЗДХЯ-аас өгсөн удирдамжийн дагуу энэхүү судалгааг хийж гүйцэтгэв.

Барьцааны эрх нь барьцаалагч буюу үүрэг гүйцэтгүүлэгчид барьцааны зүйлийн үнээс шаардлагаа хангуулах эрх олгох эрхийг илэрхийлсэн ухагдахуун бөгөөд үүнд Европын улсуудад ихэвчлэн хөдлөх хөрөнгө ба эрх барьцаалахыг ойлгодог. Харин үл хөдлөх хөрөнгийн барьцаа буюу ипотек нь тусдаа бие даан хөгжсөн ойлголт. Монгол Улсын Иргэний хуульд заасантай адил үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгийн барьцаатай нийтлэг зохицуулалтаар холбогдож буй үзэгдэл тун ховор. Хэрэв Иргэний хуулийн 153-160 дугаар зүйл буюу барьцааны эрхийн тухай нийтлэг зохицуулалтыг үл хөдлөх хөрөнгийн барьцааны зүйл заалттай харьцуулан судлаад үзвэл ипотекийн тухай Иргэний хуулийн 165 дугаар зүйлээс хойших зүйлд эдгээр нийтлэг зохицуулалтыг хэрэглэх шаардлага байдаггүй. Харин ч нийтлэг зохицуулалт нь илүү хөдлөх эд хөрөнгийн барьцаатай холбоотой нь ажиглагдана. Тиймээс энд хөдлөх эд хөрөнгө ба эрхийн барьцаа гэсэн хэсгийг өргөтгөн шинэчлэн найруулах замаар нэмэлт шинэ хууль гаргалгүй хөдлөх эд хөрөнгө ба эрх барьцааны асуудлыг цэгцлэх нэг боломж бий.

Иргэний хуульд хөдлөх эд хөрөнгө болон эрхийн барьцаатай холбоотой дараах зохицуулалтууд хангалттай тусгагджээ. Үүнд:

- Барьцааны эрхийн агуулга: Иргэний хуулийн 154 дүгээр зүйл;
- Шаардлага хангуулах арга зам маш ерөнхий: Иргэний хуулийн 158,159, 163 дугаар зүйл;
- Эрх үүсэх урьдчилсан нөхцөл: Иргэний хуулийн 156, 153, 154 дүгээр зүйл;
- Барьцааны эрх шилжих: Иргэний хуулийн 161,155 дугаар зүйл;
- Барьцааны эрх шударгаар олж авах: Иргэний хуулийн 154 дугаар зүйлийн 154.6 дах хэсэг /ерөнхий/.

Ашигт малтмалын тухай хуулийн 51 дүгээр зүйлд ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрлийг банк болон банк бус санхүүгийн байгууллагад барьцаалахдаа барьцааны бүртгэлийг төрийн захиргааны байгууллагад бүртгүүлнэ гэжээ. Гэтэл Иргэний хуулийн 156 дугаар зүйлд зааснаар үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийн эрхийн барьцааг улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж болно гэж заасан нь хууль хоорондоо зөрчилдөж байна.

Хоёр. ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН БОЛОН ЭРХИЙН БАРЬЦААНЫ БҮРТГЭЛ, ГАДААД ОРНЫ ТУРШЛАГА

2.1. ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ БОЛОН ЭРХИЙН БАРЬЦААНЫ БҮРТГЭЛ

Монгол Улсын Иргэний хуулийн 156 дугаар зүйлийн 156.2-т "Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээг улсын бүртгэлд бүртгүүлэх бөгөөд гэрээнд талуудын нэр, оршин суугаа /оршин байгаа/ газар барьцаагаар хангагдах шаардлага, түүний хэмжээ, үүргийг хангах хугацаа, барьцааны зүйл, түүний байгаа газар, үнийг заана" гэжээ. Харин 156 дугаар зүйлийн 156.4-т "Талуудын аль нэг нь хүсвэл үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээг нотариатаар гэрчлүүлэх буюу бүртгэлийн байгууллагад бүртгүүлж болно"

гэснээс үзвэл Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээг заавал бүртгүүлэх шаардлагатай, харин хөдлөх эд хөрөнгө болон эрхийн барьцааны бүртгэлийг бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх эсэх нь талуудын хүсэл зоригоор илэрхийлэгдэнэ гэж ойлгож болно. Хуулийн энэхүү заалтыг үндэслэн Улсын бүртгэлийн газар 2002-2010 оны хооронд Улаанбаатар хотын хэмжээнд хөдлөх эд хөрөнгийн эрхийн бүртгэл нийтдээ 5 удаа хийгдсэн байна. Үүнийг дэлгэрэнгүй байдлаар үзүүлбэл:[526]

№	Өмчлөгч	Анх бүртгэгдсэн огноо	Эд хөрөнгийн зориулалт, нэр	Барьцаанд тавигдсан эсэх
1.	Иргэн	2008.07.08	Ачааны вагон 1ш	Капитрон банкинд 2006 онд 1.6 сарын хугацаатай 30 сая төгрөгийн зээлийн барьцааны, 2007 онд 18 сарын хугацаанд 61.100 төгрөгийн барьцааны, 2009 онд 12 сарын хугацаатай 20 сая төгрөгийн барьцааны, 2010 онд 60 сая төгрөгийн барьцааны тус бүр барьцаалсан.
2.	ХХК	2008.08.10	Ачааны вагон 1ш	Барьцаанд тавигдсан.
3.	Иргэн	2009.08.10	Ачааны вагон 1ш	2009 онд ХЗХ-д 12 сарын хугацаатай 25 сая төгрөгийн зээлийн барьцааны тавигдсан. 2011 онд банкинд 12 сарын хугацаатай 60 сая төгрөгийн барьцааны тавигдсан.
4.	Иргэн	2009.08.10	Ачааны вагон 1ш	Банкинд 12 сарын хугацаатай 60 сая төгрөгийн барьцааны тавигдсан.
5.	ХХК	2010 .03.09	Хэвлэх үйлдвэрийн тоног төхөөрөмж	2010 онд банкинд 60 сарын хугацаатай 1.2 тэрбум төгрөгийн барьцааны тавигдсан.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас авсан мэдээгээр 8 жилийн хугацаанд 5 удаагийн эд хөрөнгийн бүртгэл хийсэн байгаа нь нийт бүртгэлийн 1%-д хүрэхгүй үзүүлэлт юм.

[526] Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2011 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 02/165 тоот албан бичгийн хариу.

ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН БОЛОН ЭРХИЙН БАРЬЦААГ БАРЬЦААЛСНЫ УЛМААС ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭГДСЭН ИРГЭНИЙ ХЭРГҮҮД /2008-2010 ОН/

2008 онд Нийслэлийн иргэний хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн хэргүүд[527]



• Баянгол дүүрэгт 2008 оны шийдвэрлэгдсэн нийт 3727 хэргийн 9 хэрэг нь хөдлөх эд хөрөнгө барьцаалсан зээл байх ба үүнээс:

1. Барьцааны гэрээгээр барьцаалан зээлдүүлэх газарт /Ломбард/ - 3
2. ББСБ-д зээлийн гэрээний барьцаанд -1
3. Хадгаламж зээлийн хоршоонд зээлийн гэрээний барьцаанд-5 иргэний хэрэг хянан шийдвэрлэгджээ.

Барьцааны зүйл нь:

1. Суудлын автомашин;
2. Бульдозер;
3. Ашигт малтмалын ашиглах лиценз.

• Сүхбаатар дүүрэгт 2008 онд нийт 4336 хэрэг шийдвэрлэгдсэнээс хөдлөх эд хөрөнгө барьцаалсан 6 хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэн.

1. Банкны зээлийн гэрээний барьцаанд – 3
2. Хадгаламж зээлийн хоршооны зээлийн гэрээний барьцаанд – 3 иргэний хэрэг хянан шийдвэрлэгдсэн.

Барьцааны зүйл нь:

1. Суудлын автомашин;
2. Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн лиценз;
3. Компаний хувьцаа;
4. Араб үүлдрийн адуу;
5. Гэр ахуйн цахилгаан бараа.

• Баянзүрх дүүргийн шүүхээр нийт 1379 хэрэг шийдвэрлэгдсэнээс хөдлөх эд хөрөнгө барьцаалж зээл олгосноос үүдэлтэй иргэний хэрэг 7 байна.

[527] Нийслэлийн шүүхийн иргэний хэргийн төв архив. Иргэний хэргийн шүүхийн шийдвэрүүдэд хийсэн судалгаа.

1. Хадгаламж зээлийн хоршоонд зээлийн гэрээний барьцааанд 3
2. Банкны зээлийн гэрээний барьцааанд 5 иргэний хэрэг хянан шийдвэрлэгдсэн ба уг зээлийн

Барьцааны зүйл:

1. Компанийн хувьцаа;
2. Суудлын автомашин;
3. Ачааны автомашин;
4. Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөлийн лиценз;

• Хан-уул дүүрэгт 947 иргэний хэрэг хянан шийдвэрлэгдсэнээс 4 хэрэг нь хөдлөх эд хөрөнгө барьцаалж зээл олгосноос үүдэлтэй иргэний хэрэг байна.

1. Хадгаламж зээлийн хоршоонд зээлийн барьцааанд 2
2. Банкны зээлийн барьцааанд 2 иргэний хэрэг хянан шийдвэрлэгдсэн.

Барьцааны зүйл:

1. Суудлын автомашин:
2. Уул уурхайн тоног төхөөрөмж;

• Чингэлтэй дүүрэгт 1640 иргэний хэрэг шийдвэрлэгдсэнээс 9 нь хөдлөх эд хөрөнгийн барьцаатай холбоотой иргэний хэрэг шийдвэрдлэгдсэн:

1. Банкны зээлийн гэрээний барьцааанд 5;
2. Хадгаламж зээлийн хоршооны зээлийн гэрээний барьцааанд 4 иргэний хэрэг шийдвэрлэгдсэн.

Барьцааны зүйл:

1. Суудлын автомашин;
2. Микроавтобус;
3. Гэр ахуйн цахилгаан бараа;

• Сонгино хайрхан дүүрэгт 1545 иргэний хэрэг хянан шийдвэрлэгдсэнээс 4 нь хөдлөх эд хөрөнгийн барьцаатай холбоотой иргэний эрх зүйн маргаан байна.

1. Банкны зээлийн барьцааанд 3
2. Хадгаламж зээлийн хоршоонд 1

Барьцааны зүйл:

1. Суудлын автомашин;
2. Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж;
3. Гэр ахуйн цахилгаан хэрэгсэл.

Дээрх онуудад шийдвэрлэсэн хэргийн шийдвэрүүдээс харахад хөдлөх эд хөрөнгө болон эрхийн барьцааны гэрээ нь зээлийн гэрээний салшгүй хэсэг болсон байхаас гадна арилжааны банкууд үл хөдлөх эд хөрөнгийг хөдлөх эд хөрөнгө, эрхийн барьцааны хамт барьцааны зүйлд авдаг байна. Харин банк бус санхүүгийн байгууллага, Хадгаламж зээлийн хоршоо, барьцаалан зээлдүүлэх газар /ломбард/нь автомашин болон бусад үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг барьцааны зүйл болгон авдаг байна[528].

[528] Шүүхээр шийдвэрлэгдэж буй бусад гэрээний маргаантай харьцуулбал барьцааны гэрээ нь харьцангуй бага хувь буюу 1%-д хүрэхгүй байна. Мөн барьцааны эрхтэй холбоотой Иргэний хуулийн 153-164 дэх зүйлүүдтэй холбоотой маргаан гэж зүйлчлэн үзэх боломжгүй харин тухайн онуудын шийдвэрүүдийг нэг бүрчлэн судалсан болно.

Шүүхээр шийдвэрлэгдсэн дээрх хэргүүдийн барьцааны зүйл нь Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэгдээгүй байх ба энэ нь тайлангийн 2.1 дэх хэсэгт дурьдагдсан Улсын бүртгэлийн газраас ирүүлсэн албан тоотын хариугаар нотлогдож байна. Үүнээс дүгнэн үзвэл Иргэний хуулийн 156 дугаар зүйлийн 156.4-т "Талуудын аль нэг нь хүсвэл үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээг нотариатаар гэрчлүүлэх буюу бүртгэлийн байгууллагад бүртгүүлж болно" гэсэн нь хэлбэрийн төдий заалт байх ба гадаадын улс орнууд хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийг харьяалсан бүртгэлийн газарт заавал бүртгүүлэхийг хуульчилсан байдаг байна./ Энэ талаар дэлгэрэнгүй 2.3 дах хэсгээс үзнэ үү/

Барьцааны гэрээтэй холбоотой шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг маргааны судлан үзвэл үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй улмаас үүрэг гүйцэтгүүлэгчид Иргэний хуулийн 158 дугаар зүйлд зааснаар шаардах эрх үүссэн. Нэхэмжлэлийн шаардлага нь барьцааны зүйлийг худалдан борлуулж барьцаалагчийн шаардлагыг хангуулахаар шүүхийн шийдвэрт тусгуулах хүсэлтээ гаргасан байх ба шүүх энэхүү хүсэлтийг хүлээн авч хангаж шийдвэрлэдэг нийтлэг жишигтэй.

2.2. БАРЬЦААНЫ ЗҮЙЛИЙГ ХУДАЛДАН БОРЛУУЛАХ АРГА, ХЭЛБЭРИЙН ТАЛААР ГАДААД ОРНУУДЫН ТУРШЛАГА

Монгол Улсын холбогдох хуулиудад оруулах нэмэлт, өөрчлөлтийн талаар санал боловсруулахад энэхүү бүлгийн зорилго орших бөгөөд тайлангийн энэ бүлгийг бичихийн тулд эрх зүйн ижил тогтолцоотой улсын хувьд ХБНГУ-ын Иргэний хууль болон иргэний процессын хуулийг жишээ болгон сонгож судалсан бөгөөд судалгааны энэ бүлгийн хамрах хүрээ нь:

1. Монгол Улсын Иргэний хууль болон бусад хууль тогтоомж
2. ХБНГУ-ын хууль тогтоомжоос:

- Иргэний хуулийн 1205-1297 дугаар зүйл /§§1205-1297/
- Иргэний процессын кодекс /§§ ZPO/ байсан болно.

А. Хөдлөх эд хөрөнгө ба эрхийн барьцаатай холбоотой нийтлэг ойлголт:

Барьцааны эрх нь барьцаалагч буюу үүрэг гүйцэтгүүлэгчид барьцааны зүйлийн үнээс шаардлагаа хангуулах эрх олгох илэрхийлсэн ухагдахуун бөгөөд Европын улсуудад үүнд ихэвчлэн хөдлөх хөрөнгө болон эрх барьцаалахыг ойлгодог. Харин үл хөдлөх хөрөнгийн барьцаа буюу ипотек нь тусдаа бие даан хөгжсөн байх ба Монгол Улсын Иргэний хуульд заасантай адил үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгийн барьцаа нь нийтлэг зохицуулалтаар холбогдож буй үзэгдэл тун ховор ажээ.

Ипотекийн эрх нь зөвхөн мөнгөн төлбөрт чиглэсэн тодорхой шаардах эрхийн баталгаа болдог бол барьцааны эрхийн хувьд шаардлагыг мөнгөн төлбөрт шилжүүлэх боломжтой байхад л хангалттай. Мөн хөдлөх хөрөнгийн болон эрхийн барьцааны эрх нь нэгэн зэрэг эд зүйлийг ашиглах эрхийг

өөртөө агуулж байх боломжтой. Ипотекийг зөвхөн үл хөдлөх хөрөнгө дээр л хэрэглэх бол барьцааны эрхийг хөдлөх хөрөнгө, эрх, шаардах эрх зэрэг бусад бүх хөрөнгийн төрөлд хэрэглэж болно.

Барьцааны эрх нь ипотекийн адил акцессор шинжтэй, Иргэний хуулийн 87дугаар зүйлд хамаарах эрх юм. Хөдлөх эд хөрөнгийг барьцаалах эрх нь Иргэний хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4-т зааснаар газар, түүнээс салгамагц зориулалтын дагуу ашиглаж үл болох эд юмсаас бусад төрлийн хөрөнгөд үүснэ. Эдгээр нь хэд хэд байх боломжтой.

Иргэний эрх зүйн харилцаанд оролцогсод сайн дурааараа хүсэл зоригоо илэрхийлэн барьцааны эрх үүсгэж буй бол үүнийг гэрээнээс үүдэлтэй барьцааны эрх хэмээн нэрлэх бөгөөд энэ тухай иргэний хуулийн 153 дугаар зүйлээс 160 дугаар зүйлд ерөнхий байдлаар зохицуулсан. Энд барьцаалуулагч дангаар эзэмших эрхээс татгалзаж, эзэмшлийн тодорхой хэлбэрийг барьцаалагчид шилжүүлэх ёстой байдаг. Барьцаа нь зээлийн үүргийн гүйцэтгэлийг хангах үндсэн чиг үүрэгтэй энэ хэсгийг Иргэний хуулийн 231 дүгээр зүйлийн 231.1.4 дэх хэсэгт зааж өгсөн байна.

Барьцааны эрх зүйд барьцааны эрх үүсэх ба түүнийг **хэрэгжүүлэх** буюу **худалдан борлуулах** 2 үе шат бүхий эрх зүйн харилцаа үүсдэг бөгөөд энэ хүрээнд:

1/ барьцаалагч болон үүрэг гүйцэтгэгчийн хооронд үүссэн үүргийн харилцаа;

2/ барьцаалагч болон барьцаа хөрөнгийн өмчлөгч ба бусад эрх бүхий этгээдийн хооронд үүсэх үүргийн харилцаа;

3/ барьцаалагч болон хөрөнгө худалдаж авсан этгээдийн хоорондын эрх зүйн харилцааг ялгаж үзэх нь зүйтэй.

Барьцаалагч нь зайлшгүй үндсэн шаардлагын үүрэг гүйцэтгүүлэгч байх бол барьцаалуулагч болон эд зүйлийн өмчлөгч нар нь 1 этгээд эсхүл хэд хэдэн этгээд байх боломжтой[529].

Барьцаалагч = Үүрэг гүйцэтгүүлэгч /заавал/

Барьцаалагч болон барьцаагаар баталгаажсан шаардлагын үүрэг гүйцэтгэгч хоёрын хооронд үндсэн шаардах эрхийг тодорхойлж байдаг үүргийн харилцаа үүснэ. Үүрэг гүйцэтгэгч нь өөрийн эд зүйлийг барьцаалж буй бол тэдгээрийн хоорондын үүргийн харилцааг барьцааны гэрээнээс тусгаарлаж авч үзэх бөгөөд жишээлэхэд зээлийн үүргийн харилцаа нь барьцааны гэрээний causa буюу үндэс нь болно. Хэрэв барьцаалуулагч нь үүрэг гүйцэтгэгч биш бол барьцаалагч болон барьцаалуулагчийн хооронд зөвхөн барьцааны гэрээ байгуулагдах ёстой. Эцэст нь барьцаалагч болон худалдан авагчийн хооронд худалдах-худалдан авах гэрээ байгуулагдана.

Энэхүү барьцаалагч ба эцсийн худалдан авагчийн хооронд байгуулагдах гэрээнд иргэний хуулийн 197 дугаар зүйл үйлчилнэ. Тиймээс хөдлөх эд хөрөнгө, эрхийг худалдан борлуулах тухай хууль шинээр батлуулахаас өмнө иргэний хуулийн 195-199 дүгээр зүйлд тусгасан зохицуулалт худалдан борлуулах ажиллагаа явуулахад хангалттай эсэхэд дүгнэлт хийсэн байх

[529] Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3 дахь хэсэг

ёстой. Энд магадгүй Иргэний хуулийн 161-163 дугаар зүйл дотор зарим дутаж буй зохицуулалтыг тусгаж, мөн дээрх зохицуулалт хэрэглэгдэхээр тусгах нь илүү тохиромжтой байх боломжтой ба дуудлага худалдаа зохион байгуулагч нь барьцаалагчийн төлөөлөгч байна[530]. Мөн эд зүйлийн өмчлөх эрхийг шилжүүлэх үед тэрээр барьцаалагчаас бүрэн эрх олгогдсон этгээд хэмээн тооцогдоно. Харин барьцаалагчид худалдан борлуулах эрх үүссэнээр хуулийн дагуу өмчлөх эрхийг шилжүүлэх бүрэн эрхтэй болдог.

Үүргийн эрх зүйн дээрх харилцаанаас гадна өмчийн эрх зүйн хувьд үүсэх дараах харилцааг мөн авч үзэх нь зүйтэй бөгөөд Иргэний хуулийн 154, 155 дугаар зүйлүүдээр өмчийн эрх зүйн үр дагаврыг зохицуулсан байна.

Барьцааг худалдан борлуулах тухай ХБНГУ-ын Иргэний хуулийн 1228 дугаар зүйлээс эхлэх зохицуулалтыг ярьж эхлэхээс өмнө манай Иргэний хуулийн хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай дараах зохицуулалтыг германы хуулийн адилтгах зохицуулалттай хамт дурьдах нь зүйтэй. Үүнд:

Хөдлөх эд хөрөнгийн болон эрхийн барьцааны тусгай зохицуулалт

/Монгол Улсын Иргэний хуулийн зохицуулалт/

161 дүгээр зүйл. Барьцаагаар хангагдах шаардлагыг шилжүүлэх

161.1.Үүрэг гүйцэтгүүлэгч барьцаагаар хангагдах шаардлагыг шилжүүлэх замаар барьцааны эрхээ бусдад шилжүүлж болно.

161.2.Хэрэв шаардлагыг шилжүүлэхэд барьцааны зүйлийг шилжүүлэх боломжгүй бол барьцааны эрх үүсэхгүй.

1250 дугаар зүйл. Шаардах эрхийг шилжүүлэх нь

/ХБНГУ-ийн Иргэний хууль/

/1/ Шаардлагыг шилжүүлснээр барьцааны эрх нь шинэ үүрэг гүйцэтгүүлэгчид шилжинэ. Барьцааны эрхийг шаардах эрхгүйгээр шилжүүлэх боломжгүй.

/2/ Шаардах эрхийг шилжүүлэхэд барьцааны эрх шилжихгүй байхаар тохирсон бол барьцааны эрх үүгээр дуусгавар болно.

Ерөнхий зөвшөөрөл авахтай холбоотой зохицуулалт Монгол Улсын Иргэний хуульд тусгагдсан бол ХБНГУ-ын Иргэний хуульд энэ нь тухайн хэрэглэгдэх тохиолдолдтой холбон зохицуулагдсан.

Монгол Улсын Иргэний хуулийн 162 дугаар зүйл. Зөвшөөрөл авах

162.1.Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол дараах тохиолдолд барьцаалагч, барьцаалуулагч нь харилцан зөвшөөрөл авах үүрэгтэй:

162.1.1.барьцаалагч нь барьцааны зүйлийг барьцаалах бол барьцаалуулагчаас;

162.1.2.барьцаалуулагч нь барьцааны зүйлийн хувьд гуравдагч этгээдтэй хэлцэл хийх бол барьцаалагчаас.

---

[530] Иргэний хуулийн 62, 63 дугаар зүйл.

Б. ХБГНУ-ын Иргэний хууль дахь барьцаанд байгаа хөдлөх эд хөрөнгийг худалдан борлуулах асуудал:

ХБНГУ-ын Иргэний хуулийн 3 дугаар хэсэг буюу Өмчийн эрх зүйн тухай номын 8 дугаар бүлэгт хөдлөх эд хөрөнгө болон эрхийн барьцааны тухай зохицуулалтыг тусгасан байдаг. Эдгээр зохицуулалт Иргэний хуулийн 1204-1296 дугаар зүйлд нийт 94 зүйлийг хамарсан байна. Энд хөдлөх хөрөнгө ба эрхийн барьцааны эрхийн агуулга, үүсэх үндэслэл, шударгаар барьцааны эрхийг шударгаар олж авах боломжтой эсэх талаар зохицуулснаас гадна иргэний хуулийн 1228-1249 дэх зүйлүүдэд хөдлөх эд хөрөнгийг хэрхэн худалдан борлуулах тухай заасан.

Харин иргэний хуулийн 1277 дугаар зүйлд зааснаар барьцааны зүйл эрх байгаа нөхцөлд талууд гэрээгээр өөр арга хэлбэрийг тохироогүй л бол зөвхөн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх аргаар шаардлага хангуулах эрхийг үүрэг гүйцэтгүүлэгчид олгосон. Мөн шүүхийн шийдвэр гүйцэтгэх явцад хөдлөх хөрөнгийг битүүмжилж, улмаар үүсэх барьцааны эрхийг тус улсын Иргэний процессын кодексын 813 дугаар зүйлээс эхлэх шийдвэр гүйцэтгэлийн тухай хэд хэдэн зохицуулалтад тусгасан.

Барьцаанд байгаа хөдлөх эд хөрөнгийг худалдах үйл явцыг тодотгох зорилгоор ХБНГУ-ын Иргэний хуулиас холбогдох заалтыг тайлбарын хамт орчуулсан ба Монгол Улсын Иргэний хуулийн холбогдох хэсгийг хавсаргав.

ХБНГУ-ын Иргэний хуулийн 1228 дугаар зүйл. Барьцааг худалдаж шаардлагаа хангуулах тухай.

/1/ Барьцаа хөрөнгийг худалдан борлуулах замаар шаардлагаа хангуулна.

/2/ Барьцаалагч нь шаардлагыг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн гаргах хугацаа болсон нөхцөлд барьцаа хөрөнгийг худалдах эрхтэй. Хэрэв гүйцэтгэвэл зохих үүрэг нь мөнгө төлөхөд чиглэсэн бол шаардлагыг мөнгөн төлбөрт шилжүүлснээр барьцааг худалдах боломж нээгдэнэ.

Монгол Улсын Иргэний хууль дахь ойролцоо зохицуулалт:

158 дугаар зүйл. Барьцаалагчийн шаардлагыг хангах

158.1.Шаардах эрх үүссэн буюу үүргийн гүйцэтгэлийг хангах хугацаа өнгөрсөн тохиолдолд барьцааны зүйлийг худалдах, бусад хэлбэрээр борлуулах замаар барьцаалагчийн шаардлагыг хангана.

158.2.Үүрэг гүйцэтгэгч үүрэг гүйцэтгүүлэгчид зохих төлбөр хийснээр барьцаалагчийн шаардлагыг хангасан гэж үзнэ.

158.3.Мөнгөн төлбөрийн шаардлагыг бүрэн буюу хэсэгчлэн хангах хугацаа болсон бол барьцаалагч нь барьцааны зүйлийг худалдан борлуулахыг шаардах эрхтэй бөгөөд зөвхөн өөрийн шаардлагыг хангах тохиолдолд энэ эрхийг эдэлнэ.

158.4.Барьцаагаар хангагдах шаардлагыг хангахын тулд хууль зүйн ач холбогдолтой ямар нэгэн үйлдэл хийх зайлшгүй шаардлагатай бол барьцаалагч уг үйлдлийг хийхийг барьцаалуулагчаас шаардах эрхтэй

бөгөөд барьцаалуулагч арван дөрөв хоногийн дотор энэ үйлдлийг хийгээгүй бол барьцаалагч барьцаалуулагчийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдтэй энэ үйлдлийг хийж болно.

158.5.Барьцааны зүйл нь хэд хэдэн этгээдэд барьцаалагдсан бол хамгийн түрүүнд түүнийг барьцаалсан этгээд уг зүйлийг борлуулахыг шаардах эрхтэй бөгөөд уг этгээд энэ эрхээ хэрэгжүүлэхээс татгалзсан бол дараагийн барьцаалагч шаардах эрхээ хэрэгжүүлнэ.

Тайлбар:

Дээрх хоёр зохицуулалт нь хэд хэдэн этгээдэд барьцаалагдсан нөхцөлд үүрэг гүйцэтгүүлэгчдийн давуу эрхийг тусгасан Монгол Улсын Иргэний хуулийн 158 дугаар зүйлийн 158.5 дугаар зүйлээс бусдаар агуулга нэгтэй. ХБНГУ-ын Иргэний хуулийн 1228 дугаар зүйлийн 1228.1 дэх хэсэгт барьцаа хөрөнгөөс хэрхэн шаардлагаа хангуулах талаар тусгасан бөгөөд энэ нь заавал худалдан борлуулах замаар явагдахаар заасан. Тэгэхээр өмч барьцаалагчид шилжих тохиролцоо байж болохгүй гэсэн үг. Мөн талууд гэрээгээр барьцааг худалдаж борлуулахыг хориглосон бол хөдлөх хөрөнгийн барьцааны эрх үүсдэггүй. Ийнхүү худалдахын тулд үүрэг гүйцэтгүүлэгч болох барьцаалагч нь хөрөнгийг дангаар эзэмшиж байх шаардлагатай. Худалдан борлуулах нь барьцаалагчийн эрх болохоос үүрэг биш. Герман Улсад гэхдээ аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны хүрээнд барьцааг цааш хүнд ашиглуулдаг этгээдэд тусгай хуульд тогтоомжоор барьцааг худалдан борлуулах үүрэг ноогдуулдаг. Худалдан борлуулаагүй нөхцөлд үүрэг гүйцэтгэгч нь шийдвэр гүйцэтгэлийг эсэргүүцэх эрх, мөн батлан даагч нь татгалзах эрхтэй болдог.Энэ тухай **ХБНГУ-ын Иргэний хуулийн 1228 дугаар зүйлийн 1228.2 дахь хэсэгт.Худалдан борлуулах эрх үүссэн байх.** Энэ нөхцөл хангагдаагүй бол худалдан борлуулах ажиллагаа 1244 дүгээр зүйлийн дагуу хүчингүй болно. Шаардлага нь мөнгөн төлбөрт чиглэсэн байх ба бүхэлдээ эсхүл хэсэгчлэн төлөх хугацаа нь болсон байх ёстой. Хугацаа хэтэрсэн гэж үзэх мөч эхэлсэн байхаас гадна хариу эсэргүүцэл, татгалзал гаргах эрх байх ёсгүй. Гэрээнд өөрөөр тохирсон бол 1245 дугаар зүйлд хамаарахаас бусад тохиолдолд зөвхөн үүргийн эрх зүйн үр дагавар үүснэ. Тиймээс 1245 дугаар зүйлээс бусдыг зөрчиж худалдсан бол өмчийн эрх зүйн үүднээс 1242 дугаар зүйлд нийцсэн гэж үздэг. Худалдан борлуулах эрх үүсэх урьдчилсан нөхцөлийг хөнгөвчилсөн эсхүл хэдийд ч худалдах боломжтой байх тухай гэрээний тохиролцоог худалдах хугацааг болсон хэмээн тайлбарлах боломжтой. Үүрэг гүйцэтгүүлэгч төлбөрийг хүлээн авах үүргээ зөрчсөн ба улмаар барьцааг худалдсан явдал нь худалдан борлуулах ажиллагааг хүчингүй гэж үзэх үндэслэл болохгүй. Гэхдээ тэрээр үүрэг гүйцэтгэгчид үүссэн хохирлыг нөхөн төлнө.

Мөнгөн төлбөрт чиглэсэгүй шаардах эрхийг мөнгөнд шилжүүлж болох тохиолдолд барьцааг худалдаж болно. Хохирол нэхэмжлэхэд чиглэсэн шаардах байлаа гэхэд үүнийг мөнгөн төлбөрт шилжүүлэн бодох, батлан даагчийн эсрэг үүргээс чөлөөлүүлэхэд чиглэх шаардах эрх нь түүнд хандан шаардлага гаргаснаар мөнгөн төлбөрт шилжинэ.

ХБНГУ-ын Иргэний хуулийн 1229 дугаар зүйл. Өмч шилжүүлэх тохиролцоо хүчингүй байх тухай.

/1/ Барьцаалагчийн шаардлагыг хугацаанд нь биелүүлээгүй нөхцөлд барьцаа хөрөнгийн өмчлөх эрх барьцаалагчид шилжих тухай тохиролцоог барьцаа худалдан борлуулах эрх үүсэхээс өмнө хийсэн бол энэ нь хүчингүй.

Ийм зохицуулалт манай хуульд байхгүй. Энэ зүйлд барьцааны эрх үүсэх ба худалдан борлуулах эрх үүсэхээс өмнө хойшлуулах болзол тавьж барьцаалагч өмч шилжүүлж авах болон өмч шилжүүлэхэд чиглэсэн шаардах эрхтэй байх талаар тохирохыг хориглосон байна. Худалдан борлуулах эрх үүссэний дараа ийм тохиролцоо хийх нь ХБНГУ-ын Иргэний хуулийн 138 дугаар зүйлд /Монгол Улсын Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэг/ үл харшлах нөхцөлд хүчин төгөлдөр байна. Дээрх агуулга бүхий тохиролцоо байгаа нөхцөлд барьцааны гэрээ бүхэлдээ хүчингүй болох эсэхийг ХБНГУ-ын Иргэний хуулийн 139 дүгээр зүйлийн /Монгол Улсын Иргэний хуулийн 61 дүгээр зүйл/ дагуу шийднэ. Ердийн тохиолдолд гэрээ хүчингүй болох нь ховор.

Гол нь шаардлагыг хангахгүй байх нөхцөлд өмч шилжих гэсэн болзолт холбоос байх явдал энэ зүйлийг хэрэглэхэд хүргэнэ. Жишээлэхэд барьцааг биржийн болон зах зээлийн ханшаар худалдагдахгүй нөхцөлд барьцаалагчид өмч шилжих тухай тохиролцоо хүчингүй болно. Мөн гэрээний шийтгэл болгож барьцаа хөрөнгийн өмчлөлийг барьцаалагчид шилжүүлэх нөхцөл хүчингүй болно.

Эсрэгээрээ шаардлагыг хангасан эсэхээс үл хамааран барьцаалагч өмчлөх эрхийг шилжүүлэн авч болохоор заасан тохиролцоо хүчинтэй. Хэрэв мөнгө барьцаалсан бол өрийн хэмжээгээр уг мөнгийг барьцаалагчийн өмчлөлд шилжүүлэх асуудал байж болно.

ХБНГУ-ын Иргэний хуулийн 1230 дугаар зүйл. Хэд хэдэн барьцаа хөрөнгөөс сонгох нь.

/1/ Хэд хэдэн барьцаа хөрөнгө бий нөхцөлд барьцаалагч нь гэрээнд өөрөөр тохирсноос бусад тохиолдолд аль хөрөнгийг худалдан борлуулахаа сонгоно.

/2/ Тэрээр зөвхөн шаардлагыг хангахад зайлшгүй шаардагдах хэмжээний барьцааг худалдаалах эрхтэй.

Монгол Улсын Иргэний хуульд дор тусгасан хэд хэдэн этгээдэд барьцаалах тухай зохицуулалт байх бол ХБНГУ-ын Иргэний хуулинд барьцаа хөрөнгө хэд хэд байгаа тохиолдлыг илүү тусгасан. Харин хэд хэдэн барьцаалагч байхыг ердийн үзэгдэл гэж үзсэн байна.

Монгол Улсын Иргэний хуулийн 158 дугаар зүйлийн 158.5. Барьцааны зүйл нь хэд хэдэн этгээдэд барьцаалагдсан бол хамгийн түрүүнд түүнийг барьцаалсан этгээд уг зүйлийг борлуулахыг шаардах эрхтэй бөгөөд уг этгээд энэ эрхээ хэрэгжүүлэхээс татгалзсан бол дараагийн барьцаалагч шаардах эрхээ хэрэгжүүлнэ.

Тайлбар: ХБНГУ-ын Иргэний хуулийн 1230 дугаар зүйл. Барьцаалагч нь эрхээ буруугаар ашиглах тухай хоригийг зөрчсөнөөс бусад тохиолдолд хэд хэдэн барьцаа хөрөнгөөс сонгох эрх эдлэнэ. Энэ зохицуулалтаас хазайсан тохиролцоо нь зөвхөн үүргийн эрх зүйн үр дагаварт хүргэнэ. Өмчийн эрх зүйн нөлөөгүй. Тиймээс зөрчил нь гагцхүү хохирол нэхэмжлэх эрх үүсгэнэ. Үүнийг ижил төрлийн олон зүйлд мөн адил хэрэглэнэ.

Шаардлагын хэмжээнээс хэтэрсэн үнэ бүхий хөрөнгийг борлуулах нь 1243 дугаар зүйлийг зөрчдөг.

1231 дугаар зүйл. Барьцаа хөрөнгийг худалдан борлуулах зорилгоор гаргуулах.

/1/ Хэрэв барьцаалагч нь барьцааг дангаар эзэмшэгүй бол худалдан борлуулах эрх үүссэн мөчөөс эхлэн барьцааг гаргуулахаар шаардах эрхтэй.

/2/ Барьцаалагчийн шаардсаны дагуу хөрөнгийг гаргуулахын оронд дундын хадгалагчийг томилж барьцааг түүнд шилжүүлж болно; хадгалагч нь хөрөнгийг шилжүүлж авах үед худалдан борлуулах зорилгоор үүнийг гаргаж өгөх үүрэг хүлээнэ.

Энд хамтын эзэмшил үүссэн нөхцөлд барьцаалагч бусад эзэмшигчээс барьцааны эзэмшлийг гаргуулах шаардах эрхийг тусгасан. Бусад эзэмшигч гэдэгт өөр бусад барьцаалагчдыг оруулна. Эцсийн зорилго нь дангаар эзэмших эрх олж авах. Хэрэв маргаан гарах юм бол шүүхээс хадгалагчийг томилж, түүнд эзэмшлийг шилжүүлэхээр шаардах эрхтэй. Эхлэзд 1231 дүгээр зүйлийн 1231.1-д заасан шаардлагыг барьцаалагч гаргасан байсан бол 1231 дүгээр зүйлийн 1231.2-ыг хэрэгжүүлэхийн тулд нэхэмжлэлийн шаардлагаа өөрчлөх ёстой. Харин эхний эрхийг шийдвэр гүйцэтгэлийн түвшинд хэрэгжүүлэх явцад дараачийн эрхийг хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн хариу эсэргүүцэл гаргах боломжгүй байдаг.

1232 дугаар зүйл. Дараа дараачийн барьцаалагчид.

/1/Барьцаалагч нь түүний дараагийн шатны барьцаалагчид хөрөнгийг худалдан борлуулах зорилгоор гаргаж өгөх үүрэггүй.

/2/ Хэрэв анхны барьцаалагч хөрөнгийг эзэмшилдээ аваагүй бөгөөд өөрөө барьцааг худалдах ажиллагааг эхлүүлээгүй бол дараа дараачийн барьцаалагчийн худалдан борлуулах ажиллагааг хориглох ёсгүй.

Хэд хэдэн барьцаа хөрөнгийн шат дараалыг тогтоосон зохицуулалт: Хэрэв эхний барьцаалагч барьцааг эзэмшилдээ авсан бол дараачийн барьцаалагч нь түүний эсрэг эзэмшлийг шилжүүлэхэд чиглэсэн шаардах эрхгүй бөгөөд худалдан борлуулах ажиллагааг бие даан эхлүүлэх эрхгүй. Зөвхөн эхэлсэн ажиллагаанд нэгдэнэ. Эхний барьцаалагч худалдан борлуулах ажиллагааг явуулахыг хүсэхгүй эсхүл чадахгүй байвал дараачийнх нь 1249 дүгээр зүйлд заасан орлуулах эрхийг эдлэнэ.

Харин дараа дараачийн барьцаалагч барьцааг эзэмшилдээ авсан бол эхний барьцаалагч түүнээс худалдан борлуулах ажиллагааг эхлүүлэх

зорилгоор барьцааг гаргуулах эрхтэй. Эхний барьцаалагч худалдан борлуулах ажиллагааг явуулахыг хүсэхгүй эсхүл чадахгүй байгаа бол тэрээр дараачийн барьцаалагч худалдах эрхийг олгоно. Гэхдээ тэрээр 1249 дүгээр зүйлд заасан орлуулах эрхийг хэрэгжүүлж бас болно. Хуульд нийцсэн худалдан борлуулах ажиллагааны дүнд бусад барьцааны эрх дуусгавар болох ба оронд олж авсан үнэ барьцааг орлоно.

Хэрэв хэд хэдэн этгээдийн барьцааны эрх нэгэн зэрэг үүссэн бол хамтран барьцаалагчид нь дор бүрнээ худалдан борлуулах ажиллагаа явуулах зорилгоор барьцааг гаргуулахаар шаардах эрхтэй. Барьцаалагчдын хэн нэгэн нь барьцааг эзэмшилдээ авсан бол бусад нь худалдан борлуулах ажиллагааг хамтран зохион байгуулах саналын эрхтэй байхаас гадна дор хаяж дараачийн шатлалд хамаарах барьцаалагчийн эрхийг эдлэнэ. Барьцааг худалдаж олсон үнэ нь эдгээр барьцаалагчид үндсэн шаардлагын хэмжээгээр ноогдоно.

Монгол Улсын Иргэний хуулийн холбогдох заалт:

158.5.Барьцааны зүйл нь хэд хэдэн этгээдэд барьцаалагдсан бол хамгийн түрүүнд түүнийг барьцаалсан этгээд уг зүйлийг борлуулахыг шаардах эрхтэй бөгөөд уг этгээд энэ эрхээ хэрэгжүүлэхээс татгалзсан бол дараагийн барьцаалагч шаардах эрхээ хэрэгжүүлнэ.

§ 1233 Худалдан борлуулах ажиллагааг явуулах тухай.

/1/ Барьцааг худалдан борлуулах ажиллагаа нь тус хуулийн 1234 – 1240 дүгээр зүйлд заасны дагуу явагдана.

/2/ Хэрэв барьцаалагч нь худалдан борлуулах эрхийнхээ талаар шүүхийн шийдвэр гаргуулсан бол тэрээр худалдан борлуулах ажиллагааг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаан дахь битүүмжилсэн эд хөрөнгийг худалдах тухай зүйл заалтын дагуу явуулах эрхтэй.

Тайлбар:

I. Шүүхийн шийдвэргүйгээр худалдах: 1233 дугаар зүйлийн 1233.1 дэх хэсэгт ердийн худалдан борлуулах ажиллагааг зохицуулсан. Германы Иргэний хуулийн 1245 дугаар зүйл, 1259 дүгээр зүйлд зааснаар эдгээр зохицуулалтаас өөр аргаар барьцааг худалдах боломжтой. Худалдан борлуулах ажиллагаа нь барьцаалагчийн нэрийн өмнөөс худалдагчаар төлөөлөн явагддаг. Зардлыг барьцаалуулагч төлнө. Худалдан борлуулах зөвшөөрөл нь өмч шилжүүлэх эрхийг мөн олгодог. Барьцаа хөрөнгө биет байдлын доголдолтой нөхцөлд ХБНГУ-ын Иргэний хуулийн 461 дүгээр зүйлээр /Монгол Улсын Иргэний хуулийн 254 дүгээр зүйл/ үйлчлэх бол эрхийн доголдлын хувьд үүрэг гүйцэтгүүлэгчийг ХБНГУ-ын Иргэний хуулийн 1244 дүгээр зүйл хамгаалсан байдаг. Эрхийн доголдлын хувьд ХБНГУ-ын Иргэний хуулийн 1244 дүгээр зүйлийн 1244.2 дахь хэсэг худалдан авагч мэдэж байсан ч бусад этгээдийн эрх худалдан борлуулах ажиллагааны дүнд дуусгавар болохоор заасан тул энэ тухай худалдах худалдан авах гэрээний хариуцлагын зохицуулалтууд ач холбогдолгүй болдог.

II. Шүүхийн шийдвэрийг үндэслэн Худалдан борлуулах ажиллагааг явуулах нь: ХБНГУ-ын Иргэний хуулийн 1233 дугаар зүйлийн 1233.2-т өмчлөгчийн эсрэг шүүхийн шийдвэр гарсан нөхцөлд худалдан борлуулах ажиллагааг хэрхэн явуулах талаар зохицуулсан.

Үүрэг гүйцэтгэгч нь бусдын эд хөрөнгийг барьцаалуулсан бол түүний эсрэг гарсан шүүхийн шийдвэр өмчлөгчийн эсрэг шүүхийн шийдвэр гаргах үндэс болохгүй. Шийдвэрт гүйцэтгэлийг хангахад чиглэсэн шаардлагыг дурьдсан байх ёстой бөгөөд нэхэмжлэл нь барьцааны эрхэд тулгуурлаж, шийдвэр барьцааг борлуулахыг хүлцэх үүргийг өмчлөгчид ноогдуулсан байна.

Барьцаалагч нь энд §1234-1240 дугаар зүйлийн дагуу эсхүл Германы Иргэний процессын хуулийн дагуу худалдан борлуулах ажиллагааг явуулах эсэхээ өөрөө шийднэ.

Монгол Улсын Иргэний хуулийн холбогдох заалт:

159. Барьцааны зүйлийг худалдах

159.1.Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол барьцааны зүйлийг энэ хуульд заасан журмын дагуу дуудлага худалдаагаар худалдана.

159.2.Барьцаалуулагч шаардсан бол барьцааны зүйлийг худалдахын өмнө түүний үнэлгээг шинжээчээр тогтоолгож болох бөгөөд холбогдох зардлыг барьцаалуулагч хариуцна.

ХБНГУ-ийн Иргэний хуулийн 1234 дүгээр зүйл.Худалдан борлуулах тухай сануулах; хүлээх хугацаа.

/1/ Барьцаалагч нь өмчлөгчид хандан эд хөрөнгийг худалдан борлуулах тухай урьдчилан сануулж, гаргуулах мөнгөн төлбөрийн үнийн дүнг нэрлэнэ. Сануулгыг худалдан борлуулах эрх үүссэний дараа өгөх бөгөөд энэ нь ямар ч үр дүнд хүрэхгүй нь илт бол мэдэгдэх шаардлагагүй.

/2/ Сануулснаас хойш 1 сарын дотор хөрөнгийг худалдан борлуулж болохгүй. Сануулах шаардлагагүй нөхцөл бүрдсэн бол худалдан борлуулах эрх үүссэн цагаас эхлэн 1 сар тоолно.

I. Сануулах үүрэг. ХБНГУ-ын Иргэний хуулийн 1228 дугаар зүйлийн 1228.2-т заасны дагуу худалдан борлуулах эрх үүссэн мөчөөс эхлэн өмчлөгчид шаардлагыг өөр аргаар хангах эрх олгох зорилгоор 1234 дүгээр зүйлийн 1234.1 дэх хэсэгт сануулах үүргийг тусгасан байна. Энэ зохицуулалт нь барьцааг 1235 дугаар зүйлд тусгасан дуудлага худалдаагаар худалдан борлуулах нөхцөлд үйлчлэх бөгөөд үүнийг талууд харилцан тохиролцоогоор өөрчилж болдог диспозитив заалт. Сануулах үйлдэл нь өмчлөгчид хандсан байх ба §1248 дугаар зүйлийн дагуу барьцаалуулагчийг өмчлөгч хэмээн тооцоход энэ цаг мөч гол ач ач холбогдолтой. Ийнхүү сануулахад огноо, сануулгыг үйлдсэн газрыг тусгах шаардлагагүй.

Сануулга илт үр дүнд хүрэхгүй гэдгийг тохиолдол бүрт тусгайлан авч үзнэ. Жишээ нь өмчлөгч олдохоргүй болсон зэрэг үүнд хамаарна. Энэ тухай хожим барьцаалагч нотлох баримт гаргах үүрэгтэй. Энэ зүйлийг зөрчсөн худалдан борлуулах ажиллагаа хуулийн хүчин төгөлдөр үлдэх

хэдий ч үүрэг гүйцэтгүүлэгчийн эсрэг 1243 дугаар зүйлийн 1243.2 дахь хэсэгт заасан хохирол шаардах эрх үүсэх магадлалтай. Тэрээр мэдэгдсэн ч илүү тохиромжтой үр дүн гарахгүй байсан гэдгийг нотолсноор хохирол төлөх үүргээс чөлөөлөгдөнө.

II. Хүлээх хугацаа. Германы хуульд 1 сар, Монгол Улсын Иргэний хуульд 14 хоног хүлээсний эцэст барьцаалагч худалдан борлуулах ажиллагааг эхлүүлнэ. Энэ хугацааг гэрээний тохиролцоогоор өөрчлөх боломжтой. Үүнийг зөрчсөн нөхцөлд дээрхийн ижил худалдан борлуулах ажиллагаа нь хүчинтэй. Гэхдээ барьцаалагч хохирол нөхөн төлөх үүрэгтэй.

Монгол Улсын Иргэний хуулийн дүйцэх заалт:

Монгол Улсын Иргэний хуулийн 163 дугаар зүйлийн 163.2. *Барьцаалагч нь барьцааны зүйлийг худалдах болсон тухай болон худалдах үнийн тухай өмчлөгчид урьдчилан мэдэгдэх үүрэгтэй. Ийнхүү мэдэгдсэнээс хойш арван дөрөв хоногийн дотор барьцааны зүйлийг худалдаж болохгүй.*

1235 дугаар зүйл. Дуудлага худалдаа

/1/ Барьцаа хөрөнгийг олон нийтийн дуудлага худалдаагаар худалдана.

/2/ Хэрэв барьцаа нь тодорхой бирж эсхүл зах зээлийн үнэлгээ бүхий зүйл бол энд тус хуулийн § 1221-ийг хэрэглэнэ.

I. Худалдан борлуулах ажиллагааг явуулах хэлбэр: 1235 дугаар зүйлийн 1235.1 дэх хэсэгт олон нийтийн дуудлага худалдаа явуулах замаар барьцааг худалдах тухай заасан. Энэ хэлбэрийг баримтлахаас татгалзсан гэрээний тохиролцоог зөвхөн худалдан борлуулах эрх үүссэний дараа л талууд гэрээнд оруулж болохоор 1245 дугаар зүйлийн 1245.2 дахь хэсэгт тусгасан. Өмнө нь дуудлага худалдаа хийхгүй байхаар тохирсон бол 1245 дугаар зүйлийн 1245.1 дэх хэсгийн дагуу хүчингүй.

Олон нийтийн дуудлага худалдаа гэдэгт юуг ойлгох тухай Германы Иргэний хуулийн 383 дугаар зүйлийн 383.3 дахь хэсэгт хадгалалтанд шилжсэн эд зүйлийг дуудлага худалдаагаар худалдах тухай тусгасан. Монгол Улсын Иргэний хуулийн 197 дугаар зүйлд дуудлага худалдаа үнэ хаялцуулах замаар гэрээ байгуулах хэлбэр хэмээн тусгагдсан. Дуудлага худалдаанд ялсан этгээдтэй автоматаар худалдах худалдан авах гэрээ байгуулагддаг. Үр дүнд нь барьцааны өмчлөх эрхийг шилжүүлэх үүрэг үүснэ.

Монгол Улсын Иргэний хуулийн 197 дугаар зүйл. Үнэ хаялцуулах ажиллагаа

197.6.Үнэ хаялцуулах ажиллагааг ***дуудлага худалдаа*** *буюу уралдааны хэлбэрээр явуулна.*

197.7.Дуудлага худалдаагаар үнэ хаялцан ялагч нь хамгийн өндөр үнэ санал болгосон этгээд байна.

197.9.Нэг этгээд оролцсон бол дуудлага худалдаа, уралдаан явагдаагүй гэж үзнэ.

197.10.Дуудлага худалдаа буюу уралдааныг нээлттэй буюу хаалттай явуулж болно.

197.11.Нээлттэй дуудлага худалдаа, уралдаанд ямар ч этгээд оролцож болно.

197.12.Хаалттай дуудлага худалдаа, уралдаанд энэ зорилгоор тусгайлан уригдсан этгээд оролцоно.

197.14.Хууль буюу зард өөрөөр заагаагүй бол нээлттэй дуудлага худалдаа, уралдаан зохион байгуулагч тэдгээрийг явуулахаас татгалзах эрхтэй. Гэхдээ дуудлага худалдаа явуулахаар товлон зарласан өдрөөс гурваас доошгүй хоногийн, уралдаан явуулахаар зарласан өдрөөс гучаас доошгүй хоногийн өмнө ийнхүү татгалзаж болно.

197.15.Энэ хуулийн 197.14-т заасан хугацааг зөрчиж дуудлага худалдаа хийх буюу уралдаан явуулахаас татгалзсан зохион байгуулагч оролцогчдод учирсан шууд хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

197.16.Хаалттай дуудлага худалдаа, уралдаан зохион байгуулагч нь түүнд уригдсан оролцогчдод учирсан хохирлыг ямар хугацаанд дуудлага худалдаа, уралдаан явуулахаас татгалзсанаас үл хамааран нөхөн төлөх үүрэгтэй.

197.17.Үнэ хаялцуулах ажиллагаанд оролцогч зард заасан хэмжээ, журмаар, заасан хугацаанд дэнчин тавина.

197.18.Үнэ хаялцуулах ажиллагааг явуулаагүй, түүнд оролцоогүй, эсхүл оролцсон боловч ялаагүй этгээдэд дэнчинг буцаан олгоно.

197.19.Ялсан этгээдтэй гэрээ байгуулахдаа дэнчинг гэрээний үүргийн гүйцэтгэлд оруулан тооцно.

197.20.Үнэ хаялцуулах ажиллагаанд ялсан этгээд болон ажиллагаа зохион байгуулагч дуудлага худалдаа, уралдааны үр дүнгийн тухай тэмдэглэлд явуулсан өдөрт нь гарын үсэг зурах бөгөөд энэ тэмдэглэл гэрээний адил хүчинтэй байна.

197.21.Ялсан этгээд тэмдэглэлд гарын үсэг зурахаас зайлсхийвэл тавьсан дэнчингээ алдана.

197.22.Зохион байгуулагч тэмдэглэлд гарын үсэг зурахаас зайлсхийвэл нөгөө талын тавьсан дэнчинг буцааж өгөхийн зэрэгцээ ажиллагаанд оролцсоноос учирсан хохирлыг дэнчингээс давсан хэмжээгээр нөхөн төлөх үүрэгтэй.

197.23.Үнэ хаялцуулах ажиллагааг гэрээ байгуулах эрх олж авах нөхцөлтэйгөөр явуулсан бол уг ажиллагааг явуулж дуусаад тэмдэглэл үйлдсэнээс хойш хорь хоногийн дотор, эсхүл зард дурдсан хугацаанд талууд гэрээнд гарын үсэг зурна. Талуудын нэг нь гэрээ байгуулахаас зайлсхийвэл нөгөө тал нь гэрээг байгуулсанд тооцож, үүргийн гүйцэтгэлийг хангуулах, учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй.

197.24.Хуулиар тогтоосон журам зөрчиж явуулсан үнэ хаялцуулах ажиллагаа хүчин төгөлдөр бус байна.

197.25.Хүчин төгөлдөр бус үнэ хаялцуулах ажиллагаанд ялсан этгээдтэй байгуулсан гэрээ хүчин төгөлдөр бус байна.

197.26.Энэ зүйлд заасан журам шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмаар явуулах дуудлага худалдаанд нэгэн адил хамаарна.

II. Чөлөөтэй худалдах хэлбэр. Олон нийтийн дуудлага худалдааны ороңд барьцааг чөлөөтэй худалдах тухай 1235 дугаар зүйлийн 1235.2 дахь хэсэгт тусгасан. 1221 дүгээр зүйл нь хөдлөх хөрөнгийн барьцаатай холбоотой зохицуулалт бөгөөд энд: "барьцааны зүйл нь биржийн болон зах зээлийн үнэлгээ бүхий хөрөнгө бол барьцаалагч нь борлуулалт эрхлэх зөвшөөрөл бүхий худалдааны зуучлагч эсхүл олон нийтийн дуудлага худалдаа эрхлэгчид тухайн үеийн ханшаар худалдах эрхийг олгож шилжүүлж болно" гэсэн байна.

Адилтгах зохицуулалт:

Монгол Улсын Иргэний хуулийн 163 дугаар зүйл. Хөдлөх эд хөрөнгө болон эрхийг худалдах

163.1.Хэрэв барьцааны зүйлийн биржийн буюу зах зээлийн үнэ тодорхой байвал барьцаалагч нь уг зүйлийг худалдааны тусгай байгууллагаар дамжуулан худалдахаар итгэмжилж болно.

III. 1235 дугаар зүйлийг зөрчиж худалдан борлуулах ажиллагааг явуулсан бол энэ нь 1243 дугаар зүйлийн дагуу хүчингүй болно. Барьцааны өмчлөх эрхийг ийм нөхцөлд шударгаар олж авах боломжгүй. Үүний зэрэгцээ барьцаалагч нь хохирол нөхөн төлөх үүрэгтэй.

1236 дугаар зүйл. Дуудлага худалдаа явуулах газар

Дуудлага худалдааг барьцаа хөрөнгө хадгалагдаж буй газар явуулна. Хэрэв энэ газар дуудлага худалдаа явуулах нь тохирох үр дүнд хүрэхгүй нь илт бол барьцааг өөр тохиромжтой газар дуудлага худалдаанд хамруулна.

Энэ зохицуулалтыг өөрчилсөн тохиролцоог гэрээнд тусгаж болно. 1245 дугаар зүйлийг анхаарах. Хадгалах газрын тухай тусгайлан тохиролцсоныг дуудлага худалдаа явуулах газрын талаарх тусгайлсан тохироо гэж үзэж болно. Хангалттай үр дүн гарах эсэх, тухайн газар нь дуудлага худалдаа явуулахад зохимжтой эсэхийг барьцаалагч шударга ёсны зарчмыг баримтлан шийднэ. Маргаан гарвал шүүх үүнийг шийдвэрлэнэ. Үүнийг зөрчсөн нөхцөлд худалдан борлуулах ажиллагаа хүчинтэй ч хохирол шаардах эрх үүснэ.

1237 дугаар зүйл.Олон нийтэд мэдээлэх тухай.

Дуудлага худалдаа явуулах он, сар, өдөр, цаг болон газрыг барьцаа хөрөнгийн нийтлэг нэрийг дурьдсаны хамтаар олон нийтэд мэдээлнэ. Ийнхүү мэдээлэх нь илт үр дүнд хүрэхгүй бол зарлал гаргахгүй байж болно. Өмчлөгч болон барьцаа хөрөнгөтэй холбоотой эрх эдэлж гуравдагч этгээдэд тусгайлан мэдэгдэх ба энэ нь ямар ч үр дүнд хүрэхгүй нь илт бол шаардлагагүй.

Олон нийтэд мэдээлэх ажлыг тухайн орон нутаг дахь хамгийн тохиромжтой, заншил болсон аргаар явуулна. Энд барьцаа хөрөнгийг онцлог шинж болон оролцогсдыг нэг бүрчлэн нэрлэх хэрэггүй; Ерөнхий зах зээлийн нэршил хангалттай. Энэ зүйл заалтаас худалдан борлуулах эрх үүссэний дараа татгалзах боломжтой. Үүнийг зөрчиж худалдан борлуулах ажиллагааг явуулсан бол энэ нь 1243 дугаар зүйлийн 1243.1 дэх хэсгийн дагуу хүчингүй болох хэдий ч барьцааг шударгаар өмчлөх боломж нээлттэй.

Өмчлөгч болон гуравдагч этгээдэд тусгайлан мэдэгдэх үүргээс татгалзах тухай урьдчилан тохирч болно. Мэдэгдлээ буцааж авах нь эс үйлдэхүй болно. Үүнийг зөрчсөн худалдан борлуулах ажиллагаа хүчинтэй ч хохирол нэхэмжлэх эрх үүснэ.

***Монгол Улсын Иргэний хуулийн 197.13**.Хуульд өөрөөр заагаагүй бол зохион байгуулагч нь зарыг үнэ хаялцуулах ажиллагаа явуулахаас гучаас доошгүй хоногийн өмнө гаргах бөгөөд түүнд ажиллагаа явуулах хэлбэр, газар, хугацаа, гэрээний зүйл, анхны үнэ, оролцогчдыг бүртгэх, ялсан этгээдийг тогтоох журам болон бусад мэдээллийг тусгана. Гэрээний зүйл нь гэрээ байгуулах эрх бол гэрээ байгуулах хугацааг заана.*

1238 дугаар зүйл.Худалдан борлуулах нөхцөл.

/1/ Барьцааг зөвхөн худалдан авагч нь үнийг шууд бэлнээр төлөх, мөн ингээгүй нөхцөлд бүх эрхээ алдах нөхцөлөөр худалдаж болно.

/2/ Дуудлага худалдааны дээрх журмыг баримтлаагүй бол барьцаалагч мөнгийг хүлээн авсанд тооцогдох бөгөөд тэрээр санал гаргасан этгээдийн эсрэг холбогдох эрхээ хэрэгжүүлэх боломжтой. Эд хөрөнгийн үнийг нэн даруй төлөөгүй бол дуудлага худалдааг хаахаас өмнө эрхээ алдах тухай хариу эсэргүүцлийг хэрэгжүүлсэн мэт тооцно.

I. Хуульд заасан худалдан борлуулах журам. Үүнийг гэрээний тохиролцоогоор өөрчилж болохоор 1245 дугаар зүйлд тусгасан. Чөлөөтэй худалдахад мөн үйлчилнэ. Худалдах худалдан авах гэрээнд тусгана. Бэлнээр худалдах нөхцөлд мөнгө төлөх ба барьцааг шилжүүлэх үйлдлийг харилцан үүргийн түвшинд холбож болно. Бэлэн мөнгө төлөгдөөгүй бол үүрэг гүйцэтгүүлэгч гэрээнээс татгалзах эрхтэй.

II. Зөрчлийн үр дагаврыг 1238 дугаар зүйлийн 1238.2 дахь хэсэгт тусгасан. Худалдан борлуулах ажиллагаа хүчингүй болохгүй, хохирол нэхэмжлэх эрх үүсэхгүй. Харин мөнгийг төлөгдсөнд тооцно. Хэрэв шаардагдах зохицуулалтыг худалдах худалдан авах гэрээнд тусгаагүй бөгөөд үүрэг гүйцэтгүүлэгч гэрээнээс татгалзах эрхээ хугацаанд нь зохих ёсоор хэрэгжүүлээгүй бол барьцаа хөрөнгийг ялагчид шилжүүлсэн мөчөөс эхлэн барьцаалагчийг шаардлагаа хангуулсанд тооцно. Ийнхүү тооцох заалт нь нэг талаас барьцаалагч ба өмчлөгч хоёрын хооронд үүссэн иргэний эрх зүйн харилцааны, нөгөө талаас үүрэг гүйцэтгэгч ба өмчлөгч нарын хоорондын харилцааны нэгэн адил үйлчилнэ. Барьцаалагч нь мэдээж худалдан авагчийн эсрэг үнээ шаардах эрхтэй хэвээр байна. Хэрэв тэрээр худалдан авагчийн эсрэг худалдах худалдан авах гэрээг цуцалж, барьцааг эргүүлэн авсан ч дээрх тооцох заалтын дүнд худалдан борлуулах ажиллагааны үр дүн өөрчлөгдөхгүй тул барьцаалагчид эд зүйлийн өмч шилжинэ.

1239 дүгээр зүйл. Үүрэг гүйцэтгүүлэгч болон өмчлөгч дуудлага худалдааны оролцох тухай.

/1/ Барьцаалагч болон хөрөнгийг өмчлөгч нь дуудлага худалдааны оролцож, үнийн санал гаргаж болно. Хэрэв барьцаалагч дуудлага

худалдаанд ялсан бол түүнээс зарсан үнийг хүлээн авсанд тооцно.

/2/ Өмчлөгч үнийг бэлнээр төлөөгүй бол түүний саналыг хүлээн авахаас татгалзаж болно. Энэ заалт нь барьцаа хөрөнгө өөр этгээдийн үүргийн гүйцэтгэлийг хангаж буй нөхцөлд үүрэг гүйцэтгэгчийн гаргаж буй саналд мөн адил үйлчилнэ.

I. Дуудлага худалдаанд үүрэг гүйцэтгүүлэгч, өмчлөгч, барьцаалуулагч, үүрэг гүйцэтгэгч болон бусад гуравдагч этгээд оролцож үнийн санал гаргаж болно. Харин дуудлага худалдаа эрхлэгч болон түүний туслан гүйцэтгэгч оролцож үл болно. Эдгээр нь гуравдагч этгээдийн төлөөлөгчөөр ажиллаж үл болно. Энэ заалт дуудлага худалдаанаас бусад борлуулах хэлбэрт мөн адил үйлчилнэ. Үүрэг гүйцэтгүүлэгч дуудлага худалдаанд ялвал үнэ хаялцуулсны дүнд нэг талын үүргийн болон өмчийн хэлцэл хийгдэх ба 1244 дүгээр зүйл үйлчилнэ. Тэрээр худалдан авагчийн эрхийг эдлэх боловч үнийг бэлнээр төлөх үүрэг хүлээхгүй. Шаардлага ба илүү гарсан үнийн тухайд 1247 дугаар зүйл үйлчилнэ. Хэрэв өмчлөгч дуудлага худалдаанд ялбал тэрээр барьцаагүйгээр эд зүйлийг олж авна.

I. Үнийн саналаас татгалзах тухай. Өмчлөгч болон үүрэг гүйцэтгэгч нь санал болгосон үнийн дүнг бэлнээр гаргаж өгөхгүй бол худалдагч болон барьцаалагч нь тэдний үнийн саналыг хүлээн авахаас татгалзана. Барьцаалуулагч нь өмчлөгч тохиолдолд түүний үнийн саналыг хүлээн авахаас татгалзаж болно. Ялагчийг тодруулахаас өмнө татгалзах үйлдэл боломжтой.

Монгол Улсын Иргэний хуулийн холбогдох заалт:

159.3.Барьцааны зүйлийг худалдах ажиллагаанд барьцааны зүйлийн өмчлөгч оролцож, уг зүйлээ худалдан авах санал гаргаж болно.

159.4.Барьцааны зүйлийн үнийг төлөөгүй тохиолдолд худалдан авах эрхээ алдахыг дуудлага худалдаанд оролцогчдод тайлбарласан байвал зохино.

1240 дүгээр зүйл. Алт ба мөнгөн эдлэл.

/1/ Алт ба мөнгөн эдлэлийг худалдахдаа тухайн үеийн алт, мөнгөний ханшнаас доогуур үнээр үнэ хаялцуулахгүй.

/2/ Хэрэв хангалттай санал ирэхгүй бол дуудлага худалдаа явуулах эрх бүхий этгээд нь худалдан борлуулах ажиллагааг алт, мөнгөний ханшаар гүйцэтгэх эрхтэй.

Үүнийг зөрчсөн худалдан борлуулах ажиллагаа хүчингүй. Гэхдээ 1240 дүгээр зүйлийн 1240.2 дахь хэсэг зөрчигдөөгүй нөхцөлд шударгаар өмчлөх эрхийг олж авах боломж бий. Худалдан борлуулах эрх үүсэхээс өмнө энэ зохицуулалтаас татгалзаж, өөрчилсөн байх боломжгүй.

1241 дүгээр зүйл. Өмчлөгчид мэдэгдэх тухай.

Барьцаалагч нь илт шаардлагагүй гэж үзэхээс бусад тохиолдолд барьцаа хөрөнгийг худалдсан тухай, мөн дуудлага худалдааны үр дүнгийн талаар өмчлөгчид нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

Ямар ч хэлбэрээр худалдан борлуулах ажиллагааг явуулсан бай энэ тухай өмчлөгчид заавал мэдэгдэнэ. Өмчлөгч өөрөө үнийн санал гаргагсад дотор багтсан эсхүл худалдаа амжилтгүй болсон нөхцөлд мэдэгдэх шаардлагагүй. Худалдан борлуулах эрх үүсэхээс өмнө өөрөөр тохирох боломжтой, зөрчсөн нөхцөлд худалдан борлуулах ажиллагаа хүчинтэй хэвээр байх ч хохирол нөхөн төлөх үүрэг үүснэ.

1242 дугаар зүйл.Хуульд нийцсэн дуудлага худалдааны эрх зүйн үр дагавар.

/1/ Хууль ёсны худалдан борлуулах ажиллагааны дүнд худалдан авагч нь өмчлөгчөөс хөрөнгийг шилжүүлэн авсантай адил эрхтэй болно. Дуудлага худалдаанд барьцаалагч ялсан бол энэ заалт нэгэн адил үйлчилнэ.

/2/ Худалдан авагч эд хөрөнгөтэй холбоотой барьцааны эрхийн тухай мэдэж байсан ч эдгээр нь дуусгавар болно. Эрх үүсэх дараалын хувьд бүх барьцааны эрхээс дээгүүрт тооцогдох узуфруктын эрх үүссэнээс бусад тохиолдолд дээрх заалт үйлчилнэ.

I.Худалдан борлуулах ажиллагаа хуульд нийцсэн байхын тулд:

1/ Үүрэг гүйцэтгүүлэгчид барьцааны эрх үүссэн байх /өмчийн харилцааг нарийн мэдсэн эсэх нь хамаагүй/;

2/ Худалдах худалдан авах гэрээ байгуулагдсан байх ба өмчийн шилжүүлэг хийгдсэн байх;

3/1243 дугаар зүйлийн 1243.1 дэх хэсэгт заасан зүйл заалтыг зөрчөөгүй байх ёстой.

II.Дээрх нөхцөлүүд биелсэн бол:

1/ Худалдан авагчид барьцаа хөрөнгийг өмчлөх эрх шилжиж, өмнөх өмчлөгчийн эрх дуусгавар болно; мөн гуравдагч этгээдийн бусад эрх дуусгавар болно; барьцааны эрхээс илүү давуу эрх болох узуфруктын эрх ч дуусгавар болно; ХБНГУ-ын Иргэний хуулийн 935 буюу /МУ-ын ИХ-ийн 91.2 дахь хэсэг/ үйлчлэхгүй.

2/ Чөлөөтэй худалдах нөхцөлд худалдан авагч солигдсон бол шаардлага сэргэх бөгөөд барьцаалагч эргээд барьцааны эрхтэй болно.

1243 дугаар зүйл. Хуульд үл нийцэх худалдан борлуулах ажиллагаа.

/1/ Энэ хуулийн § 1228.2, § 1230-ийн 2 дахь өгүүлбэр,§ 1235, § 1237-ийн эхний өгүүлбэр болон § 1240-ийг зөрчсөн нөхцөлд барьцааг худалдан борлуулах ажиллагааг хууль бус хэмээн үзнэ.

/2/ Барьцаалагч нь эд хөрөнгийг худалдан борлуулахтай холбоотой бусад зүйл заалтыг зөрчсөн гэм буруутай нөхцөлд учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

I. 1242 дугаар зүйлийн 1242.1 дэх хэсгийн хүрээнд дурьдагдсан худалдан борлуулах ажиллагааны ерөнхий нөхцөлүүд хангагдаагүй эсхүл 1243 дугаар зүйлийн 1243.1 дэх хэсэгт заасан зөрчил илэрсэн бол худалдан борлуулах ажиллагааг хуульд үл нийцсэн гэж үзнэ. Энэ тохиолдолд 1242 дугаар зүйлд заасан эрх зүйн үр дагавар үүсэхгүй. Барьцааны зүйлтэй холбоотой өмчлөх

эрхийн харилцаа 1244 дүгээр хэрэглэгдэхээс бусад тохиолдолд хэвээр хадгалагдана. Барьцаагаар хангагдсан шаардлага дуусгавар болохгүй. Үүрэг гүйцэтгүүлэгч дээрх зөрчилд гэм буруутай бол гэм хорын эрх зүйн хариуцлага хүлээнэ.

II.Худалдан борлуулах ажиллагаа 1242 дугаар зүйлийн 1242.1 дэх хэсгийг зөрчсөн үндэслэлээр хүчингүй болоогүй боловч өөр бусад хууль тогтоомжийг зөрчсөн бол хохирол нөхөн төлөх үүрэг үүсэх ба худалдан борлуулах ажиллагаа хүчинтэй үлдэнэ.

§ 1244 Шударгаар эрх олж авах.

Худалдагч барьцааны эрхгүйгээр тодорхой эд хөрөнгийг барьцааны журмаар худалдах эсхүл худалдан борлуулах ажиллагаа хуульд нийцээгүй тохиолдолд худалдан борлуулах ажиллагаа энэ хуулийн §1233. 2-ын дагуу явагдсан эсхүл § 1240.2-ыг зөрчөөгүй нь тогтоогдвол тус хуулийн §§932 - 934, 936 гэсэн зүйл заалтыг төсөөтэй хэрэглэнэ /МУ-ын ИХ-ийн §§91, 114/.

Барьцаалагчид хүчин төгөлдөр барьцааны эрх үүсэхгүй ба худалдан борлуулах ажиллагаа нь 1243 дугаар зүйлийн 1243.1 дэх хэсэгт нийцээгүй тохиолдолд энэ зохицуулалт худалдан авагчийг хамгаална. §§932 - 934, 936 нь өмчлөгч хэмээн итгэсэн нөхцөлд шууд үйлчлэх бол энэ зохицуулалтын хүрээнд барьцааг худалдах тохиолдолд худалдан авагчид төрүүлсэн итгэл үнэмшлийг хамгаалсан байна. Энэ зохицуулалт нь шийдвэр гүйцэтгэлийн хүрээнд барьцааг худалдан борлуулах, ердийн худалдан борлуулах ажиллагаа болон чөлөөтэй худалдан борлуулах аль ч тохиолдолд үйлчилнэ. Эдгээрээс өөр аргаар худалдах нөхцөлд үйлчлэхгүй. Шударгаар олж авсан буюу худалдан борлуулах эрх үүссэн хэмээн итгэж үнэмшсэн тухайгаа худалдан авагч өөрөө нотлох үүрэгтэй.

Шударгаар олж авсан гэдэгт барьцааны эрх үүссэн хэмээн итгэж үнэмшиж байсныг ойлгоно. Ийм итгэл үнэмшил байгаагүй бол худалдан борлуулах ажиллагаа нь 1243 дугаар зүйлийн 1243.1 дэх хэсгийн дагуу хүчингүй болно. Энд өмчлөгчийн тухай итгэл үнэмшил нь нөлөөлөхгүй.

Эрх зүйн үр дагавар: Худалдан авагч 1242 дугаар зүйлийн 1242.2 дахь хэсгийн дагуу бусдын эрхээс ангид байх дангаар өмчлөх эрхийг олж авна. Эд зүйлийн үнийн өмчлөх эрх 1247 дугаар зүйлийн дагуу барьцаалагчид шилжинэ. Барьцаалагч үнийг шилжүүлж авах эрхээ цааш худалдах эрхтэй. Гэхдээ барьцаалагч нь хөрөнгө худалдах бүрэн эрхгүй байсан гэдгээрээ 1243 дугаар зүйлийн дагуу хохирол арилгах үүрэг хүлээнэ. Холбогдох этгээд хожим худалдан борлуулах ажиллагааг дэмжин зөвшөөрөл олгосон бол үүнийг одоогийн үүсэхэд байгаа эрх зүйн харилцааг өөрчлөхөд чиглэсэн тохиролцоо хэмээн тайлбарлана.

Монгол Улсын Иргэний хуулийн холбогдох зүйл заалт:

154.4.Тухайн хөрөнгийг эзэмшиж байсан боловч барьцаалах эрхгүй этгээд нь эзэмших эрхийг гэрчилсэн баримт бичгийг шилжүүлэх замаар тухайн хөрөнгийг барьцаалуулсан тохиолдолд барьцаалагч нь

барьцаалуулагчийн барьцаалах эрхгүй болохыг мэдээгүй, мэдэх боломжгүй байсан бол барьцаалагчийг шударга эзэмшигч гэж үзнэ.

154.5.Энэ хуулийн 154.4-т заасан барьцаалагчнь шударга эзэмшигчийн хувьд бусад гуравдагч этгээдээс давуу эрхтэй байна.

159.5.Барьцааны зүйлийг хууль ёсоор, шударгаар олж авсан этгээдэд барьцааны зүйл эрхийн хязгаарлалтгүйгээр шилжинэ.

§ 1245 Гэрээний тохиролцоо.

/1/ Өмчлөгч болон барьцаалагч нар харилцан тохирч энэ хуулийн §§ 1234–1240-д тусгасан зохицуулалтаас өөр хэлбэрээр барьцааг худалдан борлуулах тухай гэрээнд тусгаж болно. Гуравдагч этгээд нь барьцааг худалдсанаар дуусгавар болох ямар нэг эрх эдлэх бол түүний зөвшөөрлийг авна. Худалдан борлуулах замаар эрх ашгаа хамгаалуулж буй этгээдэд хандан зөвшөөрөл олгож буйгаа илэрхийлэх бөгөөд энэхүү хүсэл зоригийн илэрхийллээс татгалзах боломжгүй.

/2/ Энэ хуулийн § 1235, § 1237-ын эхний өгүүлбэр болон § 1240-д заасан зохицуулалтыг худалдан борлуулах эрх үүсэхээс өмнө өөрчлөн гэрээнд тусгахыг хориглоно.

I. 1245 дугаар зүйлийн 1245.1 дэх хэсэгт хамаарах тохиролцоо нь өмчийн эрх зүйн шинжтэй тул өмчлөгч дампуурсан ч түүний эрх залгамжлагчийн эсрэг үйлчилнэ. Эдгээр тохиролцоог барьцаалагч, өмчлөгч нар хийх боломжтой ба хэлбэрийн шаардлага тавигдахгүй. Агуулгын хувьд §1234-1240-с хазайсан өөр зохицуулалтыг гэрээнд тусгасан бол зөвхөн үүргийн эрх зүйн нөлөөтэй; эдгээрийг зөрчсөн тохиролцоо нь хохирол нөхөн төлөх үүргийн харилцаа үүсгэнэ. **Харин өмчийн эрх зүйн үйлдэл болох худалдан борлуулах ажиллагааны эрх зүйн үр дагаварт нөлөөлөхгүй.** Дээрх тохиролцоо нь талуудын үүргийг хөнгөвчлөх эсхүл чангатгах чиглэлтэй байж болно.

Барьцаалагч, өмчлөгч нар хуулийн зохицуулалтаас өөрөөр тохирох нөхцөлд гуравдагч этгээдийн эрхийг хөндөхгүйн тулд түүнээс зөвшөөрөл авах үүрэгтэй. Монгол Улсын Иргэний хуульд ийм зөвшөөрлийг тусгаагүй бөгөөд зөвшөөрлийн тухай дор дурьдсан зохицуулалт нь өөр чиг үүрэгтэй байна:

162 дугаар зүйл. Зөвшөөрөл авах

162.1.Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол дараах тохиолдолд барьцаалагч, барьцаалуулагч нь харилцан зөвшөөрөл авах үүрэгтэй:

162.1.1.барьцаалагч нь барьцааны зүйлийг барьцаалах бол барьцаалуулагчаас;

162.1.2.барьцаалуулагч нь барьцааны зүйлийн хувьд гуравдагч этгээдтэй хэлцэл хийх бол барьцаалагчаас.

II. §1234-1240-д тусгасан зарим эрхээсээ татгалзах асуудал худалдан борлуулах эрх үүсэхээс өмнө хүчингүй.

§ 1246 Шударга ёсны үүднээс гэрээнд өөрөөр тохиролцох.

/1/ Энэ хуулийн §§ 1235 – 1240-д заасан зохицуулалтаас хазайсан гэрээний тохиролцоо нөхцөл байдлыг сайтар шалгасны эцэст талуудын ашиг сонирхолд илүү нийцэхээр байвал оролцогчдын аль ч нөгөөгөөсөө дээрх хэлбэрээр худалдан борлуулах ажиллагааг явуулахаар шаардах эрхтэй.

/2/ Талууд тохиролцоонд хүрч чадахгүй бол үүнийг шүүх шийднэ.

Тодорхой нөхцөл бүрдсэн үед аль нэг тал 1235-1240 дүгээр зүйлд заасан агуулгаас өөрөөр худалдан борлуулах ажиллагааг явуулах шаардах эрх олгосон зохицуулалт.

Гэхдээ 1234 дүгээр зүйлийг өөрчлөх эрх олгоогүй. Дампуурлын хэрэг үүссэн нөхцөлд барьцаалагч нь хөрөнгийг ердийн худалдан борлуулах ажиллагаанаас илүү үр ашигтай борлуулах арга замыг хайх ёстой байдаг. Эрх бүхий этгээдүүд нь өмчлөгч, барьцаалагч, эрх нь дуусгавар болох аюул нүүрлэсэн 1242 дугаар зүйлийн 1242.2 дахь хэсэгт тусгасан этгээдүүд. Үүрэг гүйцэтгэгч, дан ганц барьцаалуулагчийн хүсэлт хангалтгүй.

Шүүх зөвхөн худалдан борлуулах тохиромжтой арга замыг тогтоож өгөх үүрэгтэй. Харин худалдан борлуулах эрх үүссэн талаарх хүсэлтийг энэ зүйл заалтын хүрээнд авч шийдвэрлэхгүй.

§ 1247 Барьцаагаар хангагдах.

Барьцаа хөрөнгийн үнийг барьцаалагчийн шаардлагыг хангахаар олгосон бол өмчлөгч үндсэн шаардлагыг хангасанд тооцогдоно. Бусад тохиолдолд борлуулсан үнэ барьцааг орлоно.

I. Худалдан борлуулах ажиллагаа хуульд нийцсэн нөхцөлд үнийг бэлнээр төлөх нь.

Үндсэн шаардлага болон нэмэлт шаардлагуудын хамт мөн зардал зэргийг өмчлөгч барьцааны үнийн дүнгээс төлж барагдуулсанд тооцогдоно. Хэрэв өмчлөгч нь үндсэн шаардлагын үүрэг гүйцэтгэгч бол шаардлага дуусгавар болно. Барьцааны үнэ нь шаардлагаас илүүгүй бөгөөд үнийг эзэмших өөр бусад эрх үгүй бол барьцаалагч үнийг дангаар өмчлөх эрхтэй болно. Хэрэв худалдсан үнэ нь шаардлагаас их байх бол өмчлөгч болон барьцаалагчийн хамтын өмч үүснэ.

II. Бэлэн бусаар төлбөр хийх. Барьцаалагч 1238 дугаар зүйлийг зөрчин барьцааг зээлээр худалдсан бол тэрээр үндсэн шаардлагын хувьд барьцаагаар хангагдсанд тооцогдоно, §1238.2. Харин тэрээр §1245, 1246-д заасан нөхцөлөөр барьцааг зээлээр худалдсан бол худалдах худалдан авах гэрээний үнийг шаардах эрх нь үүргийн гүйцэтгэлийг орлоно.

III.Худалдан авагч өмчлөх эрхийг шилжүүлэн авч чадаагүй бол барьцааны өмчлөх эрхэд өөрчлөлт орохгүй. Барьцаалагчийн шаардах эрх дуусгавар болохгүй ч тэрээр барьцааны үнийг өмчлөх эрхтэй болно. Харин худалдан авагч 1244 дүгээр зүйлийн дагуу өмчлөх эрх шударгаар олж авсан бол үндсэн шаардлага дуусгавар болохгүй хэвээр үлдэх ба өмчлөгч нь барьцааны зүйлийн үнийг өмчлөх эрх олж авна. Энэхүү үнийг өмчлөх эрх нь барьцаалагчийн барьцааны эрхтэй хамт үүсэх тул эндээс шаардлагыг хангуулах боломжтой.

§ 1248 Өмчлөгч хэмээн тооцох заалт.

Барьцааг худалдан борлуулах үед барьцаалуулагч нь өмчлөгч биш гэдгийг барьцаалагч мэдэж байснаас бусад тохиолдолд барьцаалуулагчийг эд хөрөнгийн өмчлөгч байсан хэмээн тооцно.

§ 1249 Орлуулах эрх.

Барьцааг худалдан борлуулснаар барьцаа хөрөнгөд холбогдох эрхээ алдаж магадгүй этгээд нь үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгэвэл зохих хугацаа болмогц барьцаалагчийн шаардлагыг хангах эрхтэй. Энэ хуулийн § 268.2/ 3-ыг энд төсөөтэй хэрэглэнэ. /МУ-ын ИХ-ийн §/.

Өмчийн эрхийн шинжтэй. Үүнийг зөрчсөн бол гэм хорын хариуцлага үүснэ. Үүрэг гүйцэтгэгч үүргээ биелүүлэх эрх нь нээгдсэнээс эхлэн худалдан авагчид барьцаа хөрөнгө шилжээгүй байх хугацаанд энэ эрхийг хэрэгжүүлнэ. Эрх бүхий этгээд нь өмчлөгч болон 1242 дугаар зүйлийн 1242.2 дахь хэсгийн дагуу эрхээ алдах гуравдагч этгээдүүд.

ХБНГУ-ын эрх барьцаалах, худалдан борлуулахтай холбоотой зохицуулалт:

ХБНГУ-ын Иргэний хуулийн 3 дугаар хэсэг буюу Өмчийн эрх зүйн тухай номын 8 дугаар бүлэгт хөдлөх эд хөрөнгө болон эрхийн барьцааны тухай зохицуулалтыг тусгасан бол энэ бүлгийн 2 дугаар хэсэгт эрхийн барьцаатай холбоотой зүйл заалтыг тусгажээ. Тухайлбал §§1273-1296 зүйлд эрхийн барьцаатай холбоотой зохицуулалтыг тусгасан. Эдгээр нь хөдлөх эд хөрөнгийн барьцаатай харьцуулахад эрхийн агуулгыг тодорхойлоход чиглэсэн байх ба үүнд барьцааны эрх үүсгэх, шаардлаыг хэрхэн шилжүүлэх, үүрэг гүйцэтгэх, хүү, хөдлөх эд хөрөнгийн барьцааны хэрэглэх зохицуулалтыг тусгасан байна. Энд үндсэндээ Монгол Улсын Иргэний хуульд заасны адил эрхийг худалдан борлуулахад хөдлөх эд хөрөнгийн барьцааг худалдан борлуулахад хамаатай эрх зүйн зохицуулалт үйлчлэх боловч зөвшөөрлийн үнэт цаасыг чөлөөт хэлбэрээр худалдан борлуулахыг зөвшөөрсөн. Нэрийн үнэт цаас болон бусад эрхийн хувьд хөдлөх эд хөрөнгө худалдан борлуулах тухай зүйл заалт үйлчлэхээр байна.

Монгол Улсы Иргэний хуулийн 164 дүгээр зүйл. Эрх барьцаалах

164.1.Эрх барьцаалахад энэ хуулийн 153-160 дугаар зүйлийн холбогдох заалтууд нэгэн адил хамаарна.

2.3. ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ БОЛОН ЭРХИЙН БАРЬЦААНЫ БҮРТГЭЛИЙГ ХУУЛЬЧИЛСАН ОРНУУДЫН ЖАГСААЛТ

Судалгааны энэхүү хэсэгт хөдлөх хөрөнгө болон эрхийн барьцааны бүртгэлийг хуульчилсан орнуудын жагсаалтыг гаргахыг зорилоо. Зорилтын хүрээнд 23 орныг судлан үзсэн бөгөөд ихэнх улс орнууд Моргейжийн хуулиар хөдлөх хөрөнгө болон эрхийн барьцааны харилцааг зохицуулсан байна.

Моргейж гэдэг нь иргэдийг хувийн өмчтэй болгоход зориулж банк, санхүүгийн байгууллагаас олгож байгаа зээлийг хэлэх[531] бөгөөд хөдлөх хөрөнгө болон эрхийн барьцаа нь зээлийн гэрээнд хэрэглэгдэнэ.

[531] http://www.lectlaw.com/def2/m040.htm.

Хөдлөх хөрөнгө болон эрхийн барьцааны бүртгэлийн талаар бие даасан хуультай улс орнууд байхгүй бөгөөд тухайн харилцааг Моргейжийн хуулиар дараахь улс орнууд зохицуулдаг.

№	Улсын нэр	Зохицуулах эрх зүйн акт	Барьцааны зүйл	Бүртгэлийн хэлбэр
Эх газрын эрх зүйн системтэй улсууд:				
1.	Индонез улс*	Law on Mortgage	Үл хөдлөх зд хөрөнгө /ирэздүйд бий болох зд хөрөнгийг барьцаалдагүй/, Патент, худалдааны тэмдэг ,зохиогчийн эрх, ашигтай загвар, зд хөрөнгө буцаан худалдан авах эрх, шаардах эрхийн шилжүүлэг	Газар- улсын газрын бүртгэлийг газар Хөдлөх зд хөрөнгийг – холбогдох ХХК-ий хувьцаа эзэмшигчийн бүртгэлд бүртгүүлдэг.
2.	ОХУ**	Federal law on mortgage of immovable property	Үнэт цаас болон үл хөдлөх зд хөрөнгө	Үнэт цаас–хадгалагч банкныхаа бүртгэлд
3.	Украйн улс***	Law on mortgage 2003	Mortgage – үл хөдлөх зд хөрөнгө болон түүний дагалдах хэрэгсэл зд юмс, өмчлөх эрх	Улсын бүртгэлд бүртгүүлдэг.
4.	Итали****	Ship mortgage law	Усан онгоц түүний дагалдах зд зүйлийн хамтаар, завь	Барьцаалах бүртгэлийн харилцаагаар зохицуулагддаг. Үл хөдлөх зд хөрөнгийн бүртгэл усан онгоцны бүртгэл зэрэг барьцааны зүйл холбогдох газарт бүртгүүлдэг

хуулийн зүйн хүрээлэн www.nli.gov.mn

* www.iflr1000.com
** www.cmslegal.ru.
*** www.european Bank.com/law on mortgage
**** www.maritimeadvocate.com

5.	Голланд*	Law on mortgage	Оюуны өмч, Үл хөдлөх, хөдлөх /тоног төхөөрөмж,худалдааны тэмдэг гэрээний өр болон эрх, эдийн засгийн баталгаа/ эд хөрөнгийг барьцаалахдаа нотариатаар гэрчлүүлж үл хөдлөх эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын бүртгэлд бүртгүүлнэ.	Үл хөдлөх эд хөрөнгө- гэрээг бичгээр байгуулж нотариатаар гэрчлүүлнэ. Кадастрын улсын бүртгэлд бүртгүүлнэ. Оюуны өмчийг IP бүртгэлд бүртгүүлнэ.
6.	Унгар**	Law on mortgage	Хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө, эрх болон ерийн авлага	
7.	Болгар***	Law on mortgage bonds	Үнэт цаас, хөдөө аж ахуйн зориулалттай газар бусад үл хөдлөх эд хөрөнгө	
Англо-Саксоны эрх зүйн тогтолцоотой улс орнууд:				
8.	Венесуэль****	Chattel mortgage law	Хөдлөх эд хөрөнгийн барьцааг зохицуулдаг	Барьцааны гэрээг бичгээр байгуулж нотариатаар гэрчлүүлж Улсын бүртгэлд бүртгүүлдэг.
Социалист улсууд:				
9.	Азербайджан*****	Law on mortgage 1998.07.03	Хувийн болон хамтын өмч болон үл хөдлөх эд хөрөнгө /бараа материал түүхий эд болон бэлэн бүтээгдэхүүн, өмчлөх эрх, үүргийн харилцаанаас үүсэх эрх, өр/.	Барьцаалсан эд хөрөнгийг Улсын бүртгэлд бүртгэнэ. Бүртгэсэн үеэс барьцаа хүчин төгөлдөр болно.
10.	Тажикстан******	Pledge of movable property 2006 Law on mortgage 2008	Эрх болон иргэний харилцаанаас хамааралгүй эрх, эзэмшлийн эрхүүд, хамтын өмч болж хуваагдаагүй эд хөрөнгө, оюуны өмч, өр нэхэмжлэх бичиг, ирээдүйд бий болох эрх болон эд хөрөнгө	Улсын бүртгэлд байдаг эд хөрөнгийг барьцаалсан бол уг бүртгэлд нь бүртгүүлнэ.

* www.Van-doome.com
** www.practicallaw.com
*** www.landesa.org.
**** www.disolapate.com.
***** www.european Bank.com/law on mortgage
****** www.tajik-gateway.org.

хуулль зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

11.	Афганистан*	Law on mortgage of immovable property in banking transaction 2009	Зөвхөн үл хөдлөх зд хөрөнгийг барьцаалдаг.	Холбогдох бүртгэлийн газарт бүртгүүлнэ.
ХӨДЛӨХ ЗД ХӨРӨНГӨ БОЛОН ЭРХИЙН БАРЬЦААНЫ БҮРТГЭЛИЙГ ИРГЭНИЙ ХУУЛИАР ЗОХИЦУУЛСАН УЛС ОРНУУД				
Эх газрын эрх зүйн тогтолцоотой улс:				
12.	Дани**	Civil law	Хөдлөх болон үл хөдлөх зд хөрөнгө машин тоног төхөөрөмж, хувьцаа болон өрийн авлага.	
Социалист улсууд:				
13.	Арабын нэгдсэн Эмират улс***	Banking and Security law And civil law	Хөдлөх зд хөрөнгө биет-бараа бүтээгдэхүүн тоног төхөөрөмж, бэлэн мөнгө Биет бус- худалдааны тэмдэг, оюуны өмчийн эрх, өр, лиценз	Үл хөдлөх зд хөрөнгийг барьцааны бүртгэл, газрын албанд хотын захиргаанд бүртгүүлдэг. Хөдлөх зд хөрөнгийн хувьд бүртгүүлэх талаар зохицуулалт байхгүй.
ХӨДЛӨХ ЗД ХӨРӨНГӨ БОЛОН ЭРХИЙН БАРЬЦААНЫ БҮРТГЭЛИЙГ БАРЬЦААНЫ ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН БУСАД ХУУЛИАР ЗОХИЦУУЛСАН УЛС ОРНУУД				
14.	Польш улс****	Law on Secured Lending in Poland	Үнэт цаас,биет хөдлөх зд юмс /тоног төхөөрөмж , барааны тэмдэг, усан болон агаарын хөлөг/ оюуны өмч патент худалдаааны тэмдэг зохиогчийн эрх болон загвар	Хөдлөх болон үл хөдлөх /нотиариатаар гэрчлүүлдэг/, зд хөрөнгийг барьцааны бүртгэлд бүртгүүлдэг. Уг бүртгэл нь шүүхэд хадгалагдана. Оюуны өмчийг Польш улсын патентын газар бүртгүүлдэг.
15.	ХБНГУ*****	Property law	Дээрхи хуулиар зохицуулдаг.	
16.	БНСУ******	Үл хөдлөх зд хөрөнгийн барьцааны тухай хууль, тээврийн хэрэгслийн барьцааны тухай, агаарын хөлгийн барьцааны тухай хууль	Хувийн өмчийг барьцаалдаг. Үл хөдлөх зд хөрөнгө /газар, барилга байгууламж, хөдлөх /тоног төхөөрөмж тээврийн хэрэгсэл, агаарын хөлөг/, эдийн бус баялаг	

* www.centralbank.*gov.af laws.*
** www.practicallaw.com
*** www.tamimi.com.
**** http:// www.hg.org/ article.asp? id=21086
***** *www.iuscomp.org*
****** *www.siteresources.wordbank.org.*

17.	Энэтхэг*	Transfer of property act 2008 дотроо зохицуулдаг,	Үл хөдлөх эд хөрөнгийн барьцаалдаг	
18.	Австри**	Law on secured lending	Хөдлөх эд хөрөнгийн барьцаа: тоног төхөөрөмж, бараа материал, тээврийн хэрэгсэл, хариуцлагатай хувьцаат компани, хамтын хөрөнгө оруулалттай компани, авлага, оюуны өмч	Үл хөдлөх эд хөрөнгө- газрын бүртгэлд Хөдлөх эд хөрөнгө- Австри улсын барааны тэмдгийн бүртгэлд, Патентын газарт бүртгүүлдэг.
19.	Их Британийн Нэгдсэн вант улс***		Үл хөдлөх эд хөрөнгө, ерийн төлбөр, хувьцаа	Улсын бүртгэлд бүртгүүлдэг
20.	Шинэ- Зеланд****	Securities Act 1978	Хөдлөх /эрх үнэт цаас/ болон үл хөдлөх эд хөрөнгө	
21.	БНХАУ*****	1995 оны барьцааны хууль	Ирээдүйд бий болох хөдлөх эд хөрөнгө, түүхий эд болон бэлэн болсон бүтээгдэхүүн, барилга байгууламж, усан болон агаарын тээврийн хэрэгсэл	Газар болон үл хөдлөх хөрөнгийг- газар хариуцсан байгууллагад Хот орчмын үл хөдлөх хөрөнгийг үйлчилгээний газар, нутгийн ард түмний удирдлагын газар, шат шатны агаарын болон усан замын тээврийн хэрэгсэл- холбогдох яамд, хэлтэс газарт Тоног төхөөрөмж /хөдлөх эд хөрөнгө/- аж үйлдвэр худалдааны яамдад
22.	Вьетнам улс******		Хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээг бичгээр байгуулж нотариатаар гэрчлүүлдэг. Үүргийг болон онгоц болон усан онгоц	Үл хөдлөх эд хөрөнгө ,газар- орон нутгийн газрын бүртгэлийн төв, байгалийн баялаг хүрээлэн буй орчны хэлтэс
23.	Бангладеш*******	Specific relief act 1877	Үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгө	

* *www.indianrealtylaw.com*
** *www.dispute.practicallaw.com.*
*** *www.scribd.com.*
**** *www.legislation.govt.nz.*
***** www.deocons.com
****** www.ykvn-law.com.
******* www.bdlaws.com/bangladesh

2.4.БАРЬЦААНЫ БҮРТГЭЛ НИЙТЭД НЭЭЛТТЭЙ БАЙЖ БОЛОХ ҮНДЭСЛЭЛ

Өмчийн эрх зүйн аливаа эрх үүсэх болон шилжих үйл явцын аль аль нь энэхүү салбар эрх зүйд үйлчлэх олон нийтэд ил тод нээлттэй байх зарчимд тулгуурлаж байдаг. Энэ зарчим нь үндсэндээ олон нийтэд нээлттэй бус аргаар өмчлөх эрхийг шилжүүлэх нөхцөлд ч үйлчилдэг. Энэхүү судалгааны хүрээнд эхлээд уг зарчим хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийн хүрээнд ямар чиг үүрэгтэй байдаг тухай авч үзсэн бөгөөд улмаар барьцааны эрхийн бүртгэлийн ач холбогдлыг тодорхойлсон билээ.

Харин ямарваа нэг өр, авлагыг арилжааны зүйл болгох нөхцөлд л дээрх зарчим хангагдах боломжгүй болдог. Аливаа авлагын ард нуугдаж буй шаардах эрхийг битүүмжлэх тохиолдолд өмчийн эрх зүйн нээлттэй ил байх зарчим сая хангагдана. Учир нь битүүмжлэх тухай үүрэг гүйцэтгэгчид мэдэгдсэний дараа уг ажиллагааг гүйцэтгэнэ.

Үл хөдлөх хөрөнгийн эрхийн тухайд гэвэл эдгээр нь улсын бүртгэлд бүртгэгдсэнээр олон нийтэд нээлттэй ил боллоо гэж үздэг. /Иргэний хуулийн 109, 182 дугаар зүйл/

Хөдлөх хөрөнгийн хувьд хууль тогтоогч Иргэний хуулийн 111.1, 111.2 дахь зүйлд энэхүү нээлттэй ил тод байх зарчмыг тусгасан гэж үзэж болно. Гэхдээ үл хөдлөх хөрөнгөөс ялгагдах зүйл нь гэвэл улсын бүртгэлээр дамжуулж эл зарчмыг хэрэгжүүлээгүй; харин энд "эзэмшил" нь хөрөнгийн харьяаллыг олон нийтэд илтгэх хэрэгсэл байхаар зохицуулжээ[532]. Тодруулбал, хөдлөх хөрөнгийг шилжүүлэхэд талуудын тохиролцооноос гадна нэг бол шууд эзэмшлийг шилжүүлэх /Иргэний хуулийн §111.2.1/[533] эсхүл үүнийг орлосон гэрээ байгуулах /Иргэний хуулийн §111.2.2/ эсхүл эзэмшлийг шаардах эрхээ шилжүүлэх /Иргэний хуулийн §111.2.3/ шаардлагатай бөгөөд эдгээр нь бүгдээрээ өмчлөгч хэн болохыг нийтэд ил болгох зорилго агуулдаг. Үндсэндээ өмнөх эзэн хөдлөх хөрөнгөд тогтоосон нөөрхолоо дуусгавар болгож, нөгөө этгээдийн нөлөөлөл тогтох ёстой. Харин сүүлчийн хоёр тохиолдолд талуудаас илүү ажил шаардалгүй, нэмэлт тохиролцоо хангалтай байхаар хуулинд тусгасан.

Дээрхээс үзвэл хөдлөх эд хөрөнгийн эзэмшил болон улсын бүртгэлд бүртгүүлэх явдал олон нийтэд зохих итгэл үнэмшил төрүүлж, нээлттэй байдгаараа шударгаар өмч шилжих гол шалгуур үзүүлэлт болж байдаг. Эдгээр байр суурийг олж авсан этгээдийг өмчлөгч гэж үзэж эрхийг сэргээх, хэрэгжүүлэх шийдэл Иргэний хуулинд тусгагдсан. Хэрэв эрх бүхий этгээд эзэмшлээ өөр этгээдэд шилжүүлсэн эсхүл улсын бүртгэлд тэмдэглэгдэх эрхийг өөр этгээдэд олгох нөхцөлд уг эрхээ алдах аюултай. Иймхүү бүртгэл нь нийтийн итгэл үнэмшлийг хамгаалах хэрэгсэл болох ба улмаар өмчлөгч эсхүл шударга эзэмшигчид эрх олгох нь зүйтэй юу гэсэн асуудлыг шийдвэрлэхэд гол үүрэгтэй байдаг.

Манай улсад Хөдлөх эд хөрөнгийн болон эрхийн барьцааны тухай хуулийн төсөл боловсрогдож буйтай холбогдуулан барьцааны эрхийн, бүртгэлийг хөтлөх асуудал хурцаар тавигдаж байна. Тухайлбал, дээрх

[532] Иргэний хуулийн тайлбар толь, 2006 он, 310-с хойшихийг үзэх.
[533] Латинаар: *brevi manu traditio.*

хуулийн төслийн III бүлэг буюу12-17 дугаар зүйлд барьцааны бүртгэлийн байгууллага, бүртгэлд хамрагдах шаардлага, эрх зүйн үр дагавар, хөлс, мэдээлийн санд хайлт хийх зэргийг зохицуулахаар зэхэж байна.

Эдгээр нь үндсэндээ Европын Холбооны Иргэний хуулийн кодекс батлах бэлтгэл ажлын хүрээнд яригдаж байсан хөдлөх эд хөрөнгийн барьцааны эрхийн тухай зохицуулалтуудын хураангуйлсан хэлбэр гэж үзэж болохоор байна[534]. Хэдийгээр энэ кодексийн хүрээнд бүхий л боломжит барьцааны хэлбэрүүд болон аж ахуйн нэгжийг барьцаалах асуудлыг тусгасан ч барьцааны эрх үүсэх, бүртгүүлэх, эрхийн дараалын асуудал МУ-ын хуулинд адилхан тусгагдсан байна. Европын Холбооны хэмжээнд АНУ-ын Худалдааны Нэгдсэн Кодексийн /***Uniform Commercial Code***/ 9 дүгээр зүйлд тусгагдсан бүртгэлийн системийг нэвтрүүлэх хандлага[535] ажиглагдаж байна. Тухайлбал, энд бүртгэлийг ***notice filing*** буюу санжүүжилтийн тайланг гаргаж өгөх замаар хийгддэг, бүртгэлийг электрон хэлбэрээр хөтөлдөг байна. Ийм бүртгэлийг төрийн эрх бүхий байгуллагаас хөтлөх бөгөөд барьцааны эрхийн талаар олон нийтэд мэдээлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ. Тус цахим бүртгэл нь ХБНГУ-ын Үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлийн тухай хуулийн 12 зүйлтэй харьцуулахад шалгуур багатай байх нь эргэлзээгүй байх ба жишээлэхэд бүртгүүлэхээр хүсэлт гаргагчийн ашиг сонирхол хөндөгдсөн эсэхийг нарийвчлан шалгах тухай нөхцөлийг тусгахааргүй байна. Манай хуулийн төслийн 17 дугаар зүйлд тусгасанчлан европын холбооны барьцааны бүртгэлд цахим хайлт хийх бүрэн бололцоотой ба үүрэг гүйцэтгэгч буюу барьцаалуулагчийн нэрийн дараалаар өрсөн жагсаалт байх ажээ. Түүнчлэн энд хэрэглэгчийн эрх ашгийг түлхүү хамгаалах Opt-in-Modell тусгагджээ.

Хөдлөх хөрөнгийн барьцааны бүртгэл нээлттэй явагддаг хэд хэдэн улсыг авч үзвэл:

Бүгд Найрамдах Хятад ард улс[536]

Хөдлөх хөрөнгийн барьцааны бүртгэл нь олон нийтийн мэдээлэл төдий бус барьцаа, зээл олгохтой холбоотой зөрчилтэй нөхцөл байдлыг үр ашигтай зохицуулах арга болдог. Бүртгэл нь барьцаа олгогчийн эрхийг хамгаалах, талуудын нөхцөл байдлыг ил тод болгох гуравдагч этгээдийн эрхийг хамгаалах зэрэг сайн талтай ч, бүртгэлийн үйл явц төвөгтэй байх, талуудад очих ачааллыг нэмэгдүүлдэг гэх мэт хэд хэдэн дутагдалтай талтай ч эдгээрийг зөв зохицуулж чадвал хөдлөх хөрөнгийн барьцааны бүртгэл нь үр ашигтай байгаад зогсохгүй хэрэглэгчдэд амар хялбар болно гэж үздэг. "Хөдлөх хөрөнгийн барьцааг хийхдээ дараах тодорхой төрлийн хөрөнгийн

---

[534] http://www.sgecc.net/media/download/proprietary_securitiesjune_2005.pdf.

[535] S *Kieninger,* WM 2005, 2307 ff, 2358 mit Hinweisen auf Reformbestrebungen in einzelnen-Mitgliedstaaten, die auch schon dieses Registrierungssystem ьbernehmen wollen; zB fьrSchottland s *David O'Donnell/D. L. Carey Miller,* Security over Movables A LongstandingReform Agenda in Scots Law, ZEuP 1997, 807 ff, fьr die Schweiz s zB *Wolfgang Wiegand,*Mobiliarsicherheiten, Berner Bankrechtstag Bd 5, Bern 1997, 75; fьr Цsterreich und Deutschland s zB Fritz Baur, Das besitzlose Pfandrecht als Mittel der Kreditsicherung, in: Estudios dederecho civil en honor del Prof. Castan, Pamplona 1968, Vol. I, 95.

[536] http://eng.hi138.com/?i152777.

барьцааны хувьд заавал бүртгэл хийгдсэн байх шаардлагатай. Үүнд:

- Агаарын хөлөг, усан онгоц, тээврийн хэрэгсэл;
- Үйлдвэрийн багаж хэрэгсэл болон бусад хөдлөх хөрөнгө.

Агаарын хөлөг, усан онгоц болон тээврийн хэрэгслийн барьцааны бүртгэлийг тус тусын бүртгэл, лиценз олголтын агентлагт хийнэ. Харин бусад хөдлөх хөрөнгийн барьцааны бүртгэлийг тухайн орон нутгийн "Худалдаа, үйлдвэрлэлийн удирдах"[537] газарт тус тус хийдэг"[538]. Хэрэв эдгээр хөрөнгийн барьцааг бүртгүүлэгүй бол барьцаа нь хүчин төгөлдөр бус байх болно. Бусад хөдлөх хөрөнгийн барьцааг талууд хүсвэл бүртгэлжүүлж болно. Хөдлөх хөрөнгийн барьцааны бүртгэлийг зээлдэгчийн оршин суугаа газарт хийх бөгөөд зээлдүүлэгчид "Барьцааны бүртгэлийн гэрчилгээ"[539] олгодог. Барьцааны бүртгэлийн гэрчилгээнд дараах мэдээлэл тусгагдсан байна. Үүнд[540]:

- Зээлдэгч болон зээлдүүлэгчийн нэр, байнга оршин суугаа хаяг;
- Төлөөлөгчийн нэр;
- Зээлдүүлэгчийн хамгаалагдсан эрхийн хэмжээ болон ангилал;
- Баталгааны хүрээ;
- Зээлдэгчийн үүрэг гүйцэтгэх хугацааны хязгаар;
- Барьцааны хөрөнгийн нэр, байршил, чанар, тоо хэмжээ, байр байдал болон энэхүү хөрөнгийг эзэмших эрх болон ашиглах эрх хэнд байгаа талаар;
- Барьцаалан зээлдэгч болон зээлдүүлэгчийн гарын үсэг, тамга тэмдэг"[541].

Барьцааны бүртгэлийг ажлын таван өдрийн дотор багтаан хийдэг.

"Улсын худалдаа, үйлдвэрлэлийн газраас гаргасан 2007 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн "Хөдлөх хөрөнгийн бүртгэлийн тухай" №30 тоот журмын"[542] 11 дүгээр зүйлд зааснаар "Холбогдох хуулийн этгээд болон хувь хүн хөдлөх хөрөнгийн барьцааны бүртгэлийн эрх бүхий байгууллагаас хөдлөх хөрөнгийн барьцааны бүртгэлтэй холбоотой мэдээлэл лавлах, баримт бичиг хуулбарлан авч болно", мөн журмын 10 дугаар зүйлд зааснаар "хөдлөх хөрөнгийн барьцааны бүртгэл хийх эрх бүхий байгууллага нь олон нийтийн мэдээлэл лавлагаанд зориулан хөдлөх хөрөнгийн барьцааны гэрчилгээнд орсон өөрчлөлт болон бүртгэлээс хасагдсан зэрэг мэдээллийг тухай бүрд нь хийж шинэчлэх үүрэгтэй"[543] гэжээ. Хөдлөх хөрөнгийн барьцааны бүртгэлийн гэрчилгээг 4 хувь үйлдэж зээлдэгч, зээлдүүлэгчид тус бүр нэг нэг хувийг өгч, хөдлөх хөрөнгийн барьцааны бүртгэлийн байгууллагын архивт нэг хувийг, үлдсэн нэг хувийг нь хөдлөх хөрөнгийн барьцааны бүртгэлийн лавлагаанд

[537] local Administration of Industry and Commerce.

[538] http://www.chinalawandpractice.com/Article/1693630/Channel/7576/New-Rules-on-Registering-Mortgages-and-Other-Security-Interests.html.

[539] "Mortgage Registration Certificate".

[540] http://www.lawinfochina.com/NetLaw/display.aspx?db=law&sen=rLdDdW4drhdDdWfdrhdFdW4drDdDdWdd9DdwdWhd/hdxdWud/dd5dWndrDdDdWud/ddTdWud9Dd+&Id=6457&.

[541] Measures for Chattel Mortgage Registration /Order No.30 of the State Administration for Industry and Commerce/-*www.lawhall.com/lb/1/1352.html.*

[542] http://www.lawhall.com/lb/1/1352.html.

[543] Article 10of Measures for Chattel Mortgage Registration.

оруулдаг. Ингэснээр барьцааны бүртгэлийн мэдээлэл илүү найдвартай байх нөхцөлийг хангаж, гарч болох эрсдлээс хамгаалдаг.

Канад улс Алберта муж[544]

Эрх зүйн зөрчил болоод гарч болзошгүй алдагдлаас зайлсхийх үүднээс машин, гэр ахуйн болон хувийн эд зүйл, үйлдвэрлэл болон фермерийн багаж хэрэгсэл, онгоц зэрэг хөдлөх хөрөнгийг заавал бүртгүүлнэ. Хөдлөх хөрөнгийн бүртгэл нь Хөдлөх хөрөнгийн аюулгүй байдлын тухай хууль /*Personal Property Security Act*/ болон иргэний албадлагын актын /*Civil Enforcement Act*/ дагуу онлайн хэлбэрээр хийгддэг. Хөдлөх хөрөнгөтэй холбоотой бүх мэдээлэл Албертагийн хөдлөх хөрөнгийн электрон бүртгэлийн системд байрладаг. Бүртгэлтэй холбоотой мэдээлэл, лавлагааны үйлчилгээг бүртгэлийн төлөөлөгчийн газраар дамжуулан муж даяар хэрэгжүүлдэг.

Хөдлөх хөрөнгийн бүртгэл

Санхүүгийн нөхцөл байдлыг тодорхойлох бүх бүртгэл нь бүртгэлийн агентлагаар дамжуулан мужийн хөдлөх хөрөнгийн электрон бүртгэлийн системд тухайлбал, /Alberta Personal Property Registry Electronic System / APPRES// онлайн хэлбэрээр хийгддэг.

Хөдлөх хөрөнгийн бүртгэлийг хэрхэн хянадаг тухай

Бүртгэлийн агентлаг нь санхүүгийн мэдээллийг тусгасан бодит шалгуур тавьдаг. Хэрэв мэдээлэл бүрэн,шаардлага хангасан нөхцөлд тухайн хөдлөх хөрөнгийн электрон бүртгэлийн системд нэвтрэн орж, бүртгэлийн дугаар үүсгэдэг. Хэрэв тухайн мэдээлэлд ноцтой төөрөгдөл гэж үзэхүйц алдаа дутагдал байгаа бол хүчингүйд тооцогдоно. Энэ тохиолдолд тухайн мэдээлэл хайлтын үр дүнд гарч ирэхгүй. Мэдээллийн аюулгүй байдлыг хангаж байгаа тал нь тухайн мэдээллийг үнэн зөв байлгах үүрэгтэй. Хэрэв энэ үүргээ зөрчсөний улмаас бусдад хохирол учруулсан бол хариуцлага хүлээнэ. Хэрэв мужийн хөдлөх хөрөнгийн электрон бүртгэлийн системд бүртгүүлсэн бол бүртгэлийн агентлаг нь мэдээлэл үндэслэлтэйг нотлох баримт олгоно. Мэдээлэл үндэслэлтэйг нотлох баримтыг сайтар нягтлаад хэрэв ямар нэгэн алдаа илэрвэл нэн даруй бүртгэлийн агентлагт хандан дахин шинэчилж, өөрчлүүлнэ. Мэдээлэл үндэслэлтэйг нотлох баримтын үндсэн дээр бүртгэлийн мэдээллийг шинэчилж болно. Хөдлөх хөрөнгийн бүртгэлийг хийснээрээ хөдлөх хөрөнгийн бүх мэдээллийг илрүүлж, улмаар ззэлдэгч болон худалдан авагчийн ашиг сонирхлыг хамгаалах алхам болдог.

Мужийн хөдлөх хөрөнгийн электрон бүртгэлийн систем нь зарим хөдлөх хөрөнгийн бүртгэлтэй холбоотой мэдээллийг/жишээнь,өмчлөл/ бүртгэдэггүй. Энэ тохиолдолд хайлт хийж байгаа этгээд илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл холбогдох этгээдээс лавлаж болно. Мөн хөдлөх хөрөнгийн электрон бүртгэлийн систем дэх бүх мэдээлэл боломжтой /current/ эсхүл устгагдсан /deleted/ гэсэн статустай байх бөгөөд энэ нь мэдээллийг шалгах чухал зүйл болдог. Хайлтыг онлайн хэлбэрээр ямарч бүртгэлийн

[544] http://www.batasnatin.com/law-library/civil-law/land-titles-and-deeds/1479-foreclosure-sale-retroacts-to-registration.

агентлагаас хийх боломжтой. Хөдлөх хөрөнгийн бүртгэлийн мэдээллийг хайж олж авахад тодорхой хэмжээний хураамж төлдег.

Хөдлөх хөрөнгийн бүртгэлээс юуг хайж болох вэ?

- Хувиараа зээлдэгчийн нэр хайх;
- Бизнесийн зээлдэгчийн нэр хайх;
- Серийн дугаар хайх: тухайн дугаараар яг ямар эд зүйл бүртгэгдсэн байгааг тодруулах;
- Бүртгэлийн дугаар хайх;
- Хөрөнгө битүүмжлэгдсэн эсэх: шүүхийн шийдвэрийн албадлагыг хэрэгжүүлэх боломжтой эсэхийг шалгана;
- Бизнесийн үйл ажиллагаанд баталгаа гаргаж байгаа талыг хайх;
- Бүртгэлийн дугаар устгагдсан, хугацаа дуусан эсэхийг системээс хайх боломжтой байдаг.

Хөдлөх хөрөнгийн барьцааны бүртгэл нээлттэй байсны **давуу тал** нь:

- Зээл олгож байгаа талд эрх ашгаа хамгаалах боломж бүрддэг./ Жишээ нь, зээлдэгчийн хөдлөх эд хөрөнгийн талаарх бүх мэдээллийг авах гэх мэт/;
- Талуудад нөхцөл байдлыг илэрхий тодорхой болгодог /хөдлөх хөрөнгө хаана байршиж байгааг тодорхой болгох гэх мэт/;
- Үүргийн гүйцэтгэлийг хангах боломжтой болдог;
- Хөдлөх эд хөрөнгийн барьцааны бүртгэл хийгдсэн байх нь хөдлөх эд хөрөнгийн барьцаа хүчин төгөлдөр болох нэг гол нөхцөл болдог.

Сул тал:

- Хөрөнгө шилжүүлэхэд хүндрэлтэй болдог;
- Бүртгэлийн процедур нь талуудад хүндрэл учруулдаг;
- Талуудад очих ачаалал нэмэгддэг.

Бүртгэл хийгдээгүй бол гуравдагч этгээдийн хувьд хөдлөх эд хөрөнгийн барьцаа нь хүчин төгөлдөр бус, биелүүлэх шаардлагагүй болдог[545].

Дүгнэлт

Хөдлөх эд хөрөнгийн болон эрхийн барьцааны тухай хууль шаардлагатай юу? гэдэг асуултыг дараахь хоёр хувилбараар авч үзэв.

Хувилбар 1: Иргэний хуулийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх тухай

Шинэ хууль боловсруулахгүйгээр Иргэний хуулийн 153-160 дугаар зүйлийг өөрчлөн барьцааны үндсэн зохицуулалтыг 1-ээс 2 зүйл заалтад багтаан улмаар хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах асуудлыг Иргэний хуулийн 161-162 дугаар зүйлийг дэлгэрүүлэх хэлбэрээр оруулах боломжтой. Ингэж зохицуулахдаа бусад хуулиас үүдэх барьцааны эрх, мөн Ашигт малтмалын тухай хууль зэрэгт тусгасан барьцааны эрх зэргийг худалдан борлуулах ажиллагаанд эдгээр зохицуулалт нэгэн адил үйлчлэхээр тусгах;

Сул тал: Маш цөөн зохицуулалтад багтаан байршуулснаас хэт урт зүйл, заалт үүсэх дутагдалтай. Барьцааны эрх зүйн харилцаа дутуу тусгагдах талтай.

Давуу тал: Хуулийн тоог цомхон байлгаснаар хууль хэрэглэгч болон хууль тогтоогчдын ажлыг хөнгөвчлөх ба иргэний хуультай харилцан хамаарлын асуудал яригдахгүй бөгөөд ингэснээр хуулийн давхардал, хийдэл олшрохгүй.

[545] ttp://www.batasnatin.com/law-library/civil-law/obligations-and-contracts/825-chattel-mortgage-articles.

Хувилбар 2: Бие даасан хууль батлах

Хөдлөх эд хөрөнгийн болон эрхийн барьцааны тухай хуулийн төслийн ажил эхлээд, хууль нь эхний байдлаар боловсрогдсон тул энэ хувилбарыг сонгох нь илүү магадлалтай байна. Гэхдээ үүний хажуугаар Иргэний хуулиа эргэн харах асуудал заавал хийгдэх ёстой. Энэ нөхцөлд Иргэний хуулийн барьцааны эрх зүйн дээрх зохицуулалтыг тодотгосон хэм хэмжээ болохыг хуульдаа тусгаж, Иргэний хуультай болон бусад хуультай зөрчилдсөн тохиолдолд хэрхэн шийдвэрлэх вэ? гэдэг зөрчилдөөний хэм хэмжээ тусгаж өгөх шаардлага үүснэ.

-ШШГТХ-ийн 39 дүгээр зүйлд битүүмжилсэн эд хөрөнгийг худалдах журмыг тусгасан ба уг хуулийн 39 дүгээр зүйлийн 39-ийн 4 дэх хэсэгт Иргэний хуулийн 197 дугаар зүйлийг үйлчлэхээр зохицуулсан. Харин хөдлөх эд хөрөнгийг худалдан борлуулах тухай шинэ хууль гарвал ШШГТХ-ийн 39 дүгээр зүйлийн 39.4-т мөн нэмэлт, өөрчлөлт оруулах нь шаардлагатай болно. Учир нь дан барьцааны тухай хууль батлаад худалдан борлуулах журам нь тусдаа байх нь тохиромжтой бус тул шинэ батлах хуулийн худалдан борлуулах үйл ажиллагаатай холбоотой зүйл заалтыг мөн дээрхи зүйл заалтуудад үйлчлэхээр зааж өгөх;

Энэ хувилбарын давуу тал нь: барьцааны бүртгэлийн байгууллага, бүртгэл хийх журам зэрэг шинэ ойлголтыг зохицуулах боломж бүрдэнэ.

Хуулиас үүдэх барьцааны эрхийг шинэ хууль хамруулах уу?

Хөдлөх эд хөрөнгийн барьцааны эрхийн зохицуулалт үйлчилбэл зохих иргэний эрх зүйн бусад харилцааг авч үзвэл Иргэний хуулийн 329, 354, 429 дүгээр зүйл мөн 483 дугаар зүйлийн 483.8 дахь хэсгийг дурьдах нь зүйтэй. Гэхдээ өнөөгийн байдлаар эдгээр барьцааны эрхийг Иргэний хуулийн 153-160 дугаар зүйлтэй холбож үзэх нь тун ховор байна. Хуулиас үүдэх барьцааны эрх буюу саатуулан барих эрхүүд нь шүүхийн өмнө очилгүй "хувиараа гүйцэтгэл" явуулах зорилго бүхий арга хэрэгсэл бөгөөд зөвхөн маргаантай нөхцөлд шүүхэд хандах ба бусад нөхцөлд хөрөнгийг дуудлага худалдаа явуулах үндсэн зохицуулалтын дагуу шийдвэрлэж болдог. Харин Монгол Улсад ийм боломжгүй тул дээрх эрхүүд нь хий хоосон тунхаг болж байгаа бөгөөд үүнийг баримтлан хөрөнгийг барьцаалсан бол хүч хэрэглэж асуудлыг шийдвэрлэх, эсхүл шүүхэд хандахын аль нэгээр төгсөж байна.

Угтаа бол нэгэнт хуулиар олгогдсон барьцааны эрх бүхий этгээд нь үүнийгээ хэрэгжүүлэх боломжтой байх ёстой. Тиймээс хөдлөх эд хөрөнгийн барьцааны эрхийн тухай шинэ хууль баталбал 1 дүгээр зүйлд нь хуулиас үүдэх барьцаанд хэрэглэгдэх эсэхийг тусгах нь зүйтэй байна.

Удирдамжийн 2 дахь хэсгийн барьцааны гэрээтэй холбоотой эрхийн маргаан нь нийт шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн мөн 1 хүрэхгүй хувийг эзэлж байх ба субъектын хувьд банкны салбарт үл хөдлөх хөрөнгө, эрхийн барьцаа буюу ашигт малтмалын тусгай зөвшөөрөл барьцаалан зээл олгох нь түгээмэл бол банк бус санхүүгийн байгууллага, Хадгаламж зээлийн хоршоо, барьцаалан зээлдүүлэх газарт /Ломбард/ хөдлөх эд хөрөнгө барьцаалан зээл олгодог байна.

Зорилт 4, 5-ын хүрээнд: Барьцааны бүртгэлийг олон нийтэд ил болгох, нээлттэй байлгах явдал нь өмчийн эрх зүйн аливаа эрхийн харьяалал нийтэд ил байх үндсэн зарчим барьцааны эрхийн төвшинд хэрэгжиж, эрх зүйн тодорхой байдлыг тогтоож буй үзэгдэл юм. Ингэснээр бүртгэлд

тусгагдсан эрх нь гуравдагч этгээдийн хувьд хучин төгөлдөр үүссэнд тооцогдох эрх зүйн үр дагаварт хүрэх бөгөөд барьцаалагчийн эрхийг хамгаалах, хэд хэдэн барьцаалагч бий бол тэдгээрийн эрхийн дараалыг тогтоох гол шалгуур болдог. Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлээс ялгагдах гол онцлог нь Хөдлөх эд хөрөнгийн болон эрхийн барьцааны тухай хуулийн төслийн 14 дүгээр зүйлд тусчээ. Тухайлбал, хөдлөх эд хөрөнгийн бүртгэл нь барьцааны эрх үүссэн эсэх тухай мэдээллийг олон нийтэд хүргэж, ингэснээр нийтийн итгэл үнэмшлийг бүрдүүлэх хэрэгсэл болох ч өөр шинэ эрх үүсэх үндэслэл болохгүй, шударгаар эрх үүсэх үндэс болохгүй байхаар тусгасанд оршино. Энэ асуудал Иргэний хуулиар шийдвэрлэх асуудал хэвээр үлдэх ба үүгээрээ АНУ-ын Uniform Commercial Code болон Европын Холбооны хууль тогтоомжтой ижил төстэй болжээ. Барьцааны бүртгэлийн гол үүрэг дээрхээс үзвэл эрх бүртгэсэн дараалыг тогтоох, анхны барьцаалагчийн эрхийг түлхүү хамгаалахад оршиж байна[546].

Хөдлөх эд хөрөнгө болон эрхийн барьцааны тухай бие даасан хуультай улс орнууд байхгүй ба эрх зүйн тогтолцоогоор ангилан авч үзвэл Эх газрын эрх зүйн тогтолцоотой улс орнууд Иргэний хууль /Civil law/, Барьцааны тухай /Mortgage law/-хуулиар зохицуулдаг бол Англо саксоны эрх зүйн тогтолцоотой улсууд Өмчийн тухай хууль /Property law/, Үнэт цаасны тухай /Securities act/ хуулиар зохицуулдаг.

Улс орнууд Хөдлөх хөрөнгө болон эрхийн барьцааны бүртгэлийг тухайн улсын бүртгэлийн газар болон хотын захиргаанд бүртгүүлэхийг шаарддаг. Энэ нь барьцаалагчийг учирч болох эрсдлээс сэргийлж байгаа хэлбэр юм.

Зорилт 6-ийн хүрээнд:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1: Энэхүү албадан барьцаалсаны дүнд үүсч буй барьцааны эрх нь нийтийн эрх зүйн салбарт хамаарах тул дээрх хууль болон ИХШХШТХ-д заасан тусгай зохицуулалт үйлчилнэ. Тиймээс энд Иргэний хуулийн барьцаатай холбоотой зохицуулалт нь зөвхөн хуулийн цоорхойг нөхөх журмаар хэрэглэгдэнэ.

ХБНГУ-ын Иргэний хуульд "Барьцаалагчийн шаардлагыг хугацаанд нь биелүүлээгүй нөхцөлд барьцаа хөрөнгийн өмчлөх эрх барьцаалагчид шилжих тухай тохиролцоог барьцаа худалдан борлуулах эрх үүсэхээс өмнө хийсэн бол энэ нь хучингүй" гэсэн зохицуулалт байдаг бол манай Иргэний хуульд байхгүй тусгагдаагүй. Энэ зүйлд барьцааны эрх үүсэх ба худалдан борлуулах эрх үүсэхээс өмнө хойшлуулах болзол тавьж барьцаалагч өмч шилжүүлж авах болон өмч шилжүүлэхэд чиглэсэн шаардах эрхтэй байх талаар тохирохыг хориглосон байна.

Жишээлбэл, Барьцааг биржийн болон зах зээлийн ханшаар худалдагдахгүй нөхцөлд барьцаалагчид өмч шилжих тухай тохиролцоо хучингүй болно.Мөн гэрээний шийтгэл болгож барьцаа хөрөнгийн өмчлөлийг барьцаалагчид шилжүүлэх нөхцөл хучингүй болно гэсэн үг юм.

Монгол Улсын Иргэний хуульд барьцааны зүйл хэд хэдэн этгээдэд барьцаалагдсан бол хамгийн түрүүнд түүнийг барьцаалсан этгээд уг зүйлийг

[546] Kieninger, Security Rights in Movable Property inEuropean Private Law, 2004, 73; Kieninger, WM 2005, 2308; Kuhn, IPRax 2000, 332 ff.Beachtlich ist zudem die Anwendbarkeit des Art 9 UCC auf alle dinglichen Rechte, die funktional der Kreditsicherung dienen, unabhдngig davon, in welchem rechtlichen Gewand sieerscheinen, Kieninger, WM 2005, 2309; Kuhn, IPRax 2000, 335 spricht von einem „einheitlichen Sicherungsrecht". Generell zum US-amerikanischen Kreditsicherungsrecht vgl NationalConference of Commissioners on Uniform State Laws /Ed./, Uniform commercial code: official text 1995 with comments, 14* ed., St. Paul /Minn./ 1996.

борлуулахыг шаардах эрхтэй бөгөөд уг этгээд энэ эрхээ хэрэгжүүлэхээс татгалзсан бол дараагийн барьцаалагч шаардах эрхээ хэрэгжүүлнэ гэж заасан бол ХБНГУ-ын Иргэний хуулийн 1230 дугаар зүйлд Хэд хэдэн барьцаа хөрөнгө бий нөхцөлд барьцаалагч нь гэрээнд өөрөөр тохирсноос бусад тохиолдолд аль хөрөнгийг худалдан борлуулахаа сонгоно. Тэрээр зөвхөн шаардлагыг хангахад зайлшгүй шаардагдах хэмжээний барьцааг худалдаалах эрхтэй гэж барьцаа хөрөнгө хэд хэд байгаа тохиолдлыг илүү тусгасан. Харин хэд хэдэн барьцаалагч байхыг ердийн үзэгдэл гэж үзсэн байна.

Монгол Улсын Иргэний хуулийн 158 дугаар зүйлийн 158.5 дахь хэсэгт барьцааны зүйл нь хэд хэдэн этгээдэд барьцаалагдсан бол хамгийн түрүүнд түүнийг барьцаалсан этгээд уг зүйлийг борлуулахыг шаардах эрхтэй бөгөөд уг этгээд энэ эрхээ хэрэгжүүлэхээс татгалзсан бол дараагийн барьцаалагч шаардах эрхээ хэрэгжүүлнэ гэж заасан бол ХБНГУ-ын Иргэний хуулийн 1232 дугаар зүйлд барьцаалагч нь түүний дараагийн шатны барьцаалагчид хөрөнгийг худалдан борлуулах зорилгоор гаргаж өгөх үүрэгтэй. Хэрэв анхны барьцаалагч хөрөнгийг эзэмшилдээ аваагүй бөгөөд өөрөө барьцааг худалдах ажиллагааг эхлүүлээгүй бол дараа дараачийн барьцаалагчийн худалдан борлуулах ажиллагааг хориглох ёсгүй гэж заасан бол худалдан борлуулах тухай сануулах хугацааг Германы хуульд 1 сар, Монгол Улсын Иргэний хуульд 14 хоног хүлээсний эцэст барьцаалагч худалдан борлуулах ажиллагааг эхлүүлнэ гэж заасан нь тус тус ялгаатай зохицуулалт болсон байна.

Санал

Иргэний хуулийн 153-160 дугаар зүйлийг барьцааны эрх зүйн үндсэн зохицуулалт гэж үзэх бол Хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах асуудлыг Иргэний хуулийн 161-162 дугаар зүйлийг дэлгэрүүлэх хэлбэрээр оруулах боломжтой. Тэгвэл бусад хуулиар үүссэн эсхүл Ашигт малтмалын тухай хууль зэрэг тусгай хууль тогтоомжид тусгасан барьцааны эрх зэргийг худалдан борлуулах ажиллагаанд эдгээр зохицуулалт нэгэн адил үйлчлэхээр тусгах болно;

Дуудлага худалдаа явуулах асуудал Иргэний хуулийн 197 дугаар зүйлд тусгагдсан тул тэнд тусгасан нийтэд зарлах,үнэ хаялцуулах журмыг шинэ хуулийн төсөлдөө авч хэрэглэх;

Үл хөдлөх хөрөнгийн барьцаанд Иргэний хуулийн 153-160 дугаар зүйлийг хэрэглэх шаардлагагүй; салгах нь илүү тохиромжтой байх тул Иргэний хуулийн 153-162 дугаар зүйлд зөвхөн хөдлөх хөрөнгө ба эрхийн барьцааг дэлгэрэнгүй зохицуулах;

Манай Иргэний хуулийн дараах зохицуулалтуудыг цаашид улам нарийвчлан зохицуулах шаардлагатай байна:

- хэд хэдэн эд зүйл барьцаалах тохиолдолд яах вэ?
- Барьцааны зүйлийг худалдан борлуулах журам /Иргэний хуулийн 197 дугаар зүйлдангаар хангалтгүй байгаа бөгөөд үүнийг хөдлөх эд хөрөнгийн барьцаанд тохируулан дэлгэрүүлэх/
- Хөдлөх эд хөрөнгийг барьцаалахдаа тухайн эд хөрөнгийг хэрхэн үнэлэх талаарх асуудлыг хуульд тусгах.

__oOo__

ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛТЭЙ ХОЛБООТОЙ ХИЙСЭН СУДАЛГАА[547]

ОРШИЛ

Энэхүү судалгааны ажлын зорилго нь "Төрийн бус байгууллагын тухай" хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахтай холбогдуулан "төрийн бус байгууллагын санхүүгийн орчны эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа", "Монголын иргэний нийгэм болон ТББ-ын төлөвшлийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд" сэдвээр судалгаа хийж, санал, зөвлөмж боловсруулахад оршино.

Нэг. НИЙГЭМД АШИГ ТУСТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, ТҮҮНД ТӨРӨӨС ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

Нийгэмд тустай үйл ажиллагаа гэх ойлголтыг дараах байдлаар тодорхойлох нь түгээмэл байдаг байна:[548]

"Тодорхой нэг байгууллагын үйл ажиллагаа нь олон нийтийн материаллаг, оюун санаа эсхүл ёс заншлын хувьд дэмжих, хөгжүүлэхэд чиглэгдсэн байх тохиолдолд энэхүү байгууллага нь нийгэмд ашиг тустай үйл ажиллагаа явуулж байна гэсэн үг."

Дээрх ойлголтыг тодруулбал, нийтэд ашигтай үйл ажиллагаа нь дараах зорилгод чиглэгдсэн байдаг байна:

- Шинжлэх ухаан, судалгааг дэмжих;
- Боловсрол, хүмүүжлийг дэмжих;
- Соёл, урлагийг дэмжих;
- Үндэстэн, улс орнуудын харилцан ойлголцлыг дэмжих;
- Байгаль, ландшафт, дурсгалт хөшөөг дэмжин, хамгаалах;
- Эх оронч үзэл бодлыг суулган, хөгжүүлэхийг дэмжих;
- Ан, амьтны санг хамгаалахыг дэмжих;
- Хөгжлийн хамтын ажиллагааг дэмжин, хэрэгжүүлэх.

Харьцуулахад, Швейцарын хууль тогтоомжийн дагуу аливаа байгууллага буюу хуулийн этгээдийн үйл ажиллагааг нийгэмд ашиг тустай гэж тодорхойлохын тулд дараах шалгуурыг удирдлага болгодог байна:

- Олон нийтийн зүгээс үйл ажиллагааг ашиг тустай гэж хүлээн зөвшөөрсөн байх;
- Байгууллагын үйл ажиллагаа нь олон нийтийн ашиг тусын тулд ихээхэн хэмжээний хувь нэмэр оруулж буй;
- Байгууллагын гишүүд нь хувь хүний хувьд болон санхүүгийн хувьд золиос болж байх[549].

ХБНГУ-ын зохицуулалттай харьцуулбал, Швейцарын баримталж буй шалгуур нь нийгэмд ашиг тустай үйл ажиллагааны чиглэл, салбарыг нэг

[547] ХЗДХЯ-аас баталсан удирдамж, төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн болно.
[548] ХБНГУ-ын татварын тухай хуулийн 52-р зүйл, Австри улсын татварын тухай хууль.
[549] www.de.wikipedia.org.

бүрчлэн, эсхүл жишээ болгон дурьдах аргаар бус, харин олон нийтийн үзэл бодлоос шууд хамааруулж буй онцлогтой байна.

Нийгэмд тустай үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллагын /цаашид ТББ гэх/ жишээг дурьдвал, Ядуу болон буурай хүмүүст эмнэлгийн туслалцаа үзүүлэх эмч нарын холбоо, "Эмнести интернэшнл", "Грийнпис" зэрэг байх бөгөөд эдгээр нь хүний эрхийг хамгаалах, эрүүл мэндийг хамгаалах, байгаль орчныг хамгаалах, ядуурлыг бууруулах зэрэг зорилгыг удирдлага болгож буй нь тодорхой.

Дээр дурьдсан шинж буюу шалгуураас гадна аль ч улсын хувьд хүлээн зөвшөөрөгддөг өөр нэгэн шалгуур бол нийгэмд ашиг тустай үйл ажиллагаанаас байгууллагад орж буй орлого нь туйлын бага хэмжээтэй байх эсхүл орлого нь мөн чанарын хувьд нийгэмд тустай үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгод чиглэгдсэн байх явдал байна.[550] Улмаар нийгэмд ашиг тустай үйл ажиллагаа эрхлэн явуулж буй байгууллагын үйл ажиллагаанаас олж буй ашиг нь хувь этгээдүүдэд хуваарилагдах, тараагдах ёсгүй бөгөөд тухайн байгууллага татан буугдах тохиолдолд үлдсэн хөрөнгө нь нийгэмд тустай үйл ажиллагаа эрхэлдэг өөр нэгэн этгээд буюу хүлээн авагчид шилждэг онцлогтой. [551]

Улмаар, байгууллагын эрхэлж буй үйл ажиллагааг зорилгынх нь дагуу нийгэмд тустай гэж ангилахаас гадна, татварын шалгуураар буюу олж буй орлогын хэмжээ болон ашиг, орлого нь нийгэмд тустай үйл ажиллагаанд зарцуулагдаж буй шинж чанараар ангилдаг байна.

Харин Монголын судлаачдын үзэл бодлын дагуу, тухайлбал, академич Ж.Амарсанаагийн тодорхойлсоноор, "...олон нийтийг хамарсан үйл ажиллагааг нийтэд тустай үйл ажиллагаа болно. Энэрлийн буюу буяны үйл ажиллагаа явуулах нь уг байгууллагын гол зорилго болсон, үүнийгээ дүрмийнхээ зорилгодоо тусгасан байгууллагыг нийгэмд үйлчилдэг байгууллага гэж тодорхойлдог".[552]

Улс орнуудын хууль тогтоомж болон судлаачдын үзэл бодол, судалгааны үр дүнгүүдээс нийгэмд ашиг тустай үйл ажиллагааг тодорхойлох шалгуур, хэмжүүрүүдийн жишээ олныг дурьдаж болох боловч, нийгэмд ашиг тустай үйл ажиллагаанд хамаарах төрлүүдийг нэг бүрчлэн тодорхойлж, дурьдах нь боломжгүй юм. Учир нь, энэ ойлголт нийгэм гэх ойлголттой холбоотой бөгөөд нийгмийг бүрдүүлж буй олон тооны, өөр өөр ашиг сонирхолтой хүмүүсийн хамтран амьдрал, коммуникациас шалтгаалан нийгэмд ашиг тустай үйл ажиллагааны талаарх ойлголт тесөөлөл нь ялгаатай байх нь маргаангүй. Учир нь нийгэм гэдэг нь төр гэдэгтэй адил тогтсон нэг тодорхойлолтгүй, олон талт харилцааг илэрхийлж байдаг. Харин нийгмийг аль нэг харилцаа эсхүл, дэд тогтолцоогоор нь дамжуулж тодорхойлдог.

ТББ-тай холбоотой харилцаанд нийгэм гэдэг нь иргэд нь эрх, эрх чөлөө, үзэл бодлын хувьд чөлөөтэй эвлэлдэн нэгдэж, эдийн засаг, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах боломж бүрдсэн орчин юм. Харин ашиг тустай

[550] ХБНГУ-ын Татварын тухай хуулийн 52-р зүйл.
[551] www.de.wikipedia.org.
[552] Амарсанаа Ж./2001/ Эвлэлдэн нэгдэх эрх: *Төрийн бус байгууллагын стандарт /гарын авлага/* Уб:, 48.

үйл ажиллагаа гэдэгт ТББ-аас явуулж буй үйл ажиллагаа нь тодорхой бүлэг хүмүүсийн эрх ашигт бус, олон нийтэд чиглэгдсэн байхыг ойлгодог.

Түүнчлэн эдийн засгийн хөгжил өндөртэй орнуудад ТББ-д нийгэмд тустай үйл ажиллагаа гэх ойлголтыг даяарчлалтай холбон хамтын ажиллагаа, хөгжлийн зорилгын хүрээнд авч үзэх хандлага улам нэмэгдэж байна.

Иймд, нийгэмд ашиг тустай үйл ажиллагаа гэж юуг ойлгох талаар ерөнхий нэг ойлголт, тодорхойлолт өгөн, тодорхой байгууллагын хувьд үйл ажиллагаа нь нийгэмд ашиг тустай гэж ангилагдах талаар тухай бүрд нь тайлбарлан тодорхойлох нь оновчтой юм. Энэ нь "нийгэмд тустай үйл ажиллагаа" гэх өргөн хүрээтэй ойлголтын агуулгыг дэлгэрэнгүй тайлбар хийх аргаар тухай бүрт тодорхойлох, хүрээг нь өргөжүүлэх эсхүл хумих боломжийг нээлттэй орхиж байгаа онцлогтой. Холбогдох хуульд нийгэмд ашигтай үйл ажиллагаа хамрагдах салбаруудыг буюу зорилгыг жишээ болгон хуульчлах нь оновчтой.

Нийгэмд ашиг тустай үйл ажиллагаа явуулдаг ТББ-ын шинжийг агуулж байгаа боловч тусдаа бие даасан эрх зүйн зохицуулалт шаарддаг харилцаа бий. Энэ талаар 1997 оны "Төрийн бус байгууллагын тухай" хуулийн 3 дугаар зүйлд "энэ хууль нам, үйлдвэрчний эвлэл, сүм хийдээс бусад төрийн бус байгууллагад хамаарна" гэж ялгамжтай заасан байдаг /энд Улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлыг нэмж тусгах нь зүйтэй болов уу/. Үүнтэй адил зохицуулалт ОХУ-ын "Ашгийн бус байгууллагын тухай" хуульд тусгасан байдаг бөгөөд уг хуулийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "энэ хууль нь хэрэглэгчдийн нийгэмлэг, сууц өмчлөгчдийн холбоонд үйлчлэхгүй гэсэн бол, 4 дэх хэсэгт "энэ хуулийн 13-19, 21-23, 28-30 дугаар зүйлийн зохицуулалт шашны байгууллагад үйлчлэхгүй" гэж тус тус заасан байдаг.

ТӨРӨӨС ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

Ардчилсан нийгэмд ТББ нь иргэний нийгэм гэсэн ойлголттой салшгүй холбоотой бөгөөд уг ойлголтод багтаж байдаг. Тийм учраас судалгааны тайлангийн энэ хэсэгт ТББ-ыг иргэний нийгэмээр төлөөлүүлэн авч үзсэн.

Иргэний нийгмийн төлөвшил хөгжил бол эрх зүйт төрийг тогтоох гол үндэс, зайлшгүй нөхцөл[553]. Тийм ч учраас Монгол улсын Үндсэн хуульд "Эх орондоо хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно"[554] гэж тодорхойлсон. Энэ нь нийгмийн төвд хүнийг, төрийн бодлогын цөмд иргэнийг тавьж, иргэний аж байдал, эрх ашиг, сонирхол, хүсэл зоригийг бүхнээс дээгүүр үзэх зарчмыг бодитойгоор хэрэгжүүлнэ гэсэн хэрэг билээ.[555]

Хүний эрхийн талаарх ОУ-ын эрх зүйн баримт бичиг, дотоодын хууль тогтоомжид заасан эрхийг баталгаатай эдлүүлэх, баталгаатай эдлэх бүхий л орчныг бүрдүүлэх нь ардчилсан төрийн үүрэг байдаг. Үүний нэг илрэл нь

[553] Лүндэндорж Н. *Төрийн онол.* 2005 он. УБ. Адмон хэвлэлийн газар, 233 дахь тал.
[554] Монгол Улсын Үндсэн хууль, Оршил хэсэг.
[555] Чимэг Н. Нар. 2008 он. Иргэний нийгэм төлөвшиж буй нь III Б.Даш-Ёндон /ред./ Монголын нийгмийн өөрчлөлт УБ: МУШУА, ФСЭХ, 281 дэх тал.

Иргэний нийгмийг хөгжүүлэх, түүнийг бүрдүүлэгч ТББ-ын хөгжлийг дэмжих явдал юм.

Орчин үед ардчиллын чанарын шалгуур агуулгын хувьд засаг төрийг иргэд хараат бие даасан байдлаар хянах, үнэлж дүгнэх эрх гэсэн үзүүлэлтийг багтааж байна.[556] Нөгөө талаас ОУ-ын хэмжээнд ардчиллын хөгжлийг иргэний нийгмийн хөгжлийн түвшингээр нь шалгуур болгон улс орнуудыг ангилах хандлага байдаг. Өөрөөр хэлбэл, хувь хүний эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хэрхэн баталгаажуулж, уг эрхээ эдлэх боломжийг хэрхэн хангасан байдлаар нь улс орны ардчиллыг тодорхойлдог.

Манай Улсын хувьд Үндсэн хуульдаа иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэхээр тодорхойлж, хүний эрхийн талаарх ОУ-ын баримт бичгүүдийг хүлээн зөвшөөрсөн тул мөн л иргэний нийгмийн бүрэлдэхүүн болсон ТББ-ыг хөгжүүлэх үүргийг хүлээж байдаг. Ийнхүү хүлээсэн үүргээ сайтар биелүүлэх нь ОУ-ын түвшинд улс орны нэр хүнд өсөх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх эрх авах, ОУ-ын байгууллагын зүгээс тусламж, дэмжлэг авах маш чухал ач холбогдолтой байдаг.

ТББ-ыг төрөөс дэмжих үндсэн 2 хэлбэр байдаг.

• Бодлогоор дэмжих /Татвар хураамжаас чөлөөлөх, хөнгөлөлт үзүүлэх, зорилгодоо нийцсэн, хуулиар хориглоогүй аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх/

• Төрийн гүйцэтгэх чиг үүргийн зарим хэсгийг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх замаар ТББ-д санхүүгийн дэмжлэг үзүүлэх

Төрийн бус байгууллагыг төрийн зүгээс бодлогоор дэмжих гэдэг нь: Төрийн бус байгууллага нь үйл ажиллагаагаа явуулахын тулд тодорхой орлоготой байх ёстой[557]. ОХУ[558] болон Бүгд Найрамдах Узбекистан Улсын "Төрийн бус байгууллагын тухай"[559;560] хуулиар төрийн бус байгууллага нь зорилгодоо нийцсэн аж ахуйн үйл ажиллагаа явуулж болохоор заасан байдаг. Манай Улсын хувьд ч "Төрийн бус байгууллагын тухай" хуульдаа дүрмийн зорилго хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн байдаг.[561]

Харин ТББ-ын олсон орлогод татвар ноогдуулах нь маргаантай асуудал байдаг. Хэрэв ТББ нь зөвхөн үндсэн үйл ажиллагаагаа явуулдаг бол татвар, хураамжаас чөлөөлөгдөх эрхтэй. Гэхдээ энэ нь татвар, хураамжаас бүрэн чөлөөлөгдөнө гэсэн утгыг агуулахгүй.[562] Зорилгодоо нийцсэн үйл ажиллагаа

[556] Дурдсан бүтээл, 240 дэх тал.

[557] Савченко П. 1999 он. *Статус некоммерческих организаций* //Экономист, 87 дахь тал.

[558] ОХУ-ын "Төрийн бус байгууллагын тухай" хуулийн 24 дүгээр зүйл, 2 дахь хэсэг.

[559]ОХУ-ын хувьд уг хууль нь "О некоммерчиских организациях" /ашгийн бус байгууллагын тухай/, БНУзбекистан Улсад "О негосударственных некоммерчиских организациях" /ашгийн бус төрийн бус байгууллага/ гэж тус тус орчуулагдаж боловч агуулгын хувьд Төрийн бус байгууллагатай холбоотой харилцааг зохицуулж байгаа тул "Төрийн бус байгууллагын тухай" гэж орчуулсан болно.

[560] БНУзбекистан улсын "Төрийн бус байгууллагын тухай" хуулийн 31 дүгээр зүйл.

[561] "Төрийн бус байгууллагын тухай" хууль, 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг.

[562]Суворов А.В /2000,№20/"*О налогообложении некоммерчиских организации*"// Бухгалтерский учет, 22-23.

явуулахад дэмжлэг болох зорилгоор аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг бол түүнээс олсон орлогоосоо татвар төлөх үүрэг хүлээнэ. Жишээ нь, өрх толгойлсон эмэгтэйчүүдийн орлогыг сайжруулах зорилгоор үйлдвэрлэл эрхлэх тохиолдолд орлогын албан татвар төлнө. Энэ тохиолдолд татварын хувь хэмжээг ТББ-д ялгавартай тогтоох нь бодлогоор дэмжих нэг хэлбэр болдог бөгөөд Татварын дараах цэвэр ашиг нь тухайн ТББ-ын үндсэн үйл ажиллагаанд зориулагдана. Түүнчлэн ТББ нь хуулийн этгээдийн хувьдаа өөрийн эд хөрөнгө, эрхтэй байж болдог тул тэдгээрээс олсон ашгаас мөн л татвар төлнө. Жишээ нь үнэт цаасны ногдол ашиг, үл хөдлөх хөрөнгө түрээслэсэн, борлуулснаас олсон орлогод татвар ногдуулах гэх мэт.

ОХУ-ын хувьд төрийн болон орон нутгийн удирдах байгууллага нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд татвар, хураамжийн хөнгөлөлтийг ТББ-д үзүүлэх эрхтэй байдаг[563]. Үүнийг төрийн болон орон нутгийн өмч хөрөнгийг ТББ түрээслэж, ашиглаж байгаа тохиолдолд төлбөр, хураамжаас бүрэн болон хэсэгчлэн чөлөөлөх гэсэн утгаар тайлбарлажээ.

Гишүүддээ үйлчилдэг ТББ-ын тухайд үндсэн үйл ажиллагаа нь зөвхөн гишүүдийн татвараас санхүүжих тохиолдолд орлогын албан татварын тухай яригдахгүй. Учир нь гишүүдийн татвар нь аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлогод хамаардаггүй. Нөгөө талаас гишүүдийн татварын мөнгө нь татварын дараах орлого гэж үздэг тул ТББ нь татварын харилцаанд гишүүдийн өмнөөс аливаа татвар төлөх үүрэг хүлээхгүй.

Дээрх байдлаас харахад төрөөс ТББ-ыг бодлогын хүрээнд татвар, хураамжийн хөнгөлөлт эдлүүлэх хэлбэрээр дэмждэг болох нь харагдаж байна.

Гэрээний үндсэн дээр ТББ-д төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх: Монгол Улсын засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлд 1 дэх хэсэгт "Засгийн газар нь төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг холбогдох хууль, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн санхүүжүүлж болно" гэж заасан байдаг. Энэ ч үүднээс "Төрийн бус байгууллагын тухай" хуулийн 9 дүгээр зүйлд энэ талаарх зохицуулалтыг мөн адил тусгажээ. Тэгвэл энэ талаар ОХУ-ын "Төрийн бус байгууллагын тухай" хуульд "Төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд ТББ-д эдийн засгийн дэмжлэг үзүүлж болно"[564] гэзд "төрийн болон орон нутгийн удирдах байгууллага нь нийгмийн захиалгат ажлыг "Төрийн болон орон нутгийн хэрэгцээнд бараа худалдан авах, ажил гүйцэтгүүлэх, үйлчилгээ үзүүлэх тухай" хуульд нийцүүлэн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно" гэж мөн заажээ.

Дүгнэлт

Нийгэмд ашиг тустай үйл ажиллагааны чиглэл гэдгийг шууд тодорхойлох нь нэлээд төвөгтэй асуудал бөгөөд ийм үйл ажиллагаа явуулснаар хуульд

[563] "Төрийн бус байгууллагын тухай" Холбооны хууль, 31 дүгээр зүйл, 1 дэх хэсэг.
[564] "Төрийн бус байгууллагын тухай" Холбооны хууль, 31 дүгээр зүйл, 1 дэх хэсэг.

болон практикт ямар эрх зүйн үр дагавар үүсгэж байгаа нь тодорхой бус тул шууд дүгнэн хэлэхэд хэцүү юм. Нөгөө талаас ТББ-ын үйл ажиллагааг төрөөс дэмжлэг үзүүлбэл зохих байдлаар төрөлжүүлэх нь хэт өрөөсгөл . ОХУ болон Узбекистан улсын хуулийг харж байхад ашгийн бус байгууллагууд нь хууль тогтоомжоор хориглоогүй л бол хэдэн ч төрлийн үйл ажиллагаа явуулж болохоор заасан байдаг байна. Өөрөөр хэлбэл, гишүүддээ үйлчлэх, нийгэмд үйлчлэх давхар эрх зүйн байдалтай байж болдог. Энэ тохиолдолд нийгэмд үйлчлэх зорилгод нь тохируулан төрөөс дэмжлэг үзүүлэх нь төвөгтэй байна гэсэн үг

Төрөөс үзүүлэх дэмжлэгийг үндсэнд нь хуулиар болон гэрээгээр үйл ажиллагааг нь дэмжих гэж 2 ангилж болохоор байна.

Хуулиар дэмжих нь дараах үндсэн 3 хэлбэртэй гэж дүгнэж болохоор байна.

• ТББ-ыг зорилгодоо нийцсэн аж ахуйн үйл ажиллагаа явуулах боломжийг эрх зүйн хувьд нээлттэй болгох. Харин энэ нь ТББ-ын үндсэн зорилго болохгүй бөгөөд зорилгоо хэрэгжүүлэх эдийн засгийн хэрэглүүр байх ёстой. Үүнтэй уялдуулан ашиг хуваарилахыг хязгаарлах нь зүйтэй болов уу.

• ТББ нь ашгийн бус байгууллага болох хувьдаа бусад аж ахуйн нэгж, хувийн эрх зүйн хуулийн этгээдээс ялгамжтай /хөнгөлттэй/ байдлаар татвар төлөх, татвараас чөлөөлөгддөг байхаар хуулиар зохицуулах.

• Тусгайлсан хууль гаргах замаар ТББ-ын эрх зүйн байдлыг тодорхойлж, зохицуулах. Жишээ нь, "Өмгөөллийн тухай хуульд өмгөөлөгчдийн холбоо нь төрийн эвээл дор оршино гэж хуульчилсан. Мөн Шинжлэх ухааны академи төрийн ивээлд байхыг хуульчилсан байдаг[565]. Мөн энд энэрэл буяны зорилготой МУЗН-ийн тухай болон Төр, сүм хийдийн харилцааны талаар дурдаж болно.

Гэрээний үндсэн дээр үйл ажиллагааг нь дэмжих нь дараах 2 хэлбэртэй байна.

• Төрийн байгууллагаас уралдаант шалгаруулалт зарлан ТББ-аар ажил гүйцэтгүүлж, санхүүжүүлэн дэмжих

• Гэрээний үндсэн дээр төрийн өмчийг ТББ-д үнэ төлбөргүй түрээслүүлэх ашиглуулах. Жишээ нь, Монголын үндэсний олимпийн хороо нь мэргэжлийн холбоодод байраа үнэ төлбөргүй ашиглуулах, аж ахуйн нэгжийн ТББ-д түрээслэж буй эд хөрөнгөд татвар ногдуулахгүй байх гэх мэт.

Гэхдээ энд нэг зүйлийг анхаарах хэрэгтэй. "Төрийн бус байгууллагын тухай" хуулийн 4 дүгээр зүйлийн зохицуулалтын дагуу эрх зүйн харилцаанд төрийг төлөөлж байгаа байгууллага ТББ байгуулах, түүнд гишүүнээр элсэхийг хориглосон байдаг тул төрийн байгууллагууд нь ТББ байгуулан түүнийг аливаа хэлбэрээр дэмжих нь эрх зүйт төрийн зарчимд харшлах нь ойлгомжтой юм. Учир нь ТББ байгууллага нь Иргэний нийгмийн нэг илрэл бөгөөд түүнийг бүрдүүлэгч эд эс юм. Иргэний нийгэм, төр нэгдэлтэй оршихын хамт харилцан бие биеэ хянаж, тэнцвэржиж байдаг нийгмийн жам ёсны

[565] Ж.Амарсанаа. Эвлэлдэн нэгдэх эрх. 2001 он. *Төрийн бус байгууллагын стандарт /гарын авлага/* Уб., 89 дэх тал.

2 хүч мөн.[566] Тийм учраас төрд тавих хяналтыг төр өөрөө ТББ байгуулан тавьж болохгүй гэсэн санаа юм. Эдгээр хүч тэнцвэртэй нөхцөлд хувийн болон нийтлэг ашиг сонирхол зөв хосолж, нийгэм хөгжих хэвийн нөхцөл бүрдэнэ.[567] Нөгөө талаас төрд алба хаах нь хувь хүний зарим эрхээсээ сайн дураар татгалзах явдал гэх үзэл сургаалууд ч байдаг билээ. Өөрөөр хэлбэл, Монголын шүүгч нарын холбоо, прокуроруудын холбоо, мэргэжлийн хяналтын байцаагч нарын холбоо гэж байгуулж болохгүй гэсэн санаа юм.

Хоёр. ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ

ТББ-ыг тэр дундаа нийгэмд ашиг тустай үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагад төрөөс болоод эрх бүхий байгууллагаас санхүүгийн дэмжлэг үзүүлэх, татвараас хөнгөлөх, чөлөөлөх гэх мэт дэмжлэгийг үзүүлдэг. Ингэж хөнгөлөлт үзүүлж, тусламж, дэмжлэг олгохдоо нийгэмд бодитой ашиг тустай стандартад нийцсэн үйл ажиллагаа явуулж байгаа эсэхийг магадлан итгэмжлэх замаар тодорхойлж гэрчилгээ олгодог практик дэлхийн орнуудад нэгэнт тогтсон байна.

ТББ сайн дурын үндсэн дээр байгуулагддагийн хувьд түүний хүлээх хариуцлагын асуудал маргаантай, шийдэл нэхсэн асуудал байсаар ирсэн. Сүүлийн 10-15 жилд төрийн бус байгууллагын хариуцлагыг тодорхой болгохын тулд магадлан итгэмжлэх тогтолцоог бий болгох зайлшгүй шаардлага бий болсон.

Магадлан итгэмжлэх гэдэг процессын үйл ажиллагааг "Магадлан итгэмжлэх гэдэг нь байгууллагын үйл ажиллагааны хүчин чадал, нөөц болоцоог буюу явуулж буй үйл ажиллагаа нь шаардлага хангасан, чанартай үйлчилгээ явуулдаг болохыг албан ёсоор гэрчилж, түүний үйлчилгээнд нийт олон итгэж болохыг баталгаажуулж буй үйл ажиллагаа юм[568]" гэж тодорхойлсныг Энэтхэгийн төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх байгууллын web-хуудсан дээрээс үзэж болно.

Тэгвэл ТББ-ыг магадлан итгэмжлэх гэдэг нь төрийн бус, нийгэмд үйлчилдэг буюу нийгэмд ашиг тустай үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагын дүрэмд заасан зорилго, зорилттой байгууллагын явуулж буй үйл ажиллагаа нийцэж буй эсэх, тодорхой бодитой үр дүн гарч буй эсэх, магадлан итгэмжлэлийн шаардлага шалгуурыг хангаж буй эсэхэд эрх бүхий байгууллагаас хяналт шалгалт хийж үнэлгээ дүгнэлт өгөх замаар магадлан итгэмжлэх, цаашлаад энэхүү байгууллага олны итгэж болох байгууллага болохыг баталж буй үйл ажиллагаа гэж тодорхойлж болохоор байна.

Төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх дараах тогтолцоонууд байдаг. Үүнд:

1.Төрийн оролцоотой магадлан итгэмжлэл: Төрийн оролцоотой магадлан итгэмжлэл гэдэг нь төрийн оролцоотой буюу засгийн газраас

[565] Лүндэндорж Н. Төрийн онол. Уб., 2005 он. 111 дэх тал.

[567] Мөн тэнд.

[568]http://www.credall.org.in/ourprogrammes/accreditation.htm /хамгийн сүүлд 2011 оны 3 дугаар сарын 23-нд үзсэн/,

байгуулагдсан, эсвэл засгийн газраас эрх олгогдсон зөвлөл буюу байгууллага магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааг хариуцан эрхэлж явуулдаг хэлбэр юм. Энэхүү тогтолцоо нь төрөөс буюу засгийн газраас байгуулагдсан эсвэл засгийн газраас эрх олгогдсон байгууллага магадлан итгэмжлэлийг хийж байгаа гэдэг утгаараа магадлан итгэмжлэлийн зардал бага байх боломжтой мэт боловч олон улсын хэмжээнд энэхүү магадлан итгэмжлэх тогтолцоог зардал ихтэй магадлан итгэмжлэх хэлбэрт тооцдог. Ийнхүү магадлан итгэмжлэгдсэнээр хүмүүсийн болоод олон улсын байгуулагуудын итгэлийг хүлээх магадлал өндөртэй байдаг. Түүгээр ч зогсохгүй төрөөс санхүүгийн дэмжлэг авах, татварын хөнгөлөлт чөлөөлөлт эдлэх боломжтой болдог. Төрөөс буюу засгийн газраас байгуулагдсан эсвэл эрх олгогдсон байгууллага магадлан итгэмжлэлийг эрхлэн гүйцэтгэдэг тогтолцоотой улсуудын жишээг авч үзье.

Австрали

Австрали улсын хувьд Австралийн Олон улсын Хөгжлийн Агентлаг /AusAid/ буюу засгийн газрын агентлаг төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэдгээрээ онцлогтой. Австралийн Олон улсын Хөгжлийн Агентлаг/AusAid/–ийн төрийн бус байгууллагуудыг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлт гэж байдаг. Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу шаардлага, шалгуурыг хангасан буюу мэргэжлийн, зохион байгуулалт сайтай, нийгэмд суурилсан төрийн бус байгууллагууд төрийн зүгээс санхүүжилт болоод дэмжлэг туслалцаа авах бололцоотой болдог байна. Магадлан итгэмжлэлийн *үндсэн магадлан итгэмжлэл* буюу *бүрэн магадлан итгэмжлэл* гэсэн 2 хэлбэрийн магадлан итгэмжлэл байдаг байна. Төрийн бус байгууллагын санхүүжилт авах боломж нь ямар хэлбэрийн магадлан итгэмжлэл авсанаас хамаардаг бөгөөд үндсэн магадлан итгэмжлэлийг авсан төрийн бус байгууллага Австралийн Олон улсын Хөгжлийн Агентлаг/AusAid/–ийн төрийн бус байгууллагын хамтын ажиллагааны хөтөлбөрийн дагуу жилд дээд тал нь 100.000 хүртэлх ам.долларын санхүүжилт авах боломжтой байдаг бол бүрэн магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагад ямар нэгэн хязгаарлалт байдаггүй.

Австралийн төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх үйл явц нь:

1-байгууллагын шалгалт;

2-Санхүүгийн тогтолцооны дүн шинжилгээ гэсэн 2 үе шаттай явагддаг.

Байгууллагад шалгалт хийгдэх үед байгууллагын удирдлагын зохион байгуулах чадвар, байгууллагын тогтолцоо, үйл ажиллагаа, Австралийн нийгэмтэй хэрхэн холбогдон ажиллаж байна гэдгийг хянан шалгадаг. Үндсэн магадлан итгэмжлэлийг авах төрийн бус байгууллагын хувьд тухайн байгууллагын Австралид явуулж буй үйл ажиллагаа, дотоод бүтэц зэрэгтэй танилцдаг бол бүрэн магадлан итгэмжлэгдэх гэж буй байгууллагын хувьд тэдний дотоод дахь үйл ажиллагааг хянаж шалгахаас гадна гадаадад явуулж буй үйл ажиллагааг мөн давхар судалж шалгадаг байна. Энэхүү шалгалтыг Австралийн Олон улсын Хөгжлийн Агентлагийн болоод төрийн бус байгууллагын хамтарсан баг, мөн Хөгжлийн хамтын ажиллагааны

зөвлөлийн /CDC/ зөвлөх нэг гишүүн болоод санхүүгийн үнэлгээчний оролцоотой нэгдсэн бүрэлдэхүүнтэйгээр хийдэг. Төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх үйл ажиллагаа нь төрийн бус байгууллага магадлан итгэмжлэх шаардлага буюу шалгуур/criteria/-ыг хангасан гэдгийг нотлох бичиг баримтыг хянуулахаар илгээснээр эхэлдэг байна.

Материалаа илгээсэн ТББ-ын материалтай танилцаад төрийн бус байгууллага шаардлага, шалгуурыг хангаж байна уу гэдгийг бичиг баримтын түвшинд шалгасны дараа шалгуурыг хангаж байгаа тохиолдолд төрийн бус байгууллагад байгууллагын Австрали доторх үйл ажиллагаанд хийх шалгалтыг эхлүүлдэг бөгөөд шалгуурыг хангаагүй байгууллагын хувьд шаардлага хангаагүй тухай мэдэгдсэн захидлыг илгээдэг байна. Төрийн бус байгууллага нь байгууллагын үйл ажиллагааны шалгалтаар үндсэн магадлан итгэмжлэлийн шаардлагыг хангаж байгаа нь батлагдсан тохиолдолд бүрэн магадлан итгэмжлэх ажиллагааны шатанд орохын тулд төрийн бус байгууллага гадаад оронд явуулж буй үйл ажиллагаа нь шалгуурт мөн нийцсэн гэдгийг батлах ёстой болдог. Ингэснээр шалгалтын баг Хөгжлийн хамтын ажиллагааны зөвлөл /CDC/-д явуулах төрийн бус байгууллагын шалгуурыг хэрхэн хангаж байгаа талаар мэдээллийг бэлтгэж явуулдаг. Хөгжлийн хамтын ажиллагааны зөвлөл бичиг баримттай танилцсаны дараа Австралийн Олон улсын Хөгжлийн Агентлаг /AusAid/–н төлөөлөгч болох эцсийн шийдвэрийг гаргах хүнд төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх эсэх талаар саналаа явуулдаг. Төрийн бус байгууллага магадлан итгэмжлэл авсан тохиолдолд Австралийн Олон улсын Хөгжлийн Агентлаг/AusAid/–тай Umbrella буюу шүхрийн гэрээ гэдгийг хийдэг. Бүрэн магадлан итгэмжлэгдсэн байгууллагууд санхүүжилтийн боломжоо эдлэхийн тулд 5 жил тутамд дахин магадлан итгэмжлэгдэх ёстой. Харин магадлан итгэмжлэлийн шаардлагыг хангаагүй байгууллагууд дахин магадлан итгэмжлүүлэхээр өргөдөл хүсэлт гаргахаар 2 жил хүлээх хэрэгтэй болдог. Үндсэн магадлан итгэмжлэлтэй байгууллага бүрэн магадлан итгэмжлэлийг авахын тулд мөн шийдвэр гарсанаас хойш 2 жил хүлээх шаардлагатай болдог бөгөөд 2 жилийн дараа бүрэн магадлан итгэмжлүүлэхээр өргөдлөө гаргах боломжтой болдог.

Пакистан

Пакистаны ашгийн төлөө бус байгууллагыг магадлан итгэмжлэх хөтөлбөрийн төв гэж байдаг. Энэхүү магадлан итгэмжлэх хөтөлбөр нь Филиппиний магадлан итгэмжлэх зөвлөлийн туршлага дээр үндэслэсэн бөгөөд засгийн газраас эрх олгогдсон магадлан итгэмжлэх албан ёсны байгууллага юм.

2002 оны Орлогын татварын актад орсон нэмэлт өөрчлөлтөөр магадлан итгэмжлэгдсэн гэрчилгээ нь татвараас чөлөөлөгдөх үндэс болдог заалт нэмж тусгагдсан. Магадлан итгэмжлэх үйл явц нь төрийн бус байгууллагын сайн засаглал, ил тод, шударга байдал болоод хөтөлбөрийн үр дүнтэй байдал зэрэгт мэргэжлийн үнэлгээ хийх замаар хийгддэг. Шалгалтын мэдээллийг иргэний нийгэм, бизнес болоод засгийн газрын төлөөлөл оролцсон бие

даасан этгээд болох магадлан итгэмжлэх мэргэжилтнүүдийн зөвлөлд танилцуулдаг бөгөөд тэд магадлан итгэмжлэх эсэхийг шийдэж магадлан итгэмжлэх боломжтой байгууллагад магадлан итгэмжилсэн гэрчилгээг олгох процессын дагуу Пакистаны магадлан итгэмжлэх үйл ажиллагаа явагддаг онцлогтой.

Филиппин

Филиппиний төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөл гэж байдаг. Энэхүү байгууллага нь ашгийн бус байгууллага бөгөөд төрийн бус байгууллага санхүүгийн удирдлага, дотоод засаглал болоод хариуцлагын хувьд тодорхой шалгуурыг хангасан эсэхийг тодорхойлоход үйл ажиллагаагаа чиглүүлдэг. Энэхүү байгууллагаар магадлан итгэмжлэгдсэн байгууллага татварын хөнгөлөлтөд хамрагддаг байна. Филиппиний засгийн газар энэхүү байгууллагыг байгуулахдаа үр бүтээлгүй, татвараас зайлсхийгчдийг ялган гаргах зорилготойгоор байгуулсан. Филиппиний төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн шалгах шалгуурын стандартад дараах чиглэлүүд ордог. Үүнд: зорилго, зорилт, засаглал, удирдлага, хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд, санхүүгийн менежмент, харилцаа холбоо гэх мэт. Магадлан итгэмжлэх, гэрчилгээг олгох үйл ажиллагаа төрийн бус байгууллага шалгалтын багт өргөдлөө өгсөнөөр эхлэх бөгөөд тус баг нь Филиппиний төрийн бус байгууллагын магадлан итгэмжлэх зөвлөлийн эцсийн шийдвэр гаргах захирлуудын зөвлөлд саналаа явуулж магадлан итгэмжлэх эсэхийг шийдвэрлүүлдэг байна.

Филиппиний төрийн бус байгууллагын магадлан итгэмжлэх зөвлөл 1998-2004 оны эхэн хүртэлх хугацаанд нийт 445 төрийн бус байгууллагыг магадлан итгэмжилсэн байна. Энд нэг шүүмжлүүштэй зүйл байгаа нь магадлан итгэмжилж буй байгууллагын ажиллах хурдны асуудал юм. Филиппинд ойролцоогоор 70.000 төрийн бус байгууллага байдаг ч зөвхөн магадлан итгэмжлэгдсэн эдгээр байгууллагууд л татварын хөнгөлөлт эдлэх боломжтой байгаа.

2.Өөрийгөө магадлан итгэмжлэх тогтолцоо: Өөрийгөө магадлан итгэмжлэх гэдэг нь процессын болоод санхүүгийн хувьд хялбар магадлан итгэмжлэх тогтолцоо юм. Энэхүү тогтолцооны дагуу магадлан итгэмжлэгдэх үйл явц нь төрийн бус байгууллагын үйл ажиллагаа тодорхой дүрэмд нийцсэн байх ёстой бөгөөд энэхүү дүрэмд үйл ажиллагаа нь нийцсэн гэдгээ баталсан, аудитаар хянагдсан тайлангаа төрийн бус байгууллага эрх бүхий зөвлөлд жил бүр явуулах үүрэгтэй байдаг байна. Өөрийгөө магадлан итгэмжлэдэг улсуудын жишээг авч үзье.

Канад

Олон улсын хамтын ажиллагааны Канадын зөвлөлийн ёс зүйн дүрэм гэж байдаг. Дүрэмд нийцсэн байдлыг өөрийгөө магадлан итгэмжлэх үйл ажиллагаагаар хангадаг бөгөөд өөрөөр хэлбэл, дүрмийн дагуу гишүүн байгууллагууд жил тутам өөрсдийн аудитаар хянагдсан санхүүгийн болоод үйл ажиллагааны тайлан, хуулийн дагуу хийгдсэн өөрчлөлтүүд болоод

тэд дүрэмд нийцсэн үйл ажиллагаа явуулж байгаагаа баталсан тайлангаа зөвлөлд явуулахыг шаарддаг.

Македон

Македоны нэгдсэн улсын хүүхдийн байгууллагуудын холбооны дүрэм гэж байдаг. Энэхүү дүрэм нь ардчилсан нийгэм дэх төрийн бус байгууллагын үүрэг оролцоо, сайн дурынхан болоод ажилчдын харьцаа, байгууллагын зорилго, зорилт, санхүүгийн үүрэг хариуцлага, итгэмжлэгдсэн мэдээлэл болоод сонирхлын зөрчил дэх стандартыг тогтоож өгдөг.

3.Нийтийн сангийн байгууллагаас магадлан итгэмжлэх тогтолцоо: Энэхүү үйл ажиллагааны онцлог нь төрийн бус байгуллага тодорхой сан буюу энэрлийн үйл ажиллагаа явуулдаг олон нийтийн байгуллагын төсөл, хөтөлбөрт хамтран оролцох, мөн санхүүжилт авахаар тухайн байгуллагын магадлан итгэмжлэх шаардлага шалгуурыг хангах замаар магадлан итгэмжлэгдэх процесс юм. Жишээ нь:

Франц

La Charte de deontologie. Франц дахь сан болоод холбоодын мэргэжлийн харилцааны энэхүү дүрмийн дагуу байгуулагдсан байгуллагуудын хороо нь байгуллагуудын үйл ажиллагаа дүрэмд нийцсэн эсэхийг хянадаг.

Герман

Германы нийгмийн асуудлаарх төвлөрсөн нийгэмлэг хэмээх энэхүү байгуллага нь "Хандивын баталгаа тэмдэг"-ийг хэрэглэдэг бөгөөд энэхүү баталгааг авсан байгуллага нь татвараас чөлөөлөгдөж болдог. Энэхүү баталгааг жил бүрийн тайланг шалгасны дараа шинэчилдэг журамтай бөгөөд баталгаагаг авсан байгуллагуудын нэрс жилд 2 удаа нийтэд хэвлэл мэдээллээр зарлагддаг журамтай.

Энэтхэг

Give India буюу Энэтхэгт хандивла хэмээх энэхүү байгуллага нь интернэтийн web- хуудас ажиллуулдаг бөгөөд web-хуудсаар хандивлагчид өөрсдийн сонголтоор тодорхой ашгийн төлөө бус байгуллагад хандив өргөдөг бөгөөд энэхүү хандивыг авахын тулд байгуллагууд "Энэтхэгт хандивла" хэмээх энэхүү байгуллагын тодорхой шалгуурыг хангасан байх ёстой байдаг. Байгуллага нь ашгийн төлөө бус байгуллага гэж бүртгэгдсэн байх бөгөөд ямар нэгэн улс төрийн үйл ажиллагаанд хамаарагддаггүй нийгмийн хөгжлийн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлдэг байх ёстой.

Гурав. МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтийн хувьд Австралийн AusAID-ийн боловсруулсан шалгуур үзүүлэлт USAID-ийн хувийн, сайн дурын байгуллагуудыг бүртгэх шалгуур үзүүлэлттэй адил олон шалгуур үзүүлэлтийг агуулдаг.[569]

[569] http:// pdf.usaid.gov/pdf docs/ PNADB766.pdf /хамгийн сүүлд 2011 оны 3 дугаар сарын 18-нд

Австралийн төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх шалгуур

Төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэхийн зорилго нь бүрэн магадлан итгэмжлэгдсэн агентлаг "дэлхий нийтийн хөтөлбөр" болоод бусад хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэх боломжтой болдог байна. Дэлхий нийтийн хөтөлбөр гэдэг нь хөтөлбөрийг гадаадын түншүүд болоод тэдгээрийн салбар байгууллагуудад хуваарилах замаар хамтран хөтөлбөрийг хэрэгжүүлэхийг хэлдэг.

Доорх шалгуур үзүүлэлтэд заасан ерөнхий үзүүлэлтүүд нь бүхий л төрийн бус байгууллагуудын байгууллагын бүтэц болоод хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллаганд хамаардаг.

Агентлагийн онцлог болоод бүтэц

1. Агентлаг нь сайн дурын, ашгийн төлөө бус, төрийн бус байна. Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу агентлагийн удирдлага болоод гишүүнчлэл нь агентлагийн эд хөрөнгөнөөс ашиг олдоггүй, агентлаг нь бүхэлдээ Засгийн газраас хараат бус байх ёстой. Энэхүү зарчим нь Агентлагийн үйл ажиллагааны дүрэмд бодитоор тусгагдсан байх ёстой байдаг.

2. Агентлаг нь үйл ажиллагаа нь төвлөрөг тодорхой хаягтай, дэмжигчид болоод гишүүдийн үүрэг, хариуцлагын бүтэц зохион байгуулалтыг тусгасан дүрэм, бичиг баримттай хуулийн этгээд байх ёстой. Энэхүү шалгуур үзүүлэлт нь төрийн бус байгууллагын эрх зүйн бүтэц бүрэлдэхүүнийг тодорхой байлгах зорилготой бөгөөд удирдлагын үйл ажиллагааны бүтэц, хариуцлагын асуудлыг тодорхой болгох зорилготой. Байгууллагын удирдлага сонгогдох, томилогдох үйл ажиллагаа ил тод байх бөгөөд агентлаг хариуцлагын шударга тогтолцоотой байх ёстой.

3. Агентлаг нь Австралийн Олон Улсын Хөгжлийн Зөвлөлийн /ACFID/ Төрийн бус байгууллагын хөгжлийн байгууллагын харилцааны дүрэм /Code of Conduct for Non-Government Development/-д дүрмээ нийцүүлсэн эсвэл дээрх дүрмийг авч хэрэглэсэн байх ёстой. Энэхүү шалгуур нь агентлаг нь сайн практик болоод тухайн салбарын дүрэм журамтай нийцсэн үйл ажиллагаа явуулж байгаа гэдгийг нь тодорхой болгоход чиглэгддэг.

Хөгжлийн философи болоод үйл ажиллагааны менежмент

1.Агентлаг нь ядуурлыг бууруулах болоод тогтвортой хөгжлийн "Австралийн тусламж хөтөлбөр"-ийн зорилгод нийцсэн тусламжийн үйл ажиллагаа явуулахаа нотолсон бичиг баримттай байх ёстой. Энэхүү шалгууруар агентлаг хамгийн доод тал нь сүүлийн 2 жилд ямар нэгэн тодорхой үр дүнд хүрсэн хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байхыг шаарддаг. Агентлаг ядуурлыг бууруулах, тогтвортой хөгжлийг хангах Австралийн тусламжийн хөтөлбөрийн зорилтыг дэмжиж байгаагаа нотолж, үүнтэй адил зорилтыг өөрсдийн хөтөлбөрт тусгах ёстой.

2.Агентлаг Австралийн тусламжийн хөтөлбөрийн зорилтуудтай нийцэх хөгжлийн философитой байх ёстой. Энэхүү шалгуур нь агенлагийн хөгжлийн философи, үйл ажиллагааг тодорхой болгох зорилготой.

зочилсон/.

3.Австралийн агентлаг Австралийн тусламж /AusAID/–ийн өмнө гэрээгээр хүлээсэн үүрэгтэй нийцэх хөтөлбөрийг боловсруулах чадвартай байх ёстой. Энэхүү чадварын гол чухал зүйл нь хөтөлбөрийн бүхий л асуудлыг тодорхой гаргасан байх явдал байдаг.

I.Эрсдэлийн менежмент: Агентлаг төсөл хэрэгжих явц дахь бүхий л эрсдэлийг хянах ёстой. Үүнд:

а. Нийтийн сайн сайхныг дэмжсэн үйл ажиллагаанд зориулсан хөтөлбөрийн/төслийн үнэлгээ;

б. Австралийн Тусламжийн /AusAID/ терроризм, хүүхдийн хамгаалал болоод байгаль хамгаалалын талаарх зааварчилгаатай нийцсэн байх.

II.Шийдвэр гаргах үйл ажиллагаа: Агентлаг хөтөлбөрийн менежментийн хүрээнд шийдвэр гаргах эрх мэдэлтэй байх ёстой бөгөөд тохиромжтой үед нөлөөлөх, шийдвэр өөрчлөлт хийх эрхтэй байх ёстой. Энэхүү шалгуур нь Австралийн агентлагуудын хөтөлбөрийн туршид гүйцэтгэх үүрэг мөн хөгжлийн үйл ажиллагааны болоод эрсдэлийн хяналтын үнэлэмжийг нэмэгдүүлэхэд тохиромжтой нөлөөлөл болоод хяналтыг хэрэгжүүлж байгаа эсэхийг тодорхой болгоход чиглэгдэнэ.

4. Агентлаг үйл ажиллагааныхаа үр ашигтай байдлыг хэмжиж, хянаж тайлагнаж чаддаг байх. Энэхүү шалгуур үзүүлэлт нь Австралийн агентлагуудын болоод агентлагуудын хамтрагчид, тэдний үр дүнг үнэлэх үнэлгээний чадамж, хөгжлийн төлөөх үйл ажиллагааны нөлөөллийн хяналт, мэдээлэл, үнэлгээний тогтолцоог тодорхой болгоход чиглэгдэнэ.

5. Агентлаг менежмент болоод үйл ажиллагаагаа байнга сайжруулах тогтолцоотой байх. Энэхүү шалгуур үзүүлэлт нь агентлагийн байнгын үйл ажиллагаагаа сайжруулах, сургалт зохион байгуулах түүнийгээ менежмент болоод үйл ажиллагаандаа тусгах чадварыг тодорхойлоход оршино.

Түншлэл болоод хамтын ажиллагааг хөгжүүлэх чиг хандлага

1.Агентлаг болон үйл ажиллагаа явуулж буй улсын байгууллагуудтай түншлэлийн гэрээтэй ажиллах. Зөвхөн олон улсын агентлагуудтай хамтран ажиллаж буй нь энэхүү шалгуур үзүүлэлтийн шаардлагыг хангахгүй. Австралийн агентлагууд мэдээллийг тодорхой салбараас шууд авч өөрсдийн хяналтыг хийх, шаардлагатай үед төслийн үр дүнд нөлөөлөх чадвартай байх ёстой. Засгийн газрын газар, хэлтсүүд болоод олон улсын байгууллагуудтай түншлэх нь тэдний заавал хийх зүйл биш юм. Энэхүү шалгуур үзүүлэлт нь тухайн газар нутаг дахь төсөл болоод хөтөлбөр, түншлэлийг хянахдаа бичиг баримтжуулсан буюу гэрээжүүлсэн байхыг чухалчилдаг. Агентлаг нь гол гэрээ болох Австралийн тусламж /AusAID/-ийн гэрээнд нийцсэн, хэлбэржсэн бөгөөд түншлэгчдэд ойлгомжтой, тэднээр хүлээн зөвшөөрөгдсөн зохицуулалттай байхыг мөн чухалчилдаг.

2.Агентлаг өөрийн чадамж, энэхүү чадамжид нийцсэн түншлэгч байгууллагын хөтөлбөр, төслийг хүлээж авах, хэрэгжүүлэх боломжыг үнэлэх. Энэхүү шалгуур үзүүлэлт нь агентлагийг ямар нэгэн тодорхой чадамжийн хүрээнд түншлэлийг хязгаарлахыг зорьдоггүй. Энэхүү шалгуурын дагуу

агентлагийн төсөл болоод хөтөлбөр нь төлөвлөгдсөн, түүнийхээ дагуу хэрэгжсэн эсэх, шаардлагатай тохиолдолд чадамжийг бэхжүүлэх, өөрийн болоод түншлэгчийн чадамжийг үнэлэх системчлэгдсэн чиг хандлагыг авч хэрэгжүүлэх ёстой.

3.Агентлаг үйл ажиллагаагаа явуулж буй улсынхаа байгууллагуудтай хийсэн түншлэл, тэдгээрээс үр ашиг хүртэгчийн хоорондын харилцаа нь ашигтай бөгөөд сайн хөгжлийн практикт нийцсэн байх. Энэхүү шалгуур нь Австралийн агентлагууд, түншүүд болоод үр ашгийг нь хүртэгчдийн хоорондын харилцаа болоод түншлэлийн мөн чанар, хэв маягийг тодорхойлохыг зорьдог.

Австралийн нийгмийн бүлгүүдтэй харилцах хэлхээ холбоо

1.Авсралийн агентлаг Австралийн нийгмийн байгууллагатай харилцан үүрэг хүлээж дэмжин ажиллаж болно. Энэхүү шалгуур нь Австралийн агентлаг нийгэмдээ хэрхэн нөлөөлж, дэмжиж байна вэ гэдгийг тодорхой болгоход чиглэгдэнэ.

2.Агентлаг болоод тэдгээрийн түншүүд өөрсдийн байгууллага, үүрэг, үйл ажиллагааны талаарх үнэн зөв мэдээллийг нийгэмд хүргэнэ.

3. Агентлаг Австралийн нийгмийн байгууллагуудыг хөгжлийн хөтөлбөр, төслүүдээрээ санхүүгийн талаас сайн дураар дэмжиж ажиллана.

Санхүүгийн тогтолцоо болоод эрсдэлийн менежмент

1.Агентлаг санхүүжилт, нягтлан бодох бүртгэлийн тогтолцоо, удирдлага, менежменттэй байна. Энэхүү шалгуур нь санхүүжилт, нягтлан бодох бүртгэлийн зөв тогтолцоотой үйл ажиллагаа явуулдаг байх нөхцлийг бүрдүүлэхэд оршино.

2. Агентлаг болоод тэдний гадаад дахь түншүүд, тэдний олон улс дахь салбарууд нь мэргэжлийн шаардлага хангасан ялангуяа санхүүгийн үйл ажиллагааг явуулах чадвартай байх ёстой. Энэхүү шалгуур нь агентлаг өөрсдийн чадамж, түншүүд болоод салбаруудын санхүүгийн систем болоод чадамжийг хэрхэн тогтмол үнэлж дүгнэдэг болохыг тодорхойлоход чиглэгдэнэ.

3.Агентлаг зардлын хэм хэмжээнд тохирсон санхүүгийн эрсдэлийг удирдах, үнэлж дүгнэх тогтолцоотой байх. Үүнд түнш байгууллагуудаар дамжих зардалд хамаарах эрсдэлүүд хамаарна. Энэхүү шалгуур нь агентлаг болоод түншүүдгийн санхүүгийн эрсдэлийн менежментийн стратеги болоод санхүүгийн эрсдэлийн менежментийн практикт хэрхэн хэрэглэгдэж байгааг тодорхойлоход чиглэгдэнэ.

4. Агентлаг Австралийн хөгжлийн үйл ажиллагааг дэмжих нийгэмлэгт өгөх хандивийн хэмжээг нэмэгдүүлж болно /3 жилийн хугацаанд хамгийн доод тал нь 75000 Австрали доллар/. Энэхүү шалгуур нь агентлаг: нийгмийн хөгжлийн үйл ажиллагаа явуулж түүнээсээ мөнгөн сангаа нэмэгдүүлж чаддаг байх, сангуудаа хөгжлийн, шашны, сайн үйлсийн болоод намын бодлогын үйл ажиллагаанд зориулсан гэх мэтээр ангилдаг зэргийг тодруулахад чиглэгдэнэ.

5. Агентлаг Австралийн санг өсгөх болоод татварыг бууруулах зэрэгт хамаарах хуулийг биелүүлдэг байх. Энэхүү шалгуур нь агентлаг сайн санааны үйлст зориулах сан цуглуулах зорилгоор бүртгэгдсэн бөгөөд татварын хөнгөлөлт эдлэх эрхтэй гэж нийтэд зарлагдсан зэргийг тодорхой болгоход чиглэгдэнэ.

Нэмэлт шалгуур

1. Агентлаг нь гэр бүл төлөвлөлт болоод нөхөн үржихүйн асуудалтай холбоотой Засгийн газрын бодлогыг дэмжсэн бичиг баримтжуулсан бодлого төлөвлөгөөтэй байх.

2. Агентлаг төсөл хөтөлбөрийн бүхий л шатанд гэр бүл төлөвлөлтийн үйл ажиллагааны Засгийн газрын бодлогын үндэс болох гол зарчмуудыг гадаадад тусламжийн хөтөлбөр хэлбэрээр хэрэгжүүлж чадна гэдгээ нотолж болно.

3. Австралийн холбогдох бусад мэдээллийн бичиг баримтууд болоод тусламжийн үйл ажиллагааны зорилтуудад агентлаг засгийн газраас гаргасан гэр бүл төлөвлөлттэй холбогдох шаардлагыг хангасан байх ёстойг тусгасан байдаг.

2.2 Магадлан итгэмжлэх байгууллага

Магадлан итгэмжлэх байгууллагууд нь дээр дурьдсанчлан статус болоод байгуулагдах хэлбэрийн хувьд ялгаатай байдаг боловч явуулж буй үйл ажиллагааны хувьд нэг зорилготой байдаг. Өөрөөр хэлбэл магадлан итгэмжлэх эрх бүхий байгууллагууд гэдэг нь төрөөс буюу засгийн газраас, мөн засгийн газраас эрх олгогдсон, дүрмийн дагуу гэх мэтээр байгуулагдсан, эсвэл нийгмийн төлөөх үйл ажиллагаа явуулдаг, төрийн бус байгууллага байж болдог.

Эдгээр байгууллагуудын бүгдийг авч үзэх боломжгүй учир цугларсан материалын хүрээнд төрийн оролцоотойгоор магадлан итгэмжлэх хэлбэрийн магадлан итгэмжлэх байгууллагуудын статус, бүтэц зэргийг харьцуулан хүснэгтлэн авч үзье.

	Австралийн Олон улсын хөгжлийн Агентлаг /AusAID/	Филиппиний Төрийн бус байгууллагын магадлан итгэмжлэх зөвлөл	Пакистаны энэрэнгүй үйлсийн төв
Магадлан итгэмжлэх байгууллагын статус	AusAID буюу Австралийн олон улсын хөгжлийн агентлаг нь Австралийн тусламжийн хөтөлбөрийг удирдан зохион байгуулдаг Засгийн газрын агентлаг юм. Энэхүү агентлаг нь Австралийн Гадаад харилцаа, гадаад худалдааны Яаманд харьяалагдаж ажлаа тус яаманд хариуцан тайлагнадаг.[567]	Засгийн газраас хүлээн зөвшөөрөгдсөн, хувийн, сайн дурын, ашгийн төлөө бус байгууллага юм.	Засгийн газраас эрх олгогдсон магадлан итгэмжлэх анхны байгууллага бөгөөд 1984 онд хөгжлийн түншлэлд төр, бизнес, иргэний нийгмийг холбож өгөх зорилготойгоор байгуулагдсан.
Магадлан итгэмжлэх байгууллагын бүтэц	Ерөнхий захирал удирдах бөгөөд ерөнхий захирал гадаад хэргийн сайдад ажлаа шууд хариуцан тайлагнадаг. Энэхүү байгууллага нь 8 салбар нэгжтэй, орон тооны ажилтнуудтай том бүтэцтэй байгууллага юм.	Ерөнхийдөө 6 байгууллага /1. **Association of Foundations / AF/, 2.Bishops-Businessmen's Conference for Human Development /BBC/, 3. Caucus of Development NGO Networks /CODE-NGO/, 4. League of Corporate Foundations, 5. National Council of Social Development Foundations /NCSD/, 6. Philippine Business for Social Progress /PBSP//** –аас бүрддэг. Их сургуулийн ерөнхийлөгч болоод сангуудын захирлуудын төлөөлөөс бүрдсэн 8 гишүүнтэй.[568]	Захирлуудын зөвлөл болоод 7 хорооноос бүрддэг. Захирлуудын зөвлөл нь засгийн газрын төлөөлөл, холбоодын болоод их сургууль, зарим нэг төрийн бус байгууллагын удирдлага нарын төлөөлөл оролцсон 20 хүний бүрэлдэхүүнтэй.[569]

Дүгнэлт

ТББ-ыг магадлан итгэмжлэх практик гадаадын зарим улсад хэдийнэ тогтжээ. Магадлан итгэмжлэх үйл ажиллагаа харилцан адилгүй байдаг бөгөөд магадлан итгэмжлэх нь ТББ-ын үйл ажиллагааг чанаржуулах, тэднийг аливаа хэлбэрээр дэмжих, нийгэмд хүлээн зөвшөөрүүлэх үндсэн зорилгыг агуулж байдаг ажээ. Судалгааны түвшинд ТББ-ыг магадлан итгэмжлэх 3 арга байгааг дурдсан бөгөөд тус бүртээ давуу болон сул талтай байдаг байна.

[567] http://www.ausaid.gov.au/about/org.cfm.

[568] http://www.pcnc.com.ph/about-us.html /хамгийн сүүлд 2011 оны 3 дугаар сар 18-нд зочилсон/.

Үүнд:

✓ Төрийн оролцоотой магадлан итгэмжлэх гэдэг нь: ТББ-ын үйл ажиллагаанд төрөөс хяналт тавьж тодорхой шалгуур хангасан тохиолдолд магадлан итгэмжилдэг. Гэхдээ энэ нь бусад магадлан итгэмжлэлтэй харьцуулахад урт хугацаа шаардлаг, зардал ихтэй байдаг сул талтай.

✓ Өөрийгөө магадлан итгэмжлэх гэдэг нь: төрийн бус байгууллагын тодорхой шаардлага шалгуурыг агуулсан дүрэм буюу хуульд тухайн байгууллагын үйл ажиллагаа нийцсэн гэдгээ тухайн байгуулага өөрөө тодорхойлон тайлангаа аудитаар хянуулан тухайн төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх эрх бүхий зөвлөлд хүргүүлэх үйл ажиллагаа байдаг. Энэхүү тогтолцооны давуу тал нь хялбар бөгөөд зардал багатай байдаг боловч сул тал нь магадлан итгэмжлэл зөвхөн баримт бичиг дээр тулгуурлан хийгддэг бодит байдлын судалгаа хийгддэггүй сул талтай.

✓ Нийтийн сангийн байгууллагаар магадлан итгэмжлэх гэдэг нь: төрийн бус байгууллага тодорхой сан буюу энэрлийн үйл ажиллагаа явуулдаг олон нийтийн байгууллагын төсөл, хөтөлбөрт хамтран оролцох, мөн санхүүжилт авахаар тухайн байгууллагын магадлан итгэмжлэх шаардлага шалгуурыг хангахыг хэлдэг.

Манай улсын хувьд магадлан итгэмжлэх эдгээр аргуудын алийг ч авч хэрэглэх боломжтой бөгөөд ингэхдээ:

- Магадлан итгэмжлэлийг хүлээн авах нийгмийн сэтгэл зүй бүрдсэн байх. Өөрөөр хэлбэл, магадлан итгэмжлэлийн ач холбогдол, зорилгыг ТББ-ууд зөвөөр ойлгон хүлээж авах бэлтгэлтэй байх гэсэн санаа юм.
- Магадлан итгэмжлэх байгууллага нь ТББ-уудад хүлээн зөвшөөрөгдөхүйц байх.
- Магадлан итгэмжлэх үйл ажиллагаа эдийн засгийн хувьд зардал багатай, хэмнэлттэй байх
- Магадлан итгэмжлэл үр нөлөөтэй байх гэсэн үндсэн хүчин зүйлсийг харгалзаж үзэх хэрэгтэй юм.

Дөрөв. НИЙГЭМД ҮЙЛЧИЛДЭГ ХЭМЭЭХ ТББ-УУД ҮЙЛ АЖИЛЛАГАА, САНХҮҮГИЙН ТАЙЛАНГАА ХЭРХЭН ТАЙЛАГНАДАГ ТАЛААР

Хэдийгээр ТББ-ын тоо 2006 он гэхэд л 5500-д хүрсэн[570] боловч Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт 2009 онд 185, 2010 онд 112 ТББ үйл ажиллагааныхаа тайланг ирүүлжээ. "Төрийн бус байгууллагын тухай" хуулиар ТББ байгууллага нь үйл ажиллагааны, санхүүгийн гэсэн 2 төрлийн жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор гаргаж өгөх үүрэгтэй. Гэхдээ санхүүгийн тайланг гаргаж өгөөгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлага байхгүй. Үйл ажиллагааны тайланг гаргаж өгөөгүй бол гэм буруутай албан тушаалтныг 10000-20000 төгрөгөөр шүүгч торгох зохицуулалттай.

Тоон үзүүлэлтээс харахад хуулийн дээрх зохицуулалт нь төдийлөн үр нөлөөгүй байдаг байна. Учир нь ТББ-д тайлангаа хугацаанд нь өгөөгүй

[570] Чимэг Н. нар /2008/ Иргэний нийгэм төлөвшиж буй нь /// Б.Даш-Ёндон /ред./ Монголын нийгмийн өөрчлөлт Уб., МУШУА, ФСЭХ, 294 дэх тал.

үндэслэлээр хариуцлага тооцуулахаар шүүхэд хандсан тохиолдол байдаггүй. Нөгөө талаас ТББ нь тайланг зөвхөн хуулиар харьяалуулсан байгууллагад өгөх зохицуулалттай бөгөөд бусад хэлбэрээр нийтэд мэдээлэх үүрэг хүлээдэггүй.

ОХУ-ын "Төрийн бус байгууллагын тухай" хуулиар ТББ нь ОХУ-ын хууль тогтоомжид заасны дагуу нягтлан бодох бүртгэлийн тооцоо хөтөлнө. Мөн хууль тогтоомж болон үүсгэн байгуулах баримт бичигтээ заасны дагуу төрийн статистик болон татварын байгууллага, үүсгэн байгуулагчиддаа үйл ажиллагааныхаа талаар мэдээллийг гаргаж өгнө гэж заасан байдаг. Түүнчлэн уг хуулийн 32 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт төрийн бус байгууллагын орлого, зарлага, эд хөрөнгө, ажилчдын тоо, хөдөлмөрийн хөлсний хэмжээний талаарх мэдээлэл нь аж ахуйн нуущад хамаарах мэдээлэл байж болохгүй гэзд ТББ нь жил бүр олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон Интэрнет сүлжээгээр үйл ажиллагааныхаа тухай мэдээллийг нийтлэх үүрэгтэй гэж заасан байна.

ТББ нь санхүүгийн болон үйл ажиллагаагаа харьяа төрийн байгууллагад болон нийтэд тайлагнах нь ямар ач холбогдолтой вэ?

ТББ-ын үйл ажиллагааг хянах гол арга бол тайлангийн арга юм.[571] "Төрийн бус байгууллагын тухай" хуулийн 11 дүгээр зүйлд ТББ-ын Удирдах зөвлөл нь тайланг хэлэлцэх бүрэн эрхтэй байхаар заасан байна. Энэ нь тайланд үндэслэн дотоод хяналтаа хэрэгжүүлж үнэлэлт дүгнэлт өгөх, дараагийн ажлаа төлөвлөх, гишүүд, хандивлагчдад үйл ажиллагаагаа нээлттэй байлгах боломжийг бүрдүүлж өгч байдаг. Ийнхүү нээлттэй байх нь ТББ-д нэгдэх, хамтран ажиллах иргэдийн идэвхийг дээшлүүлэх ач холбогдолтой ч гэж үздэг. Жишээ нь, хандив өргөх, гэрээслэлээр өвлүүлэх зэрэг харилцаанд юуны өмнө ТББ-ын найдвартай ажиллагааг харах нь зүйн хэрэг юм.

Харин төрийн эрх бүхий байгууллагад ажлаа тайлагнах нь ТББ-ын талаар тоон мэдээлэл бэлтгэх, татварын болон бусад эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой гэж үздэг.

Өмнө нь дурьдсанчлан ТББ-ын санхүүгийн тайлан нь нэлээд ач холбогдолтой бөгөөд ОХУ болон БНКазахстан Улсын "Төрийн бус байгууллагын тухай" хуульд төрөөс ТББ-д тавих хяналтыг тусгай бүлэг[572] болгон зохицуулсан байдаг байна. Үүндээ гадаад улсын ТББ-ын салбар, төлөөлөгчийн газрыг онцлон авч үзсэн байдаг бөгөөд "үндсэн хуульт байгууллын үндэс, бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, улс орны аюулгүй байдлыг хангах үүднээс төрийн байгууллага нь ОХУ-ын нутаг дэвсгэрт байгаа Гадаадын ТББ-ын үйл ажиллагааг зогсоох эрхтэй"[573], "эрх бүхий байгууллагын шаардсан мэдээллийг нэг бус удаа гаргаж өгөхгүй байх нь тухайн ТББ-ыг татан буулгах талаар шүүхэд

[571] Амарсанаа Ж. Эвлэлдэн нэгдэх эрх. *Төрийн бус байгууллагын стандарт /гарын авлага/.* 2001 он. Уб., 61 дэх тал.

[572] ОХУ-ын "Төрийн бус байгууллагын тухай" Холбооны хуулийн 6 дугаар бүлэг, БНКУ-ын "Төрийн бус байгууллагын тухай" хуулийн 6 дугаар бүлэг.

[573] ОХУ-ын "Төрийн бус байгууллагын тухай" Холбооны хуулийн 32 дугаар зүйл, 13 дахь хэсэг.

нэхэмжлэл гаргах үндэслэл болно"[574] гэж тус тус заажээ. Хэдийгээр "Төрийн бус байгууллагын тухай" хуулийн 3 дугаар зүйлийн 2-т "Энэ хууль Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгуулагдан үйл ажиллагаагаа явуулдаг олон улсын болон улс төрийн бус байгууллага, тэдгээрийн салбар төлөөлөгчийн газарт нэгэн адил хамаарна" гэж заасан боловч 2009, 2010 онуудад Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт ТББ-аас ирүүлсэн тайлангуудаас харахад ОУ-ын байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газраас үйл ажиллагааны тайлан ирүүлсэн зүйлгүй байна.

Харин тайлангаа ирүүлсэн ТББ-ын мэдээллээс харахад дээрх байгууллагуудаас санхүүжилт авч төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн талаар тайлагнажээ.

Гэхдээ тайлангууд нь хэлбэр болоод хэмжээний хувьд харилцан адилгүй байдаг бөгөөд хамгийн бага нь бичгийн цаасны 1 нүүр байхад, хамгийн их нь 50 орчим нүүртэй байна.

Дүгнэлт

ТББ тайлан гаргах нь үйл ажиллагаанд нь хяналт тавих боломжийг олгодог үндсэн ач холбогдолтой байдаг. Академич Ж.Амарсанаа "санхүү болон үйл ажиллагаатай холбоотой гадаад хяналтыг хуулийн дагуу эрх бүхий байгууллага хийдэг боловч төрийн бус байгууллагын дэзд шатны байгууллага нь дотоод хяналтыг явуулдаг"[575] гэж хяналтыг гадаад, дотоод хүчин зүйлийн үүднээс авч үзжээ.

Манай улсын хувьд ТББ-уудын ирүүлсэн тайлангуудаас харахад хууль биелүүлэх үүднээс үйл ажиллагааны талаарх тайлангаа ирүүлдэг байна. Харин "Төрийн бус байгууллагын тухай" хуулийн 23 дугаар зүйлийн 1-д "Төрийн бус байгууллага нь зохих журмын дагуу жилийнхээ тайлан тэнцлийг гаргаж дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор Татварын албанд өгнө" гэж заасан боловч "Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай" хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5.-д "аж ахуйн нэгж" гэж улсын бүртгэлд бүртгэгдэж, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа компани, нөхөрлөл, хоршоо, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, тэдгээртэй адилтгах орлогын албан татвар төлөх үүрэг бүхий хуулийн этгээдийг" гэж заасан тул ТББ нь санхүүгийн тайланг гаргаж өгөх эсэх нь "бүрхэг" болжээ. Энэ байдал нь өмнө нь дурдсанчлан ТББ-д тавих гадаад хяналтыг хэрэгжүүлэх боломжгүй болж байгаа ч дотоод хяналтыг хэрэгжүүлэхэд саад болохгүй. Өөрөөр хэлбэл, ТББ-д өгсөн хандив тусламж, үйл ажиллагааг нь санхүүжүүлсэн этгээдэд санхүүгийн тайлан гаргаж өгдөг байхыг үгүйсгэх боломжгүй юм.

ТББ нь үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангаа хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан нийтэд мэдээлэх нь ховор бололтой. Учир нь ТББ-уудын 2009, 2010 оны тайлангаас харахад ихэнх нь өөрийн гэсэн цахим хуудасгүй, үйл ажиллагааныхаа тайланг бусад байдлаар мэдээлсэн талаарх мэдээлэлгүй байна.

[574] Мөн хууль, 32 дугаар зүйл, 10 дахь хэсэг.

[575] Амарсанаа Ж. Эвлэлдэн нэгдэх эрх. *Төрийн бус байгууллагын стандарт /гарын авлага/* 2001 он. Уб., 41 дэх тал.

Мөн ТББ нь нийгэмд ашиг тустай үйл ажиллагаа явуулах үндсэн зорилготой гэж заасан боловч ирүүлсэн тайлангуудаас харахад зарим ТББ нь шашны урсгалыг таниулан мэдүүлэх, сурталчилах зорилготой мэт ажээ[576].

Зарим ТББ-ын тайланд "Тайланг хүлээн авч танилцан зөвлөмж өгнө үү" гэсэн хүсэлтийг гаргажээ. Энэ нь тайланг хуульд нийцүүлэн хэрхэн зөв гаргах талаарх хүсэлт гэж ойлгохоос өөр аргагүй юм. Учир нь ТББ нь нийтлэг зорилгоороо бол ашгийн бус хуулийн этгээд, үйл ажиллагааныхаа зорилгыг дүрмээрээ тодорхойлдог тул түүндээ нийцсэн үйл ажиллагаа явуулах үүрэгтэй бөгөөд үйл ажиллагааны хувьд төрийн байгууллагаас зөвлөмж, чиглэл өгөх боломжгүй юм.

ОХУ-ын эрх зүйн зохицуулалтаас харахад ТББ-ын санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд ихээхэн ач холбогдол өгдөг бөгөөд энэ нь мөнгө угаах, үндэсний аюулгүй байдалд харш аливаа үйлдлийг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тайлан, мэдээллийн аргаар хянадаг байна. Ялангуяа гадаадын ТББ-ын салбар төлөөлөгчийн газарт энэ талаар тавигдах шаардлага нэлээдгүй өндөр байдаг байна.

Тав. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭС ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА БАЙГУУЛАХ БОЛОМЖ

Хуулийн этгээдээс ТББ байгуулах боломжийг авч үзэхийн тулд хуулийн этгээд гэж юуг ойлгох, ТББ-ын зорилго, мөн чанарыг авч үзэх нь зүйтэй юм. Ингэж авч үзэх нь асуудлын мөн чанарыг танин мэдэхэд дөхөм болох юм.

Хуулийн этгээд:

Хуулийн этгээдийн нийтлэг шинжийг Иргэний хуульд тодорхойлсон байдлаас гадна үйл ажиллагаа явуулж буй салбар, чиг үүргээр нь хувийн эрх зүйн хуулийн этгээд, нийтийн эрх зүйн хуулийн этгээд буюу төрийн байгууллага гэж 2 ангилдаг.

Хуулийн этгээдээс ТББ байгуулах харилцаанд хувийн эрх зүйн хуулийн этгээд гэж "Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай" хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5.-д заасанчлан "аж ахуйн нэгж гэж улсын бүртгэлд бүртгэгдэж, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа компани, нөхөрлөл, хоршоо, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, тэдгээртэй адилтгах орлогын албан татвар төлөх үүрэг бүхий хуулийн этгээдийг" ойлгож болно. Энэ ангилалд хамаарах хуулийн этгээд ТББ байгуулах эрх нь нээлттэй. Гэхдээ энэ нь хууль бус үйлдлийг халхавчлах зорилготой байж болохгүй.

Төрийн эрх мэдлийг хэрэгжүүлж буй байгууллага, ялангуяа тангараг өргөсөн төрийн албан хаагч өөрийн эрх ашгийг хамгаалах ТББ байгууллага байгуулах нь Иргэний нийгмийн эсрэг үйлдэл юм. Тийм ч учраас "Төрийн бус байгууллагын тухай" хуулийн 1 дэх хэсэгт хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллагаас бусад хуулийн этгээд ТББ байгуулах боломжтой талаар зохицуулсан.

[576] Жишээ нь: "Монголын библийн нийгэмлэг" ТББ, "Христэд итгэгч просбитериан чиглэлийн сүмүүдийн төв" ТББ, "Авралын хаан" ТББ.

ТББ-ын мөн чанар

Чөлөөт нийгэм дэх иргэний нийгмийн гол үүрэг бол төрийн эрх мэдлийг хязгаарлан тэнцвэржүүлэгч хүч болох явдал юм[577]. Эдгээр хүч тэнцвэртэй нөхцөлд хувийн болон нийтлэг ашиг сонирхол зөв хосолж, нийгэм хөгжих хэвийн нөхцөл бүрдэнэ[578]. Харин иргэний нийгмийг бүрдүүлэгч нь эрх, ашиг сонирхол, зорилгоороо нэгдсэн хүмүүсийн бүлгээс бүрддэг бөгөөд эдгээрийн нэг хэсгийг ТББ байгууллага эзэлдэг. Нэг хэсэг гэсний учир нь Иргэний нийгэм нь өргөн хүрээтэй ойлголт бөгөөд ТББ нь түүнийг бие даан илэрхийлж чаддаггүй, иргэний нийгмийн нэг институци нь болдогт оршино.

ТББ нь төрийн эрх мэдлийг авах ямар нэг улс төрийн зорилго агуулдаггүй, нийгмийн олон талт харилцаанд төрийн хүргэж чадахгүй байгаа үйлчилгээг нөхөн хүргэх, төрийн анхаарлыг тийш нь хандуулах байдлаар нийгэмд ашиг тустай үйл ажиллагаа явуулах зорилго дор нэгдэж байдаг мөн чанартай.

Ийнхүү ТББ нь нэг талаас иргэний нийгмийн бүрэлдэхүүн хэсэг, нөгөө талаас иргэний нийгмийн төрд тавих хяналтыг хэрэгжүүлэгч байдаг тул төрийн байгууллага ТББ байгуулах нь МУ-ын Үндсэн хуулийн оршил хэсэг дэх "Эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно" гэсэн тунхаглалтай харшилдахад хүрнэ.

Дүгнэлт

ТББ нь иргэний нийгмийн эд эс болох хувьдаа мөн чанарын хувьд зарим харилцаанд төрийн эсрэг зогсож, түүнд хяналт тавидаг ажээ. Гэхдээ ТББ-ын төрд хяналт тавих харилцаа, зорилго, үйл ажиллагааг улс төрийн харилцаанаас ангид авч үзэх хэрэгтэй. Учир нь ТББ-ын үйл ажиллагаа улс төрийн зорилго агуулдаггүй, нийгэмд тустай /энэрлийн гэж зарим эх сурвалжид тэмдэглэсэн байх нь бий/ үйл ажиллагаа явуулахад чиглэгдэж байдаг.

Хувийн эрх зүйд хориглосноос бусдыг зөвшөөрдөг бол нийтийн эрх зүйд зөвшөөрснөөс бусдыг хориглодог зарчим үйлчилдэг билээ. "Төрийн бус байгууллагын" тухай хуульд төрийн байгууллага нь ТББ байгуулахыг хориглосон агуулгатай зохицуулалт байдаг. ОХУ, БНУзбекистан Улсын хуулиудад төрийн байгууллагаас ТББ байгуулахыг хориглосон зохицуулалт байдаггүй. Гэхдээ үүнийг зөвшөөрсөн хэм хэмжээ гэж ойлгож болохгүй. Учир нь дээрх улсуудын хуулиудад Төрийн байгууллагаас ТББ-ын үйл ажиллагаанд саад учруулахыг хориглосон зохицуулалтыг тусгасан байдаг. Үүнээс үзэхэд дээрх зарчмын дагуу хувийн эрх зүйн хуулийн этгээдийн ТББ байгуулах эрхийг хязгаарлах боломжгүй. Харин төрийн байгууллага ТББ байгуулах нь төр, иргэний нийгмийн харилцан хяналт бүхий тэнцвэртэй байдлын зарчмыг алдагдуулах тул төр, түүний албан хаагчийн энэхүү эрх нь хязгаарлагдмал байдаг байна. Өөрөөр хэлбэл, төр нь Иргэний нийгмийн нэг институцийг өөрийгөө хамгаалах хэрэсэл болгож болохгүй гэсэн санаа.

[577] Ашфорд Н. Чөлөөт нийгмийн үндсэн зарчмууд /орч. ред: Х.Тэмүүжин/. 2007 он. Уб: Адмон хэвлэлийн газар, 9 дэх тал.

[578] Лүндэндорж Н. Төрийн онол. *2005 он.* Уб: Адмон хэвлэлийн газар, 111 дэх тал.

Дээрх байдлаас харахад нэг л ерөнхий дүгнэлт хийж болохоор байна. Төрийн байгууллага ТББ байгуулж болохгүй. Харин дэмжиж, хамтран ажиллах эрх нь нээлттэй байна. Жишээ нь: БН Узбекистан улс нь "Төрийн бус байгууллагын үйл ажиллагааны баталгааны тухай" хуультай.

Манай Улсын хувьд хууль, бодит байдал 2 зөрөөтэй байдаг байна. "Төрийн бус байгууллагын тухай" хуульд төрийн байгууллагыг ТББ байгуулахыг хориглосон хэм хэмжээг тодорхой заагаагүйгээс "Монголын тагнуулын ажилтны холбоо", "Монголын шүүгчдийн холбоо" гэх мэт ТББ-ууд байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна. Үүнийг мэргэжлийн холбоод гэж авч үзвэл гишүүддээ үйлчилдэг ТББ бололтой. Гэхдээ төрийн албан хаагчдын байгуулсан ТББ-ын зорилго нь төрийн албан хаагчдын хуульд заасан эдлэх нийгмийн, эдийн засгийн, улс төрийн, хууль зүйн баталгаа, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий Үйлдвэрчний эвлэлийн байгууллагын зорилгоос юугаараа ялгаатай, онцлог болох нь нэлээд сонирхол татсан асуудал юм.

Хөндвөл зохих өөр нэг асуудал нь төрийн жинхэнэ албан хаагч ТББ-ын гүйцэтгэх удирдлага байж болох эсэх асуудал юм. Хэдийгээр үүнийг "Төрийн албаны тухай" хуулиар зохицуулдаг боловч ОХУ-д "Төрийн бус байгууллагын тухай" хуулийн "Ашиг сонирхлын зөрчил" гэсэн 27 дугаар зүйлээр зохицуулдаг байна.

Зургаа. МЭРГЭЖЛИЙН ХОЛБООДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТАЛААР ТУСГАЙЛСАН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАД ХАМРАГДАХ ЭСЭХ

Мэргэжлийн холбоодыг дэлхий дахинаа мэргэжлийн байгууллага, мэргэжлийн нийгэмлэг гэх зэргээр янз бүрээр нэрлэдэг ба тогтсон нэг хэллэг, ойлголт байдаггүй.

Мэргэжлийн холбоод нь ашгийн төлөө бус байгууллага бөгөөд тодорхой мэргэжил, түүнтэй холбоотой этгээдүүдийн болоод нийгмийн ашиг сонирхлыг хамгаалах үндсэн зорилготой байдаг.[579]

Мэргэжлийн холбоодын үүрэг оролцоог янз бүрээр тодорхойлсон байдаг. Үүнд: "мэргэжлийн холбоо гэдэг нь тодорхой мэргэжлийн хүмүүсийн хууль ёсны дагуу ажиллах практик нөхцөл байдлыг хянах эрх олгогдсон мэргэжлийн дагуух хүмүүсийн нэгдэл" гэж тодорхойлсон байдаг бол мөн "нийтийн ашиг сонирхлыг хамгаалах байгууллага", "мэргэжилтэй хүмүүсийн ашиг сонирхлыг төлөөлөх байгууллага", "хянах байгууллага болох эрх мэдлээ хэрэгжүүлэх байгууллага"[580] гэх мэтээр тодорхойлдог.

Мэргэжлийн холбоод гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалахдаа мэргэжлийн ёс зүйн стандартыг хэрэгжүүлэх замаар нийтийг хамгаалах үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тэд ихэнхдээ үйлдвэрчний эвлэл буюу эвсэлтэй адил боловч тодорхой мэргэжлийн хүрээнийхэнд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг.

[579] http://en.wikipedia.org/wiki/Professional_association /хамгийн сүүлд 2011 оны 3 дугаар сар 24-нд зочилсон/.

[580] http://en.wikipedia.org/wiki/Professional_association /хамгийн сүүлд 2011 оны 3 дугаар сар 24-нд зочилсон./

Ихэнх мэргэжлийн байгууллагууд мэргэжлийн сургалтын хяналт болоод хөгжүүлэх, мэргэжилтнүүдийн дунд давтан сургалт зохион байгуулах, тухайн хүн тухайн мэдлэг чадварыг эзэмшсэн бол мэргэжлийн үнэмлэх буюу гэрчилгээ олгох гэх зэрэг үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг ба зарим холбоод гэрчилгээгээр гишүүнчлэлийг бүрдүүлдэг.

Ерөнхийдөө дэлхийн жишгээс харахад: Англи болоод Европын орнууд, Америкийн Нэгдсэн Улсын хувьд мэргэжлийн холбоодын эрх зүйн зохицуулалт янз бүрээр зохицуулагдсан байдаг. Америкийн нэгдсэн улсын хувьд гэхэд муж болгон өөрийн зохицуулалттай байх жишээтэй. Яг мэргэжлийн холбоодын талаасаа авч үзвэл мэргэжлийн холбоод /professionalassociation/, мэргэжлийнгишүүнчлэлтэйбайгууллага/professional membership organization/[581] гэх мэтээр олон янзаар тодорхойлдог/–ыг тусгайлсан эрх зүйн зохицуулалтаар буюу мэргэжлийн холбоод тус бүр тусгайлсан дүрэм, журмын дагуу зохицуулагддаг хэлбэр нь илүү нийтлэг байдаг.

Мэргэжлийн холбоо гэдэг нь ерөнхийдөө 2 ойлголтыг илэрхийлж байдаг. Үүнд:

✓ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын эрхийг хангах зорилготой холбоо. Энэ нь дэлхий нийтэд Үйлдвэрчний эвлэл гэсэн нэршлээр ойлгогдох нь түгээмэл.

✓ Нарийн мэргэшлийн гишүүнчлэлтэй, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах холбоо. Энэ нь нарийн мэргэшлийн барын холбоо хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг.

Манай улсын жишээн дээр авч үзвэл: Монголын өмгөөлөгчдийн холбоо, Нотариатчдын Ѣанхим, Мэргэшсэн нягтлан бодогчдын институтийг тус тус нэрлэж болно.

Өмнө дурдсанчлан нийгэмд ашиг тустай үйл ажиллагаагааны дотроос тусдаа хуулиар зохицуулах шаардлагатай төрлүүд гэж байдаг. Ийм төрлүүдийг тусгайлсан хуулиар зохицуулах нь ойлгомжтой юм. Харин бусад мэргэжлийн холбоодын хувьд "гишүүддээ үйлчилдэг" ТББ-ын төрөлд багтаж явдаг бөгөөд "Төрийн бус байгууллагын тухай" хуулийн нийтлэг зохицуулалтаар зохицуулаад явах боломжтой. Гэхдээ мэргэжлийн холбоодын үйл ажиллагааг зохицуулахдаа нэг эрхийг хуулиар олгодог бөгөөд энэ нь "мэргэжлийн холбоод нь өөрийн дүрэмтэй байж болох"-ыг зөвшөөрдөг. Өөрөөр хэлбэл, тусгайлан хуулиар зохицуулдаггүй боловч өөрийн зохицуулалт буюу "self regulation"-тэй байх эрхийг нээж өгнө гэсэн санаа юм.

Монгол Улсын хувьд мэргэжлийн маш олон тооны холбоо хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн байдаг. Гэхдээ тэдний ангиллын асуудал нийгэмд үйлчилдэг, гишүүддээ үйлчилдэг ТББ-ын алинд нь хамаарах нь тодорхой бус байдаг учир аль алинд нь бүртгүүлсэн байдаг.

[581] http://books.google.co.uk/books?id=8-w8qdbhSsIC&pg=PA53&dq=professional+membership+organization&hl=en&ei=o1aUTb6eMZSosQP43dHRBQ&sa=X&oi=book_r /хамгийн сүүлд 2011 оны 3 дугаар сар 23-нд зочилсон/

Долоо. ТББ-ААС ЯВУУЛАХ УЛС ТӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ХЯЗГААРЛАЛТ

Уг асуудлыг авч үзэхийн тулд өмнө нь авч үзсэн ойлголтуудаас гадна нам, улс төрийн үйл ажиллагаа гэдэг ойлголтыг лавшруулан үзэх нь зүйтэй болов уу.

Нийгэм бол хүмүүс хамтаар амьдрах хэрэгцээ, арга ухааны бодит илрэл, үндсэн зохион байгуулалт мөн. Нийгэм нь гэр бүлийн, иргэний, эдийн засгийн улс төрийн гэсэн дэд тогтолцооноос бүрдэнэ[582].

Улс төрийн харилцаа, түүнийг өөрчлөх, шинэтгэх үйл явц нь хүний улс төрийн эрх, эрх чөлөөний тэмцлээр, юуны өмнө иргэд улс төрийн хөдөлгөөний тодорхой хэлбэрээр зохион байгуулагдаж нэгдэн засгийн эрхийн төлөө тэмцэх явдлаар илэрдэг. Тийм чухал хэлбэрийн нэг нь нам мөн[583]. Нам бол чухамдаа иргэний нийгэм дотор байгаа улс төрийн бөөм, хэсэг хүний нэгдсэн байгууллага мөн билээ[584]. Монголын улс төрийн харилцааны үндэс нь олон намт парламентат ёс мөн гэж үзэж болно[585]. Улс төрийн намын эцсийн зорилго бол төрийн эрх мэдлийн төлөө тэмцэх, улмаар эзэмдэх явдал учраас эдгээр нь салшгүй холбоотой. Үүнд хүрэх арга нь сонгууль юм[586].

Улс төрийн нам, ТББ нь иргэний нийгэм гэх ойлголтод багтаж түүнийг бүрдүүлэгч "хүч" болж байдаг. Гэхдээ эдгээр нь үүсгэн байгуулагдсан зорилгоосоо хамааран оролцох эрх зүйн харилцаа нь ялгаатай байдаг. Өөрөөр хэлбэл, ТББ нь "Төрийн бус байгууллагын тухай" хуулийн 4 дүгээр зүйлд тодорхойлсны дагуу соёл, урлаг, боловсрол, хүмүүжил зэрэг чиглэлээр нийгмийн тусын тулд үйл ажиллагаа явуулдаг.

Хүн улс төрийн харилцаанд мэдлэг, хүмүүжил, соёл эзэмших гэж ордоггүй, харин эрх мэдлийн төлөө тэмцэх, түүнд хариу үйлдэл хийгээд эс үйлдэл үзүүлэх, хөндөгдсөн болон өдөөгдсөн ашиг сонирхлоо илэрхийлэх, хамгаалахын төлөө оролцдог[587].

Улс төрийн нам, ТББ нь хэдийгээр хувь хүний эвлэлдэн нэгдэх эрхийн илрэх хэлбэр боловч, зорилгын хувьд өөр өөр байдаг байна. Тийм ч учраас нийгмийн харилцаанд тус тусдаа субъект болон оролцдог. "Төрийн бус байгууллагын тухай" хуулийн 24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "ТББ нь Улсын их хурал, Ерөнхийлөгчийн болон Орон нутгийн сонгуульд нам, эвсэл, нэр дэвшигчид эд хөрөнгө, хандив өгсөн бол гэм буруутай албан тушаалтан, байгууллагыг торгох"-оор заасан байдаг. Харин БН Узбекистан Улсын хуулиар[588] гадаад улсын ТББ-ын салбар, төлөөлөгчийн газар, тэдгээрийн ажилтнууд нь тус улсын нутаг дэвсгэр дээр зорилгоосоо өөр ямар нэгэн

---

[582] Лүндэндорж Н. Төрийн онол. 2005 он. УБ., Адмон хэвлэлийн газар. 125 дахь тал.
[583] Чимид Б. Өнөөгийн улс төр хуульчийн нүдээр. 2006 он. Уб., Адмон хэвлэлийн газар, 37 дахь тал.
[584] Дурьдсан бүтээл. 93 дахь тал.
[585] Дурьдсан бүтээл, 33 дахь тал.
[586] Лүндэндорж Н. Төрийн онол. 2005 он. УБ., Адмон хэвлэлийн газар, 129 дэх тал.
[587] Дурдсан бүтээл, 127 дахь тал.
[588] Бүгд Найрамдах Узбекистан Улсын ТББ-ын тухай хууль. 30 дахь тал.

улс төрийн үйл ажиллагаанд оролцох, олон нийтийн хөдөлгөөн, улс төрийн намын явуулж буй үйл ажиллагааг дэмжих, санхүүжүүлэх, үүсгэн байгуулахыг хориглоно хэмээн зохицуулсан байдаг.

Энэ бүхнээс үзэхэд ТББ-аас улс төрийн үйл ажиллагаа явуулах харилцаанд дараах зүйлийг хориглодог.

- ТББ болон Улс төрийн нам байгуулах зорилго ялгаатай, зөвхөн зорилгодоо нийцсэн үйл ажиллагаа явуулах эрх зүйн шаардлага тавигддаг тул ТББ нь ямар нэг улс төрийн үйл ажиллагаа явуулах, санхүүжүүлэх, үүсгэн байгуулахыг хориглодог
- ТББ нь нийгэмд ашиг тустай үйл ажиллагаа явуулдаг, зөвхөн гишүүддээ үйлчилдэг, мөн заавал гишүүнчлэлтэй байхыг шаарддаггүй бол улс төрийн нам нь заавал гишүүнтэй байх шаардлага тавигддаг, гишүүддээ үйлчлэхийг зорилгоо болгодоггүй тул мөн чанарын хувьд тохирдоггүй.

Тийм учраас төрөөс баримталж буй бодлого, үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт, санал өгөх эрхээр ТББ-ын улс төрийн үйл ажиллагаа нь хязгаарлагддаг бол улс төрийн намын хувьд төрийн эрх мэдлийг авахыг зорилгоо болгон улс төрийн харилцаанд илүү өргөн хүрээнд оролцдог. Үүний илрэл нь Улс төрийн намын үйл ажиллагааг ихэнх оронд тусдаа хуулиар зохицуулдаг явдал юм.

Найм. НИЙГЭМД ҮЙЛЧИЛДЭГ ГЭСЭН ШАЛГУУР ХАНГАСАН ТББ НИЙТИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАН ШҮҮХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ БОЛОМЖ

ТББ нь улсын бүртгэлд бүртгүүлснээр хуулийн этгээдийн эрх эдэлдэг учраас үүнд хуулийн этгээдийн үндсэн шинж болох нэхэмжлэгч, хариуцагч байж чадах эрх ч багтдаг. Гэхдээ энд нийтийн эрх ашгийг хамгаалан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох харилцааг авч үзэж байгаа учир өмнө нь дурдсан эрх үүнд хамааралгүй юм.

Нийгэмд үйлчилдэг ТББ нь нийтийн эрх ашгийг хамгаалан шүүхэд нэхэмжлэл гаргах тохиолдол байдаг. Жишээлбэл, "Зар сурталчилгааны тухай" хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Хэрэглэгчийн эрх ашиг, түүнчлэн зар сурталчилгаа бүтээх, түгээх үйл ажиллагаанд оролцогчийн эрх ашгийг хамгаалах зорилго бүхий төрийн бус байгууллага зар сурталчилгаанд хяналт тавих чиглэлээр дараах эрх эдэлнэ:

-Хэрэглэгчийн нэрийн өмнөөс зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийг зөрчсөн тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргах;

-Тухайн зар сурталчилгаа хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж буй эсэх талаар зөвлөмж гаргах;

-Зар сурталчилгаа захиалагч, бүтээгч, түгээгчид зар сурталчилгаатай холбогдох санал тавих, зөвлөмж өгөх;

-Зар сурталчилгааны хяналттай холбоотой тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн улсын төсвөөс санхүүжүүлж болно" гэж заажээ.

Зар сурталчилгааны тухай хуулийг баримтлан 2008-2009 онд 3 хэргийг нийслэлийн хэмжээнд шийдвэрлэсэн байх бөгөөд эдгээр гурван

хэргийн нэхэмжлэгчээр "Иргэдийн Альяанс" төрийн бус байгууллага, хариуцагчаар ТВ9, ТВ5, UBS оролцож хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байв.[589] Нэхэмжлэлийн шаардлага нь "Архи согтууруулах ундааны ил болон далд сурталчилгааг таслан зогсоох, хууль зөрчсөн байгууллага, албан тушаалтанд хариуцлага ногдуулах тухай" байгаагаас харахад энэ нь олон нийтийн эрх ашгийг хамгаалан нэхэмжлэл гаргаж байна гэж үзэж болохоор байна.

Захиргааны эрх зүйд хамаарах маргааны хувьд Монгол Улсын Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.-д заасны дагуу иргэн, хуулийн этгээд Захиргааны хэргийн шүүхэд хандан гомдол гаргах эрхтэй. Гэвч энэ зохицуулалтын тайлбар болон практикт хэрэгжиж буй хэрэглээний асуудлыг дүгнэвэл, хуулийн этгээдийн ангилалд багтаж буй ТББ нь захиргааны маргаантай асуудлаар шүүхэд хандах эрхтэй боловч, маргаан үүсгэх үндэслэл болсон захиргааны акт нь тухайн байгууллагын ашиг сонирхлыг шууд хөндсөн байх шаардлагатай байдаг. Өөрөөр хэлбэл, тодорхой нэг захиргааны акт олон нийтийн ашиг сонирхлыг зөрчиж буй тохиолдолд нийгэмд үйлчилдэг ТББ нь олон нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс гомдол гаргах эрхтэй байх асуудал бүрхэг гэж дүгнэж болно.

Үүнтэй харьцуулбал, ХБНГУ-ын Захиргааны процессын тухай хуулийн 51 болон 61 дүгээр зүйлийн зохицуулалтаас үзвэл, Холбоод захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргах эрхтэй бөгөөд хэдийгээр захиргааны акт нь тухайн байгууллагын ашиг сонирхлыг шууд зөрчөөгүй боловч, олон нийтийн ашиг сонирхлыг хамгаалах нь иргэн бүрийн, тэр тусам нийгэмд үйлчилдэг холбооны эрхэм үүрэг тул, нийгэмд үйлчилдэг ТББ болохын хувьд олон нийтийн ашиг сонирхлыг хамгаалахын тулд гомдол гаргах эрхтэй байх нь зүй ёсны асуудал гэж үздэг байна.[590]

ОХУ-ын эрх зүйн зохицуулалтаас харахад нийтийн эрх ашгийг хамгаалан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохыг хориглосон хэм хэмжээ байдаггүй. Гэхдээ ОХУ-ын "Зар сурталчилгааны тухай" хуулийн 32 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "зар сурталчилгаа бүтээгч, түгээгчдийн холбоо, тэдний эрх ашгийг хамгаалах зорилго бүхий ассоциаци нь төрийн захиргааны байгууллагаас баталсан аливаа хэм хэмжээний талаар арбитрын шүүхэд хандах эрхтэй" хэмээн хуульчилсан байдаг бол БНУЗбекистан Улсын "Төрийн бус байгууллагын тухай" хуулийн 7 дугаар зүйлд ТББ-ын эрхийг "гишүүд, оролцогчдынхоо эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах болон төлөөлөх" гэзд төгсгөлд нь "хууль тогтоомжид заасан бусад эрх" хэмээн тусгасан байна.

Нийгэмд үйлчилдэг ТББ нь нийтийн эрх ашгийг хамгаалан шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй байдаг. Гэхдээ энэхүү эрхийг "Төрийн бус байгууллагын тухай хууль"-д тусгах нь хэт ерөнхий нийтлэг зохицуулалт болно.

---

[589] ХЗҮХ "Зар сурталчилгаа ба гэм хор" судалгааны тайлан. 2009 он, 63 дахь тал.

[590] Verwaltungsgerichtsordnung, §§51., 61 дэх тал.

Нийгэмд үйлчилдэг ТББ-ын нийтийн эрх ашгийг хамгаалан шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг "Төрийн бус байгууллагын тухай" хуулиас бусад хуульд тусгаҳдаа тухайн хуулиар ямар харилцааг зохицуулж байгаа, уг хуулиар зохицуулж байгаа харилцаанд олон нийтийн зүгээс хяналт тавьж, зөрчигдсөн тохиолдолд нийтийн эрх ашгийг хамгаалан шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй байж болох эсэхийг харгалзан оруулах нь зүйтэй болов уу. Дүгнэж хэлбэл, ТББ-ын нийтийн эрх ашгийг хамгаалан шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг "Төрийн бус байгууллагын тухай" хуульд шууд тодорхойлох бус "хууль тогтоомжид заасан бусад эрх" гэсэн байдлаар хуульчлан энэхүү эрхийг нь бусад салбар хуулиудад тодорхой тусгах нь зүйтэй юм.

Харин шүүх нэгэнт хэрэг үүсгэсэн тохиолдолд хэргийн оролцогчийг ТББ төлөөлөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох нь хэргийн оролцогчдын эрхийн асуудал юм. Үүнийг стратегийн өмгөөлөл гэж нэрлэх нь ч бий.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийн оролцогчдыг ТББ төлөөлөн оролцох нь тэдгээрийн хүсэл зоригийн асуудал байдаг ба үүнийг Иргэний хуулиар зохицуулсан тул заавал тусгайлан дахин хуульчлах шаардлагагүй юм.

---oOo---

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭЭ
www.nli.gov.mn

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

АРБИТРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ*

ОРШИЛ

УИХ-ын 38 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2012 он хүртэл боловсронгуй болгох тухай үндсэн чиглэлийн 2.102-д "Арбитрын маргаан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох, арбитрын тогтолцоог сайжруулах, арбитр, шүүхийн хоорондын харилцааг нарийвчлан зохицуулах" чиглэлээр Арбитрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах, Ёрөнхий сайдаас 2010 онд батласан "Бизнесийн орчны шинэтгэлийн жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 1.9.2-д "Эдийн засаг, бизнесийн чиглэлийн маргааныг Арбитраар шийдвэрлүүлж байх, шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн, цаг хугацаа алдахгүйгээр хангах, үйл ажиллагааг тодорхой болгох, хөнгөвчлөх зорилгоор холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна", Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.1-т "...Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн төлөв байдлыг судлан тодорхойлж, хийдэл, давхардал, зөрчлийг арилгах замаар хуулийг боловсронгуй болгоно" гэж тус тус заасныг үндэслэн Арбитрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан ажиллаж байгаа билээ[591].

Энэ судалгаа нь арбитрт хандах иргэн, хуулийн этгээдийн тоо нэмэгдэхгүй байгаа шалтгаан нөхцөлийг социологийн судалгаагаар тогтоож, байнгын арбитрыг бусад улс оронд хаана байгуулдаг талаарх харьцуулсан судалгаа хийж, Арбитрын тухай хууль болон түүнтэй холбоотой бусад материаллаг хуулийг онолын үүднээс тайлбарлаж арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах, арбитрчийг томилуулах, татгалзан гаргах асуудлыг шүүх онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх боломжтой эсэхэд хууль зүйн үндэслэлтэй дүгнэлт өгснөөрөө ач холбогдолтой болсон.

Нэг. АРБИТРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АРБИТРААР МАРГААНАА ШИЙДВЭРЛҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДЛЫН ТАЛААРХ ИРГЭДИЙН МЭДЛЭГ

Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим /МҮХАҮТ/-ын дэргэдэх Үндэсний арбитр нь байнгын арбитрын хувьд тогтмол үйл ажиллагааг тасралтгүй эрхэлж 2007 /26/, 2008 /18/, 2009 /31/ онуудад буюу сүүлийн 3 жилийн байдлаар нийт 75 маргаан шийдвэрлэжээ. Гэтэл

---

*Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2011 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 22 дугаар тушаалын дагуу ХЗДХЯ-аас боловсруудж буй хуулийн төслийн хүрээнд хийж гүйцэтгэв.

[591]Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газар, Улсын дээд шүүхийн шүүгч, Нийслэлийн шүүхийн шүүгч, Хан-Уул дүүргийн шүүхийн шүүгч, МХАҮТ-ын дэргэдэх Үндэсний арбитрын арбитрч нар, Монголын Үндэсний арбитрын ахлах мэргэжилтэн, хууль зүйн чиглэлээр судалгаа хийдэг судлаачийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хуулийн төслийг боловсруулсан.

шүүхээр 2007 /30699/, 2008 /28480/, 2009 /35822/[592] он буюу сүүлийн 3 жилийн байдлаар нийт 95001 иргэний эрх зүйн маргааныг улсын хэмжээнд шийдвэрлэжээ. Энэ мэт шүүхээр шийдвэрлэгдэж байгаа иргэний хэрэг арбитрын байгууллагаар шийдэгдэж байгаа хэргээс даруй хэд дахин их байна.

Эрх зүйн харилцаанд оролцогч 200 иргэнээс санамсаргүй түүврийн аргаар авсан анкетаас "Та шүүхийн байгууллага болон арбитрын байгууллагын талаар хэр мэдлэгтэй вэ?" гэсэн асуултыг графикаар харьцуулан харвал:

График-1

Дээрх графикаас харахад иргэд, олон нийт арбитрын байгууллагаас илүү шүүхийн байгууллагыг мэддэг болох нь харагдаж байна.

Шүүхийн байгууллагын хувьд муухан мэднэ, мэдэхгүй гэсэн хариулт 22,8 хувийг эзэлж байхад арбитрын байгууллагын талаар муухан мэднэ, мэдэхгүй гэсэн хариулт 57,2 хувийг эзэлж байгаа нь иргэд арбитрын талаар мэдлэг тааруу гэдэг нь харагдаж байна.

График-2

[592] "Арбитрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал" Уб., 2010 он

Шүүхийн байгууллагад ямар чиглэлээр хандаж байсан бэ? гэсэн асуултанд иргэд ихэвчлэн иргэний хэрэг маргааныг шийдвэрлүүлэх зорилгоор хандаж байсан гэж хариулсан байна /51,2 хувь/. Энэ нь арбитрт хандаж хэрэг маргаанаа шийдвэрлүүлэх иргэд, байгууллагын нөөц их байна гэж үзэж болох юм.

Мөн арбитр яг ямар үйл ажиллагаа явуулдаг талаар бяцхан сорилын тест явуулахад судалгаанд оролцогчдын 35,6 хувь нь мэдэхгүй гэж хариулсан бол арбитр нь зөвхөн улс хоорондын маргааныг зохицуулдаг байгууллага гэж 22,2 хувь нь хариулсан, 18,3 хувь нь арбитрыг шүүхийн байгууллага гэж хариулжээ. Харин 21,1 хувь нь арбитрыг дотоод болон гадаадын эрх зүйн этгээдүүдийн хооронд үүссэн маргааныг шийдвэрлэдэг гэж үзжээ.

График-3



Доорх хүснэгтийг харвал "Арбитрын талаар хэр мэдлэгтэй вэ?" гэсэн асуултыг "Таны бодлоор ямар үйл ажиллагаа явуулдаг байгууллага вэ?" гэдэг асуулттай харьцуулан үзвэл **Хангалттай сайн** мэдэх гэсэн иргэдийн 43,8 хувь нь зөвхөн аль нэг улсын харъяалалтайгаас үл хамааран гадаад худалдааны хэрэг маргааныг шийдвэрлэдэг гэсэн ойлголттой байна, харин дунд зэрэг мэдэх гэсэн иргэдийн 35,7 хувь буюу хамгийн өндөр хувь нь арбитрыг шүүхийн байгууллага гэсэн ойлголттой явдаг юм байна.

Хүснэгт-1

Таны бодлоор арбитр нь ямар үйл ажиллагаа явуулдаг байгууллага вэ?

Арбитрын талаар хэр мэдлэгтэй вэ?	Аль нэг улсын харьяалалтайгаас үл хамааран гадаад худалдааны хэрэг маргааныг шийдвэрлэдэг байгууллага	Зөв дүгнэсэн	Шүүхийн байгууллага гэж үздэг	Мэдэхгүй
Хангалттай сайн мэднэ	43,8	37,5	18,8	0,0
Дунд зэрэг мэднэ	26,8	32,1	35,7	5,4
Муухан мэднэ	28,8	19,2	17,3	34,6
Мэдэхгүй	5,9	7,8	2,0	84,3

Доорх графикаас үзвэл иргэдээс арбитрын талаар бусад хүмүүс хэр мэдлэгтэй талаар асуухад хангалттай сайн мэднэ гэж 0,6 хувь, 16,1 хувь нь дунд зэрэг мэднэ, муухан мэднэ гэж 52,2 хувь нь, мэдэхгүй гэж 30,6 хувь нь хариулсан байна.

График-4

Арбитрын талаар иргэд олон нийт мэдээлэл муутай байгаа. Зөвхөн гадаад худалдааны маргаан шийддэг гэж боддог.

Арбитрчиар 8 жил ажилласан, нас 38:

Иргэдээс авсан санал асуулгаар иргэд арбитрын талаар мэдлэг хомс байдаг нь харагдаж байна. Харин арбитраар үйлчлүүлсэн иргэд, байгууллагаас дээрх асуултыг асуувал Хангалттай сайн мэднэ гэсэн хариултыг сонгосон ч бас л гадаад худалдааны хэрэг маргааныг шийдвэрлэдэг гэсэн хариултыг давхар сонгосон байгаа юм. Дунд зэрэг мэднэ гэсэн хариулт сонгосон нь 100 хувь гадаад худалдааны маргааныг шийдвэрлэдэг гэж хариулжээ.

Хүснэгт 2

Таны бодлоор арбитр ямар үйл ажиллагаа явуулдаг байгууллага вэ?

Арбитрын талаар хэр мэдлэгтэй вэ?	Аль нэг улсын харъяалалтайгаас үл хамааран гадаад худалдааны хэрэг маргааныг шийдвэрлэдэг	Зөв дүгнэсэн
Хангалттай сайн мэднэ	50.0	50.0
Дунд зэрэг мэднэ	100.0	0

Дээрхээс дүгнэн үзвэл олон нийт болон арбитраар үйлчлүүлсэн байгууллага, иргэд арбитрын талаар бүрэн гүйцэд биш дутуу ойлголттой байдаг нь харагдаж байна.

Арбитраар үйлчлүүлсэн 24 иргэн, хуулийн этгээдээс арбитрын байгууллагаар хэрэг маргаанаа шийдвэрлүүлэхийн гол ач холбогдлыг асуувал: 28,6 хувь нь арбитрын шийдвэр эцсийн бөгөөд заавал шийдэгдэнэ гэсэн хариултыг өгсөн байна. Мөн шат дамжлага бага гэж 21,4 хувь нь үзсэн бол 14,3 хувь нь цаг хугацаа хэмнэнэ, хүнд сурталд автахгүй гэж хариулжээ.

График-5

Таны бодлоор арбитраар хэрэг шийдвэрлүүлэхийн гол ач холбогдол юу вэ?



Олон арван /зуун/ хавтаст хэрэгт дарагдсан шүүгчээр хам хум шийдвэрлүүлж 2-3 шат дамжлага дамжин цаг хугацаа мащ ихээр алдсан нь дээр үү? Тухайн чиглэлээр мэргэшсэн этгээд /хуульч, эдийн засагч зэрэг/ -ээр дагнасан богино хугацаанд хамгийн зөв шийдвэр гаргах магадлалтайгаар маргаанаа шийдүүлэх нь зөв.

МУИС-ийн ХЗС-ийн багш, арбитрчаар 5 жил ажилласан, 40 настай: Эдгээрээс дүгнэхэд ямар ч байсан арбитраар үйлчлүүлсэн иргэн, хуулийн этгээд нь арбитрын ашигтай талыг мэддэг нь харагдаж байна.

АРБИТРЫН ХУРААМЖ, ШҮҮХИЙН ЗАРДАЛ

"Шүүхээр хэрэг, маргаанаа шийдвэрлүүлж байгаа этгээдүүдийн тоо жил бүр нэмэгдэж байхад арбитраар хэрэг маргаанаа шийдвэрлүүлэх этгээдүүдийн тоо нэмэгдэхгүй байгаа нь юутай холбоотой гэж Та бодож байна вэ? гэдэг асуултад үйлчлүүлэгчид хариулахдаа иргэд арбитрын талаар тодорхой ойлголтгүй байдаг гэж 33,3 хувь нь хариулснаас үзвэл иргэд тодорхой ойлголтгүй нь харагдаж байна.

Хүснэгт-3

Иргэд арбитрын талаар тодорхой ойлголтгүй байдаг	33,3
Арбитрын хууль эрх зүйн орчин бүрдээгүй	11,1
Хүнд сурталтай	11,1
Зардалтай, хүнд арбитраж	22,2
Цаг их алддаг	11,1
Шүүх байгууллага нь илүү найдвартай	11,1

Харин зардал их гардаг гэж 22,2 хувь нь хариулсан байгаа нь арбитраар хэрэг маргаанаа шийдвэрлүүлэх нь хэдий ашигтай ч үнэ хөлсний хувьд өндөр байх тал ажиглагдаж байна.

График 6-аас үзэхэд мөн арбитраар үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдийн 40 хувь нь өндөр гэж үзсэн байна. Бусад 20 хувь нь боломжийн, бага гэж үзжээ.

График-6

Танд арбитрын зардал, улсын тэмдэгтийн хураамжийн үнэ хөлс, өртөг хэр боломжийн санагддаг вэ?



Эндээс харахад арбитрын үнэ өртгийн талаар үйлчлүүлэгчид харьцангуй өндөр гэж үзсэн байхад арбитрчид үнэ өртгийн хувьд 3 хүний нэг нь боломжийн үзсэн гэж үзсэн байна.

Арбитрын шийдвэрийг шүүхийн журмаар албадан гүйцэтгүүлэхэд гарч буй зардал, хураамж өндөр байгаа.

МУИС-ийн багш, арбитрчаар 6 жил ажилласан, нас 46:

ИХШХШТХ-д зааснаар арбитрын шийдвэрийг хүчингүйд тооцуулах, шүүхээс нотлох баримт бүрдүүлэх, гүйцэтгэх хуудас бичүүлэх зэрэг

ажиллагааг хангуулахаар шүүхэд хандахад Улсын тэмдэгтийн хураамж дахин төлөхөд хүрдэг нь зохимжгүй.

Арбитрчиар 8 жил ажилласан, нас 38:

Арбитрын зардлын хэмжээг багасгах талаар арга хэмжээ авах хэрэгтэй. Одоо шүүхийн зардал буюу Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасан хэмжээтэй харьцуулахад арай өндөр байдаг.

МУИС-ХЗС-ийн багш, Арбитрчиар 8 жил ажилласан, 51 настай:

Хэрэв та болон танай байгууллага ямар нэгэн маргааныг шийдвэрлүүлэхээр болбол хаана эхэлж хандах вэ? гэдэг асуултад арбитраар үйлчлүүлэгчид дахиж арбитрын байгууллагад хандахгүй гэсэн нь сонирхолтой байгаа юм.

Хүснэгт-4

Арбитрын байгууллагад	0
Шүүхийн байгууллагад	50
Мэдэхгүй	50

Шүүхээр маргаан шийдвэрлүүлэх эрх зүйн орчин арбитртай харьцуулахад илүү төлөвшсөн. Шүүхийн зардал нь Тэмдэгтийн хураамжийн тухай хуульд зааснаар харьцангуй бага. Гомдолтой эсхүл буруу шийдсэн гэж үзвэл дараагийн шатанд хянуулах боломжтой байдаг учраас ийм сонголтыг хийсэн байж магадгүй.

Доорх хүснэгтэд Арбитрын үйл ажиллагааг үнэлсэн байдлыг харвал "Арбитр эрх, үүргээ хэрэгжүүлэхдээ хараат бус, бие даасан, шударга байх байдал" гэсэн судалгаанд оролцогчдын 20 хувь нь сайн гэж хариулсан байхад бусад талаар сайн гэсэн үнэлгээ огт өгөөгүй байна. "Арбитр, зуучлалын ажиллагааг сурталчлах, сургалт семинар зохион байгуулах талаар" гэсэнд 60 хувь нь муу гэж үнэлсэн байна.

Хүснэгт-5

	Сайн	Дунд	Муу
Монгол Улсын Арбитрын хууль зүйн орчин		80,0	20,0
Шүүх арбитр 2-ын хоорондын уялдаа холбоо		60,0	40,0
Арбитр эрх үүргээ хэрэгжүүлэхдээ хараат бус бие даасан, шударга байх байдал	**20,0**	80,0	
Арбитр, зуучлалын ажиллагааг сурталчлах, сургалт семинар зохион байгуулах талаар		40,0	60,0

Энэ нь арбитрын үйл ажиллагааны талаар үйлчлүүлэгчид төдийлэн сэтгэл хангалуун биш байдаг, бусад үйл ажиллагаанд сэтгэл дундуур байгаа нь харагдаж байна.

Харин график-7 харвал "Арбитраар шийдвэрлүүлсэн хэрэг маргаан хэр шударга үнэн зөв шийдэж өгдөг гэж та боддог вэ?" гэдэг асуултанд 60 хувь нь үнэн зөв шийддэг тохиолдол их гэж хариулсан байна.

График-7

Арбитраар шийдвэрлүүлсэн хэрэг маргаан хэр шудрага үнэн зөв шийдэж өгдөг гэж та боддог вэ?



Дээрх бүгдээс дүгнэвэл өөрийгөө сурталчлах, хууль эрх зүйн орчин, шүүх, арбитрын үйл ажиллагааны уялдаа холбоо зэрэгт хангалтгүй ажиллаж байна. Харин үйл ажиллагааныхаа хувьд өөрийнхөө үүргийг сайн гүйцэтгэж чадаж байна гэж үзэж болохоор байна.

Монгол Улсад байнгын болон түр арбитрын аль нь илүү давамгай үйл ажиллагаа явуулсан нь ашигтай вэ? гэсэн асуултад үйлчлүүлэгчдийн 60 хувь нь байнгын арбитр байх ашигтай, харин 20 хувь нь аль аль нь байсан нь ялгаагүй гэж хариулсан байна.

Хүснэгт-6

Түр арбитр	0
Байнгын арбитр	60
Аль аль нь	20
Хариулаагүй	20

Байнгын арбитр мэргэшсэн чадварлаг болж бэхжих нь илүү үр дүнтэй. Энэ нь арбитрын ажилтнуудад бас хамаатай.

Арбитрчаар 8 жил ажилласан, нас 38:

Арбитриар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шат дамжлага, хугацаа, арбитрын шийдвэрт гомдол гаргах процедур нь шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас хэр ялгаатай байна вэ?

Арбитрын хэрэг маргаан шийдвэрлэх ажиллагаа шүүхийн процедуртай харьцуулахад арай хялбар явагддаг. Давах хяналтын шатанд гомдол гаргах боломж хязгаарлагдмал. Хэргийг шийдвэрлэх хугацаа богино байдаг байна. Мөн Арбитрын процесс нь илүү чөлөөтэй, талуудын хүсэл зориг, сонголтод түшиглэсэн байдгаараа ялгаатай. Цаг хугацааны хувьд 2-3 дахин бага, дагнасан, мэргэшсэн этгээдээр хэрэг маргаанаа шийдүүлэх, авлига, хээл хахуулиас ангид байдаг байна.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.mli.gov.mn

Иргэдээс арбитрыг олон нийтэд таниулахад ямар ажил хийх нь зохистой вэ? гэсэн асуултад хамгийн их санал өгсөн байдлаар нь жагсаан авч үзвэл: **Нэгдүгээрт:** олон нийтийн телевиз, радиогоор сурталчлахыг санал болгосон. **Хоёрдугаарт:** олон нийттэй тулж ажиллаж өөрсдийгөө таниулах хэрэгтэй гэж үзсэн байна.

Гуравдугаарт: арбитрын байгууллагын талаар мэдээлэл өгдөг газрыг бий болгох хэрэгтэй гэж үзсэн байна.

СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН САНАЛ

Хүснэгт-8

Арбитрын байгууллагын давуу талыг олон нийтэд зөв таниулан сурталчлах /хэвлэмэл тараах материал мөн сонин, сэтгүүл, радио, телевизээр сурталчилах, зохиомжит нэвтрүүлэг хийх зэрэг таниулах үйл ажиллагаа явуулах./
Арбитрын байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд ил тод болгох, арбитр шүүх хоёрын ялгааг иргэдэд мэдүүлэх, нээлттэй хаалганы өдөр гэх мэт олон үйл ажиллагааг сар болгон тогтмол явуулах
Арбитрын байгууллагын талаар мэдээлэл өгдөг газруудыг байгуулах, /шаардлагатай үед мэдээлэл өгдөг газар/
Эрх зүйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй сургуулиудын хичээлийн хөтөлбөрт оруулах
Хүнд сурталгүй, үнэнч шудрагаар иргэдэд хүрч ажиллах
Иргэдийг хамарсан үнэгүй лекц семинар зохион байгуулах
Нэрийг монголчилж бичих
Ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулийн мэргэжлийн биш ангийн хичээлийн хөтөлбөрт арбитрын талаар анхан шатны мэдлэг өгөх
Тодорхой бодит жишээн дээр тайлбарлан таниулах

Хоёр. БАЙНГЫН АРБИТРЫН ХАРЬЯАЛАЛ /ГАДААД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ/

Судалгааны ажлын зорилтын хүрээнд Англо-Саксон, Ром-герман, хуучин социалист орнууд байнгын арбитрыг ашгийн болон ашгийн төлөө бус хуулийн этгээдийн дэргэд байгуулдаг эсэх, эсхүл зөвхөн мэргэжлийн холбоод болон худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэд байнгын арбитрыг байгуулдаг эсэхийг эрх зүйн бүлээр нь үзвэл:

1.Эх газрын эрх зүйн системтэй улс орнууд[593]

№	Улс орны нэрс	ХАҮТ-ын дэргэд байнгын арбитр байдаг эсэх, арбитрын тухай хуульд энэ талаар зохицуулалт бий эсэх	Тайлбар
1	Армен	Танхимын дэргэд арбитрын шүүх ажилладаг. Энэ эрх зүйн зохицуулалтыг Арбитрын тухай хуулиараа зохицуулсан.	Арбитрын шүүхийн тухай хуульдаа Худалдаа Аж үйлдвэрийн танхим, Хөрөнгийн биржгэх мэт байгууллагуудад байнгын арбитр байгуулах эрхийг олгосон.
2	Беларусь	Танхимын дэргэд арбитрын шүүх ажилладаг. Энэ эрх зүйн зохицуулалтыг Арбитрын тухай хуулиараа зохицуулсан.	Байнгын ажиллагаатай Олон Улсын Арбитрын шүүх нь төрийн бус, ашгийн төлөө бус, хуулийн этгээд байна. Байнгын арбитрын шүүхийг гадаадын хуулийн этгээд, худалдаа наймаа эрхлэгчидтэй гадаад эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэхэд нь хувь нэмэр оруулах гол зорилготой арилжааны бус байгуулллага байгуулна.

[593] Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх гадаад худалдааны арбитрын 2002 оны 9 дүгээр сард хийсэн судалгаа. Арбитрын тухай хуулийн төслийг УИХ-аар хэлэлцэхэд зориулсан судалгааны материалаас МҮХАҮТ. УБ., 2003 он.

3	Венесуэль	Танхимын дэргэд арбитрын шүүх ажилладаг. Энэ эрх зүйн зохицуулалтыг Арилжааны Арбитрын тухай хуулиараа зохицуулсан.	Арбитрын төв, танхимын нэг хэлтэс болохын хувьд танхимын захирлуудын зөвлөлд ажлаа тайлагнадаг. Хуулийн дагуу худалдааны танхимууд болон аливаа худалдааны байгууллагууд, эдийн засаг, аж үйлдвэрийн ажиллагаатай холбоотой олон улсын холбоо, байгууллага, маргаан шийдвэрлэх альтернатив аргыг дэмжих зорилготой байгууллага, их сургууль, боловсролын байгууллага, маргааныг шийдвэрлэх арбитрыг байгуулсан бусад байгууллагууд нь өөрсдийн арбитрын төвийг байгуулж болно.
4	ХБНГУ	Танхимын дэргэд арбитрын шүүх ажилладаггүй.	Энэ улсын хувьд Арбитр нь бие даасан хараат бус ашгийн төлөө бус олон нийтэд үйлчилдэг байгууллага байдаг[1].
5	Индонези	Үгүй. Тусгайлсан арбитрын тухай хуульгүй.	Одоо хүртэл Индонез нь арбитрын тухай тусгай хууль батлаагүй. Иргэний хуульд арбитрын тухай зүйл заалт бий ч эдгээр нь Юнситралын загвар хуульд үндэслэгдээгүй.
6	Итали	Үгүй. Тусгайлсан арбитрын тухай хуульгүй.	Арбитрын ажиллагааг Иргэний хуулиар зохицуулсан.
7	Литва	Танхимын дэргэд арбитрын шүүх ажилладаг. Энэ эрх зүйн зохицуулалтыг Арбитрын тухай хуулиараа зохицуулсан.	Үйлдвэрлэл, худалдаа аж ахуйн нэгжийг төлөөлөх, төрийн бус байгууллага нь байнгын арбитрын байгууллагыг байгуулж болно. Байнгын арбитрын дүрмийг үүсгэн байгуулагчид бэлтгэж Хууль зүйн яам нь батладаг.
8	Нидерланд	Үгүй. Тусгайлсан арбитрын тухай хуульгүй.	Арбитрын ажиллагааг Иргэний хуулиар зохицуулсан.
9	ОХУ	Танхимын дэргэд арбитрын шүүх ажилладаг. Энэ эрх зүйн зохицуулалтыг Олон улсын Арилжааны Арбитрын тухай хуулиараа зохицуулсан.	Арбитрын шүүх улсын байнгын шүүх байна.
10	Перу	Танхимын дэргэд арбитрын шүүх ажилладаг. Энэ эрх зүйн зохицуулалтыг Арбитрын тухай хуулиараа зохицуулсан.	Арбитрын төв худалдааны танхимдаа харъяалагддаг ч өөрийн удирдлага, хууль дүрэмтэй. Арбитрын байгууллага хуулийн этгээд байх ёстой.

11	Польш	Танхимын дэргэд арбитрын шүүх ажилладаг. Энэ эрх зүйн зохицуулалтыг Эдийн засгийн танхимын тухай хуулиар зохицуулсан.	Арбитр танхимын хоорондын харилцааг арбитрын дүрмээр зохицуулна.
12	Франц	Танхимын дэргэд арбитрын шүүх ажилладаг. Арбитрын тухай тусгай хуульгүй.	Францын арбитрын үйл ажиллагааг Иргэний хуулиар зохицуулдаг. Тусгайлан гаргасан арбитрын хууль байхгүй. Францад Олон Улсын худалдааны танхимын арбитрын шүүх байдаг тул ихэнхи маргаан үүгээр шийдэгддэг. Парисын арбитрын хороо нь бие даасан, хараат бус, ашгийн төлөө бус, олон нийтэд үйлчилдэг байгууллага юм[1].

хууль зүйн үндэсний хүрээлэн
www.nli.gov.mn

[378] ХЗҮХ-ийн Олон улсын эрх зүйн секторoос "Арбитрын тухай хуулийн хэрэгжилт, хүндрэл бэрхшээл, эрх зүйн орчныг сайжруулах арга зам" судалгааны ажил. Уб., 2011 он.

2.Англо-Саксоны эрх зүйн системтэй улс орнууд[594]

№	Улс орны нэрс	ХАҮТ-ын дэргэд байнгын арбитр байдаг эсэх, арбитрын тухай хуульд энэ талаар зохицуулалт бий эсэх	Тайлбар
1	АНУ	ХАҮТ-ын дэргэд байрладаггүй.	АНУ-ын муж бүр тусдаа арбитрын тухай эрх зүйн зохицуулалттай. Гэхдээ АНУ нь Арбитрын тухай нэгдсэн хуультай. Энэ хууль бүх мужийн хувьд үндсэн зарчим болж үйлчлэх тул нарийн зохицуулалтын хэм хэмжээ агуулаагүй. АНУ-ын арбитрын зөвлөл бие даасан хараат бус, ашгийн төлөө бус олон нийтийн байгууллага буюу хязгаарлагдмал хариуцлагатай компани байдаг[1]
2	Австрали	ХАҮТ-ын дэргэд байрладаггүй.	Олон улсын арбитрын актаа Юнситралын загвар хуульд үндэслэн гаргасан. Тус актаар Юнситралын загвар хуулийг олон улсын арилжааны арбитрт хэрэглэж болохыг заасан. Австралийн арбитрчдын болон эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөл нь бие даасан, хараат бус, ашгийн төлөө бус олон нийтийн байгууллага буюу хязгаарлагдмал хариуцлагатай компани байдаг[2].
3	Англи	ХАҮТ-ын дэргэд байрладаггүй.	Арбитрын тухай актад танхимын талаар тусгаагүй. Английн Лондонгийн Олон улсын арилжааны шүүх дэлхийн хамгийн том арбитрын төвүүдийн нэг юм. Уг арилжааны шүүх нь бие дааж, хараат бус, ашгийн төлөө бус олон нийтийн байгууллага буюу хязгаарлагдмал хариуцлагатай компани байдаг[3].
4	Бразил	ХАҮТ-ын дэргэд байрладаггүй.	Бразилийн танхимуудад арбитрын ажиллагаа эрхэлдэг алба, хэлтэс байхгүй.

[594] Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх гадаад худалдааны арбитрын 2002 оны 9 дүгээр сард хийсэн судалгаа. Арбитрийн тухай хуулийн төслийг УИХ-аар хэлэлцэхэд зориулсан судалгааны материалаас МҮХАҮТ. Уб., 2003 он.

5	Канад	ХАҮТ-ын дэргэд байрладаггүй.	Арбитрын ажиллагааг хувийн байгууллага эрхлэн явуулдаг. Канадад маргаан шийдвэрлэхтэй холбоотой 50 гаруй холбооны хууль тогтоомж байдаг. Арбитрын үйл ажиллагааг зохицуулсан холбооны хууль нь Юнситралын загвар хуульд үндэслэгдсэн Арилжааны арбитрын тухай хууль юм. Муж бүр Юнситралын загвар хууль болон Нэгдсэн Вант улсын 1899 оны Арбитрын актад үндэслэсэн арбитрын хуультай. Холбооны хуулиас гадна Канадын холбооны шүүхийн журмууд нь арбитрын үйл ажиллагааг зохицуулсан зүйл заалттай.
6	Шинэ Зеланд	ХАҮТ-ын дэргэд байрладаггүй.	Шинэ Зеландын арбитрын тухай акт Юнситралын загвар хуульд үндэслэгдсэн.
7	Малайз	ХАҮТ-ын дэргэд байрладаггүй.	Малайзын арбитрын төв нь хэдийгээр Засгийн газраас дэмжлэг авдаг ч ашгийн төлөө бус байгууллага бөгөөд төрийн бус байгууллагын дэргэд байгуулагддаг байна.
8	Мексик	ХАҮТ-ын дэргэд байрладаггүй.	Мексикийн худалдааны хууль, танхим ба түүний холбоодын тухай хуулиар арбитрын ажиллагааг зохицуулсан.
9	Гондурис	ХАҮТ-ын дэргэд байрладаг. Энэ эрх зүйн зохицуулалтыг арбитрын тухай хуулиараа зохицуулсан.	Арбитрын танхим нэг хэлтэс болж ажилладаг. Хуулиар танхим арбитрын шүүх байгуулж болохыг зөвшөөрсөн. Тус хуулиар бие даасан арбитрын байгууллага байгуулахыг хориглосон.
10	Энэтхэг	ХАҮТ-ын дэргэд байрладаг.	Энэтхэгийн Засгийн газар болон Худалдаа, аж үйлдвэрийн танхимын нэгдсэн хурлаас байгуулдаг.
11	Индонези	ХАҮТ-ын дэргэд байрладаггүй.	Арбитрын үндэсний зөвлөл бие даасан хуулийн этгээд юм. Энэ зөвлөлийг танхимын дэмжлэгтэйгээр байгуулсан бөгөөд танхимтай нягт холбоотой ажилладаг.

3.Социалист эрх зүйн системтэй улс орнууд

№	Улс орны нэрс	ХАУТ-ын дэргэд байгын арбитр байдаг эсэх, арбитрын тухай хуульд энэ талаар зохицуулалт бий эсэх	Тайлбар
1	БНАСАУ	ХАУТ-ын дэргэд байдаггүй.	Эдийн засгийн маргааныг шийдэх ажиллагааг Солонгосын олон улсын худалдааны Арбитрын хороо ба Солонгосын далайн арбитрын хороо эрхэлж явуулна.
2	Хятад	ХАУТ-ын дэргэд байдаггүй. Арбитрын тухай хуулиар зохицуулсан.	Гадаадын хэрэг маргаантай холбоотой арбитрын тухай тусгай зохицуулалтыг Хятадын арбитрын тухай хуульд оруулсан байна. Гадаадын хэрэг маргааныг шийдэх арбитрын хороог Хятадын олон улсын худалдааны танхим байгуулж болно.

4.Шашны эрх зүйн системтэй улсууд

№	Улс орны нэрс	ХАУТ-ын дэргэд байгын арбитр байдаг эсэх, арбитрын тухай хуульд энэ талаар зохицуулалт бий эсэх	Тайлбар
1	Египет	ХАУТ-ын дэргэд байдаггүй.	Каирын төв Юнситралын загвар хуулийг шууд хэрэглэдэг.
2	Бахрэйн	ХАУТ-ын дэргэд байрладаг. Уг харилцааг арбитрын тухай актаар зохицуулсан.	Юнситралын загвар хуулийг шууд хэрэглэхээр хуульдаа заасан.
3	Лебанон	ХАУТ-ын дэргэд байрладаг.	Лебаноны Худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэд байгын арбитр ажилладаг бөгөөд Лебаноны цорын ганц арбитрын байгууллага юм.
4	Арабын нэгдсэн Эмират улс	ХАУТ-ын дэргэд байрладаг. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулдаг.	Дубай мужийн хувьд Дубайн худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хууль батлагдсанаар арбитрын байгууллагыг танхимын дэргэд байгуулахаар заасан байдаг.
5	Катар	ХАУТ-ын дэргэд байгын арбитр байдаг.	Худалдаа аж үйлдвэрийн тухай хуулиар байгын арбитрыг танхимын дэргэд байхаар зохицуулсан.

5.Дорнын эрх зүйн системтэй улс орнууд

№	Улс орны нэрс	ХАҮТ-ын дэргэд байнгын арбитр байдаг эсэх, арбитрын тухай хуульд энэ талаар зохицуулалт бий эсэх	Тайлбар
1.	БНСУ	ХАҮТ-ын дэргэд байнгын арбитр нь байрладагүй.	Дотоодын ба олон улсын арилжааны маргааныг шударга хурдан шийдэх мөн энэхүү хуулиар гадаад эдийн засгийн хэлцлийн дэг журмыг бий болгох үүднээс Засгийн газраас Худалдаа аж үйлдвэрийн сайдын байгуулсан арилжааны арбитрын үйл ажиллагааг эрхлэх байнгын арбитрыг байгуулах зардлыг бүхэлд нь буюу хэсэгчлэн гаргана. Энэхүү хуулийг батлахаас өмнө үйл ажиллагаагаа эрхэлж байсан Солонгосын арбитрын зөвлөл нь Сайдын байгуулсан байнгын арбитр адил тооцогдох бөгөөд түүний дүрмийг Солонгосын Дээд шүүхэзс баталсан гэж тооцно.

Англи-саксоны эрх зүйн системтэй улс орнуудад байнгын арбитрын байгууллага танхимын дэргэд бус харин бие даасан хэлбэрээр, ихэвчлэн хууль зүйн товчооны хэлбэрээр байгуулагдсан байна. Харин Ром-Германы буюу эх газрын эрх зүйн системтэй улс орнууд болон пост социалист системтэй улс орнууд байнгын арбитрыг ХАҮТ-ын дэргэд байгуулахаар хуульчилсан байна. Социалист системтэй улс орнууд арбитрыг ямар байгууллага байгуулах болон түүний эрх зүйн зохицуулалтын талаар хатуу хуульчлан тогтоосон байхад Лалын буюу шашны эрх зүйн системтэй улс орнууд /Арабын улсууд/ Арбитрын Нэгдсэн Холбоо байгуулж түүгээр дамжуулан маргааныг хянан шийдвэрлэдэг байна. Мөн зарим шашны эрх зүйн тогтолцоот хөгжингүй улсууд арбитрын шүүхийг байгуулсан байна/.Арабын нэгдсэн Эмират улс, Египет гэх мэт/ Шашны эрх зүйн тогтолцоот улсууд шариатын хууль зэрэг шашны номлолыг үндэслэн маргааныг шийддэг тул талууд өөр бусад олон улсын арбитрын байгууллагаар маргаанаа шийдвэрлүүлэхээр тохиролцдог байна. Харин Дорнын эрх зүйн системтэй улс орнууд маргааныг шүүх, арбитраар шийдвэрлүүлэхээс илүү урьдчилж зуучлал, хэлэлцээний аргаар шийдвэрлэдэг практиктай байна[595].

[595] Мөн тэнд 81

2.3. АРБИТРЫН АЖИЛЛАГААН ДАХЬ ШҮҮХИЙН ОРОЛЦОО

Арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах, арбитрч томилуулах, татгалзан гаргах нь шүүхийн практикт ердийн журмаар шийдвэрлэгдэж байгаа бөгөөд ердийн журмаар гэдэг нь нэхэмжлэлээр болон гомдлоор хэрэг маргааныг хянан шийдвэрлэхийг хэлнэ.

Нэхэмжлэлээр болон гомдлоор үүсэх хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа нь иргэн, хуулийн этгээдийн материаллаг эрх зүйн харилцаа зөрчсөнтэй холбоотой маргаан шийдвэрлэхийг хэлэх ба хариуцагч сөрөг нэхэмжлэл гаргах, хариуцагч нэхэмжлэлээсээ татгалзах, хүлээн зөвшөөрөх, эвлэрэх гэх мэт хэргийн оролцогчдын нийтлэг эрх, үүргийг хүлээдэг.

Ердийн журмаар буюу нэхэмжлэл, гомдлоор үүссэн иргэний хэргийн зорилго нь иргэн, хуулийн этгээдийн эдийн болон эдийн бус баялагтай холбоотой зөрчигдсөн эрхийг сэргээх, эрхийн маргааныг шийдвэрлэхэд оршдог. Тиймээс манай Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай[596] хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-д "эдийн ба эдийн бус баялагтай холбоотой эрх нь зөрчигдсөн тухай эрх зүйн харилцаанд оролцогч этгээдээс гаргасан нэхэмжлэл", 12.1.2-т "бусдын эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалж шүүхэд мэдүүлэх эрх нь хуулиар олгогдсон этгээдээс гаргасан нэхэмжлэл"-д шүүх иргэний хэрэг үүсгэнэ гэж заасан байна.

Харин онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилго нь эрх зүйн ач холбогдолтой үйл явдал[597], үйлдлийг шүүхээс тогтооход орших ба энэ нь хүсэлт гаргагч буюу сонирхогч этгээд байхыг ойлгоно. ИХШХШТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1.3-т "Онцгой ажиллагааны журмаар хэрэг маргаан хянан шийдвэрлүүлэхээр хуульд заасан асуудлаар сонирхогч этгээдийн гаргасан хүсэлтээр" шүүх иргэний хэрэг үүсгэнэ гэснээс үзвэл Арбитрын тухай хуулийн 15.5, 17.4- дэх хэсэгт заасан зүйлүүд онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэж болох эрх зүйн үндэслэл болно.

Онцгой ажиллагааны журмаар хэрэг маргаан хянан шийдвэрлэх маргааны төрлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 133 дугаар зүйлд заасан ба үүнд:

133.1.1.эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоох[598];

133.1.2.хүнийг сураггүй алга болсонд тооцох буюу нас барсан гэж зарлах;

133.1.3.сэтгэцийн өвчний улмаас хүнийг эрх зүйн чадамжгүй болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэдэгийн улмаас хязгаарлагдмал чадамжтай гэж тооцох;

133.1.4. хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох;

133.1.5. асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцох;

133.1.6.эрх олгосон бичиг баримтыг үрэгдүүлснээс алдагдсан эрхийг сэргээх;

---

[596] "Төрийн мэдээлэл" сэтгүүл. 2002 он. №7-д нийтлэгдсэн.

[597] ИХШХШТХ-ийн 135 дугаар зүйлийн 135.1-д зааснаар "Иргэн, хуулийн этгээдийн эдийн ба эдийн бус баялагтай холбоотой эрх үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болоход шууд хамаарах үйл явдлыг эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдал гэнэ".

[598] ИХШХШТХ-ийн 135 дугаар зүйлийн 135.2-т заасан.

133.1.7.иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд буруу бичигдсэнийг тогтоох;

133.1.8.хэргийн буюу шийдвэр гүйцэтгэлийн үрэгдсэн материалыг сэргээх;

133.1.9.нэхэмжлэгчээс гаргасан хүсэлтийн дагуу хариуцагчийг эрэн сурвалжлах;

133.1.10. хуулийн этгээдийг дампуурсанд тооцох.

Онцгой ажиллагааны журмаар хэрэг маргаан хянан шийдвэрлэх шүүхийн зорилт нь тодорхой хууль зүйн үйл баримт байгаа ба байхгүй байгааг тогтоох, иргэний эрх зүйн тодорхой байдлыг хүлээн зөвшөөрөх, иргэний эрхийг сэргээн тогтоох замаар иргэн, хуулийн этгээдийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хамгаалахад оршино.[599] Өөрөөр хэлбэл, онцгой ажиллагаа[600] нь хэн нэгний зөрчигдсөн эрхийг сэргээх талаар шаарддаггүй, иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд үүссэн хэрэг /маргаан/ биш бөгөөд гэм хорыг арилгах, нөхөн төлбөр гаргуулах гэх мэтийг шаарддаггүй, зөвхөн тодорхой үйл явдлыг /факт/ тогтоолгох зорилготой.

Хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагаа нь хэд хэдэн онцлог шинжтэй:

1.Хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагаа нь иргэн, хуулийн этгээдээс гаргасан хүсэлтэд үндэслэнэ. Энэ хүсэлт нь ямар нэгэн этгээдээс хандаж гаргасан шаардлага биш. Бас зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох, маргаантай эрхийг хамгаалахыг шаарддаггүй.

2.Хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагаанд материаллаг эрх зүйн маргаан байдаггүйгээс улбаалан хэрэгт эсрэг сонирхолтой этгээд байдаггүй. Харин энэхүү ажиллагааны явцад иргэн, хуулийн этгээдийн эрх ашиг хөндөгдсөн тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлд зааснаар гуравдагч этгээдээр оролцож болно. Тухайлбал, арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах тухай талуудын хүсэлтийг хянан шийдвэрлэх явцад МҮХАҮТ-ын дэргэдэх Үндэсний арбитраас шүүх хуралдааны үед шүүхэд мэдүүлэх эрхээ[601] эдлэх бөгөөд энэ тохиолдолд гуравдагч этгээдээр оролцож байна гэж үзнэ.

3.Хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагаа нь эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдал болон иргэний эрх зүйн байдлыг тогтооно. Энэ нь эрх зүйн хамгаалалтыг хэрэгжүүлэх нөхцөл бололцоог бий болгодог[602].

Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдал тогтоох нь яагаад онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэж байгаа үндэслэлийг авч үзвэл:

[599] С.Нарангэрэл. "Эрх зүйн эх толь бичиг". Анхны хэвлэл. 353 дах тал

[600]С.Нарангэрэл "Эрх зүйн эх толь бичиг"-т дурдсанаар "Онцгой ажиллагаа" гэдэг нь сонирхогч талуудын хооронд эрх зүйн тухай маргаангүй талаархи иргэний шүүн таслах ажиллагааны онцгой төрөл.

[601]Нийслэлийн шүүхийн 2008 оны 17 дугаар тогтоол. Арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах тухай талуудын хүсэлтийг хянан шийдвэрлэхэд МҮХАҮТ-ын дэргэдэх Үндэсний арбитраас гуравдагч этгээдээр оролцож тайлбар гаргасан.

[602] Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар. Арван гуравдугаар бүлэг. 324 дэх тал.

Шүүхээр ердийн журмаар хянан шийдвэрлэгдэж буй хэрэг, маргаан нь иргэн, хуулийн этгээдийн эдийн ба эдийн бус баялагтай холбоотой, зөрчигдсөн эрхийг сэргээхтэй холбоотой байдаг бол онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэгдэж буй хэрэг нь эрхийн маргаангүй, зөвхөн тодорхой үйлдэл, үйл явдлыг тогтоолгох юм. Тухайлбал, арбитрч томилох, татгалзан гаргах тухай хүсэлт гаргагчийн эсрэг сонирхолтой этгээд байхгүй ба зарим тохиолдолд үндэсний арбитр гуравдагч этгээдийн хувиар шүүх хуралдаанд тайлбар хийдэг байна. Үүний гол мөн чанар нь арбитрын ажиллагаанд оролцогч талуудын хооронд үүссэн эрхийн маргааныг шийдвэрлүүлэхийн тулд түүний өмнө зайлшгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай бодит үйлдлийг тогтоолгоход оршино.

Арбитрын тухай[603] хуулийн 15 дугаар зүйлийн 15.5-д "Аль нэг тал нь арбитрч томилох тухай нөгөө талын хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор өөрийн талын арбитрчийг томилоогүй, эсхүл томилогдсон хоёр арбитрч 30 хоногийн дотор гурав дах арбитрчийг тохиролцон томилж чадаагүй бол сонирхогч талын[604] хүсэлтээр давж заалдах шатны шүүх тэдгээрийг томилно", 17.4-т "Талуудын тохиролцсон журам болон энэ хуулийн 17.2, 17.3-т заасны дагуу арбитрчийг татгалзан гаргаж чадаагүй бол сонирхогч тал тухайн арбитрын бүрэлдэхүүний шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор давж заалдах шатны шүүх болон байнгын арбитрын дүрэмд заасан эрх бүхий этгээдэд энэ тухай хүсэлт гаргаж болно" гэсэн нь эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтооход чиглэгдэж байгааг харуулж байна.

Арбитрч томилох, түүнээс татгалзах, арбитрын хэлэлцээрийг хүчин төгөлдөр бусад тооцуулах /Арбитрын тухай хуулийн 40.2.1/, арбитрын шийдвэрийг хүчин төгөлдөр бусад тооцуулах тухай талуудын хүсэлтийг шийдвэрлэхтэй холбоотой асуудлыг онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэж болох эсэх үндэслэлийг авч үзвэл:

Арбитрч томилох /Арбитрын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсэг/ "Аль нэг тал арбитрч томилох тухай нөгөө талын хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор өөрийн талын арбитрчийг томилоогүй, эсхүл томилогдсон хоёр арбитрч 30 хоногийн дотор гурав дахь арбитрчийг тохиролцон томилж чадаагүй бол сонирхогч талын хүсэлтээр давж заалдах шатны шүүх тэдгээрийг томилно" гэж заасан ба талууд арбитрын шийдвэрийг хараат бус, бие даасан, бодитой гаргах чадвартай байна гэдэгт талуудад итгэл үнэмшил төрүүлэх, хэрэг маргаанаа түргэн

[603] "Төрийн мэдээлэл" сэтгүүл. 2003 он. №20

[604] Арбитрын тухай хууль болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд "Сонирхогч тал" гэсэн нэр томъёог авч хэрэглэсэн байх бөгөөд Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиудад сонирхогч тал гэсэн нэр томъёог хэрэглэсэн зүйл байхгүй, Улсын дээд шүүхээс үүнтэй холбоотой албан ёсны тайлбар гаргаагүй байна. Сонирхогч тал гэдгийг Монгол хэлний тайлбар толинд хэрхэн тайлбарласныг авч үзвэл **"Сонирхогч"** гэдгийг сонирхдог хүнийг хэлнэ, **сонирхогч этгээд** гэж сонирхож буй талыг ойлгоно гэж тайлбарласан байна. Энэ нь ИХШХШТХ-ийн зохигчийн талаарх ойлголтыг агуулсан байх ба ИХШХШТХ-ийн 26 дугаар зүйлд заасаар "Хэргийн зохигч гэдэгт нэхэмжлэгч, хариуцагч хуульд заасны дагуу тэдгээртэй эрх зүйн хувьд ижил эрх, үүрэгтэйгээр хэрэгт оролцож байгаа этгээд хамаарна" гэжээ.

шуурхай шийдвэрлүүлэх ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл, маргаанаа богино хугацаанд шударга шийдвэрлүүлэх урьдач нөхцөлийг хангаж байгаа учир нь энэ нь эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдал болно. Шүүх арбитрчийг томилохдоо дараахь зүйлийг шалгуур болгоно. Үүнд:

1.Арбитрчаар томилох хүн нь хуульд заасны дагуу арбитрчаар томилогдох боломжтой эсэх;

2.Маргааныг бие даан, хараат бусаар шийдвэрлэх чадвартай эсэх;

3.Тухайн арбитрчаар томилох гэж буй хүн талуудын тохиролцсон шалгуурыг хангаж буй эсэх;

Шүүх эдгээр зүйлүүдийг нягтлан шалгасны үндсэн дээр арбитрчийг томилох тухай шийдвэр гаргана. Шүүх Арбитрын тухай хуульд заасан дээрхи асуудлыг шийдвэрлэхдээ аймаг, нийслэлийн шүүгчийн шүүгч захирамж /шүүх тогтоол/ гаргана. Эдгээр асуудлаар гарсан давж заалдах шатны шүүхийн шийдвэр эцсийн байна[605]. Тухайлбал, уг захирамж тогтоол хяналтын шатны шүүхэд хянагдахгүй гэж ойлгож болно.[606] Түр арбитрын хувьд Арбитрын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "арбитр нь байнгын болон түр хэлбэртэй байна", 5.7-д "Түр арбитрыг маргагч талууд тухай бүр бичгээр тохиролцон байгуулна" гэсэн нь түр арбитрт байгуулж болох эрх зүйн үндэс болох ба хуулийн 5 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасснаар байнгын болон түр арбитрын маргаан шийдвэрлэх ажиллагаа адил зарчмаар явагдана гэжээ. Дээрх заалтаас харвал түр арбитрын арбитрч томилох нь байнгын арбитрын адил зохицуулалт үйлчилнэ гэж болно. Шүүхээс арбитрч томилох эрх зүйн үндэслэл нь олон улсын арилжааны арбитрын тухай хуулийн загвар заалтын 11.3-т заасснаар талууд арбитрчаа томилж чадаагүй бол шүүх арбитрчийг томилно гэжээ. Энэ нь талуудад арбитрч томилох эрхийг олгосон боловч энэхүү эрхээ хэрэгжүүлж чадаагүй, эрхийн маргаанаа шийдвэрлүүлэх урьдач нөхцөлийг тогтоож чадаагүй тул шүүхээр тодорхой үйлдэл хийлгүүлэхээр гаргаж буй хүсэлт юм.

Арбитрчийг татгалзан гаргах /Арбитрын тухай хуулийн 17 дугаар зүйл/

Арбитрын тухай хуулийн 17 дугаар зүйлд татгалзан гаргах журмыг тодорхойлохдоо:

- Арбитрчийг татгалзан гаргах журмыг талууд харилцан тохиролцоогүй;
- Арбитрчийг татгалзан гаргах журмыг харилцан тохиролцсон боловч уг журмын дагуу арбитрчийг татгалзан гаргаж чадаагүй бол.

Дээрх хоёр тохиолдолд арбитрчийг татгалзан гаргах хүсэлтийг арбитрын бүрэлдэхүүнд бичгээр гаргаж болохоор хуульчилсан. Мөн арбитрчаар томилогдсон хүн арбитрчаас санаачилгаараа татгалзаж болно. Энэ тохиолдолд талууд зөвшилцсөнөөр татгалзан гарна. Үүнээс бусад

[605] Арбитрын тухай хуульд "Давж заалдах шатны шүүхийн шийдвэр" гэж заасан бөгөөд Монгол Улсын Дээд шүүхийн иргэний хэргийн танхимын "Арбитрын хуулийг давж заалдах шатны шүүхэд хэрэглэх талаар" гаргасан зөвлөмжид уг шийдвэр нь шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар гарна хэмээн тодорхойлжээ.

[606] "Хууль дэдлэх ёс" сэтгүүл. 2006 он. №2., 35 дахь тал.

тохиолдолд татгалзан гаргах эсэхийг тухайн арбитрын бүрэлдэхүүн шийдвэрлэнэ. Үүнтэй холбоотой хуулийн заалтаас үзвэл арбитрч санаачилгаараа татгалзсан бол тухайн арбитрын бүрэлдэхүүн шийдвэр гаргах шаардлагагүй, харин талууд зөвшөөрсөн тохиолдолд татгалзан гарсанд тооцож болохоор байна.[607]

Арбитрчийг татгалзан гаргаж чадаагүй тохиолдолд шүүх оролцох боломжийг Арбитрын тухай хуульд зохицуулсан ба сонирхогч тал арбитрын бүрэлдэхүүний шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор давж заалдах шатны шүүхэд хүсэлт гаргаж болно гэжээ. Харин шүүх дээрх хүсэлтийг хүлээн аваад хэрхэн шийдвэрлэх болон ямар шүүхийн шийдвэр эцсийн байх талаар заагаагүй, зөвхөн 17.5-д "Энэ хуулийн 17.4-т заасан маргаантай асуудлаар гаргасан эрх бүхий этгээдийн шийдвэр эцсийн байна" гэжээ. Арбитрчийг татгалзан гаргаж чадаагүйгээс шүүхээр арбитрч томилуулах асуудал нь арбитрын ажиллагаа явагдсаны дараа буюу арбитрчийг томилогдсоны дараах хүсэлт гэж ойлгож болно

Хэдийгээр арбитрч томилогдсоны дараах үйлдэл боловч энэ нь арбитрын шийдвэр үндэслэлтэй болоход шууд чиглэгдсэн эрх зүйн ач холбогдол бүхий үйлдэл болно.

Арбитрын тухай хууль батлагдсанаас хойш арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах тухай талуудын хүсэлтийн дагуу нийслэлийн шүүхийн хянасан хэргийн дотор арбитрын бүрэлдэхүүн томилохтой холбоотой гарсан маргаан нэг удаа гарсан бөгөөд /хэргийн дугаар 27 тоот[608]/ хариуцагч шүүхэд гаргасан хүсэлт, тайлбартаа " ... арбитрчийг татгалзан гаргах эсэх" асуудлыг шийдвэрлэхдээ арбитрын тухай хуулийн 18.1, 19.1, 15.4, 40.2.2 дахь хэсгийн заалтуудыг зөрчсөн гэжээ. Гэтэл талуудаас томилогдсон хоёр арбитрч гуравдагч арбитрчийг томилоход энэ талаар гомдол гаргаагүй арбитрын бүрэлдэхүүн хэргийг хянан шийдвэрлэхдээ дээрх хуулийн заалтуудыг зөрчөөгүй гэж үзээд арбитрын шийдвэрт ямар нэгэн өөрчлөлт оруулаагүй байна.

Арбитрын хэлэлцээрийг хүчин төгөлдөр бусад тооцуулах /Арбитрын тухай хуулийн 11 дүгээр зүйл, 40 дүгээр зүйлийн 40.2.1 дэх хэсэг/

Арбитрын хэлэлцээр гэж Арбитрын тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаар "гэрээний шинж, хэлбэр агуулсан эсэхээс үл хамааран аль нэг эрх зүйн харилцаатай холбогдон үүссэн буюу үүсч болох бүх төрлийн, эсхүл тодорхой төрлийн маргааныг арбитраар шийдвэрлүүлэх талаар талуудын хооронд хийсэн тодорхой төрлийн хэлцлийг хэлнэ". Иргэний хуулийн 39 дүгээр зүйлд "Иргэний эрх, үүргийг үүсгэх, өөрчлөх, шилжүүлэх, дуусгавар болгох зорилгоор хүсэл зоригоо илэрхийлсэн[609] иргэн, хуулийн

[607] Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлд шүүгч, иргэдийн төлөөлөгч, шинжээч орчуулагч, хэлмэрч шүүх хуралдааны нарийн бичгийн дарга хуульд заасан үндэслэл байвал татгалзан гарах үүрэгтэй бөгөөд татгалзан гарах асуудлыг шүүх бүрэлдэхүүн /шүүгч/ зөвлөлдөх тасалгаанд хэлэлцэж тогтоол /Захирамж/ гарган шийдвэрлэнэ.

[608] Нийслэлийн шүүхийн Иргэний хэргийн төв архив. 2008 оны хэргийн хавтас.

[609] "Хүсэл зориг" гэж тодорхой этгээдийн иргэний эрх, үүргийг үүсгэх, өөрчлөх, шилжүүлэх,

этгэздийн үйлдэл, эс үйлдэхүйг хэлцэл гэнэ" гэж тодорхойлжээ. Мөн Олон улсын арилжааны арбитрын хуульд "Арбитрын хэлэлцээр нь талуудын хооронд ямар нэг эрхийн харилцаатай холбоотой үүссэн буюу үүсч болох тодорхой маргааныг арбитрт шилжүүлэх тухай гэрээний шинжтэй эсэхээс хамаарахгүй тохиролцсон тохиролцоо мөн" гэж заасан. Үүнээс харахад арбитрын хэлэлцээр болон иргэний эрх зүйн хэлцэл нь агуулгын хувьд ижил буюу аль аль нь талуудын хүсэл зоригоо илэрхийлсэн байхыг шаарддаг.

Хэлцлийг амаар[610] болон бичгийн хэлбэрээр хийж болох ба бичгийн хэлцэлд талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болдог. Бичгээр хийсэн хэлцэл нь арбитрын хэлэлцээртэй агуулгын хувьд ижил байна. Улсын дээд шүүхийн иргэний хэргийн танхимын 2004 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр[611] гаргасан Арбитрын тухай хуулийг давж заалдах шатны шүүхэд хэрэглэх талаар зөвлөмжийн 7 дугаар зүйлд зааснаар Арбитрын хэлэлцээрийг дараахь тохиолдолд байгуулсан гэж үзнэ. Үүнд:

1.Талуудын гэрээ арбитрын тухай заалттай;

2.Талууд арбитраар маргаанаа шийдвэрлэхээр гарын үсэг зурсан баримт үйлдсэн;

3.Талууд арбитраар маргаанаа шийдвэрлүүлэхээр тохиролцсоныг нотлох хоорондоо солилцсон захидал, харилцаа;

4.Маргаан гарсны дараа арбитраар маргаанаа шийдвэрлэхээр тохиролцсон тохиролцоо зэрэг болно гэжээ.

Тухайлбал, талууд гэрээндээ *"Энэхүү гэрээ, түүнтэй холбоотой үүссэн буюу гэрээг хэрэгжүүлэх, зөрчих, хүчингүй болгохтой холбоотой аливаа маргааныг Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Үндэсний арбитрын шүүхээр, түүний хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу шийдвэрлүүлнэ"* хэмээн тусгаж болно.

Дээр дурдсаныг дүгнэн үзвэл арбитрын хэлэлцээр иргэний эрх зүй дэх хэлцлийн хэлбэрийг агуулсан буюу арбитрын хэлэлцээр нь иргэний эрх зүй дэх бичгийн хэлбэрээр байгуулсан хэлцэл гэж тайлбарлаж болох ба энэ талаар М.М. Богуславскийн "Олон улсын хувийн эрх зүй" номонд тэмдэглэгдсэн байдаг[612].

Дээд шүүхийн зөвлөмжид Арбитрын хэлэлцээр хүчин төгөлдөр эсэхийг тодорхойлоход дараах асуудлыг тодорхойлно:

1. Тухайн хэлэлцээрийг эрх зүйн чадамж бүхий этгэзд байгуулсан эсэх[613];

2. Тухайн хэлэлцээрээр арбитрын маргаан шийдвэрлэхээр тохиролцсон эсэх зэргийг анхаарч үзэх ба энэ шаардлагыг хангаагүй бол арбитрын хэлэлцээрийг хүчин төгөлдөр бусад тооцуулна.

Иргэний хуулийн 56 дугаар зүйлд хэлцлийг хүчин төгөлдөр бус байх

дуусгавар болгох буюу хэлцэл хийх эрмэлзэлийг хэлэх бөгөөд уг эрмэлзэлийн гадаад илэрлийг хүсэл зоригийн илэрхийлэл гэж ойлговол зохино.

[610] Талууд хэлэлцэн тохиролцсон, хэлцэл хийснийг нотолсон пайз, тасалбар зэргийг олгосон бол хүчинтэй байна.

[611] "Улсын дээд шүүхийн мэдээлэл" 2005 он. №1

[612] М.М.Богуславский *"Олон улсын хувийн эрх зүй"*. 2008 он. 450 дахь тал.

[613] Иргэний хуулийн 56 дугаар зүйлд заасан.

нөхцөлүүдийг заасан ба арбитрын хэлэлцээрийг хүчин төгөлдөр бусад тооцох үндэслэл нь мөн үүнд хамаарна. Иргэний хуульд зааснаар хүчин төгөлдөр бус хэлцлийг сонирхогч этгээдийн нэхэмжлэлээр анхан шатны шүүх хүчин төгөлдөр бусад тооцдог ба арбитрын хэлэлцээрийг талуудын гаргасан хүсэлтээр давж заалдах шатны шүүх хүчин төгөлдөр бусад тооцно. Хэлэлцээрийг хүчин төгөлдөр бусад тооцуулах нь зөрчигдсөн эрхийг сэргээхтэй шууд холбоотой ба онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэгдэх үндэслэлгүй. Учир нь, хэлэлцээр /хэлцэл/ нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-д зааснаар эдийн ба эдийн бус баялагтай холбоотой эрх нь зөрчигдсөн тухай эрхийн харилцаанд оролцогч этгээдээс гаргасан нэхэмжлэлээр иргэний хэрэг үүсгэдэг, нэхэмжлэл гаргагчийн эсрэг тал үүнийг эсэргүүцэх, хариу тайлбар гаргах гэх мэт эрхийг эдэлдэг. Энэ нь онцгой ажиллагааны журмаар хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны зорилго, онцлогтой нийцэхгүй тул хэлэлцээрийг хүчин төгөлдөр бусад тооцох нь шүүхэд ердийн журмаар хянан шийдвэрлэгдэнэ.

Арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах /Арбитрын тухай хуулийн 40 дүгээр зүйл/

Арбитрын тухай хуульд зааснаар Арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах тухай аль нэг талын гаргасан хүсэлтийг тухайн арбитрын ажиллагаа явагдсан газрын харьяа давж заалдах шатны шүүх хэлэлцэнэ. Шүүх талуудын хүсэлтийг хүлээн авч шийдвэрийг хүчингүй болгох эсэхийг шийдвэрлэх ба илэрхий байгаа зөрчлийг арбитрын бүрэлдэхүүнээр өөрөөр нь засуулах хүсэлт гаргасан бол шийдвэр дэх зөрчилтэй асуудлыг хянах тодорхой хугацаа шүүхээс тогтоож болно. Шүүх дараахь тохиолдолд арбитрын шийдвэрийг хүчингүй болгоно.

1.Арбитрын хэлэлцээр хүчин төгөлдөр бус бол;

2.Тухайн маргаан нь арбитрын харьяаллын маргаан биш байсан нь нотлогдсон;

3.Арбитрын бүрэлдэхүүн талуудын эрхийг хангаагүй;

4.Арбитрын ажиллагааны журмыг зөрчсөн;

5.Арбитрын бүрэлдэхүүн арбитрын хэлэлцээрт хамааралгүй асуудлаар шийдвэр гаргасан;

6.Арбитрын шийдвэр нь ordre public-т буюу нийтийн эрх ашиг сонирхолд нийцээгүй нь нотлогдсон.

Арилжааны арбитрын олон улсын загвар заалтын 34 дүгээр зүйлд "Арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулахаар шүүхэд хандсан үед хэрэв шүүх боломжтой гэж үзсэн эсхүл аль нэг тал хүссэн бол арбитрт хэрэг хянан хэлэлцэх ажиллагааг сэргээн явуулах боломж олгох, арбитрын шийдвэрийг хүчингүй болгох үндэслэлийг арилгах арга хэмжээ авахаар арбитр санал гаргасан бол шүүх шийдвэр гаргахаар тогтоосон хугацааг түдгэлзүүлж болно" гэж заасан.

Мөн ИХШХШТХ-ийн 168.1, 168.3 дах хэсэгт буюу шүүх хууль болон өөр хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй, хэргийн оролцогчдын шүүх хуралдаанд биечлэн оролцох боломжийг хангаагүй

хэрэг шийдвэрлэсэн, хэргийн оролцогчийн хуулиар олгогдсон эрхийг ноцтой зөрчсөн, хууль бус бүрэлдэхүүнтэй хэргийг хянан шийдвэрлэсэн, шийдвэрт шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зураагүй, эсхүл бүрэлдэхүүнд ороогүй шүүгч гарын үсэг зурсан, хуурамч нотлох баримт болон нотлох баримтыг шүүх дутуу үнэлсэн бол анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон бол давж заалдах журмаар хянан хэлэлцсэн шүүх тухайн хэргийг дахин шийдвэрлүүлэхээр анхан шатны шүүхэд буцаана гэсэн нь Арбитрын тухайн хуулийн 40 дүгээр зүйлд заасан үндэслэлээр арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах нь эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоох бус зөрчигдсөн эрхийг сэргээх үйл явдал учир ердийн журмаар шийдвэрлэдэг болохыг харуулж байна. Тиймээс Онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх үндэслэлгүй юм.

Давж заалдах шатны шүүхэд 2006 онд 4 удаа, 2007 онд 6, 2008 онд 7, 2009 онд 2 удаа тус бүр арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах тухай гомдол ирсэн ба үүнд, талуудын эрх тэгш байх зарчмыг хангаагүй, нотлох баримтыг тал бүрээс бүрэн бодитой шинжлэн судлаагүй, арбитраас гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах тухай шүүгчийн захирамжийг хүчингүй болгуулах тухай гэх мэт хүсэлтүүд нийтлэг байлаа.

Дээрхийг дүгнэн үзвэл арбитрч томилох, татгалзан гаргахад онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэж болох ба харин хэлэлцээрийг хүчин төгөлдөр бусад тооцуулах, арбитрын шийдвэрийг хүчингүйд тооцуулах тухай талуудын хүсэлтийг давж заалдах шатны шүүх хянан шийдвэрлэхдээ ердийн журмаар шийдвэрлэх талаар дээр дурьдсан.

ЗАРИМ ГАДААД УЛСЫН ИРГЭНИЙ ПРОЦЕССЫН ХУУЛЬ ДАХЬ ОНЦГОЙ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ЗОХИЦУУЛАЛТ

1. Хятадын иргэний процессын хуулийн 12 дугаар бүлгийн 166 дугаар зүйлд[614] онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх хэрэг маргааны төрлийг заасан ба үүнд:

- Сонгогчийн эрхийг хязгаарласантай холбоотой маргаан;
- Иргэнийг сураггүй алга болсонд тооцох болон иргэнийг нас барсанд тооцох тухай;
- Иргэний эрх зүйн чадвар, чадамжийг хязгаарласан болон чадвар чадамжгүйд тооцох;
- Эзэнгүй болон гээгдэл эд хөрөнгийг тодорхойлох гэх мэтийг онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэдэг бөгөөд үүнээс бусад маргааныг ердийн журмаар шийдвэрлэдэг байна.

2. ОХУ-д Иргэний процессын хуулийн 22 дугаар зүйлд[615] зааснаар арбитрын шүүхээс гарсан шийдвэр болон гадаад улсын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэхтэй холбоотой хэргийг шүүх хянан шийдвэрлэнэ гэж заасан ба тус хуулийн 262 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар дараахь хэргийг онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэнэ гэжээ. Үүнд:

[614] http://www.novexcn.com/civil_procedure_law.html /сүүлд үзсэн 2011.03.29/
[615] http://www.russland.no/filestore/138FZ.10.doc /сүүлд үзсэн 2011.03.29/

- Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоох;
- Хүүхэд үрчлэх;
- Иргэнийг нас барсан болон сураггүй алга болсныг тогтоох:
- Насанд хүрээгүй буюу 14-18 хүртэлх насны иргэний бүрэн ба бүрэн бус чадамжийг хязгаарлахтай холбоотой хэргийн талаар;
- Иргэний чадвар чадамжийг тогтоох;
- Эд хөрөнгө тогтоох болон сонгуулийн эрхийг тогтоох;
- Бичиг баримт алдагдсанаас учирсан эрх сэргээх;
- Нотариатын үйлдэлтэй холбоотой маргаан;
- Сэтгэцийн өвчний улмаас иргэнийг сэтгэцийн эмнэлэгт хэвтүүлэх, гаргах;
- Иргэний эрх зүйн байдлыг өөрчлөх, засах.

Дүгнэлт

1.Монголын үндэсний арбитр нь 1960 онд анх үүссэн бөгөөд 1995 онд Гадаад худалдааны арбитрын тухай хууль батлагдсанаар гадаад худалдаа, эдийн засгийн хэлцлээс vvдсэн болон гадаадын хөрөнгө оруулалттай компанийн vvсгэн байгуулагчдын хооронд vvссэн маргааныг хянан шийдвэрлэх Гадаад Худалдааны Арбитр нэртэй байгуулагдан ажиллаж байв. Үүний дараа 2003 онд Арбитрын тухай хууль шинэчлэгдэн батлагдсан нь олон талын ач холбогдолтой болсон. Тухайлбал, арбитрын маргаан шийдвэрлэх харилцаанд оролцож байгаа маргагч талуудад илүү өргөн эрхийг олгосон буюу талууд өөрсдөө тохиролцож, нэгдсэн шийдэлд хүрсэн тохиолдолд ямар ч журмаар асуудлыг шийдэх боломжийг олгосон. Гэсэн хэдий ч Үндэсний арбитрын жилд шийдвэрлэж байгаа маргаан нь харьцангуй бага буюу иргэн, хуулийн этгээдийн арбитрын талаарх мэдлэг хомс байгаа нь судалгаанаас харагдаж байна. Арбитраар маргаан шийдвэрлүүлсэн иргэн, хуулийн этгээд нь арбитрын давуу талуудыг мэддэг боловч арбитрын зардал харьцангуй их байдаг тул дахин арбитрт хандахад эргэлзээ төрүүлж байна.

Шүүхээр маргаан шийдвэрлүүлэх эрх зүйн орчин арбитртай харьцуулахад илүү төлөвшсөн, шийдвэрт гомдолтой гэж үзвэл дараагийн шатанд хянуулах боломжтой байдаг тул шүүх нь арбитраас давуу талтай байдаг гэсэн ойлголт иргэдэд байдаг ба арбитрын ажиллагаанд оролцдог мэргэшсэн арбитрч нар нь Монгол Улсад байнгын болон түр арбитрын аль аль нь ашигтай гэж үздэг байна.

2.Олон улсын хэмжээнд арбитрын байгууллагын хэлбэр олон янз байна. Англо-Саксоны ба Ром-Германы эрх зүйн бүлийн тогтолцооны тухайд ангилж үзэхэд Англо-Саксоны эрх зүйн системтэй орнуудад арбитрын байгууллага гол төлөв хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр, харин Ром-Германы системийн тухайд ихэвчлэн нийгмийн нэгдэл бүхий хуулийн этгээдийн эсхүл худалдааны танхимын дэргэд /харьяа/ байгуулагддаг байна.[616]

[616] Japanese Arbitration Law http://iask.sina.com.cn/b/17830295.html /сүүлд үзсэн 2011.03.10/

3.Арбитрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа 2003 оны Арбитрын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн "Байнгын арбитрыг худалдаа аж үйлдвэрийн танхим, үйлдвэрлэгчдийн болон хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, тэдгээрийн нэгдлийн дэргэд байгуулж болно" гэсэн заалтыг хүчингүй болгохоор тусгасан нь байнгын арбитрыг хэн, хэрхэн, байгуулах нь тодорхойгүй болох төдийгүй эрх зүйн бүлийн хувьд авч үзвэл манай улсад тохирохгүй.

Олон улсын түвшинд АНУ-д Америкийн Арбитрын Холбоо, Англид Лондоны Олон Улсын Арилжааны Шүүх, Японд Арилжааны арбитр зэрэг эдийн засгийн хөгжил, эрх зүйн төлөвшилтөөр дээгүүр, өндөр хөгжилтэй улс орнууд байнгын арбитрыг бие даасан институт гэж үзэн, аливаа байгууллагаас хараат бус, бие даасан байдлаар байгуулахаар зохицуулжээ[617]. Энэ нь арбитрын хөгжил, үзэл баримтлал тогтвортой хөгжсөн, нэг мөр болсонтой холбоотой юм[618].

Харин манай улсын хувьд: Ром-Германы эрх зүйн бүлд хамрагддаг, эдийн засгийн хөгжил нь өндөр хөгжөөгүй, иргэд нь эрх зүйн төлөвшил бага, арбитрын тухай мэдэгдэхүүн багатай зэргийг харгалзан үзэж арбитрыг бие даасан, аль нэг байгууллагаас хараат бусаар байгуулах нь төдийлөн оновчтой бус байна.

4.Удирдамжийн гурав дахь хэсэгт дурьдсаныг бүхэлд нь шүүх онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх үндэслэлгүй. Тухайлбал, Арбитрын шийдвэрийг хүчингүйд тооцуулах, хэлэлцээрийг хүчин төгөлдөр бусад тооцуулах, маргааны харьяалал тогтоох тухай талуудын хүсэлтийг шүүх онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх боломжгүй бөгөөд энэ нь иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээхтэй холбоотой маргаан юм. Харин арбитрчийг томилуулах, татгалзан гаргах нь эсрэг сонирхолтой этгээд байдаггүй, өөрөөр хэлбэл, арбитрч томилох болон татгалзан гаргах эрхийг талуудад олгосон болөвч тэрхүү эрхээ хэрэгжүүлж чадаагүй байдаг тул шүүх онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх нь онолын хувьд үндэслэлтэй юм.

Санал:

1. Арбитрын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Байнгын арбитрыг худалдаа, аж үйлдвэрийн танхим, үйлдвэрлэгчдийн болон хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, тэдгээрийн нэгдлийн дэргэд байгуулж болно" гэсэн заалтыг өөрчлөх шаардлагагүй.

[617] Арбитрын тухай хуулийн төслийг УИХ-аас хэлэлцэхэд зориулсан зарим, санал, судалгааны материал. МҮХАҮТ 2003 он. 80 дахь тал
[618] Мөн тэнд

2. ИХШХШТХ-ийн 133 дугаар зүйлийн "Онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх хэргүүд" гэсний 133.1.11-д "Арбитрчийг томилуулах, арбитрчийг татгалзан гаргах" гэж нэмэх.
3. МҮХАҮТ-ын дэргэдэх Үндэсний арбитр нь өөрийн үйл ажиллагааны шүүхээс ялгагдах давуу талыг олон нийтэд зөв таниулан сурталчлах, хэвлэмэл материал тараах, мөн сонин, сэтгүүл, радио, телевизээр сурталчлах, зохиомжит нэвтрүүлэг хийх зэрэг таниулах үйл ажиллагаа явуулах.

4. Арбитрт хандах иргэн, хуулийн этгээдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор бодит байдалд нийцүүлж Арбитрын ажиллагааны зардлыг оновчтой тогтоох асуудлыг хуульчлах.

__oOo__

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

III БҮЛЭГ

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ, КРИМИНОЛОГИЙН СЕКТОР

ХУУЛЬЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

"ХҮҮХЭД, ГЭР БҮЛ, НИЙГМИЙН ЁС СУРТАХУУНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН, НӨХЦӨЛ"[619]

УДИРТГАЛ

Энэхүү судалгааны ажлын зорилго нь Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн хүрээнд гэр бүл, тэр дундаа эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг үйлдэж байгаа гэмт хэргийн сэдэлт, үйлдлийн арга нь улам харгис шинжтэй болж байгаа талаар гол төлөв гадны санхүүжилттэй төрийн бус байгууллагаас үе үе ноцтой түгшүүр зарлан хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж байгаатай холбогдуулан "Хүүхэд гэр бүл нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг" буюу Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлэгт заасан зарим төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг бодитой судалж тогтоох явдал байв.

Судалгааны хамрах хүрээ: Монгол Улсын хэмжээнд хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг зарим төрлийн гэмт хэргийн гаралт, тэдгээрийн шалгаж шийдвэрлэсэн байдлын хүрээнд хийлээ. Үүнд: Эрүүгийн хуулийн

- ✓ 114 дүгээр зүйл. Насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах
- ✓ 115 дугаар зүйл. Насанд хүрээгүй хүнийг соглуурал, мансуурал, биеэ үнэлэх, тэнүүчлэл, гуйланчлалд татан оруулах
- ✓ 118 дугаар зүйл. Асран хамгаалах үүргээ урвуулах
- ✓ 121 дүгээр зүйл. Хүүхдийг албадан болон хүчээр хөдөлмөрлүүлэх
- ✓ 122 дугаар зүйл. Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх
- ✓ 123 дугаар зүйл.Садар самууныг сурталчлах
- ✓ 124 дүгээр зүйл. Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах
- ✓ 125 дугаар зүйл. Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах
- ✓ 126 дугаар зүйл. Хүчиндэх
- ✓ 129 дүгээр зүйл. Булш сүйтгэх

Судалгааг эх сурвалж болох баримт бичгийн задлан шинжилгээ, кейс судалгаа, газар дээр нь ажиглах, асуух зэргээр эмперик түвшинд явуулав.

Бичиг баримтын судалгааг явуулахдаа Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, судалгааны төвөөс гаргасан гэмт хэргийн статистикийн үзүүлэлт, Хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудаас явуулсан судалгааны дүн, тайланг ашиглав.

Санал асуулгын судалгаа шүүх прокурор, цагдаагийн байгууллагад ажилладаг 300, төрийн бус байгуулагуудын төлөөлөл болох 200, нийт 500 хүмүүсийн дунд анкетын болон ярилцлагын судалгаа явуулав.

Кейс болон практик судалгаа: Үйлдэгдсэн, шалгагдаж байгаа тодорхой хэрэг, үйл баримтыг судлаж, тухайн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийн

[614] Цагдаагийн Ерөнхий Газрын Мэдээлэл дүн шинжилгээний төвийн ахлах байцаагч Б.Мөнхдорж, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрүүгийн эрх зүй, криминологийн секторын ЭША Г.Оюунболд нар хамтран хийсэн болно.

талаар бичигдсэн мэдэгдэл, сэтгэл зүйч, нийгмийн ажилтны тодорхойлолтыг цуглуулах, дүн шинжилгээ хийх, насанд хүрэгчдийн хохирогчидтой мэргэжилтнүүдийн туслалцаатайгаар ганцаарчилсан ярилцлага хийх хэлбэрээр явагдав.

Судалгааны тайлан

2000-2009 оны статистик үзүүлэлтүүдэд хийсэн дүн шинжилгээ: 2002 оноос хойшхи 8 жилийн хугацаанд хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг **3145** гэмт хэрэг бүртгэгдсэн нь нийт гэмт хэргийн 2.0 хувийг эзэлж байна.

Дээрх гэмт хэрэг 2006 хүн хүртэл буурч, 2006-2008 онд өсч, 2009 онд буурсан байгаа нь энэ төрлийн гэмт хэрэг өсөх, буурах байдлаар тогтонги түвшинд байна гэж үзэж болно.

Дээрх хүснэгтдүүдийг үзвэл энэ төрлийн гэмт хэрэг тедийлөн буурахгүй, тогтвортой гарах хандлагатай байгаа болох нь ажиглагдаж байна. Статистик үзүүлэлтийг зөвхөн бүртгэгдсэн гэмт хэргийн тухайд гаргадаг учраас энэ төрлийн гэмт хэргийн бодит нөхцөл байдлыг тогтоохдоо санал асуулгын судалгааны аргуудаар тодотгож, зарим нуугдмал гэмт хэргийг тохиолдол буюу кейс байдлаар судлав.

хуулийн үндэсний хүрээлэн www.legal.gov.mn

2003 оноос хойшх хугацаанд хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэргийг Эрүүгийн хуульд заасан зүйл бүрээр авч үзвэл:

№	Он	ХГБН ЕЭГХ	Өсөлт, буурал		Үүнээс: Эрүүгийн хуулийн зүйлээр																
			Хувь	Тоо	114	115	116	117	118	119	120	121	122	123	124	125	126	127	128	129
1	2003	430	0.7	3		5		10	1	9						10	386	1	4	4
2	2004	408	-5.1	-22	1	1		4	1	1			11	2	2	5	378		1	1
3	2005	352	-13.7	-56		1		1		3			9	3	2	8	320			5
4	2006	343	-2.6	-9		1		4		2			10		4	6	314		2	
5	2007	384	12.0	41				2		1			4		10	11	355			1
6	2008	426	10.9	42		1		6	1	2		1	14		27	19	354			1
7	2009	375	-12.0	-51				5		1			9	1	10	15	332		1	1
Нийт дүн		**2718**			**1**	**9**	**0**	**32**	**3**	**19**		**1**	**57**	**6**	**55**	**74**	**2439**	**1**	**8**	**13**
Дундаж		**388**																		
2010.08 сар		267						10					12		4	14	224		2	1

Дээрх хүснэгтээс үзэхэд 2003-2009 онд 2718 буюу жилд дунджаар 388 гэмт хэрэг бүртгэгджээ. Үүний 90 орчим хувь нь хүчиндэх, 2.7 хувь нь бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, 2.1 хувь нь арван зургаан насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдсэн, 2.0 хувь нь биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах, 1.2 хувь нь хүүхэд хаях, төөрүүлэх гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл

Эрүүгийн хуулийн 114 дүгээр зүйл. Насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах: Насанд хүрээгүй хүнийг хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж, хууран мэхлэх замаар гэмт хэрэг үйлдэхэд татан оруулсан гэмт хэрэг сүүлийн 8 жилд 1 удаа бүртгэгджээ. Ихэвчлэн тодорхой хэргийн ард давхар зүйлчлэгддэг шалтгаанаар ингэж бүртгэсэн байж болох тухай хуулийн байгууллагын алба хаагчид дурдаж байна.

Тухайлсан шүүхийн шийдвэрээс жишээлэн дүгнэж үзэхэд[620] нэг дүүрэгт л гэхэд жилдээ 6-8 хэрэгт насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэрэг үйлдэхэд татан оролцуулсан үйлдэл давхар зүйлчлэн гэмт этгээдэд ял шийтгэсэн байна. Ирүүлсэн тоон мэдээлэл шүүхийн шийдвэрийн харьцуулсан судалгаа илт ялгаатай байгаа нь цагдаа, прокурор, шүүхийн тоо бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой юм.

[620] 2004 онд насанд хүрээгүй хүмүүст холбогдох эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийн эмхэтгэлээс

Эрүүгийн хуулийн 115 дугаар зүйл. "Насанд хүрээгүй хүнийг согтуурал, мансуурал, биеэ үнэлэх, тэнүүчлэл, гуйланчлалд татан оруулах": Насанд хүрээгүй хүнийг согтуурал, мансуурал, тэнүүчлэл, гуйланчлал болон биеэ үнэлэхэд татан оруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэхээр заажээ. Уг хэргийг насанд хүрээгүй хүнийг хүмүүжүүлэх үүргийг хуулиар хүлээсэн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч үйлдсэн бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэхээр байна.

Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг нь өмчийн эсрэг болон хүний нэр төр, алдар хүндийн эсрэг гэмт хэрэгтэй харьцуулахад нуугдмал байдгаас шалтгаалж хуулийн байгууллагуудаар шийдэгдэж байгаа нь цөөн байна. Судалгааны дүнгээс үзэхэд Улаанбаатар хот болон хилийн боомтын хот, суурингуудад хүүхдийн бэлгийн мөлжлөгтэй холбоотой хэрэг нэмэгдэж, орон нутагт үйлдэгдэж байгаа гэмт хэрэг илэрдэггүй нь ярилцлагын судалгааны явцад тогтоогдов. Харин 2002 оноос хойш бүртгэгдсэн гэмт хэрэг ердөө 9 байна.

Бэлгийн мөлжлөгт өртсөн охидын нэлээд нь гэр бүл дэх хүчирхийлэл, зөрчилдөөний улмаас орон гэрээсээ дайжсан хүүхдүүд байдаг. 2008 оны ХҮЭК-ийн тайлангаас үзэхэд олон жил тэнэмэл амьдарлаар айл, халамжийн төв дамжин амьдардаг, хөдөө орон нутгаас нийслэлд нүүж суурьшсан, ядуу өрхийн сургууль завсардсан, гэр бүлийн хүчирхийлэлд өртдөг, зах дээр хөдөлмөр эрхэлдэг, эцэг эх нь салсан, хойд эцэгтэй охидууд бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд илүү ихээр өртөж байна[621].

Хүүхдийг бэлгийн мөлжлөгт ашиглагчдын ихэнх нь зах дээр хувиараа хөдөлмөр эрхлэгчид, гудамжинд амьдрагчид, үе тэнгийн хөвгүүд, архинд донтогчид байгаа нь сэтгэл түгшээж байна[622]. Өсвөр насны охидын дунд бусдыгаа бэлгийн мөлжлөгт зуучлах, уруу татах явдал цөөнгүй байгаа төдийгүй гэмт хэрэг үйлдсэн этгээдийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх талаар явуулж буй төрийн бодлого үйл ажиллагаа хангалтгүй байна[623].

Эрх зүйн орчин: Монгол Улсын Дээд шүүхээс: "124 дүгээр зүйлийн 124.1-д заасан ***"биеэ үнэлэхэд татан оролцуулсан" гэж шунахай болон хувийн бусад сэдэлтээр,...хохирогчийг бусадтай бэлгийн харьцаанд төлбөртэй оруулахыг хэлнэ"***. гэзд Эрүүгийн хуулийн 115 дугаар зүйлийн 115.1-д заасан "биеэ үнэлэхэд татан оруулсан" гэдгийг дээрхтэй нэгэн адилаар ойлгож, хэрэглэнэ" гэж тайлбарлажээ.

---

[621] ХЭҮК-ийн тайлан. УБ.,2008 он. 46 дах тал.

[622] Мөн тэнд

[623] Хүн амын сургалт, судалгааны төв, 2005он. ОУХБ/АЙПЕК-ийн санхүүжилттэйгээр хийгдсэн

Хүүхдийн биеийг үнэлүүлсэн этгээд насанд хүрсэн хүний биеийг үнэлүүлснээс хөнгөн ял шийтгэгдэхээр хуульчилсан ба хүүхдийн биеийг бусдад төлбөртэй үнэлүүлж мөлжих нь "хөнгөн" гэмт хэрэгт тооцогдож байна. Энэ нь хүүхдийн эрхийг хэт дорд үзсэнээс гадна Эрүүгийн хуулийн "гэм буруутай этгээдэд үйлдсэн гэмт хэрэгт нь тохирсон хариуцлага хүлээлгэх" зарчимтай нийцэхгүй байна.

"Насанд хүрээгүй биеэ үнэлэгч" гэсэн ойлголт байх ёсгүй бөгөөд насанд хүрээгүй хүнийг бэлгийн харьцаанд төлбөртэй оруулсан тохиолдол бүрийн цаана хүүхэд хэн нэгэн этгээдийн эрхшээлд байдаг шинжийг хууль тогтоогч орхигдуулснаас гэмт этгээдүүдэд ял завших, энэ төрлийн гэмт хэргийг өөгшүүлэх боломжийг бүрдүүлж байгааг анхаарах хэрэгтэй. Хууль тогтоогч ямар шаардлагын улмаас насанд хүрээгүй хүнийг бэлгийн харьцаанд төлбөртэй оруулж мөлжих үйлдлийг "биеэ үнэлэхэд татан оролцуулах" гэж үзэх болсон, яагаад хөнгөн гэмт хэрэгт тооцсон, ямар шалтгааны улмаас Эрүүгийн хуулийн 115 дугаар зүйлд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж болгон авч үзсэн нь тодорхойгүй байна.

Эрүүгийн хуулийн 118 дугаар зүйл. Асран хамгаалах үүргээ урвуулах: Бага насны хүүхдийг гудамжинд суулгаж мөнгө нь олдог эцэг, эхчүүд цөөнгүй байдаг. Эдгээр хүүхдийн эрх ашгийг хамгаалж хуулийн байгууллагад хэн гомдол гаргах вэ, ЭБШ ажиллагаанд хэн хүүхдийг төлөөлж оролцох вэ зэрэг хүндрэлтэй асуудал үүсэж байна. Энэ тохиолдолд тухайн харъяалах хорооны нийгмийн ажилтан хүүхдийн өмнөөс гомдол гаргаж ЭБШ ажиллагаанд оролцож, хүүхдийн эрх ашгийг хамгаалах боломжтой гэж үздэг.

Эрүүгийн хуулийн 118 дугаар зүйл "Асран хамгаалах үүргээ урвуулах" гэмт хэргийн хувьд субъектив талаас шалтгаалж хэрэг үүсгэх боломжгүй байгааг өөрчлөх хэрэгтэй. 118.1-д "...эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хуулиар хүлээсэн асран хамгаалах үүргээ шунахай зорилгоор урвуулан ашиглаж" гэж бүрэлдэхүүнийг тодорхойлсон нь практик дээр ямар хүндрэл дагуулж байна гэхээр хууль зөрчсөн этгээдүүд өөрсдийгөө өмөөрч надад ямар ч шунахайн сэдэлт байхгүй, амьдралын төлөө л явж байна гэхэд цааш нь шалгах боломжгүй болж байна.

Эрүүгийн хуулийн 121 дүгээр зүйл. Хүүхдийг албадан болон хүчээр хөдөлмөрлүүлэх: Хүүхдийг албадан болон хүчээр хөдөлмөрлүүлсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд судалгаагаар хот суурин газар дахь хүүхдийн хөдөлмөрийн төрлүүд, тэдгээрийн дотроос тэвчишгүй хэлбэрт тооцогдох хөдөлмөрийн хэв шинж байсаар байна. Хот суурин газрын албан ёсны хэвшилд хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн талаар улсын хэмжээний нэгдсэн статистик байхгүй боловч 2004 онд УМХГ-аас зарим аймгийн албан байгууллагад хийсэн шалгалтаар тэдгээр байгууллагуудад 18-аас доош насны 109 хүүхэд хөдөлмөр эрхэлж байжээ. НМХГ-ын 2007 оны мэдээгээр 117 хүн үйлдвэрлэлийн осолд орсны 4 нь 18-аас доош насны хүүхэд байжээ.

Улаанбаатар хот болон бусад төвлөрсөн сум суурин газруудад нийтдээ 6950[624] орчим хүүхэд хүүхэд хөдөлмөр эрхэлж[625] байгаагийн 4600 орчим нь Улаанбаатар хотод байна. Хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдийн 24.3 хувь буюу 1200 орчим[626] нь тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлж байна. Аймгуудын Хүүхдийн төвийн мэдээгээр *"албан бус хэвшилд 2334 хүүхэд хөдөлмөр эрхлэж байна"* гэжээ. Хот суурин газрын хүүхдийн хөдөлмөрийн голлох төрлүүд нь жижиглэнгийн худалдаа, ачаа зөөх, үүрэх, вагон түрэх, хоёрдогч түүхий эд цуглуулах, утсаар яриулах, мод хөрөөдөх, хагалах, автомашин угаах, харах, авто засвар, нийтийн хоолны газруудад ажиллах, нийтийн тээвэрт мөнгө хураах, урлаг, хувцас загварын үзүүлбэрт оролцох, цэвэрлэгээ хийх, айлд гэрийн үйлчлэгч хийх, хүүхэд харах зэрэг хэлбэртэй байна.[627]

5-17 насны хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, хот хөдөөгөөр



Үүнээс харахад гэрээсээ гадуур цалин хөлсгүй хөдөлмөр эрхэлдэг хөдөөгийн хүүхийн эзлэх хувь хотынхоос 1.2 пунктээр илүү байна. Орон нутагт хүүхдийг албадан болон хүчээр хөдөлмөрлүүлсэн хэргийн шийдвэрлэгдсэн баримт үгүй боловч тодорхой тохиолдлуудад энэ гэмт хэрэг гарч байгаа нь илэрхий байна.

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагааны явцад нотлоход хүндрэл бэрхшээлтэй зүйлүүд их гардаг, хүүхдийг хүчээр болон албадан хөдөлмөрлүүлдэг субъект нь ихэвчлэн садан төрөл, эцэг эх, хамаатан байх нь элбэг байна. Мөн ЭБШХ-д гэрч, хохирогчийг хамгаалсан заалт байхгүй шахам байгаагаас тэднийг эд мөнгөөр татах, хахуульдах, айлган сүрдүүлэх зэргээр байцаан шийтгэх ажиллагаанд нөлөөлж улмаар

[624] Тоог аймгуудын Цагдаагийн хэлтсийн хүүхдийн байцаагчид, Хүүхдийн төлөө төвүүдийн мэдээлэл, УМХГ-ын 2006 онд хийсэн бүртгэл, судалгааны дүн, МЭ консалтинг компанийн хийсэн "Улаанбаатар хот болон сонгогдсон хот суурин газруудын албан бус хэвшил дэх хүүхдийн хөдөлмөрийн суурь судалгаа"-ны дүнг харьцуулан гаргасан болно.

[625] Хөдөө аж ахуй, уул уурхайн салбарт хөдөлмөр эрхэлдэг, бэлгийн мөлжлөг, садар самууны сурталчилгаанд оролцдог хүүхдийн тоог хасав.

[626] Улаанбаатар хотын хөдөлмөр эрхлэгч хүүхдийн тооноос хөдөлмөрийн хэв шинжийн хувьд мөлжлөгийн чанартай олон цагаар үргэлжилсэн, хүнд нөхцөлтэй, хүүхдийн бие махбодь, эрүүл мэнд, сэтгэл санаад муугаар нөлөөлөхүйц, болвсрол олоход нь саад болохуйц ажил эрхэлж буй хүүхдийн тоог ялгаж тооцов.

[627] Монгол улс дахь хүний эрх чөлөөний байдлын илтгэл.,ХЭҮК. 2008 он

хэрэг нь хэрэгсэхгүй болж байгааг энэ төрлийн 10 гэмт хэргийн 7 нь хэрэгсэхгүй болсон тоо баримтаас харж болно.

Кейс: *1998 онд Говь Алтай аймгийн Цогт сумын иргэн Ц-гийн хүүг Өвөрхангай хүртэл мал туулган, хөлсөнд нь 10 ямаа өгөх, 12 сард гэрт нь буцаахаар тохиролцжээ. Гэтэл 4 жилийн хугацаанд хүүг буцаалгүй хүчээр хөдөлмөрлүүлж, байнга зодож дарамталж байжээ. Энэ талаар хөрш айл нь мэдэж хүүг оргуулан эгчийнд нь хүргэж өгчээ. Энэ талаар 2003 онд ХЭҮТ-д гомдол гарган шийдвэрлүүлж, хохирлыг нь барагдуулсан байна*[628] *Энэ мэт үйл баримтууд олон.*

Шийдэгдээгүй, шалгагдаагүй хэргийн ар талд хүүхэд ахин сэтгэл санаа, бие эрхтнээрээ хохирох, гэмт этгээдүүд ял завших байдлууд байсаар байдаг. Хүүхдийг албадан болон хүчээр хөдөлмөрлүүлсэн тохиолдол болгонд эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байвал[629] цаашид энэ гэмт хэргээс урьдчилан сэргийлж, хүүхдийн хөдөлмөрийн мөлжлөгийг устгахад том алхам болох юм.

"Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх" /Эрүүгийн хуулийн 122 дугаар зүйл/

"Хохирогчийг арван зургаан насанд хүрээгүй гэдгийг мэдсээр байж хурьцал үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хоёр зуун тавин нэгээс гурван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ".

Судалгаанаас үзэхэд 2003-2009 оны хооронд энэ төрлийн гэмт хэрэг 57 удаа гарчээ. 2008, 2009 онд энэ гэмт хэрэг өссөн дүнтэй гарсан ба цаашид нэмэгдэх хандлагатай байна. Хуульчидтай хийсэн ярилцлагаас үзэхэд "яагаад заавал 16 нас" гэж тогтоосон нь ойлгомжгүй байна 18 гэж тогтоож болоогүй юм уу гэж дурджээ. Хууль тогтоогчоос 16 нас гэдгийг ямар шалгуураар, ямар үндэслэлээр ийнхүү авч үзсэн нь тун ойлгомжгүй байна. Энэ гэмт хэрэг нь ихэвчлэн гэмт хэргийн бүрэлдхүүний субьектив шинжээр тогтоогддог учраас хуулийн байгууллагаар шалгагдаж шийдвэрлэгдсэн нь цөөн байна. Өөрөөр хэлбэл насанд хүрээгүй гэдгийг мэдсээр байж гэдэг субьектив шинжийг мөрдөн байцаалтын шатанд тогтооход ихээхэн бэрхшээлтэй байдаг.

"Садар самууныг сурталчлах" /Эрүүгийн хуулийн 123 дугаар зүйл/- *"Садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлсийг бэлтгэсэн, тараасан, борлуулсан, нийтэд үзүүлсэн, энэ зорилгоор улсын хилээр нэвтрүүлэхдээ арван зургаан насанд хүрээгүй хүнийг татан оролцуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг далан*

[628] Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний тайлан., 2008 он. 65 дахь тал.

[629] Тодруулга: Практикт тодорхой хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч биш "хөндлөнгийн этгээд"-үүд хүүхдээр гуйлга гуйлгаж, садар самуунд уруу татаж, тэнүүчлэл, мансуурал татан оролцуулж, биеийг нь үнэлүүлж байгаа жишээ баримт, судалгааны дүн болон ТББ-ууд, хүүхдийн халамж үйлчилгээний төвүүдийн алба хаагчидтай хийсэн ярилцлагын судалгаанаас тодорхой байна.

нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ."

Гэтэл *"садар самууныг сурталчлах"* гэсэн гэмт хэргийн бүрэлдхүүний обьектив талын шинжид заасан үйлдлүүдийг бусад хууль тогтоомжид давхардуулан зааж өгсөнөөс шалтгаалан сүүлийн 7 жилд ердөө 9 хэрэг эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан боловч шүүхээр нэг нь шийдвэрлэгдээгүй байна.

Тухайлбал *Садар самуунтай тэмцэх тухай хуулийн* 5 дугаар зүйл. Садар самууныг сурталчлахыг хориглох" гэсэн хэсэгт заахдаа :

5.1. Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр садар самууныг сурталчлахыг хориглоно.

5.2. Садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг бэлтгэх, тараах, борлуулах, энэ зорилгоор хадгалахыг хориглоно.

5.3. Садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, кино, дүрс бичлэг, зураг болон бусад зүйлийг үлсын хилээр нэвтрүүлэхийг хориглоно.

Зар сурталчилгааны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.7-д "айдас төрүүлэх, хүчирхийлэл, садар самуунд уруу татах, түүнчлэн хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд гэм хор учруулах үйлдэл, үйл ажиллагаанд хүргэж болох зар сурталчилгааг; гаргах, бэлтгэх, түгээхийг хориглоно " гэжээ.

Захиргааны хариуцлагын тухай хуулийн 41 дүгээр зүйл. "Садар самууныг сурталчлах, өнгөний өвчнийг эмчлүүлэхээс зайлсхийх".

"Садар самууныг сурталчилсан, түүнчлэн өнгөний өвчний үзлэг, эмчилгээнээс зайлсхийсэн, эмчилгээг тасалсан, өнгөний өвчин халдаагчаа нуун дарагдуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 10000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна".

Зарим тохиолдолд эрүүгийн хэргийн шинжтэй үйлдлүүд энэ хуулийн дагуу захиргааны шийтгэл хүлээгээд өнгөрдөг. СЕТХ-ийн 13.2.2 дах хэсэг нь Эрүүгийн хуулийн 124.2 дах заалттай агуулга ижил буюу чухам ямар үйлдэл нь гэмт хэрэг ямар үйлдэл нь захиргааны зөрчил болох талаар нэгдсэн ойлголт үгүй байна.

СЕТХ-ийн 12.2-т заасны дагуу бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийг цагдаагийн зүгээс хохирогч гэж хандахаасаа илүү захиргааны зөрчил гаргагч гэж хандан, хүүхдийн эрхийг зөрчих явдал гардаг. Мөн дээрх заалт нь бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн хувьд түүний хувийн нууцыг хамгаалах тухай Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 7.3 дахь заалттай нийцэхгүй байна.

Улаанбаатар хотод нэвтрүүлгээ цацдаг телевизүүд болон "ЧАТ" сувгаар нийт 254 цагийн хууль бус шинжтэй зар сурталчилгаа явагдсан байна. Үүнийг телевиз тус бүрээр нь авч үзвэл садар самуун, архи, согтууруулах ундаа болон бусад байдлаар гэмт хэрэг үүдэн гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн мэдээлэл хамгийн их цацсан телевизийн нэвтрүүлэг нь ТВ-ийн "чат"-ын суваг юм.

Тухайлбал:

№	Утас	Мэдээллийн агуулга	Түгээж буй телевиз	Огноо
1	9997....	25 настай, царайлаг, дажгүй залуу байна. Анусаар секс хийх бүсгүй байвал залга.	MTV телевиз	2009.04.02
2	8816..	7-9 насны цэвэрхэн, онгон охидууд хайж байна.		
5	9907...	Ні бүсгүйчүүдээ дуудлагаар очиж, хөхний толгой цоолж ээмэг зүүж өгнө сак бүсгүйчүүд байна уу? Үнэ хямд		

Монгол улсын хэмжээнд нийт 50 FM радио үйл ажиллагаа явуулж байгаагаас Улаанбаатар хотод 18 FM радио нэвтэрүүлгээ цацаж байна. Үүнээс буюу "life 104" болон "Инээмсэглэл 99.3" FM радиог сонгон авч мэдээллийн агуулагад дүн шинжилгээ хийхэд гол төлөв садар самууныг сурталчилсан шинжтэй сурталчилгаа явуулж байлаа. Тухайлбал: ***Шигтэгээ: FM радиогийн хөтлөгч эрэгтэй оролцогчоос асууж байгаа асуулт: "Чи нэг эрэгтэй, 2 эмэгтэй гурвуулаа секс хийж үзсэн үү? Мөнгө, хайр, секс гурвын алийг нь илүүд үүздэг вэ?, чи хамгийн сүүлд хэзээ секс хийсэн бэ? Найз залуутайгаа юу? Эсвэл зуурдын хүнтэй юу?"***

Хөтлөгчийн энэхүү садар самуун, ёс суртахуунгүй үг хэллэг хэрэглэж байгаа нь өсвөр үе залуучуудын хүмүүжилд сөргөөр нөлөөлөх хүчин зүйл болж байна. Учир нь FM радиогийн нэвтрүүлэгт холбогдсон оролцогчдын 91 хувь нь өсвөр үе буюу 14-18 насныхан байдаг нь судалгааны явцад ажиглагдлаа. FM радиод холбогдож буй сонсогчдын хүйсийг аваад үзвэл 60.5% эмэгтэй, 39.5% нь эрэгтэй байна.

Ийнхүү дээр дурдагдсан хэлбэрээр хууль бус зар сурталчилгаа газар авах нь гэмт хэрэг үүдэн гарахад нөлөөлдөг эсэх асуудлыг тодоруулах үүднээс "Хууль бус зар сурталчилгаа нь эрүүгийн хуульд заасан ямар төрлийн гэмт хэрэг үйлдэхэд голчлон нөлөөлдөг болох?" гэсэн асуултанд дараах байдлаар хариулсан байна.

- Биеэ үнэлэхэд татан оруулах, зохион байгуулах 240 буюу 80 хувь нь
- Бага насны хүүхдийг гэмт хэрэгт уруу татах 200 буюу 66.8 хувь
- Гуйланчлал, тэнүүчлэлд татан оруулах 40 буюу 13.3 хувь нь
- Хүч хэрэглэх, хүчиндэх 80 буюу 26.7 хувь нь
- Бусад 80 буюу 26.7 гэж хариулсан байна.

Манай улсад хууль бус зар сурталчилгааны улмаас хүн худалдах болон залилан мэхлэх гэмт хэргийн золиос болсон олон иргэд байгааг хэлэх нь зүйтэй[630].

[630] Б.Энхболд "Хууль бус зар сурталчилгаа" эрдэм шинжилгээний өгүүллээс

Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйл. Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах: Хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, хуурч мэхлэх замаар биеэ үнэлэхэд татан оролцуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ. гэжээ.

Сүүлийн 6 жилд шүүхээр шийдвэрлэсэн хэргийн судалгаа[631].

№	Он	Зүйл анги	Хэрэг	Хүн	Гэмт хэрэг гарсан газар	
					УБ хот	Гадаадад
1	2004	**124.2**	1	2		
2	2005	**124.2**	1	3	1	
		124.3	1	2	1	
3	2006	**124.2**	1	1	1	2
4	2007	**124.2**	6	6	6	3
5	2008	**124.1**	1	1	1	
		124.2	18	37		1
6	2009	**124.2**	7	16		
Бүгд			**36**	**68**	**10**	**6**

2002, 2008 оны Эрүүгийн хуулиудаар энэ төрлийн хэргийг дор дурьдсан байдлаар шийдвэрлэжээ.

2002 оны Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлийн 124.2 дахь хэсэгт заасан "Биеэ үнэлэх газар байгуулсан, санхүүжүүлсэн, түүнчлэн биеэ үнэлэхэд зуучилсан, тээврийн хэрэгсэл, орон байр, бусад зүйлсээр үйлчилсэн" хэрэгт 12 хүнд холбогдох 8 хэрэг,

- Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлийн 124.3 дахь хэсэгт заасан "Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн" хэрэгт 2 хүнд холбогдох 1 хэрэг;

2008 оны Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлийн 124.1 дэх хэсэгт заасан "Хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, хуурч мэхлэх замаар биеэ үнэлэхэд татан оролцуулсан" хэрэгт 1 хүнд холбогдох 1 хэрэг,

- Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлийн 124.2 дахь хэсэгт заасан "Биеэ үнэлэх газар байгуулсан, санхүүжүүлсэн, түүнчлэн биеэ үнэлэхэд зуучилсан, биеэ үнэлэхийг байнга зохион байгуулсан, тээврийн хэрэгсэл, орон байр, бусад зүйлсээр үйлчилсэн" хэрэгт 53 хүнд холбогдох 25 хэрэг,

Илрүүлэлтийн байдал: Судалгаанаас харахад энэ төрлийн хэргийн 18 буюу 26.5 хувь нь хохирогчийн гомдлоор, 27 буюу 39.8 хувь нь гүйцэтгэх ажлын шугамаар, 2 буюу 2.9 хувь нь ар гэрийнхэний гомдлоор, 21 буюу 30.8 хувь нь бусад үндэслэлээр илэрсэн байна.

Гэтэл нийгэмд гараад байгаа тодорхой мэдээллүүд болох Хүн

[631] Улсын Дээд Шүүхийн Судалгааны төвөөс 2010 онд хийсэн судалгааны дүнгээс

худалдаалах гэмт хэргийн шинжтэй үйлдлүүд байна хэмээн дуулиан шуугиан дэгдээсэн баримтууд нотлогдохгүй байна. Практикт хэвлэл мэдээллийн хэрэгсэл, ТББ-уудаас энэ төрлийн гэмт хэргийн хохирогчдын тоог 400 хол давсан, Дорнод аймагт гудамжны 200 хүүхэд ор сураггүй алга болсон, хүний наймааны золиос болсон гэх мэтээр ор үндэсгүй мэдээлж байгаа нь хуулийн байгууллагаас энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэж, түүнийг шийдвэрлэж чадахгүй байна гэх хий хардлагыг үүсгэхэд хүргэж байна. Бодит байдал дээр энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэхдээ хуулийн байгууллага өргөдөл гомдлын дагуу болон өөрийн хуулинд заагдсан арга хэрэгслээр илрүүлжээ.

Эрүүгийн хуулийн 126 дугаар зүйл. Хүчиндэх: Энэ гэмт хэрэг нь ХГБНЁЭГХ-ийн хамгийн түгээмэл үйлдэгдэж байгааг ЦЕГ-ын Мэдээлэл, судалгааны төвөөс ирүүлсэн статистик мэдээнээс харж болохоор байна. Харин "Хүчиндэх" гэмт хэргийн энэ үзүүлэлтийн ар талд насанд хүрээгүй хүмүүсийн эсрэг гэмт хэрэг болон гэр бүлийн хүрээнд үйлдэгдэж байгаа хүчиндэх гэмт хэргийн байдал ямар байгаа дүр төрх харагдахгүй байна.

Эндээс үзэхэд улсын хэмжээнд бүртгэгдсэн ***нийт гэмт хэргийн 1.7 хувийг***, хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэргийн ***87.8 хувийг*** хүчиндэх гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Цагдаагийн байгууллага 2007 оноос гэмт хэргийн илрүүлэлтийг тооцох аргачлалыг өөрчилсөн тухай дээр дурьдсан бөгөөд хүчиндэх гэмт хэргийн илрүүлэлт 2007 онд 45.0, 2008 онд 47.5, 2009 онд 77.7 хувьтай, байнга өссөн эерэг үзүүлэлт харагдаж байна.

Эрүүгийн эрх зүйн чиглэлээр судалгаа хийдэг зарим судлаачдыг зүгээс хүчиндэх гэмт хэргийг нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт оруулах шаардлагагүй. Хүнийг хүчиндэнэ гэдэг бол тухайн хувь хүний бие махбодь, сэтгэл санаанд хор хохирол учруулж байгаа учраас хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн ангилалд оруулах нь зүйтэй гэж үзсэн байна.

Гадаадын Улс орнуудын эрүүгийн эрх зүй болон, криминологийн салбарын чиг хандлагыг судлан үзэхэд дээрх ойлголтыг төрөлжүүлэн авч үзсэн байна. Үүнийг тодорхой дурьдвал **"marital rape"** буюу **"гэрлэлтэн дэх хүчин"** хэмээх ойлголтод гэр бүл, хамаатан садны хүрээнд гардаг хүчингийн гэмт хэргийг ялган нэрлэдэг бөгөөд түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага хүртэл ялгамжтай байдаг. Харин **"date rape"** хэмээх ойлголтыг

мөн тусгайлан ялган төрөлжүүлсэн байх бөгөөд үүнийг **"болзооны хүчин"** хэмээн дуйцүүлэн ойлгож болох юм. Дээр дурдсан **"хүчиндэх"** гэмт хэргийг ерөнхийд нь **"statutory rape"** гэж нэршиж заншжээ.

Сүүлийн үед нийгэмд гарч байгаа мэдээллүүд нь бага насны болон өсвөр насны охидыг хүчирхийлсэн тухай айдас цочроо өгөхөөр шинжтэй байна. Сүүлийн үед гарч байгаа хүчиндэх 2 гэмт хэрэг тутмын нэг нь согтуугаар, 3 гэмт хэрэг тутмын нэг нь бүлэглэн, 10 гэмт хэрэг тутмын нэг нь урьд нь ял шийтгэгдсэн хүмүүсээс үйлдэж байгаа онцлогтой шинжийг анхааран үзэх хэрэгтэй юм.

Гэмт хэрэг үйлдэгчдийн нийтлэг байдлыг үзэхэд хохирогчийн танил, 18-35 насны, ажилгүй, бүрэн дундаас доош боловсролтой, эрэгтэй хүмүүс байгаа дүр төрхийг олж харж болохоор байна.

Эрүүгийн хуулийн 129 дүгээр зүйл. Булш ухах: Сүүлийн үед түүх соёлын дурсгалт зүйлийн хэлбэр дүрсийг нь өөрчилж зэрлэг балмадаар эвдэх, устгах /вандализм/ зэрэг гэмт үйлдэл гарах болов. Манай улсад гарч байгаа энэ төрлийн гэмт хэргийн тоо сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгааг анхаарч ажиллах шаардлагатай байна. Вандализм буюу түүх соёлын холбогдолтой ба эд өлгийн зүйлийг устгаж сүйтгэх үйлдэлд зарим тохиолдолд хариуцлага хүлээлгэх боломжгүй байна. Тухайлбал 2006 онд улсын мэргэжлийн хяналтын газраас 21 аймагт явуулсан шалгалтын дүнгээс үзэхэд 21 аймгийн 17-д нь 75 түүх соёлын үл хөдлөх зүйлд халдаж, шарил булшийг ухаж устгах, тонох, олдворыг тарааж хаях, эрээчих сараачих, уул уурхайн нэрээр ухаж төнхөх, шатаах, туурь ухах, дээр нь хашаа хороо барих, техник хэрэгслээр эвдэх гэх мэтчилэн зүй бус харилцааны улмаас ихээхэн хэмжээний хор хохирол учруулсан байтал эдгээрт эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн нь цөөн байна[632].

Монгол Улсын Эрүүгийн хуулинд булш ухах гэсэн зүйл анги байгаа боловч үүнд түүх соёлын өв, үнэт зүйлийг хамгаалах талаар шууд заагаагүй байна. Өөрөөр хэлбэл булш ухах гэмт хэргийн үйлдэлд эртний булш, хиргисүүр ухвал хүндрүүлэн үзэх заалт байхгүй байгаа юм.

САНАЛ АСУУЛГЫН СУДАЛГААНЫ ДҮН

Тухайлан сонгож авсан дүүрэг, аймагт хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг сүүлийн жилүүдэд багассан ч гэр бүлийн хүрээнд үйлдэгдэж байгаа бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг харьцангуй өсч байгаа тухай ярилцлагын явцад илүү дурдаж байв. Анкетийн судалгаанд оролцсон 50 алба хаагчийн 85 хувь нь Хүчиндэх гэмт хэргийг сонгосон байх бөгөөд үүний дараагаар Эрүүгийн хуулийн 114, 115, 124 дүгээр зүйлд заасан гэмт хэрэг илүүтэй үйлдэгддэг хэмээн хариулжээ.

Анкетийн судалгаанд оролцсон цөөнгүй алба хаагчид 18 хувь нь 118, 121 дүгээр зүйлд заасан гэмт хэрэг үйлддэгдэг хэмээн хариулжээ. Ярилцлагын судалгаагаар энэ төрлийн гэмт хэргийг нуугдмал байдаг ч хуулийн байгууллагаар шалган шийдвэрлэгдэж байгаа тохиолдол байхгүй хэмээн тодруулан хариулав.

[632] Б.Цогтбаатар.2010 он "Археологийн дурсгалын хадгалалт, хамгаалалтын байдал, хууль тогтоомжийг боловсронгуй болгох эрдэм шинжилгээний өгүүлэл,"Түүх соёлын дурсгалт зүйл, түүнд тавих хяналт" сэдэв онол практикийн бага хурлын эмхэтгэл. 66-67 дахь тал.

Сонгон авсан аймгуудад Бие үнэлэхэд татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах буюу ЭХ-ийн 124 дүгээр зүйлд заасан гэмт хэрэг гардаггүй ч "энэ төрлийн гэмт хэрэг их гардаг" хэмээн хариулсан нь тэдэнд байгаа мэдээлэлтэй холбоотой бөгөөд тухайн аймгуудад энэ төрлийн гэмт хэрэг гарч шийдвэрлэгдээгүй байна. Хуулийн байгуулагад шалгагдаж байгаа бусад төрлийн хэргүүдийн тадлаар зарим алба хаагчид мэдээлэл муутай байгаа нь ажиглагдлаа.

Эндээс харахад хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг тогтмол гарч бүртгэгддэг боловч Эрүүгийн хуулийн энэ хэсгийн хэрэгжилт муу байна. Мөрдөн байцаагч, хэсгийн байцаагч нартай хийсэн бүлгийн ярилцлагын судалгаанаас үзэхэд энэ төрлийн гэмт хэрэг цөөн тоотой гарч бүртгэгддэг, ихэвчлэн нууц далд байдалд байдаг байна.

Үүний шалтгааныг ярилцлагын явцад судлан үзэхэд хуулийн байгууллагад энэ төрлийн гэмт хэргийн мэдээлэл ирдэггүй, ихэвчлэн гэр бүлийн хүрээнд үйлдэгддэг, гэмт хэргийн хохирогч болсон насанд хүрээгүй хүмүүсийн өмнөөс өргөдөл гомдол гаргах субьект байдаггүйтэй холбоотой юм.

Энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан: Анкетийн асуулгад оролцогчдын дийлэнх нь архидалт, ядууралтай холбон тайлбарлаж асуулгад хариулсан нь гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийн талаар хэт ерөнхий ойлголттой байгаатай холбоотой байна. Асуулгад оролцогчдын ***45 хувь*** нь хүүхдийн хараа хяналтгүй байдал, садар самуун, хүчирхийллийг сурталчилсанаас, ёс суртахууны төлөвшил тааруугаас 24 хувь нь мэдээлийн хэт задгай байдал, гэр бүлийн хүчирхийлэл, 10 хувь нь хүүхдийн чөлөөт цагаа өнгөрөөх орчин байхгүйгээс хэмээн хариулжээ. Нээлттэй асуулгад хариулсан алба хаагч байсангүй.

Хүүхэд ямар шалтгааны улмаас гэмт хэргийн хохирогч болж байна вэ гэсэн асуулгад оролцогчдын 76 хувь нь хүүхдэд тавих хяналт сул, ар гэрийн байдал нөлөөлдөг хэмээн хариулсан бол 40 хувь нь асран хамгаалагч харгалзан дэмжигч байхгүйгээс, 21 хувь нь хойд эцэг, эхийн хүчирхийлэл үлдэх 9 хувь нь хүүхдийн байгууллагын үйл ажилагаа хангалтгүйгээс гэж хариулав.

Хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдэж буй этгээдийн онцлог гэсэн асуултанд 38 хувь нь урьд гэмт хэрэг үйлдэж байсан этгээд, 34 хувь нь хамтран амьдрагч, 28 хувь нь үе тэнгийнхэн , 18 хувь нь эцэг эх, хамаатан садан, 15 хувь хөндлөнгийн этгээд 8 хувь нь танил хүн хэмээн хариулжээ.

Санал асуулгад хийсэн дүгнэлт: Хүүхэд гэр бүл нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэргийн гол шалтгаан нь хүүхдийн хараа хяналтгүй байдал, садар самуун хүчирхийллийг сурталчилсанаас хүүхдийн ёс суртахууны хүмүүжилд сөргөөр нөлөөлөн гэмт хэрэгт өртөн хохирч байгаа дүр зураг харагдаж байна. Хэдийгээр асуулгад нээлттэй хариулсан оролцогч байгаагүй ч анкетийн дараахь ярилцлагын судалгаанд хүүхдийн эрхийг хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилт сул, байгууллагуудын уялдаа холбоо түүнийг зохицуулах хууль эрх зүйн орчин хангалтгүйг ихэвчлэн дурдаж байлаа.

Түүнчлэн бодит байдал дээр хүүхдийн эрх зөрчиж байгаа үйлдэлд арга хэмжээ авдаг албан тушаалтан байхгүй. Хүүхдээр гуйлга гуйгаад, хүнд хөдөлмөр эрхлүүлээд, гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл үйлдэж байгаа эцэг эх болон бусад хүмүүст хариуцлага хүрч чадахгүй байгааг онцолж үзэж байв.

Дурдах бас нэг зүйл бол Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлгийн зарим зүйл хэсгийг бүлэглэхдээ ахин анхаарах хэрэгтэй байгааг ч зарим судлаачид хэлж байсан юм. Тухайлбал хүчиндэх гэмт хэрэгт нийгэм ямар ёс суртахуунаараа хохироод байгаа юм бэ? энд хувь хүний бэлгийн халдашгүй дархан байдал, эрх чөлөө нь зөрчигдөж сэтгэл санаа бие эрхтэнээ хохирч байдаг учраас өөр бүлэгт оруулах хэрэгтэй хэмээн үзэж байсныг дурдууштай. Хэдий тийм насанд хүрээгүй хүнийг хүчирхийлсэн, бэлгийн зүй бус харилцаанд татан оруулсан шинжтэй үйлдлийн бүрэлдхүүнийг боловсронгуй байдлаар ахин хуульчлах шаардлагатай байгаа нь харагдлаа.

Асуулгад үндэслэн гэмт хэрэг үйлдэгч этгээдийн онцлогийг үзэхэд урьд ял шийтгэгдсэн хүмүүс энэ төрлийн гэмт хэргийг үйлддэг нь харагдаж байгаа ба мөн хойд эцэг, эсвэл эхийн хамтран амьдрагч, танил талын хүрээнд буюу үе тэнгийнхэн, найз нөхдөөс үйлдэх нь элбэг байна. Хохирогч болох өндөр эрсдэлтэй хүмүүсийн тоонд яах аргагүй хүүхдүүд хамаарна. Хүүхдүүд нь гэмт этгээдээс бие бялдрын хувьд сул дорой байдаг учир хүч хэрэглэсэн гэмт хэргийн золиос амархан болдог. Судалгаанаас үзэхэд гэмт хэрэгт хохирсон хүмүүсийн 73 хувь нь ямар нэгэн шалтгаанаар хуулийн байгууллагад хандаагүй байдаг. Эдгээр хохирогчдын 31 хувь нь хэрэг сунжрахаас төвөгшөөсөн, 37 хувь нь хуулийн байгууллагын хүнд суртлаас залхсан, 10 хувь нь нэр төрөө бодсон, 29 хувь нь ямар нэгэн үр дүн гарахгүй, 14 хувь нь гэмт этгээдийн өшөө хонзон, дарамтаас айсны улмаас зохих газар хандаагүй хэмээн хариулжээ[633].

<u>Мөрдөн байцаагчийн мэдэгдэлд хийсэн дүн шинжилгээ:</u> 21 аймгаас 102 мэдэгдэл, 9 дүүргээс 65 мэдэгдэл иржээ. Үүнээс мөрдөн байцаагчийн мэдэгдлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг зөв тогтоож чадсан эсэхийг судлан үзэхэд нийт мэдэгдэлийн 45 хувь нь гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг мөрдөн байцаалтын арга хэрэгслээр хэрхэн шалган, тогтоосон нь тодорхойгүй, гэмт хэрэг үйлдэгдэх нийтлэг нөхцөл болох ажилгүйдэл ядуурлыг дурдаж авах арга хэмжээг хэт ерөнхий зааж дурджээ.

Дурдсан зарим мэдэгдэлд хүүхэд гэр бүл нийгийн ёс суртахууны эсрэг гэмт хэргээс хамгийн нийтлэг гардаг нь "хүчиндэх" гэмт хэрэг хамгийн их гардаг болох нь статистик үзүүлэлтэд хийсэн дүн шинжилгээтэй тохирч байна. Гэвч бага, өсөөр насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн талаар бичсэн мэдэглүүд дийлэнхи хувийг эзэлж байгааг анхаарууштай байна. Бодит байдал дээр гэр бүлийн хүрээнд үйлдэгдэж байгаа хүчиндэх гэмт хэрэг их байна.

Үүний шалтгааныг мэдэгдэлд дараах байдлаар дурджээ.

- Эцэг эхээс тавих хараа хяналт сул
- Дагавар болон охид хүүхдэд чиглэсэн ажил хангалтгүй

633 Д.В.Ривман. Криминальная виктимология. СПб., 2002, с 36

- Хүмүүсийн боловсролын болон эрх зүйн ухамсар хэт доогуур байгаа
- Гэр ахуйн хүрээнд эмэгтэйчүүд, хүүхэдтэй зүй бусаар харьцдаг
- Хүүхдээ ах дүү хамаатан садан болон айлуудад олон хоног сараар орхиж явах
- Эмзэг өөрийгөө хамгаалах чадваргүй байдлыг далимдуулан
- Шөнө орой гудамж, талбайд сэлгүүцэн яваа хүмүүст хараа хяналт сул
- Оройн цагаар хэтрүүлэн ажилладаг дэлгүүр, түц
- Бүлэг бөөгнөрөл бий болгон архидан согтуурдаг
- Хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хаана гомдол гаргахаа мэддэггүй
- Насанд хүрээгүй хүмүүсийг архидан согтуурахад уруу таттдаг
- Сэтгэцийн өвчтэй хүүхдийг
- Үл таних хүн довтолсон
- Бага насны хүүхдийг хууран мэхлэх
- Насанд хүрээгүй охид гадуур тэнэж архиддаг
- Мал малладаг хүн бүл цөөтэй, бага насны хүүхэдтэй айл өрхөд халдах гэсэн тухай ихэвчлэн дурдсан байна.

Монгол Улсад хохирогчтой харилцах олон улсын эрх зүйн стандартад ойртож очих өнөөгийн эрэлт хэрэгцээ, нөгөө талаас виктимологийн нөхцөл байдал, гэмт хэргийн гаралт ба хохирох явдлын харилцан үйлчлэл, урьдчилан сэргийлэх шаардлагаас үүдэж гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, тэдэнтэй хүн ёсоор харьцах, нийгмийн зүй бус үзэгдэл, сөргөлдөөнийг саармагжуулах цэгцтэй бодлого шаардлагатай байна.

Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх нэг арга зам нь хохирогчтой ажиллах, түүнийг эргэн нийгэмшүүлэх үйл ажиллагаа байдаг. Гэмт хэрэг үйлдэгчдийн дийлэнхи өөрөө урьд нь энэ төрлийн гэмт хэргийн хохирогч байдаг онцлогийг анхаарах хэрэгтэй.

Нийслэлийн хэмжээнд сүүлийн гурван жилд буюу 2007,2008,2009 онуудад Эрүүгийн хуулийн 115, 118, 121 дүгээр зүйл хэсгээр хэрэг огт шийдэгдээгүй байна.

Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэм хэргийн сүүлийн 3 жилийн статистик үзүүлэлт

/2007-2009 он/

Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэргийн сүүлийн 10 жилийн үзүүлэлтээр ерөнхий хөдөлгөөнийг илэрхийлсэн бол одоо энэ төрлийн гэмт хэргийн ихэнх буюу 90 орчим хувийг эзэлж буй хүчиндэх гэмт хэргийн сүүлийн 3 жилийн дэлгэрэнгүй криминологи шинжийн талаар дурдъя.

Энэ хугацаанд жилд дунджаар улсын хэмжээнд нийт 20782 гэмт хэрэг, үүний 395 нь хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг, мөн түүн дотроо 347 нь хүчиндэх гэмт хэрэг үйлдэгджээ.

Гэмт хэрэг үйлдэгчдийн онцлог: уг хэргийн ***51.3 хувь нь согтуугаар***, 10.6 хувь нь хүүхэд оролцон үйлдэгдсэн, 3.2 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 17.5 хувь нь бүлэглэн гүйцэтгэсэн байна. Ер хүний зан төлөвтэй холбоотойгоор согтуугаар үйлдэх хүчингийн хэрэг өсөх хандлагатай байна.

Хүчиндэх гэмт хэргийн ***14.4 хувь нь гудамж талбайд***, ***42.3 хувь нь гэр, орон сууцанд***, 4.8 хувь нь зочид буудалд, 3.2 хувь нь бэлчээрт, 0.8 хувь нь албан газар, аж ахуйн нэгжийн байранд үйлдэгдсэний зэрэгцээ ***49.4 хувь нь 22-06 цагийн хооронд үйлдэгджээ.*** Үүнээс харахад ихэвчлэн сайн таньж мэдэхгүй хүмүүстэй шөнө, оройн цагаар ууж согтуурах явдал хамгийн ихээр нөлөөлж байна.

Энэ хугацаанд бүртгэгдсэн хүчиндэх нийт 1041 гэмт хэргийн улмаас 1053 иргэн хохирч, 3 хүн нас барж, 590 хүн гэмтсэн байна. Үүний улмаас 99.8 сая төгрөгийн хохирол учирсаны 31.7 хувийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад нөхөн төлүүлжээ.

Хүчиндэх гэмт хэрэгт 1190 хүн холбогдсон шалгагдсаны 15.8 хувь нь 18 хүртэлх насны, ***55.8 хувь нь 18-30 насны***, 10.5 хувь нь 30-35 насны, 17.9 хувь нь 35-аас дээш насны хүмүүс байсан ба ***60.3 хувь нь согтуугаар***, ***30.8 хувь нь бүлэглэн гүйцэтгэж гэмт хэрэг*** үйлдсэн, 129 буюу ***10.8 хувь нь урьд нь шүүхээр ял шийтгэгдсэн хүмүүс*** байна.





<u>2007 онд:</u> Хүчиндэх 355 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 41 хэргээр буюу 13.1 хувиар өсч, нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин 1.7 байна.

Энэ төрлийн гэмт хэрэг Сэлэнгэд 21, Өмнөговьд 19, Дорнод, Төв, Ховдод тус бүр 13, Архангай, Дархан-Уул, Завхан, Орхонд тус бүр 12, Хөвсгөлд 10, Хэнтийд 9, Дорноговьд 8, Баянхонгор, Говь-Алтай, Увсад тус бүр 6, Өвөрхангайд 5, Булган, Сүхбаатарт тус бүр 4, Баян-Өлгийд 3, Дундговьд 2, Говьсүмбэрт 1, нийслэл хотод 163, үүнээс Сонгинохайрхан, Чингэлтэйд тус бүр 36, Баянзүрхэд 32, Баянгол 25, Сүхбаатарт 13, Хан-Уулд 9, Налайхад 7, Багануурт 4, Багахангайд 1, төмөр замын салбарт 1 бүртгэгджээ.

Гэмт хэргийн гаралт Архангай, Говь-Алтай, Дархан-Уул, Завхан, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Ховд аймагт 20.0 хувиас 4 дахин, нийслэл хотод 5.8 хувиар, үүнээс Баянгол, Сүхбаатар, Чингэлтэй дүүрэгт 8.3 хувиас 2.6 дахин тус тус өсч, Баянхонгор, Булган, Дорноговь, Дундговь, Орхон,

Өвөрхангай, Сүхбаатар, Увс, Хэнтий аймагт 7.7 -50.0 хувиар, нийслэлийн Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул, Багануур дүүрэгт 10.0-27.3 хувиар тус тус буурав.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 76 гэмт хэрэг бүртгэгдэн 35 хэргийн яллагдагчаар татвал зохих этгээд нь тогтоогдож, гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 46.1 хувьтай, нийслэлийн хэмжээнд 50.9 хувьтай байна.

31.6 хувь нь хүндэвтэр, 50.7 хувь нь хүнд, 17.7 хувь нь онц хүнд ангиллын хэрэг эзэлж байгаа ба 12.4 хувь нь хүүхэд оролцож, ***55.0 хувь нь согтуугаар,*** 20.0 хувь нь бүлгээр үйлдэгджээ. *2 гэмт хэрэг тутмын 1 нь согтуугаар үйлдэгдсэн байна.*

13.8 хувь нь гудамж талбайд, 40.0 хувь нь гэр, орон сууцанд, 0.6 хувь нь албан газарт, 1.4 хувь нь зах худалдаа, үйлчилгээний газар, 3.4 хувь нь зочид буудал, баар, ресторанд, 3.4 хувь нь бэлчээрт үйлдэгдсэний 8.7 хувь нь 0.6-14 цагт, 19.4 хувь нь 14-19 цагт, 18.6 хувь нь 19-22 цагт, 53.3 хувь нь 22-06 цагт тус тус үйлдэгджээ.

3 гэмт хэрэг тутмын 1 нь гэр, орон сууцанд, 2 гэмт хэрэг тутмын 1 нь 22.00-06.00 цагийн хооронд үйлдэгдсэн байна.

Гэмт халдлагад 358 иргэн өртөж, гэмт хэргийн улмаас 198 хүн хөнгөн, хүндэвтэр, хүнд хэлбэрээр гэмтжээ.

Энэ төрлийн гэмт хэрэгт 411 хүн холбогдон шалгагдсаны 22.9 хувь нь насанд хүрээгүй, 50.1 хувь нь 18-30 насны, 8.8 хувь нь 30-35 насны, 18.2 хувь нь 35-аас дээш насны, 20.7 хувь нь ажилчин, малчин, 16.1 хувь нь оюутан, сурагч, 58.9 хувь нь тодорхой эрхэлсэн ажилгүй хүмүүс байгаа ба 13.1 хувь нь урьд ял шийтгэгдсэн хүмүүс, 89.8 хувь нь согтуугаар, 40.1 хувь нь бүлгээр гэмт хэрэг үйлджээ.

2008 онд: Хүчиндэх 354 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 1 *хэргээр буюу 0.3 хувиар* буурч, нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин 1.7 болов.

Сэлэнгэд 26, Дархан-уул 18, Орхонд 16,Өвөрхангайд 13,Төв, Хөвсгөлд тус бүр 11, Архангай,Баянхонгор тус бүр 10, Дорноговь, Өмнөговь, Увсад тус бүр 9, Дорнодод 7, Булган, Завхан, Ховд, Хэнтийд тус бүр 5, Говь-Алтай, Сүхбаатарт тус бүр 4, Баян-Өлгий,Говьсүмбэрт тус бүр 3, Дундговьд 2, нийслэл хотод 169 үүнээс нийслэлийн Сонгинохайрханд 47, Баянзүрхэд 34, Чингэлтэйд 20, Баянголд 19, Сүхбаатарт 18, Хан-Уулд 15, Багануур, Налайхад тус бүр 8 бүртгэгджээ.

Энэ гэмт хэргийн гаралт Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Орхон, Өвөрхангай, Сэлэнгэ, Увс, Хөвсгөл аймагт 10.0 хувиас 3 дахин, нийслэл хотод 3.7 хувиар, нийслэлийн Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул, Багануур, Налайх дүүрэгт 6.3 хувиас 2 дахин өсч, Архангай, Говь-Алтай, Дорнод, Завхан, Өмнөговь, Төв, Ховд, Хэнтий аймагт 15.4-61.5 хувиар, нийслэлийн Баянгол, Чингэлтэй дүүрэгт 24.0-44.4 хувиар тус тус буурав.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 99 гэмт хэрэг бүртгэгдэн 47 хэргийн яллагдагчаар татвал зохих этгээд нь тогтоогдож, гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 47.5 хувьтай, нийслэлийн хэмжээнд 49.2 хувьтай байна.

53.1 хувь нь хүндэвтэр, 35.3 хувь нь хүнд, 11.6 хувь нь онц хүнд ангиллын хэрэг эзэлж байгаа ба 97.5 хувь нь санаатайгаар, 7.9 хувь нь хүүхэд оролцож, 50.3 хувь нь согтуугаар, 4.2 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 15.8 хувь нь бүлгээр үйлдэгджээ. *2 гэмт хэрэг туттмын 1 нь архидан согтуурсанаар үйлдэгдсэн байна.*

17.8 хувь нь гудамж талбайд, 39.0 хувь нь гэр, орон сууцанд, 0.9 хувь нь албан газар, аж ахуйн нэгж байгууллагад, 5.9 хувь нь зочид буудал, баар, ресторанд, 2.3 хувь нь бэлчээрт үйлдэгдсэний 13.6 хувь нь 06-14 цагт, 18.6 хувь нь 14-19 цагт, 16.7 хувь нь 19-22 цагт, 51.1 хувь нь 22-06 цагт тус тус үйлдэгджээ.

3 гэмт хэрэг туттмын нэг нь гэр, орон сууцанд, 2 гэмт хэрэг туттмын нэг нь 22.00-06.00 цагийн хооронд үйлдэгдсэн байна.

Гэмт халдлагад 357 иргэн өртөж, 35.7 сая төгрөгийн хохирол учирсаны 12.2 сая төгрөг буюу 34.2 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлсэн ба гэмт хэргийн улмаас 1 хүн нас барж, 214 хүн хөнгөн, хүндэвтэр, хүнд хэлбэрээр гэмтжээ.

Гэмт хэрэгт 383 хүн холбогдон шалгагдсаны 11.8 хувь нь насанд хүрээгүй, 60.1 хувь нь 18-30 насны, 11.5 хувь нь 30-35 насны, 16.7 хувь нь 35-аас дээш насны, 22.4 хувь нь ажилчин, малчин, 11.8 хувь нь оюутан, сурагч, 62.7 хувь нь тодорхой эрхэлсэн ажилгүй хүмүүс байгаа ба 8.9 хувь нь урьд ял шийтгэгдсэн хүмүүс, 59.0 хувь нь согтуугаар, 26.6 хувь нь бүлгээр гэмт хэрэг үйлджээ.

2009 онд: Хүчиндэх 332 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 22 хэргээр буюу 6.2 хувиар, нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин 1.6 хувь болж, 0.1 пунктээр тус тус буурав.

№	Үзүүлэлт	2008	2009	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Хүчиндэх хэрэг	354	332	-22	-6.2
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин	1.7	1.6	0.1 пунктээр буурсан	
3	Хүчиндэх гэмт хэргийн илрүүлэлтийн хувь	47.5	77.7	30.2 пунктээр өссөн	

Хүчиндэх гэмт хэрэг Дархан-Уулд 22, Сэлэнгэ, Төвд тус бүр 16, Орхон, Ховдод тус бүр 12, Өмнөговьд 10, Хэнтийд 9, Завхан, Хөвсгөлд тус бүр 8, Баянхонгорт 7, Дорноговь, Дорнод, Өвөрхангай, Увсад тус бүр 6, Баян-Өлгий, Дундговьд тус бүр 5, Архангай, Говь-Алтай, Говьсүбмэр, Сүхбаатарт тус бүр 2, Булганд 1, нийслэлд 168, үүнэс Баянзүрхэд 38, Сонгинохайрханд

34, Баянгол, Хан-Уулд тус бүр 28, Чингэлтэй 19, Сүхбаатарт 16, Налайхад 3, Багануурт 2, бусад газарт 1 бүртгэгджээ.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 112 гэмт хэрэг бүртгэгдэн 87 хэргийн яллагдагчаар татвал зохих этгээд нь тогтоогдож, гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 77.7 хувьтай байна.

Хэргийн 50.0 хувь нь хүндэвтэр, 32.5 хувь нь хүнд, 17.5 хувь нь онц хүнд ангиллын хэрэг ба 9.9 хувь нь хүүхэд оролцож, 49.1 хувь нь согтуугаар, 6.0 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 16.6 хувь нь бүлгээр үйлдэгджээ. *2 гэмт хэрэг тутмын нэг нь согтуугаар үйлдэгдсэн байна.*

Үйлдэгдсэн газрын хувьд 11.4 хувь нь гудамж талбайд, 48.2 хувь нь гэр, орон сууцанд, 0.9 хувь нь албан газар, аж ахуйн нэгж, байгууллагад, 5.1 хувь нь зочид буудал, баар, ресторанд, 3.9 хувь нь хөдөө хээр, бэлчээрт, 16.3 хувь нь 06-14 цагт, 24.4 хувь нь 14-19 цагт, 16.6 хувь нь 19-22 цагт, 42.8 хувь нь 22-06 цагт тус тус үйлдэгджээ. *2 гэмт хэрэг тутмын нэг нь гэр, орон сууцанд, 22.00-06.00 цагийн хооронд тус тус үйлдэгдсэн байна.*

Гэмт халдлагад 338 иргэн өртөж, 40.2 сая төгрөгийн хохирол учирсаны 30.3 сая төгрөг буюу 75.5 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлсэн ба гэмт хэргийн улмаас 1 хүн нас барж, 179 хүн хөнгөн, хүндэвтэр, хүнд хэлбэрээр гэмтжээ.

Гэмт хэрэгт 396 хүн холбогдон шалгагдсаны 12.1 хувь нь насанд хүрээгүй, 57.8 хувь нь 18-30 насны, 11.1 хувь нь 30-35 насны, 18.9 хувь нь 35-аас дээш насны, 8.1 хувь нь ажилчин, 8.3 хувь нь малчин, 5.8 хувь нь оюутан, 6.3 хувь нь сурагч, 68.7 хувь нь тодорхой эрхэлсэн ажилгүй хүмүүс байгаа ба 9.8 хувь нь урьд ял шийтгэгдсэн хүмүүс, 56.3 хувь нь согтуугаар, 28.5 хувь нь бүлэглэн үйлджээ.

Дүгнэлт

Хүүхэд, гэр бүл, ниймийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг нуугдмал байсаар байгаа төдийгүй цаашдын 5 жилийн хэтийн төлөв байдлыг үзэхэд энэ төрлийн гэмт хэргийн гаралт ихсэж, зарим төрлийн гэмт хэрэг зохион байгуулалтанд шилжиж болохоор байна. Нэн ялангуяа хүүхэдтэй зүй бус харьцах, хүчирхийлэх, бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөгөд ашиглах явдал түгээмэл, нуугдмал түвшинд гарсаар байна. Эрүүгийн хуулийн 17 дугаар зүйлд заасан гэмт хэрэг нь

- Гэр бүлийн эсрэг
- Хүүхдийн эсрэг
- Нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэргүүд байгаа боловч хуульд заасан гэмт хэргийн ангилалт нь боловсронгуй болоогүй байна.

Бусдыг хүчиндэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг архидалт, бүлэг бөөгнөрөл, гэр бүлийн хүчирхийлэл ядуурал холбож тайлбарлаж болох ч бодит байдал дээр гэмт хэрэг үйлдэгдэж шоронгоос суллагдсан хүмүүсээс энэ төрлийн гэмт хэрэг илүү үйлдэж байгааг анхаарах хэрэгтэй.

Түүнчлэн хүүхдийн эсрэг гэгдэх зарим төрлийн хэрэг, тухайлбал насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэрэг үйлдэхэд, садар самуун, тэнүүчлэл, мансуурал, гуйланчлал, биеэ үнэлэхэд татан оруулах гэмт хэргийн шинжтэй

үйлдлийг хуулийн байгууллагаас шалгаж, шийдвэрлэх уламжлалт хандлагаа өөрчлөхгүй бол нуугдмал гэмт хэрэг өсөх хандлагатай байна.

Өргөдөл гомдол мэдээллийг нэг бүрчлэн бүртгэж хэрэг нэг бүрийн ард энэ төрлийн гэмт хэрэг байж болохыг нягтлан шалгаж байх нь зөв зүйтэй төдийгүй хараа хяналтгүй, тэнэмэл хүүхдийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлж, хуулийг зөв хэрэглэж чаддаг байх хэрэгтэй байна. Ялангуяа хуулийн байгууллага, хүүхдийн байгууллагын хамтын ажиллагааны эрх зүйн зохицуулалт нь гэрч, хохирогч хүүхдийг хамгаалах, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд гэрч, хохирогч хамгааллаар ажлын үр дүнг дүгнэх шалгуур болгоход оршивол зохино.

Гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдэд хамааралтай Хүүхдийн эрхийн тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Иргэний бүртгэлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиудийг хэрэгжүүлэх, хүүхдийг тодорхой халамж үйлчилгээнд хамруулахад хуулийн байгууллага үүрэгт ажил биш гэж хандахгүй байх. Бодит байдал дээр хүүхэдтэй зүй бус харьцаж, мансуурал, гуйланчлал, тэнүүчлэлд татан оруулж, алтны уурхай болон гудамж, талбай траншей, хог ухаж амьдардаг эцэг, эх асран хамгаалагч эрүүгийн хариуцлага огт хүлээхгүй өнгөрч байна.

Хуулийн давхардал, хийдэл: Үндсэн хуулинд заасан "Хүүхэд, гэр бүл төрийн хамгаалалтанд байх" зарчмын хэрэгжилт сул байна. Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн хүүхдийг хамгаалах, нөхөн сэргээх төрийн үйлчилгээ байхгүй байна. Хохирогч хүүхдэд үзүүлэх төрийн үйлчилгээг зарим хууль тогтоомжуудад тусгасан боловч хэрэгжүүлэх механизм нь тодорхойгүй байна.

Хүүхдийг бэлгийн мөлжлөгт ашигласан үйлдэлд хариуцлага ногдуулах зарим хэм хэмжээ Эрүүгийн хууль, бусад хуульд давхардан зохицуулагдсан нь гэмт этгээдэд ял завших, гэмт үйлдлээ дахин давтах боломжийг олгож байна. Үүнд:

- Эрүүгийн хуулийн 115; 124 дүгээр зүйлийн "биеэ үнэлэхэд татан оролцуулах" нь хоорондоо; эдгээр зүйлүүдийн зарим шинж нь 113 дугаар зүйлийн шинжүүдтэй;
- Эрүүгийн хуулийн 115; 124 дүгээр зүйлүүдийн "биеэ үнэлэх татан оролцуулах" нь Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн "биеэ үнэлж явалдахад уруу татах"-тай давхарджээ.

Түүнчлэн хүүхдийг мөнгө олох хэрэгсэл болгосон, хүнд нөхцөлд байлгасан, албадан хөдөлмөр эрхлүүлж ашиг олсон, давуу байдал бий болгосон, өр төлбөрт түр хугацаагаар шилжүүлсэн зэрэг үйлдэл хийсэн, түүний улмаас ямар нэг гэм хор учирсан бол мөн Эрүүгийн хуулийн "Асран хамгаалах үүргээ урвуулах", "Хүүхдийг албадан болон хүчээр хөдөлмөрлүүлэх" гэмт хэргийн шинжийг агуулж байдаг. Дээрх хэлбэрүүд нь гэмт хэргийн шинжийг шууд агуулж байдаг учир "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай" хуулиар бус Эрүүгийн хуулиар тайлбарлаж хариуцлага хүлээлгэдэг байх нь зохимжтой юм. Эрх зүйн аливаа зөрчлийн хариуцлага туйлын тодорхой байх ёстой. Гэтэл уг хуулийн 19.1-т "Гэр бүлийн

хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд түүний үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанар, зөрчлийн байдал, учруулсан хохирлын хэмжээг харгалзан хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ" гэсэн нь иш татсан, хариуцлага тооцсон, алгасуулан иш татсан хэм хэмжээний аль нь болох нь мэдэгдэхгүй хэт "бөөрөнхий" байгаа юм.

Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох санал:

• "Хүчиндэх" гэмт хэргийн ойлголтыг өргөжүүлж, төрөлжүүлэх; Хүчиндэх болон түүнтэй ойролцоо төрлийн гэмт хэргийн ялгаа, түүнийг зөв зүйлчлэх талаар УДШ-ээс дэлгэрэнгүй тайлбар гаргах;

• Эрүүгийн хууль, Садар самуун явдалтай тэмцэх тухай, Захиргааны хариуцлагын тухай, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиудын давхардлыг арилгах

• Монгол Улсын Эрүүгийн хуулийн 122 дугаар зүйл /16 насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх/ -ийг нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэн "Насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх" болгон өөрчлөх;

• Тодорхой судалгаа, шинжилгээний үндсэн дээр насанд хүрээгүй гэрч, хохирогчийг байцаах тухай тусгайлсан бүлгийг Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмж оруулах;

• Эрүүгийн байцаан шийтгэх хуульд албадлагын арга хэмжээний төрөл болгон хохирогчтой "харилцахыг түр хугацаагаар хязгаарлах" арга хэмжээг оруулах;

• Хохирогч, гэрчийн аюулгүй байдлын хамгааллын асуудлыг ЭБШ хуульд тусгаж өгөх. Хохирогч, гэрчийг хамгаалах нь ЭБШ ажиллагааг хэрэгжүүлэгч /хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор шүүгч/-дийн үүрэг байхаар хуульчилж өгөх

• Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн хохирогчийг хамгаалах, эрүүл мэнд, сэтгэл засал, нийгмийн бусад үйлчилгээг хүргэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шат: Гэр бүлийн хүрээнд үйлдэгдсэн бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг цаг тухайдаа мэдээлэгдэхгүй тохиолдол байна. Хүчингийн гэмт хэрэгт өртсөн насанд хүрээгүй хохирогч сэтгэл зүйн цочрол, айдас, стресст хүчтэй ордгоос болж хүчиндүүлснээ бусдаас нуудаг нь хэргийг нотлоход хүндрэл, бэрхшээл учруулдаг. Ураг төрлийн хүчингийн гэмт хэрэг хожуу илэрдэг учир хэргийг нотлоход мөрдөн байцаагчаас тодорхой ур чадвар шаарддаг. Түүнээс гадна зөвхөн мэдүүлгэн нотлох баримт буюу хохирогч, гэрчийн мэдүүлэгт тулгуурлан хэргийг шийдвэрлэдэгтэй холбоотойгоор хохирогчид хөндлөнгөөс нөлөөлөх оролдлого их гардаг, үүнээс шалтгаалж насанд хүрээгүй хохирогч айх, дарамтанд орох, залхах, улмаар мэдүүлгээсээ буцах, мөрдөн байцаалтын шатанд хэргийн шийдвэрлэлт удаашрах зэрэг бэрхшээлүүд гардаг.

Бэлгийн мөлжлөгт тогтмол ашигласан үйлдэл нь хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг агуулсан байсан ч хүчирхийлсэн этгээдийг

Захиргааны хариуцлагын тухай хуулиар торгож байна. Судлаж үзсэн хэргүүдийн нэг нь тогтмол бэлгийн мөлжлөгт өртүүлсэн, хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг агуулсан байсан ч цагдаагийн ажилтан хохирогчийг худлаа ярьж байна хэмээн буруутган "биеэ үнэлэгч", "өөрөө буруутай" гэсэн нүдээр харж, хүчирхийлсэн этгээдийг торгоод өнгөрөөсөн баримт нэг бус байна.

Цагдаагийн байгууллагын анхан шатны нэгж, хороонд ажиллаж байгаа хэсгийн байцаагч нарт энэ төрлийн гэмт хэргийг шийдвэрлэх, шалгах эрмэлзэл бага, ур чадвар дутагдалтай учир шалгахаас зайлсхийж, ажлаа хялбарчлахын тулд Садар самуунтай тэмцэх тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хуулийг хэрэглэж байгаа нь зохисгүй юм.

Хүүхдийн эсрэг үйлдэгдэх гэмт хэргийг хүүхдийн асуудлаар мэргэшсэн мөрдөн байцаагч шалгадаг зарчимд шилжвэл шийдвэрлэгдэх боломжтой юм.

Түүнчлэн хохирогчийн ар гэрийнхэн сэжигтэн этгээдүүдийн нөлөөнд орж хувиараа тохиролцон, цагдаагийн байгууллагад шалгуулахгүй, "гомдолгүй" хэмээн эрүүгийн хэрэг үүсгэхээс өмнө хэргийг хаалгах явдал байсаар байна. Холбогдогчийн талын ах дүү нар нь хохирогчийг мэдүүлгээ өөрчлөхийг шаардах, шан харамж амлах, заналхийлэх, хуурч мэхлэх үйлдлийг байнга гаргаж байсан ноцтой баримтууд бидний ажилласан хэргүүд дээр илэрсэн. Үүний гол шалтгаан нь хүчирхийлэгч нь хохирогчтой ойрын хамаатан, садан төрөл, танил талын холбоотой, хохирогч ямар нэг байдлаар хүчирхийлэгчийн эрхшээлд байдгаас шууд шалтгаалж байна.

Кейс 2. Намайг хүчиндүүлээгүй, өөрөө порно кино үзэж байгаад зөвшөөрсөн гэж хэлбэл чиний нэр дээр хашааныхаа талыг байшинтайгаа шилжүүлнэ гээд манай ээжтэй гэрээ хийсэн. Бас намайг "чи насанд хүрээгүй юм чинь худлаа хэлсэн гэж хэрэгтэн болохгүй" гэж ятгасан. Би ээж, дүү нартайгаа хамт гудамжинд гарахаасаа айгаад, тэгээд ч ээжийн минь эгчийн нөхөр болохоор аргагүйн эрхэнд зөвшөөрч худлаа мэдүүлэг өгсөн юм. ..... тоот хавтаст хэрэгт хохирогч Б-ийн өгсөн мэдүүлгээс

Цагдаагийн байгууллага насанд хүрээгүй хүүхдийн бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгийн талаарх мэдээлэл бүрийг шалгах шаардлагатай байна. Хохирогчийн аав, ээж, ах дүү, хамаатан садных нь хүсэлтээр хаах хууль бус явдлыг таслан зогсоох нь чухал.

Хохирогчийн шүүх эмнэлгийн үзлэгийг төлбөртэй хийж байна. Шүүх эмнэлгийн үзлэг, шинжилгээний зардал нь ялангуяа ядуу амьдралтай айлын хүүхдэд дарамт учруулж байна. Хэргийг шалгах явцад хохирогч жирэмсэн болсон, бэлгийн замын халдварт өвчин туссан нь хожуу илэрч, бие махбодь, сэтгэл санаа, эрүүл мэндийн хувьд дахин хохирох, цаг хугацаа алдсанаас ураг хөндүүлэхэд хохирогчийн амь насанд аюултай нөхцөл байдал бий болсон тохиолдол гарч байлаа.

Бэлгийн замын халдварт өвчний оношилгоо, шинжилгээ үнэ төлбөргүй хийгдэж байгаа боловч эмчилгээ нь төлбөртэй, ялангуяа өвчин хүндэрсэн байх тусам илүү өндөр өртөгтэй болдог нь хохирогчийг давхар дарамтанд оруулж байна. Иймд хохирогч хүүхдийн шүүх эмнэлгийн зардал, эрүүл

мэндэд учирсан хор уршгийг арилгах, нөхөн үржихүйн шаардлагатай тусламж, үйлчилгээ, нөхөн сэргээх үйлчилгээг төрөөс үнэ төлбөргүй үзүүлдэг болгох шаардлагатай юм.

Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн хохирогч хүүхдэд шөнийн цагаар үйлчилгээ үзүүлдэг хамгаалах байр байхгүй байна. Нийслэлийн хэмжээнд хүүхдийн нэг хамгаалах байр байдаг ч төрийн бус байгууллагын энэ хамгаалах байрны санхүүжилт хүрэлцээгүйн улмаас шөнийн цагаар үйлчилгээ үзүүлэх боломжгүй байна. Төрийн байгууллагуудын харьяалалд хүүхдийг болон хүчирхийлүүлэгчийг хамгаалах байр байхгүй байгаа нь тулгамдсан асуудал болжээ.

Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийг нийгэмшүүлснээр хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, хүүхдийг биеэ үнэлэх явдал, бэлгийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх боломжтой юм.

Гэтэл мөрдөн байцаалтын шатанд хэргүүдийг шалган шийдвэрлэж байгаа дундаж хугацаа 5 сар байгаа нь хохирогчийн хувьд урт байна. Энэ хугацаанд холбогдогчийн ар гэрийнхэн хохирогчийг дарамтлах, айлган сүрдүүлэх зэргээр нөлөөлж, хүүхэд байцаан шийтгэх ажиллагаанаас залхах, улмаар бусдын ятгалгад орж мэдүүлгээсээ буцах боломжийг бүрдүүлж байна.

Үйл ажиллагааны хүрээнд өгөх дүгнэлт:

"Насанд хүрэгүй хүнийг биеэ үнэлэхэд татан оруулсан" гэмт хэргийн цаана хүүхдийг бусдад худалдах, дамжуулан худалдах гэмт хэрэг далдлагдаж байна. Насанд хүрэгүй хүүхдийг бэлгийн мөлжлөгт өртүүлсэн, хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг агуулсан ноцтой үйлдэлд хохирогчийг өөрийг нь "биеэ үнэлэгч" гэж буруутган, гэм буруутай этгээдийг Захиргааны хариуцлагын тухай хуулиар торгоод өнгөрөөхгүй байх хэрэгтэй байна. Бэлгийн мөлжлөгт өртсөн насанд хүрэгүй хохирогчдод Захиргааны хариуцлагын тухай хуулиар шийтгэл хүлээлгэж байгаа нь тэдний хуулийн байгууллагад итгэх итгэлийг алдагдуулж, улмаар цагдаагийн байгууллагад хандахаас татгалзахад хүргэж байна.

Захиргааны зөрчлийг гэмт хэрэгтэй ижил байдлаар хуульчилж, хэм хэмжээний давхардал үүсгэж байгаа нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд бэрхшээл учруулж байна. Улсын дээд шүүхийн тайлбарт "эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол" гэсэн ойлголт хэт бүрхэг байгаа нь хууль хэрэглэж, хэрэг маргааныг шийдвэрлэхэд сөргөөр нөлөөлж байна.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны шат дамжлага удаан, хохирогч гомдолтой гэсэн тохиолдолд хохирлоо нөхөн төлүүлж чадах эсэх нь эргэлзээтэй учраас хохирогч хохирлын менгэ гэж хэдэн төгрөг аваад гомдлоосоо буцахад хүрч байна. ЭБШХ-ийн 25 дугаар зүйлд зөвхөн хөнгөн гэмт хэргийг хуульд заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгодог бөгөөд бусад төрлийн гэмт хэргийн хувьд хэрэгсэхгүй болгох боломжгүй юм. Гэтэл бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн хэргийг шалгаж, шийдвэрлэх явцад "хохирогчийн ар гэрийнхэнтэй нь эвлэрсэн" гэсэн үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгож хууль зөрчих явдал гаргаж байна.

Мөрдөн байцаалт явуулж байгаа орчин, нөхцөл нь хохирогчийн нууцлал, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байна. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд "Насанд хүрээгүй гэрч, хохирогчийг байцаах" талаар тусгайлсан бүлэг одоогоор байхгүй, зөвхөн насанд хүрээгүй гэрч, хохирогчийн мэдүүлгийг шүүх ажиллагааны үед сонсох талаар л заажээ. Харин 145 дугаар зүйлд заасан Насанд хүрээгүй гэрчийг байцаах зохицуулалт нь "хохирогч хамгаалал"-ын үйл ажиллагаатай төдийлэн хамааралтай биш байна.

Мөрдөн байцаалт, шүүхийн шатанд хохирогчийг хөндлөнгийн нөлөөллөөс хамгаалах хуулийн арга хэрэгсэл байхгүй, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нарын ажил дүгнэх үзүүлэлтэд нь ордоггүй учир тэд ийм асуудалд "хуулиар хүлээсэн үүрэгт ажил биш" гэж хүнийрхсэн байдлаар хандаж байна. Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн хохирогч хүүхдийн аюулгүй байдлыг хангах, нөхөн сэргээх, эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагууд тогтвортой санхүүжилтийн эх үүсвэргүй, гаднын байгууллагын санхүүжилтээр үйл ажиллагаа явуулж байна.

Хуулийн байгууллагын үйл ажиллагаанд өгөх зөвлөмж: Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж байгаа гэмт хэргийн статистик үзүүлэлтийг төрөлжүүлэн гаргах, гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн гэмтэл, хүлээсэн хохирол, гэмт хэрэг үйлдэгчдийн онцлог гэх мэтээр нарийвчлан гаргавал үр дүнтэй байж болохоор байна.

Хүүхдийн хувьд "биеэ үнэлэлт" гэсэн ойлголт байх боломжгүй. Энэ нь бэлгийн хүчирхийллийн үр дагавар учир ийм тохиолдол бүрийг нарийвчлан судалж үзсэний үндсэн дээр шалтгаан, нөхцлийг тогтоож, цаана нь байгаа гэмт этгээдүүдийг эрүүгийн хэрэгт заавал татан шалгаж байх;

Ураг төрлийн буюу гэр бүлийн хүрээнд үйлдэгддэг хүчингийн гэмт хэргийн хохирогчийг хамгаалахын тулд хүчирхийлэл үйлдсэн этгээдэд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн эрх хязгаарлах арга хэмжээний төрлүүдээс авахуулах, хуулийн боломжийг ашиглаж хэвших;

Хуулийн давхардал хийдлийг арилгах, хуулийг хэрэгжүүлэхэд гарч байгаа хүндрэл бэрхшээлийн талаар тухай бүрд нь бодлого боловсруулагчидад хүргэх талаар санал дэвшүүлж тайланд тусгаж байх шаардлагатай.

Цагдаагийн байгууллагад өгөх зөвлөмж:

Шинэ тутам арга хэрэгслээр үйлдэгдэж байгаа гэмт хэргийн шалтгаан нөхцөл нь онцлог байдлаас шалтгаалан өөр өөр байдаг тул хууль сахиулах байгууллагын албан хаагч криминологийн судалгааны наад захын аргачлалуудыг хэрэглэж чаддаг чадвартай байх хэрэгтэй юм. Өнөөдөр хотын эсхүл аймгийн нөгөө захад хэрэглэж байгаа арга таны хариуцсан хороо нутаг дэвсгэрт өөр үр дүн үзүүлж болох тул энэхүү судалгааны аргуудыг эзэмших нь тун чухал.

Наад зах нь "Цагдаагийн байгууллагын тухай хууль"-д заасан "обьектын судалгаа" хийх явцдаа тодорхой ажиглалт, туршилт хийх /болгоомжтой хэрэглэвэл зохино./, сар бүрийн нуугдмал болон бүртгэгдсэн хэрэг дээр хэрэглээний программ ашиглан прогноз гаргаж, түүнд тохирсон арга

хэрэгслийг сонгон хэрэглэж сурах, зарим тохиолдолд иргэд олон нийтийн туслалцааг ашиглан анкетийн болон ярилцлагын судалгааг явуулж чаддаг байх хэрэгтэй юм.

Цаашид цагдаагийн байгууллагын бүх албад нь хүүхэд гэмт хэргийн улмаас хохирсон тохиолдол бүрт шалтгаан нөхцөлийг бодитой тогтоож, бичиж байгаа мөрдөн байцаагчийн мэдэгдлийн чанар үр нөлөөг дээшлүүлэх хэрэгтэй байна. Аргацаасан нүд хуурсан мэдэгдэл нь цаас, цагийг дэмий гарздаж байгаа төдийгүй судалгаанд ашиглагдах бүтээгдэхүүн болж чадахгүй байгааг анхаарвал зохино.

Хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын шатанд шалгагдсан хэргийн шалтгааныг арилгахаар бичиж байгаа мэдэгдэл нь сум дүүрэг баг хорооны засаг даргад чиглэсэн байдаг боловч тэдгээрт хүрсэн эсэх нь эргэлзээтэй, хариу авсан тухай ямар нэг тэмдэглэл байхгүй байна. Энэ бүхнийг харгалзан үзэж мэдэгдлийн хариу авалт, хэрэгжилтийн мөрөөр эргэн шалгаж биелүүлээгүй бол "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль" болон "Эрүүгийн байцаан шийтгэх хууль"-ийн холбогдох заалтыг үндэслэн торгох, сануулах зэрэг албадлагуудыг хэрэглэж байх хэрэгтэй юм.

Түүнчлэн байгалийн баялаг дагасан үйлдвэржилт, олборлолт, түүнийг дагасан хууль бус аргаар алт олборлох, нинжа гэх мэт сөрөг үзэгдлүүдийн цаана хүүхдийг албадан болон хүчээр хөдөлмөрлүүлэх гэмт хэрэг гарч болзошгүй, гуйланчлал, мансуурал, тэнүүчлэлд татан оролцуулж байгаа гэмт хэргийн тухай мэдээллийг шалгах, өргөдөл гомдол хүлээн авах, шийдвэрлэх, шалган нотлон тогтооход алба хаагчдын ур чадварыг нэмэгдүүлэхийн тулд сургалт зохиож байх;

Орон нутагт гарч байгаа элдэв харш буруу зан үйлд хүүхдийг татан оролцуулж байгаа, /тухайлбал цавуу, гааз, гутлын тос үнэртэх, архидан согтуурах/ садар самуунд уруу татаж байгаа үйлдэл бүрийг шалгаж, шийдвэрлэж байх;

Хэсгийн байцаагчийн бүртгэл судалгааг баяжуулах, түүнийг шалгах гэх мэт уламжлалт сэтгэлгээ, ажил дүгнэх үзүүлэлтийг өөрчилж түүнд хэрхэн дүн шинжилгээ хийж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд ашигласан, ямар дүнд хүрсэн зэргээр нь дүгнэж байх. Өөрөөр хэлбэл бүртгэл, судалгааг шалгалтын үед гаргаж харуулдаг, нэр төдий хөтөлж аргацаадаг байдлыг таслан зогсоох хэрэгтэй юм.

---o0o---

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

"БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ, ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙГ ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН"

Оршил

Монгол Улсад гарч байгаа насанд хүрээгүй хүмүүсийн эсрэг үйлдэгдэх гэмт хэргийн сэдэлт, арга нь улам бүр харгис хэрцгий болж, хүүхэд бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд өртөж, гэмт хэргийн улмаас сэтгэл санаа, бие махбодд, эд материалын хохирол хүлээсээр байна. Практикт гэмт хэргийн улмаас тэр тусмаа бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн улмаас хохирсон хүүхдийн эрх ашгийг хамгаалах хууль зүйн боломж байсаар байтал түүнийг анзаарахгүй орхигдуулж, гэмт этгээдүүдэд ял заавшуул боломж олгон, хуулиар хориглоогүй бусад арга хэмжээг авахгүй байна. Энэхүү өгүүллээрээ бид гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн эх сурвалжуудад дүн шинжилгээ хийн, тэдгээрийг хэрэгжүүлэхэд гарч байгаа хүндрэл бэрхшээлийг гарган ирж, тодорхой шийдлүүдийг санал болгох юм.

Бэлгийн мөлжлөгийн тодорхойлолт, ойлголт

Олон Улсын хэм хэмжээ

ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай конвенц[634] нь түүнийг соёрхон баталж буй гишүүн орнуудаас хүүхдийг биеэ үнэлэх үйл ажиллагаа, садар самууны сурталчилгаа болон садар самууны үзүүлбэрт ашиглах, элсүүлэн авах эсвэл үүнийг санал болгохыг /Заалт 3 /б// хориглох болон арилгах үр дүнтэй арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэхийг шаардажээ.

ОУХБ-ын 182-р конвенцийн 3-р зүйл:

- Боолчлолын бүх хэлбэрүүд болон хүүхдийг худалдах, дамжуулан худалдах, өрийн төлөөс, хамжлагын албат болгох, хүчээр буюу албадан хөдөлмөрлүүлэх, түүний дотор зэвсэгт мөргөлдөөнд ашиглахын тулд хүүхдийг хүчээр буюу албадан элсүүлэх зэрэг боолчлолтой төстэй үйл ажиллагаанууд;
- Хүүхдийг биеэ үнэлэх үйл ажиллагаа, садар самуун сурталчилгаа болон садар самууны үзүүлбэрт ашиглах, элсүүлэн авах эсхүл үүнийг санал болгох;
- Мөн чанар, эсвэл хөдөлмөрийн нөхцлөөрөө хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд сөрөг нөлөө үзүүлэхүйц ажил.

Мөлжлөгийн эдгээр тухайлсан тодорхойлолтууд нь уг конвенцийг хөдөлмөр эрхлэлтийн салбарт хүүхдийн эрхийг хамгаалах үйл ажиллагааг дэмжих хамгийн хүчирхэг хэрэгсэл болж байгаа юм.

[634] ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай конвенц, 1999 он /№182/

Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын Конвенц

Энэхүү олон талт арга хэрэгсэл нь оролцогч улсуудаас хүүхэд нь эдийн засгийн мөлжлөгөөс хамгаалуулах болон түүний эрүүл мэндэд хохирол учруулах буюу боловсрол олоход нь саад болох, эсхүл түүний эрүүл мэнд, бие бялдар, оюун ухаан, ёс суртахууны болон нийгмийн хөгжилд нь хор уршиг учруулж болзошгүй ямарваа нэгэн ажил эрхлэхээс сэргийлүүлэх эрхтэйг хүлээн зөвшөөрөх /1/ мөн хүүхдийг бэлэгсийн хууль бус аливаа ажиллагаанд ятгаж юмуу албадаж татан оролцуулах явдал болон хүүхдийг мөлжлөгийн зорилгоор биеэ худалдах, садар самууны зүйл, садар самуун явдлыг дүрсэлсэн материал болон бэлэгсийн хууль бус бусад хэрэгт ашиглахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үндэсний, хоёр талын, олон талын бүхий л тохирох арга хэмжээг авахыг /2/ шаарддаг байна.

Хүүхэд худалдах, биеийг нь үнэлэх болон хүүхдийг садар самуунд ашиглах тухай Хүүхдийн эрхийн конвенцид оруулсан нэмэлт протокол:

Энэхүү протокол нь оролцогч улсуудыг арилжааны бэлгийн мөлжлөгт өртөх магадлал ихтэй хүүхдүүдийг хамгаалахад онцгой анхаарал хандуулж, хохирогч-аврагдагсдад зохих ёсны бүх тусламж, үүний дотор тэднийг нийгэмд бүрэн татан оруулах болон бие махбодийн хийгээд сэтгэл зүйн хувьд бүрэн нөхөн сэргэснийг баталгаажуулах бүх боломжит арга хэмжээг авахыг шаарддаг.

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын Конвенц-ын нэмэлт болох "хүн, ялангуяа эмэгтэйчүүд болон хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ба ял шийтгэх тухай" 2000 оны Протоколын 3 дугаар зүйлийн "а" хэсэгт хүн худалдаалах гэж *"бусдыг мөлжих зорилгоор хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эмзэг байдлыг нь далимдуулах, эсхүл өөр этгээдийг хяналтандаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр хийх, ашиг олгон хахуульдах замаар хүнийг элсүүлэх, зөөх, тээвэрлэх, дамжуулах, нуух буюу хүлээн авах"*-ыг ойлгоно гэжээ.

> ***"Sexual explotation"*** *буюу* ***"бэлгийн мөлжлөг"*** *хэмээх ойлголт нь наад зах нь бусдын биеийг үнэлүүлэх буюу бэлгийн харилцаанд оруулан мөлжих бусад хэлбэрийг хэлнэ* гэснээс үзвэл хүчирхийллийн шинжтэй аливаа үйлдэл хамаарахаргүй байна. Харин үүнийг* ***"гаре"*** *буюу* ***"хүчиндэх"*** *гэсэн утгаар тусад нь ойлгож хэрэглэж байна. Үүнээс гадна* ***"abuse"*** *хэмээх ойлголтыг нь* ***"доромжлон харьцах"*** *хэмээн ойлгож болохоор байгаа бөгөөд ихэвчлэн насанд хүрээгүй хүмүүсийн үйлдэгддэг гэмт хэрэгт хэрэглэгддэг нэр томьёо юм.*

* "Хүн худалдаалах гэмт хэргийн асуудлаар ажилладаг хуулийн байгуулагын ажилтнуудад зориулсан гарын авлага", Палермогийн конвенцийн нэмэлт протокол, 3 дугаар зүйл /а/

ОУХБ-аас арилжааны шинжтэй хүүхдийн бэлгийн мөлжлөгийг хүүхэд болон өсвөр насныхны эрхийг ноцтой зөрчиж байгаа явдал бөгөөд боолын болон албадан хөдөлмөртэй адил эдийн засгийн мөлжлөгийн хэлбэр ба энэ нь охид, хөвгүүд болон өсвөр насныхныг сексийн арилжаанд ашигладаг хүмүүсийн зүгээс үйлдэж буй гэмт хэрэг хэмээн үздэг.

Арилжааны шинжтэй хүүхдийн бэлгийн мөлжлөгт:

- Гудамжинд болон янхны газар, диско клуб, массаж, баар, зочид буудал, зоогийн газар гэх мэт газруудад охид хөвгүүдийг бэлгийн үйл ажиллагаанд /тогтсон хэллэгээр бол хүүхдийг биеэ үнэлэх явдалд/ мөнгөн болон мөнгөн бус урамшуулал хэлбэрээр ашиглах, уруу татах;
- Бэлгийн арилжааны зорилгоор охид, хөвгүүд болон өсвөр насныхныг худалдаалах;
- Секс жуулчлалд хүүхдийг татан оролцуулах;
- Хүүхдийг порнограффд татан оролцуулах;
- Хүүхдийг секс үзүүлбэрт ашиглах /олон нийтийн болон хувийн/ зэргийг багтаадаг /Child sexual abuse/.

Үүний нэг адилаар Стокгольмын тунхаг[635] арилжааны шинжтэй хүүхдийн бэлгийн мөлжлөгийг ***"албадан хөдөлмөр болон боолчлолын орчин үеийн хэлбэр болж өргөжсөн хүүхдийн эсрэг албадлага, хүчирхийллийн хэлбэр юм"*** гэж тодорхойлжээ.

<u>Монгол Улсын эрх зүйн хэм хэмжээ:</u>

Монгол Улсын Эрүүгийн хуулиар хүүхдийн биеийг бусдад төлбөртэй үнэлүүлж мөлжих нь "хөнгөн" гэмт хэрэгт тооцогдож байна.

Монгол Улсын хууль, тогтоомжийн хүрээнд судлан үзвэл хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй арилжааны шинжтэй бэлгийн мөлжлөгийг үндсэндээ Эрүүгийн хуулийн 115 дугаар зүйлийн 115.1. "Насанд хүрээгүй хүнийг биеэ үнэлэхэд татан оролцуулах" гэсэн зүйл, заалтаар зохицуулж байна. **Эндээс үзвэл хүүхдийн биеийг үнэлүүлсэн этгээд насанд хүрсэн хүний биеийг үнэлүүлснээс хөнгөн ял шийтгэгдэхээр хуульчилсан ба хүүхдийн биеийг бусдад төлбөртэй үнэлүүлж мөлжих нь "хөнгөн" гэмт хэрэгт тооцогдож байгаа** нь тод харагдаж байна. Энэ нь хүүхдийн эрхийг хэт дорд үзсэнээс гадна Эрүүгийн хуулийн "гэм буруутай этгээдэд үйлдсэн гэмт хэрэгт нь тохирсон хариуцлага хүлээлгэх" зарчимтай нийцэхгүй байна.

Монгол Улсын Дээд шүүхээс: "124 дүгээр зүйлийн 124.1-д заасан ***"биеэ үнэлэхэд татан оролцуулсан" гэж шунахай болон хувийн бусад сэдэлтээр хохирогчийг бусадтай бэлгийн харьцаанд төлбөртэй оруулахыг хэлнэ"*** гэжээ Эрүүгийн хуулийн 115 дугаар зүйлийн 115.1-д заасан "биеэ үнэлэхэд татан оруулсан" гэдгийг дээрхтэй нэгэн адилаар ойлгож, хэрэглэнэ" гэж тайлбарлажээ.

---

[635] Стокгольмын тунхаг ба үйл ажиллагааны хөтөлбөр /1996/: Энэхүү баримт бичгийг Арилжааны шинжтэй хүүхдийн бэлгийн мөлжлөгийн эсрэг Дэлхийн чуулга уулзалт дээр батлсан бөгөөд энэ нь оролцогч бүх орнуудыг дээрх асуудалд анхаарал хандуулахын тулд Үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр боловсруулахыг үүрэг болгосон байна. Мөн үндэсний хөтөлбөрүүдийн дэвшил, хэрэгжилтийг хянах механизм байна гэжээ.

"Насанд хүрэгүй биеэ үнэлэгч" гэсэн ойлголт байхгүй бөгөөд насанд хүрэгүй хүнийг бэлгийн харьцаанд төлбөртэй оруулсан тохиолдол бүрийн цаана **хүүхэд хэн нэгэн этгээдийн эрхшээлд байдаг шинжийг хууль тогтоогч орхигдуулснаас гэмт этгээдүүдэд ял завших, энэ төрлийн гэмт хэргийг өөгшүүлэх боломжийг бүрдүүлжээ.**

Хууль тогтоогч ямар шаардлагын улмаас насанд хүрэгүй хүнийг бэлгийн харьцаанд төлбөртэй оруулж мөлжих үйлдлийг "биеэ үнэлэхэд татан оролцуулах" гэж үзэх болсон, яагаад хөнгөн гэмт хэрэгт тооцсон, ямар шалтгааны улмаас Эрүүгийн хуулийн 115 дугаар зүйлд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж болгон авч үзсэн нь тодорхойгүй байна. Харин Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйл буюу "Хүн худалдаалах" гэмт хэргийн бүрэлдэхүүний хүндрүүлэх бүрэлдэхүүнд шууд хамаарч байна. Иймд хуулийн дээрх хэм хэмжээг өөрчилж Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн хүндрүүлэх бүрэлдэхүүн болгон зүйлчлэх нь зохимжтой гэж үзлээ.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад гэрч, хохирогч хүүхдийг хамгаалах зохицуулалт байхгүй байна: Насанд хүрэгүй хохирогчийн хувьд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 269 дүгээр зүйлийн 2-т "насанд хүрэгүй гэрч, хохирогчийн мэдүүлгийг сонсохдоо түүний эцэг эх, хууль ёсны төлөөлөгч, түүнчлэн сурган хүмүүжүүлэгчийг оролцуулж болох, тэдгээр нь шүүх хуралдаанд даргалагчийн зөвшөөрөлтэйгээр гэрчид асуулт тавьж болно", мөн зүйлийн 3-т "хэргийн бодит үнэнийг тогтооход ач холбогдолтой бол шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаар шүүгдэгчийг хуралдааны танхимаас гаргасны дараа насанд хүрээгүй гэрч, хохирогчийн мэдүүлгийг сонсож, улмаар түүнийг танхимд орж ирсний дараа гэрч, хохирогчийн мэдүүлгийг танилцуулж, түүнд гэрч, хохирогчид асуулт тавих боломж олгоно", мөн зүйлийн 4-т "насанд хүрэгүй гэрч, хохирогчийг цаашид байлгах шаардлагагүй бол түүний мэдүүлгийг сонссоны дараа шүүх хуралдааны танхимаас гаргана" гэж тус тус заасан байна.

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн "Насанд хүрэгүй хохирогчийг байцаах" 148 дугаар зүйлийн 1-д насанд хүрэгүй хохирогчийг энэ хуулийн 145 дугаар зүйлд заасан журмын дагуу буюу насанд хүрэгүй гэрчийг байцаахдаа түүний эцэг, эх, хууль ёсны төлөөлөгч, эсхүл төрөл, садангийн хүн, түүнчлэн сурган хүмүүжүүлэгчийг оролцуулах бөгөөд тэдэнд эрх, үүргийг нь тайлбарлан өгч, энэ тухай тэмдэглэлд тусгаж байхаар заасан байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 42 дугаар зүйлд "хохирогч" гэдгийг тодорхойлохдоо "гэмт хэргийн улмаас нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн этгээдийг хохирогч гэнэ" гэсэн боловч "хохирогч хүүхэд" гэж тусгайлан заагаагүй байна.

Мөн хохирогчийн эрхийг өмгөөлөгч авах, нотлох баримтыг шалгуулах хүсэлт гаргах, гэмт хэргийн улмаас өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, 42.3.10-д цагаатгах болон шийтгэх тогтоолын хувийг авах, түүнд давж

заалдах болон хяналтын шатны журмаар гомдол гаргах эрхтэй болохыг заасан байна.

Харин хохирогч хүүхэд бие махбодь, сэтгэл санааны хувьд бүрмөсөн эдгэрэх, нийгэмшихэд хэрэгцээтэй зохих тусламжийг авах тухай болон эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад гэрч, хохирогч хүүхдийг хамгаалах талаар тусгайлсан заалт байхгүй байна.

Монгол улсын хэмжээнд хүүхдийг бэлгийн мөлжлөгт ашиглах гэмт хэрэг үйлдэгдэж байгаа нөхцөл байдал

Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн хүүхдийг хамгаалах хууль, эрх зүйн орчинд зарим дэвшил үзэгдэж байгаа боловч энэ төрлийн гэмт хэрэг нуугдмал байдгаас шалтгаалж хуулийн байгууллагуудаар шийдвэрлэгдэж байгаа нь цөөн байна. Судалгааны дүнгээс үзэхэд Улаанбаатар хот болон хилийн боомтын хот, суурингуудад хүүхдийн бэлгийн мөлжлөг нэмэгдэж, орон нутагт үйлдэгдэж байгаа гэмт хэрэг илрэхгүй байна.

Бэлгийн мөлжлөгт өртсөн охидын нэлээд нь гэр бүл дэх хүчирхийлэл, зөрчилдөөний улмаас орон гэрээсээ дайжсан хүүхдүүд байдаг. 2008 оны ХҮЭК-ийн тайлангаас үзэхэд олон жил тэнэмэл амьдарлаар айл, халамжийн төв дамжин амьдардаг, хөдөө орон нутгаас нийслэлд нүүж суурьшсан, ядуу өрхийн сургууль завсардсан, гэр бүлийн хүчирхийлэлд өртдөг, зах дээр хөдөлмөр эрхэлдэг, эцэг эх нь салсан, хойд эцэгтэй гэр бүлийн охидууд бэлгийн мөлжлөгт илүү ихээр өртөж байна[636]. Хүүхдийг бэлгийн мөлжлөгт ашиглагчдын ихэнх нь зах дээр хувиараа хөдөлмөр эрхлэгчид, гудамжинд амьдрагчид, үе тэнгийн хөвгүүд, архинд донтогчид байгаа нь сэтгэл түгшээж байна[637]. Өсвөр насны охидын дунд бусдыгаа бэлгийн мөлжлөгт зуучлах, уруу татах явдал цөөнгүй байгаа төдийгүй гэмт хэрэг үйлдсэн этгээдийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх талаар явуулж буй төрийн бодлого, үйл ажиллагаа хангалтгүй байна[638].

Энэ төрлийн гэмт хэргийн үйлдэгдэж буй хэлбэрийг үзэхэд:

- Бэлгийн мөлжлөгт өртүүлэх;
- Хүчиндэх;
- Садар самуунд уруу татах;
- Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах;
- 16 насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх;
- Хүн худалдаалах зэрэг хэлбэртэй байна.

ЦЕГ-ын Мэдээлэл дүн шинжилгээний төвөөс гаргасан сүүлийн 4 жилийн статистик үзүүлэлтийг үзвэл[639]:

2006 онд Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг хэрэг 2005 оноос 10 хувиар буурсан байна.

---

[636] ХЭҮК-ийн тайлан. УБ., 2008 он. 46 дахь тал.

[637] ХЭҮК-ийн тайлан, УБ., 2008 он. 46 дахь тал.

[638] Хүн амын сургалт, судалгааны төв, 2005 он. ОУХБ/АЙПЕК-ийн санхүүжилттэйгээр хийгдсэн

[639] ЦЕГ-аас жил бүр гаргадаг гэмт хэргийн мэдээнээс

2007 онд Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг хэрэг өмнөх оныхоос 12.0 хувиар буурсан байна. Гэмт хэргийн улмаас 19931 иргэн хохирсны 5.8 хувь нь насанд хүрээгүй хүн байна.

2008 онд Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг хэрэг *бүртгэгдсэн нийт гэмт хэргийн* 2.1 хувийг эзэлж байна. *Эрүүгийн хуулийн тусгай ангийн бүлэглэлээр авч үзвэл:* хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг хэрэг 10.9 хувиар өсчээ.

2009 онд Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг 375 гарч бүртгэгдэн, урд оныхоос 12 хувиар буурсан байна. Гэмт хэргийн улмаас19545 хүн хохирсны 5.3 хувь нь хүүхэд байна.

Үүнээс үзэхэд хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг тогтмол гарч бүртгэгддэг боловч энэ төрлийн гэмт хэрэг буурах хандлагатай байгаа эерэг үзүүлэлт байна. Гол нь илэрсэн нэг хэргийн цаана илрээгүй хэдэн хэрэг байгаа нь тодорхойгүй байдаг. Ялангуяа насанд хүрээгүй хүмүүсийн эсрэг үйлддэг гэмт хэргийн илрүүлэлт бага байдаг гэдгийг мартаж болохгүй юм. Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлгийн хэрэгжилт тааруу байна. Мөрдөн байцаагч нартай хийсэн бүлгийн ярилцлагын судалгаанаас үзэхэд энэ төрлийн гэмт хэрэг цөөн тоотой гарч бүртгэгддэг, ихэвчлэн нууц далд байдалд байдаг байна[640].

Хуулийн хэрэгжилт дутмаг шалтгааныг судлан үзэхэд хуулийн байгууллагад энэ төрлийн гэмт хэргийн мэдээлэл ирдэггүй, ихэвчлэн гэр бүлийн хүрээнд үйлдэгддэг, гэмт хэргийн хохирогч болсон насанд хүрээгүй хүмүүсийн өмнөөс өргөдөл гомдол гаргах субьект байдаггүй аж[641]. Иймээс гагцхүү гэмт хэргийн тоон үзүүлэлт бус бусад эх сурвалжид дүн шинжилгээ хийсний үндсэн дээр энэ төрлийн гэмт хэргийн нөхцөл байдал, шалтгаан, урьдчилан сэргийлэх арга замыг боловсруулж хохирогчид ээлтэй өмгөөллийн хувилбар, тактикийг боловсруулах нь зайлшгүй хэрэгцээтэй байна гэж үзэв.

Шүүхээр шийдвэрлэгдсэн байдал: Монгол Улсад 2002-2009 онд шүүхээр шийдвэрлэгдсэн, хэрэгсэхгүй болгосон ЭХ-ийн 113 дугаар зүйл, 124 зүйлд заасан эрүүгийн хавтаст хэргийн судалгаанаас үзэхэд ЭХ-ийн 113 дугаар зүйл, ЭХ-ийн 124 зүйлийг нэг мөр ойлгон хэрэглэх талаар онол-аргазүйн зөвлөмж гаргах, урьд шийдэгдсэн эрүүгийн хэрэгт дүн шинжилгээ хийсний үндсэн дээр хуулийн байгууллагын ажилтнуудад сургалт явуулах шаардлагатай байгааг харуулж байна. Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлийн "…. Хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, хуурч мэхлэх замаар биеэ үнэлэхэд татан оролцуулсан…" гэдэг хэсгийн агуулгыг өөрчлөх хэрэгтэй байна. Өөрөөр хэлбэл энэ нь ЭХ-ийн тухайн заалтыг нэг мөр хэрэгжүүлэхэд томъёоллын хувьд эргэлзээ, маргаан үүсгэх нэг хүчин зүйл болж байгаа юм.[642]

---

[640] Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн төлөв байдал" судалгааны тайлангаас, ХЗҮХ, ЭЗЗКС, 2009 он

[641] Төслийн хүрээнд УМБГ-тай хамтран зохион байгуулсан 15 мөрдөн байцаагчтай хийсэн ярилцлагын судалгаанаас, ХЗҮХ., 2009 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр.

[642] "Хүн худалдах гэмт хэргийн шийдвэрлэлт" судалгааны тайлангаас, ХТЭТ, 2009 он

2002-2008 онд хүн худалдаалах гэмт хэрэг болон биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах талаар хийсэн судалгаанаас үзэхэд энэ ***таван жилд эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлээр 4 хэрэгт 4 хүн ял шийтгүүлсэн бол 124 зүйлээр 32 хэрэгт 53 хүн ял шийтгүүлсэн байна.*** Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлээр 2006 онд-1 хэрэгт 1 хүн, 2007 онд- 1хэрэгт 1 хүн, харин 2008 онд-2 хэрэгт 2 хүн, 2009 он гарсаар 4 хэрэгт 7 хүн, 2009 оны 12 сарын байдлаар 1 хэрэг /5 холбогдогчтой./ шүүхээр эцэслэн шийдвэрлэгдээгүй байна. Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлээр 2005 онд - 2 хэрэгт 5 хүн, 2006 онд - 2 хэрэгт 1 хүн, 2007 онд – 8 хэрэг 8 хүн ял шийтгүүлсэн бол 2008 онд 20 хэрэгт-39 хүн ял шийтгүүлжээ[643].

Гэтэл ЦЕГ-ын МДШТ-ийн мэдээгээр 2007 онд хүн худалдаалах гэмт хэрэг огт бүртгэгдээгүй бол 2008 онд 9 хэрэг бүртгэгджээ. Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг 2007 онд огт бүртгэгдээгүй бол 2008 онд 27 гэмт хэрэг бүртгэгдсэн байна.

Статистик үзүүлэлт:

Судалгаанаас харахад 124 дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн 65 хувь нь эмэгтэйчүүд, нийт ял шийтгүүлсэн 37 ялтны насны байдлыг судлахад 19-30 насны 9, 31-35 насны 18, 36–аас дээш настай хүн 18 байна. Боловсролын хувьд дээд мэргэжилтэй 8, тусгай дунд 4, бүрэн дунд 16, суурь боловсролтой 7, бага боловсролтой 2 байна. Нийт ажил сургуульгүй хүн 19, гадаадын иргэн 3 хүн байна.

Нийслэлийн цагдаагийн газрын олон нийттэй харилцах хэлтсээс гаргасан мэдээгээр хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд буюу нэгдсэн арга хэмжээгээр биеэ үнэлдэг нь тогтоогдсон, хүүхдийн байцаагчийн хяналтанд байдаг насанд хүрээгүй охидын тоо 2005 онд 93, 2006 онд 156, 2007 оны эхний 9 сарын байдаар 127 гэж гарсан байна. Эрүүгийн цагдаагийн газраас гаргасан мэдээгээр улсын хэмжээнд биеэ үнэлсэн гэсэн үндэслэлээр захиргааны арга хэмжээ авагдсан насанд хүрээгүй хүүхдүүд 2005 онд 380, 2006 онд 412, 2007 онд 426 /давхардсан тоогоор/ болж өссөн байна.

Шүүхийн практикт: Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйл, биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийг үндсэнд нь зөв зүйлчилж байгаа боловч насанд хүрээгүй хүнийг хүч хэрэглэн авч явж, зодож хүчээр биеийг нь үнэлүүлсэн үйлдлийг хүн худалдаалах гэмт хэргээр зүйлчлэхгүй, Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйл *"Биеэ үнэлэхэд татан оруулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах"* гэсэн хөнгөн зүйлээр зүйлчилж, ноцтой гэмт хэрэгтнийг ял завшуулж байгаа буруу хандлага байгааг таслан зогсоох шаардлагатай юм. Үүнд биеэ үнэлж байгаа этгээдийн хүсэл зориг, үйлдэлдээ хандах харьцааг буруу илэрхийлсэн мэт санагддаг. Хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, хуурч мэхлэх арга хэлбэр нь өөрөө хүн худалдах гэмт хэрэг үйлдэгдэх нэг хэлбэр гэж үзвэл зохино.

[643] УДШ-ийн Судалгааны төвөөс хийсэн судалгаа. 2010 он.

2009 онд Улсын дээд шүүхээс Хүн худалдаалах гэмт хэргийн талаар албан ёсны тайлбар гарч, төрийн болон төрийн бус байгууллагуудаас тодорхой давтамжтай сургалт, сурталчилгаа явуулснаар дээрх гэмт хэргийн шийдвэрлэлт харьцангуй сайжирчээ. Хэдий тийм ч зарим гэмт этгээдүүдэд захиргааны арга хэмжээ авах, торгох төдийгөөр ял завшуулж, өөгшүүлж байгаа нь хууль тогтоомжийн давхардалтай холбоотойгоос гадна хуулийн байгууллагын санаачлага бүхий үйл ажиллагаа дутсантай холбоотой байна.

Ялангуяа "Хүүхэд гэр бүл нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг" үйлдэгдсэн шалтгаан, нөхцөлийг тогтоохдоо "байнга дурдагддаг" нийтлэг нөхцөл байдал болох ажилгүйдэл, ядуурал, нийгмийн байдал гэх мэт "тодорхой бус" хүчин зүйлсийг дурдахаас татгалзсан бодлого барьж ажиллах хэрэгтэйг судалгааны олон дүгнэлт, саналууд харуулж байна.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд тулгарч байгаа асуудлууд:

Ураг төрлийн хүчингийн гэмт хэрэг хожуу илэрдгээс шалтгаалж, мөрдөн байцаалтын шатанд нотлоход хүндрэл бэрхшээл үүсдэг, мөрдөн байцаагчаас тодорхой ур чадвар шаардагддаг нь ажиглагдав. Өөрөөр хэлбэл, зөвхөн мэдүүлгэн нотлох баримт буюу хохирогч, гэрчийн мэдүүлэгт тулгуурлан хэргийг шийдвэрлэдэгтэй холбоотойгоор хохирогчид хөндлөнгөөс нөлөөлөх оролдлого их гардаг, үүнээс шалтгаалж насанд хүрээгүй хохирогч айж залхах, улмаар мэдүүлгээсээ буцах, мөрдөн байцаалтын шатанд хэргийн шийдвэрлэлт удаашрах зэрэг байдлууд гарч байлаа.

Тухайлсан кейсээс үзэхэд холбогдогчийн талын эгч, дүү нар нь мэдүүлгээ өөрчилж өгөхийг шаардах, шан харамж амлах, заналхийлэх, хуурч мэхлэх үйлдлийг байнга гаргаж байсан ноцтой баримтууд илэрсэн. Үүний гол шалтгаан нь хүчирхийлэгч нь хохирогчтой ойрын хамаатан, садан төрөл, танил талын холбоотой, хохирогч ямар нэг байдлаар хүчирхийлэгчийн эрхшээлд байдгаас шууд шалтгаалж байна.

Болзооны хүчингийн гэмт хэргийн хувьд хохирогчийг буруутгах хандлага, хохирогч болзоонд очсоноороо бэлгийн харьцаанд орохыг "зөвшөөрсөн" гэсэн ойлголт цагдаагийн байгууллагын ажилтнуудын дунд байсаар байна.

"Ураг төрлийн хүчин", "***болзооны хүчин***", ***"тохиолдлын буюу гудамжны хүчин"*** хэмээн төрөлжүүлэн сонгон авсан кейсүүдийн талаар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүгч, прокурор нар үзэхдээ: "*Хүчингийн гэмт хэрэг бол хүчингийн гэмт хэрэг. Дээр дурдсанаар хүчиндэх гэмт хэргийг ангилж байгаа нь хууль зүйн ямарваа нэгэн үр дагавар үүсгэхгүй юм. Насанд хүрээгүй хүмүүсийг хүчиндсэн гэмт хэргийн бүрэлдэхүүнийг Эрүүгийн хуульд тусгайлан зааж өгсөн учир "бэлгийн мөлжлөг" гэсэн ойлголтонд хамаарахгүй, харин удаан хугацааны туршид хүчиндэж, бэлгийн хүчирхийлэлд өртүүлж байсан тохиолдолд эрүүгийн эрх зүйн онолын ойлголтоор "үргэлжилсэн үйлдэлтэй хүчиндэх гэмт хэрэг" гэж үздэг. Хууль тогтоогчоос гэмт хэрэг гэж тусгайлан тогтоосон ойлголтыг хуулиас гадуур томъёолж, илэрхийлж болохгүй"* гэж байлаа.

PS: *Гадаадын улс орнуудын эрүүгийн эрх зүй болон, криминологийн салбарын чиг хандлагыг судлан үзэхэд дээрх ойлголтыг төрөлжүүлэн авч үзсэн байна. Үүнийг тодорхой дурдвал* ***"marital rape"*** *буюу* ***"гэрлэлтэн дэх хүчин"*** *хэмээх ойлголтод гэр бүл, хамаатан садны хүрээнд гардаг хүчингийн гэмт хэргийг ялган нэрлэдэг бөгөөд түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага хүртэл ялгамжтай байна. Харин* ***"date rape"*** *хэмээх ойлголтыг мөн тусгайлан ялган төрөлжүүлсэн байх бөгөөд үүнийг* ***"болзооны хүчин"*** *хэмээн дүйцүүлэн ойлгож болох юм. Дээр дурдсан* ***"хүчиндэх"*** *гэмт хэргийг ерөнхийд нь* ***"statutory rape"*** *гэж нэршиж заншжээ.*

Хүчингийн гэмт хэрэгт өртсөн хохирогчид, тэр тусмаа насанд хүрээгүй хохирогч нь сэтгэл зүйн хувьд айдас, цочрол, стресст хүчтэй ордгоос шалтгаалан хүчиндүүлснээ бусдаас нуусан нь хэргийн шийдвэрлэлтэнд нөлөөлж нотлоход хүндрэл, бэрхшээл учруулж байсан. Хэргийг шалгах явцад хохирогч жирэмсэн болсон болон бэлгийн замын халдварт өвчин туссан асуудлыг нотлоход хугацаа алдаж, энэ нь хохирогчийн амь насанд аюултай нөхцөл байдал бий болгох, бие махбодь, сэтгэл санаа, эрүүл мэндийн хувьд дахин хохироход хүргэж байлаа.

Зарим хохирогч нарын анхны мэдүүлэг, тайлбарт *"гомдолтой, хохирол нэхэмжилнэ"* гэсэн байдаг боловч яваандаа "хохиролгүй, нэхэмжлэх зүйлгүй, гомдолгүй, шүүх хуралд суухгүй" гэхчлэн мэдүүлэг өөрчлөгдсөн нь анхаарал татаж байлаа. Энэ бүхний ард хохирогчид бодит аюул занал, далайлган сүрдүүлэг байх магадлал өндөр учир хэрэг буртгэгч, мөрдөн байцаагч нар нь насанд хүрээгүй хүмүүсийн эсрэг үйлдэгдэж байгаа бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл болон түүнтэй адил төстэй гэмт хэргийг шалган шийдвэрлэхдээ дээрх нөхцөл байдлуудыг анхаарч ***"хэвшмэл арга барил"***-аас ангижирч, шинэ туршлагыг нэвтрүүлэх хэлбэрээр ажиллах шаардлагатай байна.

Мөрдөн байцаалтын шатанд хохирогчдоос мэдүүлэг авах тусгай өрөө байхгүйгээс хохирогчийн анхаарал сарних явдал их гарч байсан төдийгүй зарим дүүрэгт хохирогчийг байцаах зориулалтаар тусгайлан тохижуулсан өрөө нь хүүхдийн байцаагч эсхүл өөр албан хаагчийн тасалгаа болон ашиглагдаж байлаа.

Мөрдөн байцаалтын шатанд хэргүүдийг шалган шийдвэрлэж байгаа дундаж хугацаа 5 сар байгаа нь хохирогчийн хувьд урт хугацаа юм.

Эрэгтэй хүүхдийг "эмэлсэн" буюу хүчирхийлсэн кейсийг тухайлан судлахад ***асуудлыг шалгах явцдаа баримтжуулж чадаагүйгээс гэмт этгээдэд ял завшуулжээ.*** Энэ хэргийг "бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах"-аар зүйлчлэн эрүүгийн хэрэг үүсгэж шалгасан боловч хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн байна.

*Sue Titus Reid. J.D., Ph.D, "Crime and Criminology"., 194-196th page., 2000

Хохирогч бие махбодийн гэмтэл авснаас гадна хэт олон хүн энэ тухай мэдсэнээс шалтгаалан сэтгэл санааны давхар хохирол амсчээ.

"Males as Rape"- *"эрийг эмлэх" буюу "эр хүнийг хүчиндэх" гэмт хэрэг гэсэн ойлголт нь гадаадын зарим оронд "хүчиндэх" гэмт хэрэг гэсэн ойлголтод багтдаг. Гэтэл манай улсад* ***"бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах"*** *гэмт хэрэг хэмээн тодорхойлж гаргцхүү эрэгтэй хүн эмэгтэй хүнд хүч хэрэглэн хурьцал үйлдсэн тохиолдолд л хүчиндэх гэмт хэрэг хэмээн үзэж байгаа нь хоцрогдсон хандлага юм.*

Шүүхийн шат

Шүүх хурлын тэмдэглэл, мөрдөн байцаалтын явцад бэхжүүлэн авсан мэдүүлгүүдтэй танилцахад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нарын зүгээс хохирогчийг *"хөнгөн явдалтай"* хэмээн буруутгах хандлагыг гаргасан ба *"Чи өөрөө дуртайдаа очиж хүчиндүүлээд байсан юм биш үү?"* гэж асуусан байдаг. Энэ нь хохирогчийн хуулийн байгууллагад итгэх итгэлийг алдагдуулахад хүргэжээ.

Шүүх хуралдааны үед хохирогч сэтгэл санааны хямралтай байсаар атал хохирогчийг тусгаарлах арга хэмжээ аваагүй, хүчирхийлэгчээс шууд хамааралтай байдлыг анхаарч үзээгүйгээс хохирогч айдаст автах зэргээр сандарч сэтгэл зүйн сөрөг байдлууд гарч байжээ.

Мөн тодорхой кейст бэлгийн мөлжлөгт өртөж сэтгэл санаа, бие махбодийн хувьд хохирол хүлээсэн этгээд ямар нэг дарамт шахалт, өөрийгөө хамгаалах чадваргүй байдлын улмаас өөрөө гэмт хэрэг үйлдсэн байж болохыг[644] анхаарч үзээгүй ял ногдуулсан нь гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн шалтгаан нөхцөлийг бодитой тогтоож, энэхүү нөхцөл байдлыг харгалзаж шийдвэрлэж байх шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүргэв.

Сайн туршлага нь эрүүгийн шүүхээс хохирогчид сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх талаар шийдвэр гаргуулж чадсан явдал байлаа. Бага насны хоёр хохирогчид сэтгэл санааны хохирол хүлээсэн гэж үзэж болох нотлох баримтыг бүрдүүлэн, шүүхэд итгүүлж чадсанаар тус бүр 2 сая төгрөг[645] гаргуулж олгохоор шүүхийн шийтгэх тогтоолоор шийдвэрлүүлжээ.

Тулгарч байсан бэрхшээл, анхаарах асуудлууд:
Нэг. Хуулийг хэрэглэх явцад гарч буй бэрхшээл

Хүүхдийг бэлгийн мөлжлөгт ашигласан үйлдэлд хариуцлага ногдуулах зарим хэм хэмжээ Эрүүгийн хууль, бусад хуульд давхардан зохицуулагдсан нь гэмт этгээдэд ял завших гэмт үйлдлээ дахин давтах боломжийг олгож байна. Үүнд:

1. Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль

"Садар самуун явдалтай тэмцэх тухай" хуулийн 3 дугаар зүйл *3.1.2-т "садар самуун явдал" гэж биеэ үнэлж явалдах,* ***түүнд бусдыг уруу татах, биеэ үнэлэхийг зохион байгуулах, зуучлах,*** *түүнчлэн садар самууныг сурталчлахыг*" гэж тодорхойлсон нь Эрүүгийн хуулийн **123 дугаар зүйл**

[644] Судлагдсан кейст хохирогч өөрөө эмзэг байдлынхаа улмаас хулгайн гэмт хэрэгт холбогдож улмаар шүүхээс хорих ялаар шийтгүүлж, эмэгтэйчүүдийн хорих ангид ял эдлэж байгаа жишээ байна.

[645] 2010 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн СХД-ийн шүүхийн №67 дугаар шийтгэх тогтоол

дэх Садар самууныг сурталчлах, 124 дүгээр зүйл дэх Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийн шинжийг агуулсан боловч эрүүгийн бус захиргааны хариуцлага оногдуулж болохоор байна. Тухайлбал: Насанд хүрээгүй хүний биеийг хүчээр үнэлүүлж, бэлгийн мөлжлөгт өртүүлсэн үйлдлүүд нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй", гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй, нийгэмд аюулгүй үйлдэл[646] биш. Гэтэл цагдаагийн ажилтнууд Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хуулийн дээрх давхардлыг ашиглан "Садар самуунд уруу татах", "Садар самууныг сурталчлах" гэсэн зүйлээр гэмт этгээдүүдэд захиргааны шийтгэл хүлээлгэн ял завшуулж байна.Мөн насанд хүрээгүй хохирогчдыг "биеэ үнэлсэн" хэмээн буруутгаж торгох шийтгэл хүлээлгэсэн байна.

2. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд сум, дүүргийн Засаг даргын шийдвэрээр дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

1/ хүүхдийг сэтгэл санааны болон бие махбодийн дарамтад байлгасан, хавчин шахаж хүч хэрэглэсэн иргэн, албан тушаалтныг 40000-50000 төгрөгөөр торгох буюу 30 хүртэл хоногоор баривчлах;

5/ хүүхдээр гуйлга гуйлгасан иргэн, эрүүл мэндэд нь харшлах ажил хөдөлмөр хийлгэсэн албан тушаалтныг 10000-20000 төгрөгөөр торгох;

6/ өөрийнх нь болон эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлгүйгээр хүүхдийг мэдээлэл, сурталчилгаанд ашигласан, бусад хэлбэрээр хууль бусаар нэрийг нь барьж, ашиг олох эрүүл мэнд, амь насанд нь аюул учруулах тоглоом, наадамд оролцуулах үйл ажиллагаа явуулсан иргэн, албан тушаалтны олсон ашиг, орлогыг хурааж, 30000-60000төгрөгөөр торгох;

Монгол Улсын Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцох үйлдэлд энэ хуулиар хариуцлага хүлээлгэх боломжтой байгаа нь хуулийн давхардал гэж үзэж болохоор байна[647].

Эдгээр заалтууд хариуцлагын үр нөлөөг багасгах, зарим тохиолдолд эрүүгийн хариуцлагаас зайлсхийх, ял завших боломжийг олгож байгаа юм. Нэгэнт Эрүүгийн хуулиар хүлээлгэх хариуцлагын талаар дурдаж байгаа учраас захиргааны хариуцлагын тухай давхардуулан авч үзэх нь илүүц юм.

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийг зөрчсөн этгээдэд захиргааны арга хэмжээ авсан сум, дүүргийн Засаг дарга байхгүй байна.

[646] Монгол Улсын Дээд шүүхийн 2007 оны 45-р тогтоолоос
[647] ХЗҮХ-ийн ЭЭЗКС-оос хийсэн "Эрүүгийн хуулийн хэрэгжилт" судалгааны тайлангаас

3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль

Уг хуулийн 6 дугаар зүйл заасан **бэлгийн хүчирхийлэл** нь энэ хуулиар бус тухайн үйлдлийнхээ обьектив шинжээс хамаарч Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан бие даасан гэмт хэрэг болно. Жишээ нь, Хүүхдийг бэлгийн мөхлөгт оруулж түүнээс ашиг орлого олсон бол **113 дугаар зүйл буюу "Хүн худалдаалах"** болон "**Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх", "Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах", "Хүчиндэх"**гэмт хэргүүдийн аль тохирох зүйл, хэсгээр хариуцлага хүлээлгэх үйлдэл юм.

Сүүлийн үед үйлдэгдэж байгаа "хүчиндэх" гэмт хэрэг нь гэр бүл, ураг төрлийн хүрээнд нуугдмал, ужгирсан шинжтэй байна.

Харин бэлгийн эрх чөлөөтэй нь холбоогүй боловч хүүхдийг ямар нэг байдлаар ашиг олох хэрэгсэл болгосон, хүнд нөхцөлд байлгасан, албадан хөдөлмөр эрхлүүлж ашиг олсон, давуу байдал бий болгосон, өр төлбөрт түр хугацаагаар шилжүүлсэн зэрэг үйлдэл хийсэн, түүний улмаас ямар нэг гэм хор учирсан бол мөн Эрүүгийн хуулийн "**Асран хамгаалах үүргээ урвуулах", " Хүүхдийг албадан болон хүчээр хөдөлмөрлүүлэх"** гэмт хэргийн шинжийг агуулж байдаг.

Дээрх хэлбэрүүд нь гэмт хэргийн шинжийг шууд агуулж байдаг учир "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай" хуулиар бус Эрүүгийн хуулиар тайлбарлаж хариуцлага хүлээлгэдэг байх нь зохимжтой юм.

Эрх зүйн аливаа зөрчлийн хариуцлага туйлын тодорхой байх ёстой. Гэтэл уг хуулийн 19.1.-т *"Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд түүний үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанар, зөрчлийн байдал, учруулсан хохирлын хэмжээг харгалзан хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ"* гэсэн нь иш татсан, хариуцлага тооцсон, алгасуулан иш татсан хэм хэмжээний аль нь болох нь мэдэгдэхгүй хэт "бөөрөнхий" байгаа юм.

Хэдийгээр "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай" хуулийн зарим зүйл заалтыг тайлбарласан УДШ-ийн 2006 оны 10 дугаар сарын 30-ний өдрийн 47 дугаар тогтоол байдаг боловч хариуцлагын талаар тайлбарлаагүй юм. Гэтэл ГБХТХ-ийн 5.1.6-д ***"эрх хязгаарлах арга хэмжээ"*** гэж хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалахад чиглэсэн хүчирхийлэл үйлдэгчид хүлээлгэх албадлага хэмээн заажээ. Практикт энэ арга хэмжээг буруу арга замаар авч байна. Өөрөөр хэлбэл, цагдаагийн байгууллага энэ эрхийг бие дааж хэрэгжүүлдэггүй, зөвхөн шүүхэд хүсэлт гаргах эрхтэй байдаг. Энэ нь бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хүчирхийлэгчээс яаралтай тусгаарлах хойшлуулшгүй арга хэмжээ авах боломжгүй байдалд хүргэж байна. Шүүхэд энэ эрх хязгаарлах хүсэлт гаргаж шийдвэрлүүлтэл ихээхэн хугацаа шаардагддаг, үүнээс болж хохирогч дахин бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэлд орж болох юм.

Хоёр. Практикт тулгарч буй бэрхшээл

Хуулийн байгууллагын ажилтнуудын хохирогчийг буруутган үзэх хандлага: Хохирогч нарын зарим хэсэг нь биеэ үнэлдэг боловч энэ нь гэмт хэрэгт өртөх хамгийн гол эрсдэлт хүчин зүйл болж байсан гэдгийг дурдах

нь зүйтэй. Тухайн тохиолдолд хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүчээр биеийг нь үнэлүүлж, бэлгийн мөлжлөгт ашиглаж байсныг судлаачийн зүгээс олж харахыг хичээлээ. "Хөнгөн явдалтай" хэмээн дурдагдсан, хэрэгсэхгүй болгон шийдвэрлэгдсэн хэргийн хохирогч нарын мэдүүлэг нь судлаачийг "энэ өнцгөөс" харахад хүргэлээ.

Сэтгэл санааны хохирлыг үнэлэх, хэмжих аргачлал байхгүй байна: Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдэд эдийн гэхээсээ илүү эдийн бус гэм хор учирдаг. Өөрөөр хэлбэл, сэтгэл санааны хүчтэй цочролд орох, амиа хорлох, хорлохыг оролдох зэрэг сэтгэл санааны хохирлыг хүлээж байдаг. Сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх практик аргачлал, шүүхийн хэвшүүлэлт байхгүй зэрэг нь хохирогчийг хамгаалахад тулгарч буй хамгийн "хүндрэлтэй" асуудал юм. Үүгээрээ энэ гэмт хэргийн нийгмийн хор уршиг тодорхойлогдож байдаг. Гэтэл сэтгэл санааны хохирлыг тодорхойлох, хэмжих, үнэлэх аргачлал байхгүй байна.

Хохирогч хамгааллын зохицуулалт дутмаг: Төслийн багийн ажилласан хэргүүд дотор хохирогчийн эрсдэл бүхий байдалтай холбоотойгоор үйлдэгдсэн хэргүүд нилээдгүй байлаа. Хохирогчийн "эрсдэл бүхий байдал" гэдэгт хамаатан садны дэмжлэг, туслалцаа байхгүй, танил нөхдийн холбоо найдваргүй, хэт итгэмтгий /найздаа итгэснээс гэмт хэргийн хохирогч болох/, түүнчлэн эцэг эхийн хайр, халамж дутагдах, гэр бүлийн хүчирхийллийн улмаас орон гэрээсээ дайжсан, хараа хяналтгүй, гудамжны тэнэмэл амьдрал зэрэг хохирогчдын "эрсдэл" бүхий шинжүүдийг ороуллаа. Жишээ нь, 2 кейст хохирогч охины биеэ хамгаалах чадваргүй, ар гэрийнх нь эмзэг байдлыг далимдуулан хүчиндэж, улмаар хүчээр биеийг нь үнэлүүлсэн байна.

Дүгнэлт, санал, зөвлөмж

Үйл ажиллагааны хүрээнд өгөх дүгнэлт

- Насанд хүрээгүй хүүхдийг бэлгийн мөлжлөгт өртүүлсэн, хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг агуулсан ноцтой үйлдэлд хохирогчийг өөрийг нь "биеэ үнэлэгч" гэж буруутган, гэм буруутай этгээдийг Захиргааны хариуцлагын тухай хуулиар торгоод өнгөрөөх явдал гарсаар байна.
- "Насанд хүрээгүй хүнийг биеэ үнэлэхэд татан оролцуулах" гэмт хэрэг гэсэн халхавчийн цаана хүүхдийг бусдад худалдах, дамжуулан худалдах гэмт хэрэг нуугдаж байдгийг анхаарах шаардлагатай байна.
- Бэлгийн мөлжлөгт өртсөн хохирогчдын хувьд өөрсдийнх нь аюулгүй байдал алдагдах, нэр төр гутаагдах, буруутгагдах эрсдэлтэй гэж үздэг /хуулийн байгууллагад үл итгэх байдал/ нь тэднийг хуулийн байгууллагад хандахаас татгалзахад хүргэж байна.
- Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны шат дамжлага удаан, хохирогч гомдолтой гэсэн тохиолдолд хохирлоо нөхөн төлүүлж чадах эсэх нь эргэлзээтэй учраас хохирогч хохирлын мөнгө гэж хэдэн төгрөг аваад гомдлоосоо буцахад хүрдэг байна.

- ЭБШХ-ийн 25 дугаар зүйлд зөвхөн хөнгөн гэмт хэргийг хуульд заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгодог бөгөөд бусад төрлийн гэмт хэргийн хувьд хэрэгсэхгүй болгох боломжгүй юм. Гэтэл бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн хэргийг шалгаж, шийдвэрлэх явцад "хохирогчийн ар гэрийнхэнтэй нь эвлэрсэн" гэсэн үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгосон нь хууль зөрчсөн үйлдэл юм.
- Олон Улсын эрх зүйн хэм хэмжээнд 18 насанд хүрээгүй хүнийг "хүүхэд" гэж үздэг[648] бөгөөд хүүхэдтэй бэлгийн харьцаанд орох нь хүч хэрэглэсэн, хэрэглээгүй, хүүхэд зөвшөөрсөн эсэхээс хамаарахгүйгээр гэмт хэрэг мөн. Гэтэл манай Эрүүгийн хуулиар 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орсон тохиолдолд л эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь 16-18 насны хүнтэй хүч хэрэглээгүй... л бол бэлгийн харьцаанд орж болохыг зөвшөөрсөн зохицуулалт болжээ.
- Захиргааны зөрчлийг гэмт хэрэгтэй ижил байдлаар хуульчилж, хэм хэмжээний давхардал үүсгэж байгаа нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд бэрхшээл учруулж байна. Улсын дээд шүүхийн тайлбараас үзэхэд "эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол" гэсэн ойлголтын тайлбар бүрхэг байгаа нь хууль хэрэглэж, хэрэг маргааныг шийдвэрлэхэд сөргөөр нөлөөлж байна.[649]
- Эрүүгийн байцаан шийтгэх хуульд "Насанд хүрээгүй гэрч, хохирогчийг байцаах" талаар тусгайлсан бүлэг одоогоор байхгүй,зөвхөн насанд хүрээгүй гэрч хохирогчийн мэдүүлгийг шүүх ажиллагааны үед сонсох талаар л заажээ[650].Харин 145 дугаар зүйлд заасан Насанд хүрээгүй гэрчийг байцаах зохицуулалт нь "хохирогч хамгаалал"-ын үйл ажиллагаатай төдийлэн хамааралтай биш байна.
- Мөрдөн байцаалт, шүүхийн шатанд хохирогчийг хөндлөнгийн нөлөөллөөс хамгаалах хуулийн арга хэрэгсэл байхгүй, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нарын ажил дүгнэх үзүүлэлтэд нь ордоггүй учир тэд ийм асуудалд "*хуулиар хүлээсэн үүрэгт ажил биш*" гэж хүнийрхсэн байдлаар хандаж байна.

Санал, зөвлөмж

- Насанд хүрээгүй хүний хувьд "биеэ үнэлэлт" гэсэн ойлголт байх боломжгүй. Энэ нь бэлгийн хүчирхийллийн үр дагавар учир ийм тохиолдол бүрийг нарийвчлан судалж үзсэний үндсэн дээр шалтгаан, нөхцлийг тогтоож, цаана нь байгаа гэмт этгээдүүдэд эрүүгийн хариуцлага заавал тооцож байхын тулд хуульчдын дунд тогтсон насанд хүрээгүй хүний биеэ үнэлэлтийг "хүлээн зөвшөөрөх" хандлагыг өөрчлөх сургалтуудыг явуулах;
- Цаашид "хүчиндэх" гэмт хэргийн ойлголтыг өргөжүүлж, төрөлжүүлэх;
- Гэмт хэргийн хохирогчид учирсан сэтгэл санааны хохирлыг хэмжих, тооцох, нөхөн төлүүлэх аргачлал боловсруулж, мөрдүүлэх;

[648] Монгол Улсын нэгдэн орсон Хүүхдийн эрхийн конвенцид
[649] ХЗҮХ., "Эрүүгийн болон Захиргааны хариуцлагын тухай хуулийн хэрэгжилт" судалгааны тайлан. 2007 он
[650] ЭБШ хуулийн 269 дүгээр зүйл

- Эрүүгийн хууль, Садар самуун явдлыг хориглох тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиудын давхардлыг арилгах;
- Монгол Улсын Эрүүгийн хуулийн 122 дугаар зүйл /16 насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх/ -ийг нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэн "Насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх" болгон өөрчлөх;
- Тодорхой судалгаа, шинжилгээний үндсэн дээр насанд хүрээгүй гэрч, хохирогчийг байцаах тухай тусгайлсан бүлэг Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмж оруулах;
- Хохирогч, гэрчийн аюулгүй байдлын хамгааллын асуудлыг ЭБШ хуульд тусгаж өгөх. Хохирогч, гэрчийг хамгаалах нь ЭБШ ажиллагааг хэрэгжүүлэгч /хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор шүүгч/-дийн үүрэг байхаар хуульчилж өгөх;
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан **"уулзахыг түр хугацаагаар хязгаарлах"** арга хэмжээг цагдаагийн байгууллага Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад бие даан хэрэгжүүлдэг байх зохицуулалт бий болгох.

Бэлгийн мөлжлөг, хүчирхийллийн гэмт хэргийн нотлогдвол зохих байдлууд,түүний хэмжээ хязгаар

Гэмт хэрэг бүрийн онцлогоос шалтгаалан хэрэг тус бүрийн нотлогдвол зохих байдлуудын бүрэн жагсаалтыг хуульчлах боломжгүй, өөрөөр хэлбэл нотолгооны зүйлийг хуульд тодорхойлж болдог бол хэмжээ хязгаарыг тогтоож болдоггүй.

*Гэмт хэргийн **нотолгооны хязгаар** гэдэг нь гэмт хэргийн нотолгоо явагдах цар хүрээг илэрхийлдэг бол **нотолгооны хэмжээ** гэдэг нь тухайн асуудлыг хангалттай нотлохын тулд хэдий хэрийн баримт сэлт, мэдээлэл цуглуулбал зохих ёстойг илэрхийлж байгаа үзүүлэлт юм.*

Өмгөөлөгч нь эрүүгийн хэрэгт оролцох явцдаа нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх ажиллагаанд идэвхтэй хэлбэрээр оролцож болох хэд хэдэн арга байдаг. Энэ нь **"хуулиар хориглоогүй бусад арга"** гэсэн ойлголтонд ордог бөгөөд хүний нэр төр, алдар хүндэд харшилсан хууль бусаар олж авсан шинжгүй байх ёстой гэдгийг онцгой анхаарвал зохино. Үүнд:

1. Цагдаагийн байгууллагад хандахаас өмнө хохирогч өөрөө үйлчилгээ үзүүлэгч байгууллагад хүргэгдэж ирсэн үед анхны мэдээлэл, бодит нөхцөл байдлыг нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нарын оролцоотойгоор бэхжүүлж авах. Ингэхдээ дүрс бичлэгийн болон гэрэл зургийн аппарат ашиглаж болно. Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын гол алдаа бол ***"анхны үйлчилгээ үзүүлсэн баримт нотлох баримт болохгүй байх"*** гэсэн хандлагаар баримтжуулалтыг дутуу хийдэг явдал юм.

Өмгөөлөгчөөс хэргийн талаар өргөдөл гомдол гарган шийдвэрлүүлэх явцдаа дээрх баримтыг нотлох баримын хэмжээнд цуглуулах, бэхжүүлэх тухай хүсэлт гарган шийдвэрлүүлж хэвших хэрэгтэй[651]. Энэ нь байцаан шийтгэх ажиллагааны журамд харшлахгүй бөгөөд бэхжүүлж авахдаа өөрсдөө тэмдэглэл үйлдэх, эсвэл хураан авах замаар нотлох баримтын хэмжээнд бэхжүүлж болно[652]

2. Тодорхойлолт авах: Өмгөөллийн тухай хуульд[653] зааснаар өмгөөлөгч бусад байгууллагаас тодорхойлолт гаргуулан авах эрхтэй байдаг. Энэхүү гаргасан тодорхойлолт хэрэг шийдвэрлэхэд ач холбогдолтой гэж үзэж байвал хэрэгт хавсаргах, бэхжүүлж авах тухай хүсэлтийг мөн л бичгээр гаргаж хэвших хэрэгтэй бөгөөд энэ нь нотлох баримтын ач холбогдлыг нэмэгдүүлдэг. Тухайлбал,хохирогч мэс засал хийлгэсэн, сэтгэл заслын үйлчилгээ авсан эсвэл хүчиндүүлснээс шалтгаалан жирэмсэлж, ураг хөндүүлэх г.м амь насанд аюултай эмчилгээ хийлгэсэн үед өвчтөний түүхийн хуулбарыг гаргуулан авах, эмнэлгээс нь өвчний шинж тэмдэг, бусад байдлын талаар тодорхойлолтыг гаргуулан авч мөрдөн байцаагчаар тэмдэглэл үйлдүүлэн хэрэгт хавсаргах гэх мэт хэлбэртэй байж болно.

3. Гэрч, мэргэжилтний хувиар сэтгэл зүйч, нийгмийн ажилтныг байцаан шийтгэх ажиллагаанд оролцуулах: Хүүхдэд үйлчилгээ үзүүлсэн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нь мөрдөн байцаагчид хүүхдэд учирсан тодорхой бэрхшээлийг тодруулах, хэрэгт ач холбогдол бүхий баримтыг бэхжүүлэхэд туслалцаа үзүүлэх нь хэргийн шийдвэрлэлтэнд шууд нөлөөлдөг. Нэн ялангуяа кейс шийдвэрлэлтийн явцад ийм байдлаар байцаан шийтгэх ажиллагаанд оролцож байгаа явдал нь ихээхэн үр дүнтэй нь мэдрэгдэж байсан юм.

Нотлох баримтыг цуглуулах үед анхаарах асуудлууд:

Өмгөөлөгч нь ЭБШХ-д зааснаар нотлох баримтыг цуглуулах эрх бүхий этгээд биш тул үүрэгт ажлаа гүйцэтгэх явцад олж мэдсэн мэдээлэл, баримт сэлтээ цагдаагийн байгууллагад гарган өгч байгаа тэр хэлбэрээр хандах нь үр дүнтэй. Доорх зүйлсийг анхаарах шаардлагатай:

- Болсон үйл баримт, фактыг үнэн зөв, бүрэн тодорхой тусгах;
- Нотлох баримт болохуйц зүйлсийг үрэгдэх, гэмтэх, солигдох, урагдах гэмтэх зэрэг байдал гаргуулахгүйн тулд гэрэл зургаар бэхжүүлэх, лацдах, шинж тэмдэг, онцлог зүйлийг тэмдэглэж авах, хувилж авч болох бол хувилж авах гэх мэт дараа нь гомдол, хүсэлт гарган шийдвэрлүүлэх баримттай байх;

---

[651] Өмгөөллийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.4-т "өмгөөлөгч нь "нотлох баримт гаргаж өгөх, шинэ нотлох баримт шаардах бүюу хэрэгт ач холбогдол бүхий бусад байдлыг шалгуулах, шинжээчийн дүгнэлт гаргуулах санал хүсэлт тавих эрхтэй" гэжээ.

[652] Мөрдөн байцаагч нартай хийсэн ярилцлагын дүн, 2010 он

[653] Өмгөөллийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т Өмгөөлөгч мэргэжлийн үүргээ биелүүлэхэд зайлшгүй шаардлагатай баримт бичиг, мэдээ сэлтийг гаргуулан авахын тулд шүүх, прокурор, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллага, бусад байгууллага, түүний холбогдох албан тушаалтанд хүсэлт гаргах эрхтэй.

- Хэрэгт цаашид ач холбогдолтой баримт сэлт, мэдээллийг шалгах бололцоог бий болгох шаардлагуудыг баримталвал зохино. Ингэхдээ нотлох чадвараа алдаж болзошгүй нөхцөл байдлын талаар анхаарах хэрэгтэй.
- Хувийн нууцлалыг хамгаалах: Төслийн багийн гишүүдээс хэргийг шийдвэрлэх явцад гарч байсан хүндрэл бэрхшээлтэй асуудал тухайн хохирогчийн хувийн нууцлал бүхий баримтыг задруулах явдал байлаа. Нэн ялангуяа байцаан шийтгэх ажиллагаанд гэрч, сэжигтний хувиар байцаагдаж байгаа этгээд хохирогчийн "***хувийн нууцлалыг задруулна"*** хэмээн айлгаж сүрдүүлсэн баримт нэг бус удаа гарч байсан бөгөөд эдгээр тохиолдол тухай бүрт нь үр дүнтэй арга хэмжээ авч хэвшүүлэх хэрэгтэй байна. Тухайлбал, гэмт хэргийн хохирогч хувийн нууцлалтай холбоотой асуудал нь мөрдөн байцаалтын нэг хэсэгт хамаардаг учир "байцаан шийтгэх ажиллагааны журам зөрчсөн" хэмээн тухайн мөрдөн байцаах албаны дарга болон шүүгчид хүсэлт гарган шийдвэрлүүлж болно.[654]

Эдгээр дурдсан зүйлүүд нь хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүд юм

Хэдийгээр Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээг зааж өгсөн боловч үүнд эрх зүйн тусламж, үйлчилгээг мөн оруулах нь зүйтэй болов уу.

Практик зөвлөмжүүд:

Судлагдсан кейсүүдээс үзэхэд энэ төрлийн гэмт хэргийг өмгөөлөх ажиллагааны явцад анхаарах шаардлагатай зүйлс нилээдгүй ажиглагдаж байсан ба энэхүү үйл ажиллагааны оновчтой загварыг гаргаж ирэх шаардлагатай байгаа нь тулгамдсан асуудал гэж үзэв.

Хүсэлт гаргах: Өмгөөллийн тухай хууль болон ЭБШХ-иар өмгөөлөгчид олгосон ашиглаж болох үйл ажиллагааны эрх зүйн хэлбэр, боломж нь хүсэлт гаргах эрх юм. Хүсэлт гаргах эрх нь өөрийн үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах , гэмт хэрэг үйлдэгдсэн, нөхцөл байдал, шалтгаан, түүний улмаас учирсан хохирлыг бодитой тогтоох талаар байж болно.

Гэмт этгээдээс сэтгэл санааны хохирол нэхэмжлэн гаргуулах: Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад өмгөөлөгчийн гаргаж болох эрх зүйн ач холбогдол бүхий баримт бичиг нь "хүсэлт" юм. Мөн эрүүгийн хэрэг дэх иргэний нэхэмжлэл байж болно. ЭБШХ-ийн 41 дүгээр зүйд өмгөөлөгчийн эрх үүргийг заасан бөгөөд шаардлагатай нотлох баримтыг цуглуулах талаар хүсэлт гаргаж болдог.

Сэтгэцийн гэм судлаач-шинжээчээр хохирогчийн сэтгэл санааны хохирлын эргийг тогтоолгож, түүнийг эмчлэх хугацааны гарах зардлыг тооцон нотлох баримтын хэмжээнд бүрдүүлж иргэний нэхэмжлэлд хавсаргах боломжтой юм.

[654] Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 77, 78 дугаар зүйлд байцаан шийтгэх ажиллагааны журам зөрчсөн тохиолдолд торгууль ногдуулж болох эрх зүйн үндэслэлийг дурдсан бөгөөд энэ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1-4 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр торгохоор заасан эдийн засгийн нилээдгүй

Нөгөө талаас гэм буруутай этгээдээс иргэний журмаар гаргуулах мөнгөний хамгийн доод хэмжээг амьжиргааны баталгаажих доод түвшингийн хэмжээтэй холбоотой авч үзэж болох юм. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдэгдсэнээс эхлэн эцэслэн шийдвэрлэгдэх хүртэлх хугацааг тухайн орон нутагт тогтоосон амьжиргааны баталгаажих түвшингийн мөнгөн хэлбэрт дүйцүүлэн /шилжүүлэн/ нэхэмжилнэ гэсэн үг юм. Учир нь амьжиргааны баталгаажих түвшин нь тухайн хүн ажил эрхэлдэггүй, орлогогүй байсан ч амьдрахын тулд зайлшгүй шаардагдах зүйлийн мөнгөн илэрхийлэл юм.

Насанд хүрээгүй хохирогчийг байцаах, эрүүгийн байцаан шийтгэх тодорхой ажиллагаанд оролцуулахад бичлэг хийлгэх, түүнчлэн тухайн хэрэгт хяналт тавьж байгаа прокурорыг байлцуулах нь ихээхэн үр дүнтэй юм. Ингэснээр хэргийн шийдвэрлэлтэд шууд нөлөөлдөг сайн талтай.

Хүүхдийн бэлгийн мөлжлөгтэй холбоотой хэргүүдийн гаралт, шийдвэрлэлтийн байдлаас шалтгаалан ТББ-ууд сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, өмгөөлөгчдийн жагсаалтыг гаргаж цагдаагийн байгууллагад хүргүүлбэл гэмт хэрэг илрүүлэх, хойшлуулшгүй ажиллагааг хамтран явуулах боломжтой.

ТТБ-д ажиллаж буй, хуульч өмгөөлөгчид нь нийгмийн ажилтан, сэтгэл зүйчидтэй хамтран ажиллах: Энэ төрлийн гэмт хэрэг нь ихэвчлэн шөнийн цагаар үйлдэгддэг учраас цагдаагийн байгууллага дээр сурган хүмүүжүүлэгч олддоггүй байна. Энэ нь ЭБША-ны явцад хохирогчийн анхны мэдүүлгийн үр нөлөөг бууруулах, улмаар нотолгооны шинж чанараа алдахад хүрдэг.

Мөн төрийн бус байгууллагууд нь эрх ашгийг хамгаалж буй хохирогчдоо байцаан шийтгэх ажиллагааны явцад мэдүүлэг өгүүлэхдээ цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах үндсэн дээр мөрдөн байцаагчийг хохирогч байгаа газар /боломжтой тохиолдолд энгийн хувцастай/ хүрэлцэн ирүүлж ажиллагаа явуулах, өөрсдөө байлцах тал дээр санаачлагатай ажиллах хэрэгтэй байна. Энэ нь нотлох баримтыг шүүх үнэлэхэд өндөр ач холбогдолтой байхыг үгүйсгэхгүй.

___oOo___

* Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч шинжилгээ хийлгэх тогтоолдоо энэ тухай асуулт оруулбал тодорхой хэмжээнд сэтгэл санааны хохирлын зэргийг тогтоох боломжтой байдаг. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хуулийн тасгийн эрхлэгч Д.Лянхуатай хийсэн ярилцлага.

ХЗҮХ., 2009 он

"ӨРШӨӨЛ ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ҮР НӨЛӨӨ"[655]

Оршил

Энэхүү судалгаа нь төрийн эрх барих дээд байгууллагын гаргасан өршөөл үзүүлэх тухай шийдвэрийн биелэлтийг хангах ажиллагааг зохион байгуулахад Засгийн газар, шүүх болон шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцдог бусад байгууллага ямар үүрэг, оролцоотой байх, энэ талаар гадаадын зарим улсын эрх зүйн зохицуулалтыг жишиг болгон судалж, үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгоход ач холбогдол бүхий санал, үзэл баримтлалын төсөл боловсруулах зорилготой байв.

Судалгааны ажлыг гүйцэтгэхдээ юуны өмнө судалж буй асуудлынхаа агуулга, мөн чанарыг төр, эрх зүйн үзэгдлийн түүхийн үүднээс зөв ойлгож, Монгол Улсын эдүгээ цаг үеийн хэрэгцээ шаардлага юунд байгааг тодорхойлох нь чухал гэж үзсэн болно.

Иймд энэхүү тайланд "өршөөл үзүүлэх" тухай ойлголт, мөн чанар, энэ талаар эрт, эдүгээгийн судлаачдын үзэл бодол, түүнчлэн монголын төрөөс гаргасан өршөөл үзүүлэх тухай хууль тогтоомжийн талаар товч дүгнэлт хийв.

I. "Өршөөл үзүүлэх" тухай ойлголт, түүний мөн чанар, эрх зүйн зохицуулалт, түүхэн уламжлал

а/ Өршөөл үзүүлэх тухай ойлголт, мөн чанар

Монгол Улсын Үндсэн хууль болон өөр хэд хэдэн хуульд "өршөөл үзүүлэх" тухай дурдсан ч уул ойлголтын хууль зүйн тодорхойлолт аль ч хуульд нь байхгүй юм. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 77 дугаар зүйлийн 77.1-ийн "Өршөөл үзүүлэх тухай Монгол Улсын хуулиар гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас, ялтанг ял эдлэхээс чөлөөлж болно" гэсэн заалт өршөөлийг хуулиар үзүүлэх ба энэ шийдвэр нь хэн нэгнийг эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлөх үр дагавартай гэсэн ерөнхий ойлголт өгөхөөр байна.

Монгол хэлний болон гадаад хэл дээрх тайлбар тольд "өршөөл, өршөөл үзүүлэх"-ийг ***amnestia***-өршөөж уучлах, мартах гэсэн утгатай грек үгнээс гаралтай гэж тайлбарлажээ.

"Эрх зүйн эх толь бичиг"-т "өршөөл үзүүлэх"-ийг "гэмт хэрэг үйлдсэн тодорхой бус этгээдүүдийг эрүүгийн хариуцлага буюу ялаас бүрэн буюу хэсэгчилэн чөлөөлөх, эсхүл ялын хугацааг багасгах, өөр хөнгөн ялаар солих, эсхүл ял шийтгэгдээгүйд тооцох журам" гэж тодорхойлжээ.

Монголын эрүүгийн эрх зүйн эрдэмтэд бүтээлдээ "өршөөл үзүүлэх" тухай ойлголтыг "***гэмт хэрэг үйлдээд ял эдэлж байгаа ялтнуud, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн үйлдсэн гэмт хэргийн хууль зүйн***

[655] Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрүүгийн эрх зүй, криминологийн секторт Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамны даалгасан "Өршөөл үзүүлэх тухай хуулийг биелүүлэх журмын тухай" сэдэвт судалгааны ажлыг баталсан удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэв.

үр дагаврыг хүчингүй болгох нөхцөл, журмыг заасан Улсын Их Хурлаас гаргах замаар хэрэгжүүлдэг онцгой ажиллагаа" гэж хууль зүйн үүднээс шинжлэх ухааны тайлбар хийжээ.

Гадаад улсын хууль тогтоомжид хэрэглэсэн "clemency", "pardon", "parole", "mercy" зэрэг нэр томъёо нь гэмт этгээдийг хариуцлагаас, ялтныг ялаас чөлөөлөх гэсэн утгыг ерөнхийд нь агуулсан байна. Тухайлбал, хууль зүйн тайлбар тольд:

- "Amnesty" : Өршөөл үзүүлэх ерөнхий хууль
- "Pardon": ял шийтгэлийг хөнгөрүүлэх, гэмт хэрэг дахин үйлдвэл шийтгэлийг буцаан эдлүүлэх...[656].
- "Parole": хорих ял шийтгүүлсэн этгээдийг ялын хугацаа дуусахаас өмнө болзол нөхцөлтэйгээр шоронгоос суллах
- "Executive clemency": Ерөнхийлөгч /зарим улсад Засгийн газрын тэргүүн/-ийн хорих ялын хугацааг багасгах зэргээр шийтгүүлсэн этгээдийн ялыг хөнгөрүүлэх эрх[657] гэж тайлбарлажээ.

"Өршөөл үзүүлэх" тухай ойлголтын үндсэн шинжүүд

Судлаачид "өршөөл үзүүлэх" нь дараах үндсэн шинжийг агуулдаг гэжээ:

- өршөөл үзүүлэх тухай шийдвэр зөвхөн төрийн эрх барих дээд байгууллагын онцгой бүрэн эрхийн асуудал;
- өршөөл нь эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг өөрчлөх, хүчингүй болгох үр дагаваргүй, харин тодорхой хугацаанд эрүүгийн хуультай нэгэн зэрэг, хамт үйлчилнэ;
- өршөөлийн хамрах хүрээ, хязгаар, болзлыг маш тодорхой зааж өгсөн байдаг;
- өршөөл үзүүлэх тухай хуульд эрүүгийн хариуцлага, эдлэзгүй үлдсэн ялаас чөлөөлөх, хасах, хөнгөн ялаар солих үндэслэл / хэм хэмжээ/-ийг заасан байдаг гэж бичжээ.

б/ Өршөөл үзүүлэх институцийн эрх зүйн зохицуулалт

Өршөөл үзүүлэх тухай эрх зүйн зохицуулалт 1924 оны анхдугаар Үндсэн хуулиас эхтэй бөгөөд дараа дараагийн Үндсэн хуулиудад тусгалаа олсон байдаг. Ингэхдээ БНМАУ-ын 1924, 1940 оны Үндсэн хууль зааснаар өршөөл, уучлалын асуудал Улсын Бага Хурлын эрх хэмжээнд байсан ба БНМАУ-ын 1960 оны Үндсэн хуулиар Ардын Их Хурал өршөөл үзүүлэх, Ардын Их Хурлын чуулганы бус цагаар АИХ-ын Тэргүүлэгчид уучлал үзүүлж байхаар зохицуулалт хийжээ.

1990 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар "БНМАУ-ын Үндсэн хуулийн Нэмэлтийн тухай хууль"-ийг баталж, өршөөл үзүүлэх явдлыг Улсын Бага Хурлын бүрэн эрхийг эрхэд хамааруулсан бол 1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлд "Өршөөл үзүүлэх тухай хуулийг батлах онцгой бүрэн эрх зөвхөн Монгол Улсын Их хуралд хадгалагдана" гэж заажээ.

---

[656] Bryan A.Garner editor, Handbook of "Basic law Terms", west group. St.Paul, Minnesto 1999, Black's law dictionary series, str 154

[657] Bryan A.Garner editor, Handbook of "Basic law Terms", west group. St.Paul, Minnesto 1999, Black's law dictionary series, str 36

Монголын анхны төрөлжсөн Эрүүгийн хууль болох 1926 онд баталсан БНМАУ-ын Шүүх цаазын бичгийн 40 дүгээр зүйлд "... Аливаа ялыг нэг мөсөн өршөөн хэлтрүүлэх буюу хөнгөтгөх эрхийг Улсын бага хурлын тэргүүлэгчид эдэлнэ..." гэж заасан нь бий. Мөн 1929, 1934 оны БНМАУ-ын Шүүх цаазын бичгүүдэд ийм утга бүхий заалт хуульчлагджээ.

1942 оны БНМАУ-ын Эрүүгийн хуулийн 49 дүгээр зүйлд "... Шүүн таслах газраас тогтоосон ялыг бүрмөсөн буюу заримыг өршөөн хэлтрүүлэх эрхийг Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн газар хадгална..." гэж заасан бол 1961 оны БНМАУ-ын Эрүүгийн хуульд өршөөл, уучлал үзүүлэх талаар өмнөх хуульд байсан хэм хэмжээ огт хуульчлагдаагүй үлдсэн нь анхаарал татдаг. Харин өршөөл үзүүлэх тухайлсан шийдвэрүүд нь Ардын засгийн газрын тогтоол, БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлиг, Монгол Улсын хууль зэрэг хэлбэрээр гарч байжээ.

Өршөөл үзүүлэхтэй холбогдсон зарим хэм хэмжээ Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд бий.

"Өршөөл үзүүлэх" талаар эрт, эдүгээгийн эрдэмтэн судлаачдын эсрэг байр суурь

Эрт үеийн эрдэмтэн мэргэд хэрэгтнийг өршөөх, уучлах асуудлыг тэр бүр сайшаан дэмждэггүй байсныг бүтээл туурвилаас нь үзэж болохоор байна. Тухайлбал: Ч.Беккари "Хууль төгс бол ял нь зөөлөн бөгөөд гарцаагүй байх ба шүүх нь шударга бол өршөөл үзүүлэх тухай асуудал огт яригдах ёсгүй гэзд харин харгис хатуу Эрүүгийн хууль, түүнээс үүдэн гарах шийдвэрээс өршөөл үзүүлэх тухай асуудал зүй ёсоор гарна,... өршөөх нь гэмт хэрэг үйлдсэний улмаас үүсэх эрх зүйн зайлшгүй үр дагавар биш, иймд гэмт хэрэг үйлдсэн ч ял шийтгэлгүй гэсэн хий хуурмаг сэтгэгдэл төрүүлдэг муу уршигтай" гэж үздэг байжээ.

Бентам "Хэрэв эрүүгийн хууль харгис хатуу бол өршөөл уучлал түүний зайлшгүй нэмэлт болдог, гэвч энэ нь хор уршиг ихээхэн авчирдаг, харин сайн хуультай бол түүнийг устгах ид шидийн саваа хэрэггүй" гэж бичсэн байна.

Өнөө үед хуульчид, эрдэмтэн-судлаачдын дунд өршөөл үзүүлснээр шударга ёсны зарчим гажуудаж, төрийн эрүүгийн цээрлүүлэх бодлого алдагдана гэж үздэг ба өршөөл үзүүлэх шийдвэрийг дийлэнх тохиолдолд нийт ард түмний хүсэл зоригоос үл хамааран гаргадаг учраас төрийн хүсэн хүлээсэн үр дүнд тэр бүр хүрдэггүй гэж үздэг хүмүүс цөөнгүй байна.

Өршөөл үзүүлэхийг дэмжигчдийн дунд ч шийдвэр гаргахын өмнө түүний сөрөг үр дагаврыг тооцох, өршөөлд хамарсан хүмүүс, ялангуяа хорих газраас суллагдсан хүмүүсийн нийгмийн амьдралд эргэн ороход нь яаж туслах зэрэг олон асуудлыг урьдчилан анхаарахыг сануулж буй судлаач олон байна.

в/ Өршөөл, уучлал үзүүлж байсан түүхэн уламжлалын талаар

Эрх зүйн аливаа үзэгдлийн түүхэн уламжлалыг судлахгүйгээр, түүний үүсч хөгжиж ирсэн байдалд шинжлэх ухааны үндэстэй үнэлэлт дүгнэлт өгөх, уг үзэгдлийн зүй тогтол мөн чанарыг зөв танин мэдэх,

түүний цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, улмаар эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох боломжгүй юм.

Гадаад улсад болон Монголд өршөөл үзүүлж байсан туухэн уламжлал

Египетээс олдсон манай эриний өмнөх XX зуунд хамаарах дал модны цаасан дээрх бичигт Синух гэгч египет эр цэргээс оргоод Сири улсад удтал хоргодсон ба эх нутагтаа ирэх хүсэлт гаргахад фараон Сенусерта I түүний хүсэлтийг ёсоор болгож, хүнд ялаас өршөөн хэлтрүүлсэн тухай тэмдэглэжээ[658]. Түүнчлэн манай эриний өмнөх XVIII зуунд Вавилонд Хаммурали хааны үед алах ял шийтгүүлсэн ялтанг өршөөн хэтрүүлж байсан тухай тэмдэглэсэн нь бий. Өршөөж, уучилж байсан дээрхийн адил жишээг эртний Грек, Ромын болон дундад зууны Европын орнуудын түүхээс олныг олж үзэх боломжтой.

Төрийн бүх эрх мэдэл нэг хүний гарт буюу хааны мэдэлд байсан эрт дээр үед өршөөл, уучлал нь "өршөөн хэлтрүүлэх" гэсэн ерөнхий ойлголтоор тодорхойлогдож байсан ба гэмт хэрэг үйлдсэн хүний амь насыг өршөөн хэлтрүүлэх буюу цаазаар авах ялаас болон бусад төрлийн ялаас өршөөн хэлтрүүлэх явдлаар илэрч байв. Энэ жишиг уламжлалын дагуу одоо ч гэсэн өршөөл, уучлал үзүүлэх эрх хуульд заасан дээд эрх гэж тодорхойлогдсоор байна[659]. нийлүүлсэн өршөөх туйлын таалалд нийлүүлбээс зохимой"[660] гэжээ.

Хаан гэм үйлдэвч уучлан хэлтрүүлж, ял шийтгүүлсэн ялтанг зарим төрлийн ялаас өршөөн хэлтрүүлж байсныг эртний хууль цааз, түүхэн эх сурвалж бичиг болох "Монголын нууц товчоо", "Их засаг", "Юан гүрний нэвтэрхий цааз" зэрэгт тэмдэглэн үлдээжээ.

Монголчууд манжийн дарлалаас чөлөөлөгдөж, тусгаар тогтнолоо зарлан тунхагласныг тохиолдуулан Монгол Улсын эзэн хаан Богд гэгээн 1911 оны 12 дугаар сарын 29-нд өршөөл үзүүлэх тухай зарлиг буулгажээ. Уул зарлигт " ... Аливаа элдэв ялтанг цөм хэлтрүүл, хэрэв нэхэл хая. Онц их хүнд буй нь агаад насан идэр болбоос цэргийн албанд оруулж зүтгүүл, насан буурай нь биеийн чадах албанд. Үүнээс дээш аливаа засаг ноёд цөм энд ирж хишигт мөргөвөөс зохимой[661]" гэжээ. ***Энэхүү зарлиг ёсоор гэмт хэрэг үйлдэж хоригдсон болон бусад ял эдэлж буй хүмүүс, түүнчлэн хэрэгт мөрдөгдөж буй бүх хүмүүсийг ял, эрүүгийн хариуцлагаас өршөөн хэлтрүүлсэн байна.***

Зарлигийг биелүүлэх ажлыг Шүүх яам хариуцан зохион байгуулж, дөрвөн аймгийн чуулганы дарга туслагч жанжин, хүрээний Эрдэнэ шанздов нар, Хөвсгөл нуурын Урианхайг бүгд захирах гүн Хишигжаргал, зүүн, баруун харуулыг бүгд захирах гүн, Хиагт замын өртөөг захирах туслагч Өлзийхутаг

---

[658] А.Я.Гршико. Амнистия и помилование. Рязань. 2006, стр 60

[659] Steven H.Gifis "legal terms" third edition, 1998, printed in Canada,ISBN0-7641-0286, Pardon гэсэн үгний тайлбараас дэлгэрүүлж харна уу.

[660] ~~Сан хөмрөг~~ Х-А-7, Д-1, ХН-100

[661] Сан хөмрөг Х-А-6, Д-1, ХН-511 "Богд Эзэн эрдэнийн сууринд залраад буулгасан хишиг тараах зарлигт тохиолдсон ялт ардын олох ялыг цөм хэтрүүлэн тавих зэрэг явдлыг дагаж шийтгүүлэхээр дөрвөн аймгийн даа жанжин, эрдэнэ шанздувын зэрэг 9 газар зарлиг тушаалаар, 4 яамнаа мэдэгдсэн явуулсан хэрэг"

нарт албан бичиг илгээжээ. Уул бичигт "... манай яамны харьяат гянданд хориулсан ялт ардын дотроос ялыг хэлтрүүлэн тавьсан ба харьяат газар тушааж гүйцэтгэн шийтгүүлэх хулгай нарын нэр аймаг, хошуу, шавь шиг халдсан хэргийн учир ялган салгаж бичгийн хойно жагсааж үүний хуваан тушаан явуулаад уг айлтгасан хэрэг буулгасан зарлигийг хичээнгүйлэн дагаж шийтгүүлсүгэй. Жич: манай газраас учир бүрдээгүйд тушааж түр хүлээлгэсэн ба өөр өөрийн харьяат газарт шийтгэн дуусан ба дуусаагүй хэргүүд буй аваас түүгээр нэн даруй гүйцэтгэн дуусгаж, Богд эзэний нигүүлсэн өршөөх туйлын таалалд нийлүүлбээс зохимой"[662] гэжээ.

1987 оны 10-р сарын 10-ны БНМАУ-ын Их Хурлын Тэргүүлэгчдийн баталсан "Аугаа их Октябрын хувьсгалын 70 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай зарлиг энэхүү зарлиг нь 1987 оны 11-р сарын 6-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно"[663] гэж заасан байдаг. Үүнээс гадна өршөөлийн хуулинд хэдний өдрийн хэдэн цагаас өмнө гэмт хэрэг үйлдсэн хүмүүс хамрагдахыг тодорхой заасан байдаг ба энэ тухай "Монголын Тулгар Төрийг Үүсгэн байгуулсны 790 жилийн ойг тохиолдуулан насанд хүрээгүй этгээд, эмэгтэйчүүд, жар түүнээс дээш насны эрэгтэйчүүдэд өршөөл үзүүлэх тухай хуулийн 7-р зүйлд энэ хууль 1996 оны 8-р сарын 22-ны өдрийн 13,00 цагаас өмнө гэмт хэрэг үйлдсэн хүмүүст хамаарна"[664] гэж заасан байна.

II. "Өршөөл үзүүлэх" талаарх Монгол Улсын хууль тогтоомжийн тойм

Бүрэн бус судалгаагаар 1931-2010 оны хооронд өршөөл үзүүлэх тухай шийдвэр /тогтоол, зарлиг, хууль / 12 удаа гарчээ. Үүнд:

- 1931 оны 7 сарын 4-нд "Өршөөл үзүүлэх тухай" Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол
- 1941 оны 6 сарын 20-нд "Үндэсний хувьсгал ба ардын хувьсгалт цэргийн 20 жилийн ойн баярыг тохиолдуулан ялтан хэрэгтэн нарт өршөөл үзүүлэх тухай" [665] Улсын Бага Хурлын тогтоол
- 1961 оны 7 сарын 8-нд "Ардын хувьсгалын 40 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай АИХ-ын Тэргүүлэгчдийн зарлиг[666]
- 1974 онд "БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай АИХ-ын Тэргүүлэгчдийн зарлиг[667]
- 1979 онд "Олон улсын хүүхдийн жилийг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай АИХ-ын Тэргүүлэгчдийн зарлиг[668]

[662] Сан хөмрөг Х-А-7, Д-1, ХН-100

[663] Аугаа их октябрийн социалист хувьсгалын 70 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай хуулийн 10-р зүйл

[664] Ардын эрх. 1996 оны 9дүгээр сарын 24-ны өдөр

[665] Улсын Бага Хурал, Засгийн газраас гаргасан хууль дүрэм, тогтоолуудын эмхтгэл. Хоёрдугаар дэвтэр. 1941 он.43-49 дахь тал

[666] БНМАУ-ын хууль, дүрэм, тогтоолын эмхтгэл. УБ, 1961 он. №4, 17-19 дэх тал.

[667] БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгчдийн зарлиг, 1974 оны 11 сарын 19 №18, "Өршөөл үзүүлэх комисс байгуулах тухай" 4 дүгээр зүйл.

[668] БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгчдийн зарлиг, 1979 оны 11 сарын 22 №18, "Өршөөл үзүүлэх комисс байгуулах тухай" 3 дугаар зүйл.

- 1984 онд "БНМАУ тунхагласны 60 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай" АИХ-ын Тэргүүлэгчдийн зарлиг
- 1987 оны 10-р сарын 10-ны өдрийн "Аугаа их Октябрын хувьсгалын 70 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай" БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн зарлиг
- 1991, 1996, 2000, 2006, 2009 онд Өршөөл үзүүлэх тухай хууль.

Өвөрхангай аймаг байгуулагдсаны ойгоор өршөөл үзүүлэх тухай шийдвэр гарч байсан тухай сонирхолтой мэдээ бий боловч холбогдох шийдвэрийг олж үзээгүй тул дээрх тоо баримтад оруулаагүй болно.

Төрийн эрх барих дээд байгууллагын эдгээр шийдвэр нь цэвэр улс төрийн, "хорих газрын ачаалал бууруулах", эсхүл засаж хүмүүжүүлэх чиглэл, өнгө аястай байсан болох нь судалгаанаас ажиглагдаж байна. Тухайлбал: 1931 оны Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн "Өршөөл үзүүлэх тухай" тогтоол[669]-ын гол зорилго нь "Ардын хувьсгалт эрхт засаг ба мөн ардын засгийг анх байгуулснаас хойш эдүгээ арван жил болсон ойн баярыг үлгэрлэж тэмдэглэх"-ийн тулд гарсан ба уг тогтоол өршөөл үзүүлэх тухай улс төрийн шинжтэй анхны тогтоол байсан бол 1961 оны 7 сарын 8-ны өдөр батлагдан гарсан өршөөл үзүүлэх тухай зарлигийг[670] нь төрийн эсрэг гэмт хэрэг, цэргийн гэмт хэрэг үйлдсэн хүмүүс хуртэл өршөөлд хамаарсан, нилээд энэрэнгүй шинжтэй шийдвэр гэж дүгнэж болохоор байна.

БНМАУ-ын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байнгын ажиллагаатай парламенттай болсноос хойш өршөөл үзүүлэх тухай шийдвэрийг хууль хэлбэрээр гаргах болж, 1991 онд батлагдсан анхны хуулиас хойш 3-5 жилийн давтамжтай 4 удаа хууль гаргажээ. Эдгээр хууль нь өршөөл үзүүлэх хэмжээ хүрээ, арга хэлбэрийн хувьд өөр хоорондоо онцын ялгаагүй байна.

Тухайлбал, өршөөлд хамрах, үл хамрах ялтан, гэмт хэргийн тухайд зохицуулалт нь бүгд ижил бөгөөд ялаас өршөөн хасах хугацааг өршөөн, өршөөлд үл хамрагдах нөхцөл байдал гэх мэт зохицуулалтын хувьд бага зэргийн ялгаатай байна. "Өршөөл үзүүлэх тухай 1991 оны хууль "Өршөөл үзүүлэх тухай" 1984 оны АИХ-ын Тэргүүлэгчдийн зарлигийн зохицуулалт нилээд төстэй байдал ажиглагдана /***Өршөөл үзүүлэх тухай хуулиудын адил ба төстэй байдлыг тайлангийн 1 дүгээр хавсралтаас үзэх/.***

III. Монгол Улсын дээд шүүхээс Өршөөл үзүүлэх тухай хуулийн зүйл, заалтыг тайлбарласан тогтоолын талаар

Улсын дээд шүүх 1991, 2000, 2006, 2009 онд гарсан Өршөөл үзүүлэх тухай хуульд тогтоолоор тайлбар хийжээ. Өршөөл үзүүлэх тухай хуулиудын адил агуулгатай зүйл, заалтын талаар нэг мөр ойлгохоор тайлбар хийсэн байх ба өөр хоорондоо зарчмын ялгаатай ойлголт өгөхөөр тайлбар үгүй байгаа нь сайшаалтай. Гэвч Өршөөл үзүүлэх тухай Монгол Улсын хуулийн

[669] Монгол Ард Улсын Бага Хурлын Тэргүүлэгчид ба Засгийн газрын хуулиуд хийгээд, тушаалуудыг эмхтгэн хавсруулсан сэтгүүл Шүүх явдлын яам. Дугаар 5-6, 21 /1931/ дүгээр он. 153-157 дахь тал. Монгол Улсын Засгийн газрын архив. ХН№9, Ф№1 Товъёог №3

[670] БНМАУ-ын хууль, дүрэм, тогтоолын эмхтгэл. УБ, 1961 он. №4, 17-19 дэх тал.

зүйл, заалтын талаар Улсын дээд шүүхийн ёс мэт гаргадаг тайлбар ирсэн шүүмжлэлтэй хандвал зохих дараах хэдэн үндэслэл байна. Үүнд:

1/ Өршөөл үзүүлэх тухай хуулийг аль болох хөндлөнгийн тайлбаргүй хэрэглэж болохоор боловсруулан баталж, мөрдөж байх нь зүйтэй.

2/ Зарим зүйл, заалтын агуулгыг Иргэний хууль болон бусад хуулиас ямар ч маргаангүй ойлгох боломжтой байхад "уламжлал" ёсоор тайлбарласаар байгаа нь илүүц ажиллагаа юм.

3/ Улсын дээд шүүх зарим тохиолдолд "бусдын буруугаар" хуулийн хэм хэмжээ тогтоосон тайлбар хийсэн байна. Тухайлбал, 2000 онд баталсан Өршөөл үзүүлэх тухай хуулийн 3 дугаар зүйлд хууль тогтоогчийн зүгээс гаргасан "цоорхой"–г Улсын дээд шүүх тайлбар гаргаж нөхөхдөө "Энэ хуулийн 3 дугаар зүйлд... "гурваас арван жил", "арван нэгээс арван таван жил" гэсэн хугацаа тогтосон бөгөөд арваас арван нэгэн жил хүртэлх хоорондын хугацаа орхигдсон байх тул арваас арван нэгэн жил хүртэлх, арван таваас арван зургаан жил хүртэлх хугацааг урагш нь "арав", арван тав" гэсэн хугацаанд оруулан тооцвол зохино..." гэж эрх хэмжээгээ хэтрүүлсэн байна.

4/ Цаашид, хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгож, хэрэглэсэн нэр томьёоны тайлбарыг хуульд өөрт нь тусгаж байх нь зүйтэй байна/ ***Өршөөл үзүүлэх тухай хуулийг тайлбарласан Улсын дээд шүүхийн тогтоолын харьцуулсан судалгааг 2 дугаар хавсралтаар үзэх***/.

IV. Ялтныг "нийгэмшүүлэх" талаар гадаадын зарим улсын туршлага

Хорих ял эдэлж буй хүмүүсийг өршөөл үзүүлэх хэлбэрээр, ямар ч судалгаагүй олноор нь сулладаг практик гадаад улсад үндсэндээ алга байгааг тайланд зориуд тэмдэглэж байна.

а/ ОХУ-ын Төрийн дум өршөөл үзүүлэх тухай шийдвэр цөөн бус гаргаж байгаа ч тус улсын дотоодын аюулгүй байдал болон бусад нөхцөл байдалтай уялдан энэ нь зайлшгүй шаардлагатай арга хэмжээ байх бөгөөд өршөөлийн үйлчлэх хугацааг хагас жилээс илүүгүй байхаар хуульчилдаг болсноор өршөөл үзүүлэх ажиллагаа манайх шиг эцэс төгсгөлгүй үргэлжилдэггүй байна.

Нийгэм-эдийн засгийн амьдралын стандартад нь дөхөж очихыг хүсч буй Европын холбооны зарим улсын хууль тогтоомжийг судлан үзэхэд ялтныг хугацаанаас өмнө ялаас чөлөөлөх боломжтой байна. Гэвч энэ нь төрийн эрх барих дээд байгууллагын шийдвэрээр гаргадаг өршөөл үзүүлэх журмаар бус, харин Эрүүгийн хуульд заасан нөхцөл, журмын дагуу ял шийтгэлийг хөнгөлж өөрчлөх, хүчингүй болгох, багасгах, хугацаанаас нь өмнө тэнсэн суллахыг ойлгодог. Тухайлбал: Германд өршөөл, уучлал үзүүлэх эрх нь Холбооны улсын хувьд бол Үндсэн хуулийн 60 дугаар зүйл, ЭБШХ-ийн 452 дугаар зүйлд заасны дагуу *Холбооны ерөнхийлөгч, муж улсын хувьд Үндсэн хууль болон холбогдох бусад* хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагууд хэрэгжүүлдэг. Жишээ нь: Саарланд муж улсад Засгийн газрын бүрэн эрхэд хамаарч, Хууль зүйн сайд нь хэрэгжүүлдэг бол Берлин, Берингер мужуудад Засгийн газрын ерөнхий сайд хэрэгжүүлдэг[671]. ХБНГУ-д Өршөөл үзүүлэх ерөнхий хуулийг сүүлийн 70 жилийн турш гаргаагүй байна.

[671] http://en.wikipedia.org/wiki/Pardon орж үзнэ үү.

Англо-Саксоны эрх зүйн тогтолцоотой улсын жишээн дээр авч үзвэл: АНУ-ын Техас муж, Канад улсад өршөөл үзүүлэх гэдгийг тайлангийн эхэнд тайлбарласан **parole** гэдгээр ойлгодог. Тухайлбал: Канадын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу ялтныг хугацаанаас нь өмнө суллах асуудлыг Зөвлөл[672] /Parole Board of Canada/ хэлэлцэж өршөөл үзүүлэх шийдвэрийг гаргадаг. Энэхүү зөвлөл нь Үндэсний байгууллага буюу 5 бүс нутгийн төлөөлөл бүрээс 2 хүн байдаг. Хугацаанаас нь өмнө тэнсэн суллах шийдвэрийг гаргахдаа Канадын цагдаагийн мэдээллийн төвөөс үйлдсэн гэмт хэргийнх нь тухай мэдээлэл авч, гэм буруугаа ухаарсан эсэх, үүнийг нь нийтээр хүлээн зөвшөөрсөн эсэхийг харгалзан үздэг ажээ. Түүнээс гадна өршөөл үзүүлэхээс өмнө ялтан хуульд заасан дараах шаардлагыг хангасан байх ёстой:

- Учруулсан хохирлыг нөхөн төлсөн, шүүхийн зардлыг төлсөн байх
- Хуулийн дагуу хугацаанаасаа өмнө тэнсэн суллагдах нөхцөл бүрдсэн байх

АНУ–ын Техас муж улсад: "өршөөл, уучлал" гэдгийг хугацаанаас нь өмнө тэнсэн суллахтай ижил утгаар ойлгож хэрэглэдэг[673] ба дараах асуудлыг заавал шийдвэрлэсэн байх ёстой:

-Risk assessment буюу эрсдэлийн талаарх дүгнэлт хийх, энэ нь дотроо 2 асуудалтай "static and dynamic factors" буюу нас, үйлдсэн хэрэг, түүний сэдэлт, хувийн байдал, нийгэмд аюултай байдал, хорих ял эдлэж байхдаа мэргэжил дээшлүүлэх сургалт болон шинээр сургалтад хамрагдсан эсэх, хорихын дэглэм, хоригдож байх хугацаандаа журам, дүрэм сахисан эсэх, элдэв зөрчилд орсон эсэхийг харгалздаг. Зөвлөлд 7 хүнтэй, 6 жилийн хугацаатай томилогддог.

-Clemency /уучлал/. Зөвлөлийн ердийн олонхийн саналаар амбан захирагч уучлал үзүүлдэг.

Дээрх улсад өршөөл үзүүлэх ерөнхий хууль байхгүй харин "өршөөл үзүүлэх" асуудлыг голчлон эрүүгийн ялаас хугацааны өмнө, нийтлэг байдлаар суллаж өршөөл энэрэл үзүүлэх хэмжээнд ойлгож хэрэгжүүлдэг байна.

Өршөөл үзүүлэх "зөвлөл", "комисс"-ын бүрэлдэхүүн, эрх хэмжээг хууль тогтоомжийн актаар зохицуулах ба бүрэлдэхүүнд хуульчийн мэргэжилтэй боловч шүүгч, прокурор, өмгөөлөгчөөс бусад хүмүүс ордог.

б/ Ялтныг "нийгэмшүүлэх ажил"-ыг нийгмийн туст ажил үйлчилгээний төрөл гэж үзэж тусгайлан хуулиар зохицуулах, эсхүл хөтөлбөр гарган хэрэгжүүлж байгаа жишиг байна. Өөрөөр хэлбэл ял эдлэж байгаа хүмүүсийг нийгэмд дасан зохицоход нь туслалцаа дэмжлэг үзүүлэх ажлыг нийгмийн үйлчилгээний нэг төрөл гэж үзэж[674] зарим улсад төрийн аль нэг айгууллагаар

---

[672] http://en.wikipedia.org/wiki/Parole Board of Canada орж үзнэ үү. Мөн website www.pardons.gc.ca. дэлгэрүүлэн харна уу.

[673] http://info.sos.state.tx.us/pls/pub/read

[674] Шоронгоос суллагдсан хүмүүсийг нийгэмшихэд нь туслалцаа дэмжлэг үзүүлэх ойлголтыг гадаадын зарим оронд нийтлэг байдлаар "resocialization эсвэл reintegration and rehabilitation of criminal offender" хэмээн томъёолдог бөгөөд тусгайлсан институтууд энэхүү үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэх үүрэгтэй байна.

гүйцэтгүүлдэг байна.[675]

Ялтныг нийгэмшүүлэх талаар судалсан улс оронд хэвшиж тогтсон хэд хэдэн хандлага байна:

1. Social control буюу нийгэм-захиргааны хяналт тогтоох гэсэн манай улсад байгаа загвар нь постсоциалист зарим оронд байдаг. Казакстан, Киргизстан гэх мэт.

2. Probation,Parol буюу тусгайлсан алба, ажилтан хяналт тавьж, дэмжлэг үзүүлэн ажиллах. Энэ нь зарим тохиолдолд "bootcamp, "halfway house" гэсэн хэлбэр буюу түр амьдрах, туслалцаа авах, орогнох зэрэг орон байр хэлбэртэй байна. Англо-Саксоны эрх зүйн тогтолцоотой орнуудад түгээмэл байдаг хэлбэр[676].

3. Хорих ангийн нээлттэй, хаалттай дэглэмийг нийгмийн ажлын үр дүнтэй хэлбэртэй хослуулан хэрэгжүүлэх систем буюу Ром-Германы эрх зүйн тогтолцоотой зарим улс, тухайлбал Герман, Эстони, Европын холбооны зарим улсад байна.

4. Тусгайлсан хөтөлбөр гарган ажиллах буюу хорих ангид ял эдэлж байгаа болон суллагдсан хүмүүсийг нийгэмшүүлэх хөтөлбөр нь хорих ял эдлүүлэх эрх зүйн орчин харьцангуй сайн хөгжөөгүй улс орнуудад хэрэглэдэг бөгөөд үүний нэг тод жишээ нь: Өмнөд Африкийн Бүгд Найрамдах улс юм[677]. Энэ улс ялтныг нийгэмшүүлэх хөтөлбөрийг 2002 оноос олон улсын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд үүндээ хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудыг өргөнөөр татан оролцуулж, төрийн зарим чиг үүрийг гүйцэтгүүлж байгаа сайн туршлагыг нэвтрүүлжээ /***Ялтныг нийгэмшүүлэх асуудлаар тус секторт гүйцэтгэсэн "Хорих ангийн нээлттэй, хаалттай дэглэмийн талаарх судалгааны тайлангаас энэ тухай дэлгэрэнгүй үзэх боломжтой/.***

V. "Өршөөл үзүүлэх тухай" Монгол Улсын хуулийг биелүүлэх журмын талаар санал, дүгнэлт

Өршөөл үзүүлэх шийдвэрийг биелүүлэх явцад гарсан зөрчил, дутагдал бэрхшээлийн талаар цагдаа, шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагаас судалгаа авахаар албан ёсоор хандаж хүссэн боловч одоогоор хариу ирүүлээгүй байна. Өршөөл үзүүлэх тухай шийдвэрийг биелүүлэх ажлыг зохион байгуулахад оролцож байсан прокурор, шүүгч, шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтнууд болон судлаачидтай хийсэн ярилцлагын судалгаанаас дараах зөрчил дутагдал, бэрхшээлийн талаар дурдсан болно:

---

[675] АНУ-д Halfway house нэртэй нэгж нь хорих ял эдлэзд суллагдсан хүмүүсийг 120-180 өдөрт шаардлагатай бол түр байршуулах хэлбэрээр эргэн нийгэмшэхэд нь дэмжлэг үзүүлдэг бөгөөд хагас хяналттай үүндээ цагдаагийн байгууллагын туслалцааг авах хэлбэрээр хамтран ажилладаг.

[676] Тухайлбал: Англи улсад The rehabiltation of offender act-1974 гэсэн хууль үйлчилдэг бөгөөд түүнд заасан арга хэрэгслээр шороонд байгаа болон суллагдсан хүмүүст нийгмийн ажил, үйлчилгээ үзүүлэх хугацаа зэргийг зохицуулсан байдаг.

[677] KC.Goyer. "Incarcerating and rehabiltitating offerders", 2002.

- Өршөөл үзүүлэх тухай шийдвэрийг Монгол Улсын эрүүгийн нөхцөл байдлыг сайтар үнэлж дүгнэлгүйгээр ойрхон ойрхон гаргаж буй нь төрийн эрүүгийн бодлого алдагдаж буйг харуулж байна.
- Өршөөл үзүүлэх тухай хуулиар хорих болон бусад ялаас чөлөөлсөн хүмүүсийг "нийгэмшүүлэх"-д төр оглтхон ч анхаарахгүй байна. Өршөөлөөр суллагдсан олон хүн очих газар, хүлээж авах хүнгүй, эрхлэх ажилгүй учраас гэмт хэрэг дахин үйлдсэн олон жишээ баримт энэ байдлыг нотолно.
- Өршөөл үзүүлэх тухай хуулийг дутуу дулимаг, яаран боловсруулж гаргадаг. Хууль гаргах нь зүйтэй гэж үзвэл төр чухам хэнд өршөөл энэрлээ хайрлахаа урьдчилан судалсны үндсэн дээр гаргаж байх.
- Өршөөл үзүүлэх шийдвэрийг гэмт хэргийн улмаас бие махбодь, сэтгэл санаа, эд хөрөнгийн хувьд хохирсон иргэд хэрхэн хүлээж авахыг огт харгалзан үзэхгүй байна. Хохирлоо нөхөн төлөөгүй этгээд Эрүүгийн хуульд зааснаар хугацааны өмнө тэнсэн суллагдах боломжгүй бол өршөөл үзүүлэх журмаар ийм боломжийг нээж өгдөг.
- Өршөөл үзүүлэх шийдвэрийг зохион байгуулах ажлыг эрх хэмжээ нь тодорхой бус Улсын Их хурлаас байгуулсан түр комисст хариуцуулж ирснийг халах.

Дүгнэлт

1/ Улсын Их Хурлын 2009 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 53 дугаар тогтоолоор Өршөөл үзүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах комиссыг байгуулж, 2009 оны 8 дугаар сарын 15-ны дотор өршөөл үзүүлэх ажлын дүнг танилцуулахыг даалгажээ. Комиссыг Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга ахлаж, бүрэлдэхүүнд шүүх, прокурор, өмгөөлөх байгууллагын болон төрийн захиргааны бусад байгууллагын төлөөллийг оруулсан байна. Өршөөл үзүүлэх талаар урьд гарсан хуулиудын хэрэгжилтийг ч мөн комисст хариуцуулах байдлаар зохион байгуулжээ.

Гэвч УИХ-ын байгуулсан энэхүү комисс нь бодит байдал дээр хуулийн биелэлтийг зохион байгуулахад оролцдоггүй бөгөөд түүний эрх хэмжээ, ажиллах журам нь ч тодорхой бус байдаг. Ял эдэлж буй хүмүүсийн хувьд өршөөл үзүүлэх ажиллагаа голчлон шүүхийн шийдвэр биелүүлэх төв байгууллага, түүний харьяа хорих ангиудад төвлөрч, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах болон шүүхийн шатанд байгаа хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хувьд байцаан шийтгэх ажиллагааны явцаас шалтгаалан өршөөлийн асуудал нилээд хожуу шийдвэрлэгддэг онцлогтой. Ийм учраас Улсын Их Хурлын тогтоолын өршөөл үзүүлэх ажлын дүнг яаравчлан танилцуулахыг даалгасан заалт анхнаасаа л бүрэн биелүүлэх боломжгүй заалт гэж үзэхээр байна. Үүнтэй уялдуулан хуулийн биелэлтийг Засгийн газарт даалган хариуцуулж, гардан гүйцэтгэх үүргийг Хууль зүй, дотоод хэргийн яам, түүний харьяа шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага хүлээдэг байхаар УИХ тогтоол гаргадаг болох.

2/ Хорих байгууллагад ял эдэлж буй ялтнуудыг өршөөл үзүүлэх журмаар суллах ажиллагааг хуулиар тогтоосон хатуу хугацаанд "баригдан", яаруу сандруу зохион байгуулснаас ажлын ноцтой алдаа, зөрчил цөөн бус гарч буйг анхаарах.

3/ Өршөөл үзүүлэх тухай хуулийг биелүүлэх журмын тухай хууль гаргах шаардлагагүй, одоо дагаж мөрдөж буй зарим хуульд зохих нэмэлт оруулснаар асуудлыг зохицуулах бүрэн боломжтой байна.

---oOo---

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ХУУЛИЙН ХАРИУЦЛАГАД ҮНДЭСЛЭЛГҮЙ ТАТАГДСАН, ЦАГДАН ХОРИГДСОН, ХИЛС ЯЛ ШИЙТГҮҮЛСЭН, ЭДЭЛСЭН ХҮМҮҮСИЙН СЭТГЭЛ САНААНЫ ХОХИРЛЫГ НӨХӨН ТӨЛӨХ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭГ ТОГТООХ АСУУДАЛ

НЭГ. УДИРТГАЛ

Судалгааны зорилго, зорилт: Судалгааг хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн хүмүүсийн сэтгэл санааны хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох, дээрх харилцааг зохицуулж буй хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал боловсруулахад харгалзан үзэх мэдээлэл цуглуулан дүн шинжилгээ хийж, эрдэм шинжилгээний санал боловсруулах зорилгоор хийсэн бөгөөд энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан болно. Үүнд:

1. Хууль бусаар эрх нь зөрчигдсөн хүмүүсийн сэтгэл санааны хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх;

2. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурорын хяналт, шүүхийн шатанд эрх нь зөрчигдсөн хүмүүсийн сэтгэл санааны хохирлын төрөл, хэмжээг тогтоож, үнэлж буй өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх/сүүлийн 4 жилээр/;

3. Гадаадын зарим орны хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн хүмүүсийн сэтгэл санааны хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох, үнэлэх, шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлах;

4. Хууль бусаар эрх нь зөрчигдсөн хүмүүсийн сэтгэл санааны хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг нарийвчлан тогтоох шалгуур /арга зам/-ыг тогтоох санал боловсруулах.

Судалгаа явуулсан чиглэл

Судалгааны зорилго, зорилтыг хангахын тулд дор дурдсан үндсэн чиглэлээр судалгааг явуулаа. Үүнд:

1. Хууль бусаар эрх нь зөрчигдсөн хүмүүсийн сэтгэл санааны хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилтийг судлан тогтоох;

2. Хууль бусаар эрх нь зөрчигдсөн хүмүүсийн сэтгэл санааны хохирлын төрөл, хэмжээг тогтоож, үнэлж буй өнөөгийн байдлыг тогтоох;

3. Гадаадын зарим орны хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн хүмүүсийн сэтгэл санааны хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох, үнэлэх, шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлах;

4. Хууль бусаар эрх нь зөрчигдсөн хүмүүсийн сэтгэл санааны хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг нарийвчлан тогтоох шалгуур /арга зам/-ыг тогтоох.

ХОЕР. СУДАЛГААНЫ ДҮН

2.1. Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн хүмүүсийн сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг тогтоох, үнэлэх, шийдвэрлэх талаарх эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилт

1.1.1. Үндэсний эрх зүйн зохицуулалт

А.Үндсэн хуулийн зохицуулалт

- БНМАУ-ын 1940 оны Үндсэн хуулийн 83 дугаар зүйлд төрийн албан тушаалтны хууль бус үйл ажиллагаанд иргэд өргөдөл, гомдол гаргах эрхтэй, түүнийг нь зохих журмын дагуу шийдвэрлэх үүрэгтэй болохыг заасан бол БНМАУ-ын 1960 оны Үндсэн хуулийн 85 дугаар зүйлд хууль бус ажиллагаанаас гадна чирэгдэл, хүнд суртал гаргасан албан тушаалтны үйл ажиллагаанд иргэн өргөдөл, гомдол гаргах эрхтэй ба энэхүү өргөдөл, гомдлыг төрийн байгууллага, албан тушаалтан нэн даруй шалгаж шийдвэрлэх үүрэгтэй болохыг заажээ.

1940,1960 оныҮндсэн хуульд төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус ажиллагаанд иргэн өргөдөл, гомдол гаргах эрхтэй болохыг хуульчилсан боловч тэдгээрийн хууль бус ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгах, иргэн уг хохирлоо нэхэмжлэх эрхийг бусад хуульд тодорхой тусгаагүй тул иргэний гомдол гаргах эрх нь илүү тунхагийн шинжтэй байжээ.

- Харин Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт*"Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх... эрхтэй"*, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт *"Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна"* хэмээн Үндсэн хуулиар бусдын хууль бусаар учруулсан хохирол буюу хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн хүмүүс өөрт учирсан хохирлоо шаардах, нөхөн төлүүлэх эрхийг тунхаглаж, улмаар уг эрхийг хангах үүргийг төрд хариуцуулсан нь чухал бөгөөд дэвшилттэй зохицуулалт болжээ. Үндсэн хуулийн энэхүү заалтаар бусдын хууль бусаар учруулсан хохирлыг эдийн болон эдийн бус гэж хязгаарлаагүй бөгөөд энэ нь хохирсон этгээдэд өөрт учирсан эдийн бус хохирлоо нөхөн төлүүлэх эрхийг хамгаалсан дэвшилттэй зохицуулалт болсон юм. Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн эрх зүйт төрийг төлөвшүүлэх, хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн дээдлэх зорилгоор 2002 онд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг шинэчлэн батлаж мөрдсөн бөгөөд уг хуулиар хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсаны улмаас иргэнд учирсан эдийн бус хохирлыг арилгах асуудлыг хуульчилжээ.

Б.Бусад хуулийн зохицуулалт

1. Хамгийн анх БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1974 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 510 дугаар тогтоолоор "Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 6 дугаар зүйлийн 1,2-т[678] заасан үндэслэлээр холбогдолгүй болсон хүмүүсийг хохирлыг арилгах тухай" журам[679] батлагдсан явдал юм. Энэхүү журмаар эрүүгийн хариуцлагад татагдаж шалгагдаад тухайн үеийн ЭБШХ-ийн 6 дугаар зүйлд заасан үндэслэлээр холбогдолгүй болсон хүмүүст учирсан ***зөвхөн материаллаг хохирлыг арилгах*** зорилгоор тэдний ажиллаагүй байсан хугацааны дундаж буюу албан тушаалын цалинг зохих тогтоол, баримт бичгийн үндсэн дээр ажиллаж байгаа газар, байгууллагаас 2 сарын цалингаас хэтрэхгүй хэмжээгээр нөхөн олгож байхаар тогтоож байв. Энэ нь тухайн үедээ хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан хүмүүст нөхөн олговор олгох талаарх хамгийн анхны эрх зүйн зохицуулалт байсан төдийгүй нөхөн олговрын хэмжээг тогтоож өгсөнөөрөө дэвшилтэт алхам болж байжээ. Хэдий тийм ч энэхүү журамд заасан нөхөн олговорыг ажил эрхэлдэггүй иргэд авах боломжгүй байв.

2. Монгол Улсын шүүх, прокурор, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх байгууллагын хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах журмын тухай хууль[680].

Энэ хуулийг иргэнийг эрүүгийн хариуцлагад хууль бусаар татан, мөрдөн мөшгөж хилсээр хорьж цагдсаныхаа төлөө төр хариуцлага хүлээх тухай асуудлыг ямар нэг хэмжээнд зохицуулсан анхны хууль гэж үзэж болно.

Уг хуулиар иргэнийг хууль бусаар ял шийтгэсэн, эрүүгийн хариуцлагад татсан, таслан сэргийлэх арга хэмжээ болгон цагдан хорьсон, мөн захиргааны шийтгэлийн журмаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу баривчлах арга хэмжээ оногдуулсныг шүүх, прокурор, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх байгууллагын хууль зөрчсөн ажиллагаа гэж үзэж, түүний улмаас учирсан хохирлыг иргэн арилгуулах эрхтэй болохыг тогтоосон байна. Гэвч энэхүү хуульд зааснаархохирсон иргэн эдийн хохирол буюу аваагүй цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж болон эд хөрөнгийн бусад хохирлыг гаргуулах боломжтой, өөрөөр хэлбэл, уг хуулиар иргэнд учирсан эдийн бус буюу сэтгэл санааны хохирлыг арилгах, нөхөн төлүүлэх тухай зохицуулаагүй байна.

3. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хууль[681]-аар хилс хэрэгт шийтгүүлсэн хэлмэгдэгчид нөхөн олговор олгохоор зааж, цаазаар авах ял шийтгүүлсэн хэлмэгдэгчийн гэр бүлийн гишүүдэд болон хорих ялаар шийтгүүлсэн хэлмэгдэгчид, хэрэв хэлмэгдэгч нас барсан бол түүний гэр бүлийн гишүүдэд 1 000 000 төгрөгийн, бусад хэлмэгдэгчид 500 000 төгрөгийн нэг удаагийн нөхөн олговор олгохоор шийдвэрлэжээ.

---

[678] Гэмт хэрэг гараагүй, гэмт хэргийн хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болсон.

[679] Үндэсний төв архив., Засгийн газрын хэрэг эрхлэх газрын хууль тогтоомжийн лавлагааны сангаас.

[680] 1990 оны 3 дугаар сарын 23-ны өдөр батлагдаж, 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр хүчингүй болсон.

[681] 1998 оны 1 дүгээр сарын 2-ны өдөр батлагдсан.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн хүмүүс энэ хуулийн дагуу нөхөн олговор авч байгаа мэт боловч хэлмэгдэгчдэд учруулсан эдийн болон эдийн бус хохирлын хэмжээг дээрх хуулиар тогтоосон нөхөн олговрын хэмжээтэй зүйрлэхийн аргагүй, тэгээд ч хилс хэрэгт шийтгүүлж цаазаар авахуулсан, хоригдон мөрдөгдөж, ялаа эдэлж байхдаа нас барсан, тахир татуу болсон хүмүүсийн амь нас, эрүүл мэндэд учруулсан гэмтэл согог болон сэтгэл санааны шаналалд үнэлэмж тогтоох гэсэн оролдлого төр хийгээгүй болох нь хуулиас харагдаж байна.

Иймд энэхүү хуулийг монголын түүхийн нэгэн эмгэнэлт цаг үед хилс хэрэгт шийтгүүлж амь нас, биеийн эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирч хэлмэгдсэн хүмүүс, тэдгээрийн гэр бүлийн гишүүдэд учруулсан эдийн болон эдийн бус хохирлыг нөхөн барагдуулах гэхээсээ илүү нэгэн цагт иргэдийнхээ эсрэг хомроглон үйлдсэн гэмт хэргийнхээ төлөө төр уучлал эрж, энэ мэт бусармаг үйл ажиллагаа түүхэнд дахин давтагдан гарахгүй байх нийгэм-улс төр, хууль зүйн дархлаа бий болгох зорилготой зохицуулалт гэж дүгнэж байна.

4. Эрүүгийн байцаан шийтгэх хууль

УИХ-аас 2002 онд батлан мөрдүүлсэн ЭБШХ-ийн[682] 44 дүгээр бүлэгт "Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах" тухай зохицуулсан бөгөөд мөн хуулийн 388 дугаар зүйлд *"... иргэн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан ..., сэтгэл санааны үр дагаврааг арилгуулах ... эрхтэй"* гэж заасан ба мөн хуулийн 391 дүгээр зүйлийн 391.1-т зааснаар:

- Эд хөрөнгийн бус хохирлыг Иргэний хуульд заасан журмын дагуу нөхөн төлнө.
- Эд хөрөнгийн бус хохирлын хэмжээг хэргийн нөхцөл байдлыг харгалзан Иргэний хуульд заасан журмаар тодорхойлно.
- Сэтгэл санаанд учирсан хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу гаргах ажээ.

Өөрөөр хэлбэл, ЭБШ хуульд эдийн бус хохирол буюу сэтгэл зүйд учирсан хохирлыг нөхөн төлүүлэхийг шаардах эрх болон шаардлага гаргах үндэслэлийг заасан боловч хохирлын хэмжээг тогтоох болон нөхөн төлөх журмыг Иргэний хуульд зохицуулахаар заасан байна.

5. Иргэний хууль

- 1926 онд батлан мөрдүүлсэн БНМАУ-ын Иргэний хуулиар нийгмийн халамжийн харилцаа болон зарим эдийн эрхийг голчлон зохицуулсан байх бөгөөд харин зөрчлийн улмаас үүсэх үүргийн тухай буюу бусдын хууль бус үйлдэл, үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг шаардах, арилгуулах асуудлыг зохицуулаагүй байжээ.
- 1952 онд батлан мөрдүүлсэн БНМАУ-ын Иргэний хуулиар гэм хор гэсэн ойлголтыг шинээр хуульчилсан байх бөгөөд уг хуулийн 6 дугаар

[682] 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан.

бүлгийн 253 дугаар зүйлд "Гэм хорыг учруулснаас үүсэн гарсан нэхэмжлэл"-ийн тухай, 17 дугаар бүлэгт "Бусдад хор хүргэснээс үүсэх үүргүүд"-ийн тухай тусгайлан авч үзсэн боловч бусдын хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас учирсан хохирлыг зөвхөн хүний бие болон түүний хөрөнгө хэмээн явцуу хүрээнд тодорхойлжээ.

- 1963 оны БНМАУ-ын Иргэний хуулиар эд хөрөнгийн болон түүнтэй холбогдсон эд хөрөнгийн бус харилцаа /хуульд заасан бол эд хөрөнгийн бус амины бусад харилцаа/-г зохицуулахаар тусгасан, 3 дугаар зүйлд "бусдад гэм хор хүргэх нь иргэний эрх, үүрэг үүсэх үндэслэл болох"-оор, мөн 6 дугаар зүйлд "Хүний нэр төр, алдар хүндийг хамгаалах" тухай, 18 дугаар бүлэгт "Гэм хор учруулснаас үүсэх үүрэг"-ийн тухай, 319 дүгээр зүйлд "Албан байгууллагын ажилчин, албан хаагчид үүргээ гүйцэтгэж байгаад өөрийн буруугаас бусдад учруулсан гэм хорыг уул байгууллага хариуцах үүрэг"-ийн тухай тусгайлан зохицуулсан байх боловч эдгээр зохицуулалтаар "сэтгэл зүйн хохирол"-ыг авч үзээгүй байна. Өөрөөр хэлбэл, уг хуулиар эдийн бус хохирлыг "бусдын нэр төр, алдар хүндэд учирсан хохирол"-оор хязгаарлан хуульчилсан байна.
- 1994 оны Иргэний хууль нь Монгол Улсад 1992 онд батлагдсан Үндсэн хуульд нийцүүлэн гаргасан хууль боловч эдийн бус хохирлын тухайд өмнөх Иргэний хуульд байсан зохицуулалттай үндсэндээ ижил зохицуулалт тусгасан байжээ.
- 2002 оны Иргэний хуулийн[683] 230, 511 дүгээр зүйлд "Эдийн бус гэм хорыг арилгах" тухай заасан байх бөгөөд эдгээр зүйлд эдийн бус хохирлыг шаардах эрх, эдийн бус хохирлыг нөхөн төлөх хэлбэр, гэм хорыг арилгах болон гэм хорын хэмжээг тогтооход харгалзах зүйлийг тусгасан боловч "эдийн бус гэм хор"-ыг зөвхөн "бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд учирсан хохирол"-оор хязгаарлан тодорхойлсон байна.

Ийнхүү ЭБШ хуулийн 391 дүгээр зүйлд "Эдийн бус хохирлыг Иргэний хуульд заасан журмын дагуу нөхөн төлнө", "Эдийн бус хохирлын хэмжээг хэргийн нөхцөл байдлыг харгалзан Иргэний хуульд заасан журмаар тодорхойлно" гэж заасан боловч Иргэний хуульд өөрт нь "... эдийн бус хохирлын хэмжээг хэргийн нөхцөл байдлыг харгалзан ... тодорхойлох" журмыг нарийвчлан заагаагүй учир хохирлын хэмжээг ЭБШ хуульд заасанчлан тогтоох боломжгүй байна.

1.1.1. Олон улсын гэрээний зохицуулалт

Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн хүмүүсийн сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг тогтоох, уг хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох талаарх олон улсын эрх зүйн зохицуулалтыг судлах хүрээнд Монгол Улсын нэгдэн орсон дараах Олон улсын гэрээг судаллаа. Үүнд:

1. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц[684]. Энэ

[683] 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан.

[684] "Төрийн мэдээлэл" эмхтгэл. Тусгай дугаар I боть. 2004 он. 109-120 дахь тал. Энэ конвенц 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Нью-Йорк хотноо батлагдаж, 1987 оны 6 дугаар сарын

конвенцийн 14 дүгээр зүйлд "Оролцогч улс өөрийн эрх зүйн тогтолцоогоороо эрүүдэн шүүгдсэн этгээд хохирлоо арилгуулах, шударга хангалттай нөхөн төлбөр авах эрх, түүний дотор эрүүл мэндээ бүрэн сэргээхэд шаардлагатай төлбөр гаргуулах эрхийг хүлээн зөвшөөрнө. Эрүүдэн шүүгдсэний улмаас хохирогч нас барвал асран хамгаалагч нөхөн төлбөр авах эрхтэй" гэж заажээ.

2. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт[685]*-ын 9 дүгээр зүйлд* "Баривчлагдаж эсхүл цагдан хоригдож эрх чөлөөгөө хасуулсан хүн бүр ийнхүү хорьж саатуулсан нь хууль ёсны эсэхийг шүүхээр даруй тогтоолгох, хууль бусаар хорьсон бол суллуулах шийдвэр гаргуулах эрхтэй.Хууль бусаар баривчлагдаж эсхүл цагдан хоригдож хохирсон этгээд хохирлоо албадан нөхөн төлүүлэх эрхтэй" гэж, 14 дүгээр зүйлд "Эрүүгийн хэрэг үйлдэж, шүүхийн эцсийн шийдвэрээр ял заагдсан бөгөөд шинэ буюу шинээр илэрсэн үйл баримт шүүн таслах ажиллагааны алдааг хөдөлбөргүй нотолсны учир оногдуулсан ялыг хожим хүчингүй болгосон буюу хэргийг цагаатгасан бол тэрхүү мэдэгдээгүй байсан үйл баримт тухайн үедээ илрээгүй нь бүхэлдээ.буюу зарим талаар уг хүний буруугаас болсон гэдэг нь батлагдаагүй бол тийнхүү шийтгүүлсэн этгээд хуулийн дагуу хохирлоо нөхөн төлүүлнэ" гэж заасан байна.

1.1.2. Гадаадын зарим улсын эрх зүйн зохицуулалт

Энэ асуудал тухайн улсын мөрдөж буй эрх зүйн систем ба уламжлал, нийгэм-эдийн засгийн хөгжлийн түвшин зэрэг олон хүчин зүйлээс хамааран харилцан адилгүй зохицуулагдсан болох нь Польш, ОХУ, Англи, Шотланд, Итали, Австрали, Шинэ Зеланд зэрэг улсад мөрдөж буй хууль тогтоомжийн судалгаанаас харагдаж байна.

Англи[686]

- Английн Эрүүгийн хэрэг шүүн таслах тухай хууль /1988 он/-ийн 133 дугаар зүйлийн 133.1-д *"Аливаа этгээд эрүүгийн хариуцлагад татагдан шийтгүүлсэн боловч хожим шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хилс ял эдлэсэн нь тогтоогдон түүнийг шийтгэсэн шүүхийн шийдвэр өөрчлөгдсөн, цагаатгагдсан бол Төрийн нарийн бичгийн дарга тухайн үйлдлийн улмаас хохирсон этгээдэд нөхөн төлбөр олгоно"* гэж заажээ. Уг хуульд зааснаар Төрийн нарийн бичгийн дарга нөхөн төлбөр олгох эсэх асуудлыг шийддэг боловч түүний үнэлгээг Төрийн нарийн бичгийн даргын томилсон бие даасан үнэлгээчин тогтоодог[687] бөгөөд үнэлгээ тогтоохдоо дараах нөхцөл байдлыг харгалзан үздэг байна. Үүнд:

26-ны өдөр хүчин төгөлдөр болсон ба Монгол Улс 2000 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр нэгдэж орсон.

[685] "Төрийн мэдээлэл" эмхтгэл. Тусгай дугаар I боть. 2004 он. 11-28 дахь тал. Ерөнхий ассемблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 2200 А /XXI/ тоот тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон . Монгол Улс 1974 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр соёрхон батлалсан.

[686] Stephanie Robertsn, 'Unsafe' Convictions: Defining and Compensating Miscarriages of Justice, London, 2003, at 2

[687] Stephanie Robertsn, 'Unsafe' Convictions: Defining and Compensating Miscarriages of Justice, London, 2003, at 2

а/ тухайн хүнийг эрүүгийн хариуцлагад татсан гэмт хэрэг болон түүнд оногдуулсан ялын хүнд, хөнгөн байдал;

б/ тухайн гэмт хэргийн мөрдөн байцаалт, яллах үйл ажиллагаа явагдсан байдал;

в/ түүнээс үүдэлтэйгээр хохирогч бусад гэмт хэрэг үйлдсэн эсэх болон түүнд оногдуулсан ялын хэмжээ[688].

Эрүүгийн хэрэг шүүн таслах тухай хууль /1988он/-ийн 133 дугаар зүйлийн 133.1-д зааснаар нөхөн төлбөрийн үнэлгээг иргэний эрх зүйн зөрчлийн улмаас учирсан хохирлын үнэлгээтэй ижил байдлаар хийдэг байна /тухайн харилцаатай холбоотой зарчмууд 2008 оны Эрүүгийн хэрэг шүүн таслах болон Цагаачлалын тухай хуулийн хүрээнд ихээхэн өөрчлөгдсөн байна/.

- Эрүүгийн хэрэг шүүн таслах болон Цагаачлалын тухай хууль /2008 оны/-ийн 61 дүгээр зүйлд гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацааг 2 жил байхаар заасан бөгөөд нөхөн төлбөрийн дээд хэмжээг тогтоож өгсөн. Хэрвээ Төрийн нарийн бичгийн дарга онцгой нөхцөл байдал байна гэж үзвэл гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацааг сунгах боломжтой. Нөхөн төлбөрийн ердийн хэмжээг ***500000 паунд***, 10-аас дээш жилээр хоригдсон бол ***1000000 паунд*** байхаар хуульчилсан байна.

Шотланд[689]

Шотландын Эрүүгийн хэргийг хянах хороо /ШЭХХХ/-г 1999 оны 4 дүгээр сард Парламентийн шийдвэрээр байгуулсан бөгөөд эрүүгийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, хилс ял эдэлсэн гэж үзэж байгаа хүн энэхүү хороонд гомдол гаргаж бolно.

- *Нөхөн төлбөрийн төлөлт.* Одоогийн байдлаар нөхөн төлбөрийг төлөх 2 төрлийн тогтолцоо байдаг байна:

- "хуулиар тогтоосон";
- "Ex Gratia"[690].

Нөхөн төлбөрийг шаардах, гомдол гаргах хөөн хэлцэлцэх хугацааг хязгаарлаагүй бөгөөд уг гомдлыг Шотландын төрийн эрх бүхий албан тушаалтанд гаргаж, тэрээр гомдол гаргагч нөхөн төлбөр авах эрхтэй эсэхийг шийдвэрлэнэ.

Нөхөн төлбөрийн хэмжээг Шотландын төрийн эрх бүхий албан тушаалтны томилсон бие даасан үнэлгээчин тогтоох ба бие даасан үнэлгээчин үнэлгээ хийхдээ иргэний эрх зүйн зөрчлийн улмаас учирсан хохирлын хэмжээг тогтоох буюу нөхөн төлбөрийн үнэлгээг хийхтэй адил зарчмаар хийнэ.

- *Нөхөн төлбөрийн хэмжээ.* Нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохын тулд бие даасан үнэлгээчин нь иргэний эрх зүйн гэм буруугийн нөхөн төлбөрийг үнэлэхтэй адил зарчмыг баримтална.

Үнэлгээг тогтоохдоо хилс ял шийтгүүлсэн, гэмт хэрэгт үндэслэлгүй татагдсан болон эрх чөлөөг нь хязгаарласнаас үүдэлтэй эдийн болон эдийн

---

[688] Sally Broadbridge, Compensation for Acquitted Defendants, 2009

[689] http://www.scotland.gov.uk/Topics/Justice/law/miscarriages/Compensation-Scheme/ExGratiaScheme/Q/editmode/on/forceupdate/on

[690] Хуулиар олгогдсон эрх гэхээсээ илүүтэйгээр төрөөс үзүүлж байгаа тусламж, дэмжлэг

бус хохирлын аль алиныг нь харгалзан үзэх ба "амьжиргааны хэмнэсэн зардал" /хоригдох хугацаандаа зарцуулаагүй амьдралын өртөг/-ыг эдийн гэм хорын нөхөн төлбөрөөс хасахгүй.

Хуулийн дагуу нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох нь үнэлгээчний бүрэн эрхийн асуудал байдаг ба Шотландын төрийн эрх бүхий албан тушаалтан тухайн үнэлгээчний тогтоосон хэмжээг өөрчлөх эрх байхгүй.

Австрали[691]

Эрүүгийн хэрэгт үндэслэлгүй шийтгэгдсэний нөхөн төлбөр. Австралийн муж улсууд болон газар нутгуудад ex gratia төлбөрийг олгодог боловч нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох арга нь тодорхойгүй байна. Австралид эрүүгийн хэрэгт үндэслэлгүй шийтгэгдсэний хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээ нь зөрчлийн улмаас учирсан хохирлын нөхөн төлбөр шиг өндөр үнэлгээтэй байдаггүй. Одоогийн нөхөн төлбөрийн ex gratia тогтолцоо нь дур зоргын шинжтэй байна. Нөхөн төлбөрийг олгох талаар Австралийн шүүх эрх мэдлийн эрх хэмжээ нь өгөөжтэй ч биш, ил тод ч биш. Хууль бусаар эрүүгийн хариуцлага хүлээсэн ихэнх хүмүүс ямар нэгэн нөхөн төлбөр авдаггүй. Хууль тогтоомжоос харахад нөхөн төлбөрийн хэмжээ хэд байх, түүнийг хэн тогтоох нь тодорхойгүй байна.

Австралид "ex gratia" нөхөн төлбөрийг олгодог ба түүнд эдийн болон эдийн бус гэм хорын нөхөн төлбөр аль аль нь багтсан шинжтэй байдаг. Шүүхээс олгож байгаа "ex gratia" нөхөн төлбөр нь дур зоргын шинжтэй байгаа учраас төлж байгаа дүнгийн албан болон албан бус хэмжээг гаргаж ирэхэд бэрхшээлтэй.

Шинэ Зеланд[692]

Шинэ Зеландад Эрүүгийн хэрэгт үндэслэлгүй татагдаж ял шийтгэгдсэн этгээдэд нөхөн төлбөр болон ex gratia төлбөр олгох удирдамжийг баталсан. Нөхөн төлбөр авах нь ex gratia тогтолцоо учраас үүнийг тогтсон эрх гэж ойлгох боломжгүй. Гэхдээ, нөхөн төлбөр олгох эсэх болон түүний хэмжээг удирдамж маягаар тогтоон нийтэд нээлттэй болгосон. Хууль зүйн сайд асуудлыг Хатан хааны зөвлөлд танилцуулах бөгөөд тэд нөхөн төлбөр олгох эсэхийг шийдвэрлэнэ. Түүний дараагаар төрийн эрх бүхий албан тушаалтан олгох нөхөн төлбөрийн хэмжээг тогтоодог.

Гомдол гаргагч өөрийгөө гэм буруугүй гэдгээ батлах үүрэгтэй. Мөн шаардаж байгаа үнийн дүнгийн саналаа гаргаж болно. Удирдамжид эдийн болон эдийн бус гэм хорыг тодорхойлох үзүүлэлтийг гаргаж, хоригдсон жил тутамд олгох нөхөн төлбөрийн доод хэмжээг 100 000 шинэ зинландын доллар байхаар тогтоосон.

[691] http://www.aic.gov.au/publications/current%20series/tandi/341-360/tandi356/view, 20paper.aspx
[692] http://www.aic.gov.au/publications/current%20series/tandi/341-360/tandi356/view, 20paper.aspx

Польш[693]

Польш улсын 1928 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуульд хууль бусаар *ял шийтгүүлсэн тохиолдолд* Төрийн сан хариуцлага хүлээнэ гэж заасан бол 1956 онд тус улсад өрнөсөн улс төрийн үймээн, хөдөлгөөний улмаас 1958 оны 11 дүгээр сарын 15-нд Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулжээ[694]. Уг нэмэлтээр "хууль зөрчсөн ажиллгааны улмаас хохирсон иргэнд Төрийн сангаас *хохирлыг нөхөн олгох" тухай* нэмж зохицуулсан байна. 1989 оны дараах нийґэм-улс төрийн тогтолцооны өөрчлөлтийн дараа 1969 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуульд[695] нэмэлт, өөрчлөлт оруулсан ч "Хууль бусаар *баривчлагдсаны* улмаас иргэнд учирсан хохирлыг Төрийн сангаас нөхөн төлнө" гэх зохицуулалт өөрчлөгдөөгүй байна.

- Хууль бус үйл ажиллагааны улмаас учирсан хохирлын нөхөн төлбөрийн тухай асуудлыг зохицуулахдаа 1991 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн "Улс төрийн хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хууль"[696]-ийг үндэслэл болгож байсан ба энэхүү хуульд улс төрийн хэрэгт хэлмэгдэгчдийн бие махбодь болон сэтгэл санааны хохирлыг Төрийн сангаас нөхөн олгох тухай тодорхой зааж өгсөн.
- Польш Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 58 дугаар бүлэгт "Иргэнийг хууль бусаар ял шийтгэсэн, баривчилсан, цагдан хорьсон хууль зөрчсөн үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгуулах тухай" зохицуулсан бөгөөд мөн хуулийн 552 дугаар зүйлд "... улмаас өөрт учирсан эд хөрөнгийн болон сэтгэл санааны хохирлоо Төрийн сангаас нөхөн төлүүлнэ" гэж, мөн "Гарцаагүй хууль бусаар баривчлагдсан, цагдан хоригдсон бол эдийн болон эдийн бус хохирлоо нөхөн төлүүлнэ" хэмээн заасан боловч хохирлын хэмжээ болон хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох талаар тодорхой зохицуулаагүй байна.
- Польш Улсын Дээд шүүхээс*"Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн хүмүүсийн*

---

[693] Por. J.Waszczynski, Odszkodowanie za niesluszne skazanie I bezzasadne aresztowanie w polskim procesie karnym, Warszawa 1967, s.18in; A.Bulsiewicz, Proces o odszkodowanie za niesluszne skazanie lub oczywiscie bezzasadny areszt tymczasowy. Torun 1968, s.10 I n.

Проф. Вашчийнский, ПУ-ын Эрүүгийн байццан шийтгэх явцад хууль бусаар ял шийтгүүлэх болон үндэслэлгүйгээр баривчлах, түүний улмаас үүссэн хохирлыг арилгуулах тухай, Торунь 1968, 10 дугаар тал.

[694] Ustawa o odpowiedzialnosci panstwa za szkody wyrzadzone przez funkcjonariuszy panstwowych /Dz.U nr.54, poz. 243/

Төрийн албан хаагчдын хууль бус ажилагааны улмаас учруулсан хохирлыг төр хариуцах тухай хууль /"Хууль тогтоомжийн мэдээлэл" сэтгүүлийн дугаар 54/

[695] Ustawa z 29 maja 1969r. o zmianie niektorych przepisow prawa karnego, prawa o wykroczeniach oraz innych ustaw /Dz.U nr.34, poz.180/

Эрүүгийн хууль, захиргааны хариуцлагын тухай хууль болон бусад хуулиудад оруулах нэмэлт өөрчлөлтийн тухай 1969 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн хууль.

[696] Dz.U nr.34, poz.149. W.Daszkiewicz, Problem rehabilitacji i odszkodowan za bezprawne represje karne, PiP, 1990, nr.2, s.16 I n.

В.Дашкевич, Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь хууль бус ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирол арилгах болон нөхөн сэргээх арга хэмжээний тухай асуудал, "Прокурор болон хууль ёс" сэтгүүлийн 1990/2, 2 тал

сэтгэл санааны хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээ /хилсээр хоригдсон хоног тутамд ногдох/-г тогтооход дараах шалгуур үзүүлэлтүүдийг баримтална" гэж тайлбарлажээ[697]. Үүнд:

1. Хохирол нь нөхөн төлүүлэх шинжтэй бөгөөд бэлгэдлийн чанартай байх бус эдийн засгийн хувьд мэдрэгдэхүйц байх;

2. Нөхөн төлбөр нь нийгмийн тухайн цаг үеийн өмчийн харилцаанд нийцсэн ухамсартай хэмжээтэй байх;

3. Нөхөн төлбөрийн хэмжээ нь хэт их, хэт бага байж болохгүй;

4. Нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо тухайн нөхцөл байдлыг цогцоор нь авч үзэх шаардлагатай. Тухайлбал: сэтгэл санааны шаналалын хэмжээ, шаналалын эрчимтэй байдал, хэвийн байдлаа алдсан шинж төлөв гэх зэрэг.

Оросын холбооны улс

- ОХУ-ын Иргэний хууль. Иргэний хуулийн 151 дүгээр зүйлд зааснаар сэтгэл санааны хохирол гэдэг нь иргэний хувийн эдийн бус эрх эсхүл, түүнд хамааралтай эдийн бус баялгийг зөрчсөн үйлдлийн улмаас учирсан болон бусад хуульд заасан тохиолдолд биеийн болон сэтгэл санааны зовлон шаналал байна. Мөн хуулийн 1100 дугаар зүйлд "дараах тохиолдолд сэтгэл санааны хохирлыг гэм хор учруулагчийн гэм буруугаас үл хамааран нөхөн төлнө:

- Аюул ихтэй зүйлсийн улмаас иргэний амьдрал, эрүүл мэндэд учирсан хохирол;
- Иргэнийг хууль бусаар шүүсэн, таслан сэргийлэх арга хэмжээг хууль бусаар хэрэглэсэн, баривчлах болон засан хүмүүжүүлэх хэлбэрээр захиргааны шийтгэлийг хууль бусаар ногдуулснаас учирсан хохирол;
- Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээлэл тарааснаас учирсан хохирол;
- Хуульд заасан бусад тохиолдол" гэж заажээ.

ОХУ-ын Иргэний хуулийн 1101 дүгээр зүйлд зааснаар сэтгэл зүйн хохирлыг нь мөнгөн хэлбэрээр нөхөн төлөх ба сэтгэл зүйн хохирлыг хохирогчид учирсан биеийн болон сэтгэл санааны зовлон шаналалын шинж чанар, хэрэв гэм буруу нь гэм хорыг нөхөн төлөх үндэслэл болж байгаа тохиолдолд гэм буруутай этгээдийн гэм буруугийн зэргийг үл харгалзан шүүх тогтоох ба гэм хорын хэмжээг тодорхойлохдоо ухаалаг байдал ба шударга ёсны шаардлагыг тооцон үзэх ёстой ажээ. Мөн биеийн болон сэтгэл санааны зовлон шаналалын шинж чанар нь сэтгэл санааны хохирол учруулсан тухайн нөхцөл байдлын үйл баримт, хохирогчийн хувийн онцлогийг харгалзан шүүх үнэлнэ.

- *ОХУ-ын Дээд шүүхийн бүгд хурлын тайлбар.* Сэтгэл санааны хохирол гэдэгт иргэний төрөхөөс болон хуульд заасан эдийн бус баялагт /амьдрал, эрүүл мэнд, хувийн үнэлэмж /достоинство/, ажил хэргийн нэр хүнд, хувийн халдашгүй байдал, хувийн болон гэр бүлийн нууц /үйлдэл/ эс үйлдэхүй/-ээр учруулсан биеийн болон сэтгэл санааны зовлон шаналал

[697] http://www.lublin.sa.gov.pl/26/213/

болон иргэний хувийн эдийн бус эрх /нэр төрөө ашиглах эрх, зохиогчийн эрх болон бусад оюуны үйл ажиллагааны үр дүнд хуулийн дагуу бий болсон эрх/ эсвэл, эдийн эрхийг ойлгоно[698]. Түүнчлэн "шүүх нь хохирогчид учирсан сэтгэл санааны болон бие махбодийн зовлон шаналал нь хэрхэн нотлогдож байгаа, ямар нөхцөл байдалд ямар үйлдэл /эс үйлдэхүй/-ээр учирсан, гэм хор учруулагчийн гэм буруугийн зэрэг, хохирогч ямар сэтгэл санааны болон бие махбодийн зовлон шаналлыг даван туулсан, хэдий хэмжээнд бусад материаллаг хэлбэрээр нөхөн төлбөрийг үнэлж байгаа болон тухайн маргааныг шийдвэрлэхэд хамааралтай бусад нөхцөл байдлыг зайлшгүй нягтлан шалгах ёстой" гэж Дээд шүүхийн бүгд хурлаас тайлбарласан байна.

ОХУ-ын Иргэний хууль болон Дээд Шүүхээс сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлөхөөр тодорхой хэмжээгээр зохицуулалт хийж байгаа боловч бүрэн төгс гэж үзэх боломжгүй юм. Мөн ОХУ-ын хууль тогтоомжид биеийн болон сэтгэл санааны зовлон шаналлын зэрэглэл, шинж чанарын тухай ойлголтыг тодорхой заагаагүй байдаг[699].

ОХУ-ын хууль тогтоомж болон хууль хэрэглэх практикт сэтгэл санааны хохирлыг тогтоох тогтоосон тодорхой шалгуур, нийтлэг арга байхгүй харин түүнийг шүүх өөрийн үзэмжээрээ тодорхойлдог байна.[700]

- *Судлаачдын байр суурь.* Зарим судлаач сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлөх хэмжээг тогтоох аргачлал боловсруулсан байх боловч түүнийг нь шүүхээс хэрэглэн хэрэг маргаан шийдвэрлэсэн тохиолдол байдаггүй байна. Тухайлбал: Судлаач А.М.Эрделевский сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлөх хэмжээг тогтоохдоо дараах томьёог боловсруулан, ашиглахыг санал болгосон байна.

D=d*fv*i*c*/1-fs/

- D-сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлөх бодит хэмжээ;
- d-сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлөх нийт хэмжээ;
- fv-гэм хор учруулагчийн гэм буруугийн зэрэг /энэ тохиолдолд 0≤fv≤1 байна/;
- i-хохирогчийн хувийн онцлогийн коэффицент /үржүүлэгч тоо/ /энэ тохиолдолд 0≤i≤2 байна/;
- c - анхаарал татсан нөхцөл байдлыг тооцоолсон коэффицент /энэ тохиолдолд 0≤c≤2 байна/;
- fs-хохирогчийн гэм буруугийн зэрэг /энэ тохиолдолд 0≤ fs ≤2 байна/[701].

Судлаач дээрх томьёоны d тоог авч үзэхдээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон тухайн гэмт хэрэгт оногдуулах ялын дээд хэмжээтэй холбогдуулан авч үзсэн байна. Жишээлбэл: хүний биед хүнд гэмтэл санаатай учруулах гэмт хэрэгт оногдуулах хамгийн хүнд ял нь 12 жилийн

[698] "Сэтгэл санааны хохирлыг нөхөн төлөх тухай хууль тогтоомжийн хэрэглээний зарим асуудал", ОХУ-ын Дээд шүүхийн бүгд хурлын тогтоол, 1994.12.20, №10

[699] Варпаховская Е.М.Вопросы компенсации морального вреда потерпевшему в российском уголовном судопроизводстве. Иркутск-2004., 143 дахь тал

[700] Дурдсан бүтээл 136 дахь тал

[701] Эрделевский А.М. Моральный вред и компенсация за страдания... 69 дэх тал

хугацаагаар хорих ял бөгөөд энэ тохиолдолд сэтгэл санааны хохирлыг гэмт хэрэг үйлдэгдэх үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 720 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээтэй байхаар тооцсон байна. Энэ хөлс нь иргэний 10 жилийн дундаж цалин хөлстэй тэнцэнэ /судлаач энэхүү хэмжээг татварын хууль тогтоомжтой уялдуулан дундаж хөлс гэж тооцоолон авч үзсэн байна/.[702]

2.2. Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн хүмүүсийн сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг тогтоож, үнэлж, шийдвэрлэж байдал / өнөөгийн практик/

Монгол Улсад

Монгол Улсад хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн хүмүүсийн сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоож, шийдвэрлэж буй өнөөгийн практикийг Нийслэлийн хэмжээнд 2006-2009 онд шийдвэрлэгдсэн 6 хэргийн материалыг судлах замаар авч үзлээ[703].

Судлагдсан 6 хэргийн хувьд хууль бусаар эрх нь зөрчигдсөний улмаас хохирол нэхэмжилсэн нэхэмжлэгчийн 3 нь прокурорын хяналтын шатанд хэрэг нь хэрэгсэхгүй болгогдсон, 2 нь шүүх хэргийг нь цагаатгасан, 1 нь эдлэх ёстой ялаас илүү ял эдэлсэн байв.

Нэхэмжлэгч нар өөрт учирсан ямар төрлийн хохирлыг хэрхэн тооцож нэхэмжилсэн байдлыг судалж үзэхэд:

№	*Нэхэмжлэгчийн эрх зөрчигдсөн байдал*	*Эрх зөрчигдсөн хугацаа, хэрэг нь аль шатанд хэрэгсэхгүй болсон*	*Сэтгэл зүйн хохирол нэхэмжилсэн байдал*	*Шүүх шийдвэрлэсэн байдал*
1.	Хүнийг санаатайгаар алах гэмт хэрэгт хамжигчаар оролцсон хэмээн шалган цагдан хорьж, яллагч ялласан*	-Шалгагдсан – 5 жил -Цагдан хоригдсон – 266 хоног. -Яллагч 25 жилээр ялласан */шүүхийн шатанд хэрэг хэрэгсэхгүй болсон/*	Эдийн бус хохирол 100.000.000 төгрөг /сэтгэл зүйд болон нэр төрд учирсан хохирол/	Сэтгэл санаанд учирсан хохиролд 15.000.000 төгрөг

[702] Варпаховская Е.М.Вопросы компенсации морального вреда потерпевшему в российском уголовном судопроизводстве. Иркутск-2004., 150 дахь тал

[703] Тайлангийн Хавсралтаас судлагдсан хэргийн шийдвэрийг харна уу.

* Л.Хажидмаагийн нэхэмжлэлтэй хэргийг шийдвэрлэсэн Баянзүрх дүүргийн шүүхийн 2007 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 496 тоот шийдвэр.

2.	Албан тушаалын болон бусдын эд хөрөнгийг завших хэрэг үйлдсэн хэмээн шалгаж, цагдан хорьсон*.	-Шалгагдсан – 9 сар - Цагдан хоригдсон – 17 хоног. */мөрдөн байцаалтын шатанд хэрэг хэрэгсэхгүй болсон/.*	Эдийн бус хохирол 100.000.000 төгрөг /сэтгэл зүйд болон нэр төрд учирсан хохирол/	Сэтгэл санаанд учирсан хохиролд 10.006.078 төгрөг
3.	Хүнийг санаатай алах, дээрэмдэх гэмт хэрэг үйлдсэн хэмээн шалгаж, цагдан хорьсон**.	-Шалгагдсан-4 жил 5 сар -Цагдан хоригдсон-1252 хоног -Цаазаар авах ялаар шийтгүүлсэн.	Сэтгэл санаа, эрүүл мэндийн хохирол 50.000.000 төгрөг	Сэтгэл санаанд учирсан хохиролд 20.000.000 төгрөг
		-Шалгагдсан-4 жил 5 сар -Цагдан хоригдсон-1115 хоног -Цаазаар авах ялаар шийтгүүлсэн.	Сэтгэл санаа, бие эрхтний хохирол 39.000.000 төгрөг	Сэтгэл санаанд учирсан хохиролд 17.000.000 төгрөг
		-Шалгагдсан-4 жил 5 сар -Цагдан хоригдсон-315 хоног. */анхан шатны шүүхэд хэрэг нь хэрэгсэхгүй болсон/*	Сэтгэл санаа, бие эрхтний хохирол 20.000.000 төгрөг	Сэтгэл санаанд учирсан хохиролд 6.600.000 төгрөг
		-Шалгагдсан-4 жил 5 сар -Цагдан хоригдсон-201 хоног. */анхан шатны шүүхэд хэрэг нь хэрэгсэхгүй болсон/*	Сэтгэл санаа, бие эрхтний хохирол 15.000.000 төгрөг	Сэтгэл санаанд учирсан хохиролд 5.000.000 төгрөг
		-Шалгагдсан-4 жил 5 сар -207 хоног цагдан хорьж, эрүүдэн шүүж, амь насыг нь хохироосон.	Сэтгэл санааны хохиролд 35.000.000 төгрөг	Хохирогчийн эхийн сэтгэл санаанд учирсан хохиролд 8.000.000 төгрөг

* Н.Энхээгийн нэхэмжлэлтэй хэргийг шийдвэрлэсэн Баянзүрх дүүргийн шүүхийн 2008 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн 700 тоот шийдвэр.

** Хүний эрхийн үндэсний комиссын төлөөлөн нэхэмжлэлтэй /Б.Баатарцогт, Д.Одонтулга, Д.Одонбаяр, Ц.Хүрэлбаатар, Г.Саранцэцэг нарыг төлөөлж/ хэргийг шийдвэрлэсэн Хан-Уул дүүргийн шүүхийн 2006 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 07 тоот шийдвэр.

4.	Шүүхээс оногдуулсан ялаас илүү хугацаагаар хоригдсон буюу хууль бусаар хорих ял эдэлсэн*.	-4 жил 19 хоног хууль бусаар /илүү/ хоригдсон.	Сэтгэл санаа, эрүүл мэндийн хохиролд 60.000.000 төгрөг	Сэтгэл санаанд учирсан хохиролд 5.000.000 төгрөг
5.	Бусдын эд хөрөнгийг завших хэрэг үйлдсэн хэмээн шалгаж, цагдан хорьсон**	-Шалгагдсан -1 жил 4 сар -Цагдан хоригдсон -15 хоног */мөрдөн байцаалтын шатанд хэрэг хэрэгсэхгүй болсон/*	Нэр төр, алдар хүнд, бие эрхтэн, сэтгэл санааны хохиролд 6.000.000 төгрөг	Сэтгэл санаанд учирсан хохиролд 1.000.000 төгрөг
		-Шалгагдсан -1 жил 4 сар */мөрдөн байцаалтын шатанд хэрэг хэрэгсэхгүй болсон/*	Нэр төр, алдар хүнд, бие эрхтэн, сэтгэл санааны хохиролд 9.500.000 төгрөг	Сэтгэл санаанд учирсан хохиролд 1.000.000 төгрөг
		Шалгагдсан -2 жил 1 сар */шүүхийн шатанд хэрэг хэрэгсэхгүй болсон/*	Нэр төр, алдар хүнд, бие эрхтэн сэтгэл санааны хохиролд 6.000.000 төгрөг	Сэтгэл санаанд учирсан хохиролд 300.000 төгрөг
		Шалгагдсан -2 жил 1 сар */шүүхийн шатанд хэрэг хэрэгсэхгүй болсон/*	Нэр төр, алдар хүнд, бие эрхтэн сэтгэл санааны хохиролд 4.500.000 төгрөг	Сэтгэл санаанд учирсан хохиролд 300.000 төгрөг

Дээрх хэргүүдийг шийдвэрлэсэн байдалд дүгнэлт хийхэд шүүх сэтгэл зүйд учирсан хохирлыг шийдвэрлэхдээ хохирлын хэмжээг хэрхэн тооцсон, нэхэмжлэлийн шаардлагын хэмжээг ямар үндэслэлээр багасгаж буюу зарим хэсгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн талаараа хууль зүйн үндэслэл бүхий дүгнэлт хийгээгүйгээс гадна хохирлын хэмжээ болон түүнийг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг хэрхэн тооцсон нь тодорхойгүй байна. Судласан хэргийн хүрээнд шүүхээс хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсаны улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тооцсон байдлыг сэжигтэн, яллагдагчаар тооцож, шалгасан хугацаа болон цагдан хоригдсон хугацаа /хоног/, сонссон болон шийтгүүлсэн ялын төрөл зэрэг / эдгээрийг шалгуур гэж авч үзвэл/-тэй харьцуулж үзэхэд харьцангуй зөрүүтэй байсан бөгөөд хохирогчийн сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг энэхүү шалгуурыг

* Ц.Батзоригийн нэхэмжлэлтэй хэргийг шийдвэрлэсэн Баянгол дүүргийн шүүхийн 2009 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 556 тоот шийдвэр.

** Өмгөөлөгч Ц.Алимаагийн төлөөлөн нэхэмжлэлтэй хэргийг шийдвэрлэсэн Хан-Уул дүүргийн шүүхийн 2009 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн 930 тоот шийдвэр.

цогцоор нь харгалзан дүгнэх боломжгүй тул жишээ болгон эрүүгийн хэрэгт шалгагдсан болон цагдан хоригдсон хугацаанд харьцуулах замаар 1 хоногт тооцогдох нөхөн төлбөрийн хэмжээг тооцож үзлээ.

№	*Шүүхээс сэтгэл зүйд учирсан хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоосон байдал*	*Нэг хоногт тооцогдох нөхөн төлбөрийн хэмжээний тооцоо /төгрөгөөр/*			
		Шалгагдсан Хоногоор	*Нөхөн төлбөрийн хэмжээ*	*Цагдан хоригдсон хоногоор*	*Нөхөн төлбөрийн хэмжээ*
1.	15.000.000 төгрөг	1825	8219	266	56 391
2.	10.006.078 төгрөг	270	37000	17	588 235
3.	20.000.000 төгрөг	1590	12579	1252	15974
4.	17.000.000 төгрөг	1590	10692	1115	15 247
5.	6.600.000 төгрөг	1590	4 150	315	20 952
6.	5.000.000 төгрөг	1590	3 145	201	24876
7.	8.000.000 төгрөг / Амь нас нь хохирсон /	1590	5 031	207	38647
8.	1.000.000 төгрөг	480	2 083	15	66666
9.	1.000.000 төгрөг	480	2 083	-	-
10.	300.000 төгрөг	750	400	-	-
11.	3.000.000 төгрөг	750	400	-	-
12.	5.000.000 төгрөг /Хорих ял илүү эдлэсэн/			1479	3 380

Дээрх хүснэгтээс харахад хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн хүмүүсийн сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг шүүх тодорхой шалгуур, үндэслэлгүйгээр; зөвхөн нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагын хэмжээтэй харьцуулж буюу уг шаардлагын тодорхой хувийг багасгах замаар шийдвэрлэж ирсэн байх бөгөөд эрүүгийн хариуцлагад татагдсан буюу шалгагдсан нэг хоногт тооцогдох нөхөн төлбөрийн хэмжээ 400-37000 төгрөг, цагдан хоригдсон нэг хоногт тооцогдох нөхөн төлбөрийн хэмжээ 3380-588235 төгрөг байна /дээрх хүснэгтийн аргаар харьцуулахад/.

Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн сэтгэл зүйн хохирлын төрөл, хэмжээг тогтоож буй байдлын талаар хуульчдаас ярилцлагын аргаар судалгаа авахад судалгаанд оролцсон хуульчид:

- Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсаны улмаас сэтгэл санааны хохирол нэхэмжилдэг боловч энэхүү хохирлын хэмжээг тогтоох, үнэлэх аргачлал байхгүйгээс хохирлын болон түүнийг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох тодорхой ажиллагаа хийдэггүй;
- Сэтгэл санааны хохирол гэдэгт юуг ойлгох, яаж тодорхойлох талаар онол, практикийн түвшинд тайлбар байхгүйгээс энэ төрлийн хохирлыг шийдвэрлэхэд бэрхшээлтэй байдаг;
- ЭБШХ-д "сэтгэл зүйн хохирлыг нэхэмжлэх" эрхийг хуульчилсан боловч Иргэний хуульд хохирлын хэмжээг хэрхэн тогтоох, үнэлэх арга замыг хуульчлаагүй учир шийдвэрлэхэд төвөгтэй байдаг гэж хариулжээ.

Харин хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан хэмээн хохирол нэхэмжилж, шүүхэд хандсан хохирогчоос ярилцлагын аргаар судалгаа авахад *хохирогчид*:

- Шүүх учирсан сэтгэл зүйн хохирлыг маань бодитой үнэлсэнгүй, хохирол болон нөхөн төлбөрт олгосон мөнгө нь бодитой тогтоогдоогүй. Шоронд хоригдож байх үед ямар хэцүү байсныг бодолцон нөхөн төлбөрийг тогтоох шаардлагатай;
- Сэтгэл зүйн хохирлыг харилцан адилгүй байдлаар буюу заримыг нь өндөр, заримыг нь багаар тогтоодог юм байна лээ. Яагаад ингэж шийдвэрлэдэг нь ойлгомжгүй;
- Сэтгэл зүйд учирсан хохирлыг хэмжих, тогтоох эрх зүйн боломж байдаггүй нь туйлын учир дутагдалтай байна гэж хариулсан юм.

Судалгаанаас шүүх хохирсон хүмүүсийн сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг харгалзан үзэх боломжтой, бодитой, тодорхой үзүүлэлтийг харгалзан үздэггүй, ийнхүү тооцож үзэх эрх зүйн зохицуулалт, арга, аргачлал байхгүйн улмаас тухайн хэргийг ийнхүү харилцан адилгүй байдлаар шийдвэрлэж байна гэх дүгнэлтэд хүрлээ.

1.1.1. Гадаадын зарим улсад

Монгол Улсад хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсний улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн төлүүлэх тухай эрх зүйн зохицуулалт байгаа боловч уг ажиллагааны улмаас учирсан хохирлын хэмжээг тогтоох, тооцох талаар тусгайлсан зохицуулалт байхгүй учраас гадаад улсын энэ талаарх туршлага, олон улсын чиг хандлагыг судалсан юм[704]. Үүнд:

Англи

Дээр дурдсан судалгаанаас харахад Англид хууль бусаар хоригдсон хүнд олгох эдийн бус гэм хорын нөхөн төлбөрийн хэмжээ 13 000-14 000 паунд байна. Эрүүгийн хэрэгт үндэслэлгүй татагдаж 25 жил хоригдсон цэрэгт 350 000 паунд олгож байсан бөгөөд энэ нь жилд дунджаар 14 000 паунд болж байгаа юм[705].

- 1973 онд Анди Эванс хэмээх 17 настай цэрэг хуарангийн хажууханд байрладаг сургуулийн сурагч Жудит Робертс гэх охины амийг хөнөөсөн хэрэгт шийтгэгдэж, 25 жилийн хорих ял эдэлсний дараа цагаатгагдсан байна. 2000 онд түүнд олгох нөхөн төлбөрийг үнэлгээчин 945000 паундаар тогтоосон бөгөөд түүний 356000 паунд нь эдийн бус гэм хорын нөхөн төлбөрт, 35000 паунд нь хохирогч амьдралынхаа үлдсэн хугацаанд санхүүгийн зөвлөх ажиллуулах төлбөрт зориулагдсан байв.
- 1990 оны 10 дугаар сард Матрикс Черчил фирмийн 2 захирлыг Ирак дахь цэргийн ажиллагаатай холбогдуулан баривчилсан бөгөөд тэр өдрөөс хойш 2 жилийн дараа сулласан байна. Энэ хугацаанд баривчлагдсан этгээдүүдийн бизнесийн нэр хүнд унаснаас үйл ажиллагаа нь бүрэн

[704] Minnesota law review, 2007.

[705] http://www.aic.gov.au/publications/current%20series/tandi/341-360/tandi356/view%20paper.aspx

зогсонги байдалд оржээ. Эрүүгийн хэрэгт үндэслэлгүй татагдаж, цагдан хоригдсоныхоо нөхөн төлбөрт тэд 4 сая паунд гаргуулжээ.

Нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо хуулийн дагуу олгох нөхөн төлбөр эсвэл ex gratia[706] нөхөн төлбөр гэдгээс нь үл хамааран иргэний эрх зүй дэх гэм хорын үнэлгээтэй адилхан арга хэрэглэнэ. .

- Карл Брижвотерийг хөнөөсөн хэрэгт хилсээр шийтгэгдсэн Винсент Хикэй болон Майкл Хикэй нарт олгох нөхөн төлбөрийг үнэлэхдээ ***"амжиргааны хэмнэгдсэн зардал"*** гэсэн ойлголтыг харгалзан үзсэн байна. Энэ нь хохирогч хоригдож байх хугацаандаа амьжиргааны ямар нэгэн зардал гаргах шаардлага гараагүй учраас хоригдоогүй бол зайлшгүй гарах байсан зардлаа хэмнэсэн гэсэн үг юм.

Нөхөн төлбөрийн үнэлгээнд ийнхүү амжиргааны хэмнэгдсэн зардлыг харгалзан үзсэнээр олон эсэргүүцэлтэй тулгарсан байна. Ноён Хилл хилсээр 16 жил хорих ял эдэлсэн бөгөөд түүний нөхөн төлбөрөөс 50 000 паундыг хэмнэсэн амжиргааны зардалд хасуулжээ. Тэрээр үүнийг эсэргүүцэн "хоригдож байхдаа идсэн хоол, унтаж байсан өрөөний төлбөрийг надаас авч байгаа нь намайг анхнаасаа хилсээр энэ хэрэгт холбогдуулан хорьсонтой дүйцэхүйц шударга бус явдал. Намайг шоронд хоригдож байх хугацаанд миний гэр бүл орон байраа алдсан боловч тэдэнд ямар нэгэн нөхөн төлбөр олгоогүй. Гэсэн ч, төр өөрийн мөнгөө буцаан авахыг санаархаж байна. Ингэснээрээ аль хэдий нь үхлүүт болтлоо зодуулаад байгаа хүний толгой руу нэмж өшиглөж байгаатай адил хэрэг болж байна" гэжээ.

Австрали

- 4 жил хилс ял эдэлсэн Линди Чамберли 1.3 сая долларын ex gratia нөхөн төлбөр, 366000 доллар хууль зүйн туслалцаа авсаны төлбөрт гаргуулсан байна.
- 2000 онд хилс хэрэгт 16 жил хорих ялаар шийтгүүлсэн 3 холбогдогч 7 жил хоригдсоныхоо эцэст цагаадан хүн нэг бүр 100 000 долларын "ex gratia" нөхөн төлбөр авсан.
- Эхнэрээ алсан хэрэгт ял шийтгүүлэн 8 жил хорих ял эдэлсэн Доглас Рендел 100 000 долларын ex gratia нөхөн төлбөр авсан.

Польш

- Польш Улсын Краков хотын давж заалдах шатны шүүхийн 2008 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн шийдвэрийг судалж үзэхэд шүүх нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо харгалзан үзвэл зохих нөхцөл байдлын талаар дараах дүгнэлтийг хийжээ. Үүнд:

1. Хилсээр хоригдсон хугацаа;
2. Тухайн ялыг эдэлж байхад амссан шаналал;
3. Байгалиас заяагдсан хувь хүний ёс зүйг зөрчсөн хэлбэр /сэтгэлийн зовиур, нөр төрөө алдах гэх мэт/;
4. Хилсээр ял эдлэх явцад албадлага дор байсан байдал;
5. Тухайн орчны онцгой нөлөөлөл;

[706] Compensation payments are often made ex gratia when a government or organisation is prepared to compensate victims of an event such as an accident or similar, but not to admit liability to pay compensation, or for causing the event.

6. Суллагдсаны дараах байдал зэрэг багтана.

Нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо аль аль талыг нь харсан ултай суурьтай, тухайн нийгмийн бодит нөхцөлтэй харьцуулсан, иргэдийн амьжиргааны өртөг, мөнгөний үнэ цэнэ зэргийг бодолцон тогтоох нь зүйтэй бөгөөд хамгийн гол нь хохирогчийн сэтгэл санааны хохирлыг арилгах, нөгөөтэйгүүр тухайн шүүхийн шийдвэр нь эргэзд хохирогчид ямар нэгэн байдлаар ашиг олох арга хэрэгсэл болохгүй байх нь чухал гэж үзжээ[707].

- А.Петрт 33 сарын турш хилсээр цагдан хоригдсоны төлөө 144 мянган злотын нөхөн төлбөр олгохоор шийдвэрлэсэн /3 злот=1 ам.доллар/ анхан шатны шүүх 24 мянган злотыг эдийн хохиролд, 120 мянган злотыг эдийн бус хохиролд тооцож шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн шийдвэрийг Польш Улсын Дээд шүүхээс хэвээр үлдээн шийдвэрлэсэн байна. А.Петр нь төрсөн эхийгээ алуулахаар Якубов гэгч этгээдэд захиалга өгсөн тухай 2001 оны 11 сард Прокуороос яллах дүгнэлт гаргасан. Тухайн дүгнэлтийг гаргахдаа Петрын эх түүнд мэдэгдэлгүйгээр хувийн байшинг нь зарж, зарсан мөнгийг хуваалцаагүйн улмаас тухайн гэмт хэргийг үйлдсэн гэж үзжээ.Анхан шатны шүүхээс Петрыг бусдыг захиалгаар алахыг завдсан хэрэгт 4 жилийн хорих ял оногдуулсан байна. Улсын Дээд шүүх Петрийн гомдлоор хэргийг хянаж, тус шүүхийн тогтоолыг хүчингүй болгон, Петрт холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосон. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны дээрх процесс нийтдээ 33 сарын турш үргэлжилсэн ба энэ хугацаанд А.Петр цагдан хоригдож байсан байна[708].

2.3. Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн хүмүүсийн сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг тогтоох шалгуур, боломж, нөхөн төлөх мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох асуудал

Хуулийн үндэслэлгүй татагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн хүмүүсийн сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг тогтоохын тулд түүнд харгалзах үзүүлэлт буюу шалгуур, боломж, мөн мөнгөн төлбөр төлөх төлбөрийн хэмжээг хэрхэн тогтоох асуудлыг олон улсын чиг хандлага, туршлагатай харьцуулан авч үзэх шаардлагатай юм:

1. Сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг тогтооход харгалзах үзүүлэлт. Судлагдсан хэргийн хүрээнд авч үзэхэд сэтгэл зүйн хохирлын хэмжээ, нөхөн төлөх мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо ямар үзүүлэлт, нөхцөл байдлыг харгалзан, хэрхэн тооцсон нь тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл, шүүх ямар хэмжээний хохирол учирсан болох, нөхөн төлбөрийн хэмжээг юуг үндэслэн, хэрхэн тогтоосон талаар хууль зүйн үндэслэлтэй, бодитой дүгнэлт тусгайлан хийгээгүй байна. Ийм учраас эхний ээлжинд хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн хүмүүсийн сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг тогтоохын тулд дараах үзүүлэлтийг зайлшгүй харгалзан үзвэл зохино. Үүнд:

[707] http://www.zielona-gora.po.gov.pl/index.php?id=27&idk=2&idp=1521

[708] http://prawo.gazetaprawna.pl/artykuly/30893,sn_utrzymal_odszkodowanie_za_niesluszny_areszt.html

а/ Гэмт хэрэгт шалгагдсан хугацаа;
б/ Баривчлагдсан, цагдан хоригдсон хугацаа;
в/ Сэрдэгдэн шалгагдсан гэмт хэргийн ангилал;
г/ Гэмт хэрэгт шалгагдах хугацаанд эрүүдэн шүүлтэд өртсөн эсэх;
д/ Хэргийг хэрэгсэхгүй болгосон шат;
е/ Хилсээр шийтгүүлсэн ялын төрөл;
ж/ Хилсээр шийтгүүлсэн тоо;
з/ Хилсээр ял эдэлсэн хугацаа;
л/ Хилс ял эдэлсэн дэглэм;
м/ Эрүүл мэндэд нь нөлөөлсөн байдал;
н/ Ажил хэрэг, хувийн амьдралд нь нөлөөлсөн байдал.

Дээрх нөхцөл байдал, үзүүлэлт нэг бүрт тодорхой үнэлэлт өгсний эцэст сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг зэрэглэх замаар тогтоох боломжтой бөгөөд ийнхүү тогтоох нь хохирогчийн сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг тал талаас нь бүрэн бодитой тогтоох ач холбогдолтой юм.

2. Сэтгэлзүйд учирсан хохирлын хэмжээг тогтоох боломж. Судалгааны үр дүнд хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн хүмүүсийн сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг бодитой тогтоох дараах арга, аргачлал, боломж байж болох юм. Үүнд:

- Дээр дурдсан харгалзах үзүүлэлт тус бүрт үнэлэлт өгөх замаар хохирлын хэмжээг зэрэглэн тогтоох;
- Хохирогчийн сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг мэргэшлийн шинжээч томилох замаар тогтоох;
- Сэжиглэгдэн шалгагдсан гэмт хэргийн ангиллаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг харгалзан тарифлах замаар сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг тогтоох.

Дээрх боломжийг нэг бүрчлэн авч үзэхэд сэтгэл зүйн хохирлын хэмжээг тогтооход харгалзах үзүүлэлт бүрт үнэлэлт өгөх замаар сэтгэл зүйн хохирлын хэмжээг тогтоох нь илүү бодитой байх магадлалтай. Учир нь энэхүү харгалзах үзүүлэлтийг баримтлан хохирлын хэмжээг тогтоохын ач холбогдол нь хууль бус ажиллагагааны улмаас учирсан сэтгэл зүй, бие махбод, эрүүл мэнд зэрэгт зайлшгүй нөлөөлөхүйц үзүүлэлтийг зөв тогтоон үнэлэлт өгснөөр сэтгэл зүйн хохирлын хэмжээ олон талаасаа, бодитой тогтоогдох боломжтой юм.

Харин хохирогчийн сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг мэргэшлийн шинжээч томилон Олон улсын 10 дугаар ангилалыг[709] баримтлан тогтоолгох нь нэг талаас илүү шинжлэх ухааны үндэслэлтэй, бодитой тогтоогдох боломжтой юм. Энэ ангиллыг баримтлан хуулийн хариуцлагад үндэслэлгүйгээр татагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсний улмаас үүссэн сэтгэл гутралын зэргийг бие болон сэтгэл зүйд үүссэн эмгэг өөрчлөлтийг үндэслэн тогтоох боломжтой боловч энэ нь тухайн хүний онцлог гэх мэт хүчин зүйлээс шалтгаалан харилцан

[709] Өвчний олон улсын ангилал. Нэгдүгээр боть. ДЭМБ. Женев хот. 224-237 дахь тал.

адилгүй тогтоогдох боломжтой тул энэхүү судалгааны сэдвийн хүрээн дэх сэтгэл зүйн хохирлын хэмжээг тогтооход учир дутагдалтай байж болно.

Хуулийн хариуцлагад үндэслэлгүйгээр татагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсний улмаас үүссэн сэтгэл зүйн хохирлын хэмжээг хохирогчийн сэжиглэгдсэн, шалгагдсан, шийтгүүлсэн гэмт хэргийн зүйлчлэл буюу хэргийн төрлөөр авч үзэн хэргийн төрөл бүрт хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тодорхой хувиар нэмэгдүүлэх замаар тогтоож болох боловч энэ нь хохиролд харгалзах үзүүлэлт нэг бүрийг хамрахгүйгээс гадна автомат байдлаар тогтоогдох, мөн хохирлын хэмжээ, түүнийг төлөх нөхөн төлбөрийн хэмжээг нэг мөр байдлаар тогтоох /эдгээр нь хууль зүйн хувьд ялгаатай ойлголт/ сөрөг үр дагаврыг бий болгож болзошгүй юм.

Ийм учраас судлаачид сэтгэл зүйн хохирлын хэмжээг тогтоох хамгийн боломжтой арга нь "хохирогчид нөлөөлөхүйц нөхцөл байдал, үзүүлэлтийг маш зөв тогтоохын зэрэгцээ харгалзах үзүүлэлт тус бүрт үнэлэлт өгөх замаар хохирлын хэмжээг зэрэглэн тогтоох" гэж үзсэн болно.

3. Сэтгэл зүйд учирсан хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох. Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсний улмаас учирсан сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох аргачлалын хувьд судлаачид дараах саналыг онолын хувьд дэвшүүлж байгаа ажээ. Үүнд:

1/ Жирийн хүн тухайн төрлийн хохирлоос зайлсхийхийн тулд хэдэн төгрөг төлөхөд бэлэн байна вэ гэдгийг судалгаагаар гарган нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох[710].

2/ Хохирогчийн сэтгэл зүйн байдлыг засахын тулд түүнд сэтгэлийн таашаал өгч чадах зүйлийг худалдан авах хэмжээгээр тогтоох[711].

3/ Хоригдсон 1 жилд тооцогдох мөнгөний үнийн дүнг тогтоож нийт хоригдсон жилээр үржүүлэх замаар хохирлын хэмжээг тогтоох[712].

4/ Тусгайлсан хууль гаргах замаар олгож болох нөхөн төлбөрийн дээд, доод хэмжээг тогтоох.

5/ Сэтгэл зүйд учирсан хохирол нь объектив байдлаар үнэлэгдэх боломжгүй учраас энэ талаар мэргэшсэн үнэлгээчнийг томилон нөхөн төлбөрийн хэмжээг тухайн тохиолдол /хэрэг/ тус бүр дээр тогтоох.

6/ Шүүхээр шийдвэрлэгдэж байгаа ижил төсөөтэй хэргүүдийг судлан нийтлэг жишгийг хэргийн төрөл бүрээр гаргах замаар сэтгэл зүйн хохирлын хэмжээг тогтоох.

Дээрх байдлаар сэтгэл зүйд учирсан хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтооно гэж үзвэл энэ нь тухайн хохирсон этгээдийн амьдралын түвшин буюу санхүүгийн чадавхиас хамааран харилцан адилгүй байдлаар тогтоогдох боломжтой тул хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсний улмаас сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг зэрэглэх байдал /I-IY/-аар

[710] Remedies in international human rights law /second edition/, Dinah Shelton, 2005, p-343

[711] Andrew J.Oswald and Nattavudh Powdthavee, Death, Happiness, and the Calculation of Compensatory Damages, 2007. Germany, p-1.

[712] http://www.aic.gov.au/publications/current%20series/tandi/341-360/tandi/view%20 paper.aspx.

тогтоосноор тухайн зэрэглэл бүрт харгалзуулан, сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг хедөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан тогтоох нь илүү боломжтой болох юм.

Дүгнэлт

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1-д заасанчлан төр нь хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцах үүргийнхээ дагуу хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсний улмаас хохирол хүлээсэн этгээдийн эрхийг хэрхэн хангаж буйг судалсны үндсэн дээр дараах дүгнэлтийг хийв.

Эрх зүйн зохицуулалтын хувьд:

1. Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн хүмүүс хууль бус дээрх ажиллагааны улмаас өөрийн сэтгэл зүйд учирсан хохирлыг арилгуулах эрх нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсгийн "...бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх...эрхтэй" гэсэн заалтад тусгалаа олжээ.

Үндсэн хуулийн энэхүү хэм хэмжээг иш үндэс болгон эдүгээ хүчин төгөлдөр үйлчилж буй ЭБШХ, Иргэний хууль, холбогдох бусад хууль хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн хүмүүсийн сэтгэл зүйд учирсан хохирлыг арилгуулах эрхийг улам баталгаажуулж, гомдлын нэхэмжлэл гаргах, түүнийг хянан шийдвэрлэх журам байхаар заажээ.

2. "Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор тухай хууль" -ийг эс тооцвол 2002 онд ЭБШ хуулийн шинэчилсэн найруулгыг мөрдөх хүртэл Монгол Улсад "сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлүүлэх" практик байгаагүй гэж үзэж болохоор байна.

3. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ /судалгаанд хамрагдсан/-нд хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсаны улмаас учирсан сэтгэл зүйн хохирлын хэмжээг болон уг хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох журмын тухай тусгайлан зохицуулаагүй байна/ гэхдээ "... шударга, хангалттай" гэж тодорхойлсон бий/.

4. ЭБШХ болон холбогдох бусад хуульд "сэтгэл зүйд учирсан хохирлыг арилгуулах"-тай холбоотой олон асуудал, түүний дотор учирсан хохирлын хэмжээг ямар аргачлалаар, яаж тогтоох, нөхөн төлбөрийн хэмжээг хэрхэн тодорхойлох зэрэг асуудал хууль зүйн зохицуулалтын хувьд хангалттай зохицуулагдаагүй байна.

5. Энэ нь гэмт хэрэгт хилсээр мөшгөгдөж, бие махбодь, эд хөрөнгө, сэтгэл санааны хувьд хохирол амссан иргэн төрийн эрх бүхий байгууллагаас нэхэмжилж хохирлоо арилгуулах эрхээ хэрэгжүүлэх боломж нь урьдын адил хязгаарлагдмал хэвээр байна гэсэн дүгнэлт хийхэд хүргэж байна. Түүнчлэн хуулийн хэм хэмжээг шүүхийн үйл ажиллагаанд харилцан адилгүй байдлаар хэрэглэж байгаа нь Үндсэн хуулиар бататгасан "хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим"-ыг алдагдуулж байна гэж дүгнэх үндэслэлтэй юм.

Судалгаагаар байцаан шийтгэх ажиллагааны явцад гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ болон түүнийг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох аргачлал, журам байдаггүй, эрх зүйн зохицуулалт нь боловсронгуй биш учраас хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтүүлсэн, эдэлсний улмаас учирсан хохирлын болон түүнийг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох ажиллагаа бэрхшээлтэй, шийдвэрлэхэд төвөгтэй атлаа тулгамдсан асуудлын нэг болох нь тодорхойлогдсон.

Иймээс хуулийн хариуцлагад үндэслэлгүйгээр татагдсанаас сэтгэл зүйд учирсан хохирлыг тодорхойлох, нөхөн төлбөр төлөх замаар учирсан хохирлыг арилгаж зөрчигдсөн эрхийг сэргээхэд зориуд анхаарал хандуулж, энэ талаар шийдвэртэй арга хэмжээ авах нь Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрхийг бодитой эдлүүлэх баталгааг хангахад нэн чухал байна. Өнөөдөр хохирлын хэмжээг тогтоох, үнэлэх аргачлал байхгүй байгаа нь иргэнийхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхэд төр хайнга хандаж байгаагийн илрэл бөгөөд хүний эрхийн эрх зүйн баталгааг хэлбэрээс агуулгад шилжүүлэх шаардлагатай байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Шүүхийн практик судалгаанаас харахад хохирсон этгээд-нэхэмжлэгчийн сэтгэл зүйн хохирлыг мөнгөн хэлбэрээр арилгуулахаар гаргасан нэхэмжлэлийн ихэнхийг нь хэрэгсэхгүй болгох, нэхэмжлэлийн шаардлагын хэмжээг эрс багасгах гэх мэтээр шийдвэрлэдэг ажээ.

ЭБШХ, Иргэний хууль болон бусад хууль тогтоомжид эдийн шинжтэй буюу эд хөрөнгийн бодит хохирлыг нөхөн төлүүлэх журмыг илүүтэй зохицуулж, хохирсон амь нас, эрүүл мэндэд учирсан гэмтэл согог, хүний сэтгэл зүйд учруулсан шаналал зовиур зэргийг үнэлэх асуудлыг орхигдуулж, учирсан дээрх хохирлын хэмжээг тодорхойлоход чиглэсэн зохицуулалт үндсэндээ байхгүй байна. Энэ талаар бусад улсын хууль тогтоомжид төгс зохицуулалт байхгүй болох нь судалгааны явцадхарагдсан боловч улс бүрт өөр өөрийн онцлогийг харуулсан хуулийн зохицуулалт үйлчилж, шүүхүүд нь илүү санаачлагатай, илүү бүтээлчээр асуудалд ханддаг байдал ажиглагдаж байна.

Судалгааны явцад хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтүүлсэн, эдэлсний улмаас сэтгэл зүйд учирсан хохирол, түүнийг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг хуулиар тогтоох, хохирсон этгээдийн санхүүгийн чадвар, чадавхийнх нь байдлыг харгалзан хохирол, нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох, мөн жишиг үнэлгээг нэг тарифаар тогтоох гэх мэт нэлээд санал дэвшүүлсэн байдаг боловч судлагдаж буй сэдвийн хүрээнд авч үзэхэд дурдсан аргаар хохирол, нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох нь учир дутагдалтай, харин сэтгэл зүйд учирсан хохирлыг тооцох харгалзах үзүүлэлтийг үндэслэлтэй тогтоон, түүнийг баримтлан хохирол, нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох нь зүйтэй юм гэх дүгнэлтийг хийж, энэ талаар тодорхой санал боловсруулллаа.

Санал

Судалгааны удирдамжид заасанчлан судалгааны үр дүнд хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн иргэнд учирсан сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох, энэ чиглэлээр холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал энэхүү судалгааны гол зорилго байлаа.

Судалгааны үр дүнгээс харахад хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсаны улмаас иргэнд учирсан сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох ажиллагааг *нэгдүгээрт,* сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээ тогтоох, *хоёрдугаарт,* сэтгэл зүйд учирсан хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох гэсэн үндсэн хоёр шаттайгаар гүйцэтгэх нь илүү бодитой болно гэж үзэж, дурдсан чиглэлээр санал боловсруулаа. Өөрөөр хэлбэл, дор дурдсан чиглэлээр санал боловсруулсан болно.

1. Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн иргэний сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг тогтоох;

2. Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн иргэний сэтгэл зүйд учирсан хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох.

Нэг. Сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг тогтоохдоо уг хохиролд хамаарах буюу харгалзах бүх үзүүлэлтийг шинж чанараар нь нарийвчлан тогтоож, тэдгээрийг нэг бүрчлэн үнэлэх замаар сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг тогтоох, улмаар уг хэмжээг зэрэглэх нь хохирлыг бодитой, мөн хохирогчийн хохирсон байдалд нь нийцэхүйц байдлаар тодорхойлох хамгийн боломжтой арга зам гэж үзсэний үндсэн дээр дараахь үзүүлэлтийг гаргалаа. Үүнд:

- Сэтгэл зүйн хохирлыг тодорхойлоход харгалзах үзүүлэлтийг уг хохиролд нөлөөлж болохуйц үзүүлэлтийг ерөнхийгөөс нарийвчилсан үзүүлэлтээр тодорхойлов. Энэхүү үзүүлэлтийг судлагдсан хэргийн материал, шийдвэр /2006-2008 онд шийдвэрлэгдсэн/-ийг харьцуулан, тэдгээрт дүн шинжилгээ хийх замаар гаргасан болно.

- Уг үзүүлэлт бүрт харгалзах үнэлгээг дараах аргачлалаар тогтоолоо:

- Хилсээр эдэлсэн ялын дээд хэмжээнд харгалзах "үнэлгээ буюу тоо"-гэхчлэн оноов.

- Дээрх "үнэлгээ буюу тоо"-той жиших замаар бусад үзүүлэлтэд харгалзах үнэлгээг "харгалзах үзүүлэлт бүрийн сэтгэл зүйд үзүүлэх нөлөөлөл"-ийг харгалзан гаргав.

- Дээрх байдлаар тогтоосон үнэлгээний дүнг харгалзан сэтгэл зүйн хохирлын хэмжээг зэрэглэн тогтоох аргачлалын талаарх саналыг дараах хүснэгт хэлбэрээр боловсруулаа.

Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн ирэгний сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээ /зэрэглэл/-г тогтоох аргачлал /Хүснэгт-1/

№	Хохирлыг тооцоход харгалзах үзүүлэлт		Үнэлгээ	Дүн
	Ерөнхий	Нарийвчилсан		
1.	Шалгагдсан хугацаа*	1 хоног	1	
2.	Баривчлагдсан буюу цагдан хоригдсон хугацаа	1 хоног	4	
3.	Холбогдон шалгагдсан гэмт хэргийн ангилал	Онц хүнд гэмт хэрэг	2000	
		Хүнд гэмт хэрэг	1500	
		Хүндэвтэр гэмт хэрэг	1000	
		Хөнгөн гэмт хэрэг	500	
4.	Эрүүдэн шүүлт хэрэглэсэн байдал	Эмнэлгийн эрүү шүүлт**	700	
		Бие махбодийн эрүү шүүлт***	600	
		Сэтгэл санааны эрүү шүүлт****	500	
5.	Хэргийг хэрэгсэхгүй болгосон шат	Хяналтын шатны шүүх	700	
		Давж заалдах шатны шүүх	600	
		Анхан шатны шүүх	500	
		Прокурорын хяналт	300	
		Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт	200	
6.	Оногдуулсан ялын төрөл	Цаазаар авах ял	700	
		10-25 жил хорих ял	500	
		5-10 жил хорих ял	400	
		1-5 жил хорих ял	300	
		Хорихоос өөр төрлийн ял	200	
7.	Ял шийтгүүлсэн тоо /хэдэн удаа ял шийтгүүлсэн болох/	5-с дээш удаа	300	
		3-5 удаа	200	
		1-3 удаа	100	

* Хэрэгт сэжигтнээр татагдсанаас эхлэн цагаатгах буюу хэргийг хэрэгсэхгүй болгох тухай шийдвэр гарах хүртэлх нийт хугацаа хамарна.

** Эмнэлгийн эрүү шүүлт гэдэг нь сэтгэцэд нөлөөлөх эм тариа болон сэтгэцэд нөлөөлөх эм тариа болон эсвэл химийн бодис ашиглан шаналгах, өөрөөс нь зөвшөөрөл авахгүйгээр шинжлэх ухаан болон эмнэлгийн олон янзын туршилтад хамруулах, мөн дотор эрхтнийг гэмтээх зорилгоор зарим төрлийн химийн бодис, бусад зүйлийг хүчээр болон албан шахалтаар уулгах гэх мэтийг хамруулсан ойлголт юм. Хүний эрх ба эрүү шүүлт. П.Оюунчимэг. 2009 он. 104 дэх тал.

*** Бие мах бодийн эрүү шүүлт нь зодох, түлэх, оглох, өлсгөх гэх мэтээр хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг чиглэсэн үйлдлээр илэрнэ. Хүний эрх ба эрүү шүүлт. П.Оюунчимэг. 2009 он. 103-104 дэх тал.

**** Сэтгэл санааны эрүү шүүлт нь хүний сэтгэл зүйд нөлөөлөх дарамт, зовлон шаналалыг учруулах хэлбэрээр хийгддэг бөгөөд энэ нь бие махбодийн хүчирхийлэлтэй адилхан ил байдагтүй. Хүний эрх ба эрүү шүүлт. П.Оюунчимэг. 2009 он. 104 дэх тал.

8.	Хилсээр эдэлсэн ял /ял эдэлсэн дэглэм, хоногоор/	Цаазаар авах ялыг гүйцэтгэсэн	90000	
		Гянданд /1 хоног/	10	
		Онцгой дэглэмтэй хорих ангид /1 хоног/	18	
		Чанга дэглэмтэй хорих ангид /1 хоног нь/	6	
		Жирийн дэглэмтэй хорих ангид /1 хоног/	4	
		Баривчлах ял /1 хоног/	2	
		Албадан ажил хийлгэх ял /1 цаг/	0,2	
9.	Эрүүл мэндэд нөлөөлсөн байдал	Үхэлд шууд хүргэх өвчин	60000	
		Үхэлд шууд хүргэхгүй боловч эдгэрэлт удаан /1 жилээс дээш/-тай өвчин	20000	
		Удаан хугацаанд шаналал үүсгэх өвчин /1-12 сар/	5 000	
		Хурдан эдгэрэх хөнгөн өвчин /1сараас бага/	1000	
Сэтгэл зүйн хохиролд харгалзах үзүүлэлтийн үнэлгээний дүн				

Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн иргэний сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээ /зэрэглэл/-г тогтоох аргачлал /Хүснэгт-2/

Сэтгэл зүйн хохирлын зэрэглэл /хэмжээ/	Сэтгэл зүйн хохиролд харгалзах үзүүлэлтийн үнэлгээний дүн
I	705-10 000
II	10 001-25 000
III	25 001-40 000
IY	40 000-с дээш

Ийнхүү судалгааны үр дүнд үндэслэн хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, баривчлагдсан,цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн иргэний сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээг хөнгөнөөс хүнд рүү зэрэглэх хэлбэрээр I-IY зэрэгт ангилан тогтоох аргачлалын саналыг боловсруулаа.

<u>Хоёр.</u> Сэтгэл санааны учирсан хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг сэтгэл санааны хохирлын зэрэглэл буюу хэмжээнд үндэслэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тодорхой хувиар нэмэгдүүлэх замаар тогтоосон бөгөөд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэх хэмжээг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 17 дугаар зүйлд заасан торгох ялын дээд, доод хэмжээтэй уялдуулсан болно. Өөрөөр хэлбэл, сэтгэл зүйд учирсан

хохирлыг нөхөн төлөх төлбөрийн доод хэмжээг торгох ялын доод хэмжээ буюу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, дээд хэмжээг мөн торгох ялын дээд хэмжээ буюу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус тогтоосон болно.

Сэтгэл санаанд учирсан хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг ийнхүү хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон торгох ялын доод, дээд хэмжээтэй уялдуулан тогтоосон нь нөхөн төлбөрийн хэмжээг хэт их буюу хэт бага тогтоохгүй байх, тухайн цаг үеийн эдийн засгийн нөхцөл байдал, мөнгөний ханшид нийцсэн, бодитой байх баталгааг хангах ач холбогдлыг харгалзан үзсэн юм.

Дээр дурдсаныг үндэслэн сэтгэл санаанд учирсан хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг дараах хүснэгтийн аргаар тодорхойлов.

Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн иргэний сэтгэл зүйд учирсан хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох аргачлал

/Хүснэгт-3/

Сэтгэл зүйн хохирлын зэрэглэл /хэмжээ/	Сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээ /хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэх хэмжээгээр/
I	5-80
II	81-150
III	151-300
IY	301-500

Дээрх аргачлалаар хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, баривчлагдсан,цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн иргэний сэтгэл зүйд учирсан хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг дээрх хүснэгтийн аргаар тооцож үзэхэд 540000-54000000 төгрөг болж байгаа юм.

Судалгааны явцад уншиж судласан хэргийн хүрээнд нэхэмжлэгчдийн сэтгэл зүйд учирсан хохирлын хэмжээ, түүнийг нөхөн төлөх төлбөрийн хэмжээг дээрх аргачлалаар тооцож үзэхэд нэлээд бодитой дүн гарч байсныг тэмдэглэж байна.

Иймд судалгааны үр дүнд боловсруулсан аргачлалыг туршиж, түүнийг улам бүр боловсронгуй болгон, улмаар зохих эрх бүхий байгууллага, албан тушаалтнаар батлуулж мөрдүүлэхийн зэрэгцээ ЭрЮЮгийн байцаан шийтгэх хуулийн 391 дүгээр зүйлийн заалтыг хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн иргэний сэтгэл санаанд учирсан хохирлын хэмжээг тогтооход харгалзах үзүүлэлт, түүнийг үнэлэх, нөхөн төлбөрийн хэмжээг хэрхэн тооцох асуудлыг журамласан зохицуулалтыг нэмэх замаар боловсронгуй болгох шаардлагатай гэж үзлээ.

—oOo—

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГАД ҮЙЛДЭГДЭЖ БАЙГАА ОНЦ ХҮНД ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН, НӨХЦӨЛ

Судалгааны зорилго: Монгол Улсын Хил хамгаалах байгууллагад гарч буй гэмт явдал, түүний дотор хүнд, онц хүнд гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судлан дүгнэж, офицер, ахлагч, цэргийн хугацаат албан хаагчийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хилийн отряд, заставт зохион байгуулах талаар санал, зөвлөмж, богино, дунд хугацааны хөтөлбөр боловсруулах

Судалгааны хамрах хүрээ: Судалгааны ажлыг хил хамгаалах байгууллагын хэмжээнд сүүлийн 10 жилд гарсан хүнд, онц хүнд гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг цэргийн болон харуулын алба хаахтай холбогдсон дүрэм, бусад журмын биелэлтийн байдалтай уялдуулан авч үзэв.

Судалгааны хугацаа, зохион байгуулалт: Судалгааны баримт материалыг цуглуулах, шинжлэн судлах, хил хамгаалах байгууллагын анхан шатны нэгжид очиж хилийн алба хаагчидтай уулзаж ярилцах зэрэг судалгааны үндсэн ажлыг 2010 оны 1 дүгээр сарын 18-наас 4 дүгээр сарын 10-ны өдөр хүртэлх хугацаанд хийв. Удирдамжид заасан зарим ажил, тухайлбал: хүнд, онц хүнд гэмт хэргийг шалгаж шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн материалыг Улсын Ерөнхий прокурорын архиваас авч судлах зэрэг ажил судалгааны багаас үл хамаарах шалтгаанаар төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэх боломжгүй байв.[713]

Судалгааны баг: ХЗҮХ-ийн Эрүүгийн эрх зүй, криминологийн секторын эрхлэгч Ж.Энхнасан удирдаж, эрдэм шинжилгээний ажилтан Г.Оюунболд /докторант/, Г.Батчимэг, Хил хамгаалах ерөнхий газрын Улсын хил судлалын секторын судлаач, хошууч Н.Даваадорж нар хийж гүйцэтгэв.

Нэг.Монгол Улс дахь гэмт явдлын өнөөгийн байдал /товч мэдээлэл/

Монгол Улсад сүүлийн 10 жилд хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг тогтмол өсч, нийт хэрэгт эзлэх хувийн жин нь нэмэгдэхийн зэрэгцээ гэмт хэргийн улмаас болон золгүй байдлаар нас барах, амиа хорлох явдал иргэдийн огт буурахгүй байна. ХЗҮХ-ийн Эрүүгийн эрх зүй, криминологийн секторын 2008-2009 онд хийсэн судалгаануудын дүнгээс үзвэл хүн амын ядуурал, архидалт, ажилгүйдэл, тэдгээрийг тойрсон нийгмийн бухимдал, төрийн байгууллагыг тойрсон хүнд суртал, авлига, салан задгай байдал зэрэг улс орны нийгэм, эдийн засгийн өнөөгийн тулгамдсан олон асуудал шийдвэрлэгдэхгүй байгаа нь нийгэмд хүч хэрэглэсэн гэмт хэрэг өсөх гол шалтгаан болсоор байна.

---

[698] Хууль зүйн үндэсний хүрээлэн Эрүүгийн эрх зүй, криминологийн секторт төвлөрүүлэн, баталсан удирдамжийн дагуу гүйцэтгэсэн бөгөөд сэтгэл зүйчийг татан оролцуулж зарим аймаг, Нийслэлийн дүүргийн цэргийн штаб, Хил хамгаалах байгууллагад алба хааж байхдаа гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгүүлсэн ялтнуудтай ШШГЕГ-ын харъяа 409, 427 дугаар ангид уулзаж, ярилцлагын судалгаа хийв.

Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг



Дээрх үзүүлэлтээс харвал гэмт хэргийн улмаас амь насаа алдаж байгаа хохирогчдын тоо буурч байгаа мэт харагдавч ***"Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг" тогтвортойгоор өсөх хандлага ажиглагдаж байна.*** Энэхүү статистик үзүүлэлтэд харгалзах бас нэг зүйл бол тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын улмаас амь насаа алдсан хүмүүсийн тоо багтаж байгааг анхаарна уу.

Төрийн тусгай албан хаагчдаас үйлдсэн гэмт хэрэг:

2009 онд Монгол Улсад үйлдэгдсэн гэмт хэргийн мэдээнээс[714] үзвэл Зэвсэгт хүчин, хилийн болон дотоодын цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдал, тагнуул, цагдаагийн байгууллагын офицер, ахлагч, гэрээт болон хугацаат цэргийн **292** алба хаагч гэмт хэрэгт холбогдон шалгагдсаны дотор цагдаагийн байгууллагын 148, зэвсэгт хүчний 44, онцгой байдлын албаны 31, шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны 29, **хилийн цэргийн 25**, дотоодын цэргийн 10, тагнуулын 5 алба хаагч байна. Үүнд:

- Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт **128,** */үүнээс бусдын бие махбодид хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмтэл учруулах хэрэгт 121,* ***хүнийг санаатай алах хэрэгт 5,*** *бусдыг болгоомжгүй алах, бусдыг амиа хорлоход хүргэх хэрэгт тус бүр 1*;
- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт **36,** */үүнээс хулгайлах хэрэгт 15, завших, үрэгдүүлэх хэрэгт 7, залилан мэхэлж авах хэрэгт 6, булаах хэрэгт 3, дээрэмдэх болон хадгалуулсан буюу бусад зорилгоор итгэмжлэн өгсөн бусдын эд хөрөнгө завших хэрэгт тус бүр 2/;*
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэгт **29**, */үүнээс тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих хэрэгт 22, зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй, зугтаах хэрэгт 7/;*
- Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт **26,** */үүнээс танхайрах хэрэгт 24, галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар олж авах хэрэгт 2/;*
- Албан тушаалын хэрэгт **25,***/Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах хэрэгт 15,* Төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх хэрэгт 3, *хээл хахууль авах хэрэгт 3, хээл хахууль өгөх, албан үүрэгтээ хайнга хандах хэрэгт тус бүр 2/;*

[714] Цагдаагийн Ерөнхий Газрын Мэдээлэл Дүн шинжилгээний төвөөс гаргасан "2009 оны гэмт хэргийн байдал" албан хэрэгцээнд зориулсан мэдээнээс

• Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт **4,***Үүнээс хүчиндэх хэрэгт 3, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах хэрэгт 1/;*

• Шүүн таслах ажиллагааны эсрэг хэрэгт 17, ***Цэргийн алба хаах журмын эсрэг хэрэгт 19,***Захиргааны журмын эсрэг хэрэгт 4, хүн амын эрүүл мэндийн эсрэг хэрэгт 2, Эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх, Хууль бусаар Монгол улсын хил нэвтрэх хэрэгт тус бүр 1 алба хаагч холбогдон шалгагдсан байна.

Үүнээс үзвэл төрийн тусгай алба хаагчид, түүний дотор офицер, ахлагч, гэрээт болон цэргийн хугацаат алба хаагчдаас үйлдсэн гэмт хэрэг өсөх хандлагатай байгаа нь анхаарал татаж байна. Тэр тусмаа ***хүч хэрэглэсэн гэмт хэргийг илүүтэй үйлдэж, бусдын бие махбодид гэмтэл учруулах, амь насыг нь хохироох гэмт хэрэг буурах төлөвгүй байна.***

Дүгнэлт: Хил хамгаалах байгуулагын үйл ажиллагааг хууль болон дүрмээр хатуу тогтоосон дэг журмаар зохион байгуулах хэдий ч тус байгууллага, түүний нийт алба хаагч нь монголын нийгмийн нэгээхэн хэсэг болохын хувьд тухайн нийгэмд бодитой оршиж буй гэмт явдал, сөрөг үзэгдлийн нөлөөнөөс ангид байх боломжгүйг анхааралдаа авч, дээрх сөрөг үзэгдлийн нөлөө, тааламжгүй үр дагаврыг хязгаарлахад чиглэсэн цогц бодлого, арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлж байх шаардлагатай.

Хоёр. Хил хамгаалах байгууллагад гарсан гэмт хэрэг, сахилгын ноцтой зөрчлийн бүртгэл судалгаа

Хил хамгаалах байгууллагын хэмжээнд сүүлийн 10 жилд гарсан гэмт хэрэг, сахилгын ноцтой зөрчлийн талаарх судлагааг үзвэл:

- 1999-2009 онд бусдын амь насыг бүрэлгэсэн хэргийн судалгаа,
- Хилийн цэргийн хэмжээнд 1993-2009 онд гарсан хүний амь нас, эрүүл мэндийг хохироосон гэмт хэргийн судалгаа /отряд-анги/,
- Хил хамгаалах байгууллагын хэмжээнд гарсан ноцтой гэмт хэргийн судалгаа /2000-2009он/,
- Хэрэг ослын мөрөөр дээд байгууллагаас томилсон ажлын хэсгийн шалгалтын танилцуулга, схем болон фото зураг, эрүүгийн хэргийн материалаас хуулбарласан гэрч, хохирогч, холбогдогчийн мэдүүлэг зэргийг эмхтгэсэн хавтас материал 11, "нотломж", "илтгэх хуудас" зэргийн хамт.

Ирүүлсэн дээрх мэдээ материал нь хилийн отряд, заставт цэргийн албан хаагчдын үйлдсэн хүнд, онц хүнд гэмт хэрэг /бусдыг галт зэвсэг хэрэглэн санаатайгаар алсан, хүнд гэмтэл учруулсан зэрэг/-үүд, түүнчлэн хүний амь нас хохирсон золгүй учрал, ослын тохиолдлыг шалгасан тухай илтгэх хуудас, тайлан зэрэг захиргааны шалгалтын материал, цэргийн алба хааж байхдаа бусдад зодуулж, улмаар бэртэж гэмтсэн тухай цэргээс халагдсан хойноо гаргасан гомдол, эмчилгээний зардал олгохыг хүссэн өргөдөл, аймгуудын цэргийн штабтай харьцсан албан бичгүүд, эдгээрт тулгуурлан хил хамгаалах байгууллагын судалгааны нэгж, судлаачийн гаргасан ноцтой хэрэг, учралын тухай судалгаа зэргээс бүрдэж байв.

Гэмт хэргийн тухай нэгдсэн мэдээг Үндэсний статистикийн хорооны зөвшөөрч, Цагдаагийн ерөнхий газраас улсын хэмжээнд нэгтгэн гаргадаг гэмт

хэргийн буртгэл мэдээний жишгийн дагуу Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн бүлэг, зүйлээр, мөн гэмт хэрэг гарсан анги байгууллага /отряд, застав, газар орны онцлог/-аар гэхчлэн гаргаж ирүүлээгүй учраас сүүлийн 10 жилд хил хамгаалах байгууллагад ямар төрлийн, хэдэн хэрэг, хаана гарсан, түүний өсөлт, бууралт, шалтгаан нөхцлийн динамик ямар болохыг бүрэн судлах боломжгүй байв /судалгааны багийн ажилласан хилийн отряд, заставуудад гэмт хэргийн бүртгэл мэдээ мөн байгаагүй/. Түүнчлэн нэгэнт гарсан хэргийг шүүх, прокурор, хэрэг буртгэх, мөрдөн байцаах байгууллага эцэслэн хянан хэлэлцэж гаргасан шийдвэрүүд байхгүй учраас хэргийн шалтгаан нөхцлийн талаар дээрх эрх бүхий байгууллагууд ямар дүгнэлт хийсэн нь тодорхой бус байна.

Иймд ХХЕГ-аас ирүүлсэн гэмт хэргийн түүвэр судалгааны материалын хэмжээнд, тэдгээрийг голчлон ашиглаж сүүлийн 10 жилд гарсан гэмт хэргийн тоог тоймлон гаргав.

Үүнд: Сүүлийн 10 жилийн хугацаанд нийт 15 онц хүнд буюу хилчид нэг нэгнийхээ амь насыг хөнөөсөн гэмт хэрэг гарчээ. Эдгээр хэргүүдэд хүнд гэмтэл учруулсан хэргүүдийг оруулаагүй болно. Уг 15 гэмт хэрэг үйлдэгдийг цол, албан тушаалаар нь ангилвал нийт 15 байлдагч буюу хугацаат цэргийн алба хаагч, үүнээс ахлагч 3, харуулын дарга 2, жолооч 1, дэслэгч 1, заставын сургалт эрхэлсэн орлогч, хурандаа 1, отрядын дарга, хохирогчийн албан тушаал, цолоор ангилвал хугацаат цэргийн албан хаагч 4, гэрээт цэргийн албан хаагч 3, дэд хурандаа 1, ар талын дарга, ахлагч 8, харуулын дарга, заставын дарга хошууч 1, отрядын албаны дарга ахмад 1, заставын орлогч дэслэгч 1, энгийн ажилчин 1 байна.

Дээрх 15 гэмт хэргийн улмаас нийт 22 хүний амь нас хохирч 4 хүн хүнд гэмтсэн байна. Судалгаанаас ажиглахад 15 хүнд гэмт хэргийн 8 нь хилийн харуулд, застав 4, отрядын төвд 3 хэрэг үйлдэгджээ.

Мөн-эдгээр гэмт хэргийн 9 нь захирах захирагдах ёсыг зөрчсөн зүй бус харьцаанаас, 2 нь цэрэгт ирэхийн өмнө хулгайн болон танхайн хэргээр ял шийтгүүлж байсан хугацаат цэргийн алба хаагчдаас, 3 нь архидалтаас, нэгийнх нь шалтгааныг хууль хяналтын байгууллага хараахан тогтоогоогүй байна. Захирах захирагдах ёсыг зөрчсөн хүнлэг бус харьцаанаас үүдэн гарсан хэргүүд нь голчлон хилийн харуул дээр хугацаат цэргийн албан хаагч харуулын дарга нарын хооронд гарсан байна.

Дүгнэлт: Хилийн алба хаагчдын үйлдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлан тогтоох, урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байх зорилгоор хил хамгаалах байгууллагын хэмжээнд нэгдсэн журмаар гэмт хэргийг хөтлөх сахилгын ноцтой зөрчлийн анхан шатны бүртгэл мэдээний тогтолцоо үгүйлэгдэж байна. Байгууллагын хэмжээнд гарч буй гэмт хэрэг, сахилгын зөрчлийг үнэн зөв бүртгэж тооцохгүйгээр түүнийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх боломжгүй юм.

2.1. Эрүүгийн хэргийн материалд хийсэн судалгаа

Хил хамгаалах байгууллагад гарсан буюу хилийн алба хаагчийн үйлдсэн гэмт хэргийн нэгдсэн бүртгэл судалгаа байхгүй, түүнчлэн эрүүгийн

хэргийн талаар шүүх, прокурор зэрэг эрх бүхий байгууллагын эцэслэн гаргасан шийдвэр, тухайлбал: шүүхийн шийтгэх тогтоол, прокурорын яллах дүгнэлт, эсхүл эрүүгийн хэргийг хэргэсэхгүй болгосон тогтоол, гэмт хэргийн шалтгаан нөхцлийн тухай мэдэгдэл зэрэг эрүүгийн хэргийн шүүн таслах ажиллагааны албан ёсны баримт бичгүүдийг нэхэж бүрдүүлээгүй зэргээс хилийн алба хаагчид холбогдох хэргийн талаарх шийдвэрийг олж судлахад ихээхэн хүндрэлтэй байв.

Иймд, судалгааны тойм мэдээг үндэслэн Дорноговь, Дорнод, Хөвсгөл, Увс зэрэг аймгийн шүүхэд зарим хэргийн талаар лавлагаа ируулэхийг хүсч хандсан боловч ажлын ачааллаас шалтгаалан судалгааны багийн хүсэлтийг хангах боломжгүй болохоо шүүх хариу мэдэгдсэн ба харин нь Ерөнхий прокурорын газрын эрүүгийн хэргийн архивт хадгалагдаж байгаа Б.Г, Л.Д, Н.Т нарт холбогдох эрүүгийн 3 хэргийн материалыг ихээхэн хөөцөлдөж байж, олж судлав.

ХЭРЭГ 1. Гэмт хэрэг гарсан шалтгаан, нөхцөл: Хэрэг гарах болсон гол нөхцөл нь цэргийн анги байрлалд гадны хүн оруулж, "дарга, цэрэггүй хамт архидан согтуурч" албаны дотоод дэг журмыг ноцтой зөрчсөнөөс үүдэлтэй байна. Түүнээс гадна хохирогч/заставын дарга/*-Б.-гийн захирагдаж буй алба хаагчидтайгаа дүрмийн бус байдлаар байнга харьцаж, эрх чөлөөнд нь удаа дараа халдаж, олон удаа гэмт хэрэг үйлдсэн байхад түүнд эрүүгийн хариуцлага ногдуулахын оронд сахилгын арга хэмжээ авсан төдийгөөр хязгаарлан өнгөрүүлж, ял завшуулж байсан нь хэрэг гарахад мөн нөлөөлжээ. Түүнчлэн заставын бие бүрэлдүүний ар гэрийнхний дунд ахуйн шинжтэй ужгирсан хэрүүл маргаан нь гэмт хэрэг гарах өөр нэг шалтаг болсон байна.

Энэхүү хэргийг шалгах явцад хилийн хориотой бүсэд малчин айл байлгах /айлд архидан согтуурах явдал олонтаа гардаг/, нутгийн иргэдээс цэргийн албанд улируулахдаа олигтой шилж сонгодоггүй зэрэг зөрчил, дутагдал илэрсэн байна.

ХЭРЭГ 2. Гэмт хэрэг гарсан шалтгаан нөхцөл 2.: Архивт байгаа эрүүгийн хэргийн материаас үзэхэд энэ гэмт хэрэг гарах болсон үндсэн шалтгаан цэргийн алба хаагчдын хоорондын зүй бус харилцаа байжээ. Ялангуяа хилийн харуулд гарах үед заставын удирдлагын хараа хяналт суларч, харуулын даргалах алба хаагч буюу түрүүч, ахлагч нараас цэргийн хугацаат алба хаагчдыг цохиж зодох, хэл амаар доромжлох явдал байнга гардаг байжээ.

Гэтэл анги байгуулагаас гаргасан тодорхойлолт, хилийн албаны шалгалтын материал зэрэгт хэрэг гарах болсон шалтгааныг зөвхөн гэмт хэрэг үйлдсэн алба хаагчийн хувийн зан чанар, зүй бус харьцаанаас үүдсэн мэтээр өрөөсгөл дүгнэлт хийжээ.

Хавтаст хэргийн болон хилийн албаны шалгалтын материалд харьцуулан дүгнэлт хийхэд гэмт хэргийн шалтгаан нөхцөлийн талаарх төсөөлөл илт зөрүүтэй байна. Отрядын бэлтгэл заставт байсан цэргийн хугацаат алба хаагчид хилийн заставт хуваарилагдан ирэхдээ сэтгэл зүйн бэлтгэлгүй, ямар нэг байдлаар "дарамт-дэглэлт" амсана гэсэн хүлээлттэй

байдаг болох нь сэжигтэн, яллагдагчийн мэдүүлгээс тодорхой байна. Анги байгууллага харуулын даргалах бүрэлдэхүүнийг томилохдоо тэдгээрийн эрх, үүрэг, хүлээх хариуцлагын талаар сайтар ойлгуулж чадахгүй байна.

Энэ хэргийн материалаас хилийн цэргийн албанд хэрэглэж буй зэвсэг хэрэгсэл, ахуйдаа өдөр тутам хэрэглэдэг эд зүйлсэд алба хаагчид хайр гамгүй хандаж, эвдэж хэмхлэх, бусдад худалдах, үрэгдүүлэх зэргээр ашиглан шамшигдуулах явдал цөөн бус гардаг атал дарга нараас тэр бүрд нь тохирсон арга хэмжээ буруутай этгээдэд ногдуулдаггүй болох нь ажиглагдлаа.

ХЭРЭГ 3. Гэмт хэрэг гарсан шалтгаан нөхцөл: Энэ хэрэг ХХЕГ-аас ирүүлсэн онц хүнд хэргийн судалгаанд байхгүй байна. Магадгүй хувийн таарамжгүй харьцаанаас шалтгаалсан иргэд хоорондын гэж үзсэн учраас оруулаагүй байж болох ч гэмт хэрэг үйлдэгч, хохирогч нь хоёул хилийн цэргийн алба хаагч, тодруулбал нэг нь албаны жолооч, нөгөө нь хилийн цэргийн офицер байв.

Хавтаст хэрэгт авагдсан баримтаас үзэхэд хувь хүмүүсийн хоорондын гэмээр үйл ойлголцлоос үүдэлтэй маргаанаас шалтгаалсан тохиолдлын шинжтэй хэрэг мэт боловч хэрэг гарахад нөлөөлсөн дараах хүчин зүйлийг анхаарахгүй байж болохгүй байна.

Нэгдүгээрт, зарим офицерын бусадтай дэндүү бүдүүлэг, дээрэнгүй харьцдаг явдал, хоёрдугаарт, архидан согтуурах явдал. Түүнчлэн жолооч-ахлагч, энгийн жолооч зэрэг бага тушаалын бие бүрэлдэхүүнийг албаны болон хүмүүжил, ёс зүйн чиглэлтэй бусад сургалтад хамруулж байх шаардлагатай болох нь хэргийн материалаас тодорхой байв.

2.2. Санал асуулгын судалгаа

Удирдамжийн дагуу ХХЕГ-ын харъяа зарим анги салбарт анкетийн болон санал асуулгын судалгаа хийв. Үүнд: Монгол Улсын хойд хил дээр үүрэг гүйцэтгэж буй хоёр отряд /0101, 0243 дугаар анги/-ын нийт 251 алба хаагчаас анкетийн судалгаа, өмнөд хил дээр үүрэг гүйцэтгэж буй мөн хоёр отряд /0108, 0168 дугаар анги/-ын нийт 144 алба хаагчаас анкетийн болон санал асуулгын судалгаа авчээ. Судалгаанд оролцсон алба хаагчид алба, ажил үүрэг гүйцэтгэх үед тулгарч буй бэрхшээл, захирах, захирагдах ёс журмын биелэлт, илэрч буй зөрчлийн хэлбэр, түүний шалтгааны талаарх асуултад хариулт өгчээ.

Анкетийн судалгааны үндсэн асуултын нэг нь хилийн цэргийн алба хаагчдын дунд "зүй бус харилцаа" буюу захирах, захирагдах ёсыг зөрчих явдал ямар түвшинд байгааг тодруулах явдал байв. Санал асуулгын болон анкетийн судалгаагаар[715] дээрх зөрчил "төдийлөн их бус" гэсэн агуулгатай хариу гарсан байх бөгөөд энэ нь бодит байдалд хир нийцэж буй нь эргэлзээтэй. Учир нь судалгаанд оролцсон цэргийн хугацаат алба хаагч болон гэрээт алба хаагчид илүү "хаалттай" буюу "гадагш нь" мэдээлэл өгөх дургүй байдал ажиглагдав.

[715] Хавсралт 1-ээс үзэх

2.3. Цэргийн штабын дарга нартай хийсэн ярилцлагын болон санал асуулгын судалгаа

Жил бүрийн цэргийн эзлжит татлагаар Зэвсэгт хүчин, дотоодын цэрэгт боловсрол, хүмүүжил сайтай цэргийн үүрэгтнийг шилж хуваарилаад үлдсэнийг нь хил хамгаалах байгууллагад хуваарилдаг гэх шүүмжлэлийн дагуу энэхүү судалгааг Нийслэлийн Чингэлтэй, Сүхбаатар дүүрэг, Дорноговь аймгийн цэргийн штабын ажилтнуудын дунд явуулав.

Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн цэргийн штабын дарга хурандаа Г, дэд хурандаа Э нар: "цэргийн алба хаахаар татагдан ирсэн залуусыг цэргийн штабаас хуваарилахдаа зөвхөн тэдний өөрсдийнх нь хүсэл сонирхлыг харгалзан үздэг. Түүнээс ямарваа нэгэн байдлаар хилийн цэрэгт үлдсэн хэдийг нь тогтоосон тоонд нь өгнө гэх ч юм у эсвэл зэвсэгт хүчин арай дөнгүүрийг нь шилээд авна гэсэн зүйл байхгүй. Харин ч хилийн цэрэг алба хаахаар гайгүй гэсэн залуус нь саналаа өгч явдаг. Шаардлагатай гэвэл манайд татагдан ирсэн хүмүүсийн материалыг үзүүлж болно" гэсний дагуу цэрэг татлагын материалтай танилцахад боловсролын түвшин доогуур, эсхүл өөр бусад байдлаар тааруу гэхээр хүмүүсийг хил хамгаалах ялган хуваарилсан гэх зүйл илэрсэнгүй.

2.4. Хорих ял эдэлж буй ялтнуудтай хийсэн ярилцлагын судалгаа

Хилийн цэрэгт алба хааж байх үедээ гэмт хэрэг үйлдэж ял шийтгэгдсэн 11 ялтнаас Улаанбаатар хотын ойролцоо ял эдэлж байгаа 3 ялтантай уулзав. Тэднээс гэмт хэрэг үйлдэх болсон шатгаан нөхцөлийн талаар асууж, харилцан ярилцав.

ШШГЕГ-ын харъяа 407 дугаар анги буюу Тоосгоны хорих ангид Өмнөговь аймгийн хилийн заставт алба хааж байх үедээ бусдын амь насыг санаатайгаар хөнөөсөн гэмт хэрэг үйлдсэн Тэ, ТҮ нартай өөрсдийнх үйлдсэн хэргийн талаар ярилцахад өөр өөр шалтгаан хэлж байсан ба тухайн үедээ хугацаат цэргийн албан хаагч байсан Т нь ахлагчаа унтаж байхад нь толгой руу нь алхаар цохиж хөнөөсөн хэрэгт холбогджээ. Тэрбээр цэрэгт татагдан ирээд удаагүй байхдаа /14 хоног болоогүй байсан/ дээрх гэмт хэргийг үйлдсэн бөгөөд өөртэй нь "нэг бус удаа таарамжгүй харьцаж шинэ цэргийг сургаж өгнө гэж бусадтай нийлэн хэлж байсан. Үүнд дургүй хүрээд унтаж байхад нь цохисон" гэж байв. Тухайн үедээ авсан дарамт шахалт, зодуур, дэглэлт зэрэг байсан уу гэхэд *"Тийм зүйл байгаагүй"* хэмээн хариулж *"Жаахан дургүй хүрээд хүнд дээрэлхүүлээд баймаргүй санагдсан* учраас дээрх хэргийг үйлдсэн" гэв.

Харин ахлагч цолтой алба хааж байсан Т нь яг харуулын пост руу явах гэж байх үедээ Заставын даргаа гэдсэн тус газар нь буудан хөнөөсөн хэргийг үйлджээ. Тухайн гаднаас ирсэн хуучин хамт алба хааж байсан ахлагчтай хамт архи уун даргатайгаа муудалцаж улмаар харилцан зодолдож гарч зугтаасан байна. Түүний ярьснаас үзвэл заставын дарга нь бусадтай зүй бус харьцдаг, зоддог нэгэн байсан бөгөөд хэрэг гарахын өмнөхөн хугацаат цэргийн алба хаагчдыг зодож хэд хэдэн шүдийг хугалсан авч үүндээ ямар

нэг хариуцлага хүлээгээгүй, заставын бие бүрэлдэхүүн түүнээс их эмэздэг байжээ.

Т-тэй ярилцах явцад заставын анги байранд гадны хүнтэй архи уусан, даргатайгаа маргасан зэрэг зүй бус үйлдлүүд байгаа болов ч шууд захирах даргын дүрмийн бус харилцаа хамгийн ихээр нөлөөлсөн нь илэрхий байв. Түүнчлэн ял эдэлж байгаа хоригдол онцгойлон дурдахдаа "Газар орны онцлог их шалтгаалдаг. Ер нь манай застав ч гэлтгүй бусад заставт заримдаа ноцтой хэрэг давтамжтай гардаг. Нэн ялангуяа цэрэг халагдах , татагдах үеэр цэргүүдийн сэтгэл санаа ч гэсэн сонин болдог" гэж ярьсныг цаашид анхаарууштай.

Хил хамгаалах байгууллагын албан хаагчидтай хийсэн ярилцлагын судалгааны үеэр ахмад хилчид энэхүү судалгааг явуулахдаа зарим газар орны онцлог хүний сэтгэл зүйд хэрхэн, яаж нөлөөлдөг, гэмт хэрэг гарах давтамжийн магадлал зэргийг судлахыг санал болгож байсныг энэхүү судалгааны явцад хэрэгжүүлэх боломжгүй байв.

2.5. Хилийн цэргийн алба хаагчдын сахилгын зөрчил

Хил хамгаалах албаны офицер, ахлагч, түрүүч, байлдагчийн дүрмээр тогтоосон дэг журмын зөрчил буюу сахилгын зөрчлийн бүртгэлийг нэгдсэн журмаар хөтөлдөггүй байна. Гэтэл сүүлийн жилүүдэд гарсан хүнд, онц хүнд гэмт хэргийн дийлэнх нь сахилгын зөрчлөөс үүдэлтэй болохыг урьд хийсэн болон энэ удаагийн судалгааны дүнгээс олж үзэж болно. Ер нь хүний амь настай холбоотой л бол хэрэг зөрчлийг бүртгээд бусдыг нь тэгэсхийгээд орхидог буруу арга барил хил хамгаалах байгууллагад тогтсон гэж дүгнэхээр байна.

Хил хамгаалах байгууллагад гарч байгаа дүрмийн бус харилцаа, сахилгын бусад зөрчлийн талаарх бүртгэл мэдээлэл хангалтгүй, хэрэг зөрчил нь нуугдмал байдгаас шалтгаалан хүнд, онц хүнд гэмт хэрэг үүдэн гарах нөхцөл, шалтгааныг үндэслэлтэй, бүрэн тогтоож чадахгүй байна. Аливаа ноцтой гэмт хэрэг ялимгүй зөрчлөөс үүдэн гарах нь маш элбэг тул тэрхүү зөрчлийн нөхцөл байдлыг судлаж, буруутанд зохих цээрлэл хүлээлгэж байх нь гэмт хэрэг гарахгүй байх нэг гол нөхцөл болно. Сахилгын хэрэг зөрчлийн талаар туршлагатай хилчидтэй санал солилцоход:

Энэ салбарт гарч байгаа зөрчил, гэмт хэргийг ерөөсөө хэдхэн зүйл дээр тогтож анхаарах хэрэгтэй[716] байна.

- Тухайн гэмт хэрэг, зөрчил цэргийн албаны аль цаг, минутад гарсан гэдгийг тогтоох нь ихээхэн ач холбогдолтой юм. Өөрөөр хэлбэл алба хаах үедээ харуулд гарахын өмнө үү, хойно уу, эсхүл харуул дээр алба хааж байхдаа юу, заставын байранд уу, амралт чөлөөт цагийн үед үү, шөнө оройн цагаар гэмт хэрэг, зөрчил их гаргаж байна уу гэдгийг нарийвчлан тогтоох нь тухайн цаг үед авах арга хэмжээг зөв сонгох, тийм үед сургалт хүмүүжлийн арга хэмжээг зөв зохион байгуулах ач холбогдолтой төдийгүй тухайн тэр үед нь завгүй байлгах, ажил үүргийг нь зөв хуваарлах гэх мэт янз бүрийн арга хэрэглэн хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж чадах юм.

[716] Хурандаа Д.Дамдин /ХЗДХЯ-ны мэргэжилтэн/-тай хийсэн ярилцлага.

- Цэргийн алба хаагчид алба хааж байх үедээ албаны бэлтгэл, аж ахуйн ажил, цэргийн бэлтгэл гэх мэт өдөр тутмын зүйлсээс илүү ар гэрийнхэнтэйгээ байнга холбоотой байх нь тэдний хэт их анхаарал халамжид автах, эсхүл гэр бүлд учирсан бэрхшээлийг мэдсэнээр стресст орох, уурлаж бухимдах, улмаар цэргийн албанаас шантрах бэрхшээх, оргох, ***амиа хорлох***, гэмт хэрэг үйлдэх гэх мэт сөрөг үр дагаварт хүргэж байна.

PS: Сүүлийн үед цэргийн алба хааж байх үедээ амиа хорлох явдал өсөх хандлагатай байна. Сэтгэцийн гэм судлаачид *"Хүн амиа хорлох нь сэтгэл гутралын хамгийн эцсийн үе шат /депресс/ бөгөөд энэ шат хүртлээ хүн тодорхой үе шатыг дамждаг" гэжээ.* Тиймээс **зөвхөн амиа хорлох талаас нь биш онц хүнд гэмт хэрэг үйлдэж болох байсан тэр эрсдэлийг ч гэсэн харах хэрэгтэй** юм. Тухайлбал: хүний сэтгэл зүйн янз бүрийн темпераментээс хамааран зарим нь амиа хорлох тухай боддог байхад нөгөө хэсэг нь ямар нэг байдлаар түүнийгээ гадагш гаргадаг байна. Амиа хорлох болсон шалтгааныг бодитойгоор тогтоож, нэг удаа болоод өнгөрсөн хэрэг явдал мэтээр орхигдуулахгүй байх хэрэгтэй".

Нийгэмд цэргийн алба хаагч амиа хорлож байгаа тохиолдлыг шлүү соргогоор хүлээн авдаг. Нэн ялангуяа ийм тохиолдол бүрийн ард "дэглэлт" буюу дүрмийн бус харилцаа байдаг гэсэн өрөөсгөл ойлголт тогтжээ. Зөвхөн судалгааны ажлын явцын 4 сарын хугацаанд гэхэд зэвсэгт хүчин, дотоодын, хилийн цэргийн салбарт нийтдээ 4 цэрэг, албан хаагч амиа хорлосон тохиолдол гарчээ. Энэ нь алба хаагчийн хооронд даамжирч, ужгирсан нуугдмал дүрмийн бус харилцаанаас гадна тэдгээрийн хоорондын хувийн таарамжгүй харилцаа, гэр бүлийн шинжтэй маргаанаас үүдэлтэй байгааг анхаарах хэрэгтэй байна. Дурдсан тохиолдолд хилийн алба хаахад гэр бүлийнхээ хамт байдаг, тэдгээрийн отряд, заставын алба хаагчийн бүрэлдэхүүн хэсэгт орж явдаг онцлогийг мартаж болохгүй юм. Энэ нь зөвхөн амиа хорлох шалтгаан болоод зогсохгүй өөр бусад гэмт хэрэг үүдэн гарах шалтгаан болдог тухай үйл баримтууд чамгүй олон байна.

Хардалт, маргаан, хов живийн шинжтэй зүйлсээс улбаалан онц хүнд гэмт хэрэг гардаг онцлог нь зөвхөн цэргийн албаны гэхгүйгээр нийгэмд гардаг гэмт хэрэгийн нийтлэг шалтгаан болдог тул цаашид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн бодлого боловсруулахдаа анхаарах хэрэгтэй байна.

Хил хамгаалах салбарт гарсан гэмт хэргийн статистик үзүүлэлтэнд хийсэн дүн шинжилгээ:

"Хилийн 17 отрядад 31 удаа гэмт хэрэг гарснаас бусдын амь насыг байлдааны зэвсэг хэрэглэн хөнөөсөн буюу шархдуулсан гэмт хэрэг 19 удаа гарсан байна. Тодруулбал, захирагчийнхаа эсрэг зэвсэг хэрэглэн амь насыг нь хөнөөсөн гэмт хэрэг давамгайлсан байна. Үүнд: байлдагч нь ахлагчийг хөнөөсөн гэмт хэрэг нийт гэмт хэргийн 20 хувь, офицерыг хөнөөсөн 12.5 хувь, түрүүчийг хөнөөсөн гэмт хэрэг 12.5 хувь байгаа[717] нь захирах, захирагдах ёс журмыг зөрчих нь онц хүнд гэмт хэрэг үүдэн гарахад хүргэдэг болохыг нотлож байна.[718]

Гэмт хэрэг гарсан цаг: Хилийн отрядад гарсан гэмт хэрэг ихэвчлэн шөнийн цагаар гарсан байх бөгөөд тодруулбал, шөнийн эхний хагас буюу 00 цагаас 03 цагийн хооронд үйлдэгдсэн байна.

Гэмт хэрэг үйлдэгсэд: Гэмт хэргийн үйлдэгсдийн 19 нь хилчин байлдагч, 3 нь тасгийн захирагч, 7 нь харуулын дарга, 3 нь заставын орлогч, 1 нь отрядын дарга байна. Үүнээс үзвэл байлдагч буюу цэргийн хугацаат алба хаагчдаас онц хүнд гэмт хэрэг илүүтэй үйлдэж байгаа бөгөөд тэдэн рүү чиглэсэн урьдчилан сэргийлэх ажил байхгүй, зөвхөн ангийн удирдлага, заставын даргын хооронд бичиг, тоот явуулах, албан даалгаварт хариу өгөх зэргээс хэтрэхгүй байна.

Хохирогч: гэмт хэргийн улмаас 9 хилчин байлдагч, түрүүч 6, ахлагч /гэрээт хилчин/ 19, офицер 10 амь насаа алдаж шархадсан байна. Дээрхээс үзэхэд шадар захирах дарга буюу ахлагч, түрүүч офицерууд гэмт хэргийн хохирогч болж байгаа нь өөрсдийн нь буруутай үйлдлээс шалтгаалсан байж болохоор байна. Тухайлсан судалгаанаас[719] үзэхэд "цэргийн алба хаагчдыг зодож дарамтлах, айлган сүрдүүлэх зэргээр хуульд дүрмийн бус хүрээнд харьцах зөрчил багагүй байна. Цэргийн алба хаагчдыг "дэглэдэх" бөгөөд энэ тухай мэдээлэл ангийн удирдлагад тэр бүр хүрч чадахгүй, далд, нууц оршиж байна. Шалгалт судалгаанд хамрагдсан ангиудын ***удирдах албан тушаалтнууд дүрмийн бус харилцаатай холбоотой зөрчил гардаггүй гэж байгаа нь нэг талаас ийм зөрчил далд хэлбэртэй байдаг, нөгөө талаас эдгээрийг илрүүлэх, арилгах арга хэмжээг хангалттай зохион байгуулаагүйтэй холбоотой байна*** "гэжээ. Дээрх дүгнэлтүүдийг хүлээн зөвшөөрөх үндэслэлтэй гэж үзэв.[720]

---

[717] ХХЕГ-ын Мэдээлэл, соёл, сурталчилгааны хэлтсээс авсан сахилга зөрчлийн мэдээ, судалгаанаас

[718] Ахмад хилчин А.Батсайхан 2009 онд хийсэн судалгааны дүгнэлтээс

[719] ХҮЭК-оос 2006-2007 онд хийсэн "Цэргийн алба хаагчдын эрхийн төлөв байдал" судалгаанаас 5 дугаар хуудас

[720] Судлаачдын баг Сэлэнгэ болон Дорноговь аймагт анкетийн болон ярилцлагын, бичиг баримтын судалгаа хийх явцад дүрмийн бус харилцаа "дэглэлт"-ийн талаар олж мэдэхэд ихээхэн бэрхшээлтэй байсан бөгөөд цэргийн алба хаагчдаас ийм асуулгад хариулахаас ямар нэг байдлаар зайлсхийж, эсхүл ор тас үгүйсгэж байв.

Дүгнэлт: Ангийн хэмжээндалба хаагчдаас гаргасан дүрмийн бус харилцаа, сахилга зөрчлийн талаар ХХЕГ-т тэр бүр мэдээлээд байхыг хүсдэггүй, учир нь гэмт хэрэг, сахилгын зөрчлөөс сэргийлэх талаар анги байгуулагадаа зохиож буй ажлыг сонирхохоос илүүтэй хэн нэгэн албан тушаалтаныг буруутгаж, хариуцлага тооцохыг урьтал болгодог удирдлагын хэвшсэн арга барил дээрх зөрчил, гэмт хэргийг нуун дарагдуулах гол шалтгаан болж байна.

ХХЕГ харьяа анги байгууллагын цэргийн сахилгын байдалд дүгнэлт хийх, удирдах албан тушаалтны ажлыг үнэлэн дүгнэхдээ тухайн нэгжид зохиосон эрх зүйн сурталчилгаа, соёл, хүмүүжлийн ажил, хүн нэг бүртэй ажилласан байдал, зөрчлийг илрүүлж, буруутныг хууль, дүрмийн дагуу цээрлүүлсэн эсэх, гэмт хэрэг, сахилгын зөрчлийн бүртгэл мэдээг үнэн зөв гаргаж ирүүлдэг тогтолцоог бий болгосон эсэхийг ажлын гол үзүүлэлт, үр дүн болгодог арга барилд шилжих нь зүйтэй юм.

Цэргийн алба хаагчдын хувийн байдал: Судалгааны дүнгээс үзвэл анги байгууллагад гарсан хүнд, онц хүнд гэмт хэргийн шалтгаан нь нийгмийн шинжтэй байхаас гадна хувь хүнээс өөрөөс нь шалтгаалсан үйл баримтууд нилээдгүй тогтоогдов. Үүнийг дурдвал:

Цэргийн алба хаахдаа ухарч няцдаг, ***гэр бүлийн болон суурь хүмүүжлийн доголдлоос шалтгаалан бусдын үг даах чадваргүй байх, цэргийн амьдралд дасахгүй байх, тэсвэр хатуужил багатайн улмаас үл ялих зүйлд гомдож өширхөх, хонзогнох, оргох улмаар бусдынхаа амь насанд галт зэвсэг хэрэглэн халдах, гэмтээх зэрэг гэмт хэргийг үйлдсэн үйл баримтууд*** байна.

Тухайлсан ярилцлагын судалгааны явцад[721] гудамжны тэнэмэл амьдралаар өссөн нэгэн этгээдийг зан харьцааны доголдол болон өөртөө харьцаагүй үйлдэл хийж улмаар гэмт хэрэг үйлдэх боломжтой байсан учир цэргийн алба хаахаар хуваарилагдан ирэхэд нь застав руу шууд явуулаагүй байна. Гэвч тэрээр алба хааж байсан газраасаа оргож нилээдгүй хүндрэл бэрхшээл учруулж, хөрөнгө мөнгөний зардал гаргасан жишээ байна.

Нэмж дурдахад, хүний амь нас хохироосон Оюунболд нарын хэргээс судлан үзэхэд "хэрэгт холбогдогчид бүгдээрээ хагас өнчин, нэг дор өссөн, ямар нэг бүлэг хэмээн өөрсдийгөө ярьдаг байсан" гэх зэрэг байдлыг илүү анхаарч, яаран дүгнэлт хийхийн оронд дээрх байдлыг яагаад судлаж тогтоогоогүй, урьдчилан мэдсэн юм бол яагаад нэг заставт хуваарилсан, харуулд яагаад нэг дор томилсон гэх зэрэг асуултад хариулт хайх хэрэгтэй байсан болов уу.

2.6. Хилийн алба хаагчдын сэтгэл зүйн судалгаа

Судалгааны багт мэргэжлийн сэтгэл зүйч ажиллаж, удирдамжийн хүрээнд дараахь судалгааг явуулжээ.

Судалгаанд офицер 26, ахлагч 22, цэргийн хугацаат алба хаагч 71, энгийн ажилтан 25 нийт 144 хүнийг хамрагдсан байх ба тэдгээрийн

[721] 247 дугаар ангийн захирагч хурандаа Батсүхтэй хийсэн ярилцлагын явцад

насны хувьд 19-51, боловсролын хувьд дээд-21%, тусгай дунд-2%, бүрэн дунд-69%, бүрэн бус дунд-8%-ийг эзэлжээ. Айдас, түгшүүрийн хувьд судалгаанд оролцогчдын 53% нь хэрэг зөрчилд холбогдохоос, 13% нь ганцаардлаас, үлдсэн хувь нь харуул манаанд гарах, эрүүл мэнд, найз нөхөд, гэр бүлийнхэнтэй холбоотой асуудлууд давамгайлжээ. Ялангуяа халагдах хугацаа нь дөхсөн хүмүүсийн хувьд хэрэг зөрчилд холбогдохгүй эсэн мэнд буцах эсэх, мөн халагдаад очиход ар гэрийн байдал ямар байгаа бол гэх зэрэг асуудалд илүүтэйг санаа зовдог байна.

Судалгаанд оролцогчдын 80-аас илүү хувь нь бие бүрэлдэхүүний харилцааны дутагдалтай талыг ярьж, дэлгэнгүйгээр бичсэн байжээ. Үүндээ, дан ганц захирагч, дарга нарын харилцааны соёлын дутагдал бус, нийт бие бүрэлдэхүүнийг хамааруулсан байжээ.

Энгийн албан хаагчдын дийлэнх нь гэр бүлийн хүний /нөхөр/-гдаган томилогдсон газарт нь очиж янз бүрийн ажил хийхэд хүрдэг, хүүхдийн цэцэрлэг, сургууль хомсдолтой гэх зэргээр нийгмийн олон асуудал шийдвэрлэгдээгүйд сэтгэл дундуур, ирээдүйдээ түгшиж байдаг ажээ. ХХЕГ-аас ирсэн албаны хүмүүс анги, заставын үйл ажиллагаа, ахуй амьдралтай танилцаж шалгахдаа хүмүүсийн хийж бүтээсэн зүйлд дэндүү шүүмжлэлтэй, заримдаа доромжилсон өнгө аясаар ханддаг байна. Хувь хүн болон гэр бүлдэх сэтгэл зүйн асуудлуудаа шийдвэрлэж чадаагүйгээс болж бие өвчлөх, архи тамхийг хэтрүүлэн хэрэглэх нь элбэг. Ялангуяа хүн цөөтэй, шинэ мэдээ мэдээлэл авах боломж хязгаарлагдмал газруудад ихээхэн тохиолддог. Нийт бие бүрэлдэхүүний хувьд стрессээ тайлах аргыг мэддэггүйгээс удаан хугацааны буюу сэтгэлийн гүн шаналал, зовиуртай байх нь элбэг.

Ажлын ачаалал их байх /зэлжгүй олон цагаар ажиллах/ нь ажлын хариуцлага алдах, ажлын бүтээмж багасах, ажилдаа дур сонирхолгүй болох, цаашилбал ажлын байрыг орхих хүртэл үйлдэл хийхэд хүргэдэг. Мөн ажлаа явуулах тав тухтай нөхцөл муу, харуул манаанд явахад унаа уналга асуудалтай байдаг зэргээр үүргээ гүйцэтгэх таатай орчин нөхцөл бүрдээгүйгээс ажил, цэргийн албанаас залхах, орхих үндсэн нөхцөлүүд болдог.

Тус байгууллагад гарч буй онц хүнд гэмт хэргийн шалтгаан нөхцөл:

а/ цэргийн болон хил хамгаалах албыг холбогдох хууль тогтоомж, дүрмээр хатуу тогтоосон дэг журмын дагуу зохион байгуулж тэр бүр чадахгүй байгаа,

б/ офицер, ахлагч, цэргийн хугацаат алба хаагчийн харилцааг захирах, захирагдах ёс журмын дагуу хэвшүүлэн төлөвшүүлж чадахгүй байгаа,

в/ ангийн байрлалд, түүнчлэн албан үүргээ гүйцэтгэх үедээ архидан согтуурах явдлыг таслан зогсоож чадаагүй,

г/ байлдааны зэвсэг, галт хэрэгслийн ашиглалт, хадгалалт хамгаалалтын байдалд тавих хяналт хангалтгүй,

д/ хил хамгаалах албанд жил бүр хүлээн авч буй бие бүрэлдэхүүн, ялангуяа цэргийн хугацаат алба хаагчийн тайван цагт галт зэвсэг агсан

байлдааны үүрэг гүйцэтгэх сэтгэл зүйн болон цэргийн хэргийн бэлтгэл бүрэн хангагдахгүй байна.

Ажилгүйдэл, ядуурал, сургууль завсардах зэрэг нийгэм дэх олон сөрөг үзэгдлийн нөлөөлөл ихсэж, хүч хэрэглэн үйлдсэн гэмт хэргүүд, түүний дотор хүний амь нас, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг улсын хэмжээнд сүүлийн арван жилд өсөх хандлагатай байгаа нь хил хамгаалах байгууллагад хүнд, онц хүнд гэмт хэрэг гарахад шууд бусаар нөлөөлж буй гадаад хүчин зүйл байхыг үгүйсгэж болохгүй юм.

Дөрөв. Судалгааны санал, зөвлөмж

Судалгааны сэдвийн хүрээг хэдийгээр Эрүүгийн хуульд заасан хүнд, онц хүнд гэмт хэргийн гаралт, түүний шалтгаан нөхцлийг судлах явдлаар хязгаарласан ч хил хамгаалах байгууллага, түүний үйл ажиллагааны болон алба хааж буй бие бүрэлдэхүүний онцлогийг харгалзан бүхэлд нь гэмт явдлаас урьдчилан сэргийлэх талаар зөвлөх нь зүйтэй гэж үзсэн. Үүнд:

1. Хил хамгаалах ерөнхий газар, түүний харьяа нийт анги байгууллагад хөтлөх

гэмт хэрэг, сахилгын ноцтой зөрчлийн бүртгэл мэдээллийн тогтолцоог юуны өмнө бий болгох. Энэхүү бүртгэл мэдээ нь хилийн застав, отрядад гарсан хэрэг зөрчлийг бүрэн илрүүлэх, түүний шалтгаан нөхцлийг судалж дүгнэх, гэм буруутай этгээдэд хууль, дүрэмд заасан хариуцлага ногдуулах, цаашид дахин гаргуулахгүйн тулд ямар ажил зохион явуулах шаардлагатайг тодорхойлох зорилготой тул түүнийг үнэн зөв бүртгэж мэдээлсэн шат дараалсан дарга, захирагч нарт шийтгэл ногдуулахыг урьтал болгох ёсгүй. Гэмт хэрэг, сахилгын зөрчил, ялангуяа захирах, захирагдах ёсны эсрэг хэрэг, зөрчил нь нуун дарагдуулсан тохиолдолд маш ноцтой үр дагавартай хүнд гэмт хэрэгт хүргэдэг учир хэрэг зөрчлийг нуун дарагдуулсан дарга, захирагчид нарт харин хариуцлага тооцож байх шаардлагатай.

2. Гарсан гэмт хэрэг, зөрчлийг хэн гаргасныг үл хамааран их, бага гэлгүй буруутай этгээдэд сахилгын хариуцлага ногдуулж, энэ тухай хамт олонд нь ил мэдээлж, хүмүүжлийн ажил зохиож хэвшүүлэх.

3. Хилийн отряд, заставт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрхэн зохион байгуулах, салбар зөвлөлд хэн, ямар үүрэгтэй оролцох, нөхцэл байдлын, социологийн болон бусад судалгааг яаж хийх, сахилгын байдалд дүн шинжилгээ хийх аргачлал, гарын авлага зэргийг боловсруулж сургалт зохион явуулах.

4. Гэмт хэрэг, сахилгын зөрчилтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажил хэдийгээр нийт нэгж, албан тушаалтанд хамаатай албаны үүрэг боловч энэ ажлыг хариуцан зохион байгуулах мэргэшсэн нэгжийг бий болгож, мэргэжлийн ажилтныг яаралтай бэлтгэж ажиллуулах шаардлагатай.

5. Хил хамгаалах байгууллагын анхан шатны нэгжүүдийг бэхжүүлэх, бие бүрэлдэхүүний алба хаах, ажиллах, аж төрөх нөхцлийг улам сайжруулах шаардлагатай. Ноцтой хэрэг осол чухамхүү хилийн застав, харуул манааны байр, харуулын цэг дээр гол төлөв гарсаар байгааг судалгаа харуулж буй тул анхаарлыг үүнд л төвлөрүүлэх нь зүйтэй.

6. Сургалт, хүмүүжлийн ажилд хэлбэрдэж хандаж огтхон ч болохгүйг анхаарах, судалгаанаас үзэхэд хилийн заставт цэрэг дайчидтай явуулж байгаа сургалт, эрх зүйн сурталчилгаа цэргийн дүрэм, Эрүүгийн хуулийн тусгай ангиас цэргийн гэмт хэргийн хэдэн зүйлийг уншиж өгөхөөс хэтрэхгүй байна. Иймд бие бүрэлдэхүүний эрх зүйн ухамсарын түвшин, ажил мэргэжлийн онцлогт тохирсон сургалт зохион байгуулах нь үр дүнтэй. Хялбарчилсан гарын авлагууд боловсруулах, "сургагч багш"-ийг бэлтгэх нь юу юунаас чухал байна.

7. Хил хамгаалах төв, орон нутгийн байгууллага тухайн орон нутгийн шүүх,прокурор, цагдаагийн байгууллагатай гэмт явдлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр харилцан ажиллах журмыг боловсруулж мөрдөх. Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг зөв тогтоохын тулд орон нутгийн хуулийн байгууллагатай нягт ажиллаж, хэрэг бүрийн араас хөөцөлдөж, түүнтэй холбоотойгоор гарсан тогтоол, шийдвэр, мэдэгдэл зэргийг авч, түүнд дүгнэлт хийж хэвшүүлэх.

8. ХЦДС-ийн дэргэд "Мэргэжлийн хилчин- ахлагч" бэлтгэх сургууль/ дамжаа/байгуулж, төгсөгчдийг хилийн анги отрядад томилон ажиллуулдаг болох. Нэн ялангуяа, сайн судлаагүй хүмүүсийг хил хамгаалах албанд ажиллуулахаас зайлсхийх хэрэгтэй.

9. Хилийн отряд, заставын удирдах,гүйцэтгэх албан тушаалдтомилон ажиллуулах офицеруудыг бэлтгэх систем /журам/ тогтоож мөрдөх. Энэхүү бэлтгэл нь албаны бэлтгэлээс гадна хүнтэй ажиллах чадвар эзэмшүүлэх, ёс зүйтэй байхад сургах, алба хаагчдынхаа хувь онцлогийг шинжиж сурах, сэтгэл санааны хямралд автсан үедээ, эсхүл ийнхүү хямралтай байгаа хүний талаар зөв шийдвэр гаргадаг байх зэргэт сургахад чиглэсэн байвал илүү үр дүнтэй байхаар байна.

10. ХХЕГ-ын урьд хийсэн /Улсын хил судлалын сектор/ судалгааны дүгнэлт, дэвшүүлсэн саналуудыг дахин авч үзэх.

---oOo---

ШОРОНГООС СУЛЛАГДСАН ХҮМҮҮСТ НИЙГЭМД ДАСАН ЗОХИЦОХОД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ БОДЛОГО БОЛОВСРУУЛАХ НЬ[722]

Бодлогын судалгааны тайлан

Судалгааны ажлын үндэслэл: Хорих ял эдэлж суллагдсан хүнийг дахин гэмт хэрэг үйлдэх, нийгмийн хэв журам зөрчихөөс нь урьдчилан сэргийлэх ажлыг Монгол Улсын зарим хууль тогтоомжид төрийн чиг үүргийн нэг болгон оруулсан байна. Энэ үндэслэлээр төрийн зүгээс шоронгоос суллагдсан хүмүүст туслаж, дэмжин нийгэмшүүлнэ гэхээсээ илүүтэй тэднийг хянан харгалзах, захиргааны хяналтад байгаа хүний зан төрх, үйл ажиллагааны талаар тодорхойлолт гаргуулж авах; бусад үндэслэлээр түүнийг хэдийд ч дуудан ирүүлэх, зөвлөгөө өгөх, шаардлага тавих, анхааруулах төдий хэлбэрүүдийг хуульчилж шаардлагатай бол захиргааны журмаар торгох зэргээр ***"цээрлэл-хяналтын"*** шинжтэй арга хэмжээг авч байна.

Гэтэл шоронгоос суллагдаж байгаа хүмүүсийн 70 орчим хувь нь давтан гэмт хэрэг үйлдэж, тэднээс үйлдэх гэмт явдлын нийгмийн хор аюул улам бүр өсөн нэмэгдэх болов. Цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлдэг "захиргааны хяналт" гэсэн арга хэмжээ нь давтан гэмт явдлаас урьдчилан сэргийлэх оновчтой шийдэл, нөлөөлөл болж чадахгүй байна. Нөгөөтэйгүүр хувь хүнийхээ үүднээс нийгэмд "гэмт хэрэгтэн" хэмээн гадуурхагдах, хэвийн ажиллаж, амьдрах эрх нь зөрчигдөх зэрэг байдлууд ч гарч байна. Судлаачийнзүгээс дээрхи тогтсон чиг хандлага, арга барил, эрх зүйн зохицуулалт нь шийдвэрлэх ёстой асуудал хэмээн дүгнэв.

Судалгааны зорилго: Энэхүү бодлогын судалгаагаар шоронгоос суллагдсан өөрөөр хэлбэл хорих болон баривчлах ял эдлээд суллагдаж байгаа хүмүүсийг нийгэмшүүлэхэд нь туслалцаа, дэмжлэг үзүүлэх үр нөлөөтэй бодлого боловсруулах явдал болно. Шоронгоос суллагдаж байгаа хүн:

- *Хорих болон баривчлах ялын[723] хугацаа дуусаж[724] суллагдах[725]*
- *Тэнсэн суллагдах[726]*
- *Хорих ялаас хугацааны өмнө тэнсэн суллах[727]*

---

[722] Нээлттэй нийгэм форум. БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР.

[723] Гэмт хэргэзс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 15 дугаар зүйл. Хорих ял эдлээд суллагдсан хүнд захиргааны хяналт тогтоох гэсэн бүлэг зохицуулалт бий.

[724] Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 5-д "...давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хорих ял эдэлж суллагдсан хүнд захиргааны хяналт тогтооно."

[725] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 130 дугаар зүйлийн 130.5-т "Гянданд ял эдэлж байсан буюу гэмт хэрэг санаатай үйлдэж хоёроос дээш удаа хорих ял шийтгүүлж байсан ялтан суллагдвал энэ тухай цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ."

[726] Эрүүгийн хуулийн 61 дүгээр зүйл.Тэнсэх: Шүүхээс 1-5 жилийн хугацаанд хорих ялыг тэнсэж, энэ хугацаанд хянан харгалзахыг цагдаагийн байгууллагад даалгадаг.

[727] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 104 дүгээр зүйлийн 104-1.1.Хорих ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллагдсан болон Эрүүгийн хуулийн 61 дүгээр зүйлд заасан үндэслэлээр тэнсэгдсэн ялтанд цагдаагийн байгууллага хяналт тавина.

➢ *Хорих ялыг хойшлуулж*[728] *суллах*[729]

➢ *Өвчний учир хорих ялаас чөлөөлөгдөх*гэсэн хэлбэрүүдтэй байгаа боловч зарим нь бүрхэлд энэ харилцааг зохицуулсан тогтолцоо, нэгдсэн журам байхгүй юм.

Хорих ял эдлэзд суллагдсан хүмүүсийг нийгэмшүүлэх ажлыг төрийн бодлогын түвшинд авч үзэхдээ "захиргааны хяналт" төдийгөөр томъёолж, цагдаагийн байгууллагын хийх ажил үүргийн хуваарьт тусгаж, хяналтыг зохих шатны байгууллагын даргын шийдвэрээр 1-3 жил хүртэл хугацаагаар тогтоож өгчээ. Судлаачын зүгээс ***"нийгэмшүүлнэ"*** гэдэг нэр томъёог ***"байнга дурддагаас"*** өөрөөр тодорхойлж, түүнийг үр дүнтэй хэрэгжүүлэх арга, аргачлал, бодлогыг хэдэн хэдэн хувилбараар боловсруулж боломжит хувилбарыг санал болгох юм. Энэ нь ял эдлэзд суллагдсан хүмүүсийг нийгэмшүүлэх систем нь***"нэгж"*** хэлбэрээр байх тэрхүү боломжийг тодорхойлох явдал гэж үзлээ.

Судалгааны таамаглал:Урьд хийгдсэн судалгаа шинжилгээний ажил, эрдэм шинжилгээний өгүүллүүд, ном, нэг сэдэвт бүтээлүүдээс дүгнэн таамаглахад хорих ял эдлэзд суллагдаж байгаа хүмүүс "нийгэм нарийн хүлээж авахгүй" гэсэн айдастай байдаг ба бодит байдал дээр нийгэмд хэвийн ажиллаж амьдрахад нь төрийн бодлого гэхээсээ илүүтэй олон нийтийн чиг хандлага түлхүү үйлчилж, гадуурхагдах, ажилд орж чадахгүй байх, ахин гэмт хэрэг үйлдэх орчиндоо очдог зэрэг сөрөг үр дагаварыг амсаж, давтан гэмт хэрэг үйлдэх зам руу орж байна.

Харин төрийн бодлогын хувьд аваад үзэхэд ялтныг хүмүүжүүлэх, нийгэмд дасан зохицоход нь дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, институци байхгүй, дахин хэрэг үйлдэж байгаа нь нийгмийн нөхцлөөс гадна нийгэмшүүлэх ажлыг буруу томъёолж хэрэглэж байгаатай шууд холбоотой байна.

Судалгааны арга, арга зүй

✓ ***Статистикийн судалгаа:*** Шоронгоос суллагдсан хүмүүс гэмт хэрэг дахин үйлдсэн байдал, тэдний нас, хүйс зэрэг онцлогийг гаргах, дүн шинжилгээ хийх

✓ ***Санал асуулгын судалгаа:*** Анкетийн судалгаагаар энэхүү судалгааг тодорхойлох боолмжгүй учир ихэвчлэн бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын аргыг хэрэглэв. Энэ нь төрийн болон төрийн бус байгуулагын албан хаагчид, эрдэмтэн судлаачид, иргэдийн дунд, шоронгоос суллагдсан хүмүүсийн дунд гэсэн хэд хэдэн фокус группын дунд хийгдсэн.

✓ ***Баримт бичиг судлах:*** Энэ талаар хийгдсэн суурь судалгаа, эрдэм шинжилгээний өгүүлэл, монограф, дипломын ажил, диссертацууд болон баримт бичгүүдийн судалгааны ажилд холбогдох хэсгийг судлав.

---

[728] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 104 дүгээр зүйлийн 104.1-т "Албадан ажил хийлгэх, баривчлах, хорих ял нь шүүхийн шийтгэх тогтоолоор хойшлогдсон ялтанд цагдаагийн байгууллага хяналт тавина." гэжээ.

[729] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 102 дугаар зүйлд Насанд хүрээгүй эттэздэд ногдуулсан хорих ялыг хойшлуулсан тохиолдолд цагдаагийн байгууллага хяналт тавихаар заасан.

✓ ***Бусад:*** судалгааны ажлын явцад дүгнэлт хийх, задлан шинжлэх, бүрэн ба бүрэн бус дидукцийн арга хэрэглэх, ажиглах, туршин үзэх, туршлага судлах, эрх зүйн орчинд үнэлгээ хийх, кейс судалгаа зэрэг аргуудыг хэрэглэсэн.

✓ ***Харьцуулсан судалгаа:*** Гадаадын орнуудын сайн туршлагыг харьцуулан үзэх замаар судалж, өөрийн орны хөрсөнд буух хувилбарыг гаргаж ирнэ.

Судалгааны тайлан

Ардчилсан нийгэмд хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, тэгш эрхтэй байх зарчмууд хууль тогтоомжид тусгалаа олоод хэдий 20 гаруй жил болж байгаа хэдий ч өнөөгийн нийгэмд гэмт хэрэг үйлдэх арга барил нарийсч, харгис хэрцгий болжээ. Сүүлийн жилүүдэд гэмт хэрэг үйлдэн ял шийтгэгдэж, хорих байгууллагаас суллагдсан хүмүүсээс дахин гэмт хэрэг үйлдэх нь ихсэж байна.

Монгол Улсын нийт хүн ам, бүртгэгдсэн гэмт хэрэг, гэмт хэрэгт холбогдогч, түүнээс давтан гэмт хэргийн хөдөлгөөнийг сүүлийн 10 жилээр дурьдвал, 2000-2009 онд урьд нь шүүхээр ямар нэгэн хэлбэрээр ял шийтгэгдсэн 18117 хүн дахин гэмт хэрэг үйлджээ. Энэ нь Монгол Улсад гэмт хэрэг үйлдсэн нийт хүмүүсийн 10 хувийг эзэлдэг.[730]

[730] ЦЕГ, ХЗҮХ-гийн 2010 хамтран хийсэн судалгааны дүнгээс

Хорих болон баривчлах ял эдлээд суллагдсан хүмүүсийг нийгэмд хүлээн авах, ажлын байраар хангах, тусламж дэмжлэг үзүүлэх, амьдрах орчин нөхцөл сайн бүрдэгүй зэрэг байдлаас ял эдлээд дуусан болон өршөөл, уучлалаар суллагдсан хүмүүс дахин гэмт хэрэг үйлдэж, давтан ял шийтгүүлэн хорих газар дасан зохицох хандлага ажиглагдлаа.

Монгол улсын хэмжээнд 2007 онд 6149 хүн, 2008 онд 6282 хүн, 2009 онд 5069 хүн баривчлах болон хорих ял эдэлж байсан ба тэдний 42-48 хувь нь урьд өмнө ял шийтгэл эдэлж байсан хүмүүс байгаагаас[731] үзэхэд дээрх дүгнэлт батлагдаж байгаа юм.

Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээд хуульд заасан шийтгэлээ хүлээх ёстой боловч, хорих байгууллагаас жил бүр суллагдаж буй 2000 орчим хүнд туслалцаа, дэмжлэг дутаж байгаа нь нийгмийн тогтолцоо, төрийн байгууллагын үйл ажиллагааны болон эрх зүйн зохицуулалт учир дутагдалтай байгаатай холбоотой байна.

Сүүлийн 3 жилийн жилийн дунджыгүзвэл 1606 хүн дахин гэмт хэрэг үйлджээ. Үүнээс үзэхэд сүүлийн арван жилдурьд шоронгоос суллагдсан хүмүүсийн дунджаар 70 орчим хувь нь дахин гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлжээ.

Хуулийн сахиулах байгууллагын алба хаагч, хохироос суллагдсан хүмүүстэй бүлгийн ярилцлагаар судалгаа хийх явцад дахин гэмт хэрэг үйлдэж байгаа шалтгаан нь *"нийгэмд хэвийн амьдарч чадахгүй"* байгаатай холбоотой төдийгүй гэмт зан үйл төлөвшсөн, эргээд гэмт хэрэг үйлдэх орчиндоо очдог зэрэг нөхцөлтэй холбоотой. Энэ нь хулгайлах, бусдын бие махбодид гэмтэл учруулах, хүчиндэх, танхайрах, дээрэмдэх, хүнийг санаатай алах гэмт хэргийг гол төлөв үйлдэж байгаагаас харагдлаа.[732]

Гэтэл дахин гэмт хэрэг үйлдэж байгаа шалтгаан нөхцөлийг хуулийн байгууллагаас урьдчилан сэргийлэх ажил хангалтгүй, тавих хараа хяналт дутсан гэхээсээ илүүтэй, тэдэнд нийгэм, хамт олноос үзүүлэх иргэнээ гэсэн бодитой бодлого, туслалцаа, дэмжлэг байхгүйгээс дахин гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг анзаарч үзэхгүй байна.

Бодит байдлыг судалж үзэхэд цагдаагийн байгууллагаас тавьж байгаа захиргааны хяналт нь сард нэг удаа дуудаж, бүртгэх хэлбэртэй байгаа ба цагдаагийн байгууллагын хэсгийн төлөөлөгч, байцаагчаас ч тэр, хяналтанд байгаа хүмүүсээс ч энэ арга хэмжээг тэзршаасанбайдалтай, үр дүнд хүрэхгүй байна.[733]

---

[731] ШШГЕГ-ын 2007,2008,2009 оны жилийн эцсийн тайлан

[732] 2000-2009 онд захиргааны хяналтанд байхдаа болон өршөөлийн хуулиар суллагдаад дахин гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн судалгааны дүн., ЦЕГ-ын Мэдээлэл, судалгааны төв. 2010 он

[733] Хэнтий аймаг, Багануур дүүргийн цагдаагийн хэлтсийн 12 хэсгийн байцаагч болон тус аймаг, дүүргийн хорих ангид ял эдлэж буй 20 хоригдол, захиргааны хяналтанд байгаа 40 хүмүүсийн дунд хийсэн ярилцлагын судалгаанаас. 2010 оны 8 дугаар сар.

Шоронгоос суллагдсан хүмүүст чиглэсэн бодлого:

Дэлхий дахинд шоронгоос суллагдсан хүмүүст чиглэсэн төрийн бодлого үндсэн хоёр хэлбэртэй байдаг. Үүнд :

- **Social controlof criminalsбуюу нийгмийн хяналтын хэлбэр**
- **Rehabilitation of criminals буюу нийгэмд амьдрахад нь дэмжлэг үзүүлэх хэлбэр**

Энэ хоёр хэлбэр нь тухайн улсын нийгмийн хөгжлийн чиг баримжаатай холбоотойгоор тодорхойлогддог.[734]

Нийгмийн хяналт нь шоронгоос суллагдсан хүмүүсийг *"засрашгүй хүмүүс"*гэж үзэзд "давтан, рецидив гэмт хэрэгтэн" хэмээн нэрлэж, түүнтэй хийх тэмцлийг чангатгадаг. Хүмүүс дахин гэмт хэрэг үйлдэж байгаа нь хууль тогтоомжийг үл ойшоож,засарч хүмүүжихийгхүсэхгүй байгааг илтгэн харуулах шалгуур гэж үзэж шоронгоос суллагдсан хүмүүст нийгмийн зүгээс тавих хяналт илүү чанга байх ёстой бөгөөд ингэснээр тэднийг ахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлж чадна гэж үздэг.

Харин либериал баримжаатай барууны гэгдэх орнуудад хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийн сэтгэл зүйг эмчлэх, нийгмийн туслалцаа үзүүлэх ажлын онолын үндэслэл 1970-аад оноос эхлэн ул суурьтай хөгжиж эхэлжээ. Энэ нь гэмт хэрэгтнийг нийгэмд дахин засаж, хүмүүжүүлж болдог, ингэхийн тулд шоронгоос суллагдсан хүмүүст туслалцаа дэмжлэг хэрэгтэй гэсэн хүмүүнлэг үзэлд тулгуурладаг.

1960-аас 1980 онд Монгол улсын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллага*"ял эдлэгсдийг дахин хүмүүжүүлэхболомжгүй болохыгпрактик амьдралаас ойлгосон"* гэх дүгнэлт гарган,гэмт хэрэг үйлдэсэн суллагдсан хүмүүсийг буруушаадаг хандлагын эхлэлийг тавьжээ. Энэ нь ч учиртай байж. Тэр үеийн нам засгийн удирдлагаас *"гэмт хэрэг үйлдэж байгаа нь өнгөрсөн нийгмийн үлдэгдэл, хөрөнгөтний нийгмийн гаж нөлөө хэмээн"*дүгнэсэнтэй холбоотойгоор гарсан[735]юм. Гэсэн хэдий ч тухайн үеийнхээ нийгмийн онцлогт тохирсон "тусгай комендатур"хэмээх алба нэгж байсан бөгөөд эдгээр алба нь социалист нийгмийн үед шоронгоос суллагдсан хүмүүсийг хүлээн авч, хуучин ажиллаж байсан газар нь эргүүлэн ажилд оруулах, нийгмийн ашиг тустай хөдөлмөр эрхлүүлэх зэргээр идэвхитэй ажиллаж түүхэн үүргээ гүйцэтгэжээ.

Орчин үед Европын холбоо зэрэг Бүс нутгийн хамтын ажиллагааны байгуулагуудаас ардчилсан хүмүүнлэг иргэний нийгмийг баримжаалан хөгжиж байгаа улс орнуудад **шоронгоос суллагдсан хүмүүст дэмжлэг үзүүлэх төрийн бодлого** илүү үр дүнтэйг зөвлөж, гишүүн улс орнууддаа энэхүү ажлын стандартыг тогтоох шаардлага тавьж байгааг бид анхаарлын гадна орхиж болохгүй юм.

---

[734] Susan Ehrlich Martin, Lee Sechrest, Robin Redner. 1981, National Research Council /U.S./. Panel on Research on Rehabilitative Techniques 'New directions in the rehabilitation of criminal offenders'

[735] Г.Даштүдэв. "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга зүй" УБ хот 2007 он., 27 дах тал

2010 оны эцсээр хорих байгууллагад ял эдэлж байгаа хүмүүсийн 50.4%нь хоёр ба түүнээс дээш удаа хорих ял шийтгүүлж байсан рецидив ялтнууд, тэдний 37.2 % нь хүч хэрэглэсэн болон шунахай сэдэлттэй гэмт хэрэг үйлдэж мэргэшсэн тусгай рецидив гэмт хэрэгтнүүд[736] байна гэсэн судалгаа гарчээ. УПЕГ-ийн Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт хэлтсийн хяналтын прокуроруудтай хийсэн ярилцлагаас үзэхэд 3-20 удаагийн давтан гэмт хэрэг үйлдсэн хүмүүс ял эдэлдэг байна.

<u>Иргэдийн санаа бодол:</u> *"Гэмт хэрэг үйлдэгдэхэд ямар нөхцөлүүд байна вэ?"*гэсэн асуулгад[737]оролцсон иргэд ажилгүй байх, хийх ажилгүй, амар хялбар аргаар амьдрах гэсэн хүсэл, хүний зан байдал, авир араншин, ёс суртахууны доголдолтой холбон үзэж, *<u>хорихоос суллагдсан хүмүүст анхаарал тавих тогтолцоо байхгүй</u>*, хөдөлмөрлөх, түүний үр шимийг хүртэж амьдрах хүсэл эрмэлзлийг төлөвшүүлэх орчин бүрдээгүй, *төр засгийн зүгээс цогцоор* гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөө хангалтгүй байгаа зэргийг дурьджээ.

"Хүнийг шоронд суулгаснаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сайн зохион байгуулах нь илүү үр дүнтэй байдаг гэсэн саналыг юу гэж үзэж байна вэ?" гэсэн асуулгаас үзэхэд *шоронд хүмүүсийг байлгаж цээрлүүлэх нь үр дүнтэй, шоронд л хийчихвэл болно гэсэн хандлага тал хувьд нь байхад* энэ нь буруу санал нийлэхгүй байгаа нь 35 орчим хувийг эзэлж байна.

[736] "Рецедив гэмт хэрэгтэн" гэдэг нь дадал олсон гэмт хэрэгтэн гэсэн утгатай үг, Б.Чимид

[737] ЦЕГ-ын МСТ-өөс 2008 оны 12 дугаар сард улсын хэмжээнд "Гэмт явдлын нийтлэг шалтгаан нөхцөл, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс"-ийг судлах зорилгоор явуулсан социологийн судалгаа



Хорих байгууллагад ял эдэлж байгаа хүмүүсээс суллагдаж гарсны дараа учрах бэрхшээлүүдийн талаар асуухад[738]ялтнуудын ихэнхи нь*"хорихоос суллагдахад учрах бэрхшээл ихтэй байдаг, нэн ялангуяа тэднийг амьдралд хүлээн авах хэн нэгэнтэй үл ойлголцох байдал бий болно, ажил олдохгүй байх"* гэсэн айдастай байхад, иргэд эсрэгээр шоронгоос суллагдсан хүмүүсийн талаар сөрөг төсөөлөл, хандлагатай байдаг нь ажиглагдлаа.

Ял шалгах хуудас:

Улсын Дээд Шүүхийн Ерөнхий шүүгч, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2008 оны А/113, 547, 494 тоот захирамж, тушаалаар батлагдсан "Шүүхээр ял шийтгэгдсэн хүмүүсийн тоо бүртгэлийг хөтлөх, лавлагаа олгох заавар"-ын 23-д зааснаар эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хянан шалгах, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааны явцад тухайн гэмт хэрэгт холбогдсон этгээдийн хувийн байдал, эрүүгийн хариуцлагын хэр хэмжээ, шинж чанарт нөлөөлөх нөхцөлүүдийг бодитой тогтоох зорилгоор Мэдээлэл, судалгааны төвөөс ял шийтгэгдсэн эсэхийг шалгах хуудсаар лавлагаа авдаг. Энэхүү "ял шийтгэлийн лавлагаа" авах ачаалал,дугаарлалттай болж, иргэдийн лавлагаа авах эрэлт, хэрэгцээ улам бүр өссөөр байна[739].

Мөн төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад ажил, сургууль, уралдаант шалгалтад орох иргэнээс ч бүх тохиолдолд ял шийтгэлийн тухай лавлагааг гаргуулж авдаг болжээ.[740] Иймээс ял шийтгүүлж байсан этгээд нийгэмд ажил хийх ямар ч боломжгүй, ялгаварлан гадуурхагдах үндсэн нөхцөл болж байна. Иймд энэ асуудлыг төрийн түвшинд авч үзэх, тогтолцоог өөрчлөх, ял шийтгэгдсэн тодорхойлолт авах шаардлага, шалгуурыг тодорхой болгох, цөөлөх, нарийвчлах зүй ёсны шаардлага байна.

[738] "Хорих ялын үр нөлөө" ХЗҮХ-ийн ЭЭЗКС-ын 2008 онд хийсэн судалгаанаас

[739] Мөн тэнд

[740] ХЭҮК, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл. 2009 он.160 дах тал

Эрүүгийн гэмт хэрэг нь санаатай болон болгоомжгүйгээр үйлдэгддэг, тухайн хүний хийсэн үйлдэл, эс үйлдэл нь гэмт хэрэг мөн эсэх нь үзэл бодлын үүднээс харьцангуй маргаантай тул *ял шийтгүүлсэн хүмүүсийг бүх насаар нь гэмт хэрэгтэн, ял шийтгэгдэж явсан бүтэлгүй этгээд гэж үзэх үнэлэмж нь хүний эрхийн зарчимд нийцэхгүй юм.*

Өршөөл үзүүлэх тухай хуулиар суллагдсан хүмүүсийн тоо мэдээг үзвэл:[741]



Энэ үзүүлэлтээс үзэхэд Өршөөл үзүүлэх хуулинд хамрагдсан хүмүүсийн тоо 2000 оноос хойш буурсан байна. Харин эсрэгээр ялаас хэсэгчлэн хассан хүмүүсийн тоо өсчээ. Судалгаанаас харахад гэмт хэрэг үйлдэж буй этгээдүүд эмэгтэйчүүд рүү халдах нь элбэг байна. Гэмт хэрэгтнүүд голдуу хүчин, дээрэм, танхай, хулгайн гэмт хэрэг үйлддэг. 2009 оны Өршөөл үзүүлэх тухай хуулиар хорихоос суллагдаад харих мөнгөгүйн улмаас дахин хулгай хийсэн нэгэн залуу олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр ярихдаа "*Би тэгээд харих мөнгөгүй яах байсан юм. Ахиад тэнд чинь очъё*" гэзд ярьж байгаа нь нэгийг бодогдуулах.

Судлаачдын хийсэн дүгнэлтээс үзэхэд өршөөлд хамрагдаж суллагдсан хүмүүс дахин гэмт хэрэг үйлдэх явдал нийт өршөөлд хамрагдагсадын 3-5 хувь байдаг боловч энэхүү бага гэж хэлж болох хэмжээ нь иргэдэд шууд нөлөө үзүүлдэг нь тодоор мэдрэгддэг байна.

Жишээ: Булган аймгийн Тэшиг суманд гэртээ үлдсэн охиныг хүчиндэн, улмаар амь насыг хөнөөн, нууранд хаясан хэргийг Өршөөл үзүүлэх тухай хуулиар суллагдсан 20 настай "махан толгой" хочит Тулга гэгч үйлджээ.

Тулга нь 2002 онд хулгайн хэргээр шоронд ял эдлээд суллагдсаны дараагаар дээрмийн хэрэг хэрэг үйлдэж мөн л хорих ял шийтгүүлсэн байна. Энэхүү ялаа эдлэж байхдаа 2009 он Өршөөл үзүүлэх тухай хуульд хамрагдан суллагдсан хойноо дээрх аймшигт хэргийг үйлджээ. Гэмт хэргийн үйлдлийн арга нь улам хүч хэрэглэсэн, хэрцгий шинжтэй болж байгаа нь илэрхий байна.

Санал асуулгын хүрээ: Урьд нь ял шийтгэгдсэн хүмүүс дахин гэмт хэрэг үйлдэж буй талаар гэмт хэрэг, зөрчлийг шалгаж шийдвэрлэж буй нийт **50**

741 ШШЕГ-ын Тогтоол Гүйцэтгэх газраас ирүүлсэн мэдээ

гаруй цагдаагийн алба хаагчдаас нээлттэй асуулгаар анкетээр судалгаа авлаа.

- Захиргааны хяналтын үр нөлөө, түүнд учирч буй хүндрэл бэрхшээл, амиа хорлох болон золгүй байдлаар амь насаа алдах гэмт хэрэг, дахин гэмт хэрэг үйлдэж буй этгээдийн талаар нийт ***20*** хэсгийн байцаагч, ***25*** захиргааны хяналт тогтоосон хүмүүстэй тус тусад нь уулзаж, ярилцлагын судалгаа.

- Хэнтий аймаг, Баганаур дүүрэг дэх 419, 427 дугаар хорих ангийн нийт 40 ялтантай уулзаж, дахин давтан гэмт хэрэг үйлдэж буй шалтгаан нөхцөл, дээрээс нь хорих ялын үр нөлөө, захиргааны хяналт тогтоож буй өнөөгийн арга механизмын талаар биечлэн тодорхой асуулгаар ярилцлагын судалгаа хийлээ.

Суллагдаад дахин гэмт хэрэг үйлдэж байгаа шалтгааны бодит дүр зургийг харахад:

➢ *Ажил олдохгүй, олдсон ч ажиллах боломжгүй*

➢ *Санхүүгийн эх үүсвэргүй, мөнгөгүйн улмаас өмчийн эсрэг гэмт хэрэг гол төлөв үйлддэг. Энэ хулгайн гэмт хэргийн 30 хувь нь давтан үйлдэж байгаагаас харагдаж байна.*

➢ *Бэлгийн болон гэр бүлийн асуудлаа шийдвэрлэж хэн нэгэнтэй харилцаа тогтоож, нийгмийн бусад гишүүдийн дунд орж чадахгүй байх*

➢ *Асуудлыг хүчээр шийдвэрлэх хандлага*

Хорих байгууллагын нийгмийн ажилтнуудтай хийсэн ярилцлагаас:

"Шоронд байдаг гал хам, эсвэл янз бүрийн бүлэг нь элдэв хүчирхийлэл, гэмт хэрэг үйлдэх арга, зан аранжинг бусаддаа халдаадаг. Өнөөдөр хүн шоронд тэр байтугай хэдхэн хоног урьдчилан хоригдоод гэмт хэрэгт суралцаад гардаг нь үнэн. Нийгмийн ажилтан нь өөрөө үүнийг засч залруулах үүрэгтэй ч бодит байдал дээр ажлын стресст хүчтэй ордог. Үүнээс шалтгаалан хоригдогсодтой зүй бус харьцах асуудал гардаг. Үнэндээ шоронд байгаа хүмүүсийн ихэнх нь муу хүмүүс буюу бидний ярьдагаар яадгаа алдсан гэмт хэрэгтнүүд биш байдаг ч эелдэг зөөлөн харьцахаараа давардаг" гэж байлаа.

Хүүхдийн хорихын талаар судалгаа хийсэн судалгааны дүнгээс үзэхэд хүүхдийн урьдчилан хорих анги, шоронд "судар солилцох" гэсэн ойлголт байдаг бөгөөд ихэнхи нь үйлдсэн гэмт хэргээ ярьж, нөгөөдөө хэрэг худалдах процессийг хэлдэг юм байна.

Хүүхдийнх ч, насанд хүрэгчдийнх ч бай шоронгоос суллагдсан хүмүүсийг орон нутагт нь хүргэх талаар хуулийн заалт байдаг ч замын унааны мөнгө гэж багахан хэсгийг өгдөг. Суллагдаж очоод "гэмт хэрэгтэн" гэсэн бичигдээгүй пайз зүүж амьдардаг.Тэр ч байтугай суллагдсан хүмүүсийн нэг нь ч ажилд ороогүйгээр барахгүй дахин нийлж өсвөр насны охиныг бүлэглэн хүчиндсэн гэмт хэрэг үйлдсэн жишээ баримт байна. Энэ нь өнөөгийн манай нийгмийн бодит дүр зураг юм.

Нийгэмшүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн байгууллагаас хийж буй ажил:

2009 онд батлагдсан "Өршөөл үзүүлэх тухай" хуулиар л гэхэд нийслэлийн хэмжээнд 1042 хүн шоронгоос суллагдсан. Тэднийг дахин гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх ажлыг дүүргүүдийн хэмжээнд зохион байгуулсан. Тухайлбал: Чингэлтэй дүүргийн цагдаагийн хэлтэс, ИТХ, ИБМТ хамтран эдгээр хүмүүсийг бичиг баримтжуулахаас гадна цагдаагийн байгууллагаас батлан даалт гаргаж, ажилд зуучлах зэрэг үр дүнтэй арга хэмжээг явуулж байгаа боловч энэ нь нийт өршөөлөөр суллагдсан хүмүүсийг бүрэн хамарч чадахгүй байгаа юм. Ялангуяа хэрэг буртгэлт, мөрдөн байцаалтын шатанд шалгагдаж байхдаа өршөөлийн хуульд хамрагдсан этгээдүүдэд энэ нь бүр ч боломжгүй байна.

Өршөөлөөр суллагдсан этгээдүүдийг өдөр тутам дагаад яваад байх аргагүй ч тэднийг гэмт хэрэг үйлдэх гэмт санаа бодлоос нь татгалзуулах нэг бүрчилсэн арга хэмжээний нэг нь заавал тусгайлсан богино хугацааны нийгэмшүүлэхэд нөлөөлөхүйц эрх зүйн, нийгэм, хүмүүжлийн шинжтэй сургалт, хөтөлбөрт зайлшгүй хамруулах явдал байж болох юм.

Хорих байгууллагаас суллагдсан хүмүүсийг нийгэмшүүлэх, нийгмийн хариуцлагатай аж ахуйн нэгж, байгууллагаар дамжуулан ажилд зуучлах ажлыг нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, засаг захиргааны болон төрийн бус байгууллагуудын хамтын идэвхи санаачлагаар идэвхжүүлж ажиллах ёстой.

Хорих ял эдэлсэн байдал: Монгол Улсад сүүлийн 10 жилийн дунджийг авч үзвэл 7272 хүн хорих ял эдэлсэн байна. Практик алба хаагчдийн хийсэн судалгааны дүнгээс[742] үзэхэд жилдээ хорих байгууллагаар дамжиж байгаа хүмүүсийн тоо 12000 байдаг гэсэн боловч хорих байгууллагын албаны хүний дүгнэлтээс үзэхэд хуучин Эрүүгийн хууль үйлчилж байх үед жилд дунджаар 8000 орчим хүн хорих ял эдэлсэн гэсэн нь хол зөрүүгүй дүгнэлт юм.[743]

[742] Ц.Мөнхбат. УЕПГ-ын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавх хэлтсийн хяналтын прокурор., "Хорих ялын хэрэгжилт өнөөгийн байдал", эрдэм шинжилгээний өгүүлэл, Хууль дэсдлэх ёс сэтгүүл 2006 оны №2., 73 дах тал

[743] Д.Дамдинцэрэн. "Шүүхийн шийдвэр, түүний хэрэгжилт" илтгэл. "Эрх зүйт төр-хууль ёсны хэрэгжилт" /Үндэсний зөвлөгөөний илтгэлүүд/. 2008 он. 162 дахь тал.

Үүнийг цааш судлан үзвэл: /Prison Brief for Mongolia[744]

Шоронгийн захиргаа	***Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газар***
Шоронд байгаа хүний тоо /цагдан хоригдож байгааг орсон/	**7,265** at 2010 /U.S. State Department human rights report/
Ял эдэлж байгаа хоригдлын дундаж тоо /100.000 хүн тутамд/	**269** /2.7 сая хүн амтай/
Эмэгтэй хоригдол /нийт хоригдлын дунд эзлэх хувийн жин/	**6.2%**
Хүүхэд /нийт хоригдлын дунд эзлэх хувийн жин/	**1.0%** /2010 - under 18/
Хорих газар /Number of establishments /	**62** /25 prisons for sentenced prisoners, 26 detention houses, 11 arresting houses/
Хорих ял эдэлсэн байдал	1993 - **6,085- /270/** 1996- **6,070- /265/** 1999 **6,414/271/** 2002 **7,256/296/** 2005 **6,998/274/** 2008 **7,570/287/**

***<u>Хорих ялын өртөг</u>*: Нэг жилд нэг ялтанд хорих ял эдлүүлэхэд дунджаар 815859 төгрөг улсын төсвөөс зарцуулагддаг бөгөөд ялтнуудад хорих байгууллагын нийт төсвийн 67 хувийг зориулагддаг.**[745] *Сүүлийн 3 жилийн дунджаар 7272 хоригдол ял эдэлж байна хэмээн үзэх юм бол зөвхөн хорих үйл ажиллагааанд 1 жилд 5 тэрбум 932 926 648 төгрөг төсвөөс зарцуулж байна. Үүний чамгүй хувийг давтан гэмт хэрэг үйлдсэн ялтнуудад зарцуулдаг.*

<u>Олон улсын туршлага</u>

ОХУ: Ялтныг нийгэмшүүлэх ажил нь хэд хэдэн үе шатанд хуваагддаг. Энэ нь *нийгэм-эрүүл мэндийн, хөдөлмөр мэргэжлийн, эрх зүйн, сэтгэл заслын, ахуй-нийгмийн* гэж хуваагддаг. Эдгээр нь тус бүртээ өөрийн гэсэн нийгэмшүүлэх тодорхой аргатай байдаг.

Эдгээр нийгэмшүүлэх ажлыг амжилттай, үр дүнтэй болгохын тулд үе шаттай байх, бүрэн дүүрэн байх, залгамж холбоотой байх, үр дүнтэй байх зарчмуудыг баримтлахаасихээхэн хамаардаг. Мөн нийгэмшүүлэх ажиллагааг явуулахдаа сайн дурын болон үүргийн, үнэ төлбөргүй болон хүртээмжтэй зарчмыг баримтлан энэ төрлийн үйлчилгээ зайлшгүй хэрэгцээтэй байгаа

[744] http://www.prisonstudies.org/info/worldbrief/wpb_country.php?country=104 /last visited 2011.10.31/

[745] Монгол Улсын хорих байгууллагын төрөл дэглэмийг нээлттэй, хаалттай тогтолцоонд шилжүүлэх зарим асуудал" хэлэлцүүлэг., 2010 он. 32 дах тал

хэсэгт /тухайлбал, ганц бие эх, өндөр настан, тэтгэврийнхэн, хөгжлийн бэрхшээлтэй болон өвчтэй хүмүүс, ажилгүйчүүд, шилжин суурьшигсад, дүрвэгсэд/ хүрч үйлчилдэг.

Энэхүү олон талт нийгэмшүүлэх ажил нь засан хүмүүжүүлэх газар эхэлдэг бөгөөд үүнд хамрагдагсдын хувийн чадавх нь нийгэмд байр сууриа бүрэн дүүрэн олох боломжтой болох хүртэлх хугацаанд хэрэгждэг[746].

Тусгаар тогтносон улсуудын хамтын нөхөрлөлийн орнуудын хүрээнд "Криминон СНГ" гэсэн бие даасан ашгийн бус байгууллага үйл ажиллагаа явуулдаг. Уг байгууллагын бүтэн нэр нь Хууль зөрчигчдийг нийгэмшүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Криминон СНГ төв гэдэг бөгөөд 2010 оны 6 дугаар сарын 17-ны өдөр ОХУ-ын Хууль зүйн яаманд бүртгэгдсэн байна. Үүнээс өмнө "Эйбл СНГ" гэдэг буяны сангийн салбар байдлаар үйл ажиллагаагаа явуулж иржээ. Энэхүү байгууллага нь "Криминон" хөтөлбөрийн зорилгод хүрэхийг хүссэн байгууллага, аж ахуйн нэгж, сайн дурынхныг нэгтгэж байдаг. Уг хөтөлбөрийн зорилго нь гэмт хэргээс ангид аюулгүй нийгмийг бий болгох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ялтныг нийгэмшүүлэх юм. Хөтөлбөрийн хүрээнд "Криминон-Новосибирск", "Криминон-Надежда"/Украйн/, "Криминон-Урал"/Екатеринбург/, "Криминон-Уфа" гэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Мөн Санкт-Петербург, Москва, Самара, Барнаул зэрэг хотуудад зайны сургалтын сүлжээ ажилладаг байна.

ОХУ-д "Криминон" хөтөлбөр нь 1996 оноос хэрэгжиж байгаа бөгөөд "Аз жаргалд хүрэх зам" нэрийн дор явуулсан туршилт хөтөлбөрийг Шахов дахь засан хүмүүжүүлэх газар /1996-1997/, Оренбург муж дахь эрэгтэйчүүдийн чанга дэглэмтэй хорих ангид /1999-2000/ тус тус явуулсан байна. Туршилтын багийг 55 ялтнаас бүрдүүлж байсан бөгөөд сургагч нар шууд газар дээр нь ажиллажээ.

Хөтөлбөр болон нэмэлт сургалтыг амжилттай төгссөн ялтнууд хөтөлбөрийг бусаддаа зааж сургах туршлага өргөжиж байгаа бөгөөд Челябинск болон Омск дахь хорих ийм маягаар сургагч багш бий болсон байна.

2010 оны 2 дугаар сарын 17-ны өдөр ОХУ-ын Холбооны бүгд хурлаас "Ял эдлэгсдийг нийгэмшүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох тухай" тогтоол гарсан байна. Үүнд ял эдлэж байгаа болон хорих ял эдлээд суллагдсан этгээдийг эргэж нийгмийн хэвийн амьдралд оруулах нь төрийн болон эрүүгийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, иргэний нийгмийн чухал асуудал гэдгийг онцлоод, сүүлийн жилүүдэд эрүүгийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудад ялын альтернатив бодлого болон аливаа шийтгэлийг энэрэнгүй ёсонд нийцүүлэх чиглэл баримтлах хэрэгтэйг дурджээ. Мөн сүүлийн 10 жилийн хугацаанд 3 сая хүн хорих ял эдлээд суллагдсан ба гэмт хэргийн 35 хувийг онц аюултай гэмт хэрэг эзэлж байгааг дурдсан байна.

[746] //www.socialwork.ru/index.php?=option

Герман: Ял эдэлж дууссаны дараа эргэд нийгэмд ороход нь туслах зорилгоор болон нийгэмтэйгээ адил хөгжих хүний эрхийг хүндэтгэх үүргээ биелүүлэхийн тулд Герман улс нь ял эдэлж байгаа хүмүүст тусгай боловсрол эзэмших янз бүрийн арга хэмжээг зохион байгуулдаг бөгөөд өөрөө хөгжих, эргэд нийгэмд орох зэрэгт байнга бэлддэг. Ялаа эдэлж дууссаны дараа ялтан нь сурсан боловсорлоороо *"Ажил олгох газар"*-т бүртгүүлэх бөгөөд хорих ял эдлээд суллагдсан хэнд боловч үйлдчилдэг. Ажил эрхлэх чадвараас нь хамаараад тохирох ажлыг нь хайх бөгөөд боломжгүй бол нөхөн олговор олгодог.Ажилгүйдлийн мөнгө нь хамгийн багадаа 400 орчим еврогоос эхлэн олгодог. Мөн энэ хугацаандаа тухайн хүний ажил эрхлэхэд нь саад болж буй бэрхшээлийг алга болгохын тулд сургалт, арга хэмжээ зохион байгуулдаг ба үүнд оролцох эрхтэй байдаг. Хүүхэд боловсрол эзэмшиж амжаагүй байдаг учраас шүүхээс ял ногдуулахдаа боловсрол эзэишүүлэхэд нь таслахгүй байх, нийгмээс нь хөндийрүүлэхгүй байхад нь хамгийн ихээр анхаардаг. Тиймээс *"насанд хүрээгүйчүүдэд туслах төв"*гэж төрийн байгууллага байдаг бөгөөд энэ нь гэмт хэрэгт холбогдосн цагаас эхлэн хүүхдийн эрх ашгийг хамгаалдаг бөгөөд шийдвэрлэгдээд дууссан ч тэр хүүхдийг нийгмэд байр сууриа олтол нь тусалж дэмждэг.

Германд ялтныг нийгэмшүүлэх чиглэлээр тугайлан бэлтгэсэн мэргэжилтнүүд ажилладаг бөгөөд насанд хүрсэн хүн, хүүхдэд хүртэл ялгаатай сурган хүмүүжүүлэгч, сэтгэл зүйч, мэргэжилтнүүд үйлчилдэг. Өөр нэг чухал зүйл нь *Ausbildung /мэргэжил олгох сургалт-их дээд сургуулиар олгох шаардлагагүй, сургалт үйлдвэрлэлийн төв/* тогооч жолооч, даатгалын ажилтан, мужаан, слесарь гэх мэт мэргэжил олгодог байна. Эдгээрийг санал болгосон байгууллагуудад хүргүүлдэг бөгөөд үүнийг хорих анги болон өөр төлрийн ял эдэлж байгаа хүмүүсийн дунд зохиодогтөдийгүй суллагдсан хүнд ч хамааралтай байдаг байна. Энэ нь дараа нь энгийн амьдарлаа цааш нь хэвийн үргэлжүүлэхэд нилээд чухал үүрэгтэй байдаг бас баталгаа болдог байна.

Энэ бүгдээс харвал Герман улсад хүний эрхийг өндөрт тавьж үздэг төдийгүй ял эдлэх нь тухайн гэм буруутай үйлдэлд нь оногдуулах арга хэмжээ бөгөөд үүнийг цааш нь хэтрүүлж хэрэглэж болохгүй гэж үздэг. Жишээ нь: хорих ял эдэлж байгаа хүний нийгмээстусгаарлагдахаас бусдаар тусгаарлагдсан байрандаа бүх эрхээ эдлэх боломжтой байдаг. Герман иргэний нийгмийн баталгаа гэх зүйл нь ял эдэлсэн хүнд ч үйлдчилдэг. НҮБ-ын Хүний эрхийн дүрмүүд ялтантай харьцах наад захын жишиг дүрмийн заалтуудыг бараг бүгдийг хуулиндаа ч, амьдралдаа хэрэгжүүлж чадсан байна.

Япон: "Суллагдагсдад тусламж үзүүлэх тухай", "Насанд хүрээгүй ялтны ялыг эдлүүлэх байгууллагын тухай", "Шоронгийн тухай хууль" болон бусад эрх зүйн актуудаар энэхүү харилцааг зохицуулдаг байна.

Монгол Улсын хууль эрх зүйн орчин:

№	Хуулийн заалт	Дүгнэлт
1	Цагдаагийн байгууллагын тухай хууль 10 дугаар зүйл. Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх 5. ... давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хорих ял эдэлж суллагдсан хүнд захиргааны хяналт тогтооно.	Хуулийн заалтаас үзэхэд захиргааны хяналт тогтоох эрх нь цагдаагийн байгууллагад байна. Хяналтын үндсэн зорилго нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бөгөөд хүний эрх ашгийн үүднээс ямар нэг заалт оруулаагүй байна.
2	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 124 дүгээр зүйл. Хүмүүжлийн ажлын хэлбэр, зохион байгуулалт 124.1.Ялтныг эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах болон бусад чиглэлээр хүмүүжлийн ажил зохион байгуулна. 124.3.Ялтандхүмүүжлийн нөлөө үзүүлэх, тэднийг хамтач үйл ажиллагааны хэм хэмжээнд сургах зорилгоор ялтны сайн дурын байгууллага ажиллуулж болно. 125 дугаар зүйл. Хорих анги дахь сургалт 125.1.Насанд хүрээгүй ялтныг ерөнхий боловсролын сургалтад бүрэн хамруулж, бусад ялтан бие дааж мэдлэгээ дээшлүүлэхэд хорих анги туслалцаа үзүүлнэ. 25.2.Боловсролын сургалтыг зөвхөн хорих ангийн байранд зохион байгуулна. 125.3.Хорих анги нь өөрийн эрхэлж байгаа үйлдвэрлэлийн чиглэлээр ялтанд хөдөлмөрийн дадлага олгох, мэргэжил эзэмшүүлэх сургалт зохион байгуулж болно.	Шоронд хорих ангид ял эдэлжэ байгаа хүмүүст авах арга хэмжээний гол зорилго нь хүмүүжлийн нөлөө үзүүлэх, тэднийг хамтач ажиллагааны хэм хэмжээнд сургах явдал байна. Үүнд: хүмүүжлийн ажлыг заавал байлгах утгаар биш харин байж болно гэдгээр оруулжээ. Сургалтын зорилго нь: • Насанд хүрээгүй ялтныг заавал сургах, ерөнхий боловсрол олгох үйл явцыг тасалдуулахгүй байх • Хөдөлмөрийн дадлага олгох, мэргэжил эзэмшүүлэх Шоронгийн аливаа харш, буруу гэмт зан үйлийг арилгах, түүнийг таслан зогсоох талаар тодорхой хуулийн заалт байхгүй байна.

3	<u>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль</u> 15 дугаар зүйл. Хорих ял эдлэхэд суллагдсан хүнд захиргааны хяналт тогтоох Эрүүгийн1 хуулийн 73-75, 86, 90, 111-113, 123, 125, 127, 239, 254 дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт 5-аас дээш жил хорих ял эдлэлсэн, эсхүл түүнийг давтан үйлдсэн хүн хорих ял эдэлж суллагдсан бол дахин гэмт хэрэг үйлдэх, нийгмийн хэв журам зөрчихөөс нь урьдчилан сэргийлэх зорилгоор захиргааны хяналт тогтооно. ... этгэзд хорих ял эдэлж суллагдаад байнга оршин суух газартаа очсоноос хойш 3 хоногийн дотор цагдаагийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй. 15.3. Хорих байгууллага хорих ял эдэлж байгаа хүнийг суллагдахаас 30 хоногийн өмнө байнга оршин суух газрын цагдаагийн байгууллагад түүний суллагдах тухай мэдэгдлийг зохих тодорхойлолтын хамт хүргүүлнэ.	Үүнээс үзэхэд төрийн эсрэг, хүний нэр төр, алдар хүндийн эсрэг, хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг үйлдэж 5-аас дээш жил хорих ял эдэлсэн, дэзрх гэмт хэргийг давтан үйлдсэн хүмүүст захиргааны хяналт тогтоохоор заажээ.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

	15.4. Захиргааны хяналтад байгаа хүний үүрэг: Нийгмийн хэв журмыг сахих;сард 1 удаа цагдаагийн байгууллагад бүртгүүлэх;цагдаагийн байгууллагаас дуудсан цагт саадгүй ирэх;байнга оршин суугаа газраасаа 14 хоногоос илүү хугацаагаар явах, гадаад улсад зорчих бол цагдаагийн байгууллагад мэдэгдэх;цагдаагийн байгууллагын шаардлагыг биелүүлэх. 15.7. Захиргааны хяналт тавих цагдаагийнбайгууллагынэрх:Захиргааны хяналтад байгаа хүний зан төрх, үйл ажиллагааны талаар ажиллаж байгаа болон оршин суугаа газрын нутгийн захиргааны байгууллагаас тодорхойлолт гаргуулж авах. захиргааны хяналтад байгаа хүн гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор болон хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр түүнийг хэдийд ч дуудан ирүүлэх, зөвлөгөө өгөх, шаардлага тавих, анхааруулах; Захиргааны хяналтаас зайлсхийсэн этгээдийг эрэн сурвалжлах, албадан ирүүлэх. 15.8. Захиргааны хяналтыг цагдаагийн зохих шатны байгууллагын даргын шийдвэрээр 1-3 жил хүртэл хугацаагаар тогтооно. 15.9. Шаардлагатай гэж үзвэл захиргааны хяналтын хугацааг 6 сараас 1 жил хүртэл хугацаагаар сунгаж болох боловч нийт хугацаа нь уг этгээдийг ял шийтгэлгүй болохоор хуульд заасан хугацаанаас хэтэрч болохгүй. 15.10. Захиргааны хяналтад байгаа хүн засрал хүмүүжил олсноо харуулбал түүний энэ талаар гаргасан өргөдлийг хянан үзэж, хугацаанаас нь өмнө захиргааны хяналтыг зогсоож болно. 15.11. Захиргааны хяналтад байгаа хүний хяналтын хугацаа дуусан, эсхүл ял шийтгэлгүй болсон бол уг хяналтыг тавьж байгаа цагдаагийн байгууллагын даргын шийдвэрээр захиргааны хяналтыг зогсоож, бүртгэлээс хасна.	Одоогийн байдлаар хорих ял эдлээд суллагдсан хүмүүс дараахь үүрэг хүлээж байна. Үүнд: • нийгмийн хэв журмыг сахих; •сард 1 удаа цагдаагийн байгууллагад бүртгүүлэх; •цагдаагийн байгууллагаас дуудсан цагт саадгүй ирэх; •байнга оршин суугаа газраа өөрчлөх тохиолдолд хяналт тавьж байгаа цагдаагийн байгууллагад мэдэгдэж шинээр очсон газрынхаа цагдаагийн байгууллагад 3 хоногийн дотор бүртгүүлэх •байнга оршин суугаа газраасаа 14 хоногоос илүү хугацаагаар явах, гадаад улсад зорчих бол цагдаагийн байгууллагад мэдэгдэх; •захиргааны хяналт тавьж байгаа цагдаагийн байгууллагын шаардлагыг биелүүлэх гэсэн хэлбэртэй байгаа бол Харин төрийн байгууллагаас хүлээсэн үүрэг, тэдэнд туслалцаа дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны болон эрх зүйн зохицуулалт байхгүй байна. Түүнчлэн шоронгоос суллагдсан хүнийг нийгэмд амьдрахад нь туслалцаа үзүүлэх эрх зүйн орчин байхгүй байна.

Журам:

№	Журам, тушаал, заавар	Агуулга
1	"Захиргааны хяналтыг сайжруулах тухай" 2003 оны №285/А/127 тоот Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын даргын хамтарсан тушаал	Сэжигтэн яллагдагчид тавих хяналтыг сайжруулж, хаяг тодруулах, ял шийтгэлийн байдал, биеийн онцлог шинж тэмдэг, гарын дардас, гэрэл зургийг нь авч санд ирүүлэх, хяналтаас зайлсхийсэн, хаягандаа байхгүй байгаа хүмүүсийг олж тогтоох, хүлээх хариуцлагын талаар суллагдсан хүмүүст ойлгуулах, хүүхдийг суллагдлахаас нь өмнө цагдаагийн хэлтсийн хүүхдийн байцаагчид хүлээлгэн өгөх талаар ажил зохиох талаар заавар өгчээ.
2	"Ажлын ур дүнг дүгнэх аргачлал" ЦЕГ-ын 2008 оны 1 дүгээр сарын 27-ний өдрийн №46 тоот тушаал.	Энэ аргачлалаар хэсгийн байцаагчийн ажил үүргийн хуваарь, ажил дүгнэх үзүүлэлт зэргийг хавсарган баталсан бөгөөд ярилцлагын судалгааны явцад дурдсан суллагдсан хүмүүст тавих хяналтын тоон үзүүлэлт нь ороогүй байна. Хэдий тийм ч шууд удирдах дарга, албан тушаалтнаас захиргааны хүмүүст сардаа нэг удаа дуудаж уулзан, хяналт тавиагүй бол тухайн алба хаагчид арга хэмжээ авч, хариуцлага тооцдог байна.

Хөтөлбөр: Судалгааны ажлын явцад Монгол улсад хорих ялтныг нийгэмшүүлэхтэй холбоотой нэг хөтөлбөр гарсан нь сайшаалтай боловч үүний үр дүнг тооцох, ололттой талыг мэдэх бололцоогүй байна. Үүний учир нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2009 оны 198 дугаар тушаал, ШШГЕГ-ын даргын 2009 оны 10 дугаар сарын 14-ны №А/91 тоот тушаалын хавсралтуудаар батлагдсан хөтөлбөр нь дөнгөж хэрэгжиж эхэлж байгаа болно.

Хөтөлбөрийн хүрээнд зайлшгүй шийдвэрлэх асуудал нь:

1.Ял эдлэгсдэд хүмүүжлийн нөлөө үзүүлэн төлөвшүүлэх,

2.Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэн, хөдөлмөрийн дадал олгох,

3.Тэднийг гэмт хэргийн улмаас хохирсон иргэдтэй ойртуулах, эвлэрүүлэн зуучлах, бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авах, ялтныг суллан гарахад бэлтгэх шаардлагатай хэмээн үзэж тус төлөвлөгөөг баталжээ.

Цаашид төрийн зүгээс хорихоос суллагдсан хүмүүст чиглэсэн бодлого боловсруулахдаа энэхүү хөтөлбөртэй зайлшгүй уялдуулах хэрэгтэй юм.

Эрх зүйн орчны талаарх дүгнэлт: Ийнхүү дээрх нөхцөл байдлаас дүгнэн үзэхэд хорихоос суллагдсан хүмүүсийг нийгмийн ажил, үйлчилгээнд зуучлах, туслалцаа үзүүлэх эрх зүйн орчин байхгүй байна. Харин Цагдаагийн байгууллагын тухай болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулиудад хорих байгууллагад байгаа болон суллагдсан хүмүүст тавих хяналтын талаар дэлгэрэнгүй зааж, тусгаж өгчээ.

Практикт хуулийн байгууллагын үйл ажиллагаа тухайлбал цагдаа, прокурорын байгууллагын хуулиар заасан дээрхи ажиллагаанд иргэд шүүмжлэлтэй ханддаг. Ялангуяа суллагдсан хүмүүст дарамт учруулдаг, алдсан дээр нь дахин түлхдэг, тэднийг нийгэмд хэвийн ажиллаж амьдрахад нь саад учруулж байгаа тухай захиргааны хяналтанд байгаа судалгаанд хамрагдсан зарим хүмүүсээс саналаа илэрхийлж байв.

Түүнчлэн хорих байгууллагад давтан гэмт хэрэг үйлдсэн хүмүүст зарцуулж байгаа төсвийг багасгах, нийгэмд хор аюултай гэмт хэрэг үйлдэхээс өмнө урьдчилан сэргийлэх нь шийдвэрлэвэл зохих асуудал юм.

Цаашид эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр ХЗДХЯ-ны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, хорих анги ялтныг нийгэмшүүлэх хөтөлбөр батлан хэрэгжүүлж, Хорих байгууллагын төрөл, дэглэмийг 2012 он гэхэд нээлттэй хаалттай системд шилжүүлэх талаар хуулийн төсөл боловсруулан ажиллаж байгаа нь сайшаалтай байна.

Хэдий ийм ч шоронгоос суллагдсан хүмүүст дэмжлэг туслалцаа үзүүлэх эрх зүйн орчин бий болгох шаардлагатай юм. Үүний тулд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Цагдаагийн байгууллагын тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хорих ялтны гэмт зан төлөвийг арилгах, ажил хөдөлмөрт зуучлах, дэмжлэг үзүүлэх талаар тодорхой үр дүнтэй заалтуудыг оруулах хэрэгтэй.

Бодлогын хувилбар

Хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийг нийгэмд дасан зохицоход нь туслалцаа дэмжлэг үзүүлэх ажил нь нийгмийн үйлчилгээний нэг төрөл бөгөөд[747] үүнийг гадаадын зарим орны туршлагаас үзэхэд төрийн аль нэг институтаар гүйцэтгүүлдэг байна.[748]

Шоронгоос суллагдсан ялтныг нийгэмшүүлэх талаар дэлхийн улс орнуудад тогтсон хэд хэдэн хандлага байдаг. Үүнд:

1. Social control буюу нийгэм-захиргааны хяналт тогтоох гэсэн манай улсад байгаазагвар нь постсоциалист зарим оронд байдаг.Казакстан, Киргизстан гэх мэт.

2. Probation, Parol буюу тусгайлсан алба, ажилтан хяналт тавьж, дэмжлэг үзүүлэн ажиллах. Энэ нь зарим тохиолдолд "bootcamp, "halfway house" гэсэн хэлбэр буюу түр амьдрах, туслалцаа авах, орогнох зэрэг орон байр хэлбэртэй байна. Англо-Саксоны эрх зүйн тогтолцоотой орнуудад түгээмэл байдаг хэлбэр[749].

3. Imprisonment type: open and close: Хорих ялын нээлттэй хаалттай дэглэмийг нийгмийн ажлын үр дүнтэй хэлбэртэй хослуулан хэрэгжүүлэх

[747] Шоронгоос суллагдсан хүмүүсийг нийгэмшихэд нь туслалцаа дэмжлэг үзүүлэх ойлголтыг гадаадын зарим оронд нийтлэг байдлаар "resocialization эсвэл reintegration and rehabilitationof criminal offender" хэмээн томьёолдог бөгөөд тусгайлсан институтууд энэхүүйл ажиллагаг эрхлэн гүйцэтгэх үүрэгтэй байна.

[748] АНУ-д Halfway house нэртэй нэгж нь хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийг 120-180 өдөрт шаардлагатай бол түр байршуулах хэлбэрээр эргэн нийгэмшэхэд нь дэмжлэг үзүүлдэг бөгөөд хагас хяналттай үүндээ цагдаагийн байгууллагын туслалцааг авах хэлбэрээр хамтран ажилладаг.

[749] Тухайлбал: Англи улсад The rehabiltation of offender act -1974 гэсэн хууль үйлчилдэг бөгөөд түүнд заасан арга хэрэгслээр шоронд байгаа болон суллагдсан хүмүүст нийгмийн ажил, үйлчилгээ үзүүлэх хугацаа зэргийг зохицуулсан байдаг.

систем буюу Ром-Германы эрх зүйн тогтолцоотойзарим улс оронд бий. Тухайлбал Герман, Эстони, Европын холбооны зарим улсууд багтана.

4. Programm: Тусгайлсан хөтөлбөр гарган ажиллах буюу шоронгоос суллагдсан хүмүүсийг нийгэмшүүлэх хөтөлбөр нь эрх зүйн орчин харьцангуй сайн хөгжөөгүй улс орнуудад хэрэгждэг бөгөөд үүний нэг тод жишээ нь: Өмнөд Африкийн Бүгд Найрамдах улс юм[750]. Энэ улс нь ялтныг нийгэмшүүлэх хөтөлбөрийг 2002 оноос олон улсын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд үүндээ хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудыг өргөнөөр татан оролцуулж, төрийн зарим чиг үүрийг гүйцэтгүүлж байгаа сайн туршлагыг нэвтрүүлжээ.

ЗӨВЛӨМЖ

1. 2009 онд баталсан "Ялтныг нийгэмшүүлэх хөтөлбөр"-т хичнээн хамрагдсан ч гэсэн суллагдсан иргэн тодорхой дэмжлэг туслалцаа авч чадахгүй бол дээрхи хөтөлбөр нь ямар ч үр дүнгүй болох юм. Ийм учраас залгамж шинж чанартай, үр нөлөө бүхий хөтөлбөр боловсруулж, шоронгоос суллагдсан хүмүүст дэмжлэг туслалцаа үзүүлэх эрх зүйн орчинг бий болгох шаардлагатай.

2. Хорихоос суллагдсан хүмүүст тавих хяналтын хэлбэрийг эрс өөрчлөх хэрэгтэй байна. Өнөөдөр суллагдсан хүмүүсийг сардаа нэг удаа дуудаж хянах нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хэлбэр гэж үзэх нь өрөөсгөл. Цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэл, хорооны нийгмийн ажилтан гэсэн гурван байгууллагын ажилтны хуулиар хүлээлгэсэн чиг үүргийн хүрээнд шоронгоос суллагдсан хүмүүст чиглэгдсэн ажил хаягдаж байна. Цаашид хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагч, прокурорын ажил дүгнэх үзүүлэлтийг ч өөрчилж ***тусгайлсан алба нэгж хэлтэс байгуулж, энэ ажлыг хариуцуулах замаар шийдвэрлэж болохоор байна.*** Үүний тулд Засгийн газраас Пробацийн алба байгуулах талаар дорвитой шийдвэр гарган хэрэгжүүлж, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Цагдаагийн байгууллагын, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудад хорих байгууллагаас суллагдсан ялтныг ажил хөдөлмөрт зуучлах, нийгэмд ажиллаж амьдрахад дэмжлэг үзүүлэх талаар тодорхой заалтуудыг оруулах хэрэгтэй.

3. Шоронд байгаа болон шоронгоос суллагдах гэж байгаа, суллагдсан хүмүүсийг нийгмээс нь хөндийрүүлэхгүй байх, шоронд гэмт зан үйл, дадалд суралцуулахгүй байх, хэвийн ажиллаж амьдрахад нь туслалцаа дэмжлэг үзүүлэх үндэснийтгтолцоо бий болгох бодлогын боломжит хувилбарыгдэвшүүлж байна.Энэхүү тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх ажлыг үе шаттайгаар явуулж нийгмийн ажлын хэлбэртэй хослуулан хөгжүүлэх нь бодлогын гол цөм байх юм. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь дараах шинжийг агуулсан байвал зохино. Үүнд:

- Шоронд байгаа, суллагдах гэж байгаа суллагдсан хүмүүст чиглэсэн байх. Эдгээр хүмүүст чиглэсэн ажил нь хоорондоо уялдаа холбоо бүхий бодит үр дүн гарахад үндэслэсэн байх ёстой.

[750] "KC.Goyer. "Incarcerating and rehabiltitating offenders", 2002

• Хуулийн байгуулагуудын үйл ажиллагаанд хүндрэл учрахааргүй, уйлдаа холбоо бүхий шинжтэй байх. Хууль, журам, заавруд нь хэрэгжих боломжтой, өдөр тутмын үйл ажиллагаа тухайлбал өөр хооронд уялдаа холбоо бүхий процессыг тусгасан байх.

• Хэрэгжүүлэх арга зам, тэр дундаа туслалцаа дэмжлэг үзүүлэххэлбэрүүдийг зааж өгөх.Эдгээр хэлбэрүүд нь хууль,тогтоомжид харшлахгүй байх, шоронгоос суллагдсан хүмүүст чиглэсэн байх.

4. Цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж буй захиргааны хяналт гэсэн арга хэлбэр нь хорих байгууллагаас суллагдсан этгээдийг сард нэг удаа бүртгэх ажлыг ор нэр төдий, прокурорын шахаж шаардсанаар хийдэг ажлын хэлбэртэй, нийгмийн хэрэгцээ, шаардлагаас хоцрогдож байгаа нь илэрхий ажиглагдлаа. Тусгайлан байгуулагдах алба нь цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай өдөр тутмын харилцаатай, шаардлагатай бол тэдний хүч туслалцааг авах боломжтой, өөр төрлийн мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулах боломж нээлттэй бөгөөд орон нутагт төрийн бус байгууллага болон хүмүүнлэгийн чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг субьектүүдийг хорих байгуулагаас суллагдсан хүмүүсийг нийгэмшүүлэх ажиллагаанд татан оролцуулах зэрэг өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулах эрхтэй байна.

5. Урьд ял шийтгэлттэй хүмүүсээс дахин гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн нийгмийн хүчин зүйл нь ажилгүйдэл байгаа учраас орон нутагт байгаа мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд зуучлах, үүнд орон нутгийн захиргааны дэмжлэгийг авах, шийдвэр гаргуулах замаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг явуулах шаардлага байна.

Нийгмийн ажилтныг татан оролцуулах боломж:

Баг хороо бүрт хоёр нийгмийн ажилтан ажилладаг. Нэг нь сум дүүргийн засаг даргын тамгын газрын нийгмийн хөгжлийн хэлтэс нөгөө нь сум, дүүргийн хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэст харъяалагддаг бөгөөд төрийн захиргааны албан хаагч буюу ТЗ-2, ТЗ-3 аар цалинжин ажилладаг. Ажлын ачаалал их, иргэний шинэчилсэн бүртгэл, баг хорооны иргэний бүртгэлтэй холбоотой ажлууд, хүний хөгжил сангийн хувиарлалт, иргэдэд халамж олгох талаар өргөдөл гомдол хүлээн авч шийдвэрлэх гэх мэт ажлуудыг хариуцан ажилладаг юм байна. Хэдийгээр зарим дүүргийн хороодод хүн амын төвлөрөөс шалтгаалаад ажлын ачаалал их боловч орон нутагт харьцангуй бага байна.

Нийслэлийн Хөдөлмөрийн газрын холбогдох мэргэжилтэн, албан тушаалтнуудтай уулзаж ярилцахад[751] хорооны хөгжлийн нийгмийн ажилтан эн ажлыг гардан гүйцэтгэх бүрэн бололцоотой төдийгүй үндсэн чиг үүрэгт хамааралтай, ажлын ачаалалд үзүүлэх хүндрэл бэрхшээл бидний төсөөлж байснаас харьцангуй бага юм. Цаашид Нийслэлийн хөдөлмөрийн газар, аймаг, дүүргийн хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тулгуурлан шоронгоос суллагдсан

[751] Нийслэлийн хөдөлмөрийн газрын ажлын албан дарга н.Оюунгэрэл "НХГ-аас 2011 онд Хорих байгуулагад ял эдэлж байгаа болон хорих байгуулагаас суллагдсан хүмүүст чиглэсэн ажлыг хийж эхлүүлэхээр төлөвлөөд байгаа" гэсэн.

хүмүүсийг нийгэмд амьдрахад дэмжлэг үзүүлэх бодлогыг хэрэгжүүлэх чиглэл боловсруулвал зохино.

Нийгэм эдийн засгийн өртөг: Хэрэв урьд ял шийтгүүлээд суллагдсан хүмүүстэй ажиллах нийгмийн ажлын төрөл хэлбэрийг зөв сонгож хэрэгжүүлбэл ял эдлүүлэхэд гарч байгаа зардлыг хэмнэж болохоор харагдаж байна.

Сургалт: Баг хорооны нийгмийн ажилтныг чадавхи, ажлын ачаалал, мэргэжлийн ур чадвар харилцан адилгүй түвшинд байдаг, хүнтэй ажиллах арга барил, онцлог зэрэг шаардлагатай зарим үзүүлэлт хангалтгүй гэж цагдаагийн анхан шатны нэгж ажилтан үзэж байгаа[752] боловч үүнийг зохих сургалтаар шийдвэрлэж болно. Одоо хэрэгжүүлж байгаа хорих байгууллагын нийгмийн ажилтнуудад зориулсан сургалтуудтай[753] уялдуулан зохицуулж, харилцан туршлага солилцуулах хэлбэрээр явуулбал илүү үр дүнтэй.

--- x ---

Хүүхдийн асуудлыг тусгайлан авч үзэх нь

Бодлогын судалгааны хүрээнд хорих байгууллагаас суллагдсан хүүхийн асуудлыг тусгайд нь авч үзэх шаардлагатай хэмээн үзлээ. 2006, 2009 онуудад батлагдан гарсан "Өршөөл үзүүлэх тухай" хуулиар хорих 411, 407 дугаар ангиас суллагдсанхүүхдүүд ахин гэмт хэрэг үйлдэж шоронд орсон, эсвэл насанд хүрсэн хүмүүсийн хорих ангид дэглэм өгсөж хоригддог[754], 50-70 хувь нь суллагдсанаас хойш 3 жилийн дотор дахин гэмт хэрэг үйлдсэн байна.

Дээрхээс дүгнэн үзвэл шоронгоос суллагдаад хүүхдүүдийн тал нь ахин гэмт хэрэг үйлдэж байгаа нь онцгой анхаарал татаж байна. Ер нь хүүхдийг хорих ялаар удаан хугацаагаар шийтгэх нь "гэмт хэргийн карьер"-ийг ахиулдаг ба ирээдүйд мэргэшсэн гэмт хэрэгтэн бэлтгэх суурийг тавьдаг.

Хорих байгууллагын ажилтан болон сэтгэл зүйч, нийгмийн ажилтан нартай уулзаж ярилцахад *"шоронд удаан хугацаагаар байсан хүүхэд эргээд нийгэмд амьдрахад онцгой нөхцөл шаарддаг, энэ асуудал анхаарал хандуулахгүй байгаагаас хүүхдүүд гэмт хэрэг ахин үйлдэж, мэргэшиж байна. Өршөөл үзүүлэх тухай хуулиудын дараагаар хүүхдийн хорих анги хоосордог боловч тун удалгүй 6-8 сарын дотор эргээд дүүрдэг нь энэ хүүхдэд ногдуулж ялын байгаа ялын бодлого гэхээсээ илүү суллагдсан хүүхдүүдэд чиглэсэн ямар ч ажил хийгдээгүйтэй шууд холбоотой"* гэж дүгнэж байв.

Хүүхдээс давтан гэмт хэрэг үйлдэж байгаа шалтгаан, нөхцлийг судлан үзэхэд:

---

[752] Чингэлтэй дүүргийн Цагдаагийн хэлтсийн Хайлаастын тасгийн ахлах мөрдөн байцаагч, ахмад Х.Мандахтай хийсэн ярилцлага

[753] ШШГЕГ-ын хэлтсийн дарга Х.Очгэрэл ярихдаа "2011 онд Хорих байгууллагын нийгмийн ажилтнуудыг чадавхижуулах сургалтын хөтөлбөр боловсруулж байгаа..." гэж дурдсан байна.

[754] "Хүүхдийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөл" судалгааны тайлангаас, НҮБ-ын Хүүхдийн сан. 2006 он, 31 дэх тал

1/ Хорихоос суллагдаад очих газаргүй, орон гэргүй,

2/ Эцэг, эх нь өрхийн орлого байхгүй, амьдралын баталгаажих түвшингээс доогуур амьдралтай,

3/ Ажил, сургуульд орох гэхэд иргэний бичиг баримтгүй, сургууль завсардсан, мэргэжил, боловсролгүй. Өөрөөр хэлбэл тэднийг нийгмийн зүгээс хүлээн авах бэлтгэл хангагдаагүй, нийгмийн хүрээлэл нь зөвөөр хүлээж авахгүй байгаа[755] нь дахин гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлдөг.

Иймээс шоронгоос /уг нь хүүхдэд хорих ял ногдуулах нь хамгийн эцсийн арга хэмжээ байх ёстой/ суллагдсан хүүхдэд амьдрах орчин бэлтгэх, түр хугацаанд байршуулах зэрэг онцгой арга хэмжээг авах хэрэгтэй юм.

Манай улсын хувьд гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүмүүст нийгмээс тусгаарлахгүйгээр оногдуулж буй хүмүүжүүлэх үр нөлөө бүхий бусад орнуудыг бодвол харьцангуй бага. Энэ нь хүүхдээс үйлдсэн зөрчил, хэргийг тусгайлан шийдвэрлэх процедур[756] манай улсад байхгүй байгаатай холбоотой. Хүүхдийн хувьд нөхөн сэргээх эрх зүйн хандлагыг алхам алхамаар төлөвшүүлж эхлэх нь зүйтэй бөгөөд тэр тусмаа насанд хүрээгүй этгээдэд үйлдсэн гэмт хэргийн шинж чанараас нь хамааран хэрэгтэнд тодорхой биечилсэн хориг хэрэглэлгүйгээр хянан харгалзах /пробаци/ албадлага хэрэглэх хандлагыг төлөвшүүлэх хэрэгтэй байдаг.

1. Хүүхдэд чиглэгдсэн хууль зүйн тогтолцоо боловсронгуй болсон боловч олон хүүхэд баривчлагдах, гэм буруутайд тооцогдох, анх удаа ялихгүй хэрэгт хүндээр шийтгэгдэх байдал их гарч байгааг анхаарч хууль зүйн хэрэгжилтийн орчинг бүрдүүлэхэд анхаарах

2. Хүүхдийн эрхийг хамгаалах болон эрүүгийн хэрэгт холбогдон шалгагдаж буй хүүхдийн эрхийг хангуулах талаархи Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээний зүйл заалтуудыг хэрэгжүүлж, ***Хүүхдийн хорих ангийн чиг үүрэг, статусыг өөрчлөн, сургалт хүмүүжлийн чиг үүрэгтэй болгох асуудлыг шийдвэрлэх*** /Хүүхдийн хорих байгууллага гэсэн нэрнээс авахуулаад хүүхдэд гэмт зан төлөв бүрдүүлдэг орчин бүрдүүлэхгүй байх чиглэсэн байх/

3. Тогтоол биелүүлэхийг хойшлуулсан насанд хүрээгүй этгээдийг дахин гэмт хэрэг зөрчил үйлдүүлэхгүй хүмүүжүүлэхийн тулд шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулахдаа уг этгээдийн ар гэрийн байдал амьдралын түвшин, өрхийн орлого, учруулсан хохирлоо нөхөн төлсөн байдал зэргийг харгалзан шүүхээс тогтоосон хянан харгалзах хугацаанд дүйцүүлэн албадан ажил хийлгэхээр хуульчилж болох юм.

Хүүхдийн төлөө ажилладаг олон төрийн ба төрийн бус байгууллагууд анхаарлаа хандуулж гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй этгээдэд хохирлоо нөхөн төлөх, хорих ял биечлэн эдлэхгүйгээр нийгэм, хүмүүсийн дунд хүмүүжихэд нь тусламж дэмжлэг үзүүлж, уг этгээдэд итгэл найдвар хүлээлгэх замаар үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллах боломжтой.

—o0o—

[755] НЦГ-ын Олон нийттэй харилцах хэлтсээс 2009 онд хийсэн "Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдэж буй гэмт хэргийн танилцуулга".

[756] Juvenile justice system.

ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

1998 оноос Монгол Улсад хэрэгжиж эхэлсэн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд 2002 онд Эрүүгийн хуулийг шинээр батлан, дагаж мөрдөөд 8 жил болжээ. Энэ хугацаанд нийтдээ Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт 2004, 2008 онд нийт 3 удаа орсон ба хуулийг бүхэлд нь шинэчлэн найруулах саналыг ч зарим хууль тогтоогч, хуульчид гаргаж байв. Бид үүний хаана явж, цаашид эрүүгийн бодлогыг хэрхэн тодорхойлж, ямар чиглэлийг баримтлах вэ гэдэг асуултанд хариу өгөх үүднээс Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн төлөв байдлын талаар тус секторооос 2004, 2009 онуудад 5 жилийн давтамжтайгаар 2 удаа хийсэн судалгааны тайланг танилцуулж байна.

Бид Эрүүгийн хуулийг шинэчлэх шаардлага бий эсэх талаар судалгаа явуулахдаа дараах гол гэж үзсэн 6 асуудлуудыг хөндөн авч үзсэн юм. Үүнд:

1. Гэмт хэрэг, захиргааны зөрчлийн зааг, ялгааг тогтоох асуудалд
2. Эрүүгийн хуульд заасан "журам зөрчсөн" гэх хэргүүд хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байгаа эсэх
3. Гэмт хэргийн ангилал
4. Эрүүгийн ялын бодлогын төлөв байдал
5. Эрүүгийн хуулийн Тусгай ангийн хэрэгжилт

Нэг. Гэмт хэрэг, захиргааны зөрчлийн зааг, ялгааг тогтоох асуудалд

Монгол Улсын Эрүүгийн хууль болон ЗХТ хууль тогтоомжийн уялдаа холбооны чухал асуудал бол ***гэмт хэрэг, захиргааны зөрчил*** нь нийгмийн хор аюулын шинж чанар, хэр хэмжээгээрээ ялгагдах хэдий боловч харилцан бие биенийгээ нөхөх замаар хоорондоо харилцан нөхцөлдсөн байдаг онцлогтой.

Учир нь гэмт хэргийн нийгэмд аюултай шинж нь байнга хувьсан өөрчлөгдөж байдаг ойлголт бөгөөд үүнтэй холбоотойгоор Монгол Улсын Эрүүгийн хуулийн 16-р зүйлийн 16.2-д "....Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан боловч ялимгүйн учир нийгэмд аюулгүй үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй..." гэсэн заалт нь Эрүүгийн хууль дахь гэмт хэрэг, эрх бусад зөрчил тухайлбал захиргааны зөрчлийн ялгааг хуульчилсан нийтлэг хэм хэмжээ болох юм.Захиргааны хариуцлагын тухай нийтлэг /ерөнхий/ хууль ба захиргааны хариуцлагын хэм хэмжээ тогтоосон бусад хууль тогтоомжийн заалтыг үзэхэд гэмт хэрэг, захиргааны зөрчлийн ялгаа "...***хэрэв эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол.***.." гэсэн ерөнхий үг хэллэгээр заагласан бий. Гэвч дээрх хууль тогтоомжийн "...хэрэв эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол..." гэсэн заалтыг судлан үзэхэд гэмт хэрэг, захиргааны зөрчлийн ялгаа бараг харагдахгүй байгаа юм.

Монгол Улсын ЗХТХ-ийн нийт 18 зүйл, хэсэг нь эрүүгийн хууль тогтоомжтой давхардаж , эрх зүйн хэм хэмжээний давхардал, зөрчилдөөн бий болгож байна.

Эрүүгийн хууль болон ЗХтХ-ийн тусгай ангид заасан заалтуудыг харьцуулан авч үзэхэд эрх зүйн зохицуулалтын хувьд авч үзэх шаардлагатай нэлээд зөрчилтэй зүйл байгаа нь ажиглагдлаа. Үүнд:

Гэмт хэргийн бүрэлдэхүүн болон захиргааны зөрчил нь ижил төрлийн харилцааг хамгаалсан зүйл, хэсгүүд 10

Эрүүгийн хууль тогтоомжид болон захиргааны хариуцлагын тухай хуульд давхардсан байдлаар тусгагдсан зүйл хэсэг 11

Эрүүгийн хууль болон ЗХТХ-д давхардсан байдлаар орсон, материаллаг /их хэмжээний/ хор уршиг шаардсанаараа ялгаатай зүйл, хэсгүүд 7 тус тус байна.

Үүнээс үзвэл хууль тогтоогчоос тус хуулиудыг батлан гаргахдаа анх баримталсан "Эрүүгийн хууль болон Захиргааны хариуцлагын тухай хууль тогтоомж нь харилцан бие биенээ нөхөж байх " гэсэн үзэл баримтлал алдагдсан гэж үзэх бүрэн үндэстэй байна. Цаашид Захиргааны хариуцлагын тухай хуулийг бүрэн шинэчилж, гэмт хэрэг зөрчлийн ялгааг нарийн гаргах шаардлагатай гэсэн дүгнэлтэнд хүрэв.

Хоёр. Алгасуулан иш татсан хэм хэмжээ

Монгол Улсын 2002 оны Эрүүгийн хуулийн бланкетний диспозицод судалгаа хийхдээ Эрүүгийн хуулийн тусгай ангийн бүлгийн системчлэлийн дагуу авч үзсэн болно. Одоогийн дагаж мөрдөж байгаа Эрүүгийн хуулийн тусгай ангид бланкетний диспозицийг тогтоосон байна. Үүнд:

1. Эрүүгийн хуульд зууд заасан бланкетний диспозици. Энэ нь Эрүүгийн хуулийн тухайн зүйл,хэсэгт ямар хууль,журам зөрчсөнийг шууд нэрлэн заасан байна.

2. Эрүүгийн хуульд шууд бусаар заасан бланкетний диспозиц. Энэ нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн тухайн зүйл,хэсэгт яг ямар хууль, журам зөрчсөн болохыг тодорхой заагаагүй бөгөөд хууль бусаар гэсэн нэр томъёогоор илэрхийлэгдэж байна.

Өнөөгийн Эрүүгийн хуульд бланкетын диспозицийг түгээмэл хэрэглэжээ. Тухайлбал, өөр хууль тогтоомж ишлэсэн 11 зүйл, ямар нэгэн журам ишлэсэн 29 зүйл хуульд тусгагдсан байна. Энэ нь "Үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох эсэхийг зөвхөн эрүүгийн хуулиар тодорхойлох" зарчим /Эрүүгийн хуулийн 1.2/, мөн Үндсэн хуулийн "хуульд заасан үндэслэл, журмаас гадуур эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглосон" заалтыг зөрчих боломж бүрдүүлнэ. Өөрөөр хэлбэл, ял оногдуулах боломжтой хориглосон үйлдлийг сайдын тушаалаар тогтоох нь Эрүүгийн хуулийн зарчимд нийцэхгүй. Түүнчлэн дээр дурдсан хууль тогтоомж эсхүл журам зөрчсөн 40 зүйлийн 15 нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй буюу ямар нэгэн хохирол, үр дагавар шаардахгүй байгаа юм. Дээрх гэмт хэргүүдийн үндсэн гол томьёолол болох ***"хууль бусаар"*** гэсэн нэр томьёог тодорхой болгохын тулд хууль хэрэглэгч холбогдох хууль тогтоомжийг тогтоож түүний чухам ямар заалтыг зөрчсөнийг үнэлэх зайлшгүй шаардлага гарч байна.

Эрүүгийн хуульд заасан журам зөрчсөнтэй холбоотой гэмт хэрэг

1.	Материаллаг	156.1, 158, 158-1, 159, 160, 183.1, 189, 190,204, 206.1, 207.1, 208, 209.1, 211, 212.1, 214-1, 215, 217, 224, 242.1, 285, 286.2, 287.1, 288.1, 289,	Нийт: 25 зүйл
2.	Хэлбэрийн	88.1, 90.1,131.1, 132.1, 133.1, 136.1, 138.1, 193.1, 199.1, 200.1, 243, 274.1, 286.1, 299.2, 300.1,	Нийт: 15 зүйл

Гурав. ***Гэмт хэргийн ангилалт:***

2002 оны шинэ Эрүүгийн хуулиар гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж байгаа ялын хүнд хөнгөнийг харгалзан гэмт хэргийг ангилсан нь одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хуульд учир дутагдалтай байгааг тэмдэглэх нь зүйтэй юм. Гадаад улс орнууд гэмт хэргийнхээ ангиллаас шалтгаалж санкцаа оногдуулдаг байхад манай Улс энэхүү онолын эсрэг санкцаасаа шалтгаалж гэмт хэргийг ангилдаг. Энэ нь өөрөө гэм бурууд нь тохирсон ял шийтгэл оногдуулах ёстой гэсэн эрүүгийн эрх зүйн зарчим зөрчихөд хүргэж байна. Судлаач Д.Баярсайханы "... гэмт хэргийн төрлүүдийг ангилахдаа дан ганц бодит хохирол, үр дагавар зэрэг обьектив хүчин зүйлийг хэт үнэлэх явдлаас зайлсхийж функциональ талаас хандах, ингэхдээ гэмт хэрэг үйлдэх сэдэл, шууд болон шууд бус санаа зэрэг сэтгэл зүйн талыг үнэлж ... хандах ёстой болжээ"[757] гэсэн дүнэлтийг хүлээн зөвшөөрөх үндэстэй байна.

Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн ангиллыг үзвэл нийт гэмт хэргийн 80 орчим хувийг материаллаг бүрэлдхүүнтэй гэмт хэрэг[758] эзэлж байна. Энэ нь гэмт хэргийг материаллаг талаас нь түүнд хамаарах бүх шинжүүдээр нь хуульчлан тодорхойлж гэмт хэргийн ангилалтыг хийхдээ тухайн гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хэмжээг гол шалгуур болгосонтой холбоотой байна. Гэтэл гэмт хэргийг ангилахдаа дээрхи үзүүлэлтээр ангилах нь алдаатай[759] бөгөөд түүнийг ангилах гол шалгуур болох гэм буруугийн хэлбэрийг хуулчилж өгөх нь зүйтэй юм.

Эрүүгийн Хуулийн Ерөнхий ангийн 21 дүгээр зүйлд заасан ялын төрөл хэмжээ нь гэмт хэргийн ангилалыг тогтоосон 17 дугаар зүйлийн заалттай нийцэхгүй байгаагаас тухайн гэмт хэрэг нь ямар ангилалд хамаарах нь ойлгомжгүй, холимог шинжтэй болж тухайн хэрэгт шүүх ямар санкц сонгосноос хамаарч хөнгөн, хүндэвтэр, хүнд, эсвэл онц хүнд гэмт хэргийн аль алинд тооцогдож болохоор байгаа нь тусгай ангийн заалтыг ерөнхий ангийн заалттай уялдуулах, шинэчлэх шаардлагатай байгаа харуулж байна.

---

[757] Баярсайхан.Д /2010.№3/, "Гэмт хэргийн бүрэлдэхүүний ойлголтыг шинээр авч үзэх нь/ "Гэмт явдалтай тэмцэх асуудал", 26/.

[758] Материаллаг бүрэлдхүүнтэй гэмт хэрэг ЭХ-ийн Тусгай ангийн 165 зүйлд тусгагджээ.

[759] Ж.Эрдэнэбулган "Эрүүгийн хуулийн Ерөниий ангийг өөрчлөх шаардлага" эрдэм шинжилгээний өгүүлэл ., "Эрх зүй" сэтгүүл. 2-3 / 2007 /16-17/ 118 дах тал.

Эрүүгийн хууль болон ЗХтХ-ийн тусгай ангид заасан заалтуудыг харьцуулан авч үзэхэд эрх зүйн зохицуулалтын хувьд авч үзэх шаардлагатай нэлээд зөрчилтэй зүйл байгаа нь ажиглагдлаа. Үүнд:

Гэмт хэргийн бүрэлдэхүүн болон захиргааны зөрчил нь ижил төрлийн харилцааг хамгаалсан зүйл, хэсгүүд 10

Эрүүгийн хууль тогтоомжид болон захиргааны хариуцлагын тухай хуульд давхардсан байдлаар тусгагдсан зүйл хэсэг 11

Эрүүгийн хууль болон ЗХТХ-д давхардсан байдлаар орсон, материаллаг /их хэмжээний/ хор уршиг шаардсанаараа ялгаатай зүйл, хэсгүүд 7 тус тус байна.

Үүнээс үзвэл хууль тогтоогчоос тус хуулиудыг батлан гаргахдаа анх баримталсан "Эрүүгийн хууль болон Захиргааны хариуцлагын тухай хууль тогтоомж нь харилцан бие биенээ нөхөж байх " гэсэн үзэл баримтлал алдагдсан гэж үзэх бүрэн үндэстэй байна. Цаашид Захиргааны хариуцлагын тухай хуулийг бүрэн шинэчилж, гэмт хэрэг зөрчлийн ялгааг нарийн гаргах шаардлагатай гэсэн дүгнэлтэнд хүрэв

Хоёр. Алгасуулан иш татсан хэм хэмжээ

Монгол Улсын 2002 оны Эрүүгийн хуулийн бланкетний диспозицод судалгаа хийхдээ Эрүүгийн хуулийн тусгай ангийн бүлгийн системчлэлийн дагуу авч үзсэн болно. Одоогийн дагаж мөрдөж байгаа Эрүүгийн хуулийн тусгай ангид бланкетний диспозицийг тогтоосон байна. Үүнд:

1. Эрүүгийн хуульд шууд заасан бланкетний диспозици. Энэ нь Эрүүгийн хуулийн тухайн зүйл,хэсэгт ямар хууль,журам зөрчсөнийг шууд нэрлэн заасан байна.

2. Эрүүгийн хуульд шууд бусаар заасан бланкетний диспозиц. Энэ нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн тухайн зүйл,хэсэгт яг ямар хууль, журам зөрчсөн болохыг тодорхой заагаагүй бөгөөд хууль бусаар гэсэн нэр томъёогоор илэрхийлэгдэж байна.

Өнөөгийн Эрүүгийн хуульд бланкетын диспозицийг түгээмэл хэрэглэжээ. Тухайлбал, өөр хууль тогтоомж ишлэсэн 11 зүйл, ямар нэгэн журам ишлэсэн 29 зүйл хуульд тусгагдсан байна. Энэ нь "Үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох эсэхийг зөвхөн эрүүгийн хуулиар тодорхойлох" зарчим /Эрүүгийн хуулийн 1.2/, мөн Үндсэн хуулийн "хуульд заасан үндэслэл, журмаас гадуур эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглосон" заалтыг зөрчих боломж бүрдүүлнэ. Өөрөөр хэлбэл, ял онногдуулах боломжтой хориглосон үйлдлийг сайдын тушаалаар тогтоох нь Эрүүгийн хуулийн зарчимд нийцэхгүй. Түүнчлэн дээр дурдсан хууль тогтоомж эсхүл журам зөрчсөн 40 зүйлийн 15 нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй буюу ямар нэгэн хохирол, үр дагавар шаардахгүй байгаа юм. Дээрх гэмт хэргүүдийн үндсэн гол томьёолол болох ***"хууль бусаар"*** гэсэн нэр томьёог тодорхой болгохын тулд хууль хэрэглэгч холбогдох хууль тогтоомжийг тогтоож түүний чухам ямар заалтыг зөрчсөнийг үнэлэх зайлшгүй шаардлага гарч байна.

Эрүүгийн хуульд заасан журам зөрчсөнтэй холбоотой гэмт хэрэг

1.	Материаллаг	156.1, 158, 158-1, 159, 160, 183.1, 189, 190,204, 206.1, 207.1, 208, 209.1, 211, 212.1, 214-1, 215, 217, 224, 242.1, 285, 286.2, 287.1, 288.1, 289,	Нийт: 25 зүйл
2.	Хэлбэрийн	88.1, 90.1,131.1, 132.1, 133.1, 136.1, 138.1, 193.1, 199.1, 200.1, 243, 274.1, 286.1, 299.2, 300.1,	Нийт: 15 зүйл

Гурав. ***Гэмт хэргийн ангилалт:***

2002 оны шинэ Эрүүгийн хуулиар гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж байгаа ялын хүнд хөнгөнийг харгалзан гэмт хэргийг ангилсан нь одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хуульд учир дутагдалтай байгааг тэмдэглэх нь зүйтэй юм. Гадаад улс орнууд гэмт хэргийнхээ ангиллаас шалтгаалж санкцаа оногдуулдаг байхад манай Улс энэхүү онолын эсрэг санкцаасаа шалтгаалж гэмт хэргийг ангилдаг. Энэ нь өөрөө гэм бурууд нь тохирсон ял шийтгэл оногдуулах ёстой гэсэн эрүүгийн эрх зүйн зарчим зөрчихөд хүргэж байна. Судлаач Д.Баярсайханы "... гэмт хэргийн төрлүүдийг ангилахдаа дан ганц бодит хохирол, үр дагавар зэрэг обьектив хүчин зүйлийг хэт үнэлэх явдлаас зайлсхийж функциональ талаас хандах, ингэхдээ гэмт хэрэг үйлдэх сэдэл, шууд болон шууд бус санаа зэрэг сэтгэл зүйн талыг үнэлж ... хандах ёстой болжээ"[757] гэсэн дүнэлтийг хүлээн зөвшөөрөх үндэстэй байна.

Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн ангиллыг үзвэл нийт гэмт хэргийн 80 орчим хувийг материаллаг бүрэлдхүүнтэй гэмт хэрэг[758] эзэлж байна. Энэ нь гэмт хэргийг материаллаг талаас нь түүнд хамаарах бүх шинжүүдээр нь хуульчлан тодорхойлж гэмт хэргийн ангилалтыг хийхдээ тухайн гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хэмжээг гол шалгуур болгосонтой холбоотой байна. Гэтэл гэмт хэргийг ангилахдаа дээрхи үзүүлэлтээр ангилах нь алдаатай[759] бөгөөд түүнийг ангилах гол шалгуур болох гэм буруугийн хэлбэрийг хуулчилж өгөх нь зүйтэй юм.

Эрүүгийн Хуулийн Ерөнхий ангийн 21 дүгээр зүйлд заасан ялын төрөл хэмжээ нь гэмт хэргийн ангилалыг тогтоосон 17 дугаар зүйлийн заалттай нийцэхгүй байгаагаас тухайн гэмт хэрэг нь ямар ангилалд хамаарах нь ойлгомжгүй, холимог шинжтэй болж тухайн хэрэгт шүүх ямар санкц сонгосноос хамаарч хөнгөн, хүндэвтэр, хүнд, эсвэл онц хүнд гэмт хэргийн аль алинд тооцогдож болохоор байгаа нь тусгай ангийн заалтыг ерөнхий ангийн заалттай уялдуулах, шинэчлэх шаардлагатай байгаа харуулж байна.

---

[757] Баярсайхан.Д /2010.№3/, "Гэмт хэргийн бүрэлдэхүүний ойлголтыг шинээр авч үзэх нь/ "Гэмт явдалтай тэмцэх асуудал", 26/.

[758] Материаллаг бүрэлдхүүнтэй гэмт хэрэг ЭХ-ийн Тусгай ангийн 165 зүйлд тусгагджээ.

[759] Ж.Эрдэнэбулган "Эрүүгийн хуулийн Ерөниий ангийг өөрчлөх шаардлага" эрдэм шинжилгээний өгүүлэл ., "Эрх зүй" сэтгүүл. 2-3 / 2007 /16-17/ 118 дах тал.

Мөн Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 29 дүгээр зүйлд хохирлын хэмжээг зохицуулсан байдаг. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь 2000 оноос хойш нийтдээ 11 удаа өөрчлөгдсөн ба анх байсан хэмжээнээс 5 дахин нэмэгдсэн байна. Энэ хугацаанд хүн амын байнгын хэрэглэх өргөн хэрэглээний хүнсний болон барааны үнийн өсөлт харьцангуй бага хувьтай байна. Энэ нь хохирлын хэмжээг бодитой тогтоох тэр байтугай торгуулийн ял хэрэгжих боломжийг хаагдуулж байна. Хуулийн хэрэгжилтийн байдлаас үзэхэд үнэлгээ тогтоож байгаа албан тушаалтан, эрх бүхий субъектүүдийн үзэмжийн асуудал шууд нөлөөлж, орон нутаг бүрт адилхан хэрэгт тохирсон эрүүгийн хариуцлага хүлээлгэж чадахгүй ял завшуулах явдал гарч байна.

Эрүүгийн хэргийг шийдвэрлэх явцад хүндрэл бэрхшээлтэй нэг асуудал бол ***хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс дээш эрүүгийн хэрэг үүсгэдэг*** явдал юм. Өнөөдөр практикт өөр аймагт малын зарагдах ханш янз бүр байгаа нь эргэлзээ төрүүлж, хуулийн байгууллагын ажилчдын дунд маргаан гаргахад хүргэжээ. Тухайлбал: нэг аймагт 2 хонь 108 мянган төгрөг хүрч байхад нөгөө аймагт хүрэхгүй байх жишээтэй. Энэ нь хууль шүүхийн өмнө хүн бүр ижил тэгш эрхтэй байна гэсэн Үндсэн хууль болон Эрүүгийн хуульд заасан зарчмыг алдагдуулахад хүргэж байна.

Жич: Монгол Улсын Эрүүгийн Хуулийг шинэчлэн баталснаас хойш нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг өөрчлөн тогтоосон байдал:

№	Засгийн газрын тогтоолын огноо, бусад	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ	Үргэлжилсэн байдал /хэдийнээс хэдий хүртэл/
1	2000.07.05 Дугаар 105	24435.6	3 сар
2	2000.10.04 Дугаар 155	10.1-нээс 17893 төгрөг, 2001.10.01-нээс 24435.6 төгрөг.	2 жил 2 сар
3	2002.12.25 Дугаар 263	30000 төгрөг	2 жил
4	2004.01.07 Дугаар 4	40000 төгрөг	1 жил 4 сар
5	2005.05.25 Дугаар 112	42500 төгрөг	7 сар
6	2006.02.08 Дугаар 14	53000 төгрөг	9 сар
7	2007.01.10 Дугаар 12	69000 төгрөг	6 сар
8	2007.07.10 Дугаар 174	80000 төгрөг	2 сар 17 хоног
9	2007.09.27 Дугаар 240	90000 төгрөг	3 сар
10	2007.12.26 Дугаар 350	108000 төгрөг	3 жил 5 сар
11	Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2011 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 1 дүгээр тогтоолоор	Нэг цагт 835 төгрөг 71 мянга буюу сарын 140.400 төгрөгөөр тогтоосон байна	

Тав. Монгол Улсын Эрүүгийн бодлогын төлөв байдал

Эрүүгийн хуулийг шинэчлэх , нэмэлт өөрчлөлт оруулах талаар гарч байсан оролдлогуудаас үзэхэд нэг удаагийн Эрүүгийн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүд нь аль нэг олон гэрээ конвенцид нэгдэж орсон, бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагаар нөхцөлдөн гарч байжээ.

2002 онд тус хуулийг батлан гаргаснаас хойш нилээдгүй нэмэлт, өөрчлөлт оруулжээ. Үүнийг дараахь хүснэгтээр үзүүлье:

Хуулийн нэр	Он сар өдөр	Н э м э л т , өөрчлөлт орсон зүйл хэсэг	Үндэслэл, шалтгаан
Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай	2007.12.26	Эрүүгийн хуулийн 131-р зүйл 131.1	Тус зүйл хэсгийг өөрчилсөн
Эрүүгийн хуульд нэмэлт. өөрчлөлт оруулах тухай	2004.05.14.	Эрүүгийн хуулийн /49.2 145.2 71.1 145.1/	а.Тус зүйл хэсэгт нэмэлт хийсэн б. тус зүйл хэсгийг өөрчлөн найруулсан
Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2009.12.24.	/166–р зүйл 166.1 166.2 166.3 268 .1/	а. тус зүйл хэсэгт нэмэлт хийсэн б. хүчингүй болсонд тооцсон.
Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай	2008.04.25.	Эрүүгийн хуульд /267–р зүйл 272 / 267. 272	а. тус зүйл хэсэгт нэмэлт хийсэн б. 2008 оны 02 дугаар сарын 01-ний өдөр батлагдсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 6 дугаар зүйлийн "267 дугаар зүйл, 272 дугаар зүйл," гэснийг хассугай
Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2008.02.01.	55-рзүйл 55¹62-рзүйл 62¹ 153¹ 155¹155¹2 156¹ 156² 156²158. 1.2. 178¹1.2. .1782.2 178²3 178².2 178².3 178³2 214¹ 1.2. 268¹1.2.3. 61.5 125.2 208.2 215.4 251.3 126.2дахь хэсэг 5 дахь заалт	Нийтдээ: 19 зүйл заалт нэмсэн.

Өөрөөр хэлбэл, нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, саналууд нь хуулийн агуулга зарчмын хувьд биш харин хуулийн тодорхой нэг зүйл, хэсгийг нэмэх, хасах эсхүл өөрчлөх байдлаар хязгаарлагдаж байв. Өнөөгийн байдлаар ямар үйлдлийг гэмт хэрэгт тооцох эс тооцох талаар санал боловсруулж, МУ-ын Эрүүгийн хуульд системчлэлгүйгээр халдаж байгаа[760] нь эрүүгийн хуулийн хэрэгжилтэнд сөрөөр нөлөөлж байна.

Хэдийгээр Эрүүгийн хуулийг боловсронгуй болгох талаар өнгөрсөн хугацаанд олон тооны санал, зөвлөмж гарч байсан боловч зөвхөн судлаач, эрдэмтдийн хүрээнд хэлэлцэгдэд УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, Засгийн газрын түвшинд хэлэлцэгдэхгүй эсхүл хэлэлцэгдсэн боловч дэмжигдэлгүй буцах тохиолдол багагүй байлаа. Тодорхой нэг байгууллагын дотоод журмаар, эсхүл аль нэг УИХ-ын гишүүний үзэмжийн асуудлаар өнөөдөр Эрүүгийн бодлогыг тодорхойлох нь яавч боломгүй юм.

Монгол Улсын Эрүүгийн хуулийг боловсруулахад хуулийн байгууллагын алба хаагчдаас санал бага гардаг мөртлөө батлагдсан хойно гомдол их үүсдэг. Тухайлахад Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх зарим арга хэмжээний талаар хуулийн байгууллагаас санал авахдаа "аар, саар хэргийг шийдвэрлэх шүүгчийн орон тоо бий болгох тухай" авахдаа Монгол Улсын Эрүүгийн хуульд байхгүй гэмт хэргийн ангилалын тухай ярьж байна.

Зургаа. Эрүүгийн хуулийн тусгай ангийн хэрэгжилт

1. АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ, ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ.

○ Эрүүгийн хуулийн 89 дүгээр зүйл буюу Хууль бусаар Монгол Улсын хил нэвтрэх" гэмт хэргийн талаар тайлбар гаргах хэрэгтэй байна. Практикт "Хүн худалдаалах" гэмт хэргийн хохирогч болсон хүн бичиг баримтгүйгээр Монгол Улсын хил нэвтэрч орж ирсэн тохиолдолд дээрхи зүйл ангиар эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан тохиолдол гарч байжээ. Өөрөөр хэлбэл гэмт хэргийн улмаас хохирогч болсон Монгол Улсын иргэн хил нэвтэрч орж ирэхэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй байх зарчмыг хуулинд тусгаж өгөх нь зүйтэй. Хуурамч баримт бичиг үйлдэж Монгол Улсын хил нэвтрэх гэмт хэрэг үргэлжилсэн шинжтэй байдаг учраас шийдвэрлэхэд бэрхшээлтэй

2. АРВАНТАВДУГААР БҮЛЭГ, ХҮНИЙ АМЬ БИЕ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

○ "Эх нь нярай хүүхдээ алах" гэмт хэргийн субьектив талын шинжийг тодорхой зааж өгөөгүйгээс хуулийн заалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл бэрхшээл үүсч байна. Гэм буруугийн шууд санаатай хэлбэрийг хуульчлах нь зүйд нийцнэ.

○ Түүнчлэн "Бусдыг амиа хорлоход хүргэх" гэмт хэргийн тоо харьцангуй их байгаа нь хүний амь нас хохирсон тохиолдол болгонд дээрхи зүйл , хэсгээр /ЭХ-ийн 95 дугаар зүйл/ эрүүгийн хэрэг үүсгэж байгаатай шууд холбоотой байна.

[760] 2002 оноос хойш Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах оролдлого 8 удаа гарчээ.

○ Бусдын биед гэмтэл учруулснаас хүний амь нас хохирсон тохиолдолд шууд хүнийг санаатай алах гэмт хэргээр зүйлчилж байна. Нийгмийн хор аюул, гэмт хэргийн шинж чанарт тохирсон ял шийтгэл байх зарчмын үүднээс өмнө байсан "Бусдын бие махбодид хүнд гэмтэл учруулснаас хүний амь нас хохирсон" агуулга бүхий заалтыг эргэн хуулинд тусгах талаар ярилцлагын судалгаанд оролцсон шүүгч, прокурор нарын зүгээс илэрхийлж байв.

○ Эрүүгийн хуулийн 99 дүгээр зүйлд заасан гэмт хэргийг ойролцоо төрлийн бусад гэмт хэргээс ялгалгүй, хутга мэс хэрэглэсэн л бол танхайрах /181 дүгээр зүйлийн 181.3/ гэмт хэрэг хэмээн үзэж хэргийн болон гэмт этгээдийн гэм буруугийн сэдэлт, зорилго зэрэг субьектив талын шинжүүдэд ач холбогдол өгөлгүйгээр буруу дүгнэлт хийж, хуулийг буруу хэрэглэж байна. Мөн шүүхүүд прокуророос танхайн гэмт хэргээр зүйлчлэн ирүүлсэн хэргийг ЭХ-ийн 99 дүгээр зүйл болгон зүйлчлэлийг өөрчлөхдөө эдгээр 2 төрлийн гэмт хэргийн субьектив талын шинжийг ялгаж чадахгүй зүйлчлэлийг үндэслэлгүйгээр өөрчилдөг дутагдал байна.

3. АРВАН ЗУРГАДУГААР БҮЛЭГ, ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ, АЛДАР ХҮНД, НЭР ТӨРИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

• Доромжлох, гүтгэх/ЭХ-ийн 110, 111 дүгээр зүйл/гэмт хэргүүд нилээдгүй гарч байгаа болов ч хуулийн байгууллагад шалгагдаж шийдвэрлэгдсэн нь цөөхөн байна. УДШ-ийн тайлбар гарснаас хойш эрүү, иргэний хэргийг ялган гэм хортой холбоотой хэсгийг ялган шийдвэрлэж сурчээ.

4. АРВАН ДОЛДУГААР БҮЛЭГ, ХҮҮХЭД, ГЭР БҮЛ, НИЙГМИЙН ЁС СУРТАХУУНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

• Мөрдөн байцаагч нартай хийсэн бүлгийн ярилцлагын судалгаанаас үзэхэд энэ төрлийн гэмт хэрэг цөөн тоотой гарч бүртгэгддэг. Ихэвчлэн нууц далд байдалд байдаг байна. Нэн ялангуяа ЭХ-ийн 115, 117, 121, 124, 125 дугаар зүйлд заасан гэмт хэргийн шийдвэрлэлт хангалтгүй байна. НЦГ-ын Хүүхдийн хаяг тогтоох тасаг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төв, болон ЭКПАТ үндэсний сүлжээ байгууллагад хамгаалах байранд байгаа хүүхдүүд болон тэдний судалж байгаа кейсүүдээс үзэхэд энэ төрлийн гэмт хэрэг илүү нууц далд байдалд үйлдэгдэж, гэмт этгээдүүд ял завшиж байна гэж дүгнэхэд хүрлээ. Гудамжинд хүүхдээр гуйлга гуйлгаж байгаа, албадан хөдөлмөрлүүлж байгаа гэмт хэргийн гаралт бүртгэгдсэн тохиолдол сүүлийн 3 жилд нэг оронтой тоонд байгаа нь хуулийн энэ зүйл хэсгийн хэрэгжилт сул байгааг харуулж байна.

• Хуулийн хэрэгжилт дутмаг шалтгааныг судлан үзэхэд хуулийн байгууллагад энэ төрлийн гэмт хэргийн мэдээлэл ирдэггүй, ихэвчлэн гэр бүлийн хүрээнд үйлдэгддэг, гэмт хэргийн хохирогч болсон насанд хүрээгүй хүмүүсийн өмнөөс өргөдөл гомдол гаргах субьект байдаггүй аж.

• "Садар самууныг сурталчилах" гэмт хэрэг Захиргааны хариуцлагын хуулийн 41 дүгээр зүйлтэй үг үсгийн хувьд ч, агуулгын хувьд ч ижил байгаа нь гэмт хэрэг үйлдсэн этгээд ял завших боломжийг олгодог.

5. АРВАН НАЙМДУГААР БҮЛЭГ, ИРГЭДИЙН УЛС ТӨРИЙН БОЛОН БУСАД ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

- Практикт иргэдийн айлгах , заналхийлэх, сүрдүүлэх явдал нилээдгүй гардаг бөгөөд хуулийн энэ хэсгийн зүйл заалт иргэдийг ямар нэгэн айлган сүрдүүлэлтээс хамгаалж чадахгүй байна. Нэн ялангуяа хувь хүний нууцыг задруулахаар айлгах, дарамтлах, гэр орных нь халдашгүй байдлыг зөрчих гэмт хэрэг гардаг боловч хуулийн энэ зүйл хэсгийн /ЭХ-ийн 136,137 дугаар зүйл/ заалтыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар хэрэглэдэггүй, шалгаж байгаа үндсэн хэрэгтээ илүү их анхаарал тавьдаг.
- Зохиогчийн эрх болон түүнд хамаарах гэмт хэргийн хувьд заавал их хэмжээний хохирол шаарддаг нь хуулийн зүйл хэсгийг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж байна. Тухайлбал үнэлэх боломжгүй зохиогчийн эрх зөрчигдвөл яах вэ гэсэн асуудлыг анхаарах хэрэгтэй.
- ЭХ-ийн 133 дугаар зүйл. Гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомж зөрчих "135 дугаар зүйл. Иргэний захидал, харилцааны нууцын халдашгүй байдлыг зөрчих, гэсэн хуулийн зүйл хэсгийн хэрэгжилт ч сул байна. Телевизийн зарим нэвтрүүлэг хүнийг хууль бусаар мөрдөн мөшгөсөн, янз бүрийн арга техник ашигласан шинжтэй байдаг ч хуулийн хариуцлага хүлээлгэж байгаа тохиолдол алга байна. /Жишээ нь "Мөрдөгч Деррик" нэвтрүүлэг/
- ЭХ-ийн 139 дүгээр зүйл буюу "Сэтгүүлчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд саад хийх" гэмт хэрэг гарч байгаа боловч хуулийн байгууллагаас шалгаж шийдвэрлэгдсэн тохиолдол байхгүй байна. Ялангуяа сэтгүүлчийн нийтлэлтэй нь холбогдуулан заналхийлэх, тэр ч байтугай бие эрх чөлөөнд халдсан явдал гарч байжээ.

6. АРВАН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ, ӨМЧЛӨХ ЭРХИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

- ЭХ-ийн 145 дугаар зүйлийн 145.4 дэх хэсэг "Энэ хэргийг булаах, дээрэмдэх, уулгалан довтлох гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд, ЭХ-ийн 146 дугаар зүйлийн 146.3 дах хэсэгт "Энэ хэргийг булаах, дээрэмдэх, уулгалан довтлох гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд,", ЭХ-ийн 147 дугаар зүйлийн 147.2 дах хэсэгт "... урьд энэ гэмт хэрэгт болон булаах, далайлган сүрдүүлэх гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд үйлдсэн,", ЭХ-ийн 148 дугаар зүлйийн 148.3-т " Энэ гэмт хэргийг урьд нь энэ хэрэгт болон хулгайлах, булаах, завших, дээрэмдэх гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд үйлдсэн, 149.3.Энэ хэргийг урьд нь хулгайлах, булаах, дээрэмдэх гэмт хэрэгт удаа дараа шийтгүүлсэн этгээд," гэж заагаад таваас арван жил хүртэл хорих ял шийтгэхээр заасан нь гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдэд хүнд тусдаг, шүүхээс гэмт хэрэгт ял ногдуулахдаа үйлдсэн гэмт хэргийн шинж чанарт тохирсон ял ногдуулдаггүй гэсэн дүгнэлтэнд жирийн иргэдийг хүргэдэг.
- Түүнчлэн "Хадгалуулсан болон бусад зорилгоор итгэмжлэн өгсөн хөрөнгийг завшиж үрэгдүүлсэн" эсвэл , "бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах" /ЭХ-ийн 148, 153 дугаар зүйлүүд/ гэмт хэргийг иргэний гэрээ хэлцэл бүхий маргаантай асуудлаас ялган зүйлчлэх явдал хангалттүй.
- Практикт танил талаар, эсхүл нэгний гуйлт ятгалгаар нотариатч бусдын өмчлөх эрхийг хязгаарлах, шилжүүлэхтэй холбоотой илт хууль бус

хэлцлийг гэрчлэн баталсан, эрхийн улсын бүртгэгч бүртгэж иргэдэд гэм хор учруулах явдал байсаар байна. Энэ гэмт хэргийн улмаас заавал их хэмжээний хохирол учирсан байхыг хууль тогтоогчоос шаардсан нь иргэдийг ахин хохирооход хүргэж байна.

7. ХОРЬДУГААР БҮЛЭГ, АЖ АХУЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

- Энэ бүлэгт заасан хуулийн хэрэгжилт өөр өөр байна. Тухайлхад ЭХ-ийн 156- 160 дугаар зүйлд заасан хуулийн зүйл хэсэг огт хэрэглэгдээгүй байгаа нь мөн энэ төрлийн гэмт хэрэг гарч бүртгэгддэггүйтэй холбоотой юм. ЭХ-ийн1561 дүгээр зүйл "Хоршооны тухай хууль тогтоомж зөрчих" гэсэн зүйл хэсгийг 2009 оны 2 дугаар сарын 1-ны өдөр нэмж оруулсан нь Хадгаламж зээлийн хоршоодтой холбоотой маргаантай асуудлыг шийдвэрлэхэд дөхөм болжээ.
- ЭХ-ийн 161 дүгээр зүйлд заасан зүйл хэсгийн хэрэгжилт сул байна. Иргэдийг хуурч мэхлэх замаар сүлжээний шатлал бүхий бизнесс үүсгэж, эсвэл тусгай зөвшөөрөл авалгүйгээр үйл ажиллагаа эрхэлж, гадаадад иргэдийг ажилд зуучлана, гадаадын иргэдтэй гэр бүл болоход зуучлана хэмээн хохироож байгаа хэргүүд цөөнгүй байгаа ч "их хэмжээний хохирол" учирсан байхыг шаарддагаараа хэрэгжихэд хүндрэл бэрхшээлийг учруулж байна. Зарим тохиолдолд иргэн хориглосон үйлдвэрлэл, үйлчилгээний улмаас бие эрхтэн, сэтгэл санаагаараа хохирох явдал байдаг. Хууль тогтоогчоос заавал их хэмжээний орлого олсон байхыг обьектив талын нэг шинж байхаар хуульчилсан нь дутагдалтай байна. Хуулийн энэ зүйл хэсэгт бусдад бие махбодын болон эд хөрөнгийн хохирол хүлээсэн, гэм хор учирсан байх обьектив талын нэмэгдэл шинж бүхий заалтыг оруулах хэрэгтэй.
- ЭХ-ийн 170 дугаар зүйл. "Хууль бусаар шан харамж авах" гэмт хэргийн албан тушаалын эсрэг гэмт хэргийн бүрэлдхүүнд оруулах саналтай байна. /Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагын ажилтан гэж тодорхой заасан байгаа/ эрх олгох албан үүргийн дагуу ажил гүйцэтгэж үйлчилгээ үзүүлэх үүргээ далимдуулан хясан боогдуулах замаар удаа дараа буюу их хэмжээний шан харамж авсан гэж зааж өгчээ. Өөрийн давуу байдлаа ашиглан шан харамж авна гэдэг нь албан тушаалын эсрэг гэмт хэргийн шинжийг агуулж байдаг. Шан харамж, хээл хахууль, авилга гэдэг үгийг хуулийн заалттай уялдуулан нэг мөр тайлбарлах хэрэгтэй байна.

8. ХОРИН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ, НИЙГМИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

- 2008 оны 7 дугаар сарын 1-нд болсон үйл явдалтай холбогдуулан ЭХ-ийн 177, 179 дүгээр зүйл хэсгийг Эрүүгийн шинэ хууль батлагдсанаас хойш анх удаа хэрэглэсэн байна.
- Танхайрах гэмт хэргийн хувьд танхайрах зөрчил удаа дараа гаргасан бол гэмт хэрэг гэж үзэж байхаар оруулсан хуучин хуулийн заалтыг эргэж харах хэрэгтэй. Ижил төрлийн танхайрах зөрчлийг гэмт хэрэг гэж үзэх эсвэл танхайрах гэмт хэргийг зөрчил гэж үзэн шийдвэрлэх явдал түгээмэл байна.

Танхайрах гэмт хэргийг ойролцоо төрлийн гэмт хэргээс ялган зүйлчлэх тухай Улсын Дээд шүүхийн тайлбар практик хэрэгцээг хангахгүй байна.

• ЭХ-ийн 185-186 дугаар зүйлд заасан галт зэвсгийн хяналттай холбоотой зүйл хэсгийн заалын хэрэгжилт харьцангуй сайн, энэ төрлийн гэмт хэрэг тогтвортой гарч бүртгэгдэж байна. Хууль тогтоогчоос ангийн буунаас бусад гэж тусгайлан заасан нь учир дутагдалтай байна. Өнөөдөр ангийн буугаар үйлдэгдэж байгаа гэмт хэрэг түгээмэл, амиа хорлох, дээрмийн зорилгод ашиглах явдал гарч байна. Иймээс ангийн буунаас бусад гэдгийг хасах саналтай байна. Галт зэвсэгтэй холбоотой зүйл хэсэг заалтууд нь ЗХТХ-ийн холбогдох зүйл ,хэсэгтэй агуулгын хувьд ижил байгаа нь гэмт этгээдийг ял завшихад ч хүргэж байна .

9. ХОРИН ХОЁРДУГААР БҮЛЭГ, ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

ЭХ-ийн 198 дугаар зүйл. "Хууль бусаар эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдэрлэх, импортлох, хадгалах, худалдах, түгээх," гэсэн зүйл хэсгийн хэрэгжилт сул байна. Эрэн сурвалжлах сэтгүүлчийн хийсэн судалгаанаас үзэхэд гар дээрээс хууль бусаар баталгаагүй эм тариа борлуулдаг, түүнээс шалтгаалж иргэд эрүүл мэнд, бие эрхтэнээрээ хохирч байсан тохиолдол гарч байжээ. Түүнчлэн таргалуулж, тураана гэх мэт нэр дор хууль бус эмийн худалдаа байсаар байна.

10. ХОРИН ГУРАВДУГААР БҮЛЭГ, БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ЖУРМЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

○ Хуулийн энэ бүлгийн хэрэгжилт хамгийн сул байна. Үүний шалтгаан нь хуулийн зүйл хэсгийн бүрхэг байгаагаас биш үнэлгээнд байгаа явдал юм. Өөрөөр хэлбэл Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргүүдийн обьектив талыг ихэнхи хэсгийг материаллаг байдлаар хуульчилсантай холбоотойгоор байгаль орчинд учирсан хохирлыг тогтоох явдал хангалтгүй байна. Тодорхой жишээ дурдахад ойгоос их хэмжээний мод бэлтгэсэн гэмт этгээдүүдийн хэргийг шийдвэрлэхэд байгаль орчинд учирсан хохирлыг тооцоолоход хүндрэл бэршээл учирч байжээ. Улсын мэргэжлийн хяналтын газрын үнэлгээгээр гэмт хэргийн шаардсан хохиролд хүрэхгүй байхад Байгаль орчны газраас гаргасан журмаар гэмт хэрэг болох жишээтэй.

○ Тодорхой журмуудын эсрэг гэмт хэргүүд гарч үйлдэгдэж байгаа боловч хуулийн хэрэгжилт сул байгаагаас шалтгаалж гэмт хэрэгтнүүд ял завшиж байгаль орчныг эргэн сэргээх боломжгүйгээр хохироож байна. Энэ нь гомдол гаргах, шалгах үүрэг бүхий субьектүүд хуулийн байгууллагад гарсан зөрчил, гэмт хэргийн талаар мэдээлэл ирүүлдэгүйтэй шууд холбоотой байна. Тухайлбал суманд үйлдэгдсэн ховор амьтныг агнасан хэргийн талаар акт тавьсан байгаль орчны байцаагч тэрхүү актынхаа хувийг цагдаагийн байгууллагад хүргүүлж байх хэрэгтэй.

○ Хууль бусаар ашигт малтмал олборлох буюу ЭХ-ийн 214 дүгээр зүйлийн хэрэгжилт муу байна. Алтны нинжа гэгдэх хүмүүс байгаль орчны тэнцэлийг илтэд алдагдуулан, илэрхий хууль бусаар ашигт малтмал олборлосоор байтал эрүүгийн хариуцлага хүлээлгэх явдал хангалтгүй 11.

11. ХОРИН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, АШИГЛАЛТЫН ЖУРМЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

○ Зам тээврийн гэмт хэргийн улмаас заавал хүндэвтэр гэмтэл авсан байх, эсхүл үлэмж хэмжээний хохирол хүлээсэн байхыг шаардсан нь практикт нилээдгүй хүндрэл бэрхшээлийг үүсгэж байна. Согтуугаар бусдын автомашиныг мөргөж, биед нь гэмтэл учруулсан үйл баримт байсаар байтал үлэмж хэмжээнд хүрэхгүй бол хэрэгсэхгүй болгож шийдвэрлэж байгаа нь иргэдийг хохирсон дээр нь ахин хохироох байдалд хүргэж байна. Ялангуяа зам тээврийн осол гаргасан, бусдын биед гэмтэл учруулсан этгээд хохирлын хэмжээ хүрээгүй, тухайн хэрэг нь хэрэгсэхгүй болохоор учруулсан хохирлоо төлөхгүй байх, зугтаах зэрэг байдлууд гаргасаар байна.

○ ЭХ-ийн 217-225 дугаар зүйл, хэсгийн хэрэгжилт бага байгаа нь дээрхи гэмт хэргийн гаралтаас шалтгаалж байна. Гэсэн хэдий ч согтуурсан, мансуурсан хүнээр тээврийн хэрэгсэл жолоодуулах, бүрэн биш тээврийн хэрэгсэл ажилд гаргах гэмт хэргүүдийн хохирлын хэмжээ их байхыг шаарддаг, уг гэмт хэргийн субьект хэн болох нь тодорхой биш /ихэнх тээврийн газрууд хувьчлагдсанаас үүдэлтэйгээр тээврийн байгууллагын ашиглалт хариуцсан ажилтан гэсэн ойлголт байхгүй болсон байна.

12. ХОРИН ТАВДУГААР БҮЛЭГ, КОМПЬЮТЕРИЙН МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

○ Хуулийн энэ бүлэгт заасан хэргээр шалгаж шийдвэрдсэн тохиолдол сүүлийн 3 жилийн хугацаанд гарч бүртгэгдээгүй боловч практикт энэ төрлийн гэмт хэрэг гарсаар байна. Засгийн газрын болон хувийн бусад веб сайтууд руу халдах, интернет гүйлгээгээ иргэдийг хуурах, хохироох явдлууд тасрахгүй байна. Өөрөөр хэлбэл энэ төрлийн гэмт хэргийг илрүүлж, шалгаж нотлоход тусгай чадвар шаарддагаас шалтгаалан хуулийн зүйл хэсгийн хэрэгжилт сул байна.

○ Хуулийн энэ бүлэгт онлайн сүлжээгээр бусдыг хууран мэхлэх, залилах гэмт хэргийн талаар заалт нэмж оруулах хэрэгтэй.

13. ХОРИН ЗУРГАДУГААР БҮЛЭГ, ЗАХИРГААНЫ ЖУРМЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

○ Хуурамч баримт бичиг тамга, тэмдэг, хэвлэмэл маягт үйлдэх, ашиглах, гэмт хэрэг бусад гэмт хэрэгтэй давхар үйлдэгддэг онцлогтой

○ Практикт ЭХ-ийн 236 дугаар зүйл буюу цэрэг татлагаас зайлсхийх гэмт хэрэг түгээмэл байдаг боловч хуулийн хариуцлага хүлээлгэж байгаа явдал тун хангалтгүй байна.

○ ЭХ-ийн 240 дүгээр зүйл буюу "Гадаадын иргэн, харъяалалгүй хүн Монгол Улсад оршин суух, дамжин өнгөрөх, зорчих журам зөрчих," гэмт хэрэг ЗХТХ-ийн зүйл хэсэгтэй агуулга үг үсгийн хувьд ч ижил байгаа нь хуулийн хэм хэмжээний давхардлыг бий болгож байна.

○ ЭХ-ийн 243 дугаар зүйл буюу мөрийтэй тоглох гэмт хэрэг мөн л ижил үйлдэгдэж байгаа боловч хуулийн хариуцлага хүлээж байгаа тохиолдол байхгүй байна.

○ ЭХ-ийн 244 дүгээр "Битүүмжилсэн эд зүйлийг дур мэдэн зарцуулах" гэмт хэрэг нь ЗХТХ-ийн зүйл хэсэгтэй нэгэн адил агуулгатай байгааг анхаарч эрх зүйн хэм хэмжээний давхардлыг арилгах хэрэгтэй.

14. ХОРИН ДОЛДУГААР БҮЛЭГ, ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

○ 245 дугаар зүйлд заасан "Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагаанд саад учруулах," гэсэн зүйл хэсгийн хэрэгжилт хангалтгүй байдаг. Энэ нь ЭБШХ-ийн "ЭБША-ны журам зөрчих" гэсэн хэсэгтэй ижил агуулгатай байдаг учраас ихэвчлэн ЭБШХ-д заасан заалтын дагуу Хэрэг бүртгэх мөрдөн байцаах албаны дарга торгуулийн арга хэмжээ аваад өнгөрдөг байна. Өөрөөр хэлбэл хуулийн хэрэгжилтийн байдалд хууль сахиулагч нар өөрсдөө санаачлагатай ажиллах шаардлагатай.

○ Гэмт хэргийг үл мэдээлэх, нуун далдлах гэмт хэргийг буруу зүйлчлэх тохиолдол байна. Нэн ялангуяа өөрийн төрөл садны эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй гэсэн Монгол Улсын Үндсэн хууль болон ЭБШХ-ийн зүйл, хэсгийн агуулгыг илтэд зөрчиж гэмт хэргийг нуун далдалсан гэж эрүүгийн хариуцлагад татаж байжээ.

○ ЭХ-ийн 257 дугаар зүйл. "Эрүүгийн хэргийн мэдээ баримтыг задруулах," гэмт хэрэг үйлдэгддэг боловч эрүүгийн хариуцлага хүлээлгэж байгаа нь цөөн , хуулийн хэрэгжилт муу байна. Мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн шийдвэр, хувь хүний нууцлалтай холбоотой шүүхийн шийтгэх тогтоол, бусад баримтыг нийтэд ил болгох, хэвлэлд нийтлэх явдал байсаар байна.

○ ЭХ-ийн 258 дугаар зүйл. "Шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх," зүйл хэсгийн хэрэгжилт хангалтгүй тухай шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нартай хийсэн ярилцлагын судалгаагаар тогтоогдож байсан. Иргэний нэхэмжлэлтэй холбогдолтой шүүхийн шийдвэрүүд биелэлт муутай байдгаас шалтгаалж тухайн зүйл хэсгээр эрүүгийн хариуцлагад татах хүндрэлтэй байдаг байна. Түүнчлэн ЗХТХ-ийн зарим зүйл хэсэгтэй ч агуулгын хувьд давхацдаг байна.

○ 261 дүгээр зүйл. Прокурорын хяналт, шүүх, цагдан хорих, хорих ангиас оргох," гэсэн зүйл хэсгийн хэрэгжилт зохих түвшинд байна. Хэдий ийм боловч хуульд тусгайлан заах шаарлагатай зүйлийн талаар прокурор нараас авсан анкетийн судалгаанд дурдсан байв. Энэ нь хэрэгсэхгүй болгосон эрүүгийн хэргийн тухайд таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан сэжигтэн, яллагдагчид энэ зүйл хэсгийг хэрэглэж эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байх талаар санал ирүүлсэн байв.

15. ХОРИН НАЙМДУГААР БҮЛЭГ, АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРЭГ

○ ЭХ-ийн 170 дугаар зүйл. "Хууль бусаар шан харамж авах" гэмт хэргийн албан тушаалын эсрэг гэмт хэргийн бүрэлдэхүүнд оруулах

○ 272 дугаар зүйл, хэсэг хуулиас тодорхой хугацаанд хасагдсанаас олон хүн ял завшсан гэсэн төсөөлөл олон нийтийн дунд байна.

○ Мөнгө угаах гэмт хэргийн талаар /Дээрх 268 дүгээр зүйлийг 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар нэмсэн/ шинэлэг зохицуулалтыг оруулж өгсөн сайшаалтай боловч энэ зүйл хэсгээр гэмт хэрэг гарч бүртгэгдээгүй байна.

○ Авилгатай тэмцэх газраас боловсруулж буй хуулийн төслүүдийг нэгтгэж үзсэний үндсэн дээр Албан тушаалын хэргийн нэр томъёог нэг мөр цэгцлэх шаарлагатай байна. Авилга, хээл хахууль гэсэн нэр томъёо хууль бүрд өөр, өөр утгатайгаар оржээ.

Дүгнэлт

Зарим улс оронд Эрүүгийн хуулинд өөрчлөлт хийхдээ эсэргүүцэлтэй тулгарч үүнийг хялбар аргаар шийдсэн байдаг. Тухайлбал ОХУ нь 1992 оноос хойш Эрүүгийн хууль даа бүлэг, институц тус бүрээр хийсээр 2003 он гэхэд бүрэн шинэчилж дуусан ба энэ нь Европын Холбооны стандартад нийцэж чаджээ. Хэрэв бид ийм аргаар, системтэй нэгдсэн бодлоготойгоор, үргэлжилсэнбайдлаар өөрчилж болох юм. Цаашид тус хуулийг өөрчлөх талаар баримтлах бодлого боовсруулахдаа ямар үйлдлийг гэмт хэрэгт тооцох эс тооцох, гэмт хэргийн ангилалыг гэм буруугийн субъектив шинжээр ангилах, нийгэм, иргэний үнэт зүйлсийг хамгаалсан, байнга хувьсан өөрчлөгдөөд байхаргүй ойлголтыг оруулах хэрэгтэй байна.

Гэмт хэргийн шинжийг ялимгүй агуулах үйлдэл гэж юу ойлгох, хөөн хэлэлцэх хугацааг өөрчлөх, Тусгай ангийн гэмт хэргийн бүлэг хэсэгт өөрчлөлт оруулах,. мөн хамтран үйлдэх, тэр дундаа хамжигч, хатгагч гэх мэтэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг тодорхой уян хатан байдлаар заах, Улсын дээд Шүүхийн тайлбарыг хуулийн агуулгаас хэтрүүлсэн хэм хэмжээ тогтоохгүй байх, хуулийн заалтад илт харшилж байгааг анхаарах гэх мэт олон асуудал та бидий өмнө тулгамдаад байна.

Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн талаар хийгдсэн судалгаа, эрдэмтэн судлаачдын байр суурийг үзвэл тус хуулийг шинэчилсэн байдлаар өөрчлөн найруулах шаардлага бий болсныг үндэслэлтэйгээр нотолжээ. Энэ нь тус хуулийн Ерөнхий болон Тусгай ангийн хэрэгжилт тааруу .байгаатай шууд холбоотой байна. Нэн ялангуяа ЭХ-ийн Ерөнхий ангид заагдсан зарчмуудыг шинээр хуульчлах, насанд хүрээгүй хүмүүст ногдуулах ялын төрөл, хэмжээг ялгавартай заах, түүнийг аль субъектээс хэрэглэх талаар зааж өгөх, гэмт хэргийн ангилал болон торгуулийн ялыг хохирлын хэмжээг зааж өгөхдөө хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хамааралтай байх шаардлага бий эсэхийг тодорхойлох зэрэг цаг үеийн шинжтэй тулгамдсан асуудлууд байсаар байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн хүрээнд тодорхой шаардлагуудын улмаас жилдээ 2-3 удаа нэмэлт өөрчлөлт хийгддэг энэ нь тогтмол, байнгын шинжтэйгээс гадна ингэж нэмэлт өөрчлөлтүүдийг ойр ойрхон хийж байгаа нь хууль энэ төрлийн харилцаагаа зохицуулах хэм хэмжээ хийдэл, давхардал ихтэйг харуулж байна. Тусгай ангийн хүрээнд өмчийн эсрэг гэмт хэргийн ялын бодлого харьцангуй хатуу байгаа боловч бусад төрлийн гэмт хэрэг тухайлбал албан тушаалын гэмт хэрэг, мэдээллийн аюулгүй байдлын

эсрэг гэмт хэрэг, хүний нэр төр, алдар хүндийн эсрэг гэмт хэрэг, хүүхдэд гэр бүл нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт ногдуулах ялын бодлого харьцангуй зөөлөн, тухайн төрлийн гэмт хэргийн бүрэлдхүүнүүд нь бусад хууль тогтоомжтой шууд давхардаж гэмт этгээдүүдийг ял завших боломжийг олгож байна.

Амьдралд зайлшгүй гардаг боловч эрүүгийн хэрэг үүсгэн шалгагддаггүй ЭХ-ийн тодорхой зүйлд заасан гэмт хэргүүд байна. Үүнд: ЭХ-ийн 101, 102 дугаар зүйлүүд "Доромжлох", "Гүтгэх", ЭХ-ийн 114, 115 "насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг үйлдэхэд татан оролцуулах",."Насанд хүрээгүй хүнийг согтуурал мансуурал, биеэ үнэлэх, тэнүүчлэл, гуйланчлалд татан оролцуулах" гэх мэт дурдаад байвал 20 орчим гэмт хэргийн бүрэлдхүүнүүд байна. Энэ нь тус хуулийн зүйл хэсгийг огт хэрэглэдэггүйтэй, эсвэл буруу тайлбарлаж, хэрэглэдэгээс шалтгаалж байгаа нь ажиглагдлаа.

2002 онд тус хуулийг батлан гаргаснаас хойш нилээдгүй нэмэлт, өөрчлөлт оруулсан боловч байнгын шинжтэй засвар хийгддэг, тэр ч байтугай хуулийн зарим зүйл хэсэг түр хугацаанд алга болдог, үүний улмаас гэмт этгээдүүд ял завшиж байжээ. Нэг жишээ авахад л мөнгө угаах гэмт хэргийн бүрэлдхүүнийг 3 удаа өөрчилсөн боловч энэ төрлийн гэмт хэрэг нэг ч шийдэгдээгүй байна.

Дээрх байдлаас дүгнэн үзэхэд Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулах шаардлага байгаа нь тодорхой байна. Хэдий тийм ч зарчмын шинжтэй өөрчлөлтийг хийлгүйгээр ингэж тогтмол шинжтэй нэмэлт, өөрчлөлт оруулаад байх нь хуулийн хэрэгжилтэнд сөргөөр нөлөөлдөг талтайг анхаарах хэрэгтэй.

Авлигатай тэмцэх үндэсний стратегийг боловсруулахад анхаарах асуудал

Нэг. Монгол дахь авлигын төлөв байдал

Өнөө үед авлига нь ядуурал, дархлалын олдмол хомсдол /ДОХ/, мансуурах бодисын хэрэглээ, цаг уурын дулаарал, цөлжилт зэрэг хүн төрөлхтний сэтгэлийг түгшээсэн олон асуудлын нэг болоод байна.

Авлигын асуудлыг дэлхий дахинаа судалж, улс нэг бүрээр авлигын түвшинг тодорхойлж байдаг "Транспаренси-Интернэшнл" /**Transparency International**/ олон улсын байгууллагын судалгаагаар авлига хамгийн их цэцэглэсэн улсын тоонд буурай хөгжилтэй улсууд төдийгүй АНУ, Итали, Франц зэрэг өндөр хөгжилтэй улс орсноос үзвэл энэхүү хорт үзэгдэл улс орны баян чинээлэг, хөгжилтэй эсэхээс төдийлөн үл хамаарч "даяарших" хандлагатай болж байна.

Швейцарийн Давост саяхан зохиогдсон Дэлхийн эдийн засгийн эзэлжит форум /World Economic Forum/-ын уулзалтын үеэр шударга бизнес эрхлэх, авлига, хээл хахуультай тэмцэх тухай асуудлыг нэгэн чухал сэдэв болгон хэлэлцжээ. Тухайлбал: "Хөгжлийг хөдөлгөгч хүч бол шударга бизнес-Давос авлигын эсрэг" сэдвийн дор болсон уулзалтын үед авлигатай тэмцэх төрийн бодлогыг хувийн хэвшил, олон нийтийн байгууллага, иргэдийн хамтын

хүчин чармайлт болгох талаар санаачлагатай ажиллахыг нийт улс гүрэнд уриалжээ. Түүнчлэн Дэлхийн эдийн засгийн чуулганы гүйцэтгэх захирал, "Авлигын эсрэг санаачилга"-ын Удирдах зөвлөлийн дарга Ричард Саманс "жил бүр нэг их наяд долларыг хэзл хахуульд зарцуулдаг" гэсэн судалгаа байгааг дурдаад, дэлхийн нэр хүндтэй томоохон компаниудад хандаж авилгатай тэмцэх талаар үлгэр жишээ үзүүлэхийг мөн уриалсан байна.[761]

Монгол Улс ардчилсан хөгжлийн замыг сонгон нийгмийн бүх хүрээнд шинэтгэл хийж эхэлсэн 1990-ээд оны дунд үеэс авлига хэмээх хорт үзэгдлийн талаар харанга дэлдэж, энэ нь олон нийтийн анхаарлыг зүй ёсоор татаж эхэлжээ. Энэ байдал ганц манай улсад ч буй болоогүй, хуучин социалист системд багтаж байсан бүх л улсыг нөмөрсөн үзэгдэл байв. Авлига эдгээр оронд онцгой анхаарал татаж эхэлсэн тухайн үе нь төрийн өмчийн хувьчлал эрчимтэй явагдсан үетэй давхцсан нь тохиолдлын бус байв. Хувийн өмч хөрөнгөгүй байсан хүмүүс зах зээлд богино хугацаанд хөлөө олох, хөрөнгөжиж баяжих ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх хамгийн дөт арга нь улсын өмчийг хувьд шилжүүлэхэд түүнээс ямар ч хамаагүй арга замаар ахиу хувь хүртэх явдал байжээ.

Монгол Улсад авлига улам бүр газар авч буйг тус улсын нийгэм-эдийн засгийн шинэ тогтолцоонд шилжих үйл явцыг дэмжиж хөрөнгө санхүүгийн тусламж, дэмжлэг үзүүлж байсан донор улсууд болон олон улсын банк, санхүүгийн байгууллагууд Улсын Их Хурал, Засгийн газарт удаа дараа анхааруулж байсан ч Монголын төр энэхүү хорт үзэгдлийг уг үндсээр нь таслахад чиглэсэн бодитой ажил зохион явуулаагүйгээс эдүгээ манай улс авлигад гүнзгий идэгдсэн улсын тоонд орж байна. Тухайлбал, ***Transparency International*** байгууллагаас тогтмол гаргадаг ***Corruption Perception Index*** 2010 оны байдлаар Монгол Улсыг авлигын түвшингээр 178 улсаас 116-д оруулжээ.

- Монгол Улсыг 2009 оноос эхлэн Global Integrity буюу "Шударга, ил тод байдлын тайлан"-д хамааруулж эхэлсэн. Уул тайланд Монголын Улсын "шударга, ил тод байдал"-ыг[762] Mongolia: Integrity Indicators Scorecard Overall Score: 57 /+/- 1.54/ - Very Weak буюу "маш сул" гэж дүгнэжээ.
- Дэлхийн банкнаас жил бүр гаргадаг "Сайн засаглалын индикатор"-т [763] Монгол Улсын авилгад тавих хяналт /control of corruption/-ын үзүүлэлт сүүлийн жилүүдэд тогтмол буурч 2009 онд 100 онооны үнэлгээнээс 24 оноогоор нилээд хойгуур жагсжээ.

НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, Азийн хөгжлийн банк, түүнчлэн АНУ-ын "Олон улсын хөгжлийн агентлаг", "Муж улсуудын шүүхийн үндэсний төв" зэрэг судалгааны байгууллагаас санхүүжүүлж монголын иргэний нийгмийн байгууллагуудын өргөн оролцоотойгоор гүйцэтгэсэн судалгаанууд Монгол дахь авлигын төлөв байдал, авлигын тухай иргэдийн төсөөлөл, хандлагыг бодит байдлаар тодорхойлоход ач холбогдол бүхий хангалттай мэдээлэл

[761] Өнөөдрийн байдлаар "Авлигын эсрэг санаачилга" -д дэлхийд тэргүүлэгч 120 орчим компани нэгдэн ажиллаж байна.

[762] http://report.globalintegrity.org/Mongolia/2009, Last visited 2011.1.14

[763] http://info.worldbank.org/governance/wgi/pdf/c147.pdf, Last visited 2011.1.14

агуулсан байна. Дээрх судалгааны тайлан, мэдээ мэдээллийг бүхэлд нь дүгнэж үзвэл эдүгээ Монгол Улсын авлигын талаар дараах төсөөлөл хийж болохоор байна[2]. Үүнд:

- Авлига төрийн албаны бүхий л салаа мөчирт өргөн тархасны дотор улс төрийн хүрээнд, ялангуяа улс төрөөр дамжин төрийн өндөр албан тушаалд хүрэгсэд /судалгаанд "Өндөр түвшин", "Элит" гэсэн нэр томъёо хэрэглэсэн байна/-ийн дунд авлига илүү их байна.
- Улс төрийн хүрээн дэх бизнесийн бүлэглэлийн сонирхлын зөрчил, сонгуулийн болон намын санхүүжилт, сонгуулийн тогтолцооны авлигад үзүүлэх нөлөө маш хүчтэй хэвээр байна.
- Төрийн байгууллагын үйл ажиллагааны хараат бус байдал суларч, улс төрийн намуудаас ихээхэн хараат болсны гадна "төрийн аппарат данхайж", улсын төсөвт эзлэх зардлын хэмжээ, хувийн жин өсөн нэмэгдсэн ч иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар улам муудаж байна.
- Улс төрийн намын дараа авлигад хамгийн ихээр автсан байгууллагаар цагдаа, газрын алба, шүүх, мэргэжлийн хяналт, татвар зэрэг байгууллагыг олон жил ээлжлэн нэрлэж байна.
- Авлига авах олон арга, хэлбэрийг судалгааны санал асуулгад дурдсан боловч эдгээрээс төрийн албанд ажилд орох, ямар нэг зөвшөөрөл олгох, тендерт оролцох буюу төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах сонгон шалгаруулалтыг онцлон нэрлэсэн байх ба сүүлийн үеийн судалгаагаар эрүүл мэнд, боловсролын салбарын эмчилгээ, үйлчилгээтэй холбоотой авилгыг олонтаа нэрлэх болжээ.
- Авлигыг "ажлаа хурдан бүтээх чухал хэрэгсэл", "авлига нь нийгэмд байх зүйл, заавал муу үр дагавартай байх ёсгүй", "тийм ч гаж үзэгдэл биш" гэх зэргээр авлигад дасан зохицох хандлага нийгмийн зарим бүлэгт төлөвшиж буй нь ажиглагдаж байна.

Хоёр. Авлигатай тэмцэх үндэсний стратеги боловсруулах хэрэгцээ, шаардлага

Монгол Улсын Их Хурлын 2008 оны 35 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.1.9-д "Авилгаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх дунд хугацааны хөтөлбөр"-ийг баталж, хэрэгжүүлэхээр заажээ.

Давосын уулзалтад оролцсон Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж тус чуулга уулзалтыг санаачлагч, Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалтын дарга профессор Клаус Швабтай уулзахдаа Улаанбаатар хотод "Зүүн азийн Давос"-ыг зохион байгуулах, Монгол Улсыг Давосын чуулганаас хэрэгжүүлж буй "Авлигын эсрэг санаачилга" төсөлд хамруулах хүсэлт тавьж, монголын бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжүүд олон улсын тавцанд гарч эхэлсэнтэй холбогдож монголын компаниудыг Давосын уулзалтад гишүүнээр элсүүлэх асуудлыг мөн судалж үзэхийг санал болгожээ.

Монгол Улсын Их Хурал, Засгийн газар "Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх дунд хугацааны хөтөлбөр" баталж, хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн Дэлхийн эдийн засгийн

чуулга уулзалтын үеэр гаргасан санал, санаачлага зэрэг нь авлига хэмээх даяарчлагдсан хорт үзэгдлээс ангижрахын тулд Монголын ард түмэн, монголын төр дотооддоо төдийгүй дэлхийн хамтын нийгэмлэгтэй үр дүнтэй, идэвхитэй хамтран ажиллах эрмэлзэл дүүрэн байгааг илэрхийлж байна.

Дээрх нөхцөл байдалд Улсын Их Хурал 1996 онд Авилгалын эсрэг хууль баталсан боловч хуулийн биелэлтийг улсын хэмжээнд зохион байгуулах үүрэгтэй Засгийн газар олон удаа солигдож авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажил үндсэндээ орхигджээ.

Хууль баталснаас хойш зургаан жилийн дараа буюу 2002 онд "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг Монгол Улсын Их Хурлын 41 дүгээр тогтоолоор батлажээ.

Энэхүү хөтөлбөрийг 2002-2010 онд хоёр үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөж, авлигаас урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг бий болгох, сонгуулийн тогтолцоо болон төрийн албыг боловсронгуй болгох, эдийн засгийг либералчлах, шүүх эрх мэдлийн хараат бус, бие даасан байдлыг хангах, авлигатай тэмцэх ажилд иргэний нийгмийн оролцоог дээшлүүлэх, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагуудаас авах арга хэмжээ гэсэн үндсэн хэд хэдэн чиглэлийн үйл ажиллагаа явуулахаар тусгасан байх бөгөөд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулж хяналт тавих үүрэг бүхий Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг мөн батлажээ. Гэвч авлигатай хийх тэмцэлд төрийн тууштай бодлого, бодитой үйл ажиллагаа дутсанаас өмч хувьчлалын үйл явцын үеэс эхлэлтэй авлига улам цэцэглэн хөгжиж, эдүгээ арга, хэлбэрийн хувьд улам нарийсч, цар хүрээ нь үлэмж өсөн тэлж монголын нийгмийн хөгжлийг чөдөрлөгч хүчин зүйл болоод байна.

Монгол Улсын эдийн засаг сүүлийн жилүүдэд харьцангуй түргэн хурдацтай өсч, үндэсний орлого нилээд нэмэгдсэн байхад хүн амын ядуурлын түвшин мөн хугацаанд дорвитой буураагүй байна. Монгол Улсын Үндэсний статистикийн газраас гаргасан мэдээгээр нийт хүн амын гуравны нэг нь Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур орлоготой байна. Өөрөөр хэлбэл улс орон хөгжиж, хөрөнгө орлогын хэмжээ нэмэгдэж буй ч орлогын тэнцвэргүй хуваарилалтаас шалтгаалан хүн амын цөөн хэсэг хэт их баяжиж, дийлэнх олонхи нь ядуу тарчиг хэвээр үлдэж хоцорчээ[764].

Иймд авлигын эсрэг төрийн шинэ бодлого, чиглэл гаргаж даруй хэрэгжүүлэх явдал нэн чухал болоод байна.

Монгол Улсын Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах үйл ажиллагаа

Улсын Их Хурлын 2002 оны 41 дүгээр тогтоолоор баталсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлснээр хүрсэн үр дүн, олсон амжилт, гаргасан алдаа эндэгдлийг хараахан эцэслэн үнэлж дүгнээгүй байгаа ч Монгол Улс Авилгалын эсрэг конвенцийг 2005 онд соёрхон баталж, Авлигатай тэмцэх тухай хууль /2006 он /-ийг батлан мөрдүүлж, авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын

[764] Үндэсний статистикийн газраас гаргадаг "Монгол Улсын эдийн засаг, нийгмийн статистикийн бюллетень, танилцуулгаас. 2009-2010 он". www.nso.mn

гэмт хэргийг илрүүлэх үүрэг бүхий хараат бус, бие даасан байгууллага /2007 он/ бий болгож, төрийн улс төр, захиргаа, тусгай албан тушаалтан болон хуульд заасан бусад этгээд хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах журам тогтоон хэвшүүлсэн зэрэг авлигатай тэмцэх бодитой алхамууд сүүлийн 5-6 жилд хийжээ[765].

Авлигатай тэмцэх газар Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан хэргийн харъяаллын дагуу 2007-2009 онд нийт 345 эрүүгийн хэрэгт хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааг явуулсны 52.1 хувь буюу 180 хэргийг тус газрын мөрдөн байцаагч эрүүгийн хэрэг үүсгэж, 47.9 хувь буюу 165 хэргийг эрх бүхий бусад байгууллагаас харъяаллын дагуу шилжүүлснээр шалгажээ. Мөн тус газрын гаргасан мэдээгээр дээрх 345 эрүүгийн хэрэгт бие даасан 563 гэмт үйлдэл шалгагдсан байна.

Мөрдөн байцаалт явуулсан нийт хэргийн үйлдлийг Эрүүгийн хуулийн зүйл, хэсэгт зааснаар ангилбал:

Мөрдөн шалгасан нийт хэрэгт 778 хүнийг сэжигтэн, яллагдагчаар татсан байх ба тэдгээрийг төрийн албаны ангилал, албан тушаалын байдлаар авч үзвэл:

[765] Төрийн захиргааны төв байгууллага, түүний харьяа агентлагууд, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрууд авлигатай тэмцэх талаар зохион явуулсан ажлынхаа тайланг Авлигатай тэмцэх газарт ирүүлдэг болсон байна. Гэвч эдгээр тайланд дурдсан ажил, арга хэмжээний бодит үр нөлөөг үнэлж дүгнэх шаардлагатай.

Гэмт хэрэгт шалгагдсан



АТГ-ын Мөрдөн шалгах ажиллагаанд хийсэн үнэлгээний тайланд[766]

Албан тушаалын байдал



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

Авлигын гэмт хэргийн шийдвэрлэсэн байдал:

Нийт шалгасан хэргийн 30.1 хувь буюу 104 хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэхээр прокурорт шилжүүлсэн, 24.9 хувь буюу 86 хэргийг хэргэсэхгүй болгосон, 24.3 хувь буюу 84 хэргийг харъяаллын дагуу шилжүүлсэн, 2.3 хувь буюу 8 хэргийг түдгэлзүүлж, 11.0 хувь буюу 38 хэргийг бусад хэрэгт нэгтгэсэн байна.

Мөрдөн шалгасан гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ 63 тэрбум 898.0 сая төгрөг, үүнээс 5 тэрбум 610.5 сая төгрөгийн хохирлыг мөрдөн байцаалтын явцад барагдуулжээ.

Яллах дүгнэлт үйлдүүлэхээр прокурорт шилжүүлсэн хэргээс 69 холбогдогчтой 42 хэргийг шүүх хянан шийдвэрлэсэн байх ба үүнээс 32 хэргийн 56 шүүгдэгчийг шүүх гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцжээ.

[766] UNODC-ооc 2010 оны 3 дугаар сард Монгол Улсын Авлигатай тэмцэх газарт хийсэн үнэлгээний тайлангаас авав.

Ял шийтгүүлсэн төрийн албан хаагчдыг төрийн албаны ангиллаар авч үзвэл төрийн тусгай албан хаагч 17 буюу 50.0 хувь,төрийн захиргааны албан хаагч 15 буюу 44.4 хувь, төрийн үйлчилгээний албан хаагч 2 буюу 5.6 хувийг тус тус эзэлж байна.

Төрийн өндөр албан тушаалтан, улс төрчдийн холбогдсон авлигын хэргийг мөрдөн шалгахад эрх зүйн зохицуулалтын болон субьектив шинжтэй саад бэрхшээл нилээд тохиолдож байна[767].

Манай улс авлигатай тэмцэх тусгай чиг үүрэг бүхий төрийн байгууллага бий болгож, үйл ажиллагааг нь дэмжиж ирсэн нь Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлсэн нэг чухал алхам мөн боловч үндэсний хэмжээнд авлигын эсрэг тэмцлийг олон чиглэлээр, нэгэн зэрэг үр нөлөөтэй аргаар, эрчимтэй өрнүүлэх нь илүү үр дүнд хүргэнэ.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцид Монгол Улсын хууль тогтоомжийг нийцүүлсэн байдал

Монгол Улс Авилгалын эсрэг НҮБ-ын конвенцийг 2005 оны 10 дугаар сарын 27-ны өдөр соёрхон батлснаар дотоодын хууль тогтоомжийг конвенцид нийцүүлэх үүрэг хүлээсэн билээ.

Энэхүү үүргийн дагуу Монгол Улсын Их Хурал 2007 оны 8 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт оруулж Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэргийн харъяаллыг тогтоосон байх бөгөөд 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуулиар Эрүүгийн хуульд авлигын гэмт хэргийн талаар томоохон нэмэлт, өөрчлөлт оруулжээ. Түүнчлэн Гүйцэтгэх ажлын тухай хууль болон холбогдох бусад хуульд зохих нэмэлт, өөрчлөлт хийсэн байна.

Гэвч гадаад дотоодын судалгааны байгууллагын шинжээч-судлаачдын үзэж буйгаар авлигатай тэмцэх асуудлыг зохицуулсан дотоодын хууль тогтоомжийг олон улсын гэрээнд нийцүүлэх шаардлага байсаар байна. Тухайлбал, Авилгалын эсрэг конвенцийн дагуу гэмт хэрэгт тооцох зарим үйлдлийг Монгол Улсын Эрүүгийн хуулиар гэмт хэрэгт тооцох үүргээ одоо хэр биелүүлээгүй, үүнд: "Хууль бусаар баяжих", "Гадаадын төрийн албан хаагч болон олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах", хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх гэх зэрэг асуудлыг огт хуульчлаагүй байна. Хэрэгтэн шилжүүлэх болон мөнгө угаах гэмт хэрэгтэй холбоотой зарим зохицуулалт, түүнчлэн авлигын хэрэг мөрдөн шалгах, түүнд хяналт тавих үүрэгтэй байгууллагын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулсан зохицуулалтыг зохих хуульд оруулах шаардлагатай.

Түүнчлэн үндэсний хууль тогтоомжийг Конвенцид нийцүүлэхтэй холбоотойгоор зайлшгүй авч үзэх өөр асуудал бол авлигыг илчлэхэд хувь нэмрээ оруулж, хууль сахиулах байгууллагатай хамтран ажилласан хүмүүсийг хамгаалах явдал юм. Гэрч, шинжээч, хохирогч, мэдээлэл өгсөн хүнийг хамгаалах талаар шаардлагатай бүх талын арга хэмжээ, түүний дотор тухайн хүмүүсийг шилжүүлэн суурьшуулах, хувийн мэдээллийг нууцлах,

[767] Авлигатай тэмцэх газар байгуулагдснаас хойш мөрдөн шалгагдсан, шийдвэрлэгдсэн эрүүгийн хэрэгт мониторинг хийх шаардлагатай.

биечилсэн хамгаалалтад авах, мэдүүлгийг дүрс бичлэг, холбооны бусад хэрэгслээр дамжуулан авах зэрэг аргыг хэрэглэх ёстойг Конвенцид заажээ. Одоогоор энэ төрлийн хамгаалалт манай эрх зүйн зохицуулалтын хүрээнд шийдэгдээгүй байгаа юм. Түүнчлэн, Конвенцид нийцүүлэн гэмт хэргээс олсон орлогын гүйлгээнээс урьдчилан сэргийлэх, түүнийг илрүүлэхтэй холбогдсон зохицуулалт, авлигын шинжтэй хууль бус хөрөнгө мөнгөний шилжилт, хөдөлгөөнийг хянах, илрүүлэхэд чиглэсэн гүйцэтгэх ажлын тусгай арга хэмжээг нутаг дэвсгэртээ явуулахыг зөвшөөрөх, энэ арга замаар олсон нотлох баримтыг шүүхийн ажиллагаанд хүлээн зөвшөөрүүлэх, хувийн хэвшилд авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд нягтлан бодох бүртгэлийн болон хөндлөнгийн хяналтын зохицуулалт, стандарт, тогтолцоог бүрдүүлэх зэрэг зохицуулалтыг үндэсний хууль тогтоомжид оруулах шаардлагатай.

Гурав. Авлигатай тэмцэх үндэсний стратеги боловсруулахад баримтлах зарчим

Алигатай тэмцэх үндэсний стратеги боловсруулахдаа юуны өмнө дотоод дахь авлигын төлөв байдалд үндэслэлтэй дүн шинжилгээ хийж, бодит нөхцөл байдалдаа тохирсон, хөрөнгө санхүүгийн нөөц боломжтой уялдуулсан үйл ажиллагаа төлөвлөхөөс гадна олон улсын байгууллагуудын үйл ажиллагааны үзэл баримтлал, хэрэгжүүлж буй хөтөлбөрийг судлан, өөрийн оронд хэрэгжүүлж болох зарим арга хэмжээг зөвлөдэн нутагшуулах нь зүйтэй юм.

I. Авлигатай тэмцэх үндэсний стратеги, үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулсан гадаад улсын туршлага, олон улсын байгууллагын зөвлөгөө

Олон улсын туршлагаас үзвэл авлигын эсрэг стратеги боловсруулахын өмнө эхлээд тухайн улс дахь засаглалын чансаа /quality of governance/-г тодорхойлж, сайн, дунд, хангалтгүй гэсэн үнэлгээ өгдөг байна. Манай улс засаглалын чансаагаар "дунд" зэрэг гэж тооцож болохоор байна.

Цаашилбал, дэлхийн улс гүрэнд хуримтлагдсан авлигатай тэмцэх олон янзын арга, хэрэгслээс чухам аль нь ямар үр дүн өгөх вэ гэдгийг засаглалын чансаанаас хамааруулан судлаачид тогтоосон байна. Энэ аргачлалд үндэслэн засаглалын чансаагаар "дунд" зэрэгт орох Монголын хувьд "дунд" болон "сайн" үр дүн өгөх арга, хэрэгслийг эн тэргүүнд ашиглах, "тааруу" үр дүн өгөх арга, хэрэгслийг тодорхой хязгаартайгаар ашиглах нь зүйтэй юм.

Нөгөө талаас, Монгол Улсын засаглалын байдлыг шинжлэн судалж үзэхэд суурь бүтэц, тогтолцоо нь "дунд" зэрэг буюу боломжийн байгаа боловч төрийн албанд ажиллах боловсон хүчний бодлого алдагдсан, нэн ялангуяа, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд ажиллах иргэнийг шилж, сонгон томилох тогтолцоо улс төрийн нөлөөнд бүрэн автсанаас хүний хүчин зүйл авлигатай тэмцэх ажлын эцсийн үр дүнд хүчтэй нөлөөлж байна.

Авлигатай тэмцэхийн тулд засаглалын чансааг бүхэлд нь дээшлүүлэх стратеги сонгож авах албагүй. Сайн засаглал бий болгох нь урт удаан хугацааны томоохон ажил бөгөөд авлигын эсрэг тэмцэл бол харин түүний нэг хэсэг юм.

Засаглалын чансаагаар "дунд" ззрэгт орох улсад тохирсон авлигатай тэмцэх арга, хэрэгсэл нь Монголын төрийн албанд "улс төрийн" томилгоо хавтгайрсан онцлог нөхцөл байдалтай логик уялдаатай байгааг доорх хүснэгтээс харж болно. Төрийн албанд оршиж байгаа энэ томоохон асуудлыг авлигатай тэмцэх стратегийн гол цем болгон авах нь зүйтэй.

Хүснэгт № 1.

Олон улсын туршлага "тааруу" үр дүн өгнө гэж үзсэн авлигатай тэмцэх арга, хэрэгсэл Монголын онцлог нөхцөл байдалд мөн адил "тааруу" үр дүн өгнө.

Авлигатай тэмцэх арга, хэрэгсэл	Засаглал "дунд" бол үр дүн ...	Төрийн албанд улс төрийн томилгоо хавтгайрсан нөхцөлд ...
Авлигын талаар олон нийтийг соён гэгээрүүлэх ажил зохиох	тааруу	Төрийн албанд буй авлигад өртөгдсөн хэсэг нь хүчтэй байхад олон нийт зохион байгуулалтад ороходоо удаан, хүн бүр бусдадаа найдаж идэвхгүй байдал гаргаж байдаг.
Төрийн албан хаагчдыг соён гэгээрүүлэх зорилгоор сургалт, семинар зохиох	тааруу	Төрийн албанд буй авлигад өртөгдсөн хэсгийг ухуулан, таниулах аргаар өөрчлөнө гэхэд маш эргэлзээтэй.
Авилгатай тэмцэх байгууллага, омбудсман бий болгох	тааруу	АТГ нь өөрөө төрийн албаны нэг хэсэг бөгөөд мөн л улс төрийн томилгоонд өртөх эрсдэлтэй.
Ёс зүйн алба байгуулах	тааруу	Төрийн албанд буй авлигад өртөгдсөн хэсэг нь ёс зүйн аливаа дүрэм, журмыг эсэргүүцнэ.
Улсын секторын цалин нэмэгдүүлэх	тааруу	Төрийн албанд буй авлигад өртөгдсөн хэсэг нь авлигаас ихээхэн орлого олж байдаг тул тэдний хувьд цалин нэмэгдэх нь ач холбогдол маш багатай.
Албан хаагчдын цалингийн зөрүүг багасгах	ялимгүй	Өмнөхтэй адил.
Санхүүгийн хариуцлага тооцох	тааруу	Төрийн албанд буй авлигад өртөгдсөн хэсэг нь санхүүгийн хариуцлагаас мултрах бүхий л арга залийг овжин ашиглах тул үр дүн өгөхгүй.
Төрийн албаны орон тоог цомхотгох	тааруу	Нийт төрийн албан хаагчдын тоо цөөрлөө ч тэдний дунд байгаа авлигад өртөгдсөн хэсгийг тоо багасах баталгаа байхгүй.
Төвлөрлийг сааруулах	тааруу	Улс төрийн томилгоо төв, орон нутагт адилхан газар авсан учраас эрх мэдлийг төвөөс орон нутаг руу шилжүүлснээр үр дүн өгөхгүй.

Хүснэгт № 2.

Олон улсын туршлага "дунд" үр дүн өгнө гэж үзсэн авлигатай тэмцэх арга, хэрэгсэл нь Монголын онцлог нөхцөл байдалд мөн адил "дунд" эсвэл бүр "сайн" үр дүн өгнө.

Авилгатай тэмцэх арга	Засаглал "дунд" бол үр дүн...	Төрийн албанд улс төрийн томилгоо хавгайрсан нөхцөлд ....
Төрийн албыг авъяас,чадварт суурилсан тогтолцоонд шилжүүлэх	дунд	Улс төрийн холбоо, сүлбээ ашиглан томилгоо хийдэг явдлыг өрсөлдөөнтэй, ил тод, шударга тогтолцоо бий болгосноор зогсоож чадна.
Иргэдэд үйлчлэхэд чиглэсэн төрийн албыг дэмжих	дунд	Төрийн үйлчилгээг шуурхай, хүнд суртал, чирэгдэлгүй болгож чадвал төрийн албанд буй авлигад өртөгдсөн хэсэг хэзээ хахууль авах боломж багасна.
Олон нийтийн санал асуулга явуулах	дунд	Төрийн албаны нээлттэй, өрсөлдөөнтэй тогтолцоог олон нийт дэмжиж байгаа эсэхийг тогтоож, авъяас чадалтай хэсгийг төрийн алба руу татах нь чухал.
Эдийн засгийн бодлогын шинэчлэл хийх	дунд	Төрийн алба чадваржсан нөхцөлд улсын эдийн засгийн хөгжлийн томоохон шийдлүүдийг гаргаж ажиллах, түүнийхээ үр шимийг хүртэх боломжтой тогтолцоо бий болгож чадвал авлигад өртөх эрсдэл багасна.
Парламентын хяналт бий болгох	дунд	Улс төрчид өөрсдөө улс төрийн томилгоонд оролцох биш түүнд хяналт тавих чиг үүрэгтэй болоод ирэхээр түүнээс зайлсхийдэг болно.
Хэвлэл мэдээлэл болон шүүхийн хараат бус байдлыг хамгаалан дэмжих, иргэдийн оролцоо	дунд	Улс төрийн томилгоог илчлэх, төрийн албаны шалгалт шударга бус явагдсан бол шүүхэд хандаж маргааныг шийдэх, иргэд төрийн албанд авъяас чадлаараа шалгарч орох гэсэн эрмэлзлэл хүчтэй болно.
Эрх зүйт ёсыг бэхжүүлэх	дунд	Төрийн албанд орох журмыг маш нарийн боловсруулж, хатуу дагаж мөрдсөнөөр үр дүн гарна.
Улсын секторын хамрах хүрээг багасгах	дунд	Авлигад өртөх боломж нь багасна.

Хүснэгт № 2-т заасан арга, хэрэгсэл дэлхийн туршлагаас үүдэн засаглалын чансаагаар "дунд" гэж үнэлэгдэж байгаа Монголд "дунд" зэргийн үр дүн авчрах болно гэсэн дүгнэлт хийж болно. Нөгөө талаас, эдгээр арга нь Монголын онцлог байдалд маш сайн нийцэж байгаа юм. Гэхдээ хүснэгт № 1-д заасан арга, хэрэглэлийг огт ашиглахгүй гэсэн үг биш. Тэдгээрийг нэмэлт болон туслах чанарын арга, хэрэгсэл болгон ашиглах нь зүйтэй.

II. Улс төрийн сонгуультай холбоотой авлигын асуудал

Монголын хувьд улс төрийн сонгууль авлигын бас нэг гол эх үүсвэр болж байна. Улс төрийн намууд сонгуулийн сурталчилгааг санхүүжүүлэхийн тулд бизнесийн зүгээс ил, далд санхүүгийн дэмжлэг авдаг бөгөөд түүний хариуд тэдэнд албан тушаал амлах, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх, тендерт ороход нь давуу эрх олгох зэргээр авлигад өртөх нь түгээмэл байна. Авлигын энэ эх үүсвэртэй тэмцэх нь зүйн хэрэг боловч богино хугацаанд амжилт олно гэхэд эргэлзээтэй. Иймд энэхүү стратегид уг асуудлыг хязгаарлагдмал хүрээнд оруулах нь бодит байдалд илүү нийцнэ гэж үзэж байна.

Төрийн албыг улс төржүүлэх явдал улс төрийн сонгуулиас эхтэй боловч авлигатай тэмцэх стратегийн хувьд улс төрийн сонгуулийг бус төрийн албыг гол чиглэл болгож авах нь зөв шийдэл гэдгийг дараах үндэслэлээр тайлбарлаж болно. Үүнд:

1. Төрийн албанд иргэд улс төрийн дэмжлэгээр бус өөрийн авъяас чадлаар шалгаран орж ажилладаг тогтолцоо нь улс төрийн сонгуулийн үр дүн ямар байхаас үл хамааран оршин тогтнох боломжтой.

2. Төрийн алба нь улс төрийн сонгуулиас илүү тогтвортой бөгөөд байнгын шинжтэй учир авлигатай тэмцэх ажлыг тийш нь чиглүүлбэл илүү үр дүнтэй.

3. Улс төрийн сонгууль нь иргэдийн улс төрийн идэвх, ухамсар гэх мэт субъектив хүчин зүйлээс хамааралтай бол төрийн албаны шалгалтын тогтолцоо нь техникийн шинжтэй учир нарийн дэг, журамд оруулж, аливаа субъектив элементийг багасгах боломжтой.

4. Улс төрийн сонгуулийг мөнгөний нөлөөнөөс бүрмөсөн ангижруулах боломжгүй[768] учир энд авлига үүсэх эрсдэл ямагт өндөр байдаг. Сонгуулийн сурталчилгаанд өгч буй хандив нь хандив өгөгчийн улс төрийн итгэл, үнэмшлийн илэрхийлэл үү, эсхүл ашиг хонжоо харсан авлигын хэлбэр үү гэдгийг практикт ялгаж танихад маш хүндрэлтэй. Иймд хяналтыг сонгуулийн шатанд бус харин түүний дараах албан тушаалын томилгоон дээр төвлөрүүлэх нь арай хялбар юм.

5. Улс төрийн сонгууль нь улс төр, эдийн засгийн ашиг сонирхол хамгийн хүчтэй төвлөрсөн хэсэг учраас авлигын эсрэг тэмцэх ажил энд хамгийн хүчтэй эсэргүүцэлтэй тулгарна.

6. Авлигатай тэмцэх стратеги нь улс төрчдийн зүгээс дэмжлэг авахын тулд тэдний амин чухал эрх ашгийг шууд хөндсөн асуудлаас аль болох зайлсхийх нь зүйтэй.

[768] АНУ-ын Дээд Шүүх 1976 онд Buckley v. Valeo гэж нэрлэгдсэн хэргийг шийдэхдээ "money is speech" буюу "мөнгө бол иргэн үг хэлэх эрхээ эдлэх үндэс мөн" гэсэн санааг дэвшүүлсэн байдаг. Иймд сонгуулийн сурталчилгаанд мөнгө зарцуулах боломжийг хязгаарлах нь үг хэлэх эрхийг хязгаарлана гэсэн үг болж байна.

III. Авлигатай тэмцэх олон янзын арга, хэрэгслийн хоорондын уялдаа холбоо

Төрийн албанд буй авлигад өртсөн хэсэгтэй тэмцэх хамгийн үр дүнтэй арга бол тэднийг төрийн албанаас шахан гаргах, шинээр орж ирэхээс сэргийлэх явдал юм. Улс төрийн томилгоо бол шууд авлигыг өөгшүүлсэн тогтолцоо мөн. Анх томилогдох үеэсээ улс төрийн "барьцаанд" орсон албан тушаалтныг авлигаас ангид байлгана гэдэг бол бараг боломжгүй зүйл.

Улс төрөөс хараат бусаар томилогдсон тохиолдолд төрийн албан тушаалтан шударга ажиллах гол үндэс суурь бүрдэнэ. Гэхдээ хяналтыг цаашид сулруулж болохгүй. Харин түүнд хяналт тавих субъектийг зөв, оновчтой тодорхойлох нь маш чухал. Төрийн албаны шатлан захирах тогтолцооны дагуу дээд шатны албан тушаалтан доод шатны албан тушаалтанд хяналт тавих ёстой байдаг. Үүнээс гадна нэмэлт хяналтын механизмыг эрх зүйн шинэлэг зохицуулалтаар бий болгох шаардлагатай байна. Төрийн тодорхой албан тушаалд өрсөлдөж байгаа иргэд бие биедээ хяналт тавих сонирхол хамгийн хүчтэй байх болно. Энэ хөшүүргийг ашиглахын тулд юуны өмнө төрийн албаны шалгалтад эхний байруудыг дараалан эзэлсэн өрсөлдөгч нараас шалгаран эхэлж томилогдсон иргэн авлигын асуудалд холбогдон ажлаас халагдсан тохиолдолд түүний дараагийн байранд орсон иргэн нөхөн томилогдох эрхийг хуулиар баталгаажуулах нь зүйтэй. Цаашилбал, төрийн албан тушаалд өрсөлдөгч нар бие биенийхээ талаар Авлигатай тэмцэх газарт мэдээлэл өгсөн тохиолдолд мэдээлэгчийг нууцлах талаар онцгой анхаарах, мэдээллийн үнэн бодитой байдлыг сайтар шалгадаг байх, өрсөлдөөн эрүүл бус арга, хэлбэр рүү орохоос сэргийлэх, АТГ өөрөө аль нэг талд үйлчлэх байдал руу орохоос хамгаалагдсан байх шаардлагатай.

Авлигатай тэмцэх бусад арга, хэрэгсэл үр дүн өгөх эсэх нь гагцхүү төрийн албаны ил тод, өрсөлдөөнтэй, шударга тогтолцоо бүрдүүлж чадах эсэхээс хамаарна.

Иргэдийн төрийн албанд орж ажиллах санхүүгийн сонирхол хувийн секторoос дутуугүй байх ёстой. Зарим иргэний төрийн албанд орж ажиллах сонирхол нь хяналт, хариуцлага сул байгааг далимдуулан албан тушаалаа ашиглаж хувийн ашиг хонжоо олох гэсэн увайгүй зорилгоор тодорхойлогдож байгаа нь нууц биш билээ.

Төсвийн байгууллагын албан хаагчдын цалинг нийтээр нь хавтгайруулан нэмэх арга бол төрийн албаны авлигад өртөгдсөн хэсэгт нөлөө үзүүлэх магадлал маш бага гэдэг нь тодорхой.

IV. Авлигатай тэмцэх стратегийн үндсэн чиглэлүүд

"Авлигатай тэмцэх" гэдэгт авлигаас сэргийлэх болон авлигын илрэлийг таслан зогсоох тухай асуудлыг багтаан ойлгож болно. Үүнээс үүдэн авлигатай тэмцэх үндсэн 8 чиглэлийг тодорхойлж, чиглэл бүрээр урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээг стратегид тусгах нь зүйтэй гэж үзнэ.

Юуны урьд улс төрийн түвшний буюу элит түвшний авлигатай тэмцэх явдал чухал. Хэдийгээр энэ нь авлигатай тэмцэх стратегийг батлах эрх

бүхий хууль тогтоох байгууллага доторх авлигатай тэмцэх асуудал учраас уг байгууллагын зүгээс эсэргүүцэлтэй тулгарч болох авч авлигын эсрэг нийгэм бүхэлдээ нэгэн эвсэл болж чадвал үр дүн гарах боломжтой гэдгийг олон улсын туршлага харуулж байна.

--- x ---

Төсөл

Тав. Монгол Улсын авлигатай тэмцэх үндэсний стратеги

Энэхүү стратеги нь 2002 оноос хэрэгжүүлсэн Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн үргэлжлэл бөгөөд 2011 оноос 2015 он хүртэл 5 жилийн хугацаанд хэрэгжинэ.

Стратегийн зорилго

Монгол Улсад төр, засгийн бүх шатны байгууллага, албан тушаалтныг авлигад өртөх эрсдлээс урьдчилан сэргийлж, авлигын аливаа илрэлийг таслан зогсоож, түүнтэй тууштай тэмцэх, олон нийтийн дунд авлигыг үл тэвчих үзэл санааг түгээн дэлгэрүүлэхэд энэхүү стратегийн зорилго оршино.

Нэг. Хууль тогтоох байгууллагад эдийн засгийн болон бусад явцуу сонирхол бүхий бүлэглэлийн нөлөөллийг арилгах

1.1. Улс төрийн байгууллага, албан тушаалтанд санхүүгийн болон бусад дэмжлэг үзүүлэх замаар хууль тогтоох байгууллагад төлөөлөл бүй болгож, төрийн бодлого тодорхойлоход хууль бусаар нөлөөлөх, хувийн буюу бүлгийн эдийн засгийн ашиг сонирхолд нийцсэн шийдвэр гаргуулах явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх

1.2. Эрх тэгш байх, нээлттэй байх, тунгалаг байх зарчимд тулгуурлан иргэд, тэдгээрийн төлөөллийн байгууллага төрөөс шийдвэр гаргах үйл явцад өргөн оролцох тогтолцоог бий болгох

1.3. Авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх явдал сонгуульд оролцох улстөрийн нам, эвслийн хүсэл зориг төдий бус, харин хуулиар заавал хүлээх үүрэг болгон хэвшүүлэх

Хоёр. Төрийн албаны ил тод, шударга, тогтвортой, мэргэшсэн, чадварлаг байх зарчмыг хангах

2.1. Төрийн жинхэнэ албанд ажиллах удирдах болон гүйцэтгэх боловсон хүчнийг сонгон шалгаруулах тогтолцоог эрүүлжүүлэх

2.2. Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны хараат бус байдлыг хангах

2.3. Төрийн албаны удирдах, гүйцэтгэх аливаа албан тушаалд сонирхлын зөрчилтэй хүнийг ажилуулахгүй байх

2.4. Төрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтын тогтвортой байдлыг хуулиар баталгаажуулах

Гурав. Төрийн үйлчилгээг хүртээмжтэй, ил тод болгож хүнд суртал, шат дамжлагыг арилгах

3.1. Төрийн албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын ажлын байрны чиг үүрэг, нөхцөл, шаардлагын талаарх мэдээллийг олон нийтэд ил байлгах

3.2. Төрийн албаны үйл ажиллагаанд мэдээллийн цахим сүлжээ, сан өргөн ашиглах, "нэг удаа-нэг үйлчилгээ" гэсэн журмыг нэвтрүүлэх

3.3. Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон захиргааны дэд актад хяналт, дүн шинжилгээ хийх

3.4. Төрийн байгууллагын үйл ажиллагааны талаар иргэн өөрөө буюу хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээлэл чөлөөтэй олж авах зохицуулалтыг бий болгох

Дөрөв. Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгох

4.1. Авлигатай тэмцэх байгууллагыг бэхжүүлэх, үйл ажиллагааны хараат бус байдлын баталгааг алдагдуулахгүй байх чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох

4.2. Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөрийн дагуу авлигын болон бусад гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны эрх зүйн үндсийг сайжруулах

Тав. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг хууль бусаар зарцуулахаас урьдчилан сэргийлэх

5.1. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашиглалт, хадгалалт, хамгаалалтын талаарх эрх зүйн зохицуулалтыг сайжруулах

5.2. Улсын болон орон нутгийн төсвийн ил тод байдлыг хангах

Зургаа. Албан тушаалтны хөрөнгө орлогын байдалд тавих хяналтыг боловсронгуй болгох

6.1. Үл хөдлөх хөрөнгө, албан тушаалтны хөрөнгө орлогын байдалд тавих бүртгэл-хяналтын тогтолцоог боловсронгуй болгох

Долоо. Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэхэд хэвлэл мэдээллийн болон иргэний нийгмийн байгууллагын идэвхитэй дэмжлэгт тулгуурлах

7.1. Хэвлэл мэдээллийн бие даасан, хараат бус байдлыг хангасан эрх зүйн орчин бүрдүүлэх

7.2. Хэвлэл мэдээллийн салбарыг авлигаас ангид байлгах, эрэн сурвалжлах сэтгүүл зүйн аюулгүй байдлыг хангах хуулийн зохицуулалт бий болгох

7.3. Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийн ёс зүйн дүрэм, мэргэжлийн үйл ажиллагааны стандартыг батлан мөрдөх

7.4. Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдийн үүсгэн бий болгосон байгууллагуудыг төрөөс зохион байгуулалтын болон хөрөнгө санхүүгийн бүхий л талын дэмжлэг, туслалцаа үзүүлэх

7.5. Иргэдийн авлигыг үл тэвчих ухамсар, итгэл үнэмшил, шударга ёсны үнэт зүйлсийг бий болгоход иргэний нийгмийн гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх

Найм. Авлигын индекс өндөртэй байгууллага, нийгэм-эдийн засгийн салбарт авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх

8.1. Газар зохион байгуулалт, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох зэрэг авлигад өртөмтгий уламжлалт салбараас гадна боловсрол, эрүүл мэндийн болон мэргэжлийн хяналт зэрэг сүүлийн үед авлигын индекс өндөртэй байгууллага-салбарт авлигаас сэргийлэх үр дүнтэй ажил зохион байгуулах

---oOo---

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.ndi.gov.mn

"ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ"

НЭГ. УДИРТГАЛ

1.1. Судалгааны зорилго, зорилт

Судалгааг ЭБШХ[769]-ийн хэрэгжилтийн төлөв байдлыг 2004-2009 оны эхний хагас жилийн байдлаар судлан тогтоох, хуулийг хэрэглэхэд гарч буй бэрхшээл, доголдол буюу эрх зүйн зохицуулалтын хувьд боловсронгуй болоогүй асуудлын талаар мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийх, улмаар хуульд нэмэлт өөрчлөлт оруулах талаар судалгааны үндэслэл бүхий санал боловсруулах зорилгоор хийсэн бөгөөд энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан. Үүнд:

1. ЭБШХ-ийн хэрэгжилтийн төлөв байдлыг судлан, дүн шинжилгээ хийх;
2. Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээнд ЭБШХ нийцэж буй эсэхийг судалж, дүн шинжилгээ хийх.

1.2. Судалгаа явуулсан байдал

ХЗҮХ[770]-ийн Эрүүгийн эрх зүй, криминологийн сектор нь Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хорооны ажлын албаны захиалгаар "ЭБШХ-ийн хэрэгжилтийн төлөв байдал" судалгааны ажлыг 2009 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн гүйцэтгэсэн бөгөөд судалгааны удирдамж, төлөвлөгөөг хэрэгжүүлэх хуваарь гарган, дараахь чиглэлээр судаллаа:

- ЭБШХ дахь хэрэглэхэд төвөгтэй буюу бэрхшээлтэй, огт хэрэгжихгүй буюу хэрэглэхгүй байгаа хэм хэмжээ, түүний шалтгааныг судлан тогтоох;
- ЭБШХ-ийн нэмж, өөрчлөгдсөн хэм хэмжээний хэрэгжилтийн төлөв байдлыг судлан тогтоох;
- ЭБШХ-ийн хэм хэмжээг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний хэм хэмжээтэй харьцуулан судалж, дүн шинжилгээ хийх.

Судалгааг бие даасан байдлаар, шинжлэх ухааны арга зүйг баримтлан явуулж, судалгааны дүгнэлтийг зөвхөн судалгаагаар тогтоогдсон үр дүнд үндэслэн бодитой гаргах зарчмыг удирдлага болгон ажиллалаа.

1.3. Судалгаа явуулсан арга, хэлбэр

Судалгааг аливаа байгууллага, албан тушаалтны бодлого, нөлөөллөөс ангид бие даасан байдлаар, шинжлэх ухааны арга зүйг баримтлан, судалгааны дүгнэлтийг зөвхөн тухайн судалгаагаар тогтоогдсон үр дүнд үндэслэн бодитой гаргах зарчмыг удирдлага болгон судалгааны сэдвийн хүрээнд хууль зүйн эх сурвалж болох баримт бичгийн задлан шинжилгээ, практикийн байдлыг газар дээр нь ажиглах, ярилцлага авах, санал асуух, сурвалжлах зэрэг аргаар явуулав.

ЭБШХ-ийн хэрэгжилтийн төлөв байдлыг тогтоох зорилгоор ЭБША-г хэрэгжүүлэгчдээс авах санал асуулгад зориулан 4 асуулт бүхий санал

[769] "Эрүүгийн байцаан шийтгэх хууль" гэхийг ийнхүү товчлов.

[770] "Хууль зүйн үндэсний хүрээлэн" гэхийг ийнхүү товчлов.

асуулгын хуудас[771] боловсруулж, улсын хэмжээнд ажиллаж буй байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгчид, өмгөөлөгч нарт тарааснаас 85 шүүгч, 68 прокурор, 79 мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч, 58 өмгөөлөгч санал асуулгад хариулт өгснийг нэгтгэн төрөлжүүлж авч үзлээ.

Санал асуулгын судалгааны үр дүнгийн магадлалыг тандах, зарим асуудлыг тодруулах, илүү дэлгэрэнгүй мэдээлэл олж авах, ЭБШХ-ийн зарим хэм хэмжээ хэрэгжихгүй, хэрэглэхэд төвөгтэй байгаагийн шалтгааныг тогтоох зорилгоор ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага хийсэн бөгөөд энэхүү судалгаанд давхардсан тоогоор 320 хуульч оролцож, нийт 189 төрлийн санал өгсөн байна. Эдгээр саналын 60 гаруй хувь нь ЭБШХ дахь нэг мөр хэрэглэхэд хүндрэлтэй хэм хэмжээний талаар, 30 гаруй хувь нь ЭБШХ дахь хэрэгжихгүй, хэрэглэгдэхгүй байгаа хэм хэмжээний талаар, 10 орчим хувь нь ЭБШХ-ийн нэмж өөрчлөгдсөн хэм хэмжээний төлөв байдлын талаархи санал байлаа.

ЭБШХ-ийн хэм хэмжээ Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний хэм хэмжээнд нийцэж буй эсэхийг тогтоох зорилгоор Монгол Улс нэгдэн орж, "Төрийн мэдээлэл" сэтгүүлд албан ёсоор хэвлэгдсэн 30 гэрээний[772] хэм хэмжээг ЭБШХ-ийн хэм хэмжээтэй харьцуулан судаллаа.

ХОЁР. СУДАЛГААНЫ НЭГДСЭН ДҮН

Судалгааг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгчдээс ЭБШХ-ийг хэрэглэх болон ЭБША[773]-ны явцад уг хуулийн хэрэгжилтийн төлөв байдал, түүний дотор эргэж харууштай зүйл байгаа эсэхийг тодруулах, цаашид засч залруулах хэрэгцээ шаардлагыг гол болгосон. Ингэхдээ байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгчид буюу хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн үйл ажиллагаа, шийдвэрийг хянах биш харин дор дурдсан хүрээнд хуулийг хэрэглэхэд гарч буй бэрхшээлтэй, төвөгтэй, цаашид төгөлдөржүүлэх асуудал, ямар зүйл, заалт байгааг тодруулахыг зорьсон билээ. Үүнд:

1.1. ЭБШХ дахь хэрэглэхэд бэрхшээлтэй хэм хэмжээ;

1.2. ЭБШХ дахь огт хэрэглэгдэхгүй, хэрэгжихгүй байгаа хэм хэмжээ;

1.3. ЭБШХ-ийн нэмж, өөрчлөгдсөн хэм хэмжээний хэрэгжилт;

1.4. ЭБШХ-ийн хэм хэмжээ Монгол Улсын Олон улсын гэрээний хэм хэмжээтэй нийцэж буй байдал.

2.1. <u>ЭБШХ дахь хэрэглэхэд бэрхшээлтэй хэм хэмжээ, түүний шалтгаан</u>

Судалгаагаар ЭБШХ дахь хэрэглэхэд бэрхшээлтэй хэм хэмжээний талаар 110 орчим санал ирснээс ЭБШХ-д өөрчлөлт оруулах 22 саналыг сонгон авч, хэрэглэхэд бэрхшээл учруулж буй шалтгаан, үндэслэлийг тайлбарлан, түүнд үндэслэн ЭБШХ-д оруулах өөрчлөлтийн агуулга, төслийг боловсруулав[774].

---

[771] Хавсралт 5-аар санал асуулгын хуудасны эхийг харуулав.

[772] Хавсралт 6-аас судалсан Монгол Улсын Олон улсын гэрээний жагсаалтыг харна уу.

[773] "Эрүүгийн байцаан шийтгэн ажиллагаа" гэхийг ийнхүү товчлов.

[774] Хавсралт 1-ийг харна уу.

Судалгааны дүнгээс харахад хуулийн хэм хэмжээг хэрэглэхэд учирч буй бэрхшээл нь үндсэндээ хуулийн хэм хэмжээ өөр хоорондоо болон бусад хуулийн хэм хэмжээтэй зөрчилдсөний улмаас, мөн хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэх явцад хуулийн хэм хэмжээ амьдрал, практиктай зөрчилдсөний улмаас бий болдог ажээ.

2.2. ЭБШХ дахь огт хэрэгжихгүй, хэрэглэгдэхгүй байгаа хэм хэмжээ, түүний шалтгаан

ЭБШХ дахь огт хэрэгжихгүй, хэрэглэгдэхгүй байгаа хэм хэмжээ, түүний шалтгааныг тогтоох зорилгоор мөн социологийн аргаар судалгаа авсан бөгөөд үүнтэй холбоотой 58 орчим санал ирснээс ЭБШХ-д өөрчлөлт оруулах 10 саналыг сонгон авч, хэрэгжихгүй, хэрэглэгдэхгүй байгаа үндэслэл, шалтгааныг авч үзэж, түүнтэй холбогдуулан ЭБШХ-д оруулах өөрчлөлтийн агуулга, төслийг боловсруулсан болно[775].

Судалгаагаар ЭБШХ-аар зарим хэм хэмжээг тухайн харилцааг буюу зохицуулахыг зорьсон харилцааг зохицуулахуйцаар бүрэн зохицуулаагүй, зохицуулсан боловч хэрэгжүүлэх боломжийг нь төрөөс хангахгүй байгаагаас тухайн хэм хэмжээ огт хэрэгжихгүй, эсвэл хэрэглэгдэхгүй байгаа байдал тогтоогдсон болно.

2.3. ЭБШХ-ийн нэмж, өөрчлөгдсөн хэм хэмжээний хэрэгжилт

ЭБШХ хүчин төгөлдөр мөрдөгдөж буй энэхүү 7 жил гаруй хугацаанд тус хуулийн хэрэгжилтийг хангах, сайжруулан төгөлдөржүүлэх зорилгоор ЭБШХ-д үндсэндээ 2 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан билээ. Нэмж, өөрчилсөн хэм хэмжээний хэрэгжилттэй холбоотой саналаас 6 саналыг сонгон, хэрэгжиж буй байдлыг тодорхойлон, цаашид улам бүр боловсронгуй болгох талаар санал боловсруулаа[776].

ЭБШХ-ийн нэмж, өөрчлөгдсөн хэм хэмжээ нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зарим оролцогчийн эрх зүйн байдлыг дордуулсан, зарим хууль тухайлбал, Эрүүгийн хуульд орсон нэмэлт өөрчлөлттэй холбоотойгоор ЭБШХ-ийн хэм хэмжээг өөрчлөхдөө уялдуулаагүй, зарим оролцогчийн эрхийг хязгаарласан заалт оруулсан зэргээс хэрэглэхэд төвөгтэй болсон байна.

2.4. ЭБШХ-ийн хэм хэмжээ Монгол Улсын олон улсын гэрээний хэм хэмжээтэй нийцэж буй байдал

ЭБШХ-ийн хэм хэмжээ Монгол Улсын олон улсын гэрээний хэм хэмжээтэй нийцэж буй эсэхийг тогтоох зорилгоор Монгол Улс нэгдэн орж, "Төрийн мэдээлэл" сэтгүүлд албан ёсоор хэвлэгдэн гарсан олон улсын 31 гэрээний 127 хэм хэмжээг түүвэрлэн, тэдгээрт Монгол Улсын ЭБШХ-ийн холбогдох хэм хэмжээг харьцуулан тайлбарлан дүгнэж, хуулийн хэм хэмжээг олон улсын гэрээнд нийцүүлэн өөрчлөх өөрчлөлтийн агуулга, төслийн томъёолол бүхий 19 саналыг боловсруулсан болно[777].

Судалгаанд хамрагдсан 31 гэрээний харьцуулан судлагдсан 127 хэм хэмжээний:

[775] Хавсралт 2-ыг харна уу.
[776] Хавсралт 3-ыг харна уу.
[777] Хавсралт 4-ийг харна уу.

• 108 буюу 85% нь үндэсний хууль тогтоомжид бүрэн тусгагдсан;
• 8 буюу 6.2% нь бүрэн бус тусгагдсан;
• 11 буюу 8.6% нь огт тусгагдаагүй байна.

Энэ нь Монгол Улс Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан "олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх" үүргээ зохих ёсоор биелүүлэхгүй байгааг илэрхийлсэн үзүүлэлт юм.

ГУРАВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

Судалгаанд оролцогчдын ЭБШХ-ийн хэрэгжилтийн төлөв байдлын талаархи санал, уг хуулийг хэрэглэж, хэрэгжүүлж буй байдлаас харахад ЭБШХ нь байцаан шийтгэх ажиллагааны оролцогчдын чиг үүргийн хяналт, хариуцлагыг зөв хуваарилах, байцаан шийтгэх ажиллагааны хүнд суртлыг багасгах, түргэн шуурхай болгох, байцаан шийтгэх ажиллагааны явцад хүний эрхийг хангах баталгааг сайжруулж, бодитой болгоход чиглэгдсэн, олон улсын болон бусад орнуудын эрх зүйн жишиг хандлагад тулгуурласан, нэлээд дэвшилттэй зохицуулалт бүхий хууль болсон гэж дүгнэгдэж байна.

Судалгааны явцад ЭБШХ-ийг хэрэгжүүлэхэд хэд хэдэн төрлийн бэрхшээлтэй асуудал тулгардаг болох нь харагдсан бөгөөд үүнийг бүлэглэн авч үзвэл:

- ЭБШХ-ийн хэм хэмжээ хоорондоо зөрчилддөг;
- ЭБШХ-ийн хэм хэмжээ бусад хуулийн хэм хэмжээтэй зөрчилддөг;
- ЭБШХ-ийн зарим хэм хэмжээ тодорхой бус хуульчлагдсан;
- ЭБШХ-ийн зарим хэм хэмжээ амьдрал, практиктай нийцээгүйгээс хэрэглэх боломжгүйд хүрдэг;
- ЭБШХ-д ойлгомжгүй байдлаар хуульчлагдсан хэм хэмжээ байгаагаас тэдгээрийг өөр өөрөөр хэрэглэдэг;
- ЭБШХ-ийн зарим зүйл заалтыг УДШ-ээс тайлбарлахдаа ойлгомжгүй буюу хуулийн хэм хэмжээтэй зөрчилтэй байдлаар тайлбарладаг;
- ЭБША-г хэрэгжүүлэгчдийн хуулийн заалтыг ойлгож хэрэглэх чадвар харилцан адилгүй байдал гэх мэт.

ЭБШХ хэрэгжиж эхэлснээс хойш нэлээд хугацаа өнгөрч, байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгч, тус ажиллагаанд хүний хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалан оролцогч-өмгөөлөгч нар уг хуулийг хэрэгжүүлэхэд өөр өөрийн үүргийн дагуу оролцож байгаа нь ойлгомжтой бөгөөд тэднээс ирүүлсэн хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэхтэй холбоотой гарч буй бэрхшээл, бэрхшээл үүсгэж буй байдалд үнэлэлт дүгнэлт өгч, түүнээс гарах гарцын талаар буюу хуулийн хэм хэмжээг сайжруулан төгөлдөржүүлэх талаар судалгааны үндэслэл бүхий санал /ЭБШХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах/-ыг боловсруулсан ба эдгээр санал нь дараах хүрээнд боловсруулагдсан.

3.1. Хууль тогтоомжийг боловсронгуй болгохтой холбоотой санал

Судалгааны үр дүнд хууль тогтоомжийг боловсронгуй болгох буюу төгөлдөржүүлэх 57 санал /давхардсан тоогоор/ боловсруулсан[778] ба эдгээрийг төрөлжүүлэн авч үзвэл:

[778] Хавсралт 1; 2; 3; 4-өөс харна уу.

- 16 буюу 29.8% нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын, ялангуяа гэмт хэрэгт холбогдсон, гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн, мөн гэрч, хохирогчийн эрхийг хангах, хамгаалахад чиглэсэн санал,
- 4 буюу 7% нь таслан сэргийлэх арга хэмжээг авах ажиллагааны явцад хүний эрхийг зөрчихгүй байх баталгааг хангахад чиглэсэн,
- 6 буюу 12.2% нь нотлох баримт олж, цуглуулах, мэтгэлцэх боломж, эрхийг хангахад чиглэсэн,
- 3 буюу 5.2% нь ЭБША-ны явцад гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нэхэмжлэлийг шийдвэрлэхтэй холбоотой,
- 14 буюу 24.5% нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгчдээс уг ажиллагааг явуулахтай холбоотой,
- 2 буюу 3.5% нь ЭБШХ үйлчлэх хэмжээ хязгаарыг өргөтгөхөд чиглэсэн,
- 6 буюу 10.5% нь эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт этгээдийг шилжүүлэн өгөх ажиллагаатай холбоотой санал байна.

Судалгааны явцад ЭБША дахь хэргийг зөвхөн байцаалтаар нотолж буй байдлыг үндсэнд нь өөрчилж, байцаалтаас бусад нотолгоогоор хэргийг нотлох эрх зүйн орчныг бий болгох, мэтгэлцэгч талууд /яллагч, өмгөөлөгч/-ын эрхийг ЭБША-ны бүх шатанд тэгш байлгах, шүүгчийн хэргийг дангаар шийдвэрлэх эрхийг өргөтгөх, эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх тогтолцоо, журмыг боловсронгуй болгох талаар нэлээд санал ирсэн ба эдгээр асуудлыг цаашид эрдэм шинжилгээний үүднээс тусгайлан судлах зайлшгүй шаардлага байна.

3.2. УДШ [779]-ийн тайлбартай холбоотой санал

Судалгаанд оролцсон зарим хуульчдаас хуулийн зарим хэм хэмжээг хэрэглэх талаар нэг мөр ойлголт байхгүйгээс тухайн хэм хэмжээг хэрэглэхэд бэрхшээлтэй байдаг, мөн УДШ-ээс зарим тохиолдолд хуультай нийцээгүй тайлбар гаргадгаас хуулийн хэм хэмжээг хэрэглэх боломжгүй байдалд хүргэж байна гэх санал гаргасан ба үүнтэй холбогдуулан дараах саналыг гаргах:

- ЭБШХ-ийн 59 дүгээр зүйлийн 5, 68 дугаар зүйлийн 68.1-т заасан "Хойшлуулшгүй тохиолдол", "оргон зайлж болзошгүй", "хэргийн бодит байдлыг тогтооход саад учруулах" гэх ойлголтууд тодорхой биш байдгаас эдгээр ойлголтыг ЭБША-г хэрэгжүүлэгчид өөрийнхөөрөө тайлбарлаж хэрэглэх тохиолдол цөөнгүй байдаг байна. Иймд УДШ-ээс эдгээр ойлголтыг нэг мөр ойлгож хэрэглэх талаар тайлбар гаргах шаардлагатай юм.
- ЭБШХ-ийн 42 дугаар зүйлийн 42.1, 43 дугаар зүйлийн 43.1, 115 дугаар зүйлийн 115.1 дэх заалтуудад гэмт хэргийн улмаас хохирсон хохирогч өөрт учирсан эдийн бус хохирлыг нэхэмжлэх буюу шаардах, шүүх уг шаардлагыг шийдвэрлэх тухай заасан атал шүүх эдийн бус хохирлын нэхэмжлэлийг "хууль зүйн үндэслэлгүй" хэмээн хэрэгсэхгүй болгон шийдвэрлэдэг тул хуулийн эдгээр заалт хэрэгждэггүй. Мөн УДШ-ээс 2009 оны 5 дугаар сарын 22-ны

[779] "Улсын дээд шүүх" гэхийг ийнхүү товчлов.

өдөр 15 тоот тогтоол гарч, уг тогтоолоор эдийн бус хохирлыг зөвхөн нэр төр, алдар хүндэд учирсан хохирлоор хязгаарласан нь хуулийн эдгээр заалтыг, цаашлаад Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсгийн заалтыг зөрчсөн хэрэг болсон. Мөн ЭБШХ-ийн 44 дүгээр бүлэгт ЭБША-г хэрэгжүүлэгчийн хууль зөрчсөн үйл ажиллагааны улмаас иргэнд учирсан сэтгэл санаанд хохирлыг гаргуулахаар заасан нь ялгамжтай бөгөөд зөрчилтэй болсон байна. Хуулийн эдгээр заалтыг хэрэглэх, хэрэгжүүлэх боломжийг хангах үүднээс Иргэний хуульд сэтгэл зүй, бие махбодид учирсан хохирлыг тооцон төлүүлэх талаар зохих өөрчлөлт оруулж, УДШ-ийн 2009 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 15 тоот тогтоолын 1.1 дэх заалтын тайлбарыг боломжтой байдлаар өөрчлүүлэх талаар УДШ-д санал хүргүүлэх шаардлагатай.

- 2010 онд УДШ-ийн Эрүүгийн хууль, ЭБШХ-ийг талийбарласан тайлбарыг тусгайлан судалж, дүн шинжилгээ хийх нь зүйтэй гэж үзэв.

1.1. Хуульчдад сургалтаар нэгдсэн ойлголт бий болгохтой холбоотой санал

Хуульд зохицуулалт нь байх боловч зарим хуулийн хэм хэмжээтэй зөрчилдөх, мөн арга, аргачлал нь тодорхойгүй, хуульчдын тухайн асуудлын талаарх мэдлэг дутмаг байдлаас хуулийн заалт хэрэгжихгүй, улмаар хүний эрх зөрчигдөх явдал байгаа тул хуульчдад тодорхой сэдвээр судалгааны үндэслэлтэй хичээл заах замаар нэг мөр ойлголт бий болгох шаардлага байх;

- "Гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл зүй, бие эрхтний хохирлын хэмжээг тогтоох, тооцох аргачлал"-ыг тогтоох зорилго бүхий тусгайлсан судалгаа явуулж, уг сэдвээр сургалт явуулах шаардлагатай.
- ЭБШХ-ийн 271 дүгээр зүйлд шүүх хуралдааны үед шинжилгээ хийлгэх тухай заасан боловч энэ ажиллагаа урьд нь дүгнэлт гаргасан шинжээчийг шүүх хуралдаанд оролцуулж, дүгнэлтийн талаар асуухаас хэтэрдэггүй. Шүүх хуралдааны үед шинжилгээ хийлгэх шаардлага гарвал хэргийг мөрдөн байцаалтад буцааж, дүгнэлт гаргуулдаг. Өөрөөр хэлбэл, хуулийн энэхүү заалт хуульчид энэ талаар нэгдсэн ойлголтгүйн улмаас хэрэглэгддэггүй байна. Иймд хуулийн энэхүү заалтыг хэрэглэх талаар өмгөөлөгч, прокурор, шүүгчдэд зориулсан сургалт зохион байгуулж, тэднийг оролцуулах замаар нэг мөр ойлголт өгөх нь зүйтэй.
- Байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгчдийг буюу хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчдийг Монгол Улсын Олон улсын гэрээг хэрэглэх аргачлал олгох сургалтад хамруулах нь тэдний олон улсын гэрээний хэм хэмжээг хэрэглэх чадвар, мэдлэгийг дээшлүүлнэ.

- ХЗҮХ-ээс зохион байгуулж буй сургалт прокурор, шүүгч, өмгөөлөгч нарт зориулагддаг ба байцаан шийтгэх ажиллагааны эхний үе шатанд ажиллаж буй хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарт зориулсан сургалт явуулах зайлшгүй шаардлага байна.

3.3. Зохион байгуулалтын хүрээнд шийдвэрлэх асуудлын талаархи санал

Хуульд зохицуулалт нь бий боловч төр зохих үүргээ биелүүлэхгүй байгаагаас хуулийн зарим хэм хэмжээ хэрэгжихгүй, мөн байцаан шийтгэх ажиллагааны хэргийн байдлыг бодитой тогтоох зарчим алдагдах, хэргийн талаар нотолбол зохих асуудал нотлогдохгүйд хүрч байна. Тухайлбал,

- ЭБШХ-ийн 99 дүгээр зүйлд ЭБША-ны зардлыг төр хариуцна гэж заасан боловч төр Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 3-ын "Шүүх үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана" гэх заалтыг туушгай хэрэгжүүлж, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах эрх бүхий байгууллага болон шүүхэд төрөөс тусгайлан байцаан шийтгэх ажиллагааны зардлыг олгодоггүйгээс "зардлыг төр хариуцна" гэх заалт огт хэрэгждэггүй байна. Иймд төрөөс хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага, шүүхийн төсөвт байцаан шийтгэх ажиллагааны зардлыг бодит байдлаар, хэрэгжихүйц хэмжээгээр тусгаж, оруулж байх арга хэмжээ авах шаардлагатай байна.
- Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээг хуульд заагаагүй, үнэлгээ хийх албан ёсны эрхгүй сум, дүүргийн ЗДТГ-ын "Үнэлгээчин" гэх этгээд тогтоодгоос хохирлын хэмжээ бодитой тогтоогддоггүй байна. Иймд гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээг тогтоох эрхийг ШШҮХ[780]-д олгож, уг байгууллагад үнэлгээ хийх эрх бүхий нэгж, шинжээчдийг бий болгох нь зүйтэй.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

[780] "Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн" гэхийг ийнхүү товчлов.

Хавсралт -1

2.1. ЭБШХ ДАХЬ ХЭРЭГЛЭХЭД БЭРХШЭЭЛТЭЙ ХЭМ ХЭМЖЭЭ, ТҮҮНИЙ ШАЛТГААН

№	*ЭБШХ-ийн зүйл хэсэг*	*Хэрэглэхэд учирч буй бэрхшээл*	*Санал*
1.	5 дугаар зүйл. *Нэр томъёоны тодорхойлолт*	ЭБШХ-ийн 371 дүгээр зүйлд насанд хүрээгүй этгээдийг байцаахад сурган хүмүүжүүлэгчийг оролцуулах тухай заасан боловч энэ нь ямар шаардлагыг хангасан этгээд байхыг хуульчлаагүйгээс практикт сурган хүмүүжүүлэгчид ямар нэг шалгуур тавилгүйгээр БША-нд оролцуулдаг ба энэ нь хүүхдийн хууль ёсны эрхийг зөрчихөд хүргэдэг. Иймээс хууль ёсны төлөөлөгчид тавих шаардлагыг хуульчлах шаардлагатай.	ЭБШХ-ийн 5 дугаар зүйлд дор дурдсан заалт нэмэх: "сурган хүмүүжүүлэгч" гэж сурган хүмүүжүүлэх ухааны боловсрол эзэмшсэн, насанд хүрээгүй хүмүүсийн гэмт хэрэг, хууль зөрчсөн хүүхдийн сэтгэл зүй, нийгмийн ажил гэх зэрэг олон талын мэдлэгтэй, хүүхэдтэй ажиллаж байсан дадлага туршлагатай этгээдийг хэлнэ.
2.	10 дугаар зүйл. *Хүний халдашгүй байх эрхийг хангах*	ЭБШХ-ийн 10 дугаар зүйлд сэжигтнийг баривчилсан тухай мэдэгдэх асуудлыг хуульчилсан боловч насанд хүрээгүй сэжигтний хувьд тусгайлсан зохицуулалт байх нь зүйтэй юм.	ЭБШХ-ийн 10 дугаар зүйлд дор дурдсан заалт нэмэх: "Насанд хүрээгүй сэжигтнийг баривчлах үед энэ хуулийн 10.5-д заасан этгээдүүдээс гадна Хүүхдийн эрхийг хамгаалах орон нутгийн байгууллагад мэдэгдэнэ".
3.	25 дугаар зүйлийн 25.2. *... хэргийн хохирогч нь яллагдагчийн эрхшээлд байгаагаас ... хэргийг хэрэгсэхгүй болгож болохгүй.*	ЭБШХ-ийн 25.2 дугаар зүйлд "зөвхөн яллагдагчийн эрхшээлд байгаа" гэж заасан нь 25.1 дүгээр зүйлтэй зөрчилдөж байна.	ЭБШХ-ийн 25.2 дугаар зүйлийн "яллагдагчийн" гэдгийг "яллагдагч, шүүгдэгчийн" гэж өөрчлөн найруулах.

4.	35 дугаар зүйл. *Сэжигтэн*	Хуулийн энэхүү зүйлд сэжигтний эрхийг тодорхой заасан байх боловч насанд хүрээгүй сэжигтний эрхийг тусгайлан зохицуулаагүй байна.	ЭБШХ-ийн 35 дугаар зүйлийн заалтыг "хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч ямар хэрэгт сэрдэгдэж байгааг насанд хүрээгүй сэжигтэн болон Хүүхдийн эрхийг хамгаалах орон нутгийн байгууллага болон түүний гэр бүлийн насанд хүрсэн гишүүн, өмгөөлөгчид нь тэр даруй, мэдэгдэнэ" гэх агуулгаар өөрчлөх.
5.	45 дугаар зүйлийн 45.4. *Гэрч нь ... хэргийн талаар өөрийн мэдэх зүйлийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй.*	Хуулийн энэ зүйлд гэрчид үнэн зөв мэдүүлэг өгөх үүргийг ногдуулж хуульчилсан боловч гэрчийг хэрхэн хамгаалах талаар хуульчлаагүй. Практикт энэ байдлаас улбаалан гэрч мэдүүлгээ өөрчлөх, улмаар хэрэг хэрэг биш болох ч тохиолдол гардаг байна.	ЭБШХ-д гэрч, хохирогчийг хамгаалах үндэслэл, журмыг хуульчлах шаардлагатай.
6.	52 дугаар зүйл. *Шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг шийдвэрлэх журам*	Тухайн шүүхийн Ерөнхий шүүгч шүүх бүрэлдэхүүнд байгаа болон хэргийг дангаар шийдвэрлэж байгаа тохиолдолд уг шүүгчээс татгалзсан хүсэлтийг хэн шийдвэрлэх талаар зохицуулалт байхгүй нь практикт нэлээд төвөгтэй байдал үүсгэдэг байна.	52 дугаар зүйлд тухайн шүүхийн Ерөнхий шүүгч шүүх бүрэлдэхүүнд байгаа, мөн хэргийг дангаар шийдвэрлэж байгаа тохиолдолд түүнийг татгалзсан хүсэлтийг хэн шийдвэрлэх талаар заалт нэмж оруулах.

7.	69 дүгээр зүйлийн 69.5. *Мөрдөн байцаагч хорьж мөрдөх үндэслэл бүхий тогтоол үйлдэж хугацаа дуусахаас 7 хоногийн өмнө прокурорт хүргүүлэх бөгөөд прокурор шүүхэд хүргүүлнэ.*	• Хуулийн энэ зүйлд мөрдөн байцаагч тогтоолыг прокурорт хүргүүлэх хугацааг заасан болов прокурорын шүүхэд саналаа хүргүүлэх хугацааг тодорхой заагаагүй. • Хуулийн 69.6-ын заалтаас харахад прокурор шүүхэд 72 цагийн өмнө хүргүүлсэн байх боломж харагдаж байх болов практикт энэ хугацааг ч мөн баримтлахгүй байх тохиолдол гардаг. • Хуульд мөрдөн байцаагч тогтоолоо, прокурор саналаа шүүхэд заасан хугацаанд ирүүлээгүй тохиолдолд хэрхэх тухай зохицуулалт байхгүйгээс шүүх прокурорын санал ирэнгүүт ТСАХ-ний асуудлыг шийдвэрлэдэг. Энэ нь хүний эрх зөрчигдөхөд хүргэдгийг ч үгүйсгэх боломжгүй байдаг байна. • Мөн хорьж мөрдөх хугацааг сунгах тухай тогтоолыг зөвхөн прокурорт хүргүүлэх тухай заасан бөгөөд өмгөөлөгчид мэдэгдэх тухай заагаагүй. Цагдан хорих асуудал хүний эрхийг зөрчдөг тохиолдол нэлээд байдаг тул уг ажиллагаан дахь өмгөөлөгчийн оролцоог хангах шаардлагатай.	69 дүгээр зүйлд прокурорын шүүхэд санал хүргүүлэх хугацааг "шүүгч цагдан хорьж мөрдөх хугацааг сунгах эсэх асуудлыг шийдвэрлэхийн тулд хэргийн материалыг судлах боломжит хугацаа"-аар зааж хуульчлах, мөн мөрдөн байцаагч, прокурор тогтоол, санал хүргүүлэх хугацааг зөрчвөл хэрхэх талаар зохицуулалт нэмэх /хуульд хугацаа заасан тул уг хугацааг зөрчсөний хариуцлага, үр дагаврыг заах шаардлагатай/. Мөн цагдан хорих тухай тогтоолыг прокурорт хүргүүлсэн даруй өмгөөлөгчид энэ тухай мэдэгдэх тухай нэмж заах.

8.	*72 дугаар зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх албадлагын бусад арга хэмжээ авах үндэслэл*	ЭБШХ-ийн 72 дугаар зүйлд эрүүгийн байцаан шийтгэх албадлагын бусад арга хэмжээний төрлийг заан хуульчилсан байх боловч эдгээр нь хүүхдэд хэрэглэх боломжгүй арга хэмжээ тул хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон албадлагын бусад арга хэмжээг хуульчлах шаардлагатай.	ЭБШХ-ийн 72 дугаар зүйлд дараах заалт нэмж оруулах: Мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нь насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид дараах байцаан шийтгэх албадлагын бусад арга хэмжээ авч болох; 1. хохирогчоос уучлал гуйлгах; 2. анги хамт олны өмнө амлалт авахуулах; 3. нийгэмд тустай хөдөлмөр хийлгэх /ганц бие хөгшчүүлд туслах гэх мэт/; 4. Хүүхдийн хорооны хяналтад өгөх; 5. Хүмүүжлийн үр нөлөө бүхий сургалтад хамруулах.
9.	*72, 77, 78 дугаар зүйл.*	ЭБШХ-ийн 72 дугаар зүйлд байцаан шийтгэх албадлагын бусад арга хэмжээний төрөлд "торгууль оногдуулах" арга хэмжээг оруулан хуульчилж, 77-78 дугаар зүйлд байцаан шийтгэх ажиллагааны журмыг зөрчсөн хохирогч, гэрч, шинжээч, орчуулагч, хэлмэрч болон холбогдох бусад этгээдэд торгууль оногдуулах үндэслэл, журам, торгууль оногдуулах эрх бүхий этгээдийг заажээ. Гэвч "торгууль оногдуулах" арга хэмжээ нь байцаан шийтгэх албадлагын бусад арга хэмжээний зорилгод нийцэхгүйгээс гадна энэ нь Захиргааны шийтгэлийн төрөлд багтах, мөн прокурор болон мөрдөн байцаах албаны дарга, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид торгууль оногдуулах эрхийг олгосон нь зөрчилтэй болжээ.	ЭБШХ-ийн 72 дугаар зүйлийн 72.1.5, 77, 78 дугаар зүйлийн заалтыг хүчингүй болгох. Харин ЭБШХ-ийн эдгээр зүйлийн заалтад дурдсан зөрчил, түүнд оногдуулах шийтгэлийг Захиргааны хариуцлагын тухай хуульд оруулах нь зүйтэй.

10.	79 дүгээр зүйлийн 79.3.	Гүйцэтгэх ажлын арга хэрэгсэл ашиглаж, нотлох баримт олж авах асуудлыг прокурорын зөвшөөрлөөр гүйцэтгэдэг нь мэтгэлцээний талуудын эрхийг харилцан адилгүй болгодог. Ялангуяа, яллах талд хэт давуу эрх олгосон хэрэг болсон. Иймд уг зөвшөөрөл олгох эрхийг мэтгэлцээний талд биш шүүн таслах ажиллагаанд хараат бус байр суурьтай оролцох шүүхэд олгох шаардлагатай.	ЭБШХ-ийн 79 дүгээр зүйлийн 3-ын "прокурорын зөвшөөрлөөр" гэдгийг "шүүгчийн зөвшөөрлөөр" гэж өөрчлөн хуульчилж, ЭБШХ-д шүүхээс гүйцэтгэх ажлын арга хэрэгсэл ашиглан нотлох баримт олж авах зөвшөөрөл өгөх журмыг хуульчилсан заалт нэмж оруулах.
11.	88 дугаар зүйл.	Эд мөрийн баримтаар хураагдсан боловч гэмт хэрэг үйлдэхэд ашиглаагүй нь тогтоогдсон эд зүйлийг буцаан олгох асуудлыг зохицуулаагүй нь учир дутагдалтай.	88 дугаар зүйлд эд мөрийн баримтаар хураагдсан боловч гэмт хэрэг үйлдэхэд ашиглаагүй эд зүйлийг эзэмшигчид нь буцаан олгох тухай заалт нэмэх.
12.	114 дүгээр зүйл	Зарим тохиолдолд тухайлбал, өмгөөлөгч ирээгүй гэх үндэслэлээр шүүх хуралдааныг хойшлуулахдаа ЭБШХ-ийн 68 дугаар зүйлд заасан үндэслэл байхгүй байхад шүүгдэгчийг цагдан хорьдог. Түүнчлэн уул шүүх хуралдааныг тухайн шүүхийн Ерөнхий шүүгч дангаар шийдвэрлэж буй, эсвэл бүрэлдэхүүнд орсон тохиолдолд 114 дүгээр зүйлийн 114.1-т заасны дагуу гомдол гаргах боломжгүй болдог. Ингэснээр хуулиар олгосон гомдол гаргах эрх хязгаарлагддаг.	ЭБШХ-ийн 114 дүгээр зүйлд цагдан хорих ТСАХ авах, хүчингүй болгох, өөрчлөх талаар гаргасан тухайн шүүхийн Ерөнхий шүүгч, эсвэл түүний оролцсон шүүх бүрэлдэхүүний гаргасан шийдвэрт гаргах гомдлыг Хэнд гаргах, түүнийг Хэн шийдвэрлэх талаар зохицуулах.

13.	123 дугаар зүйл. *Иргэний нэхэмжлэлийг хангах арга хэмжээ авах*	ЭБШХ-ийн 123 дугаар зүйлд "... иргэний нэхэмжлэлийн шаардлагыг хангах арга хэмжээ авч *болно*" гэж заасан нь авч ч болох, үгүй ч байж болох, өөрөөр хэлбэл, уг ажиллагааг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч үзэмжээрээ хийдэг байхаар хуульчилжээ. Мөн ИХШХШХ-д заасан арга хэмжээг авахад зарим тохиолдолд уг арга хэмжээ шүүхээс гарах шийдвэрийн биелэлтэд нөлөөлдөггүй тохиолдол практикт байдаг учир уг ажиллагааг илүү найдвартай, бодитой болгох үүднээс "хөрөнгө барьцаалах" арга хэмжээ авах зохицуулалт хэрэгтэй байдаг ажээ.	1/ ЭБШХ-ийн 123 дугаар зүйлийн заалтыг гэмт хэргийн улмаас эдийн болон эдийн бус хохирол учирсан тохиолдолд заавал иргэний нэхэмжлэлийн шаардлагыг хангах арга хэмжээ авч байхыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид үүрэг болгосон агуулгаар өөрчлөх; 2/ Иргэний нэхэмжлэлийн шаардлагыг хангах арга хэмжээнд "хөрөнгө барьцаалах арга хэмжээ авах" асуудал багтах агуулга бүхий зохицуулалт нэмж оруулах /ЭБШХ-д/. Өөрөөр хэлбэл, барьцааны хөрөнгөөр хохирол нөхөн төлүүлэх боломж бүхий заалт нэмж оруулах;
14.	156 дугаар зүйл. *Шинжилгээ заавал хийлгэх*	1/ ЭБША-ны өнөөгийн практикт эд зүйлийн үнэлгээг сум, дүүргийн ЗДТГ-ын ажилтнуудаас бүрдсэн комисс тогтоож байгаа бөгөөд ихэнхдээ хохирогчийн амаар тогтоодог. Энэхүү үнэлгээ нь хэргийн зүйлчлэлд нөлөөлдөг бөгөөд харилцан адилгүй тогтоогддог нь хууль тэгш үйлчлэх зарчмыг алдагдуулдаг. Мөн ЭБШХ-д заагаагүй буюу эрх хэмжээ олгоогүй этгээд үнэлгээ тогтоож, түүнийг баримтлан хэрэг шийдвэрлэж буй нь хууль зөрчсөн хэрэг болж байна. 2/ Мөн хохирогчид учирсан сэтгэл зүй, бие махбодийн хохирлын хэмжээг шинжээчээр тогтоолгох эрх зүйн зохицуулалт байхгүй байгаа нь хохирогчийн өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлэхийг шаардах эрхийг хязгаарлаж байна.	ЭБШХ-ийн 156 дугаар зүйл /шинжилгээ заавал хийлгэх/-д "гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн хохирлын хэмжээ /үнэлгээ/-г тогтоох", "эдийн болон эдийн бус хохирол нэхэмжилсэн этгээдийн эд хөрөнгө, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, сэтгэл зүй, бие махбодид учирсан хохирол /зовиур, шаналал, өвчин буюу өвдөлт/-ын зэрэг, шинж байдал, үнэлгээг тогтоох" гэсэн агуулгыг нэмж оруулах.

15.	172 дугаар зүйлийн 172.3.	Хойшлуулшгүй ажиллагаа явуулах эрх бүхий субъектийг заахдаа "цагдаагийн байгууллагын ажилтан" гэж заасан нь ойлгомжгүй болсон. Өөрөөр хэлбэл, цагдаагийн байгууллагын ажилтан гэх ойлголт нь нэлээд өргөн хүрээг хамарсан ойлголт тул практикт үл ойлголцол үүсгэдэг.	172 дугаар зүйл дэх "цагдаагийн байгууллагын ажилтан" гэхийг тодорхой ямар албан тушаалтан, эсхүл тодорхой ямар үүрэг гүйцэтгэх ажилтан байхыг нарийвчлан нэрлэж заах.
16.	188 дугаар зүйл. *Сэжигтэн, яллагдагчийн хүүхдийг харгалзан дэмжих, эд хөрөнгийг хамгаалах*	Энэ зүйлд сэжигтэн, яллагдагчийн хүүхдийг харгалзан дэмжих, эд хөрөнгийг хамгаалах талаар заасан нь сайшаалтай бөгөөд харин хуулиар шүүгдэгч, шүүхээс хорих ял шийтгүүлсэн этгээдэд энэхүү хамгаалалт байхаар зохицуулаагүй нь учир дутагдалтай болжээ. Өөрөөр хэлбэл, шүүхэд шилжсэн этгээдэд цагдан хорих ТСАХ авахад 188 дугаар зүйлд заасан хамгаалалтыг авах тухай зохицуулалт хуульд байхгүй байна.	188 дугаар зүйлд заасан арга хэмжээг шүүхэд шилжсэн этгээд буюу шүүгдэгч, мөн шүүхээс хорих ялаар шийтгүүлсэн этгээдийн хувьд хэрэгжүүлдэг байх тухай зохицуулалтыг ЭБШХ-д тусгах.
17.	234 дүгээр зүйл.	"Шүүх хуралдааныг амрах зайлшгүй шаардлагатайгаас бусад цагт тасралтгүй явуулна" гэж заасан ба харин олон шүүгдэгчтэй зайлшгүй олон өдөр хэлэлцэх шүүх хуралдааны үед түр завсарлах журмыг хуульчлаагүй. Үүнээс болж зарим тохиолдолд шүүх хуралдааныг хууль зөрчиж явуулсан гэх гомдол ч гардаг.	234 дүгээр зүйлд олон өдөр хэлэлцэх шүүх хуралдааныг түр завсарлуулах журмыг хуульчлах.
18.	289 дүгээр зүйлийн 289.2.	Шүүгч гаргасан тусгай саналаа хэрэгт ямар байдлаар хавсаргах нь буюу уг заалтыг хэрхэн хэрэглэх нь тодорхойгүй. Мөн давж заалдах, хяналтын шатны шүүхэд энэ заалтыг хэрэглэх эсэх нь тодорхойгүй байна.	Тусгай саналыг хэрхэн ямар байдлаар гаргах, уг саналтай хэзээ, хэн танилцах журмыг, мөн бүх шатны шүүхэд энэхүү заалт хамаарахаар хуульчлах шаардлагатай.

19.	306 дугаар зүйлийн 306.3.	ЭБШХ-ийн 306 дугаар зүйлийн 306.3-т заасан этгээд гомдол, эсэргүүцлээ буцаан авсан тохиолдолд шүүхээс ямар нэг шийдвэр гаргах эсэх талаар зохицуулалт байхгүй байна.	306 дугаар зүйлд гомдол гаргасан этгээд гомдлоо, эсэргүүцэл бичсэн этгээд эсвэл дээд шатны прокурор эсэргүүцлийг буцаан авсан тохиолдолд давж заалдах шатны шүүх ямар акт гаргах талаар нэмэлт оруулах.
20.	333 дугаар зүйлийн 333.1.	"... гурваас доошгүй их эмчийн бүрэлдэхүүнтэй комисс томилж дүгнэлт гаргуулна" гэх заалт нь ЭБШХ-ийн 156 дугаар зүйл /шинжилгээ заавал хийлгэх/-тэй зөрчилдөж байгаа бөгөөд уг асуудлыг ШШҮТ-ийн шинжээчид тогтоох боломжтой атал хуулийн энэхүү заалтаас шалтгаалан шинжээч бус этгээдийн дүгнэлтээр асуудлыг шийдвэрлэдэг байна.	333 дугаар зүйлийн 333.1-ийн "комисс" гэхийг шинжээч гэж өөрчлөх.
21.	339 дүгээр зүйлийн 339.1.	ЭХ-ийн 61 дүгээр зүйлийн 61.5-д зааснаар тэнсэгдсэн ялтан хянан харгалзах хугацаанд захиргааны шийтгэл хүлээсэн бол цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн хорих ялыг биечлэн эдлүүлэх асуудлыг шүүх шийдвэрлэх ба ЭБШХ-ийн 339 дүгээр зүйлд тогтоол биелүүлэхтэй холбогдож гарсан асуудлыг шийдвэрлэх заалтад тэнсэгдсэн этгээдийн ялыг биечлэн эдлүүлэх асуудалтай холбоотой зохицуулалт байхгүй байна.	ЭБШХ-ийн 339 дүгээр зүйлд тэнсэгдсэн ялтан хянан харгалзах хугацаанд захиргааны зөрчил гаргасан бол ялыг биечлэн эдлүүлэх эсэхийг шийдвэрлэх журмыг зааж хуульчлах.
22.	287 дугаар зүйл.	"... шүүгдэгчийн сэтгэцийн өвчний тухай асуудал гарсан бол түүнийг шүүх тогтоол гаргахдаа дахин хэлэлцэнэ" гэх заалт нь тухайн асуудлыг хэзээ хэлэлцэхийг тодорхой бус болгодог. Хуулийн заалтын дараалал, агуулгаас харахад зөвлөлдөх тасалгаанд орсны дараа дахин хэлэлцэх ч юм шиг байдал харагдаж байна.	287 дугаар зүйлийн шүүгдэгчийн сэтгэцийн өвчний асуудлыг хэлэлцэх үеийг тодорхой болгож хуульчлах.

23.	335 дугаар зүйл.	Энэ зүйлд зааснаар гянданд хорих ялыг хорих ангид эдлүүлэхээр солих тухай заасан. Гэвч хуульд чанга дэглэмтэй хорих ангид эдлэх ялыг жирийн дэглэмтэй хорих ангид эдлүүлэхээр солих тухай зохицуулалт байхгүй байна.	335 дугаар зүйлд чанга дэглэмтэй хорих ангид эдлэх ялыг жирийн дэглэмтэй хорих ангид эдлүүлэхээр солих тухай зохицуулалт нэмэх.

--- x ---

Хавсралт–2

2.2. ЭБШХ ДАХЬ ОГТ ХЭРЭГЖИХГҮЙ, ХЭРЭГЛЭГДЭХГҮЙ БАЙГАА ХЭМ ХЭМЖЭЭ, ТҮҮНИЙ ШАЛТГААН

№	*Хуулийн зүйл, заалт*	*Хэм хэмжээний хэрэглэгдэхгүй, хэрэгжихгүй байгаа шалтгаан*	*Санал*
1.	8 дугаар зүйл.	8 дугаар зүйлийн 8.2-т ЭБША-г хэрэгжүүлж буй этгээд хууль зөрчвөл хариуцлага хүлээлгэхээр заасан боловч энэхүү хариуцлагын талаар тодорхой заагаагүйгээс энэ заалтыг хэрэглэх боломжгүй байдаг.	ЭБШХ-ийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан хариуцлагыг тодорхой болгож хуульчлах.
2.	35 дугаар зүйлийн 35.2.1. Сэжигтэн ямар хэрэгт сэрдэгдэж байгаагаа мэдэх эрхтэй.	Сэжигтэн нь ямар хэрэгт сэжиглэгдэж байгаагаа мэдэх эрхтэй гэх энэхүү заалтын дагуу өргөдөл, гомдолтой танилцах хүсэлт тавихаар мөрдөн байцаагч хуульд өргөдөл, гомдолтой танилцах гэсэн заалт байхгүй, ямар хэрэгт сэжиглэж байгааг би чамд амаар хэлж байна, өргөдөл, гомдолтой танилцуулах боломжгүй гэсэн тайлбар хэлдэгийн улмаас хуулийн энэ заалт бүрэн хэрэгждэггүй.	Энэ зүйлийн заалтыг сэжигтэн өөрт нь холбогдуулан гаргасан гэмт хэргийн талаархи өргөдөл, гомдол мэдээлэлтэй танилцах эрхтэй гэх агуулгаар өөрчлөх.

3.	42 дугаар зүйлийн 42.1. 43 дугаар зүйлийн 43.1. 115 дугаар зүйлийн 115.1.	Хуулийн эдгээр зүйлд гэмт хэргийн улмаас хохирсон хохирогч өөрт учирсан эдийн бус хохирлыг нэхэмжлэх буюу шаардах, шүүх уг шаардлагыг шийдвэрлэх тухай заасан атал шүүх эдийн бус хохирлын нэхэмжлэлийг "хууль зүйн үндэслэлгүй" хэмээн хэрэгсэхгүй болгон шийдвэрлэдэг тул хуулийн эдгээр заалт хэрэгждэггүй. Мөн УДШ-ээс 2009 оны 5 дугаар сарын 22-ны өдөр 15 тоот тогтоол гарч, уг тогтоолоор эдийн бус хохирлыг зөвхөн нэр төр, алдар хүндэд учирсан хохирлоор хязгаарласан нь хуулийн эдгээр заалтыг, цаашлаад Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсгийн заалтыг зөрчсөн хэрэг болсон. Мөн ЭБШХ-ийн 44 дүгээр бүлэгт ЭБША-г хэрэгжүүлэгчийн хууль зөрчсөн үйл ажиллагааны улмаас иргэнд учирсан сэтгэл санааны хохирлыг гаргуулахаар шийдвэрлэсэн нь ялгамжтай бөгөөд зөрчилтэй болсон байна.	Хуулийн эдгээр заалтыг хэрэглэх, хэрэгжүүлэх боломжийг хангах үүднээс Иргэний хуульд сэтгэл зүй, бие махбодид учирсан хохирлыг тооцон төлүүлэх талаар зохих өөрчлөлт оруулж, УДШ-ийн 2009 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 15 тоот тогтоолын 1.1 дэх заалтын тайлбарыг боломжтой байдлаар өөрчлүүлэх арга хэмжээ авах. Энэ зорилгоор "Гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл зүй, бие эрхтний хохирлын хэмжээг тогтоох, тооцох аргачлал"-ыг тогтоох зорилго бүхий тусгайлсан судалгаа явуулах шаардлагатай.

4.	*62 дугаар зүйл. Таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэл*	**ЭБШХ-ийн 65 дугаар зүйлд заасан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг бусдын батлан даалтад байлгах таслан сэргийлэх арга хэмжээг зөвхөн насанд хүрсэн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид хэрэглэж болохоор заасан атал практикт сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч хүүхдэд энэхүү арга хэмжээг авах явдал түгээмэл байдаг. Харин ЭБШХ-ийн 367 дугаар зүйлд тус хуулийн 62 дугаар зүйлд заасан ТСАХ-ээс гадна эцэг, эхийн хяналтад өгөх арга хэмжээ авч болохоор заасан боловч байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгчид хуулийн ерөнхий заалтыг хэрэглэдэгээс дээрх арга хэмжээ хэрэглэгддэггүй байна. ЭБШХ-ийн 62 дугаар зүйлд заасан ТСАХ-ний төрөлд хүүхдэд хэрэглэх боломжтой арга хэмжээ байдаггүй тул ЭБШХ-ийн 62 дугаар зүйлд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч хүүхдэд хэрэглэх боломжтой таслан сэргийлэх арга хэмжээний төрлийг нэмж хуульчлах шаардлагатай юм.**	ЭБШХ-ийн 62 дугаар зүйлд дор дурдсан агуулга бүхий заалт нэмэх: Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч хүүхдэд дараах таслан сэргийлэх арга хэмжээ авч болно: 1. Хүүхдийн эрхийг хамгаалах орон нутгийн байгууллагад хариуцуулах; 2. Хүмүүжлийн нөлөөлөл үзүүлэх сургалтад хамруулах; 3. Тодорхой цаг хугацаанд тодорхой орчноос гадагш явахгүй байхыг даалгах /гэр бүл, сургууль, түр сургалт гэх зэрэг/; 4. Мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн сонгон хэрэглэсэн бусад арга хэмжээ.
5.	*68 дугаар зүйл. Цагдан хорих*	ЭБШХ-ийн 68 дугаар зүйлд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэлийг заан хуульчилсан боловч насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагч буюу хүүхдэд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэлийг ялгамжтай хуульчлаагүй нь учир дутагдалтай болсон.	ЭБШХ-ийн 68 дугаар зүйлийн 68.1-ийн "онц аюултай гэмт хэрэгтэн" гэсний дараа "онц хүнд гэмт хэрэг үйлдсэн хүүхэд" гэж нэмэх.

6.	157 дугаар зүйл.	Энэ зүйлд шинжилгээ хийлгэх үед сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, өмгөөлөгч, хохирогчийн эдлэх эрхийг заасан боловч практикт эдгээр субъектүүдэд олгосон "шинжээчийн дүгнэлттэй танилцах"-аас бусад эрх хэрэгждэггүй. Шинжилгээний байгууллагаас шинжилгээ хийх шинжээчийг нууцалдаг тул тайлбар, баримт гаргах эрх хэрэгжих боломж огт байхгүй. Мөн 155 дугаар зүйлийн 155.3-т шинжилгээ хийлцэхэд байлцах эрхтэй этгээдийг ЭБША-г хэрэгжүүлэгч дээрхязгаарласан нь 157 дугаар зүйлийн 157.1.4-тэй зөрчилддөг.	1/ 157 дугаар зүйлд заасан эрхийг хэрэгжүүлэх боломжийг хангах үүднээс шинжилгээ хийх журам, шинжилгээний байгууллагын чиг үүрэгийг тодорхойлон зохицуулсан эрх зүйн зохицуулалтыг ЭБШХ-аар эсвэл бие даасан хууль батлан гаргах замаар хийх. 2/ ЭБШХ-ийн 155 дугаар зүйлд "сэжигтэн, яллагдагч, хохирогч, шүүгдэгч, тэдний өмгөөлөгч шинжилгээ хийх үед байлцах эрхтэй" гэх хэсэг нэмэх.
7.	271 дүгээр зүйл	Энэ зүйлд шүүх хуралдааны үед шинжилгээ хийлгэх тухай заасан боловч энэ ажиллагаа урьд нь дүгнэлт гаргасан шинжээчийг шүүх хуралдаанд оролцуулж, дүгнэлтийн талаар асуухаас хэтэрдэггүй. Шүүх хуралдааны үед шинжилгээ хийлгэх шаардлага гарвал хэргийг мөрдөн байцаалтад буцааж, дүгнэлт гаргуулдаг. Өөрөөр хэлбэл, хуулийн энэхүү заалт хэрэглэгддэггүй.	Хуулийн энэхүү заалтыг хэрэглэх талаар өмгөөлөгч, прокурор, шүүгчдэд зориулсан сургалт зохион байгуулж, тэднийг оролцуулах замаар нэг мөр ойлголт өгөх.
8.	276 дугаар зүйл	Хуульд шүүх бүрэлдэхүүн шаардлагатай бол газар, орон байранд үзлэг хийх тухай заасан боловч энэхүү ажиллагаг талуудын хүсэлтээр, эсхүл шүүх өөрийн санаачилгаар хийх эсэх нь тодорхойгүй хуулчилснаас шалтгаалан талууд хүсэлт гаргасан ч шүүх уг ажиллагааг хийдэггүйгээс энэ зүйл огт хэрэглэгддэггүй байна.	Энэ зүйлд шүүх хуралдааны явцад буюу шүүх бүрэлдэхүүн шүүх хуралдааны оролцогчдыг байлцуулан газар, орон байранд үзлэг хийх ажиллагааг талуудын хүсэлтээр хийхээр зааж өөрчлөх.

9.	377 дугаар зүйлийн 377.1.2.	Насанд хүрээгүй этгээдэд хорихоос өөр төрлийн ял оногдуулах, шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах тохиолдолд олон нийтийн хүмүүжүүлэгч томилохоор заасан байх боловч "олон нийтийн хүмүүжүүлэгч" гэж хэн болохыг тодорхой хуульчлаагүйгээс, мөн Эрүүгийн хуулийн 62 дугаар зүйлд энэхүү субъектийг заагаагүйгээс хуулийн энэхүү заалт хэрэгждэггүй байна.	ЭБШХ-ийн 377 дугаар зүйл, Эрүүгийн хуулийн 62 дугаар зүйлийг нийцүүлж, олон нийтийн хүмүүжүүлэгч гэдгийг Хүүхдийн эрхийг хамгаалах орон нутгийн байгууллага гэж өөрчлөн хуульчлах.
10.	394 дүгээр зүйлийн 394.1	... эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон тухай гэмт хэрэгт холбогдсон этгээдийн ажиллаж байгаа байгууллагад лавлагаа өгөх 1 сарын хугацаа нь хуульд заасан бусад хугацаатай харьцуулахад нэлээд урт байгаагаас гадна энэ хугацаанд тухайн этгээдийн эрх давхар зөрчигдөх боломж бий болох талтай.	Энэ зүйл дэх "1 сарын" гэснийг "7 хоногийн" гэж өөрчлөх.

—оОо—

хууль зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

Хавсралт-3

2.3. ЭБШХ-ИЙН НЭМЖ, ӨӨРЧЛӨГДСӨН ХЭМ ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

№	ЭБШХ-ийн зүйл хэсэг	Хэрэглэгдэж буй байдал	Санал
1.	68 дугаар зүйлийн 68.9.	2007 оны 8 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар ЭБШХ-ийн 68.9-т насанд хүрээгүй этгээдэд энэ хуулийн 68.2-т заасан үндэслэл байхгүй бол цагдан хорих ТСАХ хэрэглэхийг хориглоно гэж заасныг хасаж өөрчилсөн нь насанд хүрээгүй этгээдийн эрх зүйн байдлыг дордуулсан заалт болсон.	68 дугаар зүйлийн 68.9-т "насанд хүрээгүй этгээд" гэж нэмж өөрчлөх.
2.	229 дүгээр зүйлийн 229.1	Энэ заалтыг 2007 оны 8 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар "шүүгдэгч хаана байгаа нь мэдэгдэхгүй бол хэргийг түдгэлзүүлэх"-ээр өөрчилсөн. Гэтэл шүүхийн шатанд яллагдагч, шүүгдэгч шүүхээс оргосон, шүүн таслах ажиллагаанаас зайлсхийсэн тохиолдолд Эрүүгийн хуулийн 261 дүгээр зүйлд заасан гэмт хэрэг гэж үзэхээр заасан /2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар/. Практикт ЭБШХ-ийн энэ заалтыг баримталбал хэргийг оргосон яллагдагч, шүүгдэгчийг хаана байгааг мэдэгдтэл түдгэлзүүлэх боломжтойгоос гадна, дээрх тохиолдолд хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах хууль зүйн үндэслэл байхгүй байна.	• ЭБШХ-ийн 229 дүгээр зүйлийн 229.1-ийн заалтыг хүчингүй болгож, 247 дугаар зүйлийн 247.1-ийн "шүүгдэгчийн байгаа газар нь мэдэгдэхгүй байгаа" гэснийг хасаж өөрчлөх. • ЭБШХ-ийн 230 дугаар зүйлд "яллагдагч, шүүгдэгч шүүхээс оргосон, шүүн таслах ажиллагаанаас зайлсхийсэн бол" гэх хэсгийг нэмж оруулах.

3.	307 дугаар зүйл 315 дугаар зүйлийн 315.3.	Давж заалдах шатны шүүх хэргийг хэлэлцээд тогтоолыг хүчингүй болгож, хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буюу анхан шатны шүүхээр хэлэлцүүлэхээр буцаах шийдвэр гаргасан тохиолдолд тухайн шийдвэрт давж заалдах гомдол гаргах, эсэргүүцэл бичих эрхгүйгээр хуульчилсан нь нэг талаар давж заалдах шатны шүүхийн эрх хэмжээг хэт өргөжүүлсэн, нөгөө талаар Үндсэн хуульд заасан "гомдол гаргах" эрхийг хязгаарласан хэрэг болсон.	ЭБШХ-ийн энэ заалтыг давж заалдах шатны шүүхийн хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах шийдвэрт гомдол, эсэргүүцэл гаргах эрхтэй байхаар өөрчлөн хуульчлах шаардлагатай.
4.	342 дугаар зүйл	Энэ зүйлд өөрчлөлт оруулан хохирогч, шүүгдэгч хяналтын гомдол гаргах эрхгүй байхаар буюу зөвхөн өмгөөлөгч хяналтын гомдол гаргадаг байхаар хуульчилсан нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсгийн заалтаар хохирогч, шүүгдэгч нарт олгосон гомдол гаргах эрхийг хязгаарласан хэрэг болсон.	342 дугаар зүйлийн 342.1 дэх хэсгийн заалтыг шүүгдэгч, хохирогчид хяналтын журмаар гомдол гаргах эрхийг олгосон агуулгаар өөрчлөх.
5.	415 дугаар зүйлийн 415.3	Насанд хүрээгүй этгээдэд холбогдох хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэхгүй гэсэн нь уг ажиллагааны мөн чанар, зарчимтай нийцээгүй зохицуулалт болсон.	Насанд хүрээгүй этгээдэд холбогдох хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэхгүй тухай энэ зохицуулалт /мөн зүйл/-ыг хүчингүй болгох.
6.	418 дугаар зүйл	Энэ зүйлийн агуулгаас харахад шүүхээс зөвхөн цагаатгах, шийтгэх тогтоол гарах ба шүүгдэгч, хохирогч эвлэрсэн ч хэргийг хэрэгсэхгүй болгох боломжгүй мэтээр хуульчилсан нь ердийн журмаар шийдвэрлэхээс хялбаршуулсан байдал харагдахгүй, зөвхөн цаг хугацааны хувьд л түргэн байхаар зохицуулсан мэт харагдаж байна.	418 дугаар зүйлд шүүгдэгч, хохирогч эвлэрсэн тохиолдолд шүүхээс ямар шийдвэр /баримт бичиг/ гаргах талаар тодорхой заалт нэмэх.

—оОо—

IV БҮЛЭГ

ОЛОН УЛСЫН
ЭРХ ЗҮЙН СЕКТОР

ХУЛЛЫЗҮЙН ҮЛГЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ЗҮҮН ХОЙД АЗИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ [781]

"Аливаа улсын бодлого оршин буй газар зүйгээр тодорхойлогдоно"
Наполеон Бонапарт

Судалгааны ажлын хүрээнд 2010 оны 6 дугаар сард Буриадын Улсын их сургуулиас зохион байгуулсан "Ази Номхон Далайн бүсийн улс орнуудын Төрийн болон эрх зүйн систем: ОХУ-тай хамтран ажиллах боломж" сэдэвт III дахь олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд "Зүүн хойд Азийн аюулгүй байдал: шинэ бодит байдал" сэдвээр Ц.Эрдэнэболд илтгэл бэлтгэж, оролцсон. Энэ оны 8 дугаар сарын 16-22-ны өдрүүдэд АНУ-ын Хавайн нийслэл Гонулулу хотод АНУ-ын Ази, Номхон далайн аюулгүй байдлын судалгааны Төвөөс зохион байгуулсан "Бүсийн аюулгүй байдлын хөгжил: үндэсний үнэт зүйлс ба бүсийн асуудлууд" сэдэвт семинарт секторын эрхлэгч Ц. Эрдэнэболд оролцож мөн илтгэл хэлэлцүүлсэн.

Мөн 2010 оны 11 дүгээр сарын 6-13-ны өдрүүдэд ОХУ-ын Владивосток хотноо "Зүүн хойт Азийн далай тэнгисийн аюулгүй байдал, хамтын ажиллагаа" сэдвээр зохион байгуулагдсан семинарт оролцож "Далайд гарцгүй орнуудын эрх зүйн байдал: Монгол Улсын жишээ" гэсэн сэдвээр илтгэл бичиж тус тус хэлэлцүүлсэн болно.

Зүүн хойд Азийн аюулгүй байдлын олон улсын эрх зүйн асуудлыг судлах ажлын хүрээнд, тус бүс дэхь олон улсын хамтын ажиллагаа, эрх зүйн зохицуулалт, хамтын ажиллагааг хангаж буй олон улсын байгууллага, тэдгээрийн статус болон энэ асуудалд Монгол Улсын эзлэх байр суурийн талаар судалж судалгааны тайландаа дурдсан болно.

XXI зууны эхэнд даяршилын үйл явц эрчимтэй өрнөж, улс хоорондын харилцаа, олон талт хамтын ажиллагааны цар хүрээ улам бүр өргөжин тэлж байна. Энэ үйл явц дэлхий нийтийн шинж чанартай болж улс төр, нийгэм, эдийн засаг, эрх зүй зэрэг бүхий л салбарыг хамаарч, улс хоорондын харилцааг өөр хоорондоо нягт уялдаатай, ихээхэн түгээмэл агуулгатай болгож байна.

Дэлхийн улс орнууд, ялангуяа хөгжиж байгаа орнууд, түүний давлагаанд өөрийн эрхгүй татагдан орохдоо давуу талыг нь үр өгөөжтэй ашиглах, сөрөг талыг нь даван туулж, үндэсний өвөрмөц шинж чанар, аюулгүй байдлаа хадгалж үлдэх, хөгжлийн тогтвортой байдлыг хангах талаас нь ихээхэн анхаарах болсон.

Үүний сацуу цаг хугацааны хүчин зүйлстэй өрсөлдөн явагдаж буй дэлхий нийтийг хамарсан эдгээр өөрчлөлт янз бүрийн шалтгаан бүхий шийдвэрлэх ёстой олон асуудлыг араасаа дагуулж буй нь улам бүр тодорхой болж байна.

[781] Тус секторын төлөвлөгөөт судалгааны ажил.

Бүс нутгийн улс төр, аюулгүй байдал олон талт хамтын ажиллагаа

Сүүлийн жилүүдэд олон улсын байдалд нааштай эерэг шинэчилэлт хувиралт гарч улс гүрний хоорондын харилцаа намжуу тайван болох, харилцан ойлголцож хамтран ажиллах хандлага аажмаар газар авах шинжтэй байна. Дэлхий ертөнцийн хүчний харьцаа шинэчлэгдэх, улс орнуудын аюулгүй байдлын талаархи олон улсын хамтын ажиллагаа цөөн хэдэн их гүрэнд хянагдахаа болих, олон талын яриа хэлцэлтэй холбогдсон олон асуудал бүс нутгийн улсуудын гарт орох шинэ хандлага гарах болсон.

Дэлхийн улс орнууд, ялангуяа жижиг, дунд орнууд дайн, сөргөлдөөнгүй тайван байдалд амьдарч, эдийн засгаа өөд татах, ачаалал багатай гадаад бодлого явуулах, зэвсэглэлийг юуны өмнө цөмийн зэвсэглэлийг хорогдуулахыг урьдаас илүү эрмэлзэх болсон. Иймэрхүү нааштай өөрчлөлт байвч улсуудын хооронд маргаан тэмцэл үргэлжилсээр цэрэг дайны аюул, улс төрийн тогтворгүй байгаа нь дэлхий дахины улс төрийн гол үйл явц нь нийгмийн амьдралыг ардчилах, хүний эрх чөлөөг хүндэтгэх, түүний аж байдлыг дээшлүүлэх, маргаантай асуудлыг хүч ул хэрэглэн, улс төрийн яриа хэлцлийн аргаар шийдвэрлэх тийш чиглэдэг болсон.

Хүн төрөлхтний анхаарлын төвд тавигдаж буй нөгөө нэг чухал асуудал бол байгаль орчноо хамгаалах, экологийн аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангахад чиглэгдэж байна. Энэ талаар НҮБ-ын Рио де Жанейрогийн Байгаль орчин, хөгжлийн асуудлаархи бага хурал эргэлтийн цэгийг тавьж өгсөн бөгөөд түүнээс хойш хугацаанд байгаль орчныг хамгаалах талаар шинэ соргог саналууд дэвшигдэн, чухал арга хэмжээ авагдах болов. Энэ нь эдийн засгийг хөгжүүлэх алив асуудлыг шийдвэрлэхдээ заавал экологийн асуудалтай холбон авч үзэх нь чухал гэсэн амьдралын шаардлагыг ухамсарлаж эхэлж буйн илрэл биззэ.

Эдүгээ дэлхий дахин тив, бүс нутгийн аж ахуй хэлхээ холбоо интернационалчлагдаж, шинжлэх ухаан, технологийн хувьсгал нийтийг хамран, мэдээлэл ба харилцаа холбооны хэрэгсэл зарчмын цоо шинэ үүрэгтэй болж байна. Хөгжингүй болон шинээр үйлдвэржсэн орнуудад эрдэм оюун их шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өргөн хүрээтэй явуулсны үр дүнд хөдөлмөрийн шинж чанарт өөрчлөлт орж байгаа.

1990 оноос дэлхий дахины ба бүс нутгийн олон улсын харилцааны системд гарсан өөрчлөлтийн үр дүнд Ази, номхон далайн аюулгүй байдлын асуудлаар олон талын яриа хэлцэл өрнүүлэн, үүнийг хэрэгжүүлэх механизм бий болгох бололцоо бий болсон.

Ази, Номхон далайн орнуудын дэвшүүлсэн аюулгүй байдлын системийн энэхүү үзэл санаа нь өнгөрсөн үеийнхээс ялгаатай бөгөөд эдгээрийг товч өгүүлбэл:

-Дэлхийн 2 дайны дараахь "хүйтэн дайны" жилүүдэд АНУ, ОХУ-аар / тухайн үед ЗХУ/ толгойлуулсан эсрэг тэсрэг хоёр лагерь оршиж байв. Ийм нөхцөлд 1950-иад онд АНУ-ын санаачилгаар /Япон, Өмнөд Солонгос, Филиппин, Австрали, Шинэ Зеланди/ 6 орны "Зүүн өмнөд Азийн батлан хамгаалалтын гэрээний" /Манилагийн гэрээ гэж нэрлэгдсэн/ байгууллага байгуулагджээ. ОХУ, БНХАУ хоёр хамтарсан мэдэгдэл гаргаж цэргийн

эвслийг "хамтын аюулгүй байдлын систем" болгон өөрчлөх санал дэвшүүлж байв.

-ОХУ 1960-аад оны эцсээр "Азийн аюулгүй байдлын систем"-ийг / Дорнод Ази, Өмнөд Ази, Өрнөд Азийг багтаасан/ байгуулах санал гаргажээ. АНУ, Хятад, Япон, Индонези, Пакистан зэрэг улс уг саналыг үл таашаасан учир хэрэгжээгүй.

-1980-аад онд тус бүс нутгийн орнуудад эдийн засгийн хамтын ажиллагааны механизм бий болгох санаачилгаа гаргав. ОХУ өөрийн бодлогыг энэ шинэ нөхцөлд тохируулан, бүс нутгийн орнууд тухайлбал, АНУ-тай харилцааны хурдацмал байдлыг намжаах алхмууд хийжээ.

-1990-ээд онд ЗХУ задарсан. Үүнтэй холбогдуулан шинэ нөхцөлд Ази, Номхон далайн аюулгүй байдлын олон талын яриа хэлцлийн механизмыг бий болгох эрэл хайгуул эхэлсэн юм.

1993 онд АСЕАН-ны орнуудын ГЯЯ-ны сайд нарын 26-р бага хурал, дараа нь 7 сард АСЕАН-ны орнуудын Сайд нарын зинданы бага хурлаар Ази, Номхон далайн аюулгүй байдлын олон талын яриа хэлцлийн механизмийн тухай асуудал хэлэлцжээ. Сүүлийн бага хуралд ОХУ, БНХАУ-ны Гадаад яамны сайд нар оролцжээ. Бага хурлаар гаргасан мэдэгдэлд АСЕАН-ны бүс нутгийн чуулга /АРФ/ байгуулах тухай зарлаж чуулганы бүрэлдэхүүнд АСЕАН-ны 6 орон дээр нэмэж Австрали, Канад, Европын холбоо, Япон, Шинэ Зеланд, БНСУ, АНУ, БНХАУ, ОХУ, Лаос, Попуа шинэ Гвиней, Вьетнан болон олон улсын байгууллагуудаас оруулжээ.

АСЕАН-ны Бүс нутгийн чуулганы анхдугаар уулзалт 1994 онд болж дурьдсан орнуудын гадаад яамны сайд нар оролцсон байна. Чуулганаар гаргасан мэдэгдэлд Ази, Номхон далайн бүс нутгийн улс орнуудад улс төр ба аюулгүй байдлын нийтлэг сонирхлын асуудлаар үр ашигтай яриа хэлцэл, зөвшилцөл хийдэг заншил уламжлал бий болгох бололцоо олгож буй энэ уулзалт бүс нутгийн хамтын ажиллагаанд шинэ бүлэг нээсэн гэж үнэлэгдэд АРФ-ийн уулзалтыг хийж бүр хийж байхаар тохиролцов.

Дээр дурьдсанаас үзвэл Ази, номхон далайн бүс нутагт улс орнуудын аюулгүй байдлын асуудлыг хэлэлцэж байх олон талын яриа хэлцлийн байгууллага байгуулах үзэл санааг бодит байдал болгох чухал алхам хийх суурь тавигдаж эхлэв.

Номхон далайн хамтын нийгэмлэг байгуулах асуудал бол нилээд нарийн төвөгтэй амаргүй зорилт байсан. Хамтын нийгэмлэг нь нэг талаас өндөр хөгжилтэй ба буурай, баян ба ядуу, дотоддоо өөр өөр системтэй болон нийгмийн хөгжлийн загвар /парадигм/-ыг сольж байгаа орнууд, нөгөө талаас Ази тив, Номхон далайн сав газарт үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын хамтын ажиллагааны байгуллага зэргийг хамтран багтааж байсан байна. Иймд эдгээр орон, байгууллагыг адилхан хөндөх нийтлэг ашиг сонирхлыг илрүүлэн олж, түүний үндсэн дээр хамтын ажиллагааг эхлэн өрнүүлэх шаардлага гаргана. Ийм ашиг сонирхол нь юуны өмнө тус бүс нутгийн худалдаа, хөрөнгө оруулалтын асуудалд төвлөрч болох юм. Үүний хамт Ази тив, Номхон далайн сав газрын олонхи улс оронд бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа, хөрөнгө оруулалтаас дутахгүй ач холбогдолтой байсан, байсаар ч ирсэн юм.

Энэ замаар 1994 онд Номхон Далайн хамтын нийгэмлэг байгуулах тухай саналыг 1994 оны 5 дугаар сард Сэүл хотноо болсон Зүүн хойд Азийн эдийн засгийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн симпозиумд өөрийн хэлэлцэх хэргийн төлөвлөгөөнд оруулан санал солилцоод ийм хамтын нийгэмлэг байгуулах боломж одоогоор байхгүй гэж үзсэн байна. Тухайн үед энэ нь эртэдсэн санаа гэж симпозиумд оролцсон эрдэмтэд, улс төрчид үзсэн байна.

Ази тив, Номхон далайн сав газрын өргөн уудам нутагт Зүүн хойд Ази бие даасан бүс нутаг болон бүрэлдэх үйл явц нилээд хэдэн жилийн өмнө эхэлж, эдийн засагчид, судлаачид, улс төрчид, эрдэмтдийн хүрээнд бүсэд багтах улс орнуудыг тодорхойлон тогтоож /Япон, БНСУ, БНАСАУ, Монгол Улс, ОХУ, АНУ, Канад/ улс төр, эдийн засаг, соёлын салбарт хамтран ажиллахын чухлыг үндэслэн онол-практикийн асуудлуудыг хэлэлцэн санал зөвлөмжүүд боловсруулах болсон байна. Зүүн хойд Азийн олон талын хамтын ажиллагааг бий болгох асуудлууд нь бүс нутгийн аюулгүй байдлын системийг тогтоохтой салшгүй холбоотой юм. Бүс нутгийн хамтын ажиллагааны энэ тулгамдсан асуудал нийт Ази, Номхон Далайн аюулгүй байдлын олон талын яриа хэлцлийн механизм бий болгох өргөн асуудлын нэг бүрэлдэхүүн хэсэг болох ёстой. Асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зайлшгүй алхам хийхэд бүсийн голлох орнууд үндсэн үүрэг гүйцэтгэх тухай онцлон тэмдэглэдэг явдал зүй ёсны зүйл бөгөөд АНУ, Япон, ОХУ, БНХАУ зэрэг орны удирдагчид уг асуудлыг нэг бус удаа хөндсөн.

Зүүн хойд Азийн бүс нутгийн аюулгүй байдал гэдэг бол бүс нутгийн тогтвортой байдлыг хадгалах гэсэн үг бөгөөд энэхүү тогтвортой байдал нь бүс нутгийн эдийн засаг, улс төр, нийгэм, соёлын дэвшилтэнд суурилсан урьдчилсан харж болох хөгжлийн үйл явц билээ. Иймээс тогтвортой байдал нь бүс нутгийн тодорхой хэсэгт зонхилох байр суурь олж авах гэсэн нэг улс гүрний оролдлоготой үл нийцнэ. Хэвэр ийм оролдлого гарвал энэ нь бүс нутгийн хүчний тэнцэлд өөрчлөлт оруулан түүнийг эвдлэх нөхцөлийг бий болгох аюултай нь ойлгомжтой.

Интеграцийн асуудлыг шийдвэрлэхэд субъектив хүчин зүйлүүд, тухайлбал түүхэн үйл явц дахь тодорхой хүмүүсийн үйл ажиллагаатай холбогдсон субъектив хүчин зүйлүүд идэвхтэй үүрэг гүйцэтгэж ирснийг тэмдэглэх хэрэгтэй. Нэгдэл нягтралын талыг баримтлагч улс төрийн зүтгэлтэн нарын хүчин чармайлт Ази, Номхон далайн болон Зүүн хойд Азид хамтын ажиллагааны үйл явцыг эхлүүлэх, хөгжүүлэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн.

Зүүн хойд Азийн бүс нутагт өнөөгийн хөгжлийн түвшин, дотоод дахь нийгмийн байгуулал, түүх-соёл-зан заншлын уламжлалаар харилцан адилгүй орнууд газар нутгийн байршлын эрхээр багтан харилцан үйлдэл, хамтын ажиллагааны бүс нутгийн сүлжээнд орж байна. Эдгээр орон хоёр тал болон олон талын харилцааг хөгжүүлэхдээ тус бүрийн онцлогтой холбогдон бие биеийн дутууг харилцан нөхөж, бие биедээ дэм тус үзүүлэх, улс орон, бүс нутгийнхаа хөгжлийг урагшлуулан түргэтгэх, энэ утгаараа бөмбөрцгийн хамтын ажиллагааг урагшлуулах, харилцан хамтын тогтолцоог бүрдүүлэх

юм. Гэхдээ улс тус бүрийн хүч бололцоо, нөөц, хүрсэн түвшин адилгүй тул бүс нутгийн хамтын ажиллагааны өнөөгийн ба ирээдүйн хөгжилд уг нутагт оршин буй орнууд ялангуяа тэргүүлэх орнууд их үүрэг гүйцэтгэж, багагүй хариуцлага хүлээж байна. Үүнийг иш үндэс болгон бүс нутгийн орнуудын геополитик, геоэкономикийн бодлогын зарим хэсгийг товч хөндье.

Өнөөдөр дэлхий дахины бодлогын гол чухал асуудлууд, тэдгээрийн дотор Зүүн Хойд Азийн асуудлууд АНУ-ын оролцоогүйгээр шийдэгдэнэ гэдэг нь тодорхой. АНУ дэлхийн 2-р дайны дараа Ази, Номхон далайн бүс нутагт хоёр талын холбооны өргөн сүлжээ тогтоож батлан хамгаалах стратегиа хэрэгжүүлсэн юм. Дэлхийд манлайлах байр суурийг баримтлан эдийн засгаас илүү, цэргийн хүч чадлыг хөгжүүлэхэд голлон анхаарч байв. Аажимдаа холбоотонтойгоо харилцах харилцаандаа манлайлан давамгайлах байр суурийнаас тэдэнтэй яриа хэлцэл хийж, чиг шугамаа зохицуулах байранд шилжих болжээ. Ази, Номхон далайн хамтын ажиллагааны үзэл санаа үүсэн гарч байхад АНУ түүнийг таашаан үзэхгүй байсан хандлагаа хожим өөрчилсөн.

1990-ээд онд ЗХУ улс задарсантай холбогдуулан түүний цэргийн аюулын эсрэг чиглэсэн Ази, Номхон далай дахь хуучин стратегиас АНУ холдож эдийн засгийн асуудлын ач холбогдлыг товойлгон тавих болжээ. Энэ нь эдийн засгийн интеграцийг хэрэгжүүлэх, ардчилах үйл явцыг дэмжих, батлан хамгаалах шинэчилсэн бүтцийг бий болгох үзэл санаанд үндэслэсэн ажээ. Зүүн Хойд Азийн хувьд гэвэл АНУ, Японы хамтарсан цэргийн эвслийг аюулгүй байдлын стратегийн гол зүрх хэмээн үзэхийн хамт энх тайван харилцааг тогтоох үүднээс, ОХУ, БНХАУ-тай урьдаас илүү зохицуулалт хийх үзэл бодол давамгайлах болжээ. АНУ "хариуцлагыг бүтээлчээр хуваалцах" үзэл санаандаа үндэслэн Номхон далайн хамтын нийгэмлэгт нийэгм-эдийн засгийн янз бүрийн систем бүхий хөгжлийн янз бүрийн түвшинд байгаа орнуудыг багтаах саналыг зөвшөөрөх болсон.

Ази тив, Номхон далайн сав газар, Зүүн Хойд Азийн бүс нутгийн байдлын цаашдын тогтворжилт, тэндэх аюулгүй байдлын систем, олон талын эдийн засгийн хамтын ажиллагааны үйл явц өргөжин хөгжих явдал АНУ-ын хандлага, чиг шугамаас ихээхэн хамаарна. Эдүгээ АНУ, Азийн харилцаа нэн чухал өөрчлөлтийн шинэ шатнаа гарч байгаа бөгөөд энэ нь цаашид нэгдсэн Азийн бодит байдалд тохирон эерэг тал өөд сайжран өрнөнө гэдэг итгэлийг төрүүлж байгаа юм.

Өндөр хөгжилтэй эдийн засгийн үлэмж их нөөцтэй Япон Улс Зүүн Хойд Азийн хамтын ажиллагаанд гол үүрэг гүйцэтгэх орны нэг юм. Японы байр суурь бэхжиж түүний эдийн засгийн нөөц нэмэгдэн олон улсын тавцанд гүйцэтгэх үүрэг, түүнд тавих дэлхий нийтийн найдлага өсөн нэмэгдсээр байна. Одоо Япон дэлхийн үйлдвэржсэн долоон том орны нэг бөгөөд НҮБ-д оруулах хөрөнгийн хэмжээгээр АНУ-ын дараа орох болж, хөгжлийн түвшин доогуур орнуудад санхүү эдийн засгийн тусламж дэмжлэг үзүүлэх талаар дэлхийд тэргүүлэх болжээ. Японы санхүү эдийн засаг, технологийн энэхүү боломжийг Зүүн Хойд Азийн бүс нутгийн зарим улс, тэдний дотор Монголын хөгжлийг түргэтгэх хоёр талын ба олон талын хамтын ажиллагааны хүрээнд ашиглах явдал ач холбогдолтой юм.

Япон Улс дангаар болон АНУ-тай хамтран Зүүн Хойд Азийн тодорхой бүс нутгуудыг хөгжүүлэх талаар боловсруулсан төслүүд нь бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааг урагшлуулахад хувь нэмэр оруулж байгаа билээ. Япон өөрийн оршин буй бүс нутагт улс төр, эдийн засгийн манлайлагч улс болох тэмүүлэлтэй байдаг. Энэ зорилтоо хэрэгжүүлэхэд нь нэг талсаас АНУ-тай тогтоосон түншлэлээ хадгалах явдал, нөгөө талаас бүс нутгийн зарим оронтой харилцах харилцаан дахь хоёр талын ашиг сонирхолыг хөндсөн зарим асуудлаа шийдвэрлэх явдал багагүй нөлөө үзүүлэх билээ.

Зүүн Хойд Азийн хамтын ажиллагааны нэг том түнш бол ОХУ юм. Бодит байдлаас үзвэл өнөөгийн ОХУ нь: Европ, Умард Номхон далай дахь чухал нөлөө бүхий бүс нутгийн их гүрэн юм. Цөмийн зэвсгийг хориглон устгах хүртэл ОХУ, АНУ ба БНХАУ-тай адил цөмийн гүрэн хэвээр үлдэнэ. Орчин үеийн хүнд бэрхшээлийг үл харгалзан ОХУ эдийн засгийн үлэмж потенциалтай том гүрэн хэвээр байгаа бөгөөд байх нь мэдээж. Энэ нь тус орны байгалийн их нөөц, мэргэжсэн ажиллах хүч, оюуны потенциал, соёл, шинжлэх ухааны хөгжлийн өндөр төвшингөөр тодорхойлогдож байна. Ийм байр суурь болон бололцоо потенциалтай ОХУ, Зүүн Хойд Азийн эдийн засгийн хамтын ажиллагаа, интеграцид оролцохдоо: юуны өмнө Оросын Алс Дорнодын бүс нутгийг хөгжүүлэхэд ихээхэн анхаарал тавьж байна.

Алс Дорнодынхоо нилээд хэсгийг нээлттэй болгож тэнд байгаа зэвсэгт хүчнээ багасгах арга хэмжээ авч бүс нутгийн хүчний тэнцвэрийг үл алдагдуулахад чухал алхам хийж байна. ОХУ, Зүүн Хойд Азийн улс оронтой хоёр талын болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлж ирсэн бөгөөд тухайлбал, БНХАУ, БНАСАУ-тай хамтран Түмэн голын сав газрыг хөгжүүлэх олон улсын төсөл хэрэгжүүлэхэд оролцон бүс нутгийн олон улсын байгууллагуудтай хамтран ажиллахыг эрмэлзэж байна. Орос Улс АСЕАН-ы бүс нутгийн чуулган \АРФ\ бүрэлдэхүүнд багтаж орсоноор Ази, Номхон далайн аюулгүй байдлын олон талын яриа хэлцлийн асуудлыг нааштай шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах ёстой. Энэ бүгдийг тооцон үзвэл ОХУ нь Ази, Номхон далайн тогтвортой байдлыг бэхжүүлэхэд урьдаас илүү чухал үүрэг гүйцэтгэх боломжтой юм. Зүүн Хойд Азийн хамтын үйл ажиллагаанд нэн их үүрэг гүйцэтгэж буй улсын нэг нь БНХАУ юм. Монгол Улс өмнөд хөрш БНХАУ-ын өөрчлөлт, шинэчлэлт, түүнээс олон улсын талбарт ялангуяа Ази, Номхон далайн бүс нутагт явуулж буй бодлого, үйл ажиллагааг байнга ажиглан сонирхож байдаг юм. Сүүлийн жилүүдэд БНХАУ-ын гадаад эдийн засгийн бодлогын чухал нэгэн чиглэл нь Зүүн Хойд Азийн бүс нутагт хандаж байгаа нь билээ. Дэлхийн хамгийн олон хүн амтай, эдийн засгийн үйлдвэрлэлийн болон цэрэг техникийн ихээхэн нөөцтэй БНХАУ нь цаг үе өнгөрөх тутам Зүүн Хойд Азийн бүс нутагт, түүгээр барахгүй Ази тив, Номхон далайн сав газарт улам бүр өсөн нэмэгдэх байр суурь эзлэх нь тодорхой. Энэ бол дэлхийн улс орон ялангуяа бүс нутгуудийн улсуудын анхааран үзвэл зохих түүхэн бодит зүйл юм. БНХАУ-ын байр суурь бодлогоос Зүүн Хойд Азийн улс төрийн аюулгүй байдал, эдийн засгийн тогтвортой хөгжил ихээхэн хэмжээгээр хамаарна.

БНХАУ эдийн засгийн шинэчлэлт, нээлттэй гадаад бодлого явуулах болсоноос хойш Зүүн Өмнөд Азийн улсуудтай эдийн засаг худалдааны харилцаагаа идвэхжүүлж Зүүн Хойд мужуудаа хөгжүүлэх төлөвлөгөөг арав, арван тав, хорин жилээр зохион хэрэгжүүлэх болсон.

Хятадын Зүүн Хойд Азид хамрагдаж буй муж, бүс нутаг нь нийт Хятадын эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэгдэг байна. Тухайлбал, тэнд орчин үеийн аж үйлдвэр хамгийн эрх хөгжсөн юм.

БНХАУ ихээхэн идэвх гарган Зүүн Хойд Азийн орнуудтай гол нь ОХУ, БНАСАУ-тай хамтран хэрэгжүүлж буй томоохон төслийн нэг нь Түмэн голын сав газрыг хөгжүүлэх төсөл юм. 15 жилийг эзлэх энэхүү төслийг хэрэгжүүлсэнээр Хятад Улс энэ бүс нутгийн улсуудтай харилцан ашигтай худалдааг хөгжүүлэх, эрдэс түүхий эдэд боловсруулалт хийх, эдийн засгийн чөлөөт бүс байгуулах гэх зэрэг шинэ бололцоог олж авах юм. Монгол Улс БНХАУ-тай эдийн засаг худалдааны харилцаа хамтын ажиллагаагаа өргөжүүлж, хилийн нилээд боомтыг нээж, Хятадын нутгаар дамжин далайд гарцтай болох эхлэл тавьгдсан.

Зүүн хойд Азийн тогтвортой байдал, хамтын ажиллагаанд Солонгосын хойг дээрх хоёр улсын нэгдмэл хүчин чармайлт өнөө үед нэн чухал болж байна. Солонгосын хойгт БНСУ, БНАСАУ хэмээх НҮБ-ын гишүүн хоёр улс оршиж, хоёулаа Зүүн Хойд Азийн бүс нутгийн хамтын ажиллагаанд тодорхой байр суурь эзэлдэг.

Олон улсын эрх зүйд заншлын хэм хэмжээнүүд томоохон үүрэг гүйцэтгэдэг. Заншил бол ОУЭЗ-н үндсэн зарчим болон ОУЭЗЭЗ-н салбарын зарчмуудын оршин байх гол хэлбэр юм. Заншлын хэм хэмжээнүүд нь ОУЭЗЭЗ-н болон ОУЭЗ-н бусад салбаруудын зонхилох хэсгийг бүрдүүлдэг. Үүнээс гадна ОУЭЗ-н ерөнхий анги үндсэндээ заншлын хэм хэмжээнүүдээс бүрддэг. Олон улсын практик заншлын хэм хэмжээнүүд нь аажмаар бий бодог. ОУЭЗЭЗ-н заншлын хэм хэмжээ бүрдэх үйл явц нь дараахь хоёр элементээс бүрдэнэ:

1.Улс орнуудын давтагдсан үйлдэл, эс үйлдэл /практик, прецедент, бичиг баримт батлах-занижя/,

2.Төрөөс заншлын хэм хэмжээг эрх зүйн хэм хэмжээ болгон хүлээн зөвшөөрөх, өөрөөр хэлбэл хуулийн хүчин чадалтай хэм хэмжээ болгох ОУЭЗ-н ерөнхий заншлын хэм хэмжээг дэлхийн эрх зүйн үндсэн тогтолцоо, гол гол иргэншлийн хэлбэрийг төлөөлдөг ихэнх улсууд буюу өөрөөр хэлбэл олон улсын нийгэмлэг бүхлээрээ баталдаг юм.

Бүс нутгийн болон орон нутгийн заншлын хэм хэмжээнүүдийг шууд ашиг сонирхол бүхий улс орон байгууллагуудын зөвшөөрөлтэйгээр баталдаг байна. Бүс нутгийн болон орон нутгийн заншлын хэм хэмжээг зөвшөөрч байгаагаа улс орнууд тодорхой илэрхийлэх ёстой. Орчин үеийн ОУЭЗЭЗ-д заншлын хэм хэмжээг бүрдүүлэхэд одоо урт удаан хугацааны практик, олон удаагийн прецедент шаардлагагүй бөгөөд хэд хэдэн, бүр нэг удаагийн горим журмыг хэлбэршүүлсэн байх нь хангалттай. Иймд заншлын хэм хэмжээнүүд нь тогтсон практикийг тусгах төдийгүй хэлбэршүүлэх үүрэгтэй байдаг. Тодорхой байх асуудал нь заншлын эрх зүйн гол асуудал болдог боловч

заншлын эрх зүйгээс туйлын тодорхой байдлыг шаардаж болохгүй бөгөөд энэ нь заншлын хэм хэмжээ хөгжих болон бүрэлдэхэд хүндрэл учруулна. ОУЭЭЗЭ-д энэ нөхцөл байдал нь чухал ач холбогдолтой бөгөөд үндсэндээ ОУЭЗ-н хэм хэмжээг хэлбэршүүлэх замаар, түүний дотор олон улсын эдийн засгийн байгууллагуудын шийдвэрээр дамжуулан хэрэгждэг. ОУЭЭЗЭ-н заншлын хэм хэмжээг үүсгэх, хэлбэршүүлэх жишээ бол 1974 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн НҮБ-ийн ЕА-н баталсан улсуудын эдийн засгийн эрх, үүргийн тунхаглал юм.

Заншлын болон гэрээний хэм хэмжээний харилцан хамаарал болон харилцан үйлчлэл нь илт тодорхой байдаг юм. Олон тооны заншлын эрх зүйн хэм хэмжээнүүд нь олон улсын гэрээнд тусгалаа олсон хэдий ч өөрийн шинж чанарыг алдалгүйгээр заншлын хэм хэмжээ хэвээр үлдсэн байна. Заншлын болон гэрээний хэм хэмжээний харилцан үйлчлэл нь ОУЭЭЗЭ-н суурь асуудлуудыг түүний шийтгэл байдал болон дэвшилтэт хөгжлийг хангах талаас нь шийдэхэд тусалдаг. Нийтлэг олон талт гэрээ нь ОУЭЗ-н нийтлэг байр суурийг хялбаршуулж, өөрийн эрх мэдлээр түүний хэм хэмжээг баталгаажуулж, агуулгыг нь тодруулж, шинэ хэм хэмжээг томьёолдог. Гэвч цөөн тооны нийтлэг гэрээнд улсууд нийтээрээ оролцсон байдаг. Түүний тусламжтайгаар гэрээний заалтууд нийтлэг ОУЭЗ-н хэм хэмжээний шинжийг олж авдаг.

Гэрээний болон заншлын хэм хэмжээний харилцан үйлчлэлийг нэн тааламжтай нөхцөлийн институт дээр авч үзье. Үндэстний нэн тааламжтай нөхцөл /ҮНТН/ олгох журам нь ОУЭЭЗЭ-н заншлын эрх зүйн зарчим болдог ба мөн хоёр талт, бүс нутгийн олон талт хэлэцээрт энэ зарчим нь тусгагдсан байдаг. Энэ тохиолдолд журам нь өөрийн үндэсний эрх зүйгээр тогтоогддог. ҮНТН-н институтэд нэн тааламжтай нөхцөлийн гэрээ заншлын хэм хэмжээнд үл хамаарах хэм хэмжээг хэрэглэх журмыг зохицуулсан бүрдэл хэм хэмжээ орно. Эдгээр үл хамаарал нь гэрээ-заншлын хэм хэмжээгээр зохицуулагддаг. Эдгээр хэм хэмжээнүүдийн нөлөөгөөр дараахь ҮНТН зарчмын үл хамаарах хэм хэмжээнүүд хүлээн зөвшөөрөгддөг.

- Хил орчмын худалдааны хүрээнд олгогдох давуу эрхийн;
- Хөгжиж байгаа улсуудад хөнгөлөлтийн нийтлэг тогтолцооны хүрээнд олгогдох давуу эрхийн;
- Газар нутгийн байдлаас шалтгаалан далайд гарцгүй орнуудад олгох давуу эрхийн;
- Олон талт хэлэлцээр болон интеграцийн нэгдлийн бусад хэлбэр дэх оролцооноос үүсэх давуу эрхийн.

Далайд гарцгүй улс орнуудад олгогдох тусгай давуу эрх болон ҮНТН-д үл хамааруулах практик нь эхэн үедээ зөвхөн заншил тодий байсан байна. Хожим энэхүү заншил нь НҮБ-н ЮНКТАД-н 1964 оны зөвлөмжид тусгагдсан гэрээ-заншлын хэм хэмжээ болсон бөгөөд олон улсын гэрээнд орсон. Тухайлбал, 1965 онд гарын үсэг зурагдсан. Далайд гарцгүй орнуудыг дамжин өнгөрөх худалдааны конвенцид орсон болно. Энэ хэм хэмжээг Далайн эрх зүйн тухай НҮБ-н 1982 оны конвенцид оруулснаар энэ журам нь нийтлэг тодийгүй хатуу тогтоосон шинжтэй болсон юм.

ОУЭЗ-н үндсэн зарчмууд гэдэг нь хууль зүйн хүчин чадалтай ерөнхийлсэн хэм хэмжээ юм. Эдгээр нь ОУЭЗ-н гол агуулга, олон улсын нийгэмлэг болон улс орны язгуур ашиг сонирхлыг бүхэлд нь тусгаж олон улсын хэм хэмжээний тогтолцоог бүрдүүлэгч болдог юм. ОУЭЗ-н үндсэн зарчмууд нь дараахь чиг үүргийг биелүүлдэг.

- Улс орны үндсэн эрх үүргийг тусгах,
- ОУЭЗЭЗ-н бусад хэм хэмжээний үйлчлэл, шинээр бий болох үндэс болох,
- Нийт хүн төрөлхтний үнэт зүйлсийн бүрдлийг хамгаалах,
- Олон улсын, түний дотор ОУЭЗХ дахь эрх зүйн журмыг хамгаалах,
- ОУЭЗ хөгжих, үйлчлэх, ОУЭЗ-н тогтолцооны нэгдмэл байдлыг хангах,
- ОУЭЗЭЗ дэх эрх зүйн хийдлийг арилгах.

Олон улсын эрх зүйн нийтлэг зарчимд дараахь зарчмууд орно:

1.Хүч хэрэглэх болон хүч хэрэглэхээр заналхийлэхээс сэргийлэх зарчим,

2.Маргааныг энхийн замаар шийдвэрлэх зарчим,

3.Үл оролцох зарчим,

4.Хамтын ажиллагааны зарчим,

5.Ард түмний тэгш эрх, өөрөө өөрийгөө тодорхойлох зарчим,

6.Улсын бие даасан хараат бус байдлын зарчим,

7.Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх зарчим,

8.Газар нутгийн чөлөөт байдлын зарчим,

9.Хүний эрхийг хүндэтгэх зарчим.

Эдгээр зарчмууд нь бүгд харилцан хамааралтай бөгөөд харилцан үйлчилсэн нөхцөлд л өөрийн чиг үүргийг биелүүлж чадна. Эдгээр зарчмууд нь нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн эрх зүйн хэм хэмжээ байдаг бөгөөд цаашилбал НҮБ-ийн дүрэм, 1970 оны НҮБ-ийн дүрэмд заасны дагуу Найрсаг харилцаа хамтын ажиллагаатай холбоотой Олон улсын эрх зүйн зарчмуудын тунхаглал, 1975 оны Европын Аюулгүй байдал хамтын ажиллагааны зөвлөгөөний төгсгөлийн баримт бичиг болон олон улсын гэрээнд тусгалаа олсон байдаг. Эдгээр зарчмуудын агуулгыг бүрдүүлэгч хэд хэдэн элемент нь өөрсдөө олон улсын эрх зүйн зарчим болсон ба жишээлбэл, улсын тусгаар тогтнол, улсуудын адил тэгш, тусгаар тогтнолын зарчмын хэсэг болсон өөрийн эдийн засаг нийгмийн тогтолцоог чөлөөтэй сонгох зэрэг юм.

Бүс нутгийн аюулгүй байдлын үнэлгээ[782]

Бүс нутгийн аюулгүй байдлын үнэлгээ сэдэвт энэхүү хэсгээр Монгол Улсын гадаад аюулгүй байдал үнэхээр хангагдсан уу гэдэг асуудлыг хөндөн тавьсан юм. Өнөөдөр Монгол Улсад гадаад улсаас аюулгүй байдалд нь нөлөөлөх шууд занал байхгүй байна, улс төр, эдийн засгийн даяаршлын улмаас дэлхий "хавтгай" болж байгаа учраас цэргийн хүчин зүйл ач холбогдлоо алдаж байна гэх мэт хандлага түгээмэл байгаа билээ. Гэтэл үнэхээр тийм үү гэдэгт тодорхой хариулт өгөх шаардлагатай юм. Энэ

[782] Профессор Ц. Ганболд, докторант О. Машбат нарын илтгэл

асуудалд хариулт өгөх олон хариулт байж болох авч энэ илтгэлийн хүрээнд манай улсыг тойрон байгаа бүс нутгийн улсуудын дотоод тогтвортой байдал хэр хангагдаж байгааг "Эмзэг байдлын индекс /ЭБИ/"-ийг ашиглан тоочих замаар Монгол Улсын оршин буй бүс нутгийн тогтвортой байдлын дүр төрхийг үзүүлэхээр оролдсон юм. *Эмзэг байдлын индексийг* Жорж масоны их сургуулийн Даяар бодлогын хүрээлэнгийн судлаач Монти Ж. Маршалл, Жак Голдстон нарын боловсруулжээ. Хожим НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрөөс захиалан, Германы хөгжлийн хүрээлэн энэ асуудлаар арга зүйн зөвлөмж боловсруулсан байна. Одоогоор энэ индекс улсын дотоод асуудал аюулгүй байдалд нь хэрхэн нөлөөлөх вэ гэдгийг тоон судалгааны аргаар гаргасан цорын ганц үнэлгээ юм. ЭБИ бол тухайн улсын дотоод тогтвортой байдлын индекс бөгөөд үүнд улс хоорондын харилцааг тооцдогүй болохыг дурдах хэрэгтэй. *Аюулгүй байдал судлал* ихэвчлэн олон улсын харилцааны эсрэгцсэн боловч тулгуур хоёр онол реалист, либерал хоёр онол дээр үндэслэн, улс хоорондын харилцаанд ач холбогдол өгдөг онцлогтой. Тиймээс ЭБИ нь тухайн улсын аюулгүй байдлыг бүхэлд нь тодорхойлоход төдийлөн тустай биш хэмээн шүүмжилж болох юм. Хүйтэн дайны үеийн хоёр туйлт ертөнц нуран унаснаас хойш, дэлхий дахинаа олон талтай өөрчлөлт гарч, нэг талаас АНУ-ын ноёрхол бэхжих мэт, нөгөө талаас даяаршлын нөлөөгөөр дэлхий даяар өрнөн буй үйл явцыг нэг гүрэн дангаараа хянах боломжгүй болж байна. Үүний үр дүнд, улс хоорондын мөргөлдөөн гарахаас илүү, аль нэг улсын доторх тогтворгүй байдал эдийн засаг, улс төрийн харилцаагаар дамжиж, бусад улсад халдварлан, нийт бүс нутгийн хэмжээний асуудал болон дэврэх эрсдэл илүү өндөр болж байна. Иймээс энэ улс орон бүрийн ЭБИ-г шинжлэх нь багагүй ач холбогдолтой билээ. Энэ хүрээнд эхлээд хоёр хөрш орны ЭБИ-г, дараа нь хөрш бүс нутгийн орнуудын төлөөлөл болгож, Төв Азиас Казахстаныг, Зүүн хойд Азиас Хойд Солонгосын ЭБИ-г танилцуулж, эцэст нь товч дүгнэлт хийнэ.

Хөрш орнууд

Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдалд хөрш хоёр гүрэн, тэдгээрийн дотоод байдал шууд нөлөөлдөг. Тиймээс хөрш орнуудын тогтвортой байдлыг ЭБИ хэрхэн үзэж байгааг сонирхъё.

БНХАУ: Авторитар дэглэм, эдийн засгийн өсөлт, угсаатны мөргөлдөөн

БНХАУ-ын тогтворгүй байдал "үргэлжилсэн" хэвээр байна. "Үргэлжилсэн" гэдэг нь энэ улсад тогтворгүй байдал үүсэх өндөр боломжтой байсаар ирснийг Зураг 1-ээс ажиглаж болно. Тэр бүү хэл ҮНБ нь жилийн 10% өсч байгаа сүүлийн жилүүдэд ч ЭБИ нь дорвитой өөрчлөлт гараагүйг олон жилийн дундаж нь төдийлөн өсөөгүй байгаагаас харж болно.



Зураг 1 Үүний шалтгааныг юун түрүүнд БНХАУ дахь коммунист тоталитарь, авторитар дэглэмтэй холбон үзэж болно. Зураг 1-ээс үзвэл, Дэн Сяопингийн бодлогын үрээр Мао Зедунгийн "хувьсгалт" тоталитарь дэглэм авторитар болон солигдох үед ЭБИ харьцангуй дээшилсэн харагдаж байна. Гэвч 1990 оноос хойш өдийг хүртэл зарчмын сайжрал ажигдахгүй байна. 2008 оны ЭБИ-г үзвэл 25 оноогоор дүгнэдэг ЭБИ-д Хятад 9 оноотой буюу харьцангуй тогтвортой гэсэн үнэлгээтэй байна. БНХАУ-ын нийгмийн бодлогын үр ашиг, легитимсэл, аюулгүйн хүчний үр ашиг өндөр байгаа ч, эдийн засаг, улс төрийн бодлогын үр дүн, легитимсэл сул хэмээн дүгнэсэн байна. БНХАУ-ын улс төр гол хүчин Хятадын коммунист нам /ХКН/-ын легитимсэл эдүгээ зөвхөн эдийн засгийн эрчимтэй өсөлтөд тулгуурлаж байна. Гэхдээ эдийн засгийн бүтэц нь туйлын гаж, цөөн хэдэн мужийн эрчимтэй өсөлтөд дулдуйддаг. 2008 оноос эхэлсэн эдийн засгийн даяар хямралд Хятадын эдийн засагт нөлөөлж, нийгмийн бухимдлыг өдөөж, 2009 оны 7 сард гарсан Шинжаан дахь угсаатан хоорондын мөргөлдөөнд хүргэсэн гэж үздэг. БНХАУ олон угсаатны улс бөгөөд олонхи болсон хятад угсаатан, цөөнх болсон бусад угсаатантайгаа төдийлөн эв түнжин сайтай байдаггүй. Нийт хүн амын 90% нь хятад угсаатан бөгөөд үндэсний цөөнхийн уламжлалт нутаг руугаа суурьшиж эхэлсэн нь уугуул угсаатных нь дургүйцлийг өдөөж байна. 2008 онд Түвдэд, 2009 онд Шинжаанд угсаатан хоорондын мөргөлдөөн гарлаа. Ийм мөргөлдөөний давтамж олширч, эрчим нь нэмэгдэж байгаа нь тус улсыг тогтворгүй болгох үндсэн хүчин зүйл болжээ. Үүний эсрэг тулгарсан үед хэрэглэхээр цэрэг, цагдаагийнхаа хүчийг бэхжүүлж, алсад нь эдийн засгийн хөгжлийн үр шимийг хүртээх бодлого Бээжин барьж байгаа нь одоогоор үр дүнтэй хэвээр байна.

ОХУ:

Дотоодын дайн, терроризм, мафижсан эдийн засаг ОХУ-ын ЭБИ-ийн олон жилийн дунджийг харвал ЗСБНХУ-ын үед ихээхэн доогуур байсан боловч ОХУ байгуулагдаад сайжирсан хандлага байна. Шинэ Орос Улсын эхний хэдэн жил, тухайлан 1995-2000 оныг хүртэл харьцангуй тогтворгүй,

2000 оноос харьцангуй тогтвортой байсан боловч сүүлийн жилүүдэд эргээд 1995-2000 оныхоо түвшинд хүрчээ. /Зураг 2/.



Зураг 2 2008 оны ЭБИ-г үзвэл ОХУ-ыг улс төр нь тогтвортой, гэхдээ аюулгүйн хүчний үйл ажиллагаа нь үр ашигтай, легитим шинжтэй байна. Үүнийг дотооддоо Чечень зэрэг газруудад дайнтай, дотоодын терроризм их зэргээр тайлбарлаж болох юм. Эдийн засаг нь үр ашигтай боловч легитим шинжтэй гэж үнэлсэн нь мафижсан эдийн засагт нь өгсөн дүн бололтой. Түүнээс гадна, 2008 оноос ОХУ-ын гадаад бодлого түрэмгий шинжтэй боллоо гэж олон судлаачид үздэг. ОХУ-ын аюулгүй байдал, гадаад бодлого, цэргийн шинэ номолд дайн хийх, цэрэг хөдөлгөх босгыг намсгаж, мөн цөмийн зэвсэг хэрэглэх боломжийг өндөр тавьжээ. Бодлогын ийм өөрчлөлтийн зэрэгцээ 2008 онд Гүржийн эсрэг хийсэн дайн олон улсын хамтын нийгэмлэгийн эмзэглэлийг улам бүр хөндөж байгаа юм.

Хөрш бүс нутаг

Монгол Улс хоёр том гүрний дунд төдийгүй, хоёр том бүс нутгийн завсар оршдог онцлогтой. Төв Ази, Зүүн хойд Азид өрнөн бүй зарим үйл явц манай улсад дам, шууд ямар ч байдлаар нөлөөлөх бололцоотой юм. Энэ судалгааны хүрээнд хоёр бүс нутагт орох бүх улсын ЭБИ-г авч үзэх бололцоогүй тул төлөөлөл болгон манайдаа хамгийн ойр байгаа хоёр улсын ЭБИ-г авч үзлээ.

Зүүн хойд Азийн аюулгүй байдал, ойлголтын асуудал

Хүйтэн дайн дуусаад олон жил өнгөрч байгаа хэдий ч Зүүн хойд Азийн бүс нутаг, тухайлбал, Япон Улс, Өмнөд ба Хойд Солонгос, БНХАУ, Тайван, ОХУ болон Монгол Улсын хамаарч буй уг бүс нь улс төрийн болон эдийн засгийн ихээхэн холбоотой бүс хэдий ч бас дэлхий дахинаа хамгийн "цэрэгжсэн" /"милитаризированный"/ бүс хэвээр үлдэж байна. Япон Улсын нутаг дэвсгэр дээр байгаа америкийн цэргийн хүчнээс гадна /ойролцоогоор 47 000/ энэ бүсэд маш их хэмжээний зэвсэгт хүчнийхэн байрлаж байгаа нь дээрхи санааг бататгаж байна. Тухайлбал, Өмнөд Солонгост - ойролцоогоор 38 000, БНХАУ-ын цэргийн хүч 1 600 000, Японд – 148 000, Оросд /зөвхөн Алс Дорнодод/ - 110 000, Өмнөд Солонгост – 588 000, Хойд Солонгост-1 000

000 болон Тайванд – 270 000 хүн байна. Энэхүү судалгааны ажлын зорилго нь дээрх нөхцөл байдлыг харуулах тедийгүй Зүүн хойд Ази дахь аюулгүй байдлын олон улсын асуудлын онцлогыг тодорхойлоход оршино.

Өнөөгийн Зүүн Хойд Азийн нөхцөл байдал нь олон улсын нөхцөл байдлаас ихээхэн шалтгаалж байгаа бөгөөд дэлхийн эдийн засгийн хямрал, Хойд Солонгос цөмийн асуудал тус бүс нутагт ихээхэн нөлөөлж байна.

Б.Обамагийн засаг захиргаа Зүүн Хойд Ази дахь гадаад бодлогодоо шинийг эрэлхийлж, шинэ эргэлтийг авчрах бус, харин ч бүгд найрамдахчуудын бодлогын залгамж чанарыг хадгалах хандлагатай байгаа нь ажиглагдаж байна. БНХАУ-тай харилцах харилцаанд Б.Обамагийн засаг захиргаа Бүгд Найрамдахчуудын адилаар өнөөгийн АНУ-ын гадаад бодлогод түгээмэл болоод байгаа татан оруулах эсхүл тогтоон барих гэсэн чиг шугамыг хослуулан баримталж байна.

Харин Зүүн хойд Ази нь АНУ, Хятадын аль альных нь ашиг сонирхлын чухал бус нутаг учраас олон улсын харилцаанд ихээхэн ач холбогдолтой бүс нутаг юм. Ялангуяа Зүүн хойд Ази нь дэлхийн том гүрнүүд болох ОХУ, БНХАУ, АНУ, Япон зэрэг улсуудын геополитикийн сонирхлын мөргөлдөөн болон нийлэмжийн талбар болдгоороо сонирхол татахуйц. Гэсэн хэдий ч Зүүн хойд Азийн энх тайван, аюулгүй байдал нь тедийлөн тогтвортой бус тедийгүй, энэ бүс нутагт ямар нэгэн цэрэг, улс төрийн ауюлгүй байдлын нэгдмэл хамтын ажиллагаа, тодорхой институц хараахан бий болоогүй байна. Харин Зүүн хойд Азид аюулгүй байдлын систем бий болгох үйл явцыг Европын холбоотой харилцан жиших үзэх нь зүйтэй юм.

Ихэнх Европчууд ЕАБХАБ-ын туршлага дээр үндэслэн Зүүн хойд Азийн аюулгүй байдлыг авч хэлэлцэж болно гэж үздэг. Уг механизмын зорилт нь эхний ээлжид зургаан талт хэлэлцээрийн гол асуудал болох цөмийн зэвсгийг зогсоох, нөгөө талаар Хойд Солонгос-АНУ, Хойд Солонгос –Японы хоёр талын харилцааг бэхжүүлэх, Солонгосын Хойгт энх тайван байдлыг тогтооход чиглэх нь зүйтэй. Ингэхдээ:

1.Цэрэг улс төрийн /цэргийн маргааныг таслан зогсоох итгэлтэй байдлыг бий болгох/

2.Эдийн засгийн /Эрчим хүч, дэд бүтэц, экологийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэх/

3.Хүмүүнлэгийн /хүний эрх, ардчилал гэх зэрэг асуудлуудад анхаарах/[783].

Мэдээжийн хэрэг, ЕАБХАБ-ын зарим ажиллагаа Зүүн хойд Азийн энх тайван аюулгүй байдлын механизмд хэрэглэж болох боловч ерөнхийдөө ямар нэгэн улс төрийн байдалд хуучин загварыг тогтоох, хиймэл оролдлого хийх нь үр дүнгүй бөгөөд цаашилбал хөнөөлтэй байж болзошгүй юм.

Уг бүс нутагт Баруун Европын туршлагыг ашиглах нь таарамжтай юу? үгүй юу? гэдэг нь маш эргэлзээтэй асуудал бөгөөд Европ болон Зүүн Азийн хувьд томоохон ялгаануд байсаар байгаа. Дэлхийн II дайны уршигт ул мөр болон дайсагналцсан харьцаагаа бүрэн даван туулж чадсан дэлхийн эдийн

[783] А.В.Воронцов "Зүүн хойд Азийн ауюлгүй байдлын өнөөгийн байдал, Орос-Хятад-Монголын хамтын ажиллагааны хэтийн төлөв" нийтлэл, "Стратеги судлал" сэтгүүл, №47 3/2009.

засгийн тэргүүлэгч орнууд болох Франц, Герман улсууд аажимдаа европын холбоог байгуулахад түлхэц болсон. Харин Зүүн хойд Азид байдал бүр эсрэгээр байна. Эдийн засгийн гол хүчтэй орнууд болох Япон, БНХАУ-ын улс төрийн харилцаа түүхийн ул мөрөөс болж сүүлийн жилүүдэд хүндрэлтэй байгаа бөгөөд одоог хүртэл сайн эвлэрч чаадахгүй байна. Бүс нутагт уг хоёр орны манлайлагч болох гэсэн тэмцэл илт явагдаж байна. Бас нэгэн шалтгаан нь хоёр Солонгос одоог хүртэл дайсагналцсан байдалтай байгаа нь бүс нутгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй байгаа юм.

Европын Холбоо нь уур амьсгалын өөрчлөлт, санхүүгийн хямралтай тэмцэхэд гол анхаарлаа хандуулж, АНУ-тай "эрх тэгш хамтран ажиллах" байр суурийг эрэлхийлж байна. Баруун Ази руу хүчтэй түрж, Ази-Европын дэзд хэмжээний чуулганаар дамжуулан Ази, номхон далай руу үйл ажиллагааны хүрээгээ улам тэлж байна. Их Британи нь Америк загварын Үндэсний Аюулгүй байдлын зөвлөл байгуулж, аюулгүй байдлын шинэ стратегиа хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд терроризм, уур амьсгалын өөрчлөлт, өвчин, ядуурал зэрэгтэй голлон тэмцэж, "даяаршлын төлөөх их гүрний хариуцлага"-аа нэмэгдүүлэн, улмаар өөр хоорондоо нягт хамтран ажиллах нэг зорилготой хамтын нийгэмлэгийг байгуулахыг зорьж байна. Франц улс ЕХ, НАТО-г аюулгүй байдлынхаа суурь дэвсгэр хэмээн үзэж буй бөгөөд ЕХ-ны интеграцыг урагшлуулах замаар цаашид олон улсын тавцанд гол дүрд тоглохыг эрмэлзэж байна. Франц батлан хамгаалах бодлогодоо 1994 оноос хойш хамгийн том зохицуулалт хийж, сансар судлалыг цэргийн шинэчлэлтээ урагшлуулах гол хүчин зүйл болгож, 2020 он гэхэд 377 тэрбум еврог цэргийн шинэчлэлдээ зориулахаар шийдвэрлэжээ. Франц нь АНУ-тай харилцаагаа сайжруулж, одоогийн олон улсын олон талт бүтцийн шинэчлэлийг урагшлуулахаар чармайж байна. Мөн Хятад, Орос, Энэтхэг зэрэг улстай гадаад харилцаагаа бэхжүүлэхийг эрмэлзэж байна.

БНХАУ нь эргэн тойрны хөрш, зэргэлдээ орнуудтай найрамдалт харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлж, улс орныхоо хөгжил, тогтвортой байдлыг ханган орчин үеийн зэвсэг, байлдааны техник бүхий зэвсэгт хүчинтэй, дэлхийн хүчирхэг гүрэн болохыг зорьж байна. Мөн дэлхийн санхүүгийн хямралыг даван туулахад гол үүрэг гүйцэтгэхийг эрмэлзэж, өөрийн "олон улсын хариуцлага", нэр хүндээ тасралтгүй нэмэгдүүлэхэд анхаарч байна.

Их гүрнүүд стратегийн бодлогодоо цаашид ч зохицуулалт хийснээр, олон улсын болон их гүрнүүдийн харилцаанд хоёр чиг хандлага давамгайлах төлөв ажиглагдаж байна.

Нэгдүгээрт, АНУ зэрэг хөгжингүй орнуудын эдийн засаг нь шинээр сэргэж буй орнуудыг улам бүр түшиглэх болов. Шинээр сэргэж буй орнуудын олон улсын тавцанд эзлэх байр суурь өдрөөс өдөрт нэмэгдэхийн хэрээр, ялангуяа санхүүгийн хямрлын дараа нөлөө илэрхий өссөнөөр хөгжингүй орнуудын гадаад стратегийн бодлого нь шинээр сэргэж буй орнууд руу чиглэх нийтлэг хандлага ажиглагдаж, олон улсын санхүүгийн тогтолцооны шинэчлэлт зэрэг гол чухал асуудал дээр шинээр сэргэж буй орнуудыг түшиглэх, татан оролцуулах байдал илэрхий нэмэгдэв.

Хоёрдугаарт, их гүрнүүдийн хоорондын харилцааны шинж байдал улам эздрээтэй болов. Шууд сөргөлдөх аюул багассан бөгөөд түншлэх хийгээд сөргөлдөх харилцааны зааг хязгаар улам бүдгэрсээр, хуваагдах, нийлэх нь улам эрчимжиж, хамтын ажиллагаа нь далд өрсөлдөөний шинжийг агуулж, олон талт зохицуулалт илэрхий шаардагдах болов. Тухайлбал, АНУ, Орос хоёр Гүржийн болон пуужингийн довтолгооноос эсэргүүцэн хамгаалах системийн асуудлаар сөргөлдөж байгаа ч, сансрын болон цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна. ЕХ олон улсын болон бүс нутгийн хэрэг явдал дээр АНУ-тай өрсөлдөхийн зэрэгцээ Барак Обамаагийн Засгийн газарт Атлант дамнасан хамтын ажиллагаа хөгжүүлэх талаар байр суурыа удаа дараа илэрхийлж, АНУ-ын бодлогын зохицуулалтад ихээхэн найдвар тавьж байна. Энэтхэг нэг талаар бусад их гүрнүүдтэй хамтран Хятадын тэлэлтийг хязгаэрлах бодлого баримталж байгаа ч, нөгөө талаар Энэтхэг, Хятадын бүх талын харилцаа, хамтын ажиллагааг тогтвортой урагшлуулж байна.

Ийнхүү үйл явдал өрнөж даяаршлын явцыг дагаад олон улсын харилцан хамаарал гүнзгийрч, олон туйлт явц хөгжих хандлагатай байгаа нь их гүрнүүдийн хоорондын зөрчлийг лавшруулахгүйгээр олон улсын аюулгүй байдлыг тогтвортой байлган, хянаж болохуйц нөхцөл рүү эргүүлж байна гэж хэлэх үндэстэй.

Нөгөө талаас энэхүү бүс нутаг дахь хамтын ажиллагааны хүрээ өдөр ирэх тусам өссөөр байна. Нийгэм, эдийн засаг, худалдаа зэрэг бүхий л салбарт хамтран ажиллаж буй тухайн бүс нутгийн улс орнууд аюулгүй байдлыг тогтвортой байдлыг хангахын эрмэлзэж байна. Энэ зорилгоор худалдаа, эдийн засгийн болон хамтын ажиллагааны байгууллагууд байгуулагдаж эхэлсэн. Тухайлбал, АПЕК буюу Ази-Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны Форум. АПЕК-ийн түүхээс зурвасхан дурьдвал, АПЕК нь Ази-Номхон далайн бvс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хvрээнд өрнөж буй сурталчилгаа интеграцын цогцолбор vйл явц юм. АПЕК-ийг бий болгох санаачлагыг Австрали Улс анх 1989 оны эхээр дэвшvvлсэн. 1989 оны 11 дvгээр сард Австралийн нийслэл Канберрад энэ бvс нутгийн 12 орны гадаад хэргийн болон гадаад худалдаа, эдийн засгийн сайд нарын хуралдааныг зохион байгуулснаар АПЕК-ийн эхлэл тавигдсан. АПЕК нь бодлого vйл ажиллагааныхаа хvрээг улам бvр тэлж, эдvгээ Ази-номхон далайн бvс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны нөлөө бvхий vйл явц болж хувираад байна.

АПЕК нь бүс нутгийн орнуудын өсөн нэмэгдэж байгаа хамтын ажиллагаа, эдийн засгийн тvргэн өсөлтийг худалдаа, хөрөнгө оруулалтын либералчлалын аргаар баталгаажуулах зорилготой vйл явц юм. Ингэхдээ Дэлхийн Худалдааны Байгууллагын худалдааны олон талт тогтолцоог бэхжvvлэх, тvvнийг дэмжих асуудлыг эн тэргvvнд vзэж, гишvvн эдийн засгуудын өөрийн vйл ажиллагааны төлөвлөгөөг хөхиvлэн дэмжихийг зорьдог. Харилцан бие биенээ хvндэтгэж, эрх тэгш байдлыг хангах, харилцан ашигтай байх, харилцан туслах, бvтээлч, шудрага тvншлэлийг эрхэмлэх, консенсусын зарчмыг баримтладаг байна.

АПЕК-ийн үйл ажиллагаа нь дараахь үндсэн тулгууртай :

- **Либералчлал:** Энд тариф, тарифын бус арга хэмжээ, үйлчилгээ, оюуны өмчийн эрх зэрэг чиглэлээр ДХБ-тай нийцсэн либералчлалын бодлого хамаарна.
- **Бизнесийн орчны хөнгөвчлөл:** Энэ нь либералчлалыг хөнгөвчлөх зорилготой байх бөгөөд бизнес хийх өртгийг багасгахад чиглэгдсэн байна: стандартуудыг нийцүүлэх, гаалийн горим, журмыг сайжруулах, мэдээллийг ил тод хүртээлтэй болгох, бизнес аялалыг хялбаршуулах, бүс нутгийн мэдээллийн сангууд байгуулах г.м. Эдийн засаг, техникийн хамтын ажиллагаа: Энэ нь худалдаа, хөрөнгө оруулалтыг сайжруулах үндэсний чадавхийг сайжруулах зорилготой. Энэ хамтын ажиллагаа салбарын ажлын хэсгүүдээр дамжин явагддаг.

АПЕК-ийн нэг том зорилт нь тус бүс нутгийн хөгжингүй орнуудыг 2010 он гэхэд, хөгжиж буй орнуудыг 2020 он гэхэд чөлөөт болон нээлттэй худалдаа, хөрөнгө оруулалтын тогтолцоонд тус тус шилжүүлэх явдал юм.

Өнөөгийн байдлаар Австрали, Бруней, Канад, Чили, БНХАУ, Хонг-Конг, Индонез, Япон, БНСУ, Малайз, Мексик, Шинэ Зеланд, Папуа Шинэ Гвиней, Филлипин, Сингапур, Тайвань, Тайланд, АНУ, ОХУ, Перу, Вьетнам зэрэг эдийн засгууд АПЕК-ийн гишүүнээр элсээд байна.

Шинэ гишүүдийн шалгуурын тухай: 1997 оны 11 дүгээр сард Канадын Ванкуверт болсон АПЕК-ийн сайд нар болон удирдагчдын уулзалтаар шинэ гишүүн элсүүлэх шалгуурыг тогтоосон.

Үүнд:

1. Ази-номхон далайн бүс нутагт байрласан байх,
2. Бүс нутагтай өргөн хэмжээний худалдаа-эдийн засгийн харилцаатай байх,
3. Зах зээлийн эдийн засгийг эрхэмлэдэг байх,
4. АПЕК-ийн зорилго, зарчмыг хүлээн зөвшөөрсөн
5. Худалдаа, хөрөнгө оруулалтын либералчлалын чиглэлээр орон тус бүр өөрийн үйл ажиллагааныхаа төлөвлөгөө гаргасан байх.

Шанхайн хамтын ажиллагааны байгууллага

ШХАБ нь өөрийн дүрэм, тодорхой бүтэцтэй, олон талт үйл ажиллагаа явуулдаг байнгын ажиллагаатай, бүс нутгийн олон улсын байгууллага юм. НҮБ-ын Ерөнхий Ассемблейн дэргэд ажиглагчийн статустай. "Шанхайн 5" нэртэйгээр анх 1996 онд үүсч, үйл ажиллагаагаа өргөжүүлэн, 2001 онд Узбекстан тус байгууллагад элсэн орсноор нэрээ "Шанхайн хамтын ажиллагааны байгууллага" нэртэй болсон. Төв Азид орших Казахстан, Киргизстан, Орос, Хятад, Тажикстан, Узбекстан улс тус байгууллагын гишүүн орнууд бөгөөд Ажиглагч орнуудын статусыг Монгол Улс, Энэтхэг, Иран, Пакистан улсуудад, "Яриа хэлэлцээрийн түнш"-ийн статусыг Беларусь, Шри-Ланка улсуудад олгосон байдаг. "Шанхайн тунхаглал"-д тус байгууллагын үндсэн зорилгыг "Төв Ази дахь энх тайван, аюулгүй байдлыг хангах, бэхжүүлэх, тогтвортой байлгах, түүнчлэн улс төр, худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техник, соёл боловсрол, эрчим хүч, тээвэр,

экологийн болон бусад салбарт хамтын ажиллагаагаа хөгжүүлэх явдал" гэж тодорхойлсон байдаг.

ШХАБ-ын үндсэн баримт бичгүүдийн нэг болох "ШХАБ-ын гишүүн орнуудын урт хугацааны сайн хөршийн найрамдалт харилцаа ба хамтын ажиллагааны тухай гэрээ" нь тус байгууллагын эрх зүйн орчин бүрдэхэд чухал алхам болж, олон талт үйл ажиллагааг чанарын шинэ шатанд гаргах урьдчилсан, суурь нөхцөлийг бүрдүүлсэн гэж үзэж болно.

ШХАБ-ын бүтцэд түүний үндсэн зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий үндсэн 7 байгууллага ажиллах ба түүний 2 нь байнгын ажиллагаатай. Дээд байгууллага нь тус байгууллагын гишүүн орнуудын төрийн тэргүүн нарын Зөвлөл бөгөөд жилд 1 удаа хуралддаг. Байгууллагын шийдвэр гаргах хэлбэр консенсус юм. Зөвлөлийн хуралдааны үр дүнгээр "Хамтарсан мэдэгдэл", "Тунхаглал" гаргадаг[784].

Зүүн хойд Ази гэдэг бүс нутгийн хил хязгаар нь яг ямар газар нутгийг хамрах талаар дэлхийд нэгдсэн ойлголт бий болоогүй байна. Энэ бол 1990-ээд онд бий болсон геополитикийн бүсчлэлийн ойлголт, харин одоо XXI зууны эхний 10 жил өнгөрөх дөхөж буй үед бол хамтын ажиллагаа, интеграцийн тухай ярихад нэгэнтээ оройтсон гэж үздэг.

Зүүн хойд Азийг ялимгүй урагшлуулаад Зүүн өмнөд Азитай харьцуулах аваас үндсэндээ интеграцчлагдах үйл явц эхлээгүй, тусдаа эхлэх төлөв ажиглагдахгүй явсаар АСЕАН-аар хөдөлгөх хүчээ хийсэн Зүүн Азийн хамтын нийгэмлэг төлөвшиж эхэлжээ. Геоэкономик талаасаа Япон, Өмнөд Солонгос, Хятад нь АСЕАН руу илүү анхаарлаа төвлөрүүлдэг. Интеграцчлагдах үйл явцын үндсийг тавих учиртай эхэлсэн Түмэн голын хөтөлбөр ажил хэрэг болох нь нэг хэсэгтээ өнгөрлөө. АНУ, Япон төдийлэн идэвхи гаргахгүй явж ирсэн ба БНАСАУ-ын зүгээс хүсэл дутлаа. Солонгосын хойгийн асуудал бүхэлдээ шийдэгдэхээс нааш энэхүү чиглэлд нааштай төлөв байхгүй.

Аюулгүй байдлын асуудлаар ТББ-ын шугамаар хийдэг яриа хэлцээ ч сүүлийн үед саармагжин, Зүүн хойд Азийн хамтын ажиллагааны яриа хэлэлцээ /The Northeast Asia Cooperation Dialogue/ үр нөлөөгүй идэвх нь сулрах хандлагатай байна. Манай оршин буй Ази тив, мөн Номхон далайн бүс нутагт бүс нутгийн, бүс нутаг хоорондын, олон улсын, салбар бүс нутгийн олон талт үйл явц, институци, дэглэм, байгууллага, форумын тоо 320-иос давж гарсан нь глобал хувьслын геополитикийн сонгодог жишээ мөн байтал Зүүн хойд Ази руу чиглэсэн олон талт механизм ганцхан байгаа нь угаасаа энэ бүс нутагт олон талт хамтын ажиллагаа явцгүй байгааг илтгэдэг.

Зүүн хойд Азийн орнуудын улс төрийн байгууламж, үзэл суртлын ялгаа, хүйтэн дайнаас улбаатай харилцан бие биедээ үл итгэдэг явдал бүс нутагт маргааныг зохицуулах, хамтын ажиллагааг хөгжүүлэх Засгийн газар хоорондын ямар нэг институци бий болгох, чуулга уулзалт хийхэд гол саад тотгор болсоор байна[785].

Эдийн засгийн хамтын ажиллагаа гэвэл зөвхөн хоёр талын харилцаа голлосон, эсхүл гурван орны хооронд өргөн хүрээтэй биш тодорхой буюу

[784] Ч.Оюунчимэг "ШХАБ-ын гишүүн орнуудын эдийн засгийн хамтын ажиллагаа" нийтлэл, "Стратеги судлал" сэтгүүл, №48, 4/2009.

[785] Д.Баярхүү "Зүүн хойд Ази дахь олон талт үйл явц ба Монгол Улс" илтгэл, 2009 он.

явцуу ямар нэгэн асуудлыг хамарсан хөтөлбөр хэлбэртэй явгдахаас өөр гарц үгүй, тодорхой механизм бий болохгүй явсаар XXI зууны эхний 20 жилийг туулах нь гэж судлаачид үзэж байна. Гэхдээ гарцыг олж тогтоох нь чухал юм. Заримаас дурдвал:

- Зүүн хойд Азийн хамтын аюулгүй байдлын
- Зүүн хойд Еврази эдийн засгийн хамтын ажиллагааны
- Зүүн хойд Еврази соёлын гэхчлэн хамтын нийгэмлэгүүд
- "Азийн Хельсинк" буюу 1975 оны Хельсинкийн төгсгөлийн баримт бичгийн хувилбараар хүний эрх, эрх чөлөөний асуудлаар Пхеньяныг татан оруулах шинэхэн санал байгаа.

Зүүн хойд Азид аюулгүй байдал, хамтын ажиллагааны олон талт харилцаа бүрдэхгүй явсаар Зүүн Азийн хамтын нийгэмлэг төлөвшчихвөл түүнийг сөрөх буюу тэнцвэржүүлэх олон улсын холбоо, форумын сэдэж санаачлах хувилбар бас байна. Эртөнц дахины энх тайвны холбооноос

- "Азийн Хельсинк"
- Энх тайвны төлөө бүс нутгийн холбоо
- Номхон далайн холбоо /үндэслэгч нь Австрали, Шинэ Зеланд, гишүүдэд Микронези, Полинези, Меланезийн арлуудын бүх улс / байгуулах санал дэвшүүлжээ
- 2007 оны 4 дүгээр сард "4-ийн бүлэг" бий болж, Япон, АНУ, Австрали, Энэтхэгийн "Стратегийн яриа хэлэлцээ" хэмээх цэрэг-стратегийн шинэ механизм үүсч байна

НҮБ-ын дэргэд Иргэншил хоорондын холбоо /Alliance of Civilizations/ байгуулах тухай Испани, Туркийн санал ихээхэн дэмжлэг хүлээж, НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга түүний шинэ даргыг томилсноос үзвэл Зүүн Азийн хамтын нийгэмлэг, "Азийн Хельсинк", бүс нутгийн холбоодыг давуулсан олон талт хүчирхэг механизм үйлчилж эхлэх магадлал бас байна. Энэ нь Зүүн хойд Азид энх тайван, тогтвортой байдлыг хангах ойрын нэг боломж байж болох талтай.

Япон, АНУ, Австрали, Энэтхэгийн "Стратегийн яриа хэлэлцээ" хэмээх шинэ эвсэл XXI зуунд Зүүн хойд ба Зүүн Ази, Өмнөд Азид ихээхэн чухал үүрэгтэй тэнцвэржүүлэгч тоглогч байхыг үгүйсгэхгүй. Хятадыг тогтоон барих, Хятадыг бүслэх, Хятадаас учирч мэдэх элдэв цэрэг-аюулгүй байдлын эрсдлээс сэргийлэх тал дээр үүнээс өөр бодитой хүч байхгүй, бий болохгүй гэж судлаачид таамаглаж байна.

Зүүн хойд Азийн бүс нутгийн дэвсгэр дээр аюулгүй байдал талаасаа эрчим хүчний асуудал нь XXI зуунд эл бүс нутгийн аюулгүй байдлын динамикийг тодорхойлох, улс орнуудын хүчийг сорих нэг чухал хүчин зүйл байх бололтой. Үүнээс үүдэн эрчим хүчний аюулгүй байдлаа хангах, найдвартай эх үүсвэртэй байх асуудал эндхийн бодлогыг тодорхойлогч гүрнүүдийн үйл ажиллагаанд гарцаагүй тулгарна.

Ийм нөхцөлд Хятад Улс Орос, Казахстаны /магадгүй Монголын/ газрын тосны ордуудыг сонирхож, далайн тэвэрлэлт, түүний эрсдэлээс үл хамаарах хуурай газрын сувагтай байх, петро-геополитикийн нөөц холбоотонтой байх хэтийн бодлого хөрш зэргэлдээ бидэнд тулгарч магад. Ингэхэд Зүүн хойд

Азийн ирээдүйн энэ их өөрчлөлт дунд Монгол Улс ямар оролцоотой вэ? Зүүн хойд Азийн асуудлыг хэлэлцэж байх механизм бий болгох чиглэлээр тодорхой алхам хийх цаг болсон гэж үзэн Монгол Улс холбогдох саналыг /Аюулгүй байдлын асуудлаар Засгийн газрын түвшинд зөвлөлдөх яриа хэлэлцээний механизм/ НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 55 дугаар чуулганы /2000 он/ үеэр томъёолон дэвшүүлж, түүнийг урагшлуулахаар ажилласан, одоо ч энэ чармайлтаа орхиогүй. Энэ санал БНСУ, ОХУ, Япон, Канад зэрэг бүс нутгийн орнуудаас зохих дэмжлэг хүлээсэн боловч угаасаа эндхийн их, бага улс орнууд интеграцчилагдах нийтлэг байр суурьгүй, үзэл бодол, байр суурийн хэт зөрүүтэйн гайгаар энэ санал түүх болж үлдсэн гэгддэг. Гэхдээ манай улсын хувьд жижиг орны ашиг сонирхолыг хадгалах, урагшлуулах, хамгаалах, илэрхийлэх талбар хэмээн эл бүс нутгаа үзэж, газар зүйн онцгой өвөрмөц байршилтай гэж өөрийгөө товойлгож баймааж л бусдын анхаарлыг татдаг.

Шинэ зуунд Монгол улс ямар орон зайд багтах, хаашаа шахагдах, хэнтэй эвсэх, хэнийг дагах, гол нь бүс нутгийн ямар бүтэц, байгууллага, форумд очиж наалдан интеграцчилагдах гэхчлэн олон асуудалд хариу өгье гэвэл

- ✓ Шанхайн хамтын ажиллагааны байгууллага
- ✓ Орос — Хятад – Монголын
- ✓ "Гурвалсан яриа хэлэлцээ"-ний механизм
- ✓ Байгалийн эдийн засаг /БЭЗ/-ийн чуулга уулзалт
- ✓ "Сибирийн хэлэлцээр" бүс хоорондын нийгэмлэг
- ✓ ЕврАзЭс буюу Евразийн эдийн засгийн хамтын нийгэмлэг
- ✓ АСЕМ буюу Ази-Европын уулзалт
- ✓ Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага /ЭКО/
- ✓ Ирээдүй цаг дээр АПЕК буюу Ази-Номхон далайн эдийн
- ✓ Засгийн хамтын ажилагааны форум
- ✓ Зүүн Азийн Эдийн засгийн соёлын орон зай, АСЕАН
- ✓ шалгуурыг давж байж Зүүн Азийн хамтын нийгэмлэг
- ✓ Энх тайвны төлөө бүс нутгийн шинэ холбоо /New Regional Alliance for Peace/
- ✓ "Азийн Хельсинк"-т нэгдэх гэзэд маш олон сонголтын өмнө тулж ирэх нь байна.

ХОЁР. ЗҮҮН ХОЙД АЗИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА МОНГОЛ УЛС

Засгийн газар эргэлзэх эрхгүй. Нэг удаа замаа сонгосон бол хоёр тийшээ харалгүй, төгсгөл хүртэл явах болно.
Отто фон Бисмарк

Азийн аюулгүй байдлын асуудлуудыг дүгнэлт хийж үзэхэд ерөнхийдөө дараах гурван хандлага ажиглагдаж байна.

Нэгдүгээрт, XX зууны сүүлчээр гарч ирсэн даяаршлын үйл явц Азийн бараг бүх улс оронд эерэг, сөрөг нөлөө үзүүлж, аюулгүй байдлаа хангах бодлого, үйл ажиллагаандаа цоо шинээр хандахыг шаардаж байна.

Хоёрдугаарт, хэдийгээр улс төр, эдийн засгийн зорилготой боловч араасаа аюулгүй байдлын хамтын ажиллагааны агуулгыг дагуулсан бүсчлэл Ази тивд улам түргэн дэлгэрч байна.

Гуравдугаарт, улс хоорондын харилцаанд эдийн засгийн хүчин зүйлс голлож улмаар геополитикийн оронд геоэдийн засгийн асуудлуудад чухал ач холбогдол өгч байна.

Дээрх хандлагуудаас олон улсын харилцаанд энхийг эрхэмлэх, эдийн засгийн хамтын ажиллагааны өндөр түвшин харилцан хамаарлыг хангах, интеграцийг цаашид гүнзгийрүүлэх замаар Ази тивд аюулгүй байдлын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх олон улсын механизмыг бий болгох бололцоотой нь харагдаж байгаа юм.

Мөн улс орнууд аюулгүй байдалд нь сөргөөр нөлөөлж буй болон нөлөөлж болзошгүй уламжлалт буй аюулаас урьдчилан сэргийлэх, түүний эсрэг тэмцэх асуудлыг хамтран шийдвэрлэхэд анхаарлаа хандуулах шаардлага гарч ирж байна.

1990 он хүртэл Монгол Улс нь гадаад худалдаа, эдийн засгийн хувьд ЗХУ-аас шууд хараат байлаа. Тийм ч учраас ардчилсан сонголтын эхний жилүүдэд энэ хараат байдлаасаа гарах, зах зээлийн эдийн засгийн үндсийг тавих оролдлогоо хийж, эдийн засагтаа бүтцийн өөрчлөлт хийснээр нэлээд хүндрэл бэрхшээлийг даван туулсан.

Түүхэн богино энэ хугацаанд улс төрийн ардчилал чиг баримжаагаа олж, анхны ардчилсан Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжууд батлагдан, эрх зүйт төрт ёс бодит зүйл болсон.

Монгол Улс газар зүйн байрлалаараа Ази тивийн геостратегийн чухал түлхэц нутаг, их гүрнүүдийн геополитик, эдийн засаг, соёл иргэншлийн ашиг сонирхлын уулзвар, дэлхийн том шашнуудын нөлөөллийн зах нийлсэн зааг дээр оршдог.

Монгол Улсыг хүрээлсэн орон зайд "хүйтэн дайн"-аас хойш гарсан эрс өөрчлөлт, хөгжлийн цаашдын хандлага нь биднийг ирээдүйн хөгжил, аюулгүй байдлын асуудлаа Ази, Номхон далайн бүс нутаг, түүний дотор Зүүн Хойд Азийн хүрээнд АНУ-тай идэвхитэй түншлэх бодлогод тулгуурлан авч үзэхэд хүргэсэн.

Энэ нь Монгол Улсын шиг бага оронд хөгжлийн ирээдүйгээ дэлхий дахины нийтлэг хэв заншил, геостратегийн ашиг сонирхол, эдийн засгийн

ижил төстэй салбар бүс нутгийн хүрээнд авч үзэх нь зайлшгүй байдагтай холбоотой юм.

Монгол Улс Зүүн Хойд Азийн улс хоорондын харилцаанд оруулах хувь нэмэр нь зөвхөн эдийн засгийн төдийгүй, улс төр, аюулгүй байдлын ач холбогдолтой байж болох юм. Өнөөдөр Монгол Улс нээлттэй, эвсэлд үл нэгдэх, олон тулгуурт гадаад бодлого явуулж байна. Энэхүү бодлогын тэргүүлэх чиглэл нь хөрш хоёр оронтойгоо буюу ОХУ, БНХАУ-тай тэнцвэртэй харилцах явдал юм. Эдгээр улс оронтой аль алинтай нь сайн хөршийн найрсаг харилцаа хөгжүүлж байгааг НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас удаа дараа сайшаан дэмжиж, түүнийг бүс нутгийн энх тайван, аюулгүй, тогтвортой байдлыг хангахад чухал хүчин зүйл болж байна гэж үнэлж байгаа болно. Монгол Улсыг цөмийн зэвсэггүй статусаа эрх зүйн бат үндэстэй болгох замаар төвийг сахисан байдлаа олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрүүлэхээр чармайн ажиллаж байгаа билээ.

Зүүн Хойд Азид бүс нутгийн аюулгүй байдлын асуудлаар Засгийн газрын түвшинд яриа хэлэлцээрийн механизмыг бий болгох саналыг Монгол Улс НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганы индрээс 2000 онд дэвшүүлсэн бөгөөд тийм механизмын талаар олон санал гарч, яриа өрнөж, үүндээ Монголын санаачлагыг том гүрнүүдийн зүгээс дэмжиж байгаа билээ.

Монгол Улсын аюулгүй байдлын бодлогод Ази тивд олон улсын байдлыг тогтвортой болгох хамтын ажиллагааны хүрээнд өөрийн үндэсний аюулгүй байдлыг хангах эрмэлзлэл чухал байр суурийг эзлэж байна. Энэ тивд терроризм гарах, тархах нөхцөлийг хаах, зэвсэглэлээр хөөцөлдөхийг эцэс болгох, улс орнуудын зэвсэгт хүчнүүдийн өсөлтийн дээд хязгаарыг тогтоох, бусад улсад цэргийн баазаа байгуулах явдлыг зогсоох, ийм баазуудыг аажимдаа үгүй болгох зэргийг манай улс тууштай дэмждэг. Монгол шиг жижиг орон өөрийн гадаад аюулгүй байдлыг зэр зэвсэг, зэвсэгт хүчинд тулгуурлаж, холбоотны хүчинд дулдуйдаж биш, харин өөрийн язгуур ашиг сонирхолыг хөрш зэргэлдээ болон бусад орны ашиг сонирхолтой нягт уялдуулан зохицуулах замаар баталгаажуулах талаар тодорхой алхмуудыг хийж, энэ чиглэлээрээ олон улсын хамтын нийгэмлэгийн дэмжлэгийг хүлээж болохыг харууж байна.

Монгол Улс аюулгүй орших нь Орос, Хятадын харилцааны байдал, төлвөөс шууд хамааралтай байна. Орос, Хятадын стратегийн түншлэлийн суурь хүчин зүйлс хэврэг байх талтай ч олон улсын тавцан дээрх өнөөгийн хүчний тэнцвэр энэ түншлэлийг тодорхойлох хугацаанд хадгалаж, урагшлуулах шалтгаан болсоор байна.

Орос, Хятадын харилцааны агуулга, тэдний хэрэгжүүлж буй харилцан уялдсан бодлого, үйл ажиллагааг анхааралтай ажиглаваас хоёр хөрш маань Америк дэлхийн тэргүүлэх гүрэн байхыг хүлээн зөвшөөрөхгүй хийгээд өөрсдийнх нь нөлөөллийн бүс Төв Азид Америкийн сонирхол хэт төвлөрөх, ялангуяа Монголд Америкийн нөлөө хэт нэмэгдэх нь тэдний аюулгүй байдлын эрх ашигт үл нийцэнэ гэж үздэг нь тодорхой. Тиймээс Америкийн эсрэг чиглэсэн хамтын ажиллагаагаа хөгжүүлэх талаар хүчин чармайлт тавих нь зайлшгүй.

Хэрвээ Орос, Хятадын стратегийн түншлэл манай "гуравдахь хөршийн" нэг АНУ-ын эсрэг чиглэвэл энэ нь зөвхөн Орос, Хятадын хооронд хавчуулсан аюулгүй байдлын хязгаарлагдсан орчинтой МУ-ын тухайд томоохон сорилт болно. Геополитиккийн үүднээс авч үзвэл дэлхийд Монгол шиг хоёр их гурний дунд орших өвөрмөц газар зүйн байрлалтай орон ховор. Хоёр хөрш болох Орос ба Хятад нь Монголоос газар нутгийн хэмжээ, хүн амын тоо болон ждийн засгийн чадавхаараа хэдэн арав дахин том гүрнүүд юм. Олон зуун жилийн турш геодолиткийнхаа хүрээг ямагт тэлж мрсэн дэлхий дахинд нөлөө бүхий хоёр эл гүрэн далайд гарцгүй, дотоод хүчин чадал сул, дорой Монголчууд бидний түүх, соёл зан заншил, хөгжил дэвшлийн бүхий л хүрээнд олон талаараа шууд болон дам нөлөө үзүүлж, эгзэгтэй үед Монголын хувь заяаг тусдаа хийгээд хамсан нийлж байгаад шийдвэрлэж байсан нь ямагт знэн билээ. Ер нь аливаа жижиг буурай улсын хувьд хөрш гэдэг нь ямагт чухал үүрэгтэй байдаг бөгөөд тухайн орны бодлого, үйл ажиллагааны чиглэлийг ч тодорхойлоход нөлөө үзүүлдэг ажээ[786].

1990-ээд оноос МУ-ын олон тулгуурт, нээлттэй, үндэсний эрх ашгийг дээдэлсэн, бие даасан гадаад бодлого явуулсан нь Өрнө, Дорнын олон шинэ түншүүдтэй учруулсан. 1990-ээд оны МУ-ын гадаад харилцаанд буй болсон шинэ хүчин зүйл бол хоёр хөршөөс гадна АНУ, Япон, Өрнөдийн гүрнүүд зэрэг дэлхийн бодлогод шийдвэрлэх нөлөөтэй зонхилох орнууд тодорхой үүрэг гүйцэтгэх болсон явдал юм. Мөн үүний үндсэн эх сурвалж нь Монголд гарсан ардчилсан өөрчлөлт, зах зээлийн ждийн засагт шилжих үйл явц байсан бөгөөд тэдгээр орнууд ч МУ-ыг ардчилсан шинэ тогтолцоонд шилжихэд бүх талын дэмжлэг үзүүлэх, нөгөө талд урд, хойд хоёр хөршид нь шилжилтийг амжилттай даван туулж буйг жишээ болгон харуулах зорилго ч агуулж байсныг тэмдэглэх хэрэгтэй.

Монгол Улс Японтой 1997 онд "Иж бүрэн түншлэл", Турктай 1999 онд "Иж бүрэн түншлэл", БНСУ-тай 1999 онд "Харилцан нөхсөн хамтын ажиллагаа, хөгжлийн түншлэл", 2006 онд "Сайн хөршийн найрамдал, хамтын ажиллагааны түншлэл", ОХУ-тай 2003 онд "Сайн хөршийн уламжлалт түншлэл", 2006 онд "Стратегийн түншлэл", БНХАУ-тай 2003 онд "Өргөн хүрээтэй түншлэл", АНУ-тай 2004, 2005 онд "Стратегийн түншлэл", ХБНГУ-тай 2008 онд "Иж бүрэн түншлэл"-ийн харилцааны эрх зүйн баримт бичгүүдийг тус тус байгуулсан бөгөөд Европын холбоо, Энэтхэгтэй энэ чиглэлээр ажиллаж байна. 1995 онд Өрнөд Европын орнуудаас анх удаа Европын Холбооны жинтэй, нөлөө бүхий гишүүн, ХБНГУ-тай "Монгол Улс, ХБНГУ-ын харилцааны үндсийн тухай Тунхаглал", Францтай 1996 онд "Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны хэлэлцээр"-ийг байгуулсан нь ч ач холбогдолтой үйл явдал болсон.

Европын Холбооны нөлөө бүхий хоёр гүрэн Их Британи, Францад МУ-ын Ерөнхийлөгч 2007 онд айлчилж, энэ хоёр улсыг "гуравдагч хөрш" хэмээн үзэж, харилцаа, хамтын ажиллагаандаа улс төрийн өндөр ач холбогдол өгдгийг нотолсон нь МУ-ын олон тулгуурт гадаад бодлогыг урагшлуулахад улс төр-стратегийн ач холбогдолтой алхам боллоо. Цаашид "гуравдагч хөрш"-ийн тухай ойлголт, үзэл баримтлалыг тодорхой агуулгаар улам баяжуулж, практик үйл ажиллагаагаар бэхжүүлэх хэрэгтэй болжээ.

[786] Д. Уламбаяр "Стратеги судлал" сэтгүүл УБ хот, 2009 он, №46

"Түнш, түншлэл"-ийг гадаад бодлогын утгын талаас нь авч үзвэл "харилцан бие биедээ ттүшиг, тулга болох", "дотно найрсаг, нөхөрсөг" зэрэг агуулгыг илэрхийлж, хоёр орны хэвийн найрамдалт сайн хөршийн харилцаа илүү хайрсаг, чин сэтгэлийн буюу гүн гүнзгий, олон талт хамтын ажиллагааны шинж төлвийг зааж байна гэж тодорхойлж болохоор юм. Гэхдээ энд "холбооны буюу эвслийн" эрх ашгийг тэргүүн зэрэгт тавих буюу харгалзах, "ах дүүгийн" харилцааны ах нь сургах, дүү нь сонсох агуулга тусгагдаагүй бөгөөд үүгээрээ түншлэгч талуудын тэгш эрх хангагдаж буй гэж үзэж болно. Мөн өргөн хамтран ажиллах утга санаа шингэсэн байдаг нь талууд амжилт, ололт, доголдол дутагдлын талаар хамтын хариуцлага хүлээдэг. Тэгэхлээр түншлэл нь улс гүрнүүдийн хэвийн, найрамдалт харилцаанаас агуулга, хэлбэрээрээ өргөн юм. Зарим улс орон түншлэлийн харилцаанд болгоомжтой ханддаг ч орчин үеийн олон улсын харилцааны шинэ дэг журам бүрэлдэн тогтох үйл явц өгнөж байгаа өнөө үед түншлэл нь гуравдагч этгээдийн эсрэг чиглэсэн шинж байх ёсгүй гэж үзэж байна. Даяаршлын одоо үед түншлэлийн эдийн засгийн утга, агуулга нь улам өргөжин тэлсээр байна.

Монгол Улсын гадаад улс төрийн бодлогын 12 дугаар хэсэгт:

Монгол Улс гадаад улс төрийн бодлогоо хэрэгжүүлэхдээ дараах чиглэлийг баримтална:

12.3. Монгол Улсын гадаад бодлогын гурав дахь чиглэл бол Азийн бүс нутагт байр суурьтай бататгаж эндхийн улс төр, эдийн засгийн интеграцид оновчтой оролцох явдал мөн. Энэ зорилтын хүрээнд Ази, Номхон далайн чиглэл, түүний дотор Зүүн-хойд Ази, Төв Азийн чиглэлд түлхүү анхаарна. Монгол Улс бүс нутгийн аюулгүй байдлыг бэхжүүлэх асуудлаар яриа хэлэлцээ өрнүүлэх, хамтын аюулгүй байдлын механизм буй болгох үйл явцад идэвхтэй оролцоно. Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага /АПЕК/-д элсэн орохыг зорино. Бүс нутгийн интеграцид орох нөхцөлийг юуны өмнө түүнд хамаарч буй улс орнуудтай хоёр талын харилцааг өргөтгөн хөгжүүлэх замаар бүрдүүлнэ хэмээн заажээ.

Монгол Улс, Ази, Номхон далайн орнуудын эдийн засгийн хамтын ажиллагааны /АРЕС/ зорилго зарчмыг дэмжиж, тус хамтын ажиллагаатай хамтран ажиллах, улмаар гишүүнээр элсэх сонирхолтой байгаагаа удаа дараа илэрхийлсэн байна. Монгол улс Хамтын ажиллагаанд гишүүнээр элсэхийн тулд холбогдох улс орон, олон улсын байгууллагын дэмжлэгийг авах талаар хоёр талын шугамаар болон Хамтын ажиллагааны Нарийн бичгийн дарга нарын газраар дамжуулан хэлэлцэж хүсэлтээ тавьж байна. 2007 онд Хамтын ажиллагаанд шинэ гишүүн элсүүлэх 10 жилийн хоригийн хугацаа дуусгавар болсон. Монгол Улс энэ байгууллагын гишүүн болох хүсэлтээ албан ёсоор тавьсан байна.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсыг бус нутгийн төвийг сахигч болгон хувиргах хэцүү эздрээтэй яриа хэлэлцээр явуулах талбар болгон цаашид "Ази дахь Хельсинки" болгон хувиргах үүднээс Монголын төвийн сахисан байдлыг хэрэгжүүлэх санааг өргөн хэлэлцүүлж байна. Бидний үзэж байгаагаар энэ сонирхолтой санаа нь анхаарал татаж байна. Мэдээж

үүнийг ажил хэрэг болгоход хэд хэдэн хүчин зүйлүүд, түүний дотор зохих санхүүгийн асуудлууд орох юм. Дээр өгүүлсэн нөхцөлүүдээс хамгийн чухал нь Улаанбаатар жинхэнэ төвийг сахисан байдлаа хадгалах ёстой бөгөөд бусад том гүрнүүдтэй харилцах харилцаандаа ижил хэмжээнд харилцан ажиллах нь чухал байгаа юм.

Жишээ нь Улаанбаатарын гол үүрэг нь яриа хэлэлцээрийн замаар Солонгосын маргааныг зохицуулж болох юм. Түүнчлэн эх газрын гурван орон болох Хятад, Орос, Монголын уламжлалт найрсаг харилцаа онцгой ач холбогдолтой бөгөөд тэдгээрийн харилцаа хамтын ажиллагаа, харилцан ойлголцол бэхжиж байх нь ЗХА-ийн энх тайван, аюулгүй байдал ихээхэн тустай юм. Учир нь Монгол орон газар зүйн байрлалын хувьд тус хоёр их гүрний дунд оршдог тул бүс нутгийн тогтвортой байдлыг хангахад тэдгээртэй нягт хамтран ажиллах шаардлагатай. Харин бүс нутгийн улсууд дотор БНХАУ, ОХУ, БНСУ, Япон, АНУ гэсэн сайн харилцааны туйлууд үүсэн байгааг харж болно. Тэгэхээр бүс нутгийн олон улсын харилцаанд оролцогч гүрнүүд бүгд нэгэн ижил эрмэлзлэлтэй болж, хамтын эрх ашгаа хамгаалахгүй гэхэд Хятад-ОХУ-ын харилцаа бэхжиж байх нь ЗХА-ийн аюулгүй байдалд эерэг хүчин зүйл болоод бана.

Харин Зүүн хойд Азийн аюулгүй байдлыг бэхжүүлэх зорилтын хүрээнд бүсийн улсууд АНУ-ыг оролцуулахгүйгээр хамтын шийдвэрт хүрсэн нь дээр.

Үүнийг ШХАБ-аар тайлбарлаж болно. Энэ байгууллагын цаашдын зорилго нь өсөн нэмэгдэж буй эдийн засаг, томоохон зах зээлтэй Хятад, ашигт малтмал, цэргийн хүчин чадлаар үнэлэгдэн буй ОХУ-ын хамтын эрх ашиг, аюулгүй байдлыг дэлхийн тавцанд хамгаалах явдал юм. ШХАБ эхнээсээ АНУ, Япон тэргүүтэй орнуудыг уриагүй нь цэвэр явцуу ашиг сонирхолын байгууллага гэдгийг харуулж байна. Гэтэл Зүүн хойд Ази гэдэг шийдвэрлэх асуудал дэнүү олон байгаа бүс нутагт АНУ, ОХУ, Хятад улсууд түнжин таарч, бүх л асуудлыг нэгэн дуугаар хүлээн зөвшөөрөх нь юу л бол. Тиймээс ОХУ, БНХАУ-тай аль алинтай нь таатай харилцаа бүхий бүс нутагтаа томоохон үүрэгтэй БНСУ-ыг татан оролцуулсан бүс нутгийн хамтын ажиллагааны яриа хэлэлцээр эхлүүлэх нь зүйтэй. Үүнд мэдээж бүсийн бүх улстай таатай харилцаа бүхий МУ-ыг оролцуулж таарна. Өөрөөр хэлбэл, ЗХА-ийн аюулгүй байдлыг хангах алхмыг урагшлуулахад эхний ээлжид түүний бүтэц нь хэт нүсэр байх шаардлагагүй бөгөөд одоогоор ашиг сонирхлоо тэнцвэрт байдлаа олсон Зүүн хойд Ази төдийгүй, олон улсын харилцаанд томоохон нөлөө бүхий Хятад, ОХУ-ын харилцаан дээр тулгуурлаж, БНСУ, МУ-ыг дагуулан Зүүн хойд Азийн энх тайван, аюулгүй байдлыг хангах доривтой алхам хийх хэрэгтэй.

Харин эдгээрийн дараа л Япон, АНУ, Хойд Солонгосыг Зүүн хойд Ази дахь энхийн төлөөх нягт хамтын ажиллагаанд урин оролцуулах хэрэгтэй.

Гэхдээ Зүүн хойд Ази дахь хамтын ажиллагааг шууд цэрэг-улс төрийн түвшнээс эхлэх нь илүүц юм. Юуны өмнө худалдаа, эдийн засгийн салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх нь зүйтэй мэт санагдаж байна.

Бусийн аюулгүй байдал – Орос-Хятадын харилцаа, хамтын ажиллагаа ба Монгол Улсын аюулгүй байдал

Евразийн баруун дүүрэгт Хятад, Орос хоёр геостратегийн эрч хүчтэй үндсэн тоглогчид болж байгааг хэлэхэд хангалттай. Тэр хоёрын хувьд Монгол Улс, дүр төрх нийтлэг сэдэл болдог болов тийм Монгол нь ямар маягаар, ямар хэмжээгээр Америктай холбоотой байх тухайд тэд санал зөрдөг юм. Гэвч хоёулаа Монгол улсад ямар нэг шинэ зүйл босгож ирэх, тэгснэрээ статус-квог өөрчлөхийг хүсч байгаа билээ. Тухайлбал, Хятад нь Монголын тухайд өөрийн гэсэн геостратегийн үзэл баримтлалтай бөгөөд тэр нь зарим нэг чухал зүйл дээр ОХУ-ын үзэл баримтлалаас ялгаатай.

Хятад нь хөгжихийг хүсч байгаа Монголд төрийн гол үүрэг гүйцэтгэхийг эрмэлзэж буй төдийгүй нэгдмэл ашиг сонирхол бүхий Зүүн хойд Ази, Зүүн өмнөд Азийн бүлэг орнуудын гол цөм нь гэж өөрийгөө тооцдог. ОХУ нь Зүүн хойд Азийн хамгийн дорвитой улс буюу бүс нутгийн эдийн засгийн "зүтгүүр", бүс нутгийн төлөвшиж буй улс гэсэн онцгой статусаа улам бүр ухамсарлах болж байна."

"ОХУ нь тусгаар тогтносон Монгол Улсыг байгуулахад Хятад, Оросын эвлэрэл зайлшгүй гэдгийг бүр II дайны төгсгөл үеэс хүлээн зөвшөөрсөн билээ. Энэхүү эвлэрэл нь Монголын түүхэн сэргэлтэд маш чухал байсан юм. Иймээс Хятадын тэргүүлэх байр суурийг хүлээн зөвшөөрсөн нь аргагүй төлвөл зохих үнэ үүний зэрэгцээ аюулгүй байдлын хувьд эмзэг Монголын хувьд Хятадын аюул бодитой байсны улмаас Зөвлөлтөд үнэнч байх нь түүний хувьд амиа авч гарах маш чухал нөхцөл болсон бөгөөд үүнийг нь Хятадууд хүртэл хүлээн зөвшөөрчээ.

Гэтэл ЗХУ задарсаны дараа илүү нэгдсэн, ардчилсан Монгол Улсыг байгуулахын тулд Хятад улс түүнд захирагдах нь зайлшгүй ч биш, зохистой ч биш болжээ. Хятад, Оросын эрх тэгш түншлэлд тусгаар Монгол одоо чухамдаа илүү хүчтэй түнш болсон ч энэхүү эрх тэгш түншлэл нь Бээжингийн хувьд шударга наймаанаас давсан зүйл байсан. Тийм учраас Монгол Улс аюулгүй байдлаа хангах асуудал дээр далайн чанад дахь холбоотон бөгөөд хамгаалагчаа илүүд үзэж байгаатай Хятадууд зүгээр эвлэрэхээс өөр арга байгаагүй юм.

Илүү чухал зүйл гэвэл Хятад-Оросын онцгой сонирхлын бүсийг хамтад нь авч үзвэл тэр нь чухамдаа Монголын баруун, зүүн хилийг тодорхойлж өгч байгаа бөгөөд энэ хоёр бүс зарим газар давхцаж буй нь стратегийн амин чухал үндэс болох Хятад-Оросын холбооны геополитикийн маргаангүй ач холбогдлыг онцгойлон харуулж байгаа юм.

Хятад Зүүн хойд Ази болон Зүүн өмнөд Азийн орнуудад үнэнхүү үр бүтээлтэй үүрэг гүйцэтгэж байдгийг тэмдэглэх нь зүйн хэрэг. Иймээс Хятад нь Зүүн хойд Азийн тогтвортой байдал, тайван хөгжилд лут дэнчин тавьсан юм. Гэвч энэхүү сонирхол нь өргөн утгаар буюу Ази номхон далайн бүс нутгийн аюулгүй байдалд ч ашигтай, Хятад нь Зүүн өмнөд азийн өмнөд хэсэгт өөрийнхөө зорилгыг эс мэдрэх аваас тогтворгүй бөгөөд аюул заналд өртөмхий байх юм.

ОХУ бол өөр хэрэг. Батлан хамгаалахын давамгайлах байр суурь маргаангүй боловч Ази номхон далайн бүс нутагт Хятадын тэргүүлэх үүргийг ил тодоор дэмжихдээ тун болгоомжтой хандаж байх ёстой. Энэ тэргүүлэх үүрэг нь Япон АНУ-ын халамжийн хүрээнд байгаа цагт тэдний сэтгэлд нийцэж байх боловч хэтдээ түүн дээр суурилуулан геостратегийг байгуулах боломж байхгүй.

Бэзжингийн зохиосон, түүний толгойлох Шанхайн 5 гэдэг бол ердөө л хэрэгжихгүй үзэл санаа. Чухам ийм учраас Монгол нь Хятадад хэрэгтэй, Хятад-Оросын хэлхээ холбоо нь Монголд хэрэгтэй.

Тусгаар, хараат бус бүс байгуулах тухай гол зорилтыг Хятадын үзэж байгаагаар бол бүс нутагт Оросын ороллыг аажим хумихын хамт Хятадын удирдлага дор Монголыг нэгтгэх замаар шийдэж болох ажээ. Гэвч Хятад Монголын ирээдүйг тодорхойлон гаргах гэж байгаа бол Монголын хэрэг явдалд Москвагийн тэргүүлэх үүргийг аажмаар хязгаарлахын зэрэгцээ Оросыг уг үйлсэд татан оруулахаас гадна бас хязгаарлан барьж байх хэрэгтэй болно. Үүний дүнд Хятадад хоёр янзын агуулга бүхий улс төрийн 2 сонголт гарч ирж байна.

Бүс нутгийн аюулгүй байдлыг хангахад зайлшгүй шаардлагатай гэж үздэг Оросын оролцоог тасралтгүй хумихын зэрэгцээ түүнийг хэрхэн хадгалах вэ? Оросыг бүс нутагт тэргүүлэх байр суурьтай болгохгүй байхын хамт Хятад-Оросын хамтын ажиллагааг Монголыг нэгтгэх улс төр, эдийн засгийн хөшүүргийнх нь хувьд хэрхэн хадгалах вэ гэсэн сонголтууд юм.

Хэрвээ Хятад жинхэнэ дэлхийн их гүрэн байсан бол дээрх хоёр сонголтыг гол зорилтоо хэрэгжүүлэх явцад шийдчихэд тийм ч хэцүү биш байх байсан.

Хятад АНУ-ыг яах аргагүй дэлхийн гүрэн гэж мэдрээд тийм учраас өөрийнх нь дааж чадахгүй, харин Америк дааж чадаж буй Монголын аюулгүй байдлыг ОХУ хангаж чадна гэж үзэж гэмээнэ хараат бус /Америкаас/ Монголд тэргүүлэх үүрэг гүйцэтгэхийг өөрөө ч гэсэн зөвшөөрөхсөн билээ.

Гэтэл Хятадын хүч чадлын бодит хязгаарыг ОХУ мэднэ. ОХУ нь эдийн засгийн хувьд Хятадаас илэрхий сулаас гадна цэргийн байгууллага нь ч гойд чадварлаг биш болсон юм. Цэргийн чадавхи нь өөрийн холбоон дахь дагуул улсуудынхаа дотоодын төрийн эргэлтийг дарахад бүрэн хүрэлцээтэй ч өөрийн нөлөөг Алс дорнодоос гадуур дэлгэрүүлэх ч чадваргүй байгаа.

Тиймээс Монголын жинхэнэ аюулгүй байдлыг хангах тухайд Хятадыг сохроор дагахыг хүсэхгүй байгаа бөгөөд Монголын аюулгүй байдалд Америк гол үүрэг гүйцэтгэх ёстой гэсэн байр суурин дээрээ баттай зогсож чадахгүй байна.

Хятад-Оросын хамтын ажиллагаа тасарвал Монголын хувьд нэн золгүй бүтэлгүйтэл, Монгол дахь Америкийн байр суурийн хувьд улам л таатай зүйл болно." Хятад-Оросын холбоо нь Зүүн хойд Азийн бүс нутагт илүү чухал үүрэг гүйцэтгэх боломж олгож байгаа болохоор түүнд онцгой сонирхлынхоо бүсэд байр суурыа эзлэхэд болгоомжлоод байх зүйл байхгүй.

Монголын хувьд, хөрш Хятад улс нь Зүүн хойд Азийн энх тайван, тогтвортой байдлыг нь хангаж буй билэг тэмдэг юм. Ирээдүйд гарах

бэрхшээлтэй асуудлуудыг зөвхөн хамтын хүчээр шийдвэрлэнэ гэсэн үзэл санааны үндсэн дээр олон төрлийн дипломат яриа хэлэлцээр хийх шаардлагатай.

Монгол дахь ардчиллын үйл явцыг дэмжих хэмжээний тухайд Америкийн хоёрдмол байр суурь Монгол Улсын статус квог яаж тодорхойлох ёстой вэ, ялангуяа Орос, Хятадаас хамааралгүй ямар улс байх, ер нь хараат бус улс байх ёстой юу гэсэн асуултуудыг бас хамаарч байна. Вашингтон Зүүн хойд Азийг Оросууд тэргүүлснээс Япон тэргүүлсэн нь дээр гэж үздэг боловч Зүүн хойд Азийн геостратегийн талаарх ОХУ-ын байр суурийг үгүйсгэдэггүй.

Америктай тогтоосон Монгол Улсын хэлхээ холбоо нь "Персийн булангийн дайн" дуусснаас хойш Монголын хувьд бүр ч чухал болжээ. Уг холбоо өнгөрсөн үед Монгол Улсыг гадны шууд аюулаас хамгаалахыг чухалчилаагүй ч тэднийг эдийн засгийн хувьд дэмжиж байв. ЗХУ задарсны дараа болон Монгол Улс ардчилсан хөдөлгөөнд нэгдсэний дараагаар нөгөө холбоо нь түүнд нэг зүйл шүхэр болж, ОХУ, түүний нөөрт хил залгаа орнууддаа дахин аюул занал үүсгэхгүйгээр Зүүн хойд Азид тэргүүлэх үүргээ илүү нээлттэй гүйцэтгэх боломжтой болсон.

Иракийн энхийг сахиулах үйл хэрэгт үнэнч байх нь Монголын хувьд олон улсын энхийг сахиулах үйл хэрэгт идвэхитэй оролцогч улсын байр суурь болдог бол Америктай нягт холбоотой байх нь түүний аюулгүй байдалд зайлшгүй чухал зүйл. Ингэхлээр, Монгол улсыг Америкаас тусдаа, хамаарал багатай байлгах хувилбар хэрэгжих бололцоогүй юм.

Монгол улс АНУ-ын тусламжтайгаар аюулгүй байдлаа бэхжүүлж Ази дахинд өөрийн холбоотноо дургүйцэх, айдаст автах байдал үүсгэх учиргүй үүргийг өөртөө хүлээх замаар сүр хүчээ сэргээж байна. Хэрэв Монгол Улс үндэснийхээ ашиг сонирхлыг хэрэгжүүлэхээр мэрийх юм бол бусад Ази чуудаас хөндийрөх эрсдэлд орно гэсэн үг. Хэрэв Монголчууд нийт Азийн ашиг сонирхлыг хэрэгжүүлэхээр чармайвал тэд азийнхний дэмжлэг тэдийгүй хүндэтгэлийг хүлээх болно." Эдүгээ Монголын ашиг сонирхол АНУ болон ОХУ-ын ашиг сонирхолтой нийцэж байгаа бөгөөд түүгээрээ нэр нүүртэй болж цаашид дэлхийн хамтын нийгэмлэгт эзлэх байр суурь нь бэхжинэ.

Дүгнэлт

Зүүн хойд Ази бол энх тайван, хөгжил цэцэглэлтийн гол тулгуур бүсийн нэг. Учир нь дэлхийн хүн амын дөрөвний нэг энэ бүс нутагт амьдарч, дотоодын нийт бүтээгдэхүүний 22 хувь энд үйлдвэрлэгдэж байна. Энэ бол асар том нөөц, ирээдүй. Харамсалтай нь энэ их эрч хүч, далайцаараа хүн төрөлхтний энх амгалан байдал, хөгжил дэвшилд, интеграцлагдсан нэгдмэл төвшинд хувь нэмрээ оруулж хараахан чадахгүй байна. Бүсийн цар хүрээ, хамруулах орнуудын тухайд улс төр, аюулгүй байдлыг чухалчлагсад Зүүн хойд Азийг бүсчлэхийг сонирхож байгаа бол эдийн засгийн интеграцыг тэргүүнд тавигсад бүс нутгийн цар хүрээг тэлж, Зүүн Азиар тогтоох чиглэл баримталж байгаа бөгөөд Зүүн хойд Азийн бүсэд Япон, Хойд Солонгос, Өмнөд Солонгос, Монгол, ОХУ-ын Алс Дорнод, Хятадын Зүүн хойд хэсгийн Хар Мөрөн, Зилин, Ляонин мужуудыг, өргөн утгаар нь ОХУ, Хятадыг хамруулдаг.

KIEP буюу Солонгосын Олон улсын эдийн засгийн бодлогын хүрээлэнгийн харьцуулсан судалгаанаас[787] үзэхэд, Зүүн хойд Ази дахь бүс нутгийн хамтын ажиллагааны нэгдсэн интеграц бүрдэхэд нийгэм, соёл, эдийн засгийн хүчин зүйл эерэгээр нөлөөлж, үйл явцыг нь хурдасгах боломжтой бол харин улс төр, аюулгүй байдлын хүчин зүйл сөргөөр нөлөөлж, тээг саад учруулж байгаа дур зураг харагдаж байна.

Зүүн хойд Азийн аюулгүй байдлыг авч үзэхэд дараахь үндсэн гурван санааг орхигдуулж болохгүй. Үүнд:

• Нэгдүгээрт, Зүүн хойд Азийн бүсэд хоёр маш чухал геополитикийн бүс байршидаг-Солонгосын Хойг ба Тайваний хоолой болон хүрээлэн буй дэлхийн томоохон улсуудын ашиг сонирхол, тухайлбал Япон, АНУ, БНХАУ ба ОХУ. Энэхүү хоёр бүс болон томоохон гүрний ашиг сонирхолын зөрчил нь тухайн бүс дэхь аюулгүй байдалд нөлөөлөх хамгийн том нөлөөлөл;

• Хоёрдугаарт, бүс хоорондын хурцадмал нөхцөл байдал нь зарим улсын статусыг хүлээн зөвшөөрөхгүй асуудалтай холбоотой. Тухайлбал, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Улсын асуудал буюу энэ оны 11 дүгээр сарын 23-нд гарсан үйл явдал. Зүүн хойд Азийн улс орнуудын дунд БНАСУ-ыг зөвхөн БНХАУ, Монгол Улс, ОХУ хүлээн зөвшөөрдөг. Япон Улс, АНУ, Өмнөд Солонгос зэрэг улсууд нь Солонгосын Хойг дахь эрчим хүчний хөгжлийн хамтын ажиллагааны нийгэмлэг /КЕДО/ байгуулан БНАСУ-ыг бараг л хүлээн зөвшөөрсөн хэдий ч дипломат харилцаа үгүйгээс хэлэлцээр явуулахад маш их хүндрэлүүдийг бий болгодог байна.

• Гуравдугаарт, бүсийн ауюлгүй байдлыг хангахын тулд дипломат харилцааг сайжруулах тэргүүний шаардлага бий болж байна[788].

Олон улсын харилцаанд бүрэн дүүрэн энхийн байдал байх боломжгүй хэмээн түгээмэл үздэг хэдий ч хамтын аюулгүй байдал нь тодорхой тэнцвэртэй байдалд байж болно. Энэ тал дээр Зүүн хойд Азийн хувьд Европын холбооноос жишээ авахад илүүдэхгүй бөгөөд "хоёр шатлалт тогтвортой байдал"-ыг дагаж мөрдөх нь чухал. Үүнд, хамтарсан аюулгүй байдалд эрмэлзэх, хоёрдугаарт уламжлалт аюулгүй байдлын хэлбэр / хүч, цэргийн холбооны тэнцвэр/ -ийг сахих гэсэн хоёр ойлголтыг зэрэг баримтлахыг ойлгоно.

Монгол Улсын хувьд аюулгүй байдлын энэхүү хоёр шатлалт тогтвортой байдалд өөрийн газар зүйн байрлалын хувьд ач холбогдолтой үүрэг гүйцэтгэж, улмаар бүсийн тулгамдсан асуудалд шийдвэрлэх үүрэгтэй оролцож болох боломжтой.

__oOo__

[787] Солонгосын олон улсын эдийн засгийн бодлогын хүрээлэнгийн тайлан, 2007 он, 66 дахь тал.

[788] Ц.Эрдэнэболд "Безопастность в Северо-Восточной Азии: Новый взгляд" илтгэл, 2010 он.

МОНГОЛ УЛСЫН НЭГДЭН ОРООГҮЙ ОЛОН УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ГЭРЭЭ, КОНВЕНЦИЙН СУДАЛГАА[789]

Олон улсын гэрээнд нэгдэхэд судалгаатай хандах практик

Монгол Улсын нэгдэн ороогүй олон улсын хүний эрхийн гэрээ конвенцийг судлахын тулд хүний эрхийн нийт гэрээ, конвенц[790]ба Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн гэрээ, конвенц[791]-ийн талаар судлах шаардлагатай юм. Манай улс 2010 оны 6 дугаар сарын байдлаар олон улсын хүний эрхийн нийт 44 гэрээ конвенцид нэгдэн орсон байна. Судалгааны ажлын удирдагчаас өгсөн чиглэл, зөвлөмжийн дагуу олон улсын гэрээнд нэгдэн ороход судалгаатай хандах тал дээр өнөөгийн практик болон холбогдох хуулийн зохицуулалт, түүний хэрэгжилт, цаашид боловсронгуй болгох талаар авч үзэх шаардлагатай болсон юм.

УИХ-аар олон улсын гэрээнд нэгдэн орох асуудлыг хэлэлцсэн протоколуудыг судлахад дараах нийтлэг дутагдал илэрч байна. Үүнд :

- Гэрээнд нэгдэн орсноор үүсэх үр дагавар;
- Гэрээнд нэгдэн орох хууль зүйн үндэслэл, бусад хуульд өөрчлөлт орох эсэх;
- Гэрээнд нэгдэн орсон бусад улс орны байдал;
- Нэгдэн орсноор үүсэх зардал, татварын асуудал зэргийг олон улсын гэрээг соёрхон батлах хуулийн төсөлд хангалттай тусгаагүй байна. Түүнчлэн УИХ дээр эдгээр асуудлыг лавлаж асуусан тохиолдолд хариулт өгч чадахгүй байдал оршсоор байгаа нь олон улсын гэрээнд нэгдэн ороход бэлтгэл сайн хангагддаггүйтэй холбоотой гэж хэлж болно.

"Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль"-ийн 9 дүгээр зүйлд зааснаар хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаархи саналыг тусгах ёстой боловч энэ ажлыг хангалттгүй гүйцэтгэж байгаа талаар "Олон улсын эрх зүйн зохицуулалтад Монгол Улсын оролцоог өргөтгөх" чиглэлээр хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын дэд хэсгийн тайланд тусгасан дүгнэлтэндээ дараах тодорхой жишээг иш татсан байна.

УИХ-ын 2006 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сарын 26-ны өдрийн нэгдсэн хуралдааны тэмдэглэлийн хэсгээс:

УИХ-ын гишүүн С.Ламбаа: "... байсхийгээд л нэг конвенц ороод ирнэ. Тэгээд дараа нь бид нар хууль тогтоомждоо өөрчлөлт хийнэ гээд л өргөн

[789] Тус секторын 2010 оны төлөвлөгөөт судалгааны ажил болно.

[790] НҮБ-ын Хүний эрхийн асуудал эрхлэх Дээд комиссарын газрын цахим хуудсан дахь хүний эрхийн олон улсын гэрээ болон заавал биелэгдэх шинжийг агуулаагүй тунхаг бичиг зэрэг нийт 113 баримт бичгийн жагсаалтыг хавсралтаас үзнэ үү.

[791] ГХЯ-аас албан бичгээр ирүүлсэн МУ-ын нэгдэн орсон хүний эрхийн гэрээ, конвенцийн жагсаалтыг хавсралтаас үзнэ үү.

бариад байх юм. Ер нь одоо конвенцид элсэхтэй холбогдуулаад энэ конвенцийн дагуу ийм ийм хуульд ингэж өөрчлөлт оруулна гэсэн юм хамт орж ирж хэлэлцэгдэж болдоггүй юм уу.... өөрөөр хэлбэл энэ конвенцийг батлаад гаргачихна. Тэгээд нөгөө хуулиуд нь хэзээ ч өргөн баригдах юм билээ. Ер нь бол бид нар нэг цогцолбороор нь иж бүрэн юмыг авч үздэг тэр тогтолцоог хэзээ бүрдүүлэх юм бэ. Ингэж болдоггүй юм уу. ... конвенцоо дагасан хууль эрх зүйн тэр өөрчлөлтүүдээ давхар оруулаад ирдэг. Тэгээд нэг мөсөн яриад ингээд гаргах бололцоо байдаггүй юм уу..."

Дээрх тэмдэглэлээс үзэхэд олон улсын гэрээг соёрхон батлахдаа тухайн гэрээг хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөхгүйгээр танилцуулж батлуулдаг нь харагдаж байгаа[792] ба гэрээнд нэгдэн орохдоо судалгаатай ханддагүйг давхар баталж байна.

Дүгнэж хэлэхэд аливаа гэрээнд нэгдэхдээ тухайн гэрээний агуулга, хэлбэрийг голлон танилцуулсан байх боловч өөрийн орны хэрэгцээ шаардлага, онцлог, тулгарах асуудал, бэрхшээл, шийдвэрлэх арга замыг харгалзсан талын судалгаа бага, үндэслэл муутай ханддаг байдал давтагддаг.

Олон улсын гэрээнд нэгдэхэд судалгаатай хандахтай холбоотой хуулийн зохицуулалт, түүний хэрэгжилт

Олон улсын гэрээг соёрхон батлах асуудлыг Үндсэн хууль, Олон улсын гэрээний тухай 1993 оны хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай 2001 оны хуулийн холбогдох заалтыг баримтлан шийдвэрлэдэг.

Доктор, профессор Б.Чимид "Олон улсын гэрээ байгуулахад Монгол Улсын хувьд баримтлах онцгой зарчим бол Үндсэн хуулийн давуу байдал/примат/-ыг хангах явдал юм."[793] хэмээн хэлсэн байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2-т "Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ", 10 дугаар зүйлийн 3-т "Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон батлагдсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.", 10 дугаар зүйлийн 4-т "Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй", 16 дугаар зүйлийн 14-т "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах эрхтэй" гэсэн заалтууд нь олон улсын эрх зүйн хэм хэмжээг үндэсний эрх зүйд хэрэглэхтэй холбогдсон гол үзэл баримтлал болдог. Нэгтгэж хэлэхэд Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх, олон улсын гэрээ нь дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчлэх тухай заалтууд тусгагдсан байна. Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг

[792] "Олон улсын эрх зүйн зохицуулалтад Монгол Улсын оролцоог өргөтгөх" чиглэлээр хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын дэд хэсгийн тайлан, 2007 он

[793] "МУ-ын Олон улсын гэрээний тухай 1993 оны хуулийн шинжлэх ухаан, практикийн тайлбар" судалгааны тайлан дахь доктор, профессор Б.Чимидийн тус хуульд хийсэн тайлбар, 2009 он

дагаж мөрдөхгүй гэдгийг мөн хуульчлан баталгаажуулсан. Эдгээр үзэл баримтлал нь олон улсын гэрээнд нэгдэн орохдоо хариуцлагатай хандах, нэгэнтээ нэгдэн орсон тохиолдолд үүргээ заавал биелүүлэх ёстой болох учир судалж, ухаалаг шийдвэр гаргах тухай гүн гүнзгий утгыг агуулж байна.

Олон улсын гэрээний тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу, олон улсын гэрээг соёрхон батлуулах саналыг Засгийн газраар хэлэлцүүлэхэд олон талт гэрээний хувьд уг саналыг гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дангаараа эсхүл гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тухайн гэрээгээр зохицуулж буй асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран Засгийн газарт өргөн мэдүүлдэг. Тусгай газрын даргын хувьд олон улсын гэрээг соёрхон батлуулах саналыг гадаад харилцааны асуудал эрхэлсэн гишүүнтэй зөвшилцөн Засгийн газарт өргөн мэдүүлсэн тохиолдол одоогоор практикт гараагүй байна. Цаашдаа ч ийм тохиолдол гарахгүй юм.[794]

"Хууль, Улсын Их хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль"-ийн дагуу олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийг боловсруулан УИХ-д өргөн барихдаа бусад хуулийн төсөл өргөн барих журмыг мөн баримталдаг. Тус хуулийн 7 дугаар зүйлийн дагуу хууль санаачлагч нь төслийг боловсруулахдаа холбогдох байгууллагын шинжээч, эрдэмтэн судлаач, мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж ажиллуулж болох тухай заажээ. Үүнээс үзэхэд олон улсын гэрээг соёрхон батлах хуулийн төслийг судалгаанд үндэслэж боловсруулах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн байна.

"Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуул"-ийн 9 дүгээр зүйлд заасанчлан, хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаархи саналыг тусгах, мөн тус хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу Үндсэн хуульд нийцсэн, бусад хууль болон Монгол Улсын олон улсын гэрээний заалттай уялдсан байх шаардлагыг хуулийн төсөлд тусгах талаар заасан зэргээр судалгаатай хандах тал дээр эрх зүйн ерөнхий зохицуулалт байгаа боловч практикт хэрэгжихгүй байна.

Судалгаатай хандах асуудал

Холбогдох эрх зүйн зохицуулалтыг хэрэгжүүлж, олон улсын гэрээнд нэгдэхэд судалгаатай хандахын тулд дараахь асуудлыг анхаарах шаардлагатай байна.

- Олон улсын гэрээг соёрхон батлахаар хэлэлцэх журмын асуудал

Олон улсын гэрээг соёрхон батлахаар Улсын Их Хурлаар хэлэлцэх журам нь хууль хэлэлцэж батлах журамтай адил байдаг ба үүний хэлэлцүүлэг нь ижил журмаар болдог учраас хэмээн тайлбар хийдэг. Гэтэл ийм байдлаар

[794] "МУ-ын Олон улсын гэрээний тухай 1993 оны хуулийн шинжлэх ухаан, практикийн тайлбар"судалгааны тайлан дахь доктор Б.Алтангэрэлийн тус хуульд хийсэн тайлбар, 2009 он

олон улсын гэрээг соёрхон баталж байгаа нь цаг үрсэн, илүү ажиллагаа гэдэг нь практикт ажиглагдаж, улмаар шүүмжлэлд өртөж байгаа тул гэрээг соёрхон батлах журмыг хууль хэлэлцэж баталдгаас илүү хялбар журмын дагуу хэрэгжүүлэх бодит шаардлага мөн гарч байна.[795] Олон талт гэрээний хувьд бүр ч хялбар журмаар хэлэлцүүлэх боломжоо бий. Нэгэнт олон улсын хурлаар хэлэлцэж баталсан гэрээнд нэгдэн орж байгаа болохоор тийм гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудал гарахгүй нь ойлгомжтой. Харин уг олон талт гэрээний заалтын дагуу тайлбар хийж болох бол тухайн гэрээний зарим заалтаар үүрэг хүлээхгүй тухайгаа мэдэгдсэн тайлбартайгаар нэгдэж болно. Ийнхүү талуудын тохиролцож гарын үсэг зурсан хоёр талын болон олон улсын хурлаар хэлэлцэгдэж батлагдсан олон талт гэрээг соёрхон батлах журмыг хууль хэлэлцдэгээс арай хялбар журмын дагуу хэлэлцэж байх шаардлага зүй ёсоор гарч байгааг тэмдэглэх нь зүйтэй юм.[796] Тэгвэл ийнхүү хялбар журмаар хэлэлцэж батлахын тулд судалгаатай хандах явдлыг туйлын чухалд тооцож, хэрэгжүүлснээр амжилттай үйл хэрэг болох юм. Өөрөөр хэлбэл, нэгэнтээ олон улсын хэмжээнд хэлэлцэж баталсан гэрээ конвенцийг дангаар нь судлахаасаа илүү өөрийн улс орны тухайд онцгойлсон үзэл баримтлалаар хандаж, хариуцлагатай судлах зарчмын асуудал тавигдах учиртай.

➢ Олон улсын гэрээ байгуулахад тавигдах хариуцлагын асуудал

1993 оны Монгол Улсын олон улсын гэрээний тухай хуулийг батлах үеийн хууль тогтоох байгууллагын үйлдсэн протоколуудтай танилцаж судлахад тус хуулийн төсөлд гаргасан ганц санал буюу УИХ-ын гишүүн С.Нарангэрэлээс "Олон улсын гэрээ байгуулагчдад хүлээлгэх хариуцлага" гэсэн томъёоллоор хуулийн 7 дугаар бүлэгт бие даасан зүйл болгон " Монгол Улсын үндэсний болон эдийн засгийн аюулгүй байдалд илтэд харшилсан олон улсын гэрээ байгуулсан эрх бүхий МУ-ын албан тушаалтанд хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ" гэсэн заалт нэмж оруулах санал байсан боловч тухайн үед хүлээж аваагүй байна. Иймдээ ч одоогийн мөрдөгдөж байгаа хуульд хариуцлагын талаар "хууль тогтоомж зөрчин байгуулсан олон улсын гэрээг хүчингүй болгох" тухай тус хуулийн 23 дугаар зүйлд заасан заалт нь нэгэнт зөрчилтэй байгуулсан олон улсын гэрээг хэн хүчингүй болгох талаар заасан болохоос хариуцлагагүй хандсан буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх талаар заагаагүй орхисон байдал үүссэн.

Хэрвээ хариуцлагын тогтолцоог бүрдүүлэн хуульчилж өгвөл тухайн гэрээ конвенцид нэгдэн орохдоо хариуцлагатай байх явдлыг анхаарахад чухал ач холбогдолтой болно. Хариуцлагатай байхын тулд судалгаатай хандах явдал аяндаа бий болон хэвших сайн үр дагаварт хүрнэ.

➢ Нэгдэн орох олон улсын гэрээний судалгаанд харгалзах шалгуур асуудал

Олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийг хялбаршуулсан, шуурхай байдлаар хэлэлцэн батлахын тулд өмнө шатанд нарийн судлах

[795]"МУ-ын Олон улсын гэрээний тухай 1993 оны хуулийн шинжлэх ухаан, практикийн тайлбар"судалгааны тайлан дахь доктор Б.Алтангэрэлийн тус хуульд хийсэн тайлбар , 2009 он
[796]Мөн тайланд.

бөгөөд түүндээ тулгуурлан үндэслэлийг нь бодитой, чанартай гаргах ажиллагааг хэрэгжүүлэн хэвшүүлэх шаардлагатай байна.

Дээрх асуудлыг анхаарах хэрэгцээ тулгамдаж байгааг тус судалгааны ажлын үр дүнд, МУ-ын нэгдэн орох шаардлагатай олон улсын хүний эрхийн гэрээ конвенцийг судлан тодорхойлоход харгалзах шалгуур боловсруулсныг зарим гэрээ конвенцийн жишээн дээр тайлбарлая.

Монгол Улс нэгдэн орох шаардлагатай олон улсын хүний эрхийн гэрээ конвенцийг судлан тодорхойлоход харгалзах шалгуур

1. Гэрээний албан ёсны нэр, монгол нэр, товч танилцуулга, батлагдсан огноо

Энэ нь олон улсын гэрээ конвенцийн албан ёсны нэрийг баримтлан судалгаанд ашиглах эх сурвалжаа тодорхойлох, түүнчлэн конвенцийн нэрийг монгол хэлнээ зөв орчуулан хэрэглэх, тухайн конвенцийн агуулга, хэлбэрийг товч байдлаар танилцуулах нь дэлгэрүүлэн судлахад ач холбогдолтой юм. Нэмж хэлэхэд олон улсын эрх зүйн хамгийн нийтлэг хэм хэмжээ болох Pacta sunt servanda зарчимд агуулагддаг "Гэрээний нэр, хэлбэр нь түүний биелэлтэд сөргөөр нөлөөлөх ёсгүй" гэсэн тодорхой хэм хэмжээг хангах зорилготой шалгуур юм. Манай улс нэгдэн орох шаардлагатай гэгддэг олон улсын хүний эрхийн гэрээ конвенц болох "Дүрвэгсэдийн эрх зүйн байдлын тухай конвенц", "Бүх цагаач ажилчин ба тэдгээрийн гэр бүлийн эрхийг хамгаалах тухай конвенц"-ийг хооронд нь андуурах, эсхүл нэг конвенц мэтээр ойлгох асуудал гарч байсан байна.

Жишээ:

Конвенцийн албан ёсны нэр : Aarhus Convention Convention on Access to Information, Public Participation in Decision-making and Access to Justice in Environmental Matters

Конвенцийн монгол нэр: Аархусын конвенц- Байгаль орчны асуудлаар мэдээлэл олж авах, шийдвэр гаргахад оролцох, шүүхэд хандах эрхийн тухай конвенц

Батлагдсан огноо: 1998.7.25 Хүчин төгөлдөр болсон огноо: 2001.10.30

Товч танилцуулга:

Дани Улсын хот болох Аархуст зохиогдсон хурлаар нэрлэгдсэн конвенц юм.

Аархусын Конвенц:

- Гомдол хүлээн авах механизмтай
- Бохирдуулагч төлөх зарчим
- Нэгтгэлийн зарчим
- Шударга байдлын зарчим агуулсан.

Хүний эрхийн агуулга:

- Мэдээлэл авах эрх
- Байгаль орчны асуудлаар шийдвэр гаргах үйл явцад оролцох эрх
- Зөрчигдсөн эрхээ шүүхээр хамгаалуулах эрх тусгагдсан.

Энэ конвенц нь байгаль орчны асуудлаар мэдээллийн нээлттэй байдлыг хангах, шийдвэр гаргахад олон нийтийг оролцоог нэмэгдүүлэх, хөндөгдсөн эрхийг шүүхээр хамгаалах асуудлыг баталгаажуулах зорилготой.

2. Гэрээнд нэгдэн орох улс төр, эдийн засаг, нийгмийн үндэслэл, хэрэгцээ, шаардлага

Олон улсын гэрээнд оролцогч этгээдийн улс төр, эдийн засаг, нийгэм соёлын ашиг сонирхол тусгагдсан байдаг. Хэлэлцэн тохирогч этгээдүүдийн бүрэн тэгш, харилцан ашигтай байх, тэдгээрийн сайн дурын үндсэн дээр байгуулсан гэрээг орчин үеийн олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцсэн тэгш эрхийн гэрээ гэж үзнэ.

Энэхүү шалгуур нь тухайн конвенцийн товч танилцуулга буюу шалгуур 1-ээс улбаалан МУ-ын нэгдэн орох шаардлагатай гэрээ конвенцоор сонгон судлах болсон чухал алхам байх зайлшгүй хүчин зүйл мөн. Аливаа конвенцид нэгдэн ороход дотоод гадаад хүчин зүйлүүдээр нөхцөлдсөн улс төр, эдийн засаг, нийгмийн үндэслэл байх бөгөөд тэдгээр үндэслэл бүрийг тусгайлан судлах шаардлагатай.

Жишээ: "Бүх цагаач ажилчин ба тэдгээрийн гэр бүлийг хамгаалах тухай конвенц"-д нэгдэн ороогүй байгаагийн шалтгааныг тус гэрээнд манай улс нэгдэн орвол цагаач ажилчин олноороо ирснээр үндэсний аюулгүй байдалд харшилна гэж тайлбарладаг. Энэ нь тухайн конвенцийг зөвхөн гаднын цагаач ажилтнуудын эрх ашгийг хамгаалах мэтээр ойлгон үзэж, нэг талыг баримталсан хандлага юм. Гэтэл манай улс өөрөө гадаадад ажиллах хүч гаргагч улсын тоонд аль хэдийн багтах болсон. Түүгээр зогсохгүй гадаадаас ажиллах хүч олноор нь хүлээгээд авчихсан байгаа өнөөгийн тохиолдолд тус конвенцид нэгдэн ороогүйн улмаас зохицуулалтгүй харилцаа үүсэд байгаа юм.

3.Хууль зүйн үндэслэл /Үндсэн хууль болон бусад хуультай нийцэж буй эсэх/

2-р шалгуур болох улс төр, эдийн засаг, нийгмийн үндэслэл, хэрэгцээ шаардлагад тулгуурлан сонгосон конвенцид хууль зүйн хувьд үндэслэл бий эсэх асуудал хамгийн чухал шалгуур билээ. "Олон улсын гэрээ байгуулахад Монгол Улсын хувьд баримтлах онцгой зарчим бол Үндсэн хуулийн давуу байдал/примат/-ыг хангах явдал юм. Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 4-т заасан "Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй" гэж заасан нь үүний баталгаа болдог."[797]

Олон улсын гэрээний тухай хуулийн 27 дугаар зүйлд олон улсын гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан хууль, хууль тогтоомжийн бусад актад хэрхэн нэмэлт, өөрчлөлт оруулах талаар заасныг Монгол Улс олон улсын олон талт гэрээнд нэгдэж ороход мөн холбогдуулан судлах ёстой.

Олон улсын эрх зүй ба үндэсний эрх зүйн харилцан хамаарлын талаарх онолоор авч үзвэл, эдгээр нь нэг салбар бөгөөд бүх эрх зүй нь нийтлэг нэг норматив шинжтэй гэж ойлгодог "монизм" гэсэн онолд манай улс хамаардаг. Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ" гэсэн тодорхой

[797] "МУ-ын Олон улсын гэрээний тухай 1993 оны хуулийн шинжлэх ухаан, практикийн тайлбар "судалгааны тайлан дахь доктор, профессор Б.Чимидийн тус хуульд хийсэн тайлбар, 2009 он

заалт үүнийг батална. Иймд олон улсын гэрээг дотоодын хууль тогтоомжид тусгах шаардлагагүй болж байгаа юм.

Гэвч зарим олон улсын олон талт гэрээнд дотоодын хууль тогтоомждоо тусгахыг шаардсан заалт байх ба тэдгээр нь голчлон хариуцлага хүлээлгэх, эрүүгийн хариуцлагатай холбоотой заалт байдаг. Тухайлбал, Монгол Улсын нэгдэн орсон Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг / Палермогийн/ конвенцийн хөрөнгө албадан хураахтай холбоотой 12 дугаар зүйлд "оролцогч улс бүр өөрийн дотоодын эрх зүйн тогтолцооны хүрээнд боломжийн хэрээр тусгаж батална" гэж заажээ. Ингэснээр энэхүү конвенцийг соёрхон батлахдаа Монгол Улсын Эрүүгийн болон бусад холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан байдаг.[798]

Тэгэхээр Үндсэн хуульд нийцэж байгааг судалж тогтоох нь тухайн гэрээнд нэгдэж орохыг тодорхойлох гол шалгуур, үндсэн зарчим байх бол бусад хуулийг хэрхэн нийцүүлэх асуудал бас чухалд тооцогдох учиртай. Үүнийг судалж тогтоох нь олон улсын эрх зүйн хэм хэмжээ ба үндэсний хууль тогтоомжийн зөрчилдөөний асуудал үүсэхгүй байх, үүсэхээр тохиолдлыг урьдаас мэдэж, ул суурьтай судалж, оновчтой зохицуулалт хийхэд суурь ач холбогдол оршино.

Жишээ: /Аархусын конвенцийн хувьд/

Монгол Улсын Үндсэн хуулийн зүйлийн 16 дугаар зүйлийн 2-т "эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй"; 16 дугаар зүйлийн 12-т "төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй"; 16 дугаар зүйлийн 14-т "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх....", 16 дугаар зүйлийн 17-д "төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй..." гэж тус тус заасан нь Үндсэн хуулийн үзэл баримтлалд Байгаль орчны асуудлаар мэдээлэл олж авах, шийдвэр гаргахад оролцох, шүүхэд хандах эрхийн тухай Аархусын конвенц бүрэн нийцэж байгааг илтгэж байна. Түүнчлэн Үндсэн хуулиа сахин биелүүлж, иргэн бүр байгаль орчноо хамгаалах журамт үүргээ гүйцэтгэхэд ч тус конвенц чухал ач холбогдол өгнө. Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлд "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна" гэсэн заалттай Аархусын конвенц нийцэж байгаа ба Үндсэн хуулийн дээрх заалтуудыг хэрэгжүүлэхэд тус конвенцид нэгдэх хэрэгцээ, шаардлага байгаа нь улам бүр харагдана.

---

[798]"Монгол Улсын Олон улсын гэрээний тухай 1993 оны хуулийн шинжлэх ухаан, практикийн тайлбар"судалгааны тайлан дахь докторант А.Төмөрийн тус хуульд хийсэн тайлбар, Уб., 2009 он

Аливаа шийдвэр гаргах явцад иргэдийн оролцоог хангах тухай хуулийн заалтыг хэрэгжүүлэх тодорхой механизмыг аль ч холбогдох хуульд суулгаагүй тул энэ эрх хэрэгждэггүй билээ. Байгаль орчны хохирлыг төр нэхэмжлэх зохицуулалттай ч ашиг сонирхлын зөрчлөөс шалтгаалан нэхэмжлэл гаргадаггүй. Хувь хүн болон төрийн бус байгууллагад нийтийн эрх ашгийн төлөө нэхэмжлэл гаргах эрх олгогдоогүй тул байгаль орчныг хамгаалах механизм, эрх зүйн орчин бүрдээгүй байна. Иймд байгаль орчны холбогдох хуулиудад энэ эрхийг суурилуулж, хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

4.Гэрээнд нэгдэн орсноор үүсэх үр дагавар, ач холбогдол

Энэ нь тухайн гэрээнд нэгдэн орсноор үүсэх нөхцөл байдлууд бөгөөд нэгдэн орох талаас судалж тогтооход үр дагавар нь голдуу ач холбогдолтой тал байх болов гарч болзошгүй сөрөг үр дагаврыг бас илрүүлэхэд тустай байх болно. Жишээ: Дүрвэгсэдийн эрх зүйн байдлын тухай конвенцийг 2 удаа Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр оруулаад хүлээж аваагүй. Шалтгаан нь нэгдэн орсноор үүсэх үр дагавар нь олон дүрвэгсдийг хүлээн авах үүрэгтэй болно, энэ нь үндэсний аюулгүй байдалд харшилж болзошгүй гэсэн байна. Гэхдээ үүнээс гадна тухайн конвенцид нэгдсэнээр манай улсад ач холбогдолтой тал бас үүсч болохыг үгүйсгэх аргагүй юм.

Жишээ: /НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколд нэгдсэнээр/ Энэхүү нэмэлт протоколд зааснаар хорих газарт шалгалт хийх явдал нь зөвхөн нөхцөл байдалтай өөрийн биеэр танилцаад зогсохгүй, шалгалт хийж байгаа мэргэжилтнүүдэд хоригдож байгаа этгээдтэй хэрхэн харьцаж байгаа мөн тэдгээрийг ямар орчин нөхцөлд хорьж байгаад үнэлэлт өгөх бололцоог олгодог. Хорих газарт шалтгалт хийх мэргэжилтнүүд нь шаардлагатай өөрчлөлтүүдийг хийх талаар зөвлөмж гаргаж, холбогдох эрх бүхий байгууллагуудтай илэрсэн алдаа дутагдлыг арилгахад туслалцаа үзүүлэх талаар хэлэлцээ өрнүүлж болдог.

Монгол Улсын тухайд энэ ажиллагааг явуулах үндэсний байгууллагуудын хэлбэр, статус, эрх хэмжээний асуудлыг бусад ойролцоо чиг үүрэг бүхий байгууллагаас /тухайлбал прокурорын байгууллагаас/ ялгаж салгах болон хамтын ажиллагааг уялдуулах замаар оновчтой зөв шийдвэрлэх явдал бол энэхүү нэмэлт протоколд нэгдэн ороход зайлшгүй тулгарах асуудал мөн. ХЗҮХ-гийн ЭЭЗКСС-ын эрдэм шинжилгээний ажилтан Г. Оюунболд Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн нэмэлт Протоколд Монгол Улс нэгдэн орох шаардлагатай эсэх талаар гаргасан санал[799]-даа "Хүний эрхийн Үндэсний комиссын удаа дараа хийгдсэн шалгалтын дүнгээс үзэхэд эрүүдэн шүүх явдал хууль сахиулах байгуулагад амь бөхтэй, нууц далд хэлбэртэй оршсоор байгаа нь бодитой бөгөөд үүнийг таслан зогсоохын тулд энэхүү нэмэлт протоколыг батлах хэрэгтэй юм. Харин хорих газруудад шалгалт хийх үндэсний байгууллагыг байгуулах тал дээр ... хуулийн байгууллагуудын тэр тусмаа прокурорын байгууллагаас гарч байсан саналаас үзэхэд "ажил үүргийн хуваарь давхардах, хийх ажилд нь нөлөөлөх магадлалтай, прокурорын бүрэн эрхийн нэг хэсгийг авч хэрэгжүүлэх гэж байна" гэсэн

[799] Хавсралт

хандлага байсан бөгөөд үүнийг сайтар харгалзах хэрэгтэй байна" гэжээ.

Практикт "тус нэмэлт протоколд нэгдсэнээр манай улсын шоронгийн байдалтай олон улсын зүгээс танилцсанаар шоронгийн орчин нөхцөл муу гэдгээ таниулах талтай гэсэн болгоомжлол байгааг дурьдахад харамсалтай байна. Энэ нь нэгдэн орох асуудлын сөрөг тал биш харин ч эерэг тал буюу манай улсын тухайд, хорих, саатуулах газруудын орчин нөхцөл сайжрахад нөлөөлөх, дэмжлэг үзүүлэх хүчин зүйл болж чадах юм. Ингэснээрээ манай улсын хүний эрхийг хангах, хамгаалах талын орчин сайжирна.

5.Гэрээнд нэгдэн ороход гарах зардал, санхүүгийн асуудал

Аливаа олон улсын гэрээнд нэгдэж орох асуудал нь тухайн улсын сайн дурын асуудал болохоор олон улсын гэрээг батлах, соёрхон батлах бол улс дотоодын үүрэг буюу түүнээс гарах зардлаа өөрсдөө биелүүлэх учиртай билээ.

Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулийн 29 дүгээр зүйлд "Монгол Улсын Их Хурлаас олон улсын гэрээг соёрхон батлах, нэгдэж орох Засгийн газраас олон улсын гэрээг батлах шийдвэр гаргахдаа тухайн олон улсын гэрээг орчуулах, хэвлэхтэй холбогдсон зардлыг тухайн байгууллага хариуцан төсөвтөө тусган санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэж байна" гэж заасан байдаг. Үүнээс харахад олон улсын гэрээг соёрхон батлах, нэгдэж ороход гарах зардал нь орчуулга болон хэвлэхтэй холбоотой зардлыг Олон улсын гэрээний тухай хуульд иймхүү тусгажээ. Гэвч түүнээс өөр зардал гарахыг үгүйсгэхгүй юм.[800]

Олон улсын гэрээний тухай хуульд бусад зардлыг, ялангуяа аливаа гэрээнд нэгдэн ороход судалгаа хийх, түүнд зориулсан төсвийн талаар заагаагүй, зөвхөн гэрээний орчуулга, хэвлэн нийтлэх ажлын зардал төдийгөөр хязгаарласан байгаа нь өнөөдөр манай улс олон улсын гэрээнд нэгдэн орохдоо судалгаатай ханддаггүйн бас нэг шалтаг, шалтгаан гэж үзэж байна.

Түүнчлэн олон улсын гэрээ конвенцид нэгдэн орох асуудлаар хэлэлцсэн УИХ-ын хуралдааны протоколыг судлан үзэхэд зардал, төсвийн асуудал, мөн гэрээ конвенцид нэгдэн орсноор төлөх татварын асуудлыг байнга асуусан байх боловч нарийн хариулт өгөөгүй нь харагддаг.

Мөн олон улсын гэрээнд нэгдэхэд өндөр хэмжээтэй татварын асуудал тулгардаг гэсэн ойлголт байдаг ба тэр нь буурай хөгжилтэй оронд дарамт болно гэсэн болгоомжлол бас анзаарагддаг. Гэвч хүний эрхийн конвенцийн хувьд ингэж ярих нь утгагүй юм. Олон улсын байгууллага, гэрээ конвенцийн итгэмжит санд төлөх татвар, хандивын тухай ЗГ-ын тогтоолоор улсын төсвөөс татварыг нь төлж байх олон улсын байгууллагын жагсаалт, улсын төсвөөс хандив төлөх олон улсын гэрээ конвенцийн итгэмжит сангийн жагсаалтыг тус тус хавсралтаар баталсан байна. Эдгээр жагсаалттай танилцахад Халимны менежментийн тухай олон улсын конвенцийн итгэмжит санд хандив төлдөг нь сонирхол татаж байгаа юм. Тэгэхээр хүний эрхийн аливаа

[800]"МУ-ын Олон улсын гэрээний тухай 1993 оны хуулийн шинжлэх ухаан, практикийн тайлбар"судалгааны тайландахь докторант А.Төмөрийн тус хуульд хийсэн тайлбар, 2009он

гэрээ конвенцид нэгдэн ороход татварын асуудал саад болох учиргүй боловч судалж зохицуулахгүй байх үндэсгүй чухал зүйл мөн.

6.Монгол Улсын Гадаад Харилцааны Яамны баримталж буй чиглэл

Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 1-д Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна, Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ гэж заасан байдаг. Энхийг эрхэмлэсэн бодлого явуулах зарчим нь төрийн гадаад бодлого, тэр дундаа олон улсын гэрээ байгуулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсийг илэрхийлж байгаа юм. Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх явдлыг аливаа гадаад харилцаанд суурь зарчим болгон баримтална.[801] Үндсэн хуулийн энэхүү үндэслэлийн дагуу МУ-ын Их хурал 1994 онд "МУ-ын гадаад бодлогын үзэл баримтлал"-ыг баталсан нь олон улсын гэрээний талаар баримтлах бодлогын үндэс болно.

Гадаад харилцааны яам бол төрийн гадаад бодлогыг хэрэгжүүлж буй байгууллага учир тухайн конвенцид нэгдэн орох талаар ямар байр суурьтай хандаж байна, тухайн конвенцид нэгдэж ороогүйн шалтгаан эсхүл нэгдэж орох талаар ямар бодлого, чиглэлтэй ажиллаж байгааг тодруулж судалгааг баяжуулах, судалгааны үр дүнтэй харьцуулах зорилготой. Гэхдээ энэ нь өөрөө судалгааны ажил учир судалгааг бие даасан, хараат бус байдлаар явуулах зарчмыг баримтлах нь зүйтэй.

7.**Бусад орны жишиг**

Энэ нь тухайн конвенцид нэгдэн орсон, соёрхон баталсан, гарын үсэг зурсан болон нэгдээгүй байгаа улс орнуудын талаархи мэдээллийг агуулах бөгөөд Монгол Улс тухайн конвенцид нэгдэхдээ харгалзах шалгуурт тооцогдох, Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд тусгагдсан зүйл юм. Тус үзэл баримтлалд "Монгол Улсын гадаад бодлогын зорилт нь тус улс хүн төрөлхтний хөгжлийн жамыг даган бүх улс оронтой найрсаг харилцаатай байж, олон улсын хамтын нийгэмлэгт байр суурьиа бэхжүүлэн, бүс нутгийн болон дэлхийн нөлөө бүхий улс гүрнүүдтэй улс төр, эдийн засгийн болон бусад ашиг сонирхлын шүтэлцээ бүхий харилцааны сүлжээ бүрдүүлэх замаар улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бат найдвартай хангах явдал мөн" гэж заасныг үндэс болгохын сацуу "Монгол Улс гадаад улс төрийн бодлогодоо энхийг эрхэмлэж, улс гүрэнтэй сөргөлдөхгүй байхыг аль болохоор чухалчилж, олон тулгуурт бодлого явуулна. Үндэснийхээ ашиг сонирхлыг ямагт дээдлэхийн хамт бусад улс, түншийнхээ хууль ёсны

[801] "МУ-ын Олон улсын гэрээний тухай 1993 оны хуулийн шинжлэх ухаан, практикийн тайлбар"судалгааны тайлан дахь доктор, профессор Б. Чимидийн тус хуульд хийсэн тайлбар, 2009 он

ашиг сонирхлыг хүндэтгэнэ. Монгол Улсын үндэсний ашиг сонирхлыг шууд хөндөөгүй хөрш хоёр орныхоо маргаанд хөндлөнгөөс үл оролцоно...", "ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд аль нэгийг нь өрөөсгөлөөр дагахгүй, бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хамтын ажиллагаа хөгжүүлнэ...." зэрэг улс төрийн бодлогыг хэрэгжүүлэхдээ баримтлах чиглэлүүдийг ч харгалзах хэрэгтэй юм. Жишээлбэл, 2 хөрш орон тухайн конвенцид ямар байр сууринаас хандаж байна; "Бүх цагаач ажилчин ба тэдний гэр бүлийн эрхийг хамгаалах тухай конвенц"-ийн тухайд манай улсын иргэд олноороо цагаачлан ажиллаж амьдардаг БНСУ, АНУ гэсэн орнууд нэгдэж ороогүй байгаа тохиолдолд манай улс нэгдэж орох ашигтай эсэх маргаан өрнөж болох юм.

Нэмж хэлэхэд тухайн гэрээ конвенцид нэгдэж орсон улс орнуудын зөвхөн элсэлтийн тооноос гадна элсэж орсноос хойшхи гэрээний хэрэгжилтийн байдал, гарч буй зөрчлийн шийдвэрлэлт зэрэг практик туршлагыг судалж үзэх хэрэгтэй. Мөн бусад улс орнууд олон улсын гэрээ конвенцид нэгдэн орохдоо ямар шалгуураар харгалзан үздэг болохыг тухайлан судлах шаардлага бас анхаарал татаж байна.

Дүгнэлт

Судалгааны ач холбогдол

Олон улсын эрх зүй нь улс орнуудын харилцааг улс төрөөс ангид үр дүнтэй зохицуулах хэрэгсэл төдийлөн болж чадахгүй байгааг анхааралдаа авч, орчин үеийн гадаад бодлогын үзэл хандлагад Монгол Улсын нөлөөг бэхжүүлэх үүднээс аливаа гэрээ, хэлэлцээрт тодорхой нэг үзэл баримтлалаар хандах, үүсэх үр нөлөө нь гадаадад болон дотооддоо зөрчил гаргахгүй байх үүднээс манай улсад олон улсын гэрээнд нэгдэж орох асуудалд судалгаатай хандах шаардлага урган гарч байна. Тиймээс тус судалгаа нь нэгдэн орох шаардлагатай олон улсын гэрээ конвенцийг тодорхой шалгуураар судлан тодорхойлох зохицуулалтыг болвсронгуй болгох, цаашид олон улсын гэрээнд нэгдэхтэй холбоотой хууль зүйн системийн нэгдсэн практик тогтооход дөхөм үзүүлэх ач холбогдолтой юм.

Олон улсын гэрээнд нэгдэн ороход судалгаатай хандах асуудлыг хэрэгжүүлж ажиллавал :

✓ Олон улсын эрх зүйн зохицуулалтад амжилттай оролцох, олон улсын харилцаанд зөв алхам хийх

✓ Улс төр, эдийн засаг, нийгмийн харилцаанд зөв бодлого боловсруулах, оновчтой шийдвэр гаргах

✓ Олон улсын эрх зүйн хэм хэмжээ ба дотоодын хууль тогтоомжийн уялдаа, холбоог нийцүүлэх

✓ Олон улсын гэрээг хэрэглэх, сургалт, сурталчилгаа явуулахад ашиглах эх сурвалж бэлтгэгдэх

✓ Олон улсын гэрээг хэрэгжүүлэх, биелэлтийг шалгах, тайлагнах зэрэг шат шатны үйл ажиллагаанд харгалзан үзэх шинжлэх ухааны үндэстэй шалгуур үзүүлэлт бий болох зэрэг тал бүрийн ач холбогдлыг бий болгох болно.

Судалгааны үр дүн

Олон улсын гэрээ конвенцид нэгдэж ороход судалгаатай хандах саналыг дэвшүүлж, судалгаанд ашиглах шалгуурыг боловсруулж гаргасан ба энэ шалгуураар МУ-ын нэгдэн орох хүний эрхийн гэрээ конвенцийг судлан тодорхойлох нь аливаа гэрээ конвенцид нэгдэхдээ үндэслэлтэй хандаж, авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хуульд оруулах өөрчлөлт, гарах үр дүн, тулгарах зардал, санхүүгийн асуудал зэргийг давхар харгалзан шийдвэрлэж нэгдэх зэрэг ач холбогдолтой талыг илрүүлж, асуудал дэвшүүлсэн үр дүнд хүрлээ. Мөн энэ ажлаараа МУ нэгдэн орох шаардлагатай олон улсын хүний эрхийн гэрээ конвенцийн жагсаалтыг тойм байдлаар судалж гаргалаа.

Тус судалгааны ажлын хүрээнд боловсруулсан шалгуур нь Монгол Улс нэгдэн орох шаардлагатай гэрээ конвенцийг дэлгэрэнгүй судлахад үр дүнтэй юм. Судалгааны ажлын дүнд "Олон улсын гэрээнд нэгдэхэд судалгаатай хандах асуудал" сэдвээр "Хууль дэздлэх ёс" сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлэхээр бэлтгэсэн.

Судалгааг хийх явцад тулгарсан бэрхшээл:

Тус судалгаа нь ХЗҮХ-ийн 2010 оны төлөвлөгөөт судалгаа бөгөөд Монгол Улс нэгдэн орох шаардлагатай гэрээ конвенцийн жагсаалтыг гаргах төдий байдлаар төлөвлөгөөнд тусгагдсан, мөн ажлыг гүйцэтгэх хугацаа хангалтгүй байсны улмаас судалгааны онол практикийн үндэслэл, харгалзан үзэх шалгуурын асуудлыг боловсруулж харгалзсан ололттой тал байгаа боловч нэгдэн орох шаардлагатай гэрээ конвенцийг зөвхөн тойм байдлаар судалсны үндсэн дээр нэрсийн жагсаалтыг гаргалаа. Гэхдээ энэ нь тухайн конвенц бүр дээр, тэрчлэн тухайн конвенцид нэгдэн орох үндэслэл бүр дээр тусгайлсан судалгаа шаардлагатай гэсэн судлаачийн зүгээс дэвшүүлж байгаа санал, зарчмын үүднээс үзэхэд судалгааны ажлын хугацаа хангалтгүй ба тухайн конвенцид нэгдэхтэй холбоотой зардал, эдийн засгийн тооцоог тус судалгааны ажлын хүрээнд хийх боломжгүй болно.

Дүгнэлт

Тус судалгаагаар Монгол Улсын нэгдэн ороогүй ба нэн даруй нэгдэх шаардлагатай гэрээ конвенцийн хувьд зөвхөн нэрсийн жагсаалт гаргахыг урьтал болгоогүй бөгөөд олон талт гэрээнд нэгдэн орохтой холбоотой олон улсын эрх зүйн хэм хэмжээ болон дотоодын хууль тогтоомжийн зохицуулалт, түүнтэй холбогдсон харилцааг онол, практикийн төвшинд судаллаа. Олон улсын гэрээг соёрхон батлах хуулийн төслийг судалгаанд үндэслэж боловсруулах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн эрх зүйн ерөнхий зохицуулалт байгаа боловч практикт хэрэгжихгүй байна.

Иймд олон улсын гэрээг соёрхон батлахад хэлэлцэх асуудлыг ямар түвшинд дэлгэрэнгүй үндэслэл сайтай судалж хандах явдлыг нарийн зохицуулах шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл, олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийг богино хугацаанд хэлэлцэн батлахын тулд өмнө шатанд нарийн судлах бөгөөд түүндээ тулгуурлан үндэслэлийг нь бодитой, чанартай гаргах ажиллагааг идэвхжүүлэн хэвшүүлэх шаардлагатай байна.

Олон улсын гэрээнд нэгдэн ороход судалгаатай хандах асуудалд анхаарлаа хандуулж, холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар зарим саналыг дурьдсан болно. Мөн олон улсын хүний эрхийн 5 конвенцийг нэгдэн орох шаардлагатай гэж тус судалгааны ажлын хүрээнд тодорхойлж, санал гаргалаа.

Санал

Тус судалгааны ажлын хүрээнд дараах саналыг гаргаж байна. Үүнд:

-Олон улсын гэрээнд нэгдэн ороход судалгаатай хандахад эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох тухай санал

- МУ нэгдэн орох шаардлагатай гэрээ конвенцийг судлан тодорхойлоход харгалзах шалгуур

- МУ нэгдэн орох шаардлагатай болон нэн даруй нэгдэх шаардлагатай олон улсын хүний эрхийн гэрээ конвенцийн жагсаалт

- Монгол Улс нэгдэн орох шаардлагатай олон улсын хүний эрхийн гэрээ конвенцийн тухайд ХЗҮХ-ийн Эрүүгийн эрх зүй, криминологийн секторын судалгааны саналыг нэмэв.

Олон улсын гэрээнд нэгдэн ороход судалгаатай хандахад эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох тухай санал

Санал 1

Олон улсын гэрээнд нэгдэн ороход судалгаатай хандахад эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох тал дээр зарим саналыг дараахь байдлаар гаргаж байна. Үүнд:

1.1993 оны "Олон улсын гэрээний тухай хууль"-ийг боловсронгуй болгох хүрээнд:

1/ МУ-ын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд заасан Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээг дагаж мөрдөхгүй байх тухай заалтыг хангах зохицуулалтыг нарийвчлах;

2/Гэрээнд нэгдэхтэй холбоотой зардал, санхүүгийн асуудалд судалгаанд холбогдох зардлын талаар нэмж тусгах;

3/ Хүчин төгөлдөр бус гэрээ буюу хүчингүйд тооцогдох олон улсын гэрээ байгуулсан, байгуулахад хүргэсэн, нөлөөлсөн, урьдчилан сэргийлээгүй болон бусад хэлбэрээр алдаа, зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцох тухай заалт оруулах;

2. "Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль"-ийн зохицуулалтыг боловсронгуй болгох хүрээнд:

1/ Олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийн төсөлд тавигдах шаардлагыг нарийвчлан тодорхойлох;

2/ Олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг хялбаршуулсан, шуурхай байдлаар хийхийн тулд тухайн олон улсын гэрээнд нэгдэхтэй холбоотой судалгааг тодорхой шалгуур, аргачлалын дагуу чанартай хийж, хуулийн төсөлд хавсарга байдлаар танилцуулж байх зохицуулалтыг тусгах

Санал 2

Монгол Улсын нэгдэн орох шаардлагатай олон улсын хүний эрхийн гэрээ конвенцийг судлан тодорхойлоход харгалзан үзэх наад захын жишиг гэж үзэх шалгуурыг санал байдлаар гаргаж байна.

Монгол Улс нэгдэн орох шаардлагатай олон улсын хүний эрхийн гэрээ конвенцийг судлан тодорхойлоход харгалзах шалгуур

1.*Гэрээний албан ёсны нэр, монгол нэр, товч танилцуулга, батлагдсан огноо*

2.*Гэрээнд нэгдэн орох улс төр, эдийн засаг, нийгмийн үндэслэл, хэрэгцээ, шаардлага*

3.*Хууль зүйн үндэслэл /Үндсэн хууль болон бусад хуультай нийцэж буй эсэх/*

4.*Гэрээнд нэгдэн орсноор үүсэх үр дагавар, ач холбогдол*

5.*Гэрээнд нэгдэн ороход гарах зардал, санхүүгийн асуудал*

6.*МУ-ын Гадаад Харилцааны Яамны баримталж буй чиглэл*

7.*Бусад орны жишиг*

Санал 3

Монгол Улс нэгдэн орох шаардлагатай олон улсын хүний эрхийн гэрээ конвенцийн жагсаалт:

1. *НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт протокол*

2. *Иргэний болон Улс төрийн Эрхийн тухай Олон улсын Пактын хоёр дахь Нэмэлт протокол / Цаазаар авах ялыг халах зорилго бүхий /*

3. *Бүх цагаач ажилчид ба тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай конвенц*

4. *Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай конвенц*

5. *Аархусын конвенц - Байгаль орчны асуудлаар мэдээлэл олж авах, шийдвэр гаргахад оролцох, шүүхэд хандах эрхийн тухай конвенц*

Санал 4

ХЗҮХ-ийн Эрүүгийн эрх зүй, криминологи судалгааны секторын санал

Монгол Улс нэгдэн орох шаардлагатай олон улсын хүний эрхийн гэрээ конвенцийн тухайд

Цаазаар авах ялыг халах зорилготой Иргэний болон Улс төрийн Эрхийн тухай Олон улсын Пактын Хоёр дахь Нэмэлт Протокол : Тухайн олон улсын конвенцийг соёрхон баталснаар үүсэх сөрөг үр дагавар үгүй бөгөөд хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгмийг байгуулах /ҮХ-д заасан/ зорилгод нийцсэн алхам болох юм.

Нэгдэн орсон тохиолдолд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт заавал оруулах шаардлагагүй бөгөөд тус хуулийн Арван зургадугаар зүйлийн нэгд "Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно" гэж заасныг өөрчлөх үндэслэл болохгүй юм. Харин Эрүүгийн

хуульд заасан цаазаар авах ялыг өөрчлөх, ялын төрлийг шинээр хуульчлах замаар шийдвэрлэх бололцоотой байна.

Эрүүдэн шүүхийн эсрэг нэмэлт протоколын тухайд: Дээрх нэмэлт протоколыг соёрхон батлах хэд хэдэн шаардлага байна. Үүнд:

- Эрүүдэн шүүх явдлаас урьдчилан сэргийлэх
- Хорих болон урьдчилан хорих байранд гарч байгаа эрүүдэн шүүх явдлыг таслан зогсоох, арга хэмжээ авах

Хүний эрхийн Үндэсний комиссын удаа дараа хийгдсэн шалгалтын дүнгээс үзэхэд эрүүдэн шүүх явдал хууль сахиулах байгуулагад амь бөхтэй, нууц далд хэлбэртэй оршсоор байгаа нь бодитой бөгөөд үүнийг таслан зогсоохын тулд дээрх нэмэлт протколыг батлах хэрэгтэй юм.

ХЗХДЯ дээрх нэмэлт протоколд нэгдэн орох асуудлыг судлах зорилгоор 2008 онд ажлын хэсэг гарч ажиллаж байсан бөгөөд нэгдэн орох эсэх талаар дүгнэлт хийгдээгүй байна. Тухайн үед хуулийн байгууллагуудын тэр тусмаа прокурорын байгууллагаас гарч байсан саналаас үзэхэд "ажил үүргийн хуваарь давхардах, хийх ажилд нь нөлөөлөх магадлалтай прокурорын бүрэн эрхийн нэг хэсгийг авч хэрэгжүүлэх гэж байна" гэсэн хандлага байсан бөгөөд үүнийг сайтар харгалзах хэрэгтэй байна.

Тухайн нэмэлт протоколд зааснаас үзэхэд нэгдэн орсон улс нь тусгайлсан дэд хороог байгуулах хэрэгтэй бөгөөд уг хороо нь хэнээс ч хараат бусаар үйл ажиллагаа явуулж, хорих, мөрдөн байцаах байгууллагад хэдийд ч нэвтрэн орж эрүүдэн шүүж буй бүхий л хэлбэрүүдийг таслан зогсоох, урьдчилан сэргийлж байх талаар зөвлөмж өгч байх эрх, үүрэгтэй байна. Хүний эрхийг хангах талаар гадаадын улс орнуудын туршлагыг судлан үзэхэд дээрх хороог байгуулан ажиллаж эхлээд байгаа юм.

Монгол Улс нэгдэн орох шаардлагатай олон улсын хүний эрхийн гэрээ конвенцийн танилцуулга[802]:

Бүх цагаач ажилчин ба тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай конвенц

Конвенцийн албан ёсны нэр : *International Convention on the Protection of the Rights of All Migrant Workers and Members of Their Families*

Батлагдсан огноо : 1990.12.18

Хүчин төгөлдөр болсон огноо:

ТАНИЛЦУУЛГА:

1990 оны 12 дугаар сард НҮБ-ын Ерөнхий ассамблей "Бүх цагаач ажилчин ба тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай конвенц"-ийг батлалсан.

"Цагаач ажилтан" гэдэг нь гадаад улс оронд цалин хөлстэй ажил эрхлэх гэж байгаа буюу одоо эрхэлж байгаа, эсхүл тийм ажил хийж байсан хүнийг хэлнэ. Конвенц нь цагаач ажилтны эрхийг хүлээн зөвшөөрүүлэх, уг эрхийг хамгаалах, хүндэтгэн үзэх талаар тавьж буй хүчин чармайлтын түүхэнд шинэ хуудас нээсэн юм. Энэ нь заавал биелэгдэх шинжтэй гэрээ конвенци, НҮБ-ын хүний эрхийн талаархи судалгаа, шинжээчдийн хурлаас гаргасан дүгнэлт, зөвлөмж болон сүүлийн хорь гаруй жилд НҮБ-ын эрхлэх байгууллагуудаас цагаач ажилтны эрхийн асуудлаар хийсэн хэлэлцүүлэг, баталсан тогтоол зэргэт үндэслэн боловсруулсан олон улсын хүний эрхийг хангахад дэвшил болсон цогц гэрээ байдаг.

Уг конвенц нь олон улсын хүний эрхийн бусад гэрээ конвенцуудын адил улс тус бүрийн хууль тогтоомж, шүүхийн болон захиргааны хэргийг байцаан шийтгэх ажиллагаанд загвар болох хэм хэмжээг тогтоосон. Конвенцид гарын үсэг зурсан буюу нэгдэн орсон улсуудын засгийн газар шаардлагатай арга хэмжээг авах замаар түүний заалтуудыг хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг. Мөн эрх нь зөрчигдсөн цагаач ажилтанд шүүхэд хандаж эрхээ хамгаалуулах нөхцөлийг бүрдүүлэх ёстой.

Нэгдэх үндэслэл, шаардлага:

Цагаач ажилтны эрхийн асуудал нь одоо цагт хүний эрхийн гол анхаарал татсан асуудлуудын нэг болоод байна. Ядуурал, нөгөө талаас өөрийгөө болон гэр бүлээ хангалттай тэжээж чадахуйц цалин хөлс авч чадахгүй байх нь хүмүүсийг нэг улсаас нөгөө улс руу ажил хайн явах нэгэн гол шалтгаан болж байдаг.

[802] Энэхүү танилцуулгын зарим мэдээлэл нь холбогдох байгууллага болон www.mfat.gov.mn, www.mn-nhrc.org, www.upr-mongolia.mn, www.forum.mn*зэрэг* веб сайтуудаас судалгаанд авч ашигласан зөвхөн мэдээллийн шинжтэй хавсралт бөгөөд судалгааны ажлын хүрээнд боловсруулсан шалгуураар конвенц бүрийг нарийвчлан судлах шаардлагатай гэсэн саналыг тайланд тусгасан болно.

Зарим улс өөрийн иргэдийг гадаадад ажиллуулахыг дэмждэг бол нөгөө зарим нь гадаадын ажилтныг олноор нь авч ажиллуулдаг. Манай улс өөрийн иргэдийг гадаадад ажилуулахыг дэмждэг улсад багтах ба ихэнхдээ БНСУ, АНУ, Япон, Тайваньд ажиллах хүч гаргаж байна. Манай улсаас авч ажиллах хүчний тоогоороо БНСУ тэргүүлдэг юм. Нийгэм, эдийн засаг, хөдөлмөрийн тогтолцоо, эрх зүй, хэл, ёс заншил, сэтгэл зүйн огт өөр нөхцөлд ажиллаж буй монгол иргэдэд орчиндоо дасан зохицох, хөгжих, өөрийн эрх ашиг, эрүүл мэндээ хамгаалах талын мэдээлэл дутагдалтай байдаг . Иргэд хөдөлмөрийн хөлсөө авч чадахгүй байх, үйлдвэрийн осолд орох, гэмтэх бэртэх, эрүүл мэндээрээ хохирох, амь насаа алдах зэргээр эрх нь зөрчигдөх тохиолдол цөөнгүй гардаг байна.

Ер нь цагаач ажилтан нь гэрээгээр буюу бусад албан ёсны тохиролцооны дагуу ажиллаж байгаа, эсхүл өөрсдийн санаачилгаар хөдөлмөр эрхлэж байгаагаас хамаарахгүйгээр очих гэж буй орныхоо хэл, соёл, эрх зүйн болон нийгэм, эдийн засгийн тогтолцооны талаар наад захын ойлголтыг олж авсан байх шаардлагатай. Мөн тэнд очоод авах цалин хөлс, ажлын нөхцөл болон амьдралын ерөнхий нөхцөл байдлын талаар урьдчилан мэдсэн байх учиртай. Бүх цагаач ажилтан ба тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын Конвенцийн 33 дугаар зүйлд заасан ёсоор оролцогч улсууд энэхүү конвенциор олгогдсон эрх болон хүлээн авагч улсад дагаж мөрддөг захиргааны болон бусад дүрэм журмын талаархи мэдээллийг цагаач ажилтан ба тэдний гэр бүлийн гишүүдэд хүсэлтийнх нь дагуу үнэ төлбөргүйгээр, хэрэв боломжтой бол тэдний ойлгодог хэлээр өгөх талаар холбогдох арга хэмжээг авахыг үүрэг болгосон. Мөн түүнчлэн конвенцийн 37 дугаар зүйлд цагаач ажилтан болон тэдний гэр бүлийн гишүүд "хүлээн авагч улс руу явахаас өмнө эсхүл цаад зах нь тус улс руу нэвтрэхээс өмнө" тийнхүү нэвтрэхэд шаардагдах бүхий л нөхцөл шаардлага болон "хүлээн авагч улсад биелүүлэх ёстой шаардлагууд ба тэдгээр шаардлага өөрчлөгдсөн үед хандах ёстой байгууллагын талаар" мэдээлэл авах эрхтэй хэмээн заасан байдаг.

Хөдөлмөрийн салбарт цагаач ажилтныг ялгаварлан гадуурхах янз бүрийн хэлбэр байдаг. Тухайлбал, цагаачдад нээлттэй буюу хаалттай байдаг ажлын төрөл хэлбэрүүд, мэргэжлийн боловсрол эзэмшихэд учирдаг саад тотгор зэргийг дурдаж болно. Ажлын нөхцөлийн талаар тухайн улсын харьяат иргэд болон цагаач иргэдэд ихэвчлэн ялгаатай стандарт үйлчилдэг бөгөөд хөдөлмөрийн гэрээ ч цагаачдад зарим нэг давуу тал олгодоггүй.

Бүх цагаач ажилтан ба тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай конвенцийн 25 дугаар зүйлийн 1-д "цагаач ажилтан нь цалин хөлсний болон ажлын байрны бусад нөхцөл, хөдөлмөрийн нөхцөлийн хувьд ажил олгогч улсын харьяат иргэдэд үйлчилдгээс дутуугүй таатай нөхцөлийг эдлэнэ" хэмээн заасан бол 25 дугаар зүйлийн 3-т цагаач ажилтны дээрх эрхийг хасаж болохгүйг баталгаажуулсан.

Цагаачдыг тодорхой төрлийн ажлыг албадан хийлгэх буюу тусгай бүс нутагт албадан байлгах, түүнчлэн ижил төрлийн ажилд тэгш бус цалин хөлс, зэрэглэл тогтоосон хууль зүйн болон захиргааны журмын талаар жишээ

баримт байсаар байна. Хөдөлмөрийн нөхцөлтэй холбоотой журамд цагаач ажилтныг хамруулахгүй, тэднийг Үйлдвэрчний Эвлэлийн үйл ажиллагаанд оролцох эрхийг нь зөрчих тохиолдол гардаг.

Цагаач ажилтныг хууль бусаар элсүүлж, тээвэрлэж, ажиллуулж байгаа нөхцөлд хүний эрх, үндсэн эрх чөлөө нь хамгийн ихээр зөрчигдөх аюултай тулгардаг. Хөгжиж буй олон орон дахь нийтийг хамарсан ядуурал, ажилгүйдэл, ажлын байрны хомсдол зэрэг нь ашиг хонжоо хайсан ажил олгогчид, хувь зуучлагчдад аятайхан хөрс болж байдаг бөгөөд тэр ч байтугай зарим тохиолдолд ажилтныг нууцаар гаргах үйл ажиллагаа гэмт хэргийн шинжтэй байдаг.

Бүх цагаач ажилтан ба тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай конвенцийн 68 дугаар зүйлд заасан ёсоор оролцогч улсууд "хууль бус буюу далд шилжилт хөдөлгөөн болон цагаач ажилтны хууль бус хөдөлмөр эрхлэлтээс урьдчилан сэргийлэх, устгах асуудлаар хамтран ажиллахыг" даалгасан. Тодруулбал, оролцогч улсууд цагаачлалын асуудлаар буруу ташаа мэдээлэл тараахын эсрэг, хууль бус ба далд цагаачлалыг илрүүлж, устгах, хууль бус, далд цагаачлалыг зохион байгуулж, хэрэгжүүлж, түүнд туслалцаа үзүүлж байгаа болон хууль бусаар амьдарч байгаа цагаач ажилтны эсрэг хүч, заналхийлэл, сүрдүүлэлт хэрэглэж буй эсхүл тийм ажилтныг ажиллуулж байгаа хувь хүн, бүлэг буюу байгууллагад үр нөлөөтэй ял шийтгэл оногдуулах талаар зохих арга хэмжээ авах үүрэг хүлээнэ.

Өөрийн улсын иргэдийг гадаадад гаргахаас гадна гадаадаас ажиллах хүч авч эхэлсэн нь манай улсын хувьд цагаач ажилтны тал дээр анхаарал хандуулах зайлшгүй шаардлага байгааг илтгэж байна. Мөн дээр дурьдсан асуудлууд манай улсын иргэд гадаадад цагаачлан ажиллаж амьдрахад элбэг тохиолдож байгаа юм.

Шилжин суурьшигчдын асуудлаар тодорхой бодлогын шинжтэй баримт бичиг шаардлагатай байгаа учраас НҮБ-ын Цагаач ажилчин ба тэдний гэр бүлийн эрх ашгийг хамгаалах тухай конвенцид манай улс нэгдэн орох хэрэгцээ бий болсон байна.

Хууль зүйн үндэслэл:

Migrant-Цагаач хэмээн албан ёсоор орчуулах нь зүйтэй. Монгол хэлэнд цагаач гэдэг нь хэрэн хэсч амьдрах хүн хэмээн ойлгогддог. Олон улсын цагаачлалын эрх зүйн ойлголт ёсоор цагаач ажилчид гэдэг нь тухайн үндэсний бус буюу тухайн үндэсний харьяалалгүй этгээд ажил эрхлэх ойлголт юм.

Монгол Улсын Үндсэн хуульд хүний эрхийн ойлголтыг иргэний эрхийн ойлголттой давхцуулсан байдаг ба гадаадын иргэний эрх зүйн байдлыг дараах байдлаар тогтоожээ. Үүнд:

Монгол Улсын Үндсэн хууль 18 дугаар зүйл:

1.Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэний эрх, үүргийг Монгол Улсын хууль, уул иргэнийг харьяалсан улстай байгуулсан гэрээгээр тогтооно.

2.Монгол Улс олон улсын гэрээгээр гадаадын иргэний эрх, үүргийг тодорхойлохдоо уул иргэнийг харьяалсан улстай энэ талаар харилцан адил байх зарчим баримтална.

3.Монгол Улс нутаг дэвсгэртээ байгаа харъяалалгүй хүний эрх, үүргийг өөрийн хуулиар тогтооно.

4. Үзэл бодол, улс төрийн хийгээд шударга ёсны бусад үйл ажиллагааныхаа улмаас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харъяалалгүй хүн үндэслэл бүхий хүсэлт гаргавал Монгол улсад орогнох эрх олгож болно.

5.Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөг тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харъяалалгүй хүнд эдлүүлэхдээ Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний салшгүй эрхээс бусад эрхийн хувьд үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд хуулиар зохих хязгаарлал тогтоож болно.

Уг конвенцийн 1 дүгээр зүйлд тодорхойлсончлон цагаачид нь өөрийн хэл, соёл, үзэл бодол, шашны урсгалаас үл хамааран хүнийхээ хувьд адил эрхтэй болохыг дурьдсан нь олон улсын гэрээний ерөнхий үзэл баримтлал Үндсэн хуулийн 16.1 дүгээр зүйлтэй давхцаж байгааг илтгэнэ.

Үндсэн хуулийн зохицуулалт дахь гадаадын иргэдийн асуудал ерөнхий бөгөөд гадаадын иргэн нь дотроо цагаач болон дүрвэгсэд хэмээн хэд хэдэн чиглэлд хуваагддаг. Эдгээр этгээдүүдийн эрх зүйн байдлын нэгдсэн системийг эрх зүйн тогтолцоондоо зөв хэлбэршүүлэн суулгах нь эрх зүйн шинэтгэлд чухал ач холбогдолтой. Уг конвенци нь энэхүү байдлыг тодорхой хэмжээгээр олон улсын стандартад нийцүүлэн тогтооход гүйцэтгэх үүрэг үлэмж юм.

Нэр томъёоны хэсэг дэх цагаач ажилчдын ангиллыг эрхлэх хөдөлмөр, түүний давтамж улирлаар нь ангилж өгсөн нь эрх зүйн зохицуулалтын түвшинд чухал ач холбогдолтой юм.

Конвенцийн III дугаар хэсэгт цагаачдын эрхийг тодорхойлон өгсөн бөгөөд дараахь байдлаар илэрхийлжээ. Үүнд:

- Цагаачид нь энэ конвенцид дурьдсанаас бусдаар нийтийн дэг журмыг зөрчсөн болоод үндэсний эрх ашгийг хөндсөн тохиолдолд хуулиар тогтоосноос өөрөөр ямар нэгэн хязгаарлалтгүйгээр өөрийн харъяалах улсаа чөлөөтэй орхин гарах эрхтэй.
- Цагаач иргэдийн болоод тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдлыг хуулиар хамгаалах ёстой.
- Аливаа эрүүдэн шүүх болон бусад хэлбэрийн харгис хэрцгий байдлаар хандах ёсгүй.
- Шашин шүтлэгийн эрх чөлөө эдэлнэ.
- Хөндлөнгийн оролцоогүйгээр өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх хэрэгтэй. Бичгээр болон амаар хэрэгцээт мэдээллээ авах эрхтэй.
- Хууль бус хэрэгт сэжиглэгдэн баривчлагдсан тохиолдолд нөхөн төлбөр авах эрхтэй.

Монгол Улс өнөөдөр энэ конвенцид нэгдэн ороогүй байгаа шалтгааныг тодруулахад манай улсын иргэд олноороо цагаачлан ажиллаж амьдардаг АНУ, БНСУ зэрэг орнууд тус конвенцид нэгдэж ороогүй байгаа нь манай

оронд харилцан ашигтай тал үүсэхгүйд гол учир байгаа гэдэг. Хүний эрхийн хөгжлийн үүднээс энэ нь үр ашиггүй шалтгаан бөгөөд харин ч энэ гэрээнд нэгдэн орж, бусад улсад үлгэр үзүүлэх зорилго бас байх хэрэгтэй гэж үзэж байна.

Үндсэн хуулиар нэгэнтээ бид иргэний ардчилсан хүмүүнлэг нийгэм байгуулахыг зорьсон тул ардчилсан бус шалгууруар энэхүү конвенцийг шалгах нь зохимжгүй юм. Иргэний эрхийн хувьд адил биш нөхцөлийг тавьж буй ч хүний эрхийн хувьд бид цагаачдын талаар баримтлах бодлогын хувьд энэхүү конвенцийг батлах нь зүйтэй. Аливаа асуудал сайн муу аль ч талтай учир судлаачийн хувьд үзэхэд, төрийн зүгээс цагаачдын хувьд баримтлах бодлогыг урьдчилан тодорхойлж түүнийг үр нөлөөтэй байдлаар хэрэгжүүлэх тохиолдолд энэхүү конвенц нь манай улсын эрх зүйн систем дэх хүний эрхийн байдлыг сайжруулах нэгэн түлхэц болох юм.

Тэгээд ч манай улс цагаач ажилчдын тал дээр энэхүү конвенцид нэгдэж ороогүйгээр ашигтай байгаа тал байхгүй байна. Харин ч манай улс цагаачлан ажиллаж амьдарч байгаа иргэдийг нэгэнтээ хүлээн авсан байгаа нь зохицуулалтгүй харилцааг бий болгон эмх замбараагүй байдлыг үүсгэж байгаа гэж болно. Иймд энэхүү гэрээ конвенцид нэгдэн ороод өөрийн орны иргэд гадаадад цагаачлан ажиллаж байгаа байдалд ашигтай талыг бий болгох хэрэгтэй байна.

Иргэний болон Улс төрийн Эрхийн тухай Олон улсын Пактын Хоёр дахь Нэмэлт Протокол/Цаазаар авах ялыг халах зорилго бүхий/

Конвенцийн албан ёсны нэр : *Second Optional Protocol to the International Covenant on Civil and Political Rights, aiming at the abolition of the death penalty*

Конвенцийн монгол нэр : *Иргэний болон Улс төрийн Эрхийн тухай Олон улсын Пактын Хоёр дахь Нэмэлт Протокол/Цаазаар авах ялыг халах зорилго бүхий/*

Батлагдсан огноо : 1989 он

ТАНИЛЦУУЛГА:

Улс үндэстнүүд цаазаар авах ялыг халах тухай олон улсын дөрвөн гэрээ хэлэлцээрийг баталжээ. Үүний нэг нь дэлхийн улс орнуудыг хамарсан, нөгөө гурав нь бүс нутгийн улс орнуудад хамаатай юм.

НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1989 онд дэлхий нийтийн хэмжээнд хэрэглэгдэх Цаазаар авах ялыг халах зорилго бүхий Иргэний болон Улс төрийн Эрхийн тухай Олон улсын Пактын Хоёр дахь Нэмэлт Протоколыг баталсан. Энэ нь цаазаар авах ялыг бүхэлд нь халахыг хангадаг бөгөөд оролцогч улсуудад Протоколд нэгдэн орох буюу соёрхон батлах үедээ тайлбар хийсэн тохиолдолд энэ ялыг дайны цагт хэрэглэхийг зөвшөөрдөг байна. 2008 онд Аргентин, Чили, Гондурас, Руанда, Узбекстан зэрэг 5 улс цаазаар авах ялыг халах зорилготой Иргэний болон Улс төрийн Эрхийн тухай Олон улсын Пактын Хоёр дахь Нэмэлт Протоколд нэгджээ. Аргентин, Чили нь цаазаар авах ялыг халах тухай Америкийн Хүний эрхийн конвенцийн

Протоколыг мөн соёрхон баталжээ. Тухайн хоёр гэрээг соёрхон батлахдаа Чили улс нь дайны үеийн онц ноцтой цэргийн гэмт хэргүүдэд цаазаар авах ял хэрэглэж болзошгүй хэмээн урьдчилан тайлбар хийсэн байна.

Цаазаар авах ялыг халж байгаа болон хяналтандаа авч байгаа орнууд сүүлийн жилүүдэд нэмэгдэж байна. Хамгийн ойрын жишээ бидний хөрш, ОХУ цаазаар авах ялыг халсан бөгөөд БНХАУ нь 2007 оны 1 сараас эхлэн ялын дээд хэмжээ оногдуулах хуулиндаа өөрчлөлт оруулсан байна. Хятадын анхан болон дунд шатны шүүх 1980 оноос хойш цаазаар авах ялыг оногдуулах эрхтэй байсан бол одоо Хятадын Дээд шүүхээс энэ ялыг оноож байхаар хуульчилсан байна.

Өнөөдөр дэлхийн улс орнуудын гуравны хоёр нь буюу 133 улс цаазаар авах ялыг хуулиндаа болон практикт халаад байна. 90 улс орон газар нутагт бүх төрлийн гэмт хэргүүдэд цаазаар авах ял оноохыг зогсоож, 11 улс дайны үеийн гэмт хэргээс бусад тохиолдолд цаазаар авах ялыг оноохыг хориглож, 32 орон цаазаар авах ялыг практикт халсан бөгөөд хуулинд нь байгаа боловч сүүлийн 10 гаруй жил нэг ч цаазаар авах ялыг гүйцэтгэгүй байна. Бусад 64 орон цаазаар авах ялыг хэрэглэж байгаа ч хэд хэдэн орнуудад нэг жилд гүйцэтгэх тоо нь буурсаар байгаа юм.

Иргэний болон Улс төрийн Эрхийн тухай Олон улсын Пактад оролцогч улсууд нь Хоёр дахь Нэмэлт Протоколын оролцогч улс болох боломжтой. Манай улс Иргэний болон Улс төрийн Эрхийн тухай Олон улсын Пактад 1974 онд нэгдэн орсон.

Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалт:

Монгол улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:

16.1/ амьд явах эрхтэй. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно;

ХЗҮХ-гийн Эрүүгийн эрх зүй, криминологи судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан докторант Г. Оюунболд Цаазаар авах ялыг халахад чиглэсэн энэхүү нэмэлт протоколд манай улс нэгдэх тал дээр саналаа дараахь байдлаар тусгажээ. Үүнд :

"Тухайн олон улсын конвенцийг соёрхон баталснаар үүсэх сөрөг үр дагавар үгүй бөгөөд хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгмийг байгуулах /ҮХ-д заасан/ зорилгод нийцсэн алхам болох юм.

Нэгдэн орсон тохиолдолд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт заавал оруулах шаардлагагүй бөгөөд тус хуулийн Арван зургадугаар зүйлийн нэгд "Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно" гэж заасныг өөрчлөх үндэслэл болохгүй юм. Харин Эрүүгийн хуульд заасан цаазаар авах ялыг өөрчлөх, ялын төрлийг шинээр хуульчлах замаар шийдвэрлэх бололцоотой байна." гэжээ.

Үүсэх үр дагавар:

Цаазаар авах ялыг халах тал дээр бусад орнуудын чиг хандлагыг судалсан байдлаас үзэхэд уг ялыг халахдаа нийгмийн сэтгэлзүйг харгалзан үздэг, хууль тогтоомжоосоо шууд хасалгүй, хэрэглэх тохиолдлыг багасгах замаар алгуур байдлаар халдаг жишиг бас байдаг.

Өнөөгийн байдлаар манай улсын хувьд эрдэмтэн судлаач ба практикийн хуульчдын дунд энэ ялыг халах асуудлаар санал тэнцүү хуваагдсан байдалтай байдаг. Энэ нь аргагүй юм. Гэхдээ судлаачийн зүгээс хэлэхэд, цаазаар авах ялыг халахад чиглэгдсэн тус нэмэлт протоколд нэгдэж орох асуудал зайлшгүй боловч манай улсын нийгмийн хөгжил, ард иргэдийн соёл, иргэншил, төлөвшлийн талаасаа зөвхөн цаг хугацааны хувьд харгалзан үзэх шаардлага байхыг үгүйсгэх аргагүй.

Дүгнэж хэлэхэд энэхүү нэмэлт протоколд нэгдсэнээр хүний салшгүй, заягдмал эрх болох амьд явах эрхийг олон улсын гэрээ конвенцид заасан наад захын стандартад нийцүүлэх боломж бүрдэх юм.

Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай конвенц

Конвенцийн албан ёсны нэр : Adopted on 28 July 1951 by the United Nations Conference of Plenipotentiaries on the Status of Refugees and Stateless Persons convened under General Assembly resolution 429 /V/ of 14 December 1950

Конвенцийн монгол нэр: *Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай конвенц*

Батлагдсан огноо : 1951 он

Хүчин төгөлдөр болсон огноо: 1954.4.22

Швейцарь улсын Женев хотноо 1951 онд АНУ, Израйль, Ирак гэсэн хоорондоо эрс ялгаатай 26 улсын төлөөлөгчид Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай конвенцийг баталсан байдаг.

Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай 1951 оны Конвенцийн дагуу дүрвэгч гэж:

- арьс өнгө, шашин шүтлэг, иргэний харъяалал, нийгмийн тодорхой бүлгийн гишүүн буюу улс төрийн үзэл бодлын улмаас мөрдлөг хавчлагад өртөнө гэж баттай үндэслэлээр болгоомжилж буй, уугуул орныхоо гадна буй, мөрдлөг хавчлагаас болгоомжлон тухайн орондоо буцах буюу түүний хамгаалалтанд орох боломжгүй буюу орохыг хүсэхгүй байгаа;
- Уугуул буюу харьяат оронд нь бүхэлдээ буюу аль нэг хэсэгт нь нийгмийн хэв журмыг ноцтой алдагдуулсан гадаадын түрэмгийлэл, булаан эзлэлт, гаднын хүчирхийлэл буюу бусад хэрэг явдал тохиосны улмаас тухайн орноо арга буюу орхин гарсан аливаа хүн;
- Амь нас, аюулгүй байдал буюу эрх чөлөөнд нь түгээмэл хүчирхийлэл, гаднын түрэмгийлэл, дотоодын мөргөлдөөн, хүний эрхийг хавтгайруулан хөсөрдүүлсэн хүчирхийлэл буюу нийгмийн хэв журмыг ноцтой алдагдуулсан бусад нөхцөл байдлын улмаас эх орноо орхин гарсан хүмүүсийг хэлдэг байна.

Энэ конвенц нь дүрвэгсдийн аж амьдралын хамгийн суурь үндсэн асуудлыг тусгасан, тэднийг хүнийхээ хувьд эдлэвэл зохих үндсэн эрхийг

цогцоор нь тодорхойлсон. Энэхүү эрх нь конвенцид зааснаар доод тал нь тухайн оронд хууль ёсоор амьдарч буй гадаадын иргэдийн, цаашилбал олон тохиолдолд тэр орны харъяат иргэдийн эдэлдэг эрх чөлөөтэй дүйж байхаар заасан юм. Түүнчлэн дүрвэгсдийн эрх, үүний дотор шашин шүтэх, шилжин суурьших эрх чөлөө, ажил эрхлэх, сурч боловсрох, зорчих бичиг баримт олж авах зэрэг эрхийг нь зааж өгөхийн зэрэгцээгээр орогнол олгосон улс орны өмнө дүрвэгсдийн хүлээх үүргийг бас тодорхойлсон байдаг.

Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай конвенцид одоогоор дэлхийн нийт 147 орон нэгдэн ороод байна. Үүнд 1951 оны конвенц болон 1967 оны нэмэлт протоколд орсон улсууд багтсан тоо юм.

АНУ-ын дүрвэгсэд болон цагаачдын асуудал эрхэлсэн хорооноос гаргасан мэдээгээр дэлхий дээр одоогийн байдлаар нийт 62.000.000 дүрвэгсэд байгаагийн 34.000.000 дайн байлдааны улмаас, үлдсэн хувь нь дотооддоо ямар нэгэн шалтгааны улмаас шахан боогдсон хүмүүс байна гэжээ. НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн Дээд Комиссарын Газрын мэдээгээр Афганистан, Ирак, Мянмар, Судан, Палестин дүрвэгсэд хамгийн их тоог эзэлж байна. Тухайлбал, Суданы дүрвэгсэд 5 сая гаран, Иракийн 4.7 сая дүрвэгсэд байна. Статистикаас харахад сар бүр 60.000 хүн гэр орноо орхин өөр улс орон руу дүрвэдэг ажээ .

Манай Улсын хувьд хэдийгээр Монголоос дүрвэн гарч буй иргэд байхгүй ч гэсэн цаашдаа бид бүхэн Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай конвенцид нэгдэн орох эсэх асуудлыг судалж, шийдвэрлэх шаардлагатай.

Үндсэн хуулийн холбогдох заалт буюу Монгол Улсын Үндсэн хуулийн 18 дугаар зүйл:

1. Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэний эрх, үүргийг Монгол Улсын хууль, уул иргэнийг харъяалсан улстай байгуулсан гэрээгээр тогтооно.

2. Монгол Улс олон улсын гэрээгээр гадаадын иргэний эрх, үүргийг тодорхойлохдоо уул иргэнийг харъяалсан улстай энэ талаар харилцан адил байх зарчим баримтална.

3. Монгол Улс нутаг дэвсгэртээ байгаа харъяалалгүй хүний эрх, үүргийг өөрийн хуулиар тогтооно.

4. Үзэл бодол, улс төрийн хийгээд шударга ёсны бусад үйл ажиллагааныхаа улмаас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харъяалалгүй хүн үндэслэл бүхий хүсэлт гаргавал Монгол улсад орогнох эрх олгож болно.

5.Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөг тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харъяалалгүй хүнд эдлүүлэхдээ Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний салшгүй эрхээс бусад эрхийн хувьд үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд хуулиар зохих хязгаарлал тогтоож болно.

Дүрвэгсдийн асуудал нь манай улсын хувьд тулгамдсан асуудал бөгөөд орогнол хүссэн иргэний Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалаар /ХЭТТ/ олгогдсон эрхийг эдлэх бололцоогоор хангаж буй эсэх талаарх асуудал одоо

хүртэл ил тод биш байна. Монгол улсаас дүрвэн гарч буй иргэдийн талаарх статистик мэдээлэл байхгүй байна. Манай улс тус конвенцид нэгдэн орохгүй байгаа шалтгаан нь үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр гараагүй байгаатай холбоотойгоор засгийн газрын хуралдаанаас 2000, 2005 онуудад 2 удаа буцсан байна. Иймээс дүрвэгсдийн талаар мэдээ баримтыг нээлттэй болгож хүний эрхийн байгууллагуудад дүрвэгсэдтэй ажиллах боломж олгох нь Монгол Улсын засгийн газрын зайлшгүй хийх алхам юм. Монгол улс нь үндэсний хууль тогтоомжийн хүрээнд дотоод болон гадаад шилжилт хөдөлгөөний асуудлыг зохицуулж байгаа хэдий ч шилжин суурьшигсдад ашигтай, бодлогын шинжтэй баримт бичиг байхгүй байна. Монгол Улс дүрвэгсдийн асуудлыг зохицуулсан олон улсын гэрээ конвенцид нэгдэн ороогүйгээс орогнол хүссэн иргэдтэй холбоотой асуудлыг зохицуулахад хүндрэл учруулж байна. Орогнол хүссэн иргэдийн асуудлыг олон улсын зан заншлын хэм хэмжээнд тулгуурлан явуулах, тэднийг хүндэтгэн харьцах, үндсэн эрх, эрх чөлөөгөө эдлэх боломжоор хангах нөхцөлийг бий болгох шаардлагатай байна.

Монгол Улс тус конвенцид одоогоор нэгдэж ороогүй байгаа гол шалтгаан болох "Үндэсний аюулгүй байдалд харшлах" гэсэн үзлийг өөр байдлаар нухацтай хандах, энэхүү гэрээнд нэгдсэнээр муу талаасаа илүү, сайн үр ашигтай, хөнгөлөлт эдлэх боломжуудыг судалж үзэх хэрэгтэй гэж үзэж байна. Ялангуяа манай улс гадаадын иргэдтэй холбоотой харилцааг тусгасан олон улсын хүний эрхийн гэрээнд нэгдэх асуудлыг авч үзэхдээ дандаа нэг талыг харж, өөрөөр хэлбэл гаднаас хүн ирэх, гаднын хүнд үйлчлэх, тэдний эрх ашгийг хамгаалах талын асуудлыг дагнан ойлгодог гаж дутагдал байсаар байна. Гэтэл аливаа олон улсын гэрээ конвенц бол харилцан ашигтай талыг бий болгодог билээ.

Үр дагавар:

• Шилжилт хөдөлгөөнийг нэгдсэн байдлаар зохицуулсан бодлогын шинжтэй баримт бичиг бий болгож тус баримт бичигт гадаад, дотоод шилжилт хөдөлгөөн, түүнээс гарч буй үр дагавараас урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх, эргэн нийгэмшүүлэх нөхцөлийг бий болгох агуулгыг тусгасан байх

• Монголчууд урт хугацаагаар гадаадад амьдрах болсноор тэдний үр хүүхэд тухайн орныхоо иргэн болох явдал цөөнгүй байгааг анхааран монголчууд олноор ажиллаж амьдарч буй орнуудтай иргэний давхар харьяалалыг бий болгох талаар эрх зүйн гэрээ хэлэлцээр, консулын конвенц байгуулах боломжийг судлах

• Гадаад шилжилт хөдөлгөөнтэй холбогдон гарч буй монголчуудын эрх ашгийг хамгаалах, иргэдээ бүртгэх, нэгдсэн мэдээллийн баазыг бий болгох, уг харилцаатай холбоотой дотоодын хууль тогтоомжийг боловсронгуй болгох

• Монголчууд олноор ажиллаж, сурч буй орнуудын элчин сайдын яамны дэргэд хүний эрхийн асуудал хариуцсан алба ажиллуулах

• Өнөөг хүртэл Монгол Улсын Засгийн газар Дүрвэгсдийн асуудлаар нэгдсэн мэдээлэл, тоо баримт байхгүй, дүрвэн ирсэн болон гарсан иргэдийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчин бүрдээгүй учир энэ талаар мэдээ баримтыг цэгцлэх, олон нийт, хүний эрхийн байгуулагуудад нээлттэй болгох тал зэрэгт ахиц гарна.

Хавсралт

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн нэмэлт Протокол[803]

Конвенцийн албан ёсны нэр : *Optional Protocol to the Convention against Torture and other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment*

Конвенцийн монгол нэр : *НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протокол*

Батлагдсан огноо : 2002.12.18

Хүчин төгөлдөр болсон огноо: 2006.6.22

Танилцуулга :

2002 оны 12 дугаар сарын 18-ны өдөр НҮБ-ын Ерөнхий Ассемблей хуралдаж НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколы гбаталсан билээ.

Нэмэлт Протоколын зорилго нь хорих байруудад эрүүдэн шүүх болон бусад байдлаар хэрцгийгээр, хүнлэг бусаар харьцах явдлыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх үүднээс үндэсний ба олон улсын хараат бус байгууллагуудын зүгээс тогтмол шалгалт хийх тогтолцоог бий болгох явдал юм.

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцид нэгдэн орсон, эсхүл конвенцийг соёрхон баталсан улсууд конвенцийн Нэмэлт Протоколд нэгдэж орох, эсхүл түүнийг соёрхон баталж болно.

Хэрэгцээ шаардлага:

Хэдийгээр эрүүдэн шүүх ба бусад хэлбэрээр хэрцгий харьцахыг олон улсын эрх зүйгээр хориглосон ч түүнтэй холбоотой хүний эрхийн зөрчил дэлхий даяар гарсаар байгаа юм. Эрх чөлөөгөө хасуулсан буюу хоригдогсод энэхүү хүний эрхийн зөрчилд өртөх эрсдэл өндөр байдаг. Тэдгээр хүмүүс хоригдох хугацаандаа гадаад орчноос тусгаарлагдсан байдаг бөгөөд тэдний амьдралын үндсэн хэрэгцээ, эдлэх эрхийн байдал нь бусдаас хамааралтай, төрийн эрх мэдэлтнүүдээс бүрэн хараат байдалд ордогт гол шалтгаан оршиж байна. Тус Нэмэлт протоколын түүхэн ач холбогдол нь дэлхий даяар хорих газруудад хүнийг эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, энэ төрлийн хүний эрхийн зөрчлийг зогсооход тодорхой арга хэмжээ авах санал болгож байгаагаараа онцлог олон улсын баримт бичиг юм.

Олон улсын туршлагаас үзэхэд хорих газруудад шалгалт явуулах нь хоригдогсдыг эрүүдэн шүүхэд өртөж байгаа эсэхийг тогтоох түүнчлэн хорих газрын орчин нөхцөлийг сайжруулах хамгийн үр дүнтэй арга зам болох нь батлагдсан билээ. Хорих газарт шалгалт хийх явдал нь зөвхөн

[803] 2008 оны 4 дүгээр сарын 14-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яаман дээр зохион байгуулагдсан "Монголд эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх шинэ эрин үе" сэдэвт семинарын холбогдох материалыг ашигласан болно.

нөхцөл байдалтай өөрийн биеэр танилцаад зогсохгүй, шалгалт хийж байгаа мэргэжилтнүүдэд хоригдож байгаа этгээдтэй хэрхэн харьцаж байгаа мөн тэдгээрийг ямар орчин нөхцөлд хорьж байгаад үнэлэлт өгөх бололцоог олгодог. Хорих газарт шалгалт хийх мэргэжилтнүүд нь шаардлагатай өөрчлөлтүүдийг хийх талаар зөвлөмж гаргаж, холбогдох эрх бүхий байгууллагуудтай илэрсэн алдаа дутагдлыг арилгахад туслалцаа үзүүлэх талаар хэлэлцээ өрнүүлж болдог.

Нэмэлт протоколоор олон улсын ба үндэсний байгууллагуудаас хорих газруудад тогтмол шалгалт хийх тогтолцоог бий болгосон юм. Нэмэлт протоколд нэгдэж орсноор, эсхүл түүнийг соёрхон батлснаар оролцогч улсууд хорих газруудад доорхи байгууллагуудаас урьдчилан мэдэгдэлгүйгээр шалгалт хийх зөвшөөрлийг олгож байгаа хэрэг юм.

Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны дэргэдэх олон улсын дэд хороо: Хорих газруудад шалгалт хийх тогтолцоон дахь шинэхэн байгуулагдсан олон улсын байгууллага нь эрүүдэн шүүхийн эсрэг хорооны дэргэдэх дэд хороо юм. Дэд хороо нь эхний үед Нэмэлт протоколд оролцогч бүх улсуудын нутаг дэвсгэр дээрх хорих газруудад тогтмол шалгалт хийх, төрөл бүрийн мэргэжлийн салбараас төлөөлөлтэй хараат бус арван мэргэжилтнээс бүрдэх юм.

Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний байгууллагууд: Эрүүдэн шүүхээс хамгаалах тогтолцооны хоёр дахь хэсгийг эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний байгууллагууд бүрдүүлэх юм. Нэмэлт протоколыг соёрхон батлснаас буюу түүнд нэгдэн орж нэмэлт протокол хүчин төгөлдөр үйлчилж эхэлсний дараа жилээс хэтрэхгүй хугацаанд оролцогч улсууд хорих газарт шалгалт хийх нэг буюу хэд хэдэн эрх бүхий байгууллагыг байгуулах ёстой. Нэмэлт протоколоор хорих газруудад шалгалт хийх дотоодын байгууллагуудын хэлбэрийг тогтоож өгөөгүй тул уг байгууллагын чиг үүргийг улс орнуудын Хүний Эрхийн Комисс, Омбудсменууд, Парламентаас байгуулагдсан комиссууд, мөн түүнчлэн төрийн бус байгууллагууд хэрэгжүүлж болох юм. Харин оролцогч улсуудын зүгээс эдгээр байгууллагуудад үйл ажиллагаагаа ямар нэг саадгүйгээр явуулах, тэдгээрийн үйл ажиллагаанд төрийн зүгээс оролцохгүй байх баталгааг хангах ёстой.

НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцид оролцогч улсууд уг Нэмэлт Протоколыг ойрын хугацаанд соёрхон батлах боломжтой эсэхийг авч хэлэлцэх ёстой.

Үндэсний хүний эрхийн болон эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийн эрхтэй холбоотой үйл ажиллагаа явуулж буй бусад байгууллагууд нь Нэмэлт Протоколын дагуу эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг хэрэгжүүлэгч байх боломжтой талаар хангалттай мэдээлэл авсан байх ёстой.

Нэмэлт Протокол үйлчилж эхэлсэнтэй холбогдуулан улс орнуудад эрүүдэн шүүх явдлыг таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх асуудлаар үндэсний хэмжээний хэлэлцүүлгүүд өрнөж байх ёстой гэжээ.

Иргэний нийгмүүд олон улсын түвшинд эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх дэд хороонд өөрийн мэргэжилтнийг ажиллуулахаар санал болгож

болох бөгөөд энэхүү Нэмэлт Протоколыг соёрхон батлах, хэрэгжүүлэх үйл явцад идэвх, санаачлагатай оролцох ёстой болж байна.

Эрүүдэн Шүүхээс Урьдчилан Сэргийлэх Нийгэмлэг

Эрүүдэн Шүүхээс Урьдчилан Сэргийлэх Ниймгэмлэгийг /ЭШУСН/ анх Жан-Жак Готье 1977 онд санаачлан, үүсгэн байгуулсан бөгөөд тус холбоо нь Швейцари Улсын Женев хотноо байрладаг. Тус нийгэмлэг нь хараат бус төрийн бус байгууллага бөгөөд эрүүдэн шүүхээс сангид байх, эрүүдэн шүүхээс урьдчилсан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг. ЭШУСН эрүүдэн шүүхийг хориглосон стандартуудыг үндэсний түвшинд хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ эрх чөлөөгөө хасуулсан хүмүүстэй ажиллагсдад зориулж сургалтын материал боловсруулахад туслалцаа үзүүлдэг юм. Тус байгууллага нь хорих газруудад шалгалт хийх, эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх хяналтын механизмд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа явуулдаг бөгөөд НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт протоколыг хэрэгжүүлэхэд гол үүргийг гүйцэтгэж буй байгууллага юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан "Монгол улсын иргэн ... төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй; ...халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ...", түүнчлэн тус хуулийн 19 дүгээр зүйл-д" Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." зэрэг заалтууд тус конвенцийн үндсэн үзэл санаатай бүрнээ нийцэж байна.

Үр дагавар:

Монгол Улсын тухайд энэхүү үндэсний байгууллагуудын хэлбэр, статус, эрх хэмжээний асуудлыг бусад ойролцоо чиг үүрэг бүхий байгууллагаас /тухайлбал прокурорын байгууллагаас/ ялгаж салгах болон хамтын ажиллагааг уялдуулах замаар оновчтой зөв шийдвэрлэх явдал бол энэхүү нэмэлт протоколд нэгдэн ороход зайлшгүй тулгарах асуудал мөн. Практик дээр "тус нэмэлт протоколд нэгдсэнээр манай улсын шоронгийн байдалтай гаднынхан танилцсанаар шоронгийн орчин нөхцөл муу гэдгээ таниулах муу талтай гэсэн болгоомжлол байгаар дурьдахад харамсалтай байна. Энэ нь нэгдэн орох асуудлын сөрөг тал биш харин ч эерэг тал буюу манай улсын тухайд, хорих, саатуулах газруудын орчин нөхцөл сайжрахад нөлөөлөх, дэмжлэг үзүүлэх хүчин зүйл болж чадах юм. Ингэснээрээ манай улсын хүний эрхийг хангах, хөхиүлэн дэмжих, хамгаалах талын орчин сайжирна.

Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний ба олон улсын байгууллагууд нь дурын хорих газарт шалгалт хийж болох ба хорих газарт

хоригдож байгаа эрх чөлөөгөө хасуулсан этгээд уулзахыг хүссэн тохиолдолд түүнтэй хувийн журмаар уулзаж, ярилцаж болох юм.

Хорих газарт шалгалт хийсний дараагаар дээрх байгууллагууд нь хорих газарт хоригдож байгаа этгээд нартай харьцах харьцааны байдал ба тэдгээрийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулахад чиглэсэн зөвлөмжийг гаргана. Хамтын ажиллагааны уур амьсгалыг тогтоох зорилгоор олон улсын дэдхороонызөвлөмжүүдньнуудцбайхшинжийгагуулахбөгөөд, мэргэжилтний илтгэлийг зөвхөн оролцогч улс зөвшөөрсөн тохиолдолд, эсхүл тухайн улс мэргэжилтнүүдтэй хамтран ажиллахаас татгалзсан үед хэвлэн нийтэлж болно.

Холбогдох төрийн эрх бүхий байгууллагууд зөвлөмжийг биелүүлэхийн тулд хэлэлцээ хийх ёстой болно. Мөн эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний ба олон улсын байгууллагууд нь өөр хоорондоо зөвлөлдөх, түүнчлэн мэдээлэл солилцох байдлаар нягт хамтран ажиллах юм. Үндэсний байгууллагуудын хувьд жил бүр хийж гүйцэтгэсэн ажлаа олон нийтэд танилцуулан тайлагнаж байх юм.

Нэмэлт протоколд тодорхойлогдсоны дагуу өргөн хүрээнд авч үзвэл, шалгалт хийгдэж болох газрууд буюу хорих газар гэдэгт "цагдаагийн хэлтэс, газрууд, аюулгүй байдал, хүчний байгууллагуудын газрууд, бүх төрлийн урьдчилан хорих газрууд, урьдчилан хорих төвүүд, хорих ангиуд, насанд хүрээгүй бага насны хэрэг зөрчилд холбогдогчдыг хорих төвүүд, цагаач хүмүүсийг түр саатуулах төвүүд, олон улсын дамжин өнгөрүүлэх бүсүүд, орогнол эрж байгаа этгээдийг саатуулах төвүүд, сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагууд, захиргааны урьдчилан *хорих газрууд" зэрэг багтах юм.*

Хавсралт

Аархусын конвенц-Байгаль орчны асуудлаар мэдээлэл олж авах, шийдвэр гаргахад оролцох, шүүхэд хандах эрхийн тухай конвенц

Конвенцийн албан ёсны нэр : *Aarhus Convention Convention on Access to Information, Public Participation in Decision-making and Access to Justice in Environmental Matters, Aarhus, 1998*

Конвенцийн монгол нэр : *Аархусын конвенц - Байгаль орчны асуудлаар мэдээлэл олж авах, шийдвэр гаргахад оролцох, шүүхэд хандах эрхийн тухай конвенц*

Батлагдсан огноо : 1998.7.25

Хүчин төгөлдөр болсон огноо: 2001.10.30

ТАНИЛЦУУЛГА:

Дани Улсын хот болох Аархуст зохиогдсон хурлаар нэрлэгдсэн конвенц юм.

Аархусын конвенц нь Мэдээлэлд нээлттэй бөгөөд байгаль орчны асуудлаар хуулийн байгууллагад хандах, шийдвэр гаргахад олон нийтийг оролцоог нэмэгдүүлэх зорилготой.

Аархусын Конвенц:

- Байгаль орчны асуудлаар мэдээлэл олж авах, шийдвэр гаргахад оролцох, шүүхэд хандах эрхийн тухай
- 1998 оны Европын улсууд баталсан
- Европын холбооны улсуудаас гадна конвенцийн үзэл санааг хүлээн зөвшөөрсөн ямар ч улсад нээлттэй
- Гомдол хүлээн авах механизмтай
- Бохирдуулагч төлөх зарчим
- Нэгтгэлийн зарчим
- Шударга байдлын зарчим тусгагдсан.

Олон улсын хүний эрхийн үндсэн конвенцийн бүрэлдэхүүнд багтдаггүй боловч байгаль орчны салбарын олон улсын гэрээ конвенц дотор хүний эрхтэй шууд холбоотой, өнөө үед тулгараад байгаа байгаль орчин, уул уурхайн чиглэлийн үйл ажиллагаанаас үүсэн гарч буй зөрчлийг шийдвэрлэх, тухайн харилцаанд иргэдийн эрх ба байгаль орчинд хариуцлагатай хандах асуудлыг баталгаажуулж өгч байгаагаараа чухал ач холбогдолтой конвенц юм.

Агуулга:

- Мэдээлэл авах эрх
- Байгаль орчны асуудлаар шийдвэр гаргах үйл явцад оролцох эрх
- Зөрчигдсөн эрхээ шүүхээр хамгаалуулах эрх агуулагдсан.

Нэгдэх үндэслэл, шаардлага:

Монгол Улсын хувьд:

- Улам бүр эрчимжиж байгаа уул уурхайн үйл ажиллагаанаас болж нутгийн уугуул иргэдийн эрх зөрчигдөж байгаа байдал гарсаар байна.
- Албан тушаалтан дураар авирлаж, шүүх шударга ажиллахгүй тохиолдолд иргэдийн шударга шүүхээр хэргээ шийдвэрлүүлэх, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх эрх нь давхар зөрчигдөнө гэж үздэг. Тухайлбал, 2007 онд Дархан-Уул аймгийн Хонгор суманд 340 гаруй иргэд мөнгөн ус цианидаар хордож, эрүүл мэндээрээ хохирсон боловч нэг ч хүн нөхөн төлбөр авч чадаагүй гэсэн мэдээллийг иргэний нийгмийн төлөөллөөс асуудал болгон дэвшүүлдэг.
- Манай улс байгаль орчинг бохирдуулсан аж ахуйн нэгжид хариуцлага тооцож чаддаггүй гэж дүгнэгддэг. Дээд тал нь 250 мянган төгрөгөөр торгож байна. Гэтэл үнэн чанартаа завшигчид асар их хэмжээний ашиг олж, харин нөгөө талд байгаль орчин ба ард иргэд асар их хохирол хүлээдэг.
- Уурхайн компаниудын байгаль орчны нөхөн сэргээлтэд тавих хяналт маш сул, нөхөн сэргээлт хийгээгүй компаниудтай хариуцлага тооцдоггүй. 1992 оноос хойш улсын хэмжээнд нийт 14565 га газар уул уурхайн нөлөөллөөр эвдрэлд орсон ч дөнгөж 3708,4 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн ба нөхөн сэргээлт хийгдээгүй 10 000 га газар байна. Энэ нь эрчимтэй явагдаж байгаа цөлжилтөд нөлөөлж байна.
- Байгаль орчны хохирлыг төрийн байгууллага нэхэмжлэх зохицуулалт байгаа боловч төрийн албан тушаалтнууд ашиг сонирхлын зөрчлөөс шалтгаалан нэхэмжлэл гаргадаггүй. Гэтэл нийтийн эрх ашгийг хамгаалах

хүсэл зориг бүхий иргэний нийгмийн байгууллагуудад байгаль орчны хохирлыг нэхэмжлэн хамгаалах эрх хуулиар олгогдоогүй байгаа юм. Иймээс байгаль орчинг зүй зохисгүй ашигласан гэм буруутай хүмүүс хариуцлагын гадна үлдэж, хүний эрхийн зөрчил улам гаарсаар байна.

- 2009 оны 4 дүгээр сард Засгийн газрын 86-р Тогтоолоор 25 тусгай хамгаалалттай бүс нутгаас нийт 62,256.58 гектар газрыг ашигт малтмал хайх зорилгоор тусгай хэрэгцээнээс гаргасан Энэ нь Мянганы Хөгжлийн Зорилтуудын 7а-д "2015 он гэхэд газар нутгийнхаа 30%-ийг тусгай хамгалалтанд авсан байна" хэмээн олон улсын өмнө хүлээсэн амлалт, Мянганы Хөгжлийн Зорилтуудаас ухарсан хэрэг юм. Энэ мэтчлэн албан тушаалтнууд дур зоргоор авирлах, хяналтгүй байх, иргэдийн эрх зөрчигдөх, зөрчигдсөн эрхийг сэргээх, нөхөн олговор олгох зэрэг олон асуудал зохицуулалтгүй явж байгааг анхаарах хэрэгтэй болсон нь Аархусын конвенцид нэгдэх үндэслэлийг бүрдүүлж байна.

Хууль зүйн үндэслэл

Монгол Улс олон улсын хүний эрхийн голлох гэрээ конвенциудад нэгдсэнээс гадна Биологийн төрөл зүйлийн тухай, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай, Зэрлэг амьтан ба ургамлыг ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай, Озоны үе давхаргыг хамгаалах тухай, Ган цөлжилтөд ноцтой нэрвэгдэж буй орнуудын, ялангуяа Африкийн цөлжилттэй тэмцэх тухай конвенци зэрэг нийт Олон Улсын 11 конвенци, бүс нутгийн 3 гэрээ хэлэлцээрт нэгдэн орсон байна. Мөн Мянганы Хөгжлийн Зорилтуудын 14б-д *2015 он гэхэд газар нутгийнхаа 30%-ийгтусгай хамгалалтанд авах*, 15-д *Гол, горхины усны эхийг хамгаалж, нөхөн сэргээх замаарширгэлтийг багасгах* гэсэн амлалт авсан.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2-т "эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй"; 16 дугаар зүйлийн 12-т "төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй"; 16 дугаар зүйлийн14-т "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол_ гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх....", 16 дугаар зүйлийн 17-д "төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нуущад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй..." гэж тус тус заасан нь Үндсэн хуулийн үзэл баримтлалд энэхүү конвенц бүрэн нийцэж байгааг илтгэж байна. Түүнчлэн Үндсэн хуулиа сахин биелүүлж, иргэн бүр байгаль орчноо хамгаалах журамт үүргээ гүйцэтгэхэд ч чухал ач холбогдолтой. Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлд "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна" гэсэн заалтыг хэрэгжүүлэхэд Аархусын конвенцид нэгдэх шаардлага улам бүр урган гарч байна.

Гэвч аливаа шийдвэр гаргах явцад иргэдийн оролцоог хангах тухай хуулийн заалтыг хэрэгжүүлэх тодорхой механизм аль ч хуульд суулгаагүй тул энэ эрх хэрэгждэггүй. Байгаль орчны хохирлыг төр нэхэмжлэх зохицуулалттай ч ашиг сонирхлын зөрчлөөс шалтгаалан нэхэмжлэл гардаггүй. Хувь хүн болон төрийн бус байгууллагад нийтийн эрх ашгийн төлөө нэхэмжлэл гаргах эрх олгогдоогүй тул байгаль орчныг хамгаалах механизм, эрх зүйн орчин бүрдээгүй байна.

Үүсэх үр дагавар, ач холбогдол:

"Байгаль орчны асуудлаарх аливаа хэрэгт шийдвэр гаргахад мэдээлэл авах, оролцох болон шүүхэд хандах тухай" Аархусын конвенцид нэгдэн орсноор хүний эрхийг бодитой хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх, нийтийн эрх ашгийгнэхэмжлэх механизмуудыг үндэсний хуулиудад суулгах, хэрэгжүүлэх зэргээр олонулсын хүний эрхийн гэрээ конвенц, стандартад нийцүүлэх тал дээр шат дараатай алхмууд хийгдэх ач холбогдолтой.

- байгаль орчны асуудлаар иргэдийн оролцоог бий болгож, үндэсний хууль тогтоомж ялангуяа байгаль орчны бүх хуулиудыг нийцүүлэн боловсронгуй болгох.
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд орон нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд орон нутгийн иргэд оролцох, хяналт тавих механизмыг хуульчлах
- Төрийн бус байгууллагад байгаль орчны хохирол, нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах эрх олгосон эрх зүйн орчин бүрдүүлэх зэрэг ач холбогдол бүхий үр дагавартай юм.

✓ Энэхүү конвенцид манай улс нэгдэх тухай асуудлаар Монгол Улсын хүний эрхийн болон байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудаас санал дэвшүүлсэн байгаа болно.

__oOo__

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛИЙГ ОХУ-ЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬТАЙ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА /ЕРӨНХИЙ АНГИ/[804]

Судалгааны зорилго:

Дэлхий нийтээр даяарчлагдаж байгаа өнөөгийн нөхцөлд гадаад орнуудын хууль тогтоомж, тэр дундаа хөрш зэргэлдээ, эрх зүйн систем нь ижил ОХУ-ын хууль тогтоомжийг судлах, Монгол орны нөхцөлд тохирох сайн туршлагыг авч нутагшуулах, харьцуулах зорилгоор энэхүү судалгааг хийлээ.

Зорилт:

- ОХУ-ын Эрүүгийн хуулийг Монгол хэл дээр бүрэн орчуулах;
- ОХУ болон Монгол Улсын Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн ижил төстэй болон ялгаатай талуудыг тодорхойлох;
- Монгол Улсын Эрүүгийн хуульд байхгүй шинэлэг заалтуудыг тусгайлан авч үзэх;
- ОХУ-ын Эрүүгийн хуулийн дэвшилттэй ямар заалт, зохицуулалтыг Монголын нөхцөлд авч хэрэглэх боломжтой эсэхийг тодорхойлох;
- Хоёр улсын Эрүүгийн хуулийг зүйл, заалт бүрээр нь харьцуулж дүгнэх зэрэг болно.

НЭГ. ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ

1. Нийтлэг үндэслэл

ОХУ-ын Төрийн дум нь шинэ Эрүүгийн хуулийг 1996 оны 5 дугаар сарын 24-ний өдөр баталж, 2002 оны 09 сарын 15-нд өөрчлөн найруулсан ба түүнээс хойш хэд хэдэн удаа нэмэлт өөрчлөлт орсоор өнөөдрийг хүрчээ.

Шинэ Эрүүгийн хуулийн төслийг боловсруулах ажлыг ЗХУ задарснаар шууд эхлүүлсэн /1992 оны төсөл/ бөгөөд түүний үндсэн зорилго нь хүний амь нас болон эрүүл мэндийг хамгаалах, олон улсын эрх зүйн хэм хэмжээг дээдлэх, гэмт хэрэгт ял шийтгэлийг оногдуулахдаа хүмүүнлэг, энэрэнгүй ёсны зарчмыг хангах талаар зохицуулалт оруулах байв.

Уг хууль нь хуучин ЗХУ-ын Эрүүгийн хуулиас хэд хэдэн зүйлээр ялгагдаж байна.

Тухайлбал, тангарагтны шүүхийн ажиллах зарчим, шүүхийн өмнөх гэмт этгээд болон прокурорын хоорондын тохиролцоо, ял оногдуулах журам, ялын төрлүүдийг нэмэгдүүлсэн, зарим хүнлэг бус ялын төрлүүдийг хассан, гэмт хэргийн 30 гаруй төрлийг халж мөн шинээр 20 гаруй үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан зэрэг болно.

Орчин үеийн ОХУ-ын Эрүүгийн төрөлжсөн хууль нь тус улсын Үндсэн хууль болон олон нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын эрх зүйн хэм хэмжээнд тулгуурласан ба Ерөнхий анги нь 6 бүлэг, 15 хэсэг, 104 зүйлээс бүрддэг.

[804] Судалгааг ЭЭЗКСС, ОУЭЗС хамтран гүйцэтгэсэн ба тус судалгааны ажил нь он дамнан үргэлжилж байгаа бөгөөд Эрүүгийн хуулийн ерөнхий ангид суурилж хийсэн урьдчилсан судалгаа болно.

Уг хэсэгт Эрүүгийн хуулийн ерөнхий зарчим, зохицуулалтыг зааж, Эрүүгийн хуулийн үйлчлэх хүрээ, гэмт хэргийн тухай ойлголт, ангилал, эрүүгийн хариуцлага хүлээх субьект, гэм буруу, түүний хэлбэр, төрөл, төгсөөгүй гэмт хэргийн тухай ойлголт, хамтран оролцогч, ял шийтгэл, түүний төрөл, зорилго, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл, насанд хүрээгүй хүмүүсийн хариуцлагын онцлог, эрүүгийн эрх зүйн шинжтэй бусад арга хэмжээний талаар тус тус заажээ.

1 дүгээр зүйл. ОХУ-ын Эрүүгийн хууль тогтоомж

1. ОХУ-ын Эрүүгийн хууль тогтоомж нь энэ хуулиас бүрдэнэ. Эрүүгийн хариуцлагын талаар заасан шинэ хуулиуд энэ хуульд багтсан болно.

2. Эрүүгийн хууль тогтоомж нь ОХУ-ын Үндсэн хууль, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээнд үндэслэнэ.

2 дугаар зүйл. ОХУ-ын Эрүүгийн хуулийн зорилт

1.Оросын Холбооны Улсын Эрүүгийн хуулийн зорилт нь хүний ба иргэний эрх, эрх чөлөө, өмч, олон нийтийн аюулгүй байдал, байгаль орчин, үндсэн хуулийн журмыг гэмт халдлагаас хамгаалах, энхтайван, хүн төрөлхтний аюулгүй байдлыг хангахад мөн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд оршино.

2.Эрүүгийн хууль энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд эрүүгийн хариуцлагын үндэслэл ба зарчмууд, хүн, төр, нийгэмд аюултай ямар үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, түүнийг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдэд хүлээлгэх ялын төрөл, хэмжээг тогтооно.

3 дугаар зүйл. Хууль ёсны зарчим

1.Үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, түүнд оногдуулах ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг зөвхөн энэ хуулиар тодорхойлно.

2.Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхийг хориглоно.

4 дүгээр зүйл. Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим

Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд түүний үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролыг үл харгалзан эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

5 дугаар зүйл. Гэм буруугийн зарчим

1. Гэмт этгээдийн гэм буруутай нь тогтоогдсон бол зөвхөн нийгэмд аюултай үйлдэл /эс үйлдэл/-дээ мөн нийгэмд аюултай хор уршиг учруулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

2.Гэм буруугүйгээр энэ хуульд заасан хор уршиг учруулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.

6 дугаар зүйл. Шударга ёсны зарчим

1.Ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ нь гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруутай этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдалд тохирсон шударга байна.

2.Хэн ч үйлдсэн гэмт хэрэгтээ хоёр удаа эрүүгийн хариуцлага хүлээхгүй.

7 дугаар зүйл. Энэрэнгүй ёсны зарчим

1. ОХУ-ын Эрүүгийн хууль тогтоомж нь хүний аюулгүй байдлыг хангана.

2.Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ нь хүнлэг бус, хэрцгий хандах, нэр төр, алдар хүндийг нь гутаах зорилго, хэлбэр агуулж болохгүй.

8 дугаар зүйл. Эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл

Энэ хуульд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний бүх шинжийг агуулсан хэрэг үйлдэгдсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

Тайлбар: Монгол Улсын Эрүүгийн хуулийн зорилт нь Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөө, өмч, үндэсний баялаг байгаль орчин, эрх зүйн журам, энхтайван, хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалхад оршино гэжээ.

Оросын Холбооны Улсын Эрүүгийн хуулийн зорилт нь хүний ба иргэний эрх, эрх чөлөө, өмч, олон нийтийн аюулгүй байдал, байгаль орчин, үндсэн хуулийн журмыг гэмт халдлагаас хамгаалах, энхтайван, хүн төрөлхтний аюулгүй байдлыг хангахад мөн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд оршино.

Эрүүгийн хууль энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд эрүүгийн хариуцлагын үндэслэл ба зарчмууд, хүн, төр, нийгэмд аюултай ямар үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, түүнийг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдэд хүлээлгэх ялын төрөл, хэмжээг тогтооно.

Харьцуулан үзэхэд, Монгол Улсын Эрүүгийн хуулийн зорилт нь гэмт халдлагаас хамгаалах гэсэн нэг л зорилтыг тусгасан бол ОХУ-ын Эрүүгийн хуулийн зорилт нь нийгмийн үнэт зүйлсийг гэмт халдлагаас хамгаалах, энхтайван, хүн төрөлхтөний аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх гэсэн 3 зорилттой байгаа нь илүү дэвшилттэй байна.

Эрүүгийн хуулийн 2 дугаар зүйлийн 2.2-д Эрүүгийн хууль тогтоомж нь энэ хуулиас бүрдэнэ гэж заасан боловч хориглосон үйлдлийн агуулгыг бусад хууль, эрх зүйн актаар тодорхойлоход хүргэдэг бланкетын диспозиц хэрэглэсэн хэм хэмжээг цөөнгүй хэрэглэсэн байгаа.

Эрүүгийн хуулийг хэрэглэх зарчмын хувьд хоёр улсын Эрүүгийн хууль бүх талаараа ижил төстэй бөгөөд ялгаатай ганц заалт нь ОХУ-ын Эрүүгийн хуулийн 7 дугаар зүйл "Энэрэнгүй ёсны зарчим" гэсэн заалтад "...ОХУ-ын эрүүгийн хууль тогтоомж нь хүний аюулгүй байдлыг хангана" гэжээ.

2. Эрүүгийн хуулийн цаг хугацаа болон орон зайн үйлчлэл

9 дүгээр зүйл. Эрүүгийн хууль үйлчлэх цаг хугацаа

1.Гэмт үйлдэл болон ял шийтгэл нь хэрэг үйлдэх үед дагаж мөрдөж байсан Эрүүгийн хуулийн дагуу тодорхойлогдоно.

2.Гэмт хэргийн хор уршиг хэзээ илэрснээс үл хамааран нийгэмд аюултай үйлдэл /эс үйлдэл/ үйлдсэн үеийг гэмт хэрэг үйлдэгдсэн цаг хугацаанд тооцно.

10 дугаар бүлэг. Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх

1.Үйлдэл гэмт хэрэгт тооцохгүй болсон буюу оногдуулах ялыг хөнгөрүүлсэн эсхүл бусад аргаар гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн эрүүгийн хуулийг буцаан хэрэглэж, тухайлбал тус хуулийг батлагдахаас өмнө гэмт үйлдэл хийсэн буюу ял эдэлж байгаа, ял эдэлсэн боловч ялтай байдалтай байгаа этгээдэд хамаарна.

2.Шинэ эрүүгийн хууль тухайн ял эдэлж буй этгээдийн ялын хэмжээ багасгасан тохиолдолд шинэ эрүүгийн хуулиар зохицуулсан ялыг дүйцүүлэн хасна.

11 дүгээр зүйл. ОХУ-ын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн этгээдэд Эрүүгийн хууль үйлчлэх

1.ОХУ-ын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн этгээдэд энэ хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

2.ОХУ-ын газар нутгийн тэнгисийн болон агаарын орон зайд үйлдэгдсэн гэмт хэргийг ОХУ-ын газар нутагт үйлдэгдсэнд тооцно. Энэ хууль нь түүнчлэн эх газрын хэсэгт болон эдийн засгийн тусгай бүсэд ч үйлчилнэ.

3.ОХУ-ын боомтод бүртгэлтэй онгоцонд хилийн чанадад, нээлттэй усан болон агаарын орон зайд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хэрэв ОХУ-ын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Энэ хуулиар түүнчлэн ОХУ-ын цэргийн хөлөг болон байлдааны агаарын онгоцонд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хаана байрлаж байснаас үл хамааран эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

4. Гадаад улсын дипломат дархан эрх эдэлж байгаа төлөөлөгчид болон өөр бусад иргэд ОХУ-ын газар нутагт гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай асуудлыг ОХУ-ын олон улсын гэрээний дагуу шийдвэрлэнэ.

12 дугаар зүйл. Оросын Холбооны Улсын хилийн гадна гэмт хэрэг үйлдсэн этгээдэд Эрүүгийн хууль үйлчлэх

1.ОХУ-ын иргэн, тус улсад байнга оршин суудаг харьяалалгүй хүн ОХУ-ын гадна энэ хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг үйлдэж, тухайн хэрэгтээ ял шийтгүүлээгүй бол энэ хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

2.ОХУ-ын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаад улсад алба хааж байхдаа гэмт хэрэг үйлдсэн ОХУ-ын цэргийн албан хаагчид энэ хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

3.ОХУ-д байнга оршин суудаггүй гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн тус улсын хилийн гадна ОХУ-ын ашиг сонирхлын болон ОХУ-ын иргэний эсхүл ОХУ-д байнга оршин суудаг харьяалалгүй хүний эсрэг гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд, түүнчлэн ОХУ-ын олон улсын гэрээнд заасан тохиолдолд, хэрэв ОХУ-д байнга оршин суудаггүй гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн гадаад улсад ял шийтгүүлээгүй бол энэ хуулийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээнэ.

13 дугаар зүйл. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шилжүүлэх

1. Гадаад улсын нутагт гэмт хэрэг үйлдсэн ОХУ-ын иргэнийг тус улсад шилжүүлж өгөхгүй.

2.ОХУ-ын хилийн гадна гэмт хэрэг үйлдсэн бөгөөд ОХУ-ын нутаг дэвсгэрт байгаа гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнийг эрүүгийн хариуцлага хүлээлгэх буюу ял эдлүүлэхээр ОХУ-ын олон улсын гэрээнд заасны дагуу гадаад улсад шилжүүлж болно.

Эрүүгийн хууль үйлчлэх цаг хугацаа, Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх үндэслэл хоёр улсын хуульд адил заагдсан байна.

Гэмт үйлдэл болон ял шийтгэл нь хэрэг үйлдэх үед дагаж мөрдөж байсан Эрүүгийн хуулийн дагуу тодорхойлогдоно.

Гэмт хэргийн хор уршиг хэзээ илэрснээс үл хамааран нийгэмд аюултай үйлдэл /эс үйлдэл/ үйлдсэн үеийг гэмт хэрэг үйлдэгдсэн цаг хугацаанд тооцно.

Тайлбар: Монгол Улсын Эрүүгийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-д "...Монгол Улсын төрийн далбааг мандуулсан хөлөг онгоц, агаарын хөлөгт гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд энэ хуулиар хариуцлага хүлээлгэнэ" гэжээ.

Энд үүсэж байгаа асуудал нь Гадаад улсын олон тооны усан онгоц Монголын төрийн далбааг мандуулан далайгаар аялдаг бөгөөд өөр улсад бүртгэлтэй, өөр улсын боомтод харъяалагддаг хөлөг онгоц дээр гарсан гэмт хэргийг Монгол Улсын Эрүүгийн хуулиар хариуцлага хүлээлгэх боломжгүй бөгөөд энэ заалтыг дээрх ОХУ-ын Эрүүгийн хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасанчлан "...олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хууль үйлчилнэ" гэж өөрчлөн найруулах нь зөв юм.

ХОЁР. ГЭМТ ХЭРЭГ

1. Гэмт хэргийн ойлголт, ангилалт

14 дүгээр зүйл. Гэмт хэргийн тухай ойлголт

1. Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ.

2. Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан боловч ялимгүйн учир нийгэмд аюулгүй үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй.

Тайлбар: ОХУ-ын Эрүүгийн хуулийн 14 дүгээр зүйлд гэмт хэргийн ойлголтыг "...Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ" гэсэн нь зарчмын зөрүүгүй байна.

15 дугаар бүлэг. Гэмт хэргийн ангилал

1. Энэ хуульд заасан нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээнээс хамаарч гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

2. Энэ хуульд хоёр хүртэлх жилийн хугацаагаар баривчлах ял шийтгэхээр заасан санаатай болон болгоомжгүйгээр үйлдсэн гэмт хэргийг хөнгөн гэмт хэрэг гэнэ.

3. Энэ хуульд таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан санаатай үйлдсэн гэмт хэргийг хүндэвтэр гэмт хэрэг гэнэ, болгоомжгүйгээр үйлдсэн гэмт хэрэгт энэ хуулийн дагуу хоёроос дээш жилийн хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4. Энэ хуульд арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан санаатай үйлдсэн гэмт хэргийг хүнд гэмт хэрэг гэнэ.

5. Энэ хуульд арван жилээс дээш хугацаагаар хорих буюу хатуу ял шийтгэхээр заасан санаатай үйлдсэн гэмт хэргийг онц хүнд гэмт хэрэг гэнэ.

Тайлбар: ОХУ-ын Эрүүгийн хуульд гэмт хэргийг ангилахдаа гэм буруугийн хэлбэрийг харгалздаг бөгөөд энэ нь хүнд болон онц хүнд гэмт хэрэгт зөвхөн санаатай гэмт хэрэг байхаар хуульчилснаас харж болно.

ОХУ-д гэмт хэргийг нийгмийн аюулаар их биш, дунд зэргийн нийгэмд аюултай гэмт хэрэг, хүнд болон онц хүнд гэмт хэрэг гэж ангилсан нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн 17 дугаар зүйлд заасан гэмт хэргийн ангилалтай ойролцоо байна.

Нийгмийн аюулаар их биш гэмт хэрэг /Монголын Эрүүгийн хуулиар хөнгөн гэмт хэрэг/ нь 2 жил хүртэл хорих ял шийтгэхээр заасан санаатай болон болгоомжгүй гэмт хэргүүдийг хамааруулна гэжээ.

Тэгвэл Монгол Улсын Эрүүгийн хуульд 1-3 сар баривчлах ялтай, ХХДХ-г 5-50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр торгох, 100-250 цаг хүртэл албадан ажил хийлгэх ялтай хэргийг хөнгөн гэмт хэрэг гэж тодорхойлжээ.

Харьцуулахад Монгол Улсын Эрүүгийн хуульд заагдсан хөнгөн гэмт хэргийн хүрээг хэтэрхий хязгаарлан тогтоосноос эрүүгийн хариуцлагад татах хугацаа өнгөрсөн тохиолдолд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, хохирогчтой эвлэрсэнээр хариуцлагаас чөлөөлөх боломж багасаж заавал ял шийтгэхээр болж байгаа зэрэг дутагдалтай талууд харагдаж байна.

Хүндэвтэр хэрэгт 5 жил хүртэл хорих ялтай санаатай гэмт хэргүүд хамаарах ба болгоомжгүй гэмт хэрэгт 2 жилээс дээш хорих ял оногдуулж болохгүй гэж ОХУ-ын Эрүүгийн хуулийн 16 дугаар зүйлд заажээ.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсэгт "... арван жил хүртэл хорих ял шийтгэхээр заасан санаатай үйлдсэн гэмт хэргийг хүнд гэмт хэрэг" гэж, 15 жилээс дээш хугацаагаар хорих буюу илүү хатуу ял шийтгэхээр заасан санаатай үйлдсэн гэмт хэргийг онц хүнд гэмт хэрэг гэнэ" гэжээ.

2. Давтан болон нийлмэл гэмт хэрэг

18 дугаар зүйл. Гэмт хэрэг давтан үйлдэх /Рецидив гэмт хэрэг/

1.Гэмт хэрэг өмнө нь үйлдэж байсан этгээд гэмт хэрэг дахин үйлдэхийг давтан гэмт хэрэг гэнэ.

2.Гэмт хэрэг давтан үйлдэх нь дараахь тохиолдолд аюултайд тооцогдоно:

а.Өмнө нь хоёр ба түүнээс дээш удаа хүнд гэмт хэрэг үйлдэж хорих ял эдэлж байсан этгээд хорих ял оногдуулахуйц хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн бол;

б.Өмнө нь хүнд болон онц хүнд гэмт хэрэг үйлдэж хорих ял эдэлж байсан этгээд хүнд гэмт хэрэг үйлдсэн бол.

3.Гэмт хэрэг давтан үйлдэх нь дараах тохиолдолд онц аюултайд тооцогдоно:

а.Өмнө нь хоёр ба түүнээс дээш удаа хүнд гэмт хэрэг үйлдэж хорих ял эдэлж байсан этгээд хорих ял оногдуулахуйц хүнд гэмт хэрэг үйлдсэн бол;

б.Өмнө нь хоёр ба түүнээс дээш удаа хүнд ба онц хүнд гэмт хэрэг үйлдэж хорих ял эдэлж байсан этгээд онц хүнд гэмт хэрэг үйлдсэн бол.

4.Дараах тохиолдолд давтан гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй:

а.Санаатай гэмт хэрэг үйлдсэн ялтай байсан;

б.18 хүртэл насны этгээд гэмт хэрэг үйлдсэн ялтай байсан

в.Гэмт хэрэг үйлдэн ялтай байсан этгээд түр тэнсэн суллагдсан, эсхүл шүүхийн шийтгэх тогтоол хойшлогдсон, хорих газарлуу илгээгдээгүй буюу энэ хуулийн 86 дугаар зүйлд заасан журмын дагуу ялгүй болсон эсхүл ялгүй чөлөөлөгдсөн бол

5.Энэ хуулиар зохицуулсаны дагуу гэмт хэрэг давтан үйлдэх нь илүү хатуу шийтгэлийг оногдуулах болно.

Тайлбар:Энэ хэсгийг Монгол Улсын Эрүүгийн хуулийн холбогдох хэсэгтэй харьцуулахад давтан гэмт хэргийг өөрөөр тодорхойлж, рецидив гэмт хэрэг нь ямар тохиолдолд аюултай болон онц аюултай болох, ямар тохиолдолд рецедив гэж үзэхгүй байх талаар заажээ.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 24 дүгээр зүйлд заасан "Онц аюултай гэмт хэрэгтэн" гэх ойлголт ОХУ-ын Эрүүгийн хуульд байхгүй бөгөөд заагдсан шинжүүдийн зарим нь рецедив гэмт хэргийн онц аюултай гэж үзэж шинжид хамаарч байна.

3.Эрүүгийн хариуцлага хүлээх этгээд

Тайлбар: Эрүүгийн хариуцлага хүлээх этгээд нь 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай этгээд байна гэсэн заалт нь хоёр улсын хуульд адил төстэй байна.

Түүнчлэн 14 наснаас эхлэн хариуцлага хүлээлгэх гэмт хэргүүдийн төрлүүдийг харьцуулахад мөн ижил байна.

Ялгаатай тал нь ОХУ-ын Эрүүгийн хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэгт "...насанд хүрээгүй этгээд энэхүү зүйлийн нэг болон 2-р хэсэгт заасан насанд хүрсэн боловч сэтгэл зүйн хөгжлийн хувьд хоцрогдолтой бөгөөд

сэтгэцийн хувьд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлах буюу үйл ажиллагаагаа удирдан жолоодох чадваргүй болсон тохиолдолд ял оногдуулахгүй" гэсэн заалт байна.

Насанд хүрээгүй этгээд энэхүү зүйлийн нэг болон хоёрдугаар хэсэгт заасан насанд хүрсэн боловч сэтгэл зүйн хөгжлийн хувьд хоцрогдолтой бөгөөд сэтгэцийн хувьд. өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлах буюу үйл ажиллагаагаа удирдан жолоодох чадваргүй болсон тохиолдолд ял оногдуулахгүй.

Хэрэг хариуцах чадваргүй байдал, согтуурсан буюу мансуурсан байдалд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөхгүй гэсэн заалтууд адил байна

4. Гэм буруу

Тайлбар: Гэм буруугийн хэлбэр, гэмт хэргийг санаатай үйлдэх, болгоомжгүй үйлдэх, түүний хэлбэрийн талаар хоёр улсын Эрүүгийн хуулийн заалтууд ижил байна.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 27 дугаар зүйлд гэм буруугийн давхардсан хэлбэрийн талаар заасан бөгөөд үйлдэлдээ санаатай, хор уршигтаа болгоомжгүй хандсан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ, бүхэлдээ ийм хэргийг санаатай үйлдсэн гэж тооцно гэжээ.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 28 дугаар зүйлд "хор уршиг гэм буруугүйгээр учруулах талаар заахдаа "гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлаагүй, хэргийн нөхцөл байдлын улмаас ухамсарлах боломжгүй байсан, түүнчлэн учирч болох нийгэмд аюултай хор уршгийг урьдчилан мэдэх боломжгүй, мэдэх ёсгүй байсан бол хор уршиг гэм буруугүйгээр учруулсан гэж үзнэ.

Гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгэмд аюултай үр дагаварыг урьдчилан мэдсэн хэдий ч тухайн этгээдийн сэтгэл санааны болон биеийн чадвар нь онцгой нөхцөл байдалд буюу сэтгэл мэдрэлийн ачаалалтай үед хүрэлцэхгүй байх үед гэмт хэргийг таслан зогсоож чадаагүй бол хор уршиг гэм буруугүйгээр учруулах гэж үзнэ. Энэ заалт Монгол Улсын Эрүүгийн хуульд байхгүй.

5. Төгсөөгүй гэмт хэрэг

29 дүгээр зүйл. Төгссөн болон төгсөөгүй гэмт хэрэг

1.Үйлдэл, эс үйлдэхүй нь энэ хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн бүх шинжийг агуулсан байвал төгссөн гэмт хэрэг гэнэ.

2.Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэх, завдахыг төгсөөгүй гэмт хэрэг гэнэ.

3.Төгсөөгүй гэмт хэрэг үйлдсэн этгээдэд энэ хуулийн 30 дугаар зүйлийг журамлан тусгай ангийн зохих зүйл, хэсэгт зааснаар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Тайлбар: ОХУ-ын Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 6 дугаар бүлэг нь "Төгсөөгүй гэмт хэрэг" гэсэн гарчигтай бол Монгол Улсын Эрүүгийн хуулийн 6 дугаар бүлэг нь "Гэмт хэрэг үйлдэх үе шат" гэсэн гарчигтай байна. Гэвч тус бүлэгтээ гэмт хэрэг үйлдэх үе шатны талаар тусгалгүй зөвхөн бэлтгэлт,

завдалт, төгссөн гэмт хэрэг, гэмт хэрэг үйлдэхээс сайн дураараа татгалзах талаар заажээ.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 30 дугаар зүйлд "гэмт хэрэгт бэлтгэх, завдах талаар заасан ба зөвхөн хүнд болон онц хүнд гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр зааснаас гадна завдалтыг төгссөн болон төгсөөгүй завдалт гэж ангилаагүй.

Харин Монгол Улсын Эрүүгийн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-д "... хөнгөн гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн этгээдийн үйлдэлд өөр гэмт хэргийн шинжгүй бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй" гэсэн байна.

Гэмт хэрэг үйлдэхээс сайн дураараа төгс татгалзах зүйл заалтын хувьд ерөнхийдөө Монголын Эрүүгийн хуультай адил боловч хамтран оролцогчдыг ямар тохиолдолд сайн дураараа төгс татгалзсан гэж үзэх тал дээр дэлгэрэнгүй тайлбарласан.

Тухайлбал, зохион байгуулагч, хатгагч нь гэмт хэрэг үйлдэгдэх гэж байгаа талаар төрийн холбогдох байгууллагад мэдэгдсэн буюу өөр арга хэмжээ авч гэмт хэргийг бүрэн үйлдэгдэхээс урьдчилан сэргийлсэн тохиолдолд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөнө.

Хамжигч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч гэмт хэргийг бүрэн үйлдэгдэхээс урьдчилан сэргийлсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөнө, харин зохион байгуулагч хатгагч нарын дээрх үйлдэл нь гэмт хэрэг үйлдэгдэхийг зогсоож чадаагүй бол энэ нь хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдал болно.

6. Гэмт хэрэгт хамтран оролцох

33 дугаар зүйл. Гэмт хэрэгт хамтран оролцогчийн төрөл

1. Гүйцэтгэгчийн хамтаар зохион байгуулагч, хатгагч болон хамжигч этгээдийг гэмт хэрэгт хамтран оролцогч гэнэ.

2. Гэмт хэргийг гардан үйлдсэн, эсхүл бусад этгээдтэй хамт гэмт хэрэг үйлдсэн/хамтран оролцогч нартай/, насанд хүрээгүй, эсхүл сэтгэцийн чадамжгүйн улмаас эрүүгийн хариуцлага хүлээхгүй бусад этгээдүүдийг ашиглан гэмт хэрэг үйлдсэн этгээдийг гэмт хэрэг гүйцэтгэгч гэнэ.

3.Гэмт хэрэг үйлдэхийг гардан зохион байгуулсан буюу удирдсан, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл байгуулж, үйл ажиллагааг нь чиглүүлж удирдсан этгээдийг зохион байгуулагч гэнэ.

4. Ятгах, заналхийлэх болон бусад аргаар гэмт хэрэг үйлдэхэд бусдыг өдөөн түлхсэн, зоригжуулсан этгээдийг хатгагч гэнэ.

5. Зааж зөвлөх, зэвсэг, хэрэгсэл өгөх, учрах саадыг арилгах, унаа, орон байраар хангах зэргээр гэмт хэрэг үйлдэхэд дэмжлэг үзүүлсэн, түүнчлэн гэмт хэрэг үйлдсэн этгээд болон гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, хэрэгсэл, гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйлийг нуун далдлах, зарж борлуулах, гэмт хэргийн ул мөрийг баллахаар урьдчилан амалсан этгээдийг хамжигч гэнэ.

34 дүгээр зүйл. Гэмт хэрэгт хамтран оролцох хүлээлгэх хариуцлага

1. Гэмт хэрэгт хамтран оролцогчид хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг гэмт хэрэг үйлдэхэд гүйцэтгэсэн үүрэг, үйлдлийн шинж чанар, хэр хэмжээг харгалзан хүлээлгэнэ.

2. Гэмт хэрэг хамтран гүйцэтгэгч нар энэ хуулийн 33 дугаар зүйлээс гадна энэ хуулийн тусгай ангиар зохицуулсаны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

3. Гэмт хэрэг хамтран гүйцэтгэгчийн хувиар оролцоогүй тохиолдолд зохион байгуулагч, хатгагч, хамжигчийн үйлдсэн гэмт хэргийн хариуцлагыг энэ хуулийн 33 дугаар зүйлийн дагуу хүлээлгэнэ.

4. Энэ хуулийн тусгай ангид тусгайлан заасан гэмт хэргийн субьект болоогүй этгээд энэ зүйлд заасан гэмт хэрэг үйлдэхэд оролцсон бол тус гэмт хэргийн зохион байгуулагч, хатгагч эсхүл хамжигчийн хувиар эрүүгийн хариуцлага хүлээнэ.

5. Өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар гүйцэтгэгч гэмт хэргийг дуусгаагүй бол бусад хамтран гүйцэтгэгч нар тухайн гэмт хэрэгт бэлтгэсэн болон завдсан үйлдлийнхээ төлөө эрүүгийн хариуцлага хүлээнэ.

35 дугаар зүйл. Бүлэглэн, урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, зохион байгуулалтай бүлэг, гэмт бүлэглэл хэлбэрээр гэмт хэрэг үйлдэх

1.Хоёр буюу түүнээс дээш этгээд урьдчилан үгсэж тохиролцоогүй боловч гэмт хэрэг үйлдэхдээ санаатай нэгдсэн бол бүлэглэн гүйцэтгэгч гэнэ.

2.Гэмт хэрэг хамтран үйлдэх талаар урьдчилан үгсэж тохиролцсон хоёр буюу түүнээс дээш этгээдийг урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг гэнэ.

3.Гэмт хэрэг үйлдэхийн тулд урьдчилан нэгдсэн, тогтвортой бүлгийг зохион байгуулалттай бүлэг гэнэ.

4. Нэг буюу түүнээс дээш гэмт хэрэг үйлдэж ашиг олох зорилготой, санхүүгийн сонирхолтой, бүтэц, зохион байгуулалттай, нэг удирдлага доор, нэг буюу түүнээс дээш тооны этгээдүүдийн нэгдлийг гэмт бүлэглэл гэнэ.

5.Зохион байгуулалттай бүлэг эсхүл гэмт бүлэглэл зохион байгуулсан, удирдсан этгээд энэхүү бүлэглэлийг зохион байгуулсан, удирдсаны төлөө энэ хуулийн 208, 209, 210 болон 282.1-д заасны дагуу эрүүгийн хариуцлага хүлээх бөгөөд тус зохион байгуулалттай бүлэглэл ба гэмт бүлэглэлийн хийж гүйцэтгэсэн бүхий л гэмт хэргийн төлөө хариуцлага хүлээнэ. Зохион байгуулалттай бүлэг ба гэмт бүлэглэлийн бусад гишүүд энэ хуулийн 208, 209, 210 ба 282.1.-д заасан нөхцөлийн дагуу хариуцлага хүлээхээс гадна өөрийн оролцсон гэмт хэргийн бэлтгэл болон үйлдэлийн дагуу хариуцлага хүлээнэ.

6.Энэ хуулийн тусгай ангиар зохицуулаагүй нөхцөлөөр зохион байгуулалттай бүлэг үүсгэн байгуулж гэмт хэрэг үйлдсэн бол тэрхүү гэмт хэргийг бэлтгэсэн болон үйлдсэнийхээ төлөө хариуцлага хүлээнэ.

7.Бүлэг, урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэлээр гэмт хэрэг үйлдсэн бол энэ хуульд заасан журмын дагуу илүү хүнд ял оногдуулна.

Тайлбар: Гүйцэтгэгч нь бусад оролцогч мэдээгүй, өөрөөр хэлбэл, түүнтэй тохиролцоогүй гэмт хэрэг үйлдэхийг зөрчиж гүйцэтгэх гэнэ. Зөрчиж гүйцэтгэсэн гэмт хэрэгт бусад хамтран оролцогчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.

Хамтран оролцогчдын төрлийн хувьд Монгол Улсын Эрүүгийн хуульд 5 төрлийг заасан байдаг. Үүнд: гүйцэтгэгч, зохион байгуулагч, захиалагч, хатгагч, хамжигч хамаарна.

Тэгвэл ОХУ-ын Эрүүгийн хуулийн 33 дугаар зүйлд хамтран оролцогчдын 4 төрлийг заасан бөгөөд захиалагчийг тусдаа төрөл гэж үзэхгүй хатгагчийн нэгэн дэд төрөл гэж үздэг байна. Өөрөөр хэлбэл, хатгагч гэдэг нь ятгах, заналхийлэх болон бусад аргаар гэмт хэрэг үйлдэхэд бусдыг өдөөн түлхсэн, зоригжуулсан этгээд байхыг хуульчилжээ. Бусад аргаар гэмт хэрэг үйлдэхэд бусдыг өдөөн түлхсэн, зоригжуулсан гэдэгт эд хөрөнгө амлах, мөнгө өгөх зэрэг багтана гэж үздэг.

Гэмт хэрэгт хамтран оролцогчдын хэлбэр нь ОХУ-ын улсын Эрүүгийн хуульд бүлэглэн гүйцэтгэх, урьдчилан үгсэн тохиролцсон бүлэг, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл буюу гэмт байгууллага байна гэж заасан.

Гэмт байгууллага гэж гишүүд нь нэг буюу түүнээс дээш хүнд болон онц хүнд гэмт хэрэг үйлдэж материаллаг ашиг олох зорилготой, нэгдмэл удирдлагатай, зохион байгуулалтын тодорхой бүтэцтэй этгээдүүдийн нэгдлийг хэлнэ.

Гэмт хэрэгт хамаарагсдын талаар Монгол Улсын Эрүүгийн хуулийн 7 дугаар бүлэг буюу хамтран оролцох гэсэн бүлгийн 39 дүгээр зүйлд заасан бол ОХУ-ын Эрүүгийн хуулийн холбогдох хэсэгт заагаагүй байна.

7. Гэмт хэргийн нийгмийн аюулыг үгүйсгэх нөхцөл байдал

Тайлбар: ОХУ-ын Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 8 дугаар бүлэгт гэмт хэргийн нийгмийн аюулыг үгүйсгэх 6 нөхцөл байдлын талаар заажээ. Үүнд:

- Аргагүй хамгаалалт;
- Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах саатуулах үед гэм хор учруулах;
- Гарцаагүй байдал;
- Биеийн болон сэтгэл санааны албадлага;
- Үндэслэл бүхий эрсдэл;
- Тушаал захирамж биелүүлэх зэрэг болно.

37 дугаар зүйл. Аргагүй хамгаалалт

1.Аргагүй хамгаалалтын байдалд, өөрөөр хэлбэл, энэ хуулиар хамгаалагдсан төр, нийгмийн ашиг сонирхол, өөрийн болон бусдын амьд явах, халдашгүй чөлөөтэй байх, түүнчлэн бусад эрх, эрх чөлөөг нийгэмд аюултай халдлагаас хамгаалахдаа энэ хуулийн тусгай ангид заасан үйлдэл

хийж, халдагч этгээдэд гэм хор учруулсныг гэмт хэрэгт тооцохгүй.

2.Хүчирхийлэлд автсан эсхүл хүчийрхийлэлд автах боломжтой нөхцөлд өөрийн болон бусдын амь насыг аюултай халдлагаас хамгаалах нь аргагүй хамгаалалтын зохимжит түвшинг хэтрүүлэхгүй, тус хамгаалалт нь учирч болзошгүй аюулаас илүү хэмжээний хохирол учруулахгүй тохиолдолд энэ хууль ёсны аргагүй хамгаалалтыг хэмжээг хэтрүүлэхгүй гэж үзнэ.

2.1. Аргагүй хамгаалалт үзүүлж буй этгээд гэнэтийн халдлагын үед өөрийн хамгаалалтын үр дүнд учирч болзошгүй хор уршигийн түвшин, хэр хэмжээг мэдэх боломжгүй нөхцөлд байсан бол түүнийг аргагүй хамгаалалтын хэмжээг хэтрүүлсэн гэж үзэхгүй.

3.Хүн бүр албан тушаалын байдал, мэргэжил, хуулиар хүлээлгэсэн үүрэг, албаны тусгай бэлтгэлээс хамаарахгүйгээр аргагүй хамгаалалт хийх эрхтэй. Хамгаалагч нийгэмд аюултай халдлагаас зайлсхийх, төрийн байгууллага, албан тушаалтан, бусад хүмүүсээс тусламж хүсэх боломжтой байсан эсэх нь аргагүй хамгаалалт хийх эрхэд нөлөөлөхгүй.

38 дугаар зүйл. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, саатуулах үед гэм хор учруулах

1.Гэмт хэрэг үйлдсэн этгээд болон оргосон ялтан шинээр гэмт хэрэг үйлдэх боломжийг таслан зогсоох, түүнийг төрийн байгууллагад хүргэхийн тулд баривчлах, саатуулах үед энэ хуулийн тусгай ангид заасан үйлдлийг хийж гэм хор учруулсан бол гэмт хэрэгт тооцохгүй.

2.Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах үед түүнд гэм хор учруулахдаа тус этгээдийн үйлдсэн гэмт хэргийн шинж чанар, нийгэмд учруулсан аюулын хэр хэмжээнээс илүү, нөхцөл байдалд тохирохгүй их хэмжээгээр гэм хор учруулж болохгүй. Ийм тохиолдолд санаатай гэм хор учруулах үйлдэл байсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

39 дүгээр зүйл. Гарцаагүй байдал

1. Энэ хуулиар хамгаалагдсан төр, нийгмийн ашиг сонирхол, өөрийн болон бусдын амьд явах эрх, түүнчлэн бусад эрх, эрх чөлөөнд тулгарсан аюулыг зайлуулахын тулд энэ хуулийн тусгай ангид заасан үйлдлийг хийж, учруулсан хохирол нь учирч болох байсан хохирлоос бага бөгөөд уг аюулыг тухайн нөхцөл байдалд өөр аргаар зайлуулах боломжгүй байсан бол уг үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй.

2. Учирч болзошгүй байсан аюулд тохирохгүй шинж ба түвшингийн гэм хор учруулах, гарцаагүй байдалд хийсэн үйлдэл нь тус этгээдэд учирч болзошгүй гэм хороос илүү их аюулыг авчирсан тохиолдолд гарцаагүй байдалын эрх хэмжээг хэтрүүлэх гэнэ. Ийм тохиолдолд санаатай гэм хор учруулах үйлдэл байсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

40 дүгээр зүйл. Биеийн хүчний болон сэтгэл санааны албадлага

1. Энэ хуулиар хамгаалагдсан эрх ашгийн хүрээнд өөрийн үйлдлийг удирдах чадваргүй этгээдэд биеийн хүчний албадлага учруулах нь гэмт хэрэгт тооцогдохгүй.

2. Сэтгэл санаяны хувьд албадах , тус этгээдийг өөрийн үйлдлийг удирдах чадвартай байх үед биеийн хүчний хувьд албадах үед эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал энэ хуулийн 39 дүгээр зүйлийн зохицуулалтын дагуу шийдвэрлэгдэнэ.

41 дүгээр зүйл. Үндэслэл бүхий эрсдэл

1.Нийгэмд ашигтай зорилгод хүрэхээр хийсэн энэ хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд гэм хор учруулсныг гэмт хэрэгт тооцохгүй.

2.Эрсдэл бүхий үйлдэл, эс үйлдэхүй хийхгүйгээр тухайн зорилгод хүрч чадахгүй байсан бөгөөд эрсдэл хийсэн этгээд энэ хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд гэм хор учруулахгүйн тулд хангалттай арга хэмжээ авсан бол үндэслэл бүхий эрсдэлд тооцно.

3.Олон хүний амь насанд гэм хор учруулах, нийтийг хамарсан буюу байгалийн гамшигт үр дагаварт хүргэх аюултай хоршсон эрсдэл хийснийг үндэслэл бүхий эрсдэлд тооцохгүй.

42 дүгээр зүйл. Тушаал, захирамж биелүүлэх

1.Заавал биелүүлэх тушаал, захирамжийг биелүүлэхдээ энэ хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд гэм хор учруулсан бол гэмт хэрэгт тооцохгүй. Харин хууль бус тушаал, захирамж өгсөн этгээдэд гэм хор учруулсны төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

2.Илт хууль бус тушаал, захирамж биелүүлж энэ хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд гэм хор учруулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Илт хууль бус тушаал, захирамжийг биелүүлээгүй этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.

Тайлбар: Аргагүй хамгаалалтын тодорхойлолт адил боловч ОХУ-ын Эрүүгийн хуулийн 37 дугаар зүйлд аргагүй хамгаалалт нь хэр хэмжээнээс хэтрээгүй тохиолдолд хууль ёсны байна гэжээ. Тухайлбал, "...хүчирхийлэлд автаагүй эсхүл хүчирхийлэлд автах боломжтой нөхцөлд өөрийн болон бусдын амь насанд аюултай халдлагаас хамгаалах нь аргагүй хамгаалалтын зохимжит түвшинг хэтрүүлээгүй, тус хамгаалалт нь учирч болзошгүй аюулаас илүү хэмжээний хохирол учруулахгүй тохиолдолд энэ хууль ёсны хамгаалалтыг хэр хэмжээ хэтрүүлээгүй гэж үзнэ".

Аргагүй хамгаалалт хийж буй этгээд гэнэтийн халдлагын үед өөрийн хамгаалалтын үр дүнд учирч болзошгүй хор уршигийн түвшин, хэр хэмжээг мэдэх боломжгүй нөхцөлд байсан бол түүнийг аргагүй хамгаалалтын хэмжээг хэтрүүлсэн гэж үзэхгүй хэмээн ОХУ-ын Эрүүгийн хуульд заажээ.

Хэрэв гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах саатуулах үед болон аргагүй хамгаалалтын хэр хэмжээг хэтрүүлж хүний амь хохироосон бол тусгай ангийн 108 дугаар зүйлд зааснаар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах саатуулах үед гэм хор учруулсан тохиолдолд гэмт хэрэгт тооцохгүй боловч гэм хор учруулахдаа тус этгээдийн үйлдсэн гэмт хэргийн нийгмийн шинж чанар, нийгэмд учруулсан аюулын хэр хэмжээнээс илүү, нөхцөл байдалд илт тохироогүй хэтэрсэн гэм

хор учруулж болохгүй бөгөөд учруулсан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 41 дүгээр зүйлд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах саатуулах үед гэм хор учруулсан тохиолдолд ямар нэгэн хязгаарлалт хийгээгүй бөгөөд гэмт хэрэгт тооцохгүй байгаа.

Үзэл баримтлалын хувьд Монгол Улсын Эрүүгийн хуульд заагдсан гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах саатуулах үед болон аргагүй хамгаалалт хийж бусдад гэм хор учруулсан тохиолдолд гэмт хэрэгт тооцохгүй байгаа нь давуу талтай мэт харагдавч практик шийдлийн хувьд ОХУ-ын Эрүүгийн хуулийн дээрх заалтууд илүү амьдралд нийцэж байна.

Монгол Улсын шүүхийн практикаас харахад аргагүй хамгаалалт хийж бусдын амь насыг хохироосон үйлдлийг бусдыг санаатай алсан хэмээн Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлээр зүйлчилж 10-15 жилийн хорих ял оногдуулж байгаа нь Эрүүгийн хуулийн бодлого, хууль тогтоогчийн санаа хэрэгжихгүй байгааг харуулж байна.[805]

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 40 дүгээр зүйлд "Биеийн болон сэтгэл санааны албадлага" гэсэн Монгол Улсын Эрүүгийн хуульд огт байхгүй нөхцөл байдлыг тусгасан байна. Эрүүгийн хуулиар хамгаалагдсан эрх ашгийн хүрээнд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйг удирдан жолоодох чадваргүй этгээдэд биеийн хүчний албадлага хэрэглэж гэм хор учруулсаныг гэмт хэрэг тооцохгүй.

Эрүүгийн хуульд заагдсан эрх ашгийн үүднээс өөрийн үйлдэл, эс үйлдэхүйг удирдан жолоодох чадвартай этгээдийг биеийн болон сэтгэл санааны хувьд албадаж гэм хор учруулсан бол энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу хариуцлага хүлээлгэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

39 дүгээр зүйл нь "гарцаагүй байдал" гэсэн гарчигтай бөгөөд 1 дэх хэсгийн заалт нь Монголын Эрүүгийн хуулийн 42 зүйлтэй адил бол 2 дахь хэсэгт "...учирч болзошгүй байсан аюулаас илүү буюу тэнцүү хэмжээний гэм хор учруулсан тохиолдолд гарцаагүй байдлын хэм хэмжээг хэтрүүлсэн гэж үзнэ", ийм тохиолдолд санаатай гэм хор учруулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэн гэжээ.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 41 дүгээр зүйлд "үндэслэл бүхий эрсдэл" гэж заасан бол Монгол Улсын Эрүүгийн хуульд "Үйлдвэрлэл, шинжилгээ, судалгааны ажлын үндэслэл бүхий эрсдэл хэмээн тодорхойлсноороо ялгаатай байна.

Эрсдэл нь үнэхээр нийгэмд ашигтай зорилгоор хийгдсэн, үндэслэл бүхий, эрсдэл хийхгүйгээр тухайн зорилгод хүрч чадахгүй байсан бол гэмт хэрэгт тооцохгүй бөгөөд заавал "Үйлдвэрлэл, шинжилгээ, судалгааны ажлын" гэж тодотгох шаардлагагүй юм.

ГУРАВ. ЯЛ

1. Ялын ойлголт, зорилго

Тайлбар:ОХУ-ын Эрүүгийн хуулийн 43 дугаар зүйлд "...ял нь гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдийн эрх, эрх чөлөөнд энэ хуульд заасны дагуу шүүхийн шийтгэх тогтоолоор хязгаарлалт тогтоосон

805 Ц. Цэлмэг "Криминологи" УБ хот, 2005 он,

төрийн албадлагын арга хэмжээ" гэзд ялын зорилго нь иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлхэд оршино.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3 дугаар хэсэг, 9 дүгээр бүлэгт Эрүүгийн хариуцлагын зорилго, төрлийн талаар авч үзжээ. 45 дугаар зүйлд эрүүгийн хариуцлагыг энэ хуулиар тогтоосон ял, бусад арга хэмжээгээр хүлээлгэнэ, эрүүгийн хариуцлагын зорилго нь "...иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлхэд оршино" гэжээ.

Зөрчилтэй байгаа асуудал нь гэмт хэрэг үйлдсэн сэтгэл мэдрэлийн архаг өвчтэй, оюун ухааны хомсдолтой этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх зорилго байж таарахгүй зөвхөн нийгмээс тусгаарлаж эмчлэх зорилго байж болно, энэ утгаараа эрүүгийн хариуцлагын зорилго бус ялын зорилго гэж өөрчлөх шаардлагатай нь харагдаж байна.

2. Ялын төрөл

Тайлбар:Монгол Улсын Эрүүгийн хуульд торгох, тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах, эд хөрөнгө хураах, албадан ажил хийлгэх, баривчлах, хорих, цаазаар авах гэсэн 7 төрлийн ялыг хуульчилж өгсөн.

Эдгээрээс торгох, албадан ажил хийлгэх, баривчлах, хорих, цаазаар авах гэсэн 5 ялыг үндсэн ялын чанартай, тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг үндсэн болон нэмэгдэл ялын чанартай, эд хөрөнгө хураах ялыг зөвхөн нэмэгдэл ялын чанартай хэрэглэхээр хуульчилсан.

Тэгвэл ОХУ-ын Эрүүгийн хуулийн 44 дүгээр зүйлд 12 төрлийн ялыг хуульчилжээ. Үүнд:

1.Торгох;

2.Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах;

3.Тусгай, цэргийн, эсхүл хүндэт цол, хэргэм болон төрийн шагналыг хасах;

4.Албадан ажил хийлгэх;

5.Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх;

6.Цэргийн албыг хязгаарлах;

7.Эрх чөлөөг хязгаарлах;

8.Баривчлах;

9.Сахилгажуулах цэргийн ангид байршуулах;

10.Тодорхой хугацаагаар хорих;

11.Насаар нь хорих ял;

12. Цаазаар авах.

Эд хөрөнгө хураах ялыг тусад нь хуульчилсан байна.

Тайлбар: ОХУ-д албадан ажил хийлгэх, хүмүүжлийн ажил хийлгэх, цэргийн албыг хязгаарлах, сахилгын цэргийн ангид байршуулах, тодорхой

хугацаагаар хорих, насаар нь хорих, цаазаар авах ялууд нь үндсэн төрөлд хамаарна.

Торгох, тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах, эрх чөлөөг нь хязгаарлах гэсэн 3 төрлийн ялыг үндсэн болон нэмэгдэл ялын аль алинаар нь хэрэглэж болно.

Тусгай, цэргийн, эсхүл хүндэт цол, хэргэм болон төрийн шагналыг хасах ял нь нэмэгдэл ялын төрөлд хамаардаг.

Эндээс дүгнэхэд хорихоос өөр төрлийн ял харьцангуй олон байгаа, торгох ялыг үндсэн болон нэмэгдэл ялын аль алинаар нь хэрэглэх боломжтой байхаар Монгол Улсын Эрүүгийн хуульд тусгах шаардлагатай.

Торгох ялын тухайд ОХУ-ын Эрүүгийн хуулийн 46 дугаар зүйлд "... торгох ялыг гэмт хэрэг үйлдсэн этгээдийн 2 долоо хоногоос 5 жил хүртэлх хугацааны цалингийн хэмжээ болон бусад орлогын хэмжээ, эсхүл 2500-1000,000 рубль хүртэлх хэмжээний мөнгөн дүнгээр тогтооно.

Таван зуун мянган рубль эсхүл гэмт хэрэг үйлдсэн этгээдийн 3 жилийн болон түүнээс дээш хугацааны цалин болон бусад орлогын хэмжээгээр торгох ялыг зөвхөн хүнд болон онц хүнд гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд оногдуулна.

Үйлдэгдсэн гэмт хэргийн хэр хэмжээ болон гэмт хэрэг үйлдсэн этгээдийн болон түүний гэр бүлийн эд хөрөнгийн нөхцөл байдал, түүнчлэн гэмт хэрэг үйлдсэн этгээдийн авах цалин болон бусад орлогын хэмжээг харгалзан шүүхээс торгох ялын хэмжээг тогтооно.Мөн дээрх нөхцөлүүдийг харгалзан шүүх торгох ялын төлөлтийг гурав хүртэлх жилийн хугацаагаар хэсэгчлэн тогтоож болно.

Нэмэгдэл ялын хувиар торгох ялыг зөвхөн тусгай ангид заасан тохиолдолд л оногдуулж болно. Үндсэн ялын хувиар оногдуулсан торгох ялаас ноцтойгоор зайлсхийвэл бусад төрлийн ялаар сольж болно.

Дээрх заалтуудыг Монгол Улсын Эрүүгийн хуульд авч хэрэглэх нь зүйтэй гэдэг үүднээс нэг бүрчлэн оруулж байгаа бөгөөд өнөөдрийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр торгох ялыг хэрэглэж байгаа нь буруу гэдгийг байнга өсөн нэмэгдэж байгаа байдал, Засгийн газраас өөрчлөн тогтоодог, шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулдаг зэргээр тайлбарлаж болно.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 48 дугаар зүйлд Тусгай, цэргийн, эсхүл хүндэт цол, хэргэм болон төрийн шагналыг хасах ялын талаар заахдаа "...хүнд болон онц хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хувийн байдлыг нь харгалзан шүүхээс тусгай, цэргийн, эсхүл хүндэт цол, хэргэм болон төрийн шагналыг нь хасах ял оногдуулж болно" гэжээ.

Албадан ажил хийлгэх ялын тухайд ОХУ-ын Эрүүгийн хуулийн 49 дүгээр зүйлд "...ялтны эрхэлсэн ажил, сурдаг сургуулийн цагаас бусад цагт үнэ төлбөргүй, нийгэмд ашигтай ажил хийлгэхийг ойлгох ба ажлын төрөл, ажиллах байрыг нутгийн өөрөө удирдах байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай тохиролцон шийдвэрлэнэ" гэжээ.

Хугацааны хувьд 60-200 хүртэл цагаар, өдөрт дөрвөөс дээшгүй цаг байна гэсэн бол Монголд 100-500 цаг, өдөрт 3 цагаас доошгүй байна гэзд

дэзд хязгаарыг нь зааж өгөөгүй нь 8-10 цаг ажиллуулж болох нөхцөл байдлыг бүрдүүлжээ.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 50 дугаар зүйлд "Хүмүүжлийн ажил хийлгэх" ялын агуулгыг заасан байна. Эрхэлсэн үндсэн ажилгүй ялтанд харъяаллын газарт нь нутгийн өөрөө удирдах байгууллага болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгуулагаас тогтоосон ажлыг хийлгэж авсан цалингаас нь 5-20 хувийг нь суутган авах агуулгатай ял бөгөөд хугацааны хувьд хоёр сараас 2 жил хүртэл байна.

Хүмүүжлийн ажил хийлгэх ялаас санаатайгаар зайлсхийвэл эдлээгүй үлдсэн хүмүүжлийн ажил хийлгэх 3 өдрийг нэг өдрийн хорих ялаар сольж эдлүүлнэ.

Тахир дутуугийн 1-р зэрэгтэй иргэн, жирэмсэн эмэгтэй, 3 хүртэлх насны хүүхэдтэй эх, цэргийн жинхэнэ хугацаат албан хаагч, гэрээт цэргийн албан хаагчид энэ ялыг оногдуулахгүй.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 51 дүгээр зүйлд "Цэргийн албыг хязгаарлах" гэмт хэргийг заасан ба агуулга нь "...гурван сараас 2 жилийн хугацаатайгаар цэргийн жинхэнэ алба хааж байгаа этгээд, мөн гэрээгээр цэргийн алба хааж буй этгээд энэ хуулийн тусгай ангид заасан зохих зүйл заалтын дагуу цэргийн албаны эсрэг гэмт хэрэг үйлдсэн бол хүмүүжлийн ажлын оронд цэргийн албыг хязгаарлах ял ононгдуулна.

Ялтны цэргийн албыг хязгаарласан үед авсан цалингаас шүүхийн тогтоолын дагуу хориос хэтрэхгүй хувиар суутган авч улсын орлого болгоно. Ялын хугацаанд яллагдагч албан тушаал, цэргийн цол ахихыг хориглох бөгөөд дараагийн цэргийн цол авах хугацааг тоолохгүй.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 52 дугаар зүйлд "Эрх чөлөөг хязгаарлах" ялыг заасан бөгөөд агуулга нь "...шүүхээс тогтоосны дагуу яллагдагчийн эрх чөлөөг дараах байдлаар хязгаарлана". Үүнд:

- Тодорхой цагуудад гэрээсээ гарч явж болохгүй;
- Тодорхой газруудад очихыг хориглох;
- Холбогдох нутаг дэвсгэрээс гарахгүй байх;
- Олон нийтийн төвлөрөл бүхий арга хэмжээнд оролцох;
- Оршин суух хаяг, ажил, сургуулиа ялыг гүйцэтгэж буй байгууллагын зөвшөөрөлгүйгээр өөрчлөхгүй байх зэрэг эрхийг хязгаарлана.

Яллагдагч тухайн ялыг гүйцэтгэж буй тусгай байгууллагад сард 1-4 удаа ирж бүртгүүлэх үүрэгтэй бөгөөд тусгайлсан байгууллагын зөвшөөрөлгүйгээр оршин суух хаягаа солих, байрших, тухайн нутаг дэвсгэрээс явах зэрэг эрх чөлөөг хязгаарлах нь заавал биелэгдэх шинжтэй байна.

Эрх чөлөөг хязгаарлах ялыг хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн үед үндсэн ялын чанартай 2 сараас 4 жилийн хугацаатай, нэмэгдэл ялын чанартай бол 6 сараас 2 жилийн хугацаатай оногдуулна.

Цэргийн албан хаагч, гадаадын иргэд, харьяалалгүй этгээд болон ОХУ-ын нутаг дэвсгэрт байнга оршин суух эрхгүй этгээдэд энэ ялыг оногдуулахгүй.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 55 дугаар зүйлд заасан "Сахилгажуулах цэргийн ангид байрлуулах" ялын агуулга нь "...цэргийн жинхэнэ албан хаагч

болон шүүхийн шийтгэх тогтоол гарах үед хуулиар заасан хугацаагаар цэргийн албаа бүрэн хаагаагүй байсан байлдагч болон түрүүч, гэрээт цэргийн албан хаагчдад хэрэглэнэ. Энэ ялыг 3 сараас 2 жилийн хугацаагаар энэ хуулийн тусгай ангид заасан цэргийн албаны эсрэг гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувьд хэрэглэх бөгөөд мөн үйлдсэн гэмт хэрэг, яллагдагчийн хувийн байдлаас хамаарч түүнд оногдуулсан хорих ялыг сахилгын цэргийн ангид байрлуулах ялаар солих боломжтой тохиолдолд хэрэглэнэ.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 56 дугаар зүйлд тодорхой хугацаагаар хорих ялыг 2 сараас 20 жилийн хугацаатай эдлүүлнэ. Нийлмэл гэмт хэрэгт ялыг нэгтгэх үед ялын хугацааг 25 жилээс хэтрэхгүйгээр, хэд хэдэн шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулсан ялыг нэгтгэх үед 30 жилээс хэтрэхгүй байна гэжээ.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 57 дугаар зүйлд "Насаар нь хорих ял"-ын агуулгыг заахдаа онц хүнд гэмт хэрэг үйлдэж хүний амь хохироосон, нийгмийн аюулгүй байдлын эсрэг онц хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хэрэглэнэ.

Эмэгтэйчүүд, гэмт хэрэг үйлдэх үедээ 18 насанд хүрээгүй этгээд, шүүхийн шийтгэх тогтоол гарах үед 65 нас хүрсэн эрэгтэйчүүдэд насаар нь хорих ялыг хэрэглэхгүй.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 59 дүгээр зүйлд "Хорих ял эдлүүлэх байгууллагыг сонгон оногдуулах" гэсэн заалт байгаа ба энэ нь хорих ялыг ямар дэглэмд эдлүүлэх талаар заасан Монгол Улсын Эрүүгийн хуулийн 52 дугаар зүйлтэй утга нэг байна. ОХУ-д хорих ялыг дараах байдлаар эдлүүлнэ:

а.Болгоомжгүй гэмт хэрэг үйлдсэн, эсхүл санаатайгаар анх удаа хөнгөн буюу хүндэвтэр гэмт хэрэг үйлдэж улмаар хорих ял оногдуулсан этгээдийн ялыг хорих ангид эдлүүлнэ. Гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал ба яллагдагчийн шинж чанарыг харгалзан үзэж шүүхээс тус этгээдийн ялыг жирийн дэглэмтэй засан хүмүүжлийн хорих ангид эдлүүлэхээр тогтоож, тогтоосон шалтгаанаа шийдвэртээ тусгана.

б.Хүнд гэмт хэрэг үйлдсэн өмнө нь хорих ял эдэлж байгаагүй эрэгтэй хүн, хүнд болон онц хүнд гэмт хэрэг үйлдсэн, гэмт хэрэг давтан үйлдсэн эмэгтэй хүнд оногдуулах хорих ялыг жирийн дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ.

в.Онц хүнд гэмт хэрэг үйлдсэн, өмнө нь хорих ял эдэлж байгаагүй этгээд, эсхүл өмнө хорих ял эдэлж байсан давтан, хүнд давтан гэмт хэрэгтэй этгээдийн ялыг чанга дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ.

г.Насаар нь хорих ял оногдуулсан эрэгтэй хүн, онц хүнд давтан гэмт хэрэгтэй этгээдийн ялыг онцгой дэглэмтэй хорих ангид эдлүүлнэ.

2. Онц хүнд гэмт хэрэг үйлдэж хорих ял таваас дээш жилийн хугацаагаар оногдуулсан эрэгтэй хүн, мөн онц хүнд давтан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болох хүртэлх цагдан хоригдсон хоногийг шүүхийн шийдвэрээр хорих ял эдэлсэн хоног болгон тооцно.

3.Шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болох үед арван найман нас хүрээгүй этгээдийг хүмүүжлийн хорих ангид ялыг эдлүүлнэ.

4. Засан хүмүүжүүлэх байгууллагыг өөрчлөх тухай шийдвэрийг ОХУ-ын эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн дагуу шүүх шийдвэрлэнэ.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 59 дүгээр зүйлд "Цаазаар авах" ялын төрлийг заасан бөгөөд гүйцэтгэх аргыг хуульдаа шууд заагаагүй бол Монгол Улсын Эрүүгийн хуулийн 53.2-д "...цаазаар авах ялыг буудаж гүйцэтгэнэ" гэсэн байдаг. Эмэгтэйчүүд, гэмт хэрэг үйлдэх үедээ 18 насанд хүрээгүй этгээд, шүүхийн шийтгэх тогтоол гарах үед 65 нас хүрсэн эрэгтэйчүүдэд цаазаар авах ял оногдуулахгүй.

ОХУ-ын байгуулсан олон улсын гэрээ, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээний дагуу эрүүгийн мөрдлөг явуулахаар ОХУ-д хүлээлгэн өгсөн гадаадын иргэнийг, тус иргэний улсын хууль тогтоомжийн дагуу цаазаар авах ял тус төрлийн гэмт хэрэгт оногдуулдаггүй, эсхүл цаазаар авах ял хэрэглэхгүй байх нөхцөлтэйгээр хүлээлгэн өгсөн, эсхүл бусад шалтгаанаар түүнд цаазаар авах ял оногдуулж болохгүй тохиолдолд цаазаар авах ял оногдуулахгүй болно.

4. Ял хөнгөрүүлэх нөхцөл байдал

ОХУ-ын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 61 дүгээр зүйлд шүүх ял оногдуулахдаа харгалзан үзэх хөнгөрүүлэх нөхцөлийн талаар тусгажээ. Тус зүйлийн дагуу ОХУ-ын Эрүүгийн хуулиар нийт 10 нөхцөл байдлыг тусгасан бөгөөд тус зүйлийн 2-т: "*...Ял оногдуулахдаа энэ зүйлийн нэгдүгээр хэсэгт тусгагдаагүй хөнгөрүүлэх нөхцөл байдал харгалзан үзэж болно*" хэмээн заасан байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 55 дугаар зүйлд заасан ял хөнгөрүүлэх нөхцөл байдлын хувьд авч үзвэл мөн 10 нөхцөл байдлыг тусгасан бөгөөд 55.2-т тус нөхцөл нь энэ хуулийн тусгай ангийн тодорхой зүйлд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж болж байгаа бол түүнийг ял оногдуулахдаа харгалзаж үзэхгүй талаар тусгажээ.

Дээр хэлсэн нөхцөлүүдийг харьцуулан авч үзвэл, ижил төстэй зохицуулалтууд олон байна. Тухайлбал, ижил төстэй заалтуудын авч үзвэл,

- тохиолдлын шинжтэй нөхцөл байдлын улмаас анх удаа хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн;
- насанд хүрээгүй этгээд, жирэмсэн эх гэмт хэрэг үйлдсэн,
- хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэхэд автсан, эсхүл эд хөрөнгө, албан тушаалын болон өөр байдлаар эрхшээлд нь орсноос гэмт хэрэг үйлдсэн,
- хохирогчийн хууль бус үйлдлээс болж санаа сэтгэл нь хүчтэй цочрон давчидсаны улмаас болон хохирогчийн хэт хайхрамжгүйгээс гэмт хэрэг үйлдсэн,
- өөрт нь болон гэр бүлийн гишүүнд нь, түүнчлэн бусад хүмүүст тохиолдсон хүнд нөхцөл байдлын улмаас гэмт хэрэг үйлдсэн,
- үйлдсэн гэмт хэрэгтээ чин санаанаас гэмшсэн буюу гэмт хэргээ сайн дураар илчилж ирсэн, түүнчлэн гэмт хэрэг болон гэмт хэрэг үйлдсэн этгээд, гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйлийг илрүүлэхэд идэвхтэй дэмжлэг үзүүлсэн,

• бусдын амь нас, эрүүл мэндэд гэм хор учруулсан гэмт хэрэг үйлдсэн даруйдаа хохирогчид эмнэлгийн болон бусад тусламж үзүүлсэн зэрэг зохицуулалтууд ижил төстэй байна.

Монгол Улсын хуульд бага насны хүүхэдтэй эмэгтэй хэмээн заасан бол ОХУ-ын хуулинд гэм буруутай этгээд хэмээн тусгасан нь эрэгтэй, эмэгтэйгээс үл хамааран гэмт хэрэг үйлдсэн этгээд нь бага насны хүүхэдтэй бол энэ нь ял хөнгөрүүлэх нөхцөл болно. Мөн ОХУ-ын Эрүүгийн хуулийн 61.1.ж-д: "Аргагүй хамгаалалт, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг баривчлах, саатуулах, гарцаагүй байдал, үндэслэл бүхий эрсдэл, тушаал захирамж биелүүлэх зэрэг нөхцөлд гэмт хэрэг үйлдвэл" ял хөнгөрүүлэх нөхцөл байдлаар тооцно хэмээн тусгасан байна.

4.Ял хөнгөрүүлэх нөхцөл байдалтайгаар ял оногдуулах зохицуулалт

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 62 дугаар зүйлд ял хөнгөрүүлэх нөхцөл байдалтай ял оногдуулах талаар тусгаж, гэмт хэрэгтэй гэмшсэн, гэмт хэргээ сайн дураар илчилж ирсэн, түүнчлэн гэмт хэрэг болон гэмт хэрэг үйлдсэн этгээд, гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйлийг илрүүлэхэд идэвхтэй дэмжлэг үзүүлсэн, бусдын амь нас, эрүүл мэндэд гэм хор учруулсан гэмт хэрэг үйлдсэн даруйдаа хохирогчид эмнэлгийн болон бусад тусламж үзүүлсэн зэрэг хөнгөрүүлэх нөхцөлд оногдуулах ялын дээд хэмжээг зааж өгсөн байна.

Тус зүйл нь тодорхой хөнгөрүүлэх нөхцөл байдалтай үед оногдуулах ялын дээд хэмжээг зааж өгсөн байна. Мөн тус зүйлд харилцан ажиллах тухай шүүхийн өмнөх тохиролцоо байгуулах талаар дурджээ. Харилцан ажиллах талаарх шүүхийн өмнөх тохиролцоо байгуулсан тохиолдолд шүүхийн шийдвэр гаргах болон түүнийг хэрэглэх журам нь ОХУ-ын хуульд шинэлэг зохицуулалт юм. 2009.06.29-ний өдрийн "ОХУ-ын Эрүүгийн хууль болон Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Холбооны хуулийн дагуу ОХУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд энэхүү зохицуулалтыг бие даасан бүлэг болгон оруулжээ[806]. Энэ зохицуулалтын товч агуулгыг авч үзвэл, яллагдагч эсхүл сэжигтэн нь прокурорт шүүхийн өмнөх тохиролцоонд хүрэх сонирхолтой байгаа талаар өргөдөл гаргаж, тус өргөдөлдөө гэмт хэрэг илрүүлэхэд болон мөрдөн шалгахад өөрийн зүгээс хамтран ажиллах, туслалцаа үзүүлэх талаар тусгадаг байна. Ийнхүү өргөдлийг прокурор хүлээн авах эсэх талаар шийдвэрээ гаргаж, хүлээн авч өргөдлийн дагуу сэжигтэн, яллагдагч үүрэг биелүүлсэн тохиолдолд прокурор шүүх ажиллагаанд тус этгээд шүүхийн өмнөх тохиролцоогоо хэрхэн биелүүлсэн талаар санал гаргадгаараа онцлог байна.

Мөн ОХУ-ын Эрүүгийн хуулийн 64 дүгээр зүйлд харилцан ажиллах талаархи шүүхийн өмнөх тохиролцоог зөрчихөд ял оногдуулах талаар тусгасан байна.

[806] Рыжаков А.П."Досудебное соглашение о сотрудничестве: постатейный комментарий к новой главе УПК РФ", Москва, 2010 г.

5. Ял хүндрүүлэх нөхцөл байдал

ОХУ-ын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 63 дугаар зүйлд ял хүндрүүлэх нөхцөлийн талаар тусгасан байна. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 56 дугаар зүйлийн дагуу мөн тус нөхцөлүүдийг зохицуулсан байдаг. Энэхүү хоёр зохицуулалтыг харьцуулан авч үзэхэд нилээд олон ялгаатай зүйлс ажиглагдаж байна. Тухайлбал, Монгол Улсын Эрүүгийн хуульд гэмт хэрэгт татан оролцуулах субьектын хувьд "...эрүүгийн хариуцлага хүлээх насанд хүрээгүй этгээдийг гэмт хэрэгт татан оруулсан, эрүүгийн хариуцлага хүлээх насанд хүрээгүй, хэрэг хариуцах чадваргүй хүнээр гэмт хэрэг үйлдүүлсэн..." хэмээн тусгасан бол ОХУ-ын хуульд насанд хүрээгүй этгэдээс гадна, сэтгэл мэдрэлийн хүнд өвчтэй этгэд, мансуурал, согтуурлын байдалтай этгэдийг гэмт хэрэгт татан оруулах гэсэн заалтыг зохицуулжээ.

ОХУ-ын хуулиар аливаа нийгмийн бүлгийн улс төр, үзэл баримтлал, арьсны өнгө, үндэс угсаа, шашин шүтлэгийн үзлээс хамаарч үзэн ядах, дайсагнан хандаж гэмт хэрэг үйлдэх нь ял хүндрүүлэх нөхцөлд орно. Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд: "хүнийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно" хэмээн хүний үндсэн эрх, эрх чөлөөг тусгасан байдаг. Тэгвэл дагуу дээрхи ОХУ-ын дээрх зохицуулалтыг Монгол Улсын Эрүүгийн хуульд хүндрүүлэх нөхцөл байдлыг хувиар оруулж өгөх хэрэгтэй.

Мөн жирэмсэн болон бага насны хүүхэдтэй эхийн эсрэг гэмт хэрэг үйлдэх гэсэн Монгол Улсын эрүүгийн хуулийн зохицуулалтыг ОХУ-ын хуулинд "*энэ талаар мэдэж байсан жирэмсэн эхийн хувьд....*" хэмээн тусгажээ.

Нэгэн онцлог бол 63.1-ийн "н" буюу "о" дэд хэсгүүд. Энэ нь,

"1.Шүүх ял оногдуулахдаа дор дурдсан хүндрүүлэх нөхцөл байдлыг харгалзан үзнэ:

н.Төрийн эрх мэдлийн төлөөлөл бүхий дүрэмт хувцас, үнэмлэх ашиглан гэмт хэрэг үйлдэх;

о.Дотоод яаралтын төрийн байгууллагын ажилтан санаатайгаар гэмт хэрэг үйлдэх"

Манай улсын хувьд цагдаагийн дүрэмт хувцас, эмчийн хувцас ашиглан гэмт хэрэг үйлдэх тохиолдолууд гарч байсан бөгөөд энэ тохиолдолд дээрх зохицуулалтыг тусгаснаар ял хүндрүүлэх нөхцөл байдлын хувиар авч үзэх боломжтой юм.

6.ОХУ-ын Эрүүгийн хуулийн Ерөнхий ангид буй ял оногдуулах зарим онцлог

ОХУ-ын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 10 дугаар бүлэгт эрүүгийн ял оногдуулах талаархи зохицуулалтыг агуулсан. Энэ нь Монгол Улсын эрүүгийн хуулиар ял оногдуулах мөн 10 дугаар бүлэгтэй ижил зохицуулалтыг цөөнгүй агуулсан хэдий ч зөвхөн дээрхи хуулинд агуулагдах онцлогууд мөн байна. Тухайлбал энэ нь тус хуулийн 63.1 буюу 64, 65 дугаар зүйлүүд юм.

63.1-д хамтран ажиллах тухай шүүхийн өмнөх тохиролцоог зөрчсөн тохиолдолд ял оногдуулах талаар зохицуулжээ. Энэхүү ажлынхаа 2 дугаар хэсэгт "харилцан ажиллах тухай шүүхийн өмнөх тохиролцоо"-ны талаар

бичсэн байгаа. Энэхүү тохиролцоо нь ял оногдуулах хөнгөрүүлэх нөхцөл байдалд ордог бол энэхүү байгуулсан тус тохиролцоогоо зөрчиж, "... мөрдөн байцаагч, прокуороос гэмт хэрэг үйлдэгдэх чухал мэдээлэл нуун дарагдуулсан, хуурамч мэдээлэл өгсөн бол..." шүүх хөнгөрүүлсэн нөхцөл байдалтай ял оногдуулахгүй энгийн.журмаар ял оногдуулах болно. Өөрөөр хэлбэл тус яллагдагч хөнгөрүүлсэн нөхцөл байдалтай ялаа оногдуулах эрхээ алдах болно гэсэн үг.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 64 дүгээр зүйл мөн онцлогтой. Монгол Улсын Эрүүгийн хуулинд ял хөнгөрүүлэх нөхцөлийг тусган зааж өгсөн байдаг бол ОХУ-ын хуулийн хувьд хөнгөрүүлсэн нөхцөлийг зааж өгөхөөс гадна, тус нөхцөлтэйгээр ял оногдуулах журам, мөн оногдуулах ёстой ялаас доогуур ял оногдуулах зарим тохиолдлын талаар тусгажээ. Жишээ нь, ОХУ-ын 64 дүгээр зүйл:

"1.Гэмт хэргийн зорилго, шалтгаанаас хамаарч, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн үүрэг, оролцоо, үйлдэх үед болон дараа нь гаргасан зан авир зэрэг гэмт хэргийн нийгмийн аюулыг багасгах нөхцөлд, мөн бүлэглэн үйлдсэн гэмт хэргийн үед хамтрагч нь гэмт хэрэг илрүүлэхэд идэвхтэй оролцох зэрэг зарим нөхцөлд энэ хуулийн тусгай ангиар зохицуулсан ялыг багасгаж оногдуулах, эсхүл шүүх энэ зүйлд зааснаар илүү хөнгөн ял оногдуулах, эсхүл зайлшгүй хэрэглэх ёстой нэмэлт ялыг хэрэглэх гүйбайх боломжийг үүсгэнэ."

65 дугаар зүйл буюу "тангаргатны шүүхийн хүлцэнгүй хандах тухай шийдвэрээр ял оногдуулах" талаарх зохицуулалт нь мөн манай улсын зохицуулалтанд агуулагдаагүй онцлог зохицуулалт юм. Тангаргатны шүүхийн талаар товчхон дурдахад, ОХУ-ын 1993 оны Эрүүгийн хуулийн 10 дугаар бүлэгт "Тангаргатны шүүхээр хэрэг хэлэлцэх" талаарх зохицуулалтыг хуульчилжээ. Ингэснээр Москва, Ивановск, Саратовск зэрэг хэд хэдэн газруудад тангаргатны шүүх байгуулагджээ. 1993 оны 12 дугаар сарын 12-ний өдөр батлагдсан ОХУ-ын шинэ Үндсэн хуулиар тангаргатны шүүхийн шийдвэрийг хуулийн дээд хүчинтэй болгосон байна. Тус шүүхээр хэргээ шийдвэрлүүлэх нь яллагдагчийн өөрийн эрх бөгөөд яллагдагч энэ тухай өргөдөл гаргасны үндсэн дээр 12 тангаргатны оролцоотойгоор шүүх хуралдаан явагддаг байна. Тангаргатны шүүхээр бүх хэргүүдийг хэлэлцдэггүй бөгөөд тус шүүхээр хэлэлцэх хэргүүдийг /хүн алах, хүчиндэх, танхай г.м./ хуулиар тодорхойлжээ. Харин ОХУ-ын Эрүүгийн хуулийн 65 дугаар зүйлийн хувьд гэвэл тус зүйлээр тангаргатны шүүхийн хүлцэнгүй хандах тухай шийдвэрийн дагуу ял оногдуулахад тус ялын дээд хэмжээг зааж өгснөөр гадна тус шийдвэрийн дагуу гэмт хэрэгтэн буруутай боловч хүлцэнгүй хандах боломжтой хэмээн тооцогдсон бол энэ тохиолдолд хүндрүүлэх нөхцөл байдлыг тооцохгүй хэмээн хуульчилжээ.

7. Хамтран оролцсон гэмт хэрэгт ял оногдуулах

Монгол Улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангид гэмт хэрэгт хамтран буюу бүлэглэн оролцох нь ял оногдуулах хүндрүүлэх нөхцөлд тооцогдоно. ОХУ-ын Эрүүгийн хуулийн хувьд хамтран оролцсон гэмт хэрэгт ял оногдуулах талаар 67 дугаар зүйлээр зохицуулжээ. Гэмт хэрэгт хамтран оролцогчид ял

оногдуулахдаа уг этгээдийн тухайн гэмт хэрэгт оролцсон хэмжээ, гэмт хэрэг зорилгодоо хүрэхэд гүйцэтгэсэн үүрэг, учирсан гэм хорын шинж байдал болон хэмжээнд нөлөөлсөн эсэх үзүүлэлтүүдийг харж ял оногдуулдаг.

8. Давтан гэмт хэрэгт ял оногдуулах онцлог

Монгол Улсын эрүүгийн хуулийн дагуу гэмт хэрэг давтан үйлдэх нь ял оногдуулах хүндрүүлэх нөхцөлд тооцно. ОХУ-ын хувьд гэмт хэрэгт давтан үйлдсэн тохиолдолд ял оногдуулах талаархи зохицуулалтыг эрүүгийн хуулийн 68 дугаар зүйлд агуулагджээ. Дашрамд сонирхуулахад, "гэмт хэрэг давтсан үйлдсэн этгээд" хэмээн тодорхойлохгүй "давтан үйлдсэн гэмт хэрэг" гэсэн нэр томьёогоор тодорхойлжээ. Өөрөөр хэлбэл, этгээдийн бус тус гэмт хэргийг "давтан" хэмээн томьёолсон байна. Тус хуулиар давтан, хүнд давтан, онц хүнд давтан гэмт хэргийн ялыг оногдуулахдаа тухайн гэмт хэргийн нийгэмд учруулсан аюул, хор уршгийн хэр хэмжээ, мөн өмнө нь үйлдсэн гэмт хэргийн ялыг оновчтой оноогүйгээс давтан үйлдсэн байх нөхцөлийг харгалзан үздэг байна. ОХУ-ын эрүүгийн хуулийн хувьд аливаа гэмт хэрэгт ял оногдуулахдаа оногдуулах ялын дээд буюу доод хязгаарыг ерөнхий ангиараа тусгаж өгдөгөөрөө онцлог. Тухайлбал,

"68.2.Давтан хэлбэрээр үйлдэгдсэн тохиолдолд түүнд оногдуулах ял нь энэ хуулийн тусгай ангиар зохицуулсан ялын хэмжээний хүрээнд энэхүү гэмт хэрэгт оногдуулах ялын гураевны нэгээс багагүй байж болохгүй."

Мөн Монгол Улсын хуулинд давтан нь хүндрүүлэх нөхцөлд ордог бол ОХУ-ын хуулийн хувьд энэхүү нөхцөлийг хөнгөрүүлэх, хүндрүүлэх ял ч хэсэгт оруулалгүйгээр зохицуулж, харин давтангийн үед хөнгөрүүлэх нөхцөл илэрвэл үүнийг тооцож ял оногдуулна хэмээн зохицуулжээ.

9. Хэд хэдэн шийтгэх ялаар ял оногдуулах

70 дугаар зүйл. Хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял оногдуулах

1.Шүүхийн шийтгэх тогтоол гарсны дараа буюу оногдуулсан ялыг бүрэн эдэлж дуусахын өмнө гэмт хэрэг шинээр үйлдэж шийтгүүлж байгаа бол шүүхийн сүүлчийн шийтгэх тогтоолоор оногдуулсан ял дээр өмнөх шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулснаас эдлээгүй үлдсэн ялыг нэмж нэгтгэн уг этгээдийн биечлэн эдлэх ялыг тогтооно.

2.Хэд хэдэн шийтгэх тогтоолоор нэгтгэсэн ял нь хорих ялаас илүү зөөлөн байвал энэ гэмт хэрэгт энэ хуулийн тусгай оногдуулдаг ялын дээд хугацаа болон хэмжээнээс хэтэрч болохгүй.

3.Хэд хэдэн шийтгэх тогтоолоор нэгтгэж буй хорих ялын хугацаа нь гучин жилээс хэтрэхгүй.

4.Хэд хэдэн шийтгэх тогтоолоор нэгтгэн оногдуулж буй ял нь шинээр үйлдсэн гэмт хэрэгт оногдуулж буй ял болон өмнөх шүүхийн тогтоолоор эдлүүлж байсан ялаас их байна.

5.Хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял оногдуулж, нэмэлт ял оногдуулахдаа энэ хуулийн 69 дүгээр зүйлийн 4 дэхь хэсэгт заасан дүрмийг баримтлана.

Тайлбар: Хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял оногдуулах талаархи зохицуулалтын хувьд тус зүйлийн нэгдүгээр зүйлд буй ял оногдуулах журмын

хувьд хоёр орны хуулийн хувьд ижил төстэй байна. Тухайлбал, шүүхийн сүүлчийн шийтгэх тогтоолоор оногдуулснаас эдлээгүй үлдсэн ялыг бүгдийг нь нэмж нэгтгэн тооцох талаар зохицуулалт юм.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 58.5-д заасан баривчлах, хорих ялыг хооронд нь нэмж нэгтгэхдээ баривчлах ялын нэг хоногийг хорих ялын нэг хоногтой тэнцүүлж тооцно хэмээн заасан бол ОХУ-ын Эрүүгийн хуулиар тус зүйл энэ тухай тусгаагүй хэдий ч энэ хуулийн 71 дүгээр зүйлээр тусгайлан зохицуулсан байна. Энэхүү зохицуулалт дэлгэрэнгүй зохицуулалт болж чадсан төдийгүй зөвхөн баривчлах, хорих ял төдийгүй эрх чөлөө хязгаарлах, хүмүүжлийн ажил хийлгэх, цэргийн албыг хязгаарлах зэрэг эрүүгийн ялын төрлийг хорих ялын хоногтой дүйцүүлэн бодох талаар тусгажээ. Тухайлбал:

71 дүгээр зүйл. Хэд хэдэн ял нэмэж тооцоход хугацаа тооцох журам

1.Хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн ба хэд хэдэн шийтгэх тогтоолоор бүрэн буюу хэсэгчлэн ял оногдуулахад хорих ялын нэг хоногийг дараах ялын төрлийн нэг хоногтой тэнцүүлж тооцно:

а.Баривчлах, сахилгын цэргийн ангид байршуулах ялын нэг хоног;

б.Эрх чөлөө хязгаарлах ялын хоёр хоног;

в.Хүмүүжлийн ажил хийлгэх эсхүл цэргийн албыг хязгаарлах ялын гурван хоног;

г.Албадан ажил хийлгэх ялын найман цагтай тус тус тэнцүүлж болно.

2.Эрх чөлөө хязгаарлах, баривчлах, сахилгын цэргийн ангид байршуулах, хорих ялтай нэгтгэн оногдуулж буй торгууль, тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах, тусгай, цэргийн болон хүндэт цол, хэргэм болон төрийн шагналыг хасах ялыг дангаар нь эдлүүлнэ.

10. Тэнсэх

73 дугаар зүйл. Тэнсэх

1. Шүүх хүмүүжлийн ажил хийлгэх, цэргийн албыг хязгаарлах, сахилгын цэргийн ангид байршуулах, найм хүртэлх жилийн хугацаагаар хорих ял оногдуулахдаа түүнд оногдуулсан ялыг биечлэн эдлүүлэх шаардлаггүй гэж шүүх үзвэл уг ялыг тэнсэж болно.

2.Тэнсэнг үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөл байдлыг харгалзан оногдуулна.

3.Шүүх хянан харгалзах хугацаа тогтоож, энэ хугацаанд тэнсэн суллагдсан этгээдэд засарч хүмүүжсэнээ батлах ёстой. Нэг жил хүртэлх хугацаагаар хорих ял эсхүл илүү хөнгөн ял оногдуулсан тохиолдолд хянан харгалзах хугацааг зургаан сараас доошгүй гурван жилээс дээшгүй хугацаагаар, нэг жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулсан тохиолдолд хянан харгалзах хугацааг зургаан сараас доошгүй таван жилээс дээшгүй хугацаагаар тогтооно.

4.Тэнсэн суллагдсан этгээдэд нэмэгдэл ял оногдуулж болно.

5.Шүүх яллагдагч этгээдийг тэнсэнгээр суллахдаа тус этгээдийн нас, хөдөлмөрийн чадамж, эрүүл мэндийн байдлаас хамаарч дараах үүрэг оногдуулна: тэнсэнгээр суллагдсан этгээдийн хянан харгалзах ажиллагаа явуулж буй тусгайлсан байгууллагын зөвшөөрөлгүйгээр байнгын оршин суух хаяг, эрхэлдэг ажил, сурдаг сургуулиа өөрчлөхгүй байх, архины, мансууруулах бодисны, токсины эсрэг эмчилгээнд хамрагдах, бэлгийн замын халдварт өвчин эмчлүүлэх, олон нийтийн байгууллагад хөдөлмөрлөх /ажилд орох/ зэрэг. Шүүх тэнсэнгээр суллагдсан этгээдэд засан хүмүүжүүлэх үүднээс өөр төрлийн үүрэг ногдуулж болно.

6.Тэнсэн суллагдсан этгээдийн хянан харгалзах ажиллагааг тусгайлсан байгууллага, цэргийн албан хаагчдийн хувьд цэргийн ангийн захиргаанаас хэрэгжүүлнэ.

7.Хянан харгалзах нийт хугацаанд тус ажиллагааг хэрэгжүүлж буй байгууллагын саналаар шүүх тус этгээдэд өмнө нь оногдуулсан үүргийг бүрэн буюу хэсэгчлэн өөрчилж, нэмж болно.

74 дүгээр зүйл. Тэнсэнг болиулах эсхүл хянан харгалзах хугацааг сунгах

1.Хянан харгалзах хугацаа дуусахаас өмнө тэнсэн суллагдсан этгээд өөрийн зан байдлаараа засан хүмүүжсэн гэдгээ баталсан бол тус ажиллагааг хэрэгжүүлж буй тусгайлсан байгууллагын саналаар шүүх тэнсэн суллахыг болиулж, яллагдагчийг тэнсэнгээс суллана. Энэ тохиолдолд хянан харгалзах хугацааны доод тал нь хагасаас доошгүй хугацаа өнгөрсөн байх зайлшгүй шаардлагатай.

2.Тэнсэн суллагдсан этгээд түүнд шүүхээр оногдуулсан үүргээ биелүүлэхээс санаатайгаар зайлхийсэн, захиргааны шийтгэл оногдуулах нийтийн хэв журмыг зөрчсөн бол энэ зүйлийн 1 дүгээр хэсэгт заасан байгууллагын саналаар шүүх хянан харгалзах хугацааг нэг жилээс хэтрэхгүй хугацаагаар сунгаж болно.

3.Тэнсэн суллагдсан этгээд хянан харгалзах хугацаанд удаа дараа нийгмийн хэв журам зөрчиж, захиргааны шийтгэл хүлээсэн, эсхүл шүүхээс оногдуулсан үүргээс санаатайгаар зайлхийсэн, хяналтаас зугтсан бол хянан харгалзах ажиллагаг хэрэгжүүлж буй байгууллагын саналаар шүүх тус этгээдийн тэнсэнг зогсоож, шүүхийн шийтгэх тогтоолыг биечлэн эдлүүлнэ.

4.Тэнсэн суллагдсан этгээд хянан харгалзах хугацаанд санамсаргүй гэмт хэрэг эсхүл санаатай хөнгөн гэмт хэрэг үйлдсэн бол түүний тэнсэнг өөрчлөх эсхүл үлдээх асуудлыг шүүх шийдвэрлэнэ.

5.Тэнсэн суллагдсан этгээд хянан харгалзах хугацаанд хүндэвтэр гэмт хэрэг санаатай үйлдсэн, хүнд болон онц хүнд гэмт хэрэг санаатай үйлдсэн бол шүүх тэнсэнг зогсоож энэ хуулийн 70 дугаар зүйлд заасан журмын дагуу ял оногдуулна. Мөн энэ журмын дагуу энэ зүйлийн 4 дүгээр хэсэгт заасан ялыг тогтооно.

6. Энэ зүйлийн 4 ба 5 дугаар хэсэгт заасан журмыг тэнсэн суллагдах тухай шүүхийн шийтгэл тогтоол хүчин төгөлдөр болохоос өмнө тэнсэн

суллагдсан тохиолдолд мөн хэрэглэнэ. Энэ тохиолдолд тэнсэн суллагдах тухай шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсоны дараа шинэ гэмт хэргийн шүүх ажиллагаа явагдана.

Тайлбар: Ялыг тэнсэх тухай асуудал 2 улсын хуульд зарчмын өөр байдлаар тусгагджээ. Монгол Улсын Эрүүгийн хуулиар зөвхөн хорих ялыг тэнсэх тухай заасан бол ОХУ-ын Эрүүгийн хуульд хүмүүжлийн ажил хийлгэх, цэргийн албыг хязгаарлах, сахилгын цэргийн ангид байршуулах, найм хүртэлх жилийн хугацаагаар хорих ял оногдуулах гэсэн 4 төрлийн ялыг тэнсэхээр заасан байна.

Монгол Улсын Эрүүгийн хуульд тэнсэнгийн хүрээг ихээр хумьж зөвхөн хүндэвтэр гэмт хэрэг анх удаа үйлдсэн, хохирлоо бүрэн нөхөн төлсөн тохиолдолд хорих ялыг тэнсэж байгаа бол ОХУ-д хохирол төлсөн байхыг шаардахгүйн дээр 8 хүртэл жилийг тэнсэж болохоор, өөр төрлийн ял дээр ч тэнсэн байхаар заажээ.

Мөн ОХУ-ын хуулийн хувьд Тэнсэнг болиулах эсхүл хянан харгалзах хугацааг сунгах талаар 74 дүгээр зүйлээр тусгайлан зохицуулсан бөгөөд энэ нь тэнсэнгээр суллагдсан этгээдийн хувьд тэнсэнтэй хугацаандаа шүүхээр оногдуулсан үүргээ биелүүлэхгүй тохиолдолд шүүхээс ялыг "сэргээж" болох эрхийг олгосон болно.

ДӨРӨВ. ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА БОЛОН ЯЛААС ЧӨЛӨӨЛӨХ

1. Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх

75 дугаар зүйл. Үйлдсэн гэмт хэргээ илчилж ирсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх

1. Хөнгөн буюу хүндэвтэр гэмт хэрэг анх удаа үйлдэж, сайн дурааараа хэргээ илчилж ирсэн, гэмт хэргийн мөрдөх болон илрүүлэхэд туслалцаа үзүүлсэн этгээд учруулсан хохирлоо бүрэн төлсөн, гэм хорыг арилгаж улмаар тус үйлдэл нь нийгмийн аюултай шинжээ алдсан бол түүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно.

2. Өөр ангилалын гэмт хэрэг үйлдсэн этгээдийг энэ хуулийн тусгай ангид заасан зарим тохиолдолд эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно.

76 дугаар зүйл. Хохирогчтой эвлэрсэн үндэслэлээр эрүүгийн хариуцлага чөлөөлөх

Хөнгөн буюу хүндэвтэр гэмт хэрэг анх удаа үйлдсэн гэм буруутай этгээд хохирогчтой сайн дурааараа эвлэрсэн бөгөөд учруулсан хохирлоо бүрэн төлсөн, гэм хорыг арилгасан бол түүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно.

Тайлбар: Дээрх 2 тохиолдол Монгол Улсын Эрүүгийн хуулийн 70, 71 дүгээр зүйлд тусгагдсан боловч зөвхөн хөнгөн гэмт дээрх журмыг хэрэглэхээр заасан байдаг бол ОХУ-ын Эрүүгийн хуульд хүндэвтэр гэмт хэргийг хамааруулж байгаагаараа онцлогтой.

78 дугаар зүйл. Эрүүгийн хариуцлагад татах хугацаа өнгөрсөн тохиолдолд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх

1. Гэмт хэрэг үйлдсэнээс хойш дор дурдсан хугацаа өнгөрвөл гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагад татаж болохгүй:

а. хөнгөн гэмт хэрэг үйлдсэнээс хойш хоёр жил өнгөрсөн;

б. хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэнээс хойш зургаан жил өнгөрсөн;

в. хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван жил өнгөрсөн;

г. онц хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван таван жил өнгөрсөн.

2. Хөвөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон өдөр хүртэл тооцно. Тус этгээд энэ хугацаанд шинэ гэмт хэрэг үйлдсэн бол хөвөн хэлэлцэх хугацааг үйлдсэн гэмт хэрэг тус бүрээр нь тооцно.

3.Гэмт хэрэг үйлдсэн этгээд мөрдөн байцаах ажиллагаа болон шүүхээс зайлсхийвэл хөвөн хэлэлцэх хугацаа тасрах болно. Энэ тохиолдолд тус этгээдийг баривчилсан өдрөөс эхлэн хөвөн хэлэлцэх хугацааг сэргээн тоолно.

4.Цаазаар авах ял, насан туршид нь хорих ял шийтгүүлж болох гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хөвөн хэлэлцэх хугацаа хэрэглэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ. Хэрэв шүүх тухайн этгээдэд хөвөн хэлэлцэх хугацаа хэрэглэх боломжгүй гэсэн дүгнэлтэд хүрвэл цаазаар авах болон насан туршид нь хорих ял оногдуулж болохгүй.

Тайлбар: Монгол Улсын Эрүүгийн хуульд дээрх хугацааг мөн заасан бөгөөд хөнгөн гэмт хэрэгт 6 сар, хүндэвтэр гэмт хэрэгт 5 жил, хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш 15 жил, онц хүнд гэмт хэрэгт 25 жилийн хөвөн хэлэлцэх хугацаа тавьсан нь харьцангуй болжээ.

Өөрөөр хэлбэл хөнгөн гэмт хэрэгт дөнгөж 6 сар, хүндэвтэр хэрэгт 5 жил, хүнд хэрэгт 15 жилийн хугацаа тавьсан бол ОХУ-д хөнгөн хэрэгт 2 жилийн хугацаа тавьж байгаа. Хөнгөн гэмт хэрэг үйлдсэнээс хойш 6 сар өнгөрвөл хариуцлагад татахгүй гэдэг нь хэтэрхий богино бөгөөд дөнгөж илрүүлж хэрэг бүртгэлт явагдаад шүүхээр хянан шийдвэрлэж амжих үгүйтэй л байдаг. Зарим этгээд зориуд сунжруулж байгаа хугацааг дуусгадаг тохиолдол цөөнгүй байна.

2. Ялаас чөлөөлөх

80 дугаар зүйл. Эдлээгүй ялыг илүү хөнгөн ялаар солих

1. Шүүх хорих ял эдэлж байгаа, сахилгын цэргийн ангид хоригдож буй этгээдэд түүний зан байдлыг харгалзан ялын үлдсэн хэсэгт илүү хөнгөн ял оногдуулж болно. Энэ тохиолдолд тус этгээд нэмэлт ялаас хэсэгчилэн буюу бүрэн чөлөөлөгдөж болно.

2. Ялтан оногдсон ялынхаа дор дурдсан хувийг эдэлсэн тохиолдолд илүү хөнгөн ял оногдуулж болно:

- хөнгөн буюу хүндэвтэр гэмт хэрэгт оногдуулсан хорих ялын гуравны нэгээс доошгүй хувийг;

- хүнд гэмт хэрэгт оногдуулсан хорих ялын талаас доошгүй хувийг;

- онц хүнд гэмт хэрэгт оногдуулсан хорих ялын гуравны хоёроос доошгүй хувийг;

Насанд хүрээгүй хүмүүсийн эсрэг бэлгийн гэмт хэрэг буюу энэ хуулийн 210 дугаар хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн бол оногдуулсан хорих ялын дөрөвний гурваас доошгүй хугацаа.

1. Шүүх эдлээгүй ялын хэсгийг илүү хөнгөн ялаар солихдоо энэ хуулийн 44 дүгээр зүйлд заасан ялын төрлүүдээс, гэмт хэрэг бүрт зориулан оногдуулахаар энэхүү хуулиар зохицуулсан аль ч төрлийн илүү хөнгөн ял сонгож хэрэглэж болно.

Тайлбар: Монгол Улсын Эрүүгийн хуулийн 74 дүгээр зүйлд зааснаар хугацааны өмнө тэнсэн суллах заалттай төстэй бөгөөд учруулсан хохирлоо нөхөн төлсөн байх, зан төлвийн хувьд засарч хүмүүжсэнээ харуулсан байх гэдэг шалгуур тавьж байгаагаараа ялгаатай.

Хугацааны өмнө суллах хугацааны хувьд ч ОХУ-ын хууль илүү зөөлөн бөгөөд хөнгөн хүндэвтэр хэрэгт гуравны нэгээр, хүнд хэрэгт 50 хувиар, онц хүнд хэрэгт л ялынхаа гуравны хоёр хувийг эдэлсэнээр суллагдах, өөр хөнгөн ял шийтгэлээр солих боломжтой байна.

Монголд бол хохирлоо нөхөн төлсөн этгээд хүндэвтэр хэрэгт ялынхаа 50 хувийг эдэлсэнээр, хүнд хэрэгт гуравны хоёроор, онц хүнд хэрэгт тавны дөрвөөр суллах боломж нээгддэг.

80.1 дүгээр зүйл. Нөхцөл байдал өөрчлөгдсөнтэй холбоотойгоор хариуцлагаас чөлөөлөгдөх

Нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн гэмт хэргийн шинжийг агуулсан үйлдэл нийгэмд аюултай шинж чанараа алдсан буюу уг этгээд нийгэмд аюулгүй болсон нь тогтоогдвол эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно.

81 дүгээр зүйл. Өвчний учир ялаас чөлөөлөх

1.Гэмт хэрэг үйлдсэний дараа сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, сэтгэцийн хувьд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлаж буюу үйл ажиллагаагаа удирдан жолоодох чадваргүй болсон этгээдийг шүүх ял оногдуулахгүй ба мөн дээрх нөхцөлтэй этгээд ял эдэлж байгаа бол шүүх ялаас чөлөөлнө.

2.Гэмт хэрэг үйлдсэний дараа ялтан ял эдлэхэд саад учруулахуйц хүнд өвчнөөр өвчилсөн бол шүүхээс түүнийг ял эдлүүлхээс чөлөөлж болно.

3.Баривчлагдсан цэргийн албан хаагчид эсхүл сахилгын цэргийн ангид хоригдож буй этгээд цэргийн албанд тэнцэхгүй шалтгаанаар цаашид алба хаахаас чөлөөлөгдөж болно. Эдлээгүй ялын хэсгийн илүү хөнгөн ялаар сольж эдлүүлнэ.

4.Энэ зүйлийн 1 ба 2 дугаар хэсэгт заасан этгээд эрүүл мэндийн хувьд эрүүл болсон тохиолдолд энэ хуулийн 78 ба 83 дугаар зүйлд заасан хөөн хэлэлцэх хугацаа дуусаагүй тохиолдолд үлдсэн ялаа эдлэж болно.

82 дугаар зүйл. Ял эдлүүлэх хугацааг хойшлуулах

1.Хүнд болон онц хүнд гэмт хэрэг үйлдэж 5-аас дээш жилээр хорих ял оногдуулсан этгээдээс бусад жирэмсэн эмэгтэй, 14 хүртэлх насны

хүүхэдтэй эх, 14 хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эцэгт хүүхдийг нь 14 нас хүртэл нь шүүхээс ялыг биечлэн эдлүүлэхийг хойшлуулж болно.

2.Энэ зүйлийн 1 дүгээр хэсэгт заасан этгээдийг биечлэн ял эдлүүлэхийг хойшлуулсан хугацаанд хүүхдээсээ татгалзсан эсхүл хүүхдийг өсгөн хүмүүжүүлэх үүргээс зайлхийсэн бол тус этгээдийн зан байдлыг нь хянаж буй байгууллагын нэг удаагийн анхааруулгын дараа шүүх дээрхи байгууллагын саналыг үндэслэн тус этгээдийн ялыг хойшлуулахыг цуцалж, шүүхийн шийтгэх тогтоолын дагуу ял эдлүүлэх газарлуу илгээнэ.

3.Хүүхдийг 14 нас хүрэх үед энэ зүйлийн 1 дүгээр хэсэгт заасан этгээдийг шүүх ял эдлүүлэхээс чөлөөлж, эсхүл үлдсэн ялыг илүү хөнгөн ял эдлүүлэхээр солих асуудлыг шийдвэрлэнэ.

4.Хүүхдийг 14 нас хүртэл хойшлуулсан ялын хугацаа дуусаж, тус этгээдийн зан байдлыг хянаж байсан байгууллага энэ хуулийн 1 дүгээр хэсэгт заасан нөхцөлийг биелүүлж, засан хүмүүжсэн гэсэн дүгнэлтэнд хүрвэл шүүх энэхүү байгууллагын саналаар уг этгээдийн ялын хугацааг багасгаж, ялаас чөлөөлөх эсхүл ялын үлдсэн хэсгээс чөлөөлөх тухай шийдвэрийг гаргана.

5.Ял хойшлуулсан хугацаанд энэ хуулийн 1 дүгээр хэсэгт заасан этгээд шинээр гэмт хэрэг үйлдвэл шүүх түүнд энэ хуулийн 70 дугаар зүйлд заасан дүрмийн дагуу ял оногдуулна.

Тайлбар: Монгол Улсын Эрүүгийн хуулийн 62, 63 дугаар зүйлд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах тухай заасан бөгөөд хамрах этгээд нь гагцхүү насанд хүрээгүй этгээд, жирэмсэн эмэгтэй, 3 хүртэлх насны хүүхэдтэй эх буюу ганц бие эцэг байхаар тусгажээ.

ОХУ-ын Эрүүгийн хуульд хүүхдийн насыг 14 хүртэл гэж зааж өгсөн нь тухайн эх хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх бололцоогоор илүү хангасан гэж үзэж болохоор ч Монголын хуультай адил 2 жил хүртэл хойшлуулна гэж заагаагүй. Манайд 2 жилийн дараа ял хойшилсон хугацаа дуусаны дараа үлдсэн ялыг хугацааг эдлүүлэхгүй, тэр ч байтугай ялтайд тооцох хугацаа ч дуусахаар учир дутагдалтай заалт байгааг анхаарахгүй байх аргагүй.

3.Өршөөл, уучлал, ялтай байдал

84 дүгээр зүйл. Өршөөл

1.Өршөөлийг ОХУ-ын Холбооны Зөвлөлийн Төрийн Думаас тодорхой холбогдолгүй бүлэг хүмүүсийн хувьд зарлана.

2.Өршөөлийн тогтоолоор гэмт хэрэг үйлдсэн этгээд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөнө. Гэмт хэрэг үйлдсэн этгээд эрүүгийн хариуцлагаас бүрэн чөлөөлөгдөж, эсхүл тэдгээрийн ялыг багасгаж, илүү хөнгөн ялаар сольж, эсхүл нэмэгдэл ялаас чөлөөлөгдөж болно. Өршөөлийн тогтоолоор ял эдэлж буй этгээдийг ялгүйд тооцож болно.

85 дугаар зүйл. Уучлал

1.Уучлал үзүүлэх тогтоолыг ОХУ-ын Ерөнхийлөгч тодорхой хүний хувьд гаргана.

2.Гэмт хэрэг үйлдэж ял оногдуулсан этгээд уучлал үзүүлэх тухай тогтоолоор тус ялаас бүрэн чөлөөлөгдөж, эсхүл түүнд оногдуулсан ялыг багасгаж, эсхүл илүү хөнгөн ялаар сольж болно. Уучлал үзүүлэх тухай тогтоолоор ял эдэлж буй этгээдийг ялгүйд тооцно.

Тайлбар: Монгол Улсын Эрүүгийн хуулийн хувьд өршөөлийн асуудлыг Монгол Улсын хуулийн дагуу шийдвэрлэж, уучлалыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар үзүүлнэ. ОХУ-ын хувьд өршөөл үзүүлэх асуудлыг ОХУ-ын Төрийн Дум, уучлал үзүүлэх асуудлыг ОХУ-ын Ерөнхийлөгч гаргадаг шийдвэрлэх байна.

Өршөөлийг тодорхой бүлэг хүмүүсийн хувьд /Жишээ нь, насанд хүрээгүй этгээд, эмэгтэйчүүд г.м./ гаргана. ОХУ-д Өршөөлийн тогтоолоор гэмт хэрэг үйлдсэн этгээд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөж, эсхүл тэдгээрийн ялыг багасгаж, илүү хөнгөн ялаар сольж, эсхүл нэмэгдэл ялаас чөлөөлөгдөж, эсхүл ял эдэлж буй этгээдийг ялгүйд тооцож болно.

86 дугаар зүйл. Ялтай байдал

1.Ялтан шүүхийн шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн түүнийг ялгүйд тооцох буюу ялгүй болох хүртэл хугацаанд ялтайд тооцогдоно. Энэ хуулийн дагуу давтан гэмт хэрэг үйлдэх буюу ял оногдуулахад ялтай байдлыг харгалзана.

2.Ялаас чөлөөлөгдсөн этгээдийг ялгүйд тооцно.

3.Яллагдагч дараах тохиолдолд ялгүй болно:

а.Тэнсэж хянан харзалзсан хугацаа дуусан;

б.Хорих ялаас илүү хөнгөн ял оногдуулсан этгээдийн хувьд ял эдэлснээс хойш нэг жил өнгөрсөн бол;

в.Хөнгөн буюу хүндэвтэр гэмт хэрэг үйлдэж яллагдсан этгээдийн хувьд ял эдэлснээс хойш гурван жил өнгөрсөн;

г.Хүнд гэмт хэрэг үйлдэж яллагдсан этгээдийн хувьд ял эдэлснээс хойш зургаан жил өнгөрсөн;

д.Онц хүнд гэмт хэрэг үйлдэж яллагдсан этгээдийн хувьд ял эдэлснээс хойш зургаан жил өнгөрсөн.

4.Энэ хуулиар тогтоосон журмын дагуу ялаас хугацаанаас өмнө суллагдсан эсхүл үлдсэн ялыг илүү хөнгөн ялаар сольсон этгээдийн ялгүй болох хугацааг үндсэн ба нэмэгдэл ял эдлэхээс чөлөөлөгдсөн үеэс тоолно.

5.Ял шийтгүүлсэн этгээд ялаа эдэлж дуусаны дараа зан байдал, засрал хүмүүжлээрээ үлгэр жишээч байвал түүний өргөдлийн дагуу шүүх хугацаанаас нь өмнө ялгүйд тооцож болно.

6.Ялтай байдлаас чөлөөлөх эсхүл ялгүй болох нь ялтай байдалтай байхтай холбоотой бүх эрх зүйн үр дагаварыг арилгана.

Тайлбар: Энэ тохиолдолд мөн "давтан гэмт хэрэгтэн" буюу "давтан гэмт хэрэг" гэсэн ойлголт гарч ирж байна. ОХУ-ын хуулийн хувьд "давтан гэмт хэрэг үйлдэх буюу ял оногдуулахад ялтай байдлыг харгалзана" гэсэн зохицуулалтыг агуулж байна. ОХУ-ын Эрүүгийн хуулийн бодлогын дагуу "давтан гэмт хэрэгтэн" хэмээх нэр томъёог хэрэглэхгүй, "давтан гэмт хэрэг үйлдэхэд" гэсэн ойлголтыг агуулж байна. Харин ялгүйд тооцох үндэслэлийн

хувьд хоёр орны хуулийн зохицуулалт ерөнхий байдлаараа ижил төстэй байна. Манай улсынх хөнгөн гэмт хэрэг ял шийтгүүлсэн бол гэж зохицуулдаг бол ОХУ-ын хувьд "хорих ялаас хөнгөн гэмт хэрэгт ял шийтгүүлсэн бол" хэмээн оруулжээ.

ТАВ. НАСАНД ХҮРЭЭГҮЙ ЭТГЭЭДИЙН ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА

1. Насанд хүрээгүй этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх

ОХУ-ын Эрүүгийн хуульд насанд хүрээгүй этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх 10 зүйл бүхий бүлгээр зохицуулж өгсөн байхад манай улсын Эрүүгийн хуульд насанд хүрээгүй этгээдтэй холбоотой 62, 62[1], 69 дүгээр зүйлүүдэд заасан бөгөөд насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах, насанд хүрээгүй этгээдэд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх гэсэн хоёр л заалт байсан бол 2008 оны 02 сарын 01-ний өөрчлөлтөөр 62[1] буюу насанд хүрээгүй этгээдэд Эрүүгийн хуулийн тусгай ангид зааснаас хөнгөрүүлж хорих ял оногдуулах гэсэн заалтыг оруулж өгсөн байна.

87 дугаар зүйл. Насанд хүрээгүй этгээдийн эрүүгийн хариуцлага

1.Насанд хүрээгүй этгээд гэдэг нь гэмт хэрэг үйлдэх үед 14 нас хүрсэн, 18 нас хүрээгүй этгээдийг хэлнэ.

2. Насанд хүрээгүй гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ, эсхүл өөр ял оногдуулж болох бөгөөд ялаас чөлөөлөгдсөний дараа шүүх тус этгээдийг боловсролын тусгай сурган хүмүүжүүлэх хаалттай төрлийн байгууллагад байршуулж болно.

Тайлбар. ОХУ-ын Эрүүгийн хуулийн 87 дугаар зүйлд насанд хүрээгүй этгээд гэдэг нь гэмт хэрэг үйлдэх үед 14 нас хүрсэн, 18 нас хүрээгүй этгээдийг хэлнэ гэсэн бол Монгол Улсын Эрүүгийн хуулинд энэ тухай зохицуулалт байхгүй байна.

2.Насанд хүрээгүй этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл

ОХУ-ын Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 88 дугаар зүйлд насанд хүрээгүй этгээдэд хүлээлгэх ялын төрлийн талаар заажээ.

Үүнд : - Торгууль;

- Тодорхой үйл ажиллагаа эрхлэх эрх хасах;
- Албадан ажил хийлгэх;
- Хүмүүжлийн ажил хийлгэх;
- Эрх чөлөөг хязгаарлах;
- Тодорхой хугацаагаар хорих.

Харин Монгол Улсын Эрүүгийн хуульд насанд хүрээгүй этгээдэд хүлээлгэх ялын талаар тусгайлан заасан заалт байхгүй байна.

3.Насанд хүрээгүй этгээдэд албадлагын арга хэмжээ хэрэглэх онцлог

ОХУ, МУ-ын Эрүүгийн хуульд заасан хүмүүжүүлэх чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай адил заалт байгаа бөгөөд хүмүүжлийн чанартай

албадлагын арга хэмжээнүүд нь адил тэгш боловч өөр өөр заалтууд бас байна. Тухайлбал ОХУ-ын эрүүгийн хуулинд:

- Сануулга
- Эцэг эх, асран хамгаалагч, тусгайлсан байгууллагын хяналтанд шилжүүлэх;
- Учирсан хохирол барагдуулах үүрэг хүлээлгэх;
- Ямар нэгэн үйлдэл хийхийг хязгаарлах, тодорхой шаардлагыг дагахыг шаардах зэрэг арга хэмжээнүүд байна. Эдгээр арга хэмжээнээс хэрэглэж хэрэв хүмүүжсэн гэж үзвэл эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө гэж заажээ.

Харин манай Улсын Эрүүгийн хуульд анх удаа хөнгөн буюу хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй этгээдэд ял оногдуулахгүй байх нь зохистой гэж шүүх үзвэл хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ оногдуулж болохоор заасан.

Үүнд:

- зургаан сараас нэг жил хүртэл хугацаа тогтоож засарч хүмүүжихийг даалгах
- арван зургаан насанд хүрсэн этгээд бие дааж орлого олдог бол хохирлыг өөрийн хөдөлмөрөөр арилгах үүрэг хүлээлгэх
- эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч, ойрын төрөл, садангийн хүний хяналтад өгөх;
- хамт олон буюу төрийн бус байгууллага, түүнчлэн тодорхой иргэний хяналтад байлгахаар тэдний хүссэнээр буюу зөвшөөрснөөр шилжүүлэх, шаардлагатай гэж үзвэл хүмүүжүүлэгч томилох.

ОХУ-ын эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлд албадлагын арга хэмжээнүүдийг тодорхой тайлбарлажээ.

Ялгаатай нь ОХУ-ын Эрүүгийн хуулинд хэрэглэхээр заасан сануулгын болон ямар нэгэн үйлдэл хийхийг хязгаарлах, тодорхой шаардлагыг дагахыг шаардахыг тусгасан байхад МУ-ын эрүүгийн хуульд тодорхой хугацаанд засарч хүмүүжихийг даалгах, хамт олон буюу төрийн бус байгууллага, түүнчлэн тодорхой иргэний хяналтад байлгахаар тэдний хүссэнээр буюу зөвшөөрснөөр шилжүүлэх, шаардлагатай гэж үзвэл хүмүүжүүлэгч томилох зэргийг заажээ.

Учирсан хохирлоо барагдуулах үүрэг хүлээлгэх нь тус насанд хүрээгүй этгээдийн эд хөрөнгийн байдал, хөдөлмөрийн чадварыг нь харгалзан үзсэний үндсэн дээр оногдуулдаг байна, харин манай улсын эрүүгийн хуульд нас зааж 16 насанд хүрсэн, өөрөө бие даан орлого олдог бол уг арга хэжээг хэрэглэхээр заасан байна.

4. Насанд хүрээгүй этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх

Хөнгөн эсхүл хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй этгээд засан хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авхуулснаар эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөнө мөн хүнд эсхүл онц хүнд гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй этгээдийг шүүхээс ял эдлүүлэхээс чөлөөлж, боловсролын тусгай сурган хүмүүжлийн хаалттай байгууллагад байршуулна гэж ОХУ-ын Эрүүгийн хуулийн 92 дугаар зүйлд заажээ. Харин манай улсын эрүүгийн

хуульд хэрэв насанд хүрээгүй этгээдэд арга хэмжээ авагдсаны дараа засраагүй гэж үзвэл насанд хүрээгүй хүмүүсийн сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад явуулах арга хэмжээгээр сольж болно гэжээ.

Харьцуулан үзэхэд, Монгол Улсын Эрүүгийн хуульд насанд хүрээгүй этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, насанд хүрээгүй этгээд гэж чухам хэнийг хэлэх, тэдэнд оногдуулах ялын төрөл, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх зэргийг тусгаж өгөөгүй нь дутагдалтай байна.

ЗУРГАА. ЭМНЭЛГИЙН ЧАНАРТАЙ АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ

1. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэгжүүлэх үндэслэл

ОХУ-ын Эрүүгийн хуулиар эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний талаар дэлгэрэнгүй авч зохицуулсан бөгөөд тус арга хэмжээг шүүх хуульд заасан тодорхой тохиолдолд оногдуулж эрх бүхий байгууллагад тус этгээдийг шилжүүлдэг байна. Энэхүү арга хэмжээг нэгд, гэмт хэрэг үйлдсэн, хоёрт тухайн гэмт хэрэгт үйлдэх цаг мөчид эсхүл үйлдсэний дараа сэтгэцийн үйл ажиллагаа нь сарнисан, эсхүл байнгын сэтгэцийн өвчтэй этгээд үйлдсэн тохиолдолд оногдуулах төдийгүй сэтгэцийн хувьд эрүүл мөртлөө сэтгэл мэдрэлийн эмнэлэгт эмчлүүлэх зайлшгүй шаардлага үүсэн этгээдэд оногдуулна.

Хэрэг хариуцах чадваргүй байх, хорих ял бус сэтгэл мэдрэлийн эмнэлэгт эмчлүүлэх ялын төрлийг эдлэх зэргийг тодорхойлох маш нарийн процесстой ажиллагаа юм. ОХУ-ын Эрүүгийн хуулийн тайлбарт тус арга хэмжээг хэрэглэснээр өөрийн үйлдэл /эс үйлдэл/-ийн мөн чанар болон нийгмийн аюултай шинж чанарыг ухамсарлах боломжгүй, удирдах чадваргүй этгээдэд, өөрөөр хэлбэл эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжгүй, нөгөө талаас дахин нийгмийн аюултай гэмт хэрэг үйлдэх боломжгүй нөхцөлийг үүсгэж байна.

97 дугаар зүйл. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх үндэслэл

1.Шүүх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг дараах этгээдэд оногдуулна:

а.Хэрэг хариуцах чадваргүй үедээ энэ хуулийн тусгай ангид тусгасан гэмт хэргийг үйлдсэн этгээдэд;

б.Гэмт хэрэг үйлдсэний дараа сэтгэцийн үйл ажиллагаа нь сарниж, ял оногдуулах буюу эдлүүлэх боломжгүй болсон этгээдэд;

в.Хэрэг хариуцах чадвартай сэтгэцийн өвчтэй этгээд гэмт хэрэг үйлдсэн.

2.Энэ зүйлийн 1 дүгээр хэсэгт заасан этгээдэд, түүний сэтгэцийн өвчин нь бусдад гэм хор учруулах боломжтой тохиолдолд зөвхөн эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ оногдуулна.

3.Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх журмыг ОХУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон бусад Холбооны хуулийн дагуу тогтооно.

4.Энэ зүйлийн 1 дүгээр хэсэгт заасан этгээдэд, түүний сэтгэцийн өвчин нь бусдад гэм хор учруулах боломжгүй тохиолдолд шүүх ОХУ-ын эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийн дагуу тус этгээдийг эмчлэх, сэтгэцийн эмнэлэг рүү шилжүүлэх асуудлаар эрүүл мэндийн байгууллагад баримт бичгийн шилжүүлнэ.

98 дугаар зүйл. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх зорилго

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх зорилго нь энэ хуулийн 97 дугаар зүйлд заасан этгээдийг эмчлэх, тэдгээрийн сэтгэцийн байдлыг сайжруулах, мөн энэ хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг шинээр үйлдэхээс зайлхийхэд оршино.

Тайлбар: Монгол Улсын Эрүүгийн хуулиар эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээнээс гадна хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэдэг бөгөөд уг арга хэмжээг насанд хүрээгүй этгээдийн хувьд хэрэглэдэг. Харин хуулийн хувьд насанд хүрээгүй этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай бие даасан бүлэгт зохицуулсан байна.

2. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрлүүд

99 дүгээр зүйл. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл

1.Шүүх дараах төрлийн эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлнэ:

а.Эмнэлгийн албадан хяналтанд эсхүл сэтгэл мэдрэлийн эмчийн хяналтанд байлгах;

б.Сэтгэцийн эмгэг судлалын ердийн эмнэлэгт байлгах;

в.Сэтгэцийн эмгэг судлалын тусгай эмнэлэгт байлгах;

г.Сэтгэцийн эмгэг судлалын хүч нэмэгдүүлсэн хяналттай эмнэлэгт байлгах.

2.Хэрэг хариуцах чадвартай боловч сэтгэцийн эмчилгээ хийлгэх шаардлагатай гэж үзсэн этгээдэд шүүхээс ял оногдуулахын зэрэгцээ эмнэлгийн албадан хяналт эсхүл сэтгэл мэдрэлийн эмчийн хяналтанд байлгах эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно.

Тайлбар: Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний хувьд хоёр орны Эрүүгийн хуульд ижил төстэй зохицуулалтыг олныг агуулсан. ОХУ-ын Эрүүгийн хуулийн хувьд манай улсаас ялгаатай нэг зохицуулалт агуулсан нь "Эмнэлгийн албадан хяналтанд эсхүл сэтгэл мэдрэлийн эмчийн хяналтанд байлгах" хэмээх зохицуулалт юм.

104 дүгээр зүйл. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг ялтай хамтад нь эдлүүлэх

1. Энэ хуулийн 99 дүгээр зүйлийн хоёрдугаар хэсэгт заасан тохиолдолд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хорих ял эдэлж буй газарт нь, харин бусад төрлийн ял шийтгүлэхээр оноогдсон этгээдүүдийн хувьд сэтгэц эмгэг судлалын эмнэлгийн байгууллагад эдлүүлнэ.

2.Гэм буруутай этгээдийн сэтгэцийн байдал өөрчлөгдөж эмнэлэгт, сэтгэл мэдрэлийн эмнэлэгт буюу бусад эмнэлгийн байгууллагад хэвтэж эмчлүүлэх шаардлага бий болвол эрүүл мэндийн тухай ОХУ-ын хууль тогтоомжинд заасан журам, үндэслэлийн дагуу эмчлүүлнэ.

3.Заасан эмнэлгийн байгууллагад эмчилгээ хийлгэх хугацааг ял эдлүүлэх хугацаанд оруулж тооцно. Гэм буруутай этгээд цаашид эмчлүүлэх шаардлага үгүй болсон тохиодолд эрүүл мэндийн тухай ОХУ-ын хууль тогтоомжинд заасан журам, үндэслэлийн дагуу эмнэлгээс гарґана.

4.Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг ялтай хамтад нь эдлүүлэх арга хэмжээг зогсоох асуудлыг сэтгэл мэдрэлийн эмч нарын дүгнэлтийг үндэслэн ялыг хэрэгжүүлж буй байгууллагын тодорхойлтоор шүүх шийдвэрлэнэ.

Тайлбар: Монгол Улсын хуулинд тусгайлан зохицуулагдаагүй энэхүү зохицуулалт дараах санааг агуулжээ: нэгд, шүүхийн шийтгэх тогтоол гарч ял шийтгүүлсэний дараа гэм буруутай этгээд сэтгэцийн хувьд өөрчлөлтөнд орж, эмчлүүлэх шаардлагатай бол хориг ялыг эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээгээр сольж болно, хоёрт, эмнэлгийн байгууллагад эмчлүүлэх хугацааг ял эдлэсэн хугацаанд оруулж тооцно, гуравт, хорих ял эдлэхээр шийтгүүлсэн этгээдийн хувьд хорих ял эдэлж буй газарт нь эмчилгээ явагдаж, хорихоос бусад ял эдлэхээр шийтгүүлсэн этгээдийн хувьд эмнэлгийн байгууллагад эмчлүүлнэ.

ДОЛОО. ЭД ХӨРӨНГӨ ХУРААН АВАХ

ОХУ-ын Эрүүгийн хуулийн Ерөнхий ангид эд хөрөнгө хураан авах тухай зохицуулалтыг 2003 оны 12 дугаар сарын 8-ны өдөр 162 тоот Холбооны хуулиар[807] ялын төрлөөс эд хөрөнгө хураан авах ялыг хасаж 2008 оны 12 дугаар сарын 25-ны 280 тоот Холбооны хуулиар дахин оруулжээ.

ОХУ-д эд хөрөнгө хураан авах бүлэгт учирсан хохирол барагдуулах тухай заалтыг оруулжээ. Тус заалтаар эд хөрөнгө хураан авах асуудлыг шийдвэрлэхдээ эхний ээлжинд хууль ёсны эзэмшигчид учирсан хохирлыг барагдуулах асуудал шийдвэрлэгдэх бөгөөд хураан авах эд хөрөнгө байхгүй тохиолдолд түүний үнийн дүнгээс хохирогчийн хорихолыг барагдуулж үлдсэн хувийг нь төрийн орлого болгон авна гэсэн зохицуулалтыг агуулжээ.

Дүгнэлт

Тус судалгааны ажлын хүрээнд хөрш зэргэлдээ, эрх зүйн систем нь ижил ОХУ-ын хууль тогтоомжийг судлах, Монгол орны нөхцөлд тохирох сайн туршлагыг авч нутагшуулах, харьцуулах зорилго тавьсан. Судалгааны ажлын хүрээнд 2010 онд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн:

1.ОХУ-ын Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийг хүснэгтлэн монгол хэлнээ хөрвүүлсэн.

2.Монгол Улсын Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийг хүснэгтлэн орос хэлнээ хөрвүүлсэн.

3.Хоёр орны Эрүүгийн хуулийн ерөнхий ангийг харьцуулан судалсан.

Дээрх ажлыг хийж гүйцэтгэх явцад ОХУ-ын Эрүүгийн хууль, түүний онцлог зохицуулалтууд, мөн манай орны хуультай ижил төсөөтэй зохицуулалт олон байгаа нь харагдаж байна. 1996 оны 5 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан уг хуулийн хувьд батлагдсан өдрөөс хойш 2010 оны 7 дугаар сар хүртэл нийт 29 удаа нэмэлт, өөрчлөлт орж байсан. Өөрөөр

[807]Парламентская газета, 2003, 11 декабря.

хэлбэл анхны редакцаасаа нилээдгүй өөрчлөлт орсон бараг "шинэ" хууль болсон гэж хэлж болно.

Мөн ОХУ-ын Ерөнхийлөгч энэ оны 11 дүгээр сард ОХУ-ын Үндсэн хуулийн 84 дугаар зүйлийн дагуу "ОХУ-ын Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" холбооны хуулийн төслийг Төрийн Думд оруулжээ. Ерөнхийлөгчийн албан ёсны мэдээллийн цахим хуудсанд мэдээлсний[808] дагуу тус хууль нь Эрүүгийн хуулийг "зөөлрүүлэхэд" чиглэсэн байна. Тухайлбал, тэнсэх, тэнсэнг болиулах эсхүл хянан харгалзах хугацааг сунгах талаархи 73, 74, 79 дүгээр зүйлд өөрчлөлт оруулжээ. Хуучин зохицуулалтаар тэнсэнгийн хугацаанд хянан харгалзаж байгаа этгээд хөнгөн гэмт хэрэг үйлдсэн бол тэнсэнг зогсоож зайлшгүй ял оногдуулдаг байсан бол шинэ зохицуулалтаар шүүхийн шийдвэрээр тэнсэнгийн хянан харгалзах хугацааг сунгаж болно.

Мөн 68 дугаар зүйлд давтан гэмт хэрэг үйлдэхэд оногдуулах хорих ялын доод хэмжээг заасан бол санал болгож буй зохицуулалтаар нийгэмд учирсан хор аюулыг харгалзан үзэж доод хэмжээг тогтоох зохицуулалтыг хэрэгсэхгүй болгож, дээд хэмжээг урьдын адил үлдээжээ. Өөрөөр хэлбэл, өмнө нь тус гэмт хэрэгт тусгай ангиар нь оногдуулдаг ялаас гуравны нэгээс доошгүй ялыг давтан гэмт хэрэгт оногдуулдаг байсан бол одоо үүнээс ч доогуур оногдуулах боломжтой юм.

Тус судалгааны дүгнэлтэнд ОХУ-ын Эрүүгийн хуулийн шинэлэг зохицуулалтын талаар дурьдах болсон нь энэхүү зохицуулалтын хүмүүнлэг, илүү зөөлөн чанарыг харуулах гэсэнд оршино. Оросын олон хуульчид нь өнөөгийн хуулийг хатуу зохицуулалттай хэмээн үздэг байна. Өмнө үйлчилж байсан 1960 оны Эрүүгийн хуулийг бодвол илүү ардчилсан, хүмүүнлэг зохицуулалттай гэж зарим эрдэмтэд үздэг хэдий ч зарим эрдэмтэд шинэ, хуучин хоёр хуулиа харьцуулан үзэхэд шинэ хуулийг илүү зөөлөн бус харин ч 1 дүгээр бүлэгтээ заасан энэрэнгүй, шударага ёсны зарчмыг бүрэн мөрдөхгүй байна гэж үздэг. ОХУ-ын Ерөнхийлөгч Дмитрий Медведевын цохон тэмдэглэснээр[809], Эрүүгийн хуульд шинэ зохицуулалт оруулах нь тус хуулийн 6 дугаар зүйлд заасан шударага ёсны зарчмыг баримтлах үндэс болно гэжээ.

Хоёр орны хуулийг харьцуулан авч үзэхэд, ОХУ-ын хууль нь зарим асуудлаар илүү дэлгэрэнгүй зохицуулалтыг агуулсан төдийгүй гэмт хэрэг үйлдсэн хүний эсрэг бус тухайн үйлдсэн гэмт хэргийн эсрэг зохицуулттайгаар давуу талтай хэмээн үзэж байна. Тухайлбал, нийгмийн маш чухал субъект төдийгүй "үнэт зүйлс" хэмээн нэрлэж болох насанд хүрээгүй этгээд, түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын асуудлаар тусгайлан зохицуулсан зохицуулалтууд. Мөн давтан гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрүүгийн хариуцлагын асуудал зэрэг олон зохицуулалтыг дурдаж болно.

Судалгааны ажлын төлөвлөгөөний дагуу 2011 онд ОХУ-ын Эрүүгийн хуулийн тусгай ангийн зохицуулалтыг авч үзэх төдийгүй бусад зарим улс орнуудын шинэлэг, давуу зохицуулалтын талаар судлах болно.

__oOo__

[808]http://www.kremlin.ru/news/9646

[809]Мөн тэнд.

ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН ХҮРЭЭНД ОЛОН УЛСЫН ХУВИЙН ЭРХ ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭГ ХЭРЭГЛЭХ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ: ОЛОН УЛСЫН ХУДАЛДААНЫ ЭРХ ЗҮЙГ АРБИТРЫН ШҮҮХЭД ХЭРЭГЛЭХ АСУУДАЛ[810]

НЭГ. ОЛОН УЛСЫН ХУДАЛДААНЫ ЭРХ ЗҮЙ

1.Олон улсын худалдааны эрх зүй ОУХЭЗ болох нь

Олон улсын хувийн эрх зүй гэдгийг гадаадын элемент оролцсон иргэний эрх зүйн хэргийг зохицуулж буй бүх хэм хэмжээг бүхэлд нь ойлгож болох бөгөөд энэ утгаараа захиргааны эрх зүй нь ОУХЭЗ-н нэг бүрэлдэхүүн хэсэг болж байгаа юм.[811]

Хувийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд дараах онцлог шинжүүд ажиглагдаж байдаг. Үүнд:

- Диспозитив хэм хэмжээ голлодог;
- Субъектуудын хүсэл зоригын илэрхийлэл нээлттэй байдаг;
- Харилцаанд оролцогчид хийсэн үйлдлийнхээ төлөө өөрсдөө хариуцлага хүлээдэг;
- Шүүхийн хамгаалалтаар баталгаажсан байдаг;
- Амин хувийн эрх ашгийг хангах хандлагатай байдаг.

Харин нийтийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд дараах онцлог шинжүүд ажиглагдаж байна. Үүнд:

- Нийтийн ашиг сонирхолыг хангах чиг баримжаа түлхүү байдаг;
- Эрх зүйн субъектийн нэг талын хүсэл зориг илрэн гардаг;
- Заавал биелүүлэх хэм хэмжээ голлосон байдаг;
- Субъектуудын харилцаа ба эрх зүйн акт, хэм хэмжээ зохих дэг журамд орсон байдаг.

Манай улсын хувьд 1992 оны Үндсэн хуулиар нийтийн болон хувийн өмчийн төрлийг баталгаажуулсан нь эрх зүйн тогтолцоог нийтийн, хувийн эрх зүй гэж ангилах онолын үндсийг баталгаажуулсан юм.

Ихэнхи эрдэмтэн судлаачид олон улсын гэрээг олон улсын хувийн эрх зүйн эх сурвалж мөн гэж үздэг.

ОУ-ын хувийн эрх зүй ба ОУ-ын нийтийн эрх зүй хоёрын хоорондын нягт уялдаа, ялангуяа олон улсын эдийн засгийн харилцааны салбарт тод илэрч байна. Худалдааны гэрээ, санхүү, татварын хэлэлцээр нь гадаад эдийн засаг, худалдааны талаар улс хоорондын харилцан хүлээх үүргийг тогтоодог. Эдгээрийн үндсэн дээр байгуулсан гадаад худалдааны хэлэлцээр бараа тээвэрлэх, хүлээн авах, төлбөр хийх зэрэг ажиллагаанд иргэний эрх зүйн харилцаа үүсдэг.

Улс хоорондын худалдааны гэрээг зөрчвөл олон улсын нийтийн эрх зүйн дагуу Засгийн газрын хэмжээнд яригдаж, цаашид дипломат шугамаар эсэргүүцэл илэрхийлж, хариу арга хэмжээ авах бололцоотой болно.

[810] Тус секторын төлөвлөгөөт судалгааны ажил.

[811] Т. Мэндсайхан "Олон улсын хувийн эрх зүйн үндэс" УБ хот, 2002он.

Тэгвэл хуулийн этгээдийн хоорондбайгуулсан гэрээ, хэлцлийг зөрчих нь иргэний эрх зүйтэй холбоотой учраас түүнээс үүдэн гарах гомдлыг холбогдох улсын шүүхээс, эсхүл арбитраар шийдвэрлүүлдэг нь ОУХЭЗ арга хэрэгсэл болж байгаа юм.[812]

Дээр дурдсанаас дүгнэж үзвэл ОУНЭЗ ба ОУХЭЗ нь тус тусдаа зохицуулах зүйл, арга, харилцаатай онцлог систем боловч хоорондоо нягт уялдаатай, бие биенээсээ харилцан хамааралтай үзэгдэл мөн болох нь харагдаж байгаа юм.

Даяаршиж байгаа өнөө үед улс хоорондын харилцаа улам бүр нарийсаж байгаа бөгөөд үүний дотор худалдаатай холбоотой хамтын ажиллагаа нь илүү өргөн цар хүрээг хамарч байгаа билээ.

Дээр дурдсанчлан хуулийн этгээдийн хоорондхийгдэж байгаа харилцаа нь иргэний эрх зүйн хэм хэмжээ байдаг учраас олон улсын худалдааны салбарын хэм хэмжээг ОУХЭЗ хэм хэмжээнд хамруулан ойлгож болох юм.

2.Олон улсын худалдааны эрх зүйн үндсэн ба бусад эх сурвалж

Олон улсын худалдаа ба гадаад худалдаа нь нэг талаар ойролцоо шинжийг агуулдаг ч үндсэн агуулга, мөн чанарын хувьд ялгаатай. Ойролцоо шинж нь хоёулаа бараа, эд хөрөнгийн эргэлтийг хамаардаг, эдийн засгийн харилцаа юм. Ялгаатай тал нь гадаад худалдаа нэг орны экспорт, импортоос бүрддэг улс орны төлбөртэй худалдаа бол олон улсын худалдаа нь 2 ба түүнээс дээш улс орнуудын хоорондын худалдааны харилцаа бөгөөд хамрах хүрээ, төрлийн хувьд ерөн ойлголт юм.

Олон улсын худалдааны эрх зүй нь улс хоорондын худалдааны хүрээн дэх харилцааг зохицуулдаг хэм хэмжээнүүдийн нийлбэр цогц юм. Түүнчлэн олон улсын эрх зүйн хэм хэмжээний зарчимд үндэслэгддэг болно.

Олон улсын худалдааны эрх зүй нь улс хоорондын гэрээ хэлэлцээр, заншлын хэм хэмжээний эх сурвалжаас бүрэлдэнэ. Тухайлбал: олон улсын худалдааны эрх зүйн зохицуулалтад худалдааны хэм хэмжээг тогтоосон гэрээ, хэлэлцээр, конвенц, холбогдох заншил, олон улсын шүүх, Дэлхийн худалдааны байгууллагын шийдвэр, үндэсний хууль тогтоомж хамаардаг.

Олон улсын худалдааны эрх зүйн зохицуулалтанд хамаарах харилцаа, үйл ажиллагааны хэлбэр, гэрээ хэлэлцээрийг дараах байдлаар төрөлжүүлэн авч үздэг байна[813]. Үүнд:

- Бараа, эд хөрөнгө худалдах, худалдан авах хэлэлцээр;
- Үйлчилгээний тухай хэлэлцээр;
- Хувцас, даавууны хэлэлцээр;
- Хөдөө аж ахуйн хэлэлцээр;
- Оюуны өмчийн эрхийн худалдааны хэлэлцээр;
- Засгийн газрын худалдан авах ажиллагааны хэлэлцээр;
- Иргэний агаарын тээврийн хэлэлцээр;
- Хөрөнгө оруулалтын тухай хэлэлцээр;
- Төмөр замын тээврийн тухай хэлэлцээр;

[812] Т. Мэндсайхан "Олон улсын хувийн эрх зүйн үндэс" УБхот, 2002он.
[813] Гүргэмжав Э., Амартүвшин М. Олон улсын худалдаа. УБ хот, 2009 он.

- Авто машинаар олон улсын хүрээнд ачаа тээвэрлэх хэлэлцээр;
- Даатгалын хэлэлцээр гэх мэт.

Олон улсын худалдааны нийтлэг журмыг боловсруулж тодорхойлох ажилд голлох үүргийг олон улсын эдийн засгийн байгууллагууд гүйцэтгэдэг. Олон улсын худалдааны үйл ажиллагааг зохицуулах чиглэлээр ажилладаг байгууллагуудыг дурдвал:

- ЮНСИТРАЛ нь олон улсын худалдааны эрх зүйгээр НҮБ-ын комиссын үүргийг гүйцэтгэдэг байгууллага /олон улсын худалдааны эрх зүйг ижилсгэх болон харилцан тохиролцоход дэмжлэг үзүүлэх зорилготойгоор 1966 онд байгуулагдсан бөгөөд өөрийнхөө үйл ажиллагааг 1968 оноос явуулж эхэлсэн/. Гол зорилго нь:
  - Олон улсын худалдааны дүрмийг ижилсгэх болон тохиролцоход дэмжлэг үзүүлэх
  - Олон улсын худалдааны эрх зүйн салбарт нэг загварын хууль, олон улсын шинэ конвенцид бэлтгэх
  - Энэхүү салбарт мэдээллийг төвлөрүүлж дэлгэрүүлэх, олон улсын худалдааны заншлыг коджуулахад дэмжлэг үзүүлэх
  - Олон улсын худалдааны эрх зүйн асуудлаар ажилладаг олон улсын байгууллагын ажлыг холбож уялдуулах
  - Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа конвенцүүдэд улсуудын оролцох оролцоог аль болохоор дэмжих
  - Хөгжиж байгаа орнуудад онцгой шаардлагатайг харгалзан олон улсын эрх зүйн салбар дах боловсон хүчнийг сургаж бэлтгэхэд тусламж дэмжлэг үзүүлэх
  - Бараа худалдах-худалдан авах олон улсын гэрээ, олон улсын төлбөр ба тооцоо, олон улсын худалдааны арбитраж болон далай ба тэнгисийн тээвэрлэлтийн салбар дах олон улсын хууль тогтоомж гэх мэт эрх зүйн нэг загварын хэм хэмжээг судалж бэлтгэх асуудал хамаарна.
- УНИДРУА нь олон улсын хувийн эрх зүйгээр ажилладаг олон улсын институт. 1926 онд байгуулагдсан. Гол зорилго нь:
  - Эрх зүйн нэг загварын зохицуулалтыг олон улсын практикт боловсруулж, нэвтрүүлэх замаар олон улсын эдийн засгийг хөгжүүлэх тааламжтай нөхцөлийг бий болгох
  - Зарим улс ба бүлэг улс орны хувийн эрх зүйг тохиролцон уялдуулах замаар судлах
  - Нэг загварын эрх зүйн хэм хэмжээг янз бүрийн улс орнуудаар хүлээн зөвшөөрүүлэхийн тулд түүнийг боловсронгуй болгох.
- ЮНКТАД нь худалдаа ба хөгжлийг дэмжих олон улсын бага хурал. 1975 оноос эхэлж Америкийн улсуудад олон улсын хувийн эрх зүйн сэдвээр бага хурал 3 жил тутамд явагддаг болсон.
- ЕЭКООН нь НҮБ-ын Европын эдийн засгийн комиссын үйл ажиллагааг явуулдаг байгууллага[814]. Олон улсын худалдааны үйл ажиллагааг зохицуулах салбарт худалдааг хөгжүүлэх хорооны

[814]Авирмэд Д. Олон улсын худалдааны эрх зүйн зохицуулалт. УБхот, 2007 он.

хүрээнд томоохон цогц асуудлыг шийдвэрлэдэг. Хорооны ажилд Европын эдийн засгийн хамтын нийгэмлэг болон бүс нутгийн ихэнх орны гадаад эдийн засгийн байгууллагын төлөөлөгчид оролцдог. Гол зорилго нь:

- Худалдаа ба эдийн засгийн хамтын ажиллагааны тухай урт хугацааны гэрээ байгуулах
- Худалдааг хөгжүүлэх зам дах янз бүрийн саадыг арилгах
- Бүс нутагт нөхөн төлбөртэй худалдааг хөгжүүлэх
- Ажил хэргийн харилцаа ба маркетингийн арга, зах зээлийн тухай мэдээлэл солилцоог хөгжүүлэх
- Олон улсын худалдааны дүрэм ба журмыг боловсронгуй болгох
- Аж үйлдвэрийн салбарт олон улсын гэрээний үйл ажиллагааг хөгжүүлэх гэх мэт.

Тариф худалдааны ерөнхий хэлэлцээр

Олон улсын худалдааг өргөжүүлэхийн тулд гаалийн тарифын хэмжээг харилцан бууруулахын тулд 23 орон 1947 оны 10 сард "Худалдаа ба Гаалийн тарифын Ерөнхий Хэлэлцээр"-т /GATT/ гарын үсэг зурсан байна. Энэхүү хэлэлцээр нь 1948-1994 оны хооронд олон улсын худалдааны ерөнхий эрх зүйн хүрээ болж байсан. ТХЕХ нь доорх 4 дүрэмд дээр үндэслэн байгуулагдсан.[815]Үүнд:

1. Most Favoured Nation Clause, Non-discrimination. *Үндэсний нэн тааламжтай нөхцөл буюу тэгш эрх*

Энэ нөхцөл нь, гишүүн орнуудын хоорондох ялгаварлан гадуурхах асуудлыг арилгах зорилго агуулсан. Энэ дүрмийн дагуу гишүүн орон нь бусад ямар нэгэн оронд худалдааны тааламжтай нөхцөл байдлыг бий болгон өгсөн бол GATT-ын бусад гишүүн орнуудад ижил нөхцөлийг олгох ёстой. Гэхдээ энэхүү дүрэмд Гаалийн холбоо, Чөлөөт худалдааны бүсийн хэлэлцээр, Хөнгөлөлтийн ерөнхий систем /GSP/ гэх мэтчилэн хөгжиж буй орнуудад олгодог гаалийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт зэрэг хэлэлцээрийн нөхцөлүүд хамаарахгүй.

2. National Treatment. *Үндэсний харьцаа*

Үндэсний харьцааны дүрэм нь, дотоодын зах зээлийн худалдааны хууль дүрмүүд нь дотоодын бүтээгдэхүүн болон импортын бүтээгдэхүүн аль алинд ч адилхан үйлчлэх ёстойг тусгасан байна. Энэ дүрэм нь, бараа, үйлчилгээ ба оюуны өмчийг улсын хилээр нэвтрэн зах зээлд орсны дараа үйлчилнэ. Тиймээс энэхүү дүрэмд гаалийн татвар хамаарахгүй.

3. Гаалийн татваруудыг бууруулан тогтворжуулах

GATT-ын хүрээнд хамгийн түрүүнд гаалийн татваруудыг бууруулахаар хэлэлцээр хийгдсэн байна. Гишүүн орон бүр, тодорхой гаалийн татварын хэмжээнээс илүү гаргалгүйгээр гаалийн татвараа тогтоох ёстой.

[815] МУ-ын ГЕГ-ын дэргэдэх ГЭЗДС. ДЭЛХИЙН ХУДАЛДААНЫ БАЙГУУЛЛАГА-олон улсын худалдаа, эдийн засгийн харилцааны эрх зүйн үндэс болох нь. УБ хот, 2010 он.

4.Гаалийн тарифаар хамгаалах

Худалдаанд дотоодын зах зээлийг хамгаалах хамгийн ил тод арга бол гаалийн тарифаар хамгаалах явдал юм. ТХЕХ–ийн хүрээнд тарифын бус ихэнх худалдааг хязгаарлах хууль дүрэм гаргахыг гишүүн орнуудад хориглодог.

Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр байгуулагдсан 1948 оны худалдаатай харьцуулахад дэлхийн худалдаа 27 дахин өссөн байна. Өнгөрсөн 60 гаруй жилийн хугацаанд явагдсан хэд хэдэн үе шатны хэлэлцээрийн үр дүнд хөгжингүй орнуудын импортын дундаж тариф 20-30 хувиас 4 орчим хувь болж буурчээ[816].

GATT-ын хүрээнд хийгдсэн хэлэлцээнүүд:

Жил	Хэлэлцээ	Хэлэлцээний гол асуудлууд	Орнуудын тоо
1947	Женев	Гаалийн тариф	23
1949	Аннеси	Гаалийн тариф	13
1951	Торквай	Гаалийн тариф	38
1956	Женев	Гаалийн тариф	26
1960-1961	Диллоны хэлэлцээ	Гаалийн тариф	26
1964-1967	Кеннедийн хэлэлцээ	Гаалийн тариф болон антидемпингийн хэмжээ	62
1973-1979	Токион хэлэлцээ	Гаалийн тариф, тарифын бус хязгаарлалт, "бүтцийн" хэлэлцээрүүд	102
1986-1994	Уругвайн хэлэлцээ	Гаалийн тариф, тарифын бус хязгаарлалт, худалдааны дүрмүүд, үйлчилгээ, оюуны өмч, арбитрын асуудал, оёдол,сүлжмэл, хөдөө аж ахуй, ДХБ-ыг байгуулах гэх мэт	123
2001-	Дохагийн хэлэлцээ	Хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрийн салбар, үйлчилгээ; оюуны өмч	

Уругвайн хэлэлцээр

Уругвайн хэлэлцээр 1986 оны 9 сард эхэлсэн бөгөөд 1993 оны 12 сард дуусгавар болсон. Үүнээс өмнөх хэлэлцээрүүдэд гаалийн татварыг хөнгөлөх асуудал яригдаж байсан бол, Уругвайн хэлэлцээрт гаалийн татвар түүний хажуугаар, дэлхийн худалдааны хууль дүрмийн талаар гишүүн орнууд 29 гэрээ хэлэлцээрт гарын үсэг зурсан байдаг.

Уругвайн хэлэлцээрийн үед хийсэн хамгийн чухал хэлэлцээр бол ДХБ-ын хүрээнд худалдааны асуудал зөрчилдөөнийг шийдэх арбитрын байгууллагыг бий болгосон явдал юм.

[816] МУ-ын ГЕГ-ын дэргэдэх ГЭЗДС. ДЭЛХИЙН ХУДАЛДААНЫ БАЙГУУЛЛАГА-олон улсын худалдаа, эдийн засгийн харилцааны эрх зүйн үндэс болох нь. УБ хот, 2010 он.

Уругвайн хэлэлцээрийн дагуу гишүүн орнууд тодорхой үе шатлалтайгаар гаалийн татвараа бууруулж тогтворжуулах амлалт авсан байдаг.

Дохагийн хэлэлцээр

Дохагийн хөгжлийн хэлэлцээр нь ДХБ-ын хүрээнд хийгдэж буй анхны хэлэлцээр юм. Энэ хэлэлцээр нь чөлөөт худалдааг бий болгох зорилгоор, худалдааны саад тотгоруудыг багасгах талаар явагдаж байгаа юм. Хэлэлцээр 2001 онд Катарын Доха хотод сайд нарын түвшний хурлаар эхэлсэн бөгөөд, дараагаар нь Мексикийн Канкун /2003/ болон Хятадын Хонг Конгод /2005/ болсон ижил түвшний хурлаар үргэлжилсэн байна. Үүнтэй холбоотой мөн Женевт /2004/, Парист /2005/, ахин Женевт /2006/ онд уулзалтууд болсон.

Дохагийн хэлэлцээр 2006 оны эцэс хүртэл 4 жил үргэлжлэхээр төлөвлөгдсөн байсан авч, өнөөдрийг хүртэл тодорхой амжилтанд хүрээгүйн улмаас үргэлжлэхээр болсон.

Уругвайн хэлэлцээрийн хүрээнд ихэнх орнуудын гаалийн татварын хэмжээ буурч тогтворжсоноос, гадаадын зах зээлд нэвтрэх асуудал илүү хялбар болсон. Түүнчлэн гаалийн тарифийг тогтмол байлгах журмаас үүдэн гишүүн орнууд гаалийн татварыг гэнэт нэмэх магадлал багассан.

Худалдааны эдгээр хэлэлцээрүүд нь гадаад худалдаа эрхлэгчдэд худалдааны боломж олгоод зогсоогүй мөн дотоодын жижиг дунд үйлдвэрлэгчид болон худалдаа эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалсан заалтууд агуулсан байна.

Гадаад худалдаа эрхлэгчид ямар нэгэн асуудал зөрчилдөөнтэй тулгарвал, хамгийн түрүүнд өөрийн улсын гадаад худалдаа хариуцсан байгууллагад хандаж болно. Тухайн байгууллага асуудал үүссэн улстай засгийн газрын түвшинд, асуудал зөрчилдөөнийг арилган хэлэлцээрт хүрэхийг зорих бөгөөд хэрэв ямар нэгэн зөвшилцөлд хүрч чадахгүй аваас Дэлхийн худалдааны байгууллагын арбитрт /шүүхэд/ хандаж болно.

Оюуны өмчийн эрхийн худалдааны асуудлаарх хэлэлцээр

Олон улсын худалдааны үйл ажиллагаанд технологи чухал үүргийг гүйцэтгэнэ. Технологи бол үйлдвэрлэлийг хөгжүүлэх хүчин зүйлийн нэг билээ.

Технологийн зах зээлийн үүсэл хөгжлийн материаллаг үндэс бол технологийн олон улсын хуваарилалт юм. Үйлдвэрлэлийн бие даасан хүчин зүйл болох технологийг лицензэ, патент, ноу-хау-гын худалдаагаар дамжуулан борлуулж байна. Тухайлбал: олон улсын худалдааны зах зээл дээр технологийн худалдаа нь үндсэн 2 хэлбэртэй. Үүнд:

- Лицензийн бус замаар үйлдвэрлэл, худалдааны ноу-хауг худалдаалах
- Лицензийн хэлэлцээрийн дагуу патент болон ноу-хауг ашиглах эрхийг худалдаалах.

Олон улсын худалдааны хөгжилд гажуудал, саад учруулах явдлыг багасгах, ингэхдээ оюуны өмчийн эрхийн үр нөлөөтэй зүй зохистой хамгаалалт зайлшгүйг анхаарч, оюуны өмчийн эрхийн хэрэгжилтийн арга хэмжээ, үйл явц нь өөрөө хуулийн дагуух худалдаанд саад болохгүй байх

нөхцөлийг хангахыг эрмэлзэж энэхүү хэлэлцээрийг байгуулсан. 1994 оны Худалдаа, үнийн тухай ерөнхий хэлэлцээрийн үндсэн зарчим болон оюуны өмчийн талаар холбогдох олон улсын хэлэлцээр, конвенцийн дагуу хэрэглэхийг зарчим болгосон.

Оюуны өмчийн эрхийн хамгаалалт, хэрэгжилт нь технологийг шинэчлэх, түүнийг шилжүүлэх, дэлгэрүүлэхэд нэмэр хандив болох ба технологийн мэдлэгийг ашиглагч, үйлдвэрлэгчийн харилцан ашигтай байдал буй болгох, нийгэм эдийн засгийн аж байдалд тааламжтай байдлаар нөлөөлөх ба эрх, үүргийн тэнцвэрт байдлыг хадгалах ёстой. Оюуны өмчийн эрхийн байдал, хэмжээ, хэрэгжилтийн талаархи хэм хэмжээ нь:

➢ Зохиогчийн эрх ба хамаарах эрх / Зохиогчийн эрхийн хамгаалалт нь биелэлээ олсон онцлог зүйлд үйлчлэнэ. Тухайлбал: Нэвтрүүлэгч байгууллага, дуу авианы бичлэг үйлдвэрлэгч, тоглогчдыг хамгаалах, мөн бүтээл туурвих, уран зураг зурах гэх мэт/

➢ Барааны тэмдэг / Нэг үйлдвэрийн газрын бараа буюу үйлчилгээг нөгөө үйлдвэрийн бараа үйлчилгээнээс ялгаж болох аливаа тэмдэг, тэмдгийн аливаа хослол нь барааны тэмдгийн бүрдлийг хангана. Хувийн нэр, үсэг, тоо, дүрс хэлбэр, өнгөний хослол, түүнчлэн тийм тэмдгийн аливаа хослолыг барааны тэмдгээр бүртгэж болно/.

➢ Газар зүйн заалт / газар зүйн заалт нь гишүүний нутаг дэвсгэр, бүс буюу тодорхой газраас үүсэлтэй барааг адилтгаж буй тэмдэглэл бөгөөд барааны тодорхой чанар нэр хүнд, бусад шинж нь түүний газар зүйн үүсэлтэй ихээхэн хэмжээгээр холбогдоно/.

➢ Бүтээгдэхүүний загвар

➢ Патент / патент нь техникийн бүх салбарт арга ажиллагаа буюу бүтээгдэхүүний аливаа шинэ бүтээлийн хувьд олгогдох ба тэдгээр нь шинэ байх ба шинэлэг талыг агуулсан, үйлдвэрлэлд ашиглах боломжтой. Патент болон патентын эрхийг гаднаас оруулж байгаа, дотоодод үйлдвэрлэж байгааг үл харгалзан технологийн салбар, шинэ бүтээлийн байршилд ялгаварлахгүйгээр олгоно/ гэх мэт.

Дээрх оюуны өмчийн эрх зүйн хамгаалалтын хэрэглүүр нь олон улсын худалдааны зах зээлд технологийн зах зээлийг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Цаашилбал үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд улс орнуудын технологийн зах зээлийг хөгжүүлж, худалдааны үйл ажиллагааг эрчимжүүлэхэд эрх зүйн хүчтэй хамгаалалт болж чадах юм. Иймд улс орон бүр оюуны өмчийн эрхийн хамгаалалтанд анхаарал хандуулдаг билээ.

Олон улсын худалдааны эрх зүйн бусад эх сурвалж:

Далайд гарцгүй орны транзит худалдааны тухай Нью-Йоркийн конвенц 1965/1966. Олон улсын бараа худалдах, худалдан авах тухай Венийн конвенц 1980 /1997. Олон талын хөрөнгө оруулалтыг баталгаажуулах байгууллагын конвенц 1985/ 1997. Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Марракешийн хэлэлцээр 1994 /1997. Өнөөгийн байдлаар ДХБ-ын гишүүд худалдааг хөнгөвчлөх чиглэлээр 50 гаруй санал боловсруулан хэлэлцэж байгаагаас манай улс гаалийн брокер, худалдаатай холбоотой эрх зүйн баримт бичгийг урьдчилан хэвлэх, зөвлөлдөх, баримт бүрдүүлэлтийг

хялбарчлах, уялдуулах, олон улсын стандартыг хэрэглэх, мэдээллийг хэвлэн нийтлэх, нийтэд хүртээмжтэй болгох зэрэг асуудлаар найман санал боловсруулаад байна.

Дохагийн үе шатны хэлэлцээр амжилттай дуусвал хэлэлцээрийн "ширээнд" буй эдгээр саналуудыг нэгтгэсэн Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр байгуулагдах юм.

Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр байгуулагдсаны дараа хэлэлцээрийн заалтыг хэрэгжүүлэх үүднээс гишүүн орон бүр хэрэгжилтийн хугацаа бүхий үүрэг амлалтын нарийвчилсан жагсаалт гарган ДХБ-д мэдүүлж, тус байгууллага буюу гишүүн орнуудын өмнө үүрэг хүлээнэ.

Олон улсын худалдааны гэрээ /бараа худалдах, худалдан авах гэрээ/

Олон улсын худалдааны практикт өргөн хэрэглэгддэг гэрээний ерөнхий загвар нь[817]:

1.Гэрээний дугаар, он, сар, өдөр, гэрээг хаана хийж байгаа, гэрээг ямар талууд хийж байгаа талаар тусгана.

2.Гэрээний ерөнхий зүйл: энэ хэсэгт ямар барааг, хичнээн хэмжээтэй, ямар чанарын баталгаатайгаар, ямар хугацаанд нийлүүлэх талаар дурдана. Үүнийг хавсралтаар заасан байж болох ба энэ тохиолдолд тухайн хавсралт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болнохыг заана.

3.Нийлүүлэх нөхцөл, үнэ: гэрээний дагуу нийлүүлэх барааны нэг бүрийн үнийг, мөнгөний нэгжийг, нийт үнийн дүнг энд тусгана. Мөн үүний зэрэгцээ нийлүүлэх нөхцөлийг буюу инкотермсийн нөхцөлийг заана.

4.Барааны чанар ба баталгаа: худалдагчийн нийлүүлж байгаа бараа нь ямар стандарт, норм, норматив, баримт бичигт заасан үзүүлэлт, шаардлагад нийцэж байгааг, барааны чанар, аюулгүй байдлыг худалдагч тал хаанаас хаа хүртэл хариуцах, худалдан авагч тал хэрэв шаардлага хангаагүй бараа нийлүүлэгдвэл дутагдлыг хэрхэн баталгаажуулах, яаж шийдвэрлэх талаар энд тусгана.

5.Ачуулалт: гэрээний хавсралтад заасан хугацааг баримтлан нийлүүлэлтийг хийнэ. Бараа ачуулахад бэлэн болсон тухай мэдээллийг ямар хэрэгслээр хэрхэн мэдээлэх, ачуулснаас хойш хэд хоногийн дотор ямар мэдээллийн хэрэгслээр мэдээллийг дамжуулах зэрэг асуудлыг тусгана. Энд ачуулсан он, сар, өдөр, гэрээний дугаар, барааны нэр, баглааны тоо хэмжээ, цэвэр, бохир жин, вагоны дугаар гэх мэт мэдээллүүд багтана.

6.Төлбөрийн нөхцөл: төлбөрийг ямар нөхцөлөөр хийх, хэдий хугацаанд хийх, худалдагч төлбөрийн нэхэмжлэлийн хамт ямар баримтуудыг бүрдэл болгож өгөх зэргийг заана.

7.Баглаа, боодол, хаяглалт: бүтээгдэхүүнийг ямар баглаа боодолтой нийлүүлэх, баглаа бүрт хийгдэх хаяглалт /хүрэх станцын нэр, хүлээн авах хаяг, гэрээний дугаар, тоо хэмжээ, баглааны дугаар, болгоомжлох тэмдэг, бохир цэвэр жин, худалдагчийн хаяг/ зэргийг тусгана.

8.Гомдол: барааны талаарх гомдлыг худалдан авагч хэдийд яаж тавих, баталгаа нь юу байх, худалдагч гомдлыг хүлээж авснаас хойш хэдий хугацаанд даруй өгөх, хүлээн авсан тохиолдолд арга хэмжээ авна.

[817]С. Норжинсүрэн Гадаад худалдааны зохицуулалт УБ хот, 2008 он.

9.Баталгаа: аль нэг тал нь гэрээний үүргээ биелүүлж чадахгүйд хүрвэл хэрхэн мэдэгдэх, үүнтэй холбогдон гарах хариуцлагыг яаж тооцох, тээвэрлэлтийн явцад бараа дутагдсан бол яах, бараа хугацаандаа нийлүүлэгдээгүй бол хариуцлага яаж тооцох талаар заана.

10.Давагдашгүй хүчин зүйл: талууд өөрсдийн эрх ашгийн үүднээс ямар нөхцөл байдлыг давагдашгүй хүчин зүйлд оруулахыг урьдчилан тохирдог. Үер, газар хөдлөлт, хүчтэй салхи, гал түймэр зэрэг байгалийн гамшиг, экспорт, импортод тавих хориг, дайн, дайчилгаа гэх зэрэг гэнэтийн шалтгаануудыг давагдашгүй хүчин зүйлд хамруулдаг. Аль нэг талд нь давагдашгүй хүчин зүйл тохиолдвол эсрэг талдаа хэрхэн мэдэгдэх талаар тусгах ба гэрээгээр хүлээсэн эрх үүргээ хэрхэн шийдвэрлэх талаар тусгана.

11.Арбитр: аливаа маргаан, саналын зөрөлдөөн гарвал яаж шийдвэрлэх, ямар орны, ямар арбитрын шүүхээр асуудлыг шийдвэрлэх талаар тусгана.

12.Бусад нөхцөл: гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах бол яах вэ, ямар нөхцөлд гэрээг цуцлах, аль нэг тал нь өөрийн эрхээ гуравдагч этгээдэд шилжүүлэх бол яах вэ, гэрээ хүчин төгөлдөр байх хугацаа, гэрээг хэдэн хувь, ямар хэлээр үйлдсэн зэрэг асуудлыг тусгана.

Инкотермсийн нөхцөлийг олон улсын худалдааны гэрээ байгуулахад өргөнөөр ашигладаг. Инкотермс нь бараг нийлүүлэх болон барааны нийлүүлэлтийг хүлээн авах талуудын үүргийг тодорхойлж, худалдах, худалдан авах гэрээ байгуулах үйл ажиллагааг хөнгөвчилж, худалдагч, худалдан авагчдын дунд зардлыг хуваарилж, барааны үнийг тогтооход ач холбогдолтой. Инкотермсийн нөхцөлийг гэрээний нөхцөл болгон тусгаснаар эрх зүйн үндэстэй болдог. Инкотермс нь олон улсын худалдааны үндсэн суурь нөхцөлийг илэрхийлсэн нэр томъёоны тайлбар юм. Инкотермсийг олон улсын худалдааны танхимаас анх 1936 онд олон улсын худалдааны нэр томъёоны тайлбар нэртэйгээр 2 суурь нөхцөлтэйгээр боловсруулан гаргасан бөгөөд үүнээс хойш 1953, 1967, 1976, 1980, 1990, 2000 онуудад тус тус шинэчлэгдсэн.[818]

3. Дэлхийн худалдааны байгууллага ба Монгол Улс

Дэлхийн худалдааны байгууллага нь улс орнууд хоорондын худалдааны талаархи дүрэм, журмыг тогтоож баталдаг цорын ганц олон улсын байгууллага бөгөөд түүний үйл ажиллагааны үндэс нь олон улсын худалдаанд оролцогч дийлэнх улс орноос зөвшилцөж гарын үсэг зурсан хэлэлцээрүүд байдаг.

Эдгээр хэлэлцээр нь олон улсын арилжааны үйл ажиллагааг зохион байгуулах эрх зүйн бааз суурь болдог бөгөөд уг хэлэлцээрүүдийн дийлэнхийнх нь хүрээнд улс орнууд олон улсын стандарттай уялдуулан худалдааныхаа бодлогыг явуулахаар үүрэг хүлээсэн байдаг.

Хэдийгээр эдгээр хэлэлцээрийг засгийн газруудын түвшинд хэлэлцэж гарын үсэг зурдаг боловч тэдгээрийн үндсэн зорилго нь бараа, үйлчилгээ үзүүлдэг үйлдвэрлэгчид болон экспорт, импортын үйл ажиллагаа явуулдаг компаниудад дэмжлэг үзүүлэхэд оршдог билээ.

[818]С. Норжинсүрэн ИНКОТЕРМС УБ хот, 2008 он.

ДХБ-ын үндсэн чиг үүргийн талаар дурдвал:

1. Олон улсын худалдааны эрх зүйн хэм хэмжээг тогтооход дэмжлэг үзүүлэх:

➢ Олон улсын худалдааны асуудлаархи олон талт худалдааны яриа хэлэлцээрийн талбар болгох

➢ ДХБ-ын системийн олон улсын худалдааны гэрээ, хэлэлцээрийн талаар тайлбар өгөх

2. Олон улсын эрх зүйн хэм хэмжээг сахин мөрдөх:

➢ Олон улсын худалдааны салбарт улс хоорондын маргаан шийдвэрлэх механизмыг бий болгож, түүний хэвийн үйл ажиллагааг хангах

➢ Олон улсын худалдааны салбарт өөрийн үүргийн дагуу үүссэн нөхцөл байдлын улмаас ДХБ-ын гишүүнд хүлээлгэсэн үүргээс чөлөөлөх тухай шийдвэр гаргах

➢ Худалдааны бодлогыг хянан үзэх механизмын тусламжтайгаар ДХБ-ын системийн олон талт худалдааны хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт тавих гэх мэт чиг үүргийг хэрэгжүүлдэг.

"Олон талт" худалдааны тогтолцоо

ДХБ нь 1995 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн үйл ажиллагаагаа явуулсан боловч уг байгууллагын баталсан худалдааны харилцааг зохицуулдаг тогтолцоо нь 50 жилийн өмнө бий болжээ. 1948 онд Тариф, худалдааны тухай ерөнхий хэлэлцээрээр /ТХЕХ буюу ГАТТ/ худалдааг зохион байгуулах дүрэм, журмыг тогтоосон юм.

Үндсэн бүх экспортлогч болон импортлогч орнуудыг оролцуулаад дийлэнх улс орнууд энэ тогтолцооны гишүүн нь билээ. Гэхдээ зарим улс үүнд багтан ордоггүй учраас уг тогтолцоог "дэлхий нийтийн" буюу "глобаль" гэж нэрлэдэггүй, харин "олон талт" хэмээн нэрлэдэг байна. ДХБ-аас явуулж буй үйл ажиллагаатай уялдуулан авч үзэхэд, "олон талт" гэдэг үгийг бүсийн хэмжээнд буюу цөөн тооны хэсэг улс орны түвшинд явуулж буй ажиллагаанд сөргүүлэн тавих байдлаар хэрэглэж байгаа болно. Олон улсын харилцааны бусад салбарт "олон талт" гэсэн нэр томъёог ийм утгаар хэрэглэдэггүй. Жишээ нь, аюулгүй байдлын тухай "олон талт" хэлэлцээрийг бүсийн түвшинд байгуулж болдог[819].

ДХБ ба ГАТТ

ДХБ болон ТХЕХ нь хоорондоо салшгүй холбоотой шинжийг агуулж байдаг учраас энэхүү сэдвийг зайлшгүй хөндөх нь зүйтэй юм.

Тариф, худалдааны тухай ерөнхий хэлэлцээр /ТХЕХ буюу "ГАТТ"/ нь 2 чиг үүрэгтэй.

1.Олон улсын хэлэлцээр, өөрөөр хэлбэл, олон улсын худалдааны ажиллагааг хэрхэн зохион байгуулах талаарх дүрэм, журам бүхий баримт бичиг юм;

2. Хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх үүднээс сүүлд байгуулагдсан олон улсын байгууллага юм.

[819] Г. Сэсээр "*Дэлхийн худалдааны байгууллагын эрх зүйн зарим асуудал*". УБ., 2000 он.

Баримт бичиг нь хууль тогтоомжийн үүрэг гүйцэтгэж харин байгууллага нь нэгэн зэрэг гүйцэтгэх болон шүүхийн байгууллага болж ажиллаж байсан.

ГАТТ нь олон улсын байгууллагын хувьд одоо байдаггүй ба харин түүний оронд Дэлхийн худалдааны байгууллага бий болсон.

ДХБ болон ГАТТ хоорондын ялгааг дор дурдсан байдлаар харуулбал[820]:

➢ ГАТТ нь түр зуурын шинжтэй байсан бөгөөд тусгай зорилтууд хэрэгжүүлж байв. Ерөнхий хэлэлцээрийг гишүүн улсуудын парламентаас хэзээ ч соёрхон баталж байгаагүй ба уг баримт бичигт байгууллага байгуулах тухай заалт тусгагдаагүй юм. Харин ДХБ болон түүний хэлэлцээрүүд нь байнгын шинжтэй юм. Олон улсын байгууллага болохынхоо хувьд ДХБ нэлээд том эрх зүйн баазтай, учир нь ДХБ-ын хэлэлцээрүүдийг гишүүн орнууд соёрхон баталдаг бөгөөд тэдгээр хэлэлцээрүүдээр ДХБ-ын үйл ажиллагааг зохицуулдаг байна.

➢ ДХБ өөрийн гишүүдтэй. Харин ГАТТ хэлэлцээнд оролцогч талуудтай, энэ нь ГАТТ-ыг зөвхөн эрх зүйн баримт бичиг байсныг нотолж байгаа хэрэг юм.

➢ ГАТТ нь бараа худалдаалах асуудлыг хамарч байсан бол ДХБ нь үүнээс гадна мөн үйлчилгээ ба оюуны өмчтэй холбоотой асуудал эрхэлдэг.

➢ ДХБ-аас баталсан маргаан шийдвэрлэх ажиллагаа нь илүү өргөн хүрээтэй бөгөөд урьд өмнө үйлчилж байсан ГАТТ-ын ажиллагаанд зарцуулдгаас хавьгүй бага хугацаа зарцуулахыг шаарддаг.

Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр нь цаг ямагт бараа худалдаалах асуудлыг зохицуулж байсан бөгөөд одоо ч энэ чиг үүргээ гүйцэтгэсэн хэвээр байгаа билээ. ГАТТ-д нэмэлт оруулснаас гадна түүнийг ДХБ-ын шинэ хэлэлцээрүүдэд багтаан оруулсан байна. Шинэчлэн өөрчлөгдсөн ГАТТ нь одоо Үйлчилгээний худалдааны тухай ерөнхий хэлэлцөөр /ГАТС/ болон Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон асуудлын тухай /ТРИПС/ шинэ хэлэлцээрүүдтэй нэгэн адил үйлчилсэн хэвээр байгаа. ГАТТ нь олон улсын байгууллагынхаа хувьд оршин тогтнохоо больсон хэдий ч олон улсын хэлэлцээр болохынхоо хувьд үйлчилсэн хэвээр байна. Хэлэлцээрийн хуучин бичвэрийг одоо "ГАТТ-1947", харин шинэчлэгдсэн хувилбарыг нь "ГАТТ-1994" хэмээн нэрлэдэг.

Дээр дурдсанаас гадна, ГАТТ-ын үндсэн зарчмууд үйлчилгээ болон оюуны өмч худалдаалах тухай хэлэлцээрүүдийн үндэс нь болж өгсөн юм.

Дэлхийн худалдааны байгууллагын гол хэлэлцээрүүд

Дэлхийн худалдааны байгууллагын хэлэлцээрүүд нь дараах хэлэлцээрээс бүрдэнэ[821].

1. 1994 оны Тариф, худалдааны тухай ерөнхий хэлэлцээр /ГАТТ 1994/, уг хэлэлцээрт дараахь баримт бичгүүд багтан орно:

[820] Г. Сэсэгэр Дэлхийн худалдааны байгууллагын эрх зүйн зарим асуудал УБ хот, 2000 он.

[821] Олон талт худалдааны хэлэлцээний Уругвайн үе шатны дүнд байгуулагдсан эрх зүйн баримт бичгүүд

➢ 1947 оны Тариф, худалдааны тухай ерөнхий хэлэлцээр;

➢ 1994 оны Тариф, худалдааны тухай ерөнхий хэлэлцээрийн II-ын 1В зүйлийн тайлбартай холбогдсон тохиролцоо;

➢ 1994 оны Тариф, худалдааны тухай ерөнхий хэлэлцээрийн XYII зүйлийн тайлбартай холбогдсон тохиролцоо;

➢ 1994 оны Тариф, худалдааны тухай ерөнхий хэлэлцээрийн төлбөрийн тэнцвэрт хамааралтай зүйл, заалтуудтай холбогдсон тохиролцоо;

➢ 1994 оны Тариф, худалдааны тухай ерөнхий хэлэлцээрийн XXIY зүйлийн тайлбартай холбогдсон тохиролцоо;

➢ 1994 оны Тариф, худалдааны тухай ерөнхий хэлэлцээрийн хүрээнд үүргээс чөлөөлөгдөх талаархи тохиролцоо;

➢ 1994 оны Тариф, худалдааны тухай ерөнхий хэлэлцээрийн XXYIII зүйлийг тайлбарлахтай холбогдсон тохиролцоо;

➢ 1994 оны Тариф, худалдааны тухай ерөнхий хэлэлцээрийн Марракешийн протокол.

2.Дараах олон талт хэлэлцээрүүд:

➢ Барааны худалдааны тухай олон талт хэлэлцээр;

➢ Хөдөө аж ахуйн тухай хэлэлцээр;

➢ Эрүүл ахуй, ургамлын хорио цээрийн арга хэмжээ хэрэглэх тухай хэлэлцээр;

➢ Сүлжмэл эдлэл болон хувцасны тухай хэлэлцээр;

➢ Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээр;

➢ Худалдаатай холбогдсон хөрөнгө оруулалтын арга хэмжээний тухай хэлэлцээр;

➢ 1994 оны Тариф, худалдааны тухай ерөнхий хэлэлцээрийн YI зүйлийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр /демпингийн эсрэг/;

➢ 1994 оны Тариф, худалдааны тухай ерөнхий хэлэлцээрийн YII зүйлийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр;

➢ Ачилтын өмнөх хяналт шалгалтын тухай хэлэлцээр;

➢ Гарал үүслийн дүрмийн тухай хэлэлцээр;

➢ Импортын лицензийн журмын тухай хэлэлцээр;

➢ Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээр;

➢ Хамгаалалтын арга хэмжээний тухай хэлэлцээр.

3.Үйлчилгээний худалдааны тухай ерөнхий хэлэлцээр /ГАТС/;

4.Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон асуудлын тухай хэлэлцээр /ТРИПС/;

5.Маргаан шийдвэрлэх асуудлыг зохицуулах дүрэм, журмын тухай харилцан ойлголцох баримт бичиг;

6.Худалдааны бодлого хянах механизмын тухай хэлэлцээр;

7. Олон талт худалдааны дараахь хэлэлцээр:

➢ Иргэний агаарын тээврийн онгоц худалдах тухай хэлэлцээр;

➢ Засгийн газрын хангалтын тухай хэлэлцээр;

➢ Сүүн бүтээгдэхүүний тухай олон улсын хэлэлцээр;

➢ Үхрийн махны тухай олон улсын хэлэлцээр.

/Тайлбар: эдгээр 4 хэлэлцээрийг гагцхүү нэгдэн орсон улс орнууд дагаж мөрдөх үүрэг хүлээнэ/.

ДХБ-д Монгол Улс нэгдэн орох болсон шаардлага

Монгол Улс Үндсэн хуулийн 5 дугаар зүйлд " Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна" гэж заасан нь нэг ёсондоо эдийн засгийн хаалттай бүлэглэлээс татгалзаж, дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, глобалчлалын бодлогод тушиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндэс бүрдсэн билээ.

Монгол Улс эдийн засаг, эрх зүйн зохицуулалтын өвөрмөц онцлог бүхий хоёр их гүрний хооронд оршдог, газар зүйн байршлын хувьд Ази тивд байрладаг онцлогийг тэргүүн эзлжинд харгалзан үзэх нь зайлшгүй болсон юм. Үүний зэрэгцээ Монгол Улс далайд гарцгүй, дэлхийн зах зээлээс алслагдсан байдал нь бас нэгэн онцгой хүчин зүйл юм.

Хөрш хоёр оронтойгоо транзит худалдааны хэлэлцээр хийсэн боловч улс төр, эдийн засаг, эрх зүйн хүчин зүйлүүд нь олон улсын хамтын нийгэмлэгийн глобалчлалын бодлого, чиг хандлагын дагуу өөрийн бодлогыг тодорхойлох, жижиг орны хувьд олон улсын эрх зүйн баталгаатай хамгаалалтын замыг сонгож авахыг зүй ёсоор шаардаж эхэлсэн бөгөөд ийм хамгаалалтад орох гол хэрэгсэл нь Олон улсын томоохон байгууллагууд, тэдгээрийн ивээл доор байгуулагдан хэрэгжиж байгаа олон улсын үндсэн гэрээ хэлэлцээрт нэгдэж орох явдал юм.[822]

Ийнхүү ДХБ-д элсэх суурийг тавьж эхэлсэн бөгөөд ДХБ-д элссэнээр дараах асуудлуудыг шийдвэрлэж эхэлсэн байна. Тухайлбал:

- Монгол Улс 1990 оноос хойш олон улс оронтой худалдааны хэлэлцээрийг шинэ нөхцөл байдалд тулгуурлан байгуулсан бөгөөд хөрөнгө оруулалтыг хамгаалах, хөхиүлэн дэмжих, давхар татвараас чөлөөлөх, татвар төлөхөөс залсхийх явдалтай тэмцэх тухай хэлэлцээрүүдийг цоо шинээр байгуулж эхэлсэн.
- Өмчийн бүх хэлбэрийг Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаалах болсон
- Үнэ тогтоох тогтоолцооны хувьд зөвхөн зах зээлийн нөхцөлөөр тодорхойлогдох болсон
- Тарифын системийг шинэчлэн сайжруулах ажил нэгэнт эхэлж ихээхэн импортын барааны гаалийн татварыг 15 хувиар тогтоож, татвар ногдуулах, хураан авах, импортын барааны гаалийн үнийг тогтоох аргачлалыг олон улсын жишигт нийцүүлэх үйл ажиллагаа эхэлсэн.
- Монгол Улсын Иргэний хууль болон Гаалийн тухай хуульд оюуны өмчийн эрхийг хамгаалахтай холбоотой хэд хэдэн чухал заалт тусгагдсаны дээр Зохиогчийн эрхийн болон Патентийн хуулийг батлан гаргасан байна.

Монгол Улс ДХБ-д нэгдэн орохдоо авсан үүрэг амлалт

Монгол Улс ДХБ-д элсэх тухай Протоколд заасны дагуу Монгол Улс 1997 оны 1 дүгээр сарын 29-ний ДХБ-ын бүрэн эрхт гишүүн болсон.

ДХБ-ын Ажлын хэсгийн 1996 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн илтгэлд тусгагдсан түүний 61 дүгээр хэсэгт дурдсан үүрэг амлалтуудыг багтаасан

[822] Г. Сэсээр Дэлхийн худалдааны байгууллагын эрх зүйн зарим асуудал.УБ хот, 2000 он.

Протокол нь ДХБ-ын тухай хэлэлцээрийн салшгүй хэсэг юм. Монгол Улс дараах үүрэг амлалтыг авсан билээ[823]. Тухайлбал,

- ДХБ-ын шаардлагын дагуу үүрэг амлалтын жагсаалтад тусгагдсан импортын тарифаас өөр ямар нэгэн шинэ тариф нэвтрүүлэхгүй байх. Экспорт, импорттой холбоотой үйл ажиллагаа, үйлчилгээнд авах хөлс, хураамж нь зөвхөн тухайн үйлчилгээ, үйл ажиллагаанд тохирсон хэмжээнд байх тухай ТХЕХ-ийн 8 дугаар зүйлийг хэрэгжүүлэх. Нэгдэн орох тухай Протоколын дагуу Монгол Улсын Засгийн газар импортын гаалийн татварын тарифын хэмжээ болон үйлчилгээний салбараар авах үүрэг амлалтыг тохирсон юм. Энэхүү тохиролцооны дагуу импортын гаалийн татварын ерөнхий түвшин 20 хувь байх юм. Дотоодын үйлдвэрлэлээ дэмжих, зах зээлээ хамгаалах үүднээс оёмол, сүлжмэл бараа, нэхий савхин эдлэл, хивс зэрэг барааны импортын барааны тарифыг уе шаттайгаар бууруулах хөтөлбөрийг хүлээж авсан. Гишүүн орнуудаас импортлох, эдгээр оронд экспортлох бүтээгдэхүүнд "үндэсний нэн тааламжтай" буюу ердийхөөс хөнгөлөлттэй хувь хэмжээний тариф хэрэглэх тухай ТХЕХ-ийн 1 дүгээр зүйлийн дагуу барааны нэр төрлөөр /БТКУС-ийн ангиллын дагуу/ ялгавартай тогтоох талаар Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд тусгасан. Ялгавартай тариф нь дотоодын зах зээлийг хамгаалах, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, төлбөрийн тэнцлийг хангах зэрэг худалдааны бодлогыг тусган зохицуулах хууль ёсны арга хэрэгсэл болсон юм. Монгол Улс 1997 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 24 дүгээр тогтоол гаргаж импортын барааны гаалийн татварыг тэглэсэн бөгөөд энэ нь нилээдгүй алдаатай бодлого байсан ба энэ алдааг засах чиглэлээр УИХ-аас 1999 оны 7 дугаар сарын 1-нээс эхлэн импортын бараанд 5 хувийн гаалийн татвар тогтоосон юм.
- Дотоодын болон импортын бараанд ялгавартай татвар ногдуулахгүй байх. Татвар тооцоход хэрэглэж буй арга нь адил байх ёстой.
- Лицензид хамаарах химийн барааны нэр төрлийг цөөлөх талаас нь авч үзэх. Үүнтэй холбогдуулан УИХ-ын 1998 оны 5 дугаар тогтоол болон Засгийн газрын 214 дүгээр тогтоолуудыг тус тус батлан гаргаж мөрдөж байна.
- Монгол Улсын Засгийн газар ДХБ-д элссэн өдрөөс эхлэн экспорт, импорт болон лицензтэй барааны худалдааг түр хориглох асуудлыг ДХБ-ын шаардлагын дагуу тухайлбал ТХЕХ 1994-ийн 6, 10, 18, 20, 21 дүгээрзүйлболонбусадхэлэлцээр,тохиролцооны дагуузохицуулахын зэрэгцээ ДХБ-ын заалтуудаар тусгайлан зөвшөөрөгдөөгүй тоо хэмжээний хязгаарлалт, зөвшөөрөл, лицензэрэг тарифын бус арга хэмжээг хэрэгжүүлэхгүй байна . Техникийн журам, чанарын баталгаа, стандарт, сертификат, баглаа боодлын шаардлагын хяналт, журам нь

[823] Г. Сэсээр Дэлхийн худалдааны байгууллагын эрх зүйн зарим асуудал УБ-2000 он, МУ-ын ГЕГ-ын дэргэдэх ГЭЗДС. ДЭЛХИЙН ХУДАЛДААНЫ БАЙГУУЛЛАГА-олон улсын худалдаа, эдийн засгийн харилцааны эрх зүйн үндэс болох нь. УБ хот, 2010 он.

импортын болон дотоодын бараанд адил ба импортыг хязгаарлахад тэдгээрийг хэрэглэхгүй. Баталгаажуулалт, үзүүлэлт нь ил тод байх ба тэдгээр нь худалдаанд хэрхэн нөлөөлж буй талаар ДХБ-ын гишүүн орнуудтай зөвлөлдөнө.

- Монгол Улс ДХБ-д элссэн өдрөөс эхлэн импортын лицензийн хүчинтэй байх хугацааг нэг жил болгож сунгана.
- Шилжилтийн үед худалдаа, эдийн засагт гарч буй өөрчлөлтийн талаар ДХБ-д ил тод мэдээлж байх, хувьчлалын хөтөлбөр болон ДХБ-ын өмнө хүлээсэн үүргийн биелэлтийг ДХБ-д 2 жил тутам мэдээлнэ.
- Худалдаатай холбоотой аливаа хууль, журам, тогтоолыг хэрэгжүүлж эхлэхээс өмнө тэдгээртэй танилцах боломж олгох үүднээс тер, засгийн газрын төв хэвлэлд нийтлэх. Нийтлэхээс өмнө тэдгээр нь хүчин төгөлдөр болохгүй байх.
- Монгол Улс ТХЕХ 1994-ийн 7 дугаар зүйлд заасан шилжилтийн хугацааг хэрэглэхгүй бөгөөд ачилтын өмнөх хяналт шалгалтыг ДХБ-ын холбогдох хэлэлцээрийн дагуу гүйцэтгэнэ.
- Гаалийн ажиллагаа, бүрдүүлэлтийг ТХЕХ 1994-ийн 7,8,10 дугаар заалтуудад нийцүүлэн хийнэ.
- Худалдааны хэлэлцээрүүдийг байгуулахдаа ТХЕХ 1994-ийн 24 дүгээр зүйл, Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрийн 5 дугаар зүйлийг мөрдөх ба худалдааны хөнгөлөлт үзүүлсэн аливаа хэлэлцээрийг ДХБ-д мэдэгдэж байна.
- Монгол Улсын Засгийн газар ДХБ-ын 1А хавсралт дахь олон талт худалдааны хэлэлцээрийг ДХБ-д элссэн өдрөөс эхлэн мөрдөнө.
- Чөлөөт бүсийн талаар авах арга хэмжээний тухай ДХБ-ын гишүүн орнуудад мэдээлхийн хамт тус байгууллагаас энэ асуудлаар баримтлах чиглэл журмыг зөрчихгүй байх.
- Чөлөөт бүс байгуулсан тохиолдолд уг бүсээс Монголын бусад нутаг дэвсгэрт худалдаалагдах импортын бараа, эсхүл импортын бүтээгдэхүүн оролцсон бараанд татвар, тариф, гаалийн хураамжийн ердийн хэмжээг хэрэглэх бөгөөд чөлөөт бүсэд фирмүүд байгуулахад олгох хөнгөлөлтийг ДХБ-ын Татаас болон нөхөн тэгшитгэх арга хэмжээний тухай хэлэлцээрт нийцүүлэх.
- Монгол Улс ДХБ-д элссэн өдрөөс Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбоотой асуудлын тухай хэлэлцэрийг бүрэн биелүүлэх гэх мэт 20 төрлийн үүрэг амлалтыг авсан билээ.

Монгол Улс ДХБ-д элссэнээс хойш үүрэг амлалтаа биелүүлэх талаар багагүй хүчин чармайлт гаргасан нь тодорхой бөгөөд үүний үр дүнд худалдаа, эдийн засагийг чөлөөтэй, нээлттэй болгох, чөлөөт өрсөлдөөний орчныг бүрдүүлэх, тарифын бус хориг, хязгаарлалтыг багасгаж тарифчлах үйл ажиллагаа эрчимтэй хийгдсэн.

Монгол Улсын хувьд цаашид анхаарах зүйл

Монгол Улс нь ДХБ-тай хамтран ажиллахдаа дараах зүйлсд анхаарлаа хандуулах хэрэгтэй байгаа юм.

- Экспортыг хөгжүүлэх

Монгол Улс нь ДХБ-ын гишүүнийхээ хууль ёсны эрх, давуу байдлаа бүрэн ашиглахын тулд экспортыг дэмжсэн бодлого явуулах шаардлагатай. ДХБ эрх зүйн хувьд гадаадын зах зээл дээр гарах боломжийг олгодог боловч хөгжиж буй орнуудын хувьд багагүй бэрхшээлтэй тулгардаг. Өөрөөр хэлбэл хөгжилтэй орнуудын зах зээл дээрх барааны стандартад зайлшгүй нийцэж байж гадаад зах зээл дээр гарах болдог. БНСУ болон Зүүн өмнөд Азийн зарим орны туршлагаас үзэхэд "гарааны тэнцүү нөхцөл" нь үндэсний үйлдвэрлэгчдэд ихээхэн ач холбогдолтой байсан байна.[824] Гэтэл Монголын дотоод, гадаад зах зээл дээр гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид үндэсний аж ахуйн нэгжүүдтэй харьцуулахад өрсөлдөх давуу боломжийг олгосон байдаг. Монголын татварын болон гаалийн тарифын тухай хуулиудаар гадаадын хөрөнгө оруулалттай үйлдвэрүүдийг татвар, тарифаас тодорхой хугацаагаар чөлөөлсөн байдаг. Иймд Монголын экспортлогчидыг гадаад зах зээл дээр өрсөлдөх гарааны тэнцүү нөхцөлөөр хангах зайлшгүй шаардлагатай байгаа юм.

- Маргаан шийдвэрлэх механизмыг ашиглах

Энэ асуудлын хүрээнд маргаан шийдвэрлэх үйл явцад мэргэжлийн түвшинд оролцож чадах мэргэшсэн хуульчдыг бэлтгэх хэрэгтэй байна.

- ДХБ-ын үйл ажиллагаанд идэвхитэй оролцох

ДХБ нь нэг талаас манай орны хувьд ихээхэн ач холбогдолтой байгууллага, нөгөө талаас бид гишүүнчлэлийн өндөр хураамж төлдөг учраас гишүүн орны хувьд идэвхитэй оролцоотой байж үр шимийг нь хүртэх хэрэгтэй юм.

ГУРАВ. ШҮҮХ ЭРХ МЭДЭЛ ДЭХ ОЛОН УЛСЫН ХУДАЛДААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

1.Олон улсын арилжааны арбитр

Улс бүр өөрийн нутаг дэвсгэрийн хүрээнд арбитрын үйл ажиллагааг зохицуулах хуулийг тогтоодог. Монгол Улсын 2003 оны Арбитрын тухай хууль нь ЮНСИТРАЛ-ийн загвар хууль дээр үндэслэгдсэн байдаг.

Арбитраар маргаан шийдвэрлэх арга нь:

1.Маргаан шийдвэрлэлтийн нэгдсэн нэг хэв маягт ороогүй

2.Талууд тохиролцсон бол гадаад, дотоодын эрх зүйн хил хязгаарыг харгалзахгүйгээр хэрэглэх боломжтой.

3.Олон улсын хувийн эрх зүйн хэв маягт тогтмол харяьалагддаггүй зэрэг шинж чанартай байдаг.

Арбитрын үйл ажиллагаатай холбоотой дараах эх сурвалжууд байдаг.

Үүнд:

1.Хоёр талын хөрөнгө оруулалтын гэрээ

Улс орнууд өөр хоорондоо худалдаа, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаа явуулахдаа нөгөө талын ашиг сонирхолын дагуу тодорхой нөхцөлийг санал болгож, маргаан гарсан тохиолдолд арбитрын журмаар шийдвэрлүүлэхээр тохиролцож болдог. Сүүлийн жилүүдэд хоёр талын

[824] Г. Доёд Монголын экспортын өнөөгийн байдал, эрчимжүүлэх арга зам 29-32 дахь тал

хөрөнгө оруулалтын гэрээний тоо нилээд өсч байна. Аль нэг тал болох улс урьд нь тохиролцоогүй байсан ч маргаан гарсан үед биш маргаан гарахаас өмнө арбитрт хандах хэлэлцээрийн тухай санал гаргахад хөрөнгө оруулагч тухайн саналыг хүлээн аваад "Арбитрын хэлэлцээр" байгуулж болно.[825]

2."Арбитрын хэлэлцээрийн тухай" 1923 оны.Женевийн конвенц

Энэхүү конвенц нь хоёр үндсэн зорилготой. Гол зорилго нь арбитрын хэлэлцээрүүд олон улсын хэмжээнд хэрэгжих боломжтой, арбитрын хэлэлцээрийн аль ч тал маргаан гарсан тохиолдолд маргаанаа шийдвэрлүүлэхийн тулд шүүхээс илүү арбитрт хандхыг баталгаажуулсан явдал юм. Мөн арбитрын хэлэлцээр байгуулсан нутаг дэвсгэрт хэрэгжиж, хүчин төгөлдөр шийдвэр болохыг батлах асуудал нь энэ конвенцийн бас нэг зорилго нь юм.

3."Гадаадын арбитрын шийдвэрийг биелүүлэх тухай" 1927 оны Женевийн конвенц

1927 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр Женевт гадаад улсын арбитрын шийдвэрийн хэргжилттэй холбоотойгоор Үндэстнүүдийн холбооны дэмжлэгтэйгээр уг конвенц батлагдсан. Энэхүү конвенцийн гол зорилго нь гэрээний талуудын газар нутагт конвенцийг хэрэгжүүлж хүлээн зөвшөөрүүлэхийн тулд зохицуулалт хийсэн. Өөрөөр хэлбэл арбитрын хэлэлцээр, арбитрын шийдвэрийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх замд эхний алхам хийсэн ба үүнтэй холбоотойгоор үндэсний шүүхийн ороолцооны асуудлыг анх удаа зохицуулж өгсөн байна.

4."Гадаадын арбитрын шийдвэрийг биелүүлэх тухай" 1958 оны Нью-Йоркийн конвенц.

5.Олон улсын эрүүгийн шүүх 1953 онд олон улсын худалдааны арбитрыг зохицуулах шинэ гэрээг санаачилсан. Олон улсын эрүүгийн шүүхийн саналыг НҮБ-ын эдийн засаг нийгмийн зөвлөл хүлээн зөвшөөрч, үүний үр дүнд 1958 онд Нью-Йоркийн конвенц батлагдсан байна. Энэхүү конвенц нь арбитрт холбогдох хамгийн чухал гэрээ юм. Нью-Йоркийн конвенц нь 1927 оны Женевийн конвенцийн сайжруулсан загвар болж улмаар уг конвенцийн талуудыг дахин гишүүнчилж, хоёр конвенцийн аль алины талууд болох улс орнуудын хооронд гадаад арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, хэрэгжилтийг хангах илүү энгийн, сайн аргыг агуулсан зохицуулалт болсон. Тухайлбал, уг конвенцийн 2 дугаар зүйлийн 3-т конвенцид нэгдэн орсон шүүхэд ирсэн маргаан арбитрын хэлэлцээртэй байвал түүнийг хүлээн авч шийдвэрлэхээс татгалзаж болох талаар заажээ.

Нью-Йоркийн конвенц орчин үеийн олон улсын худалдааны арбитрын үндсэн шинжийг анх гаргасан байна. Үүнээс хойш ямар ч конвенц арбитрын асуудлыг нарийвчлан тусгаж өгч чадаагүй. Европ дахь НҮБ-ын Эдийн засгийн хорооны Худалдааны хөгжлийн хорооны дэмжлэгээр Женевт 1961 онд Европын конвенци батлагдсан. Энэхүү конвенц Европын болон өөр улсуудын хооронд худалдааны маргааныг шийдвэрлэх олон улсын арбитрын ажиллагаанд хэрэглэх зохицуулалтыг агуулсан байна. Уг конвенци нь үндэсний шүүх болон олон улсын арилжааны арбитрын харилцан уялдааны талаар талуудын харилцан тохиролцон байгуулсан

[825] Олон улсын арилжааны арбитр –УБ хот, 2008 он.

арбитрын хэлэлцээр байгаа тохиолдолд шүүх тухайн маргааныг хэлэлцэхээс татгалзах үүрэгтэй гэсэн үндсэн зэрчмыг агуулсан байдаг. Конвенц нь өөрөө бүс нутгийн шинж чанартай учраас түгээмэл хэрэглэх боломжгүй байдаг. Олон улсын арилжааны практикт НҮБ-ын хүрээнд дараах баримт бичгүүд боловсруулагдсан байна. Үүнд:

- НҮБ-ын Европын Эдийн засгийн комиссын 1966 оны Европын Арбитрын Дүрэм
- НҮБ-ын Ази болон Алс дорнодын эдийн засгийн комиссын 1966 оны Арбитрын Дүрэм
- ЮНСИТРАЛ-ын 1976 оны Арбитрын Дүрэм
- ЮНСИТРАЛ-ын 1985 оны Олон Улсын Арилжааны Арбитрын Дүрэм

Орчин үед бизнес, худалдааны эрх зүй хөгжсөн ихэнх орнуудад иргэний эрх зүйн маргааныг олон улсын арбитраар шийдвэрлүүлэх нь түгээмэл болсон. Хүн төрөлхтөн худалдаа, наймаа хийж эхэлсэн үеэс л арбитр түүнтэй төстэй арга хэрэгслийг бий болгон ашиглаж байсан баримт байдаг байна. Худалдаа арилжаанд гарсан маргаанаа тухайн нөхцөл байдалдаа нийцүүлэн хамгийн итгэлтэй хүнээрээ шийдүүлдэг байсан тэр үеийн худалдаачдын уламжлал өнөө үед олон улсын арбитрын үйл ажиллагаа агуулга, зарчмын хувьд бараг өөрчлөгдсөнгүй хэрэглэгдсээр байна.

Арбитрын маргаан шийдвэрлэдэг гол үзэл санаа нь маш энгийн ойлгомжтой ухагдахуунаар илэрхийлэгддэг. Эрт үеэс арбитрын буюу гуравдагч этгээдийн оролцоотойгоор маргаан шийдвэрлэдэг байсан практик байсан. Хоёр худалдаачин үнэ, чанартай холбоотой маргааныг шийдвэрлүүлэх зорилгоор хэн хэн нь сайн мэддэг, итгэдэг гуравдагч этгээдэд хандах эсхүл гэмтсэн бараанаас үүсэн маргаанаа шийдвэрлүүлэхийн тулд тэдгээрийн нэгэн адил худалдаа эрхэлдэг хүнд шүүх эрх олгож түүгээр шийдвэрлүүлдэг байсан байна[826].

Өнөө үед талуудын өмнөөс сонгосон нэг буюу түүнээс дээш тоотой бүрэлдэхүүн хэргийг хянан шийдвэрлэж, шийдвэр гаргадаг. Арбитрын хурал нь өөрөөр тохиролцоогүй бол талуудын тайлбарыг сонссоны дараа шийдвэр гаргадаг ба шүүх хурлын шийдвэрийг бичгээр гаргах бөгөөд шийдвэр гаргах болсон шалтгаан, шийдвэрийн үндэслэлийг тайлбарласан байна. Шийдвэрийг хууль зүйн тодорхой үндэслэлтэйгээр маргааныг таслах хэлбэрээр гаргана. Хэрэв шийдвэрийг сайн дураар биелүүлэхээс татгалзвал түүнийг шүүхийн шийдвэр биелүүлэх арга хэрэгслээр гүйцэтгэнэ.

Арбитрын онцлог шинж чанар:

- Арбитрын хэлэлцээрийн үндсэн дээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулдаг;
- Арбитрч сонгодог;
- Арбитрын шийдвэр нь эцийн бөгөөд заавал биелэгдэх;
- Шийдвэрийг албагдлага хэрэглэн биелүүлэх боломжтой.

Арбитрын ажиллагааны ач холбогдол

Гэрээт талууд хоорондын маргааныг арбитраар шийдвэрлүүлэхээр харилцан зөвшилцсөн байх нь хамгийн чухал юм. Арбитраар хэрэг

[826] МҮХАҮТ-ын дэргэдэх МҮА "Олон улсын арилжааны арбитр". УБ., 2009 он.

маргаанаа шийдвэрлүүлэхээр харилцан зөвшөлцөөгүй тохиолдолд арбитр хэрэг хэлэлцэх боломжгүй. Хэрэг маргаанаа шийдвэрлүүлэхэд арбитрыг дараах хоёр шалтгааны улмаас сонгодог байна. Үүнд:

1.Арбитр нь талуудад төвийг сахисан хэлэлцүүлэг болон төвийг сахисан арбитрын шүүхийг сонгох таатай боломж олгодог.

2.Арбитрын шийдвэр нь зөвхөн шийдвэр гаргасан газар биш Нью-Йоркийн конвенц дээр тулгуурлан олон улсад хэрэгжиж байдаг.

Олон улсын арилжааны гэрээний талууд ихэнхдээ өөр улсад харьяалагдах нь бий. Нэг талын дотоодын шүүх нь нөгөө талдаа гадаадынх байдаг. Гадаадын гэсэн утгаараа уг шүүх нь өөрийн гэсэн журамтай, олон улсын маргааныг шийдэхэд өөрийн гэсэн хэлтэй, энэ нь гэрээний хэл биш байж болох бөгөөд өөрийн шүүгч, өмгөөлөгчтэй байна. Арбитраар хэргээ шийдвэрлүүлэх тухайгаа гэрээндээ тусгаагүй тал нь маргаан үүссэн тохиолдолд гадаадын шүүхэд хандан ийм хэрэг дээр ажиллаж заншаагүй бол өмгөөлөгч хөлслөх, гэрээ болон холбогдох баримтыг цаг, мөнгө гарздан орчуулах хэрэг гарах юм. Арбитрыг сонгосноор маргааныг аливаа нэг талын биш төвийг сахисан мэтгэлцээн маягаар шийдэж болдог. Үүнийг олон улсын арилжааны маргаантай холбон авч үзэхэд их чухал юм.

Арбитрын ажиллагаа дуусах үед "талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд" арбитраас гарах шийдвэр нь эцсийн байна.

1.Арбитрын процессын эцсийн дүн нь хариуцлага хүлээлгэх шийдвэр байна.

2.Энэхүү шийдвэр нь эцсийн шийдвэр байх бөгөөд шүүхийн шийдвэртэй адил давж заалдах ажиллагаа явагддагүйгээрээ онцлог

3.Шийдвэр гүйцэтгэл нь дотоодын болон олон улсын түвшинд гүйцэтгэгдэж болдог.

ЮНСИТРАЛ-ийн дүрэмд зааснаар: "Хэрэв талууд шийдвэр гаргахаас өмнө эвлэрхээр тохиролцсон тохиолдолд арбитр нь арбитрын ажиллагааг зогсоох шийдвэр гаргах буюу талуудын хүсэлтийн дагуу шийдвэрээр зөвшөөрөгдсөн нөхцөлд хэлэлцээрээр тохиролцсон болзлууд дээр арбитрын шийдвэр гаргаж болно. Үүнийг арбитр тайлбарлах албагүй. Хэдий тийм боловч талууд маргаанаа шийдэж чадахгүй байгаа тохиолдолд маргааныг шийдвэр гарган зохицуулах нь арбитрын үүрэг юм. Энэхүү шийдвэрийг бичгээр гаргана. Арбитрт шүүхийн байгууллагын онцгой бүрэн эрх болон эрх ямба байхгүй боловч талууд нь арбитрт хариуцлага хүлээлгэх шийдвэр гаргах эрх мэдэл олгож, үүрэг даалгасан нь арбитрыг дотоодын шүүхтэй нэн төстэй болгожээ. Арбитрын шүүх нь талуудтай шударгаар харилцах, мөн талуудад өөрийн асуудлаа танилцуулах болон эсрэг талын хэрэгтэй танилцан хариу өгөх боломж олгох үүрэгтэй.

Олон улсын худалдааны арбитрт "олон улсын" гэдэг нэр томьёог тодорхойлох зорилгоор хоёр шалгуурыг хэрэглэдэг байна. Үүнд:

➢ Маргааны мөн чанарт дүн шинжилгээ хийхийг шаардаг, өөрөөр хэлбэл тухайн арбитр нь олон улсын худалдааны ашиг сонирхолыг агуулсан байвал түүнийг олон улсын гэж үзнэ.

➢ Талуудын харьяалал буюу байнгын хаягийг, аль эсхүл холбогдох нутаг дэвсгэрийнх нь харьяаллыг тухайн тал нь нэгдсэн аж ахуйн нэгж мөн анхаардаг.

Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд учирч буй бэрхшээлүүд

Арбитрын талаарх судлагаануудыг үзэхэд хамгийн их бэрхшээлтэй зүйл дотор зардал, арбитрын хязгаарлагдмал эрх мэдэл, олон талын маргааныг нэг арбитр шийдвэрлэх чадваргүй байдал болон маргаантай арбитрын шийдвэрүүд багтдаг байна.

Зардал: Арбитрын хөлс болон зардал нь талуудаас гарна. Энэ зардал нь бүх төрлийн олон улсын арилжааны арбитрт, тэрхүү зардал нь маргаанд яригдаж буй мөнгөний тоотой холбогдуулсан үнэлэгдсэн бол чухал ач холбогдолтой. Олон улсын арилжааны арбититрын зардал нь шүүх ажиллагаанаас хямдхан байх магадлал тун бага. Арбитр нь "нэг цэгийн үйлчилгээ"-ний хэлбэр гэсэн үг. Үүний зардал нь эцсийн байдаг тул шат шатны шүүхэд төлбөр төлж цаг хугацаа их зарцуулахтай харьцуулахад бага байж болно.

Арбитрын хязгаарлагдмал байдал: Арбитрын шүүхийн дотоодын хуулийн зохицуулалтаас хамаарна. Заримдаа арбитрч нь шүүгчид олгогдсоноос давуу эрх эдлэх талтай байдаг. Жишээ нь, арбитрч худалдааны зан заншлын хэм хэмжээг хэрэглэх эрхтэй. Хаана энэ зарчим хэрэгжиж байна тэнд арбитр бизнесменүүдийн хүсэл сонирхолыг өөртөө бий болгоно. Ерөнхийдөө арбитрчидад олгосон эрх мэдэл нь маргааныг шийдвэрлэхэд хангалттай боловч, нотлох баримт гаргуулах эд хөрөнгө битүүмжлэх зэрэгт энэ эрх мэдэл нь хүрэлцдэггүй юм. Жишээ нь гэрчийг мөнгөн торгуул буюу хорих шийтгэл ноогдуулан шүүхэд ирэхийг шаардах, шийдвэр гүйцэтгэлийг банкны данснаас суутгах эсхүл хөрөнгийг барьцаанд авах эрх мэдэл нь төрийн бүрэн эрхэд хамаарна. Практик дээр арбитр нь албадлагын арга хэмжээ авах шаардлага гарсан тохиолдолд дайвар аргаар тухайлбал дотоодын шүүхээр дамжин хийгддэг[627].

Арбитрын төрөл

Байнгын арбитр нь талууд өөрсдөө зөвшөөрсөн, эсхүл арбитрын шүүхээр тогтоосон журмаар байгуулагддаг. Талууд өөрсөддөө зориулж хэрэг хянан шийдвэрлэх хуулиа сонгох нь чөлөөтэй бөгөөд тэрхүү хууль нь талуудад тэгш үйлчилнэ, тэд үүнийгээ өөрт ашигтайгаар хэрэглэж болно.

Давуу тал: Дүрэм журмыг шууд хэрэглэж болдог нь байнгын арбитрын нэг давуу тал юм. Талуудын аль нэг нь үүргээ биелүүлэхгүй байх тохиолдол гарвал арбитрын ажиллагааг үргэлжлүүлэн явуулж болох нөхцөлийг заасан байдаг. Олон Улсын Худалдааны Танхимын дүрэмд жишээлбэл: "Хэрэв талууд хэдийгээр зарлан дуудсан ч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирэхээс татгалзвал арбитр хурлаар хэргийг авч хэлэлцэх эрх хэмжээтэй байх ёстой" гэсэн байдаг. Үүргээ биелүүлэхгүй тохиолдолд иймэрхүү дүрэм журам нилээд шударга юм. Өөр чухал давуу тал нь арбитрын удирдлага мэргэшсэн албан хаагчидтай байдаг. Арбитрт урьдчилгаа хөлс төлдөг. Энэ нь ерөнхийдөө

[627] МҮХАҮТ-ын дэргэдэх МҮА Олон улсын арилжааны арбитр УБ хот, 2009 он.

арбитрын ажиллагаа саадгүй жигд явгдах баталгаа болно.

Сул тал: Зарим арбитрын дүрмийн дагуу талууд арбитрын болон харьяалах байгууллагын төлбөр гэж арбитрын төлбөрт урьдчилан тогтосон хөлс төлдөг. Нөгөө талаас арбитрт тогтсон хөлс төлөх нь талууд өөрийн талд агшигтайгаар ажиллуулж болох талтай. Өөр нэг сул тал нь арбитрын ажиллагааны тодорхой үе шатуудыг тодорхой шаардлагын улмаас хугацаа хойшлуулах явдал болно. Гомдол гаргагчийн хувьд хэргийн холбогдолтой нотлох баримтыг бэлтгэж хариуцагчид болон арбитрын байгууллагад хүлээлгэн өгөхөд уг тогтоосон хугацаа нь хангалтгүй байдаг. Заримдаа хугацааг сунгахыг зөвшөөрч болох боловч хариуцагч хэргийг эхнээс нь сунгах хүсэлтийг тавих нь нилээн чирэгдэлтэй байдаг.

Байнгын бус арбитрын давуу болон сул тал: Байнгын бус арбитрын давуу тал нь талуудын хүсэлээр болон онцгой маргааны тохиолдолд хоорондоо уулзаж мэтгэлцэн маргаан шийдвэрлэлтэнд нөлөөлж болдог явдал юм. Шийдвэрлэх ажиллагааг илүү идэвхтэй, үр нөлөөтэй болгохын тулд талууд болон өмгөөлөгчийн хамтын ажиллагаа хэрэгтэй. Гэхдээ байнгын бус арбитрт зориулж тусгай дүрэм журам боловсруулахад цаг хугацаа зарцуулдаг. Байнгын бус арбитрын сул тал нь талууд болон тэдгээрийн хуульчдын хоорондын бүрэн идэвхитэй хамтын ажиллагаанд тулгуурладаг. Байнгын бус арбитрыг зөвхөн арбитр оршин байгаа тохиолдолд л дүрэмд нийцүүлэн байгуулдаг.

Арбитрын байгууллагад арилжааны маргаанд хэрэглэдэг арбитр, зуучлал, эвлэрүүлэх гэсэн 3 үндсэн арга байдаг. Арбитр нь хамгийн их хэрэглэгддэг арга юм. Үүнд дараах үндсэн шалтгаанууд байдаг.

- Арбитрын ажиллагаа нь уян хатан байдаг;
- Талуудын хяналт;
- Төвийг сахисан байдал;
- Зардлын үр дүнтэй удирдлага;
- Богино хугацаанд эцэслэн шийддэг;
- Шийдвэрийн биелэлт;
- Олон улсын хэмжээнд арбитрыг хүлээн зөвшөөрдөг болсон.

2003 онд Арбитрын тухай Монгол Улсын хууль батлагдсанаар Арбитрын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1-д "Арбитр нь байнгын болон түр хэлбэртэй байна" гэж заасан нь Монгол Улсад байнгын болон түр арбитрыг хүлээн зөвшөөрөх арбитрын сонголтот хэлбэрүүд хөгжих эрх зүйн орчинг бүрдүүлсэн юм.

Байнгын арбитрыг дотор нь:

- Арбитрын институт;
- Арбитрын шүүх;
- Арбитрын төв;
- Арбитрын холбоо;
- Бусад /комисс, сан, удирдах газар/ зэрэг удирдлагын онцлог гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны төрөл, цар хүрээгээр нь ангилан авч үзэж болно.

Арбитрын институт гэж өөрийн арбитрын дүрмийн дагуу маргаанд арбитрын ажиллагааг байнга эрхлэн явуулдаг, арбитр болон маргаан

шийдвэрлэх сонголтот аргуудаар сургалт судалгаа тогтмол явуулдаг байгууллагыг ойлгоно.

Арбитрын төв гэж тусгайлсан нэг төрлийн маргааанд эсхүл маргаан шийдвэрлэх арбитр болон альтернатив аргаар илүү дагнан ажиллагаа явуулдаг.

Арбитрын холбоо нь илүү холимог шинжийг агуулдаг, маргаан шийдвэрлэхээс гадна боловсрол, сургалт, олон нийтийн үйлчилгээг үзүүлдэг удирдлага, бүтэц зохион байгуулалтын хувьд онцлогтой байгууллаг юм.

Ерөнхийдөө байнгын арбитр нь өөрийн дүрэмд заагдсан хэмжээнд арбитрын ажиллагааг удирдах, арбитрын бүрэлдэхүүнийг байгуулах, томилох зэрэг талуудад шаардлагатай зүйлүүд дээр хэсэгчилсэн болон хязгаартай дэмжлэг үзүүлдэг. Мөн байнгын арбитрын хэсэгчилсэн болон бүрэн удирдлага зохион байгуулалттай гэж ангилж болно. Ихэнхи арбитрууд маргааанд арбитр, зуучлал, эвлэрүүлэх ажиллагаа аль алиныг нь явуулдаг. Энэ талуудад маргаанаа шийдвэрлэхэд нь сонголт хийх өргөн боломжмйг олгож өгдөг. Зарим байнгын арбитр нь зөвхөн эвлэрүүлэх ажиллагаа явуулдаг. Эвлэрүүлэх ажиллагаа нь ерөнхийдөө дараах хэлбэртэй.

- Түр арбитрын эвлэрүүлэх ажиллагаа
- Байнгын арбитрын эвлэрүүлэх ажиллагаа

Түр арбитрын эвлэрүүлэх ажиллагаа нь байнгын арбитрын ямар нэг туслалцаагүйгээр талууд өөрсдөө эвлэрүүлэх ажиллагааг удирдах энгийн ажиллагаа юм. Байнгын арбитрын эвлэрүүлэх ажиллагаа нь байнгын арбитр эсхүл эвлэрүүлэх ажиллагаагаар мэргэшсэн төвөөс ажиллагааг удирдан зохион байгуулдаг ба ерөнхийдөө арбитрын ажиллагааны процедурын дагуу явагдана.

Зуучлалын хувьд мөн ялгаагүй түр арбитрын зуучлалын ажиллагаа, байнгын арбитрын зуучлалын ажиллагаа гэж байна.

Арбитрт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дараахь процессын дагуу явуулна.

- Арбитрт нэхэмжлэл хүлээн авах арбитрын ажиллагаанд бэлтгэх
- Хугацаа тогтоох болон түүнд хяналт тавих
- Арбитрчийг татгалзах нөхөн томилох асуудлыг шийдэх
- Маргааны харьяалал тогтоох
- Талуудын эзгүйд ажиллагааг хянах, арбитрын бичиг баримтыг явуулах, гардуулах
- Арбитрын ажиллагааны журмыг тодорхойлох
- Арбитрын ажиллагааны зардлыг тооцох
- Мэргэшсэн албан хаагчдын дэмжлэг, арбитрын хуралдаанд бэлтгэх
- Арбитрын шийдвэрийг нарийн шалгах

Байнгын арбитрын маргааны харьяалал:

1. Дотоод /domestic/-талууд хоёулаа дотоодын иргэн, хуулийн этгээд байна.
2. Олон улсын /international/-аль нэг тал нь гадаадын иргэн, хуулийн этгээд эсхүл талууд хоёулаа гадаадын иргэн, хуулийн этгээд байна.

- Internal-дотоодын иргэн, хуулийн этгээдийг эсрэг гадаадын иргэн, хуулийн этгээд арбитрт нэхэмжлэл гаргах
- External-гадаадын иргэн, хуулийн этгээдийн эсрэг дотоодын иргэн, хуулийн этгээд арбитрт нэхэмжлэл гаргах гэсэн хоёр хэлбэртэй байдаг.

2.Монгол Улсын арбитр

Монголын Үндэсний арбитр нь хуулиар харьяалуулсан маргааныг арбитрын хэрэг үүсгэн, хянан шийдвэрлэх үйл ажиллагааг эрхлэн явуулах бүрэн эрх бүхий төрийн бус байгууллага юм. Монгол улсад арбитр 1930-аад оноос хөгжиж эхэлсэн. Арбитрын үйл ажиллагааны анхны эрх зүйн хэм хэмжээний акт болох Гадаад Худалдааны Арбитрын тухай хууль 1995 онд батлагдсан. Хуулийн нэрээс нь харахад энэ хууль гадаад худалдаатай холбоотой маргааныг арбитраар шийдвэрлэх ажиллагааг зохицуулсан нь мэдэгдэнэ. Энэхүү хуулийн зарим зүйл зохицуулалт олон улсын арбитрын зарчимтай нийцэхгүй байсан тул Хууль зүй, дотоод хэргийн яам Арбитрын тухай хуулийн төслийг бэлтгэсэн билээ. 2003 оны 5 дугаар сарын 9-ний өдөр Арбитрын тухай шинэ хууль батлагдан хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Шинэ хуулийн ихэнх зүйл заалт ЮНСИТРАЛ-аас гаргасан Олон Улсын Арилжааны Арбитрын Загвар хуулийн үзэл баримтлалыг дагаж мөрдсөн. 1995 оны хуулиар зөвхөн олон улсын арбитрыг зохицулсан нь дотоодын маргаан зөвхөн шүүхээр шийдвэрлэгдэж байсан юм. Гэхдээ Загвар хуулиас ялгаатай нь Монгол улсын шинэ хууль олон улсын ба дотоодын арбитрыг зохицуулсан нэгдсэн дэглэмийг бий болгосон байна. Арбитрын ажиллагаа явуулах газар Монгол Улсын нутаг дэвсгэр байгаа тохиолдолд шийдвэр дотоодын шийдвэр байна. Иймд талууд Монгол Улсын биш байсан мөн материаллаг эрх зүй нь Монгол Улсын хууль биш байсан ч хэрэв арбитрын ажиллагаа явуулах газар нь МУ байх тохиолдолд гарсан арбитрын шийдвэр дотоодынх болно[828].

1995 оны хуулиар зохицуулаагүй байсан түр арбитрыг шинэ хуулиар зөвшөөрсөн. Арбитрын тухай хуулиар байнгын ба түр арбитрыг тодорхойлсон бөгөөд байнгын арбитрыг зөвхөн нэг арбитр байхаар хязгаарлаагүй.

Арбитрын тухай хуулиар хэрэв талууд Иргэний хуулийн дагуу гэрээний стандарт нөхцөл байгуулсан бол арбитрын хэлэлцээрийг маргаан гарсны дараа байгуулна. Мөн бусад хууль тогтоомжоор маргааныг шүүх болон бусад байгууллагаар тусгайлан шийдэгдэхээр харьяалуулсан тохиолдолд тухайн маргаан арбитрын харъяаллын маргаан болохгүй.

Шинэ хуулийн 15 дугаар зүйлийн дагуу Үндсэн хуулийн цэцийн гишүүн, шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажилтан болон тухайн хэрэгт өмнө нь оролцож байсан өмгөөлөгч, нотариатч, хуулиар бусад ажил эрхлэхийг хориглосон этгээд артбитарчаар томилогдохгүй. Түр арбитрын хувьд арбитрч томилох, татгалзах, өөрчлөх асуудлыг давж заалдах шатны шүүх шийднэ гэж заажээ. Харин байнгын арбитрын хувьд энэ асуудлыг тухайн арбитрын дүрмээр

[828] МҮХАҮТ-ын дэргэдэх МҮА "Олон улсын арилжааны арбитр".УБ., 2009 он

зохицуулж болно. Арбитрчийг томилох, татгалзах журам ЮНСИТРАЛ-ын Загвар хуулийн зохицуулалттай адилхан. Загвар хууль арбитр дахь шүүхийн оролцоог хязгаарлах зарчмыг баримталсан. Ихэнх тохиолдолд давж заалдах шатны шүүх эрх бүхий шүүх байдаг. Арбитрын бүрэлдэхүүн арбитрын шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авах эрх хэмжээтэй. Хэрэв энэ арга хэмжээг нөгөө тал гүйцэтгэгхгүй бол давж заалдах шатны шүүхэд хандаж болно[629].

1995 оны хуулиар арбитрт шүүх оролцдоггүй байсан бөгөөд арбитрын бүрэлдэхүүн арбитрын шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ авах эрхгүй байсан. Арбитрын шийдвэр шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газраар шууд биелэгддэг байв. Аль нэг тал зд хөрөнгө битүүмжлэх эсхүл нотлох баримт цуглуулах зэрэгт шүүхийн туслалцаа зайлшгүй хэрэг болно. Ялангуяа арбитрын шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээг гуравдагч этгээдийн эсрэг авахад шүүхээс туслалцаа авах шаардлагатай болно. Учир нь арбитр хэлэлцээрийн шинж чанартай тул арбитрын хэлэцээр гуравдагч этгээдэд үйлчлэхгүй юм. Талууд арбитрын ажиллагаа явуулах хэлээ тохиролцох эрхтэй бөгөөд ийнхүү тохиролцоогүй бол арбитрын ажиллагааг Монгол хэлээр явуулна. Арбитрын ажиллагаанд нэгээс дээш арбитрч оролцож байгаа тохиолдолд арбитрын бүрэлдэхүүний шийдвэрийг олонхийн саналаар гаргана. Гэхдээ арбитрын процедурын шинжтэй асуудлыг даргалагч арбитрч дангаараа шийдвэрлэж болно. Арбитрын тухай хуулийн 37 дугаар зүйлээр арбитрын шийдвэрийн хэлбэр, агуулгын талаар зохицуулсан. Арбитрын шийдвэрт арбитрын бүрэлдэхүүний нэр, арбитрын ажиллагаа явуулсан газар, шийдвэрийн үндэслэл болон арбитрын зардлын талаар тусгана. Шийдвэрт санал үл нийлсэн арбитрч саналаа бичиж болно. Арбитрын шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл загвар хуулийн үндэслэлтэй адилхан. Давж заалдах шатны шүүх арбитрын шийдвэрийг хүчингүй болгох хүсэлтийг хүлээн аваад хэрэв үндэслэлтэй бол арбитрын бүрэлдэхүүнд алдаагаа засах хугацаа олгодог. Хэрэв арбитрын бүрэлдэхүүн алдаагаа засахгүй тохиолдолд шүүх хэргийг хүлээн авч шийднэ. Хэрэв арбитрын шийдвэрт тооцоо, үг үсэг, тооны алдаа гарсан тохиолдолд бүрэлдэхүүн түүнийг өөрийн санаачлагаар эсхүл аль нэг талын хүсэлтээр засна.

Бүрэлдэхүүн арбитрын шийдвэрийг тайлбарлах, засвар оруулах эсхүл орхигдуулсан асуудлаар нэмэлт шийдвэр гаргаж болно. Арбитрын зардлыг Арбитрын тухай хуулийн 41 дүгээр зүйлд зохицуулсан. Арбитрын зардалд арбитрчийн урамшуулал, арбитрчийн арбитрын ажиллагаанд оролцохтой холбоотой зардал, орчуулгын хөлс, гэрчийн зардал олон бусад зардал орно. Талууд өөрөөр тохиролцоогүй бол нэхэмжлэлийг бүрэн хангасан бол арбитрын үндсэн зардлыг хариуцагч, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон бол нэхэмжлэгчээс гаргана. Хэрэв нэхэмжлэлийг хэсэгчлэн хангасан бол ийнхүү хангасан хэмжээгээр нэхэмжлэгч, хариуцагчид хуваарилна. Хэрэв арбитрын шийдвэрийг аль нэг тал сайн дураар биелүүлэхгүй бол шийдвэрийг шийдвэр гүйцэтгэлийн журмаар биелүүлэхээр Давж заалдах шатны шүүхэд хандана.

[629] МҮХАҮТ-ын дэргэдэх МҮА "Олон улсын арилжааны арбитр".УБ.,2009 он

Гадаад арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх тухай Нью-Йоркийн 1958 оны конвенцэд Монгол Улс гишүүн тул гадад арбитрын шийдвэрийг энэ конвенцийн дагуу биелүүлнэ. Хэрэв давж заалдах шатны шүүх хууль бусаар шийдвэр гүйцэтгэх хуудас бичихгүй бол шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн алба биелүүлнэ.

МҮА-ын зорилго:

- Монгол Улсад маргаан шийдвэрлэх арбитр зуучлалын ажиллагааг хөхиүлэн дэмжих, хөгжүүлэх
- Арбитр, салбар арбитрын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, өдөр тутмын үйл ажиллагаг хангах
- Арбитр, зуучлалын ажиллагааны талаар судалгааны ажил хийх, сургалт семинар зохион байгуулах, мэргэшүүлэх сургалт хийх
- Арбитр, зуучлалын ажиллагааг сурталчлах
- Гадаадын арбитрын төвүүдтэй ажил хэрэгч холбоо тогтоон, хамтын ажиллагаа, харилцааг хөгжүүлэх
- Арбитрын ажиллагааны нууцыг хадгалж, арбитрын ажиллагааг хараат бус, шударгаар түргэн шуурхай явуулах

Манай улсад үйл ажиллагаа явуулж байгаа Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх МҮА нь хэрэг хянан шийдвэрлэх дүрэмдээ гадаад дотоодын эрх зүйн этгээдүүдийн түүнчлэн дотоодын эрх зүйн этгээдүүдийн хооронд үүссэн эдийн болон эдийн бус бялагтай холбоотой арбитрын харьяалалд хамаарах аль ч төрлийн маргаанд арбитрын ажиллагааг байнга эрхлэн явуулах эрхтэй байнгын арбитр юм. Зарим арбитрын хувьд тодорхой төрлийн маргаанд дагнан арбитрын ажиллагааг явуулдаг. Манай Арбитрын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 6-д "Байнгын арбитр нь арбитрын харъяалалд хамаарах аль ч төрлийн болон оюуны өмчийн, гадаад арилжааны зэрэг тодорхой төрлийн маргаанаар арбитрын ажиллагааг дагнан явуулж болно" гэж хуульчилсан. Ихэнх байнгын арбитр нь өөрийн гаргасан дүрэм, арбитрын заавар заалтуудтай байдаг. Тухайлбал Монголын Үндэсний Арбитр нь:

1.Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрэм

2.Зуучлалын ажиллагааны дүрэм

3.Түр арбитрт дэмжлэг үзүүлэх тухай дүрэм

4.Санхүүгийн маргаан шийдвэрлэх дүрэм г.м.

Байнгын арбитруудын арбитрчдыг томилох механизм нь өөрсдийн дүрэмд заасны дагуу хэрэгжинэ. Тухайлбал олон улсын арилжааны танхимын дүрмээр талууд гурван арбитрчаар маргаанаа шийдвэрлүүлэхээр бол гурав дахь арбитрчийг арбитр өөрөө томилдог онцлогтой.

Арбитрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1.2-д "Талууд тодорхой нэг маргааныг шийдвэрлүүлэх зорилгоор нэг удаа байгуулсан арбитрыг түр арбитр гэнэ." гэж тодорхойлсон байна.

ЮНСИТРАЛ-ын арбитрын дүрэм ихэнх түр арбитрын ажиллагаа явуулах нөхцөлийг хангаж өгдөг. Учир нь ЮНСИТРАЛ-н дүрэм нь аливаа эрх зүйн системд, аль ч улсын маргааныг шийдвэрлэх боломжтой уян хатан хараат бус дүрэм юм. Талууд байнгын арбитраас дэмжлэг авч болох юм. Өөрөөр

хэлбэл арбитрын ажиллагааг хурдан шуурхай, мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар дүрмийн дагуу явуулах боломжтой юм. Тухайлбал, Монголын Үндэсний Арбитр нь түр арбитрт дэмжлэг үзүүлэх тухай дүрэмтэй. Дүрмээр Монголын Үндэсний Арбитр нь дараах үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:

- Талууд болон арбитрчдад бичиг баримт хүргүүлэх
- Арбитрын хуралдааны тэмдэглэл хөтлөх
- Арбитрын хуралдаанд хэлмэрчлэх, орчуулах
- Арбитрын хуралдааныг явуулах өрөөгөөр хангах
- Арбитрын хуралдаан хийх газар, хугацааг товлох, талуудад мэдэгдэх
- Арбитрчдад зочид буудал, байрлах газар бэлтгэх
- Түр арбитрын зардлыг тооцох г.м.

Манай хуулиар байнгын болон түр арбирын маргаан шийдвэрлэх ажиллагаа адил зарчмаар явагддаг бол тус дүрмээр байнгын арбитраас дэмжлэг авахаар бол талууд аритрчдын нэрийн жагсаалтаас бус жагсаалтад ороогүй арбитрчийг томилох эрхтэйгээр онцлог юм[830].

Арбитрын хэлэлцээр

Арбитрын тухай хуулийн 11 дүгээр зүйлд "Арбитрын хэлэлцээр гэж аль нэг эрх зүйн харилцаатай холбогдон үүссэн буюу үүсч болох бүх төрлийн, эсхүл тодорхой төрлийн маргааныг арбитраар шийдвэрлүүлэх талаар талуудын хооронд хийсэн тодорхой төрлийн хэлцлийг хэлнэ" гэж заасан байдаг. Арбитрын хэлэлцээрийн хоёр үндсэн төрөл байдаг байна. Үүнд:

1.Арбитрын заалт

2.Арбитрын бие даасан хэлэлцээр

Арбитрын заалт нь ирээдүйд үүсч болох маргааныг арбитраар шийдвэрлүүлэхээр үндсэн гэрээндээ анх заасан заалт байдаг. Арбитрын заалт нь ерөнхийдөө богинохон байдаг бол бие даасан хэлэлцээр нь ихэнх тохиолдолд нилээд урт бичигддэг байна. Арбитрын заалтыг ирээдүйд үүсч болох маргааныг шийдвэрлэх үед хэрэглэхээр тусгаж байгаа тул нарийн асуудлыг тэр болгон тусгадаггүй ба тухайн гэрээний чухам аль хэсэгтэй холбогдож маргаан үүсэх нь урьдаас тодорхойгүй байдагтай холбоотой юм. Тэгвэл арбитрын бие даасан хэлэлцээрийн тухайд асуудал арай өөрөөр тавигддаг ба энэ нь мэдээж нэгэнтээ маргаан үүссэн хойно хийж байгаа тул гаргаж буй асуудал болон бусад нөхцөл байдал зэрэгтэй холбоотой бүх зүйлийг нарийвчлан тохиролцох шаардлага гардаг байна. Олон улсын худалдааны гэрээ ихэвчлэн арбитрын заалт агуулсан байдаг. Учир нь гэрээндээ гол анхаарлаа хандуулаад гэрээний төгсгөлийн хэсэгт арбитрын заалт оруулахдаа маргаан шийдвэрлүүлэх арбитр болон бусад сонголтыг буруу хийснээс болж эрсдэл гарах нь элбэг байдаг. Хамгийн гол нь талууд маргааныг шийдвэрлэхдээ арбитраар уу, эсхүл шүүхээр шийдвэрлүүлэх үү гэдгээ тохиролцон тогтоосон байх шаардлагатай ба арбитрын хэлэлцээр хууль зүйн хувьд шаардлага хангасан хүчин төгөлдөр байх хэрэгтэй юм.

[830] МҮХАҮТ-ын дэргэдэх МҮА Олон улсын арилжааны арбитр УБ хот, 2009 он.

Арбитрын хэлэлцээрт тавигдах үндсэн шаардлага:

Арбитрын хэлэлцээрийн үндсэн шаардлагыг 1958 оны Нью-Йоркийн конвенци болон Олон улсын бусад конвенциудад заасан байдаг. Нью-Йоркийн конвенцийн 2.1-т "гэрээнд оролцогч улс бүр хэлэлцээрийг бичгээр байгуулахыг хүлээн зөвшөөрөх, талууд ямар нэгэн тодорхой гэрээтэй болон бусад эрх зүйн харилцаатай холбоотой тэдний хооронд үүссэн буюу үүсч болох аливаа маргааныг арбитрт шилжүүлэх үүргийг хүлээдэг ба түүний объект арбитрын ажиллагааны зүйл байж болно. Конвенцийн 5.1.а-д арбитрын шийдвэрийг биелүүлэх буюу хүлээн зөвшөөрөх талаар заахдаа хэрэв "2-р зүйлд заагдсан хэлэлцээрийн талууд эрх зүйн чадамжгүй эсхүл тухайн хэлэлцээр хийсэн талуудын мөрдөж буй хуулиар хэлэлцээр хүчин төгөлдөр бус, мөн уг шийдвэрийг гаргасан улсын хуульд тийм заалт байхгүй бол" талууд шийдвэрийг татгалзаж болно. Эсхүл конвенцийн 2.3-т заасны дагуу бусад тохиолдолд арбитрын хэлэлцээр нь хүчин чадлаа алдаж хүчин төгөлдөр бус байх ёсгүй гэжээ. Нью-Йоркийн конвенцид арбитрын хэлэлцээрт дараах шаардлагуудыг заасан. Үүнд:

1.Хэлэлцээрийг заавал бичгээр байгуулах ёстой

2.Хэлэлцээр нь талуудын хооронд үүссэн болон үүсч болох маргааныг шийдвэрлэхэд хамаатай байх

3.Маргаан нь гэрээнээс гадуур эрх зүйн шинжтэй байх

4.Эрх зүйн харилцааны объект нь арбитрын ажиллагааны зүйл байх

5.Арбитрын хэлэлцээрийн талууд хууль хэрэгжүүлэх эрх зүйн чадамжтай байх

6.Арбитрын хэлэлцээр нь арбитрын шийдвэр гарсан улсын эсхүл хэлэлцээрийг солилцсон талуудын мөрдөж буй хуулиар хүчин төгөлдөр байх ёстой.

Нью-Йоркийн конвенц болон Монгол Улсын хууль тогтоомжид арбитрын хэлэлцээр хүчин төгөлдөр байх анхдагч шаардлага нь түүнийг бичгээр байгуулах явдал юм гэж заасан байдаг. Конвенцийн 2.2-т заасан хэлэлцээрийг бичгээр байгуулах тухай ойлголтыг Монгол Улсын Арбитрын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2-д заасан байна. Хэрэв "талуудын гарын үсэг зурсан баримт бичигт тусгагдсан эсхүл талууд захидал мэдээлэл цахилгаан солилцох замаар мөн бусад электрон холбоо ашиглан, нэхэмжлэлийн санал болон мэдүүлэг солилцох замаар талуудын аль нэг нь хэлэлцээр байгуулсан гэдгийг баталж түүнийг нөгөө тал нь татгалзаагүй" бол арбитрын хэлэлцээрийг бичгээр байгуулсан гэж үзнэ. Нью-Йоркийн конвенцид нэгдэн ороогүй дэлхийн зарим улс маргаан үүсвэл түүнийг арбитрт шилжүүлэх тухай хэлэлцээрийг хүлээн зөвшөөрдөггүй. Арбитраар шийдвэрлэж буй маргааны ихэнх нь гэрээний харилцаанаас үүссэн байдаг. Мөн арбитрын бус журмаар маргаан үүсгэн шийдвэрлэж болох гэрээтэй шууд бус холбоотой зарим маргаан ч хамаарна. Тухайлбал, хохирол учруулсанаас үүсэх үүрэг, хуурамч гэрээтэй холбоотой асуудал, түүнчлэн хууль болон захиргааны эрх зүйн харилцаанаас үүссэн шаардлагууд гэх мэт орно. Нийтийн ашиг сонирхолыг хөндсөн маргааныг аль ч улсад шийдвэрлэдэг ба зарим улс маргааныг арбитраар шийдвэрлэх нь оновчгүй гэж үздэг. Учир нь арбитрт эрүүгийн эрх болон хүний эрхийн асуудал хамаардаггүй.

Дүгнэлт

Дэлхийн улс орнууд даяаршиж байгаа өнөө үед улс хоорондын харилцаа улам бүр нарийсан хөгжиж тэр дотроо худалдаатай холбоотой хамтын ажиллагаа нь илүү өргөн цар хүрээг хамарч байгаа.

Тус судалгааны ажлын үр дүнд шүүх эрх мэдлийн хүрээнд ОУХЭЗ-н хэм хэмжээг хэрэглэх, тэр дундаа олон улсын худалдааны эрх зүйд хэрэглэх, үндэслэл арга зүйн талаар судалхыг эрмэлзэв. Ийнхүү үндэслэл, арга зүйг тайлбарлахдаа нэгдүгээрт, ОУХЭЗ ба ОУНЭЗ-н харилцаа холбоо, уялдааг тайлбарлаж, улмаар олон улсын худалдааны эрх зүйг ОУХЭЗ-д хамааруулан судалсан шалтгааныг тайлбарлах, хоёрдугаарт, олон улсын худалдааны харилцаанд хэрэглэгддэг олон улсын гэрээ, хэлэлцээр тухай бүрийн зорилго, цар хүрээний талаар, гуравдугаарт, МУ-ын арбитрын шүүх, түүний үндсэн зорилго, үйл ажиллагааны чиглэлийн талаар тус тус тусгав.

Олон улсын хувийн эрх зүй гэдгийг гадаадын элемент оролцсон иргэний эрх зүйн хэргийг зохицуулж буй бүх хэм хэмжээг бүхэлд нь ойлгож болох бөгөөд энэ утгаараа захиргааны эрх зүй нь ОУХЭЗ-н нэгэн бүрэлдэхүүн хэсэг болж байгаа юм.[831]ОУХЭЗ ба ОУНЭЗ хоёрын хоорондын нягт уялдаа, ялангуяа олон улсын эдийн засгийн харилцааны салбарт тод илэрч байна. Худалдааны гэрээ, санхүү, татварын хэлэлцээр нь гадаад эдийн засаг, худалдааны талаар улс хоорондын харилцан хүлээх үүргийг тогтоодог. Эдгээрийн үндсэн дээр байгуулсан гадаад худалдааны хэлэлцээр нь бараа тээвэрлэх, хүлээн авах, төлбөр хийх зэрэг ажиллагаанд иргэний эрх зүйн харилцаа үүсдэг талаар нэгдүгээр бүлэгтээ дурьдсан.Ихэнхи эрдэмтэн судлаачид олон улсын гэрээг олон улсын хувийн эрх зүйн эх сурвалж мөн гэж үздэг. Тиймээс улс орнуудын хооронд хийгдэж буй худалдааны асуудал нь бүгд гэрээ хэлцлийн үндсэн дээр явагддаг учраас олон улсын хувийн эрх зүйд хамруулж ойлгож болох юм.

Олон улсын худалдаанд оролцож байгаа улс орнууд харилцан ашигтай хоорондоо ижил түвшинд оролцох сонирхолтой байдаг ба энэ харилцааг зохицуулахын тулд ТХЕХ нь олон улсын худалдааны эрх зүйн үндсэн эх сурвалж болж өгдөг байна. Өөрөөр хэлбэл олон улсын худалдааны үйл ажиллагаа нь бүхэлдээ ТХЕХ-ийн дагуу явагддаг гэж хэлж болох юм.

Нэгэнтээ олон улсын худалдаа түүнтэй холбоотой шүүхийн практикийн талаар судалсан учраас арбитрын асуудлыг дурьдах нь зайлшгүй зүйл юм.

Шүүгч, арбитрч нар нь хуулийг албан ёсоор эцэслэн хэрэглэж байгаагаараа хуулийг хэрэглэх эрхтэй бусад этгээдээс ялгагдах ажлын онцлогтой субъектууд юм. Эрх зүйг хэрэглэх гэдэг нь хуулиар эрх олгогдсон этгээд эрх зүйн хэм хэмжээний заалтыг удирдлага болгон хууль зүйн тодорхой асуудлыг шийдвэрлэхийн тулд эрх зүйн шийдэл гаргахад чиглэгдсэн үйл ажиллагаа гэдгийг бид мэднэ. Тэгвэл арбитрт хэрэг, маргааныг шийдвэрлэхдээ зөвхөн тухайн харилцааг зохицуулсан дотоодын хуулиас гадна гадаад улсын хууль, олон улсын хэлэлцээр зэргийг хэрэглэдэг.

[831] Т.Мэндсайхан "Олон улсын хувийн эрх зүйн үндэс" УБ., 2002 он.

Хуулийг хэрэглэхдээ:

➢ Тухайн харилцаа нь нийгмийн ямар харилцаанд хамаарахыг нь нягтлах;

➢ Төрөөс тухайн харилцааг зохицуулж байгаа эрх зүйн хэм хэмжээг зөв сонгон авах;

➢ Тухайн шийдэх гэж буй асуудлаар түүнийг зохицуулж буй хуулийн зүйл, хэсэг, заалт, цэг, таслал, үг, өгүүлбэрээр нь нарийвчлан авч үзэж тохируулах;

➢ Эрхийн актад хуулийн зүйл заалтыг албан ёсоор баримтлах гэсэн үе шатуудыг дамжина.

Монгол Улсын Иргэний хуулийн 540 дүгээр зүйлд "Монгол Улсын хууль, Монгол Улсын Олон улсын гэрээнд харшлаагүй гадаад улсын хууль болон олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээнд заншлын хэм хэмжээг иргэний эрх зүйн харилцаанд хэрэглэж болно" гэж заажээ.

Арбитрч гадаад улсын хуулийг хэрэглэх шаардлагатай гэж үзвэл:

➢ Тухайн улсын хууль, хуулийн тайлбарыг зөв ойлгож авах;

➢ Уг хууль, тайлбараа албан ёсоор төрийн албаны хэл дээр орчуулга хийлгэн баталгаажуулах;

➢ Тухайн хууль нь манай улсын хуультай нийцэж байгаа эсэхийг анхаарах;

➢ Тухайн улсын арбитрын практикийг судлах журмаар хууль хэрэглэсэн байдлыг тогтоох зэргийг анхаарах шаардлагатай.

Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн гурав дахь хэсэгт зааснаар Олон улсын гэрээг УИХ-аар соёрхон баталсан байхыг шаарддаг ба мөн зүйлийн дөрөв дэх хэсэгт "Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй" гэж заасныг хэрэгжүүлэхдээ Монгол Улс олон улсын гэрээнд нэгдэн ороогүй, соёрхон батлаагүй, хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн, улс, нийгмийн эрх ашигт харшилсан эсхийг анхаарна. Мөн зүйлийн хоёр дахь хэсэгт "Олон улсын гэрээ бусад хуулийн заалттай зөрчилдсөн тохиолдолд олон улсын гэрээний заалтыг баримтлана" гэж заасан нь арбитрч нарт олон улсын гэрээг баримтлах иш үндсэн болж байгаа юм.

1992 оноос өнөөг хүртэл Монголын Үндэсний Арбитраар шийдвэрлэгдсэн хэрэг маргааануудыг ажиглахад дийлэнх хэсэг нь буюу 43%-ийг худалдах, худалдан авах гэрээнээс үүдэлтэй маргаан, мөн бараа нийлүүлэх тухай гэрээнээс үүдэлтэй маргаан 16%-ийг, хөрөнгө оруулалтын гэрээнээс үүссэн маргаан 13%-ийг эзлэж байна.

Энэ нь шүүхийн практикт олон улсын худалдаатай холбоотой тэр дундаа дийлэнх хэсгийг ямар гэрээнээс үүссэн маргаан эзлэж байгааг харуулж буй үзүүлэлт юм.

1992 оноос 2000 он хүртлэх маргааануудын хариуцагч талаар ихэнхдээ МУ-ын хуулийн этгээд оролцож байсан бол 2000 оноос хойших маргааануд дээр Монгол Улсын хуулийн этгээдүүд нэхэмжлэгч тал болж оролцох байдал нь харьцангуй нэмэгдсэн байна.

Ер нь цаашдаа олон улсын худалдааны үйл ажиллагаа эрхлэж байгаа талууд хоорондоо байгуулж буй гэрээ хэлцлээ тодорхой бичиж, гэрээгээр зохицуулагдах харилцаа бүрийг нэг бүрчлэн зүйл заалт болгон тусгаж өгөх шаардлагатай. Ингэж тусгаагүйгээс болж Монголын Үндэсний Арбитраар 1992 оноос хойш шийдвэрлэгдсэн хэрэг маргаануудын дийлэнх нь гэрээгээ буруу эсхүл бүрэн гүйцэд боловсруулаагүйгээс үүссэн байх жишээтэй.

Олон улсын худалдааны гэрээ нь улс орнын тэгш эрх, тусгаар тогтнолын тухай зарчмын үүднээс гэрээний харилцагч талуудын эрх, үүрэг хариуцлагыг зохих ёсоор нь тусгадаг. Хэрэв олон улсын худалдааны гэрээнд харилцан тохиролцогч талуудын эрх, үүрэг хариуцлагыг зохих ёсоор тусгаагүй эсхүл тэдгээрийн эрх, үүрэг, хариуцлагыг хэлбэрийн тедий тусгасан бол гэрээ нь тэгш эрхгүй гэрээ болох юм. Мөн түүнчлэн гэрээнд түүний зүйл, үйлчлэх хүрээ, хэрэглэгдэх эрх, хугацаа, үнэ, чанар, тоо хэмжээ, нийлүүлэлт, төлбөр хийх арга, маргаан үүссэн тохиолдолд хэрхэн шийдвэрлэх нөхцөл, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүсч болох хохирол зэрэг гэрээнд зайлшгүй байх ёстой үндсэн болон нэмэлт элементүүдийг нарийн тодорхой, талуудын хэн хэнд нь ойлгомжтойгоор тусгах ёстой байна. Хэрэв ингэж чадаагүй тохиолдолд гэрээг хэрэгжүүлэх явцад талуудын хооронд үл ойлголцох байдал үүсч, гэрээ зохих ёсоор дуусгавар болж эцсийн зорилгодоо хүрч чадахгүй байх тохиолдол байгаа юм. Энэ нь манай улсын хувьд дээрх хэрэг маргааануудыг шийдвэрлэсэн байдлаас ажиглагдаж байна.

Гэрээний нөхцөлд мөн гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөнөөс үүсэх хариуцлагыг тусгана. Энэ нь нөхөн төлбөрийн болон торгуулийн шинжтэй байх ба гэрээний нэг талаас нөгөө талынхаа зүй бус үйлдэлд эдийн засгийн аргаар нөлөөлөх найдвартай хөшүүрэг нь болж өгдөг юм.

Дээрх тоо баримтуудаас харахад гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөнөөс үүссэн маргаан дараах хэлбэрүүдээр зонхилж байна. Үүнд:

- Бэлтгэн нийлүүлэх хугацаа хожимдох;
- Төлбөрөө хугацаанд нь хийхгүй байх;
- Гэрээний нөхцөлөөр тохиролцсон барааг нийлүүлэхгүй байх гм.

Ийнхүү талууд хоорондоо тэгш эрхгүй гэрээ байгуулах, гэрээний үндсэн болон нэмэлт нөхцөлүүдийг нарийвчлан, тодорхой заагаагүй байх, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй буюу зохих ёсоор биелүүлэхгүй байх зэргээс болж гадаад худалдааны гэрээ хэлцлийг хэрэгжүүлэх явцад талуудын хооронд маргаан үүсэх нь элбэг байна.Энэхүү үүссэн маргааныг шийдвэрлэх аргыг дараах байдлаар хуваан үзэж болох юм.

- Шууд хэлэлцээр;
- Гуравдагч талын туслалцаатай хийх хэлэлцээр;
- Үндэсний шүүх;
- Олон улсын арилжааны арбитр.

Гадаад худалдааны хэлцлээс үүссэн ихэнх маргааныг тухайн хэлцэлд оролцсон талууд нь шууд хэлэлцээр хийх замаар шийдвэрлэдэг. Өөрөөр хэлбэл талууд маргаанаа шууд хэлэлцэн эвлэрлийн арга замыг сонгоно гэсэн үг юм. Энэ нь маргаанаа шийдвэрлэх хамгийн зүй зохистой хэлбэр юм. Ийнхүү эвлэрч чадаагүй тохиолдолд маргааныг гол төлөв хөндлөнгийн шүүх болон арбитраар шийдвэрлүүлдэг байна. Иймээс хэлэлцэн тохиролцогч

талууд нь гэрээний явцад үүсч болзошгүй аливаа маргааныг шийдвэрлэх журмаа гэрээндээ тодлорхой тусгах хэрэгтэй байдаг.

Шүүхийн практик дээр талуудын хооронд байгуулсан гэрээ нь хүчин төгөлдөр бус болох, гэрээнд заагдсан харилцан хүлээх үүргээ буруу эсхүл бүрэн гүйцэд ойлгоогүйгээс хохирох зэрэг үйлдлүүд маш их тохиолдсон байна.

Дотоодын үндэсний зах зээлийг олон улсын практикт ойртуулахад худалдааны бодлого, зохицуулалтыг улам боловсронгуй болгох, түүнийг дэлхийн нийтийн жишигт ойртуулах, эрүүл, соёлтой худалдааг дэмжин хөгжүүлэх асуудлыг төрийн бодлогын түвшинд тодорхойлон, худалдааны эрх зүйн орчинг бий болгож, бодлого хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зохистой, менежментийн өндөр чадавхитай бүтцийг бий болгох шаардлага тавигдаж байна.

Худалдааг дэмжих талаарх төрийн болон төрийн бус байгууллагуудын эрх, үүргийг тодорхойлон, тэдгээрийн ажлын уялдаа холбоог сайжруулах шаардлагатай байна.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

__oOo__

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ХАРЬЯАТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ЗОРИЛГООР ХИЙСЭН СУДАЛГАА[832]

Оршил

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын иргэд гадаад улс руу цагаачлах, эсхүл өөр улсын харьяат болох тохиолдол олширч байна. "Харьяатын тухай хууль"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төсөл хилийн чанадад буй гадаад улсын иргэн болсон "иргэд"-ээ эх орондоо эгүүлэн татах зорилгоор тэдэнд хандсан эрэг бодлогыг баримталж байна. Иймд төсөөтэй зохицуулалт бүхий орнуудыг жишээ болгон судаллаа.

Судалгааны ажлын хүрээнд гадаад оронд буй өөрийн улсын иргэн байсан, нэг үндэс, угсаатай хэдий ч өөр улсын харьяат болсон, эсхүл харьяаллаасаа гараагүй боловч өөр орны харьяат болсон буюу давхар харьяалалтай болсон "иргэд"-ээ харьяалалдаа эгүүлэн татах асуудлыг зохицуулж буй жишээг Бүгд Найрамдах Унгар Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Казакстан улсуудын жишээн дээр, байнгын оршин суугчийн зохицуулалтын талаар Бүгд Найрамдах Чех Улс, Австрали Улс, Европын Холбооны улсууд болон бусад улсуудын жишээн дээр судаллаа. Мөн ХЗДХЯ-ны захиалгаар ХЗҮХ-ийн ОУЭЗС-ийн 2008 онд хийсэн "Харьяатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд хийх хавсарга судалгаа[833]"-ны ажлын тайланд буй жишээг олж үзэж болно.

[832] Энэ судалгааг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2011 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 22 дугаар тушаалын дагуу ХЗДХЯ-аас боловсруулж буй төслийн хүрээнд хийж гүйцэтгэсэн болно.

[833] Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Олон улсын эрх зүйн секторын 2008 оны "Харьяатын тухай хуулийн шинэчилсэн найруулга" /харьцуулсан судалгаа/-ын материал

НЭГ. Хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрдөггүй орнууд хоёрдмол харьяаллын асуудлыг шийдвэрлэж буй байдал

Хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрдөггүй орны тоонд Швед, Армян, Киркиз, Казакстан, Хятад[834] зэрэг орнууд багтана. Эдгээр орнууд хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрдөггүй боловч улс төрийн болон түүхэн шалтгааны улмаас тус орны иргэний харьяаллаас гарсан үндэс угсаа нэгтэй, хэл, соёлын хувьд нийтлэг гадаад орны иргэдэд хандан, тэдэнд зориулсан хөнгөлөлттэй бодлого явуулдаг нь тэдэнд зориулж иргэний харьяалал олгох процедураа хөнгөвчилдгөөс харагдана. Жишээлбэл, Казакстан Улс нь тэдгээр иргэдэд хандан, иргэншил олгох процедураа хөнгөвчилдөг бөгөөд иргэншил хүсэгч нь өмнөх улсынхаа харьяаллаас гарсан байхыг шаарддаг.[835]

Судалгааны удирдамжийн дагуу хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрдөггүй орнууд хоёрдмол харьяаллын асуудлыг шийдвэрлэж буй байдлыг "green card"-ын жишээн дээр судлах учир энэ талаар тодруулъя.

Байнгын оршин суугч буюу "permanent residency"гэдэг нь хэн нэгэн хүн тухайн орны иргэн биш боловч тус оронд оршин суух эрхтэй байхыг ойлгоно. Орон бүр ямар нэг хэмжээгээр байнгын оршин суугчийн статустай байдаг. "Нэн тааламжтай" гэж хэлж болох байнгын оршин суугчийн статустай орон бол Европын холбооны гишүүн орнууд байдаг.

Байнгын оршин суугчийн эрх, үүрэг: Ихэнх оронд байнгын оршин суугчийн эрх, үүрэг ойролцоо байдаг. Байнгын оршин суугчийн хувьд дараахь эрхийг хязгаарладаг. Үүнд:

- ✓ Сонгуульд оролцох эрх;
- ✓ Төрийн удирдах болон зарим төрлийн өндөр албан тушаалд томилогдон ажиллах;
- ✓ Төрийн нууцтай холбоотой аливаа ажилд ажиллах /Сингапур Улсын хувьд байнгын оршин суугч эрэгтэй хүний хувьд энэхүү эрхийг олгодог байна/;
- ✓ Үл хөдлөх хөрөнгө эзэмших буюу газар өмчлөх эрх;
- ✓ Тухайн орны иргэний үнэмлэхтэй байх;
- ✓ Консул, элчингийн хамгаалалтанд байх;

Байнгын оршин суугчийн эрхээ алдах: Ихэнхи орны хувьд өөрийн орны хуульд заасан үндэслэлээр байнгын оршин суугчийн эрхийг хасдаг. Тухайлбал:

✓ Хуульд заасан тодорхой хугацаагаар тухайн оронд оршин суугаагүй бол оршин суугчийн эрхээ алдах;

✓ Улсын нууцад халдахтай холбоотой гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд байнгын оршин суугчийн эрхээ алдаж, албадан гаргуулна.

Байнгын оршин суугчтухайн орны харьяат болох: Байнгын оршин суугч нь тухайн байнга оршин сууж буй улсдаа тодорхой хугацаагаар амьдарсны дараа иргэншил авахаар өргөдөл гаргах эрх үүснэ. Тухайн улсын харьяат

[834] Пунцагдаш.О /2002/, *Иргэний харьяалал /олон улсын эрх зүйн асуудал/*, Уб, 13 дахь тал
[835] http://www.multiplecitizenship.com/wscl/ws_KAZAKHSTAN.html/сүүлд үзсэн 2011.02.18/

болохын тулд Унгарт 3, Алжир, Их Британид 7, ХБНГУ-д 8, Шведэд 12, Франц, Чадад 15 жилийн хугацаагаар тус тус байнга оршин суусан[836] байхыг шаардана. АНУ-ын хувьд 5 жилийн турш байнгын оршин суугч байсан бол, эсхүл АНУ-ын иргэнтэй гэрлэж, 3 жил байнгын оршин суугч байснаар иргэншил хүсэх эрх үүснэ[837].

Байнгын оршин суугч болсноор, байнгын оршин суугч гэдгийг нотлох "байнгын оршин суугчийн үнэмлэх"-тэйболно. Энэ нь:

✓ АНУ-ын хувьд цээж зураг бүхий ногоон өнгийн карт байх ба үүнээс үүдэн "green card" хэмээх нэршил бий болсон;

✓Австрали, Шинэ Зеландад байнгын оршин суугчийн үнэмлэх байдаг.

Байнгын оршин суугчдад таатай нөхцөл олгодог орнууд: Энд Австрали, АНУ болон Европын холбооны улсуудын жишээг дурдъя.

Австрали Улс: Австрали нь цагаачлалыг дэмждэг орнуудын тэргүүн эгнээнд байдаг орон бөгөөд Австралийн байнгын оршин суугчид нь бусад орны байнгын оршин суугчдаас илүү таатай боломжоор хангагддаг. Австрали Улсад байнгын оршин суугч дараах эрхийг эдэлнэ[838]. Үүнд:

✓ Байнгын оршин суугч нь тус улсад өөрийн хүссэн хугацаагаар амьдарч болно /Виззэ тухай бүрт нь сунгуулаад/;

✓ Байнгын оршин суугчдад ажлын цагийн хязгаар тогтоохгүй бөгөөд хүссэн цагаараа ажиллах эрхтэй

✓ Байнгын оршин суугч нь их, дээд сургуульд суралцахдаа бусад гадаад улсын оюутнуудтай харьцуулахад илүү хөнгөлттэй төлбөрөөр суралцана;

✓ Байнгын оршин суугч нь эрүүл мэндийн даатгалд хамрагдах боломжтой бөгөөд эмчилгээний төлбөрөөс чөлөөлөгдөх, хөнгөлөлт эдлэх эрхтэй;

✓ Байнгын оршин суугч нь Австралид 2 жил амьдарсны дараагаар нийгмийн хамгааллын тэтгэлэг болон тэтгэмжид хамрагдах эрхтэй;

✓ Байнгын оршин суугч нь өөрийн эх орон болон бусад улсад чөлөөтэй зорчих эрхтэй;

✓ Байнгын оршин суугчийн үр хүүхэд нь Австрали улсын иргэн болж болно;

✓ Байнгын оршин суугч нь Шинэ Зеланд Улс руу визгүйгээр зорчиж, ажиллаж, амьдарч болно.

Америкийн Нэгдсэн Улс: АНУ-ын байнгын оршин суугч хэмээх ойлголтыг "ногоон карт[839]" хэмээх нэршлээр нь илүүтэй мэднэ. АНУ-ын байнгын оршин суугчид олгох "байнгын оршин суугчийн үнэмлэх" нь анх ногоон өнгөтэй байснаас үүдэн энэхүү нэршил үүссэн юм. АНУ-ын байнгын оршин суугч нь сонгуульд оролцохоос бусад эрхүүдийг эдэлдэг. Тухайлбал, эрүүл мэндийн даатгал, тэтгэвэр, тэтгэмж буюу нийгмийн бүхий л халамжуудад хамрагддаг байна. Их, дээд сургуульд суралцахад бусад орны иргэдээс илүү хөнгөлттэй

---

[836] Пунцагдаш.О /2002/, *Иргэний харьяалал /олон улсын эрх зүйн асуудал/*, Уб, 9 дэх тал

[837] US Citizenship and immigration http://www.uscis.gov/portal/site/uscis/сүүлд үзсэн 2011.02.28/

[838] Visas, immigration and refugees http://www.immi.gov.au/migrants/ /сүүлд үзсэн 2011.02.28/

[839] Green Card /Permanent Residence/ http://www.uscis.gov/portal/site/uscis /сүүлд үзсэн 2011.02.28/

нөхцөлөөр суралцах боломжтой. Мөн өөр нэгэн давуу хүчин зүйл бол байнгын оршин суугч нь АНУ-ын иргэн болох боломжтой юм.

Европын Холбооны Улсууд: Европын холбоонд хамаарах улсууд тус тусын орны хуулиар зохицуулагдах "байнгын оршин суугч"-ийн статустай хэдий ч Европын Холбооны зүгээс байнгын оршин суугчийн бас нэгэн шинэлэг зохицуулалтыг бий болгосон нь "Цэнхэр картын систем"[840] юм. Энэ нь мэргэжлийн өндөр ур чадвар шаардах ажлын байранд Европын Холбооноос өөр бусад орны иргэдийг хөдөлмөр эрхлүүлэх зорилгоор Европын Холбоонд багтдаг орнуудын нутаг дэвсгэрт удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл олгох хэлбэр юм.[841] Европын Холбооны улсуудад нарийн мэргэжлээр ихэвчлэн гадаад орны иргэд суралцдаг бөгөөд ингэж суралцсан мэргэжилтнүүдийг эх оронд нь буцаан алдахаас сэргийлж, нөөц, бололцоог нь өөрийн орондоо ашиглах зорилгоор ийм зохицуулалт бий болгосон юм.

Европын Холбооны гишүүн улс болох Чех Улсын тухайд "цэнхэр карт"-ын дагуу тус улсад байнга оршин суухын тулд доод тал нь 3 сараас 2 жил хүртэлх хугацаагаар тус улсад хөдөлмөр эрхлэх гэрээ байгуулах үүрэг хүлээнэ[842] Мөн:

✓ 5 жил байнга оршин сууж, ажилласны дараа тус улсын иргэн болох эрхтэй;

✓ Түүний гэр бүл нь ямар нэгэн хязгаарлалтгүйгээр тус улсын байнгын оршин суугчийн эрхийг олж авах эрхтэй;

✓ Хөдөлмөрийн гэрээний дагуу тус этгээдийн сарын цалин нь тус улсын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс 1,5 дахин илүү байхаар тус тус зохицуулжээ.

ХОЁР. Хоёрдмол харьяалалтай болсон иргэдийнхээ харьяаллын асуудлыг хөнгөвчилсөн журмаар зохицуулан тэдний эрх ашгийг хамгаалж байгаа орны туршлага

Хоёрдмол харьяалалтай буюу өөр улсын харьяалалтай болсон иргэдэд зориулж, тэднийг төрөлх эх орондоо татах бодлогын үүднээс болон Хүний эрхийн түгээмэл[843] тунхаглалын 13-р зүйл болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт[844]-ын 12-р зүйлд заасан "Хэн боловч аливаа улс орныг, түүний дотроо эх орноо орхин явах, эх орондоо эргэж очих эрхтэй" гэсэн заалтыг хангах үүднээс харьяаллаасаа гарсан иргэдийг эх орондоо буцаж очих үед ямар нэг хөнгөлөлт эдлүүлэх зохицуулалтыг олон орны хуулиар зохицуулсан байдаг. Тухайлбал, Армян, Болгар, Хятад, Хорват, Чех, Франц, Герман, Унгар, Орос зэрэг орнуудыг нэрлэж болно.[845]

[840] About the Blue Card http://www.ccypcg.qld.gov.au/employment/ /сүүлд үзсэн 2011.02.28/

[841] Blue Card /European Union/ http://en.wikipedia.org/wiki/Blue_Card_/European_Union/ /сүүлд үзсэн 2011.02.28/

[842] Czech Republic: Legislation Introduces New Visa and Residence Permit Requirements, Blue Card for Highly Skilled Workershttp://www.martindale.com/immigration-law/article_Fragomen-Del-Rey-Bernsen-LoewyLLP_1230198.htm/сүүлд үзсэн 2011.02.28/

[843] Хүний эрхийн түгээмэл тунхаглал /1946/

[844] Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт /1966/

[845] Right of return, http://en.wikipedia.org/wiki/Right_of_return#/сүүлд үзсэн 2011.02.18/

Бүгд Найрамдах Унгар Улс: Дэлхийн нэгдүгээр дайны дараа Бүгд Найрамдах Унгар Улс болон Өрнийн холбоотон улсууд "*Трианоны гэрээ*"-г байгуулсан. Энэ гэрээгээр Унгар Улс нь Австри, Чехословак, Румын, Серби, Хорват зэрэг хөрш улсуудынхаа шинэ хил хязгаарыг зөвшөөрч, үүний улмаас газар нутгийнхаа гуравны хоёрыг алдаж, 20.9 сая иргэдтэй байснаас 7.6 сая иргэдтэй болсон.[846] 2010 оны 7 дугаар сарын байдлаар Бүгд Найрамдах Унгар Улс нь 9 сая 976 мянган хүн амтай [847] болсон бөгөөд одоогийн байдлаар хил залгаа Румын, Серби, Словак, Украин зэрэг улсуудад нийт 2.5 сая мажар үндэстэн амьдардаг.[848]

2010 оны 5 дугаар сард Унгар Улс харьяатын тухай хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулж, мажар үндэстнээ татах бодлогыг хуульдаа тусгасан.[849] Унгар Улс нь хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрдөг бөгөөд энэ тохиолдол нь өөр орны харьяат болох мажар үндэстэндээ зориулж Унгар улсын иргэн болох хөшүүрэг болгон тэдэнд зориулсан эрэг, таатай зохицуулалтыг хуульдаа оруулжээ. Гадаадын иргэд Унгар улсын иргэн болохын тулд тодорхой шаардлагуудыг хангах ёстой байдаг. Тухайлбал, Үндсэн хууль болон унгар хэлний тодорхой мэдлэгийг эзэмшсэн байх, Унгар улсад тодорхой хугацаанд оршин суусан байх, өөрийн улсын харьяалал нь Унгар улсын эрх ашигтай зөрчилдөхгүй байх, эрүүгийн хэрэгт холбогдоогүй байх зэрэг багтана. Харин энэ хуулиар мажар үндэстэн нь Унгарын иргэн болоход ердөө хоёрхон шаардлага хангахаар заасан. Энэ нь мажар үндэстэн байх, мөн унгар хэлээр ярьдаг байх гэсэн шаардлага юм. Гэхдээ одоогоор эдгээр Унгар улсын иргэн бологсдод сонгуулийн эрх олгоогүй байна.

Үүнтэй адил өөрийн орны иргэн биш боловч нэг үндэстэн болох хүмүүсийг бусад орны иргэдээс илүү хөнгөлөлттэй, хялбаршуулсан журмаар өөрийн улсын иргэнээр бүртгэдэг орны тоонд ХБНГУ, Армян Улс орно. Армяны хувьд Унгараас ялгаатай нь иргэний давхар харьяаллыг хүлээн зөвшөөрдөггүй юм. Мөн Беларус Улс нь Беларус үндэстэн болон түүний үр удмыг Беларус улсад байнгын оршин суугчаар амьдрахад давуу эрх олгодог. Болгарын хувьд ч мөн адил нэг үндэстнээ иргэнээр бүртгэхдээ тус улсад иргэншил олгодог журмаа хөнгөвчилж өгдөг байна. Энэтхэгийн хувьд хинди үндэстнээ хөнгөлөлттэй журмаар бүртгэдэг.

Ийнхүү хэл, үндэстэн гэсэн хоёр шалгуураар иргэний эрхийн зарим хэсгийг давуу эдлүүлдэг байна. Нэгэнт хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрсөн учир хоёрдмол харьяалалтай иргэн гэдэг нь тухайн улсын иргэний эрхийг эдлэх нь ойлгомжтой тул тэдэнд үзүүлэх тусгайлсан хөнгөлөлтийн талаар нарийвчлан судлах шаардлагагүй гэж үзлээ.

---

[846] Treaty of Trianon /1920/,http://en.wikipedia.org/wiki/Treaty_of_Trianon#Distribution_of_the_Hungarian_population_in_the_Kingdom_of_Hungary /сүүлд үзсэн 2011.02.18/

[847]https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/geos/hu.html /сүүлд үзсэн 2011.02.18/

[848] Michael A.Weinstean, /2001/ "Hungary's Referendum on Dual Citizenship: A Small Victory for Europeanism http://www.threemonkeysonline.com/als/_hungarian_citizenship_referendum_ethnic_hungarians_dual_citizenship.html /сүүлд үзсэн 2011.02.18/

[849] Changes in the Hungarian Citizenship Law and adopted on 26 May 2010 http://eudo-citizenship.eu/docs/CountryReports/recentChanges/Hungary.pdf/сүүлд үзсэн 2011.02.18/

Оросын Холбооны Улс: ОХУ-ын хувьд харьяатын асуудлыг зохицуулж буй хэд хэдэн эрх зүйн актууд байдаг бөгөөд хоёрдмол харьяаллыг хуулиараа хүлээн зөвшөөрдөг улс юм. Гэвч ОХУ-ын эрх зүйн зохицуулалтын талаар энэ бүлэгт тухайлан тусгах болсон нь тус улс хилийн чанадад буй иргэддээ чиглэсэн бодлогыг цогцоор явуулдагтай холбоотой. ОХУ-ын Үндсэн хуулийн 52 дугаар зүйл заалт, ОХУ-ын Харьяатын тухай Холбооны хуулийн 6 дугаар зүйлд[850] хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрдөг байна.Тухайлбал:

"ОХУ-ын иргэн өөр улсын иргэний харьяаллыг олж авах нь түүнийг ОХУ-ын харьяаллаас гаргах үндэслэл болохгүй" хэмээн тусгажээ.

ОХУ-ын хувьд иргэний харьяаллын асуудлыг дараах эрх зүйн актуудаар зохицуулдаг байна. Үүнд:

✓ ОХУ-ын Харьяатын тухай Холбооны хууль /2002.04.19/[851];

✓ ОХУ-ын Харьяатын тухай Холбооны хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Холбооны хууль /2003.11.03/[852];

✓ Хилийн чанадад байгаа эх орон нэгтнүүдийн талаар баримтлах төрийн бодлогын тухай ОХУ-ын Холбооны хууль /1999.05.24/[853];

✓ Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай ОХУ-ын Холбооны хууль /2002.06.10/[854];

✓ 2015 он хүртэлх хугацааны ОХУ-ын хүн ам зүйн хөгжлийн үзэл баримтлал /2001.09.01/;

✓ ОХУ дахь шилжилт, хөдөлгөөний талаарх төрийн бодлогын тухай үзэл баримтлал /1999/;

✓ ОХУ дахь шилжилт, хөдөлгөөний явцын талаарх төрийн бодлогын тухай үзэл баримтлал /2002/.

Монгол Улсын хувьд иргэний харьяалал, хүн ам зүйн бодлогын талаарх зохицуулалт бүхий Монгол Улсын эрх зүйн актуудыг түүвэрлэж үзэхэд иргэний харьяалал, харьяалалгүй иргэний эрх зүйн байдал, түүний эрх, үүрэг, статусын талаар зохицуулсан эрх зүйн зохицуулалт байдаг хэдий ч шилжилт хөдөлгөөн, хүн ам зүйн бодлогыг тодорхойлсон эрх зүйн зохицуулалт дутмаг байна[855].

Шилжилт, хөдөлгөөний хурдацтай хөгжлийн өнөөгийн нийгэмд дэлхийн ихэнхи улс орнууд давхар харьяаллыг хүлээн зөвшөөрөхгүй байх бодлогыг баримталж байгаа хэдий ч хуулиараа давхар харьяаллыг хүлээн зөвшөөрч буй тохиолдлууд олон байна. ОХУ-ын хувьд хуулиараа хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрсөн хэдий ч шилжилт, хөдөлгөөний хяналтын бодлогыг улсын түвшинд баримталдаг байна. ОХУ-ын хувьд ЗХУ задарч тухайн үеийн ЗХУ-ын гишүүн орнуудын иргэд нэг харьяаллаасаа салан бутарч өөр өөр улсын иргэд болцгоосон. Энэ замаар харьяалал нь тодорхойгүй, харьяалалгүй,

---

[850] Федеральный закон "О гражданстве Российской Федерации" № 62-ФЗ 2002.03.31.

[851] Мөн тэнд.

[852] Федеральный закон "О внесении изменений и дополнений в Федеральный закон "О гражданстве Российской Федерации" № 369592-3 2003.11.03.

[853] Федеральный закон "О государственной политике Российской Федерации в отношении соотечественников за рубежом" № 99-ФЗ 1999.05.24.

[854] Федеральный закон "О правовом положении иностранных граждан в РФ" № 115-ФЗ 2002.06.25.

[855] Судлагааны ажлын хавсралт 1-ээс харна уу.

давхар харьяалалтай олон тооны иргэд бий болсон. Сүүлийн жилүүдэд энэхүү асуудлыг шийдвэрлэж, хууль эрх зүйн орчныг төгөлдөржүүлж чадсан гэж үзэж болно. Судалгааны ажлын асуудлын хүрээнд Хилийн чанадад байгаа эх орон нэгтнүүдийн талаар баримтлах төрийн бодлогын тухай ОХУ-ын Холбооны хуулийг судалж үзэх нь ач холбогдолтой хэмээн үзлээ. Хилийн чанадад амьдарч буй "эх орон нэгтнүүд[856]"-ээ өөрийн улс руу эгүүлэн татах, тэдгээр иргэдийг уугуул соёл, уламжлалаа өвлөн хадгалах, хөгжүүлэх төрийн бодлогыг ОХУ-д баримталдаг байна. Мөн "Хилийн чанадад амьдарч буй эх орон нэгтнүүдийн талаар улсаас баримтлах бодлогын үндсэн чиглэлийн тухай[857]" 1994.08.11-ний өдрийн 1681 тоот ОХУ-ын Ерөнхийлөгчийн тушаалыг баталснаар хилийн чанадад амьдарч буй эх орон нэгтнүүдийн талаар төрөөс баримтлах бодлогын тухай хуулийн төсөл бэлтгэх, хилийн чанадад амьдарч буй эх орон нэгтнүүдийн асуудал эрхэлсэн Засгийн газрын хороо байгуулахаар болжээ.

Тус хуульд "*хилийн чанадад буй эх орон нэгтнүүдтэй харилцах харилцаа нь ОХУ-ын төрийн гадаад болон дотоод гол бодлогуудын нэг юм*" хэмээн тусгажээ.[858] "Эх орон нэгтнүүд" хэмээх ойлголтыг задлан авч үзэхэд энэ нь дараахь ойлголтуудыг багтаажээ.[859] Үүнд:

✓ "Эх орон нэгтэн" гэж нэг улсад төрсөн, тэрхүү улсад амьдардаг эсхүл амьдардаг байсан, нэгдмэл хэл, шашин шүтлэг, соёлын өв, зан уламжлалтай хүмүүс болон тэдгээрийн үр удмыг хэлнэ;

✓ "Хилийн чанадад буй эх орон нэгтнүүд" гэж гадаад улсад урт хугацаагаар, байнгын оршин суудаг ОХУ-ын иргэд; ЗХУ болон ЗХУ-д багтаж байсан орны иргэд, харьяалалгүй иргэн; ОХУ-аас /ЗХУ-аас/ цагаачилж өөр улсын иргэн болсон иргэд болон тэдгээрийн үр удмыг хэлнэ.

Энэхүү зохицуулалтын хүрээнд "эх орон нэгтэн" гэх ойлголтыг тайлбарлахаас гадна тус этгээдүүдэд төрөөс хандах хандлага, үзүүлэх хөнгөлөлт, дэмжлэг буюу тэдгээртэй холбоотой харилцаанд төрийн байгууллагуудын үүрэг, оролцооны талаар тус тус дурьджээ. Дараахь төрлийн дэмжлэгийг тусгасан байна. Үүнд:

✓ Хүний үндсэн эрх, эрх чөлөөний салбарт эх орон нэгтнүүдээ дэмжих

Олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн тохиолдолд ОХУ-ын Засгийн газраас дэмжлэг үзүүлэх, алагчлах, ялгаварлан гадуурхах буюу бусад хэлбэрээр тус эрхийн зөрчлийг хүлээн зөвшөөрөхгүй байх, таслан зогсоох, хамгаалах зэрэг;

✓ Эдийн засаг, нийгмийн салбарт дэмжлэг үзүүлэх.

ОХУ-ын Засгийн газар, төрийн байгууллагууд нь ОХУ-ын аж ахуй эрхлэгчид, хуулийн этгээд нь эх орон нэгтний аж ахуй эрхлэгч, хуулийн этгээдтэй хамтран ажиллах, түншлэхэд дэмжлэг үзүүлэх, хамтарсан

[856] "Федеральный Закон о государственной политике РФ в отношении соотечественников за рубежом" http://www.antropotok.archipelag.ru/grd/grd.htm/сүүлд үзсэн 2011.02.18/

[857] Указ Президента РФ "Об основных направлениях государственной политики Российской Федерации в отношении соотечественников, проживающих за рубежом" 1994.08.11 № 1681

[858] Мөн тэнд.

[859] Мөн тэнд.

үйлдвэр, хоршоолол, нийгэмлэг байгуулахад түлхэц өгөх, эх орон нэгтнүүдийг Оросын эдийн засагт хөрөнгө оруулахыг урамшуулах, олон тооны эх орон нэгтнүүд ажилладаг гадаадын хуулийн этгээдтэй Оросын хуулийн этгээд ажиллахад давуу эрхтэй[860] хүлээн зөвшөөрөх зэрэг бодлогыг баримталдаг;

Нийгмийн салбарт хамгаалалт байхгүй эх орон нэгтнүүдэд нийгмийн хамгаалалт үзүүлэх, ОХУ-ын Засгийн газраас тогтоосон журмын дагуу онцгой байдалд орсон эх орон нэгтнүүдэд туслалцаа үзүүлэх зэрэг.

✓ Соёл, хэл болон боловсролын салбарт эх орон нэгтнүүдээ дэмжих-

ОХУ-ын Засгийн газар, төрийн байгууллагууд эх орон нэгтнүүдийн өвөрмөц соёлын нэгэн хэсэг болох соёлын өв болон хэлийг хамгаалах, хөгжүүлэх, боловсролын бүх шатанд эзэмших боломжоор хангах бодлого баримталж, энэ зорилгын хүрээнд тодорхой бодлогыг хэрэгжүүлдэг байна;

Эх орон нэгтнүүдийн хэл, соёлын төв, боловсролын түвшингээ дээшлүүлэхэд шаардлагатай гэж үзвэл гадаад улсад байрлаж буй оросын эрдэм шинжилгээ, судалгааны төвүүд, эрдмийн байгууллагад хандах эрхийг нээлттэй олгосон;

Гадаад улсад байгаа эх орон нэгтнүүдийн санаачилгаар байгуулагдсан архив, музей, номын сан зэрэг соёл, эрдэм, судлагааны байгууллагад ОХУ-ын Засгийн газраас фонд /сан/ бүрдүүлэх, шаардлагатай баримт, бичиг олох зэрэг ажилд дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

ОХУ нь эх орон нэгтнүүдийг орос хэл эзэмших, оросын түүх, соёлын талаар судлахад дэмжлэг үзүүлж, энэ зорилгын хүрээнд гадаад улсад багшилж буй багш нарын бэлтгэлийг хангах, эх хэлийг гадаад улсад сургах сурах бичгийг бэлтгэх хөтөлбөр зохион байгуулдаг. Зарим тохиолдолд гадаад улсад буй боловсролын байгууллагатай энэ салбарт хамтран ажилладаг.

✓ Мэдээллийн салбарт эх орон нэгтнүүдээ дэмжих.

ОХУ-ын Засгийн газар нь тус улсын талаар өв, соёл, урлагийн талаар гадаад улсад буй эх орон нэгтнүүддээ мэдээлэл хүргэх үүднээс гадаад улсын олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан тодорхой хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг байна. Тухайлбал, орос хэлээр нэвтрүүлдэг телевизийн суваг нээж, ажиллуулах, гадаад улсад худалдаалагдах орос хэл дээрх сонин, сэтгүүл хэвлэн гаргах зэрэг ажлуудыг хийж байна. Энэ ажлын хүрээнд ОХУ-ын төрийн бодлогыг сурталчлах, эх орон нэгтнүүддээ шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах, соёл, урлагийн сурталчилгааны ажил тус тус зохион байгуулдаг. Мөн гадаад улсад буй эх орон нэгтнүүдийн санаачилгаар байгуулагдсан олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд шаардлагатай мэдээ, мэдээллийг өгөх ажлыг ОХУ-ын Засгийн газраас дэмждэг байна.

Дээрх зохицуулалтаас харахад ЗХУ-ыг задарсан шалтгаанаас үүдэн өөр өөр улсын харьяалалтай болсон олон тооны иргэдээ дэмжих, хамгаалах бодлого баримтлахын зэрэгцээ өөрийн орны өв соёл, хэл, уламжлалаа хамгаалж байгаа юм. Дээр хэлсэнчлэн ОХУ нь давхар харьяаллыг хуулиараа

[860] Монгол Улсын хуулийн этгээдийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн үйл ажиллагаатай холбоотой зохицуулалт бүхий хуулиудад "давуу эрхтэй хүлээн зөвшөөрөх" талаарх зохицуулалтыг агуулаагүй байна.

хүлээн зөвшөөрдөг хэдий ч улсын хүн амын нягтрал, хөгжлийн бодлогыг баримталдаг. Тухайлбал, шилжилт, хөдөлгөөн, түүний үйл явцын талаархи төрийн үзэл баримтлал, 2015 он хүртэлх ОХУ-ын хүн ам зүйн хөгжлийн үзэл баримтлал зэргийг дурьдаж болно.

Дээрх хуульд 2010 оны 7 дугаар сарын 9-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан нь эх орон нэгтнүүдийн бүрэн дэмжлэгийг хүлээжээ[861]. Өөрчлөлтийн үр дүнд «*гадаадад амьдардаг эх орон нэгтнүүд*» гэсэн томъёололыг тодруулж, *"гадаадад амьдардаг эх орон нэгтнүүд"* гэсэн ойлголтонд соёлын болон оюун ухааны ашиг тусын төлөө түүхэн эх оронтойгоо холбоо тогтоох сонголт хийсэн гадаадад байнга амьдардаг Оросуудыг нэрлэнэ[862]" хэмээн тусгасан байна.

ОХУ-д Хилийн чанадад амьдарч буй эх орон нэгтнүүдийн асуудал эрхэлсэн Засгийн газрын хороо үйл ажиллагаа эрхэлдэг. 2011 оны 3 дугаар сарын байдлаар тус хороо нь 11 хүний бүрэлдэхүүн бүхий ажлын албатай бөгөөд хороог ОХУ-ын Гадаад хэргийн яамны сайд тэргүүлдэг байна. Тус хороо нь хилийн чанадад буй эх орон нэгтнүүдтэй холбоотой ОХУ-ын төрийн байгууллагуудын харилцааг зохицуулах, эх орон нэгтнүүдийн талаархи эрх зүйн зохицуулалтыг боловсруулах, хэрэгжилтийг хангах, ОХУ-ын Ерөнхийлөгч, Засгийн газарт эх орон нэгтнүүдийн талаар төрийн бодлогын хэрэгжилтийн талаарх мэдээлэх, санал өргөн барих, эх орон нэгтнүүдэд хуулиар олгосон эрхийн хэрэгжилтийг хангах зэрэг үүрэг хүлээсэн байгууллага юм.[863] Тус байгууллагын хувьд хилийн чанадад байгаа эх орон нэгтнүүдийн талаар баримтлах төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 3 жилээр боловсруулж, ОХУ-ын Засгийн газраар батлуулдаг байна. Манай улсын хувьд Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэдэх Хилийн чанадад буй Монгол Улсын иргэдтэй хамтран ажиллах зөвлөл үйл ажиллагаагаа[864] явуулдаг бөгөөд ОХУ-аас ялгаатай нь тус ажлын алба нь гадаад улсад буй Монгол Улсын иргэдтэй хамтран ажиллах ажлыг зохион байгуулдаг юм. Энэ тохиолдолд тус байгууллага нь өөрийн үйл ажиллагааны эрх үүргээ тэлж, хилийн чанадад буй эх орон нэгтнүүдтэй хамтран ажиллах ажлыг мөн зохион байгуулах хэрэгтэй хэмээн үзэж байна.

ГУРАВ. Хоёрдмол харьяаллыг хуулиар шууд хүлээн зөвшөөрдөггүй боловч нэгэнт үүссэн нөхцөлд тэдгээр иргэдээ эх орондоо буцааж татах бодлого явуулж байгаа орнуудын эрх зүйн зохицуулалтын талаар

Бүгд Найрамдах Казакстан Улс: Бүгд Найрамдах Казакстан Улс нь 1991 онд тусгаар тогтносны дараагаар тус улсын Засгийн газраас бусад оронд буй казак үндэстнээ "түүхэн эх орон"-доо эргэн ирэхийг урьж, тусгай хөтөлбөр

---

[861] "Эх орон нэгтнүүдийн тухай хуулинд оруулсан өөрчлөлтийг Европд амьдардаг оросууд дэмжлээ" нийтлэл http://mongolian.ruvr.ru/2010/04/05/9342977.html /сүүлд үзсэн 2011.03.24/

[862] Федеральный закон«О внесении изменений в Федеральный закон«О государственной политике Российской Федерациив отношении соотечественников за рубежом» 2010.07.09

[863] Правительственная комиссия по делам соотечественников за рубежомhttp://www.mid.ru/bul_newsite.nsfkartaflat/03_5.03 /сүүлд үзсэн 2011.03.24/

[864] www.cooperation.gov.mn /сүүлд үзсэн 2011.03.24/

боловсруулсан. Шинжэзчдийн дүгнэснээр дэлхийд 2 сая казак үндэстэн байгаа бөгөөд тэдгээр нь голчлон Хятад, Орос, Монгол, Узбекстан улсуудад байдаг.[865] Казакстан Улс нь иргэний давхар харьяаллыг зөвшөөрдөггүй бөгөөд Казакстан Улсын Харьяаллын тухай хуулийн 3-р зүйлд[866] зааснаар "хэлмэгдүүлэлт болон тухайн үеийн улс төрийн бусад шалтгаанаар Казакстан Улсаас хүчээр гаргасан, одоо өөр улсын иргэн болсон казак үндэстнээ Казакстан улсад эргэн ирэхийг хүлээн зөвшөөрнө" хэмээн тусгажээ. Эргэн ирж буй тус казак үндэстэнд хөнгөлөлттэй нөхцөлөөр харьяалал олгодог. Тухайлбал, тус хуулийн дагуу гадаадын иргэн Казакстаны харьяалал хүссэн бол тус улсад 5-аас дээш жил байнга оршин суусан байхыг шаарддаг бол эргэн ирж буй казак үндэстэнд энэхүү шаардлагыг тавьдаггүй байна. Мөн ийнхүү эргэн ирсэн казак үндэстэнд жил бүр тэтгэмж олгохоор улсын төсвт тодорхой хэмжээний мөнгөн дүн төсөвлөдөг байна. 2009 оны байдлаар 1991 оноос хойш Казакстанд Хятадаас нийт 21133 , Монголоос 39359, Узбекстанаас 177822 казак үндэстэн тус тус эргэн ирсэн байна. Мөн эдгээр казак үндэстэнд зориулж, нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор Казакстаны баруун өмнө зүгт байрлах Актау хотод тусгай төв барьж байна.[867]

Монгол Улсаас Казакстан Улсад шилжин суурьшиж буй дийлэнх хүмүүс хялбаршуулсан журмаар Казакстан Улсын харьяат болдог нь Монгол, Казакстаны хоёрдмол харьяалал үүсэх суурийг бүрдүүлж байна[868]. "Сайн дураараа шилжин суурьших болон хөдөлмөрийн гэрээгээр Бүгд Найрамдах Казакстан Улсад ирсэн хүмүүсийг иргэний харьяаллын асуудлыг зохицуулах тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Казакстан Улсын хоорондын Гэрээ[869]"-ний 4 дүгээр зүйлийн дагуу "Хөдөлмөрийн гэрээгээр Бүгд Найрамдах Казакстан Улсад ирсэн хүмүүс Монгол Улсын харьяатаас гарч Бүгд Найрамдах Казакстан Улсын харьяат болох талаар бичгээр гаргасан хүсэлтийг Монгол Улсын эрх бүхий байгууллага ёсоор болгосон тухайгаа Казакстан Улсын холбогдох байгууллагад мэдэгдсэн өдрөөс эхлэн Бүгд Найрамдах Казакстан Улс тэдгээр иргэнийг өөрийн харьяат болгоно" хэмээн зохицуулжээ. Ер нь Монгол Улс, Казакстан Улсын хооронд харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар 40 орчим гэрээ, хэлэлцээр байгуулсан байдаг[870]. Үүсэд буй

---

865 "Astana calling" http://portal.mfa.kz/portal/page/portal/mfa/resources/Pictures/Astana%20Calling%20/PDF//2009-10-06/ASTANA%20CALLING%20031109.pdf /сүүлд үзсэн 2011.03.24/

866 Law on citizenship http://www.legislationline.org/documents/action/popup/id/4993 /сүүлд үзсэн 2011.03.24/

867 "Astana calling"http://portal.mfa.kz/portal/page/portal/mfa/resources/Pictures/Astana%20Calling%20/PDF//2009-10-06/ASTANA%20CALLING%20031109.pdf /сүүлд үзсэн 2011.03.24/

868Пунцагдаш.О /2005-4/, *Монгол, Казакстаны хоёрдмол харьяалал үүссэн шалтгаан, түүнийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу зохицуулан шийдвэрлэх асуудалд* // Хууль дээдлэх ёс, 77

869"Сайн дураараа шилжин суурьших болон хөдөлмөрийн гэрээгээр Бүгд Найрамдах Казакстан Улсад ирсэн хүмүүсийг иргэний харьяаллын асуудлыг зохицуулах тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Казакстан Улсын хоорондын Гэрээ" 1994 он.

870 Пунцагдаш.О /2005-4/, Монгол, Казакстаны хоёрдмол харьяалал үүссэн шалтгаан, түүнийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу зохицуулан шийдвэрлэх асуудалд // Хууль дээдлэх

хоёрдмол харьяаллын асуудал нь Монгол Улсын хуульд нийцэхгүй тул энэ асуудлыг зохицуулах үүднээс Казакстан Улсын иргэн болсон хоёрдмол харьяалал бүхий 30 000 иргэдийг өөрсдөө Монгол Улсын харьяатаас сайн дураар татгалзаж буй өргөдлөө Казакстан Улсад гаргасан тул Монгол Улсын харьяаллаас хасах хэрэгтэй хэмээн үзэж байна[871]. Мөн тус шилжин суурьшсан иргэдийн нэрсийн жагсаалтыг Хил хамгаалах ерөнхий газрын шугамаар Монгол Улс, БНХАУ-ын хилийн шалган нэвтрүүлэх боомтуудад хүргүүлж, эзэмшиж буй гадаад паспортыг хураан авч, хүчингүй болгосноор хоёрдмол харьяаллыг таслан зогсоож чадна хэмээн судлаач О.Пунцагдаш өөрийн нийтлэлдээ[872] бичсэн байна.

ДӨРӨВ. Олон улсын гэрээ, конвенц дахь зохицуулалт

Иргэний харьяаллын асуудал онолын хувьд олон улсын эрх зүйд, практикийн хувьд үндэсний эрх зүйн чухал асуудал юм. Хүн бүр харьяалалтай байх баталгаагаар хангагдах эрхийг 1948 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоолоор баталсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалаар[873] тогтоосон. Мөн Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 24.2-т: "Хүүхэд бүр иргэний харьяалалтай болох эрхтэй[874]", Хүүхдийн эрхийн тухайтунхаглалын 8.1-д"Оролцогч улсууд хуульд заасан иргэний харьяалалтай байх, нэр авах, гэр бүлийн холбоогоо хадгалах зэргээр хувийн онцлог байдлаа хадгалах, хүүхдийн эрхийг хүндэтгэх, үүнд хууль бусаар оролцохгүй байх үүрэг хүлээнэ[875]" хэмээн иргэний харьяаллын талаар тус тус зохицуулжээ.

Дэлхийн I дайны дараа үед харьяалалгүй, хоёрдмол харьяалалтай хүний тоо огцом өсөж энэ үеэс эхлэн хоёрдмол харьяаллын асуудлыг дэлхий дахинаа зохицуулж ирсэн байна[876]. Олон улсын түвшинд анх 1930 онд Гааг хотноо болсон олон улсын бага хурлын үр дүнд "Харьяатын тухай хуулийн зөрчилдөөнийг арилгах тухай Конвенц"[877]-ийг баталжээ.

Дэлхийн II дайны дараа НҮБ-ын Олон улсын эрх зүйн комисс энэ асуудлыг анхааралдаа авч давхар харьяаллыг багасгах хандлагыг баримтлан 1963 онд "Олон харьяаллыг багасгах ба олон харьяалалтай иргэний цэргийн үүргийн тухай Конвенц"[878]-ийг баталсан байна. Энэ замаар олон улсын

ёс, 77

[871] Мөн тэнд. 78.

[872] Мөн тэнд.78.

[873]Төрийн мэдээлэл /Тусгай дугаар -1/ "Хүний эрхийн түгээмэл тунхаглал" НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 217/А/III/ тогтоолоор 1946.12.10 батлагдсан. 15 дугаар зүйл.

[874] Төрийн мэдээлэл /Тусгай дугаар -1/ "Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт" 2200А/XXI/ тоот тогтоолоор 1973.03.23-ны өдөр хүчин төгөлдөр болсон. 24 дүгээр зүйл.

[875]Төрийн мэдээлэл /Тусгай дугаар -1/ "Хүүхдийн эрхийн тухай Конвенц" 1990.09.02-ны өдөр хүчин төгөлдөр болсон. 8 дугаар зүйл.

[876]Уильям Старлинг Берджесс "Натурализация" http://monah.tk/?p=845 /сүүлд үзсэн 2011.03.29/

[877]"Конвенция регулирующая некоторые вопросы, связанные с коллизией законов о гражданстве" 12 апреля 1930 годаhttp://www.memo.ru/prawo/citiz/300412.htm /сүүлд үзсэн 2011.03.29/

[878]"Конвенция о сокращении случаев многогражданства и о воинской повинности в случаях

түвшинд иргэний харьяалал, хоёрдмол харьяаллын асуудлыг зохицуулсан олон тооны олон улсын гэрээ, хэлэлцээрийг баталсан байдаг. Тухайлбал, "Иргэний харьяаллын тухай Европын Конвенц[879]", "Харьяаллыг багасгах тухай Нью-Йоркын Конвенц[880]", "Нөхөрт гарсан эмэгтэйн харьяаллын тухай Конвенц[881]", "Харьяалалгүй хүний эрх зүйн байдлын тухай Конвенц[882]" зэрэг орно.

Монгол Улсын хувьд дээрх конвенциудад нэгдэн ороогүй бөгөөд иргэний харьяаллын асуудлын зохицуултыг агуулсан Монгол Улсын олон улсын гэрээг түүвэрлэж үүнд хавсаргав[883]. Хоёрдмол харьяаллын асуудлыг шийдвэрлэх аргын нэг бол тухайн хоёр улсын хооронд хоёрдмол харьяаллын асуудлаар гэрээ байгуулах явдал юм. Хоёрдмол харьяаллын асуудлаарх гэрээг хоёр үндсэн зорилгоор хийдэг байна[884]. Энэ нь нэгдүгээрт, давхар харьяаллыг хүлээн зөвшөөрөхгүй байх, таслан зогсоох, хоёрдугаарт, давхар харьяаллыг харилцан зөвшөөрч, үүсэх асуудлуудыг зохицуулах гэсэн хоёр төрлийн зорилготой байдаг. Тухайлбал, улс орнууд хоёрдмол харьяаллаас урьдчилан сэргийлэх бөгөөд устгах тухай хоёр талын хэлэлцээрийг хийдэг байна. Үүнд, АНУ нь Норвеги /1930 он/, Швед /1933 он/, Швейцар /1937 он/, Финлянд /1939 он/ зэрэг улстай, Франц нь 1958 онд Швейцар, 1959 онд Израил, 1970 онд Испани, 1963 онд Финлянд Улстай тус тус хийсэн хэлэлцээр зэргээр жишээ татаж болно.

Манай улс хоёрдмол харьяаллын асуудлыг олон улсын түвшинд хоёр талт гэрээгээр зохицуулдаг байна. Монгол Улс 1990 оноос өмнө тухайн үеийн нэршлээр Бүгд Найрамдах Унгар Улс, Бүгд Найрамдах Социалист Болгар Улс, Бүгд Найрамдах Социалист Чехословак Улс, Бүгд Найрамдах Социалист Югослав Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Улс, Бүгд Найрамдах Куба Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай иргэн, гэр бүл ба эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээг тус тус байгуулсан. Харин 1990 оноос хойш Бүгд Найрамдах Франц Улс, Бүгд Найрамдах Казакстан Улс, Бүгд Найрамдах Польш Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Украйн Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс, Бүгд Найрамдах Киргиз Улс, Бүгд Найрамдах Турк Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улсуудтай иргэн, гэр бүл ба эрүүгийн хэргийн талаар харилцан туслалцах гэрээ байгуулжээ.[885] Тус гэрээгээр иргэний

многогражданства" 6 мая 1963 года. http://dallakian.narod.ru/grazh/nbgrazh.htm /сүүлд үзсэн 2011.03.29/

[879]"Европейская конвенция о гражданстве" 6 ноября 1997 года http://dallakian.narod.ru/grazh/nbgrazh.htm /сүүлд үзсэн 2011.03.29/

[880]Нью-Йоркская конвенция о сокращении безгражданства 30 августа 1960 года. http://dallakian.narod.ru/grazh/nbgrazh.htm /сүүлд үзсэн 2011.03.29/

[881]Конвенция о гражданстве замужней женщины 20 февраля 1957 года. http://dallakian.narod.ru/grazh/nbgrazh.htm /сүүлд үзсэн 2011.03.29/

[882]Конвенция о статусе апатридов 28 сентября 1958 года http://dallakian.narod.ru/grazh/nbgrazh.htm /сүүлд үзсэн 2011.03.29/

[883] Хавсралт 2-ыг харна уу.

[884] ХЗҮХ-ийн Олон улсын эрх зүйн секторын 2008 оны судалгааны ажлын тайлангаас харна уу.

[885] Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ, сургалт мэдээлэл, сурталчилгааны үндэсний төв, /2003/, "Монгол Улсаас бусад улстай байгуулсан эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай гэрээ /эмхэтгэл/, Уб.

харьяаллын асуудлыг хэсэгчлэн зохицуулсан байдаг. Тухайлбал, Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсын хооронд иргэн, гэр бүл болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээний 2 дугаар зүйлд "Хэрэв гэрлэгсэд өөр өөр харьяалалтай байвал гэрлэлт ба түүнийг цуцлах, хүчингүйд тооцохтой холбогдсон асуудлыг уг хэргийг хянаж байгаа Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллага өөрийн орны хууль тогтоомжийг баримтлан шийдвэрлэнэ" хэмээн зохицуулсан байна. Ер нь Монгол Улсын хувьд харьяаллын асуудлыг зохицуулсан олон улсын олон талт гэрээнд нэгдэн ороогүй, харьяаллын асуудлыг хөндсөн хоёр талт гэрээг цөөн тооны улстай байгуулсан зэрэг нь хоёрдмол харьяалалтай иргэд олшрох, эдгээр иргэдийн эрх зүйн байдлыг цогцлон шийдвэрлэж чадахгүй байх зэрэг сөрөг үр дагаварт хүргэнэ.

Монгол Улсын хувьд хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрсөн улсад иргэний харьяалал олж авсан Монгол улсын иргэд байхыг үгүйсгэх аргагүй. Учир нь Монгол улсын мэдээллийн сан бүрхэг, нөгөө талаас хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрч байгаа орнууд бусад улсын иргэдэд хоёрдмол харьяаллыг өгөхдөө нөгөө улсын харьяаллаас гарсан байхыг шаарддаггүй байж болно. Үүнийг Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар нарийвчлан судлах шаардлагатай.

ТАВ. Гадаад улсад буй иргэдэд үзүүлж болох хөнгөлөлтүүдийн талаар, тус хөнгөлөлтийг хуулийн хүрээнд хэрхэн эдлүүлж болох талаарх санал

Харьяалал нь хувь этгээдийн эрх зүйн байдлын анхдагч ба үндсэн элемент юм. Өөрөөр хэлбэл харьяалал нь тодорхой этгээдийн эрх, эрх чөлөөг ханган хамгаалахын зэрэгцээ тодорхой үүргийг хүлээлгэдэг. Иргэний харьяалал нь төр ба иргэн хүн хоёрыг холбож буй улс төр, эрх зүйн тогтвортой холбоос юм.

Гадаад улсад буй иргэдэд үзүүлж болох хөнгөлөлтийн талаар судлахаас өмнө *"хөнгөлөлт", "дэмжлэг", "туслалцаа"* гэсэн нэр томъёоны талаар дурдъя. *"Дэмжлэг"* гэдэг нь тодорхой субьектэд хамааралтай зүйлийг /хөрөнгө, мөнгөн дүн, үүрэг зэрэг/ хөгжүүлэх, сайжруулах үйлдлийг хэлнэ.[886] *"Хөнгөлөлт"* гэдэг нь тодорхой субьектэд хамааралтай зүйлийг /хөрөнгө, мөнгөн дүн, үүрэг зэрэг/ хөнгөлөх, хялбаршуулах үйлдлийг хэлнэ.[887] Харин *"туслалцаа"* хэмээх нэр томъёоны хувьд тодорхой субьектэд ямарваа нэгэн үйлдэл хийхэд түлхэц өгөх, дэмжихийг хэлнэ.[888] Өмнөх бүлэгт дурьдагдаж буй Хилийн чанадад амьдарч буй эх орон нэгтнүүдийн талаар баримтлах

[886] http://dictionary.cambridge.org/dictionary/british/ /сүүлд үзсэн 2011.03.30/
[887] Мөн тэнд
[888] Мөн тэнд

төрийн бодлогын тухай ОХУ-ын Холбооны хуульд ОХУ-ын Засгийн газраас хилийн чанадад буй гадаад улсын иргэд болох эх орон нэгтнүүдийн хувьд *"дэмжлэг үзүүлэх"* гэсэн нэр томъёог өргөнөөр хэрэглэсэн байна.

ОХУ-ын хуулийн хувьд "дэмжих" гэдгийг гадаад улсад буй эх орон нэгтнүүдэд Оросын соёл, уламжлал, хэл, ёс заншлыг авч үлдэхэд нь туслалцаа үзүүлэх, ОХУ-д бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд хөнгөлттэй нөхцөлөөр бүртгэх зэрэг ойлголтуудыг багтаажээ.

Монгол Улсын хувьд "жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих"[889], "хөдөлмөр эрхлэлтийг дэмжих"[890] гэсэн ойлголтуудыг зохицуулсан боловч "хүний үндсэн эрх, эрх чөлөө, нийгэм, эдийн засаг, соёл, хэл, боловсролын салбарт эх орон нэгтнүүдээ дэмжих" гэсэн ойлголтыг хуульчлаагүй байна

Судлагааны ажлын хүрээнд Монгол Улсын харьяаллаас гарсан тохиолдолд хуульд заасан Монгол Улсын иргэний эдлэх эрхээс ямар эрх нь хязгаарлагдах талаар судалсан болно. Тухайлбал:

✓ *Монгол Улсад гарах-орохдоо виз авах, баримт бичиг бүрдүүлж. бүртгүүлэх* - Монгол Улсын Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 16.1-р зүйлд зааснаар Монгол Улсад байнгын оршин суугч, цагаач, гадаадын иргэн, харьяалалгүй хүнд гарах-орох визийг 120 хүртэл хоногтой тодорхой баримт бичиг бүрдүүлж, бүртгүүлсний үр дүнд олгодог. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2003.03.12-ны өдрийн 62 тоот "Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан гадаадын иргэн, харьяалалгүй хүнд тавих шалгуурыг тогтоох журам"-нд заасан шалгуурыг хангасан тохиолдолд Монгол Улсын иргэн болох асуудал нь шийдвэрлэгдэнэ.

✓ *Газар өмчлөх, ашиглах эрх хязгаарлах*- Монгол Улсын Газрын тухай хуулийн 5.2-р зүйлд зааснаар "Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно", мөн хуулийн 44 дүгээр зүйлд зааснаар Монгол Улсад байнга /183 хоногоос дээш хугацаагаар/ оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд газрыг *зөвхөн гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалтаар ашиглуулах* асуудлыг дуудлага худалдааны зарчмаар тухайн шатны Засаг дарга шийдвэрлэнэ хэмээн заажээ. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5.2-р зүйлд заасны дагуу Монгол Улсын иргэнтэй гэр бүл болсон гадаадын иргэн, харьяалалгүй хүн газар өмчлөх эрхгүй.

✓ *Галт зэвсэг өмчлөх эрхгүй*–Монгол Улсын Галт зэвсэг өмчлөх тухай хуулийн 5-р зүйлд заасны дагуу "...гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэрт галт зэвсэг өмчлөхийг хориглоно" хэмээн зохицуулжээ.

✓ *Монгол Улсын иргэний үнэмлэх, үндэсний гадаад паспорт эзэмших эрхгүй* –Монгол Улсын Иргэний бүртгэлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу "...гадаадын иргэн, харьяалалгүй хүнд Монгол Улсад оршин суух үнэмлэхийг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1-р зүйлд Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх алба олгоно" хэмээн зохицуулжээ.

[889] Жижиг дунд үйлдвэрийн тухай хууль /2007/
[890] Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль /2001/

✓ *Иргэний эрх зүйн чадварыг хуулиар хязгаарлах*-Монгол Улсын Иргэний хуулийн 543.1-р зүйлд "Гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын иргэний нэгэн адил иргэний эрх зүйн чадвартай байна. Энэхүү чадварыг Монгол Улсын хуулиар хязгаарлаж болно" хэмээн тусгажээ.

✓ *Сонгох, сонгогдох эрх* – Монгол Улсын Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 8.1.2-р зүйлд заасны дагуу гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын болон орон нутгийн хурлын сонгуульд сонгох, сонгогдох, ард нийтийн санал асуулгад оролцох эрхгүй хэмээн заажээ.

✓ *Улс төрийн үйл ажиллагаа явуулах байгууллага байгуулах эрхгүй* - Монгол Улсын Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 8.1.2-р зүйлд заасны дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт улс төрийн үйл ажиллагаа явуулах байгууллага байгуулах, түүнд элсэн орох, хөрөнгө, санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэргээр улс төрийн аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

✓ *Монгол Улсын иргэнээс газар өмчлөх, эзэмшил, ашиглалтандаа газар шилжүүлэн авах эрхгүй* - Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 28.1.1-р зүйлд заасны дагуу газар өмчлөгч Монгол Улсын иргэн гадаадын иргэн, харьяалалгүй хүнд өмчийн газраа худалдах, арилжих, өвлүүлэх, бэлэглэх, барьцаалах зэргээр газраа гадаадын хуулийн этгээд, гадаадын иргэн, харьяалалгүйхүний өмчлөл, эзэмшилд шилжүүлэх эрхгүй байна.

✓ *Газрыг бусдад дамжуулан хөлслөх, дамжуулан түрээслэхийг хориглох*

- Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 29.9-р зүйлд заасны дагуу иргэний өмчийн газрыг гэрээний үндсэн дээр хөлсөлж, түрээсэлж байгаа гадаадын хуулийн этгээд, гадаадын иргэн, харьяалалгүй хүн уг газрыг бусдад дамжуулан хөлслөх, дамжуулан түрээслэхийг хориглоно.

✓ *Улсын хилийн бүсэд байнга оршин суух эрхгүй* – Монгол Улсын Хилийн тухай хуулийн 26.5-р зүйлд заасны дагуу улсын хилийн бүсэд гадаадын иргэн, харьяалалгүй хүн байнга оршин суухыг хориглоно хэмээн тусгажээ.

✓ *Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглуулах эрхгүй*

–Монгол Улсын Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 33.2-р зүйлд заасны дагуу тусгай хамгаалалттай газар нутагт гадаад улсын хуулийн этгээд олон улсын байгууллага, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газар ашиглуулахыг хориглоно хэмээн тусгажээ.

✓ *Төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх эрхгүй* – Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 16.2.5-р зүйлд заасны дагуу гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг төрийн жинхэнэ албан тушаалд авч ажиллуулахыг хориглоно.

✓ *Хүний хөгжлийн сангаас тэтгэмж авах эрхгүй* – Монгол Улсын Хүний хөгжлийн сангийн тухай хуулийн 15.1-р зүйлд заасны дагуу "сангаас хүн ам, өрхийн бүртгэлд бүртгэгдсэн, иргэний харьяаллын зөрчилгүй Монгол Улсын иргэнд хишиг, хувь хүртээнэ" хэмээн зохицуулжээ.

Дүгнэлт

Олон улсын эрх зүй судлаачдын үзэж байгаагаар[891] орчин үед улс болгон харьяаллын асуудлыг өөрийн зохицуулалтаараа шийдсэн ч олон хүндрэлтэй асуудлууд үүсч байгаа бөгөөд дийлэнх улс орнууд давхар харьяаллыг хүлээн зөвшөөрөхгүй байх, эсхүл тодорхой хэмжээгээр хязгаарлах хандлагыг баримталдаг. Судлаач А.И.Ковлевын үзэж байгаагаар "хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрсөн улс болгон харьяаллын хүндрэлтэй асуудалтай /дипломат хамгаалал, цэргийн алба, хүүхдийн харьяаллыг тогтоох зэрэг/ учрах төдийгүй, улс хоорондын харилцаанд тодорхой нөлөөлөл үзүүлэх болно".[892]

Хоёрдмол харьяаллын эсрэг үзэл баримтлалыг баримтлагч Швейцарын судлаач Р.Шererийн үзэж байгаагаар "Улс гэдэг нь нэгэн том бие бүрэлдэхүүн бөгөөд өөрийн бүрэлдэхүүнд буй иргэдийн асуудлыг өөрөө бүрэн шийдвэрлэж байх хэрэгтэй. Гэтэл давхар харьяаллын асуудал үүссэнээр хоёр өөр улсын хооронд үл ойлголцох асуудал үүсэх, иргэний хувьд ч эздрээтэй асуудал үүсгэж байдаг. Амьдралд гарах аливаа асуудал бүгдийг гэрээ, конвенц, хуулиар шийдвэрлэх боломжгүй" [893] хэмээн үзэж байна.

Судалгаанаас харахад хоёрдмол харьяаллыг хүн ам цөөтэй улс гүрнүүд хүлээн зөвшөөрдөггүй байна.

Монгол Улсын Харьяатын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах үзэл баримтлалын хувьд гадаад улсад амьдарч буй монголчуудаа эгүүлэн татах, Монгол Улсын харьяаллаас гарч байгаа иргэдийн урсгалыг зогсоох зорилго агуулж байгаа бөгөөд тус судлагааны ажлаар ийм зохицуулалтыг агуулсан гадаадын орнуудыг судлан үзсэн.

Гадаадын орнууд гадаад улсын иргэн болсон үндэстэн нэгтнээ эгүүлэн татахдаа болон гадаадын иргэдийг өөрийн оронд татахдаа дараах зохицуулалтуудыг ашиглаж байна. Энэ нь:

- Иргэншил олгох процедураа хөнгөвчлөх: Унгар, Герман, Казакстан зэрэг улсууд нь өөрийн орны иргэн биш боловч хилийн чанадад амьдарч буй нэг үндэстэндээ зориулж иргэншил хүссэн тохиолдолд бусдаас хөнгөлөлттэй нөхцөлөөр иргэншил олгож байна.
- Давхар харьяаллыг хүлээн зөвшөөрөх: Энэ нь тухайн иргэнээ иргэний харьяаллаасаа хасахгүйн тулд давхар харьяалалтай байхыг зөвшөөрч байна. Мөн Европын Холбооны Улсууд нь давхар харьяаллыг Европын Холбоонд багтдаг улсуудын хувьд зөвшөөрч байна.
- Байнгын оршин суугчийн эрх олгох: Гадаадын орнууд өөрийн орондоо ажиллах хүч, хүн ам зүйн бодлого зэрэг олон шалтгааны улмаас гадаадын иргэдэд байнгын оршин суугчийн эрх олгож, тодорхой эрхүүдийг эдлүүлж байна. Жишээлбэл: *"Цэнхэр карт"*-ын системээр байнгын оршин суугчийн

[891]А.В. Белов /2002-2/ *Двойное гражданство и проблема лояльности*// Правоведение. С. 157-161.

[892] Ковлер А.И. *Двойное гражданство: панацея или ловушка?*// Актуальные проблемы гражданства: Материалы международной научно-практической конференции по проблемам гражданства. М., 1995. С.119

[893] Шерер Р. *Практика и опыт стран Западной Европы в решении вопросов двойного гражданства// Материалы семинара по вопросам гражданства, безгражданства и статуса иностранцев в государствах СНГ и Балтии*. Хельсинки, 1994. С. 47

эрх авсан гадны иргэдэд нийгэм, эдийн засгийн хувьд давуу боломж олгож байна.

• Гадаадад буй эх орон нэгтнүүддээ зориулсан зохицуулалт бий болгох: ОХУ нь *"эх орон нэгтэн"* гэсэн ойлголтыг тодорхойлж, энэ хүрээнд тэдэнд зориулсан бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлж байна.

Судалгаанаас үүдэн дараахь саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрөх эсэх асуудлаар:

Судалгаанд хамрагдсан орнуудын хувьд хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрөх замаар харьяат иргэдээ алдахгүй байх бодлого хэрэгжүүлдэг. Харин Монгол Улсын хувьд Харьяатын тухай хуулиар гадаад улсад буй иргэддээ зориулсан зохицуулалтыг оруулахыг удирдлага болгож байгаа бөгөөд хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрөх асуудал нь иргэдийн "гадагш гарах урсгал"-ыг ихэсгэх сөрөг үр дагаварт хүргэх аюултай. Олон тооны Монгол Улсын иргэд гадаад улс руу явж ажиллах, суралцах, амьдрах хүсэлтэй байдаг хэдий ч тодорхой шалтгаанаар бүгд цагаачилдаггүйн нэг учир бол Монгол Улсын харьяаллаасаа гарахгүй байх хүсэл зоригт оршино. Мөн "гадагш чиглэх урсгал"-аас гадна "дотогш чиглэх урсгал"-ыг бодолцох хэрэгтэй. Тухайлбал, манай улсад БНХАУ, БНСУ, ОХУ-аас ирсэн олон тооны иргэд байдаг төдийгүй Монгол Улсын хүн ам зүйн байдал, хөгжлөөс хамаарч энэхүү иргэдийн тоог огцом нэмэгдүүлэх нь үндэсний аюулгүй байдал, хүн ам зүйн хувьд аюул учруулна. Дээрх шалтгаанаас улбаалан хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрөхгүй байх нь зүйтэй гэж үзэж байна. Мөн Монгол Улсын хувьд харьяаллын асуудлыг зохицуулсан олон улсын олон талт гэрээнд нэгдэн ороогүй, харьяаллын асуудлыг хөндсөн хоёр талт гэрээг цөөн тооны улстай байгуулсан зэрэг нь хоёрдмол харьяалалтай иргэд олшрох, эдгээр иргэдийн эрх зүйн байдлыг цогцолон шийдвэрлэж чадахгүй байх зэрэг сөрөг үр дагаварт хүргэнэ. Иймд энэ төрлийн гэрээнд нэгдэн орох, байгуулах шаардлагатай гэж үзэж байна.

2. Харьяаллын асуудлыг шууд бус хүлээн зөвшөөрөх замаар шийдвэрлэж болох эсэх:

Судалгааны ажлын удирдамжийн дагуу хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрдөггүй орнууд хоёрдмол харьяаллын асуудлыг хэрхэн шийдвэрлэж буйг судлахаас гадна мөн хоёрдмол харьяалалтай болсон иргэдийнхээ харьяаллын асуудлыг хөнгөвчилсөн журмаар зохицуулан, тэдний эрх ашгийг хамгаалж байгаа орны туршлагыг судлах зорилт дэвшүүлсэн. ОХУ-ын эрдэмтэн А.И.Ковлевын энэ асуудал дээр дэвшүүлж буй саналыг авч үзэхэд, гадаад улсад буй өөрийн орны иргэдэд харьяаллын болон бусад салбарт илүү хөнгөлөлттэй нөхцөлийг бүрдүүлэх журмыг хуулийн бус хүрээнд зохицуулах хэрэгтэй хэмээн үзжээ[894]. Өөрөөр хэлбэл энэ хүрээний асуудлыг тухайн улс өөрийн боловсруулсан үзэл баримтлал, хөтөлбөр хэлбэрээр шийдвэрлэж болно. Харьяатын тухай хуульд "Монгол Улсын харьяатаас гарч гадаад улсын иргэн болсон иргэний хувьд..." гэсэн нэр

[894] Ковлер А.И. *Двойное гражданство: панацея или ловушка?//* Актуальные проблемы гражданства: Материалы международной научно-практической конференции по проблемам гражданства. М., 1995. С.119

томъёо оруулах нь Монгол Улсын хувьд олон улсын гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүргээ зөрчиж, хүний үндсэн эрх, эрх чөлөөг хязгаарлаж, алагчилж буйг харуулна хэмээн үзэж байна. Дээр дурьдсан "Хилийн чанадад байгаа эх орон нэгтнүүдийн талаар баримтлах төрийн бодлогын тухай ОХУ-ын Холбооны хууль"-ийн 6-р зүйлд "...ОХУ-ын байгуулсан олон улсын гэрээ, конвенцид үл харшлах тохиолдолд..." гэсэн тодорхой заалтыг оруулсан байдаг

3.Харьяатын тухай хуулиар харьяаллаас гарсан иргэдийн асуудлыг шийдэх эсэх:

Монгол Улсын Харьяатын тухай хуулийн 4 дүгээр зүйлд "Монгол Улсын харьяат нэгэн зэрэг гадаад улсын харьяат байхыг хүлээн зөвшөөрөхгүй. Гадаад улсын харьяат нь Монгол Улсын харьяат болохыг хүсвэл тухайн улсынхаа харьяатаас гарсан байх шаардлагатай[895]" хэмээн тусгасан. Харьяатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд "..хоёрдмол харьяаллыг хязгаарлагдмал хүрээнд зөвшөөрөх замаар гадаад улсад амьдарч, оршин суудаг иргэдийнхээ хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах баталгаг бий болгох нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын үзэл санаатай нийцсэн зохицуулалт юм..." гэсэнтэй санал нийлэхгүй байна. Нэгдүгээрт, хуулиараа хоёрдмол харьяалал хүлээн зөвшөөрөөгүй тул гадаад улсын иргэн болсон иргэдийг "гадаад улсын иргэн" хэмээн тооцно. "Амьдарч буй улсынхаа иргэн биш этгээдэд хамаарах хүний эрхийн тунхаглал"-ын 1 дүгээр зүйлд: "гадаад улсын иргэн" гэдэг нь амьдарч буй улсынхаа иргэн биш этгээдийг хэлнэ"[896] хэмээн тодорхойлжээ. Хоёрдугаарт, нэгэнт гадаад улсын иргэн гэсэн ангилалд багтаж байгаа бол "Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай хууль"-иар тус этгээдтэй холбогдсон асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй хэмээн үзэж байна.

4.Төсөл, хөтөлбөрөөр зохицуулах:

Дээр хэлсэнчлэн Монгол Улсын харьяаллаас гарсан гадаад улсад амьдарч буй монголчуудаа эгүүлэн татах бодлогыг Харьяатын тухай хуулиар цогцоор шийдвэрлэх боломжгүй юм. Гадаад орнуудын жишээг авч үзэхэд тусгай хөтөлбөр, үзэл баримтлалыг санал болгодог байна. Энэ тохиолдолд Хилийн чанадад байгаа эх орон нэгтнүүдийн талаар баримтлах төрийн бодлогын тухай ОХУ-ын Холбооны хуулийг жишээг авч болно. Тус хуулийн талаар дээр дурдсан бөгөөд гол санаа нь өөрийн орны өв, соёл, уламжлалыг хөгжүүлэх, эх хэлээ авч үлдэхэд оршино. Тухайлбал, гадаад улсын иргэн болсон, ОХУ-ын иргэн хэдий ч урт хугацаагаар гадаад улсад амьдарч буй иргэд, тэдгээрийн үр хүүхэд орос хэл, соёл, уламжлалаа хөгжүүлэх, хадгалахад ОХУ-ын төрөөс хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх санааг агуулжээ. Энэ нь эдгээр иргэд нь ОХУ-д эргэн ирэх зайлшгүй шаардлагыг үүсгэхгүй байна. Ийм төрлийн үзэл баримтлал баталсан тохиолдолд дараах санааг агуулсан байх шаардлагатай хэмээн үзэж байна. Үүнд:

[895] Монгол Улсын Харьяатын тухай хууль, 1995 оны 6 дугаар сарын 5-ны өдөр

[896] НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1985 оны 12 дугаар сарын 1-ны өдрийн 40/144 тоот тогтоолоор баталсан. Монгол Улс нэгдэн ороогүй. http://www1.umn.edu/humanrts/instree/Rw4dhri.htm/сүүлд үзсэн 2011.03.09/

✓ Ямар төрлийн субьектэд зориулсан үзэл баримтлал /хөтөлбөр/ байх талаар тодорхой зааж өгөх /гадаад улсад амьдарч буй Монгол Улсын иргэд, эсхүл Монгол Улсын харьяаллаас гарсан иргэд, өндөр, дээд боловсрол, нарийн мэргэжил эзэмшсэн гадаад улсад амьдарч буй монголчууд, тэдгээрийн үр хүүхэд зэрэг хөтөлбөрт хамрагдах субьектыг тодорхой болгох/;

✓ Субъектыг тодорхой болгох хүрээнд *"эх орон нэгтэн"* хэмээх нэр томъёо Монгол Улсын хуулиар тодорхойлсон зохицуулалт байхгүй байгаа тул Хилийн чанадад байгаа эх орон нэгтнүүдийн талаар баримтлах төрийн бодлогын тухай ОХУ-ын Холбооны хуульд[897] *"эх орон нэгтэн"* гэсэн ойлголтыг авч үзэж буйг анхаарч, Монгол Улсын хувьд ийм нэр томъёо агуулсан зохицуулалт шаардлагатай хэмээн үзэж байна. Монгол Улсад *"эх орон нэгтэн"* хэмээх ойлголтыг тусгахын тулд нэр томъёоны хувьд маш тодорхой тайлбарлах шаардлагатай. Тухайлбал,

-*"Эх орон нэгтэн"* – монгол хэл, соёл уламжлал, заншил, зан уламжлалтай, эцэг, эх нь Монгол Улсын иргэн /иргэн байсан/ гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнийг;

-*"Эх орон нэгтэн"* – урт хугацаагаар гадаад улсад оршин сууж байгаа Монгол Улсын иргэн, гадаад улсын иргэнтэй гэр бүл болсны улмаас Монгол Улсын харьяаллаа алдсан этгээд гэсэн ойлголтуудыг агуулж болно.

✓ Мөн ОХУ-ын дээрх хуульд буй "Нэгдмэл хэл, шашин шүтлэг, соёлын өв, зан уламжлалтай хүмүүс", "гадаадад амьдардаг эх орон нэгтнүүд", "соёлын болон оюун ухааны ашиг тусын төлөө түүхэн эх оронтойгоо холбоо тогтоох сонголт хийсэн гадаадад байнга амьдардаг оросууд" гэсэн ойлголтуудыг Монгол Улсад эрх зүйн зохицуулалтын хүрээнд нэвтрүүлэх хэрэгтэй. Ингэснээр өөрийн орны уугуул соёл, уламжлалаа өвлөн хадгалах, хөгжүүлэх, гадаад улсад буй эх орон нэгтнүүдээ эгүүлэн татах, эх орон нэгтнүүд, тэдгээрийн үр хүүхдэд монгол соёл, уламжлал, хэл, ёс заншлыг нэвтрүүлэх, хадгалах зэрэг ач холбогдолтой зохицуулалт бий болно

✓ Тус үзэл баримтлал /хөтөлбөр/-ийн зорилгыг тодорхой болгох. Тухайлбал өндөр, дээд боловсролтой, нарийн мэргэжил эзэмшсэн монголчуудаа эх орны хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор эгүүлэн татах бодлого, эсхүл өөрийн орны соёл, хэл, өв, уламжлалаа хамгаалах, хадгалах, хөгжүүлэх, эсхүл Монгол Улсын харьяаллаас татгалзаж гадаад улсруу гарч буй иргэдийн тоог багасгах, эсхүл харьяалал нь тодорхойгүй иргэдийн хувьд гэр бүл бүртгэл, виз, хүүхэд үрчлэлт, дипломат хамгаалал зэрэг асуудлыг хөндөх, эсхүл хоёр улсын иргэний дундаас төрсөн хүүхдийн харьяаллын асуудлыг тодотгох зэрэг тодорхой зорилготой байх хэрэгтэй;

✓ Тус үзэл баримтлал/хөтөлбөр/нь ямар төрлийн давуу хөнгөлөлтүүдийг эдлүүлэх гэж буйг сайтар судласны үндсэн дээр зохицуулах хэрэгтэй. Аливаа хөнгөлөлт нь иргэдийг татах бус гадагш гарах байдлыг үүсгэж болохыг харгалзах хэрэгтэй.

✓ Монгол Улсын хуулиар "Эх орон нэгтэн" хэмээн ойлголтыг хуульчилсан тохиолдолд тэдгээр хүмүүст чиглэсэн дараахь төрийн бодлогыг баримталж болох талтай. Тухайлбал,

[897] Федеральный закон "О государственной политике Российской Федерации в отношении соотечественников за рубежом" № 99-ФЗ 1999.05.24.

- Монгол соёл, ёс заншил, хэл, өв уламжлалаа хадгалах, хөгжүүлэх үүднээс гадаад улсад буй эх орон нэгтнүүддээ чиглэсэн боловсрол, сургалтын хөтөлбөр боловсруулж, нэвтрүүлж болно. Энэ тохиолдолд олон тооны монголчууд байрших газрыг сонгон авч монголчууд, тэдгээрийн үр хүүхдэд зориулсан монгол хэл, соёл уламжлал, зан заншлын талаар суралцах сургалтын төсөл хэрэгжүүлж болно;
- Энэ хүрээнд Дипломат албаны тухай хуульд заасан Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газар нь Монгол Улсын иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн дагуу дипломат аргаар хамгаалах, консулын болон нотариатын үйлчилгээ үзүүлэх, иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийг хөтлөх, эд материал, санхүүгийн дэмжлэг үзүүлэх үүрэгтэй гэсэн чиг үүргийг[898] өргөжүүлж, уг газраар дамжуулж, Монгол Улсын иргэн, эх орон нэгтнүүддээ хэл соёл, түүх, зан заншил, уламжлалын хичээл зааж болох юм., Өөрөөр хэлбэл хилийн чанадад буй иргэдээ эгүүлэн татах шууд зохицуулалт хийхээс гадна тэдгээр иргэдийг эх орондоо өөрсдөө ирэх сэдэл төрүүлэхүйц бодлогыг явуулах хэрэгтэй байна.
✓ Монгол Улсын хөгжилд хувь нэмэр оруулах зорилготойгоор бизнес эрхлэх, төсөл хэрэгжүүлэх гэж буй эх орон нэгтний санаачилгыг дэмжих, тодорхой түвшинд төрөөс хөнгөлөлт үзүүлэх;
✓ Эх орон нэгтнүүд олон тоогоор оршин суух гадаад улсад монгол хэлээр олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслийг нэвтрүүлж ажиллуулах.

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын 4.8.3, Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.7-д заасан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 9 дүгээр сарын 28-ний өдрийн 250 дугаартай "Хөтөлбөр батлах тухай[899]" тогтоол баталжээ. Тус тогтоолын дагуу "Зөгийн үүр" хөтөлбөр[900], төлөвлөгөөг баталсны дагуу: "Хилийн чанадад өндөр боловсрол, мэдлэг, ур чадвар эзэмшин ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдийг эх орондоо урт, богино хугацаагаар эргэн ирж ажиллах, бизнес эрхлэх, гадаадын дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, мэдлэг дамжуулах, хөрөнгө оруулалт татах зэрэг олон хэлбэр, чиглэлээр эх орныхоо хөгжил дэвшилд хувь нэмэр оруулах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор энэхүү хөтөлбөрийг боловсруулав" хэмээн тусгажээ. Гадаад улсуудын жишээг авч үзэхэд, тус төрлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд эдийн засгийн хөшүүргээс гадна тодорхой нийгмийн хөшүүрэг байх хэрэгтэй хэмээн үзэж байна. Монгол Улсын хувьд "эх оронч сэтгэлгээ", "өөрийн орны ирээдүй, хөгжлийн төлөө санаа зовнисон сэтгэл" зэрэг үзүүлэлтүүдийг ашиглан хөшүүрэг үүсгэх боломжтой.

---

[898] Дипломат албаны тухай хууль-7.

[899] "Зөгийн үүр" хөтөлбөрийг баталсан тогтоол, http://cooperation.gov.mn /сүүлд үзсэн 2011.03.09/

[900] ЗГ-ын 2010 оны 09 сарын 28-ны өдрийн 250 тоот тушаалын хавсралт "Хилийн чанад дахь Монгол Улсын иргэдийг улс орны бүтээн байгуулалтад оролцоход дэмжлэг үзүүлэх Зөгийн үүр" хөтөлбөр

Хавсралт 1

ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ, ХҮН АМ ЗҮЙН БОДЛОГЫН ТАЛААРХ ЗОХИЦУУЛАЛТЫГ АГУУЛСАН ЭРХ ЗҮЙН АКТУУД

№	Хуулийн нэр	Заалт
		НЭГ. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:
1.	Аялал жуулчлалын тухай хууль /2002/	НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл 3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёо 3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно: 3.1.5."жуулчин" гэж аялал жуулчлал хийж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг;
2.	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль/1993/	НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт Энэ хуулийн зорилт нь гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсад орох, гарах, дамжин өнгөрөх, оршин суух журам, тэдний эрх, үүргийг тогтоож, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. 4 дүгээр зүйл. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай Монгол Улсын хуулийн хамаарах этгээд Энэ хуулийн заалт нь Монгол Улсад зорчигч, тус улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөгч, түр буюу удаан хугацаагаар оршин суугч, байнгын оршин суугч цагаач гадаадын иргэн, харьяалалгүй хүн / цаашид энэ хуульд"гадаадын иргэн" гэх/ -д хамаарна. ГУРАВДУГААР БҮЛЭГ Монгол Улсын виз, Монгол Улсад орох, гарах, дамжин өнгөрөх 3/ Монгол Улсад байнга оршин суугч, цагаач гадаадын иргэн, харьяалалгүй хүнд гарах, гарах-орох виз олгох; /Энэ заалтын дугаарыг 2001 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчилсөн/ 16 дугаар зүйл. Визийн хугацаа 1. 6/ Монгол Улсад байнга оршин суугч, цагаач гадаадын иргэн, харьяалалгүй хүнд гарах-орох визийг 120 хүртэл хоног. /Энэ заалтад 2000 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/
3.	Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль/1993/	НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ 3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо 2. "Гадаадын хөрөнгө оруулагч" гэж Монгол Улсад хөрөнгө оруулалт хийж буй гадаадын хуулийн этгээд, хувь хүн /Монгол Улсад байнга оршин суудаггүй гадаадын иргэн болон харьяалалгүй хүн, түүнчлэн гадаадад байнга оршин суудаг Монгол Улсын иргэн/-ийг хэлнэ. 3. "Монголын хөрөнгө оруулагч" гэж хөрөнгө оруулалт хийж буй монголын хуулийн этгээд, хувь хүн /Монгол Улсын иргэн, Монгол Улсад байнга оршин суудаг гадаадын иргэн болон харьяалалгүй хүн/-ийг хэлнэ.

4.	Газрын тухай/2002/	ТАВДУГААР БҮЛЭГ Газар эзэмшүүлэх, ашиглуулах 32 дугаар зүйл. Газар эзэмших тухай хүсэлт гаргах 32.2. Иргэн энэ хуулийн 32.1-д заасан хүсэлтэд дараахь зүйлийг тусгана: 32.2.2. эзэмших газрын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн харьяалал, хэмжээ, зааг, байршил, нэгж талбарыг харуулсан тойм зураг; 32.3. Аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 32.1-д заасан хүсэлтэд дараахь зүйлийг тусгана: 32.3.1. аж ахуйн нэгж, байгууллагын нооссон нэр, харьяалал, хаяг, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар; 32.3.2. тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах газрын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн харьяалал, хэмжээ, зааг, байршил, нэгж талбарыг харуулсан тойм зураг; 44 дүгээр зүйл. Газар ашиглуулах 44.4. Монгол Улсад байнга /183 хоногоос дээш хугацаагаар/ оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд газрыг зөвхөн гэр бүлийн хамтын хэрэгцээний нь зориулалтаар ашиглуулах асуудлыг дуудлага хуалдааны зарчмаар тухайн шатны Засаг дарга шийдвэрлэнэ. 44.7. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн газар ашиглах тухай хүсэлт гаргахын өмнө гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн эрх бүхий байгууллагаас тодорхойлолт авсан байна.
5.	Газрын төлбөрийн тухай/1997/	3 дугаар зүйл. Газрын төлбөр төлөгч Газрын тухай хуульд заасан нөхцөл, журмын дагуу гэрээ байгуулан газрыг эзэмшиж, ашиглаж байгаа Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, газар ашиглаж байгаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газар, гадаад улсын хуулийн этгээд, гадаадын иргэн, харьяалалгүй хүн газрын төлбөр төлөгч байна.
6.	Газрын хэвлий тухай/1988/	НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ 9 дүгээр зүйл. Газрын хэвлийг ашиглагч 2. Монгол Улсын хууль тогтоомжид заасан тохиолдолд газрын хэвлийг гадаад улсын хуулийн этгээд, иргэн, харьяалалгүй хүнд зохих журмын дагуу ашиглуулж болно.
7.	Галт зэвсгийн тухай /2001/	ХОЁРДУГААР БҮЛЭГ Галт зэвсэг өмчлөх 5 дугаар зүйл. Галт зэвсэг өмчлөх 5.4. Хуульд өөрөө заагаагүй бол дипломат болон олон улсын байгууллагад ажиллаж байгаагаас бусад гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэрт галт зэвсэг өмчлөхийг хориглоно.
8.	Галын аюулгүй байдлын тухай/1999/	ГУРАВДУГААР БҮЛЭГ Галын аюулгүй байдлын талаархи нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн эрх, үүрэг 15 дугаар зүйл.Галын аюулгүй байдлыг хангах талаархи иргэдийн эрх, үүрэг 15.1.Галын аюулгүй байдлыг хангах талаар Монгол Улсын иргэн болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн дараахь эрхтэй байна: 15.1.1.гал түймэр гарсан үед амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөө хамгаалуулах, гал түймрийн шалтгаан, нөхцөлийг тогтооход биечлэн оролцох; 15.1.2. гал түймэртэй холбогдолтой үнэн зөв мэдээ авах; 15.1.3.Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг холбогдох байгууллагаас шаардах. 15.2.Галын аюулгүй байдлыг хангах талаар Монгол Улсын иргэн болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн дараахь үүрэгтэй байна: 15.2.1.галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг сахин биелүүлэх; 15.2.2.гал түймэр гарч байгаа тохиолдолд гал түймэртэй тэмцэх байгууллагад нэн даруй мэдэгдэх; 15.2.3.гал түймэр унтраах, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг авран хамгаалах үйл ажиллагаанд бололцоотой дэмжлэг туслалцаа үзүүлэх; 15.2.4.гал түймрийн талаархи зөрчил, дутагдлыг холбогдох байгууллагад шуурхай мэдэгдэх.

9.	Гэр бүлийн тухай хууль/1999/	НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ 4 дүгээр зүйл. Гэрлэлт, гэр бүлийн харилцааны зарчим 4.6.Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугаа гадаадын иргэн,харьяалалгүй хүн гэр бүлийн харилцаанд Монгол Улсын иргэнтэй адил тэгш эрх эдлэж, үүрэг хүлээнэ. ХОЁРДУГААР БҮЛЭГ Гэрлэлтийн харилцаа үүсэх үндэслэл, гэрлэх нөхцөл, журам, гэрлэлт дуусгавар болох 6 дугаар зүйл.Гэрлэх нөхцөл 6.1.Энэ хуулийн 9.1-д заасан харшлах шалтгаангүй бол 18 насанд хүрсэн Монгол Улсын иргэн эрэгтэй, эмэгтэй хоёр буюу Монгол Улсын иргэн нь гадаадын иргэн, харьяалалгүй хүнтэй харилцан зөвшөөрөлцсөнөөр Монгол Улсад гэрлэж болно. 6.3.Монгол Улсад байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүний гэрлэх асуудлыг шийдвэрлэхэд Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийг баримтална. 6.4.Монгол Улсын иргэд хоорондоо, эсхүл Монгол Улсын иргэн нь гадаадын иргэн буюу харьяалалгүй хүнтэй гадаад улсад тухайн улсын хуулийн дагуу гэрлэсэн нь энэ хуулийн 9-д харшлахгүй бол Монгол Улсад хүчинтэйд тооцогдоно. 6.6.Монгол Улсын иргэн нь гадаадын иргэн, харьяалалгүй хүнтэй гадаад улсад гэрлэсэн бол тэдгээрийн эрх, үүргийг гэрлэгчдийн сонгосон улсын хуулиар, сонгоогүй бол энэ хуулиар тодорхойлно. 12 дугаар зүйл.Гэрлэлт цуцлах журам 12.3.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүний гэрлэлт цуцлах асуудлыг шийдвэрлэхэд Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийг баримтлана. 14 дүгээр зүйл.Гэрлэлтийг шүүхийн журмаар цуцлах 14.10.Гадаад улсад байнга оршин суугаа Монгол Улсын иргэд болон Монгол Улсын иргэн нь гадаадын иргэн, харьяалалгүй хүнээс гэрлэлтээ цуцлуулсан нь Монгол Улсын олон улсын гэрээ болон энэ хуульд харшлахгүй бол гэрлэлт цуцлуулсныг хүчинтэйд тооцно. ТАВДУГААР БҮЛЭГ Эцэг, эх, хүүхдийн хоорондын харилцаа 23 дугаар зүйл.Хүүхдийн эцэг, эхийг шүүхийн журмаар тогтоох 23.3.Хүүхэд Монгол Улсын иргэн бол Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнтэй холбогдолтой эцэг, эх тогтоох асуудлыг Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн дагуу шийдвэрлэнэ. ДОЛДУГААР БҮЛЭГ Хүүхэд үрчлэх 58.10.Энэ зүйл нь харьяалалгүй хүнд нэгэн адил хамаарна. НАЙМДУГААР БҮЛЭГ Асран хамгаалах, харгалзан дэмжих, хүүхдийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэх 67 дугаар зүйл.Асран хамгаалах, харгалзан дэмжих 67.3.Гадаад улсад оршин суугаа Монгол Улсын иргэн, Монгол Улсад байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг асран хамгаалж, харгалзан дэмжихэд энэ хуулийг дагаж мөрдөнө.
10.	Даатгалын тухай/2004/	НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл 5 дугаар зүйл. Гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүний даатгал 5.1. Гадаад улсын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа эд хөрөнгө, эдийн бус хөрөнгөө Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн нэгэн адил нөхцөлөөр даатгуулах эрхтэй.
11.	Жагсаал, цуглаан хийх журмын тухай/1994/	4 дүгээр зүйл. Жагсаал, цуглаан зохион байгуулах эрх 2. Хууль Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаж байгаа жагсаал, цуглаанд оролцох эрхтэй.

12.	Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай/2006/	ХОЁРДУГААР БҮЛЭГ Зохиогч, зохиогчийн эрхээр хамгаалах бүтээл 4 дүгээр зүйл. Зохиогчийн эрх эдлэх этгээд 4.1.Зохиогчийн эрхийг энэ хуулийн дагуу дараахь этгээд эдэлнэ: 4.1.1.бүтээл нь нийтлэгдсэн эсэхээс үл хамаарч бүтээл туурвисан Монгол Улсын иргэн, тус улсын нутаг дэвсгэрт байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн;
13.	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай/1995/	НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг зүйл 5 дугаар зүйл. Өргөдөл, гомдол гаргах эрх 2. Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн харьяалалгүй хүн өргөдөл, гомдол гаргах талаар Монгол Улсын иргэний адил эрх эдэлнэ.
14.	Иргэний бүртгэлийн тухай хууль/1999/	18 дугаар зүйл.Овог, эцгийн нэр, нэр өөрчлөгдсний бүртгэл 18.4.Иргэн овог, эцгийн нэр, нэрээ өөрчлөх тухай өргөдлее /өргөдөлд өргөдөл гаргагчийн овог, эцгийн нэр, нэр, төрсөн он, сар, өдөр, оршин суугаа газрын хаяг, гэр бүлийн байдал, төрсөн болон үрчлэн авсан хүүхдийн овог, эцгийн нэр, нэр, өргөдөл гаргагчийн сонгож авсан овог, эцгийн нэр, нэр, тэдгээрийг өөрчлөх болсон үндэслэл зэргийг дурдсан байна/ гаргаж дараахь баримт бичгийг хавсаргана: 18.4.7.гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг Монгол Улсын харьяат болгосон тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг;

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХЭЛТ
www.nli.gov.mn

ХОЁРДУГААР БҮЛЭГ ИРГЭНИЙ ГЭР БҮЛИЙН БАЙДЛЫН БОЛОН ХҮН АМЫН ӨРХИЙН БҮРТГЭЛ

12 дугаар зүйл.Төрснийг бүртгэх

12.15.Эцэг, эхийн хэн нэг нь Монгол Улсын харьяат, нөгөө нь гадаад улсын харьяат, эсхүл харьяалалгүй хүн бол тэдний дундаас тус улсын нутаг дэвсгэр дээр төрсөн хүүхдийг эцэг, эхийн хүсэлтийг үндэслэн энэ зүйлд заасан журмын дагуу бүртгэнэ.

13 дугаар зүйл.Гэрлэлтийн бүртгэл

13.6.Тус улсын нутаг дэвсгэр дээр Монгол Улсын иргэн гадаадын иргэн, харьяалалгүй хүнтэй, эсхүл гадаадын иргэд, харьяалалгүй хүмүүс хоорондоо гэрлэснийг Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11.1 дүгээр зүйлд заасан байгууллага эрхлэн бүртгэнэ.

13.9.Энэ хуулийн 13.2, 13.7-д заасан баримт бичгийг хавсаргасан өргөдлийг хүлээн авмагц иргэний бүртгэлийн ажилтан гэрлэснийг 30 хоногийн дотор бүртгэж, гэрчилгээ олгоно. Гэрлэлтийн гэрчилгээнд дараахь зүйлийг тусгана:

13.9.1.гэрлэгчдийн харьяалал, овог, эцгийн нэр, нэр, төрсөн он, сар, өдөр;

14 дүгээр зүйл.Гэрлэлт цуцалсны бүртгэл

14.6.Сум, дүүргийн Засаг даргын тамгын газрын иргэний бүртгэлийн ажилтан энэ хуулийн 14.2, 14.3, 14.5-д заасан баримт бичгийг хавсаргасан өргөдлийг хүлээн авч шийдвэрлэн гэрлэлт цуцалсныг бүртгэж, гэрчилгээ олгоно. Гэрлэлтийг цуцалсан гэрчилгээнд дараахь зүйлийг тусгана:

14.6.1.гэрлэлтээ цуцлуулсан нөхөр, эхнэрийн харьяалал, овог, эцгийн нэр, нэр;

14.8.Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн гэрлэлтээ цуцлуулах асуудлаа Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Гэр бүлийн тухай Монгол Улсын хуулийн дагуу шийдвэрлүүлнэ.

16 дугаар зүйл.Үрчлэлтийн бүртгэл

16.3.Гадаадын иргэн Монгол Улсын харьяат болон тус улсын нутаг дэвсгэр дээр оршин суугаа харьяалалгүй хүүхдийг үрчлэн авах тухай нотариатаар гэрчлүүлсэн хүсэлтээ нийслэл Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвд, орон нутагт аймгийн Засаг даргын дэргэдэх иргэний бүртгэл мэдээллийн албанд тус тус бичгээр гаргана.

16.5.Монгол Улсын харьяат болон тус улсын нутаг дэвсгэр дээр оршин суугаа харьяалалгүй хүүхдийг үрчлэн авах журам болон гадаадын иргэнээс бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг хууль зүйн болон эрүүл мэнд, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

17 дугаар зүйл.Эцэг тогтоосон тухай бүртгэл

17.3.Гэрлэлтээ бүртгүүлээгүй эцэг, эхээс төрсөн хүүхдийн эцгийг тогтоосныг эцэг, эхийн хамтран гаргасан өргөдлийг /өргөдөлд хүүхдийн эцэг мөн болохоо хүлээн зөвшөөрч байгаа иргэний овог, эцгийн нэр, нэр төрсөн он, сар, өдөр, иргэний харьяалал, оршин суугаа газрын хаяг, хүүхдийн овог, эцгийн нэр, нэр, хүйс, төрсөн он, сар, өдөр, газар, эцэг тогтоосны дараа хүүхдийн овог, эцгийн нэр, өөрчлөгдөх эсэхийг дурдсан байна/ үндэслэн иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд бүртгэнэ.

17.6.Хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнтэй холбогдсон эцэг тогтоосныг бүртгэхдээ энэ хуулийн 17-д заасныг баримтална.

		19 дүгээр зүйл.Нас барсны бүрттэл 19.5.Сум, дүүргийн Засаг даргын тамгын газар энэ хуулийн 19.3-т заасан баримт бичгийг хүлээн авч иргэний нас барсныг бүртгэж, гэрчилгээ олгоно. Гэрчилгээнд дараахь зүйлийг тусгана: 19.5.3.иргэний харьяалал, оршин суух байсан газрын хаяг; 19.7.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр, эсхүл тус улсын агаарын болон бусад хөлөг осолдсоны улмаас нас барсан гэж үзэх үндэстэй үед алга болсон гадаадын иргэн, харьяалалгүй хүн Иргэний хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу нас барсан гэж зарласныг бүртгэж болно. ГУРАВДУГААР БҮЛЭГ ИРГЭНИЙ ҮНЭМЛЭХ, ҮНДЭСНИЙ ГАДААД ПАСПОРТЫН БОЛОН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ БҮРТГЭЛ 22 дугаар зүйл.Иргэний үнэмлэх 22.4.Монгол Улсын харьяат 16 нас хүрсэн иргэн оршин суугаа нутаг дэвсгэрийнхээ сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт иргэний үнэмлэх авах тухай өргөдлөө гаргаж, дараахь баримт бичгийн аль нэгийг хавсаргана: 22.4.2.Монгол Улсын харьяат болгосон болон иргэний харьяаллыг сэргэн тогтоосон Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг. 24 дүгээр зүйл.Оршин суух үнэмлэх 24.1.Монгол Улсын эрх бүхий байгууллагаас олгосон Монгол Улсад оршин суух зөвшөөрлийн дагуу цагаач гадаадын иргэн, харьяалалгүй хүнд Монгол Улсад оршин суух үнэмлэхийг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1-д заасан Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба олгоно. 26 дугаар зүйл.Шилжин суурьших хөдөлгөөнийг бүрттэх 26.5.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугаа цагаач гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэр дээр шилжин суурьших тохиолдолд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг баримтална. ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ИРГЭНИЙ БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ 29 дүгээр зүйл.Иргэний бүрттэл, мэдээллийн сан 29.1.Иргэний бүрттэл, мэдээллийн сан дараахь мэдээллийг агуулна: 29.1.13.Монгол Улсад байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүний; ДОЛДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ 39 дүгээр зүйл. Иргэний бүрттэлийн хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага 39.1.Иргэний бүрттэлийн ажилтны хууль бус үйл ажиллагааны улмаас Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүний эрх хохирсон бол учирсан гэм хорыг хууль тогтоомжид заасны дагуу арилгана. 39.2.Иргэний бүрттэлийн тухай хууль тогтоомж зөрчсөн Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

15.	Иргэний хууль/2002/	НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл 7 дугаар зүйл. Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч 7.2. Иргэн гэж иргэний эрх зүйн харилцаанд оролцогч- Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг ойлгоно. ЖАРАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Олон улсын иргэний эрх зүйн харилцаанд оролцогчид 543 дугаар зүйл. Гадаад улсын иргэн, харьяалалгүй хүний иргэний эрх зүйн чадвар, чадамж 543.1.Гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын иргэний нэгэн адил иргэний эрх зүйн чадвартай байна. Энэхүү чадварыг Монгол Улсын хуулиар хязгаарлаж болно. 543.3.Харьяалалгүй хүний иргэний эрх зүйн чадамжийг түүний байнга оршин суугаа улсын хуулиар тодорхойлно. 543.5.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хийсэн хэлцэл, гэм хор учруулснаас үүсэх үүргийн талаархи гадаад улсын иргэн, харьяалалгүй хүний иргэний эрх зүйн чадамжийг Монгол Улсын хуулиар тодорхойлно. 546 дугаар зүйл. Иргэнийг сураггүй алга болсонд тооцох, нас барсан гэж зарлах 546.2.Харьяалалгүй хүнийг сураггүй алга болсонд тооцох, нас барсан гэж зарлахад тухайн эзтгэздийн байнга оршин суудаг газрын хуулиар, хэрэв байнгын оршин суух газар байхгүй бол Монгол Улсын хуулиар зохицуулна.
16.	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай/2002/	АРВАН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ Олон улсын иргэний эрх зүйн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа 189 дүгээр зүйл. Олон улсын иргэний эрх зүйн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны харьяалал 189.1.Монгол Улсын шүүхээр гадаад улсын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнтэй холбогдолтой иргэний хэргийг хянан шийдвэрлэхэд тэдгээр нь хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн адил эрхтэй байна. 189.2.Монгол Улсын шүүх дор дурдсан олон улсын иргэний эрх зүйн холбогдолтой иргэний хэргийг өөрийн харьяалалд хамааруулан хянан шийдвэрлэх ажиллагааг явуулна: 189.2.1.нэхэмжлэлийн хариуцагч нь Монгол Улсад байнга оршин суудаг буюу аж ахуйн үйл ажиллагаа явуулдаг; 189.2.2.нэхэмжлэлийг хэд хэдэн этгээд хамтран гаргасан ба тэдгээрийн аль нэг нь Монгол Улсад байнга оршин суудаг; 189.2.3.гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас нэхэмжлэл гаргасан ба тухайн үүргийг Монгол Улсад гүйцэтгэх ёстой байсан; 189.2.4.бусдад гэм хор учруулсны улмаас Монгол Улсын нутаг дэвсгэр дээр тухайн этгээдэд хохирол учруулсан; 189.2.5.хуулийн этгээдийн Монгол Улсын нутаг дэвсгэр дэх салбар буюу төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны улмаас маргаан үүссэн; 189.2.6.Монгол Улсын иргэн буюу Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суудаг гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн эцэг тогтоох ба тэтгэмж төлөхтэй холбогдсон нэхэмжлэл гаргасан;

		189.2.7.нэхэмжлэлийн зүйл нь өв залгамжлах эрх, өв залгамжлуулагчаас зд хөрөнгийг хуваах, гэрээслэл, үүрэг гүйцэтгэхтэй холбоотой бөгөөд өв залгамжлуулагч нас барахаасаа өмнө Монгол Улсад амьдардаг буюу оршин суудаг байсан, эсхүл тухайн өв хөрөнгө Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа. 189.2.Монгол Улсын шүүх дор дурдсан олон улсын иргэний эрх зүйн холбогдолтой иргэний хэргийг өөрийн харьяалалд хамааруулан хянан шийдвэрлэх ажиллагаг явуулна: 190 дүгээр зүйл. Олон улсын иргэний эрх зүйн холбогдолтой иргэний хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн онцгой харьяалал 190.1.Монгол Улсын шүүх дор дурдсан олон улсын иргэний эрх зүйн холбогдолтой иргэний хэргийг өөрийн онцгой харьяалалд хамааруулан хянан шийдвэрлэх ажиллагаг явуулна: 190.1.1.Монгол Улсын нутаг дэвсгэр дээрх үл хөдлөх зд хөрөнгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой маргаан; 190.1.2.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байршилтай хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, татан буулгах буюу тухайн хуулийн этгээдийн болон түүний салбар, төлөөлөгчийн газрын гаргасан шийдвэртэй холбоотой үүссэн маргаан; 190.1.3.Монгол Улсын шүүх буюу бусад эрх бүхий байгууллагын бүрттэл хүчин төгөлдөр эсэх талаархи маргаан; 190.1.4.Монгол Улсын эрх бүхий байгууллага патент, барааны тэмдэг болон бусад оюуны өмчтэй холбоотой эрхийг бүрттэсэн, бүрттэхээр өргөдлийг хүлээн авсантай холбоотой маргаан; 190.1.5.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх арга хэмжээ авсан буюу холбогдох этгээд ийм арга хэмжээ авахуулахаар өргөдөл гаргасан бол.
17.	Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай /2002/	ХОЁРДУГААР БҮЛЭГ Эрүүл мэндийн даатгал 6 дугаар зүйл. Даатгалд хамрагдах хүрээ 6.2. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн эрүүл мэндийн даатгалд сайн дураар даатгуулж болно.
18.	Компанийн тухай /1999/	ГУРАВДУГААР БҮЛЭГ Компани байгуулах 12 дугаар зүйл. Компанийн үүсгэн байгуулагч 12.1.Компанийн үүсгэн байгуулагч нь Монгол Улсын иргэн, хуулийн этгээд, түүнчлэн хуульд заасан бол гадаадын иргэн, хуулийн этгээд,харьяалалгүй хүн байж болно. 12.2.Компаниас гаргасан хувьцаат иргэн, хуулийн этгээд, гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн эзэмшиж болно.
19.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай/1993/	7 дугаар зүйл. Сонгуулийн үйл ажиллагааны эдийн засгийн баталгаа Төсөвт ба төрийн өмч оролцсон байгууллага /төрийн өмчийн хэсгээс нь/, гадаадын байгууллага /хамтарсан байгууллагын гадаадын оролцогч/, иргэн, харьяалалгүй хүнээс сонгууль бэлтгэн явуулах хугацаа /сонгууль зарласнаас эхлэд дууталхи/-нд хандив авч болохгүй.
20.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай/1993/	ХОЁРДУГААР БҮЛЭГ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БҮРЭН ЭРХ 15 дугаар зүйл.Ерөнхийлөгчийн бусад бүрэн эрх 4.Үзэлбодол, улстөрийн хийгээд шударгаёсны бусад үйл ажиллагааныхаа улмаас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн үндэслэл бүхий хүсэлт гаргасан тохиолдолд Монгол Улсад орогнох эрх олгох асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

21.	Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай /2002/	НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл 5 дугаар зүйл. Иргэнд газар өмчлүүлэхэд баримтлах зарчим, үндэслэл 5.2. Монгол Улсын иргэнтэй гэр бүл болсон гадаадын иргэн, харьяалалгүй хүн газар өмчлөх эрх эдлэхгүй. ХОЁРДУГААР БҮЛЭГ Иргэдэд газар өмчлүүлэх болон хувийн өмчийн газрын харилцааг зохицуулах талаархи төрийн байгууллага, нутгийн удирдлагын бүрэн эрх 12 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх 12.1.4. аймаг, нийслэлийн Засаг даргын шийдвэрээр газар өмчилж авсан иргэн өмчийнхөө газрыг гадаадын хуулийн этгээд, гадаадын иргэн,харьяалалгүй хүний өмчлөл, эзэмшилд шилжүүлсэн, газар тариалангийн газрыг зориулалт бусаар ашигласан, хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашигласан тохиолдолд тухайн газрыг хураан авах шийдвэр гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах; 14 дүгээр зүйл. Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх 14.1. Сум, дүүргийн Засаг дарга дараахь бүрэн эрхтэй: 14.1.5. иргэн өмчийнхөө газрыг гадаадын хуулийн этгээд, гадаадын иргэн, харьяалалгүй хүний өмчлөл, эзэмшилд шилжүүлсэн, газар тариалангийн газрыг зориулалт бусаар ашигласан, хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашигласан тохиолдолд тухайн иргэнд газар өмчлүүлэх шийдвэр гаргасан сумын Засаг дарга газрыг нь хураан авах шийдвэр гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах, эсхүл тухайн иргэнд газар өмчлүүлэх шийдвэр гаргасан аймаг, нийслэлийн Засаг даргад шүүхэд нэхэмжлэл гаргах саналыг уламжлах; ГУРАВДУГААР БҮЛЭГ Иргэнд газар өмчлүүлэх 20 дугаар зүйл.Газар өмчилж авах тухай өргөдөл гаргах, түүнийг хянах 20.1.Иргэн газар өмчилж авах тухай өргөдөлд дараахь зүйлийг тусгана: 20.1.2.оршин суугаа газрын хаяг, утасны дугаар, өмчилж авах газрын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн харьяалал;
		ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ Иргэний газар өмчлөх харилцааны онцлог зохицуулалт 28 дугаар зүйл. Газар өмчлөгч иргэнд хориглох зүйл 28.1.Газар өмчлөгч иргэнд дараахь зүйлийг хориглоно: 28.1.1.өмчийнгазраахудалдах,арилжих,өвлүүлэх,бэлэглэх,барьцаалах зэргээр гадаадын хуулийн этгээд, гадаадын иргэн, харьяалалгүйхүний өмчлөл, эзэмшилд шилжүүлэх; 29 дүгээр зүйл. Иргэн өмчийн газраа бусдад эзэмшүүлэх, ашиглуулах 29.9. Иргэний өмчийн газрыг гэрээний үндсэн дээр хөлсөлж, түрээслэж байгаа гадаадын хуулийн этгээд, гадаадын иргэн, харьяалалгүй хүн уг газрыг бусдад дамжуулан хөлслөх, дамжуулан түрээслэхийг хориглоно.
22.	Монгол Улсын Үндсэн хууль/1992/	НЭГДҮГЭЭР БҮЛЭГ МОНГОЛ УЛСЫН БҮРЭН ЭРХТ БАЙДАЛ Зургадугаар зүйл. 3. Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно. Энэ нь газрын хэвлийг өмчлөхөд хамаарахгүй. Иргэд хувийн өмчийнхөө газрыг худалдах, арилжих, бэлэглэх, барьцаалах зэргээр гадаадын иргэн,харьяалалгүй хүний өмчлөлд шилжүүлэх, түүнчлэн төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр бусдад эзэмшүүлэх, ашиглуулахыг хориглоно. 5. Төрөөс гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд газрыг төлбөр, хугацаатайгаар болон хуульд заасан бусад болзол, журмаар ашиглуулж болно.

23.	Монгол Улсын хилийн тухай/1993/	ХОЁРДУГААР БҮЛЭГ УЛСЫН ХИЛИЙН ДЭГЛЭМ 23 дугаар зүйл. Монгол Улсын хилийн төлөөлөгч 5. Хилийн төлөөлөгч, орлогч, туслагч нь хил зөрчсөн гадаадын иргэн б олон харьяалалгүй хүнийг хил залгаа улсын хилийн байгууллагад хүлээлгэн өгөх хүртэлх хугацаанд саатуулна. ГУРАВДУГААР БҮЛЭГ УЛСЫН ХИЛ ОРЧМЫН ДЭГЛЭМ 26 дугаар зүйл. Улсын хилийн бүс, түүнд мөрдөх журам 5/ хуульд өөрөөр заагаагүй бол улсын хилийн бүсэд гадаадын иргэн, харьяалалгүй хүн байнга оршин суухыг хориглоно.
24.	Нийгмийн даатгалын тухай/1994/	НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл 4 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын хэлбэр, хамрах хүрээ 4. Монгол Улсад байнга оршин суудаг, тус улсын аль нэгэн байгууллагад ажиллаж байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн, түүнчлэн тус улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулж байгаа гадаадын байгууллага, аж ахуйн нэгжид ажилладаг Монгол Улсын иргэн Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид хамаарна.
25.	Нийслэлийн эрх зүйн байдлын тухай/1994/	ГУРАВДУГААР БҮЛЭГ НИЙСЛЭЛИЙН УДИРДЛАГА, ИРГЭД, БАЙГУУЛЛАГЫН ХООРОНДЫН ХАРИЛЦАА 13 дугаар зүйл. Нийслэл хотын оршин суугч, нийслэлийн емнө түүний хүлээх үүрэг 3. Нийслэл хотын оршин суугч биш Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн нийслэл хотод амьдарч байх хугацаандаа энэ хууль, бусад хууль тогтоомж, нийслэлийн удирдлагаас гаргасан шийдвэрийг сахин биелүүлэх үүрэгтэй.
26.	Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай /2002/	НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл 5 дугаар зүйл. Албадан саатуулагдсан, цагдан хоригдсон этгэздийн эрх зүйн байдал 5.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт албадан саатуулагдсан, цагдан хоригдсон гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын Үндсэн хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль,1 энэ хууль болон бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд тусгайлан зааснаас бусад тохиолдолд Монгол Улсын иргэний адил эрх, эрх чөлөө эдэлж, үүрэг хүлээнэ.
27.	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай/1994/	ДОЛДУГААР БҮЛЭГ ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТ ГАЗАР АШИГЛАХ, СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ ЯВУУЛАХ 33 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах 2. Тусгай хамгаалалттай газар нутагт гадаад улсын хуулийн этгэзд олон улсын байгууллага, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газар ашиглуулахыг хориглоно.
28.	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай/1999/	3 дугаар зүйл. Нэрийн данс нээх нөхцөл, журам 3.1.Нэрийн дансыг нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан нөхцөл, журмын дагуу тэтгэврийн даатгалд хамрагдсан, 1960 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр ба түүнээс хойш төрсөн Монгол Улсын иргэн, тус улсад байнга оршин суугаа гадаадын иргэн болон харьяалалгүй хүнд нээнэ.

29.	Төрийн албаны тухай/2002/	ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ Төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх болзол, журам 16 дугаар зүйл. Төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх болзол 16.1.Төрийн тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангасан иргэний төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх эрхийг үндэс, угсаа, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол болон нам, олон нийтийн бусад байгуулл агын харьяалал зэргээр ялгаварлаж үл болно. 16.2.3. хууль тогтоомжоор зөвшөөрснөөс бусад тохиолдолд албан үүргийн хувьд нэг нь нөгөөдөө шууд захирагдах буюу шууд хяналт тавих албан тушаалтантай гэр бүл, төрөл, садангийн хүн нь тухайн ажлын албаны нэгжид хамт ажиллахаар бол; 16.2.4. гадаадын иргэн, харьяалалгүй хүн;
30.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай/1996/	ХОЁРДУГААР БҮЛЭГ Төрийн өмчийн зүйлс 4 дүгээр зүйл.Төрийн нийтийн зориулалттай өмч 4.Төрийн нийтийн зориулалттай өмчлөлийн зүйлсийг хуульд заасан нөхцөл, журмын дагуу иргэн /Монгол улсын иргэн, гадаадын иргэн,харьяалалгүй хүн/, бусад өмчийн хуулийн этгээдэд эзэмшүүлж, ашиглуулж болно.
31.	Улс төрийн намын тухай/2005/	ХОЁРДУГААР БҮЛЭГ Төрийн өмчийн зүйлс. 4 дүгээр зүйл.Төрийн нийтийн зориулалттай өмч 4.Төрийн нийтийн зориулалттай өмчлөлийн зүйлсийг хуульд заасан нөхцөл, журмын дагуу иргэн /Монгол улсын иргэн, гадаадын иргэн,харьяалалгүй хүн/, бусад өмчийн хуулийн этгээдэд эзэмшүүлж, ашиглуулж болно.
32.	Харьяатын тухай хууль/1995/	Бүрэн эхээр нь харах.
33.	Хувь хүний орлогын албан татварын тухай /2006/	ХОЁРДУГААР БҮЛЭГ Албан татвар төлөгч 5.1.Тухайн татварын жилд албан татвар ногдох орлого олсон, эсхүл тийм орлого олоогүй ч хуульд заасны дагуу албан татвар төлөх үүрэг бүхий Монгол Улсад оршин суугч Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн энэ хуулийн дагуу албан татвар төлөгч байна.
34.	Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай/2004/	ГУРАВДУГААР БҮЛЭГ Бусад зүйл 9 дүгээр зүйл. Иргэний эрх, үүрэг 9.3. Энэ зүйлийн заалт тус улсын нутаг дэвсгэрт оршин суугаа болон дамжин өнгөрөгч гадаадын иргэн, харьяалалгүй хүнд нэгэн адил хамаарна.
35.	Хүүхдийн эрхийг хамгаалах тухай/1996/	НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл 3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ 2.Энэ хууль Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүний хүүхдэд нэгэн адил хамаарна. ХОЁРДУГААР БҮЛЭГ Хүүхдийн эрх, журамт үүрэг 5 дугаар зүйл.Хүүхдийн амьдрах эрх 1.Хүүхэд төрмөгцөө нэр авах, Монгол Улсын харьяат байх эрхтэй. Хүүхэд гадаадын харьяат болох, гадаадын иргэн, харьяалалгүй хүний хүүхэд Монгол Улсын харьяат болох асуудлыг холбогдох хууль тогтоомж, олон улсын гэрээгээр зохицуулна.

36.	Эрүүгийн хууль/2002/	АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ 80 дугаар зүйл.Тагнуул хийх 80.1.Гадаад улсын иргэн буюу харьяалалгүй хүн Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах хүчин чадалд хохирол учруулах зорилгоор төрийн нууц, түүнд хамаарах мэдээ, баримт, бусад зүйлсийг хулгайлсан, цуглуулсан, тэдгээрийг гадаад улс, түүний тагнуулын албанд шилжүүлэн өгсен бол арван зургаагаас хорин таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 89 дүгээр зүйл.Хууль бусаар Монгол Улсын хил нэвтрэх Тайлбар: Үзэл бодол, улс төрийн болон шударга ёсны бусад үйл ажиллагааныулмаасхавчигданмөшгөгдсөнгадаадыниргэн, харьяалалгүй хүн орогнох эрх олж авахын тулд хууль бусаар Монгол Улсын хил нэвтэрсэн бол энэ зүйл хамаарахгүй.
37.	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай/2000/	4 дүгээр зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар төлөгч 4.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт үл хөдлөх эд хөрөнгө өмчилж байгаа дараахь этгээд үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар төлөгч байна: 4.1.4. Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн; 8 дугаар зүйл. Албан татвар ногдуулах, төсөвт төлөх 8.3. Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор нэг удаа төлнө.
38.	Өмгөөллийн тухай/2002/	ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ Өмгөөллийн үйл ажиллагаа зохлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, түүнийг хүчингүй болгох 16.4. Монгол хэл мэддэг, Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хуульд заасан сонгон шалгаруулалтад тэнцэж, гэрчилгээ авсан харьяалалгүйхүн, гадаадын иргэн хуульч Монгол Улсын нутаг дэвсгэрт өмгөөллийн үйл ажиллагаа явуулахыг хүсвэл мэргэшлийн шалгалт өгсний үндсэн дээр тусгай зөвшөөрөл авна.
		ХОЁР. УИХ-ЫН ТОГТООЛ
39.	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс нэвтрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай/1999.06.10-ны өдрийн дугаар 43 тогтоол/	1/тэтгэврийн даатгалд даатгагдсан 1960 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр ба түүнээс хойш төрсөн Монгол Улсын иргэн, тус улсад байнга оршин суугаа гадаадын иргэн болон харьяалалгүй хүнд тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс нээх, эхний үлдэгдэл, шимтгэлийг уг дансанд тооцох, нийт даатгуулагчид мэдээлэх ажлыг 2000 оны эхний хагаст багтаан дуусгах;
40.	Харьяатын тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай /1995.06.05-ны өдрийн дугаар 33 тогтоол/	Иргэний харьяаллын асуудлаар хүчин төгөлдөр үйлчилж байгаа Сайд нарын Зөвлөлийн тогтоол, бусад шийдвэр, журмыг харьяатын тухай хуульд нийцүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасугай.

ГУРАВ. ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ		
41.	Журам батлах тухай /Монгол Улсын үндэсний гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам/ /1997.04.30-ны өдрийн дугаар 109 тогтоол/	Хавсралт Долоо.Харьяалалгүй хүний гадаадад зорчих үнэмлэх 30.Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга оршин суугаа харьяалалгүй хүнийг гадаадад зорчиход түүнд зорчих үнэмлэх олгоно. 31.Харьяалалгүй хүнд олгох зорчих үнэмлэхийн загварыг Хууль зүйн сайд батална. 32.Харьяалалгүй хүнд зорчих үнэмлэх олгох, нэгдсэн бүртгэл хөтлөх, хяналт тавих ажлыг Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв хариуцна. 33.Харьяалалгүй хүний зорчих үнэмлэх болон түүнд хавсаргах хүүхдийн үнэмлэхэд Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвийн дарга, хэлтсийн дарга гарын үсэг зурна.
42.	Журам батлах тухай /Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам/ /2002.10.22-ны өдрийн дугаар 124 тогтоол/	Хавсралт 1.6. Гадаадын иргэн, харьяалалгүй хүний шилжилт хөдөлгөөнийг бүртгэхтэй холбоотой харилцааг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу зохицуулна.
43.	Журам батлах тухай "Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан гадаадын иргэн, харьяалалгүй хүнд тавих шалгуурыг тогтоох журам" /2003.03.12-ны өдрийн дугаар 62 тогтоол/	/Бүрэн эхээр нь харах/
44.	Орон сууцны салбарыг зах зээлийн харилцаанд шилжүүлэх бэлтгэлийг хангахтай холбогдсон зарим арга хэмжээний тухай /1994.03.09-ний өдрийн дугаар 55 тогтоол/	Хавсралт. Гадаадын болон харьяалалгүй иргэдэд орон сууц хувьчлан өмчлүүлэхгүй.

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

45.	Хуулиудыг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай /Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийх журам/ /2003.02.07-ны өдрийн дугаар 28 тогтоол/	Хавсралт 1. Монгол Улсын иргэнд өмчлүүлэх болон иргэний өмчийн газар, Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах болон тэдний эзэмшиж, ашиглаж байгаа газар, гадаад улс, олон улсын байгууллага, гадаадын хуулийн этгээд, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын иргэн, харьяалалгүй хүнд хууль тогтоомжийн дагуу ашиглуулах болон ашиглуулж байгаа .газарт, түүнчлэн өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгоогүй терийн өмчийн бусад газарт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа /цаашид "хянан баталгаа" гэх/ хийхэд энэ журмыг дагаж мөрдөнө. 27. Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн газарт хянан баталгаа хийхэд тухайн газрыг өмчлөгч, эзэмшигч, ашиглагч Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгэздийн эрх баригч буюу захиалагч биеэр байлцах үүрэгтэй. 31. Газрын төлөв байдал, чанарын тодорхойлолтыг үндэслэн Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаад, дотоодын хуулийн этгээдийн эзэмшиж, ашиглаж, өмчилж буй газрын хянан баталгааны паспортыг хянан баталгаа хийх эрх бүхий аж ахуйн нэгж хөтөлнө. Хянан баталгааны паспортыг газар эзэмшүүлэх, ашиглуулах тухай эрхийн гэрчилгээ, гэрээнд болон Монгол Улсын иргэний өмчилж авсан газрын үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээнд тус тус хавсаргана. 4/ гадаад улс, олон улсын байгууллага, гадаадын хуулийн этгээд, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын иргэн,харьяалалгүй хүнд ашиглуулах газрын хил, заагийг тогтоох, түүнд өөрчлөлт оруулах, тодотгох; 9. Газар зохион байгуулалтыг дараахь харьяаллын дагуу эрхлэн гүйцэтгэнэ: 3/ иргэнд өмчлүүлэх, эзэмшүүлэх, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, түүнчлэн гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаад улсын байгууллага, хуулийн этгээдэд ашиглуулах газрын газар зохион байгуулалтыг хийхдээ аль болох нэг дор байрлах боломж эзэлдэх газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн хууль ёсны эрхийг хохироохгүйгээр зохион байгуулах, газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн сервитут, узуфрукт эрх эзэгийг харгалзах. 24. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын иргэн, харьяалалгүй хүнд ашиглуулж байгаа газрыг улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авахад энэ журмыг дагаж мөрдөнө. 1. Монгол Улсын иргэн, түүний гэр бүлийн гишүүн-Монгол Улсын иргэнд дундаа хамтран өмчлөх хэлбэрээр хуульд заасан зориулалтаар газар өмчлүүлэх /цаашид "иргэнд газар өмчлүүлэх" гэх/, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх, түүнчлэн Газрын тухай хуулийн 44.4-т заасны дагуу гадаадын иргэн, харьяалалгүй хүнд газар ашиглуулах дуудлага худалдаа /цаашид "дуудлага худалдаа" гэх/-г зохион байгуулахад энэ журмыг дагаж мөрдөнө. 5. Дуудлага худалдаанд оролцох хүсэлтээ илэрхийлж, данчингээ зохих журмын дагуу тавьсан Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын иргэн, харьяалалгүй хүн дуудлага худалдаанд оролцох эрхтэй. 6. Дуудлага худалдаанд оролцогч Монгол Улсын иргэн 5000 төгрөг, аж ахуйн нэгж, байгууллага болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн тус бүр 10000 төгрөг, ажиглагчаар оролцогч иргэн 1000 төгрөгийн хураамж төлнө.

Хавсралт 2

ИРГЭНИЙ ХАРЬЯАЛЛЫН АСУУДЛААР ЗОХИЦУУЛАЛТЫГ АГУУЛСАН МОНГОЛ УЛСЫН НЭГДЭН ОРСОН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНИЙ ЖАГСААЛТ

№	ГЭРЭЭНИЙ НЭР	ЗААЛТ
1	Апартеидын гэмт хэргийг таслан зогсоох, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай олон улсын конвенц*	/С/ арьс үндэстний нэг буюу хэд хэдэн бүлгийг тухайн улсын улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын амьдралд оролцоход саад учруулахад чиглэсэн хууль тогтоох шинжтэй буюу бусад арга хэмжээ авах, мөн хөдөлмөрлөх эрх, хүлээн зөвшөөрсөн үйлдвэрчний эвлэл байгуулах эрх, сурч боловсрох эрх, эх орноосоо гарч явах, буцаж ирэх эрх, иргэний харьяалалтай байх эрх, чөлөөтэй зорчих, оршин суух газраа сонгох эрх, өөрийн үзэл бодолтой байж, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх, тайвнаар жагсаал, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрхийг оролцуулан арьс үндэстний нэг буюу хэд хэдэн бүлгийн гишүүдийн хүний эрх, үндсэн эрх чөлөөг үгүйсгэх замаар тийм нэг буюу хэд хэдэн бүлэгт бүрэн хөгжиж дэвшихэд нь саад учруулах нөхцөл байдлыг санаатайгаар бий болгох;
2	Арьс үндсээр алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц**	/III/ иргэний харьяалалтай байх эрх; Оролцогч улсууд харьяалалдаа байгаа хүн бүрийг энэхүү Конвенцийг зөрчин хүний эрх, үндсэн эрх чөлөөнд халдаж байгаа арьс үндсээр алагчилах аливаа үйлдлээс харьяалах үндэсний шүүх, төрийн бусад байгууллагаар дамжуулан үр нөлөөтэй хамгаалуулах, арга хэмжээ авахуулах, түүнчлэн арьс үндсээр алагчласны уршгаар үүссэн аливаа хохирлыг шударга бөгөөд зохих ёсоор нөхөн төлүүлэх талаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхээр хангана.
3	Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсын хоорондх иргэн, гэр бүл болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ***	г/зохигчид, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч болон ялтны овог нэр, тэдний байнга буюу түр оршин суугаа газар, иргэний харьяалал, эрхэлдэг ажил, боломжтой бол сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч болон ялтны төрсөн газар, он,сар, өдөр; 2.Хэрэв гэрлэгсэд өөр өөр харьяалалтай байвал гэрлэлт буюу түүнийг цуцлах, хүчингүйд тооцохтой холбогдсон асуудлыг уг хэргийг хянаж байгаа Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллага өөрийн орны хууль тогтоомжийг баримтлан шийдвэрлэнэ. 2.Иргэний өөр өөр харьяалалтай эхнэр, нөхөр хүүхэд үрчлэн авч байгаа бол Хэлэлцэн тохирогч хоёр Талын нутаг дэвсгэрт мөрдөгдөж буй хууль тогтоомжийг хэрэглэж болно.
4	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт****	1. Энэхүү Пактад оролцогч улс бүр нутаг дэвсгэртээ болон харьяалалдаа байгаа бүх хүний энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн буюу бусад байдлаар ялгаварлахгүйгээр хүндэтгэн хангах үүрэгтэй.2. 2. Хүүхэд бүр иргэний харьяалалтай болох эрхтэй.
5	Хүний эрхийн түгээмэл тунхаглал*****	1. Хүн бүр иргэний харьяалалтай байх эрхтэй. 2. Аливаа хүний иргэний харьяалал болон харьяаллаа өөрчлөх эрхийг дур мэдэн цуцлах ёсгүй.

* 1973 онд батлагдаж, Монгол Улс 1975 онд нэгдэн орсон
** НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1965 онд баталж, Монгол Улс 1969 онд соёрхон баталсан.
*** 1988 онд байгуулсан.
**** НҮБ 1966 онд баталж, 1968 онд Монгол Улс нэгдэн орсон.
***** НҮБ 1946 онд баталж, 1961 онд Монгол Улс нэгдэн орсон.

6	Хүүхдийн эрхийн тухай конвенц*	2.1. Оролцогч улсууд хүүхдийн, түүний эцэг, эх буюу хууль ёсны асран хамгаалагчийг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэс, угсаа, нийгмийн гарал, зд хөрөнгө, эрүүл мэнд, төрсөн болон бусад байдлаас үл шалтгаалан аливаа хэлбэрээр алагчилахгүй энэхүү Конвенцид заасан бүх эрхийг харьяалалдаа байгаа хүүхэд бүрийн хувьд хүндэтгэн хангана. 7.1.Хүүхэд төрөгцөө бүртгүүлэх, төрсөн цагаасаа нэр авах, иргэний харьяалалтай болох, түүнчлэн эцэг эхээ боломжийн хэрээр мэдэх, хайр халамжийг нь хүртэх эрх эдэлнэ. 7.2. Оролцогч улсууд эдгээр эрхийг, ялангуяа хүүхэд иргэний харьяалалгүй болох тохиолдолд үндэсний хууль тогтоомж, холбогдох олон улсын баримт бичгийн дагуу хүлээсэн үүрэгтэй нийцүүлэн хэрэгжүүлнэ. 8.1.Оролцогч улсууд хуульд заасан иргэний харьяалалтайбайх, нэр авах, гэр бүлийн холбоогоо хадгалах эрэгээр хувийн онцлог байдлаа хадгалах хүүхдийн эрхийг хүндэтгэх, үүнд хууль бусаар оролцохгүй байх үүрэг хүлээнэ.
7	Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц**	1. Оролцогч улсууд иргэний харьяалалтай болох, түүнийг өөрчлөх буюу хэвээр хадгалах асуудлаар эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдтэй тэгш эрх олгоно. Тухайлбал, оролцогч улс эмэгтэйчүүд гадаадын иргэнтэй гэрлэх, гэрлэлтийн хугацаанд нөхөр нь иргэний харьяаллаа өөрчлөхөд эхнэрийнх нь иргэний харьяаллыг шууд өөрчлөхгүй байх, мөн түүнийг иргэний харьяалалгүй болгохгүй байх, эсхүл нөхрийнх нь иргэний харьяаллыг авахыг албадахгүй байхыг хангана. 2. Оролцогч улсууд хүүхдийн иргэний харьяаллын тухайд эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдтэй тэгш эрх олгоно.

* НҮБ 1989 онд баталж, 1990 онд Монгол Улс нэгдэн орсон.
**НҮБ 1979 онд баталж, 1980 онд Монгол Улс нэгдэн орсон.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ISBN 9996214702